

С.Дэмбэрэл

**Эрх чөлөө ба  
Ногоон хөгжлийн  
тухай миний бодлууд**

2015 он.

## ӨМНӨХ ҮГ

Монгол улсын иргэд, хүндэт сонгогчид,  
Иргэний Зориг Ногоон Намын дэмжигчид  
болон эрхэм журмын нөхөд та бүхэндээ энэхүү  
эмхэтгэлээрээ дамжуулан мэндчилж байна.


Та бүхний өгсөн итгэл найдвар, хийсэн сонголт, даатгаж хүлээлгэсэн үүрэг даалгавар, 2012 оны Сонгуульд дэвшүүлсэн "АМЬДРАЛ" мөрийн хөтөлбөрийг өөрийн болон нөхдийнхөө оролцоо, дэмжлэгтэйгээр хэрхэн биелүүлж байгаагаа харуулах, иргэд, сонгогчид болон намын гишүүд дэмжигчиддээ зориулсан байнгын нээлттэй тайлан болгон харуулах зорилгоор энэхүү өчүүхэн товхимолыг толилуулж байна. Энэхүү товхимолд орсон олон зүйлийг та бүхэн миний тухай мэдээлэлийг албан ёсоор тогтмол илэрхийлдэг **demberels.parliament.mn** цахим хуудаснаас мөн харж болно. Энэ цахим хуудаснаас Улсын Их Хурлын гишүүн миний санаачилан, өргөн мэдүүлсэн хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслүүд, Засгийн газрын гишүүдэд тавьсан асуулт, асуулга, чуулганы нэгдсэн болон байнгын хороодын хуралдаануудад хэлсэн үг, хяналт шалгалтын болон хууль, тогтоолын төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан байдал, байр суурь, санал санаачилга төдийгүй цаг үеийн болон бусад мэдээ мэдээлэл, хэвлэлд өгсөн ярилцлага, нийтлэл, эрдэм шинжилгээ судалгааны материал, Төрийн мэдээллийн цуврал, УИХ-д өргөн баригдсан зарим хууль, тогтоолуудын төсөл болон тэдгээртэй холбоотой материалууд, хувийн болон байгууллага, хамт олны бүтээлүүдийн тойм зэргийг шууд болон хавсралтаар үзэж танилцах, хуулж авах, илтгэл болон видео бичлэг хэлбэрээр үзэх боломжтой байгаа билээ. Харин энэхүү товхимолоор эдгээрийн заримаас түүвэрлэн хүргэж байна. Мөн цаг үеийн асуудлуудаар хэвлэл мэдээлэлийн ажилтанууд, сэтгүүлчидэд өгсөн ярилцлагуудын заримыг энэхүү товхимолд орууллаа.

Эрхэм сонгогчид, ажил хөдөлмөр эрхлэгчид өргөдөл, гомдол, санал санаачлага, хүсэл мөрөөдөл бүхнийг төрийн аливаа бодлого шийдвэрүүд хууль тогтоолуудад оруулахыг хичээх, төлөөлөн

илэрхийлэх, манай намын уриа болсон “Монголдоо сайхан амьдрах” бүхий л нөхцөл бололцоог хангахын төлөө өөрийн мэдлэг, чадвар, бололцоо бүхнээ дайчлан ажиллаж байгаагаа та бүхэндээ илэрхийлж байна. УИХ-ын гишүүн, ИЗНН-ын даргын хувьд УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын байнгын хорооны бүрэлдхүүнд орж, эдгээр хороодоор дамжин УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэж буй бүхий л асуудалд саналаа хэлж, шүүмжилж, бас цөөнгүй ажлын хэсгийн бүрэлдхүүнд орж, ахалж ажиллалаа.

Мөн УИХ дахь “Ногоон бүлэг”-ийг байгуулан ахалж байна. Мөн хувиараа болон аж ахуйн бүхий л хэлбэрээр хөдөлмөрлөж, бизнес эрхэлж, өөрийнхөө болон гэр бүл, хамт олон, төрөл төрөгсөд, улс орныхоо төлөө давхар давхар ачаа үүрэн зүтгэл яваа эгэл жирийн ард иргэд та бүхнийхээ ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бий болгохын төлөө өөрсдийн зүгээс шалтгаалах бүхнийг бүтээлчээр хийж гүйцэтгэх гэж чармайж байгаагаа илэрхийлье. Тиймээс ч та бүхнээс асуулт, санал хүсэлтийг шуурхай хүлээн авах болно. Таны ажил үйлсэд тань амжилт ололтын дээдийг, амьдрал ахуйд чинь хамгийн сайн сайхан бүхнийг чин сэтгэлээсээ хүсэн ерөөе.

**Монгол Улсын Их Хурлын гишүүн,  
Иргэний Зориг Ногоон Намын дарга**



**Самбуугийн ДЭМБЭРЭЛ**

## ТЭРГҮҮН БҮЛЭГ.

### ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ, НОГООН ХӨГЖИЛ ГЭСЭН 3 ТУЛГУУР БАГАНА БОЛ МОНГОЛЫН ХӨГЖЛИЙН ГАРЦ

#### НЭГ. Хүний эрх, эрх чөлөө бол бидний өдөр тутмын амьдралын асуудал мөн.

*“Би хувь хүнийхээ хувьд либерал үзлийг баримталдаг”*

*24 tsag.mn цахим хуудсанд 2011 оны 11 сарын 1-нд гарч байсан  
ярилцлагыг та бүхэнд сөхөн харуулъя гэж бодлоо.*

*МҮХАҮТ-ын дарга С.Дэмбэрэл ИЗНН-д гэнэт элссэн нь өнгөрсөн  
долоо хоногийн үнэхээр гэнэтийн үйл явдлын нэг байлаа.  
“Танхимын” хэмээх хочтой шахуу болсон энэ хүн яагаад, яаж, яах  
гэж ийн “гэнэдцүлсэн” тухайгаа яриу.*

- Та бол бизнесийнхний нэрийн хуудас болсон хүн. Гэнэт яагаад намын гишүүн болж, улс төр сонирхоод эхлэв. Эсвэл бизнест тань улс төрийн хамгаалалт хэрэгтэй болов уу?

- Бизнесийнхний нүүр царай болсон гэж дүгнэсэнд баярлалаа. Ямар ч гэсэн хувийн хэвшлийг төлөөлж арваад жил ажиллалаа. Харин сая С.Дэмбэрэл гэдэг хувь хүний хувьд үзэл бодлоо дагаж намд элслээ.

- Гэхдээ яагаад заавал ИЗНН гэж?

- 1990 онд либералчилах, либерал үзлийг анх Монгол улсад дэлгэрүүлж байсан цөөхөн хүний нэг нь би. Тухайн үед МҮДН-ын суурь болж байсан Үндэсний шинэ дэвшилтэт холбоо, либерал үзлийг сурталчилдаг эдийн засагчдын клубын анхны гишүүн байсан. Би хувь хүнийхээ хувьд либерал үзлийг баримталдаг. Энэ нь хувь хүнд эдийн засгийн болон улс төрийн эрх чөлөөг дээд зэргээр хангаж өгөх, харин төр эдийн засагт хязгаарлагдмал бөгөөд үр ашигтай оролцох явдал юм. Энэ үзэл бодлоо дагаж би ИЗНН-д элссэн. Саяхан Лондон хотноо болсон либерал интернационал чуулганаас албан ёсны гишүүнчлэлээ авсан, хэвлэлийнхэн та бүхний тодорхойлж бичдэгчлэн энэ жижиг намыг сонголоо. Ер нь ИЗНН нийгэмд дэвшил хийчихсэн нам. Хамгийн түрүүнд намын хатуу гишүүнчлэлээс татгалзъя гэж дуугарсан, мөн дэмжигч гишүүдийнхээ статусыг анх удаа албажуулсан. Одоо дарга нар нь намын хатуу гишүүнчлэлгүй болгохоор хууль санаачлаад явж байна. Дээр нь нэгэнт дэлхий дахины хандлага болчихсон ногоон үзэл баримтлалыг ярьж, хэрэгжүүлдэг. Өнөөдөр Монголын эдийн засаг 17-20

хувийн өсөлттэй байхад яагаад хүн амын 50 хувь нь ядуу байна яагаад хүн амд нь таван төрлийн өвчин зонхилж, уул ус татарч, цөлжилт хурдацтай яваад байна гэж санаа зовдог учраас дуу хоолойгоо нэгтгэхийн тулд ийм шийдвэр гаргасан.

**- Мэдээж та ИЗНН-д орохдоо сул гишүүн байхаар тооцоогүй байх. Яваандаа энэ намын дарга болох уу?**

- Би үүнийг урьдчилж хэлж мэдэхгүй шүү дээ. Намын гишүүдийн шийдэх асуудал. Улс төрийн хувьд би дөнгөж нэгдүгээр ангид орж байна.

**- Тэгвэл эхний ээлжинд УИХ-д нэр дэвших санаатай байгаа юм байна, тийм үү?**

- УИХ-д нэр дэвших асуудлыг ИЗНН-ын нийт гишүүдийн хурал шийддэг юм. С.Дэмбэрэл гэдэг хүнд итгээд та нэрээ дэвшүүлээч гэвэл би татгалзахгүй. Эдийн засаг, улс төрийн эрх чөлөөг дээдэлсэн, хүмүүс нь өөрөө өөрсдийнхөө амьдралыг өөд татахад төр тэгш боломжоор хангаж өгдөг хөгжлийн загварыг иргэд хүсч байна. Ийм бодлогыг хэрэгжүүлэх, Монголын бизнесийн, жижиг, дунд үйлдвэрлэгчдийн эрх ашгийг төлөөлөх туршлага хуримтлуулсан гэж өөрийгөө үзэж байгаа. Хувийн хэвшлийнхний жаргал, зовлонг мэдэрдэг хүний хувьд засаглалд, баялаг бүтээгчдийн дуу хоолойг маш тодорхой дамжуулах чадвар надад бий. Тэгээд ч төлөвлөж байгаа зүйлээ улс төрд орж байж гүйцэлдүүлэх боломжтой. Би болсон болоогүй бизнесийн реформ, төр хувийн хэвшлийн түншлэл гэж яриад нэмэр алга. Төрд бизнесийн дуу хоолойг хүргэх амаргүй юм байна. Төрд зах зээлийг ойлгодог, эдийн засгийг зөв замаар хөтлөх олон хүн хэрэгтэй. Тэдэнтэй хамтран ажиллаж, хэтэрхий данхайсан төрийг хязгаарлах зорилгоор улс төрд орлоо. Тэгээд ч ард иргэд нь зүгээр суугаад мөнгө авдаг, ямар ч хөрөнгө оруулалт хийгээгүй мөртлөө бүгд хувьцаа эзэмшигч боллоо. Ийм нийгэм бүтээгээд, түүнийгээ зөв зам гэж бодоод байна. Би эдийн засагч хүн, Монгол улсын иргэний хувьд энэ гажгийг хөндлөнгөөс зүгээр хараад суумааргүй байна.

**- Харин ч хөндлөнгөөс хараад явах нь дээр байсан юм биш үү. Улс төр хамгийн бохир гэж ярьдаг шүү дээ. Та дунд нь орохоороо тэдний адил болчих байх даа?**

- Хийнэ, бүтээнэ өөрчилнэ гэж орчихоод бусад улстөрчдийн адил болчихоод байгаа нь өнөөдрийн эмгэнэл байхгүй юу. Гэхдээ яагаад цэвэр улс төр байж болохгүй гэж. Дэлхийн улс оронд ганц үг хэлсэнийхээ төлөө огцордог улстөрч олон байна шүү дээ. Ер нь ардчиллыг хөгжүүлбэ гэвэл улс төр нь цэвэр байх ёстой. Бохир байвал Монголд ардчилал хэзээ ч хөгжихгүй. Өнгөрсөн 20 жил улс төр бохирдож, ард иргэд нь төрдөө итгэхээ больж. Хүнийг биологийн амьтан талаас нь биш, хөгжил талаас нь харах улстөрчидтэй болмоор байна. УИХ бол мэдлэг, туршлага бүхий хүмүүсийн өрсөлдөөний талбар байх ёстой. Өнөөдрийнх шиг тендер хувааж иддэг, өөрийн атгаг санаагаа гүйцэлдүүлэхийн тулд дэвшдэг хэвээр байвал улс төр 2012 оноос хойш улам бохир болно. Энэ муу муухайг цэвэрлэхийн тулд хамтран зүтгэж чадна гэж бодоод би ИЗНН-ыг сонгосон. Гэхдээ ард иргэд улс төрийг бохир гэж харахаасаа илүү зөв хүнээ сонгож гаргах нь чухал. Гаднынхан Монгол улсад дэндүү их анхаарал хандуулж байна. Энэ нь хоёр талтай, эхнийх нь сайныг хүсч байгаа л байх, нөгөөх нь Монголыг

залгих гэж улайраад байна. Тэгэхээр хүн бүхэн сонор сэрэмжтэй байж, эрүүл шийдвэр гаргах хүнийг УИХ-д олноор нь гаргах хэрэгтэй.

- **Танд АН, МАН-ынхан намдаа элсээч гэсэн санал тавьсан уу?**

- 2008 оны сонгуулийн үед санал ирсэн. Би маш тодорхой “үгүй” гэж хариулж байсан. Хувь хүнийхээ хувьд би бусад намын дарга нартай найз. Гэлээ гэхдээ “Би танай намд оръё, надад тийм юм өгчих.” гэж суудал бөглөөд суухыг хүсээгүй. Найз бол найз, харин үзэл бодол минь тусдаа. Тиймээс л өөртөө урам зориг өгч, хүмүүсийн зөвлөгөөг дагаад энэ намд элссэн. Би 2005 онд нэг ярилцлагадаа “Намд элсвэл ИЗН-д л орно. Гэхдээ би улс төрд орохгүй байх аа” гэж хэлж байсан. Цаг цагаараа байдаггүй юм байна. ИЗНН-ыг л сонгочихлоо.

- **Магадгүй та удахгүй танхимаа орхих юм шиг байна. Танхимыг ямар хүн удирдаасай гэж хүсч байна вэ?**

- Танхимыг хэзээ нэгэн цагт орхиж таарна. Би сая сонгогдсон, 2014 онд ажлаа өгнө. Одоо байгаа төвшнөөс буулгачихгүй, бусдын төлөө үнэн санаанаасаа ажиллах хүн хэрэгтэй. Бас туршлагатай, олон мянган бизнесийнхнийг төлөөлж чадах хүн байгаасай.

- **Таны суудал ч бас нэлээд өрсөлдөөний талбар болдог шүү дээ.**

- Эрүүл өрсөлдөөн хаа ч хэрэгтэй.

- **Та хувийн бизнестэй юү?**

- Хувийн бизнес хийдэггүй. Намайг энд тэнд бизнес хийгээд явж байхыг хүмүүс хараагүй байх. Яагаад гэвэл байхгүй учраас. Харин хамаатан садан, дүү нар бизнес эрхэлдэг. Би зөвлөгөө өгөх маягаар тусалдаг.

- **Таны дүү С.Ганболд Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг удирдаж байсан. Энэ ажилд очиход ч ард нь С.Дэмбэрэл байгаа учраас дарга боллоо гэх зэргээр байнга холбодог?**

- Ард нь үнэхээр С.Дэмбэрэл байгаа л юм чинь, тэгж хардах нь аргагүй л дээ. Би дүүдээ туслахгүй бол ах гэж явах хэрэг байна уу. Буруу, зөв ч байсан, гэр бүлийнхэн бие биеийнхээ л төлөө явдаг шүү дээ. С.Ганболдын хувьд орчин үеийн сайн бизнесмэн залуу. Маш овсгоотой, ухаалаг, нийгэм рүү хандсан үйл ажиллагаа явуулж чаддаг. Тухайн үедээ уналтад орж, өрөнд баригдсан улсын үйлдвэрийн газрыг хүлээн авч, хэдэн тэрбумын өрнөөс нь салгаж хөл дээр нь босгож өгөөд төрөөс одон авч байсан хүн шүү дээ. Улсын үйлдвэрийн газар удирдаж байгаа хүнд янз бүрийн шахаа заавал ирдэг. Тэр шахааг огт цэвэрхэн тойроод гарчихна гэж байхгүй. Тэгэхээр С.Ганболд ажлаа сайн хийсэн, төр үнэлсэн. Гэтэл Авлигатай тэмцэх газарт дуудаад байдаг юм. Төр өөрөө төрийн өмч гэж бий болгочихоод түүндээ хяналт тавьж, сайн менежмент хийхгүй болохоор тэнд очсон хүн нь муу болж харагддаг. Хувийн компанийнхан яагаад сайн явдаг юм бэ. Ерөөсөө төр бүх өмчөө хувьчлах хэрэгтэй. Төрийн оролцоо байгаа цагт хувийн хэвшил шиг өөрийнхөө төлөө ажилладаггүй байхгүй юу. Үүнийг сайн ойлгосон бусад улс төрийн өмчөө хувьчилдаг. Миний дүүгийн хувьд одоо хувийн бизнесээ хийгээд явж байгаа. Түүнийг янз бүрээр оролддог шиг байгаа юм. Цаана нь ямар шалтгаан байгааг бүү мэд. Ер нь олон залуус бизнес эрхэлж байна. Тэдэнд бизнесээ хийгээд явах боломжийг л төр олгочих. Авлига руу түлхээд байгаа эдийн засгийн орчноо цэвэрлэх хэрэгтэй шүү дээ.

- Танаас асуулгүй өнгөрч болмооргүй санагдлаа. Төсвийг нэг их наядаар танахгүй бол ирэх жил инфляц 20 хувьд хүрнэ гэж Монголбанкнаас анхааруулж байгаа. Энэ талаар таны бодлыг сонсмоор байна?

- Монгол улсын эдийн засаг хэт халалттай байна. Инфляц өндөр гарах нь гэж яриад л.байгаа юм, Үнэн хэрэгтээ компанийн эздэд эдийн засаг халаад байгаа юм мэдэгдэхгүй л байна шүү дээ. Жишээ нь, манай барилгын салбарынхан ярьж байна лээ. Энэ салбарт эдийн засаг халсан юм алга. Бидэнд мөнгө хэрэгтэй байна гэж байна. Тэгэхээр инфляцийг тодорхойлж байгаа хэлбэр, түүнтэй тэмцэж байгаа арга барил учир дутагдалтай байгаа биз дээ.

- Жишээ нь, юугаараа учир дутагдалтай гэж?

- Тухайлбал, Монголбанк бодлогын хүү нэмэх хэлбэрээр инфляцийг хазаарлах гэж оролдож байна. Ер нь ч ингэж л инфляцийг өсөхөөс сэргийлж ирсэн. Гэтэл бодлогын хүүг нэмлээ гээд инфляц хэзээ хоёр оронтой тооноос салж байсан юм бэ. Сүүлийн жилүүдэд байнга л арав гаруй хувьтай явж ирлээ шүү дээ. Эндээс дүгнэхэд ийм арга хэлбэрээр тэмцэх нь хоцрогдсон гэж ойлгож болно.

-Таныхаар бол инфляцтай яаж тэмцэх ёстой вэ?

- Хэрэглэгч тал руугаа бэлэн мөнгө цутгалгүйгээр үйлдвэрлэгч, бүтээгч талд хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй. Ингэж байж эдийн засгийн өсөлт зүй ёсны байж, инфляцийг хазаарлах болно.

*Ярилцсан М.Алтанцэцэг*

## **Би МАН-ыг бус, сонгогчдыг нь бодож хууль санаачилсан**

- Таныг УИХ-ын гишүүн Ц.Цолмонтой хамт УИХ-ын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барьсныг зарим хүн буруутгаж байна. Дөнгөж орж ирээд л лоббид орлоо гэж ярьж байна л даа?

- УИХ-ын гишүүн ямар ч хуулийн төсөл өргөн барьж болно. Үүсээд байгаа гацааг арилгах л зорилготой шүү дээ. Ингэснээр сонгогчдын эрх ашгийг хүндэтгэж байгаа юм. Ийм л учраас анхны хуулийн төслөө өргөн барилаа. Гацаа үүссэн шалтгаан нь одоо мөрдөгдөж буй хуулийн “24 цагийн дотор” гэсэн заалтаас болж байгаа. Тиймээс 24 цагийн арилгахад цаашид УИХ одоо байгаа гишүүдийн хүрээнд бүрэн бүрэлдэхүүнээрээ хуралдах, ингэснээр олон ургальч үзэл бий болж, УИХ-д хуулиар заасан намын бүлэг ажиллах боломж бүрдэнэ. УИХ-ын үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл бүрдэнэ гэж үзсэн. Энэ зорилгоор хуулийн төслийг санаачилсан.

- Ямар нэгэн лобби байгаа юм биш биз дээ. Үүнийг МАН-ынхан өөрсдөө санаачилж болох л байсан шүү дээ?

- Лоббисоод байх зүйл байхгүй ээ. Хэд хоногийн өмнө би энэ асуудлаар хуулийн төсөл өргөн барина гэж Оюун гишүүнд хэлж байсан. Хэнч санаачилж болно шүү дээ. Түрүүлж санаачилсан болохоор л ийм ярианд орж байгаа биз. АН цөөнх байсан ч би энэ хуулийг санаачилсна. Хуулийг санаачлах гэж байгаагаа Ц.Цолмонд хэлтэл хамтрая гэж хэлсэн. Бас

бус гишүүд ч оролцъё л гэж байсан. Харин өргөн барих үед оролцоё гэж байсан гишүүд байхгүй байсан болохоор нь бид хоёр өргөн барьсан юм. Ерөнхийдөө гол зүйл бол үүний ард байгаа сонгогчид чухал. 26 хүнийг сонгосон сонгогчид байна. Тэдний УИХ-д хуульд заасан дуу хоолой санал бодол УИХ-ын гишүүн 26 хүнээр илэрхийлэгдэх учиртай. Мөн энэ гацаанаас хурдан гарах нь хоёр намд бус улс орны хэтэд ашигтай шүү дээ.

**- Гэхдээ УИХ-ын дарга МАН-ынхныг хуулийн төслөө санаачлаад аваад ир гээд байгаа. Гэтэл МАН-ынхан хөдлөхгүй байгаа нь гүрийгээд байгаа бололтой?**

- МАН-ынхан яагаад байгааг би хэлж мэдэхгүй. Хувь гишүүний хувьд би өргөн барьчихвал асуудлыг хурдан шийдэх боломжтой болов л гэж бодсон. Хурлаас завсарлага авдаг байдлыг хуульчлах үүднээс гишүүд хуулийн төсөл санаачилж байгаа юм билээ. Энэ хуультай ч холбоотой.

**- Хоёулаа ярианыхаа сэдвийг жаахан өөрчлөө. Шинэчлэлийн гэх тодотголтой Засгийн газарт анхаарлаа хандуулж байна уу. Яамдын тоог цөөлөх нь эдийн засгийн хувьд үр ашигтай гэж ярьж байна. Таны хувьд үүнийг хэрхэн харж байна вэ?**

- Би үүнийг арай өөрөөр харж байгаа. Тэр тоо талаас нь бус үр дүн нь ямар байх вэ гэдгийг харж байна. 1997 онд Монгол Улс Шинэ Зеландын туршлага гэж одоогийн энэ яам, тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг гэсэн бүтцийг нэвтрүүлж эхэлсэн юм. Яамд нь бодлого боловсруулдаг, тохируулагч агентлаг нь тохируулдаг, хэрэгжүүлдэг байдлыг авсан гэсэн үг. Энэ байдлаар 10-аад жил явлаа. Одоо үр дүнг нь харъя. Монгол Улсад төр данхар байна, хүнд суртал, хээл хахуул, авлига нэмэгдэж байна гэж яриад байна вэ. Энэ бол бидний авсан засаглалын хэлбэр Монголд нутагшсангүй гэдгийг л харуулж байгаа хэрэг. Яам нь боллого боловсруулж байна гэж цаас үйлдвэрлэдэг. Тэгэхээр аливаа засаглалын бүтэц тухайн орны нөхцөлд таарахгүй бол засаглалын чанарыг муутгадаг юм байна.

**- Тэгвэл одоогийн хувилбар тохирох болов уу?**

- Төрийн ажлыг төрийн болон, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, засаглалыг хуваах үйл ажиллагааны анхны оролдлогыг хийж байна гэж би хувьдаа харж байна. Хэдэн сайд, хэдэн яам гэдэгтээ чухал биш. Энэ нь цаашид хэрхэн хэрэгжихээс л засаглалын үр ашиг нь харагдана. Үүнийг реформын эхлэл гэж харж байна.

**- Ингэснээр яамдын орон тоо харин данхайгаад байна уу гэж харагдах боллоо?**

- Мэдээж, тухайн салбарт төрийн албан хаагчдын тоо зохистой байж чадаж байна уу гэдгийг тухайн салбар хариуцсан сайд шийднэ. Гэхдээ бусад улс орны туршлага харахад орон тооны цомхотголд ордог. Хамгийн гол нь тухайн агентлаг нь ямар үр дүнтэй ажилладаг вэ гэдгийг ард түмнээс асуух ёстой. Ер нь, энэ агентлаг сайн ажилладаг байсан шүү гээд нэрлэх агентлаг байхгүй байх.

**- Засгийн газрын бүтэц ярьж байхад таныг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдаар очих байх гэсэн таамаг байсан. Та яагаад сайдаас татгалзав?**

- Намайг сайд болно гэж бичсэн хэвлэлийнхэнд баярлалаа. Би зарчмаар амьдардаг хүн. Эхлээд УИХ-ын гишүүний ажлаа хийж суръя. Дөнгөж суралцаж байна. Тэр байтугай, УИХ-ын танхимд кнопоо яаж дарахаа



мэдэхгүй заалгаж байна шүү дээ. Кноп дарахаа сураагүй байж сайд хийнэ гэдэг чинь болохгүй биз дээ. Хоёрдугаарт, би энэ намд элсээд жил ч болоогүй байна. Жил ч болоогүй байж сайд болно гэдэг чинь бас болохгүй. Гуравдугаарт, би ногоон хөгжил, ногоон эдийн засагтай холбоотой бүх зүйлийг Монголд санаачлагч. Энэ талаар би УИХ-д үг хэлэх эрхтэй. Би сайд болоогүй ч энэ үзэл баримтлалаа Ерөнхий сайдын чиг үүрэгт шигтгүүлж чадсан. Өнөөдөр дэлхий дахины гол чиг хандлага бол тогтвортой хөгжил гэсэн томъёоллоор илэрхийлэгддэг. Тэгвэл анх удаа Монголын засаглалын түүхэнд тогтвортой хөгжил гэдэг үг Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээнд орлоо. Энэ яамдын бүтэц ярихад, манай намаас, миний гаргасан гол санал юм. Байгаль орчны яамыг хуучин байдлаар нь хандаж, ийм байдлаар цаашид дөрвөн жил явуулмааргүй байна. Өнөөдрийн орчин үеийн Монгол Улсын хөгжлийн шаардлагыг харгалзан үзвэл, ногоон хөгжил гэдэг зүйл буюу ногоон хөгжлийг хариуцсан яам байх ёстой гэж үзсэн. Тиймээс Байгаль орчин, ногоон хөгжлийн яам гэдгийг санаачилсан. Цаашид УИХ, Засгийн газрын ногоон хөгжил тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд УИХ-д хийх ажил олон байна.

- **С.Оюуныг сайд болсоны дараа зарим нэг улс төрийн намууд ашиг сонирхлын зөрчилтэй мэтээр ярьж байна. Энэ мэдээж Монголын Ногоон намынхан?**

- Тийм яриа байдаг юм аа. Миний байр суурь энгийн. Ногоон нам бол дэлхий дээр байдаг нам. Ногоон үзэл баримталдаг. Харин тэд ИЗНН Засгийн газрын чухал авсанд баяр хүргэж хамтран ажиллах зүйлээ л ярих ёстой. Тэдний итгэл үнэмшил ногоон хөгжлийг тунхагладаг л юм бол ИЗНН-ын удирдлага яамны толгойд очиж байгаад харин баярлаж, хамтран ажиллах асуудлыг л ярих хэрэгтэй.

*Г.ДАВАА*

*2012 оны 8 сарын 22. [www.assa.mn](http://www.assa.mn)*

## **Монгол улс хэзээ хэвлэлийн бүрэн эрх чөлөөтэй болох вэ?**

*Монгол Улсын Их Хурлын намрын чуулганы 2013 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр (Пүрэв гариг)-ийн хуралдаан 10 цаг 40 минутад Төрийн ордны Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс: Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг дээр*

**С.Дэмбэрэл:** - Хууль санаачлагчдаас 2, 3 асуулт асууя. Нэгдүгээр асуулт нь энэ Монгол Улсыг хил хязгааргүй сэтгүүлчдийн байгууллага болон freedom house гэдэг байгууллагаас хэвлэлийн эрх чөлөө хагас гэж үздэг юм байна лээ. Тэгэхээр энэ хуулийн гол зорилго нь хагас эрх чөлөөтэй Монгол Улсыг бүрэн хэвлэлийн эрх чөлөөтэй Монгол Улс болгох зорилгоор гаргаж байгаа байх гэж би ойлгож байна. Тэгэхээр энийг ямар хүлээлттэй байгаа вэ? Хууль санаачлагч. Өөрөөр хэлбэл энэ хууль гарсны дараа Монгол

Улс тэдэн жилийн дараа ч гэдэг юм уу, энэ олон улсын байгууллагуудын үнэлгээгээр бүрэн эрх чөлөөтэй болно гэсэн ийм нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт, ашигт малтмалын нөөц дээр суурилсан эдийн засаг, тэр дээр улсын өмч сүүлийн үед их орж ирж байгаа ийм улс оронд ашигт малтмалын нөөцийн ил тод байдал болон хэвлэлийн эрх чөлөө 2 хоорондоо шууд хамааралтай, шууд корреляциятай болоод байгаа тийм юм ажиглагдаж байна. Энийг зохицуулсан, сэргийлсэн ямар заалтууд орсон юм бол доо гэсэн хоёрдугаар асуулт.

Гуравдугаар асуулт нь Хэвлэлийн зөвлөл дээр иргэдийн төлөөлөл гээд тэнцүү тооны хэвлэн нийтлэгч, сэтгүүлч, иргэдийн төлөөлөл гээд тэнцүү тооны төлөөлөл орчихсон. Гэтэл иргэдийн төлөөллийг яаж сонгох, оруулах тэр хуулийн заалт нь байхгүй болохоор иргэдийн төлөөлөгч нэрээр Хэвлэл мэдээллийн зөвлөлд хэн нэгэн дарга, хэн нэгэн захиалгын албан тушаалтан орчих байдал үүсч болзошгүй. Тийм учраас иргэдийн төлөөллийг яаж яах вэ гэдэг дүрэм гэж хүлээлгүйгээр энэ хуульдаа тодорхой зохицуулалт хийгээд явж болсонгүй юу гэдэг бас нэг асуулт. Тэрний дараа төрийн байгууллагын хэвлэн нийтлэх үйл ажиллагаа гээд иргэдийн төлөөлөл болдог, иргэд өөрсдөө сонгодог, иргэдийн эрх чөлөөг илэрхийлдэг эдийн засгийн бүх эрх чөлөөг нь илэрхийлдэг нутгийн өөрөө удирдах байгууллагыг өөрийнхөө дэргэд хэвлэл мэдээллийн ямар нэгэн хэрэгсэлтэй байж болохгүй гэсэн тийм зүйл. Энийг яагаад ийшээ оруулчихав? Нутгийн өөрөө удирдах байгууллага бол иргэдийн цэвэр төлөөллийн байгууллага хажуудаа иргэдэд зориулсан хэвлэл мэдээллийн юм хийж болно шүү дээ. Ийм л асуулт байна, баярлалаа.

**З.Энхболд:** - Хууль санаачлагч хариулъя. Ажлын хэсэг Б.Галаарид байна. Ч.Сосормаа эхлээд хариулъя.

**Ч.Сосормаа:** - Энэ хуулийн үндсэн зорилго бол хараат бус хэвлэл мэдээлэл, хариуцлагатай хэвлэл мэдээллийг бий болгохыг зорьж байгаа. Тэгэхээр Монгол Улс хэвлэлийн хагас эрх чөлөөт улсаар шалгараад байгаагийн гол шалтгаан нь бол сэтгүүлчээ барьж хорьдог Эрүүгийн хуулийн 110, 111 дүгээр холбоотой юм, гол нь тэр шүү дээ. Тэгэхээр тэр дээр хууль санаачлагчийн зүгээс ахиад тодруулахад Эрүүгийн хуулийн 110 доромжлохыг хүчингүй болгох, 111 баривчлах, хорихыг хүчингүй болгохоор бол хуулийн төсөл бэлдэж өргөн барьсан. Энэ нь бол одоогийн Эрүүгийн хуульд бол улам боловсронгуй хийгдэж байна. Доромжлох бол одоогийн шинэчлэн найруулж байгаа хуулиас авч байгаа, гүтгэхийг 2 салгаад, хэрвээ санаатай гүтгээд шүүхийг хуурсан бол Эрүүгийн хэрэг болоод, харин буруугаа хүлээсэн бол зөрчлийн байдлаар шийдэгдэх, нэр төрийг гутаах бол зөрчлийн хуулиар зохицуулах гээд бид нарын тусгаж амжаагүй олон зүйлийг нэлээн боловсронгуй болгоод хийгдэж байгаа. Дараагийн асуудал бол бид нар энэ хуулийг Байнгын хороогоор хэлэлцэж байх үед Хууль зүйн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо, Глоб интернэйшнл ТББ, Иргэний танхим хамтраад энэ гүтгэх, доромжлох бол гэмт хэрэг мөн үү гэсэн хэлэлцүүлэг хийсэн. Энэ хэлэлцүүлгээс нэлээн олон саналууд гарсан байгаа. Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллага, эрдэмтэд судлаачдын зүгээс гарсан саналуудыг багцлаад ажлын хэсэг дээр өгчихсөн энэ дээр ажиллаж байгаа юм. Ямар ч байсан энэ асуудал багцаараа, цогцоороо шийдэгдэнэ байх. Энэ Хэвлэлийн эрх чөлөөний хууль дээр бол бид нар ил тод хэвлэл мэдээллийн байгууллагын хараат бус

байдлыг хангах, мөн түүнчлэн хариуцлагатай болгох, ил тод байдал, эзэн хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлэгчээ мэдээлэх хариуцлага олон зүйлийг оруулсан байгаа гэдгийг хэлмээр байна.

Дараагийн асуудал ашигт малтмалын асуудалтай холбоотойгоор хэвлэл мэдээллийн эрх чөлөө хамааралтай байдаг гээд хууль дээр энэ хүрээнд ил тод байдлын олон зохицуулалтыг оруулсан. Энийг бол ажлын хэсэг дээр яриад улам боловсронгуй болгосон байгаа юм. Тухайлбал хэвлэл мэдээллийн байгууллага нь өөрийнхөө эздийг, хөрөнгө оруулагчийг мэдээлж байх, захиалгат мэдээллээ хэн захиалж байгаа юм нэртэй нь мэдээлж байх. Мөн хэвлэл мэдээллийн байгууллагыг ямар нэгэн байдлаар дарамтлахгүй байх, хэвлэж нийтлэггүйн төлөө төлбөр авахгүй, энэ чиглэлээр гэрээ хийхгүй байх гэх мэтийн олон саналууд бас хууль санаачлагчийн зүгээс ч орсон байгаа, ажлын хэсэг дээр улам боловсронгуй болгож оруулсан байгаа гэдгээ хэлмээр байна.

Тэр Хэвлэлийн зөвлөлтэй холбоотой асуудал байгаа юм. Энэ дээр нэлээн хэлэлцүүлэг өрнөсөн юм. Уг нь бол олон улсын жишгээр Хэвлэлийн зөвлөл..

**З.Энхболд:** - Цагтаа багтаж хариулахгүй бол цагтай. С.Дэмбэрэл гишүүн ингэж асуусан шүү дээ, чи нэг л онож хариулахгүй юм. Ашигт малтмал, хэвлэлийн эрх чөлөө 2 урвуу хамааралтай байдаг юм. Энэ бол дэлхий даяар яваад байна шүү дээ. Манайд бас энэ процесс яваад байгаа юм уу гэж асуугаад байна шүү дээ. М.Батчимэг гишүүн хариулъя.

**М.Батчимэг:** - Энэ хуулийн төсөл дээр ерөнхий санаа нь явж байгаа, хэлэлцүүлгийн үед ажлын хэсгээс санал гараад, Байнгын хороо дээр дэмжигдээд, батлагдсан хаалтын гэрээ гэдэг ойлголтыг хориглох ийм заалт орж ирж байгаа. Ямар нэгэн этгээдийн зүгээс хэвлэл мэдээллийн байгууллагад хандаж тодорхой мэдээллийг нийтлүүлэхийн төлөө юм уу, эсвэл нийтлүүлэхгүйн төлөө захиалга өгөх, гэрээ байгуулахыг хориглож байгаа. Энийг зөрчих юм бол тухайн хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх ийм заалт орж ирж байгаа. Тийм учраас таны санаа зовж байгаа байдал нэг талаасаа бага ч гэсэн шийдэгдэх болов уу, нөгөө талаас зөвхөн Хэвлэл мэдээллийн хуулиар зохицуулагдах асуудал гэж ойлгохгүй байна. Тухайн компанийн засаглалыг ил тод болгох, хууль шүүхийн байгууллагын үйл ажиллагаа, засаглалын ерөнхий үйл ажиллагаа сайжрахтай холбоотой цогц асуудал байх гэж харж байна нэгдүгээр асуулт. Тэр Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын хувьд бол нэлээн мэтгэлцээн, маргаан явсан. Хууль санаачлагчийн анхны төсөл дээр ерөөсөө аль ч төрийн байгууллага татвар төлөгчдийн мөнгөөр хэвлэл мэдээллийн байгууллага үүсгэн байгуулахыг хориглосон байгаа. Ажлын хэсгийн ярилцлагын үеэр бол Иргэдийн төлөөлөгчдийн Хурал, Улсын Их Хурал бол ард түмний иргэдийн төлөөллийн байгууллага гэдэг утгаараа байнгын нээлттэй үйл ажиллагаа явуулах ёстой. Тийм учраас хуралдааныг байнга нээлттэй дамжуулж байдаг ийм сувагтай байхыг иргэдийн төлөөллийн байгууллагуудад зөвшөөрөх ёстой гэсэн ийм саналтай гишүүд байсан. Зарим гишүүд бол Байнгын хорооны хэлэлцүүлгийн үеэр яг үнэндээ монголын бодит амьдрал дээр энэ чинь эрх барьж байгаа намын дуу хоолой, хэрэгсэл болоод хувирчихдаг юм улс төрийн шоу болдог нэгдүгээрт. Хоёрдугаарт Иргэдийн төлөөлөгчдийн Хурал бол Улсын Их Хуралтай адилхан байнгын үйл ажиллагаатай байдаггүй, тийм учраас Улсын Их Хурал, Иргэдийн төлөөлөгчдийн байгууллага бол

ард түмэнд нээлттэй үйл ажиллагаа явуулах энэ үүргээ бусад арга замаар хэрэгжүүлэх боломжтой. Тухайлбал телевизийн сувгуудтай гэрээ байгуулах замаар үйл ажиллагаагаа нээлттэй дамжуулах энэ үүргийг нь бол өөр хуулиудаар төрийн өмчийн мэдээллийн хэрэгсэл гэдгээс өөр хуулиудаар зохицуулах шаардлагатай гэж үзсэн. Тэгээд санал хураалтын дүнд Төрийн байгуулалтын байнгын хорооноос төрийн байгууллагад өөрийн өмчийн хэвлэл мэдээлэлтэй байхыг хориглоё гэсэн ийм зүйл дээр санал нэгдсэн байгаа.

**З.Энхболд:** - Хэвлэлийн зөвлөлийн иргэний төлөөлөл нь яаж сонгох уу гээд.

**М.Батчимэг:** - Хэвлэлийн зөвлөлийн иргэний төлөөллийн хувьд бол энийг цэвэр Хэвлэлийн зөвлөлийг үүсгэн байгуулж байгаа тэр хэвлэл мэдээллийн салбарын болон сэтгүүлчдийн төлөөллийн өөрсдийнх нь мэдэлд үлдээсэн байгаа. Энийг үүсгээд байгуулах хурлаараа Хэвлэлийн зөвлөлийг байгуулах дүрэм журмаа тогтооно гээд холбогдох зохицуулалтуудыг энэ Хэвлэлийн зөвлөлийн үүсгэн байгуулах хурлаар хийхээр зохицуулсан. Энэ дээр мэдээж өөр саналтай зарим гишүүд байсан л даа. Хуульд ийм заалт орж ирж байгаа юм. Яагаад гэвэл нэгэнт бид нар хэвлэл мэдээллийн салбарыг тодорхой хэмжээний түрүүний Г.Уянга гишүүний хэлдгээр бусад салбартай харьцуулахад илүү чөлөөтэй байх ёстой төрийн зохицуулалт хэтэрхий орох шаардлагагүй салбар гэж үзэж байгаа юм бол энэ болгоныг төрөөс орж зохион байгуулаад, зохицуулаад төр энийг оруул гээд зааж өгөөд байх юм бол бас дахиад сөрөг үр дагавар гарна. Тийм учраас энэ өөрийн зохицуулалтын байгууллага өөрсдөө энэ дүрэм журмаа хийх ёстой гэсэн ийм зарчмаар дүрэм журмаа өөрсдөө гаргана гэсэн ийм зохицуулалт орсон байгаа.

**З.Энхболд:** - Тодруулах уу?

**С.Дэмбэрэл:** - Тэр Хэвлэлийн зөвлөлийн тэнд дараагийн заалт дээр ийм байна л даа. Хэвлэн нийтлэгч гээд тийм хэвлэн нийтлэгч, сэтгүүлч тодорхойлолтыг нь өгчихсөн, тэгээд олон нийтийн төлөөлөл энэний тэнцүү гэхэд гурав гурван хүн болж байгаа юм. Хэвлэн нийтлэгчийн эрх зүйн статус нь юу юм бэ? Тэр тодорхой хуульд байна уу? Яг хэвлэн нийтлэгч гэж хууль зүйн талаасаа хэн юм бэ? нэгдүгээрт.

Хоёрдугаарт, тэр Их Хуралтай холбоотой Иргэдийн төлөөлөгчдийн Хуралтай холбоотой, жишээлбэл Их Хурлын өөрөө мэдэх Их Хурлын тухай хуулиудаар зохицуулах юмыг Хэвлэлийн эрх чөлөө гэсэн хууль Их Хурал хажуудаа дэргэдээ байж болно гэсэн зөвшөөрөл өгдөг тийм хуулийн заалт байж таарахгүй. Энийг яагаад тийшээ оруулчихав? Энэ ерөөсөө төрийн хэвлэл мэдээлэл гэсэн заалтыг тэр чигээр нь хасч болохгүй юу? гэсэн ийм асуулт байна.

**З.Энхболд:** - М.Батчимэг гишүүн.

**М.Батчимэг:** - Хэвлэн нийтлэгч гэдэг дээр бол энэ хуулийнх нь нэр томъёоны тайлбар дээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэл мэдээллийн байгууллага гэсэн тодорхойлолт орж байгаа юм. Хэвлэн нийтлэгч гэдгийг тэр хүрээнд ойлгож байгаа. Энийг нэр томъёоны хувьд хэрвээ энэ хуульд ойлгомжгүй байна гэвэл найруулгынх нь түвшинд засч болно. Ер нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэл мэдээллийн байгууллага гэж ойлгож байгаа юм нэгдүгээрт. Хоёрдугаарт асуулт энэ дээр бол гол зохицуулалт нь Их Хурал, Засгийн газрын байгууллагууд нөгөө хууль, тодорхой төрийн

бодлого, мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор л лавлагаа, мэдээллийн товхимолыг гаргаж болно гэж байгаа юм. Өнөөдөр Төрийн мэдээлэл гээд товхимол гардаг, өөрөөр хэлбэл яагаад энэ хуульд заагаад байгаа юм гэхээр төр аль болохоор хэвлэл мэдээллийн зах зээл, салбарт оролцох оролцоог хязгаарлаж байгаа учраас зөвхөн энэ зүйлтэй байж болно гэсэн ийм...

### **“Хүний ёс жудаг гэж бас бий”**

*Улсын Их Хурлын Чуулганы хуралдаан 2013 оны 04-р сарын 18-нд дэд дарга С.Баярцогтыг цэрэгт ажлаас чөлөөлөх тухай асуудлаарх асуулт хариулт дууссаны дараа гишүүд үг хэлэх цээр УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлийн хэлсэн үг:*

- “Дэлхийн 30-аад орны 40 гаруй сэтгүүлчдийг оролцуулсан оффшор компаниуд хуулийн хүрээнд татвараас зугтаасныг илчлэх төсөл хэрэгжиж үйл ажиллагаа нь дуусч байгаа юм байна. Үүний үр дүнд 3000 хүн илчлэгдээд байна. Тэдгээрээс ганцхан хүн нь би алдаа гаргажээ гээд албан тушаалаасаа огцорхоор өнөөдөр энд сууж байна. Улс төрийн жудаг гэж мэдэхгүй. Харин хүний жудаг гэж юу байдгийг мэднэ. Би унасан хүнийг зоддог хүн биш. Та бол 3000 хүний дундаас ёс зүйгээ хүлээж байгаа анхны хүн. Та ямар ч хууль зөрчөөгүй гэж байгааг би үнэмшиж байна. Ямар ч гэсэн хүний ёс жудаг гэж юм бий. Тэр тусмаа гэр бүл нь хүнд тохиолдолд байгаа хамгийн хэцүү үед энэ хүн өөрөө ёс зүйгээ ухамсарлаад сууж байхад тал талаас нь өшиглөж болохгүй. Энэ үгний төлөө намайг олон хүн үзэн ядаж магадгүй. 5 удаа монгол төрийг төлөөлж хар залуугаасаа маш их туршлага хуримтлуулсан энэ хүнийг ёс зүйн алдаа гаргасны төлөө дээд зэргийн байцаагч нарт ч байдаггүй таамаглалуудыг гарган ирж, тал талаас нь дайрч байгаад харамсаж байна.

### **С.Дэмбэрэл гишүүн зарим нэршлүүдийг ойлгохгүй байна**

*Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар сарын 07-ны өдөр (Мягмар гариг)-ийн хуралдааны тэмдэглэлээс:*

**А.Бакей:** М.Батчимэг гишүүний санал байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хуулиас асуулт байна уу?

**С.Дэмбэрэл:** Хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэж юу юм бэ?

**М.Батчимэг:** Хэвлэл мэдээллийн байгууллагууд гэж ойлгоно л доо.

**С.Дэмбэрэл:** Энэ олон улсын нэр мөн үү? Эсхүл би үүнийг л ойлгодоггүй, хэрэгсэл гээд байдаг юм. Юун хэрэгсэл юм бол? Яадаг хэрэгсэл юм бол?

**А.Бакей:** Санал хураагдаад дууссан, С.Дэмбэрэл гишүүн. Дараа нь М.Батчимэг гишүүн С.Дэмбэрэл даргад сайн тайлбарлаж өгөөрэй. Үүрэг өглөө. Батчимэг гишүүний санал байна. Өгөгдлийн тухай хууль 2014 онд шинээр гэж байна. Энэ Өгөгдлийн тухай хуулийг шинээр санаачилгья гэж байна. Тайлбар байна уу?

**М.Батчимэг:** Энэ бол уг нь Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль хэлэлцэгдэж байх үеэр багцаараа яригдаж байсан хуулиуд байгаа юм. Энэ дээр орж ирээгүй байна. Өгөгдлийн тухай хууль гэж юуг хэлж байна вэ гэхээр, Контентын хууль гэж хэлээд байдаг. Ерөөсөө Монгол Улсад хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа хэвлэл мэдээллийн байгууллагуудад хуулиар зөвшөөрөгдөх контент гэж, өөрөөр хэлбэл бид нар үндэсний аюулгүй байдлын эсрэг алан хядах, үймээн самуун дэгдээх, хүний эрхийн эсрэг ч гэдэг юм уу? ийм контентуудыг хориглох асуудалтай холбоотой хуулиуд байхгүй байгаа юм. Тэгээд дээрээс нь бусад улс орнуудад байдаг өөрийнхөө үндэсний соёл, түүхээ сурталчилсан тийм контентыг урамшуулах ч гэдэг юм уу? контентын зохицуулалттай хууль байхгүй учраас үүнийг гаргах шаардлагатай гэж үзэж байгаа юм.

**С.Дэмбэрэл:** Өгөгдөл гэж яг юу юм бэ? би ойлгохгүй байна. Өгөгдөл гэдэг бол биет, контент гэвэл агуулга. Аль нь юм бэ?

**М.Батчимэг:** Харин тийм, тэгээд явчихсан. Манай энэ хуулийн төслүүд дээр чинь өгөгдөл гэсэн утгаар орчуулагдаж орчихоод байна.

**С.Дэмбэрэл:** Өгөгдөл гэдэг чинь буруу үг.

**М.Батчимэг:** Нэр томъёо хэтэрхий олон эрээн болгохгүйн үүднээс хэрэглэсэн нэр томъёог нь хэрэглээд байгааж юм. Түүнээс биш бид нар энэ дээр ярих ёстой.

**А.Бакей:** Контентын тухай гэж хэлж болохгүй юу?

**С.Дэмбэрэл:** Монгол бэлэн үг байна шүү дээ. Агуулга гэж.

**М.Батчимэг:** Наадах чинь эргээд ойлгогдохгүй болчихож байгаа юм. Эсхүл Контентын хууль гэдгээрээ явчихаад, хуулиа гаргах үед тэр агуулгаа ярьж болж байна. Ойлгомжтойгоор нь Контентын хууль гээд явчихаж болно.

**А.Бакей:** Контентын тухай хуулийг жагсаалтад оруулъя гэсэн саналыг дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 12-оос 10. Дэмжигдлээ.

## **Наадмын тухай хууль хэрэгтэй юм уу?**

*2013 оны 06 сарын 28-нд Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааны хуралдаан дээр “Үндэсний Их Наадмын тухай” хуулийн төсөл хэлэлцэх цээр:*

**С.Дэмбэрэл:** УИХ-ын нэр бүхий гишүүдийн энэ хууль тогтоох санаачилга дээр эрхийг хүндэтгээд байна. Гэхдээ даргаас бас нэг зөвшөөрөл авах гэсэн юм. Энэ хуулийн төслийг би бүхэлд нь эсэргүүцэж байгаа учраас, эсэргүүцэж байгаа саналаа хэлээд энэ ажлын хэсгээс намайг чөлөөлж өгөөч гэсэн ийм санал байна нэгдүгээрт.

Хоёрдугаарт: Ер нь, нэг бөхийн цолны тэмдэг нэрийг нэмж хасахын тулд далай байна уу, нуур байна уу, гол байна уу, даян байна уу, даяарчлал байна уу, энийг хэлэлцэж байдаг энэ Улсын Их Хурал ямар сонин байгууллага вэ? Энэ чинь хууль санаачлах байтугай, бусдын хууль санаачлах, бусдын өөрөө өөрсдийгөө удирдах эрхийг нь булаан авч, хийж байна шүү дээ. Гэтэл хуулийн төслийн үзэл баримтлал гэхээр өрсөлдөөн гэхийсэн байгаа. Өрсөлдөөн. Нэг чимгийг аваад, нэг чимгийг нэмээд, нэг заалтыг хасахаараа өрсөлдөөн болчдог юм уу? Тэгээд дээр нь, үнэхээр бөхийн асуудлыг шийдэх гээд байгаа юм бол тэр найрааны асуудлыг яаж зохицуулахаар



оруулсан юм бэ? Явал шударгаар өрсөлдөж, найраа хийхгүй байх юм бэ? Энэ асуудал яаж тусгагдсан юм бэ? Тэр чинь алга байна. Тэгсэн мөртлөө 512,1024 гэсэн ийм юм яриад байдаг. Өөрөөр хэлбэл үзэл баримтлал гэдэг үг энд чинь зохихгүй байна, хуулийн төслийн үндэслэл, хамрах хүрээ, үндсэн шаардлага, нийгэм, эдийн засгийн дагавар гэдэг үг чинь энэ хуулийг уншихаар инээд хүргээд байна. Гэхдээ та бүхний хууль хийж байгааг ямар нэгэн байдлаар доош нь чихэж байгаа юм биш. Зүгээр л, бид ийм хууль санаачлах шаардлагатай юу? Энэ чинь Монгол Улсад үнэхээр хэрэгтэй юм уу? Эсвэл тэр төрийн бус байгууллагууд нь, мэргэжлийн олон холбоод нь байгаа. Эд нар нь өөрснөө шийдээд, зохицуулаад явах нь өөрсдийнх нь зохицуулалтын асуудал шүү дээ. Дээр нь энэнийг бүүр энгийнээр хэлье. Х.Баянмөнх гуай юу гэж хэлсэн юм? Ж.Мөнхбат гуай юу гэж хэлсэн юм? А.Сүхбат юу гэж хэлсэн юм? Бусад холбоод юу гэж үзэж байгаа юм бэ? Энэ бүх өөрснөө шийдчих асуудлыг УИХ-ын гишүүд бид 2013 онд, баяр наадмын тухай хууль болгож ярилцаад, Монгол үндэстний соёл иргэншлийн олон зуун жил явж ирсэн түмэн зүйл зан заншлыг хуульчилдаг, хуулиар зохицуулдаг ийм буруу практиктэй болж байна. Бусад улс орнуудад иймэрхүү зүйлүүдэд төр нь ерөөсөө оролцдоггүй. Үүнийг төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоодын өөрснийнх нь шийдэх асуудал гэдгийг би хэлээд, миний санал гэж тооцуулмаар байна. Даргаас зөвшөөрөл аваад, явахыг минь зөвшөөрнө үү.

### **Судалгаа шинжилгээний ажил их дутагддагаас болоод хуулийн чанар үр өгөөж нь тааруу байна**

*2013 оны 06 сарын 28-ны Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээс: “Монгол Улсын 2012 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан хэлэлцэх цээр*

С.Дэмбэрэл: За одоо би Зангад даргаас л асуух байх даа. Энэ тендерийн баримт бичгүүд, зардлуудыг хараад байхад, хэд хэдэн удаа суманд ёслол хүндэтгэлийн ордон барих гэж байгаа юм шиг байх юм. Энэний тоог нь надад хэлж өгөөч. Монгол Улсын хэмжээгээр нийтдээ, төр засгийн газрын хэмжээнд, орон нутгийн түвшинд, сумдын түвшинд, нийт хичнээн ширхэг ёслол хүндэтгэлийн орднууд байна вэ? Тэр ёслол нь ямар ёслол хийдэг юм бол? Ямар хүндэтгэл хийдэг юм бол? Яагаад ордон гэж нэрлэсэн юм бэ? Зүгээр байшин эсвэл Ордон байшин гэвэл өөр өөр. Иймэрхүү зүйл байх юм. Энэ дээр одоо манай аудитын газрын тоолсон юм байна уу? Монгол Улсад сүүлийн жилүүдэд энгийн нүдээр хараад байхад, элдэв ордон барьдаг моод дэлгэрч байх шиг санагдаад байх юм. Тэгээд бүгд л урдаа чулуун нохойнуудтой, Чингисийн ч гэдэг юм уу эсвэл ямар нэг сайхан, түүхэн юм сүр зүүсэн орднууд сүүлийн үед их төлөвлөгдөж байна л даа. Энэнийг одоо тэр аудитын газар нь бүтээн байгуулалт мөн гэж үздэг юм уу, үгүй юу? Төрийн байгууллагуудын өөрсдийгөө тэтгэсэн хөрөнгө оруулалтууд хэр зэрэг нэмэгдэж байна вэ? Та бүхний анализд энэ ажиглагдав уу? гэсэн ийм асуултууд байх юм.

**Зангад:** Хөрөнгө оруулалтын аудитын явцад энэ асуудлыг тусад нь судалгаа хийж гаргасан. Сум хөгжүүлэх хөтөлбөр, баг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд ямар ямар арга хэмжээнүүд явагдсан юм вэ гэсэн асуудлаар тусад нь судалгаа хийсэн. Энэ судалгаа хийсэн аудитууд дээр материалууд нь байгаа. Нэгтгээд, дүнг нь тусдаа мэдээлье.

**С.Дэмбэрэл:** Тодруулчихъя. Одоо надад ийм ийм юм гаргаж өгөх юм байна гэж ойлголоо. Монгол улсын хэмжээгээр ёслол хүндэтгэлийн ордон, төрийн ордон гэсэн нэртэй бүх объектуудын жагсаалтыг, үнийн дүнтэй нь, төлөвлөгдсөн хэмжээ, бүх мэдээлэлүүдтэй нь хамт гаргаж өгнө гэж ойлголоо. Зөв үү?

**Зангад:** Зөв.

**С. Дэмбэрэл:** Баярлалаа. Энэ хуулиудыг оруулж ирэх болсон шалтгаан, энэ хуулийн эрэлт хэрэгцээ нийгэмд ямар байгаа юм бэ гэдгийг тодорхойлохын тулд хараад байхад, дандаа засгийн газар, төрийн байгууллагууд л санал оруулж ирээд байна л даа. Миний асуух асуулт бол нэгэнт хууль тэр чигтээ нийгэмд үйлчилдэг, нийгмийн захиалгаар, нийгмийн эрэлтээр гардаг учраас нийгмийн бусад институцууд болох хувийн хэвшил, иргэд, олон нийтийн байгууллагуудын саналыг яаж тусгадаг юм бэ? Энэ талын юу байна вэ?

2. Нэгэнт энэ хуулиуд цаашдаа хийгдэх учраас тогтоолын төсөлд хууль боловсруулах энэ үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэслэл, чанарыг дээшлүүлэхийн тулд энэ дотор тухайн хууль орж ирэхдээ, тухайн хуулийн үзэл баримтлал энэ бүхэн дээр судалгаа шинжилгээний ажилд хэр зэрэг түшиглэсэнийг харуулсан ийм зүйлийг албажуулж оруулж ирэхгүй бол болохгүй санагдаад байна. Сүүлийн үед миний харсан хуулиуд дээр энэ талын судалгаа шинжилгээний ажил их дутагддаг нь ажиглагдаж байна. Энэнээсээ болоод хуулийн чанар үр өгөөж нь тааруу байдаг. Ийм зүйл нийгэм дээр ажиллагдаж байгаа. Төрийн байгуулалтын байнгын хорооны хувьд, судалгаа, хуулийн чанар дээр бас нэг тодорхой заалт оруулж ирвэл болох уу гэсэн бас нэг асуулт байна?

**А.Бакей:** С.Дэмбэрэл гишүүний асуулт нь асуулт гэхээсээ илүү санал байна. Ер нь энэ жагсаалтыг батлаж бэлтгэхдээ энэ ажлын эрэлтийг зөвхөн засгийн газрын болон төрийн байгууллагуудынхыг биш, хувийн хэвшил, иргэдийн саналыг авах асуудал, мөн хуулийн үзэл баримтлалыг боловсруулахдаа шинжлэх ухааны үндэслэлтэй хандах, судалгаа шинжилгээ хийж байж, сайжруулах энэ асуудал бэлтгэл шатыг нь анхааруулвал яасан юм бэ гэсэн энэ асуудлыг цаашдаа анхааръя. Ялангуяа Улсын Их Хурлын дэгийн тухай хууль болон бусад холбогдох хууль дээр энэ асуудлыг анхаарч болно. Гэхдээ энэ жагсаалтанд орсон зарим хуулиудаас, жишээлбэл, Ашигт малтмалын тухай хуульд бол төсөл санаачлагч нь мэдээллийн хэрэгсэлд байрлуулж урт удаан хугацааны турш гишүүдийн, бас олон нийтийн саналыг авч байгаа байдал байгаа. Улсын их хурлын даргын захирамжаар гурван хуулийн төслөөр ажлын хэсэг байгуулагдсан. Энэ ажлын хэсэг бас давхар судалгаа шинжилгээний ажил хийж байгаа гэдгийг хэлье. Энэ саналыг цаашдаа онцгой анхаарна.

**С.Дэмбэрэл:** Бакей даргаа, би нэг санал хэлчих үү. Яг энэ Д.Эрдэнэбатын хэлж байгаа шиг, зөв санал Үндсэн хуульд орох ёстой. Би тийм учраас асуусан юм л даа. Энэ хуулиудад, энэ орж байгаа хуулиудад тэргүүнчлэлийг нь яаж тогтоосон юм бэ? Энийг л яриад байна даа тиймээ, гол суурь.



Энэнийг бол их зөв гэж ойлгож байгаа. Гэхдээ үүн дээр 2 үг нэмээд хэлчихье. Гэхдээ ардчилсан намын бүлэг энэ тэр гэсэндээ хамаа байхгүй. Их хурал дотор байгаа сайн дурын бүлгүүд тухайлвал авилгалын эсрэг сайн дурын бүлэг МОНПАС байгаа. Эд нарын хэлсэн зүйл бол хамгийн түрүүнд энэ Аудитын тухай хууль, авилгалтай тэмцэх хууль энэ бүхэнд өөрчлөлт оруулах хэрэгтэй гэж үзэж байгаа. Тийм учраас шаардлагатай тогтоосон зүйлүүдийг нь бас ингээд дурдаад Эрдэнэбатын санал дээр нэмээд дурдаад өгчихвөл зүгээр байна. Үүнийг манай гишүүд, бас энд сууж байгаа хүмүүс дэмжинэ байхаа гэж бодож байна.

### **Сонгуулийн хуулиар хоёрхон намын ноёрхлыг тогтоож, хадгалах гэж оролдож болохгүй**

*Монгол Улсын сонгуулийн нэгдсэн /Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиудыг нэгтгэх/ хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийн 07 дугаар сарын 08-ны Хуралдааны тэмдэглэлээс...*

С.Дэмбэрэл: Сонгуулийн хуулийн төсөлд ажлын хэсгээс авах санал гэдэгт саналаа хэлье. Гуравдугаар зүйлд байгаа Сонгуулийн хуулийн төслийн ерөнхий зарчим нь хамгийн сүүлд батлагдсан Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд үндэслэсэн гэдгээ тодруулах хэрэгтэй байна. Яагаад гэвэл эндээс хүн ойлгохгүй, хуулиудын тэгш бус байдлыг үүсгэхээр зүйл орж ирээд байна. Чи өөрөө дөнгөж сая л аргументийг нь хэлж байна. Яагаад Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд үндэслэсэн юм бэ гэхээр, энэ хууль нь бусдаасаа илүү болсон, шинэ элементүүд орсон гэж тайлбарлаж байна шүү дээ. Тийм учраас нэгдсэн хууль гэж нэрлэх гэж байгаа бол зарчимын хувьд нэг хууль дээр үндэслэж гарах ёсгүй. Энэ бол нэгдүгээрт, хуулиудын тэгш бус байдал гэж бодож байна. Зөв ярьж байна уу, Батболд хуульч аа. Хоёрдугаарт, нэрийн хувьд “Сонгуулийн хууль” гээд нэрлэчихлээ. Энэ дотор чинь институт орж байна. Ерөнхийлөгчийн институт, УИХ-ын институт, орон нутгийн институт гээд явчихна. Энэнийг бүхэлд нь хамарч нэрлэхээр, энд тайлбарласнаар бол Иргэний хууль, Эрүүгийн хуультай адилхан түвшинд үзэж байгаа юм байна. Ерөнхий хууль гэхээр Татварын ерөнхий хууль гэдэг шиг зүйлээр би ойлгож байсан. Татварын ерөнхий хууль гээд татварын ерөнхий харилцааг зохицуулдаг, бусад дагалдах хуулиудтай байдаг. Тусдаа нэмэгдсэн өртгийн, компанийн ашиг, орлогын гэх мэтчилэн задардаг шиг явбал ойлгомжтой юм гэж бодсон. Тэгэхээр Сонгуулийн хууль гэж бүхэлд нь нэрлэх үндэслэл бидэнд өгсөн энд байгаа мэдээллээр бол гарч ирж чадаагүй л байна. Сая харж байхад, сонгуулиар маш их реклам явлаа. Сонгуулийн ирц сүүлийн жилүүдэд улам буураад байна. Ирцийг хангахын тулд нэгж өгсөн. Тэр нэгж тараасныг ямар хуулиар, яаж тайлбарласан бэ гэдгийг нь асуухаар сайн дурын юм болчихсон. Маш олон хүн үүнийг сонгогчдыг худалдаж авч байгаа хэрэг гэж үзэж байсан. Ийм зүйлийг техник талаасаа яаж зохицуулсан бэ? Жишээлбэл, сүүлийн жилүүдийн сонгуулийн ирц буурч

байгааг нэмэгдүүлэх, эсвэл тоог нь тогтвортой барих талаас нь юу төлөвлөж байна? Гадаадад хичнээн мянган Монголчууд байгаа ч саяын сонгуулиар иргэдийн санал өгсөн хувь нь маш өчүүхэн бага хувь эзэлж байсан. Энэ байдал дараагийн сонгуульд давтагдах уу, яг энэ байдлаараа явагдвал давтагдах л талтай. Элчин сайдын яамдуудын тайлбарлаж байгаагаар бол гадаадад байгаа бүх Монголчуудыг сонгуульд хамруулж чадахгүй гээд янз бүрийн шалтгаанууд тоочдог. Иргэний ухамсартай, заавал сонгуульд оролцоно гэсэн эрмэлзэлтэй цөөн хэдэн иргэд л Элчин сайдын яаман дээрээ очиж саналаа өгдөг. Энэ хэвээрээ үлдэх үү? Үүнийг хэрхэн өөрчлөх вэ? Ямар эрхзүйн зохицуулалт хийх вэ? Мөн залуусыг татах гэж оролдлого хийлээ. “Залуусаа, сонгуулиа өгөөрэй.” гэж уриалж байсан. Нийгмийн нэг хэсэг нь сонгууль өгөх дургүй байдаг юм шиг байна. Тэр хүмүүсийг цаашид ч гэсэн сонгуулиа өгөөрэй гээд гуйгаад, уриалаад яваад байх юм уу, эсвэл сонгуулийн ирцийг нэмэгдүүлэх тал дээр хууль эрх зүйн хүрээнд ямар хөшүүрэг хийх хэрэгтэй юм бэ? Эсвэл дөрвөн компани ярилцаад, нийгмийн хариуцлагынхаа хүрээнд сонгуульд саналаа өгсөн иргэдэд нэгж өгч байя гэж яригдаж байсан. Энэ зөв үү, цаашдаа үргэлжлэх үү?

Зургадугаар заалт дээр, “мэргэшсэн хуульчид ажиллахаар...”, маргаан гарвал үүнийг хуульч байсан ч гэсэн газар дээр нь шийдэж чадах уу? Өнгөрсөн туршилгаас нь харахад хуульч биш учраас газар дээр нь асуудлыг шийдэж чадахгүй байгаа юм уу гэмээр байна. Хуульчид баймаар л юм. Гэтэл гарсан маргааныг газар дээр нь ингэж шийднэ гэсэн хуулийн заалт байхгүй учраас л тэгж шийдэхгүй байна гэж би ойлгоод байгаа. Тэрнээс биш мэргэшсэн хуульч мөн байна уу, биш байна уу гэдэгт асуудал нь биш юм шиг санагдаад байна. Энийг анхаараарай.

Наймдугаар заалт дээр, “...сертификаттай болгох...” гэж байна. Улс төрийн намуудыг харахаар, өөрийнхөө ажиглагчдаа бэлдээд, энэ чиглэлээр гайгүй байж болох хүмүүсээ явуулаад байх шиг байгаа юм. Наймдугаар заалтын дагуу сонгуулийн хороодын гишүүдийг сургалтанд хамруулах юм уу? Ингэснээрээ сонгуулийн хууль тогтоомжоор мэргэшсэн боловсон хүчин төв орон нутагт бэлтгэгдэх, эсвэл улс төрийн намуудын энэ чиглэлийн чадавхийг нь дээшлүүлэх ийм заалт орж болох уу? Яагаад гэвэл, намууд л нэр дэвшүүлж байгаа, намуудад энэ чиглэлээр мэргэшсэн хүмүүс байвал дараа нь янз бүрийн маргаан гарахад тэр хүмүүс нь тодорхой хэрэгтэй болно.

Есдүгээр заалт дээр, манай улсад сонгуулийн порпорциональ систем анх удаа туршигдаад, манай намаас л гэхэд арай гэж хоёр хүн орж ирсэн. Улс төрийн “жигжиг” намуудын босгыг нь өндөрсгөж, 5-10 хувь гэсэн өндөр босго тавих гээд байна уу? Үүн дээр би санал огт нийлэхгүй байна. Өөрөөр хэлбэл, цаашдаа порпорциональ системийг нэмэгдүүлнэ гэж яриад байгаа биш үү? Эсвэл хоёр “том” нам өөр бодолтой байдаг юм уу? Хоёрхон намын ноёрхолыг энэ улсад хуулиар тогтоож, хадгалах гэж оролдож болохгүй. Парламентаас гадуур байгаа бусад намуудад боломж олгосон ийм заалт байхаар, хамгийн ихдээ л 5 хувь гэсэн босго байхаас биш, 5-10 хувь гэсэн интервал байж ерөөсөө болохгүй. Дээр нь нэгээс доошгүй суудал авсан гэсэн болзол шаардлага бүр байж болохгүй. Гадаадын улс төрийн туршлага бол Монголын хөрсөнд, тэр тусмаа улс төрийн систем нь дангаж бүрэлдэн тогтнож байгаа, олон намын систем бодитойгоор хэлбэршин бүрэлдэх хэрэгцээ шаардлагатай байгаа манай улс төрийн орчинд гадны тогтчихсон

системийг механик байдлаар, шууд хуулбарлаж аваад, нааж хэрэглэх нь буруу байх гэж бодож байна. Хаалтын гэрээ гээд их ярьдаг. Хаалтын гэрээ гэдэг хууль зүйн нэр томъёолол байхгүй. Хэвлэлийн эрх чөлөөний хууль байж байгаад, буцаагаад татаад авчихсан. Энэ хуулиар л хаалтын гэрээний асуудлыг шийдэх ёстой. Энэ талыг нь яаж холбох вэ?

Хамгийн сүүлд нь “үр дүнгийн хувийг нэр дэвшигч, нам эвслийн авсан саналын дүнгээр гаргадаг болох.” гэдгийг би сайн ойлгохгүй байна. Одоо яаж гаргадаг юм бэ? Энийг авснаараа ямар үр дүн гарах вэ? Энэ дээр надад хариулт өгөөч. Түрүүн бас, намуудын санхүүжилт гэж ярилаа. УИХ эхлэнгүүт, УИХ-ын Тамгын газрын судалгаа шинжилгээний хэлтэст би захиа бичээд, энэ чиглэлийн судалгаа гаргуулж авсан. Өөрөөр хэлбэл, бусад улс орнуудад сонгуулийн санхүүжилт ямар байдаг вэ гэсэн судалгаа. Энэ чиглэлийн мэдээллийг та бүхэн ч бас Тамгын газраас, миний сайтаас аваарай. С.Оюун, С.Дэмбэрэл нарын захиалгаар хийгдсэн 20-30 хуудастай судалгааг өгөөч гээд уг хэлтсээс очоод асуугаад, олоод аваарай. Хоёр судалгаа байгаа шүү.

**Хариулт:** - Яаж ирцийг нэмэх вэ гэдэг дээр манай хуулинд нэг заалт байгаа нь юм. Сонгуульд оролцох, эс оролцохоо иргэн өөрөө чөлөөтэй сонгоно, тэрэнд хэн ч нөлөөлөхгүй гэсэн заалттай. Бусад улс оронд сонгуульд оролцох нь үүрэг гэж үздэг. Манайх болохоор оролцохгүй байх нь эрх гээд үзчихсэн. Үүнийг хэрхэн үүрэгжүүлэх вэ гэдгийг бодох хэрэгтэй байгаа. Эрх гэгчихсэн болохоор нэгж өгөх зэрэг хөшүүргийн хэлбэрийг ашиглаж байгаа юм. Зарим оронд бол, сонгуульд оролцоогүй иргэн ямар нэг байдлаар олон нийтийг төлөөлөх эрх нь хязгаарлагддаг. Жишээлбэл, төрийн өмчит компанид хараат бус ТУЗ-ын гишүүнээр томилогдож, хотын зөвлөлийн гишүүн болж чадахгүй, эсвэл оюутны 70 мянга авч чадахгүй гэдэг ч юм уу, тийм зүйлтэй нь л холбож байна. Зарим улс торгуультай. Тайландад 5 доллар, Австрали 20 долларын торгуультай байх жишээтэй. Манайх бол оюутны автобусны билет хөнгөлөлттэй авдагтай нь холбодог ч юм уу, яах вэ гэдгээ ажлын хэсэг яриад зөвхөн ирцийг хэрхэн нэмэх вэ гэдэг дээр гарч байгаа хувилбаруудыг үнэлээд сайн, муу талыг нь гэж гаргаж бэлдээд, дараагын хурал дээр танилцуулж болно.

Гадаадад байгаа иргэдийн саналын тоог нэмэгдүүлэхийн тулд нэг арга байгаа. Иргэдийн саналыг шуудангаар авдаг болох юм бол идэвхи нь нэмэгдэнэ. Зөвхөн элчин сайдын яаман дээр ирж саналаа өг гэхээр бэрхшээл дагуулаад байгаа юм. Өөр нэг ирцийг нэмэгдүүлэх арга нь иргэдийг зөөх явдал юм. Манай намууд нууцаар иргэдийг зөөдөг. Бусад оронд машинаа бүртгүүлээд, хүмүүсээ зөөхийг нь зөвшөөрдөг, гэхдээ дотор нь ажиглагч суулгаж явуулдаг гэдэг ч юм уу, иймэрхүү арга хэмжээ авч болно. Иймэрхүү зохицуулалт оруулж, ирцийг нэмэх тал дээр цогц ярих хэрэгтэй.

**С.Дэмбэрэл:** Олон орон сайн дурын үндсэн дээр хүнийхээ ухамсарт тулгуурладаг, нэг хэсэг оронд шахалт үзүүлэх системийг нэвтрүүлж байна. Тэр цөөхөн орноос ихэнх нь буцаж больж байна. Энэ мэдээллийг интернетээс авч болно. Хүчээр ингэх нь дэмий юм гэж ойлгосон. Монголын хувьд бол сайн дурын, хагас шахалт үзүүлэх, халамж авч байгаа хүмүүсийн халамжтай нь холбох тодорхой элемент байна. Тэр нь юу гэхээр, “нөхцөлт мөнгөн шилжүүлэг”. Жишээлбэл, гэртээ мод тарих, хүүхэддээ улаан бурханы тариа хийлгэх, хүүхдээ сургуульд сургаж байж мөнгөн халамж

нь шилжиж ордог. Үүнийг дэлхийн банкнаас бусад хэд хэдэн улс орнуудад хэрэгжүүлээд, нийгмийн бодлогыг нь шинэчилж байгаа нөхцөлт үйлчилгээ гарч ирээд байна. Энэ бодлогыг сонгуульд холбож болох үгүйг л бодоод, гайхаад сууж байна. Бусад улс оронд бол сонгуульд хүчээр оролцуулахыг эрх зөрчиж байгаа хэлбэр гэж үздэг юм билээ.

**Хариулт:** Дунд сургуулийн хичээлд сонгуулийн ач холбогдлын тухай хичээл заагдахгүй байна. 18 нас хүрсэн хүүхдүүд ямар ч ойлголтгүй байна. Энэ бүхнийг харгалзан үзэж цогцоор нь шийдэх ёстой.

**С.Дэмбэрэл:** Зарчмын гэж яригдаад байгаа энэ суурь асуудлуудын жагсаалтыг гаргаад, эхнийх нь улс төрийн намуудын дарга, ерөнхий нарийн бичгийн дарга нарын хүрээнд саяны ярьсан листээрээ санал бодлоо солилцоод байгаа. Тэрний дараа УИХ-д оруулж ирээд, намын бүлэг нь яриад явцгаая.

### **Авлигажсан төсөв нь лоббижсон төсөв боллоо**

УИХ-ын нэгдсэн чуулганаар 2014 оны төсвийн төслийн хоёрдугаар хэлэлцүүлгийг хийлээ. Хэлэлцүүлгээр 100 гаруй асуудлыг хэлэлцэж батлав. УИХ дахь намын бүлгүүд ажлын хэсэг гаргаж ажилласны дүнд төсвийн ерөнхийлөн захирагч нарын мэдлийн хөрөнгийг 5-10 хувиар бууруулсан дүнтэйгээр хоёрдугаар хэлэлцүүлэгт оруулжээ. Тухайлбал, БХБ-ын сайд 1.1 тэрбум, Зам тээврийн сайд 5.2, Хөдөлмөрийн сайд 3.2 тэрбум төгрөгөөр урсгал зардлаа хасуулсан байна. Түүнчлэн төсвийг “авлигажсан төсөв” гэж цоллуулахад хүргээд буй төсөвт өртөг нь 5-10 дахин нэмэгдсэн 200 гаруй барилга, объектоос 144-ыг нь хасч, 46 барилгыг үргэлжлүүлэн барихаар болсон байна. Ингэснээр 300 гаруй тэрбум төгрөг хэмнэж байгааг Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн онцолсон юм. Гэвч санхүүжилтийг нь үргэлжлүүлэхээр төсөвт тусгасан 46 барилга дээр нэмж 96 барилгыг төсөвт тусгахаар болсон нь гишүүдийн дунд маргаан үүсгэв. Өөрөөр хэлбэл, намын бүлгүүд ажлын хэсэг дээрээ “Эдгээр барилгыг төсвөөс шууд хасч болохгүй. Санхүүжилтийг нь “0” заалттай буюу аудитын шалгалтын дүнг гартал түр царцаая” гэж тохиролцжээ. Үүнийг зарим гишүүд эсэргүүцэж байлаа. Тэд “төсөвт тусгаснаар бол эдгээр барилгыг ирэх онд үргэлжлүүлэн барихгүй ч байж болох юм байна. Ингэж сунжирснаар дутуу баригдсан барилгуудын чанар муудаж, дахин сэргээн барихад одоо шаардагдаж байгаагаасаа ч их хөрөнгө зарцуулна” гэж байв. Үүнд Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн “Энэ 96 барилгын хувьд дутуу хаяж болохгүй гэж үзсэн учраас төсөвт суулгахаар болсон. Гэхдээ аудитын шалгалтын дүн гарах хүртэл буюу ирэх оны гуравдугаар сарын 1 хүртэл санхүүжилтийг нь царцаая гэж байгаа юм. Энэ хугацаанд барилгуудын санхүүжилтийн хөрөнгө нь Сангийн яамны мэдэлд байж байна. Эдгээр барилга аудитын шалгалтаар төсөвт өртөг нь үндэслэлтэй нэмэгдсэн буюу зөрчилгүй байвал санхүүжилийг нь олгоод явах юм. Үүнээс гадна зарим зам, гүүрийн ажлыг дуусгах ёстой гэж үзсэн учраас төсвөөс салгаж, Хөгжлийн банкинд шилжүүлсэн байгаа” гэсэн тайлбар хийсэн юм. Ерөнхийдөө гишүүд 2014 оны төсвийн төслийн хоёрдугаар хэлэлцүүлгийн үеэр сонгогдсон тойрогт

нь баригдаж байгаа барилга, объектуудын хувь заяанд нэлээд анхаарч байлаа. Жишээлбэл, Ховдоос сонгогдсон С.Бямбацогт болон Д.Батцогт нар Ховд аймгийн Булган сумын ерөнхий боловсролын сургуулийн барилга шатсан. Барилгыг нь сэргээн засварлах, эсвэл шинээр барих шаардлагатай байгааг сануулж байв. Түүнчлэн Ж.Батзандан гишүүн нийслэлд барьж байгаа III төрөх эмнэлгийн барилгын ажил 90 хувьтай байгаа ч 2014 онд барьж дуусгахаар болсон 46, санхүүжилтийг нь түр царцаахаар болсон 96 барилгын алинд ч багтаагүй байгааг хэлсэн юм. Учир нь, эмнэлгийн барилгын төсөвт өртөг нь найман тэрбумаас 13 тэрбум болж өсөөд байгаа юм байна. Түүнчлэн нийслэл, ЭМЯ санхүүжилтийн асуудал дээр ойлголцоогүйгээс 2014 оны төсөвт тусгааж чадаагүй юм байна. Тиймээс төсөв батлагдахаас өмнө III төрөх эмнэлгийн асуудлыг шийдэж, төсөвт тусгахаар болсон юм. Ийнхүү төсөвт өртөг нь хэд дахин өссөнөөс болж төсвөөс хасагдах дээрээ тулаад байсан барилгуудаас 96-г нь эргэж харж үзэхээр болов. Энэ хугацаанд барилгын ажил гүйцэтгэгч компаниуд нь төсөвт өртөг нь үндэслэлтэй нэмэгдсэнийг аудитын байгууллагад нотолж чадвал санхүүжилтээ авах боломж бүрдэж байгаа юм байна. Төсвийн хэлэлцүүлгийн талаар УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлийн байр суурийг сонирхлоо.

**- Төсвийн хэлэлцүүлгийн үеэр та нэг ч асуудлыг дэмжсэн санал өгсөнгүй. Яагаад ингэх болов?**

- Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд төсвийн хариуцлагатай байдлыг тусгаж өгсөн. Өнгөн дээрээ бид үүнийгээ мөрдөөд байгаа юм шиг харагдаж байна л даа. Гэвч эцсийн дүндээ эсрэгээрээ болоод байна. Жишээ нь, төсөв хэлэлцэж байгаа одоогийн механизм саань хэн сайн лоббидож чадсанд нь үйлчилж байгааг бид сая харлаа шүү дээ. Тэд үнэхээр сайн лоббидож чадсан учраас тойрогтоо хийж байгаа бүтээн байгуулалтыг авч үлдэж чадаж байна. Тэр хүмүүст баяр хүргэе. Гэхдээ нэг хэсэг нь сэтгэл хангалуун болсон ч, нөгөө хэсэг нь сэтгэл дундуур үлдэж байх шиг байна. Зарчмын хувьд улс төрийн намууд ингэж тохиролцож, лоббид автаж төсвөө батлах нь улс орны амин чухал асуудал болсон эдийн засгийн бодлогоо буруу тал руу нь чиглүүлж байна гэсэн үг. Тийм учраас би бүх асуудал дээр татгалзсан байр сууринаас хандсан

**- Танихаар бол төсвөө яаж хэлэлцэх ёстой байсан бэ?**

- Гурван намын бүлэг хамтраад төсвөө цаг хугацаанд нь баталж байгаа нь сайн боловч эцсийн дүндээ оруулж ирсэн төслийнх нь гэдэс дотрийг задлаад үзэхээр эхийг нь эцээж, тугалыг нь тураахгүй, аль болох тойрогт нь барилга, объектыг нь суулгаж өгөхийг зорилгоо болгосон харагдаж байна лээ. Энд сайн, муу гэж ялгахаасаа илүү тухайн процесст хэн сайн лоббидсон нь хожсон. Хоёрдугаарт намууд хоорондын тохиролцоо ямар байв гэдгийг харж болно. Энэ утгаараа бол энэ хариуцлагагүй төсөв болж байна. Энэ үзэгдэл үүгээр л дуусаасай билээ. Ирэх жилээс дунд болон урт хугацааны хөгжил, сангийн болон төсвийн бодлогын уялдаа ямар байх юм гэдэг механизмаа тохирдог, дараа нь хөрөнгө оруулалтынхаа төсвийг эдийн засгийн ач холбогдлоор нь эрэмбэлж баталдаг. Дараа нь нийгмийн ач холбогдлоор нь гэх мэт бүрэн утгаар нь анализ, дүгнэлт хийсэн төсөв хэлэлцэж батлах ёстой шүү дээ.



- Төсөвт зарим нэг эерэг зүйл ажиглагдсан шүү дээ. Жишээ нь, зардлаа багагүй танасан.

- Орлог, зарлага гээд бүх тал дээрээ л хариуцлагагүй байгаа

- Уг нь ирэх жилийн төсвийг намуудын ажлын хэсэг, Байнгын хороод гээд нэлээн өргөн бүрэлдэхүүнтэйгээр хэлэлцсэн шүү дээ?

- Бусад Байнгын хороогоор хэлэлцдэг ч Төсвийн байнгын хороон дээр очоод вакумд орчихдог шүү дээ. Бусад нь бол зүгээр л формальны хэлэлцэж байгаа. өөрөөр хэлбэл, Төсвийн байнгын хороон дээр нөгөө л тохиролцоо, лобби ордог. Ер нь цаашдаа төсөв хэлэлцдэг процедур болон хуульдаа өөрчлөлт оруулах хэрэгтэй.

- Сөрөг хүчний байр суурийг та хэрхэн үнэлж байна вэ?

- Чуулган дээр МАН-ын бүлэг дүгнэлтээ танилцуулсан. Эхлээд их л шүүмжлэлтэй хандаж байлаа. Гэвч төгсгөлдөө “Бид тохиролцсоныг онцлон тэмдэглэе” гээд явчихсан. Өөрөөр хэлбэл, өөрсдийнхөө хэлсэн, ярьсан, шүүмжилсэн зүйлийг логикоороо, төсөвт оролцож байгаа байдлаараа үгүйсгэчихсэн. Ийм байхад хоёр том намын тохиролцоог эрүүл гэж хэлэхэд хэцүү л юм.

- Эндээс гарах үр дүн ямар байх бол?

- Ерөнхийдөө хариуцлагагүй төсөв батлагдчихаар эдийн засгийн бодит үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нь тодорхой. Энэ тохиолдолд зайлшгүй төсвөө тодотгох процесс руу хөтөлнө л дөө.

*Х.Түвшин*

## **УИХ-ын гишүүн чинь өөрөө ард түмний төлөөлөл, нэг хэсэг нь мөн**

*2013 оны 12 дугаар сарын 10-ны Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг хэлэлцэх цээр:*

С.Дэмбэрэл: - Сонгуулиар бий болсон шинэ УИХ-ын гишүүд Чуулганы анхдугаар хуралдаан болон өөрийн оролцсон анхны хуралдаан дээр тангараг өргөх тухай ярилцаж байна. Үндсэн хуулийн 3-р зүйлийн 1-р хэсэгт “Монгол улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх байрих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэж заасан байдаг. Тэгэхээр 1 нь хоцроод, 75 гишүүн энэ эрхийг эдлээд сууж байна гэж бодъё. Тэгтэл “энд 1 гишүүнийг 75 хүнээс хамааралтай болгочихлоо, тиймээс ингэж болохгүй” гээд ийм өөрчлөлт оруулах гээд байгаа юм уу? Өөрөөр хэлбэл, ямар нэг шалтгаанаар хожимдож эрхээ авч байгаа 1 гишүүн нь бусад 75 гишүүнээсээ субьектив хамаатай болчихож байна. Гэтэл Үндсэн хуулийн энэ заалтанд тоо заагаагүй. УИХ-ын гишүүн чинь өөрөө ард түмний төлөөлөл, нэг хэсэг нь мөн гэж заачихсан байна шүү дээ. Ард түмэн тэнд сууж байгаа юм. Тэгэхээр хожигдож орж ирж байгаа хүн буюу тэр хэсэг ард түмэн чинь төрийн сүлдний өмнө тангараг өргөж байгаа болохоос биш, 75 хүнд тангараг уншиж байгаа юм биш шүү дээ.

Субъектив гэж харагдаж байгаа бол 75 хүн нь ширээнийхээ дор нуугдаж ч болно. Анхны өдөр, анхны хуралдаан эхлэнгүүт, хамгийн эхний үйл ажиллагаа бол тангараг өргөх ёслол байх ёстой. Өөрөөр хэлбэл хуралдаан албажих ёстой. Хуралдаан эхлэхээс өмнө гэхээр янз бүрийн ойлголтууд бий болоод байна. Хуралдаан эхэлмэгц, эхнийх нь үйл ажиллагаа нь гишүүд тангарагаа өргөнө, хоцорсон хүн тангарагаа өргөх асуудал нь дараа дараагийн хурлын хөтөлбөрт ороод л явчихвал албажина. Хоцорч орсон 1 хүн маань тангараг өргөх ёслол хийсний дараа бусад нь хүлээн зөвшөөрөх эсэх тухай асуудал байж болохгүй. Энэ бол ёсчлол, төрийн ёсчлол шүү дээ. Ямар нэгэн шийдвэр гарахгүй, зөвхөн ёслол үйлдэгдэж байгаа хэрэг. Энэ хуулинд би тэгж л орох ёстой гэж ойлгож байгаа юм. Яагаад гэвэл, бодит амьдрал дээр ч гэсэн, бидний хэн нь ч, юу ч асуудаггүй биз дээ. Хэн ч, юу ч асуудаггүй, ямар ч асуудал авч хэлэлцдэггүй юмыг юунд субъектив гэж үзэх ёстой юм бэ? Тийм учраас би үүнийг ёслол үйлдэж байгаа явдал гэж үзэж байгаа юм. Ёслол нь харин өөрийн дэг журамтай байх нь харин зүйтэй.

“Хуулийн төсөл баталсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, эрх зүйн дагаварын талаар...” гэжээ. Эдийн засгийн дагавар байхгүй гэнээ. Тэгэхээр нийгэм, эрх зүйн ямар үр дагавар гарах юм бэ? Эсвэл энд буруу бичив үү? Үүнийгээ тодруулбал зүйтэй байна. Яагаад гэвэл, үүнийг баталсаны дараа эдийн засгийн үр дагавар байхгүй, нийгэм, эрхзүйн үр дагавар байх юм шиг ойлгогдоод байна. Энэ бол техникийн алдаа байх. Миний хувьд энэ бол төрийн ёслол үйлдэж байгаа болохоос ямар нэгэн зүйл хэлэлцэхгүй байгаа гэдгийг анхаараарай. Шинээр сонгогдсон 76 төлөөлөгчдийн тангараг өргөж байгааг өмнө нь ажиллаж байсан 75 гишүүн хараад сууж байгаа ёслол гэдгийг санах хэрэгтэй. Үүнээс өөр ямар нэг асуудал хэлэлцэх процесс үүн дээр байхгүй.

### **Ул сууртай хууль ярьж байгаа үед, оюун ухаант хүмүүсийнхээ хувьд ээлжит жижүүрийн маргаанаа больж, зөвшилцөж, асуудлыг шийдвэл ямар вэ**

*2014 оны 01 сарын 14-нд хуралдсан Төрийн байгуулалтын байнгын хорооны хурлын тэмдэглэлээс: Монгол улсын засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол улсын их хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Монгол улсын ерөнхийлөгч өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийн цээр*

С.Дэмбэрэл: Д.Эрдэнэбат гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Засгийн Газрын гишүүний ажлыг давхар хийж болох тухай асуудлыг сонгуулийн үр дүнтэй холбон тайлбарлаж байна. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурлын сонгуулийн дараа улс төрийн хүчнүүд ямар суудал эзэлж байна гэдгийг үндэслэл болгоод, Засгийн газарт давхар ажиллах боломжийг 50% хүртэл байна гэж оруулж ирсэн. С.Бямбацогт гишүүний хувьд тавьж байгаа зарчмын зөрүүтэй санал нь Улсын Их Хурлын үр дүнгээр байгуулагддаг Гүйцэтгэх Засаглалын бүтэц нь үндсэн болон үндсэн биш салбарын чиг

үүрэгтэй уялдаж байх талаас нь шалгуур болгон тогтоож байхыг үндэслэл болгон оруулж ирсэн байна. Тиймээс энэ хоёр нь Засгийн газрыг байгуулах өөр өөр үндэслэлд тулгуурлаж байна. Тэгэхээр намын бүлгүүд яагаад ажлын хэсэг гаргаж харилцан ярилцаад үүнийг тохирч чадсангүй вэ гэдгийг асуумаар байна.

2. С.Бямбацогт гишүүн 2014.07.01-нээс, Р.Гончигдорж гишүүн болохоор завсартайгаар, 2016.07.01-нээс эхлэн хэрэгжүүлнэ гэсэн санал байна. 2014 оны 7 дүгээр сарын 1 байх ёстой гэдгийг үндэслэсэн шалтгааныг ардын аман яриа буюу “дан дээл, давхар дээл” гэсэн ойлголтоор тайлбарлаж байна. Улсын Их Хуралд аман ярианд тулгуурлаж ярьдаггүй, харин хуулийн үндэслэл ярих ёстой. Тиймээс үүнийгээ дээл, мээл гэсэн үг хэрэглэлгүй, албан ёсны үндэслэлээр тайлбарлаж өгөөч. Р.Гончигдорж гишүүн болон Д.Эрдэнэбат гишүүний хувьд бас яагаад хуулиа 2016.07.01-ээс эхлэн хэрэгжүүлэх ёстой гээд байгаагаа мөн “дан болон давхар дээл” гэдэг үг хэрэглэлгүйгээр хууль зүй, эдийн засаг, улс төрийн талаас нь үндэслэн тайлбарлаж өгнө үү. УИХ-ын гишүүний хувьд саяны зарчмын зөрүүтэй байр сууриудын талаар надад ч гэсэн өөр үндэслэл бас байна. Би өөрөө тайлбарлана. Гэхдээ зарчмын зөрүүтэй томъёололыг санаачилсан хүмүүсийн тайлбарыг эхэлж сонсоод, дараа нь би гараа өргөмөөр байна.

**Д.Эрдэнэбат:** Би С.Дэмбэрэл гишүүнтэй нэг юман дээр санал нэгтэй байна. Гудамжны яриагаар популист шинжтэй юм яриад, төрийн бодлогыг хөнгөхөн шийдэж болохгүй. “Энэ төрийг дан дээлтэй болгочихвол сайжраад явчихна. Байгаа хэдэн сайд нараа солиод өөр хэдэн сайд нар тавьсанаар төрийн ажил цэгцэрчихнэ.” гэсэн гэнэн ойлголт яриад байна. Энэ чинь үндсэндээ, төрийн тогтолцооны суурь ойлголт шүү дээ. Бүр нарийн ярих юм бол, хэрэв энэ хуулинд жижигхэн мэт харагдаж байгаа ганц өгүүлбэр ч гэсэн цаана Монголын төр хаашаа явах гээд байгааг заахуйц тийм ухагдахууны эх үүсвэр шүү дээ. Тийм учраас ийм нарийн зүйлийг олон түмэнд дан болон давхар дээл мэтээр харагдуулж, таалагдаж байгаад төрийн тогтолцоог үймүүлчихье гэсэн бодол байж болохгүй гэж бодож байна. Лавшруулаад ярьвал Үндсэн хуультай холбогдох асуудал болно. Үүнээс цаашаа ухаад ярих юм бол, энэ улс 22 жилийн өмнө баталсан Үндсэн хуулийнхаа суурь зарчмаар явах юм уу, эсвэл өөр зарчмаар явах юм уу гэдгийг шийдээч гэсэн үг шүү дээ. Өнөөдөр Монгол Улс Үндсэн хуулиндаа парламентат ёсыг тунхагласан улс мөн гэж би ойлгож байна. Парламенттай улс нэг толгойтой байх ёстой. Парламент болон гүйцэтгэх засаглалын тэнцвэр нь бусад дагалдах цогц хуулиара хангагдаж явах ёстой байхад, өнөөдөр энэ тэнцвэрийг хангаагүй байж, “дан, давхар дээл” мэтээр гэнэн хандаж, төрийн тогтворгүй байдлын ул суурийг тавьж болохгүй гэж бодож байна. Тийм учраас өнөөдөр Ардчилсан Нам бүлгийн хурлаараа энэ хуультай холбоотой цогц хуулиуд болох Улс төрийн намуудын болон Сонгуулийн тухай хуулийн асуудлаар ажлын хэсгийн мэдээлэлийг сонссон нь зөв гэж бодож байгаа. Бид үүнийг нухацтай авч үзэх ёстой. Бид сонгуулийнхаа хуулинд пропорциональ тогтолцоог оруулсан. Пропорциональ тогтолцоонд орсноороо холимог системтэй улс төрийн парламентаас засгийн газар руу, Засгийн газраас УИХ-ын гишүүн рүү шилжиж болох, түүнийг нөхөн орлуулж болох сонгуулийн эрх зүйн орчныг юуны өмнө бүрдүүлж байж энэ тэнцвэртэй орчныг өгөх ёстой.



2. УИХ-ын гаднаас үл мэдэгдэх хэн нэг хүн төрийн бодлогыг хэрэгжүүлэхээр Гүйцэтгэх Засаглалд орж ирэх юм уу, эсвэл намын дэвшүүлсэн суурь бодлогын дагуу сонгуулийн зарчмаар сонгуульд оролцсон, энэ төрийн бодлогыг ойлгосон хүн буюу өөрөөр хэлбэл, олонхи болсон намын бодлогод захирагдаж, сонгуульд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийг нь хэрэгжүүлэх чадвартай боловсон хүчин, нөгөө талаар ард түмэнд танигдсан боловсон хүчин л УИХ-ын гаднах Засгийн газрын бүрэлдхүүнд орох юм шүү гэдэг тогтолцоог маш тодорхой болгож байж л энэ асуудлыг шийдвэрлэх ёстой гэж үзэж байгаа. Түүнээс биш, заавал УИХ-ын гишүүн хүн л Засгийн газрын гишүүн байх ёстой гэж дайрч байгаа юм ерөөсөө байхгүй. Энэ цогц асуудалд хамаарах бусад хуулиудыг эмхэлж бүрдүүлэхийн тулд 2016 он гээд байгаа юм. 2016 он хүртэл бусад холбогдох хуулиудад өөрчлөлт хийгээд, Үндсэн Хуулиар баталгаажсан парламентад ёсны тэнцвэрийг хангах энэ орчинд орох ёстой гэсэн байр суурийг илэрхийлж байгаа.

**С.Бямбацогт:** “Овоо босгоогүй болвол, шаазгай хаана суух вэ” гэдэг ардын үгээр бас ярьчихая даа. Яагаад энэ асуудлыг ярьж байгаа юм бэ гэхээр, “Ерөөсөө болохгүй байна. Улсын их хурлын гишүүн засгийн газрын гишүүний албыг давхар хаашдаг нь буруу юм байна” гэдгийг олон жил бид ярьж байгаа. “Болохгүй байгаа учраас, үүнд цэг тавих ёстой” гээд Монгол Улсын Ерөнхийлөгч, төрийн тэргүүн нь хууль санаачлаад оруулж ирсэн. Үүнийг нь Улсын Их Хурлын гишүүд бүгд дэмжиж байгаа. Ганцхан яагаад заавал 2016.07.01-нээс мөрдөх гээд байна вэ? Буруу юм бол буруугаа хурдан засъя. Алдаагаа хурдан засаад, эртнээс энэ асуудлаа шийдье” гэдэг байдлаар л асуудалд хандаж байгаа юм. Яагаад болохгүй байгааг хууль зүйн талаас нь тайлбарлах гэж оролдоё. Өнөөдөр Үндсэн хуульд заасны дагуу УИХ бол Монгол улсын төрийн эрх барих дээд байгууллага. Гэтэл хууль тогтоох байгууллагын маань дээр гүйцэтгэх засаглал нь гараад суучихсан. Хуулийг хэрэгжүүлэн биелүүлдэг, хэрэгжүүлэх ёстой Засгийн газар маань өнөөдөр, Улсын Их Хурлыг хөтөлдөг болчихсон байгаа. Засгийн газрын 17 гишүүн УИХ-ын гишүүний албыг давхар хашдаг. Хууль санаачилж, боловсруулж, оруулж ирчихээд, Улсын Их Хурлын чуулганд өөрсдөө орж ирээд, санал хураалтанд оролцож, өөрсдөө баталчихаад, эргээд явчихаж байна. Засгийн газар нь хуулийг хэрэгжүүлж, хуулийн хэрэгжилтийг УИХ-даа тайлагнах үүрэгтэй мөртлөө, тайлагнадаггүй, өөрөө өөртөө дүн тавиад явж байна. Өөрөө өөртөө хариуцлага тооцох асуудал огт байхгүй, өөрсийнхөө алдаа дутагдлаа нуугаад, хаацайлаад явчихдаг. Ийм л болчихоод байна. УИХ-ын гишүүн, сайд, дээрээс нь 3 байнгын хорооны гишүүн гээд, нэг хүнд ахадсан олон ачааг энэ гишүүд чинь үүрч байна. Ажлаа хийж дийлэхгүй байна шүү дээ. Өнөөдөр Монгол Улсын нийгэм эдийн засгийн байдал нилээн хүнд байна. Ард иргэдийн амьдрал доройтож байна. Хэтэрхий олон давхар ачаа үүрсэн байгааг л “давхар дээлийг дан болгоё” гэж хэлж байгаа юм. Тэгвэл “давхар дээл дээрээ хантааз өмсчихсөн байна” шүү дээ. Хэтэрхий олон албан тушаал, ачаа буюу “дээлэндээ” сайд нар чинь төөрч, түүртэж байна шүү дээ. хийж чадах ажлаа хийгээд, үүрч чадах ачаануудаа л үүрээд явъя. Нэг хэсэг нь хууль тогтоох ажлаа хийе, нөгөө нэг хэсэг нь гүйцэтгэх ажлаа хариуцаад л явъя л гэж байгаа юм. Үндсэн хуульд заасан зарчмаа л хэрэгжүүлбэ гэж яриад байгаа юм.

Үүнийг буруу гэж хэн ч ярихгүй байгаа. Ганцхан хугацааны хувьд, “2016 он хүртэл ухаалаг биш, бодлогогүй төртэй явья. 2016 он хүртэл данхайсан том төртэйгээ байя. Өнөөдөр өөрчлөх хэрэггүй.” гээд хойш тавиад байгаа нь ямар учиртай юм бэ? Албан тушаалтайгаа зууралдаад байгаа асуудал мөн үү, биш үү? Тийм учраас Монгол Ардын Намын бүлэг Улсын Их Хурал дээр ч ярьсан. Заавал 2016 оны 07 сарын 01-нээс гээд яах вэ, 2014 оны 07 сарын 01-ээс мөрдөөд явья. Бололцоо, боломж, хугацаа байна. Холимог системээр сонгууль явагдсан учраас жагсаалтаар УИХ-д орсон гишүүд маань гишүүнээсээ татгалзаад, сайдын ажлаа хийж болно, эсвэл УИХ-д ороогүй, жагсаалтад байгаа нэр дэвшсэн хүмүүсээсээ сайдын албан тушаалд сонгоод явах бололцоо байна. Ийм олон талын гарц байж байгаа. Ерөнхий чиг үүргийн яамууд гэж байгаа. Заавал 17 биш, хэдэн ч яамтай байсан 50% нь, хэрэв УИХ-д олонхи бүрдээгүй бол Засгийн газрын 2/3 буюу 66% УИХ-аас бүрдсэн сайд байх ёстой гэж ярьж байна л даа. Давхар дээлээ тайлъя гэж зөв ярьж байсан мөртлөө, буцаагаад зарим нь давхар дээлтэй зарим нь дан дээлтэй байх ёстой буюу Улсын Их Хурлын гишүүн, засгийн газрын гишүүний ажлыг давхар хийе гээд байх юм. Энд бас бодлого байх ёстой. Бодлогын буюу ерөнхий чиг үүргийн яамны сайд давхар гишүүнийхээ ажлыг хийж болно гэж үзэж байгаа. Энэ үүднээсээ энэ саналыг гаргасан юм.

**Р.Гончигдорж:** Эхлээд би өөрийнхөө саналыг тайлбарлая. Сонгуулийн тухай хуульд зарим давагдашгүй хүчин зүйлүүд бий болсон үед сонгууль хойшлогдож болдог нөхцөлүүд бий. Тийм учраас тэр үеийн цагийг мэдэхгүй байна. “7 сарын 1” гэж Монгол улсын ерөнхийлөгч оруулахдаа сонгууль болоод, сонгуулийн дараа УИХ бүрэн эрхээ эхэлж, засгийн газрыг бүрдүүлэх тухай асуудал ярьж эхлэх үед энэ хууль хүчин төгөлдөр байж байх ёстой гэсэн байдлаар тийм хугацааг тооцоолсон болов уу. Саяны байж болзошгүй гэдэг хүчин зүйлүүдийг үндэслээд хугацааг нь “2016 оны ээлжит сонгуулийн дараа, шинэ УИХ-ын бүрэн эрх хэрэгжиж эхэлмэгц, энэ хуулийг дагаж мөрдөнө” хэмээн цаад агуулгаар нь хуулинд оруулах нь зүйтэй гэсэн ийм саналтай байна.

2. Хууль тогтоогчид олон түмний дунд байдаг янз янзын хэллэгийг хэрэглэж болно л доо. Гэхдээ тэр хэллэгийг энгийн иргэд энгийн утгаар нь ойлгоод, энэ нь санаатайгаар асуудлыг хууль эрх зүйн шинж чанараас нь холдоод, тэрэн дээр нь тоглоом хийх, популист тоглолт хийх боломжийг бүрдүүлдэг нь харамсалтай. Би бас “Дан дээлтэй гарсан юм сан. Даараа болов уу, яагаа бол...” гэсэн ардын дууны үгнээс хэлж болно шүү дээ. Сүүлийн өгүүлбэр нь илүү тохиромжтой байгаа. Өөрөөр хэлбэл, “бид Засгийн газрыг зөвхөн гадна талаас бүхэлд нь байгуулсан. Хөөрхий энэ засаг маань, тогтох юм болов уу, үгүй юм болов уу” гэж зовж байгаа үг байхгүй юу. Агуулгаараа энэ илүү тохиромжтой. Хууль эрх зүйн зарчим бий. Мөн Үндсэн хуулиар тогтоогдсон зарчим бий. Энэнийг бид нар Ардын Намынханы хэлж байгаагаар явбал одоо хүчин төгөлдөр ажиллаж байгаа засгийн газар огцорно. Засгийн газрыг хууль гаргаж, огцруулдаг тийм Үндсэн хуулийн эрх зүйн орчин байхгүй. Тийм учраас Монгол улсын ерөнхийлөгч үүнийг мэдэж байгаа. Мэдэхийн сайнаар мэдэж байгаа. Тийм учраас хугацаа бол, дараагийн шинэ засгийн газар бүрдүүлэхэд энэнийг баримтална гэсэн ийм үзэл баримтлалтай юм шүү. Тийм учраас үүнийг өөр утгаар ашиглаж, тоглож наргих хэрэггүй. Өөр агуулгаар мушгиж, тодорхой зорилгыг биелүүлэхийн тулд ашиглах гэж оролдох гэж хэрэггүй...

**С.Дэмбэрэл:** Асуултандаа хариу аваад, хэлэх саналаа ч цэгнэж байна. Одоо бас нэг асуулт асууя. Бид хууль батлана гэдэг ажил хийгээд байна. Хараад байхад янз янзын байнгын хороон дээр, үе үе иймэрхүү маргаан гараад, үр дүнд нь дандаа ажил явалгүй, гацдаг. “Манай намын хувьд ингэж байсан, танай намын хувьд ингэдэг” гэсэн ээлжит, жижүүрийн яриагаа иймэрхүү нилээд ул сууртай хууль ярьж байгаа үед, оюун ухаант хүмүүсийнхээ хувьд болиод, ийм чиглэлээр зөвшилцвөл яасан юм бэ? Хууль хэлэлцэж байгаа үед, “манай нам ингэж байсан, танай нам ингэж байсан...” гэх мэтчилэн шууд нам руу хандсан, эсвэл өнгөрсөн түүхийг хүүрнэн өгүүлсэн зүйлүүдээ больчихоод, зүгээр л хуулиа хэлэлцээд, намуудын бүлгүүдийн хоорондын тохиролцоо асуудлыг намууд бүлгүүд дээрээ яриад орж ирдэг байж болох уу гэж 2 Намын бүлгийн даргаас асуумаар байна. “Тийм, үгүй” гэсэн үгээр хариулт авъя.

**Д.Эрдэнэбат:** Энэ асуудлаа С.Бямбацогт даргад тодорхой ярьсан. “Энэ бол төрийн тогтолцооны амин чухал асуудал. Хэдүүлээ нэг долгион дээр очье” гэсэн саналыг тавьсан. Бүлэг нь өөр шийдвэр гаргасан байгаа юм.

**С.Бямбацогт:** Зарим хүмүүс маань бие биенийгээ давж л байвал болох юм шиг хандаад байна. Асуудалд бид маргалдаад, мэтгэлзээд, бодлогоо оролцуулаад, асуудлаа шийдэх ёстой. Харамсалтай нь, “олонхи л юм чинь бид давж байх ёстой, бид эрх барьж байгаа юм чинь хариугаа авах ёстой. Эд нар эрх барьж байхдаа яадаг байлаа” гэж дандаа өнгөрсөнөө сөхөж, хуучин руугаа бухаж ярьж байгаад харамсаж байгаа. Дахиж ийм байдалтай ярихгүй байхыг хичээ. Эрх баригчид л өөрсдөө санаачилгатай, хариуцлагатай байх юм бол мэдээж, бид юм болгон дээр буруу ишилсэн сүх шиг байгаад байхав дээ.

## Үр дүн багатай чуулган болж байна

*“Монголын эдийн засгийн чуулган 2014”-ын хоёр дахь өдрийн үдээс өмнөх хуралдаан завсарлав. Хуралдааны завсарлагаанаар УИХ-ын гишүүн, МҮХАҮТ-ын дарга С.Дэмбэрэлтэй уулзаж чуулганы талаарх сэтгэгдлийг нь сонирхлоо. Эрхэм гишүүн маань “Монголын эдийн засгийн чуулган 2014”-ын талаар жаахан сэтгэл дундуур яваагаа нугаагүй юм.*

- Та МҮХАҮТ-ын даргын хувиар энэ удаагийн чуулганы үйл ажиллагаанд ямархуу сэтгэгдэлтэй байна вэ?

- Яг үнэндээ тун тааруухан сэтгэгдэлтэй байна. Хүмүүс энэ чуулган маш олон асуудлыг шийдвэрлэх гарцын талаар ярилцана гэж харж, хүлээж байсан чинь яг ярих ёстой юм аа ярихгүй тойрч давхиад байна. Уг нь бол валютын ханшны хөөрөгдөл, түүнийг цаашид яг хэрхэн шийдвэрлэх юм, 2000 хүргэх юм уу, үгүй бол энэ үнийн хөөрөгдлийг ямар арга замаар шийдвэрлэвэл зохилтой гэдгийг хамгийн түрүүнд ярилцах ёстой байлаа. Түүнчлэн Монголын үндэсний тоотой хэдхэн компаниудын санхүү эдийн засаг, өрсөлдөх чадвар өдрөөс өдөрт буурч, ноцтой байдалд орж байгаа талаар таг дуугүй сууцгаагаад байна. Тэднийг татвар, гаалийн бодлогоор сөхрүүлж байгаа одоогийн гажигтай тогтолцооны талаар яг энэ чуулган

дээр л дорвитой хэлэлцэх учиртай юм. Гэтэл бүлх залгицгаасан юм шиг л дуугүй суух юм уу, шал хэрэггүй хоосон уриа лоозон, тунхаглалын шинжтэй юмнууд ярилцсан болоод байна.

Яг үнэндээ Монгол Улсад татварын реформ буюу эрс шинэчлэл хэрэгтэй байхад “Ялгаатай татвар ногдуулах” энэ тэр гэсэн юм л ярилцсан болоод сууцгааж байна. Би өчигдөр арга тасраад “Энэ улсад чинь татварын реформ, эрс шинэчлэл хэрэгтэй болохоос биш ялгавартай байх уу, үгүй гэдэг юм яриад сууж байх цаг биш” гэдгийг хэлсэн. Тэсч үлдсэн үндэсний хэдхэн компаниа яаж шоронжуулахгүй, тавиад туучихгүй авч үлдэх вэ, яагаад төр хувийн хэвшлийн хооронд ийм их ан цав, үл итгэлцэл үүсчихэв, энэ аюулыг хамгийн хохирол багатай даван туулах ямар арга зам байж болох вэ, яагаад эдийн засгийн албан ёсны сектор руугаа дайрч давшлаад, албан бус нь өргөжин тэлээд байна гэх зэрэг үндсэн гол асуудлуудлаа л нухацтай ярилцмаар байна.

**- Валютын ханшийг одоо байгаа хэмжээнд нь тогтвортой барих ганцхан арга л үлдсэн талаар ихэнх эдийн засагчид санал нэгдэж байх шиг байна. Харин та энэ талаар ямар бодолтой явна?**

- Валютын ханшийн энэ их савалгааны талаар ерөөсөө ярихгүй байгаа. Магадгүй ихэнх хүмүүсийн урам хугарснаас “За даа, яриад ч нэмэргүй юм шив дээ” гэсэн хандлага давамгайлж байгаа байх. Валютын ханшийн тухайд Монголбанк ажлаа олигтой хийж чадахгүй байгаатай л холбоотой. Алсын хараа, нэгдмэл ойлголттой мөнгөний нийлүүлэлт хийхгүй зүгээр л нэг гал унтраасан байдалтай явж ирсний гай л ингэж гарч байгаа юм. Өнөөдөр хоёр оронтой тоонд эргэлдэж байгаа инфляцийн өсөлтийн хүчин зүйлийнх нь шинжилгээг тун давгүй хийчихсэн залуучууд байж л байна. Инфляцийг яаж нэг оронтой тоонд хазаарлан барих вэ, ер нь мөнгөний бодлого болж байгаа юм уу үгүй юу гэдгийг яг жинхэнэ халуухан мэтгэлцэж, ярилцдаг газар чинь л энд байх ёстой юм л даа. Гэтэл харамсалтай нь дэндүү хуурай, өнгөцхөн чуулган болж байгаад миний хувьд бухимдалтай явна.

**- Уг нь Монгол Улсад Хүн амын орлогын албан татвар, Нэмэгдсэн өртгийн албан татвар, Компанийн албан татвар гээд орлого бүрдүүлдэг татварууд хангалттай олон бий. Гэтэл яагаад улсын татварын орлого жил бүр тасалдаад байдаг юм бол?**

- Хангалттай олон татвар, хураамж байгаа нь маргашгүй үнэн. Гэтэл энэ олон татвар нь эдийн засгаа дэмжих биш түүнийг боомилоч үндсэн хүчин зүйл болчихоод байгаа юм. Зүй нь олон татварынхаа хэмжээг багасгаад бүгдээрээ ямар нэг хөнгөлөлт, чөлөөлөлтгүй төлдөг болох хууль эрх зүйн орчныг яаралтай бүрдүүлэх хэрэгтэй байгаа юм. Тэгэхгүйгээр өнөөдрийн байдлаар яваад байвал татвараа төлдөг хэдхэн компани нь бүгд дампуурч хаалгаа бариад, улсаараа аажимхан дампуурал руу дөхөх аюултай байдлын өмнө ирээд байна. Би сүүлийн сар гаруйн хугацаанд олон компанийн удирдлагуудтай уулзаж, ажил хэргийн яриа өрнүүлсээр явна. Дөнгөж саяхан л гэхэд томоохон хоёр ч компанийн төлөөллүүдтэй уулзлаа. Тэд бүгдээрээ үнэхээр их урам хугарсан, бас ууртай байгаагаа хэлж байна. Байдал ийм байхад хэдхэн тоонд хууртаж “Эдийн засгийн өсөлт өндөр байна, хөрөнгө оруулагчид буцаад орж ирэх нөхцөл бүрдлээ” энэ тэр гэсэн хоосон ярианд хууртацгааж болохгүй. Эдийн засгийн түр

зуурын өсөлтийн цаана хөөсөн өсөлт байна уу, хэдхэн компаниудаа эдийн засаг, санхүүгийн хувьд сөхрүүлсэн өсөлт явж байна уу гэдгийг маш сайн анзаарах хэрэгтэй.

Сүүлийн үед компаниудыг хооронд нь улстөржүүлж, тендерийн сонгон шалгаруулалтанд өнөөх л улстөрийн нам хүчнүүдийн нөлөө, урт гар маш ихээр орж ирж байгаа тухай сэтгэл эмзэглүүлсэн зүйлс ярьцгааж байна. Уг нь энд яг тэдгээр асуудлуудыг л ярих ёстой. Харамсалтай нь тэгэхгүй байна. Тэгэхээр энэ чуулганаас миний л хувьд олигтой үр дүн хүлээхгүй байгаа. Товчхондоо ийм шив дээ.

*Д.Монгол  
2014 оны 03-р сар*

### **Татвар төлөгчид сэтгэл хангалуун байх ёстой**

*УИХ-ын 2014 оны 05-р сарын 07-ны Нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс: Тогтоолын төслийн хавсралтад “татвар төлөгчид, төрийн бус байгууллагаас төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, шалгалт хийх, төсвийн зарцуулалтыг хамт олонд мэдээлэх, хэвлэлд тайлангаа мэдээлж байх” гэсэн заалт нэмэх эсэх тухай хэлэлцэх цээр.*

**С.Дэмбэрэл:** Татвар төлөгч нь өөрсдийнхөө төлсөн татвараа хэрхэн зарцуулагдаж байна гэдгийг хөндлөнгөөс хараат бус байдлаар бие дааж хянах тийм тогтолцоог бий болгье гэсэн санаа. Өөр элдвийн санаа агуулаагүй. Өөрөөр хэлбэл татвар төлөгчдөд өөрсдийн төлсөн мөнгийг шалгах “заяагдмал” эрх байх ёстой л доо. Түүнийг нь бид нар хийж өгдөггүй болохоос биш. Хаа нэг газар вэбсайт дээр эсвэл гадаа самбар дээр тавих бол өөр хэрэг. Засаглалын үйл ажиллагаа маань өөрөө бүх этгээдүүдийг оролцуулсан, тэр тусмаа хөндлөнгийн, хараат бус хяналтын тогтолцоог бий болговол энэ улс маань эрүүл болно. Уг нь энэ бол зөвхөн татвар дээр яригддаг асуудал биш юм даа. Бүх хуулин дээр яригдаж байх ёстой. Сүүлийн үед бид нэг дэвшил хийж байгаа. Тэр нь аливаа нэгэн хууль орж ирэхэд ямар нэгэн удирдах зөвлөл байгуулахдаа зөвхөн төрийн захиргаадаас бүрдсэн биш, төрийн бус иргэний нийгмийн төлөөллийг ажлын хэсэгтээ оролцуулаад, түүн дээрээ төр болон хувийн хэвшлийн засаглалын шинэ механизмыг оруулах гээд оролдож байна. Түүнтэй нэгэн адил цаашдаа энэ улсад татвар төлөгчдийн төлсөн мөнгө нь бүгдэд ил тод байж, ядахдаа татвар төлөгчид төлсөн мөнгөнийхөө төлөө сэтгэл хангалуун байдаг, үүнийгээ хаана, хэн, юунд зарцуулсныг мэддэг байх болно. Бид нар бүтээн байгуулалт гэж ярьдаг боловч үнэн хэрэгтээ нийтийн хөрөнгө оруулалтыг хэр зэрэг үр ашигтай зарцуулж байна, бидний төлсөн мөнгө хэр зэрэг үр ашигтай зарцуулагдаж байна гэдгийг мэддэг тийм эрх зүйн боломжийг бий болгох талаар ажиллаасай гэсэн л заалт шүү дээ. Шинэчлэлийн засгийн газар маань өөрөө шинэчлэлийг хийе, ил тод байдлыг бий болгье гээд, түүнчлэн дөнгөж сая хаалтын гэрээ муу зүйл гээд хэлчихсэн үед бол энэ заалтыг дэмжээд гаргасан нь зөв байх гэж бодож байна.



### **Чуулганаа 3 өдөр хийж, яаралтай олон асуудлаа шийдээд, ач холбогдол муутай хуулиудыг хойшлуулъя**

*УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2014 оны 06-р сарын 18-ны хуралдааны тэмдэглэлээс: “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн зарим заалтыг хэцүүн хэцүү болсонд тооцох тухай, Дипломат албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн хуулийн төслүүдийг хэлэлцэх цээр:*

**С.Дэмбэрэл:** - Яах вэ, одоо явж байгаа нь бүр болохоо больчихоод, цаг хугацааны хувьд яаралтай өөрчлөлт оруулахаар тийм хууль гэж би бодохгүй байна. Одоо ингээд наадам болно. Нөгөө ёслол чинь явдгаараа л явна. Аль нэг улсын ерөнхийлөгч ч юм уу, Ерөнхий сайд ирнэ. Ёслол хийдгээрээ л хийнэ. Юу нь буруу болчихоод байгаа юм бэ, одоо? нэгдүгээрт энэ.

За би тэр гүйцэтгэх засаглалын асуудал, энэ тэрийг ойлголоо. Ёслол л юм байна. Бид сүүлийн үед зан заншлыг хуульчлах гэх оролдох боллоо. Зүгээр л, хуульгүйгээр болчих зүйлсийг, бараг зохицуулалтаар, өөрийнхөө зохицуулалтаар болчих юмнуудыг хүртэл хуульчлах гэж оролдоод байх юм. Нэгэн мундаг хүн, муу төрийн тухай хэлэхдээ, “Хууль их байх тусам авлигажсан төр байдаг” гэж бүр хэдэн зууны өмнө бидэнд сануулсан байна билээ.

Хоёрдугаарт, цаг хугацаагаа бод. Жишээлбэл, би даргын зөвлөл дээр “Лхагва, Пүрэв, Баасан гарагуудад Чуулган хуралддаг болъё. Тэгэхгүй бол Засгийн газраас оруулж ирж байгаа энэ асуудлуудыг чинь бид хэлэлцэж амжихгүй нь. Хугацаанд нь баталж чадахгүй байна. Маш чухал чухал эдийн засгийн ач холбогдолтой хуулиудыг батлах гээд байдаг. Бид өөрсдийнхөө приоритет буюу тэргүүчлэлийг нь Их Хурал дээрээ хүртэл тэрийгээ гаргах ёстой. Гэтэл Засгийн газраас оруулж ирж байгаа хуулиуд маань ихэнхи нь одоо энэ 100 хоногт ч гэдэг юм уу, тодорхой хугацаатай орж ирж байна. Ерөнхийдөө эдийн засгийг идэвхжүүлэх тийм хуулиуд их орж ирж байна. Эд нар чинь цаг их авдгийг та бүхэн мэднэ. Нэг Байнгын хороон дээр одоогийн энүүн шиг ач холбогдол муутай, дараа нь буюу намрын чуулганаар хэлэлцэж болох ийм хуулийг оруулж ирээд, үүнийг нь бид хэлэлцэх эсэх дээр маргаж суудаг нь хэр зохимжтой юм бол? Бидний өнөөдрийн Монгол Улсын эдийн засгийн байдал нэгдүгээрт. Хоёрдугаарт, тэр байтугай манай энэ Байнгын хороо, энэ өөрөө приоритет нь мөн үү? Би бол биш гэж бодож байна. Тийм учраас үүний хэлэлцэх эсэхийг нь хойшлуулаад, энэ 100 хоног дуусаад, энэ оны эцсээр, намрын чуулганы нэг хэсэгт нь оруулаад, яаралгүйхэн шиг баталчихвал яасан юм бэ гэсэн ийм санал байна даа.

## **Их Хурлын гишүүд үнэхээр ажиллая гэвэл Зуны чуулган гэж хийх ёстой**

*УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2014 оны 06-р сарын 24-ны хуралдааны тэмдэглэлээс: Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2014.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн/ хэлэлцэх цээр.*

Төсөл санаачлагчийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин танилцуулав.

**Р.Гончигдорж:** - Гишүүд саналаа хэлье. С.Дэмбэрэл гишүүн.

**С.Дэмбэрэл:** - Монгол Улс маань их сайхан улс юмаа. “Их сайхан амардаг улс”. Би одоо энэ орж ирсэн юмыг “Ашгүй хэд хоног амрах нь” гэж их “дэмжиж байгаа”. Тэгэхээр яагаад амардаг юм бэ гэхээр, нэгдүгээрт, зун тэртээ тэргүй хэн нь ч ажил хийдэггүй л байхгүй юу. Хэн ч ажил хийдэггүй. Зөвхөн хувийн хэвшлийнхэн л ажил хийдэг. Төрийн байгууллагуудыг амрахаар хувийн хэвшлийнхэн шүүрс алдаж, санаа алдаж, баярладаг байхгүй юу. “Ашгүй дээ. Эд нар илүү олон хоног амраасай” гэж баярладаг.

Хоёрдугаарт, Их Хурлын гишүүд бид нар өөрсдөө хамгийн их амардаг хүмүүс байхгүй юу. Зунжингаа амардаг. Уучлаарай. Бүгд амардаггүй. Тойргоор явна гэдэг чинь нэг ёсны амралт. Би ер нь саналаа хэлчихье. Тийм ээ. Тийм учраас хамгийн их амардаг хүмүүс, амардаггүй хүмүүсийн тухай энэ хэдэн өдрийн, хоёр өдрийн тухай ярилцаад байгаа нь өөрөө их шог байна л даа. Их Хурлын гишүүд үнэхээр ажиллая гэвэл Зуны чуулган гэж хийх ёстой байхгүй юу тэгвэл. Хаврын чуулган, намрын чуулган, зуны чуулган гээд. Тэгж байж энэ улс бүгдээрээ амрахгүй талаар ярих моральный /ёс суртахууны/ эрхтэй байна уу гэхээс биш өөрсдөө хамгийн их амардаг мөртлөө хүмүүсийг амруулахгүй гээд байж болохгүй шүү дээ. Тэр байтугай хүүхдийн баярыг нь хасчихъя ч гэх шиг. Энэ улс орны энэ ард иргэд чинь өөрсдөө амралт ажлаа зохицуулаад ирчихсэн. Хуультай, хуульгүй тэрийгээ тэмдэглээд явдаг юм уг нь бол. Тийм учраас энэ 2 хоног нэмэхийг би дэмжиж байна. Тэртээ тэргүй энэ чинь өөрөө амраад л явчихдаг юм.

За тэгээд та нар бод. Одоо жишээлбэл 3 хоног амарлаа гэхэд хэзээ тойрог руугаа явж байсан юм. Бүгд аймаг руугаа явдаг биз дээ. Тойрогтоо очих нэрийдлээр аймаг руугаа явж байгаа шүү дээ. Хүлээж бай. Би өөрийнхөө саналыг хэлье. Та нар дараа нь хэлээрэй. Хүлээж бай. Тийм учраас Улсын Их Хурлын, хамгийн их амардаг хүмүүс нь, амардаггүй хүмүүсийн асуудлыг шийдэх ёс суртахууны эрх байна уу гэдэг суурь асуулт гарч ирнэ. Амрах гэдэг байна шүү дээ тархиа хэр зэрэг ажиллуулж байна гэдгээр бас хэмждэг юм шүү дээ. Километрээс гадна. Хүний оюун ухаан хэр зэрэг зарцуулагдаж байна гэдгээр. Тэр нь тэгээд хэр зэрэг үр дүн өгч байна гэдгээр бас хэмждэг юм. Тийм учраас үүнийг бүтээмж гэдэг юмаар хэмжчихдэг юм. Тийм учраас 5 хоногийг дэмжиж байна. Өөрсдөө аягүй их амардаг хүмүүс ийм юман дээр жаахан болгоомжтой хандаж ярьсан нь дээр байхаа гэж бодож байна.

**Р.Гончигдорж:** - Амралт гэдгийн тухай л маргаан боллоо. Тэрнээс өөр юм болсонгүй. Тийм ээ. Өөрийн мэдлээр бүх ажлаа зохион байгуулж болох боломжоор бүрэн хангагдсан өдрийг амралтын өдөр гэнэ гэж тодорхойлъя. Тийм ээ. Бие биенийгээ ойлгож бай л даа. Серьёзные хэлж байгаа. Яаж хэлж байгаа.

**Р.Бурмаа:** - С.Дэмбэрэл гишүүн ээ. Наад үгээ татаарай. Бид нар бол листээр сонгогдсон ч гэсэн энэ дээр, юун дээр ажилладаг шүү дээ. Орон нутагт томиллолтоор ч явдаг. Хууль дүрэмтэй.

**С.Дэмбэрэл:** - Би томиллолтоор явдгийг үгүйсгээгүй байна шүү дээ. Монголчуудын ихэнх нь, угаасаа зун бүгдээрээ амардаг. Ажлаа хийнгээ амардаг байлгүй дээ. Нэг их эмзэглээд байх юм байхгүй шүү дээ.

**Р.Гончигдорж:** - Ер нь бол С.Дэмбэрэл гишүүн ээ. Бараг гишүүдээсээ уучлал гуйчих нь зөв байхаа гэж бодож байна.

**С.Дэмбэрэл:** - Би энэ дээр огт уучлал гуйх шаардлагагүй гэж бодож байна.

**Р.Гончигдорж:** - За ойлголоо. За ингээд үг хэлэх гишүүд дууслаа. Санал хураалтдаа оръя.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье гэсэн саналыг дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. Дэмжиж байгаа гишүүд 16-аас 9. Хэлэлцэх нь зүйтэй гэж дэмжигдлээ.

## **Одоо Их хурал, Засгийн газар, Төв банк онцгой дэглэмээр ажиллах хэрэгтэй**

*“Өдрийн сонин” сурвалжлагч УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлтэй ярилцжээ.*

- УИХ-ын гишүүд ам.долларын ханшаар улстөржөөд байх юм. Уг нь төгрөгийг чангаруулах арга замын тухай яримаар санагдаад байна. 2009 онд 1700 төгрөгт хүрсэн ам.доллар сарын дотор 1300 болсон түүх бий. Үүнд та өөрийнхөө байр суурийг илэрхийлэхгүй юу?

- Одоо манайхан эдийн засаг бодит хөрсөн дээрээ буулаа гэдэг зүйлийг ярьж байна. Валютын ханшийн удирдлага гэж нэг ойлголт байдаг. Энэ үед “ханш уян хатан чөлөөтэй тогтоно” гэдэг онолын үгийг хэлээд байж таарахгүй. Монгол Улсын валютын ханшийн дэглэм бол зохицуулалттай хөвөх ханшийн дэглэм юм. Ихэнх орнууд валютын ханшийнхаа зах зээлийг удирддаг. Интервенц хийнэ гэдэг нь байгаа валютаа тийш нь хийгээд байна гэсэн үг биш. Ийм нөхцөлд валютын ханшийн талаар хэд хэдэн талаас нь болгоомжтой ярих ёстой. Ханшийн зах зээл дамын хүчин зүйлүүдэд их эмзэг байдаг. Тиймээс хамрын доор хагархай бий гэсэн шиг хамаагүй яриад байж болдоггүй. Энэ нь өөрөө хүлээлтэд нөлөөлдөг зүйл. Өнөөдөр Төв банк дотооддоо сайн ажиллах хэрэгтэй. Төв банкны зүгээс “тохируулга хийгдэж байна. Засгийн газар болохгүй байна. Хөрөнгө оруулалт орж ирэхгүй байна” гэсэн зүйлийг хэлж байгаа. Засгийн газар хөрөнгө оруулалт, экспортыг нэмэгдүүлэх талаар ажиллах ёстой л гээд байх юм. Хамгийн гол нь “аяж” гэдгийг нь хэн ч хэлэхгүй байна. Төв банк ч гэсэн үүн дээр ажиллах шаардлагатай. 1994 онд батлагдсан Валютын



зохицуулалтын тухай хуулинд валютын ханшийн бодлогыг тодорхой илэрхийлж чадаагүй. Интервенц хийх арга, зорилго, түүний давтамж, яаж хийх арга хэлбэрийг хуулиар зохицуулдаггүй юм аа гэхэд маш тодорхой бодлого байх ёстой. Ханшийн эрсдэлээс хамгаалдаг механизмуудыг хийсэн байх хэрэгтэй. 2014 оны мөнгөний бодлогод анх удаа үүнийг суулгаж өгсөн. Харамсалтай нь энэ талаар юм хийсэнгүй. Мөн Төв банкны тухай хуулинд Санхүүгийн зохицуулах тогтвортой байдлын зөвлөлийн тухай бий. Бусад орнуудад ч байдаг. Энэ мэтчилэн зөвлөлүүдийн чиг үүргүүдийг маш нарийн тодорхойлох шаардлага бий.

**- Ханшийг яах ёстой вэ?**

- Ийм үед ханш ингэж болноо гээд ярих нь учир дутагдалтай. Өнөөдрийн ханшийн зах зээлийг харахад нэг нийлүүлэгчтэй нэлээд хэдэн хүлээн авагч буюу арилжааны банкуудтай байна. Мөнгөний бодлогоор дамжуулан инфляцийг онилох бодлого хэрэгжиж байгаа. Инфляцийг онилох бодлого ханшийн бодлого хоёр хоорондоо маш холбоотой. Энэ талаасаа манайд дутагдал их харагдах юм. Бид бодлогын хүүг нэмчихээр валютын ханш руу нөлөөлж ханшийн зах зээл дээрх тоглогчдын хүлээлт өөрчлөгдөнө гэж гэнэн бодож явч болохгүй. Ханшийн зах зээл дээр дамын хүчин зүйлсийн нөлөөлөх зүйл их байгаа нь өдөр тутмын ханшийн өөрчлөлт, валютын дуудлага худалдааны нийлүүлэлт, эрэлт хоёрын зөрүүг харах хэрэгтэй. Арилжааны банкуудын 2014 оны эхний хагас жилийн балансыг үзэх ёстой. Түүнчлэн валютын гүйлгээний хяналтын асуудлыг сайжруулах шаардлага бий. Ханшийн зах зээл дээр интервенц хийх зорилгоо тодорхойлохоос гадна ханшийн зах зээлийн түвшинг бууруулах асуудлыг ярьж чадахгүй. Ханшийн хөдөлгөөний хурдацыг багасгах, бууруулах тал дээр ажиллах боломжтой. Ханшийн сулралын үед инфляци өндөр болсон ч ханшийн чангаралтын үед инфляци буурахгүй байна гэсэн олон улсын туршлага байна. Манайх ханшийг шингээх чадвар байхгүй болчихсон. Энэ нь ганцхан Монголд болоод байгаа юм уу гэхээр, бас үгүй. Ханш туслах бодлогын хувьд зах зээл дээрх нөлөөлөл нь ханшаар дамжиж инфляци нэмэгдэж байгаа үед ханшийн цочролыг шингээгч биш цочролыг үйлдвэрлэгч генератор болоод хувирчихдаг.

**- Үүнээс гарах ямар арга зам байна?**

- Инфляцийг яаж тогтвортой байлгах вэ гэсэн арга нь хувийн хэвшлийг золиослох замаар хийгдэх гээд байна. 2009 онд ч гэсэн ингэж л байсан. Тэгсэн ч тэр нь тогтвортой байж чадаагүй. Заавал инфляцийг нэг оронтой тоонд багтаана гэхээсээ илүү инфляци нийгэм, эдийн засгийг доргиохгүй, аядуу түвшинд буюу хоёр оронтой тоонд байж болно. Хувийн хэвшлийн эргэлт сайн байх шаардлагатай. Тиймээс бодлогын хүүг нэмээд ч хэрэггүй. Ханш дээр анхаарах зүйлийг дахин хэлэхэд дамын хүчин зүйл, дотоод хяналтыг сайжруулах ёстой.

**- Ам.доллараа хазааргүй алдсан энэ явдалд хэн буруутай бол? Төв банк уу, Засгийн газар уу?**

- Буруутныг хүнээс бүү хай. Ханшийн бодлого, түүний эрх зүйн үндсийг 1994 оноос хойш бараг хөндөөгүй, санаачлаагүй УИХ хамгийн түрүүнд буруутай. 2014 оны мөнгөний бодлогод урьд өмнө нь зөвхөн “уян хатан, чөлөөтэй тогтоно” гэж олон жил явсан заалт дээр ханшийн эрсдлээс хамгаалах, түүнийг удирдах талаар УИХ-аас баталж өгсөн бодлогыг хэрэгжүүлэх тал дээр санаачилгагүй ажилласан Төв банк, Монгол Улсад

хуулиараа санхүүгийн тогтвортой байдлыг хангах учиртай Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, түүнийг олигтой ажиллуулаагүй, хянаагүй, шаардаагүй УИХ, Засгийн газар буруутай. Бүгд буруутай байна, одоо бие биенээсээ буруутныг хайх бус, бурууг засаад зөв болгоод явах нь өлзийтэй, өгөөжтэй. Валютын ханшийн өнөөгийн үйлчилж буй зохицуулалттай хөвөх ханшийн дэглэм, энэ дэглэмийн үед хэрэгжвэл зохих арга хэмжээнүүд, интервенцийн бодлого, зорилго, хамрах хүрээ, арга хэрэгслүүд, үр дүнг нь тооцох хэмжүүрүүд гэх мэтийн эрх зүйн, институцийн болон засаглалын механизм тодорхой биш байна. Мөнгөний бодлого, ханшийн бодлого болон макро эдийн засгийн ерөнхий болон сангийн бодлогын уялдаа огт хангалтгүй байна. Ийм нөхцөлд “Тамирын голын мөсийг долоох шахам байж” цуглуулсан валютын нөөцөө гөвөхөөсөө өмнө эсвэл интервенцээ зогсоо эсвэл бодлогод нь өөрчлөлт оруулж жинхэнэ ёсоор удирдах хэрэгтэй байна. Ханшийн зах зээл дээр “стратегийн тоглогч” байж болох Оюутолгой, Тавантолгой, Эрдэнэт гэх мэт компаниудыг ханшийн зах зээлийн нийлүүлэлтийн суваг болгох сэдэл, хөшүүргийг бий болго. Ялангуяа валютын ханшийн зах зээл дээр сүүлийн саруудад үүссэн спекулятив буюу дамын хүчин зүйлүүд, авир төрхийг маш сайн судал, Төв банк системийн доторх хяналтаа эрс сайжруул, Засгийн газар валютын илүүдэл эрэлт үүсгэхгүй байх, нөөцийн удирдлагад, ханшийн хэлбэлзлийг арилгахад Төв банкттай идэвхтэй хамтран ажиллах ёстой гэдгийг зөвлөө. Нэгэнт л хуулиар Төв банк ханшийг уях, мөлхүүлэх, хонгил тогтоох нэмэх, хасах таван хувийн “хонгил” бий, энэ хонгилыг магадгүй нэмэх, хасах 10-15 хувь ч болгох хэрэгтэй байж магадгүй юм. Төгрөг, долларын зээл, хадгаламжийн зохистой харьцаанд Төв банк тодорхой бодлого, арга хэмжээ авч болно Уг нь ямар ч хууль зөрчихгүй. Өөрчлөлт хийхэд хууль саад болж байна гэж хуулиар гул барихаасаа илүүтэйгээр тодорхой, шийдэмгий, стандарт бус ч байж болох бодлого, арга хэмжээг УИХ, Төв банк, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, Засгийн газар ойрын саруудад онцгойлон анхаарч хэрэгжүүлэх ёстой.

**- М.Зоригт гишүүн та хоёр ээлжит бус чуулган зарлан хуралдуулах тухай уриалга гаргасан байсан. Гишүүдийн гуравны нэг нь хуралдуулах санал гаргавал уг нь хуралдах боломж бүрдэх байх аа?**

- Эдийн засаг гэхээр л экспорт, хөрөнгө оруулалт, өр гээд л яриад эхэлдэг. Монголын экспортын 20 хувь нь уул уурхайн бус бүтээгдэхүүн байна. Орос руу лаазалсан бүтээгдэхүүн гаргалаа гэхэд манай хүчин чадал муу. Гаргалаа гэхэд 20 гаруй хувийн татвар төлөх болдог. Монголынхоо зах зээлийг идэвхжүүлж гэж байгаа бол хоёр хөршийн төрийн тэргүүн Си Жиньпин, В.Путин нараас 20 хувийн экспортдоо 0 хувийн татвар ноогдуулдаг болох боломжийг олж авах ёстой. Тэгвэл Монголын экспортын өнгө нь өөрчлөгдөнө. Хоёр зах зээлийг мөлжих, бүтээгдэхүүнээ гаргах маш том боломж нээгдэнэ. Экспортын бодлого гэж баталчихаад, Хөгжлийн банкин дээр оччихоод байхад төр нь ч тэр, банкныхан ч мэдэхгүй суугаад байж болохгүй. Мэддэг чаддаг ТББ-уудад санхүүжилтийг нь шийдэж өгөөд явчихбал дээр хэлсэн эдийн засгийн дипломатын аргаар шийдэж болно. Хөрөнгө оруулалтыг татъя гэж байгаа бол хууль эрхзүйн орчныг нь таатай болго. Тэдний эргэлзээг арилга. Миний оруулсан хөрөнгө баталгаажих чадах уу, намайг ямар нэгэн байдлаар шоронд хийчих болов уу, авлигын нэрээр хүнийг ангуучилдаг байдал энэ улсад байна уу гэдгийг хөрөнгө

оруулагчид хамгийн түрүүн хардаг. Түүнээс их нүүрс, зэстэй байх нь тийм ч чухал биш. Улс төр нь тогтвортой, хүний эрх, эрх чөлөө, бизнесийн эрх, эрх чөлөө хангагдаж байна уу, бизнесийн реформ хийгдэж байна уу, амьдрах орчин ямар байна гэдгийг анхаардаг тул үүнийг нь бид шийдээд өгчих хэрэгтэй.

**- Эдийн засгийн өршөөлийн хуулийн талаар ярихгүй юу?**

- Эдийн засгийн өршөөлийн хууль нь хэдхэн улс төрчдийг л шоронгоос гаргах гэж байгаа мэт пиар явчихсан. Эдийн засаг хүндрэлтэй ийм байгаа үед татварын реформыг хийгээд цаг алдалгүй ээлжит бус чуулганыг хуралдуулах шаардлага байгаа биз. Хууль эрхзүй, татварын реформ гээд хэлэлцэх асуудал их байна. Гагцхүү одоо улс төрийн чин зориг, хүсэл эрмэлзэл хэрэгтэй. Эдийн засаг, татварын холбогдолтой асуудлуудыг найм, есдүгээр сард хэлэлцээд цогцоор нь шийдчих л дээ. Тэгж гэмээнэ ирэх оны хагас жилд энэ хүдрэлээс гарчих бүрэн боломж харагдаад байна. Нүүрс, нефтийн үнэ ямар байх вэ гэдэг нь биднээс хамаардаггүй зүйл. Хүмүүсийн ярьж байгаа шиг Засгийн газрыг, тэр сайдыг огцруулмаар байна гэж байгаа нь хэрэггүй. Үнэхээр Монголын цаашдын хөгжил, ард түмний амьдралд жаахан ч гэсэн дэм болъё гэж байгаа бол энэ чиглэлд анхаарах хэрэгтэй. Инфляцийг нэг оронтой тоонд барина гэдгийг ганц Монголбанк хийж чадахгүй. Төсвийн тухай хуулиараа Засгийн газар инфляцийн талаар маш сайн ажиллах шаардлагатай юм. Үнэ тогтворжуулах хөтөлбөр явахгүй байна. Уг хөтөлбөрөө нэг бол зогсоох, шаардлагатай гэж үзвэл шинээр хийх ёстой. Үнэ тогтворжуулах хөтөлбөрөөс жишээ нь махыг хасах хэрэгтэй. Зах зээлийнх нь шугамаар явуул л даа. Малчдын дунд орлогын тэгш бус байдал хүчтэй өрнөж байна. Зах зээлд мах нийлүүлж буй хүмүүсийг харахад 57 хувийг 500-аас доош толгой малтай малчид нийлүүлж байгааг статистикийн судалгаанаас харж болно. Зах зээлд нийлүүлж буй бүх махны 43 хувийг малчдын 15 хувь болох 500-аас дээш мянгат малчид нийлүүлж байна. Малчдаа нийгэм, татварын харилцаанд оруулах хэрэгтэй. Татвараас гадуур явж болохгүй. Энэ бүхэн малчдад ихээхэн хэрэгтэй зүйл.

**- Эдийн засгийн хөгжлийн бодлогын талаар ямар байр суурьтай байгаа бол?**

- Эдийн засгийн хөгжлийн бодлогын хувьд цаг хугацааны мэдрэмж, хямралын гол цэгүүдийг олж харан шуурхай, иж бүрэн арга хэмжээ авах чадвар илт дутагдаж байна. Өнөөдөр бидэнд тулгараад буй гол асуудал бол хямралыг хэрхэн даван туулах тухай асуудал. Дэлхийн банкны гүйцэтгэх захирал саявтархан Монголд айлчлахдаа хямралыг боломж болгох талаар тодорхой санаа, зөвлөмж өгсөн. Гэтэл бодит байдал дээр Монгол Улс баахан мастер төлөвлөгөө, урт хугацааны стратеги боловсруулаад тулгамдсан гол гол асуудлаа донор орон, олон улсын байгууллагуудад найдаад л орхиж байна гэхэд хилсдэхгүй. Бодит сектор бартерийн харилцаанд аль хэдийн орж одоо бараг цэнэг нь дуусаж байна. Барилгын сектор дахь өр зээлийн хямрал банкуудаа татаж унагах хэмжээнд очих аюулд ойртож байгаа, Төв банк нь гуравдугаар сард албан ёсоор тодорхойлсноор "...тэртээ тэргүй унаж буй хувийн хэвшлийг" зөнд нь орхиод, инфляцийг онилох, валютын ханшийг тогтворжуулах мөнгөний хатуу бодлого явуулсаны хүчинд л арайхийж эдийн засгийг зогсолтгүй уналтаас аварч чадлаа гэж шал худлаа сүржигнэж илтгэсэн. Ингэж байх хооронд нь банк ба бизнесийн амьд орчил нь энэ бодлогын л гайгаар аль хэдийн тасраад одоо амь тариа нэхэх

хэмжээнд очсон байна. Амь тариаг амьтай байхад нь хийдэг болохоос амь тасарчихсан хойно нь хийдэггүй.

- **“ЭЗЭН 100” хөтөлбөр дуусчихлаа. Үр дүн юу байв?**

- “ЭЗЭН 100” хөтөлбөр зөв байсан. Гэтэл ардын намынхан өөдөөс “АРД 100” гээд л улс төржүүлээд эхэлсэн. “ЭЗЭН 100” хөтөлбөрийн хүрээнд шаардлагатай арга хэмжээнүүдийг авсан уу гэвэл авсан. “Одоо 100 хоног болчихлоо яасан бэ” гэж улс төржүүлэх нь хамгийн буруу үзэгдэл. Суурь тавигдсан уу, тодорхой хэмжээгээр ажилласан уу гэвэл тийм. Энэ Засгийн газар гар хумхилгүй ажиллаж байна л даа. Энэ тохиолдолд үргэлжлүүлээд л явах ёстой. “ЭЗЭН 100”-гаа дүгнэнэ, Н.Алтанхуягт хариуцлага тооцно, дүн тавина гээд түүнийгээ улс төр болгох гэж байгаа бол Монголын эдийн засаг, хөгжлийг хорлож байгаа алхам. Гэхдээ толгойг нь илээд яв гэсэн үг биш. Буруу зүйлс их байна. Тиймээс ч, түүнийг нь тодорхой гаргаад яг яах ёстой юм бэ гэдгийг нь хэлээд өгчих хэрэгтэй. Одоо Их хурал, Засгийн газар, Төв банк онцгой дэглэмээр ажиллах сарууд эхэлчихлээ. Тулгамдсан асуудлуудаа хувийн хэвшилтэйгээ, эрдэмтэдтэйгээ зөвлөлдөөд, гарцаа ол гэсэн мессэж хүчтэй ирж байна. Мессэж илгээгч нь инфляци, ханшид дээрэлхүүлсэн ард түмэн, хүлээн авагч нь төр.

- **Хөрөнгө оруулалтыг цаашид хэрхэх нь зүйтэй вэ?**

- Цээжилтэл ярьсан, экспортын диверсификац үр дүнтэй байдлаар огт хийгдэхгүй байна. Яг үнэндээ төрд үүнийг хийх чадвар алга. Бодлого нь уул нь батлагдсан. Өөрийгөө яая гэж ядаж байгаа Хөгжлийн банк дээр очоод замхарсан. Төв банкны экспортын санхүүжилтийн арилжааны банкуудаа дэмжсэн, Хөгжлийн банктай, Засгийн газартай хамтарсан тодорхой бодлого, уялдаа холбоо байхгүй. Экспортын даатгалын механизм бий болгоно гээд төр нь будилаад л яваа. Экспорт “diplomacy” буюу Монголын экспортыг дэмжин урамшуулах, хөгжүүлэх гадаад бодлого байхгүй. Экспортын бодлого уул нь дэмжин урамшуулах, хөгжүүлэх гэсэн хоёр хэсэгтэй. Энэ нь дотроо уламжлалт ба уламжлалт бус экспортыг дэмжин урамшуулах, хөгжүүлэх, хөгжүүлэх нь дотроо бүтээгдэхүүний хөгжил, экспортын маркетинг, брэндинг гэх мэт тодорхой сувгууд, үйл ажиллагаануудтай. Энэ бүхнийг хийх чадвартай, Засаг нь итгээд дэмжээд санхүүжүүлээд өгчихвөл хэрэгжүүлээд явчих боломжтой МҮХАҮТанхим гэж байна, бусад холбоод байна. Бодлогын хандлага ингэж өөрчлөгдөж байж л явна. Ингэхгүй бол нөгөө 888 төслийн 200 орчим экспортын чиглэлийн төслүүд шиг арилжааны банкуудын үүд сахисаар эсвэл тэдний ширээн дээр л үлдэнэ.

*Сурвалжлагч Э.ЭНХБОЛД*

## **Зугтаж шийдэх үү? Зулгааж шийдэх үү?**

*УИХ-ын Чуулганы 2013 оны 12 сарын 12-ны нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс: “УИХ-ын гишүүн Р.Амаржаргалын УИХ-ын гишүүнээс татгалзах өргөдөл өгсөнийг хэлэлцсэн тухай” асуудлыг хэлэлцэх цээр.*

**З.Энхболд:** - С.Дэмбэрэл гишүүн асууна уу.

**С.Дэмбэрэл:** - Баярлалаа. Би Р.Амаржаргал гишүүний чөлөөлөгдөх хүсэлтийг төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан дээр хэлэлцэх

үед хэлсэн үгийг нь анхааралтай уншлаа. Тэгээд надад нэг асуулт төрлөө. Гэхдээ асуулт асуухаасаа өмнө нэг зүйл тайлбарлая.

Нэгдүгээрт, Та чөлөөлөгдөх хүсэлтээ 4 бүлэг үндэслэлээр тайлбарласан байна. Тэгээд үүнийгээ дотор нь 2 хувааж, субъектив болон объектив шалтгааныг бичсэн байна. Субъектив шалтгаанд нь хүнд төрөхөд нь хамт төрдөг “ичих булчирхай” гэдэг тэр биологийн шинж чанарыг өргөдөл бичихтэйгээ холбосон байна. Объектив талаасаа болохоор эхний шалтгаан чинь, “Монголын парламент салаа замын уулзвар дээр ирсэн байна. Энэ салаан дээр 8 сонголт байна. Үүний алинаар нь явах вэ?” гээд, “Бид сайн сонголт хийх парламент бүрдүүлж чадаагүй тул хариуцлага хүлээх ёстой” гэсэн 2-р аргументаа гаргаж тавьжээ. 3-р аргумент нь, Монгол улсын төр, эдийн засаг, нийгмийн бүх асуудлуудыг авч үзээд, хамгийн сүүлд нь “Ардчилсан нам гарч ирээд ч ялгаа алга байна шүү дээ” гэсэн хүмүүсийн шүүмжлэлийг үндэслэл болгон, /гэхдээ ямар судалгаагаар, яаж энэ үндэслэлээ баталгаажуулсаныг би мэдэхгүй байна./ “Ардчилсан намын төлөө би хариуцлага хүлээж байна” гэжээ. Ийм шалтгаан үндэслээр дотроо 4 бүлэгтэй, 2 талаас нь авч үзсэн үг хэлсэн байна. Эндээс надад нэг л асуулт гарч байна. Өнөөдөр Монголын нийгэм асуудалтай байгаа нь үнэн. Таны энд бичсэн бүх зүйлтэй би санал нийлж байна. Тийм учраас миний асуух асуулт бол:

1. Энэ субъектив болон объектив шалтгааны аль нь танд давамгайл нөлөөлж, энэ шийдвэрийг гаргахад хүргэсэн бэ?
2. Бид өнөөдөр та бидний олон жил ярьсан тэр “Сайн засаглал, ухаалаг төрийг байгуулах” салаа замын бэлчир дээр ирчихээд байна. Энэ бол их том асуудал. Энэ асуудлаас зугтаж шийдэх юм уу, зулгааж шийдэх юм уу гэдэг ийм сонголтын өмнө бид байна. Та яаж шийдэх гэж байна? Зугтах гэж байна уу? Зулгааж шийдэх гэж байна уу?

Энэ 2 асуултанд хариулж өгнө үү. Баярлалаа.

**Р.Амаржаргал:** - За С.Дэмбэрэл гишүүний асуултанд хариулахад, Объектив, субъектив шалтгааны аль аль нь нөлөөлсөн. Салгах аргагүй юм. Объектив шалтгаан нь бол бодитой байж байна. Үгүйсгэх аргагүй, хүссэн хүсээгүй ил байна. Монголын парламентийн ардчилал /хэрвээ тийм юм байдаг бол/ энэ 20 гаруй жилд хэд хэдэн үе шат дамжлаа. Гэвч наад зах нь ийм хэдэн асуудал дээр шийдэл олж чадаагүй л байна. Миний хувьд хамгийн түрүүнд санаанд орж байгаа 8 зүйлийг л түүж бичсэн юм. Цааш нь нэмээд бичээд байвал өөр зөндөө л зүйл гараад ирнэ. Гэхдээ энэ бол объектив бодитоор оршиж байгаа учир шалтгаанууд. Үүн дээр зөв шийдэлийг бид хайж олох учиртай. Энэ эрэл хайгуулыг УИХ маань бүрэн гүйцэд хийж чадсангүй. УИХ-д хүлээх ёстой хариуцлага маш олон байна. Ний нуугүй хэлэхэд хол явах хэрэггүй. Бид л хариуцлага хүлээх ёстой. Нөгөө л 1 сая төгрөг, 1,5 сая төгрөгний асуудлууд байж байна. Улс төрчид болон улс төрийн намууд мэдэгдэл хийсэн л байх. Гэхдээ эцсийн шийдвэрийг албажуулж, баталгаажуулсан байгууллага нь УИХ шүү дээ. УИХ л шийдвэр гаргасан. Өнөөдөр Таван толгой яагаад ашиггүй ажиллаж байгаа юм бэ л гээд байх юм. Аргагүй шүү дээ. Үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулж эхлэхээсээ өмнө дампуурчихсан байсан. Бүх уялдаа холбоо, гинжин урвалыг нь харахаар УИХ дээр л ирж байна шүү дээ. Тэрний төлөө УИХ хариуцлага хүлээсэн үү? УИХ-ыг төлөөлдөг байгуулагууд хариуцлага хүлээсэн үү гэдэг асуудал гарцаагүй яригдах ёстой гэх мэтчилэн объектив бодит асуудлууд олон байна. Үүнийг бүгд хүлээн зөвшөөрөх ёстой байхаа.



Хоёрдугаарт, намайг яах гээд байгааг асууж байх шиг байна. Би өөрийн гэсэн тэмцлийн арга барилтай хүн. Өөрийнхөө хэмжээнд асуудлыг дэвшүүлж, бас шийдвэрлэх гэж оролдож байна. Тэр маягаараа л явж байна. Миний тэмцлийн арга хэлбэр хэн нэгэн хүнд таалагдахгүй байгаа бол тэр нь тэр хүний л хэрэг байхаа...

**З.Энхболд:** - Гишүүд асуулт асууж дууслаа. Одоо саналаа хэлцгээнэ үү.

**С.Дэмбэрэл:** - Би энэ Р.Амаржаргал гишүүний хэлсэн үгийн 3-р зүйл буюу эдийн засгийн асуудал гэдэг дээр эдийн засагч хүний хувьд үг хэлэхгүй бол болохгүй юм шиг байна. Энд “Банкны систем сул дорой, эмзэг байна. Саяхан 5 дахь банк дампуурсан. Одоогоор 4 том банк байгаагын 2 нь асуудалтай, өөрийн хөрөнгө өчүүхэн, хадгаламж хумигдаж, зээлийн эрэлт эрс нэмэгдэж байгаа учраас хөрөнгийн асар их хомсдолд орохоор байна” гэж, маш ноцтой зүйл бичсэн байна. Би ч бас Монголбанкны цахим хуудас руу байнга ордог хүн. Би муу ч гэсэн, 20 гаруй жил баланс уншиж, эдийн засаг судалж байгаа хүн л дээ. Энэ дүгнэлт чинь бодит бус байна. Монголбанкны ажлыг 2 сар гаруй шалгалаа. Мөнгөний бодлогын ажлын хэсгийг ахалж ажиллалаа. Өнөөдөр Монгол Улсын банкны сектор эрүүл бөгөөд хэвийн байгаа гэдгийг би эндээс хариуцлагатайгаар хэлж байна. Энэ чиглэлээр надтай маргая гэвэл, маргахдаа тоо барьж маргая гэвэл хэдэн өдөр ч маргахад бэлэн байна.

Хоёрдугаарт, “Инфиляци 2 оронтой тоонд орсон” гэжээ. Энэ үнэн. Үүнийг хэн ч нуугаагүй байна. Сар болгоны статистикаар, нийт эдийн засагт үнийн өсөлт зугуухан нэмэгдээд, ялангуяа валютын ханшны хэлбэлзлээс болж инфляцид нөлөөлөх нөлөөлөл нь нэмэгдэж байгаа одоо хамгийн сүүлийн Үндэсний Статистикийн мэдээгээр ч тод харагдаж байгаа. энэ байдлыг сайжруулж, инфляцийг 1 оронтой тоонд оруулахын тулд, зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулахын тулд, 2014 оны Мөнгөний бодлого урьд өмнө байгаагүй байдлаар батлагдсан. Үүнийг Р.Амаржаргал гишүүн уншсан, эдийн засагч хүний хувьд бас ойлгосон гэж би найдаж байна. Ийм үед ийм мэдэгдлийг хэвлэл мэдээлэл, олон нийтэд цацан тараахаар банкинд итгэх итгэл сулрах үр дагавартай байдаг гэдгийг хэлэх нь зүйтэй болов уу.

Эцэст нь хэлэхэд, түрүүминий хэлсэнчлэн, асуудлаас зугтаж биш, зулгааж шийддэг байх нь чухал юм шүү. Монгол улс өнөөдөр үнэхээр салаа замын бэлчирт ирчихээд бид нийгмээрээ сонголтоо хийж байна. Зарим сонголтоо хийчихсэн. “Нийгмийн эрэлт нь байхгүй байна” гэсэн байна. Нийгмийн эрэлт байна. Түүний нийлүүлэлт нь дутагдаж, нийлүүлэлт хийх шийдвэр нь удаан, хөшингө, гацаатай байгаа болохоос биш, эрэлт, тэр дундаа нийгмийн эрэлт хэроэгцээ нь аль хэдийн бэлэн, тодорхой байгаад байна. Энэ эрэлтийг л бид хамтдаа хангаж, зөв бодлогоор, зөв шийдвэрээр энэ улсынхаа эдийн засаг – нийгмийг, төрдөө итгэх итгэлийг нийлүүлэлтийн арга хэмжээгээрээ хангах ёстой. Түүнээс биш, нийгмийн эрэлт байхгүй байна гэж харах нь учир дутагдалтай гэдгийг хэлчихмээр санагдаад байна. Таны сонголт мэргэн байх болтугай. Баярлалаа.

## **Хохиролыг барагдуулахдаа санхүүгийн эрсдлийг давхар тооцох ёстой**

*2014 оны 05-р сарын 10-ны УИХ-ын чуулган дээр “Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг хэлэлцэх цээр УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлийн хэлсэн үг:*

С.Дэмбэрэл: Би энэ хуулийг үзэл баримтлалаас нь авхуулаад уншаад байхад хэд хэдэн зүйл тодорхой биш байна. Саяны Л.Энх-Амгалан гишүүний хэлсэнчлэн татвар төлөгчдийн мөнгөөр тэднээс зөвшөөрөл авалгүйгээр, тэдэнтэй ярилгүйгээр төлөх гэж байгаа нь нэгдүгээрт асуудал байна. Хоёрдугаарт энэ хохирлыг зах зээлийн үнээр үнэлсэн, тэгээд хадгаламж зээлийн хоршоо гэсэн ийм нэгжийн социал институтцийн хийгдэх үйл ажиллагаан дотор явагдсан процесс. Гэтэл өнөөдөр ганцхан Х.Тэмүүжин сайд суучихсан, бусад санхүүгийн тогтвортой байдал буюу, санхүүгийн эрсдлээс урдчилан сэргийлэх институцуудын гол хүмүүс нь алга байна. Өөрөөр хэлбэл санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан энэ хадгаламж зээлийн хоршоодоос 70 хэдэн тербум төгрөгний цаашид нь яаж санхүүгийн эрсдлээс хамгаалах юм вэ гэсэн хуулийн өөрчлөлт орж ирсэнгүй. Хуулийн хохирлыг эргэж буцааж төлөгдөх нөхцөлтэйгээр хэсэгчлэн барагдуулах ба хадгаламж зээлийн хоршооны системд санхүүгийн эрсдэлээс урдчилан сэргийлэн хамгаалах ийм механизмыг бүрдүүлэх ийм иж бүрэн утгатай хууль орж ирэх ёстой. Тэр алга. Тэр алга байгаа нөхцөлд Х.Тэмүүжин сайд хууль зүйн талаас нь хариуцлага тухай яаж яарсан угаасаа энэ системийн гажиг нь засагдахгүй. Тийм учраас энэ талаас нь энэ хуулийг ийм яаруу батлах нь буруу гэж бодож байгаа. Тийм учраас дахин боловсруулж, саяны миний хэлсэнээр санхүүгийн эрсдлийн механизмыг яаж цаашдаа оруулж ирэх юм вэ гэсэн иж бүрэн талаас нь авч орж ирсэн нь дээр байхаа гэсэн ийм саналтай байна.

## **Хүний эрх зөрчсөн төсөв батлах гээд байна**

*УИХ-ын 2014 оны 05 дугаар сарын 23-ны Нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс: “Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд” хэлэлцэх цээр*

С.Дэмбэрэл: Инфиляцийг нэг оронтой тоон дээр барина гээд байгаа талаар асуух зүйл байна. Хүн амын амьжиргааны 72 хувь нь хүнсний бус зардалд, 24 хувь нь хүнсний зардалд гарчихаад байхад ямар аргаар тооцоолоод 24 хувийг 7 юм уу 8 хувьд барьна гээд байна вэ? нэгдүгээрт. Хоёрдугаарт бид бүхэн хүний эрх зөрчсөн төсөв батлах гээд байна. Хууль зүйн яамны төсөв нь өмнөх жилд 138 орчим байсан юм байна. Одоо орж

ирж байгаа тодотголоор 24,7 болоод багассан байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тайланг уншихад бидэнд төсөв байдаггүй учраас хүний эрхийг өөрийн эрхгүй зөрчих бодит нөхцөлд байдаг. Өдөр болгон хоолонд нь цувдай өгдөг байдлаа боль гэхлээр хэрэв бидэнд баталж өгсөн төсвөөр байдлыг өөрчилвөл 6 сар болоод төсөв маань дуусна гэдэг. Энэ байдлаас харахад ял эдэлж байгаа газар хүний наад захын хэрэгцээг хангах зүйлс нь төсөвт нь тусгагддаггүйн улмаас, өөрөөр хэлбэл Хууль зүйн яамны төсөв хасагдаж орж байгаа байдлаас харахад бид бүхэн “хүний эрхийг цаашид зөрчөөд яв” гэсэн төсвийг Тэмүүжин сайдад баталж өгөх гэж байна уу? гэсэн утгаар би хараад байна. Гуравдугаарт, хязгаарлагдмал хүрээ ч бай, хязгаарлагдмал биш ч бай бид валютынхаа ханшны тооцоог маш бодьтой хийж өгөхгүй бол одоогийн гаргаж ирсэн тооцоо чинь инфляцитай чинь уялдахгүй байгаа шүү. Бид инфляцийг 6 эсвэл 7 ч юм уу нэг оронтой тоон дээр барьна гэж үзэж байгаа л юм бол бодлого нь маш өөр байх ёстой шүү. Засгийн газар инфляцийг хязгаарлах үүрэгтэй. Мөнгөний бодлогоор бид инфляцийг нэг оронтой тоонд барь гээд өгчихдөг. Валютын ханш өссөн тохиолдолд инфляци чинь нэг оронтой тоонд баригдахгүй. 100 ч бай 200 ч бай хоногт энэ байдал харагдахгүй байна. Ийм нөхцөл бүрдсэн байхад төсвийн тодотгол гээд ийм төсөөлөл хийж болох уу? Бодит байдалтай хэр нийцэж байгаа вэ?



## **ХОЁР. Эдийн засгийн эрх чөлөө ба сайн засаглал бол хоосон нэр томьёо биш**

*Би Ностродамус биш, оны эцэст инфляци ч, зээлийн хурч ч хоёр оронтой тоондоо л байж байна гэдгийг баттай хэлчихвэ*

*УИХ-ын гишүүн, ИЗНН болон МҮХАҮТ-ын дарга С.Дэмбэрэлийг “УЛС ТӨРИЙН ТОЙМ” сонин “Ярилцах танхим”-д урьж ярилцжээ. /2013 оны 03 сарын 21./*

**УТТ:** - Өмнө нь Монголбанкныхан мөнгөний бодлогоо хатууруулахгүй л бол инфляцийг бууруулах аргагүй гэдэг онол дээр хатуу зогсож тэр нь хувийн хэвшлийнхэн, иргэдэд хүндээр тусдаг байлаа. Гэтэл Монголбанкны одоогийн удирдлагууд мөнгөний бодлогын хүүгээ 0,75 хувиар бууруулсан хэрнээ инфляцийг бууруулчихлаа. Энэ “өөр арга”-ын талаар та ямар бодолтой байгаа вэ?

**С.Дэмбэрэл:** - Инфляци буурсан юм уу?

**УТТ:** - Монголбанкны одоогийн удирдлагууд өнгөрсөн оны аравдугаар сард ажлаа хүлээж авахад инфляци 15 хувьтай байсан. Оны эхэнд 14 хувь байсан. Саяхан 11,3 хувь болголоо. Үүнийг буурсан гэж үзэхгүй гэж үү?

**С.Дэмбэрэл:** - Хэдийгээр, улсуудын төв банкууд бүгд инфляцийг онилох бодлого явуулдаг боловч Монгол Улсын бодит эдийн засгийн байдал, инфляцийн өөрийнх нь шинж чанараас хамааран манай баримталж ирсэн бодлогын хувьд огтхон ч байндаа оновчтой тусч ирсэнгүй. Гэхдээ, инфляци Монголбанкны бодлогод шууд хамааралтай гэж үзэх үндэслэл байхгүй. Олон жилийн дундажаар, бүх статистик үзүүлэлтээр мөнгөний нийлүүлэлт, инфляцийн хэмжээ, Монголбанкны мөнгөний бодлогын шийдвэрүүдийг харахад тийм шууд хамаарал байдаггүй. Инфляцийн хурдац нь буурлаа гэж бас ярьж байгаа. Уучлаарай, жил бүрийн өдийд хурд дандаа буурдаг юм. Улирлын онцлогоос хамаараад, цагаан сарын дараа, инфляци ч гэсэн “ядарчихдаг”. Энэ чинь хүмүүсийн авир, төрхтэй адилхан шүү дээ.

**УТТ:** - МҮХАҮТ-ийн байрны дээр “Зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулах бодлогыг дэмжих жил” хэмээн бичсэн байх нь сонирхолтой санагдлаа. Энэ бол хувийн хэвшлийнхэн, иргэд, ерөөсөө Монголд санхүү, эдийн засгийн харилцаанд оролцож буй хүн бүхний мөрөөдөл. Тиймээс хоёулаа эндээс яриагаа эхлэх үү?

**С.Дэмбэрэл:** - МҮХАҮТ-ээс энэ жилийг зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулах төрийн бодлогыг дэмжих жил болгон зарласан. Яагаад гэвэл Засгийн газрын мөрийн хөтөлбөрт ч тэгж орсон. УИХ-аас баталсан 2013 онд мөнгөний бодлогын талаар төрөөс баримтлах бодлогод “Зээлийн хүүг гуравны нэг хувиар бууруулах боломжтой. Инфляцийг найман хувьд барина” гээд биччихсэн байгаа. Монголбанкныхан УИХ дээр ярьж байснаараа бол инфляцийг нам дор төвшинд барьж чадвал зээлийн хүү тодорхой хэмжээгээр буурах боломжтой. Энэ жилийн мөнгөний бодлогын нэг шинэ зүйл нь юу вэ гэвэл нийлүүлэлтийн шатанд үнийг өсгөөд байгаа

гол саад бэрхшээлийг арилгах талаар тодорхой төслүүдийг хэрэгжүүлж эхэллээ. Тухайлбал мах, шатахуун, барилгын материал зэргийг дурьдаж болно. Урьд нь нийлүүлэлтийг огт анзаарахгүй зөвхөн эрэлт талаас нь анхаарч эдийн засгаас мөнгөө татаж авчихдаг тийм гэнэн, сурах бичгийн онолоор явж байсан. Харин энэ жилээс Монголбанкны бодлого хөрсөн дээр бууж хүмүүсийн, бизнесийнхний амьдралыг мэдэрч Засгийн газартай хамтран ажиллаж эхэллээ. Энэ бол дэвшил. Гэхдээ оны сүүлч гэхэд инфляци ч, зээлийн хүү ч хоёр оронтой тоонд хэвээрээ л байна гэдгийг баталгаатай хэлье.

**УТТ: - Яагаад. Оны эцэст инфляци нэг оронтой тоонд байх боломжтой нь харагдаж эхлээд байгаа юм биш үү?**

**С.Дэмбэрэл:** - Би бол Нострадамус ч биш, Дэмбэрэлдамус ч биш. Энэ оны мөнгөний бодлогыг батлахад би ганцаардсан, цөөнх болсон. Учир нь би “Инфляцийг онилохоос гадна эдийн засгийн өсөлтийг онилъя” гэж хэлсэн юм. Гэтэл “Эдийн засгийн өсөлтийг онилох бодлоготой улс дэлхий дээр байдаггүй юм байна билээ” гэж дөнгөж сургууль төгссөн нэг хөөрхөн хүүхэд хэлсэн. Би их өхөөрдсөн, тэр хүүхдийг. Энэ Эдийн засгийн өсөлтийг онилох гэдэг маань ажил эрхлэлтийг онилохыг хэлдэг. Тэр байтугай валютын ханшийг ч онилдог орнууд бий. Төрийн тэргүүнээс эхлээд “Эдийн засгийн өсөлт өрх бүрийн амьдралд нөлөөлөхгүй байна” гэдгийг хэлж буй. Үүнийг оролцоогүй эдийн засгийн өсөлт гэдэг. Миний болон Танхимын хэлээд байгаа санаа бол оролцоотой эдийн засгийн өсөлтийг онилъя. Үүний тулд хөдөлмөр эрхлэлтийн багтаамж ихтэй хувийн хэвшлийнхэн, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжье гээд байгаа юм.

**УТТ: - Энэ талаар олон жил ярилаа. Харин одоо яг яаж хиймээр байгаагаа тайлбарлана уу?**

**С.Дэмбэрэл:** - Өнөөдөр Засгийн газрын 1,5 тэрбум ам.долларын бондыг хэд хэдэн төсөлд хуваарилж байх шиг байна. УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны харьяанд Жижиг дунд үйлдвэр эрхлэлтийн дэд хороо гэж байдаг. Энэ хорооны хуралдаад “Жижиг дунд үйлдвэрлэлийн салбарт бондын хөрөнгөөс 200 сая ам.доллар өгөөч” гэсэн хүсэлт тавьсан. Хоёр сар боллоо, хариу өгсөнгүй. Үүгээр яах гээд байна вэ гэвэл инфляцийг нам дор төвшинд байлгаж, эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэхийн тулд хямд үнэтэй эх үүсвэрийг эдийн засагт оруулах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл гаднаас орж ирж буй энэ мөнгөөр шууд ажлын байр бий болгож болох юм. Үүний тулд Жижиг дунд үйлдвэрлэлийн сан, Зээлийн баталгааны санд 200 сая ам.доллар байршуулж өгөөч гэсэн хүсэлт тавьсан юм. Я.Санжмятав сайд их дэмжиж байгаа ч тэднийд мөнгө байхгүй. Өмнө нь дотоодын бондын хөрөнгөөс “илүүчилсэн” ч үр ашиг нь орж ирээгүй байна. Таван жилийн хугацаанд орж ирэх ёстой. Тиймээс Жижиг дунд үйлдвэрлэлийн сан, Зээлийн баталгааны санд өнөөдөр мөнгө алга. Арилжааны банкуудын зээлийн хүү 20 гаруй хувьтай хэвээрээ байна. Засгийн газар, гадны зээл тусламжаар жижиг дунд үйлдвэрлэлийн салбарыг дэмжиж байгаа ч боломжийн зээлийн эх үүсвэр нэмж оруулах маш их шаардлагатай байна. Нийт санхүүгийн секторын 95 хувь нь банкууд, 5 хувь нь банк бус санхүүгийн байгууллага г.м байна. Энэ бол зөв тогтолцоо биш. Тиймээс Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгасанчлан санхүүгийн

салбарын реформыг иж бүрнээр хийх ажлыг хурдавчлах шаардлагатай. Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх альтернатив тогтолцоог бий болгож, Хөрөнгийн биржээс гадна хөрөнгө оруулалтын сан, тэтгэвэр, тэтгэмжийн сан, даатгалын санг хөгжүүлж банк, санхүүгийн байгууллагуудын эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай. Ингэснээр санхүүгийн төрөлжилт сайжирч өрсөлдөх чадвартай болно. Үүний үр дүнд л зээлийн хүү өрсөлдөөний зарчмаар буурна.

**УТТ: - Яг ийм реформ хийхэд ямар хугацаа шаардлагатай вэ?**

**С.Дэмбэрэл:** - Хоёроос таван жилийн хугацаанд хийж амжина. Саяхан би УИХ-ын Эдийн Засгийн байнгын хороонд санал оруулж МҮХАҮТ, Банкуудын холбоо, ББСБ-уудын холбоо, Даатгалын сангуудын холбоо, Хадгаламж зээлийн хоршоодын холбоо зэрэг санхүүгийн зах зээл дээр ажилладаг Төрийн бус байгууллагуудын агентуудыг цуглуулаад тэдний оролцоотой ажлын хэсэг байгуулж өөрөө сайн дураараа ахлаж ажиллахаар болсон. Ингээд зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулах альтернатив буюу зэрэгцээ хувилбарыг боловсруулахаар боллоо. УИХ-аас Монголбанк, Сангийн яаманд протоколын журмаар даалгавар болгоод өгчихсөн нэгэн зорилт байгаа. Тэд бас зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулах талаар бодлогоо боловсруулсан байх ёстой. Ингээд тавдугаар сарын 15 гэхэд хоёр хувилбарыг харьцуулж үзэх юм. Цаашид Монголын санхүүгийн салбарын реформ, тэр тусмаа банкны зээлийн хүүг өрсөлдөөний зарчмаар бууруулахад гол анхаарлаа хандуулна. Өөрөөр хэлбэл зөвхөн банкууд бус тэдэнтэй өрсөлдөхүйц хүүтэйгээр зээл олгодог байгууллагуудтай болно гэсэн үг. Төв банкны хувьд валютын нөөц төд боллоо гэж бахархан мэдэгдэхээсээ илүүтэй ямар хэмжээний хямд эх үүсвэрүүдийг олж арилжааны банкуудад өгснөө мэдээлдэг болох хэрэгтэй. Банкуудыг заавал байлгах нөөцийн доод хэмжээг бууруулах сэжид түлхэц өгсөн уян хатан бодлогын хэрэгсэл болгох бүрэн боломж байна. Жишээ нь зээлийн хүүгээ тодорхой хэмжээнд бууруулсан банкинд заавал байлгах нөөцийн хэмжээгээ бууруулах боломж олгодог байх зэрэг хөшүүргийн арга хэмжээ чухал нөлөөтэй.

**УТТ: - Хэрэв та Төв банкны ерөнхийлөгч байсан бол эдийн засгийн өсөлтийг л онилох байсан уу. Эсвэл инфляцийг уу?**

**С.Дэмбэрэл:** - Аль, алиныг нь онилох байсан. Ер нь одоо эрүүлжих хандлага руугаа явж байна гэж ойлгож байгаа. Өнгөрсөн хугацаанд ч, одоо ч би Монголбанкныхантай их маргалддаг л даа. Гэхдээ тэр бүхэн Монгол Улсад төрийн мөнгөний бодлогыг барьж буй институци Монголбанк маань ардиргэдийнхээ дуу хоолойг сонсож тэр тусмаа гол объект болсон арилжааны банкуудынхаа үгийг сонсоосой гэсэн үүднээс л байдаг юм. Банкуудаас гадна банк бус санхүүгийн байгууллагуудыг Санхүүгийн зохицуулах хороо хариуцна гээд хаячихдаг. Тэр ч байтугай хэн ч анхаардаггүй хэрнээ хамгийн өргөн хэрэглээтэй “Ломбард” гэж байгууллага байна.

**УТТ: - Ломбардыг Санхүүгийн зохицуулах хороо хянах, анхаарах ёстой биз дээ?**

**С.Дэмбэрэл:** - Иргэд эмээл хазаар, алт, монетон ээмэг, бөгжөө тавьж 7-8-хан хувийн хүүтэй зээл авдаг энэ байгууллага эрэлтгүй учраас л байгаад байна. Үүнийг санхүүгийн үйлчилгээ үзүүлж байгаа гэдэг талаас нь, яавал хүү багатай болох, үйлчлүүлэгчид нь хохирдоггүй байлгах вэ гэдэгт

анхаарч хууль санаачлах судалгааг би хийж байна. Хөрөнгө оруулалтын сан, даатгалын компаниудын хувьд ч мөн адил. Гэтэл бид сурах бичигт зааснаар яваад байна. Одоо Хөрөнгийн биржийн тухай хуулийн төсөл бэлэн болсон. Хаврын чуулганаар хэлэлцэгдэх байх. Ингэж санхүүгийн салбарын реформоо цогцоор хийх хэрэгтэй.

**УТТ:** - Энэ бүхнийг хийхэд инфляци буурах уу?

**С.Дэмбэрэл:** - Энэ бүхнийг хийсний дараа буурч болно. Харин түүний наана хийх олон ажил байна. Хөдөө аж ахуйн бирж гэж олон жил ярилаа. Тэр бүтэхгүй. Ченжүүд байдгаараа байна. Зөв гольдролоор л явуулах хэрэгтэй. Засгийн газар тээвэрлэлт, ложистик, дэд бүтцийн талаар их зүйл хийх шаардлагатай. Энэ бол Монголбанкны үүрэг биш. Зөвхөн санхүүгийн реформ хийснээр асуудал шийдэгдэхгүй, инфляци буурахааргүй байгаа биз дээ. Газрын үнэ нэмэгдвэл яах вэ. Ядуурал 30 хувиас буурахгүй олон жил боллоо. Ажлын байр бий болгосноор шийдэгдэхгүй. Олон хүчин зүйл нөлөөлдөг асуудал. Дээр нь бидний яаж ч шийдэж чаддаггүй нэг бэрхшээл бол импортын инфляци байна. Хүнд суртлын инфляцитайгаа тэмцэх явцад авлигатай тэмцээд явж байгаа. Одоогоор ЗГХЭГ-ын дарга Ч.Сайханбилэгийн мэдэлд 11 ажлын хэсэг ажиллаж байна. Энэ бүх ажлын үр дүнд инфляци нам дор төвшинд буурах боломжтой. Дахин хэлэхэд инфляци бууруулахад Монголбанк дангаараа ажиллаад амжилтад хүрэхгүй. Засгийн газар том нөлөөтэй. Монголбанк зээлийн хүүгээ л бууруулахад анхаарах хэрэгтэй. Гэхдээ Монголбанк бодлогын хүүгээ өчүүхэн багаар бууруулах уламжлалт аргаас татгалзаж огцом бууруулах ёстой. Ингэлээ гээд Монголын эдийн засаг сөнөхгүй.

**УТТ:** - Статистикт тэнэгүүд л итгэдэг гэх нь бий. Гэтэл статистикгүйгээр бодит тооцоо судалгаа гаргах аргагүй. Та статистикт итгэдэг үү?

**С.Дэмбэрэл:** - Статистик боловсруулах, хиам үйлдвэрлэх хоёрыг харах хэрэггүй гэдэг үг байдаг. Өөрөөр хэлбэл статистик боловсруулахад хийсвэр элемент олонтаа ордог. Гэхдээ байгаа нь л ардчилал гэдэг шиг байгаа нь л статистик юм чинь итгэхээс аргагүй. Нөгөөтэйгүүр статистик нийгмийн амьдралын зөв хандлагыг илэрхийлж чаддаг учраас Монголбанк хэрэглээний үнийн индексээр баримжаа авдаг. Энэ бол динамик шинжлэх ухаан. Байнга хөгжих ёстой. Ирэх 2014 оноос GDP-ээс гадна GNP-г тооц. Цэвэр үндэсний орлогоо тооцож оруулж ирэх ёстой гэдэг саналыг би УИХ-ын гишүүний хувьд оруулж ирнэ. Ингэж байж статистик илүү сайн хөгжинө. Цаашдаа ногоон эдийн засаг, өсөлтийг хэмжих асуудал тулгамдсан зорилт болж байна.

**УТТ:** - Заримдаа “Статистик улстөржөөд байна уу” гэж хардмаар үе байдаг. Тэнд хүн ажиллаж байгаа учраас тэгж хардах үндэслэл бий юү?

**С.Дэмбэрэл:** - Гэнэт сонгуулийн үеэр ядуурал огцом буурдаг учраас тэгж байна уу. Яг тийм учраас тэр байгууллагыг УИХ-д “уяж” өгсөн юм. УИХ-д ажлаа тайлагнадаг, бие даасан, хараат бус байгууллага гэсэн статустай ажиллаж байгаа. Гэхдээ энэ байгууллагын санхүүжилт чамлалттай учраас асар олон чухал судалгааг хийж хүчирдэггүй гэдэг юм билээ. Энэ талаар цаашид анхаарах л хэрэгтэй. Тэдний “хуурай” тооны цаана ард түмний “нойтон” амьдрал явдаг учраас тэр.

**УТТ:** - Та сая ядуурлыг 30 хувьтай байна гэлээ. Дэлхийн банкны тооцооллоор уу. Яагаад манай статистикчдын тооцооллоос зөрөөд байдаг юм бэ?

**С.Дэмбэрэл:** - Аргачлалын л зөрүү байсан юм билээ. Хамгийн бодитой нь буюу PPP аргачлалаар тооцоолж өрхүүдийн судалгаагаар тогтоосноор ядуурал 30 хувьтай байгаа. Түүний дээр ядуурал гэсэн ангилал руу уначих гээд байгаа 10 хувь байгаа гэж үзэх хэрэгтэй. Тэгэхээр 40 хувьтай байна гэж тооцоход хилсдэхгүй. Саяхан Орхон аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимаас иргэдийнхээ аз жаргалын индексийг тооцоолж гаргасан байна. Дэлхий дээр “Аз жаргалын эдийн засаг” гэдэг шинжлэх ухаан хэдийнэ үүсчихсэн. Бутаны хаан хэдэн жилийн өмнө үндэсний нийт аз жаргалын индексээ тооцоолж гаргаад тэр тухайгаа ярихад нь хүмүүс “галзуу” гэж бодож байсан бол одоо НҮБ-ын хэмжээнд ярьдаг болсон. Мөн 2009 онд Францын Ерөнхийлөгч Н.Саркози Нобелийн шагналт эдийн засагчидтайгаа хамтран тусгай комисс байгуулж ДНБ-ээр амьдралаа хэмжих нь зөв үү гэдэг асуудлыг дэлгэн тавьсан юм. Тэгэхэд дээрх эдийн засагчид “Энэ бол буруу. Яг хүний амьдралын чадамж, сэтгэл хангалуун байдлыг бид буруу тооцож байжээ” гэсэн дүгнэлт хэлсэн.

**УТТ:** - Энэ бол сонин тооцоолол. Хүн заавал хэзээ ч гартаа атгаж үзэхгүй нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ гэгч тооноос илүү аюулгүй, амгалан, эрүүл орчинд хүссэн амттанаа идэж, дуртай гар утас, автомашинаа хэрэглэж түүндээ сэтгэл хангалуун байгааг илэрхийлэх үзүүлэлт гэж ойлгож болохоор?

**С.Дэмбэрэл:** - Тэгэхээр Орхон аймгийн энэ туршлагыг үндэсний хэмжээнд тархааж иргэдийнхээ аз жаргалын индексийг тогтоож дэлхий дахинд зарлаж яагаад болохгүй гэж. Тухайлбал Үндэсний Статистикийн газар, ЭЗХЯ, БОНХЯ хамтран жил бүр ДНБ, бусад тооцоо судалгааны зэрэгцээ иргэдийнхээ аз жаргалын индексийг УИХ-д оруулж ирдэг байж болно. Ингэснээр хүний хөгжлийн талаасаа ч их тустай, илүү альтернатив баримжаатай болох юм.

**УТТ:** - Улс орнуудын аз жаргалын индексийг харахад нэг хүнд ногдох ДНБ-ээс илүү өөдрөг үзүүлэлттэй гарсан байдаг. Энэ нь магадгүй төрөөс нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийн эерэг хүлээлт үүсгэх учраас иргэдийн сэтгэл санаанд ч эергээр нөлөөлдөг байж таарна. Сэтгүүлчид харин энэ ажилд дуртайяа туслах төдийгүй чухал үүрэг гүйцэтгэх байх шүү?

**С.Дэмбэрэл:** - Тийм шүү. Сэтгүүлчдийн үүрэг их. Аливаа хүлээлтийг удирдаж болдог. Инфляцийн хүлээлтийг Монголбанк удирдах гэж хичээж байна. Жишээ нь шүүхэд байнга шахам сөрөг хүлээлтэй байдаг. Ер нь нийгэм эерэг хүлээлтийг хүсээд эхэлчихлээ. Одоо та нарын л ажил үлдэж байна. Гэхдээ хуурч болохгүй. Үндэслэлтэйгээр эерэг сэтгэгдлийг бий болгож та нар чадна шүү дээ.

**УТТ:** - Ярилцсанд баярлалаа.

## **Засгийн газарт тавьсан асуултууд маань голдуу санал, тэгээд бас сануулсан утгатайг анхаараарай**

*УИХ-ын Чуулганы 2013 оны 1-р сарын 18-ны хуралдааны тэмдэглэлээс:*

**З.Энхболд:** - С.Дэмбэрэл гишүүн асууя.

**С.Дэмбэрэл:** -За баярлалаа. Асуултууд маань голдуу санал, тэгээд бас сануулсан утгатай гэдгийг анхаарна уу?

*Нэгдүгээрт*, инфляцитай холбогдуулаад зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулах асуудлыг энэ оны эхний улиралд оруулж ирэх ёстой. Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд энэ чиглэлээр юу хийгдэж байна вэ гэсэн сануулга асуулт байна.

*Хоёрдугаарх нь*, мөн инфляцитай холбоотой, тэр дундаа махтай холбоотой. Яг өнөөдрийн байдлаар инфляцид гол нөлөөлж байгаа бас нэг хүчин зүйл бол Монгол Улсын нийт малчдын ихэнх нь 200 хүртэл толгой малтай байна. Тийм учраас малжуулах ажлыг Засгийн газар хийх үү гэсэн асуулт байна.

*Гуравдугаарх нь*, Засгийн газрын мөрийн хөтөлбөрт байгаа уул уурхайн бус экспортыг дэмжих сан байгуулна, стратеги төлөвлөнө гэсэн. Энэ ажил хэр зэрэг явж байна?

*Дөрөвдүгээрх нь*, таны байгуулсан тогтвортой хөгжлийн хороог ойрын хугацаанд хуралдуулах уу? Аймгууд эхнээсээ ногоон хөгжлийн загвар аймаг болъё гэж байна. Архангай аймаг саналаа гаргалаа. Энэ талаас нь дэмжих хэрэгтэй байна. Тэрний дараагийнх нь бол саяхан хуралдсан жижиг дунд үйлдвэрлэлийн дэд хорооноос санал гарсан, энэ бондын тодорхой хэсгийг 300-500 сая долларын тодорхой хэсгийг нь жижиг, дунд бизнесийг дэмжихэд зориулвал яасан юм бэ гэсэн хүсэлтийг танд тавих гэж байна. Энийг бас авч хэлэлцэж болох уу гэсэн нэг асуулт байна.

*Түүний дараа*, сүүлийн үед ажиглаад байхад гадаадын түншүүд болон Олон Улсын байгууллагуудад хандах Монгол Улсын нэг ерөнхий мессеж дутагдаж байна. Өөрөөр хэлбэл нэг хэсэг нь манай улс их мундаг болсон гээд байдаг. Нөгөө хэсэг нь дуугүй байгаад байдаг. Бодит амьдрал дээр асуудлууд хуримтлагдчихсан. Олон улсын түншүүд болон Олон Улсын байгууллагын туслалцаа манайд хэрэгтэй. Тийм учраас энэ дээр нэг цонх, нэгдсэн нэг мессеж өгөх талаар бас бодолцвол яасан юм бэ гэсэн бас нэг зүйл байна.

Мөн гадаадын хөрөнгө, стратегийн хөрөнгө оруулагчдыг үргээж байгаа болгоомжлолд оруулсан нэг зүйл байна. Стратегийн хөрөнгө оруулалтын тухай. Энэ хуулийг дахин авч үзэх үү гэсэн асуулт байна.

Таван толгойн хувьцааг эзэмшсэн, худалдан авсан үндэсний компаниудад хандаж та юу хэлэх вэ?

*Хамгийн эцсийнх нь*, сүүлийн үед хувийн хэвшлийнхний дотоодын нийт бүтээгдэхүүнд оруулах хувь нэмэр сүүлийн 2 жилд буурах, тогтох хандлага ажиглагдаад байна. Эсрэгээр, улсын секторынх нь их нэмэгдэж байна. Энэ чиглэл дээр таны байр суурь ямар байна вэ? баярлалаа.



**З.Энхболд:** -Ерөнхий сайдаас эхлэх үү. Дараа Н.Батбаяр гишүүн.

**Н.Алтанхуяг:** -Тогтвортой хөгжлийн хороогоо ирэх долоо хоногт хуралдуулчихъя. Жижиг дунд бизнесийг эрхлэх чиглэлээр нөгөө бондын зөвлөл дээр бид нар нилээд олон чиглэл төслүүдийг ярьсан байгаа. Тэрэн дотор ингээд жижиг дундын юм явж байгаа та Баттулга сайдад өгөөд тэндээс ороод ирвэл сайн. Бид нар бол түрүүн Ганбаатар гишүүн бас хэлчихнэ лээ. Бондынхоо мөнгөөр экспортод чиглэсэн чадавхиа нэмэгдүүлээд авъя. Гэдэг бодлогыг бол барьж байгаа. Энэ рүү бол тодорхой хэмжээний мөнгө бол гаргана. Тухайлбал ноос, ноолуур, арьс, шир, оёдол магадгүй мах гээд энэ чиглэлээр ингээд экспортод гарах бүтээгдэхүүнийхээ боловсруулалт болоод бусад түвшинг дээшлүүлэх чиглэлд нь бол илтээр манай ерөөнд ирж ноос, ноолуурынх, арьс, ширнийхэн, оёдлынхон, махныхан бүгдээрээ перцентэшин тавьсан. Тэрийгээ бид нар тодорхой дэмжих юм гэж ярьсан. Энийгээ одоо бид нар бодлогынхоо зөвлөл дээр оруулж ирж эцэслэж ярина. Тэгэхээр энэ чиглэлийг дэмжинэ. Гадаадын хуулиар Н.Батбаяр сайд хариулчих.

**Н.Батбаяр:** -Зээлийн хүү бууруулах асуудлаа юу болж байна гэж. Ямар ч байсан зээлийн хүү бууруулах үндсэн суурь асуудлаа эхэлчихсэн. Тэр бол бондоо босгоод мөнгөө оруулаад ирсэн учраас төгрөгний нийлүүлэлт бүрдүүлэх боломж бүрдсэн. Энэ тал дээр арилжааны банкууд болон Монголбанк, холбоотой газруудад судалгаа хийгдэж байна. Зээлийн хүүгийн бууралт олон нийтэд энэ нэгдүгээр улиралдаа багтаад мэдрэгдэнэ. Өөрөөр хэлэх юм бол энэ оны нэгдүгээр улиралдаа багтаагаад зээлийн хүүг бууруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. 2 жилийн хугацаанд үндсэндээ бид нарын тооцоолж байгаагаар бол зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулах боломж бүрдэнэ гэсэн тооцоотойгоор ажлаа явуулж байна. Энэ хүрээнд зээлийн хүүг бууруулахад зөвхөн эх үүсвэр нэмэгдүүлэх урт хугацаатай бага өртөгтэй эх үүсвэр нэмэгдүүлэх биш бусад санхүүгийнхээ бүтцийг бүтэн болгох ёстой болж байгаа. Энэ утгаараа гэх юм бол бизнесийн даатгалын компани байгуулах шаардлагатай байна. Лизингийн томоохон компаниуд бий болох шаардлагатай байна. Мөн одоо гадаад худалдаагаа өртөг багатай үйл ажиллагаа явуулдаг болгохын тулд Монголын экспорт, импортын банкыг байгуулах шаардлагатай байж байна. Тэгээд Моргежийн зээлийг жинхэнэ бодит утгаар нь хэрэгжүүлэхийн тулд 2 дахь ... ажиллах моргежийн компанийг хүчтэй дэмжиж байгуулах энэ ажлыг хийх шаардлагатай болж байна. энэ ажлын судалгааны ажлууд хийгдэж байна. Ойрын үед эхнээсээ ажил болоод явна гэж хэлье баярлалаа.

**Н.Алтанхуяг:** -Тэр улсын секторын оролцоо нэмэгдээд байна уу гэдэг тийм судалгаа надад алга.

**Б.Бадамцэцэг:** -2011 он хүртэлх олон жилийн динамик надад байна л даа. Тэгээд 11 онд гэхэд хувийн хэвшлийн ДНБ-нд эзэлж байгаа хувь 75.3 хувьтай байгаа. 2009 онд 73 хувьтай, 2010 онд 73.4 хувьтай, 2011 онд 75.3 гэсэн ийм хувиуд байна. Бага зэрэг өсөлттэй.

## **Бондын мөнгөнөөс жижиг дунд бизнесийг дэмжих зүйл яагаад ороогүй юм бэ?**

**2013 оны 03-р сарын эхээр, Монгол Улсын Ерөнхий сайд “Хаврын бүтээн байгуулалтын ажлын бэлтгэлийн талаар” мэдээлэл хийх цеэр:**

**С.Дэмбэрэл:** - За баярлалаа. *Нэгдүгээрт*, Ерөнхий сайдаас асууя. Бодлогынхоо зөвлөлийн гишүүдийг яагаад бүрэн бүрэлдэхүүнээр нь байлгаж болохгүй байна вэ? Уг нь надад Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Нийслэлийн Засаг дарга гэсэн гурван хүнээс юм асуух зүйл байх юм. Энэ хүмүүсээс чинь нарийн ширийн асуулт асуумаар байна шүү дээ.

*Хоёрдугаарт*, бодлогын зөвлөлд чинь Улсын Их Хурлын хоёр Байнгын хорооны дарга орчихсон байна. Хэрэв байнгын хорооны дарга гэсэн албан тушаалаар нь оруулж байгаа бол энэ хоёр хүн гишүүддээ мэдээлэл хийх, гишүүдийн өгсөн саналыг бодлогын зөвлөлд дээр Их Хурлын гишүүдийн саналыг гаргаж хэлэх гэсэн утгаар л албан тушаалаараа орно. Гэтэл энэ яагаад хэрэгжихгүй байна гэсэн асуулт байна.

*Гуравдугаарт нь*, энд жижиг дунд бизнесийг дэмжих нэг ч зүйл алга. Дотоод бондын 200 орчим тэрбум төгрөг чинь одоо эргэлтэд гарчихсан. Жилдээ 10-аас 20 тэрбум нь эргэж төлөгдөж байгаа. Зээл авах эрэлт асар их байна. Гэтэл яагаад ороогүй байна вэ? Төлөөлөл байхгүй учраас орсонгүй юу? Хариуцсан сайд нар энэ талаар анхаарсангүй юу. Дотоод бондоор энийг нөхнө гэж, гэтэл одоогийн жижиг дунд зээлийн бизнесийн зээлийн эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй.

*Дараагийнх нь*, санхүүгийн менежментийн гэрээн дээр нэлээн тодруулах юм байна. Жишээлбэл, яг ямар нөхцөлөөр арилжааны банкуудад байршуулж байгаа юм бэ? Энд банк бус санхүүгийн байгууллагууд оролцож байгаа юм уу? Оролцож байгаа бол нэг хэрэг. Оролцоогүй бол Санхүүгийн зохицуулах хорооны даргын бодлогын зөвлөлд байхын ач холбогдол нь юу юм бэ гэсэн асуулт байна.

*Түүний дараа* энэ төслүүд! энэ бол Ерөнхий сайдын хэлсэн шиг чиглэлүүд биш байна Ерөнхий сайд аа. Энэ бол тодорхой нэртэй төсөл хөтөлбөрүүд гээд биччихсэн байна. Төсөл хөтөлбөрүүдийн нэр байна. Тэгэхээр энэ төсөл хөтөлбөрүүдийг өнөөгийн цэвэр ертгөөр нь эрэмбэлээд хөрөнгө оруулалтынх нь дотоод өгөөжөөр нь ангилсан ийм зүйл хэзээ гарах вэ гэсэн нэг асуулт байна.

*Эцэст нь*, төрөлжсөн гудамж төсөл гээд нэг юм явж байх юм? Энэ бүхнийг яаж оруулсан юм бэ? Жишээ нь, Я.Санжмятав сайдын өгсөн, хамгийн чухал, жижиг дунд бизнес ороогүй байна. Яагаад гэсэн асуулт байна.

**Н.Алтанхуяг:** - Өнөөдөр нөгөө бодлогын зөвлөлөө бүрэн бүрэлдэхүүнээрээ оруулаагүй нь энэ бол бодлогын зүйл дээр ярьсан гэдэг бол шийдвэр гарсан үг биш. Тэгэхээр энэ чиглэлийн ийм 70, 80 төрлийн юм орж ирснээс 20-иодыг нь эхний ээлжинд ингээд аваад явж байгаа. Процесс явж байгаа шүү гэдэг

агуулгыг хэлж байгаа юм. Энэ бол шийдвэр бас биш. Бодлогын зөвлөл ч эцсийн шийдвэрээ гаргахгүй. Засгийн газар ороод шийдвэр гаргана. Засгийн газраас гарсан шийдвэр бичгээр Улсын Их Хурлын даргад ирнэ. Тэр нь гишүүдэд тараагдах учиртай. Тэгэхээр бид нар нөгөө анхнаас нь ил тод байлгая, Их Хурлын гишүүдэд ил тод, ард иргэдэд ил тод байлгана гэдгээрээ явж байгаа процессоо л хэлж байгаа юм. Одоо энэ 20-иод юмнаас алиныг нь үлдээх вэ гэдэг бол тус бүрд нь үнэтэй, өртөгтэй, ач холбогдолтой нь ярьж байж шийдэх юм. Жижиг дунд бизнес ороогүй гэдэг нь жижиг дунд бизнесийг бид нар илүү. Үгүй яах вэ дээ одоо зарим юмнууд нь байгаа л даа. Нэгдүгээрт бид нар төсвийн мөнгөнөөс нэлээн их хэмжээ, тэгээд дээр нь бонд, дотоодын бондоос жижиг дунд үйлдвэрийг дэмжиж яваа. Нөгөө талаасаа энэ дотор төмөрлөгийн, экспортын чиглэлийн бас үйлдвэрүүд орж яваа. Тэр агуулгаараа бид нар түрүүчийн хэн нь асуулаа. Экспортыг аль зэрэг дэмжих гээд байгаа юм бэ гэж. Тэр чиглэлийн үйлдвэрүүдийг нь илүү зонхилсон. Тэгэхдээ бол эцэслэн шийдээгүй ингээд цаашаагаа яриад шийдэж болох байх.

**Та биднийг энд маргаж байхад олон айл өлмөн  
зөлмөн амьдарч, энэ УИХ, Засгийн газраас ядуурлыг  
бууруулах талаар юу хийх бол гэж хүсэн хүлээгээд  
сууж байгаа**

*2013 оны 04 сарын 16-ны Төрийн байгуулалтын Байнгын Хорооны хурлын тэмдэглэлээс: Ерөнхий сайдыг огцруулах тухай асуудал хэлэлцэх цээр.*

Байнгын хорооны дарга А.Бакей: - За одоо С.Дэмбэрэл гишүүн ярина уу.

С.Дэмбэрэл: -Баярлалаа. Өнөөдөр манай Улсын Их Хурлын гишүүд ажил хэргийн маш их идэвхтэй байгаад бол би их баярлаж байна. Гэхдээ өнөөдрийн асуудлыг ярихаасаа илүү та бүхний анхаарлыг дараагийн асуултад хандуулмаар байна. Яг та биднийг өнөөдөр ингээд яриад сууж байхад монголын эдийн засгийн байдал ирэх саруудад муудах нь ээ. Өнөөдөр мянга мянган бичил жижиг, дунд бизнесүүд мөнгө хайгаад, энэ бондоос горьдоод, санхүүгийн байдал сайжрах болов уу гээд бидэнд өшөө ямар тусламж, бодлогын дэмжлэг энэ 76 хүнээс гарах бол гээд хараад явж байна. Яг та бид нарыг энд сууж байхад олон айл өлмөн зөлмөн амьдраад, энэ ядуурлыг бууруулах талаар, энэ УИХ, Засгийн газраас юу хийх бол оо гэж хүсэн хүлээгээд сууж байгаа. Яг та бид нарыг өнөөдөр ингээд мэтгэлцэж байхад Монгол Улсын байгаль орчины хүндрэлтэй байдлууд олноороо гарч, цаашдаа энэ улсын хөгжлийг ямар зөв замаар явуулах бол доо эд маань гэж чагнаад сууж байгаа.

Түрүүн энд анх орж ирээд харж байхад, надад “Цогт тайж” киног үзэж байгаа юм шиг санагдсан. “Цогт тайж” кинон дээр ингэж хоорондоо

хэрэлдээд, удалгүй хоёр талаасаа сэлэм шүүрч аваад л үзэж тардаг шүү дээ. Ард түмний дундаа 76 мангар гэж ярьдаг юм байна лээ. Бид 76 уг нь мангар биш л дээ, гэхдээ бид тэгж хэлэх шалтаг өгөөд байна. Бидэнд Монгол Улсыг хөгжүүлэх, өсөлтийг нь зөв замаар явуулах даалгавар өгсөн. Та бүхний маргалдаж байгаа сэдэв чинь өсөлтийг нэг нь бууруулсан, нэг нь бууруулаагүй гэж ярьж байна.

Гэтэл өнөөдөр энэ өсөлтийг ярьдаг цаг биш. Яагаад гэвэл өсөлт чинь хөгжлийг хэмжих буруу хэмжүүр гэдгийг дэлхий нийт аль хэдийн хүлээн зөвшөөрөөд, огт өөр томъёолол, өөр стратеги гаргачихаад, түүгээрээ хэмжээд явж байхад бид өндөр өсөлт яриад, өндөр өсөлт нь намхан болчихлоо, энийгээ яахав, ийхэв гээд яриад явж болмооргүй байна. Тийм учраас ярих зүйлээ, жишээлбэл өнөөдөр бид 17 хувийн өсөлт, 20 хувийн өсөлт гэж бие биендээ онгирох уу, эсвэл өсөлтийн чанар нь айл гэрийн хаалгаар орж чадаж байна уу, үгүй юу, энэ өсөлтийг айл өрхийн хаалгаар оруулахын тулд Монгол Улсыг 20 жил удирдсан энэ хоёр нам юу хийж байна, хамтраад юу хийж байна гэдгийг л бид ярих ёстой.

Бахархаад байгаа тэр өндөр өсөлт чинь айлын гэрийн хаалгаар тэр болгон орж чадахгүй байна шүү дээ. Инфляци гээд ярьж байна. Инфляцийг бас л улс төрийн хэрэгсэл болгож байна. Хэрэв махны үнийг өсгөхгүй юмсан гэж бодож л байгаа л юм бол эндээс баталсан тэр бүх амьдралд тушаа болсон хөтөлбөрүүдийгээ хүчингүй болго л доо. Нэг кг тутамд 2 мянган төгрөг өгдгийгөө больчих. Малчин айлын хүүхдэд нь стипенд өгдгөө больчих. Цааш цаашдаа махны үнэ чинь өсөхөөс өөр аргагүй. Зөвхөн тогтворжуулах асуудал дээр л хувийн хэвшилийнхэнтэйгээ ярихгүй бол, төрийн капитализмын хамгийн муу хувилбарыг бид нар хамт суугаад бүтээж байна шүү.

Өөрөөр хэлбэл, төрийн оролцоог хэт их шүтсэн, төрийн зохицуулганд ямагт дулдуйдсан энэ харьцаа өнгөрсөн 20 жилийн туршид байсан, одоо ч үргэлжилсээр байна. Хэн хэнийгээ муулах вэ дээ. Өнгөрсөн 20 жилийн түүхийн сайн нь ч танай хоёр намд хамаатай. Муу нь ч танай хоёр намд хамаатай. Тийм учраас цаашдаа энэ улсыг хөгжүүлэе гэж бодож байгаа л юм бол хүмүүс рүүгээ хандсан, нийгмийнхээ олон төрлийн хэсэг, бүлэг бүр рүү хандсан ийм үйл ажиллагаа явуулахгүй бол та нарын жолоодлогоор Монгол Улс эцэг төртэй, халамжийн эдийн засагтай орон болж хувирсан. Одоо ч халамжлах арга чинь бас дуусаагүй үргэлжилсээр л байна.

Тийм учраас энэ асуудал дээр хэн нэгэн хүнийг огцруулах гэхээсээ илүү цаашдаа Монгол Улсыг авч явдаг хоёр нам нь хоорондоо хэл амаа олоод явах нь зөв. Мэдээж хэрэг, бие биенийхээ дутагдлыг нууж болохгүй. Гэхдээ хамгийн гол нь нэг зүг рүү харж, энэ улсын ард түмэнд нь, тэр сонгогчдод нь тэр хүсээд байгаа ажлын байрыг нь, хүсээд байгаа ядуурлаас гарах боломжийг нь, хүсээд байгаа бизнесийг нь, нэг оронтой зээлийг нь, нэг оронтой инфляцийг нь бий болгоход хамтран ажиллах хэрэгтэй.

Би сургаал айлдаж байгаа юм биш, энийг чинь энгийн хүмүүс та бүхнээс хүсч байна. Үүнийг л ойлгох хэрэгтэй. Энэ өнөөдөр телевизээр гарна, нэг их сайхан харагдахгүй. Хэн нь ч телевизээр уран гоё цэцэрхлээ гэсэн дараа нь нэг л хөндий, хүйтэн байдлаар харьцдаг. Тийм учраас та бүхэн минь, хоёр том нам маань, өнгөрсөн 20 жилийн жаргал зовлонг

хоёулангий нь авчирсан хоёр нам маань хоорондоо учраа олоод, цаашаа ажиллаач ээ. Энэ ирж байгаа саруудад их хэцүү байдалд орно шүү. Тийм учраас энэ асуудлууд дээр та нар нэгдсэн бодолтой байгаач ээ. Баярлалаа.

**Ерөнхий сайдад зөвлөгөө өгөх шаардлага бий.  
Би сөрөг хүчин шиг огцруулья гэхгүй, сайжруулах л юм ярина.**

*“Өнөөдөр сонинь сурвалжлагч 2013 оны 04-р сард УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлтэй цаг үеийн сэдвээр хийсэн ярилцлага:*

- Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг МАН-ынхан оруулаад санал хураахын өмнөхөн завсарлага авсан. Түүнийг огцруулах үндэслэлийг Та хэр бодиттой гэж үзэж байна вэ?

- Үндэслэлтэй нь танилцах шаардлага надад байхгүй. Надад Засгийн газрыг үнэлэх өөрийн үнэлгээ бий. Зөвхөн Засгийн газрыг хамтран байгуулсан ИЗНН-ын гишүүний биш, эдийн засагч хүний үүднээс байгуулагдсан цагаас нь хийж буй ажил, үйл ажиллагааг мэдэж байгаа. Бизнес, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах реформд оролцоод явж байна. Ерөнхий сайдын хувьд дутагдал бий. Гэвч улсынхаа цаашдын эрх ашгийг бодох нь чухал. Гэхдээ энэ нь Засгийн газрын дутагдлын хажуугаар дуугүй өнгөрнө гэсэн үг биш. Ирэх долоо хоногт Н.Алтанхуягийг огцруулах асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэх үед Засгийн газар юуг дутуу анхаарч байгаа, Ерөнхий сайдын хувьд Н.Алтанхуяг юун дээр анхаарах ёстой талаар бодол, саналаа хэлэхээр бэлдсэн.

- Ерөнхий сайд, Засгийн газарт Та ямар зөвлөгөө өгөх гэж байгаа юм бэ?

- Оны хоёрдугаар улирлын эцсээр макро эдийн засгийн тогтвортой байдалд сөрөг нөлөө гарч, төсвийн орлого нэлээд хэмжээгээр дутахаар байгаа. Тиймээс төсвийн биелэлт, бодлогын реформ чухал. Ганц хөлтэй эдийн засгийг олон хөлтэй болгох талаар Засгийн газрын ажил жаахан удааширч байгаа. Мөн жижиг, дунд үйлдвэрлэлээ дэмжиж, баялаг бүтээгчдэд санхүүгийн эрх чөлөө, таатай орчин бүрдүүлэх ёстой. Зээлийн хүү, инфляцыг нэг оронтой тоонд барих талаар Засгийн газрын баримталж буй бодлогод ч алдаа бий. Өмнө нь инфляцын нийлүүлэлтийн тал дээр Засгийн газар, Монголбанк хоёр хамтарч ажилладаггүй байсан. Одоо бол санхүүжилтийн схемийг хамтарч боловсруулаад, нийлүүлэлтэд садаа болж буй зүйлийг арилгахаар ажиллаж байна. Гэхдээ ингэлээ гээд зээлийн хүү болон инфляц нэг оронд орчихгүй. Тиймээс мөнгөний бодлогоо өөрчлөх ёстой. Үүний тулд инфляцыг онилох зорилтоо зэрэгцүүлж, эдийн засгийн оролцоотой өсөлтийг анхаарах нь чухал. Бодлогын хүүг ямар хэмжээнд хүргэн бууруулж, банкны салбарт яаж өөрчлөлт хийх, заавал байлгах нөөцийн доод хэмжээг хэрхэн уян хатан байлгахыг ярина. Н.Алтанхуяг гэдэг хүний макро алсын хараа муу байна. Эдийн засгийн хөгжлийн бүх асуудлаа Н.Батбаярт, хууль эрх зүйн шинэчлэлээ Х.Тэмүүжинд, байгаль орчны асуудлыг С.Оюунд хариуцуулчихаад УИХ дээр асуулт тавихад тэд

өмнөөс нь хариулдаг. Ядуурлыг бууруулахын тулд зөвхөн ажлын байр нэмэгдүүлээд болчихгүй. Үүнийг ганцхан Я.Санжмятавын яаманд даалгаад шийдчихгүй. Ядуурлын олон төрөл бий. Сэтгэлгээний ядуурал ярихаар халамжийн системтэй холбогдоно. Хавтгайрсан халамжаас татгалзсан ч гэсэн нуугдмал хэлбэрт шилжчихээд оршоор байна. Хүүхдийн мөнгийг би нуугдмал халамжийн систем гэж үздэг. Халамжийг мод тарих, хүүхдээ вакцинд хамруул гэх мэтийн тодорхой нөхцөл тавьж, биелүүлсэн хүнд нь олгодог байх учиртай. Санхүүгийн салбар ч олон хөлтэй байх ёстой. Банкны салбар үүний 95 хувийг эзэлдэг байж таарахгүй. Тус салбарт өрсөлдөөн бий болгохын тулд гаднын хөрөнгө оруулалтыг хэрхэн татахыг ч Ерөнхий сайд анхаарах ёстой. Чуулган дээр гишүүд асуулт тавихаар Ерөнхий сайд макро түвшинд ярьдаггүй. Өмнөөс нь сайд нар хариулдаг. Үүнийгээ “Би сайд нартаа итгэдэг” гэж тайлбарлах байх. Уучлаарай, гэхдээ “Итгэ, бас удирд.” гэж хэлмээр байна. Сайд нар сайн, гэхдээ Та илүү сайн байх ёстой. Энэ талаас нь Ерөнхий сайдад зөвлөгөө өгөх шаардлага бий. Би сөрөг хүчин шиг огцруулъя гэхгүй, сайжруулах л юм ярина.

- Цалин, тэтгэвэр нэмэхгүйгээр, аж ахуйн нэгжүүдэд дэмжих замаар үүнийг хөөрөгдлийг зохицуулах Засгийн газрын бодлогыг буруу гэж сөрөг хүчин үзэж байгаа. Та үүнийг юу гэж үзэж байна вэ?

- Төрийн албан хаагчдын бүтээмж, гүйцэтгэлийг нэмж байж энэ тухай ярина уу гэхээс, гурван тал суугаад шийдвэр гаргадаг хуучны хандлагаас татгалзах ёстой. Одоо цалин нэмэх биш, хэмнэлтийн горимд шилжих цаг. Тодорхой хэдэн бүтээгдэхүүн дээр санхүүжилтийн схем бий болгох ёстой. Аливаа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах ганцхан арга бий. Энэ бол нийлүүлэлтийг чөлөөтэй, өрсөлдөөнтэй болгох. Санхүүгийн зах зээлд ч энэ зарчим хамаарна. Банкуудтай өрсөлдөх байгууллагууд гарч ирэхэд л банкны зээлийн хүү, инфляц буурна. Үүнийг л би Ерөнхий сайдын алсын хараа гэж хэлээд байгаа юм.

- Гадаадын хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлт буурсныг МАН-ынхан Ерөнхий сайдын бодлого буруу байгаатай холбосон. Ерөнхий сайд болохоор “Анх хүлээж авсан эдийн засгийн нөхцөл хүнд, өмнөх Засгийн газрын үед тавьсан зээлийн ачааг одоо үүрч байна” гэсэн. Хэн нэгнийх нь буруу юү, эсвэл 50:50 хувьтай юү?

- Одоо улс төр л явж байна. Эдийн засгийн өсөлт 17 байснаа 10 хүртэл шалчийтал уналаа гэв. Унахад яадаг юм. Бидэнд бодит байдлыг маань л мэдрүүлж байна шүү дээ. Ганц, хоёрхон бүтээгдэхүүн дээр суурилсан эдийн засгийн өсөлт дээр хамаг аз жаргалаа төсөөлөөд байна. Тэгвэл “Энэ худлаа, би өөрчлөгддөг шүү.” гэсэн сургамжийн дохио л хангинаж байгаа нь энэ. Түүнээс хэн нэг хүн өсөлтийг 17-оос 10 хувь болгоод буулгачихаагүй. Биднээс хамаарахгүй шалтгаанууд бас бий. Хамгийн том хөрш, БНХАУ-ын дотоод зах зээлд болж буй үйл явцтай ч холбоотой. Ер нь алийн болгон Засгийн газар, улс төрийн намууд эдийн засгийн зөвхөн өсөлтийг харах юм. Дэлхий дахинд оролцоотой эдийн засгийн тухай ярьж байна. Эдийн засгийн чанар, агуулга чухал. Өсөлт 10 хувь байж болно. Гэтэл түүнд жижиг бизнес эрхлэгчид, баялаг бүтээгчид хэр оролцож чадаж байна вэ? Тэдний оролцоотойгоор баялаг бүтээж, үйлчилгээ хөгжиж, зах



зээл идэвхжиж байгаа бол 10% гэдэг чинь чанар мөн болно. Үүнд анхаарч, баримтаа гарга, хариултаа өг гэж аль аль талд нь хэлье.

- Засгийн газрыг бүрдүүлж буй олонх болох АН-ынхан бодит ажил хийхээсээ илүү шоудах нь давамгайлж байна гэсэн шүүмжлэл бий. Нүүрсний үнийг буулгахдаа Ерөнхий сайд өөрөө шуудайтай нүүрс үүрч байгаа нь таатай харагдаагүй. Та энэ шүүмжлэлийг бодит гэж үзэх үү?

- Шоудах ч юм байгаа л даа. Гэхдээ би нүүрс үүрснийг шоудсан гэж үзэхгүй. Тодорхой зүйлийг барьж аваад, үнэ өссөнийх нь учрыг олох гэж оролдож буй “судлаач залуу” гүйгээд байгаа юм.

- Одоо сэдвээ танай нам руу хандуулъя. Ерөнхийлөгчийн сонгууль хаяанд ирлээ. ИЗНН-ын Үндэсний хорооноос энэ сонгуульд анх удаагаа дангаар оролцох шийдвэр гаргасан юм билээ. Нэр дэвших магадлалтай хүмүүсээр С.Оюун гишүүн та хоёрыг нэрлэж байгаа...

- Эцсийн шийдвэр гараагүй шүү дээ. Дараа сарын эхээр Үндэсний хороо дахин хуралдаад эцсийн шийдвэрээ гаргана. Миний нэр дэвших тухайд бол, би аль эрт тодорхой хэлчихсэн. Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших түвшний хүн хараахан биш, одоогоор тэр хэмжээнд хүрч, бүрэн боловсроогүй байна. Эхлээд УИХ-ын гишүүнийхээ ажлыг хийж суръя, би чинь бас төгс төгөлдөр хүн биш шүү дээ. “Засгийн газарт орж ажиллах уу” гэж надаас асуухад ч, “Эхлээд энэ ажлаа хийж суръя.” гэж хэлсэн. Одоо л энэ ажил минь гарт орж эхэлж байна. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт манай намын 40 гаруй заалт орсон. Үүнийгээ 2016 он хүртэл хэрэгжүүлж, намынхаа үйл ажиллагааг бэхжүүлэхийн төлөө л ажиллана.

- ИЗНН-ынхан дотроо хагаралдаж эхэллээ. “Иргэний зориг” гэдэг жигүүртэй болсон байна лээ. Тэд намаа нэг хүнийх боллоо, шинэчлэх шаардлагатай гэж үзэж буй юм билээ?

- Аливаа намд дотоод ардчилал чухал. Саяхан Үндэсний хороо хуралдахад дэд дарга Х.Бат-Ялалт ажлаа хүлээлгэж өгье гэсэн, ерөнхий нарийн бичгийн дарга С.Жаргал намын бусад гишүүдийнхээ итгэлийг даагаагүй учир солигдсон. Тэр хүмүүс юу ч бодож болно. Гэвч гол дутагдал нь үргэлж арагшаа харж явсанд л байсан. Нам урагшаа харж, цаашид юу хийхээ бодож л ажилладаг. Мөрийн хөтөлбөрт тусгасан олон зорилгоо хэрхэн хэрэгжүүлэх талаар оюунаа уралдуулах ёстой. Гэхдээ хүмүүс үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь ногоон үзэл, эрх чөлөөг тунхагладаг намд бол хэвийн зүйл юм. Гэвч гүтгэх, шоудах байдлаар үндэслэлгүй зүйл ярьж болохгүй. Нэг хүний нам, сонгуулиар өөр намаас мөнгө авсан гэх мэт яриа нь тэдний л бодол. Намын олон гишүүн, дэмжигчид үүнийг ялгаж, салгаад өөр өөрийнхөөрөө хүлээж авах байх. Энэ хоёр хүний хэлж буй үг, авир намыг хөдөлгөөнд оруулсан сайн талтай. Гэхдээ шударга үнэний шалгуурын хүрээнд л асуудал өрнөх ёстойг мариаж болохгүй.

## **Эцсийн бүлэгт түших ганц юм чинь баялаг бүтээгчид шүү дээ**

*“Зууны мэдээ” сонины “Ярилцах цаг” нэвтрүүлгийн сурвалжлагч Ж.Цогзолмаа УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлтэй 2013 оны 04 сарын 17-нд ярилцлаа. Мөнгөний бодлого болоод төсөв санхүү, улс төр “буцалсан” энэ үед тэрээр байр сууриа ийн илэрхийлжээ.*

- Парламентын гишүүн боллоо. Ингэхээр эдийн засгийн бодит дүр төрхийг шилний цаанаас харахаа больж байх юм уу. Ер нь ямар харагдаж байна даа?

- УИХ-д мэдээлэл тааруу байна. Салбар бүрийн компаниудын мэдээлэл Үндэсний статистикийн хорооны тайланд ч бага байдаг юм байна. УИХ-ын үйл ажиллагаа нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны тал дээр учир дутагдалтай байна. Компаниудын саналыг авдаг эерэг хандлага ажиглагдаж байгаа ч угаасаа хууль тогтоомжийг батлахад тэдний саналыг бодитоор тусгах, өргөн хэмжээнд харилцан ярилцсаны үндсэн дээр зөв, бурууг нь мэдрүүлэх, мэтгэлцүүлэх зүйл их дутдаг юм байна. УИХ-д ажиллаж байгаагийн хувьд хувийн хэвшлийнхний байр суурийг хууль тогтоомжид тусгуулах, бодлогын өөрчлөлтүүдэд оруулах зүйлсийг хэрээрээ хийж л байна.

- Төсөв, мөнгөний бодлого яригдаж байна. Мөнгөний бодлого иргэдийн амьдралд буух болов уу?

- Мөнгөний бодлогод Монголын банкуудын холбоо, Банк бус санхүүгийн холбоо, бусад холбоодын саналыг авдаг хэрнээ тусгах нь дутмаг байгаа. Хувийн хэвшлийг гололгүйгээр, тэднийг think tank гэж ойлгох бодлогын сэтгэлгээ дутаж байна. Зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулна, санхүүгийн реформ хийнэ гээд л яригдаж байна. Үүний тулд Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо юм хийгээд л байгаа сурагтай. Гэтэл энэ чиглэлд Монголын банкны холбоо, Банк бус санхүүгийн холбоо, Санхүүгийн зах зээлийн холбоо, Даатгалын холбоо, Хадгаламж зээлийн хоршоодын холбоо юу бодож байна гэдгийг нь тусгах зорилгоор Эдийн засгийн байнгын хороонд тогтоол гаргуулахдаа Санхүүгийн салбарын реформ болон зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулах альтернатив буюу зэрэгцээ хувилбар гаргаж ирэх ажлын хэсэг байгуулж, би өөрөө ахалж ажиллаж байна. Ирэх сарын 15 гэхэд бид саналуудаа гаргаж ирнэ. Үүний үндсэн дээр УИХ-ын гишүүдийн ширээн дээр хоёр зүйл очих ёстой. Нэг нь, УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооноос өгсөн даалгаврын дагуу Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны боловсруулсан зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулах санал, нөгөө талд нь манай ажлын хэсгийн материал байх юм. Үүгээрээ гишүүдийн дунд хэлэлцүүлэг өрнүүлж, эндээс Монгол Улсын 2014 оны мөнгөний бодлогод тусгах, санхүүгийн салбарын реформыг эхлэх бодлогын баримт бичгүүд гарах ёстой.

- Ер нь хувийн хэвшлийнхний саналыг хуульд тусгахгүй байна гэж эдийн засагчид байнга хэлдэг. Тэдний санал хуульд тусгалаа олддоггүйн шалтгаан нь юу юм бэ?

- Дотор нь ороод харахад, санаатай, санаагүй гэж юм алга. Ерөөсөө л энэ чинь бидний бодлогын соёлын төвшин байхгүй юу. Одоо дэлхий даяараа, хүнийхээ, ард иргэдийнхээ дуу хоолойг сонсдоггүй нь муу засаглалын шалтгаан, үндсэн шинж гэдгийг хүлээн зөвшөөрч, нотолчихлоо шүү дээ. Хүнээ сонсдог, сайн засаглал хэрэгтэй юм байна гэдгийн томъёолчихсон. Үүний хүрээнд Улаанбаатар хотод оролцоог хангах ажлын хэсэг гэж байгуулагдаад байна. Оролцоо гэдэг чинь учир зүггүй хүмүүсийг цуглуулаад бай гэсэн үг биш. Хууль батлах гэж байгаа бол зайлшгүй энэ салбарынх нь дуу хоолойг сонсдог байх ёстой.

**-Зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулна гэлээ. Гэхдээ мөнгөний бодлого халамжаар хавтгайраад байвал зээлийн хүү нэг оронтой тоонд орох боломжгүй гэж банкныхан хэлдэг шүү дээ?**

-Инфляцийг онилоод байгаа ч, байндаа онохгүй байгааг би хэлсээр ирсэн. Гэхдээ би инфляцийг онилохоо бүрмөсөн боль гэж хэлэхгүй. Хажуугаар нь эдийн засгийн өсөлтийг давхар онилж л гэж байгаа юм. Дэлхий даяар, ажил эрхлэлтийг давхар онилдог жишээ бас их олон байна. Сүүлийн үед улс орнууд инфляцийг дангаар нь онилох гээд байдгаа больж, нэлээд уян хатан болгож байна. Зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулъя гэсэн бодлогын итгэл үнэмшил байгаа бол нийлүүлэлтийн тал дээр ажилла, хажуугаар нь жижиг, дунд болон бичил бизнесийг дэмжих төрийн мөнгөний бодлогыг гаргаж ирэх хэрэгтэй. Ингэснээр, эдийн засгийн өсөлтийг онилж байгаа хэрэг юм. Хүмүүсийг оролцуулдаггүй, зөвхөн уул уурхайгаас хамаардаг эдийн засгийн өсөлтийг биш, хүмүүс ажлын байрыг өөртөө болон өрөөл бусдад зориулан бий болгодог, оролцоотой эдийн засгийг хөгжүүлэх хамгийн энгийн механизм нь жижиг, дунд бизнесийнхэнд боломж сайн олгодог, таатай бодлогыг гаргаж ирэх ёстой. Үүний тулд арилжааны банкнид тавьж байгаа Төвбанкны шаардлагуудыг өөрчилж, уян хатан болгох замаар тухайлбал, бодлогын хүүг 0.5 хувиар бууруулснаа их юм хийчихлээ гэж хэлэх биш, 5-7 хувь хүртэл бууруулах ёстой. Бас банкуудын заавал байлгах нөөцийн доод хэмжээг ч хөшүүрэг болгосоор байна. Банкууд өөрсдөө мөнгө босгох боломжийг нь хангаж өгье. Хөгжлийн банкыг хар, бусад банкуудаасаа тасарчихсан, Сан болоод хувирчихсан. Өөрөөр хэлбэл, хэрэггүй юмаа чихдэг амбаар шиг болчих гээд байна. Гэтэл тэр нь банк л юм бол банкны системийн нэг хэсэг нь байх ёстой. Хуулийг нь өөрчлөөд үр ашиг талаас нь боддог зүйл байх хэрэгтэй.

**-Энэ жилийн мөнгөний бодлогод зээлийн хүүг бууруулж, инфляцийг нэг оронтой тоонд оруулна гэсэн байх аа?**

-Энэ жилийн мөнгөний бодлогод зээлийн хүүг гуравны нэгээр бууруулж, инфляцийг нэг оронтой тоонд оруулна гэсэн байна. Яг ийм байдлаараа бол бүтэхгүй. Өрсөлдөөн, мөнгө алга. Ганц хөлтэй эдийн засгийг тэтгэдэг байсан, салбар нь хямралтай байна. Эцсийн бүлэгт түших юм чинь баялаг бүтээгчид шүү дээ. Баялаг бүтээгч гэхээр “Эрдэнэт” мэтээр их томоор төсөөлөөд байдаг. ТҮЦ ажиллуулдаг хүн ч баялаг бүтээгч шүү дээ.

- Дараагийн асуултаа хөрөнгө оруулагчдын талаар тавьмаар байна. Хөрөнгө оруулалтын хуулийг өөрчлөх болохоор л гадаадынхан Монголоос гарчихъя, явчихъя гэх ухааны юм хэлдэг. Үндэсний үйлдвэрлэл рүү тэр бүр хөрөнгө оруулалт орохгүй байна. Ингэхээр Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин хэнд нь ээлтэй байна вэ?

- Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин хэнд ч ээлгүй байна. 2018 он хүртэл Монгол Улсын эдийн засгийн талаар эерэг төсөөлөл гарсан юм байна. Харин би тэгж харахгүй байгаа. Зөвхөн уул уурхайд бус, бүх салбарт хөрөнгө оруулалт дутаж байна. Одоо стратегийн гэж яриад байна. Гэтэл стратегийн чанартай бүтээгдэхүүн л гэхээс биш, стратегийн салбар гэж ярих нь хэр оновчтой юм бол. Одоо УИХ-д ганцхан заалттай хууль орж ирэх гэж байна. “Стратегийн хөрөнгө оруулалтын 100 саяас дээш босготойг нь УИХ-аар хэлэлцүүлнэ” гэж. УИХ-аар хэлэлцүүлэхгүй ч байж болно. Тэр заалтыг бүр авчихаж ч болно. Ингэлээ гээд хөрөнгө оруулалтын итгэл дахиад сэргэх юм уу. Миний бодлоор тэр хуулийг тэр чигт нь яаралтай хүчингүй болгох ёстой. Бас Хөрөнгө оруулалтын хууль хийж байгаа гэсэн. Энэ хууль нь миний бодлоор тодорхой салбарыг, ялангуяа шинжлэх ухааны багтаамж ихтэй, ажлын байр ихээр бий болгож байгаа, байгаль орчинд ээлтэй, цэвэр технологи хэрэглэдэг, Монголд дутагдаж байгаа зүйлсийг дэмжсэн сэдэл санаа, сэжим түлхэц хийсэн байх ёстой. Тэгэхгүй бол манай хуулиудыг харахад, голдуу торгууль шийтгэлийг нь анхаардаг юм билээ. Түүний оронд салбараар нь урамшуулсан бодлого хэрэгтэй. Сүүлийн үед манай хөрөнгө оруулалтын орчинд улсжих хандлага их ажиглагдаж байна. Тавантолгой дээр гэхэд төрийн өмчит компани байгуулаад, цаашдаа олон нийтийн болгоно гэсэн хэрнээ одоо хүртэл хувьцаагаа тараагаагүй байна. Ингэхийн оронд ерөөсөө л гадаад дотоодын хувийн хэвшлийг оруулбал яасан юм. Бид улсжаад, төрийн капитализмын хамгийн муу хэлбэрийн жишээ байж болохгүй. “Economy” сэтгүүлд “State capitalism” гэж нийтлэл гарсан, түүнд Монголыг бичсэн байсан шүү. Ингээд нүдэн дээр баялгийн хараалын шинж тэмдгүүд нь илрээд байна.

**- Тэгвэл хөрөнгө оруулалт зөвхөн уул уурхай руу явчихаад байгаагийн цаад учир нь юу юм бэ?**

- Бизнес, хөрөнгө оруулалтын орчин бохир байвал хөрөнгө оруулалт зөвхөн аль нэг салбар луу ордог. Ингэхээр авлига гэдэг зүйл амь бөхтэй дагаж л явдаг. Уул уурхайгаа хөгжүүлбэ гэхдээ, эдийн засгаа олон хөлтэй болгоё. Солонгосон эдийн засагтай болъё. Эхлээд энэ талын хөтөлбөр, эрх зүйн үндсийг бий болгох хэрэгтэй. Жишээлбэл, жижиг, дунд үйлдвэрлэл байна. Энэ салбарт нөгөө бондын мөнгөнөөсөө 200 саяыг нь өгчихөөчээ гэж бид гуйгаад байна. Нэг дүүрэгт зээлийн хороо 11 хүнтэй байлаа гэхэд нэг л хүн нь хувийн хэвшлийнх, бусад нь төрийн төлөөлөл байна. Ийм байхад яаж ажил явах вэ дээ. Төр, хувийн тэнцүү тооны төлөөлөлтэй байх хэрэгтэй. Хөрөнгө оруулалтыг авлигаас хол байлгая гэвэл хамгийн гол нь ил тод засаглалын механизмыг бий болгох ёстой.

**- Орон сууцны шинэ хөтөлбөрөө Засгийн газар танилцуулж ам метр талбайн үнийг нэг сая төгрөгт, зээлийн хүүг нь 8-9 хувьд байлгана гэсэн. Хэрэгжих боломжтой юм уу?**

- Энэ бол боломжтой гэхээсээ илүү хийгдэх ёстой ажил. Өнөөдөр энэ талын санхүүгийн боломжийн орчин байхгүй байна. Моргэйжийн тогтолцоо нь сайн засаглалын системд л бий болох ёстой. Нөгөө талаар барилгын материал, барилга эхлүүлэх үйл явцыг ярих ёстой. Барилга эхлүүлэхэд 140 гаруй гарын үсэг цуглуулдаг байсныг 70 гаруй болгосон. Энэ хангалттай биш. Орон сууцны үнийн хөөсийг яах юм. Хэн нь худалдан

авах чадалтай, хэн нь чадалгүй юм. Санхүүгийн урт хугацааны тогтвортой байдлыг хангаж чадах уу. Энэ системийг оруулснаар Монголын санхүүгийн тогтвортой байдал, арилжааны банк, систем бүрдүүлэгч арилжааны банкууд, санхүүгийн бусад институцуудын хэмжээнд яаж хэрэгжих вэ гэдгийг ярьсан зүйл УИХ-д байхгүй л байна. Хямд орон сууцтай, зохистой санхүүжилтийн схемийг нийт санхүүгийнхээ системд ямар байр эзлэхийг, эерэг, сөрөг нөлөөг нь харсан бодлогоо гаргасан уу гэдэг асуултыг би тавина. Хүнд таалагдах гэж ярихын оронд гэр хорооллыг дахин төлөвлөж байгаагийн цаадах 140 мянган жорлонгийн дор байгаа хөрсний бохирдлыг яах юм, усны асуудлаа яах юм гэдгээ ярихгүй байна. 8-9 хувийн зээл байж болно оо. Харин түүнийг чинь худалдаж авах өнөөх жижиг, дунд болон бичил бизнесийнхэн тойргийн гадна орхигдчихсон байна. Тэдэнд бараг мөнгө олдохгүй байна. Барилгын томчуудад нь ч хөшүүрэг алга.

**- Асуултаа улс төр лүү хандуулъя. Танай намын Үндэсний Хорооны хурал болсон. Бүтцийн өөрчлөлт хийлээ. Та үүнд ямар байр суурьтай байна?**

- Энэ бол улс төрийн намд байдаг л зүйл. Ерөнхий нарийн бичгийн дарга байсан нэг хүнд Үндэсний хорооны ихэнх гишүүд итгэл үзүүлж чадахгүй нь гээд, тодорхой хэмжээний зохион байгуулалтын өөрчлөлт орсон. Миний итгэж байгаагаар, энэ нам асуудлаа дотроо ардчиллын замаар шийдээд явахаас гадна нийгэмд хэн бэ гэдгээ харуулах нь л чухал. 2016 он хүртэл энэ нам байна, зорилтынхоо төлөө ажиллаж байгаа гэдгээ харуулах нь бидний үүрэг. Түүнээс биш дотроо толхилдох нь онц чухал зүйл биш.

**- Танай намын Ерөнхий нарийн бичгийн дарга асан С.Жаргал “Манай нам нэг хүнийг тойрсон байдлаар яваад байна” гэж ярьсан байна лээ?**

- Нэг хүнийг тойрохгүй бол хэнийг тойрох юм. Баг бүр удирдагчтай байж л явна шүү дээ. Хувь хүн гэдэг талаас нь хүндлэхгүй юм гэхэд, улс төрийн капитал гэдэг талаас нь харах хэрэгтэй. Бидний дунд байгаа, цуцалтгүй зүтгэлээр улс төрийн их туршлага хуримтлуулсан “С.Оюун” гэдэг капиталыг дэмжих л ёстой. Бас намын удирдлагаа ч идэвхжүүлэх ёстой. Тэр талаас, би С.Жаргал, Х.Бат-Ялалт нартай санал нэг байна. Ялангуяа, Х.Бат-Ялалттай. Гэхдээ би тэдэнд “Хойшоо хэтэрхий их хараад байна шүү. Урагшаа харж явъя” гэж байнга хэлдэг байсан. Хүмүүс ч тэгж боддог юм билээ. Тэгэхээр энэ бол зүгээр С.Оюуныг тойрсон бүлэглэл биш эрх чөлөөний, ногоон хөгжлийн үзлийг өөртөө тээсэн энэ намын урагшаа явах үйл явцад гарч байгаа зүйл. Ногоон хөгжил гээд ярихад С.Оюун ганцаардаж байна шүү дээ, үнэнийг хэлэхэд. Тиймээс ч ногоон хөгжлийг дэмжсэн бодлогын шинэ уур амьсгал бий болгох хэрэгтэй байна.

**- Энэ сарын сүүлээр танай намын Үндэсний хороо дахиад хурлаа хийнэ. Энэ хурлаас ямар өөрчлөлт гарах бол. Таны хүлээж байгаа үр дүн цухалзах болов уу?**

- Би Намынхаа Үндэсний хороонд тайлан тавьсан л даа. УИХ-д Иргэний Зориг Ногоон Намыг төлөөлөн сууж байгаагийн хувьд бид ийм юм хийлээ, цаашдаа ийм юм хийе. Нам дээрээ бүтэц бий болгоё гэж байгаа. Орон нутагт ч бүтцээ хийе гэдгээ хэллээ. Бодлогоо нэгтгээд Ерөнхий нарийн бичгийн дарга аваад явах ёстой. Бас УИХ-д сууж байгаа хоёр гишүүн болон Үндэсний хорооны зуун хэдэн гишүүн үнэт зүйлээ урагшаа авч явах үүрэг

хүлээчихсэн байгаа. Цаашдаа Иргэний Зориг Ногоон Намын үйл ажиллагаа маш идэвхжинэ. Монголын нийгэм өөрөө үүнийг шаардаж байна. Ногоон хөгжил гэдэг хүн бүрийн амьдралд шаардагдаад байна, нийгмийг ийшээ түлхэх улс төрийн уриалгыг Иргэний Зориг Ногоон Нам л гаргах ёстой.

**- Ерөнхийлөгчийн сонгууль хэдхэн сарын дараа болох гэж байна. Танай нам хэнийг сойх бол?**

- Иргэний Зориг Ногоон Нам хурлаа хийнэ, үүнийг хэлэлцэнэ. Нэг хэсэг хүмүүс “Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдье. Ялахгүй ч гэсэн манай намын нэр хүндэд хэрэгтэй. Намаа сурталчлах сайхан боломж гарна.” гэж байна. Нөгөө хэсэг нь “Ардчилсан намтай нэг засагт байгаа юм чинь хамтарч орсон тунхаглалынхаа үзэл санааг дагаад Ардчилсан намаас дэвшүүлсэн хүнийг нь буюу одоогийн Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийг дэмжье.” гэж байна. Энэ бүхнээ мөдхөн болох үндэсний зөвлөлдөх хорооны хурлаараа сайхан яриад шийдчихнэ. Аль ч тохиолдолд олонхийн саналаар шийднэ. Бид Монгол Улсын бодит байдлыг харах ёстой. Ямар ч гэсэн миний харж байгаагаар С.Оюун бүрэн боломжтой. Гэхдээ ярилцлагуудаас үзэхэд тэр өөрөө “Үгүй” гэж байгаа. Эцсийн дүнд Үндэсний хороо л шийдвэрийг гаргадаг. 2016 онд энэ нам УИХ-д хоёр биш, бүлгийн хэмжээнд ажиллахад энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгууль хэр зэрэг эерэг нөлөөлж чадахыг тал талаас нь дүгнэх ёстой.

**- Тэгвэл бие даагчаа өрсөлдүүлэх үү. Эсвэл үнэхээр Ардчилсан намын нэр дэвшигчийг дэмжих гээд байна уу. Та юу гэж харж байна. Танд дуулсан цуу байна уу?**

- Одоо зүгээр л аар саар ярианы хэмжээнд явж байна. Ерөнхийлөгчийн сонгуульд бие даагч өрсөлдүүлэх үү, эсвэл бусадтай нийлж Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх эрхтэй МАН, Ардчилсан нам, Шударга ёс эвсэл гэсэн гурван субъект л байна шүү дээ. Энэ гуравтайгаа ярих уу, эвсэх үү гэдэг нь Үндэсний хороогоор л шийдэгдэнэ. Ардчилсан зарчмаар.

**- Танай нам дотор таныг өрсөлдүүлье гэсэн яриа гарсан гэж дуулсан. Энэ үнэн юм уу?**

- Улс төрийн хувьд би шинэ хүн. УИХ-ын гал тогоонд би шинэ уур амьсгал оруулдаггүй юм гэхэд, өөрийнхөө баримталдаг үнэт зүйлийн зарчмын дүнд, хамтын ажиллагаагаар хийх юм их байна. Гүйцэтгэх засаглалд намайг оруулъя гэхэд нь ч би: “Би эхлээд УИХ-ын гишүүн гэдэг ажлаа хийж суръя.” л гэж хэлсэн. Энэ бол кнопоо дарахыг хэлж байгаа юм биш, олон жил ярьж бичиж байсан зүйлсээ энэ институци /бүтэц, бүрэлдхүүний/ дотор ороод, хэрэгжүүлэх ажлаа хурдан хийе л гэж байгаа юм. Би ямар ч гэсэн эхний алхмуудаа хийгээд явж байна. Би олон түмэнд танигдсан гэхээсээ, ажил хэргийн хүрээнд илүү танигдсан хүн. Надад Ерөнхийлөгчид өрсөлдөх хэмжээний туршлага байхгүй. Би тийм хэмжээнд очтол төлөвшиж чадаагүй байна. Тиймээс би угаасаа өрсөлдөхгүй гэж хэлсэн. Надад хийх ажил их байна. Би даруу зан гаргаж байгаа юм биш. Энэ улсыг улс төрийнх нь талаас, нийгмийн талаас, ёс суртахууны талаас, шүүх засаглалынх нь талаас удирдах туршлага С.Дэмбэрэл гэдэг хүнд байхгүй.

**- Тэгвэл танд нэрлэх хүн байна уу?**

- Байхгүй. Тухайн үед нь л хэлье.



**- Ерөнхий сайдыг огцруулах тухай яригдаад байна. Та үүнийг юу гэж харж байна?**

- Энэ бол хоёр том намын хоорондын асуудал. Н.Алтанхуяг гэдэг хүн нүүрстэй шуудай бариад явахыг, зах дээр хүмүүстэй уулзаад явахыг нь, сар бүр 222 гэдэг уулзалтад юм яриад явахыг нь би харсан. Эндээс харахад энэ хүн сайн зөвлөхүүдтэй бол Монгол Улсад тодорхой юм барьж авах гээд байна гэдэг нь харагдсан. Гэвч нэг жижигхэн шүүмжлэл хэлэхэд, шуудайтай нүүрс барьж явах нь зөв өө. Гэхдээ энэ улсад чинь Ерөнхий сайд нь хардаг нэг макро /том/ бодлого гэж бий. Тэгэхээр, зөвхөн тэр чиглэлийн сайд нартаа найдалгүйгээр, өөрөө тэр талд анхаармаар санагдсан. Санхүүгийн салбарын реформын тухай Ерөнхий сайдын амнаас гарах л үг. Огцруулах шалтгааныг нь би мэдэхгүй. Алдаа гаргаж байгааг нь бол мэднэ. Гэхдээ реформын чиглэлээр ажиллаад байгааг нь ч мэднэ. Би хувьдаа энэ Засгийн газрыг огцруулна гэвэл, гараа өргөхгүй.

**- Томилгооноос болоод энэ яриа гарч эхэлсэн биз дээ. Таны хувьд энэ шалтгаан мөн үү?**

- Томилгооны асуудал аль ч Засгийн газарт байдаг шүү дээ. Гол нь энэ хүн түүнийг цэглэж чадсан уу гэдэг нь асуудал. Миний хувьд, энэ хүн цэглэж чадаагүй. Монгол Улсад төрийн албан хаагчдыг намаар нь, төрөл садангаар нь ялгаварладаг байдал хэвээрээ л байна. Үүнийг зогсоох ёстой. Улс төрийн намуудын энэ байдал үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хэмжээнд хүрсэн учраас Ерөнхийлөгч энэ тал дээр шийдвэртэй арга хэмжээ авах ёстой гэж би хэлж байсан. Ерөнхийлөгч ч хэлсэн. Би хувьдаа, Н.Алтанхуягийн эхлүүлсэн ажлыг нь үргэлжлүүлэх саналтай байна.

### **Намуудыг төрийн дээрээс буулгах ёстой байтал, оруулж ирсэн хууль чинь байдлыг улам гүнзгийрүүлэх нь байна.**

*2013 оны 05 дугаар сарын 01-ны өдөр хуралдсан Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээс: “Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл хэлэлцэх цээр*

С.Дэмбэрэл: Намууд төрийн дээр гараад байна гэж байна. Тэгэхээр энэ оруулж ирж байгаа хууль чинь төрийн дээр гарах намуудын одоо байгаа байдлыг улам гүнзгийрүүлэх гэсэн юм шиг зүйл ойлгогдоод байна. Уул нь бид чинь Намуудыг төрийн дээр гаргах биш, төрийн дээрээс буулгах хэрэгтэй. Тийм л зорилгоор гурван ажлын хэсэг байгуулагдсан гэж би ойлгосон юмсан. Эсвэл энэ гэр бүлийн тухай хуулинд өөрчлөлт оруулмаар юм уу гэж санагдаад байна шүү. Аль нэг гэр бүлийн нөхөр нь, эрх баригч намын гишүүн бол тэр гэр бүлийн хэрүүл шүүхээр шийдэгдэнэ гэж өөрчилчихмөөр юм уу? Өөрөөр хэлвэл, нийгмийн амьдрал руу, улс төрийн намуудын сайн төлөвшөж чадаагүй байгаа харилцааг, тэр дундаа нийгэмд тэр болгон сайн зүйл өгч байгаагүй энэ бүтэц, зохион байгуулалтын хэлбэрийг ингэж улам гүнзгийрүүлэхээр оруулж ирэх гээд байна. Тийм учраас сая үг хэлсэн

хүмүүстэй би санал нэг байна. Тэр ажлын хэсэгт нь санал болгоод л өгчих. Энэ саналуудыг авах гэж л ажлын хэсэг байгуулагдсан биш үү? Жишээлбэл, Үндсэн Хуулинд өөрчлөлт оруулах эсэх тал дээр бол би, Цог гишүүнтэй санал нийлж байгаа. Шууд тэгж заасан л байгаа бол жагсаалт гэдэг чинь таарахгүй байна. Энэ чинь үндсэн хуулийг өөрчлөх нэг шалтгаан биш юм уу? Эдийн засаг дээр, сүүлийн үед өмчийг улсчлах бодлого яваад байгаа. Үндсэн хуулинд ингэж заагаагүй гэж үзэх шалтгаанууд гарч ирээд байгаа. Цаанаа нэлээд хууль зүйн үндэстэй ч байж магадгүй. Наад хууль чинь миний хар ухаанаараа ойлгож байгаатай ижилгүй юм байна. Энийг ажлын хэсэгт өгөөд, ийм заалтыг өөрчлөх ёстой байна, энэ дээр ингэлээ гээд явчих. Өнөөдөр энийг хэлэлцэхгүй гээд шийдэхэд энэ улсад юу ч болохгүй. Ийм л саналтай байна. Ач холбогдол нь харагдахгүй байна...

**Мөн өдрийн хуралдаанаар “Олон нийтийн радио, телевиз дээр зарим хуулийн хэрэгжилттэй танилцсан дүн”-г хэлэлцсэн бөгөөд энэ хуралдаан дээр УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл:**

- Асуулт асуух гэсэн юм. Олон нийтийн телевизийн үндэсний зөвлөлийн төсөв гэж байдаг уу? Төсвийг хэн баталдаг вэ? Төсөв гэж өөрийн үйл ажиллагаагаа явуулах үндэсний зөвлөл үйл ажиллагаагаа явуулах төсөв гэж байдаг юм болов уу? Байдаггүй юм болов уу? Хэрэв байдаг бол хэн баталдаг вэ? Хоёрдугаар асуулт, бас л үндэсний зөвлөлөөс асууж байна л даа. Энэ олон нийтийн радио телевизийн бие даасан байдлыг хангасан хуулийн дагуу шаардлага хангасан ямар шийдвэрүүдийг 2013 оны эхний улиралын байдлаар гаргасан бэ? Өөрөөр хэлбэл, бие даасан хараат бус тэр байдал нь хуулиар олгогдчихсон. Гэхдээ тэрнийг хэрэгжүүлж байгаа шийдвэрүүд нь мэдээж засгийн газраас гарахгүй. Үндэсний зөвлөлөөс л гарна. Яагаад гэвэл хараат бус байх шийдвэр гаргасан. Эхний улиралд ч юм уу, олон нийтийн шинэ үндэсний зөвлөл байгуулсанаас хойш ч юм уу, хичнээн ийм шийдвэр гаргасан бэ гэдгийг тодруулмаар байна?

- Үндэсний олон нийтийн радио телевизийн тухай хуульд тусгай заалттай байдаг. Үндэсний зөвлөлийн ажиллах боломжийг ерөнхий захирал хариуцана гэсэн ийм заалттай. Оны төсөвт үндэсний зөвлөлийн ажиллах тусгайлан заалт ордоггүй байсан. Энэ жил бол тусгайлан яриад ийм заалт оруулсан байна лээ. Нэг зардал гээд байх юм байхгүй. Үндэсний зөвлөлийн гишүүд урамшуулалын 250.000 авдаг. Тэр хуулинд цалин, түүнтэй адилтгах.....

**С.Дэмбэрэл:** Үгүй би батлагдсан төсөв чинь хэд вэ гээд л асуусан.

- Өөр илүү хангамж ер нь байхгүй. Олон нийтийн радио телевизийн үндэсний зөвлөлийн тусгайлсан төсөв гэж жилийн төсөвтэй, дотоод төсөвт тусдаг л даа. Гэхдээ голдуу урсгалаараа яваад, ингээд гараад явчдаг. Хараат бус байдлыг хангах талаар ийм юмаа. Бид нар дүрмийг шинэчилж авч үзсэн. Шинэчилсэн бүртгэлтэй холбогдуулаад радио телевизийн дүрэм гээд тусдаа дүрэм байдаг. Тэнд 2 зүйлийг хуучин дүрмээс хасахаар санал оруулаад хасагдаад явж байгаа. Тэр юу вэ гэхлээр зэрэг хуулиар болвол үндэсний зөвлөл бол стратегийн төлөвлөгөөг батлана гэсэн. Хөтөлбөр нь хуулинд нийцэж байхыг сануулсан л заалттай. Хуучин дүрмэн дотор жилийн төлөвлөгөөгийн баталсан радио телевизийн дотоод

журмыг батлахаар дүрмэндээ тусгаад, хэрэгжүүлээд явж байсан юм байна лээ. Энийг аваад үзэхээр, хууль давсан дүрэм ийм заалт орсон байсныг зогсоосон. Жилийн төлөвлөгөө батлахгүй байгаа, дотоод журмыг батлахгүй байгаа, өөрснөө батлаад өгч байгаа. Ер нь хараат байдлын тухай хуульд тодорхой заасан байдаг л даа. Ганц үндэсний зөвлөл ч биш. Ерөөсөө радио телевизийн удирдлага ерөнхий захиралаас авхуулаад энэ албан тушаалтнууд бол нэвтрүүлэгт орохыг үндсэндээ хориглосон заалттай, хуулиндаа. Жишээлбэл, тодорхой нэвтрүүлгийг эфирт гаргахыг зогсоох эрхийг нь зааж өгсөн байгаа хуулиндаа. Уг нэвтрүүлгийг бэлдсэн редактор, сэтгүүлч 2 нэвтрүүлгээ үзээд хэрэв одоо бодит байдалд тохирохгүй юм уу, худлаа ч юм байвал эфирт гаргахыг зогсоох эрхтэй. Өөр энийг хэн ч зогсоох эрхгүй, ерөнхий захиралд ч байхгүй бусад улсуудад ч байхгүй. Одоо эфирт гаргахын өмнө хяналт байхгүй, ерөөсөө. Радиод ч байхгүй, телевизэд ч байхгүй. Тэгэхлээр хараат бус байдал ер нь сэтгүүлчийнхээ хэмжээнд бүрэн хэрэгжиж байгаа гэж бодож байгаа. Захиалгаар, тийм юм оруулаач, энэ тэрээ гэсэн тийм хүсэлт зөндөө ирнэ л дээ. Заримдаа боломжгүй гэсэн хариу өгдөг, заримдаа бол хариу өгөхийн хэрэг ч байхгүй. Ингээд л явдаг.

**С.Дэмбэрэлийн тодруулах асуулт:** Би зүгээр л төсвийг чинь сонирхож байна шүү дээ. Наранбаатараас асуух юм уу? Яг хичнээн төгрөг 2013 онд баталсан вэ? Өөрөөр хэлбэл энэ хараат бусаар үйл ажиллагаа явуулах Үндэсний зөвлөл шүү дээ. Үндэсний зөвлөлд яахаараа тэгж ерөнхий захирал нь мөнгө баталж өгдөг юм? Ийм сонин юм байх гэж үү? Хараат бус байдлын институт шүү дээ, тэр Үндэсний зөвлөл чинь! Би тэрнийг л асуугаад байна. Үндэсний зөвлөл чинь хичнээн шийдвэр гаргасан бэ? Ямар мониторинг хийсэн бэ? Ямар шийдвэр гаргасан бэ? Энийг асуугаад байхад л өөр юм яриад байх юм. Сэтгүүлч нь хараат бус байвал л бусад нь болно гэсэн үг үү, яг юу гээд байгаа юм бэ?

**Хариулт:** - Ер нь сэтгүүл зүйн хараат байдал гэдэг бол угтаа сэтгүүлчийн л хараат бус байдал юм. Ийм учраас, Үндэсний зөвлөл бол сэтгүүлчийн хараат бус байдал зөрчигдөхгүй байгаа л гэж үзэж байгаа юм. Үндэсний зөвлөлөөс олон шийдвэр гарсан л даа. Гол нь, хуулиараа бол 20 сая төгрөгнөөс дээш бүх зардлыг, гэрээ хэлэлцээр хийх, нэвтрүүлэг хийх бүх зардлыг /хуулиар бишээ/ гэрээгээр Үндэсний зөвлөл баталдаг. 20 саяаас дээш зардалтай гэрээнүүд бүгдээрээ Үндэсний зөвлөлд ороод батлагдаад явж байгаа. Би тоолж үзээгүй. Он гарснаас хойш 4 удаа хуралдсан. Нэг хурлаас 3,4 тогтоол гардаг. Урсгал ажлын тогтоол, стратегийн төлөвлөгөө баталсан тогтоол бол 2010 онд гарсан. Энэ оны сүүлчээр өөрчилнө. Ажил хэргийн чанартай тийм том тогтоолууд гардаггүй. Ер нь бараг гаргаж болох ч үгүй байх. Өөрөөр хэлбэл тийм тогтоол гаргах эрх хуулиар, радио телевизийн Үндэсний зөвлөлд байхгүй байгаа. Ерөөсөө мөнгө төгрөгтэй холбоотой... хариултын цаг дууслаа.

**С.Дэмбэрэл:** Би яах гээд асуугаад байсан бэ гэвэл, ерөөсөө энэ Үндэсний зөвлөл, менежментийн баг олон улсын хэмжээнд байдаг тэр харилцаа мөрдөгдөж чадаж байна уу? гэдгийг л асуух олж мэдэх гэсэн чинь чаддаггүй юм байна. Өөрснийгөө буруу ойлгодог юм байна.

Нэгдүгээрт, Үндэсний зөвлөл. Үндэсний зөвлөл нь тэр Бурмаагийн хэлж байгаагаар идэвхтэй биш юм байна гэдэг нь харагдаж байна. Гэхдээ энийг нөхцөлдүүлж байгаа хүчин зүйлийн нэг нь санхүүгийн бие даасан

байдал, нийт санхүүжилтийн хэмжээ маш дутуу байдагтай холбоотой юм байна. Дээр нь, жишээлбэл, түрүүн хараат бус байгууллагуудын гаргасан судалгааг хэлээд байна. Тэрнийг л Үндэсний зөвлөл барьж аваад, за энэ яагаад ингэж байгаа юм бэ? Яагаад энэ хараат бус байдал алдагдав гээд Үндэсний зөвлөл өөрсдөө санаачилж гаргаж хийх ёстой. Би яагаад та нарыг хөдөө яв гэж байгаа юм бэ гэхээр хүн амьтанаас асуу л гэсэн үг. Энэ нэвтрүүлгүүд маань, энэ явж байгаа юм маань болж байна уу? гэдгийг явж, судлаасай л гэсэн санаа юм. Баярцогт, эд нар маань сая чухал санал хэллээ. Техникийн талаас нь сайжруулах гэж! Үнэхээр тэгэж байгаа. За дээр нь, Үндэсний зөвлөлийн бас нэг хийх зүйл нь энэ олон нийтийн радио телевизэд хөрөнгө оруулалт хангалттай хэмжээгээр байж чадаж байна уу гэдэг дээр анализ хийгээд, танилцуулах ёстой. Би андуураагүй бол тэр байшинд чинь өвөл их хэцүү, хүйтэн юм байна. Монгол Улсын үндэсний телевиз гэж байгаа тэр байшин их л өрөвдөлтэй байдаг. Та нар бүгдээрээ дотор нь орж үзсэн байх. Тэгээд ийм байхад хөрөнгө оруултынхаа төлөвлөгөөг оруулж ирэх ёстой. Өөрснийхөө төлөвлөгөөг, бас өөрснийхөө санхүүжилтийн бие даасан байдлыг хангах саналыг ч оруулж ирэх ёстой, томилсон хүмүүс дээрээ. Энэ 50 сая төгрөг ярьж байна. Яаж тэр санхүүгийн бие даасан, үйл ажиллагааны бие даасан байдал чинь хангагддаг юм. Та бүхнийг саяны ярьж байгаагаар, нэг намаас томилсон байж магадгүй. Гэхдээ угаасаа өөрсдийн чинь мэргэжлээс болоод тэр хүмүүс дандаа л тэрийгээ /өөрсдийнхөө хүссэн зүйлийг та нараар явуулуулахыг/ хүсдэг. Хараат бус байдлыг хүсдэг хүмүүс мэдэж байгаа. Энэ хүмүүст итгэж болно л доо. Гэхдээ өөрсдийнхөө эрхийг өөрснөө дутуу ойлгоод байна. Тийм ч учраас зарим нь хэлж байна, хийх ажил байхгүй гээд. Маш их ажил байна. Хамгийн түрүүн барьж байгаа юм нь тэр хараат бус институтийн судалгаа. Институтийн гаргасан тэр судалгаан дээр дүгнэлт хийгээд энэ яагаад ингэв гэдгийг л ярьж байх ёстой. Эсвэл өөрснөө ингэдэг юм уу? Энэ нэг асуудал. Жишээлбэл, НТ ярьж байна шүү дээ. Энэ байгууллагад жилийн жилд өгдөг төсөв нь маш ядуу, магадгүй тэр зөвлөмж болгох гэж байгаа бол, хамгийн түрүүний зөвлөмж болох юм чинь төсвийг нь ихэсгэ гэсэн зөвлөмж байх ёстой. Энэ чинь олон нийтийн телевиз. Төсвийн чинь мөнгө олон нийтийн мөнгө, төрийн мөнгө биш, олон нийтийн мөнгө, татвар төлөгчдийн мөнгө. Тэр мөнгөнөөс олон нийтэд үйлчилдэг энэ газартаа төсвийг нь нэм л гэж хэлж байгаа хэрэг шүү дээ. Хамгийн энгийн, ойлгомжтой логик. Эцэст нь, би сая бас нэг ноцтой юм сонслоо. Тэр архивтэй холбоотой нэг тийм юм. Үнэхээр тийм бол ингэж заварч болохгүй. Хэн нэгэн хувь хүн рүү, тухайлбал гүйцэтгэх захирал руу нь, унагачих санаатай иймэрхүү юм болно гэж би арай бодохгүй байна. Гэхдээ тийм сэжиг төрөөд явчихлаа. Хэрэв тийм юм байвал болохгүй. Хуулиар хориотой. Тийм учраас эцэст нь хэлэхэд, энэ байнгын хороогоор орно. Гэхдээ зөвлөмж гарах уу гэдэг дээр бол бас нэг юм асуух ёстой л доо. Олон улсын соёлтой хэлбэрийг харж байхад бол (stronger) гэж ярьдаг хүчтэй зөвлөмж болгодог. Зарим хэсэгт нь зөвлөмж гэж явчихдаг. Тэр хэлбэрийг сонгох юм уу, эсвэл шууд ингэ тэг гэсэн хэлбэрийг, эрх зүйн талаас нь, сайн бодож байж сая одоо гишүүд хэлсэн, миний хамгийн түрүүн хэлэх юм бол санхүүжилтийг нь сайжруул, эрх чөлөөг нь олго, Үндэсний зөвлөлд нь энэ боломжийг нь хангаж өг гэсэн ийм л гол юмнууд байна.

## **Үндсэн чиглэлүүдийг боловсруулахдаа хүний амьдралд наалддаг үзүүлтүүд дээр наалдуулж төлөвлөх хэрэгтэй**

*Эдийн засгийн байнгын хорооны 2013 оны 5 сарын 8-ны хуралдааны тэмдэглэлээс: “Монгол Улсын хууль тогтоомжийг 2016 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Үндэсний статистикийн хорооны 2012 оны үйл ажиллагааны тайланг тус тус хэлэлцэх цээр*

С.Дэмбэрэл: Энэ төслүүдийг үзээд, ард талынх нь Байнгын хороо дээр хэлэлцсэн, дүгнэсэн байдал болон Байнгын хороон дээр гарсан санлуудыг нь бүгдийг нь үзлээ. Яагаад эдийн засгийн Байнгын хороонд бусад Байнгын хороод саналаа ирүүлдэг вэ гэвэл, үүнийг тусгаачээ гэж л ирүүлдэг. Түүнээс биш хавсрах биш. Энэ УИХ-ын тогтоол чинь одоо яг энэ хэлбэрээрээ байвал бүтэхгүй. Нэгдүгээрт, тийм учраас энийг өөрчлөх ёстой. Би өчигдөр зөвлөхтэй ярилцсан. Тэр өөрийн саналыг хэлсэн. Ерөнхий сайд Алтанхуяг даалгахгүй гэсэн байна. Яг энэ өгүүлбэрийг уншаад та нар Алтанхуягийн байранд өөрийгөө тавиад бодоорой. Ойлгох уу? Ойлгохгүй, ойлгохгүй учраас анхаарахгүй, тодорхой биш байна. Сая одоо та бүхэн үндэсний хуулийн тэр заалтын талаар маргаад байх шиг байна. Маргаад байх юм байхгүй. Зүгээр л хэвийн эдийн засагтай, хэвийн бодлого боловсруулагчтай улс л мөн бол өөрийнхөө улсын эдийн засгийг жил болгон авч хэлэлцэнэ. Тэр байтугай улиралын хуваарьтай авч хэлэлцдэг. Тийм учраас:

*Нэгдүгээрт*, энэ санал, тогтоол дотор, цаашдаа, хэрэв, энэ үндсэн чиглэлийг боловсруулахаас авахуулаад хэлэлцэх шат хүртэл чанрыг нь дээшлүүлэе л гэвэл улиралын хуваарьтайгаар, мөнгөний бодлогын хэрэгжилттэйгээр, төслийн хэрэгжилттэйгээр, байнга авч хэлэлцдэг дэглэмд орох хэрэгтэй. Тэгэхгүй бол 2011 оны 7 сарын 9-нд боловсрогдоод, 2012 оны тайлан нь ирээд, 2013 оны 5 сарын 8-нд хэлэлцэж байна. Бид статистикийн байгууллага биш. Өнгөрсөнийг дүгнэж хийгээд хэрэггүй. / манай харъяанд байдаг статистикийн байгууллага түүнийг чинь хийгээд өгчихдөг./ Бид бол Монгол Улсын эдийн засаг, нийгмийн үндсэн чиглэл яаж явагдаж байгаа процессийг хянаж, тэрэнд сайжруулах зүйлүүдийг нь хэлж өгдөг УИХ-ын институци. Тэр тусмаа УИХ-ын эдийн засгийн асуудлыг нь хариуцдаг хамгийн гол институци. Энэ маань дутагдаж байна. Тийм учраас хамгийн түрүүнд энэ тогтоолыг өмнөх Байнгын хороонд болон улиралын хувиартай тодорхой болгох хэрэгтэй, нэгдүгээр асуудал.

*Хоёрдугаарт*, үндэсний аудитийн газрын хийсэн дүгнэлт, саналуудыг энд тодорхой тусгаж өгөх ёстой. Дээр нь үндэсний аудитийн газар болон статистикийн байгууллагуудын бие даасан байдалтай холбогдсон тодорхой саналууд байвал, түүнийг нь ч бас тусгаж өгөх ёстой. Хоёр талаасаа ажиллах ёстой. Жишээлбэл, Монгол Улсын бүх юм яагаад тасраад, жилийн хоцрогдолтой яваад байдаг юм бэ гэхээр боловсруулсан хуулинд чинь байна. Жишээлбэл, засгийн газрын худалдан авалт 50-700 өдрөөр хоцорч байна. Энэ хууль чинь ажил хийлгэхгүй байна. Тэгэхээр, энэ



хуулиндаа өөрчлөлт оруулах ёстой. Энэ асуудлыг тавих ёстой. Өнөөдөр засаглалд гарч байгаа бүх баримт бичгүүдийн эргэлтийн хурдыг хөөгөөд үзэхээр асар удаан байна. Шийдвэр гаргах гэж хамаг ажлыг авч, хугацаа алдаж байна. Баримт эргэлтийг хурдасгах, засаглалд эргэж байгаа шийдвэр гаргах явцыг орцоос авхуулаад гарц хүртлэх энэ бүх шатанд эргэлтийг нь хурдасгах ийм шийдвэрийг УИХ-ын тогтоолоор засгийн газарт оруулах хэрэгтэй. Үүнийгээ хурдасга, тэгэхгүй бол ажил чинь явахгүй байна, энэ баримт эргэлтийг хурдасгахгүйгээр шийдвэр гаргах гээд л, нэг ажлын хэсэг байгуулаад, эсвэл ингэж, тэгээд явж байтал чинь ажил хэргийн цикл дуусчихаад байна.

*Гуравдугаарт*, энэний дараа бид статистикийн тайланг хэлэлцэнэ. Энэ статистикийн тайланд чинь үндсэн чиглэлд оруулах ёстой бүх судалгаанууд нь байж байхад үндсэн чиглэл, статистик хоёр нь хоорондоо ямар ч уялдаа алга. Бид Үндсэн чиглэлдээ макро эдийн засгийн тэнцвэр гэж ярьж байдаг мөртлөө, ганцхан мэддэг юм нь дотоодын нийт бүтээгдэхүүн гэсэн хэдэн ужгирсан үг хэллэг, хэдэн тоо л ярьдаг. Гэтэл тэрний ард байгаа үнэлгээ, дүгнэлт, тэднийг тооцсон салбар хоорондынхоны харьцаа, аль салбарт юу болж байна гэдгийг бүгдийг нь үзүүлдэг үйлдвэрлэл, хэрэглээ, эдгээрийг бүх талаас нь үзүүлдэг статистикийн анализ нь алга байна. Хаа нэг газар, бид нарын ширээнийхээ нүдэнд, эсвэл статистикийн байгууллагын номын санд л хадгалагдаад үлдэж байна. Энэ бүхнийгээ яагаад энэ бодлогынхоо эргэлтэнд оруулахгүй байгаа юм бэ? Өөрөөр хэлбэл, Үндсэн чиглэлээ боловсруулж хийх, цаашдаа үнэлэх зүйл чинь дутагдаад байгаа учраас УИХ-ын тогтоолд маань дахиж ийм зүйлийг нэмж оруулах ёстой.

*Тэрний дараа*, салбарын яамнууд болон статистикийн газраас гаргасан, хүн амын ядууралттай холбоотой, Монголын хүн амын амьдралын чанартай холбоотой маш олон үзүүлтүүд байна. Саяхан ЭМЯ-аас 2012 оны Эрүүл мэндийн сектор судалгаа гарсан байна. Мөн БОНХЯ-аас энэ улсын чинь байгаль орчны төлөв байдлын үнэлгээ гарсан байна. Энэ маань хаана байна? Энэ дотор, үндсэн чиглэлд чинь, биелэлтэнд, анх оруулсан зүйлүүдэд чинь ерөөсөө тийм юм байхгүй байна. Тийм учраас нөгөө эдийн засгийн өсөлт чинь хүн рүү наалдахгүй байна. Хүмүүс үнэмшдэггүй! Энэ Үндсэн чиглэлийг чинь хэн ч сонирхдоггүй! Хүний амьдралд наалддаг үзүүлтүүд дээр л төлөвлөх хэрэгтэй. Жишээлбэл, өнөөдөр монголд яагаад хүмүүс халтирч үхсэн байна? Хамгийн тэнэг үхлээр үхэж байгаа энэ үхэл яагаад Монгол улсын нийт нас баралтын ихэнх хувийг эзлээд байна вэ? Яагаад сүрьеэ зэрэг 5 төрлийн өвчин зонхилох байр эзлээд байгаа юм бэ? Энэ бол Үндсэн чиглэлийн төсөв маань мэдрэмжгүй байна л гэсэн үг. Хүн ардаасаа хол байна гэсэн үг. Тийм учраас, энэ Үндсэн чиглэлээ хүний мэдрэмжтэй болгоё гэвэл, мөн үүнийгээ үнэлж дүгнэдэг болгоё гэвэл саяны хэлсэн зүйлүүдийг хийх хэрэгтэй. Тогтоолын төслийг яг энэ байдлаар нь явуулбал ерөнхий сайд ч ойлгохгүй, ямар ч сайд ойлгохгүй, хэн ч энийг хэрэгжүүлэхгүй. Тэгээд дараа жил бид нар дахиад л ингээд сууж байх болно. Та бүхэн ингэж суух дуртай байж болно. Би тэгэж суух дургүй. Тийм учраас бүгдээрээ дургүй болцгооё. Энийг дахин шинэчлэн боловсруулцгаая. Эцэст нь нэг мэдээлэл хэлье. Өчигдөр төрийн байгууллалтын Байнгын хороон дээр УИХ-д ажлаа тайлагнадаг бүх байгууллагуудад зориулж, тусгай тогтоол гаргасан. Тэд



нарт үйл ажиллагаагаа сайжруулах, чанарыг нь сайжруулах, УИХ руу ирүүлдэг мэдээ баримтуудынхаа чанарыг сайжруулах, улмаар энэ бүхэнд нь зориулж өөрсдөө болон бусдаар системчилсэн үнэлгээ хийдэг болгох тухай УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны тогтоол гарсан. Цаашдаа УИХ-д, Эдийн засгийн Байнгын хороонд ажлаа тайлагнадаг Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн байгууллагын ажлын чанар сайжирна гэсэн үг. Одоо харин энэ сайжирсан мэдээлэл дээр суурилоод, бид нар өөрсдөө гаргах шийдвэрээ сайжруулах хэрэгтэй болж байна. Тийм учраас энэ УИХ-ын тогтоол дотор чинь зөвхөн засгийн газарт биш, Эдийн засгийн Байнгын хороо болон холбогдох бусад байгууллагууд ч өөр өөрсдөдөө даалгавар өг гэсэн ийм л саналтай байна.

### **Бичил, жижиг бизнесд шаардлагатай байгаа хөрөнгийн эх үүсвэрийг ярилцах ёстой**

*2013 оны 05 сарын 13-нд Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны үйл ажиллагааны тайланг Байнгын хороогоор хэлэлцүүлэх бэлтгэл хангах, Байнгын хорооноос гарах шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлээс:*

**С.Дэмбэрэл:** Тэр тогтвортой байдлын зөвлөлд танай хороо 2012 онд ямар асуудлууд оруулсан бэ? тэр нь яаж шийдэгдсэн бэ, гэсэн нэгдүгээр асуулт.

**Хоёрдугаарт,** Монголын Улсын санхүүгийн секторыг бүхлээр нь аваад үзэхээр танай системийн хувьд яг 5% гэдэг нь зөв үү? Энэ 5%-ийг яаж 10%, 15%, 20% улмаар хамгийн багадаа 70:30-ийн харьцаатай болгох вэ? тийм бодлого, тийм баримт бичиг гарч ирж байна уу?

**Гуравдугаарт,** Банк бус санхүүгийн байгууллагууд банкуудтай өрсөлдөх талаар, төрийн болдлогоор, түүний дотор хямд эх үүсвэртэй санхүүжилтээр дэмжих талаар, танай хорооноос засгийн газар, УИХ-д ямар санал 2012 онд оруулсан вэ?

**Дөрөвдүгээрт,** Түрүүн тэр хадгаламж зээлийн хоршоо энэ тэр гээд л ярилаа. Зээлийн батлан даалттай 2 банктай гэрээ байгуулсан гээд нэмэр байхгүй. Тэнд чинь хамгийн гол нь мөнгө байхгүй. Монголын бичил бизнесийн, жижиг бизнесийн батлан даалтыг хангаж чадахуйц, ядахдаа 50%-ийг нь хангаж чадахуйц мөнгө хэрэгтэй байж байж тэр чинь ажиллана. Тэрний эх үүсвэрийн тооцоог гаргасан уу?

Өнөөдөр /2012 онд ч юм уу/ Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, Эдийн засгийн хөгжлийн яам гэхчилэн 3 байгууллага байна. Эд нар эдийн засагт нэн шаардлагатай, түүн дотроо бичил жижиг бизнесд шаардлагатай байгаа хөрөнгийн эх үүсвэрийг болон энэ үйлчилгээг яаж хөгжүүлэх талаар уг нь ярилцаж байх ёстой. Жил болгоны мөнгөний бодлого дээр танай ганцхан өгүүлбэр орж ирдэг. Танай байгууллагыг доош нь чихдэг. Энэнийгээ өөрчлөх хэрэгтэй. Доош нь чихүүлээд явуулаад байж болохгүй. 5% эзлээд байж, тэрнийгээ 10% болгохын төлөө өрсөлдөөн өрнүүлэх тийм юм танай дээр дутагдаад байна. Эсвэл хүч чинь хүрдэггүй байдаг байж

магадгүй. Ийм чиглэлээр одоо та бүхэн үнэнээ л хэлээч. Энэ байнгын хороонд үнэн байдлаа хэлээд, ийм байдаг юмаа гэдгийгээ тайлбарламаар байна. За ахиад нэг асуулт байна.

Ерөнхийдөө Монгол Улсад 1076 ломбард байна. Ломбард гэдэг бол бичил санхүүгийн үйлчилгээг хамгийн их мөнгөний хэрэгцээтэй иргэдэд нь хүргэж байгаа, хүргэх ёстой хэлбэр. Гэтэл өнөөдөр иргэд ломбардад 5-8% хүүтэйгээр монетон бөгж, гар утас, эд хөрөнгөө тавьдаг, харин тэр нь ямар ч санхүүгийн зохицуулалтгүйгээр цагдаагийн газар, эсвэл хааяа нэг татварын газарт ганц нэг мэдээ очих төдий, ийм байдлаар явж байна. Уул нь энэ бол хөдөө хөгжүүлэх гээд байгаа хадгаламжийн хоршоо шиг, энэ чинь өөрөө санхүүгийн үйлчилгээний шууд хүмүүст хүрдэг нэг бичил, шуурхай тийм хэлбэр нь болох талаас нь харах төрийн бодлого дутагдаад байгаагийн шинж. Тийм учираас энэ чиглэлээр, хууль эрх зүйн талаар ч юм уу, бодлогын талаар танай хорооноос цаашдаа хийх гэж бодож, төлөвлөж байгаа зүйл байна уу?

Эцэст нь өнөөдөр Монгол Улсад танай хорооны хамгийн гол анхаарал хандуулах зүйл чинь хөрөнгийн бирж биш. Монголын бодит амьдралыг үзэх юм бол, хөрөнгийн биржийн үнэт цаасны хуулиа батлаж гаргах гэж байна. Гэхдээ энэ мань Монгол Улсын эдийн засагт бодитой үр дүнгээ өгөхөд доор хаяж 5-10 жил шаардлагатай. Тэгэхээр өнөөдрийн хэмжээнд та нарын гол анхаарах зүйл, яг ард иргэдэд шууд очдог, өсөлтийг шууд аваачих тийм санхүүгийн хуваарилалтын механизм буюу бичил санхүүгийн оролцоотой, тогтвортой үйлчилгээг яаж хөгжүүлэх вэ гэдэг л хамгийн гол асуудал чинь байгаа юм шүү. Энэ талаасаа Азийн хөгжлийн банк, Монгол Улсад чинь энэ 2 байгууллага чинь л юм хийгээд л байх шиг байна. Гэхдээ энэ чиглэлийн эх үүсвэр, үндсэн чиглэл, ер нь юмнуудад тусгуулахгүй байгаа. **Санжментавын яам** хариуцаж байгаа ч юм шиг, хариуцахгүй байгаа ч юм шиг. Тэгээд 5 сая төгрөг, 1 сая төгрөг энэ тэр гээд авдаг тэрэнд нь танай хорооны ямар ч оролцоо байхгүй. Эх үүсвэр гэж Монгол банк жилийн мөнгөний бодлогоо оруулж ирдэг ч санхүүгийн зах зээлийн мөнгө бодлогыг монополь харьцаанааас нь гаргаж, өрсөлдөөнт орчин бий болгох тал дээр, ялангуяа энэ бичил, жижиг бизнесийн энэ санхүүгийн оролцоотой хүртээмжтэй үйлчилгээ хүргэх талаар танай хорооны бодлого цаашдаа чиглэх ёстой. Энэ чиглэлээр цаашдаа юу хийх вэ гэсэн ийм нэг асуулт байгаа.

Хэлсэн үг илүүдчихнэ шүү. Энэнийг сайн анхаараарай. Яагаад гэвэл танай хороо хийхгүй бол Монгол банк хийхгүй байна. Одоо мөнгөний бодлого орж ирнэ. Түүн дээр мянга мянган хүний санхүүгийн хэрэгцээг хангах механизм байхгүй орж ирнэ. Тийм биз... Зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулна гэсэн, тийм ээ? Тэр зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулах тэр бодлогын чинь нэг оролцогч нь танайх. Өөрсдийнхөө хариуцаж байгаа системийн хэмжээнд энэ чиглэлээр өрсөлдөөн үүсэхээс гадна бүхэл бүтэн санхүүгийнхаа систем дотор өрсөлдөөн үүсэх санаачлага танайхаас л гарахгүй юм бол Монгол банкнаас гарахгүй. Тийм учраас энэ талаас нь бодож би саяны хэд хэдэн чиглэлүүдийг хэлсэн шүү. Энэнийг 2013-2014 оны үйл ажиллагаанд тусгаад энэ чиглэлээр манай байнгын хороонд та нар яг тийм юмнууд оруулж ирнэ байх гэж бодож байна. Дээр нь

танай байгууллагын болон энэ УИХ -д тайлагнадаг 6-7 байгууллагуудын системчилсэн үнэлгээ хийх аргачлал та бүхэн саяхан авсан байх. ТББХ-гоор батлагдаад системчилсэн үнэлгээг өөрснөө хийх, хөндлөнгийн байгууллагаар хийлгэх, холимог байдлаар хийх гэсэн ийм аргачилал. Тийм учраас дараа жилээс тайлан орж ирэхэд тэр нь маш их өөр, энэ асуудал их өөр, танай байгууллагын үйл ажиллагааг тал бүрээс нь ухаан гаргасан тийм байдлаар, тайлан чинь системчилсэн байдлаар орж ирнэ шүү. Яагаад гэвэл УИХ-ын байнгын хорооны тогтоол гарсан байгаа. Энэнийг хэлэх гэсэн юм.

### **С.Дэмбэрэл гишүүн өнгөрсөний статистик, одоогийн байдал, ирээдүйн үр дүн гурвыг асууя**

*УИХ-ын Чуулганы 2013 оны 5-р сарын 24-ны Нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс: Улсын Их Хурлын гишүүн Гарамгайбаатараас Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдад тавьсан Монголбанк, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамтай хамтран 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдөр баталсан Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдал. Түгнчлэн Улсын Их Хурлын 2011 оны Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай 30 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнгийн талаарх асуулгын хариуг хэлэлцэх цээр*

**З.Энхболд:** -Ажлын хэсгийг танилцуулъя. Үйлдвэр, хөдөө аж ахуйн дэд сайд Ц.Туваан, Төрийн нарийн бичгийн дарга Х.Золжаргал, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Тунгалаг, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Рэнчинсэнгээ, Хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганцэцэг, мөн яамны Үжиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн захирал Баттүвшин.

Асуулттай гишүүд нэрээ өгье... С.Дэмбэрэл гишүүн асууя.

**С.Дэмбэрэл:** - Би Хөдөлмөрийн яамнаас асуух гэсэн юм. Хүнсний талон ноднин жил нэг мэдээ уншиж байхад гурван аймаг, хэдэн дүүрэг ч билээ, тарааж байсан. Өөрөөр хэлбэл, тогтворжуулалтын зорилгоор, инфляцид ядуу гэр бүлүүдийг өртүүлэхгүйн тулд тараасан. Үүний хамгийн сүүлчийн статистикийг хэлж өгөөч. Хичнээн дүүрэгт, хичнээн аймагт ямар багцаар хүнсний купон тараагдчихаад байгаа юм бэ? Үүний нийт үр дүн, үнийн дүнгийн талаар мэдээлэл өгнө үү.

*Хоёрдугаарх нь, Х.Баттулга сайдаас. Бид Эдийн засгийн байнгын хороон дээр яриад байсан. Бонд авсан уу, батлагдсан уу? Эхлээд намайг ажлын хэсгийг ахалж байхад, /Эдийн засгийн байнгын хороон дээр биш, Байгаль орчны байнгын хороон дээр. Дараа нь Гарамгайбаатар гишүүн ахалж байна./ бид яриад бараг гурван сар болчихлоо. Арьс ширний сезон нь аль хэдийн өнгөрчихлөө. Энэ яг гацаа нь хаанаа байна вэ гэдгийг та хэлж өгөөч. Би аваагүй гэж сонсоод байгаа юм. Үүний гацаа нь яг юундаа*

байгаад байна вэ? Энэ дээр яг дүгнэлт хийгээд хэлж өгөөч гэсэн ийм хоёрдугаар асуулт байна.

*Гуравт нь*, импортоор сая шинэ хууль батлагдсантай холбогдуулаад аж ахуйн нэгж импортлох эрх авсан. Үүнтэй холбогдуулаад, хууль батлагдсанаас хойш хүнсний аюулгүй байдал талаасаа биш, хүнсний нийлүүлэлт тал дээр ямархуу нэмэлт, нэмэгдэл зардал ч гэдэг юм уу, тийм талын ямар ажиглалт харагдав? Энийг бас хүнсний бодлого хариуцсан газрын даргаас асуумаар байна. Баярлалаа.

**З.Энхболд:** - Ажлын хэсгээс нэр зааж асуусан хүмүүс хариулъя.

**Б.Ганцэцэг:** - Хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга. С.Дэмбэрэл гишүүний асуултад бид нар өнгөрсөн жил яам байгуулагдахаас өмнө хүнсний купоны асуудал асууж байгаа учраас би бичгээр хариулахыг хүсэж байна. Дараа нь таны нэр дээр.

**З.Энхболд:** - Н.Батбаяр сайд. Уг нь Я.Санжмятав байгаа юм байна шүү дээ. Мэдэхгүй юу?

**Н.Батбаяр:** - С.Дэмбэрэл гишүүний асуултад хариулъя. Арьс ширний бондын асуудлыг хөндөж байна. Тийм ээ? Би арьс ширний бондтой холбоотой асуултад хариулъя. Их Хурлаас өнгөрсөн жил шийдвэр гарсан байж байгаа. Тэгээд тогтоол гараад 140 тэрбум төгрөгийн арьс ширний салбарыг дэмжих төгрөгийн бонд гаргаж арилжаалах шийдвэр гарсан. Тэгээд түүнийгээ компаниудад зээлээр олгохдоо зээлийн хүүг дээд тал нь 7 хувь байхаар тогтоож өгсөн байгаа. Тэгвэл өнөөдрийн байдлаар бид нар энийг төгрөгийн бондын хүү бол 7 хувиас бууж чадахгүй байгаа. Тэгэхээр өндөр хүүтэй өгнө гэхээр Их Хурлын тогтоолоор 7 хувьтай өгнө гээд хэлчихсэн байдаг, тэрэнд нь таардаггүй. Дээр нь доллараар бонд гаргаад, харьцангуй бага хүүтэй зээл гаргаад, тэгээд тэрийгээ арилжааны банкуудад дамжуулаад өгье гэхээр дахиад 7 хувиасаа давчих гээд байгаа учраас энэ үнэ ханшны өнөөгийн нөхцөл байдлаас болж одоогийн байдлаар хэрэгжиж чадаагүй байгаа. Энэ дээр гол асуудал болохоор хуучин бид нар 2011 онд гаргасан 150 тэрбум төгрөгийн үйлдвэр дэмжих бондыг гаргахдаа 7 хувиар олгоё. Гэхдээ хүүгийн зөрүүг нь улсын төсвөөс зөрүүг өгөхөөр шийдвэрлэсэн байсан. Энэ жилийн шийдвэр гаргахдаа улсын төсөв батлагдсаны дараа гарсан учраас зайлшгүй энэ асуудлыг шийднэ гэвэл төсвийн тодотголыг хүлээх ёстой. Төсвийн тодотгол хуулиараа одоогийн байдлаар хийх бололцоогүй байгаа. Тэгээд намар тийшээ болчих гээд байгаа тийм л байдалтай болчихсон сууж байгаа. Яг бодит эдийн засгийн байдал бол.

**Үйлдвэр хөдөө аж ахуйн яамны хүнсний үйлдвэрийн бодлогыг хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Тунгалаг:** - С.Дэмбэрэл гишүүний асуултад хариулъя. Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга. Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль батлагдсанаас хойш ямар дэвшил гарав гэж. Тэгэхээр хууль маань батлагдаад хэрэгжих хугацаа нь 3 дугаар сарын 01-нээс хойш байсан. Өнөөдрийг хүртэл хоёр, бараг гурван сар болох гэж байна. Энэ хугацаанд энэ хоёр хуулийг дагаж гарах дүрэм, журмууд ерөнхийдөө боловсрогдоод дуусаж байна. Ер нь хүнсний салбарын суурь хууль байсан. Зарчмын хувьд маш том, том өөрчлөлтүүд гарсан учраас энэ дээр манай салбарын

мэргэжилнүүд өдөр, шөнөгүй л ажиллаж байна гэж хэлье. Тэгээд яг ямар үр дүнд хүрэх гэхээр өнөөдрийн байдлаар хүнсний хангамжийн хувьд аваад үзвэл бид нар махыг ямар ч байсан дотооддоо хангах тийм хэмжээнд байгаа. Гэхдээ 2013-2014 оны махны хувьд бид асуудал бага байна. Гэхдээ ирэх жилийн махны нөөцийн асуудал дээр арай өөр хэлбэрээр бэлтгэх тийм бодлогын асуудлууд яригдаж байгаа. Сүүн дээр өнөөдөр бондын хөрөнгөөр тодорхой хэмжээний санхүүжилтийг шийдсэн байгаа. Гурил, төмс, хүнсний ногооны хувьд бид нар дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангах боломжтой байна. Хүнсний ногооны хувьд 65 хүртэл хувиар хангах бололцоо харагдаж байгаа. Тусгай зөвшөөрлийн хувьд манай Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамнаас зөвхөн согтууруулах ундаан дээр тусгай зөвшөөрөл олгодог. Согтууруулах ундааны үйлдвэрлэл дээр олгож байгаа тусгай зөвшөөрөл бол тэмдэгтийн хураамж нь 50 сая төгрөг хүртэл байдаг. Энэ хураамжийг аваад тэгээд зохих журмын дагуу тусгай зөвшөөрлийг сунгах ажил хийгдэж байгаа. Түүнээс биш өөр тусгай зөвшөөрлийн асуудал өнөөдөртөө манай яаман дээр яригдаагүй байна. Стратегийн хүнсний импорт, экспортын хэмжээнд квот тогтоох асуудал хийгдсэн. Үүний урьдчилсан судалгаа нь хийгдээд, Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд ирсэн байгаа. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлөөс манай яаманд буцаагаад зөвлөмж хүргүүлэх ёстой байгаа.

## С.Дэмбэрэл гишүүний нэхэл хатуутай асуултууд

*2013 оны 07 сарын 05-ны УИХ-ын Нэгдсэн Чуулганы тэмдэглэлээс:  
Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийн цаг дээр:*

**С. Дэмбэрэл:** Нэгдүгээр асуулт. Жижиг дунд үйлдвэрийн зээлийн баталгааны санд бондын үлдэгдэл мөнгөнөөс хувиарлах талаар төлөвлөж байгаа юу?

*Хоёрдугаарт,* би хэд хэдэн удаа асуугаад хариуг нь одоо хүртэл олоогүй байна. Хүнсний талон Монгол улсад хэдэн дүүрэг, хэдэн аймаг, хэдэн иргэнд, ямар нөхцөлтэйгээр, хэн яаж, ямар судалгааны үндсэн дээр тараасан юм бэ гэсэн асуултанд мэдээлэл олж авч чадахгүй байна. Энийг асууж мэдмээр байна. Үүнтэй шууд холбоотойгоор Засгийн газрын хуралдаанаар 2013 онд ядуурлын асуудлыг тусгайлан авч хэлэлцсэн үү? Эсвэл хэлэлцэх үү?

*Гуравдугаарт,* Хүн амын хөгжил, Нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ-д дөрвөн удаа хэлсэн санал асуулт байгаа юм. Энэ санал нь “Нөхцөлт мөнгөн шилжүүлэг” буюу “Conditional cash transfer”. Олон улсын хэмжээнд төрөл бүрийн тэтгэвэр, тэтгэмж, халамж өгөхдөө иргэд нь зүгээр сууж байгаад авдаггүй, хөдөлж байж авдаг, хөшүүрэг хэрэглэдэг ийм нэг арга байдаг. Энэ аргыг Монгол Улсад, Засгийн газрын хэмжээнд тусгайлан авч хэлэлцээд хэрэглэх боломж байна уу? Судалгаанаас харахад халамжинд хамрагдаж байгаа хүмүүс өдрийн 20-30 мянган төгрөг өгье, **ажил хий** гэхэд ажиллахгүй, сайхан, эрүүл хүмүүс халамж аваад амьдраад яваад байх юм. Тэгэхээр энэ тал дээр халамжын **нуугдмал** хэлбэрээс бас



зайлсхийн тулд ба нэг хөшүүрэг хэрэглэх боломж байна уу? Миний хэлдэг Дэлхийн банкны дэмждэг “нөхцөлт мөнгөн шилжүүлэг” гэдэг механизмыг хэрэглэх боломж байна уу? гэсэн ийм нэг асуулт байна.

*Дөрөвдүгээрт*, Монгол банк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Эдийн засгийн хөгжлийн яамтай шууд холбоотой асуулт байна. Энэ бол зээлийн хүүг 2013-2016 онд нэг оронтой тоонд оруулах дэд хөтөлбөрийг УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны протоколоор боловсруулаад, эргүүлээд УИХ-д мэдээлж байх ёстой. Энэ асуудал дээр Засгийн газрын зүгээс, зээлийн хүүг бууруулах хөтөлбөрийг боловсруулахад шахалт тавьж ажиллана уу. Монгол банкнаас үйл явцынх нь талаар мэдээлэл авмаар байна. Ерөнхий сайд үүнд дэмжлэг үзүүлээч гэсэн хүсэлт байна.

*Тавдугаарт*, саяхан УИХ-ын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтсээс хоёр судалгаа хийсэн. Нэг судалгаа нь тендерийн судалгаа байсан. Тэрүүгээрээ Засгийн газарт хуулинд өөрчлөлт оруулах тухай асуудал оруулсан. Тендерээс гадна ерөнхийдөө, бичиг баримтын эргэлт их удаан байгаа гэсэн нэг судалгаа гарсан. Засгийн газрын хэмжээнд эргэлдэж байгаа бичиг баримтын эргэлтийг хурдасгах тал дээр, тухайлбал, Яам, Тамгын газруудаас Засгийн газарт оруулж байгаа төрөл бүрийн шийдвэрийн төсөл дээр хугацаа заадаггүй учраас баримтын эргэлт удаашрах гол шалтгаан болоод байх шиг санагдаад байгаа юм. Энэ чиглэлээр, баримтын эргэлтийг түргэсгэх тал дээр ойрын хугацаанд Засгийн газраас авах арга хэмжээ юу байна вэ гэсэн ийм асуулт байна.

*Эцэст нь*, түрүүний таны хэлсэн төрийн үйлчилгээний цэг гэдгийг тодорхой байгууллагын хүсэлтээр, тухайлбал, олон хүн цуглардаг газруудад тэдний хүсэлтээр нь нэмж ажиллуулж болох уу? Тийм боломж байна уу? Одоо тэр бизнесийнх нь ч гэдэг юм уу маш их олуулаа цуглардаг газарт тавиад, тэндээс нь бас үйлчилгээгээ авдаг, Хужирбулан энэ гээд бага ашиглалттай газар байж байснаас ашиглалт, хөдөлгөөн ихтэй газар нь үйлчлэх цэгийн тоог нь нэмэх арга бий юу? Иймэрхүү асуултууд байна. За баярлалаа.

**Н.Алтанхуяг:** Өмнөх Засгийн газар хүнсний талон өгөөд явж байсан, энэ ажил үргэлжилж байгаа. Намар бид нар халамжын бодлогоо яах вэ гэж Засгийн газар дээрээ ярилцаад, ямарч гэсэн 21.000 төгрөгийг үргэлжлүүлж өгөх боломжгүй юм байна гэж үзсэн. Тэртээ тэргүй зээлээр өгсөн халамж учраас баахан өр үүсгэсэн. Хоёрдугаарт нь хүнсний талоноо яах вэ гэж ярьж байгаад, үргэлжлүүлэн олгож байгаа. Дэлхийн банк хэрэгжүүлж эхэлсэн төсөл юм билээ. Дээр нь төсвөөс мөнгө өгч байгаа. Энэ яаж байгаа гэхээр амьжиргааны түвшин тогтоох шалгуур гаргаад тэр түвшингээс доогуур байгаа айл өрхийн гишүүдэд сар бүр 10000 төгрөг өгөх халамж үргэлжлээд явж байгаа. Манай Засгийн газрын гишүүд ярьж байгаад тоог нь нэмэгдүүлэхгүйгээр урьд авч байсан иргэдэд үргэлжлүүлээд олгох нь зүйтэй гэж үзсэн. Зээлийн батлан даалтын сангийн талаар Хөдөлмөрийн яамны Я.Санжмятав сайд хэлчихлээ. Эзэнгүй дундын байгууллага болоод хувирчихлаа. Тэгэхлээр Эдийн засгийн хөгжлийн Н.Батбаяр сайд маань юу ярьж байгаа вэ гэхээр, экспортын даатгалыг манайд бий болгох ёстой юм байна. Тэр зөвхөн зээлийн батлан даалт хийх юм уу, экспортын даатгалтайгаа оролцуулаад, тодорхой хэмжээгээр, шаардлагатай бол



Чингис бондоос мөнгө гаргаад явах юм бол зээл авах хүрээ хүртээмж улам өргөн болж нээгдэх юм байна гэдгийг диллерүүд нь ажиглаж байгаа. ТҮЦ машины тухайд одоогоор Улаанбаатар хотод 17 машин манай мэдээллийн албаныхан өөрийнхөө мөнгөөр тендерээрээ худалдаад авсан юм. Ерөнхий сайдын 50 тэрбум дотор 120 ширхэг түц машин худалдаж авах тендер одоо зарлагдаж байгаа. Тэр хүрээд ирэх юм бол иргэд их олноороо байдаг газарт нэмж өгөх боломжтой. Мөн аймгийн төвүүдэд 3-4 ширхэгийг байрлуулна.

**Монгол банкны мөнгөний бодлого, судалгааны газрын дарга Болдбаатар:** Зээлийн хүүг бууруулах орчин бүрдүүлэх төлөвлөгөөг өнгөрсөн жил Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банк хамтарч батлаад хэрэгжүүлж байсан. Түүн дээр дүгнэлт хийгээд дууссан. Шинэ хөтөлбөр боловсруулаад Монгол банкны удирдлагууд удахгүй Засгийн газар холбогдох байгууллагуудтай хамтраад, 2013-2016 онд дахиад шинэ хөтөлбөр хэлэлцэнэ.

**Н.Алтанхуяг:** Сая Болдбаатар дарга хэлчихлээ. Одоо Монгол банктай бид нар яриад байгаа. Авч болох боломжтой арга хэмжээгээ аваад, зээлийн хүүгээ нэг оронтой тоонд оруулсан. Цааш нь дахиад арилжааны банкнуудын эрсдлийг багасгах юм бол зээлийн хүү буух боломжтой. Энд саад болж байгаа нэг зүйл бол орон сууц, үл хөдлөх хөрөнгийн барьцааг шүүхийн бус журмаар борлуулдаг энэ асуудлыг шийдэх юм болвол дахиад хүүг 2,3 функтаар бууруулах боломж бүрдэж байгаа. Засгийн газар энэ нь дээр ажиллаж байгаа. Намар бид УИХ-д хуулийнхаа төслийг өргөн барина. Ингэх юм бол цаашдаа нэг оронтой дотроо дахин зээлийн хүү буух тэр боломж бүрдэнэ.

## **Хөдөө орон нутагт хөрөнгө оруулалтыг дэмжие**

*2013 оны 9-р сард, Хөрөнгө оруулалтын хуулийн төслийн 9-ын 3-р зүйл дээр “Хөрөнгө оруулалтын асуудал харууцсан засгийн газрын гишүүний эрхийг зааж оруулах тухай” хэлэлцэж хуралдаан дээр:*

**С.Дэмбэрэл:** Энэ дээр би нэг зүйл хэлье. Сүүлийн үед хуулиуд дээр нэг дэвшилттэй зүйл орж ирж байгаа. Тэр нь аливаа нэг институцийг байгуулахдаа олон этгээдүүдийн бүрэлдхүүн бүхий, бие даасан, хараат бус зөвлөл байгуулах журмаар зохицуулж байна. Жишээлбэл, Шударга бус өрсөлдөөний газар шиг олон газарт бид ийм бүтэц хийж өгөөд байгаа. Ингэснээрээ олон улсын жишгийг дагаад Хөрөнгө оруулалтын агентлаг байгуулагдлаа гэхэд Төлөөлөн Удирдах зөвлөл нь гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг илэрхийлсэн төрийн бус байгууллага болно. Төрийн байгууллагуудын төлөөлөл бүхий Удирдах Зөвлөл байна гэдгийг хуулиндаа зааж өгчихөөд, тэрний дараа энэ зөвлөлийн бүрэлдхүүн, ажиллах журмыг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн тогтоож өгнө гэж зааж өгсөн. Дараа нь хуулинд заагдаагүй гээд ямар нэг зүйл гарвал, жишээлбэл энэ Н.Батбаяр сайд дан Засгийн газрын гишүүдээр Удирдах зөвлөлөө бүрдүүлчихэж магадгүй шүү дээ. Тийм учраас хуулиндаа бусад

хуулинд заасантайгаа адилхан жишгээр төрийн бус байгууллагуудын төлөөлөл болон хөрөнгө оруулагчдын төлөөлөлийг оруулж өгнө гэдгийг онцолсон. Нэг л зүйлийг буюу сайд ажиллах журмыг нь зааж өгнө гэж л оруулсан.

Би нэг тайлбар хиймээр байна. Энд Багануур, Багахангай, Налайх гээд орон нутаг заагаад хөрөнгө оруулалтыг тооцсон байгаа. Үүнийг бид Ажлын хэсэг дээр хөдөө орон нутагт хөрөнгө оруулалтыг дэмжие л гэж ярилцсан. Улаанбаатарт бүртгэлтэй компани Багахангайд хөрөнгө оруулахыг дэмжие л гэсэн үг. Тийм учраас Улаанбаатар дахь хөрөнгө оруулалтын төвлөрөлийг сааруулаад, орон нутаг руу оруулах хөрөнгийг нэмэгдүүлэх гэсэн утгаар л орсон. Уул уурхай, хүнд үйлдвэр, дэд бүтцийг хариуцсан сайд нь үүнийг мөн орон нутагт тусад нь оруулж өгье гэж ярьж байна. Үүнийг бас тэгээд оруулчих ёстой. 3 тэрбумын хувьд бол, ерөнхийдөө нөгөө жижиг дунд үйлдвэрийн хуулийн тодорхойлолтыг нь аваад тэгж хэмжээ тавьсан. Үүний дараа жижиг дунд үйлдвэрийн тухай хуулинд яаралтай өөрчлөлт оруулах ёстой. Жижиг дунд үйлдвэрт оруулах хөрөнгө чинь янз бүрийн хэмжээтэй байх болно. Үүнийгээ тэр хуулин дээрээ зааж, нийт бизнесийг тэгш эрхтэйгээр авч үзэн, хоорондоо логик уялдаатай хуулиудыг оруулъя л гэж зорьсон юм шүү.

### **Ажил эрхлэлт болон эдийн засгийн оролцоотой өсөлтийг онилдог орчин үеийн загвар энэ бодлогод орж байна**

*2013 оны 10 дугаар сар 8-ны УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хурлын тэмдэглэлээс: “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл хэлэлцэх үеэр уг тогтоолын төслийг боловсруулах Ажлын хэсгийн ахлагчаар ажилласан УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлийн хийсэн тайлбар.*

С.Дэмбэрэл: Өнөөдөр бид 2014 оны мөнгөний бодлогыг хэлэлцэх эсэхийг ярилцаад сууж байна. Тэгэхээр, өмнөх жилүүдийн мөнгөний бодлогыг хамгийн товчхоноор та бүхэнд сануулах нь бас зүйтэй гэж үзэж байна. өмнөх жилүүдэд Төв банк “Эдийн засгаас мөнгийг татаж авах замаар инфляцийг удирдаж болно.” гэдэг /2007 оноос хойш/ гэдэг бодлого дандаа баримталж ирсэн. 2007 оноос өмнө мөнгөний агрегатуудыг зохистой байлгах чиглэлээр бодлого явсан. 2012 онд шинэ УИХ, шинэ Засгийн газар, Монгол банкны шинэ ерөнхийлөгч гарч ирсэн. 180<sup>0</sup> градус өөрчлөгдсөн шинэ зөв бодлого гарч ирсэн. Өөрөөр хэлбэл, УИХ-ын гишүүдийг тойрог дээрээ очиход нь байнга сонсож байдаг “зээлийн хүүг 1 оронтой тоонд оруулаад өгөөч”, “зээлийн олдцийг нэмэгдүүлээд өгөөч”, “зээлийн орчныг сайжруулаад өгөөч”, зэрэг сонгогч бүрээс, ялангуяа бизнес эрхэлдэг сонгогч бүрээс хэлдэг тэр үгийг 2013 оны мөнгөний бодлогод суулгаж өгсөн. Үүнийг бид нэлээд сайн ярилцаж байгаад, 2013 оны мөнгөний бодлогод оо хийж өгсөн билээ. Энэ бодлого хэрэгжиж эхлээд жил ч болоогүй байна. Одоо бид дараагийн

оных нь бодлогыг ярих гэж байна. Энэ тохиолдолд, саяны ярьсан бодит секторын идэвхжилийг нэмэгдүүлэх, төрийн мөнгөний бодлого тодорхой тодорхой секторуудад хэрэгжээд, тэр нь тодорхой үр дүн гараад, үүнийхээ хажуугаар эдгээр бодит секторууд идэвхжсэний дүнд инфляцийн нам дор байх түвшин тодорхой хэмжээгээр хангагдаад байгаа ийм бодлогын цоо шинэ, өмнөхөөсөө 180<sup>0</sup> градус өөр бодлогыг л бид нар ярьж байгаа шүү дээ. Бидний хүсдэг юм маань л энэ шүү дээ. Энийг л дандаа ярьж байдаг. Тэгэхээр энэ маань өөрөө 2014 онд үргэлжлэх юм байна. /Миний уншиж байгаагаар./ 2014 онд үргэлжлэхдээ, тодорхой секторуудын төдийгүй, нийт эдийн засгийн, түүний дотор нийт эдийн засгийг бүрдүүлж байдаг, ялангуяа уул уурхайн бус эдийн засгийг бүрдүүлж байдаг, “Эдийн засгийг солонгоруулъя, олон хөлтэй болгоё” гэж бидний яриад байдаг тэр бодлогыг мөнгөний бодлогоор дэмжих ийм бодлого орж ирлээ гэж би ойлгож байгаа юм. Энийгээ харин зөв томъёолоод, тодорхой хэлмээр байна. Одоо орчин үеийн төв банкнуудын бүгдийнх нь хийж байгаа арга барил буюу зөвхөн инфляцийг онилох төдийгүй, ажил эрхлэлтийг онилдог, эдийн засгийн оролцоотой өсөлтийг онилдог тэр загвар энд агуулгаараа энд орж сууж байна. Эдийн засгийн тэр иммунитет /дархлаа/-ийг сайжруулна гэдэг нь угтаа, цаад санаагаараа бол энэ юм. Энийг нь бид цаашдаа үргэлжлүүлэх ёстой. Энэ талаас нь бодож мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх тийм зүйлийг бид хийх ёстой. Нэг талаас.

Нөгөө талаас валютын ханшны талаар ярьж байна. Үнээн. Оны эхэнд, 01 сарын 25-нд Монгол банкны мөнгөний бодлогын зөвлөл анх байгуулагдаад, валютын ханшийг оны эцэст 1450 байлгахыг тухайн үеийн параметруудээр прогнозлож /хэтийн төлвийг тогтоож/ байсан. Бид явцын дунд, /УИХ юу хийж өгсөн бэ гэхээр/ санхүүгийн тогтвортой байдлыг хангах институцийг байгуулж өгсөн. Тэр санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гол чиг үүрэг нь санхүүгийн тогтвортой байдал, түүний дотор валютын зах зээл дээр ханшийн тогтвортой байдлыг зөвхөн 1 тоглогч биш, төрийн 3 институци хамтраад хийх үүргийг Эдийн засгийн байнгын хороо, УИХ батлаж өгсөн. Тэгээд саяхан 7-8 дугаар сард болсон ханшийн хөдөлгөөнтэй холбоотой бүх протоколыг нь аваад үзэхээр, бидний ажил хийгээрэй гэж байгуулсан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл маань ажиллаагүй, зөвхөн Монгол банкыг үлдээгээд явчихсан байна. Бүх баримтаар ингэж нотлогдож байна. Тэгэхээр энэ бодитой баримт фактуудыг бид харж байж, энэ талаар цаашдаа авч авах арга хэмжээнүүдийг 2014 оны мөнгөний бодлогодоо суулгаж өгөх ёстой. Дутагдалтай талууд байна. Сайн талууд ч байна. Өөрөөр хэлбэл урьд өмнө нь огт байгаагүй, тэр байтугай 2009 оны хямралын үед хувийн хэвшлийг золиослох замаар эдийн засгийг аврана гэж байсан тэр бодлого 2010-2011 онд үргэлжлээд, ерөнхийдөө хатуу мөнгөний бодлого хэрэгжиж байсан тэр үеийг та бүхэн эргээд нэг санаад үзээсэй гэж бодож байна. Мөнгөний бодлогыг хэрэгжүүлдэг институци, Засгийн газар хоёрын хоорондын уялдаа тааруу байсан. Энэ уялдааг бий болгохын тулд санамж бичгүүд гаргаж эхэлсэн. Дээр нь 1,5 тэрбумын бондыг байршуулах санхүүгийн хэлцэл хийсэн. Санамж бичиг байгуулсан. Институцийн хувьд 2 тал үүргээ авсан. Одоо энийг Засгийн газрын зүгээс яаж дэмжсэн бэ, яаж биелэлтийг нь хангасан бэ гэдгийг гаргаж ирээд, үүний дараа 2014 оны

мөнгөний бодлого дээр хэрэгжиж ирсэн тэр бодлогыг гүнзгийрүүлэх, нийт эдийн засгийн идэвхжлийг, түүний дотор уул уурхайн бус эдийн засаг, жижиг дунд бизнес, тэр байтугай бичил бизнес буюу та бүхний тойрог болгон дээрээ очиж уулзах үед иргэдийн хэлж байдаг тэр санаануудаар л мөнгөний бодлогоо цаашид хэрэгжүүлэх ёстой. Ийм ч учраас ажлын хэсэг байгуулах, тэр ажлын хэсэг дээрээ энэ асуудлыг гүнзгийрүүлэн ярих, томьёолох зүйлийг хийгээсэй гэж бодож байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

### **Нэмэлт арга хэмжээ авсанаар л хэрэгжих боломжтой зүйлс**

***УИХ-ын “Мянганы хөгжлийн зорилтууд болон ядуурлыг бууруулах асуудлын дэд хороо”-ны хуралдаан 2013 оны 11 сарын 01-нд болж, “Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн талаарх үндэсний тав дахь илтгэл”-ийг авч хэлэлцэх цээр УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлийн хэлсэн үг:***

- Миний хувьд асуулт алга, шууд саналаа хэлье. Эхний зорилтын хүрээнд “Ядуурлыг бууруулах үндэсний стратеги алга байна. Үүнийг бий болгоё.” гэж дүгнэсэн байна. Энэ зөв. Ерөнхийдөө өнөөдрийн байдлаар эдийн засгийн хөгжлийн яамны цахим хуудсан дээр “ядуурал” гэсэн нэг үг байгаа. Статистикийн мэдээн дотор нэг зүйл бий. НХХАХЯ дээр энэ чиглэлээр хийж байгаа бага зэргийг ажил байгаа. Гэхдээ Монгол Улсад ядуурлын талаар анхаарч үздэг нэгдсэн бодлого байхгүй болсон, өөрсдийн санал санаачилга гэдэг юм алдагдаад хэдэн жил болж байна. Тийм учраас “country ownership” буюу Монгол улс өөрийнхөө асуудлыг өөрсдөө шийдвэрлэдэг бодлого хэрэгтэй. Түүнээс биш, “Дэлхийн зөн”, “Дэлхийн банк” ирж шийддэг юм биш гэдгийг анхаарах ёстой.

- Энд “дүгнэх боломжгүй” гэсэн нэлээд хэдэн зүйл байна. Жишээлбэл, Зорилт-4 дээр “төвлөрөл, шилжих хөдөлгөөнтэй холбогдон гарч буй сөрөг үзэгдлийг багасгах, шилжин суурьшигчдийг нийгмийн суурь үйлчилгээнд хамруулах” гэдэг зүйл бол дүгнэх боломжгүй биш, дүгнэх боломжтой зүйл. Харин нэмэлт арга хэмжээ авснаар хэрэгжих боломжтой зүйл юм. Ер нь дүгнэх боломжгүй юм гэж байхгүй. Дүгнэх боломжгүй гэж байгаа бол юу ч хийгээгүй л гэсэн үг. Энэ чиглэлээр Улаанбаатар хотын хэмжээнд, аль эсвэл бусад холбогдох яамдын хэмжээнд хийж байгаа ажлууд байгаа. Үүнийг бас анхаарах хэрэгтэй.

- “Улс төрд, шийдвэр гарах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх” гэдгийг “дүгнэх боломжгүй” гэсэн байна. Энэ бас л нэмэлт арга хэмжээ авснаар биелэгдэх боломжтой зүйл. Заавал, УИХ-д эмэгтэйчүүдийн тоог 30%-д хүргэх гэхээсээ илүү, гүйцэтгэх шатанд эмэгтэйчүүдийн оролцоо ямар байгаа юм бэ, тухайлбал гааль, татварын байгууллагуудыг аваад үз. Тэдгээрийн удирдах албан тушаалууд, яам, тамгын газруудыг тооцоод үз. Энд улс төр, шийдвэр гаргах түвшин гэдэг 2 үгийн хооронд таслал байгаа шүү дээ. Эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшинд оролцох

оролцоо бий. Энэ нэмэгдэж байна. Гэхдээ нэмэлт арга хэмжээ авснаар улс төрийн дээд албан тушаалд эзлэх тоо нэмэгдэх тухай ярихаас биш, үүнийг хэмжих боломжгүй гэж ярьж болохгүй. Ялангуяа бүхэл бүтэн улс ингэж дүгнэж болохгүй.

- Дараагийн асуудал бол “байгаль орчны тогтвортой байдлыг хангах” гэдгийг биелэх боломжгүй гэсэн байна. Энэ чинь юу гэсэн үг вэ? Мэдээлэл яаж авдаг юм бэ? Энд ой нутгын эзлэх хувь, хэмжээ гэхчилэн бичсэн байна. Байгаль орчны тогтвортой байдал гэдэг юм ярьж байхад, шал өөр юмнууд хамаад бичээд байх юм. Тогтвортой хөгжил гэдэг асуудал нь манай улсын гол зорилт болоод явж байгаа. Үүнийг Засгийн газрын тухай хуулинд өөрчлөлт оруулаад, тогтвортой хөгжил гэдэг үгийг Монгол Улсын засаглалын түүхэнд анх удаа авч хэрэглэн, ерөнхий сайдын шууд хариуцах ажил болгон тогтож, Тогтвортой хөгжлийн үндэсний хороо байгуулагдаад, нэг удаа хуралдчихаад байна. Дээр нь УИХ-аар ногоон хөгжлийн асуудал, энэ бүхэн ороод, одоо баглагдах шатандаа явж байгаа гэх мэтчилэн мэдээллүүд нь байсаар байтал энэ чиглэлийн юмнуудаа оруулаагүй байна. Дутуу мэдээлэл аваад орхисон байна. Хийгдэж байгаа ажил дээрээ нэмэлт арга хэмжээ аваад бүрэн биш хэдий ч, биелэх боломжтой гэж үзэж байна.

- “Худалдааны болон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх замаар Мянганы хөгжлийн зорилтыг хангах таатай нөхцөл бүрдүүлэх...” гээд энд бичихдээ маш дутуу дулимаг юм бичсэн байна. Худалдааны болон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх гэдэг маань өөрөө манай улсад ид явагдаж байна шүү дээ. Одоо УИХ-ын Эдийн засгийн байнгын хороон дээр “Санхүүгийн секторын шинэчлэлийн иж бүрэн баримт бичиг” мөдхөн батлагдана. Ийм зорилготой ажлын хэсэг байгуулагдаад, би өөрөө тэрийг нь ахлаад ажиллаж байгаа. Дээр нь санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр холбогдох яамууд, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийг байгуулаад, энэ чиглэлээр институцийн хувьд хөгжүүлээд явж байна. Энэ бүхэн чинь ажил биш юм уу? Дээр нь худалдааны хувьд энд зөвхөн экспорт, импорт гэж бичихийн оронд Монгол Улс худалдааны бодлогын хувьд юу хийсэн юм бэ гэдгийг яагаад бичээгүй юм бэ? Дөнгөж сая, сарын өмнө Засгийн газар “Экспортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” баталчихлаа. Мөн экспортоор холбогдсон гадаад худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагааг эхлээд, экспорт импортоор шаардагдаж байгаа бичиг баримтуудыг цөөрүүлээд, одоо 4 ажлын хэсэг байгуулагдаад явж байна. Тэдгээрийн дотор худалдаатай холбоотой, санхүүтэй холбоотой бичиг баримтуудыг цөөлөх зорилгоор Ч.Сайханбилэг сайдаар ахлуулсан ажлын хэсэг ч ажиллаад, лиценз, тусгай зөвшөөрлүүдийг багасгах гээд оролдож байна. Ийм л юмнуудаа бичнэ шүү дээ. Хилийн худалдааг өргөжүүлэн хөгжүүлэхийн тулд “Хилийн боомтын тухай” хууль удахгүй УИХ-аар эцсийн хэлэлцүүлэгтээ ороход бэлэн болчихоод явж байна. Худалдаатай холбоотой өөр олон зүйл бий. Жижиг дунд бизнесийг хөгжүүлэх сангаас “импортыг орлох, импортын бүтээгдхүүнтэй өрсөлдөх үйл ажиллагааг дэмжинэ” гээд Засгийн газар нь өөрөө мөрийнхөө хөтөлбөрт зорилт тавиад, 2013, 2014 оныхоо үйл ажиллагааны үндсэн чиглэлд хийчихсэн байгаа. Энэ бүхнийгээ хийх ёстой шүү дээ. Тэгээгүй байж “биелэх боломжгүй” гэхсэн байх юм. Энэ тэгэхээр маш дутуу мэдээлэл байна. Эдгээр нь мөн



л хэрэгжих боломжгүй асуудал биш, харин нэмэлт арга хэмжээ авсанаар биелэгдэх боломжтой асуудал.

- “Далайд гарцгүй Монгол Улсын онцгой хэрэгцээ шаардлагыг харгалзан, илүү тааламжтай нөхцөлөөр далайд гарцтай болгох, гадаадаар дамжин өнгөрөх тээврийн үр ашгийг дээшлүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийг өргөжүүлэх...” гээд, үүнийг бас “биелэх боломжгүй” гэхсэн байна. “Транзит Монгол” гэдэг хөтөлбөр хэрэгжээд явж байгаа. УИХ-ын гишүүн Г.Батхүүгийн ахалсан “Тээвэр ложистикийн үндэсний сүлжээ хийх ажлын хэсэг” байгуулагдаад, тэр нь ажлаа хийгээд дуусч байна. Мөдхөн Эдийн засгийн байнгын хорооноос ажлын хэсэг ажиллаад, энэ ондоо багтаж бодлогын баримт бичгээ гаргах гэж байна. Ноднин жил энэ чиглэлээр хийсэн өчнөөн ажил бий. Төмөр замын дамжин өнгөрөх, нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлэх чиглэлээр хичнээн олон арга хэмжээ авч байгааг мэдэж байна уу? Энэ бүхнийг бич. “биелэх боломжгүй” гээд хаячихсан байх юм. Мэдээлэл чинь дутуу байна. Энэ бас л нэмэлт арга хэмжээ авсанаар хэрэгжих боломжтой асуудал мөн.

- Харин “мэдээлэл, холбооны шинэ технологийг хөгжүүлэх, мэдээлэлжсэн нийгэм байгуулах...” гэдгийг “бүрэн биелсэн” гэж үнэлсэн байна. Энэ худлаа. Бүрэн биелээгүй, харин хэрэгжиж байна. Монгол улс мэдээлэлжсэн нийгэм болоогүй байна. Малчдыгаа хар. Wi-Fi интернет сүлжээнийхэн хамралтыг хар. Сургуулиудын бага, дунд түвшин дэхь компьютержсэн байдлаа хар. Энэ ямар түвшинд хүрсэнийгээ “бүрэн биелсэн” гэж бичдэг юм бэ? Процесс явагдаж байна. Мөн л нэмэлт арга хэмжээ хэрэгжүүлсэнээр биелэх боломжтой асуудал.

- “Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хэрэгжүүлэх...” гэдгийг “дүгнэх боломжгүй” гэхсэн байна. Учлаарай, хамгийн дүгнэх боломжтой юм чинь энэ. “1111”, “Ард иргэдээ сонсоё.” “нээлттэй засаг, утас” гээд л янз бүийн машин ажиллуулаад л байна. “Хүний эрхийг хангах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх, нээлттэй нийгэм, нээлттэй төр засаг”, “шилэн цонх” “шилэн түрийвч”, шууд ардчилал гээд 2000 хүн бэлдэж байгаа энэ бүхэн чинь юу юм бэ? Эд чинь бүгд л хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хэрэгжүүлэх чиглэлээр хийж байгаа ажлууд. Эд чинь бүхэл бүтнээрээ Засгийн газрын тайланд нь тусчихсан байгаа. Түүнээс гадна Монгол улсын хүний эрхийн комиссоос жил болгон илтгэл тавигддаг. Дээр нь Р.Бурмаа гишүүний ахалдаг хүний эрхийн ажил хүртэл байгаа. Энэ бүгдийг цуглуулаад, мэдээлэл аваад бич. Энэ чинь дүгнэх боломжтой. Харин нэмэлт арга хэмжээ авснаар хэрэгжих боломжтой. Өөрөө хэлбэл нэмэлт санхүүжилт болон бусад арга хэмжээ хэмжээг нэмж авсанаар хэрэгжих боломжтой ажлууд.

- “Ардчилсан үндсэн зарчим...” гээд яг ижилхэн зүйл байна.

- “Авилгыг тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон, хэвшүүлэх...” гэнэ. Үүнийг бас “дүгнэх боломжгүй” гэхсэн байна. Та нар улс төрийн үр дагаварыг нь бод доо. Монгол Улс өнөөдөр “Transference international”-ийн хувьд ямар байдалтай байна? Өөрсдөө ямар хүчин чармайлт гаргаж байгаа билээ? Энэ чиглэлээр юу хийж байгаа билээ? Хүнд суртлыг арилгах гэсэн их ажил өрнөж байгаа нь авилгалыг үндсээр арилгах гэсэн оролдлого. Энэ чиглэлээр хийж байгаа реформ өөрчлөлтүүдээ ингэж



үнэлээд биччихээр бид яах юм? Бүрэн биеллээгүй ч нэмэлт арга хэмжээгээр хэрэгжих боломжтой л ажлууд шүү дээ.

Иймэрхүү л байна. Бүхэлд нь дүгнээд хэлэхэд, дээр хэлсэн бүх “биелэх, дүгнэх боломжгүй” гэж үзэж байгаа зүйлс чинь нэмэлт арга хэмжээ авсанаар л хэрэгжих боломжтой зүйлс. Тиймээс эдгээрийг үүндээ зөвөөр оруулж тусгаж өгөх хэрэгтэй.

## **Эрүүл мэндийн салбарын санхүүжилт хүрэх ёстой түвшиндээ хүрээгүй байна**

*УИХ-ын “Мянганы хөгжлийн зорилтууд болон ядуурлыг бууруулах асуудлын дэд хороо”-ны хуралдаанаар “Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн талаарх үндэсний тав дахь илтгэл”-ийг авч хэлэлцэх цеэр:*

Р.Бурмаа: - Засгийн газрын хийж байгаа бүх зүйлийг мянганы хөгжлийн зорилтын хэрэгжилт рүү авчирч хийгээд байх юм бол тусад нь ингэж 26 зорилт гаргаж ирж давхар ярих ямар хэрэгтэй юм бэ? Мянганы хөгжлийн зорилтыг биелүүлэхийн тулд төсөвтөө ийм зүйлсийг тухайлан нэмж оруулах хэрэг юу байгаа юм бэ? Ерөөсөө л засгийн газрын хийж байгаа ажлыг бүхэлд нь хамруулах гэж байгаа юм бол иусад нь ингэж ярьж цаг барж яах юм бэ?

С.Дэмбэрэл: - Р.Бурмаа гишүүний үгийг дэмжиж байна. Бид цаг алдаж байна. Тийм учраас үүнийг буцаая. Сайжруул. Нэмж хэлэх нэг санал байна. “Бүрэн биелсэн” гэж бичсэн байна. Тийм зорилт байхгүй. Тэр байтугай Эрүүл мэндийн салбарт, нялхсын эндэгдэл Ази Номхон далайн бүсдээ буурсан хэдий ч ерөнхий утгаараа өндөр байгаа. Үүнийг биелсэн гэж хэзээ ч ярьж болохгүй. Дээр нь эрүүл мэндийн салбарын санхүүжилт дотоодын нийт бүтээгдхүүнтэй харьцуулахад хүрэх ёстой түвшиндээ хүрээгүй байгаа. Ийм, хүрэх ёстой болзоллоо хангаагүй байж “биелсэн” гэж ярьж огт болохгүй. Ихэнх зүйлдээ “нэмэлт санхүүжилт, нэмэлт арга хэмжээ авч байж биелэх боломжтой” гэсэн тийм л хариу гарахаар байна. Ялангуяа “бүрэн биелсэн” гэдэг үг бүр байхгүй шүү гэдгийг анхаарах хэрэгтэй.

Нөгөө талаар “Мянганы хөгжлийн зорилтууд” гэдэг энэ зүйл маань хэдэн яамнуудын дунд хаячихсан зүйл болжээ. Ямар нэг байдлаар үүнийг хариуцсан, хооронд нь уялдуулсан, нэгтгэж базсан, үүнд ач холбогдол өгсөн институци байхгүй учраас Монгол Улс өнөөдөр “архагшсан ядуурал”-тай болчихоод, үүнийгээ арилгаж чадахгүй байгаа шүү. Мянганы хөгжлийн зорилт үүнд л уг нь чиглэж байгаа юм. Тийм учраас институцийн хувьд мянганы хөгжлийн зорилтуудыг цаашдаа болон 2014, 2015 онуудад хэрэгжих Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилтуудтай хэрхэн холбож биелүүлэх юм бэ гэдгийг Институцийнх нь хувьд бид бас тодорхойлж хэлж өгөхгүй бол болохгүй юм байна. Тийм учраас миний санал бол, энэ тайлан илтгэлийг буцаая. Гишүүдийн хэлсэн саналуудыг аваад, мэдээ мэдээллээ нэмж сайн хийгээд дахин оруулж ирэх хэрэгтэй. Дахин хэлэхэд “бүрэн

биелсэн” зорилт нэг ч байхгүй шүү. Анхаарал тавьсанд баярлалаа.

бид өнөөдөр Монгол улсын хөгжлийн хандлагыг ярилцаж байна. Хэн нэгэн судлаачийн “би үүнийг ингэж бичсэн юм” гэсэн хувийн дүгнэлт, тайлбараас илүү, монголчууд бид гадаадын ямар нэг тусламж дэмжлэгт дулдуйдаж, хамаг юмаа хаялгүйгээр, өөрсдийнхөө хүчээр хөгжилдөө хандах хандлагыг шүүн хэлэлцэж, ярилцаж байгаа болохоос биш, хэн нэгэний тайланг юм уу, хэн нэгэнд “бүрэн биелчихлээ” гэж тайлагнах явдал гол нь биш юм. Бид хамгийн гол нь олон жилийн турш хөгжилд хандах хандлагаа цемент, байшин, дэд бүтэц зэрэг зүйлсээр орлуулдаг байдалтай явж ирлээ. Гэтэл хүнээр, эрүүл мэндээр, боловсролоор нь дутуу орлуулдаг энэ хандлагыг ярьж байна. Тийм учраас, “бүрэн биелсэн” гэж хэлээд байгаа зүйлсийг чинь “бүрэн биелээгүй” гэж үзээд байгаа юм. Танай Эрүүл мэндийн яамны 2012 оны илтгэл дээр чинь “Ази Номхон далайн орнуудтай харьцуулахад манай эдгээр үзүүлэлтүүд сайжирч, ДЭМБ-аас магтагдсан боловч бодит амьдрал дээр 0-5 насны хичнээн хүүхэд анхан шатны тусламж авч чадахгүйн улмаас ямар нэгэн шалтгаанаар амь насаа алдаж, бэртэж гэмтэх, эндэх, рахит сульдаа тусах зэргээр ядуурал ба эрүүл мэндийн кореляци хамаарал нь сүүлийн хэдэн жилд нэмэгдсэн байна шүү дээ. Танай яамны тайлан мэдээн дээр энэ байж байгаа. Энэ бүхнийг бид ярьж, цаашдынхаа зорилтыг бодитойгоор тогтоох гээд байгаа юм. Хэн нэгэний илтгэлийг хэлэлцээгүй. Ажил хийх гээд байна. Тийм учраас үүнийгээ буцааж авч яваад сайжруулаад аваад ир гэж байгаа юм. Одоо асуулт хариулт гэж цаг алдаад хэрэггүй. Шийдвэрээ гаргаж буцаая, сайжруулж ирсэний дараа дахин хэлэлцье.

### **Зах зээлийн жамаар ард түмнийг хохироож болдоггүй юм**

*“Зууны мэдээ” сонины сурвалжлагч УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлтэй  
уулзаж, цаг үеийн асуудлаар ярилцжээ.*

- Ам.долларын ханш 1748 төгрөгт хүрлээ. Үүнээс болж ам.долларын зээлтэй хүмүүс, компаниуд ихээхэн алдагдал хүлээж, зарим нь үүдээ барихад ойрхон байна. Эндээс ярилцлагаа эхэлье?

- Энэ асуудал бүр долдугаар сарын сүүлчээс л эхэлсэн юм шүү дээ. Тэр үед МХАУТ компаниудаасаа мэдээлэл авч байлаа. Харин улс төр амарч, компаниуд ажиллаж байлаа. Валютын ханш өссөөр байгаад одоо 1760 болчихлоо. Хараад байхад аль аль талаасаа арга хэмжээ авах шинжгүй. Холбогдох хүмүүсийнх нь өгч байгаа тайлбар нь “Зах зээлийн жамаараа явж байгаа” гэнэ. Тэгвэл зах зээлийн жамаар ард түмнийг хохироож болдоггүй юм. Валютын ханшийн тодорхой түвшин юмны үнэнд нөлөөлөөд, зугуухнаар өсөөд ирэх үед төгрөгийн худалдан авах чадвар унадаг. Түүнчлэн бизнес хийж байгаа хүмүүст ч хохиролтой болж ирдэг юм. Одоо экспортлогчдод ч ялгаагүй хохиролтой тусч байна. Экспорт хийхийн тулд импортын орц авдаг л байхгүй юу. Тиймээс нийт бизнест хохиролтой болчихлоо. Ялангуяа импортоор худалдаа хийдэг, завсрын бүтээгдэхүүн

авч үйлдвэрлэлээ явуулдаг, дээрээс нь валютын зээлтэй, тендерт оролцсон компаниуд одоо зовж байна. Хажуугаар нь татварынхаа орлогыг биелүүлэх гээд компаниудыг дарамталж эхэллээ. Бас компаниудыг эрүүгийн хэрэгт татах хуулийн заалтууд байна. Энэ мэтчилэн хувийн хэвшлийнхэнд очих дарамт их байгаа учраас Ерөнхийлөгч маань “*бизнесмэнцүдийг хамгийн их дарлагдсан ард түмэн*” гэж хэллээ шүү дээ.

- Тэгвэл валютын ханшийн өсөлтийг хэрхэн зохицуулах вэ? **Бизнесмэнүүдийн алдагдлыг яах вэ?**

- 2014 оны “Мөнгөний бодлого”-д энэ талаар өөрчлөлт оруулсан. Би өөрөө ажлын хэсгийн ахлагч байсан. Бас Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны ажлыг хянах ажлын хэсгийн ахлагч нь байсан. Валютын ханшийн тухайд анхны төсөл дээр ганцхан л заалт орж ирсэн байсан юм. Тэр нь “*Макро эдийн засгийн нөхцөлтэй нийцсэн валютын ханш цаашид уян хатан тогтох зарчмыг цргэлжлүүлэн баримтална*” гэсэн нэг л өгүүлбэр байсан. Жил бүр л ийм өгүүлбэр орж ирдэг. Тиймээс энэ жил тэр өгүүлбэрийг нь өөрчилсөн. Валютын ханш бодитой тогтох нь зүйтэй. Гэхдээ төр гэж байгаа бол валютын ханшийн эрсдэлээс хамгаалдаг дэлхий дахинд хэрэгжүүлж байгаа арга хэрэгслийг ашиглах бодлого хэрэгтэй. Бодлого гэдэг маань, зүгээр сул тавьчихыг хэлдэггүй юм аа. Гэтэл валютын зах зээлд оролцогчдын тоо цөөн байна. Тиймээс ирэх оны мөнгөний бодлогод валютын зах зээлийг өөрчлөхөөр тохирсон.

- **Яаж өөрчлөх юм бэ?**

- Нэгдүгээрт, валютын үүсмэл хэрэгслийн зах зээлийг бий болгох, хоёрдугаарт, валютын ханшийн зах зээлд оролцогчдын тоог банк бус санхүүгийн байгууллагууд, томоохон экспортлогчид, импортлогчдыг оролцуулсан онлайн дуудлага худалдаа хэлбэрээр явуулах боломж байна. Гуравдугаарт, валютын нэрлэсэн болон бодит ханш тогтож байгаа үйл явцад дүгнэлт хийх, түүнийгээ макро эдийн засгийн бусад үзүүлэлттэйгээ уях чиглэлээр Монголбанкны мөнгөний бодлогын талаар гаргасан УИХ-ын тогтоол, нэг хэсэг заалт нь орж өгч байгаа. Нэг хэсэг заалт нь Эдийн засгийн байнгын хорооны хурал, протокол, Монголбанкны 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд суух гэж байна. Тэгэхээр ирэх онд Монгол Улс валютын өөр бодлоготой явна. Ханшийг дур зоргоор нь тавих биш, харин удирддаг болох юм. Зөвхөн интервенцээр бас биш. Ингэх нь урагшлахгүй байна. Нөөцөө бараад дуусах нь. Тиймээс интервенцээс гадна, валютын ханшийн эрсдэлээс хамгаалсан механизмыг нийт зах зээлд оролцогчдод бий болгох хэрэгтэй байна.

- **Одоо 2013 он. Таны хэлж буй санаа ирэх онд хэрэгжинэ гэсэн хаягтай байна шүү дээ. Эдийн засагчдад яг одоо л үр дүн хүлээж байна?**

- Тийм ээ. Ирэх онд хэрэгжих бодлогыг зүгээр хараад суух уу гэсэн асуулт гарч байгаа юм. Валютын дотогшлох урсгалд ойрын 3-5 сард өөдрөг дүр зураг харагдахгүй байна. Гадаадын хөрөнгө оруулалтынхаа хуулийг дөнгөж саяхан баталлаа. Бас л өөдрөг дүр зураг харагдахгүй байна. Гэтэл одоо “*Гадаадаас л мөнгө орж ирвэл валютын ханш тогтворжино*” гээд байна шүү дээ. Тиймээс шаардлагатай бүх арга хэмжээг дараагийн зургаан сард хэрэгжүүлэхээр төлөвлөх ёстой. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр төгрөгөөр гүйлгээ хийх хуулийн заалтыг сайжруулах, сайн хянадаг

болгохоос гадна компаниудаа, түүний дотор экспортын орлого оруулдаг компаниудаа янз бүрийн татварын шалгалт, мэргэжлийн хяналтынхны дарамтаар дарамтлахаа болих хэрэгтэй. Аль ч улсад хямралаас авч гардаг хүмүүс нь хувийн хэвшлийнхэн л байдаг. Энэ үед Монголбанкнаас валютын ханшид стандарт бус аргыг хэрэглэж болно шүү дээ. Ийм аргуудыг нь ч МҮХАҮТ-аас санал болгож байгаа.

**- Дээрх арга хэрэгслүүдийг авлаа гэхэд компаниудын алдагдлыг нөхөж, иргэдийн амжиргаанд нөлөөлж амжих уу?**

- Үнэхээр анхаарлаа хандуулж чадвал ханшийг гааруулахгүй байж болно. Ямар ч гэсэн одоо энэ арга хэрэгслүүд, стандарт бус аргуудыг ашиглахыг МҮХАҮТ түрүүлж дуугарч санал болгож байна. Ханшийн эрсдэлээс хамгаалах механизм чинь нэг өдрийн дотор хийгдчихдэг эд биш шүү дээ. Хугацаа авна. Энэ хооронд цаг алдахгүйн үүднээс валютын ханшийг удирдах арга хэрэгслээ ашиглах хэрэгтэй.

**- Танхимынхан түрүүлж дуугарсан гэлээ. Гэхдээ олон хүн харин ч танхим оройтож байр сууриа илэрхийллээ. Ниргэсэн хойно нь хашхирав гэгч болж байна гэж үзэх нь ч байна лээ?**

- Үгүй ээ үгүй. Бид аль хэдийнэ дуугараад эхэлсэн. СЕО форумд би 650 бизнесмэний өмнө *“Валютын ханшаас болж хохирсон хүн байна уу”* гэхэд тэр хүмүүс бүгд гараа өргөж байсан юм. Өмнө нь бүр нэгдүгээр сард, ноднин жил, бүр тэгж ярьвал ирэх оны мөнгөний бодлогод санал болгосон шиг саналуудыг бид байнга тавьсаар ирсэн. Харамсалтай нь, тэр үед би УИХ-ын гишүүн байгаагүй. Ямартаа ч УИХ-ын гишүүн болоод макро эдийн засаг, мөнгө, төсвийн бодлогод анхаарал тавих ёстой гэж ажилласан. Мөнгөний бодлогын ажлын хэсгийг ахлаад, ямар ч гэсэн зарчмын хувьд огт өөр мөнгөний бодлого болж орсон. Энэ бол зөвхөн инфляцийг онилох биш, эдийн засгийн оролцоотой өсөлтийг томъёолох гэж би хэлдэг юм. Тэр нь бизнесийн орчныг сайжруулах, санхүүгийн орчныг сайжруулах, бизнесийн санхүүжилтийг сайжруулах явдал. Энэ талаар дуугардаг ганц байгууллага нь МҮХАҮТ л даа. Танхим оройтож дуугараагүй ээ. Харин засаг оройтож ойлгож байна. Танхим байнга эртэч шувуу шиг дуугарч байсан бол засаг шар шувуу шиг орой ойлгож байна л даа.

**- Тэгвэл та УИХ-ын гишүүн болсноосоо хойш хэзээ анх удаа ам.долларын ханшийн талаар, бас ам.долларын зээлтэй хүмүүсийн талаар мэдэгдэл хийсэн юм бэ?**

- УИХ-д орж ирснээсээ хойш *“2013 оны төсөв хагас халамжийн төсөв байх нь. Валютын ханшийг удирдах ёстой шүү”* гэдгийг байнга л дуугарч байна. Ер нь энэ чиглэлээр юм хийх шинжгүй, урсгалаар тавих гээд байна. Тиймээс ирэх оныг хүлээлгүй арга хэмжээгээ авч эхэлье гэж өнгөрсөн Лхагва гаригт Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк Эдийн засгийн байнгын хороон дээр хуралдлаа. Өнгөрсөн хугацаанд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл дэх байгууллагууд валютын ханшийн талаар тодорхой ажил хийгээгүй. Зөвхөн Монголбанк интервенц хийж, ханшийг тогтоох гэж оролдож байна. Тиймээс дээрх болсон уулзалтаар ерөнхийдөө ажлын хэсэг байгуулагдсан. Энэ ажлын хэсэг дараагийн зургаан сард ханшийг гааруулахгүй байх, ханшийг 2000 хүргэхгүй байх, 1700 гэсэн ханшийг бууруулах бүх арга хэрэгслийг хэрэглэнэ.

- Зарим бизнесмэн таныг УИХ-д сонгогдсон учраас ам.долларын ханшийг зохистой төвшинд барих бодлогод нөлөөлж, шийдвэр гаргуулах байх гэж харж байсан гэдэг. Гэтэл ханш 1700 давж, 1800 руу дөхөж, ам.долларын зээлтэй хүмүүс хохирлоо. Та тэдэнд ямар хариулт өгөх вэ. Эсвэл ганц хүн дуугараад, санал нь цуурай болоод байна уу?

- Нэг хүн нөлөөлж болно л доо. Нөлөөлж эхэлж л байна. Ингэвэл онгирсон хэрэг болчих байх. Мөнгөний бодлогод валютын ханшийн талаар нэг өгүүлбэр байдаг байсан бол би зургаан өгүүлбэр болголоо. Бодлогынх нь чиглэлийг гаргаад өглөө. Гэхдээ Дорж гэдэг иргэн, Дондог гэдэг бизнесмэн хохиролтой байгааг шууд С.Дэмбэрэл гэдэг хүн хэлээд л болчихдог эд биш шүү дээ. Би өөрийнхөө хэмжээнд л, УИХ-ын гишүүнийхээ хувьд, олгогдсон эрх мэдлийн хүрээнд, надад байгаа хуримтлуулсан туршлагынхаа хүрээнд л нөлөөлөх бодлогынхоо баримт бичигт нөлөөлөөд сууж байна. Дээр нь шуурхай байдлынхаа талаасаа өөрөө санаачлаад дээр дурдсан байгууллагуудын удирдлагуудыг уриад, Эдийн засгийн байнгын хорооны дарга нь сууж байгаад, дараагийн зургаан сард валютын ханшийг гааруулахгүй байх, тогтвортой байлгах, бууруулах боломжуудыг гаргаад ир гэж ярилцлаа. Энэ бол бас тийм ч хожимдсон арга хэмжээ биш. Яагаад гэвэл өмнө нь бүр тавдугаар сард энэ чиглэлээр Эдийн засгийн байнгын хороо тогтоол гаргаж байсан юм. Энэ оны нэгдүгээр сард хүртэл *“Хэрэв ийм байдлаар Засгийн газар харуцлагагүй явбал валютын ханш асар их сулрах нь байна шүү”* гэж Монголбанкны хурлын протоколд гурван удаа сануулсан байдаг юм. Энэ юу гэсэн үг вэ гэхээр, манай төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо их муу байна. Ханшийг суларна гэдгийг мэдэж байсан хэрнээ арга хэмжээ аваагүй л байхгүй юу. Тэр байтугай валютын ханш ид суларч байх үед буюу долдугаар сард бүх хүн амарчихсан байхад, Монголбанк өөрт хуулиар олгогдсон интервенцээ хийж байхад, Засгийн газрынхан байхгүй л байсан. Ерөнхий сайд тухайн үед ярьж байсан л гэж байна. Гэхдээ тэр нь Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн протокол дээр нь байдаггүй. УИХ-ын дарга ямар сайндаа Санхүүгийн зохицуулах хорооны дэд даргыг дуудаж олны өмнө загнаа биз дээ. Гэтэл тэр шалтгаан биш байхгүй юу. *“Найман шарга”* шалтгаан биш. Тэнд ханшин дээр тав, арван төгрөг нэмж зардаг хэдэн хүн л бий. Санхүүгийн зах зээлийн 96 хувьд нь биш, 4 хувьд нь л байдаг хүмүүс. Хамгийн гол нь төр засгийн төсвийн бодлого юм. Хөрөнгө оруулалтын бодлого нь өнгөрсөн нэгдүгээр сараас хойш уялдаа холбоогүй явж ирлээ. Монголбанкны дүгнэлтээр бол энэ оны нэгдүгээр сарын 20-ны үеэр Засгийн газарт сануулж байсан байна. Тухайн үедээ захидал бичиж байсан байна шүү дээ.

- Засгийн газар гэснээс Ерөнхий сайд валютын ханш өсгөсөн хэргийн эздийг олчихсон, удахгүй зарлана гэснээс хойш багагүй хугацаа өнгөрлөө. Та ажлын хэсгийн ахлагчийн хувьд, бизнесмэнүүдийн төлөөллийн хувьд энэ тухайд чих тавьж л байгаа биз дээ?

- Хөөрөгдсөн хүмүүсийг олсон гэж байгаа нь хувь хүмүүсийн асуудал биш байхгүй юу. Энэ бол институцийн үр ашгийн асуудал. Тэрнээс биш А гэдэг валют солилцооны цэг дээр ханшийг нэмж зарж байгаа хэрэг огт биш. Банкнуудын 7-9 дүгээр сар хүртэлх өдөр бүрийнх нь ам.долларын гүйлгээ, банк бус санхүүгийн байгууллагууд буюу валютын цэгүүдийн



өдөр бүрийн гүйлгээг харахаар их сонин юм ажиглагддаг юм. Валют солилцооны цэгүүд чинь арилжааны банкуудын зарласан ханшин дээр 10-15 төгрөг нэмж байна. Гэтэл зарим үед дамын хүчин зүйл нөлөөлөх нь байна. Зарим үед ханш 50-80 төгрөгөөр хүртэл нэмэгдчихсэн байдаг юм. Энэ юу гэсэн үг вэ гэхээр валютын ханшид дамын хүчин зүйл нөлөөлсөн гэсэн үг. Олон тендер зарлахад л валютын эрэлт нэмэгдэнэ шүү дээ. Ирэх оны төсөв батлагдлаа. Удахгүй шинэ жил болно. Энэ хэрээр дахиад л эрэлт нэмэгдэнэ. Тиймээс тэвчиж болох валютын зарлагын захиргааны арга байж болно. Ингэснээрээ хөрөнгө оруулалтын ажлууд зогсоно. Гэхдээ валютын ханш тогтворжино.

Ерөнхий сайдын хувьд үнэхээр тэр дөрвөн хувьд нь багтаж байгаа хүмүүсийг хэлсэн бол энэ хаяг нь биш. Валютын ханш өсөөд байгаа шалтгаан нь манай эдийн засгийн суурь шалтгаан буюу гадаадын хөрөнгө оруулалт, экспортын орлого багассанаас гадна, валютын ханшийн бодлого, Монгол Улсын мөнгөний болон төсвийн бодлогын уялдаагүй байгаагаас л болж байна. Түүнээс биш эзэн гэж байхгүй. Эзэн нь гэвэл төр өөрөө. Хөрөнгө оруулалт яагаад багассан билээ? Буруу хууль батлаа биз дээ. Сая түүнийгээ заслаа шүү дээ. Экспортын орлого яагаад багассан юм бэ? “Чалко”, Хятад гээд бөөн юм болоо биз дээ. Ийм субъектив шалтгаанууд их байна. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр Дорж, Дулмаа гэсэн буруутныг хайхаасаа илүү төрийнхөө үйл ажиллагааг л сайжруул гэсэн үг. Ерөнхий сайд тэгж хэлснийг би мэдэхгүй. Гэхдээ эзэн нь хэн юм гэвэл, төр өөрөө.

- **Ерөнхий сайд “Ам.долларын зээл авсан хүмүүс нь ам.долларын орлоготой учраас алдагдал хүлээх зүйлгүй” гэж хэлсэн байна лээ. Та үүнд ямар байр суурьтай байна?**

- Манай бизнесмэнүүдийн маш цөөхөн хэсэг нь ам.долларын орлоготой байгаа. Хэдийгээр экспортлогчид ч гэсэн тэд импортоор бараа бүтээгдэхүүнээ авдаг л байхгүй юу. Тэгэхээр ханш өнөөдөр зөвхөн импортлогчид гэлтгүй экспортлогчдод ч алдагдалтай болгож байна. Тэгэхээр ханш нь өсчихвөл импортоор орж ирж байгаа бараа бүтээгдэхүүнийх нь үнэ өсчихвөл яах вэ.

- **Тэгвэл Ерөнхий сайд ийм хариуцлагагүй мэдэгдэл хийж болох юм уу?**

- Энэ бол хариуцлагагүй мэдэгдэл биш. Энэ бол дутуу мэдээлэл дээр суурилсан зүйл. Засгийн газар мөнгөний бодлогыг сайн судлаад, төсвийн бодлоготой нь уялдаж байна уу гэж харах асуудал. Өнгөрсөн хугацаанд ханшийн өсөлтийг экспортлогчдод ашигтай мэтээр тайлбарлаад байсан. Энэ бол сурах бичиг дээр л байдаг зүйл. Бодит амьдрал эсрэгээрээ байна. Өнөөдөр бүгд хохирч байна. Ялангуяа, хувийн хэвшлийн олонхийг бүрдүүлдэг жижиг, дунд бизнесмэнүүд. Импортлогчид бас их хохирч байна. Импортлогчдыг үзэн ядаад байх юм байхгүй шүү дээ. Тэд чинь ард түмэнд хэрэгцээтэй барааг хурдан оруулж л ирдэг байхгүй юу.

- **Ингэхэд яг одоо валютын ханшийг гааруулахгүй байхад ямар ажил хийх гэж байна вэ?**

- Валютын ханшийг тогтворжуулах, эдийн засгийн идэвхжлийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх ажлын талаар байнгын хорооны тогтоолын дагуу ажлын хэсэг байгуулсан. Энэ бол гурав дахь ажлын хэсэг нь. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороотой шалгалт хийх нэг ажлын хэсгийг нь би ахалсан. Хоёрдугаарт нь,



2014 оны Мөнгөний бодлогыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт бас ажиллалаа. Одоо нэмж валютын ханшийг тогтворжуулах талаар юу хийж болох вэ гэдэг дээр Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд нь ороод, Эдийн засгийн хөгжлийн сайд нь ороод, би, УИХ-ын гишүүн Б.Гарамгайбаатар, А.Тлейхан нар орсон, намуудын төлөөлөл орсон ажлын хэсэг байгуулагдаад Д.Зоригт гишүүн ахалж байна. Тэгэхээр төр, УИХ зүгээр суухгүй байгаа биз дээ.

**- Үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйлгээ хийх тухай хуулиар зээлийг ам.доллараар авч болдог хэр нь бараа бүтээгдэхүүнийг ам.доллараар зарж болохгүй гэж байна. Ингэхээр энэ хууль нь өөрөө валютын ханшийг өсгөхөд нөлөөлөөд байгаа юм биш үү?**

- Наадах чинь л одоо яригдаад байна. Долларжилт бол муу. Энэ тохиолдолд стандарт бус арга хэмжээ авахыг манай танхимаас санал болгож байгаа юм. Ам.долларын зээл, төгрөгийн хадгаламжийн зохистой харьцааг нь тогтоогооч гэж байгаа юм. Өөрөө хэлбэл, хадгаламж эзэмшигч болон компаниуд аль болохоор төгрөгийн зээл авах сэдэл, санааг нь өрнүүлэх зохистой харьцааг арилжааны банкуудад эхний ээлжинд заагаад өгчих. Төвбанк нь үүнийг хэлээд өгвөл арилжааны банк дагахаас өөр аргагүй л болно. Тэгвэл ард түмэн чинь төгрөгөө ам.долларт шилжүүлэх гэж ханш дахин өснө гэсэн хүлээлттэйгээр гүйхээсээ илүү монгол төгрөг тогтвортой байх юм байна. Яагаад гэвэл Төвбанк ийм арга хэмжээ авч эхэлсэн юм байна. Арилжааны банкууд ч үүний дагуу ажиллаж байна гэж үзсэний үндсэн дээр төгрөгтөө итгэх итгэл эргэж сэргэнэ. Нөгөө талаас энэ хууль чинь өөрөө сайн хэрэгжихгүй байгаа. Манай зарим хуульд ам.доллараар тооцоо хийхийг гааль, онцгой албан татвар дээр зөвшөөрчихсөн байгаа. Энэ хуулиудыг яаралтай өөрчлөх үүрэг өгөгдчихсөн. Энэ хуулиудыг ердийн хууль шиг авч үзээд, нэг их удаан хүлээлтэд байх юм байхгүй. УИХ-ын хийх ажил бол урт дараалал дундуур дайрч ороод л, иймэрхүү шинэчлэлийн чанартай хуулиудыг хурдан батлаад өгөх хэрэгтэй.

**- Ер нь энэ хуульд байгаа ам.доллараар зээл өгнө гэсэн заалтыг нь бүр хасчихаж болдоггүй юм уу. Хүмүүст хүү нь бага болохоор ам.долларын зээл ашигтай юм шиг харагдаад байдаг юм билээ?**

- Тийм амархан байсан бол эдийн засаг, онол гэж байх хэрэггүй л дээ. Нэг хэсэг нь хожиж байхад, нөгөө хэсэг нь хохирно шүү дээ. Төвбанк өөрийнхөө харьяанд байгаа 13 арилжааны банкинд бодлогоороо, иргэдийн хадгаламжаа төгрөгөөр хийх сонирхлыг нь, зээл авах сонирхлыг нь өдөөх арга хэмжээг албан бус зөвлөгөө маягаар хийж өгмөөр байгаа юм. Дээр нь энэ үзүүлэлтүүдийг маш сайн хэрэгжүүлсэн банкуудаа заавал байлгах нөөц ч гэдэг юм уу, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтэд нь уян хатан байхаар урамшуулж болно. Энэ бол уян хатан бодлогын л асуудал юм.

**- Таныг хараад байхад зөвхөн МҮХАҮТ-ын даргаар ажиллаж байсан үеэсээ илүү зөөлөрсөн мэт санагдлаа. Засгийн газрыг ч хатуухан шүүмжилдэг байсан шүү дээ. Харин одоо бол судалгаа муутай байна гээд л жаахан бөөрөнхийлөөд байна уу?**

- Үгүй үгүй. Харин ч би илүү хүчтэй байгаа. Дотор нь ороод, бодлогын алдаануудыг нь илүү тод олж харж байна шүү дээ. Өмнө нь би мөнгөний

бодлогыг шүүмжилдэг байсан. Таван жил шүүмжиллээ. Гэтэл энэ жил өөрчилчихлөө шүү дээ. Харин энэ жил би төсөвт орж чадаагүй. Чадах хэмжээгээрээ санал гомдлоо өгөөд, цаасан дээр “Хариуцлагагүй төсөв” гэж бичээд явж байсан. Дараа жил би төсөвт илүү гүнзгий орё гэж бодож байна.

*“Зууны мэдээ” сонины сурвалжлагч Ж.Цогзолмаа*

## **Санхүүгийн секторын шинэчлэл тулгамдсан асуудал болоод байна**

*Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүдийг томилох, чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн 12 дугаар сарын 26-ны УИХ-ын нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс:*

**С.Дэмбэрэл:** - Санхүүгийн зохицуулах хорооны цаашдын үйл ажиллагааны талаар шийдвэр гаргах ёстой хүмүүсийн шинэ бүрэлдхүүнийг хараад сууж байна. Та бүхнийг би үнэндээ сайн мэдэхгүй юм. Ямар ажил, яаж хийж байсан бэ гэдгийг ч мэдэхгүй байна. Санхүүгийн салбартай ойрхон байсан хүмүүс биш гэдэг нь л лавтай байна. Мэдээж, заавал санхүүгийн салбарт ойрхон хүн байх ёстой гэсэн шаардлага байхгүй л дээ. Та бүхэнд анхааруулж хэлэхэд:

*Нэгдүгээрт*, Одоогийн байдлаар, санхүүгийн секторын шинэчлэл, шинэтгэл тулгамдсан асуудал болоод байна. Энэ бол 2014 оны эхний улиралд багтаж орж ирэх ёстой бичиг баримт шүү.

*Хоёрдугаарт*, санхүүгийн секторт (95:5) гэсэн эрүүл бус харьцаа үүссэн байгаа. Энэ харьцааг өөрчлөх чиглэлээр, мөн танай СЗХ-ны удирдлагад байдаг Банк бус байгууллагууд болон бусад санхүүгийн корпорациудтай хамтраад зээлийн хүү санхүүгийн жамаар буурах нөхцөлийг бий болгох ёстой. Энэ тал дээр та бүхний шийдвэр гарах ёстой.

*Гуравдугаарт*, Саяхан СЗХ дээр хийгдсэн шалгалтын дүгнэлт удахгүй танай дээр очно. Тэр дүгнэлтийг шинэ бүрэлдхүүнээрээ үзээд, түүн дээр маш тодорхой өгөгдсөн даалгаваруудыг хэрэгжүүлэх чиглэлээр юу хийх вэ гэдгээ УИХ-д эргэж мэдээлэх хэрэгтэй. Ерөнхийдөө банкны байгууллага давамгайлсан одоогийн санхүүгийн секторын үүргийг өөрчлөн шинэчлэх эдийн засгийн шинэтгэл болон цаашдын салбарын хөгжил дэвшилд танай Хорооны үүрэг оролцоо асар их хэрэгтэй байгаа шүү. Энэ бол зөвхөн хөрөнгийн биржийн асуудал биш, банкбус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоод төдийгүй, одоо хүртэл зохицуулалтанд ороогүй байгаа Ломбардуудын асуудлыг хүртэл танай Хороо өөрсдийн санаачлагаар авч үзэж, судалгаа хийж шийдвэрлэх ёстой. Тэгэхгүй бол энэ улсад бичил санхүүжилтийн ийм нэг хэлбэр бараг л мөнгө хүүлэх аргаар ажиллаж, энэ нь хэний ч анхааралд өртөхгүйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Хэн ч тэднийг тоож, авч үзэхгүй байна. Уг нь санхүүгийн үйлчилгээг зохицуулагч гэсэн утгаараа танай хороо үүнийг анхаарч ажиллах, санаачлагатай хандаж, тодорхой дүрэм, журам, зохицуулалт

оруулж ирэх ёстой. Үүнд, шинээр сонгогдож байгаа гишүүд та бүхэн бүтээлчээр хандах хэрэгтэй. Одоо та нарт миний хэлж байгаа зүйл буухгүй байгаа. Зарим нь, шулуухан хэлэхэд ойлгохгүй байгаа. СЗХ-ны зөвлөл маш чухал шийдвэр гаргах ёстой. Энэ эдийн засгийг бүхэлд нь, тэр дундаа санхүүгийн секторыг бодит сектортой нь холбох бодлогыг илүү өргөнөөр харах ёстой юм. Түүнээс биш ямар нэг хууль, дүрэм журамд өөрчлөлт оруулах, санхүүгийн салбарт ажиллаж байгаа операторуудыг тэр хууль, дүрэм журмуудаараа скоч /туузан наалтуур/ шиг ороож суух ёсгүй. Түрүүн миний хэлсэн тэрхүү буруу харьцааг эвдэх, үгүй ядахдаа (80:20) болгон өөрчлөх талаар иймэрхүү тодорхой зорилт тавиад ажиллах хэрэгтэй. Даатгалын байгууллагууд, банк бус санхүүгийн байгууллагууд, үнэт цаасны арилжаа эрхлэгчид, бусад санхүүгийн секторын операторуудыг жинхэнэ харилцаа, яриа, хамтын ажиллагааны механизмыг бүрдүүлэх нь 2014 оны СЗХ-ны шинэ үүрэг, зорилт шүү. Үүнд онцгой анхаарахыг та бүхэнд сануулж байна. Амжилт хүсье. Баярлалаа.

### **С.Дэмбэрэл гишүүний санаачилсан тогтоолын төслийг хэлэлцэв**

*Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 12 сарын 18-ний өдрийн хуралдааны тэмдэглэлээс: “Ухаалаг төр рүү шилжих үйл явцыг эрчимжүүлэх чиглэлээр тодорхой бодлого арга хэмжээний төсөл боловсруулах” цэрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг.*

**А.Бакей:** - Тогтоолын төсөлийг санаачлагч нь С.Дэмбэрэл гишүүн тогтоолынхоо талаар товчхон танилцуулга хийе.

**С.Дэмбэрэл:** - Нэг талаас Ухаалаг төр рүү шилжих үйл явцыг Улсын Их Хурлын институциудын асуудал эрхэлдэг байнгын хорооны анхааралд хамгийн түрүүнд оруулах, энэ чиглэлээр манай байнгын хорооны үйл ажиллагаанд энэхүү үйл явцыг манлайлан дэмжих чиглэлээр тодорхой бодлого арга хэмжээ боловсруулах. Нөгөө талаас засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа хүнд суртлыг устгах төслийн баг байгаа. Тэр төслийн багт ерөнхий сайдтай тохиролцсоны дагуу Ч.Сайханбилэг гишүүнээр удирдуулсан УИХ-ын 5 гишүүн ажиллах гээд ерөнхий сайдын захирамж гарсан байгаа. Том төрөөс ухаалаг төр лүү шилжих гэсэн энэ үйл явц маань уг нь цоо шинэ огт биш юм. Өмнөх засгийн газрын үед ч яригдаж байсан. Хүнд суртлыг устгах, бизнесийн орчныг чөлөөтэй байлгах асуудал энэ үйл явцын хамгийн гол бүрэлдхүүн хэсэг нь байдаг. Саяхны түүхийг сөхөхөд, ерөнхий сайд Сү.Батболдын удирдаж байсан өмнөх засгийн газрын үед, 2010 онд, бизнесийн орчны шинэтгэлийн хөтөлбөр боловсруулж байсныг би маш сайн санаж байна. Энэ хөтөлбөр хэрэгжиж байсан. Мөн Шадар сайд байсан М.Энхболд тусгай зөвшөөрөл лицензийн тоог бууруулах ажлын хэсгийг ахлан ажиллаад, тодорхой тооны тусгай зөвшөөрөл лицензийг багасгаад үр дүн гаргаж л байсан. Энэ маань өөрөө явж байсан л процесс. Энэ хугацаанд улсын их хурал ямар ажил хийж байсан юм бол гэхээр би

одоогоор бичиг баримт олоогүй л дээ. Жишээ нь, тухайн үеийн төрийн байгуулалтын байнгын хорооноос энэ чиглэлээр ямар нэгэн тогтоол гарч байсан уу? Бусад байнгын хороодоос хүнд суртлын талаар ямар нэг шийд гаргаж байсан уу гэхээр алга л байх шиг байдаг юм. Засгийн газар нь тухайн үедээ бага зэрэг хэрэгжүүлээд явсан болохоос УИХ-ын зүгээс уялдаа нь байхгүй, дэмжлэг дутагдаж байсан тал ажиглагддаг юм. Энэ бол үүнийг боловсруулах 2 дахь шалтгаан нь болоод, энэ тогтоолын төслийг боловсруулах санаа төрсөн. Тийм учраас энэ маань нэгдүгээрт манай байнгын хороонд ухаалаг төр лүү шилжих үйл явцыг манлайлан дэмжих, нөгөө талаасаа засгийн газраас хэрэгжүүлж байгаа хүнд суртлыг устгах төслийн багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр зөвлөгөө өгөх, тодорхой арга хэмжээний төсөл боловсруулах зэргээр манай байнгын хорооны 2014 оны төлөвлөгөөний төсөлд орвол сайн байна. Энэ ажлууд бол 2013 төгсгөлөөр эхэлсэн, урьд жилүүдээс эхлэлтэй, их чухал үйл явц мөн. Төрийн байгуулалттай институци хоорондын үйл ажиллагаануудтай уялдаа холбоотой энэ үйл явцыг дэмжих нэлээн олон арга хэмжээ тусах байх гэсэн үүднээс энэ тогтоолын төслийг санаачилсан. Тогтоолыг хурдхан батлаад өгчихвөл сайн байх гэж...

**Н.Батцэрэг:** 1. “Хүнд суртлыг устгах” гэсэн байх юм. Сонгуульд орж байгаа нэг нам ч юм уу, нэг улс төрч ч юм уу “хүнд суртлыг устгана” гэвэл ойлгож болно. Төрийн байгуулалтын байнгын хорооны тогтоол дотор “хүнд сурталыг устгах” гэсэн үг орох нь хэр зохимжтой вэ? Тэгж чадах юм уу? Хүнд суртал гэдэг чинь тодорхой хэмжээнд байх ёстой зүйл. Хүнд суртал байж байж хэрэгждэг зүйл ч бас бий шүү дээ. хэт сэтгэл хөдлөлийн чанартай зүйлийг хэрэглэх нь ямар вэ? “Хүнд суртлыг устгах”, ялангуяа “устгах” гэдэг үгээ тайлбарлаач.

2. Ажлаа эрчимжүүлэх арга хэмжээний төсөл боловсруулна гэж байна. Ямар төсөл байх юм вэ?

3. Ерөнхий сайд захирамж гаргаад 4 гишүүн оролцсон гэж дурдах шиг боллоо. Ерөнхий сайдын гаргасан захирамжаар УИХ-ын гишүүн ажлын хэсэгт орж байгаа юм уу? Ажил үүргийн давхардал, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн харилцан хамаарал энэ тэр гээд түрүүн ярьж байсан олон асуудал бий. Ерөнхий сайд УИХ-ын гишүүнийг ямар нэгэн ажилд томилон оруулахаар захирамжилж болохгүй. Үүнийгээ юу гэж харж байна?

**С.Дэмбэрэл:** Маш чухал асуулт тавьж байна. Төсөлд “хүнд сурталыг устгах” гэсэн ойлголт “глиоттин” буюу Францын хувьсгалын үед хүмүүсийг цаазалдаг байсан багаж хэрэгсэлээр нэрлэсэн төрийн зохицуулалтын реформын орчин үеийн хамгийн чухал хандлагын нэршил юм. Маш олон оронд глиоттин буюу хүнд сурталыг тас цавчин устгах арга барилыг л хэлсэн хэрэг. Энэ арга барил маань одоо Монгол улсад бодитойгоор, гүйцэтгэх засаглалын түвшинд, бүр яг энэ нэрээрээ, ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан ажлын дэд хэсэг байж байгаа, УИХ-ын гишүүд оролцсон Ажлын дэд хэсэгт нь УИХ-ын 4 гишүүдтэй тохиролцсоны үндсэн дээр энэ чиглэлээр явуулж байгаа. Засгийн газрын тусгай зөвшөөрөл лицензүүдийн тоог засгийн газрын түвшинд, яамдуудын түвшинд, комиссын түвшинд шийдэж чадахгүй, болохгүй зүйлүүдийг энэ баг руу оруулж ирээд, тэр

баг яамдын сайд нартай тулж уулзсаны үндсэн дээр тодорхой асуултууд асуугаад, шалгуурууд тавиад, энэний үндсэн дээр хөндлөнгийн журмаар, бие даасан, хараат бус зарчмаар шийдвэрлүүлэх үүднээс УИХ-ын гишүүдийг энэ багт оруулсан. Төсөл нь энэ арга хэмжээний төсөл. Ямар бодлого хэрэгжүүлэх ёстой вэ гэдгийг төсөл маягаар байнгын хорооны хуралдаанаар оруулахыг хэлж байна.

**М.Батчимэг:** Миний нэр тогтоолын төсөл дотор орсон явж байгаа. Би бас тодруулмаар байна. Сая С.Дэмбэрэл гишүүний тайлбарласанчлан, засгийн газраас санал аваад, зөвшилцөж, тохиролцсоноор. Засгийн газарт олон давхацсан зөвшөөрөл лицензүүдийг байхгүй болгох зорилготой, хэт хүнд суртлыг багасгахын тулд ажлын хэсэг байгуулагдсан. Энд С.Дэмбэрэл гишүүн болон миний бие бас явж байгаа. Тэгэхлээр засгийн газрын хийж байгаа өргөн бүрэлдхүүнээр, нэлээн цаг зав зараад хийх гэж байгаа энэ ажил явж байхад байнгын хороон дээр зэрэг ажлын хэсэг байгуулах зайлшгүй шаардлага байна гэдгийг би сайн олж харахгүй байна. Тийм учраас тайлбар сонсох гээд байна. Энэ ажлыг өөрөө салбар, салбарын хүрээнд үйлчилж байгаа зөвшөөрөл, лицензүүдийг нэг бүрчлэн судлаад, зайлшгүй байх шаардлага юу байна гэдэг дээр нухацтай авч хэлэлцээд, тодорхой багийн хүрээнд энэ саналыг гаргаад, цаашдаа зөвхөн засгийн газрын хүрээнд биш, хууль тогтоох, боловсронгуй болгохдоо улсын их хурлаас хамаарч байгаа ямар асуудал байна вэ гэдгийг хамтад нь гаргаж ирэх зорилго гаргасан. Нэгэнт Засгийн газар дээр хийгдэж байгаа болохоор давхцуулж хийх шаардлага байна уу үгүй юу гэсэн нэгдүгээр асуулт байна?

2. Магадгүй яг өнөөдөр өөр ажлын хэсэг байгуулаад ажиллах шаардлага байна уу гэж би харж байна. Юу вэ гэхлээр, дөнгөж өнөөдөр хэлэлцсэн засгийн газрын тухай хууль улсын их хуралтай холбоотой хууль, засгийн гишүүний ажил үүргийн давхцыг арилгах ажлыг ярилцаж байна. Цаана нь бид нар засаглалын тэнцвэрийг оновчтой тэнцвэртэй байлгах, засаглал хуваах эрх мэдлийг илүү оновчтой болгох үүднээс цогц арга хэмжээ авах шаардлагатай бусад хуулиудыг авч хэлэлцэх шаардлагатай гэж ярьж байгаа. Засгийн газрын дийлэнх бүрэлдхүүн нь гаднаас байгуулагддаг болчих юм бол гүйцэтгэх эрх мэдлийг хангалттай түвшинд байлгах талаар тодорхой хууль санаачлах шаардлагатай гэсэн гишүүдийн бодолтой санал нэг байна. Энэ мэтчлэн хариуцлагын механизмыг зөв оновчтой болгох ямар хуулиудыг авч хэлэлцэх ёстой юм гэдгийг төрийн байгуулалтын байнгын хороо яаралтай ажлын хэсэг байгуулаад, судалгаа хийх ёстой гэж бодож байна. Яагаад гэвэл өнөөдрийн хуулийг хэлэлцэх болсоноор холбоотойгоор. Би энэ ажлын хэсгийг зайлшгүй байгуулах шаардлагатай талаар С.Дэмбэрэл гишүүнээс тайлбар сонсох гээд байна.

**С.Дэмбэрэл:** М.Батчимэг гишүүний асуусан давхцаад байгаа юм биш үү гэсэн асуултанд хариулъя. Нэгдүгээр заалтыг уншвал, төрийн байгуулалтын байнгын хороо нэгдүгээрт, манлайлан дэмжих ёстой. Өөрөөр хэлбэл ухаалаг төр лүү шилжих гэдэг үйл явц маань өөрөө хамгийн түрүүнд тусах, хамгийн түрүүн барьж авах үүрэг нь төрийн байгуулалтын байнгын хороонд нэг талаасаа ноогдож байгаа юм. Нөгөө талаасаа, засгийн газрын хийж байгаа тэр глиоттин буюу хүнд суртлыг устгах, зөвшөөрөл лицензийн тоог багасгах ажил нь үүнтэй огт давхцахгүй. Яагаад гэвэл хууль зүйн



хэлтсийн дарга Энхтуяагаар ахлуулсан УИХ-ын ажлын дэд хэсэг байгаа. Тэр ажлын хэсэг шийдэж чадахгүй, яамдын зүгээс эсэргүүцэл үзүүлсэн зүйлүүдийг Ч.Сайханбилэг гишүүнээр ахлуулсан, дан улсын их хурлын гишүүдээс бүрдсэн ажлын хэсэгт оруулж ирнэ. Энэ ажлын хэсэг маань ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан. Энэ тохиолдолд яамдын зүгээс энэ процессийг тодорхой хэмжээгээр эсэргүүцэж, өөрийнхөө яаманд тодорхой лиценз зөвшөөрлүүдийг авч үлдэх гэсэн ил, далд эсэргүүцэл гарна. Ийм тохиолдолд их хурлын төрийн институцийн асуудлыг эрхэлсэн төрийн байгуулалтын байнгын хороон дээр буфер хамгаалах, эрчимжүүлэх чиглэлээр дээрээс нь хэлж өгдөг, УИХ-ын зүгээс нь нөлөөлдөг, хэлж өгдөг ийм баг байхгүй бол энэ нь ганцаардал үүсгэнэ. Тийм учраас ийм зорилгоор болон өмнөх төрийн байгуулалтын байнгын хорооны хувьд манлайлан дэмжих, том төрөөс ухаалаг төр лүү шилжих процессыг төрийн байгууламжтай холбоотой манлайлан дэмжих гэсэн ийм 2 утгаар орж байгаа гэдгийг хэлэх гэсэн.

**А.Бакей:** Нэмээд хариулья. Засгийн газар хэзээ асуудал оруулж ирэх юм вэ гээд байнгын хороо хараад сууж болохгүй. Байнгын хороо төрийн эрх барих, хууль тогтоох том бүтэц байгаа. Ухаалаг төр лүү шилжих асуудал бол зөвхөн засгийн газрын ажлын хэсгийн хүрээнд том хүрээтэй асуудал. Энэ ажлын хэсэг бол 2 чиглэлээр ажиллана гэж бодож байгаа. Нэгдүгээрт, төрийн байгуулалтын байнгын хороо ухаалаг төр лүү шилжих үйл явцтай холбоотой бүтэн жилийн турш ямар төлөвлөгөөтэй ажиллах талаар бас бодлого боловсруулж тодорхой болгох. Хоёрдугаарт, холбогдох хуульд өөрчлөлт оруулах санаачлагаар энэ дотор таны ярьж байгаа засгийн газрын бүтцийн тухай хууль ч юм уу, засаглалын тэнцвэрийн асуудал, эрх мэдлийн хуваарилалтын асуудал хариуцлагын механизмыг энэ бүгд орж байгаа.

**М.Энхболд:** Ерөнхийдөө А.Бакей дарга ярьж байна. С.Дэмбэрэл гишүүн санаачилж Улсын Их Хурал, тэр дотор манай байнгын хороо зөвхөн нэг асуудлаар биш бүхэлд нь төрийн аппарат, түүний үйл ажиллагааг илүү боловсронгуй болгох, зургыг уялдуулж харъя гэсэн санаа бол зүйтэй гэж үзэж, дэмжиж байна. С.Дэмбэрэл гишүүн маань амьдрал дээр байдаг бэрхшээлүүдийг сайн ойлгож, тэнд бас оролцоод, тухай тухайн засагт ажиллаж байсны хувьд бол зөвхөн бизнесийн орчноос гадна бусад хууль дүрмүүдтэй уялдуулж харъя гэсэн санаа хийж байгаа нь зөв зүйтэй гэж үзэж байна. Тэгэхгүй бол ерөөсгөл болчихоод байдаг юм. Зөвхөн лиценз зөвшөөрөлтэй холбоотой асуудалд орооцолдоод байхаар бусад хууль зохицуулалтууд нь саатуулсан зүйл заалттай байдаг учраас нэлээн том зургаар харахгүй бол хэдхэн лиценз, зөвшөөрлийг цуцалсан болоод орхивол, амьдралд хууль болон хэрэгжиж үр дүнгээ өгч чаддаггүй. Тийм учраас өмнө ярьж байсан улсын их хурал энэ хуулийг боловсронгуй болгохдоо холбогдуулаад төдийгүй амжилтанд хүрээгүй учраас энэ зүйлүүдийг бүхэлд нь санаачилж уялдуулан гаргаж байна гэдгээр дэмжиж байна. Харин С.Дэмбэрэл гишүүний санаачилж байгаа зүйлийг олонхийн зүгээс, эрх баригчдын зүгээс дэмжиж, идэвхтэй оролцох, бүр шаардлагатай бол ажлын хэсгийг ахлах хэмжээнд хүртэл оролцох нь зүйтэй болов уу гэсэн санаа байна.



2. Нэгэнт энэ асуудлыг төрийн асуудлаа нээлттэй боловсронгуй болгох асуудал ярьж байгаа учраас зөвхөн дотроо өөрсдийгөө харахаас гадна энэ заалтанд бусад байгууллагууд, ялангуяа иргэний нийгэм, бизнесийн салбар энэ бүгдийн оролцоо санал бодлыг ил гаргаж, санал авдаг ердийн горимоороо явах юм уу, эсвэл энэ дээр нь бас нэмэлт ажлын хэсэг, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсэг зориуд нэмж ач холбогдол өгч оруулах юм уу? Ердийн горимоороо саналаа авдаг энэ зарчим байж болно л доо. Бид үүнийг төрийн боловсронгуй болгох асуудлыг бусад нийгмийн сигментүүдтэй хамтарч хийе гэсэн санал оруулж байгаа учраас дэд хэсгээ өргөтгөн ажиллуулах боломжийг нь төрийн байгуулгын байнгын хорооны ажлын хэсэгтээ тусгаад өгчихвөл илүү баяжуулсан болж харагдах юм болов уу? Нөгөө талаасаа баяжуулсан болж харагдахаасаа илүү, бодит бэрхшээлийг мэддэг хүмүүс амьдралд байж байгаа. Эс тэгвэл энд зөвхөн шийдвэр гаргагчид болон тэдэнд асуудлыг нь боловсруулж өгдөг төрийн албаныхан л орох болчихоод байна. Тийм учраас энэ талаас нь бас өргөтгөж, бүр өргөжүүлж харвал яасан юм вэ?

**С.Дэмбэрэл:** Энэ бол маш зүйтэй санал. Үүнийг сайн анхаарсангүй. Гэхдээ энд зайлшгүй төрийн бус байгууллагуудын төлөөлүүдийг ажлын дэд хэсэгт юм уу, эсвэл бүр 3-р заалт болгоод альтернатив хөндлөнгийн санал өгөх дан төрийн бус байгууллагуудаас бүрдсэн ажлын хэсэг байгуулж болно. Дэд хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх нэг хэсэг, мөн альтернатив санал бодлоо илэрхийлэх ажлын дэд хэсэг гээд маш олон төрийн бус байгууллагууд мэргэжлийн холбоодуудыг оруулж болж байна. Тэд нарыг нэг жагсаагаад, оруулбал тэд нартай ажлын хэсгийн үр дүн маш сайн болно. Тийм учраас М.Энхболд гишүүний саналыг бүрэн дүүрэн дэмжиж байна. Тогтоолын төсөлд тусгаасай гэж хүсч байна.

**Д.Эрдэнэбат:** Би ингэж бодож байна. Үйл явц биш л дээ. Тогтоол чинь бантан шиг санагдаад байна. Тоон дотор үсэг цохиж яваа ч юм шиг. Энэ бол зүгээр ерөнхийлөгчийн санаачлага байна. Санаачлагыг дэмжээд, Байнгын хороо ерөнхий бодлого төлөвлөгөө арга хэмжээг боловсруулаад, 2014 онд хэрэгжүүлээд, ажлын хэсэг байгуул байна. Энд засгийн газар ямар ч хамаагүй. УИХ нь засгийн газрынхаа ажлыг эрчимжүүлэхийн тулд тогтоол боловсруулаад гэхээр нэг л ойлгомжгүй болоод байна. Засгийн газраас хэрэгжүүлж байгаа хүнд суртлыг устгах төслийн баг гэж чухам юу юм вэ? Надад энэ тухай мэдээлэл өгөх хүн байвал сайн байна. Тогтоол товчхон гарах ёстой. Товчхон гарахдаа төрөөс ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн ухаалаг төр лүү шилжих санаачлагыг дэмжиж байгаа утгаараа гарах ёстой. Байнгын хороо үүнтэй холбогдуулаад тодорхой төсөл боловсруулаад, 2014 оны жилийн төлөвлөгөөндөө тусгая гэсэн үүрэг бүхий ажлын хэсэг байгуулна гэсэн утгатай тогтоолын төсөл байх ёстой юм уу гээд гэж бодож байна.

2. Ажлын хэсгийн гишүүдийг /түрүүн М.Батчимэг гишүүн хэлчихлээ/ автомат маягаар тавьж болохгүй. Намайг байхгүй байхад, ажлын хэсэгт оруулсан байна гээд байна. Энэ нь дээр гишүүдийнхээ саналыг сонсож тавьсан нь дээр байхаа. Энд цэвэр УИХ-ын гишүүдээс бүрдсэн, болж өгвөл тогтоолын төсөл хэрэгжихтэй холбоотойгоор бүх байнгын хорооны төлөөллийг хамарсан, ийм л хэмжээний тогтоол байх ёстой болов уу гээд

ойлгоод байна. Зөвхөн байнгын хороогоороо гаргах юм уу, УИХ-аараа гаргах юм уу? Тэгвэл одоо байнгын хороо дотроосоо л гаргах байлгүй дээ? Тогтоолын төслийн өгүүлбэрийг саяны миний хэлсэн зарчмын дагуу өөрчлөх ёстой. Ийм л санаатай байна.

**С.Дэмбэрэл:** - Нэгдүгээрт, Ерөнхийлөгчийн санаачлагыг дэмжих гэж болно. Хоёрдугаарт, хүнд сурталыг устгах баг гээд бодитой ажиллаж байгаа. Энд маш олон яамдын, төрийн бус байгууллагуудын төлөөлөл 7 хоногт 2 удаа уулзаж, бүх яамдын зүгээс манай яамдын хэмжээнд ийм ийм тусгай зөвшөөрөл байна, ийм юм байна гээд энэ бүх юманд нь анализ дүгнэлт хийгээд, олон улсын санхүүгийн корпорацийн глиоттин буюу хүнд сурталыг устгах гэсэн бас тийм нэг төслийн багийнхан орж ажилладаг. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хууль зүйн хэлтсийн дарга Энхтуяа гэдэг эмэгтэй удирддаг. Түрүүн хэлсэн, гишүүдтэй тохиролцсоны үндсэн дээр байгуулсан ч одоогоор анхны хуралдаанаа хийгээгүй байгаа. Манлайлан дэмжих гэдгийг илүү анхаараад санаачлагчийн тус байнгын хороонд үйл явц гээд угаасаа үйл явц л даа, реформын процесс гэдэг чинь. Монгол улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн том төрөөс ухаалаг төр лүү шилжих санаачлага гэж яваад, 2-рт ажлын хэсгийн ахлагчийн хувьд С.Дэмбэрэл гэдэг гишүүн заавал байх шаардлагагүй гишүүд бүр чөлөөтэй байх ёстой. Гишүүдийн өөрсдийн саналыг аваад оруулах нь маш зүйтэй. Сүүлийн үед ийм хандлага гарчихаад байна. Намуудын төлөөллийг хангасан уу гээд. Энэ бол байж болно. чөлөөтэй зүйл шүү.

**М.Батчимэг:** А.Бакей дарга, С.Дэмбэрэл гишүүний тайлбарласанаар энэ бол зөвхөн хүнд сурталыг устгах том төрөөс ухаалаг төр лүү шилжих энэ санаачлагыг дэмжих хүрээнд УИХ, тэр дундаа төрийн байгуулалтын байнгын хороо санал боловсруулья гэсэн зорилгоор ажлын хэсэг байгуулах гэж байна. Тэр дундаа бизнесийн хүнд сурталыг буруулах асуудал орж байгаа юм байна. Энэ агуулгаар нь тогтоол ажлын хэсэг байгуулахыг дэмжиж байна. Гишүүнээр оролцож болно. Зөвхөн тогтоолын төслийн энэ хэлбэрийг ярьж байгаа Д.Эрдэнэбат гишүүнтэй ойролцоо саналтай байна. Яагаад гэвэл, бид нар маш ерөнхий концепцийн шинжтэй асуудлыг их деталь, багийн ажилтай зэрэгцүүлээд байгаа нь тогтоолын утга агуулгаас харахад тэнцвэртэй биш харагдаад байна. Миний санал бол, томъёолохдоо Монгол улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачлагатай холбоотойгоор том төрөөс ухаалаг төр лүү шилжих санаачлагыг байнгын хорооны зүгээс манлайлан дэмжигч байх гэхчээд, хойд талд нь баг, энэ тэр гэж оруулахгүйгээр, хүнд сурталыг устгах гэсэн зарим тодорхой үгнээсээ зайлсхийгээд, төрийн чиг үүргийг боловсронгуй болгох, төрөөс бизнесийн салбарыг дэмжээд хүнд сурталыг буруулах асуудлыг судлах гэсэн ийм байдлаар томъёолвол яасан юм бэ?

2. Бүрэлдхүүний хувьд засаглалын механизмаа яаж сайжруулах юм, бизнесээ яаж дэмжих юм вэ, төрийн энэ талын оролцооны асуудлыг яаж зохицуулах юм бэ гээд өргөн хүрээнд ярьж байна. Тэгэхлээр энэ дотор нэг бүрчлэн дэд хэсэгт хамаатай хүмүүсийг оролцуулана гэх юм бол маш олон хүний нэр орох шаардлагатай болчихоод байна. Наад заах нь засаглалын үндэсний механизм ярих гэж байгаа бол үндсэн хууль судалдаг хүмүүс орох шаардлагатай болно. Тэгэхлээр миний санал бол, Д.Эрдэнэбат гишүүний

саналтай ойролцоо. Төрийн байгуулалтын байнгын хорооны санал болгоод бусад байнгын хороодоос төлөөлөл оролцуулсан өргөн бүрэлдхүүнтэй зөвхөн их хурлын гишүүдийн 2014 онд хийх төлөвлөгөөнд тусах арга хэмжээг шийдвэрлэх ёстой асуудлыг санал боловсруулах ажлын хэсэг болгоод тэрүүгээрээ тогтоол гаргаж батлуулаад, гарсан тогтоолын дагуу магадгүй өөр байнгын хороонд ажлын хэсэг байгууллагдаж магадгүй. Тэгэхгүй бол энэ том асуудлыг хамрах учраас дэд хэсэг гээд хорь гучхан хүн тавилтай биш. Ерөнхийлөөд гаргачвал тогтоол болгож батлуулсаныхаа дараа 2014 оны төлөвлөгөөндөө тогтоол болгож батлуулаад, дахиад дэд хэсэг болгож ажиллавал илүү зохион байгуулалтын хувьд ойлгомжтой болох юм биш үү?

**С. Дэмбэрэл:** Энэ санал бол зөв. Гэхдээ мөлгөр байна. Өөрсдийгөө мөлгөр гэдгээ харуулж байгаа байхгүй юу. Энэ хороо мөлгөр гэдгээ харуулж болохгүй. Процесс чинь ядаргаатай, зүгээр ингээд шууд явахад хэцүү шүү дээ. Хүнд сурталыг устгах гэсэн детальный юмыг нь хасчихъя. Гэхдээ энэнийг мөлгөр болгочихож болохгүй. Бидний итгэл үнэмшил чинь өгүүлбэрээр илэрхийлэгдэх ёстой. Хорооны коллектив итгэл үнэмшил нь. Тийм учраас эндээс эрс шинэчлэлийн гэдэг санаа оруулах гээд байгаа ухаантай юм. Глиоттин гэдэг чинь тоглоомын үг биш. Энэ бол албан ёсны нэршил. Тухайлбал, эдийн засгийн байнгын хороонд хэлэлцэгдэж байгаа өнөө мөдгүй батлагдах энэ ойрын хугацаанд улс орны эдийн засаг валютын ханштай холбоотой энэ үг бүр албажиж орж байгаа. Улсын их хурлын түүхэнд глиоттин гэдэг үг өөрөө албажиж орох ёстой. Өөрөө реформын эрс хандлагыг илэрхийлсэн үг байна. Тийм утгаар оруулвал зүгээр гэсэн санал байна. Найруулгын хувьд бол ер нь засах ёстой юм байна.

## **Эрүүл мэндийн даатгалын тухай хууль маш буруу замаар явлаа**

*УИХ-ын Намрын ээлжит чуулганы 2014.01.23-ний өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс: Ишийн анхны хэлэлцүүлэ дээр*

**С. Дэмбэрэл:** Энэ хуулийг гайхаад байна. Уг нь энэ бол эдийн засгийн асуудал тэр тусмаа санхүүгийн секторын асуудал. Гэтэл хэдэн гишүүд санаачлаад, огт хамаагүй байнгын хороо энэ асуудлыг авч хэлэлцээд, эдийн засгийн байнгын хорооны саналыг албан ёсоор авалгүй, эдийн засгийн асуудал талаас нь хэлэлцэлгүйгээр, ийм сонин хууль батлах гэж байна. Энэ байдлаараа явбал Монгол улсад ерөөсөө хэрэгтэй хууль болохгүй. Ганц яаманд хэрэгтэй болж магадгүй. Тийм учраас, энэ хууль маш буруу замаар явлаа шүү гэдгийг би урьдчилан анхааруулах гэсэн юм. Энэ эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудал шүү. Энэнийг та бүхэн маш сайн бодож үзээсэй гэж хүсэж байна.

**Ядууралгүй, Хүн амын эрүүл мэнд нь онцгой  
сайн байх тийм юмыг хийж чаддаг төр бол  
Ухаалаг төр мөн.**

*Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэлийн гаргасан хүсэлтийн дагуу Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо “Ядуурал ба эрүүл мэнд” сэдэвт нээлттэй сонголыг 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулагдлаа...*

**С.Ганбаатар:** Өнөөдрийн арга хэмжээг С.Дэмбэрэл гишүүн 5 сарын өмнө санаачлаад нийгмийн бодлогын байнгын хороотой ярилцаад өнөөдөр хийж байна. Нилээд үр дүнтэй боллоо гэж үзэж байна. Олон чухал илтгэлүүд тавигдлаа. Асуулт хариулт явагдлаа. С.Дэмбэрэл гишүүн хаалтын үг хэлнэ үү.

**С.Дэмбэрэл:** За баярлалаа. Би Нийгмийн бодлогын байнгын хороонд байхдаа ЭМЯ-ны 2012 оны тайлан илтгэл болох нэг ногоон номноос Монгол улсын хүн амын ядуурал, эрүүл мэндийн байдал хоёрын хооронд улам бүр нэмэгдэж байгаа **корреляци** буюу харилцан холбоо хамаарлыг олж харсан. Энэ нь бодит амьдралд хүмүүст их мэдрэгддэг байсан. Эндээс, төр нь энэ чиглэлээр юу хийж байна? Төр өөрөө энэ асуудалтай **корреляцитай** байж чадаж байна уу? гэсэн асуулт гарч ирсэн. Төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо гэж ярьдаг, тэр маань хангагдаж байна уу? Хувийн хэвшлийн оролцоо ямар байдаг юм бэ? Иргэд яаж оролцдог юм бэ? гээд олон асуулт гарч ирсэн. Тийм учраас энэ асуудлыг өнөөдөр ярьж байгаа нь маш чухал. Яг өнөөдөр нөгөө зааланд, 2 сайдыг огцруулах эсэх тухай асуудал яригдаж байна. Тэр нь их сонирхолтой санагдаж байгаа байх. Гэвч үнэндээ энэ өрөөнд яригдаж байгаа зүйл илүү ач холбогдолтой. Уг нь тэнд биш, энд сэтгүүлчид дүүрэн байж байвал, энэ чухал асуудлыг нийгэмд хүргэх талаасаа хавьгүй чухал, үндэсний хэмжээний том асуудал юм. Энэ бол нэг, хоёр, эсвэл гурван яамны асуудал биш. Гэтэл одоо энд 2 Яамны сайд л сууж байна. Үнэндээ, энд жишээлбэл, уул уурхайн сайд сууж байх ёстой. Эцсийн дүндээ бид, ядууралд хандах Монгол улсын төрийн бодлогын хандлага нь ямар байгаа юм бэ гэдгийг сайн тодорхойлоод авъя. Монгол төрийн ядууралд хандах хандлагын эндээс үүссэн эндээс суурилсан бодлого нь ямар байдлаар явагдаж байна вэ, яаж явагдах гэж байгаа юм бэ, цаашдаа юу хийгдэх юм бэ гэдэг асуудал хурцаар тавигдаж байна. Алтанхуяг гэдэг эмч эмэгтэйн Баянзүрх дүүргийн жишээн дээр авч үзэхэд л өрхийн эрүүл мэндийн үйлчилгээний төвд тулгамдсан асуудал өнөөдөр асар их байна. Өөрөөр хэлбэл өнөөдөр макро гэж ярих их дуртай байна шүү дээ. Гэтэл микро түвшинд тулгамдсан асуудал асар их хуримтлагдсан байна. Шийдвэрлэх арга замыг энэ хүмүүс хэлж байна. Бид энд хариулт өгөх ёстой. Та бүхний илтгэлд маш үнэтэй, олон чухал санаанууд гарлаа. Хоёр сайд төрийнхөө бодлогыг маш сайн тодорхой хэлчихлээ. Гэтэл энэ 2 Яаманд хандах Улсын Их Хурлын хандлага ямар байна вэ? Миний бодлоор хандлага нь маш дутуу дулимаг байна. Асуудлыг

дутуу үнэлж байна. Бид өнөөдөр нүүрс, зэсэнд маш их ач холбогдол өгч байна. Гэтэл Нэгдсэн Үндэсний Байгууллагын төлөөлөгч болон та бүхний илтгэлд “Хүний амьдралд бага ач холбогдол өгөөд байна” гэдгийг шууд болон шууд бус утгаар илэрхийлсэн. Тийм учраас үүнтэй холбогдуулаад хөрөнгө оруулалт, санхүүжилт, тэрний тогтолцоо, нийгэмд хандах хандлага, өөрөөр хэлбэл ядуурал бол сонголт биш, хувь заяа ч биш, харин нийгэм - эдийн засгийн том орчинд байгаа бидний шийдвэл зохих том асуудал буюу Улсын Их Хурлын онцгой анхаарах номер нэг, үндэсний хэмжээний асуудал болсон байна. Хамгийн сүүлд яригдаж байгаа “Ухаалаг төр” гэдгийн номер нэг асуудал. **Ухаалаг төр юм бол ядууралгүй улс байх ёстой. Хүн амын эрүүл мэнд нь онцгой сайн байх тийм юмыг хийж чаддаг төр бол Ухаалаг төр мөн.** Илтгэлүүдийг сонсоод байхад, маш олон үгнүүд орж ирж байна. Энэ бүхний ард дандаа бодлого, тэрний тулгамдсан асуудал байгаа. Жишээлбэл, mortgage, байгаль орчны бохирдол, хөгжлийн бэрхшээлийн асуудал болон микро түвшинд шийдэх гэж оролдож байгаа төр институтийн буюу өрхийн эрүүл мэндийн асуудал, энэ чиглэлээр олон улсын байгууллагуудын хийж байгаа үйл ажиллагаанууд хэр зэрэг, хэрхэн уялдаж байна вэ гэдэг асуулт гарч байна. Аливаа олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байхад, том том бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, тухайн асуудлыг шийдвэрлэхэд тухайн улсынхан өөрсдөө, хэр зэрэг санаачлагатай, голлон оролцож байна вэ, хандлага, арга барил нь тухайн улсынх байна уу эсвэл өөр олон улсын аргад суурилж уу гэдгийг их анхаардаг. Хатуу ч гэсэн дэгсдүүлсэн нэгэн ёжлолыг хэлэхэд, ядуурлаа “Дэлхийн Зөн” ОУБ-д даатгачихаад, агаарынхаа бохирдлыг “Мянганы зорилтын сан”-д даатгаад хаячихсан байх шиг байна. Надад заримдаа тийм сэтгэгдэл төрдөг. УИХ-ын 76 гишүүд бид адилхан коллегууд. Гэхдээ дор хаяж 10 хүн энд орж ирсэн бол... Энэ бол ерөөсөө бидний сэтгэлгээ харагдаж байна. Бид өнөөдөр эдийн засгийн өсөлтийг багасгачихлаа, ихдүүлчихлээ гэдэг шалтгаар нэг хэсгийгээ огцруулна гэж сууцгааж байна. Гэхдээ энэ өсөлтөнд чинь, ерөнхийлөгчийн хэлсэн тэр “Ухаалаг төр”, НҮБ-ийн хүмүүсийн хэлээд байгаа “эдийн засгийн оролцоотой өсөлт” маань байна уу үгүй юу? Бид энэ чиглэлээр зохих анхаарлыг тавьж чадаж байна уу, үгүй юу? Би нэг зүйлийг сайн санаж байна. 2005 онд, УИХ-аас хол байхдаа би “Ядуурал ба эдийн засгийн өсөлтөнд хандах 2 Е-ийн хандлага” гэж нэрлэсэн жижигхэн юм бичиж байсан. 2 Е гэдэг нь англи үг. Нэг нь бол Empowerment, нөгөөх нь Entrepreneurship. Өөрөөр хэлбэл нэг нь бол боломж бололцоо, дэмжлэг бүхнийг агуулсан асуудлыг шийдэх утгатай үг. Нөгөөх нь овсгоо самбаачилал гэсэн утгатай. Тэгэхээр бид өнөөдөр, нөөцөөр баян улсын эдийн засгийн өсөлтийн загварт буюу хэт их уул уурхай руу анхаарчихаад, хүний хөгжил, эрүүл мэндийн чиглэлийн асуудлыг дутуу анхаарч байна. Анх удаа Монголын төрийн институциудын дунд Хүний хөгжлийн яам байгуулагдсан. Хүнийг хөгжүүлэх талаас нь харж, санаж эхэлсэн. Одоо энэ асуудал дээр зузаан ботьнууд эхнээсээ гарч ирээд, тодорхой бодлогууд нь боловсрох зүг рүүгээ явах хандлагад орж байна. Энэ бол бидний зугтахын аргагүй үнэн. Ядуурал гэдэг юм сонголт биш нь үнэн. Ядуу төрдөггүй, сүүлийн үед баян төрдөг болоод байгаа. Ядуурал нь хувьчлал гэдэг зүйлтэй



төстэй. Эхлээд ядуурлын өмнөх шат гэж байдаг. Тэрний дараа ядуурлын шат өөрөө явагддаг. Тэр нь дотроо пирамидтай. Дэлхийн зөнгийн микро түвшинд ажигласан пирамидийн 3 хэсэгтэй. Тэгээд ядуурлын дараах шат буюу эмзэг шат гэж бий. Амжиргааны түвшний ядуурлын индексээр үзэхэд 27.8% нь ядуу байна. Дээр 10 гаруй хувь бүхий хэсэг эмзэг бүлгийн хүмүүс байж байна. Эндээс харахад манай ядуурал нь **de facto** буюу бодит амьдрал дээр 40 шахам хувьтай байна. Энэ нь бас дотроо хот хөдөө, газар зүйн байршил, бүс нутгаар ялгараад явдаг. Тэгэхээр энэ бол асар том асуудал байгаа биз дээ. Ийм том асуудлыг бид өнөөдөр ярьж байна. Энд бас хувийн хэвшлийг орхичоод байна. Хувийн хэвшил яах ёстой вэ? Зүгээр л, хамгийн их буюу maximum ашгийн төлөө яваад байх юм уу? Үгүй. Сүүлийн үед Компаниудын нийгмийн хариуцлага гэсэн нэг шинэ философи бас гарч ирж байгаа. Тэгвэл хувийн хэвшлийнхэн ядуурлыг арилгах, эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагаа явуулах ёстой. Тэднийг “Хүн бүр эрүүл байх ёстой, нийгмийн биеийн тамир нь сайн байх ёстой” гэсэн энэ концепци руу хэр зэрэг оруулж чадаж байна вэ? Энэ чиглэлийн хөшүүргийн систем бидний хууль тогтоомжоор гарч ирэх гэж байна уу, үгүй юу? Хөрөнгө оруулалтын асуудал бас байна. Та бүхэн мэднэ, УИХ-д өөр өөрсдийн тойрог юм уу, эсвэл тодорхой төслүүдэд хөрөнгө оруулалт хийхийн тулд улсын хөрөнгө оруулалт, бодлого гээд янз янзаар шүүмжлээд, сайн муу ярьдаг. Тэгвэл хүн ам, эрүүл мэнд, ус, жорлон руугаа хэр зэрэг хөрөнгө оруулалт хийж байна вэ? Жорлон гэдэг чинь “ариун цэврийн байгууламж” гэдгийн ардын хэллэг шүү дээ. “Ариун цэврийн сайжруулсан байгууламж” гэхээр арай илүү нөхцөлтэй жорлонг хэлж байгаа юм. Хавар болгон гэсдэг бохирдол руу хөрөнгө оруулалт хэр зэрэг хийсэн бэ? Өрхийн эмнэлгийн дутаад байгаа санхүүжилт болон “Дэлхийн зөн”-ийн хоорондын холбоосыг яаж хангасан юм бэ? Ийм асуудлуудыг ярих ёстой. Бид ярьлаа. Хамгийн ухаалаг төрийн, хамгийн ухаалаг хөрөнгө оруулалт нь ядуурлыг арилгах, эрүүл мэндийг сайжруулах явдал мөн гэсэн эцсийн дүгнэлт гараад ирж байна. Хөрөнгө оруулалтын гол зүйл маань энэ. Тэгэхээр бид ядуурал луу хандах хандлагаа, харцаа өөрчлөх цаг нь болжээ. Бид үүнийг С.Эрдэнэ сайдын, Н.Удвал сайдын болон Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны ярьдаг асуудал гэж үзэхээ больцгооё. Энэ бол үндэсний хэмжээний том асуудал. Үндэсний хэмжээний том асуудал байхын тулд институци талаас нь, төрийн байгуулал талаас нь харахаар оролдлоо. Ядуурлыг буруулах үндэсний хороо гэж улс орнуудад бий. Манайд Усны үндэсний хороотой, өөр маш олон үндэсний хороотой. Гэтэл минимум 30% нь ийм хэмжээнд хүрчихсэн байна. Энэ архагшсан асуудлыг шийдэх чиглэлээр юм хийх л хэрэгтэй. 5 төрлийн өвчин улам бүр голлож, хүн амын эрүүл мэнд нь муудаж, залуучууд нь цэрэгт тэнцэх нь ховордоод байгаа энэ асуудлуудыг гуравхан яамны асуудал гэж үзэж огт болохгүй байна. Хөрөнгө оруулалт, бодлогынхоо бүх анхаарлыг энэ асуудал руугаа чиглэх юм бол, энэ л бидний шинэ бодлогын, Ухаалаг төрийн хамгийн гол үндсэн шинж болох ёстой гэдгийг хэлмээр байна. Энэ сайхан тоо баримттай, анализ дүгнэлттэй илтгэлүүдийг бусдад түгээхийн тулд энэ байнгын хорооноос нэг ном болгож эмхэтгэж гаргах нь зүйтэй. Хамгийн гол нь ямар шийдэл гаргах вэ гэдэг асуудал байна. Public hearing буюу



Нээлттэй сонсголын шийдвэр гаргадаг гол механизм нь УИХ-ын тогтоол юм байна. УИХ-ын тогтоол гаргах ажлын хэсэг байгуулах ёстой. Энэ талаас нь бодож миний тавих хүсэлт бол УИХ-ын тогтоол байна. Би өөрөө ажлын хэсэгт нь орно. Энэ асуудалд нилээн ойрхон хүмүүс учраас С.Ганбаатар, С.Эрдэнэ, Н.Удвал нар ч орно. Мөн бусад байнгын хороод, тухайлбал эдийн засгийн байнгын хороо ч оролцох ёстой. УИХ-ын даргын захирамжаар тогтоол гаргаад, энэ чиглэлээр, өнөөдөр яригдсан бүх асуудлуудыг боловсруулах дэд хороотой, УИХ-ын түвшинд асуудлыг оруулах Ажлын хэсэг байгуулагдах нь зөв гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, асуудлыг шийдэх, хууль зүйн талаас нь энэ тогтоолыг гаргах чиглэлээр ажиллацгаая. Ялангуяа өнөөдрийн нээлттэй сонсголд оролцсон, Монголчуудын зовлонг ойлгож, мэдэрч явдаг олон улсын байгууллагуудын төлөөлөгчид мөн ирээд, маш сайхан дүгнэлт, цаашдын хийх ажлын чиглэл, зөвлөмжүүдийг өгч байгаад их баяртай байна. Энэ бол Follow up буюу нэг өдрийн дараа хоол иддэг асуудал биш. Энэний дараа бидний жинхэнэ гол ажил эхэлнэ. Тэр нь юу вэ гэхээр энэнийг хэлбэржүүлэх буюу тогтоолын төсөл боловсруулахад та бүхнийг туслаасай гэж бодож байна. Энд илтгэл тавьсан болон үг хэлсэн хүн болгон ажлын хэсэгт оролцох талаар, байнгын хороо болохоор нээлттэй сонсгол хийсний дагуу УИХ-ын тогтоол гарах нь зүйтэй гэж үзэж ингээд явбал зохих байна. Үүний дараа бид жишээлбэл, Баянзүрх дүүргийн эмчийн ярьж байгаа, тэр ТББ-ын залуугийн ярьж байгаа энэ бүх яриа маань ядуурал гэдэг асуудалд хандах хандлага төдийгүй, ерөөсөө хөгжилд хандах хандлага, хүний царайтай, хүний дүр төрхтэй болж ирэх асуудалд буцалтгүй орно гэдгийг хэлмээр байна. Та бүхэн анхаарал тавьсанд баярлалаа.

### **Хуулиндаа мөнгөний бодлоготой уялдуулсан заалт оруулж өгвөл гараад байгаа үл ойлголцлуудыг тодорхой хэмжээгээр шийдэх механизм бүрдэнэ**

*2012 оны 12 сарын 25-нд 09.00 цагаас “Б” танхимд болсон Эдийн засгийн байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээс: “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэг дээр*

С. Дэмбэрэл: Тодруулъя. “Хувиараа” гэсэн үгийг “бичил уурхай” гэж өөрчлөх гэж байгааг Д.Ганхуяг сайдаас асууя. Хувиараа аж ахуй гэдэг нь хууль бус шүү дээ, тиймээ? “Бичил уурхай” гэвэл бизнес аж ахуйн хэлбэрт орж байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл цаашдаа Монгол улсын эрдэс баялагийн салбарт хувиараа уул уурхайн бизнес эрхэлж болохгүй юм байна. Зөвхөн бичил уурхайн аж ахуй хэлбэрээр эрхэлнэ гэсэн тийм санаа мөн үү?

Д.Ганхуяг: Хуулинд “бичил уул уурхай” гэсэн томъёолол байгаа. Угаасаа Монгол улсад хууль бус үйл ажиллагаа явуулж болохгүй шүү дээ. Ямар ч үйл ажиллагаа хуулийн дагуу явагдах ёстой. Бичил уурхайчдыг бол нөхөрлөл, хоршоонд нэгдэн хамтарч ажиллах, том компаниудын туслан гүйцэтгэх ажил хийх, том компаниудын хийхгүй ажлыг нөхөж

хийдэг, соёлтой, албан ёсны хэлбэрээр ажиллах ёстой гэж ойлгож байна. Зөвшөөрөл өгнө гэсэн ойлголт байхгүй...

**С.Дэмбэрэл:** 2.1.8 дахь заалтыг хасч байгааг хэвлэл мэдээлэлээр дамжуулан хүмүүс зөв ойлголт өгөх зорилгоор тайлбарлах зүйл надад байна. Энэ заалтан дотор байсан “Хойч үедээ үлдээнэ” гэсэн зүйл заалт нь энэхүү бодлогын баримт бичгийн үзэл баримтлалын томъёололд бүрэн шингэчихсэн зүйл байгаа юм. Тогтвортой уул уурхай гээд орчихсон байгаа юм. Энэ нь өнөөгийн болон хойч үеийнхэний эрх ашгийг баланслах гэдэг байдлаар энэ бизнесийн үзэл санаа, философи нь үүнд орчихсон учраас энэ заалтыг хасч байгаа гэдгийг хэлэх гэсэн юм...

**С. Дэмбэрэл:** Алтны тушаалт, валютын нөөц, төгрөгийн ханш... Энэ бүх асуудлууд нь эдийн засгийн бодлого шаардсан асуудал. Саяхан бид 2014 оны Мөнгөний бодлогоороо валютын зах зээлд оролцогчдын тоог нэмэгдүүлнэ гэж заадаг маань цаад утгаараа, алтны компаниудыг валютын зах зээлд оролцох боломжтой экспортлогчдынх нь хувьд оролцуулах, ингэснээрээ алтаа тушаагаад доллар аваад, валютын зах зээлд чөлөөтэй оролцох, зарах боломж олгоно гэсэн үг. Энэ чинь Оюу толгойд ч бас хамаатай. Нэг ийм механизм хийж өгсөн.

Нөгөө талаар төв банкны хийгээд байгаа зүйл нь бас үндэсний мөнгөн тэмдэгтийн эрсдлээс хамгаалах механизм шүү дээ. Энэ талаас нь ойлгоод, энэ чиглэлээр хуулиндаа бас мөнгөний бодлоготой уялдуулсан заалт оруулж өгвөл гараад байгаа үл ойлголцлуудыг тодорхой хэмжээгээр шийдэх механизм гэж үзэж байна. Энэнийг анхаарна уу. Баярлалаа.

## **Эдийн засаг, нийгмийн бодлогод наймаалцал байж хэрхэвч болохгүй**

*“Улс төрийн тойм” сонины сурвалжлагч Т.Урангэрэл 2014 оны 1-р сарын 28-нд УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлийг “Ярилцах танхим”-даа урьж, цаг үеийн асуудлаар хийсэн ярилцлага*

- УИХ-аар Хамтын тэтгэврийн тухай хуулийн төсөл болон малчдыг тэтгэвэрт хамруулах гэх мэт төсөв шаардагдах хуулийн төслүүдийг хэлэлцэж байна. Зарим нь халамжийн шинж чанартай. Мөн цалин, тэтгэврийг нэм гэсэн шаардлагыг Зас-гийн газарт өгөөд байгаа. Төсөвт энэ бүхнийг биелүүлж өгөх мөнгө байгаа юу?

Төсөвт мөнгө байхгүй. Их тааруу байгаа. Энэ оны төсвийг өөдрөг батлаад, тодотгол хийх гэж яаж зовлоо. Төсвөө арай гэж баталсан. Баахан бүтээн байгуулалт хийнэ гэхчхэн. Тэрэнд нь зориулах мөнгө дутагдалтай байгаа. Бүтээн байгуулалтад зарцуулах мөнгийг гаргахын тулд төсөвт тодотгол хийж таарах байх. Дээр нь төр эдийн засгийн үйл ажиллагаанд оролцдог номлолоос бид татгалзаад эхэллээ шүү дээ. Ухаалаг төр гэдэг нь төр өөрөө бизнесмэн байх зарчмыг хэлж байгаа хэрэг биш. Төр нь зохицуулагч байх ёстой. Ийм загварыг сонгож авсан. Эхнээсээ энэ чиглэлийн хуулийн төслүүд орж ирээд, энэ чиглэлийн үйл ажиллагаанууд хийгдээд эхэллээ. Ийм үед эдийн засаг ба нийгмийн гэсэн хоёр жингийн түүхайг маш зөв

бодож зохицуулахгүй бол эдийн засгийн даах чадвар хэцүү байдалд орно. Ингэхгүй бол бүхнийг халамжлах гэсэн эцэг төрийн тогтолцооноос гарч чадахгүй болно. Яах вэ, сүүлийн үед үүнийг ойлгож байгаа. Цалин, тэтгэврийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Цалин-үнэ-цалин гэсэн нэг тогтолцоо байна. Цалин нэмэгдэхээр бараа, бүтээгдэхүүний үнэ нэмэгддэг. Улмаар цалингаа бушуухан нэм гэж улс төрийн өнцгөөс асуудалд ханддаг. Үүнээсээ ч гарч чадахаа байчихсан. Одоо Засгийн газар цалин, тэтгэврээ зарлаж нэмэхгүй гээд хүүхэд шиг юм яриад байх юм. Ингэх хэрэггүй. Харин цалин нэмэгдэхээр барааны үнэ нэмэгддэг байдлыг яаж саармагжуулах вэ гэдэг бодлогоо эхлээд гаргах хэрэгтэй. Цалин нэмэхээр хувийн хэвшлийнхэн тагагдаад явчихдаг. Тийм учраас улс орнууд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоохдоо зөвхөн Засгийн газар, зөвхөн МҮЭХ биш хувийн хэвшлийнхэнтэйгээ бүгд хамтраад асуудлаа шийддэг баймаар байна. Инфляция тооцдог. Хөдөлмөр, эдийн засаг, нийгмийн хослол дээр гаргаж ирэх ёстой ийм бодлого хэрэгтэй. Энэ талаасаа манайх учир дутагдалтай байна.

#### **Хамтын тэтгэврийн тухай хуулийн төслийн тухайд?**

Хамтын тэтгэврийн тухайд санаа нь зөв юм шиг. Хамтын тэтгэвэртэй улс орнууд байна уу, байна. *Нэгдүгээрт*, энэ бол даатгалын тухай асуудал. Гэтэл оруулж ирсэн төсөл дээр даатгалын мэргэжлийн байгууллагууд нь огт оролцоогүй байна. Энэ асуудлыг хариуцдаг Санхүүгийн зохицуулах хороо ч оролцоогүй. Яамдууд дангаараа төсөл боловсруулаад оруулж ирэх жишээтэй. Тэгэхээрээ л анхнаасаа буруу замаар явах гээд байгаа нь харагдаж байгаа юм.

*Хоёрдугаарт*, энэ чиглэлээр Засгийн газрын өөрийнх нь байр суурь алга. Даатгалын хэлбэрээр илэрсэн хамтын тэтгэвэр гэдэг энэ зүйл Засгийн газар болон УИХ-ын 2012-2016 оны мөрийн хөтөлбөрт байна уу гэдгийг тодруулах хэрэгтэй. Иймэрхүү зүйлийг тодруулсан уур амьсгал УИХ дээр байгаа. Намуудын байр суурь ч тодорхойгүй байна. Чуулганд оруулаад ирэхээр зарим нь бодлогоор дэмжиж байгаа гээд шууд кноп дарж магадгүй. Энэ асуудал эдийн засаг, нийгэм, хөдөлмөрийн бодлоготойгоо холбогдож орж ирэх ёстой. Нөгөө талаас бүх төрлийн халамжийг нөхцөлтэй, болзолтой болгох ёстой. Нөхцөлт мөнгөн шилжүүлэг гэж Дэлхийн банкнаас судалгаа хийчихсэн хоёр боть ном бий. Энэ бүхнээс харахад халамжийг эргээд нийгэмд нэг зүйл хийсэн байх ёстой гэсэн нөхцөлтэйгээр өгөх хэрэгтэй юм байна. Гэртээ мод тарьдаг ч юм уу. Ийм системийг зарим улс орон хэрэгжүүлсэн нь үр дүнтэй болсон. Гэхдээ энэ бүхэн манайд гарч ирээгүй байна. Ямар ч байсан манай улс хавтгайрсан халамжаас хагас руу орж чадсан. Халамж байх ёстой юу гэвэл, байх ёстой. Зорилтот хэсэгт өгөх хэрэгтэй. Халамжийн бодлогоо эргэж нэг харах цаг болсон. Үүнийгээ эдийн засгийн бодлоготойгоо уялдуулах шаардлага бий.

Намын бүлгүүд дээр дурьдсан хуулийн төслүүдийг батлахдаа “Танайхыг дэмжвэл манайхыг батална биз дээ” гээд наймаалцах гээд байна уу. Завсарлага авч, “Бидний оруулсан хуулийн төслийг хэлэлцэхгүй байна” гэж байгаагаас нь үзвэл шүү дээ. Уг нь дэмжээд байгаа юм шиг. Тэгсэн хэрнээ завсарлага авдаг?

Асуудалд ингэж хандаж, ийм шинж тэмдэг үзэгдэж л байгаа бол буруутаад явчихна. Нийгмийн тодорхой хэсэгт чиглэсэн малчинд хайртай, хайргүй гэх ч юм уу тусдаа бодлого байж болно. Энэ тохиолдолд дахиад л нөхцөлт мөнгөн шилжүүлэг гэдэг бодлого байх ёстой. Аливаа наймаалцал эдийн засаг, нийгмийн бодлого дээр огт байж таарахгүй. Өмнө нь төсвийн хэлэлцүүлгийн үеэр энэ хоёр намын бүлэг завсарлага авч байгаа орж ирэхдээ баахан объект тохирчихоод ороод ирж байсан. Ийм маягаар завсарлага аваад байвал утгагүй хэрэг. Түүнээс болоод тухайн хөрөнгө оруулалтын үр ашиг, нийгмийн ач холбогдол нь мэдэгдэхгүй болдог. Зөвхөн тойргийн талаас нь бодчихсон, эсвэл манай намын тэрний тойрог дээр гэсэн наймалцал явахаараа эдийн засгийн утга учраа алддаг. Эцсийн эцэст олонхийн санал бүгд үнэн байдаггүй. Нэг зүйлийг олонхиороо баталлаа гэхэд ард нь үлдсэн цөөнхийн байр сууринд зөв зүйл байж л байдаг. Энэ мэтийг бодож байж шийдвэрээ гаргахгүй бол эдийн засаг хараахан сайжраагүй байна.

**Монголын эдийн засаг ирэх жилүүдэд ямар байх бол. Алт, зэсийн үнэ ямар байх талаар прогноз хийсэн үү?**

Энэ онд алтны үнэ жаахан муудах байх. Зэс, нүүрсний үнэ жаахан дээшлэх магадлалтай. Манай түүхий эдийн үнэ дэлхийн зах зээл цаашдаа ерөнхийдөө сайнгүй байна гэсэн дүгнэлт ч байгаа. Бодит байдал ийм байна. Ойрын таван жилдээ ч гэсэн хэцүү болно. Тийм учраас “Нэг хөлтэй эдийн засагтай байж болохгүй. Олон хөлтэй болго. Эдийн засгаа салаалуул” гээд байгаа юм. Энэ нь эдийн засаг олон салаа мөчиртэй мод шиг, нийлээд ургадаг ийм л эдийн засгийг хэлж байгаа юм. Монголын эдийн засагт одоо гажуудал үүсчихсэн байгээ. Харин үүнийг гүнзгийрүүлэх асуудлууд одоо орж ирээд байна.

**Жишээ нь?**

Жишээ нь, уул уурхайн ба уул уурхайн бус секторуудын хооронд 90:10 гэсэн харьцаа үүсчихэж. Банк, банк бус санхүүгийн байгууллагуудын харьцаа 95:5 гэсэн харьцаатай. Энэ бол гажиг.

**Дээр дурьдсан эрсдэлүүдийг УИХ дээр тооцоолж засаж, залруулах хандлага ажиглагдаж байна уу?**

Ажиглагдаж байгаа. Хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүд хэр зэрэг үр бүтээлтэй ажиллаж байна, намын байр суурь гэхээсээ илүүтэйгээр асуудалд бодитоор хандаж чадаж байна уу гэдгээс их зүйл хамаарч байгаа. Тэрнээс бус нэг хэсэг нь давамгайлаад үүнийг лоббидож байгаа юм шүү гээд явчихвал бүтэхгүй. Дээр нь байнгын хороо намчирхалгүйгээр эдийн засаг, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр авч хэлэлцсэн хууль, бодлогууд их аятайхан гарч байгаа шүү. **Хуулийн төслүүдийг хэлэлцэж байгааг нь сонсохоор “захиалгын хууль” гэдэг үг их дурьдагдах юм. Сая л гэхэд Ашигт малтмалын тухай хуулийн төслийг “Оюутолгой”-н захиалгаар батлах гэлээ гэж шүүмжилсэн?**

Тэр бол өөр хэрэг. “Оюутолгой”-д огт хамаагүй. Өмнө нь байгуулсан гэрээгээрээ л явна. Өнгөрсөн долоо хоногт би алтны зах зээл муудаж байгаа гэдгийг хэлсэн. Ашигт малтмалын тухай хуулийг алтны хууль бус худалдаа нэмэгдсэн энэ тохиолдолд зайлшгүй авах ёстой арга хэмжээ гэж харж байгаа. Зарим үед тодорхой хэсгийн эрх ашигт нийцсэн төсөл орж ирдэг. Гэхдээ мэргэжлийн хүмүүстэй ярилцаж, үгийг нь сайн

сонсоод оруулж ирсэн бодлогын баримт бичгүүд гайгүй гараад байгаа. УИХ өнгөрсөн жилүүдэд 400 орчим төсөл, хөтөлбөр баталчихсан юм байна. Тэрний үр дүн гэж юу байна вэ. Нэг хэсэг нь хэрэгжиж, зарим нь хэрэгжих шатандаа явж байгаа. Бүр огт хэрэгждэггүй нь ч бий. Тийм учраас цэвэрлэгээ хийх талаар УИХ ярьж байна. Хэрэгждэг, санхүүгийн нөөц нь тодорхой, тэрүүгээрээ баталгаажсан хөтөлбөрүүдийг батлах хэрэгтэй. Төрөөс малчдын төлөө баримтлах бодлого гэх ч юмуу асар том үнийн дүнтэй хөтөлбөр оруулаад ирдэг. Тэрэнд нь өгөх мөнгө байдаггүй. Ийм л байдалтай байгаа.

**Одоо НӨАТ-ын босгыг 50 сая төгрөг болгох, татварын буцаан олголт өгөх талаар хэлэлцэж байгаа. Таны байр суурь юу вэ?**

Нэгдүгээрт, бүгд татвараа шударгаар төлөх ёстой. Хоёрдугаарт, хувь хэмжээг нь багасгах ёстой. Гуравдугаарт, хураадаг үйл явц нь тодорхой байх ёстой. Одоо бол хэтэрхий төвөгтэй. Энэ бүхнээс татгалзаад хялбаршуулсан, борлуулалт, худалдааны маягтай татварын тогтолцоо руу оръё гэж байгаа. Нөгөө талаас татварын 90 хувийг буцааж өгөх талаар ярьж байна. Би асуусан. “Нэгэнт 90 хувийг нь буцааж өгөх юм бол төвшингөө багасгаж болдоггүй юм уу” гэж. Одоо аж ахуйн нэгжийн орлогын татвараа хураалгана. Борлуулалтын орлого нь 1.5 тэрбумаас доош байвал 90 хувийг нь буцааж олгоно гэж байгаа. Буцааж авч яах юм бэ. Анхнаас нь ийм хэмжээний татвар авдаггүй тийм төвшинд аваач гэж хэлээд байгаа юм. **Таны хувьд УИХ-д орж ирэхээсээ өмнө Монгол Улсын эдийн засгийн бодлого шүүмжлэлтэй ханддаг байсан.**

Одоо ч шүүмжилдэг хэвээрээ.

**Гаднаас нь шүүмжлэх, дотор нь ороод ажиллах хоёр мэдээж ялгаатай. “Ингэх нь зөв шүү” гэдэг байр сууриа ажил хэрэг болгож чадаж байгаа юу?**

Тодорхой хэмжээнд чадаж байгаа. Хийх юмаа, бодлогын зүйлсээ УИХ-д оруулаад байгаа. Саяхан мөнгө угаах, терроризмтэй тэмцэх хуультай холбоотой маргаан болсон шүү дээ. Хуулийн төсөлд зургаан заалт байсан. Ямар ч байсан хасуулсан. Би Хууль зүйн байнгын хорооны гишүүн биш. Гэсэн ч УИХ-ын гишүүнийхээ эрхийг эдэлж ажлын хэсэг, байнгын хорооны хуралдаан дээр ороод зарчмын зөрүүтэй санал хэлж, гишүүд тэр саналыг маань дэмжиж зургаан заалтыг хассан. Ийм боломжууд байна. УИХ-д орсноороо нөгөө олон жил ярьсан, шүүмжилж байсан зүйлээ бодлогод тусгаж чадаж байгаа. Мөнгөний бодлого байна. Ямар ч гэсэн өмнө нь баталж байснаас цоо шинээр гаргаж ирсэн. Хүмүүс үр дүнг нь одоохондоо мэдрэхгүй байж магадгүй. Төсвийн бодлого дээр хангалттай оруулж чадаагүй. Гэхдээ бусад хөрөнгө оруулалтын хууль, жишээлбэл Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого дээр төрийн оролцооны тухай гол заалтуудыг нь би хийсэн. Төр зохицуулагч, ерөнхий гэрээлэгч байх ёстой гэсэн өгүүлбэр орсон. Жижиг, дунд бизнесийн асуудал дээр ч гэсэн. Өөрөө хууль санаачлах, батлах эрхтэй болж, гал тогоонд орж ирээд хамтарч суугаад бизнес эрхлэгчид, ард түмний хэлдэг зүйлийг хэлж байгаа. Нэлээн олон зүйл дэмжигдээд явчихлаа.

**Бондын хөрөнгийг тансаглалд зарцуулж байна гэж эдийн засагчид дүгнэх болж. Үүнтэй санал нийлэх үү?**

Тансаглал биш юм аа. Бид нэг л зүйл дээр алдаж байна. Аливаа улсад тэргүүнчлэл гэж зүйл байгаа. Тэргүүнчлэлээ өнөөдрийн ба ирээдүйн гэж тодорхойлоод цаг хугацаа талаас нь хөрөнгө оруулалтаа бодох хэрэгтэй. Өнөөдөр ба маргаашийн балансыг сайн барьж чадахгүй байна. Жишээ нь, өнөөдөр юу хэрэгтэй байна вэ. Хүмүүс эмнэлгийн коридорт унтаж байгаа. Төрөх ерөөний орон дээр хоёр эх хөлөө зөрүүлээд хүүхдүүдтэйгээ унтаж байна. Агаарын бохирдол их. Ядуурал архагшчихсан, 30 хувиас буудаггүй. Энэ бүх юм руугаа хөрөнгө оруулалт хийх ёстой. Замд анхаарал хандуулах нь зөв. Гэхдээ дээр дурьдсан жишээнүүд болон жижиг дунд бизнес рүүгээ хөрөнгө оруулах нь ч чухал. Одоо бол тэргүүлчлэлээ алдчихаад байна. Тансаглалдаа бол биш. Эдийн засгийн бодлого маань өнөөдрийн асуудал, хүний амьдралд шууд хэрэгцээтэй байгаль орчин, хүнс, санхүү рүү чиглэх ёстой. Ийм зүйл рүүгээ хөрөнгө оруулалтаа түлхүү хийгээд явах хэрэгтэй юм. Бодлогодоо жаахан амь оруулах, хүний нүүр төрхтэй болгох асуудал байна.

Сонгууль талаас нь харвал иргэд “Энэ Засгийн газар миний амьдралт бодитой өөрчлөлт оруулах юу хийсэн юм бэ” гэдгийг харах байх шүү. Зээл авахад надад ямар хөнгөлөлт үзүүлсэн бэ. Юмны үнийг барих тал дээр юу хийв гэх мэт. Ийм л амьдралын асуудлыг харж байж иргэд дүнгээ тавина. Энэ талын бодлогод түлхүү анхаарах ёстой. Мянга мянган хүмүүс бөгжөө барьцаанд тавьж зээл авах гээд ломбардны хаалга тогшоод явж байгаа. Энэ хүмүүсийн асуудлыг шийдэж чадсан уу. Санхүүгийн бичил орчин бүрдүүлж чадсан уу. Энэ асуудал л эдийн засаг, хөгжлийг тодорхойлно. Түрүүн би санхүүгийн сектор гажигтай байна гэж хэлсэн.

Дахиад нэг гажиг гараад ирсэн. Тэр нь манай хандлага. Санхүүгийн сектороо их дутуу боддог юм байна. Энэ бол Монголбанкны асуудал гээд хаячихдаг. Санхүүгийн сектороо хөгжүүлж байж бодит сектороо түлхэж явна. Ганцхан банк давамгайлах биш бусад санхүүгийн байгууллагын үйлчилгээ сайжирч, зээлийн хүүгийн бодлого зөөлөрнө. Амьдралаа сайжруулъя гээд явж байгаа жижиг, дунд салбарынханд амьдралд нь тохирсон зээл өгнө. Даатгал нь хүнд хэрэгтэй болно. Энэ бодлого хоцорчихож. Бүтээн байгуулалт гэж том том юм ярина. Тэрний мөнгийг зөвхөн бондоос гаргана гэсэн ойлголттой. Нийт масс санхүүгийн сайн орчинд амьдарч чадахгүй байгаа учраас хүмүүсийн сэтгэл ханамж доогуур л байна. Ийм юмыг анхаарч чадсан нам 2016 онд ялалт байгуулна.

-Ярилцсанд баярлалаа.

## **Яагаад 10 гаруй жил болоход иргэд газраа олж авч чадахгүй байна вэ?**

*УИХ-ын чуулганы Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2013 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс: Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын иргэнд*



*газар өмчлүүлэх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай /шинэчилсэн найруулга/ хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Л.Болд, Ц.Оюунгэрэл, Г.Баярсайхан, Л.Гантөмөр, Д.Ганхуяг, С.Одонтуяа, Л.Эрдэнэчимэг нарын өргөн мэдүүлсэн –ийг хэлэлцэх цээр*

**Байнгын хороон дарга Г.Баярсайхан:** С.Дэмбэрэл гишүүн асуултаа асууя. **С.Дэмбэрэл:** Иргэн хүн газар авахад одоогийн байдлаар хичнээн баримт бичиг бүрдүүлж байна вэ? Тэгэхдээ хууль, дүрмийн дагуу биш, бодит амьдрал дээр хичнээн цаг хугацаа орж байна вэ гэдгийг *нэгдүгээрт* лавламаар байна. Яагаад гэвэл 2003 оноос хойш энэ улсад иргэнд газар өмчлүүлэх шийдвэр нь гарсан бол өдий хүртэл тийм бага хувьтайгаар одоо хүртэл иргэд олж авахгүй байгаа заавал нэг том суурь шалтгаан байх ёстой. Өөрөөр хэлбэл агаарын бохирдлын 5-6 шалтгаан нэрлэдэг шиг ийм нэг хэдэн суурь шалтгаан байх ёстой. Үүний эхний 3 гол шалтгааныг хэлж өгнө үү? *Хоёрдугаар* асуулт маань энэ.

*Гуравдугаарх нь*, би хууль санаачлагчаас асуумаар байна. Энэ газар гэдэг тодорхойлолтоо яг юу гэж өгч байна вэ? Газар өөрөө газар зүйн талаасаа, эрх зүйн талаасаа, тэгээд эдийн засгийн орон зай гэдэг талаасаа, тэгээд яг олон улсын туршлагыг хараад газар гэдгийг юу гэж тодорхойлсон бэ? Хэрэв өнөөдөр хүртэл газрын асуудал хариуцсан байгууллагууд нь иргэддээ хангалттай хэмжээнд хурдацтайгаар энэ газрыг өмчлүүлж чадаагүй юм бол газрын корпораци гэсэн нэртэй байгууллага нь дараагийн 4 жилд хичнээн хувийг нь өмчлүүлж чадах вэ гэсэн хүлээлт байгаа вэ? Үүнийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл нь яг юу байх юм бэ? Жишээлбэл, газар олголтын нэгдсэн электрон цонх гэж байна уу? байгуулагдах уу? эсвэл газрын бирж гэж яриад байдаг, түүгээр явах юм уу гэсэн ийм асуудлуудыг хуульд яаж тодорхой тусгасан юм бол гэсэн хуулиа уншаагүй хүний анхдагч асуулт байна.

**Г.Баярсайхан:** Ц.Оюунгэрэл гишүүн та хариулчих. Дараа нь ажлын хэсэг.

**Ц.Оюунгэрэл:** Яг одоо иргэн газар өмчлөхдөө хичнээн баримт бичиг бүрдүүлж байгааг манай ажлын хэсэг дараа нь хэлээд өгөх байх. Хичнээн цаг зарцуулж байгаа вэ гэдэг дээр сонгуулиар сонгогчидтой уулзаад явж байхад, иргэд гомдол гаргаж хэлж байсан. Хамгийн хурднаараа явахад нэг жил болдог, нэлээн удаанаар явахад бид нар 6 жил болж байж, яг энэ газар гэдэг зүйлээ баталгаажуулж авч байна гээд. Яагаад ингээд 6 жил болчихдог юм бэ гээд сонирхохоор яг эхлээд газар гэдэг зүйлийг хаана хувьчлах вэ гэдэг нь тодорхойгүй. Нэг газрыг сонгож очиж аваад, тэндээ кадастр хийлгээд, баримт бичиг бүртгүүлсээр яваад, өргөдлөө гаргасаар явтал өө наад газар чинь хүнийх юм байна гэж хэлдэг. Дахиад нэг газар сонгодог гэж байгаа. Тийм учраас энэ газар сонгох гэдэг нь өөрөө бараг 2-3 жилийн ажил байдаг учраас үүнийг нь хялбар болгохын тулд бид нар геодезийн хүмүүс очиж хэмжиж өгнө, газрын корпораци хувьчлах газрыг нь сугалаанд оролцтол нь хэмжих, бэлтгэх ажлыг урьдчилж өөрийн зардлаар хийнэ гэдэг энэ заалтыг оруулж ирсэн. Энэ заалт оруулж ирснээр

хүмүүсийн 3 жилийн буюу хурдан хөөцөлдөж чаддаг азтай нэгнийх нь 6-7 сарын ажил хөдөлмөр хөнгөвчлөгдөнө гэж үзэж байгаа.

Нөгөө талаас газар хувьчилахад гардаг эхний гол 3 саад гэж байгаа. Саяных бол газраа олох гэдэг бол нэг том саад. Хоёрдугаарт нь, тэр газраа заавал та нар хашаалсан байж байх ёстой гэж хуучин хуульд байсан. Энэ хашаа гэдэг зүйлийг мөнгөгүй хүмүүс хийж чаддаггүй. Хотын захад очоод модоор хашаа баривал хүн хулгайлаад түлчихдэг, бетоноор баривал 3-4 сая төгрөгний үнэтэй. Манаачаар сахиулна гэвэл илүү их зардалтай байдаг учраас хүмүүс энэ зардлыг дийлж чадахгүй, мөнгөө багасгаж чадахгүй байсаар байгаад бас нэг, хоёр жил болдог. Ийм учраас энэ саадыг арилгахын тулд бид нар шон гэдэг зүйлийг дахиад оруулж ирж байгаа. Хүн заавал тэнд очиж хашаа барих шаардлагагүй, газрын корпорациас заагаад өгчихсөн тэр номероор нь хүмүүс очоод газраа байрлалаар нь авчихбал тэр хүний хувийн газар хашаатай ч байж болно, хашаагүй ч байж болно гэдэг утгаараа энд явж байгаа. Тэгэхээр зэрэг цаг хугацааны болон эдийн засгийн хувьд гардаг хоёр том саадыг ингэж Газрын корпорацийн шинэ зохион байгуулалт, үүргийг оруулснаар хөнгөвчилж байгаа юм.

Гурав дахь нэг том саад нь, хүмүүсийн хувийн өөрийнх нь амьдрал дээр гардаг саад. Жишээ нь, цэргийн хүмүүс хүссэн газраа очоод газраа авч чаддаггүй, армийнхан. Жишээлбэл, Хараагүй болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдөө биечлэн газар дээрээ очиж чаддаггүй. Биечлэн газар дээрээ очиж газраа өмчилж авч чадахгүй иргэд одоогийн байгаа хуулиар бол 100 хувь газаргүй үлдээд байгаа юм. Үүнийг ийм хүмүүст газрыг биечлэн биетээр авахаасаа илүү газрын сертификатаа арилжаанд оруулах замаар эдийн засгийн аргаар газар өмчлөлийнхөө үр шимийг хүртэж болохуйц уян хатан зохицуулалт оруулах үүднээс энэ газрын сертификат гэж оруулж ирж байгаа юм. Ингээд энэ нь амьдралын бүх төрлийн тохиолдолд газраа ч авч болох юм байна. Газраа өмчилж авахаасаа өмнө сертификатаа эдийн засгийн эргэлтэд оруулах замаар газар өмчлөлийнхөө эрхээр дамжуулан эдийн засгийн хувьд өөртөө үр ашиг гаргаж болохоор юм байна гэсэн ийм уян хатан 3 зохицуулалт оруулсан байгаа.

Эдийн засгийн хувьд хүмүүс энэ газрыг хувьчилж авах ямар арга механизм тусгасан бэ гэж түрүүн С.Дэмбэрэл гишүүний асуултад түрүүчийн хариултууд давхар явчихлаа. Бид нар цагийг нь хэмнэж өгөх, иргэдийн өөрсдөө хийж чадахгүй байгаа зүйлийг нь төрөөр хийлгэх. Тэгээд дээр нь биетээрээ газрыг хөөцөлдөж олж авч чадахгүй байгаа иргэдэд биржээр дамжуулан эдийн засгийн үр ашгаа хүртэх ийм уян хатан зохицуулалтууд оруулсан.

**Г.Баярсайхан:** Одоо санал хэлнэ. Содбаатар, Цолмон, С.Дэмбэрэл, Бакей, Эрдэнэбат, Болорчулуун, Бат-Эрдэнэ нар

**С.Дэмбэрэл:** Баярлалаа. Үхмэл капиталыг эргэлтэд оруулах анхны суурь хууль орж ирж байна гэж би ойлгож байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжин орсоноос хойш 22 жилийн дараа энэ зах зээлийн эдийн засгийн хамгийн гол суурь болсон газрыг эдийн засгийн харилцаанд оруулах энэ хуулиа зах зээлийн эдийн засгийн шинэ тогтолцоо руу оруулах шаардлагатай эхний хууль гэж бодож байна. Гэхдээ энэ хууль маань орж ирэхдээ бусад хуулиудтай бас багцаар хэлэлцэгдэх

ёстой. Тэгэхээр энэ логик дэс дараалал нь яваад энэ хуулийн цаад талын хүлээж байгаа нийгмийн шаардлага нь их байгаа. Үүнийг бид яаж түргэн бөгөөд үр ашигтай зөв хэлэлцэж чадах вэ гэдэг дээр бас цаашдаа бодох ёстой. Яагаад гэвэл, өчигдөр телевизээр сонссоноор Ардчилсан намын бүлэг дээр энэ хуулийг нэлээн нухацтай авч хэлэлцье гэсэн тийм шийдвэр гараад явж байгаа юм билээ. Энэ талын ажлуудтайгаа нэлээн уялдуулах ёстой байх.

*Хоёрдугаарт*, энэ хуулийн хоёр зориулалт гэж байна. Гэр бүлийн хэрэгцээ, аж ахуйн эргэлт гэсэн. Энэ бүхний ерөнхий нэг шалгуур нь энэ хуульд зааснаар шударга ёсны шалгуур гэжээ. Гэтэл гэр бүлийн хэрэгцээ, аж ахуйн хэрэгцээ гэдэг нь шударга ёсны шалгуураас гадна эдийн засгийн үр ашиг, эргэлтэд орох үр өгөөжтэй нь холбогдсон ийм асуудал болоод ирэхээр шалгуурууд нь өөрчлөгдөх байх гэж үзэж байгаа юм. Энэ бүхэн маань хуульдаа яаж тусгагдсан бэ гэдэг дээр би сайн мэдэхгүй байна, хоёрдугаар анхаарах ёстой асуудал нь энэ байгаа.

*Гуравдугаарт* нь одоо хүртэл байж ирсэн газартай холбоотой төрийн институциудын бүтэц энэ хуулиар яаж өөрчлөгдөөд, ямар илбэ шидээр үүсээд, дараагийн 4 жилийн эцэс гэхэд /2016 он гэхэд/ нийт газрын хичнээн хувь нь иргэнд очсон бэ гэдэг асуудлыг шийдэж чадвал, өөрөөр хэлбэл өмнөх жилүүдийнхээс маш дэвшилттэй бөгөөд шударга ёсны шалгуураар явах тийм орлох ийм институцийн болон хууль эрх зүйн орчныг бүрдүүлж өгч чадвал энэ хуулийн ач холбогдол оршино. Тийм учраас энэ дээр нь их анхаарах ёстой болов уу гэж бодож байна. Баярлалаа.

## **Эдийн засгийн эрх чөлөөг боомилсон шийдвэрийг багасгана**

*Монгол Улсын баялаг бүтээгчид нь бизнес эрхлэгчид. Улсын хэмжээнд 40 гаруй мянган аж ахуйн нэгж идэвхтэй цйл ажиллагаа явуулж буй статистик мэдээ байна. Тэднийг төрөөс дэмжиж хууль эрх зүйн орчин бүрдүүлж өгч байгаа ч цйл ажиллагааг нь боомилсон шийдвэр олонтаа гардаг. Энэ нь тухайн бизнесийн эдийн засгийн эрх чөлөөнд шууд утгаараа халддаг гэж болно. Тиймээс энэ асуудлаар УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлтэй сэтгүүлч С.Заяа ярилцсан юм.*

- Эдийн засгийн эрх чөлөө гэх ойлголтыг манай уншигчдад тайлбарлаж өгөхгүй юу. Монголд эдийн засгийн эрх чөлөө байна уу?

- Эдийн засгийн эрх чөлөөний тухай ойлголт суурь зүйл. Хүн төрөхдөө эрх чөлөөтэй төрдөг. Үүнийг жам ёсны эрх чөлөө гэнэ. Мөн эндээс урган гарсан аж амьдрал болон бизнесээ авч явах зэрэг нь эрх чөлөөтэй байх ёстой. Үүнийг төр тодорхой хуулиудаар зохицуулдаг. Энэ хүрээнд эдийн засгийн эрх чөлөөг боомилоогүй, хориглоогүй, урамшуулсан төрийн бодлого байх ёстой юм. Монгол Улс эдийн засгийн эрх чөлөөний индексээр дундаж төвшинд ордог. Манайд хийгдэж буй реформ буюу төрөл бүрийн хүнд суртлыг арилгах, тусгай зөвшөөрөл, лицензийн тоог бууруулах,

ухаалаг төр рүү шилжих гээд байгаа нь эдийн засгийн эрх чөлөөг бүрэн олгох гээд буй санаа юм. Дэлхийд эдийн засгийн эрх чөлөөний индексээр Хонконг дээгүүр ордог. Манайх ядахдаа эхний 20-30-д орох бодлого байх ёстой. Одоогийн төр засгаас хэрэгжүүлж буй бодлого энэ аргачлал руу чиглэж байна. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн эрх чөлөө тааруу байгаа учраас арилгах ёстой. Бизнесийг боомилсон, дарамталсан, төрөл бүрийн тусгай зөвшөөрөл, хяналт шалгалтыг багасгах шаардлага байна.

**- Бизнесмэнүүдийг боомилоод байгаа тэр тусгай зөвшөөрөл, хяналт шалгалтыг яаж багасгах гэж байна вэ?**

- Энэ байдлыг арилгахаар үе үеийн Засгийн газар янз бүрийн арга хэрэглэж байсан. Гэхдээ үүнд нэг зүйл л чухал байдаг. Тэр нь итгэл үнэмшил. Ард иргэд, бизнес эрхлэгчдэдээ эдийн засгийн эрх чөлөөг нь олгочихъё, хэт их төрийн оролцооноос бид зоригтойгоор татгалзъя, бизнес эрхлэгчидтэйгээ энэ чиглэлээр ярилцъя гэсэн итгэл үнэмшил байвал уг ажил амжилттай урагшилдаг. Энэ УИХ, Засгийн газар ийм итгэл үнэмшилтэй байгаа гэдэгт би найдаж байна. Тиймээс энэ чиглэлээр ажиллаж байгаа. Миний бие Засгийн газрын хүнд суртал тусгай зөвшөөрөл, лицензийн тоог багасгах ажлын хэсэгт ажиллаж байна. Өнгөрсөн долоо хоногт энэ чиглэлээр хуралдаж, нэлээдгүй тусгай зөвшөөрөл лицензийг багасгахыг холбогдох яам, агентлагуудад үүрэг болголоо.

**- Тухайлбал?**

- Санхүүгийн зохицуулах хорооны асуудлыг ярилаа. Тус хороо 60 гаруй зөвшөөрлөөс өөрсдөө сайн дураараа 20 гаруйгаас нь татгалзсан байсан. Үлдсэн зөвшөөрлүүдээ зайлшгүй хэрэгтэй гэж оруулж ирсэн. Бид тэгж үзээгүй. Үүнийгээ дахин 50 хувь багасгах үүрэг даалгавар өглөө. Зарим байгууллага ганцхан зөвшөөрөл хэлэлцүүлэх гэж оруулж ирсэн. Гэтэл ард нь 10 гаруй зөвшөөрөл байх жишээтэй. Тиймээс энэ зөвшөөрлүүдтэй нь цуг авч хэлэлцэнэ гээд буцаалаа. Иймэрхүү маягаар асуудлыг хэлэлцэж байна.

**- Сүүлийн үед батлагдан гарсан хуулийн хэрэгжилтэд төрийн оролцоо их байна гэж бизнес эрхлэгчид шүүмжлэлтэй хандаж байсан. Танай ажлын хэсэг үүнд хэрхэн анхаарах бол?**

- Үүнтэй санал нэг байна. Эдийн засгийн эрх чөлөөг боогдуулсан, бизнес эрхлэгчдийн сайн сайхны төлөө юм шиг мөртлөө бодит байдалд хор учруулдаг хэт их оролцоог байлгахгүй байхад манай ажлын хэсэг анхаарна. Ухаалаг төр гэдэг нь эдийн засгийн эрх чөлөөг хангадаг механизм юм. Түүнээс биш мэдээллийн технологид суурилж, хүнд суртлыг автоматчилдаг төрийг хэлдэггүй. Хүн агаар амьсгалдагтай адил тухайн хүн бизнес эрхэлж, аж амьдралаа дээшлүүлэх иргэний эдийн засгийн эрх чөлөө гэж бий. Монгол Улсын Үндсэн хуульд хүн аюулгүй, эрүүл байх, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй гэж заасан. Энэ талаас нь бодож, эдийн засгийн эрх чөлөөний асуудлыг танай сэтгүүл их хөндөж байгаа юм байна. Энэ чухал асуудал. Эрх чөлөө гэдэг ойлголт манай ард түмний тархинд их хол санагддаг. Тэгсэн хэр нь бидний өдөр тутмын амьдралд эрх чөлөө дутагдаж байна. Дугаарлахгүй, хүнд сурталтай учрахгүй, хүүхдээ гадаа хонон өнжин байж цэцэрлэгт оруулахгүй, Гэмтлийн эмнэлгийн коридорт унтахгүй байх, зээлээ арын хаалгагүй хөөцөлдөөд авах, чөлөөтэй өрсөлдөх

зэрэг эрх чөлөө бидэнд хэрэгтэй байна. Энэ бүхэн хүний эдийн засгийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай бүхий л нөхцөл боломж, хөшүүргийг бий болгох нь чухал. Монгол Улсын баялгийг бий болгох хүмүүс эрх чөлөөтэй байх ёстой юм.

**- Засгийн газар, УИХ-аас гарсан ажлын хэсгийнхэн бизнес эрхлэгчдийг боомилсон зүйл заалтуудыг багасгана гэж ойлголоо. Ажлын үр дүн хэзээ гарах вэ?**

- Францын хувьсгалын дараа хүн цаазлахад хэрэглэдэг багажийг гилиотин гэж нэрлэдэг байсан. Өөрөөр хэлбэл, тас цавчих багаж гэсэн үг. Манай баг энэ багажтай утга дүйж очно. Баг маань хоёр хэсэгтэй. Эхний хэсгийг Засгийн газрын хууль зүйн хэлтсийн дарга Энхтуяа ахалж байна. Төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн энэ багийнхан 1200 гаруй тусгай зөвшөөрөл, лицензэд бүтэн жилийн турш ажилласан. Дээд хэсэг буюу Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгээр ахлуулсан УИХ-ын гишүүдээс бүрдсэн баг мөн ажиллаж байна. Ажлын хэсэгт УИХ-ын гишүүн Д.Зоригт, М.Батчимэг, Б.Гарамгайбаатар миний бие ажиллаж байгаа. Бид дэд хэсгийн ажиллаж багасгасан тусгай зөвшөөрөл, лицензийг дахин авч хэлэлцэж байна. Үүнийг бид авч хэлэлцэхдээ гурван асуулт асууж байгаа. Бүр тодруулбал, яагаад хэрэгтэй юм, үүнгүйгээр болохгүй юм уу, үүнийг өөр газруудад шилжүүлж болох уу, бизнест ээлтэй байж чадах уу гэдгийг асууж байна.

### **Бид бизнест учруулдаг хүнд суртлыг багасгаж арилгах гэж ажиллаж байна**

*Засгийн газраас “Тусгай зөвшөөрөл, лицензтэй холбоотой бүх асуудлуудыг зохицуулах” чиглэлээр байгуулагдсан ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлээс. ... Санхүүгийн зохицуулах хороонд нийтдээ 84 тусгай зөвшөөрөл лиценз байдаг. Эндээс 21-ийг хүчингүй болгох шаардлагатай. 62-ийг нь хэвээр нь үлдээх ёстой гэсэн анализийн багаас санал болгосон... Хэлэлцэх асуудал: Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн асуудал...*

С.Дэмбэрэл: Гилиотиний баг гээд биднээс бүрдсэн нэг баг байна. Тэрний дэд хэсгээс, жишээлбэл, санхүүгийн зохицуулах хороонд 84 тусгай зөвшөөрөл байсныг та нартай яриад 21-ийг нь хүчингүй болгоод, 62-ийг нь үлдээсэн юм байна. Бидэнд бол ямар сонирхол байна вэ гэхээр, Монгол улсад бизнес дарамтгүй байдаг, бизнесийг хөнгөвчилсөн, элдэв хүнд суртал гардаггүй байлгах зорилгоор Ерөнхий сайдын захирамж гараад, УИХ-ын гишүүд бид ороод ажиллаж байна. УИХ-аас томилогддог энэ төрийн байгууллага ч гэсэн бас л тийм сэтгэл санаатай, ижил зорилготой байх ёстой. Гэхдээ өнөөдөр бид өөр өөр зорилготой байгаад байна. Та нар хамгаалдаг, бид “цаазлах” гэж зүтгэдэг юм шиг болоод байна. Дэд хэсэг ажиллаад, 62-ийг нь “бид учраа олохгүй байна, та бүхэн шийдэж өгөөч” гээд оруулж ирээд, тэгээд бид нэг нэгээр нь хэлэлцэж явах гэж байна. Энэ бол маш их цаг авна. Тийм учраас миний санал бол, нэгдүгээрт, ижилхэн санаатай бай. Энэ төр, бид



бизнес учруулдаг хүнд суртлыг багасгаж арилгах энэ чиглэлээр ажиллаж байна. Тийм учраас танайд ажлын хэсгээс даалгавар өгмөөр байна. Энэ 62 зөвшөөрлөө 50% багасгаад, шууд л 31 лиценз болгочихоод ороод ир. Тэгээд дараагийн хуралд 31 асуудлыг л ярилцъя. Гэхдээ энэ үлдсэн 31 зөвшөөрлийн нэг хэсгийг нь даатгалын холбоо руу өгье. “Бид үүнийг хийх хэрэггүй. Даатгалын холбоонд шилжүүлбэ. Хуулинд ийм өөрчлөлт оруулъя” гэж даатгал руу шилжүүлээд, “энэ хэсэг нь зайлшгүй манай хороонд байх ёстой. Үүнийг шийдэж өгөөч” гээд аваад ир. Ингэж, чиг үүргээ шилжүүлэх саналаа бас хамт аваад ирвэл 31 асуудал дээр ажиллаж болно. Санхүүгийн зохицуулах хорооны ерөнхий, бүр эрхэм зорилго нь бол Монгол улсад санхүүгийн зах зээлийг л хөгжүүлэх явдал юм. Гэтэл 62 тусгай зөвшөөрөл олгодог энэ институци маань зөвхөн хэдэн тусгай зөвшөөрлийн хүрээнд л ажиллаад байхаас биш, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, энэний хөгжилд нь дөхөм үзүүлэх, зах зээлийн оролцогчдыг дэмжих талаар хийж байгаа ажил, бодлого, шийдвэр нь харагддаггүй. Энэ бол шалгалтын явцад ч гэсэн мэдэгдсэн. Тиймээс та бүхэнд хүчтэй зөвлөхөд 62-ийг 31 болгоод л ороод ир. Үлдэж байгаа 31-ээс нь бусдад шилжүүлэх нь энэ гээд дараагийн хуралдаанаар тодорхой хугацаатайгаар оруулж ир гэж л хэлэх байна. Миний санал бол энэ.

### **Танай салбарт олгогддог ямар тусгай зөвшөөрлийг багасгах, хүчингүй болгох талаар санал бодлоо хэлнэ үү**

*УИХ-ын гишүүн, МҮХАҮТ-ын дарга С.Дэмбэрэл эрцл мэндийн салбарынхантай уулзсан уулзалтын тэмдэглэл: Уулзалт 2014 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 15:30 цагт МҮХАҮТ-ын хурлын өрөөнд болов.*

УИХ-ын гишүүн, МҮХАҮТ-ын дарга С.Дэмбэрэл, МҮХАҮТ-ын орлогч дарга Ц.Янсанжав, МҮХАҮТ-ын дэргэдэх Эрүүл мэндийн салбарын зөвлөлийн дарга, “Монголэмимпекс” ХХК-ийн ерөнхий захирал Б.Болормаа, Эрүүл мэндийн салбарын зөвлөлийн гишүүд: “Монолаб”, “Тун-Эрдэнэ Фарм”, “Цомбо”, “Эйч энд Эйч”, “Хэрбон”, “Нэмэх трейд”, “Гурвангал”, “Монфарм трейд”, “Омбол”, “Астра фарм”, “Ароно”, “Бинамикс”, “Лабтекс”, Медимпекс”, “УБ Сонгдо”, “Нахиа импекс”, “Монсэрум”, “Монос групп”, “Мон-Энзим”, “Бэриш фарм”, “Хүрмэн”, Монголын эм хангамж, үйлдвэрлэгчдийн холбоо, “Сетунари”, “Мон Со Баян”, “Гялс”, “Барагшун фарм”, “Ази фарм”, “Нью Ремеди” компаниудын төлөөлөл. /нийт 31 хүн/

***Эрцл мэндийн салбарын бизнест тохиолдож буй саад бэрхшээл, тцүнээс гарах арга зам***

С.Дэмбэрэл: Сүүлийн өдрүүдэд миний бие салбарын бизнес эрхлэгчидтэй уулзаж, бизнест тохиолдож буй саад бэрхшээл, үүнд ялангуяа тусгай зөвшөөрлийн талаар санаа бодлыг нь сонсож байна. Энэ удаад эрүүл мэндийн салбарынхантай уулзаж, та бүхний жаргал зовлонг сонсох гэсэн зорилготой юм. Иймээс та бүхэн танай салбарт олгогддог ямар тусгай



зөвшөөрлийг багасгах, хүчингүй болгох талаар санал бодлоо хэлнэ үү. Эрүүл мэндийн салбарт төрийн ямар зохицуулалт хэрэгтэй байгаа вэ? Төрөл бүрийн тушаал, дүрэм, журам бизнест чөдөр болж байгаа эсэх, цаашлаад татварын орчин, валютын ханшны өсөлт бизнест сөрөг нөлөө үзүүлж буй эсэх, тендерийн асуудлын талаар та бүхэнд хэлэх санаа оноо байгаа байх гэв.

**Б.Болормаа:** - Манай салбарынхантай уулзаж, бидний үгийг сонсох уулзалтыг зохион байгуулсанд талархал илэрхийлж байна. Эрүүл мэндийн салбар бол өөрөө тун эмзэг. Тиймээс эмзэг салбарыг төр анхааралдаа авах хэрэгтэй. Бидэнд бэрхшээл зовлон байсаар ирсэн. Манай салбарт гол нь шударга бус орчин саад болж байна. Тухайлбал, тендэр гэж юм байна. Мөн түүнчлэн эмийн салбарынхан бараг бүгд л импортлогчид. Сүүлийн саруудын валютын ханшны өсөлт биднийг сөхрүүлэх боллоо. Зарим компаниуд бүр алдагдалд орсон. Төр үүнд зохицуулалт хийхгүй бол эмийн салбар унахад бэлэн байна.

**С.Дэмбэрэл:** - Валютын ханшны өсөлтөөс болж компаниуд алдагдал хүрч байгаад төр хуваалцах ёстой гэсэн байр суурьтай байдаг, би. Төрийн буруу бодлогоос болж бизнес муудах ёсгүй. Удахгүй энэ талаар Монголбанкттай ярьж, мэдэгдэл гаргуулах болно. Тендэрийн тухайд хэдэн жил ярьж байна. Өнөөдөр энэ асуудал шинэчлэгдэхгүй байгаа нь үнэн. Тиймээс тендэрийн талаар хууль эрх зүйн орчны талаар хийхээр төлөвлөж байгаа юм бий. Харин та бүхэнд энэ талаар тодорхой санал байвал бичгээр өгөөрэй.

**А.Цолмон /эмнэлгийн тоног төхөөрөмж импортлогч “Эйч энд Эйч” ХХК-ийн ерөнхийлөгч /:** - Эрүүл мэндийн салбарын тусгай зөвшөөрлүүд бол хэрэгтэй зүйл. Гэхдээ зарим нэгэн импортын зөвшөөрлүүд нь давхацдаг. Өөрөөр хэлбэл, худалдах болон импортын тусгай зөвшөөрлийг хэлэх байна. Манайд эрүүл мэндийн тоног төхөөрөмжийн стандарт ер байдаггүй.

**С.Дэмбэрэл:** - Зарим салбарт стандарт бизнест саад болдог гэдэг. Харин нөгөө хэсэг нь стандартыг сайн дурын үндсэн дээр байлгах саналтай юм билээ. Давхацсан тусгай зөвшөөрлийн талаар манай Гиллиотины багаар оруулахыг зөвлөж байна.

**О.Дамба /Монголын эм хангамж, үйлдвэрлэгчдийн эм холбооны гүйцэтгэх захирал/:** - Эмийн салбарт өнөөдөр 40 орчим зөвшөөрөл байдаг судалгаатай бөгөөд давхацсан зүйл бий. Түүнээс гадна эм импортлогчдод зөвхөн төмөр замаар тээвэрлэх гэсэн нэг шаврын хаалт журам байдаг. Эрүүл мэндийн улсын байгууллагууд төрөөс жилдээ 70 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилт авдаг. Харин хувийн хэвшлийнхэн төрөөс юм хүртэхгүй байгаа. Хувийн хэвшлийнхэн нийгмийн төлөө л явдаг. Өнөөдөр ядуурал буураагүй л байна. Ядууралд хувийн хэвшлийнхний үүрэг их байх ёстой. Сайн эмнэлэг, чанар сайтай эм ядуурлыг бууруулах нэг хөшүүрэг гэж үздэг. Эмийн сангуудаар худалддаг хөнгөлөлттэй эмийг ядуучууд биш, харин боломжийн иргэн хүртэж байгаа нь нууц биш. Иймд эмийн хөнгөлөлтийн асуудлыг эргэж харах хэрэгтэй. Тендэрт шалгарсан байгууллага валютын ханшийн өсөлтийг даахгүй байгаа бөгөөд араасаа авлига, хүнд суртлыг дагуулсаар байна. Татварын буцаан олголтыг бид хүсэж байна. Эмийн бүх компаниуд өнөөдөр НӨАТ төлдөг. Үүнийг бууруулах талаар та ямар бодолтой байгааг сонирхох байна.

**С.Дэмбэрэл:** - Одоогоос таван жилийн өмнө МҮХАҮТ Монгол Улсад бизнес хийх замын зураглал гаргасан. Энэ номонд эм импортлох процесс, үүнд цаг хугацаа зардал, эмийн импортын үйл ажиллагааны диаграмм зэргийг тусгасан. Тухайлбал, эм импортлоход таван үе шат дамжиж, шат бүрдээ 18-19 хүний гарын үсэг цуглуулж, зөвшөөрөл авдаг гэж гарчээ. Энэ шат дамжлага өнөөдөр хэвээрээ байна уу?

**О.Дамба:** - Өнөөдөр эм импортын шат дамжлага буураагүй, харин ч ихэссэн.

**С.Дэмбэрэл:** - За, тэгвэл, эрүүл мэндийн салбарынхны бизнес хийх замын зураглалыг шинэчилж, ойрын хугацаанд тусгай зөвшөөрлийн хувь заяаг шийдвэрлэдэг Гиллиотины багаар оруулмаар байна. Харин та бүхэн манай зөвлөлтэй хамтран замын зураглалаа шинэчилж, томоор гаргаж, Гиллиотины хуралд ирээрэй гэж хүсэх байна. Энэ дашрамд нэг зүйлийг хэлэхэд, НӨАТ бууруулах талаар хуулийн төсөл боловсрогдож байгаа. Энэ төслөөр бүгд НӨАТ төлнө, гэхдээ бүгд 5 хувь гэж орсон. Хаврын чуулганаар энэ асуудал хэлэлцэгдэнэ, дэмжих эсэхийг мэдэхгүй. Нэмж бас нэг мэдээлэл хийхэд, сарын өмнө миний бие Эрүүл мэндийн сайд Н.Удвалтай уулзаж, эрүүл мэндийн салбарынхныг оролцуулсан эрүүл мэндийн чуулганыг ирэх тавдугаар сард зохион байгуулах талаар саналаа солилцсон. Иймд манай зөвлөл та бүхэн хамтран энэ чуулганыг хийвэл их сайн байна. Одооноос бэлтгэл ажилдаа орохыг зөвлөө. Яам чуулганыг дэмжинэ гэдгээ хэлсэн байгаа.

**Ц.Ганбат /эмнэлгийн хэрэгслийн импортлогч “Лабтекс” ХХК-ийн захирал/:**

- Өнөөдөр банкны зээл өндөр хэвээр байна. Импортын татвараас бүх эмнэлгийн тоног төхөөрөмж чөлөөлөгдөж чаддаггүй. Жишээ нь, оношлогооны төхөөрөмжөөс импортын татвар авдаг. Импортыг тэглэсэн журмын хугацаа дууссан. Эм, эмийн тоног төхөөрөмж үйлдвэрлэгчид уг нь бүгд ЖДҮ эрхлэгчид шүү дээ. Энэ асуудлыг дахин шийдвэрлэмээр байна.

**Р.Мөнхцэцэг /эмийн худалдаа, үйлдвэрлэлийн “Цомбо” ХХК-ийн ерөнхий захирал/:** - Монголд эмийн үйлдвэрлэл эрхэлдэг 30 гаруй компаниуд бий. Эрүүл мэндийн яам, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас гаргасан олон улсын өндөр стандартыг биднээс шаарддаг. Гэтэл бид энэ стандартад чирэгдэх болсон. Манайд эмийн бодлого гэж байдаггүй. Эх орондоо үйлдвэрлэж чадаж байгаа эм, эмийн бүтээгдэхүүнд импортын зөвшөөрөл олгомооргүй байна. Тендэр хүндрэлтэй явагддаг. Тухайлбал, 20 эм үйлдвэрлэнэ гэсэн тендэрт шалгарсан үйлдвэр бараг 200 эм шинээр үйлдвэрлэх болдог. Энд санхүүжилт маш их хэрэгтэй. Тиймээс тодорхой хэмжээнд төр санхүүжилт гаргавал сайн байна.

**О.Дамба:** - Эрүүл мэндийн салбарт шалгаруулсан тендэрт хөндлөнгийн мониторинг яаралтай хийх хэрэгтэй байна. Эндээс их юм гарна, тендэр зөв шударга, чанартай явагдаж уу гэдэг нь ил болно. Монголд эм, эмийн бүтээгдэхүүний стандарт өөр өөр байдаг. Үүнийг цэгцлэх хэрэгтэй.

**Н.Жавчиндорж /рашаан сувиллын “Нэмэх трейд” ХХК-ийн ерөнхий захирал/:**

- Өнгөрсөн сарын 17-ны өдөр Эрүүл мэндийн сайд 51 дүгээр тушаал гаргажээ. Тушаалын нэр нь “Эмнэлэг, сувиллын орны дээд хязгаарыг

батлах тухай “ гэж. Энэ тушаалыг би шүүмжилмээр байна. Төр, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд хутгалдаж байгаагийн нэг жишээ энэ юм. Яам хувийн эмнэлэг, рашаан сувиллын орны тоонд хязгаарлалт тавьж байгааг ойлгохгүй байна. Үйлчлүүлэгч хүрээд ирвэл уучлаарай, манай орны тоо гүйцсэн гээд явуулж таарах нь. Нөгөө талаас уг тушаалд эмнэлгийн орны дээд хязгаарт өөрчлөлт орсонтой холбогдуулж, хувийн хэвшлийн эмнэлгийн байгууллагуудад эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих орны тоо, өөрийн орлогоор санхүүжих орны тоог зааж өгчээ. Тодруулбал, хувийн эмнэлгүүдэд даатгалын сангаас санхүүжих орны тоо нь улсынхтай харьцуулбал харьцангуй бага гарсан байна. Өөрөөр хэлбэл, санхүүжилт ялгавартай батлагджээ. Тиймээс энэ яамны тушаалыг хүчингүй болгох санал гаргаж байна. Бас нэг санал хэлэхэд Эрүүл мэндийн яамны цахим сайт дээр бидэнд хэрэгцээтэй мэдээлэл огт байдаггүй. Тэгж журамлав, ингэж зөвшөөрлийг хязгаарлана гэсэн бизнесийг дэмжих бус, дарамтлах мэдээлэл түлхүү байдаг.

**Д.Дандий /биобүтээгдэхүүн үйлдвэрлэгч “Монсэрүм” ХХК-ийн захирал/:**

- Биобэлдмэл болон вакциныг эм гэж тодорхойлоход бэрхтэй. Эдгээр нь хүний эрүүл мэндтэй холбоотой учир анхаарахгүй бол болохгүй нь. Вакцин, биобэлдмэл хоёр эмнээс хоцорч байна. Өнөөдөр шүлхий, галзуу өвчин гээд газар авах нь. Одоо манайд хэрэглэж байгаа вакцинуудыг ДЭМБ зөвхөн зөвшөөрсөн болохоос биш, хоёр сая гаруй хүн амтай улсад аль серийн вакцин нь тохиромжтой гэдэг дээр хэзээ ч зөвлөмж өгч байгаагүй. Тэд ч тухайн улс ямар вакцинаа иргэндээ тарих нь огт хамаагүй, бид зөвхөн гэрчилгээ олгодог гэдэг. Манайд орж ирж байгаа вакцинууд чанарын хувьд хоцрогдсон гэж хэлэх байна. Дийлэнх улс орон хүн амдаа ямар вакцин тарих эсэхээ эхлээд тухайн улс руу явж, судалгаа хийснээр, за ийм серийн вакцин энэ вируст тохиромжтой гэсэн саналаа гаргадаг юм. Манайх энэ туршлагыг хэрэгжүүлэх хэрэгтэй.

Миний бие 60 гаруй жил биобэлдмэлийн талаар судалгаа шинжилгээний ажил хийлээ, одоо ч хийсээр байна. Биобэлдмэлийг эндээ үйлдвэрлэхэд түүхий эд байна, боловсон хүчин ч бий. Одоо гагцхүү байр савтай болж, тодорхой хэмжээний санхүүжилтийг төр гаргаж үйлдвэрлэлээ эхлүүлмээр байх юм. Эхний удаад альбумин, гемоглобулин хийх хэрэгтэй. Энд өөр нэг санал хэлэхэд, манайд оюуны бүтээлийг барьцаалах тухай хууль гарах нь уу? Мөн гепатит С,В вирусийн загвар технологийн төсөл боловсруулсан байгаа. Үүндээ патент авмаар байна.

**С.Дэмбэрэл:** - Вакцины талаар манай ард түмэн сайн ойлголтгүй байгаа. Манайхны эрүүл мэндийн боловсрол ч тааруу. Нийтээрээ эрүүл саруул байж, эрүүл саруул сэтгэж, хөдөлмөрлөнө. Эрүүл мэндийн даатгалын сан мөн л хангалтгүй байдаг нь ДЭМБ-аас гаргасан судалгаагаар харагдана лээ. Орчин үеийн шинэ дэвшилтэт эмнэлгийн тоног төхөөрөмжийн санхүүжилтийг төр өөр дээрээ авсан ч уг нь болно. Манай Танхимын цахим сайт дээр оюуны бүтээлийн барьцааны тухай хуулийнд саналаа өгнө үү гэсэн мэдээлэл байгаа. Та энд саналаа өгөөрэй.

**Н.Эрдэнэ /эмийн худалдаа, үйлдвэрлэлийн “Нахиа импекс” ХХК-ийн дэд захирал/:** - Сүүлийн үед төр эмийн хангамжийн компаниуд руу дайрдаг

болжээ. Үүнээс үүдэж нийгэмд бидний талаар буруу мессеж нисч байна. Эмийн сангууд хэд дахин бүтээгдэхүүнээ өсгөдөг гэнэ. Энэ бол маш ташаа мэдээлэл. Эмийн чиглэлээр 40-50 компаниуд тусгай зөвшөөрөл авдаг бөгөөд энэ бичиг баримт хэрэгтэй зүйл. Харин зөвшөөрлөөр гадны стандартыг шаарддаг нь амьдралд нийцэхгүй байна. Өнөөдөр эмзүйч мэргэжилтэй боловсон хүчин дутмаг байна. Эцэст нь хэлэхэд төр жижиг компаниудыг устгах чиглэл барьж байгаа мэт бодлого нь харагдаж байна.

**Ж.Нина /эмийн худалдаа, үйлдвэрлэлийн “Монфарм Трейд” ХХК-ийн зөвлөх/:**

- Эмийн жорын стандартыг өөрчлөх хэрэгтэй. Эмийг олон улсын эмийн худалдааны нэрээр болгох шаардлагатай байна.

**Ж.Рэнцэн-Амгалан /”Тун-Эрдэнэ фарма” ХХК-ийн ерөнхий захирал/:**  
- Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэйгээр 370-380 эм олгодог. Миний бодлоор төр дотоодын зах зээлийн эмийн бараг 80 хувийг нь даатгалд хамруулах хэрэгтэй гэж санагдаж байна. Эдгээр хөнгөлөлттэй эм жинхэнэ хүндээ хүрдэггүй. Өнөөдөр эмийн салбарынхныг Нийслэлийн эрүүл мэндийн газар, Нийслэлийн даатгалын газар дарамтлах нь их болсон.

Анхны хувьчлагдсан салбар бол эмийн сангууд. Анх орцонд, дараа нь орон сууцны нэгдүгээр давхарт үйл ажиллагаагаа явуулж байлаа. Харин одоо бол орон сууцны нэгдүгээр давхарт эмийн сан ажиллуулахыг хатуу хориглоод байна. Дээр нь эм хангамжийн газруудыг нийслэл хотоос хөөх болов. Эмийн салбарынхан өнөөдөр тун хэцүү байдалтай үйл ажиллагаа явуулдаг. Төр нь дэмжих битгий хэл, бараг гадуурхах болсон. Ерөнхий сайд хар зах дээр үр зулбуулдаг эм зардаг алуурчдыг илрүүлж чадахгүй байж, мань мэтийгээ буруутгаж байна. Манай салбарт төрийн бодлого байхгүй. Хүний эрүүл мэнд чухал гэдгийг төр ухаарахгүй явна. Эм импортлох зөвшөөрөлгүй байж “Оюунтолгой” эм, эмийн бүтээгдэхүүнээ гаднаас зөөдөг болсон. Ямар ч бүртгэлгүй эм орж ирж байна. Эрүүл мэндийн салбарын статистик буруу зөрүү, тогтворгүй гардаг. Эм болон хүнсийг нэг дор зохицуулах болоод байна. Энэ бол бүтэхгүй, эмийн хангамжийн тусгай агентлаг бий болгох хэрэгтэй юм.

**Б.Оюунбат /”Оргил фарм” ХХК-ийн менежер/:** - Тусгай зөвшөөрөл манай салбарт хэрэгтэй. Гэхдээ төр олон хяналт шалгалтыг устгамаар байна. Аливаа шалгалт дэмжих бодлого барих ёстой.

**С.Дэмбэрэл:** - Та бүгдийн ярианаас сонсоход эрүүл мэндийн салбар маш замбараагүй байдаг юм байна. Эрүүл мэндийн салбарт төрийн бодлого байлаа ч, гол нь хэрэгждэг байх ёстой. Ард түмний дунд эмийн худалдааны талаар буруу ойлголт яваад байгаад та бүхэн өөрсдөө сайн пи-ар хийх хэрэгтэй. Хэвлэлийн бага хурал зохиох, сонин хэвлэлд булан гаргах зэрэг нь нээлттэй шүү.

**З.Зузаан /Азийн хөгжлийн банкны Эмийн салбарын зохицуулалтын зөвлөх/:**

- Манай банкнаас эм хангамжийн талаар төсөл боловсруулаад Засгийн газарт хүргүүлсэн байгаа. Төсөлд эмийн зар сурталчилгааг оруулж, эх орны үйлдвэрлэлийг дэмжих, эрүүл мэндийн салбарт төрийн нэгдсэн зохицуулалт байх шаардлагатай, тогтолцоог бий болгох санал орсон байгааг дуулгах байна.

**Ц.Норовпил /"Ароно" шүдний эмнэлгийн захирал/:** - Миний бие шүдний эмчилгээ болон шүдний цөөн тооны тоног төхөөрөмж гаднаас оруулж ирдэг юм. Гэтэл шүдний зориулалтын зүйлсээс кресло сандал л цор ганцаараа чөлөөгдсөн байдаг. Бусад нь бүгд татвартай, бид чинь жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид шүү дээ. Тиймээс энэ асуудлыг эргэж харж үзнэ үү. Өнөөдөр шүдний салбар сайн хөгжиж байна, боловсон хүчин ч мөн сайн байна. Харин гаднаас энэ салбарт орж ирж байгаа эмнэлгүүдийг таслан зогсоох хэрэгтэй. Шүдний эмнэлгийг зөвхөн нэг газар үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрдөг. Өөр газар салбар нээхийг зөвшөөрдөггүй. Энэ бол бизнесийг нэг талаар хязгаарлаж байна. Эмнэлгийн салбарын импортын зөвшөөрлийг тоног төхөөрөмж болгоноор 14 хоногийн хугацаатай авдаг нь хүндрэлтэй байна.

Хүүхдийн шүдний өвчлөл их байна. Тиймээс энэ асуудлыг төр дангаараа хариуцаж болдоггүй юм уу. Манайд шүдний урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй явагдана. Хоёрт, эрүүл мэндийн даатгалд бүх иргэдийг хамруулж оруулах хэрэгтэй байна. Монгол эмч нар тухайн өвчнийг анагаах чадаж байгаа салбарт гадны эрүүл мэндийн чиглэлийн компаниудыг эх орондоо оруулмааргүй байна.

**С.Дэмбэрэл:** - Та бүгдийн ярианаас сонсоход өнөөдөр эрүүл мэндийн салбар хэцүүхэн байдалтай байгаа юм байна. Энэ удаагийн уулзалтын тэмдэглэлтэй сайтар танилцаж, ямар арга хэмжээ авах талаар холбогдох байгууллагатай ярилцах болно. Дахин хэлэхэд, Гилиотины багаар оруулах асуудлаа сайтар боловсруулж, тусгай ямар зөвшөөрөл бизнест саад болж байгаагаа замын зураглал хэлбэрээр гаргахыг зөвлөж байна. Эрүүл мэндийн даатгалын хуулийн төсөл явагдаж байгаа. Эрүүл мэндийн салбарын бизнес эрхлэгчид жижиг, дунд үйлдвэрлэлд хамаарах ёстой. Энэ утгаараа төрийн бодлогод орох ёстой юм. Салбарын тендэрийн асуудалд мониторинг та бүхний зөвлөсний дагуу хийе.

Миний бие Нийгмийн Бодлогын байнгын хороонд эргээд орох бодолтой байгаа. Хорооны гишүүний хувьд эрүүл мэндийн боловсрол, эрүүл мэндийн даатгалын системтэй холбоотой асуудалд түлхүү анхаарч ажиллах болно. Эрүүл мэнд бол ядууралтай холбоотой. Өрхийн эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулахаас эхлээд энэ салбарт хийх ажил их байна гэж ойлголоо. Ирэх тавдугаар сард болох эрүүл мэндийн чуулганы үер та бүхэн зовлон жаргалаа сайн ярих хэрэгтэй.

Бид бараг гурав цаг орчим хуралдлаа. Энэ удаагийн уулзалт үр дүнтэй болсон эсэхийг ажил хэрэг харуулах ёстой. Өөрөөр хэлбэл, энэ салбарт ямар шинэчлэл гарав гэдгээс хамаарна. Би одоо Элчин сайдтай цаг товлосон учир гарлаа. Тиймээс уулзалтыг Ц.Янсанжав үргэлжлүүлэн удирдаад явна.

**Ц.Янсанжав:** - Зөвлөлийн гишүүд улиралд нэг удаа уулзалт хийж, салбарынхаа зовлон жаргалаа ярьж баймаар байна. Зөвлөлийн ажлыг тогтмолжуулах, идэвхжүүлэх нь чухал. Та бүхэн бизнест саад болж байгаа, ямар бэрхшээл учирдаг талаараа Танхимд бичгээр саналаа тогтмол өгч байхыг зөвлөө. Бид хамтарч ажлаа явуулж байж, бизнесийн таатай орчинг бий болгох ёстой. Та бүхэнд амжилт хүсье.

*Уулзалтын тэмдэглэлийг хөтөлсөн: МҮХАҮТ-ын дэргэдэх Эрцүл мэндийн салбарын зөвлөлийн нарийн бичиг Б.Сарантуяа*



## **Валютын ханшаас үүдсэн хохирлыг төр хуваалцах ёстой**

***“Өдрийн сонин”-ы сурвалжлагч Э.Энхболд УИХ-ын гишүүн, ИЗНН болон МҮХАҮТ-ын дарга С.Дэмбэрэлтэй зарим сэдвээр ярилцжээ.***

**- МҮХАҮТ-аас бизнес эрхлэгчдийг хүлээн авч ам.долларын ханшийн талаар уулзалт зохион байгуулжээ. Бизнес эрхлэгчид ам.долларын ханшийн тал дээр ямар байр суурь илэрхийлэв?**

- Энэ уулзалт зөвхөн өнгөрөгч долоо хоногт болсон юм биш. УИХ-ын завсарлагаанаар салбар бүрийн бизнес эрхлэгчидтэй тав дахь уулзалтаа хийлээ. Аль ч Их хурлын гишүүн Монгол Улсын ямар ч албан тушаалтан улс орны эдийн засгийн байдалд дүн шинжилгээ хийж, санаа нь зовж, цаашид авах арга хэмжээний талаар төлөвлөлт хийн ямар нэгэн тоон дээр ажиллах шаардлагагүй. Төсвийн орлого ингэлээ, макро эдийн засаг тэглээ гэж ярих нь хангалттай биш. Бодит сектор руу орж тэдэнтэй уулзаж, зовлон жаргалыг нь хуваалцаж, сорилт шалгуурыг нь сонсож, цаашид авах арга хэмжээн дээрээ цаасан дээр байгаа хуурай тоотойгоо хослуулж төлөвлөх шаардлагатай байгаа юм. Төр хариуцлагагүй байдаг түүн дээр нь хувийн хэвшлийн хариуцлагагүй байдал нөлөөлсөн л байх. Аль аль нь хариуцлагагүй байхаас гадна асуудал яагаад ийм байдалд хүрэв. Эдгээр барилгууд зураг төсөлгүй байна гэдгийг анхаарах ёстой. Үүнд тодорхой хэмжээнд валютын ханш хамааралтай. Валютын ханшийн галзуурал, түүнийг тогтоон барьж чадахгүй байгаа нь хүмүүсийг хохироож байгаа. Тендерийн гэрээ хэлцэл дээр нь валютын ханшийн талаар юу ч алга. Өнгөрөгч баасан гаригийн уулзалтаар ам.долларын ханш бизнест нөлөөлж байгаа нь үнэн гэдгийг хэлж байсан. Би эхэндээ бизнесийнхэнд эерэг нөлөөлөл байгаа байх гэж бодсон. Тэгсэн үгүй байна лээ. Монгол Улсын хамгийн том экспортлогч Эрдэнэт үйлдвэрийнхэн хүртэл гомдол мэдүүлж байна. Томоохон бизнес эрхлэгчид валютын ханшийн савлагаа бизнесийн тогтвортой байдлыг алдагдуулж байна, алдагдалд оруулж байна, төлөвлөж болохгүй байна гэдгийг хэлсэн. Ямар сайндаа валютын ханшийн өөрчлөлтөөс болж хохирсон талаараа шүүхээр яваад нэмэр алга. Иргэний хуулийн 218-ын А гэсэн заалтад ямарваа нэгэн гадаад валютаар хийгдсэн бараа үйлчилгээний хэлцлүүд дээр валютын ханшийн зөрүүгээс болж алдагдал үүссэн бол хэлцэл хийгдсэн үеийн ханшаар тооцно гээд цагаан дээр хараар тов тодорхой заачихсан. Гэтэл үүнийг янз бүрээр тайлбарладаг. Ханшийн зөрүүнээс болоод хохирсны дараа шүүхээр явахаар үр дүнд хүрэхгүй байна.

**- Ханшийн эрсдэлийг яах ёстой вэ. Хүмүүсээс асуухаар тодорхой хариулт өгөхгүй байна?**

- Валютын ханшийн хэлбэлзлийг бий болгож хүмүүсийг хохироочихоод, ард иргэдийн бараа бүтээгдэхүүний үнийг нь нэмж өгсөн хэрнээ төсвийн орлого нь хохирдоггүй ийм нөхцөлд валютын ханшийн эрсдлээс хэрхэн хамгаалах вэ гэдгээ үндэсний хэмжээнд ярих асуудал гарч ирж байна. Тэр нь 2014 оны мөнгөний бодлогод уг нь анх удаа тавигдсан. Түүнээс өмнө



"Валютын ханш уян хатан бөгөөд чөлөөтэй тогтох ёстой" гээд 10 гаруй жил явж ирсэн. Ингэж явсаар тодорхой хэмжээний хэлбэлзэлд нь валютын нөөц ихтэй үед нь интервенц хийгээд яваад ирж болсон. Гэтэл экспортын орлого нь муудсан, гадаад хөрөнгө оруулалт татарчихсан, дотоодын хөрөнгө оруулалтаа эвдчихсэн энэ үед хүмүүс хөрөнгө оруулалт хийхээсээ айж, үргэж, зугтаж байгаа нөхцөлд зургадугаар сард сайхан болно, мөнгөтэй болно гээд сууж болохгүй. Гадаад худалдааны тэнцэлд ашигтай импорт багасч байна. Эдийн засгийн идэвхижил байхгүй болчихож. Монголын эдийн засаг гаднаас ихээхэн хамааралтай. Хэрэв дотоод зах зээл дээр импорт татраад цаасан дээр нэмэх тэмдэгтэй эсвэл тэнцүү гарлаа гэхэд дотоодод идэвхжил унаад, инфляци нэмэгдээд, валютын ханш бизнесийн орчинд сөргөөр нөлөөлөөд эхэллээ. Энэ тохиолдолд аль нь зөв бэ. Мэдээж хүн амын худалдан авах чадвар муудна. Бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлнө. Засгийн газраас импортыг орлох экспортыг нэмэгдүүлэх хөтөлбөрийг зарлачихсан. Ийм тохиолдолд бид энэ асуудлыг яаралтай хэлэлцэх ёстой хэмээн бизнес эрхлэгчид хэлж байсан.

**- Валютын ханшийг тогтвортой байлгах гарц нь юу вэ?**

- Одоо интервенцээр ам.долларын ханшийг тогтоон барих талаар яригдаж байна. Ийм тохиолдолд тодорхой хугацаанд гурваас зургаан сарын хугацаанд захиргааны шинжтэй аргыг хэрэглэх шаардлагатай. Энэ зах зээлээс гажууд зүйл биш. Бусад орнууд ч гэсэн иймэрхүү зүйлийг хэрэглэдэг байсан. Манай улсын валютын ханшийн дэглэм бол зохицуулалттай хөвөх ханшийн дэглэм байгаа юм. Зохицуулалттай гэдэг нь төр оролцох ёстой гэсэн үг. Төрийн өмнөөс Төвбанк оролцоно. Түүнээс гадна хоёр субъект болох Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо мөн дефакто буюу Эдийн засгийн хөгжлийн яам зэрэг газрууд валютын ханшийн хөдөлгөөнийг санхүүгийн тогтвортой байдлыг Монгол Улсад хангах үүрэгтэй. Харамсалтай нь үүргээ биелүүлж чадахгүй байна. Санхүүгийн тогтворгүй байдал үүсч байна.

**- Үүргээ биелүүлж чадахгүй байгаа эдгээр газруудын удирдлагууд муу байна гэсэн үг үү?**

- Удирдлагууд муу байгаа гэхээс илүү манай төрийн байгууллагуудын хоорондын уялдаа муу байна. Хэдийгээр 2014 оны мөнгөний бодлогод өмнө нь орж ирж байсан ганц өгүүлбэрийг тав, зургаан өгүүлбэр болгоод задалсан. Үүний нэг гол зүйл нь валютын ханшийн эрсдэлээс хамгаалах механизмыг бий болго гээд цагаан дээр хараар бичээд өгчихсөн байгаа. Дээр нь Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийг ажиллуулсан шиг ажиллуулж, институци талаас нь бэхжүүл, үүний тулд хууль эрхзүйд нь өөрчлөлт оруул гээд даалгавар өгөгдчихсөн. Зарим нэг ажлууд хийгдэж байгаа ч харамсалтай нь маш удаан байна.

**- Өнгөрсөн оны долдугаар сараас хойш ам.долларын ханшийн өөрчлөлтөөс бий болсон хохирлыг хэн төлөх вэ?**

- Хүмүүс алдалдлыг нь бид яах юм гээд тендерг орохоосоо хүртэл айж эхэлсэн. Иймэрхүү байдалтай үед валютын ханшийн зохицуулалтыг стандарт бус аргаар хийх ёстой. Тэр нь юу гэсэн үг вэ гэхээр валютын ханшийн хэлбэлзэх хязгаар нь 1700-1800 руу дөхөж байна. Өмнө нь 1500 байхад нь 1600 руу алдсан. 1600 байхад нь 1700 руу алдсан. Энэ мэтчилэн тэгш тоонууд

нь сэтгэлзүйн түвшинд цаашид өсөх юм байна гэсэн хүлээлт үүсгэчихдэг. Ийм үед дамын тоглолт ихээр явагдаж ханшийн өөрчлөлт дээр ашиг хийх гэдэг. Үүнийг бизнесүүд хийж чадахгүй байна. Бизнесийнхэн валютын ханш төдий хэмжээгээр нэмэгдэнэ гээд төлөвлөгөө гаргасан байдаг. Гэтэл 30 хувиар суларчихаар тэдний огт хүлээж байгаагүй нөхцөл бүрдчихдэг. Шинэ зах зээлийг тогтвортой байлгахын тулд иймэрхүү валютын ханшид шууд нөлөөлөх захиргааны шинж чанартай тухайлбал валютын хонгилын хэмжээг тогтоох, валютын зээл, хадгаламжаас төгрөгийн зээл, төгрөгийн хадгаламж ашигтай байхаар зохицуулалтыг хийх хэрэгтэй. Ханшийн зах зээл дээр орологчдын тоог нэмэх шаардлагатай. Өнөөдөр 5-7 банк оролцож байгаа тэр эрэлтийг нь хангаж байна. Гэтэл нийлүүлэлтийн эх үүсвэр нь ганцхан төв банк. Экспорт хийдэг том компаниудыг оролцуулах нь зөв. Импорт хийдэг томоохон компаниудыг оролцуулах боломжийг хангаж өгөх хэрэгтэй байна. Банк бус санхүүгийн байгууллага болон бусад санхүүгийн байгууллагуудын оролцоог хангах нь зүйтэй. Валютын ханшийн зах зээлийг өргөтгөх үүний үндсэн дээр эрэлт, нийлүүлэлтийн харьцааг бодитой тогтоох гэх мэт үйл ажиллагааг зайлшгүй хийх ёстой.

**- Ээлжит бус чуулганаар валютын ханшийн талаар ярих уу?**

- Бид ээлжит бус чуулган гээд төсвийн тухай л юм яриад байна. Валютын ханшийн өсөлт эдийн засагт эрс нөлөөлж байгааг харлаа. Эдийн засгийн эрс нөлөөлөл нь Үндэсний статистикийн хорооноос гардаг судалгаан дээр энгийн нүдээр харахад төдийлөн тусгагдахгүй байгаа. Зах зээл бүхэлдээ хэрэглэгч, үйлдвэрлэгчийн талаасаа ч идэвхгүй байдалд орчихлоо. Энэ тохиолдолд түүнийг зохицуулах, хажуугаар нь санхүүгийн мөнгөн урсгалыг оруулж ирэх асуудал гарч ирнэ. Түүнээс зургадугаар сард хөрөнгө оруулалт нэмэгдэнэ гээд Оюу толгойд найдаад байх шаардлагагүй. Энэ бол өөр үзүүлэлт. Уг бодлого явах ёстой. Гэтэл наана нь байгаа гурван сард валютын ханш хэд хүрэх вэ. Ингээд явуулаад байх юм уу. Саяхнаас эхлээд форвард хэлцлийн дагуу Монголбанк ирээдүйг угтан харсан ханшаар зарж байна. Гэхдээ өмнө нь 2013 онд аль хэдийнэ хохирчихсон компаниуд болон 2014 онд хохирч байгаа компаниуд шууд нөлөө үзүүлж чадахгүй. Арилжааны банкууд хэрэгцээтэй шаардлагатай боломжоор нь өгч чадахгүй. Дээр нь ханшийн хөдөлгөөнийг долдугаар сараас хойш харахад хуульд заасан нэмэх, хасах таван хувиас гарахгүй явж байгаад сүүлдээ түүнээсээ даваад гарчихсан. Нэгтгэсэн дүнгээрээ бизнес, иргэдэд их хохиролтой байгаа. Дамын шинж чанартай тоглолтууд дээр төв банкнаас хяналт тавих ёстой. Иймэрхүү байдлаар иж бүрэн арга хэмжээ авах ёстой.

**- Ам.долларын ханшийн үнийн зөрүүн дээрээс хохирчихоод байгаа ихээхэн хэмжээний зээл авсан компаниуд цаашид яах бол. Алдагдлуудыг цаашид яах ёстой вэ. Төр мөнгө өгөх ёстой юу?**

- Хадгаламж зээлийн хоршооныхны хохирол гэдэг шиг юм арай болохгүй байх. Бизнесийнхнээс өөрөөс нь, тэдний хүсэл зоригоос үл хамаарах шалтгаанаар зах зээл дээр бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн үйл явц нь төрийн буруугаас болж хийгдэж байна. Хөрөнгө оруулалт яагаад татарсан бэ. Монголын төр хөрөнгө оруулалтын буруу хууль гаргасныхаа дараа больсон. Экспорт нь багассан нь Оюу толгойтой ч юм уу хэлэлцээрээ хийж чадаагүй будилснаас болсон. 2013 оны сүүлээр

Монгол Улс анх удаа экспортынхоо хөтөлбөрийг батлаа биз дээ. Энэ мэтээр үйлдлүүд болон Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл хуулиар заасан үйл ажиллагаа биелүүлж чадахгүй байна. Тэгэхээр энэ бизнесийнхний буруу биш байгаа биз. Тиймээс төр сугарч үлдэж болохгүй. Валютын ханшаас үүдсэн хохирлыг зайлшгүй хуваалцах ёстой. Тэгж хуваалцдаг механизмаа бүрдүүлэх шаардлагатай. Эрсдлээс хамгаалах нь зөвхөн төв банкны ажил биш. Төв банкинд инфляци, валютын ханшийг даалгасан тул манайд хамаагүй гэж Засгийн газар, УИХ бодож болохгүй. Энэ үндэсний хэмжээний асуудал. Үүнийг ээлжит бус чуулганаар тусгайлан авч үзэх ёстой. УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны зүгээс анхаарал хандуулсан. Бизнес эрхлэгчид жагсахгүй л байгаа болохоос эдийн засгийн тайван жагсаал хийе гэж байгаагаа илэрхийлсэн. Бизнесийнхэн хүртэл жагсах тухай боддог болжээ. Таныг орж ирэхийн өмнө би Ерөнхий сайд руу "Монголынхоо компаниудыг хүлээж аваад ярилцаач" гээд мессэж бичээд сууж байлаа. Бизнесийнхэн Эдийн засгийн байнгын хорооныхонтой хуралдаж Төвбанк, Сангийн яамныхантай санал бодлоо солилцмоор байна гэсэн.

**- Таныг төрийн гурван өндөрлөгт албан бичиг хүргүүлж, дээд шүүхээр явах тухай яриа гарчээ. Ам.долларын ханшийн талаар уу?**

- Иргэний хуулийн 218-ын А гэдэг маш зөв заалт байна. Уг заалтыг тайлбарлах шүүгч нарын тайлбар нь янз бүр байгаа юм. Тендерийн хуулийн дээр валютын ханшийн өөрчлөлтийг яах вэ гэж ганц нэг удаа кейс болгоод Их хурал дээр оруулж ирснийг санаж байна. Замын компаниудад валютын ханшийн зөрүүнээс болж 30 гаруй тэрбум төгрөг өгч байсан. Хаа хаанаа хариуцлагатай байхын тулд эрсдлийг хуваалцах механизмаа хуулиараа тогтоож өгөх хэрэгтэй. Хуулийн дээр байгаа зөв заалтыг буруу гэж үздэг УИХ-ын гишүүн байна. Тэд эдийн засгийн бодит байдлыг мэддэггүй хүмүүс. Би төсвийн төлөө хамгийн их санаа зовдог хүн. Гэтэл татварын реформ хийж татварын хувь хэмжээг багасгая гэхээр "Төсвийн орлого яах юм" гэдэг.

**- Эдийн засаг, бизнесийн чиглэлийн гишүүдтэйгээ нийлээд эдийн засгийн лобби бүлэг байгуулж болохгүй юу. Хамтаараа гарцаа хайвал дээр биш үү?**

- Бизнес хийж байгаа хүмүүс Их хуралд орж ирсэн. Өмнө нь ч гэсэн байсан. Гэхдээ ямар ч лобби бүлэг байгаагүй. Тэдэнд өөрийнхөө компанийг ингэх гэж байна гэсэн олны амнаас халгасан сэтгэлзүйн садаа байдаг юм шиг байна лээ. Түүний оронд Монгол Улсын эдийн засгийн хөгжилд баялгийг бүтээгчид, өсөлтийг бий болгогчдын бодит байдлыг эдийн засгийн өсөлтийн цаана хэн байдаг гэдгийг ойлгодог хэн ч бай энэ асуудалд лоббидох буюу заавал нэг бүлэг бололгүйгээр ойлгох хэмжээний чадамжтай Их хурал бүрэлдсэн гэж үзэж байгаа.

**- Бизнесийн салбарт ам.долларын ханшаас гадна тулгамдаж буй ямар асуудлууд байна вэ?**

- Жижиг дунд бизнес эрхлэгчид гэхэд гаалийн татварын асуудал байна. Засгийн газрын тогтоолоор жижиг дунд бизнес эрхлэгчдийн тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлөх ёстой. Гэтэл тогтоол нь оны өмнө дуусчихсан. Дараагийн тогтоол нь хэзээ гарах нь мэдэгдэхгүй бизнес

эрхлэгчид яахаа мэдэхгүй байна. Мөн ноднин үнэ тогтворжуулах хөтөлбөр хэрэгжүүлээд үнэ тогтворжиж чадаагүй ч тодорхой хэмжээнд бензиний үнийг тогтвортой байлгасан. Үүнийх нь дүнд бензиний компаниуд алдагдалд орчихсон. Тэр алдагдлыг нь хэн, яаж, ямар аргаар нөхөх юм. Эсвэл ингээд яваад байх юм уу. Үнэ тогтворжуулах хөтөлбөрийг эхэндээ зөв гэж бодож байсан ч сүүлийн үед эргэлзэж эхэлсэн. Валютын ханшийнхаа хэлбэлзлийг тооцох эрсдлээс хамгаалах механизмаа хийж чадахгүй байна гэдэг ч юм уу. Огт энэ зээлд хамрагддаггүй банк, банк бус санхүүгийн байгууллага, ломбард эрхэлж буй бичил бизнес эрхлэгчид яах вэ. Зээлийн баталгааны сан гэж байсан. Жижиг дунд бизнесийн зээлийн санд 500 тэрбум төгрөг эргэлддэг гэдэг. Үнэндээ тэр тийм биш. Тэр мөнгийг үйлдвэр, үйлчилгээндээ хэрэглэчихсэн. Буцаж орж ирсэн мөнгөнөөс нь авах гэж бөөн юм болж байна. Энэ ажлаа засаг өөрөө хийж байгаа. Үүн дээр эрс өөрчлөлт хийх ёстой. Манай экспорт гэхэд уул уурхайн болон уул уурхайн бус гэж ангилагддаг. 90:10 гэсэн гажиг харьцаа байна. 10 хувиа цаашид яаж нэмэгдүүлэх юм. 10 хувьд багтсан ноос, ноолуур, махнаас гадна өөр юуг ямар аргаар гаргаж болох вэ. Манай зарим компанийнхан Орос руу очоод экспортлох боломж асар их байна гэсэн. Төр жаахан дэмжээд өгвөл болчих гээд байна гэдгээ хэлж байна лээ.

### **Эдийн засгаа улам сайн харж, зөв тооцоолох тусмаа бидэнд хэрэгтэй**

*УИХ-ын 2014 оны 5 сарын 30-ны Нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс: Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөлөлийн тухай хуулийн болон “Чиглэл өгөх тухай” УИХ-ын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг дээр:*

С.Дэмбэрэл: Сүүлийн үед Засгийн газрын эдийн засгаа үнэлж дүгнэдэг, урьдчилж хардаг, төсөөлдөг чадавхи нь нэмэгдээд байгаа гэж би бодож, их бахархаж байгаа. Яагаад гэвэл бид эдийн засгаа улам сайн харах тусам, зөв тооцоолох тусам бидэнд хэрэгтэй. Инфиляцийг ямар байхыг 6, 7, 8 гээд гурван оны байдлаар бодсон байгаа. Инфиляцийг тооцож байгаа хэрэглээний үнийн индекс чинь өнөөгийн, 2013 оны өрхийн зарлагын бүтцээр авч үзэх юм бол хүнсний зүйлийн хэрэглээ 24-40 орчим хувь байгаа. Өөрөөр хэлбэл инфляцийг тооцоходоо ард түмнийхээ амьдралын дундаж амьжиргааны хэрэглээний 24-40 хувьд нь тооцоод та бүхнийг 6, 7, 8 гэсэн тоогоо гаргасан байх аа гэж бодож байна. Миний асуух гэж байгаа гол асуулт бол ДНБ-ний дифлятор 2015, 16, 17 онд та бүхэн хэд байна гэж төсөөлж байгаа вэ? Яг тодорхой тоог надад хэлж өгнө үү. Яагаад гэвэл энэ хоёрыг харьцуулж харж байж цаашдын хандлагыг харахгүй бол одоо бидний CPI-р тооцсон тооцоо чинь өөрөө худлаа шүү гэдгийг хэлж байна.

**Ч.Улаан:** Инфляцийг бид бүхэн зах зээлд зөв сигнал өгөх эдийн засгийн бодлогын эерэг үр дагаварыг өөртөө шингээсэн тийм л үзүүлэлтийн түвшинд төсөөлдөг. Түүнээс биш инфляцийг яг онож зөв төлөвлөж чаддаггүй нь

ойлгомжтой. Тийм учраас байгаа түвшнээс их өндөр дохиоллыг зах зээл рүү өгөх юм бол бодлого үйл ажиллагаа маань мууднаа гэсэн дохиолол болж зах зээлийг таагүй байдалд оруулна. Ер нь хэрэгжүүлж байгаа бодлогынхоо чиг хандлагыг харгалзаад бид нар аль болохоор эерэг түвшинд зөв сигнал өгөх, инфляцыг бууруулахад бүх бодлого үйл ажиллагаа чиглэгдэж байх тэр бодлогыг харгалзан үзэж ингэж төсөөлдөг. Мэдээжийн хэрэг инфляцийн тооцоонд хэрэглээний бүтцийг харгалзан үзэж байгаа. Хэрэглээний бүтэц дотор хүн амын хүнсний хэрэглээ 24-40 хүртэл байгаа гэдэг үзүүлэлт нь өөрөө тийм ч муу үзүүлэлт биш гэдгийг та бүхэн сайн мэдэж байгаа гэдэгт би эргэлзэхгүй байна. Үүний цаана үлдэж байгаа нэлээд хэсэг нь өндөр үнэтэй, удаан хугацаанд хэрэглэгдэх эд зүйлд зарцуулагдаж байгаа нь тодорхой байгаа.

**Г.Батхүрэл /Эдийн засгийн хөгжлийн яамны Хөгжлийн бодлого, стратеги, төлөвлөлт, зохицуулалтын газрын орлогч дарга/:** Инфляцийн хувьд хэрэглээний үнийн индекс дахь жингээр нь аваад үзэхэд 30 хувийг хүнсний бүлгийн бараа эзэлж байгаа, 70 хувийг хүнсний бус бүлгийн бараа эзэлдэг. Үүн дээр ялангуяа хүнсний бус бүлгийн барааны хувьд импортын бараа бүтээгдэхүүн дээр ханшны нөлөө нилээд их байдаг. Бид нар сагсны 12 бүлгийг аль аль хэсэг нь импортын бараа бүтээгдэхүүнээс хамаарч байна вэ гээд 12 бүлэг тус бүрд нь авч үзсэн байгаа. Үүнээс авч үзэхэд 0.36 гэдэг жин нь ерөнхийдөө импортын бараа бүтээгдэхүүн байгаа учраас энэ нь ханшны нөлөөлөлд нилээд их өртөмтгий юм байна гэсэн байдал ажиглагдаж байгаа. Харин таны асуусан ДНБ-ний дифляторын хувьд бид нар хэрэглээний үнийн индекс дээр тооцсон үзүүлэлт инфляцийн түвшнээс арай доогуур авч үзсэн байгаа. *Тухайлбал, 2014 оны дифлятор 8.7, 2015 оных 4.7, 2016 оных 5.5, 2017 оных 3.6 хувь гэж тооцсон байгаа.*

### **Миний хэлснээр ажил үргэлжилбэл, Монголын эдийн засаг оны эцэс гэхэд сайжирна**

*Эх сурвалж: “NEWS WEEK” сонин 065. “Долоо хоногын тойм” сониноос сэтгүүлч Ш.Чимэг УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлтэй цаг үеийн асуудлаар ярилцсан ярилцлагыг та бүхэнд толилуулж байна. /2014 оны 6-р сарын 10./*

- Өнгөрсөн баасан гариг /VI.06/-ийн чуулганы хуралдаанаар Жижиг, дунд үйлдвэрийн тоног, төхөөрөмжийг гааль, НӨАТ-ын татвараас чөлөөлөх хуулийн төслийг баталлаа. Энэ хуулийн төслийг маш олон бизнес эрхлэгчид хүлээж байсан байх?

- Энэ төсөл эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоногт хамгийн их хүлээгдэж байсан, заавал батлагдах хуулийн нэг л дээ. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн 2012 оны арванхоёрдугаар сарын 31-нээс хойш жижиг, дунд үйлдвэрийн тоног төхөөрөмжийг гааль, НӨАТ-аас чөлөөлөх асуудал зогссон байсан. Татвараа төлж чадахгүйгээс ажил нь зогсонги байдалд орсон газрууд ч байлаа. Тэгэхээр эдийн засгийг эрчимжүүлэх УИХ-ын тогтоол болон эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоногийн ажилд тусгагдсан чухал хуулийг УИХ баталлаа гэж үзэж байгаа.



**- Энэ хуулийг хэзээнээс хэрэгжүүлэх вэ. Хугацааны хувьд маргаантай байсан?**

- Жижиг, дунд үйлдвэрлэлийн тоног, төхөөрөмжийг гааль, НӨАТ-аас чөлөөлөх хуулийн төслийг 2015 оноос хэрэгжүүлэхгүй бол Төсвийн тухай хууль зөрчих гэж байна гэсэн саналыг ажлын хэсгээс гаргасан. Гэтэл бизнесийг эрчимжүүлэх, идэвхжлийг нь хангахын тулд энэ хуулийн хэрэгжилтийг яаравчлахаас аргагүй юм. Хууль батлагдсан өдрөөсөө хэрэгжихэд хууль зөрчих асуудал байхгүй. Бизнес эрхлэгчид дахиад л хүлээлтийн байдалтай байна. Тиймээс хуулийг батлагдсан өдрөөс нь хэрэгжүүлэхийг УИХ-ын гишүүдийн олонхи дэмжсэн. Тэгэхээр баасан гаригаас буюу 2014 оны зургадугаар сарын 06-наас эхлэн Монголын жижиг, дунд бизнес эрхлэгчид гаднаас тоног, төхөөрөмж оруулж ирэхдээ гааль, НӨАТ-аас чөлөөлөгдөхөөр болж байна. Арваад хоногийн өмнө Засгийн газраас жижиг, дунд үйлдвэрлэгчдэд 100 тэрбум төгрөгийн төсвийг Чингис бондоос гаргаж өгөхөөр болсон байгаа. Удахгүй жижиг, дунд үйлдвэрийн хуульд өөрчлөлт оруулахаар төлөвлөж байна. Ингээд ирэхээр энэ салбар маань сэргэх, ажил нь урагш явах нөхцөл бий болно.

**- Тоног, төхөөрөмжийг татвараас чөлөөлөхөд хэчнээн аж ахуй нэгж хамрагдах тооцоо байна?**

- Тэр талаар тодорхой тоо хэлж мэдэхгүй байна. Ер нь бол үйлдвэрлэл явуулдаг бүх л аж ахуйн нэгжүүд гаднаас тоног, төхөөрөмжөө авдаг. Тэр бүгд хамрагдана.

**- Жижиг, дунд үйлдвэрлэгчдийг татварын бодлогоор дэмжчихлээ. Одоо төсвийн орлогын 90 хувийг бүрдүүлдэг томоохон аж ахуйн нэгжүүдээ яаж дэмжих вэ гэсэн хүлээлт байна?**

- Хөрөнгө оруулалт хийж байгаа томоохон аж ахуй нэгжүүдийн гаалиар оруулж ирж байгаа тоног, төхөөрөмжийг хоёр жилийн хугацаагаар татварыг нь хойш сунгах эсвэл хэсэгчлэн төлөх боломжийг олгохоор болсон. Эдийн засгийн хүдрэлтэй нөхцөлд томоохон аж ахуй нэгжүүд ажилчдаа яаж барих вэ гэсэн асуудалтай тулгардаг. Ийм үед нь гаалиар оруулж ирж байгаа тоног төхөөрөмжийн татвараа шууд төлөх бус хоёр жилийн дараа буюу өөрсдийнх нь санхүүгийн нөхцөл байдал сайжирсны дараа мөнгөө бага багаар төлөөд явах боломжийг нь олгож байгаа хууль юм. Эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоногийн хугацаанд манлай аж ахуйн нэгжүүдийг төрүүлэх, дэмжих хөтөлбөрийг өнгөрсөн долоо хоногт Ерөнхий сайдад гардуулсан. 1000 орчим томоохон аж ахуйн нэгжүүдэд зориулж дэмжлэг үзүүлэхээр бэлтгэж байна. Харин нийт бизнес эрхлэгчдэд зориулан тусгай зөвшөөрөл, лицензүүдийн тоог цэгцлэх ажлыг явуулж байгаа. Одоо энэ бүхэн дээр нэмээд татварын шинэчлэл хийх шаардлагатай байгаа юм. Засгийн газраас Татварын хуулинд өөрчлөлт хийхээр оруулж ирсэн боловч УИХ-ын зарим гишүүд татварын реформ хийе гэсэн санал гаргаж байгаа. Тэгээд татварын реформтойгоо зэрэгцүүлээд эдийн засгийн өршөөлийг үзүүлэх асуудал бий. Энэ мэтийг оруулсан эдийн засгийн реформ энэ 100 хоногийн хугацаанд хийгдэх юм. Он дуусахад бизнесийнхэн үр шимийг нь мэдэрч, ажлын байраа хадгалж, хөрөнгө оруулалт, төсвийн орлого нэмэгдэнэ гэсэн тооцоололтой байна. Бид бонд, нүүрс ярихгүйгээр дотоод нөөц боломжоо гаргаж, эдийн засгаа хоёр хуваахгүй байх нөхцөлийг бүрдүүлбэл Монголын эдийн засагт хангалттай их мөнгө орж ирэх боломжтой.



**- Гааль, НӨАТ-ын татвараас чөлөөлөх нь нөгөө талдаа улсын төсвийн бүрдүүлэлт буурах сөрөг нөхцөл үүсгэдэг гэдгийг шүүмжлэх хүмүүс олон бий?**

- Тэр үнэн л дээ. Бидний төлөвлөсөн татварын шинэчлэл хийх гол зорилго нь хэт их хөнгөлөлт, чөлөөлөлтийг багасгаж, татварын хувь хэмжээг бууруулж, татвар төлдөг хүмүүсийн тоог ихэсгэх юм. Татвар төлдөггүй хүмүүсийн татварын хувь хэмжээ багасаад, татварын байгууллагын татвар төлөх процесс нь хялбаршаад ирэхээр татвар төлөгчдийн тоо нэмэгдэх боломжтой болох юм. Энэ шинэчлэлийг удахгүй хийнэ.

**- Татварын хөнгөлөлтүүдийг өмнө нь яагаад хийж болоогүй юм бэ?**

- Өнгөрсөн жилийн долдугаар сараас валютын ханш огцом өсөх асуудал хөндөгдөж, хувийн хэвшлийнхэнд их хэмжээний хохирол үзүүлсэн. Өнгөрсөн оны сүүлчээс л 2014 он бүрхэг харагдаж байсан шүү дээ. Тэр үед УИХ-ын хэсэг гишүүд ойрын хугацаанд яаралтай хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалт гэж гаргасан. Сангийн сайд Ч.Улаан, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр нарыг ч оруулаад явсан. Тэгээд энэ асуудлыг Засгийн газар дээр ярилцаж, Засгийн газар оруулж ирэхээр болсон юм. 2014 онд эдийн засаг хүндэрнэ гэдгийг угтаж харсан уу гэвэл харсан. Яахав дээ, энгийнээр бол хүнд хэцүү үед ирж байж юу хийх ёстойгоо анхаарч эхэлж байгаагийн илрэл гэж цаг хугацааны хувьд тайлбарлаж болох юм. Уул уурхай дээр ч гэсэн Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлогыг УИХ-аар баталсан. Энэ бодлогод төр уул уурхайн бизнест хэт их оролцохыг хязгаарласан, төрийн өмчит компани олон нийтийн байх ёстой буюу төрийн бодлогыг хувийн хэвшлээр хийлгэдэг гэрээлэгч компани байх ёстой гэсэн үзэл санааг оруулсан, уул уурхайн бизнес эрхлэгч нь байгаль орчныг хайрлах буюу ногоон уул уурхайн бизнес хийнэ гэдгийг ч тусгасан. Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлогод та бизнес хий, ногоон байгалиа хамгаал гэдгийг хуульчилж өгсөн. Энэ тохиолдолд маргаан гарах боломжгүй болж байгаа. Ингээд ирэхээр уул уурхай сэргэж, уул уурхайг дагасан жижиг бизнесүүд хөгжих боломжтой. Бид гадныхны нүдэнд маш муухай ааштай гэрийн эзэгтэй шиг хандах нь бий. Хил дээрээсээ эхлээд л... Виз авах гэж есөн дамжлага давдгийг багасгах төслийг УИХ-д оруулж ирэхээр Ц.Оюунгэрэл сайд бэлтгэж байгаа. Энэ мэтээр энэ 100 хоногийн хүрээнд уул уурхайд түшиглэдэггүй бодлого руу чиглэсэн асуудалд анхаарч байна. Энэ бол хамгийн зөв зүйл.

**- Хөрөнгө оруулалтын хуулийг өнгөрсөн намар баталсан. Гэтэл одоо болтол хөрөнгө оруулагчдын хандлага нааштай биш байна. Эдийн засгийг эрчимжүүлэх хүрээнд хөрөнгө оруулагчдыг хэрхэн татах төлөвлөгөөтэй байгаа вэ?**

- Хөрөнгө оруулагчид одоо орж ирнэ. Бид Хөрөнгө оруулалтын хуулинд тогтвортой байдлыг хангах, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулах зэргийг онцгойлсон. Монголчууд гадны хөрөнгө оруулагчдыг дарамталж, биднийг мөлжиж байна гэж хардаг сэтгэхүйгээ өөрчлөх ёстой. Хөрөнгө оруулалтын эрхийг хамгаалах институци шаардлагатай байсныг анхаарч Хөрөнгө оруулалтын газар гэж байгуулсан. Одоо харин энэ хуулийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг идэвхижүүлэх шаардлагатай байна. Жишээлбэл, сая бид Эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулагчдын чуулганыг анх удаа зохион байгууллаа. Гадаадын 68, дотоодын 100

гаруй хөрөнгө оруулагч оролцсон. Эрүүл мэндийн салбарт зөвхөн төсвийн хөрөнгө оруулалтаар эмнэлэг барьдаг байсан бол хувийн хэвшлийнхнээр энэ ажлыг хэрэгжүүлэх боломж олгож байгаа юм. Энэ нь хуулийн үзэл санааг хэрэгжүүлж байгаа алхам.

- Гадныхан гол нь л Хөрөнгө оруулалтын хуулийн хэрэгжилтийг анхаарч, ажиглаж байх шиг байна?

- Гол зүйл нь тэр. Жишээлбэл, хөрөнгө оруулалт хариуцдаг байсан дарга нь шоронд хоригдлоо. Бас нэг маш том хөрөнгө оруулалт хариуцдаг байсан дарга нь хорих газарт нас барлаа. Нэлээн олон хөрөнгө оруулагчийг Монгол Улсын нутаг дэвсгэрээс гарч болохгүй гэгчсэн, олон компанийг татвараа төлөөгүй гэсэн шалтгаанаар шалгаж байна. Хөрөнгө оруулагчид хуулийн засаглалыг л хардаг. Энэ улсад хуулийн засаглал байна уу, хуулиар гул барьсан засаг байна уу гэдгийг эхлээд хардаг. Хууль эрх зүйн орчин нь хэр шинэчлэгдэж байна, хүний эрхийг дээдэлдэг эсэх гэх мэт том дүр зургийг хардаг. Өөрөөр хэлбэл, энэ улсад хөрөнгө оруулахад надад итгэл төрүүлэхүйц зүйл юу байна вэ гэдгийг тэд эхлээд харна.

- Одоо хүмүүсийн дунд эдийн засаг хэзээ сайжрах вэ гэсэн хүлээлт байсаар байна. Та эдийн засагч хүний хувь юу гэж дүгнэж байгаа вэ?

- Би зөн билэгч биш л дээ. Гэхдээ миний саяны хэлснээр ажил үргэлжилбэл Монголын эдийн засаг оны эцэс гэхэд сайжирна гэж харж байгаа. Дотоод нөөц бололцоогоо ашиглаж хөдөлбөл бидэнд эдийн засгаа сэргээх бүрэн боломж байна гэдгийг олж харах хэрэгтэй.

## **Бичиг хэргийн өндөр соёлтой, арвин туршлагатай ахмад үеэрээ зөвлөгөө өгүүлэх үйлчилгээ нэвтрүүлмээр байна**

*2014 оны 06 сарын 19-нд болсон УИХ-ын Төрийн байгуулалтын болон Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хамтарсан хуралдааны тэмдэглэлээс: “М” хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг, Н.Батцэрэг, А.Бакей, Г.Батхүц, Л.Гантөмөр, Н.Энхболд нар 2014.5.16-ны өдөр өргөн мэдүүлсэн/ хэлэлцэх үеэр.*

С.Дэмбэрэл: - Ажлын хэсгээс асуух хэд хэдэн зүйлс байна.

1. Монгол Улсын Үндсэн хуулинд үндэсний цөөнхөд, өөрсдийн хэл, бичгээр бичих, суралцах эрх хадгалагдсан байгаа. Хэлний тухай хуулийн төсөлд энэ асуудал хэрхэн тусгагдсан бэ?

2. Одоо бичгийн соёл их муудсан байдал ажиглагдаж байна. Аж ахуйн нэгжүүд, албан байгууллагууд хоорондоо харилцаж байгаа албан бичгүүдийг ажиглаж байхад, маш олон алдаа харагдах юм. Албан захиа бичиж сураагүй байна. Ийм үе гарч ирээд байна. Гэтэл бичиг хэргийн өндөр соёлтой, арвин туршлагатай ахмад үе маань байсаар байна. Энэ ахмад үеийнхэнээр заавар зөвлөгөө өгүүлэх нэг төрлийн үйлчилгээг нэвтрүүлмээр санагддаг. Энэ бол нэг талаар бичгийн соёл бий болгох ажил үйлчилгээний нэг хэлбэр юм. Үүнийг энэ хуулинд тусгаж болох уу?

3. Энэ асуудалд шууд хамаагүй боловч 2 том байнгын хорооны хамтарсан хуралдаан учраас асуумаар нэг зүйл байна. Эдийн засаг нийгмийн хүндрэлтэй үед Засгийн газар нь 100 хоногын хугацаатай нэг хөтөлбөр гаргаад, УИХ нь яаралтай авах арга хэмжээний тухай хууль эрх зүйн баримт бичгүүдийн төсөл дээр ажиллаж байна. Энэ 100 хоногт энэ 2 байнгын хороон дээр яаралтай хэлэлцэх асуудал байна уу, үгүй юу? Энэ улс орны нийгмийн байдал ямархуу байгаа билээ? Эдийн засаг нь ямар байна, төрийн байгууллагуудын ажил ямар байна? Энэ бүхнийг сайжруулах талаар энэ 2 байнгын хороон дээр яагаад юу ч хэлэлцэхгүй байна вэ гэсэн гайхашрал надад төрөөд байх юм. Үүнд 2 байнгын хорооны дарга нар хариулж өгвөл баярлахсан.

**Д.Батцогт:** - С.Дэмбэрэл гишүүний асуултанд эхлээд, М.Батчимэг гишүүн, дараа нь А.Бакей гишүүн хариулна.

**М.Батчимэг:** - Та чухал асуудал хөндөж асуулаа. Баярлалаа. Үнэхээр, Монгол Улсын Үндсэн хуулиар өөр хэл бүхий үндэсний цөөнхийн хэл соёлыг хамгаалах талаар хуульчлагдсан. Ялангуяа манай казак иргэдийн хэл соёлтой холбоотойгоор нэлээд яригддаг. Үндэсний цөөнхийн хэл соёлыг хамгаалах асуудал бол төрийн үүрэг мөн. Энэ хууль ч бас Үндсэн хуулийн энэ зарчимд тулгуурлан боловсруулагдсан. Бид энэ хэсгийг бараг тэр чигээр нь төсөлдөө оруулсан бөгөөд, хуульчид үүнийг заавал давхардуулан заах хэрэггүй гэж бас зөвлөж байгаа. Мөн хэлний сургалттай холбоотой зарим асуудлуудыг, хууль өргөн барьсны дараа тодотгох шаардлага байна гэдгийг зарим иргэдээс ирүүлсэн. А.Бакей гишүүд бид нар ч бас энэ асуудлаар санал солилцсон. Хуулийн хэлэлцүүлгийн явцад энэ санаа тусаад явах боломжтой гэж үзэж байгаа.

Бичгийн соёлтой холбоотой хоёр дахь асуудлаар, бичгийн эрдэмтэн, мэргэжилтэн, ахмад туршлагатай хүмүүсийг олноор нь татан оролцуулж байх талаар чухал асуудлыг та хөндлөө. Хууль өргөн барих болсон үндсэн шалтгаануудын нэг нь яг үүнтэй холбоотой. Монгол Улс хилээ манадаг мөртлөө, хэлээ манаж, хамгаалах манаачгүй явж ирсэн байна. Манай улс хэл бичгийн олон сайхан эрдэмтэн мэргэдтэй мөртлөө, эдгээр хүмүүсийнхээ эрдэм чадлыг зөв сайнаар нэгтгэж ашиглах, хэл соёлоо хамгаалах үйлсэд гар нийлж ажиллаж чадалгүй өдий хүрчээ. Үүнийг зохицуулсан эрх зүйн баримт бичиг ч хомс байсан байна. Манай улсад бусад орнуудын адил Хэл Зохиолын Хүрээлэн /ХЗХ/ бий. Энэ хуулиар энэхүү ШУА-ын ХЗХ-д монгол хэлний дүрмийг өөрчлөх, засан сайжруулах, нэмэлт оруулах асуудлуудыг хариуцуулахаар зааж байгаа. Мөн Төрийн албан ёсны хэлний төрийн хэлний зөвлөлийн чиг үүргийг өргөтгөөд, эрдэмтэн мэргэд оролцсон “Хэлний бодлогын үндэсний зөвлөл” гэсэн бүтэцтэй болох юм. ингэснээр таны хэлсэн ахмадуудаа оролцуулах албан ёсны бүтэц, тогтолцоо энэ хуулиар бий болох юм. Мөн энэ хуулинд “Төрийн байгууллагууд бичиг үсгийн түшмэлтэй байна” гэж заасан. Төр захиргааны бүх байгууллагууд бичиг хэргийн албатай байгаа. Гэхдээ хуулиар, чиг үүргийг нь нарийвчлан зааж өгөөгүйн улмаас бичиг хэргийн албаныхан нь ерөнхийдөө, механик ажил хийдэг болчихсон. Цаашдаа албан байгууллагын бичиг хэргийн хүмүүс нь хэлний чадвар сайтай, бичгийн соёл өндөртэй бичиг хэргийн түшмэлүүд болох учиртай юм. Тиймээс, энэ хууль батлагдсанаас бичиг

хэргийн хэл найрлага, албан хэргийн хөтлөлт, соёл дээшилнэ гэсэн бодолтой байгаа.

Нэмж хэлэхэд, энэхүү хууль Хаврын чуулганаар хэлэлцэгдэж батлагдах нь маш чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Учир нь, энэ хуулийг дагаж улсын төсөвт аливаа ачаалал дарамт гарахгүй. Гэхдээ орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт орох нь гарцаагүй. Улсын төсөв хэлэлцэхээс өмнө энэ асуудал хэлэлцэгдээд явах нь хуулийг хэрэгжүүлэхэд тус дөхөм болно гэж үзэж байна. Хэлний асуудал нь өнөөдөр нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудал биш юм шиг харагдаж байгаа боловч, үнэн чанартаа бол улс үндэсний аюулгүй байдалтай холбоотой, өдрөөс өдөрт гээгдэж байгаа амин чухал хэл соёлтой холбоотой асуудал юм.

**С.Дэмбэрэл:** - Та миний бодлыг тааж хариулаад байна. Би танд тийм асуудал тавиагүй. Байнгын хорооны дарга нарт тавьсан асуулт бол таны хэлэлцүүлж байгаа хуультай холбоогүй, тусдаа асуулт юм шүү.

**А.Бакей:** - Эдийн засгийг идэвхжилийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоол гарсан. Энэ талаар Засгийн газар 100 хоногын дотор багтааж хийж гүйцэтгэх зүйлсээ төлөвлөөд, ажил нь явагдаж байгаа. Энэ хүрээнд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох бусад томоохон асуудлууд тусгагдсан. Тухайлбал, холбогдох чиг үүргийн байнгын хороодод хуулиуд хэлэлцэгдээд явж байгаа. Манай Төрийн байгуулалтын байнгын хорооны хувьд бас ойрд хэлэлцүүлэхээр төлөвлөж байгаа чухал асуудлууд бий. Жишээлбэл, Хяналтын тухай хууль бол бизнес эрхлэгчдэд учир байгаа дарамтыг бууруулахад чиглэгдсэн багц хуулийн төсөл боловсруулагдаж, өргөн баригдаад байгаа. Мөн төсвийн тодотголоор төрийн байгууллагуудын төсвийг 20% танах шийдвэр гарсан. Энэ дагуу ЗГХЭГ-ын даргаар ахлуулсан ажлын хсэг байгуулагдаж, төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгохтой холбоотой асуудлаар саналаа боловсруулж байна. Ирэх долоо хоногт ТББХ-ны хурлаар төрийн байгууллагууд өөрсдийн хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хоорондын ажлын уялдаа холбоогоо хэрхэн хангаж ажиллаж байгаа талаар тогтоол гаргахаар бэлтгэж байна. 100 хоногын дотор бүх зүйл өргөс авчихсан юм шиг өөрчлөгдөнө гэж бодож болохгүй. Суурь асуудлууд шийдэгдэх байхаа. Тэгэхээр үүний хажуугаар бид өнөөдрийн хэлэлцэж байгаа хуулиуд шиг шаардлагатай бусад хуулиудыг ч бас хэлэлцээд явах нь зөв гэж үзэж байна.

**С.Дэмбэрэл:** - Хуулийн 6.1.12 дахь “6.1.12.Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулж байгаа бараа бүтээгдэхүүний цйлдвэрлэгч, хүчинтэй хугацаа, орц найрлагын талаарх мэдээлэл, хэрэглэх заавар, холбогдох анхааруулга, санамж.” гэдэг зүйл дээр нэлээд маргалаа. М.Батчимэг ч өөрөө их хамгааллаа. Энэ байж болохгүй ээ. Ийм зүйл байвал энэ хууль эсэргүүцэлтэй тулгарна. Сайхан хууль боловсруулж оруулж ирчихээд, хүнсний болон бусад хуулиудад байдаг, угаасаа Монгол Улсад байдаг төрийн хүнд суртлыг үүгээр дамжуулан асар ихээр нэмэгдүүлэх зүйлийг энэ хуулиар оруулж ирэх хэрэггүй. Үүнийг хууль санаачлагч цаашдаа анхаараарай. Эс тэгвэл яг энэ заалтан дээр чинь би болон бусад гишүүд нэлээд их маргах болно шүү. *Нэгдүгээрт*, үүнийг хэлэх байна.

*Хоёрдугаарт*, бид монгол хэлээр дамжуулан монгол соёлыг хадгалж хамгаалах, авч үлдэх, монгол соёлыг гадаадад түгээх энэ асуудал нь эцсийн дүндээ монгол хүнийг монгол хүнээр нь өсгөн хүмүүжүүлэх, хадгалж, хамгаалах явдал юмаа гэж би ойлгож байгаа. “Монгол судлал”-ын талаар бид УИХ-ын тогтоол батлаад, түүн дээрээ төсөв мөнгө ч тавьж өгөлгүй, гаргалгүй орхичихсон. Хэрэгждэггүй “нэг худлаа юм” гарчихаад Монгол судлал нь ч хөгждөггүй, гацчихсан. Түүн шиг, монгол хэлээр дамжин монгол ахуй соёл, зан заншилыг түгээн дэлгэрүүлж, сурталчилдаг ийм ажил хийгддэггүй УИХ-ын тогтоол шиг нэг хууль гарчих вий. Тиймээс “Монгол Судлалын хөгжүүлэх” тэр үзэл санааг энэ хуулийнхаа нэгтгээ, тохиромжтой газар нь суулгаж өгвөл, бидний баталсан тогтоолын үзэл санаа маань хуулийн үг үсэг, заалт болоод орчихвол илүү үр дүнтэй, дараа дараагийн жилүүдэд хуулийг хэрэгжүүлэх мөнгө санхүү нь батлагдан гарч байх болно гэж бодож байна.

## **Үнэндээ, төрийн үрэлгэн зардал их байна**

*“Өглөөний Сонин”-ы сурвалжлагч Б.Төрбат Монгол Улсад үцсээд буй эдийн засгийн хямрал, түүнээс хэрхэн гарах талаар УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлтэй уулзаж ярилцсан ярилцлагыг эрхэм уншигч та бүхэндээ хүргэж байна.*

- Засгийн газар “Эдийн засгаа эрчимжүүлэх 100 хоног”-ийн хүрээнд эдийн засгаа аварч, хямралаас гарч чадах болов уу. УИХ-ын гишүүн бус эдийн засагч хүний хувьд үүнд ямар тайлбар өгөх вэ?

- Өнөөдөр Монгол Улсад эдийн засгийн хүндрэл бодитойгоор тохиолдож байгаа нь хамгийн эхэнд иргэдийн худалдан авах чадвар, амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлж эхэллээ. Ямар ч байсан УИХ-аас эдийн засгаа аврах, идэвхжлийг сэргээх тогтоол гаргаж баталсан. Ард иргэд 100 хоногийн дараа эдийн засаг сайжирна ч гэдэг юм уу их зүйл хүлээгээд байх шиг байгаа юм. Үүнд би маш тодорхой хариулт өгье. Тэгэхээр 100 хоногийн дараа бүх зүйл хүссэнээр болж үр дүн гарахгүй. Харин энэ оны эцэс гэхэд гарч болох юм.

- Яаж тэр вэ?

- Бид эдийн засгийнхаа дотоодод байгаа бүхий л нөөц, бололцоог ашиглаж шавхах хэрэгтэй. Өнөөдөр Монгол Улсын эдийн засаг хоёр хуваагдчихсан байна. Албан, албан бус эдийн засаг гэж. Тиймээс албан бус эдийн засгийг албажуулах, түүний дотор далд эдийн засгийг ил болгох, нөгөөтэйгүүр Монгол Улсад үйлчилж байгаа татварын орчинг сайжруулах нэн шаардлагатай. Ингэхийн тулд хамгийн эхэнд иргэд татвараа үнэнч шударгаар төлөх нь чухал юм. Засгийн газраас ч гэсэн ямар нэгэн хүндрэлгүйгээр хялбаршуулсан татварын тогтолцоонд шилжих буюу түүнийгээ шинэчлэх шаардлагатай. Дээр нь жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж, нийт секторыг идэвхжүүлэх санхүүгийн арга хэрэгсэл, түүний дотор зээлийн хүүг бууруулах зэрэг арга хэмжээг аваад явчих юм бол бондтой бондгүй оны эцэст Монголын эдийн засаг хувийн хэвшлийнхээ хүчээр сэргэх болно.

Харамсалтай нь өнөөдөр Засгийн газраас орж ирж байгаа нэмэгдсэн өртгийн албан татварын босго хэмжээг тогтоох, аж ахуйн нэгжүүдийн орлогын татварын тодорхой хэмжээнээс доогуурх буюу татварын 90 хувийг нь буцааж олгох нь реформ биш юм. Реформ гэдэг нь Татварын ерөнхий хуулиас эхлээд бүх хуулийг, түүний дотор Нэмэгдсэн өртгийн албан татвар, Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, Хүн амын орлогын албан татвар, Нийгмийн даатгалын шимтгэлийн албан татвар гэх мэтийн нийт хувь хэмжээг нь доошлуулж, багасгах зүйл хийх хэрэгтэй. Түүнчлэн Татварын ерөнхий хуулиараа татвар төлөгч болон төр хоёрын хоорондох харилцааг нэг нь үйлчилдэг, нөгөөх нь үйлчлүүлдэг харилцан эрх үүргийг нь тэнцвэржүүлсэн зүйлүүдийг оруулж ирэх хэрэгтэй байна. Одоогоор энэ чиглэлээр УИХ-д намын бүлгүүд болон гишүүдийн дунд нэгдсэн ойлголт алга байна.

**- Таныхаар гишүүд болон намын бүлгүүдийн дунд нэгдсэн ойлголт бий болгохын тулд яах ёстой гэж?**

- Уг нь УИХ-ын даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан боловч хоёрхон удаа л хуралдсан. Өнөөг хүртэл тодорхой асуудлаа ярилцаагүй л байна. Гэтэл Засгийн газраас оруулж ирсэн татварын нэмэгдсэн өртгийн босгын арга хэмжээ, дээр нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 90 хувийг буцаан олгох асуудал хэлэлцэгдээд эхэлчихлээ. Үүнийг би хувьдаа буруу гэж харж байгаа.

**- Яагаад?**

- Дээрх ажлын хэсэг УИХ-ын даргын захирамжаар байгуулагдахдаа улстөрийн намын бүх төлөөллийг оролцуулсан байдаг. Эдийн засгийн татварын орчин, тогтолцоонд нь шинэчлэл хийе гэсэн энэхүү ажлын хэсэг эцсийн үгээ хэлж байж цаашид Монгол Улсад татварын шинэчлэл хийгдэх үү, эсвэл косметик маягийн өөрчлөлт хийх үү гэдгээ шийдэх ёстой. Харамсалтай нь одоогийн байдлаар косметик маягийн өөрчлөлт л яригдаж байна. Ийм тохиолдолд, тэр тусмаа 100 хоногт эдийн засгаа аврах, өөрчлөлт хийнэ гэдэг маш хэцүү юм.

**- Үнэхээр хувийн хэвшлээ дэмжих аваас бид оны эцэс гэхэд эдийн засгийн хямралаас гарч чадна гэж үү?**

- Тийм ээ. УИХ-аар Эдийн засгийн өршөөлийн хууль, Ил тодын хууль ороод ирлээ. Энэ хоёр хуулиа татварынхаа шинэчлэлтэй хослуулж хийх ёстой. Үүгээрээ гол зарчмын асуудал болох далд буюу албан бус эдийн засгийг ил болгох, ингэснээр бүгдээрээ бага хэмжээгээр татвар төлдөг болох юм. Улмаар татварынхаа суурийг өргөжүүлэх энэхүү асуудал шийдэгдэнэ. Далд байгаа тэрхүү хөрөнгө ил болж, эдийн засагт шаардлагатай мөнгөний хэрэгцээг хангах, хөрөнгө оруулалт явагдах, идэвхжих нөхцөл бүрдэх ёстой юм.

Дээр нь бизнесийн орчинг цэвэрлэх асуудал байна. Өөрөөр хэлбэл бизнест садаа болж байгаа бүх төрлийн тусгай зөвшөөрөл, лицензийн асуудал УИХ-аар хэлэлцэгдэж байна. Цаашид ийм асуудал гаргахгүйн тулд Хяналтын тухай хууль, Стандартын тухай хууль зэргээс эхлээд жижиг, дунд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аль нэгнээс нь чөлөөлөх, томоохон хэмжээний хөрөнгө оруулалтын асуудлыг хоёр жилийн хугацаатайгаар татварын амралт өгөх, эсвэл хэсэгчлэн төлүүлэх гэх мэт хуулиуд батлагдсан.



Гэхдээ УИХ-д ороод ирчихсэн олон хуулийг ач холбогдлоор нь ангилаад үзэх аваас 100 хоногт эдийн засгийн хүндрэлтэй байдлаас гарахад шууд хамааралтай эдийн засгийн хуулиуд бага байна. Нийгэм, соёлын ч гэдэг юм уу бусад асуудлаа хойш тавих хэрэгтэй. Нэг үгээр хамгийн чухал хуулиудаа хамгийн эхэнд нь батлах л шаардлагатай. Харамсалтай ингэж чадахгүй байна. Иймэрхүү үйлчлэлийн зарчим явагдахгүй байгаа учраас магадгүй УИХ өөрөө 100 хоногт эдийн засгийг эрчимжүүлэх, идэвхжлийг сэргээх үйл ажиллагаандаа садаа тушаа болохыг үгүйсгэхгүй. Тиймээс л би, УИХ-ын даргын зөвлөлийн хуралд “Хамгийн гол гэсэн 15-16 хуулиа л яаралтай хэлэлцье, бусдыг нь ирэх намрын чуулганд шилжүүлье” гэдэг санал тавиад байгаа юм. Энэх асуудал шийдэгдчивэл Засгийн газар ч, УИХ нь ч нэн яаралтай дэглэмээр ажиллах хэрэгтэй. Ингэж чадах юм бол оны эцэс гэхэд Монголын эдийн засаг сэргэх бүрэн боломжтой юм.

**- Саяхан наадмын төсвийг 2.2 тэрбум төгрөгөөр баталлаа. Иргэд ч нэлээд шүүмжлэлтэй хандаж байх шиг байна. Үүнийг та хэрхэн харж байна вэ?**

- Наадмын төсөв, Иргэдийн төлөөлөгчид Бразил улс руу хөл бөмбөг үзэхээр явсан зэрэг нь эдийн засгийн хүндрэлийн гол асуудлыг сайн тусгаж авахгүй байна л гэсэн үг. Өнөөдөр Улаанбаатар хотын эдийн засагт ямар хэмнэлт хийж байгаа юм бэ? Тэд энэ 100 хоногт юу хийх нь ямар ч тодорхойгүй байна. Үнэндээ иймэрхүү асуудлууд байж болохгүй. Хэрэв эдийн засгийн хүндрэлээс гарцгаая л гэж байгаа юм бол нийгэм даяараа хөдлөх ёстой.

Өөрөөр хэлбэл, засаглалын бүх түвшинд хөдлөх ёстой юм. Төв болон орон нутгийнхан бүгд эдийн засгийг эрчимжүүлэх өөрсдийнхөө тодорхой төлөвлөгөөг гаргаж ирэх ёстой. Ингэж байж, эдийн засаг идэвхжинэ. Гэхдээ эцсийн гол зүйл нь хувийн хэвшилдээ л найдах хэрэгтэй. Тэднийгээ л сайн дэмжиж, бизнес хийх таатай орчинг нь яаралтай сайжруулж, татварын шинэчлэл, эдийн засгийн өршөөлөө хийх шаардлагатай байна. Дээр нь хяналтаа хялбаршуулж, татварын янз бүрийн шалгалтаа аль болох хөнгөвчлөх ёстой.

**- Нөгөөтэйгүүр эдийн засгийн эрэлтийн тал дээр ард иргэдийн худалдан авах чадвар маш муу болчихлоо. Инфляци хоёр оронтой тоонд хэвээрээ л байна шүү дээ?**

- Үнэн. Эцсийн эцэст хэн ингэж инфляцийг хоёр оронтой тоонд бариад байгаа юм бэ. Төр засаг л биз дээ? Үнэндээ төрийн үрэлгэн зардал их байна. Мөн инфляцийг нэмэгдүүлж байгаа төрийн янз бүрийн бодлого байна л даа. Энэ бүхэн ганц Монголбанк биш нийт Засгийн газрын, УИХ-ын хамтын үйл ажиллагааны үр дүн байх ёстой. Ард иргэдийн цалин, тэтгэвэр тэтгэмжийн асуудлыг ярих хэрэгтэй байна. Тодорхой хугацаагаар ард иргэдийн төлж байгаа нийгмийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татварыг хойшлуулж өгөх хэрэгтэй. Нэг үгээр татварын амралт өгч болно шүү дээ. Иймэрхүү байдлаар эдийн засагтаа нэмэлт бэлэн мөнгөний оролт бий болгох, зах зээлд эрэлт болон нийлүүлэлтийн талаас идэвхжүүлэх зүйлүүдийг хийх ёстой. Түүнээс биш нүүрс болон зэсийн зах зээлийг хүлээх маягаар хандана гэвэл эдийн засаг явахгүй. Улстөрийн маргаан байсаар байгаад л дуусна.

- Эдийн засгийн хямралтай холбогдуулан сөрөг хүчний зүгээс Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярыг суудлаас нь огцруулах шаардлага хүргүүлээд байгаа. УИХ-ын гишүүний хувьд үүнд ямар байр суурьтай байна вэ?

- Эдийн засгийн сайдаа огцруулчихаар эдийн засаг сайжирчихдаг бол сайхан л байна. Эдийн засгийн хямрал хүндээ байгаа юм биш л дээ. Гэхдээ Эдийн засгийн яаманд бодлогын алдаа байгааг үгүйсгэхгүй. Эдийн засгийн хөгжлийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яамны хоорондын ажлын уялдаа сул гэвэл сул. Гэхдээ сөрөг хүчний зүгээс эдийн засгаас яаж гарах, иргэдийн амьжиргаа, худалдан авах чадварыг хэрхэн сайжруулах зэргийг бодох ёстой байтал, ганцхан сайдыг огцруулна гэх зэргээр улстөр хийж байгаа нь явцгүй юм.

## **Татварын шинэчлэл хийх итгэл үнэмшил, хүсэл эрмэлзэл байна уу?**

*2014 оны 06 дугаар сарын 17-ны Мягмар гарагт болсон УИХ-ын Нэгдсэн чуулганы хурлын тэмдэглэлээс: А /Засгийн газар 2014.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, татварын 90 хувийг буцаан олгох тухай/ хуулийн анхны хэлэлцүүлэг дээр*

С.Дэмбэрэл: -Засгийн газрын мөрийн хөтөлбөрт “Татварын шинэчлэлийн 2 дахь үе шатыг эхлүүлнэ.” гээд биччихсэн байгаа. Мөн УИХ-ын даргын захирамжаар Татварын хуулиудад өөрчлөлт оруулах зорилгоор, УИХ дахь улс төрийн бүх намуудаас төлөөлөл оролцсон Ажлын хэсэг байгуулагдаад С.Баярцогтоор ахлуулан ажиллаж байна. Энэ ажлын хэсэг болон ердийн журмаар орж ирж байгаа татварын хуулийн өөрчлөлтүүд хоорондоо ямар ч уялдаа холбоогүй, огтхон ч авцалдахгүй байна. Тиймээс надад асуух зүйл байна.

Миний дуулсанаар бол, Ардчилсан Нам “Дөрвөн 10-ын бодлогоо цргэлжлүүлнэ. Аливаа юмыг доошоо болгохгүй. Тиймээс реформ хийгдэхгүй.” гэсэн яриа гараад байх юм. Хувь хэмжээг багасгах эсэх талаар танай байнгын хороон дээр ер нь яригдсан уу? Энэ бол зөвхөн нэг л хууль. Үүнээс гадна өөрчлөх ёстой олон хууль, тэр дундаа Татварын ерөнхий хууль, бизнесийнхэний хувь хэмжээг нь багасгуулах гэж хүсээд байгаа саналууд буюу араасаа нэлээд маргаан дагуулж байгаа Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль, мөн Хүн амын орлогын албан татвар төдийгүй Нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой олон асуудал шийдээ хүлээж байна. Энэ бүхнийг нэгтгээд шинэчлэл ярихын оронд, Засгийн газраас цуварч орж ирж байгаа ганц нэг жижиг хуулиудыг “өнгө засал” байдлаар явуулаад байх юм. Төсвийн байнгын хороон дээр реформ хийх итгэл үнэмшил, хүсэл эрмэлзэл байна уу? Үүнтэй холбоотойгоор намын бүлгүүдийн үзэл баримтлал, байр суурь орж ирсэн үү? Хувь хэмжээний талаар ямар хандлагатай байна вэ? Хөндөхгүй, багасгахгүй гэсэн байр суурь байна уу? үгүй юу? Үүнийг тодорхой мэдмээр байна.

Нөгөө талаар, хариуцлагатайгаар мэдэгдэхэд, хэрэв бид ийм байдлаар ар араасаа цуварсан, хоорондоо ямар ч холбоогүй зүйлсээр татварын тогтолцоог өөрчлөх өнгөц засвар хийх гэж байгаа бол энэ нь “ШИНЭЧЛЭЛ” огтхон ч биш юм. Ингэвэл 2012-2016 онд хэрэгжүүлдэхээр төлөвлөсөн Ардчилсан намын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт байгаа “ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛ” гэж бичигдсэн тэр өөрчлөлт буюу *“Татварын шинэчлэлийн 2 дахь үе шатыг эхлүүлнэ.”* гээд бичсэн энэ заалтын үзэл санаа, үг үсэгт таарахгүй зүйл болно. Тийм учраас АН, МАХН, МАН-ын гишүүд та бүхэнд энэ өөрчлөлтийг санаа нэгдэн хийхийг уриалж байна. Энэ байдлаараа бол Татварын реформ болохгүй, далд эдийн засаг ил болохгүй, эдийн засгийн шинэчлэл, өршөөлийн хуулиуд чинь хүсэн хүлээсэн үр дүнгээ өгөхгүй болно. Энэ талаас нь та бүхэн бодож, УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийг ажиллуулж өгөөч, эдгээр өөрчлөлтийн төслүүдээ тэр ажлын хэсэгтэй холбож өгч, хамтран ажиллаач ээ гэж хүсэх байна. Тэгэхгүй бол, Ажлын хэсэг байгуулагдаад 2-хон л удаа хуралдсан, баахан хүн баахан хүлээлттэй хэвээрээ байна. Нийгэм даяар биднийг хараад *“жинхэнэ реформ энд л хийгдэх нь, бүгдийг нь доошоо болгох нь, татварын элдэв процедурууд маш ихээр хялбарчлагдах нь, хоёр биш, нэг л эдийн засагтай болох нь, бид 2 биш, ганц л баланстай болох нь”* гэсэн хүлээлт үүсчихээд байна. Энэ байдлаараа бол нийгмийн энэ хүлээлтийг биелүүлж чадахгүй болох гээд байна. Тийм учраас үүнийг анхаарч ажиллах талаар юу бодож байна вэ?

**Ц.Даваасүрэн /Төсвийн байнгын хорооны дарга/:** - С.Дэмбэрэл гишүүний асуултанд хариулъя. Намын бүлгүүдээс Татварын шинэчлэлтэй холбоотой ямар нэг санал дүгнэлт Байнгын хороон дээр ирээгүй. Ер нь намын бүлгүүд Татварын шинэчлэлийн асуудал дээр ямар байр суурьтай байна вэ гэвэл, *“Энэ өөрчлөлт, шинэчлэлт хийгдэх ёстой, цогцоор нь авч үзэх ёстой...”* гэсэн хандлагатай байгаа учраас, УИХ-ын гишүүдийн санаачилсан, Засгийн газраас оруулж ирсэн энэ хуулиудыг нэгтгээд, нэг санал дүгнэлт боловсруулж оруулах Ажлын хэсгийг С.Баярцогт гишүүнээр ахлуулан байгуулсан билээ. Энэ ажлын хэсэг 2 удаа хуралдсан байхаа. Миний хувьд С.Баярцогт гишүүнд: *“Хэрвээ Татварын шинэчлэл хийх гэж байгаа бол энэ Хаврын чуулганы хугацаанд үүнийгээ багтаан хийж дуусга.”* гэсэн тодорхой санал хэлсэн. Яагаад гэвэл, 2015 оны төсвийн төлөвлөлт энэ 07 дугаар сараас эхлэн хийгдэж эхэлнэ. Үүнээс өмнө Татварын хуулиуд гарсан байх ёстой. Асуудлууд нь тодорхой болсон байх ёстой. Тэр утгаараа эдгээр хуулийн өөрчлөлтүүдийг хэлэлцэхгүй байж бас болохгүй болчихоод байгаа юм. Ажлын хэсэг дээр энэ талаар тодорхой яриагүй юм байна. Гэхдээ ажлын хэсэг яриагүй, хуралдаагүй гээд үүнийг бид хэлэлцэлгүйгээр хойшлуулж, орхиж бас болохгүй. Яагаад гэвэл бид энэ тооцоог төсөвт тусгах ёстой. Хаврын чуулган завсарлахаас өмнө, ялангуяа энэ 30-аад тэрбум төгрөгийн хөрөнгийн асуудал яригдаж байгаа шиг асуудлууд, шинэчлэлийн асуудлууд шийдэгдсэн байх ёстой болоод байна. Тэр агуулгаараа өнөөдөр энэ асуудлыг хэлэлцэх нь зүйтэй гэж үзэж байна.

## **Архагшсан ядууралд анализ, дүгнэлт хийхгүйгээр эдийн засгийн асуудлыг цааш явуулж болохгүй**

*Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан “Монгол улсын эдийн засгийн гадаад орчин, гадаад өр, тулгамдаж буй асуудлуудаар судалгаа хийж, үнэлэлт дүгнэлт гаргах цүрэг бүхий” ажлын хэсгийн 2013 оны 05-р сарын 27-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс:*

**О.Чулуунбат:** -Их Хурлын даргаас өгсөн үүргийн дагуу ерөнхийдөө өнөөдрийн манай эдийн засагт үүсээд байгаа байдалд бид дүгнэлт өгөх ёстой. Ийм зорилгоор яам, тамгын газруудаас нэлээн том хүчтэй ажилласан. Мөн хувийн судлаачдыг мөн их дайчилсан. Тэдний судалгаа, тооцооны ажлыг авсан. Нийт энэ ажилтай холбогдуулан 100-аад том тайлан гарсан байгаа. Тэрийг хэрэгтэй гэвэл та бүхэн өөрсдөө харж үзнэ биз.

Үндсэндээ дүгнэлт хийгээд 10-аад хуудас тайлан гарсан байгаа. Энэ та бүхний ширээн дээр байгаа. Бүгдийг нь базаад энэ л дээ. Өнөөдөр эдийн засаг яагаад ийм байдалд орчихов, яагаад бизнесийн идэвхгүй үйл ажиллагаа байгаад байна, яагаад хөрөнгө оруулалт явахгүй байна. Энд жишээлбэл, манай гадаад орчин нөлөөлөв үү, гадаад хөршийн худалдаа, эдийн засгийн байдал маань манай өнөөдрийн хэрэгцээг хангаж байна уу, үгүй юу? Хятадтай юу болж байна, ОХУ-тай яаж байна, дотооддоо Хөрөнгө оруулалтын хууль болж байна уу, үгүй юу, дотоодын манай засгийн төвшин хир байгаа вэ? Засаглал ер нь хэтэрхий төрийн өмчинд ороод байна уу, үгүй юу. Бид нар төрийн өмчөөс гаръя гэсэн том бодлого явуулах гээд оролдоод байдаг. Гэтэл өнөөдрийн алхам маань дандаа буцаад төрийн өмч болох гээд байдаг. Төрийн өмч болж болно л доо. Болохгүй юм юу байх вэ, хэрэгтэй чухал юм нь төрийн өмч байх л ёстой. Гэтэл төрийн өмчөөрөө дамжуулаад дандаа хувийн бизнес, хувийн ах, дүү, хамаатан саднаа шахдаг, төрийн өмчөөр дамжуулаад тийш нь ямар ч хэрэгтэй, хэрэггүй бараа шахдаг. Энэ үйл явдал маань өнөөдөр хүртэл үргэлжлээд байгаа юм.

Төрийн зохицуулалт гэдэг чинь өнөөдрийн бидний хэрэгцээнд байна уу, үгүй юу. Гааль, татвар, мэргэжлийн хяналт гээд баахан байцаагчид өөрсдөө дангаараа очиж хүн торгох эрхтэй. Тэгээд ганцаараа очоод тэрбум төгрөгийн торгууль сонсгочихоод 500 болгож буулгаж өгье, тэгэхээр 100-г өгчихөөч гэдэг юм уу ийм наймааны бизнес болчихсон. Өнөөдрийн сонин, хэвлэлээр гараад байгаа том шүүмжлэл бол ерөөсөө яг энэ схемийн төрийн зохицуулалтын наймааны бизнес болчихсон. Татвар дээр ч тэр, гааль дээр ч тэр, мэргэжлийн хяналт зэрэг бүгд иймэрхүү байдалтай байж байна. Энэ бүгдийг дүгнэсэн ийм дүгнэлтийн тайлан гаргачихсан байгаа. Та бүхэн энэ дээр үгийг нь бид сул хийсэн байна уу, тэгвэл бас чангалмаар хэрэгтэй бол тэгж санаа гаргаж болно. Эсвэл бид хэтэрхий шууд хатуу үгээр хэлчихсэн байж болох юм. Ямар, ямар тоо баримтаар нэмж баталгаажуулах хэрэгтэй байна вэ. Яахав, том тайлан дээр ерөнхийдөө бүх тоо баримтууд нь байгаа. Бодвол бидний ширээн дээр байгаа арваадхан хуудас материал бол олон нийтэд ч гарч болох ийм бүрэн бололцоотой. 11 гишүүнтэй Их Хурлын

ажлын хэсэг л шийднэ. Товчхондоо ийм л мэдээлэл байна. Үүнтэй холбогдуулан би эндээс асуух бөгөөд ажлын хэсгээс асуух асуулт гарвал хариулъя.

**Б.Гарамгайбаатар:** - Баярлалаа. Гишүүд тайлантай холбоотой асууж тодруулах, бас нэмж хийх, эсвэл болж байна гэсэн ийм тодорхой саналууд байвал хэлээд, хэлээд явчихъя. С.Дэмбэрэл гишүүнээр эхэлье.

**С.Дэмбэрэл:** - Эннийг сонсоод бид яах ёстой юм бэ? Бид нэмэлт юм хийгээд сүлчийн байдалд оруулах ёстой биз, тийм ээ?

**Б.Гарамгайбаатар:** - Дэд ажлын хэсэг ажиллаад, үндсэн дүгнэлтүүдээ гаргаад ирчихсэн байгаа. Энэ дээр гишүүд танилцаад дутуу юм байна уу, үгүй юу, нэмэх үү, хасах уу. Сая Чулуунбат сайдын хэлдэг шиг үгийг нь нэлээн хатуу хэлэх юм уу, эсвэл арай жаахан зөөлөн хэлэх юм уу. Ямар байдлаар энийг цаашид ажил болгож явах вэ гэдэг асуудлаар санал солилцоод явна.

**С.Дэмбэрэл:** - Надад ганц, хоёр асуулт байна. Гол нь санаануудаа л хэлчихье. Энэ материалын дэлгэрэнгүй болон хураангуйтай аль алинтай нь би танилцсан. Энд дутуу байгаа юм юу байсан бэ гэхээр ядуурлын анализ байхгүй байсан. Энэ нь архагшсан үзэгдэл шүү дээ, Монголын нийгэмд. Энийг хөндөхгүйгээр аливаа эдийн засгийн юм явагдаж болохгүй. *Нэгдүгээрт энэ.*

Сая ажлын хэсгийн дэд хэсгийн хүмүүстэй ярилцаж байхад энэ дээр ойрын хугацаанд хийхэд боломжтой. Үндэсний статистикийн газар бүх материалууд нь байж байгаа /олон жилийн/. Тийм ээ, Мэндээ? Энэ дээр хийгдсэн дүгнэлт нь байж байгаа. Тийм учраас энэ архагшсан ядуурлыг яаж боломж болгох вэ гэдэг тал дээр л зөвлөмж гаргах хэрэгтэй.

Мөн үүнтэй шууд холбоотой хоёр сектор байгаа. Нэг нь орсон байна. Байгаль орчны доройтол гээд. Гэхдээ байгаль орчны доройтол дээр материалууд бас дутуу байна. Энэ дээр өмнө нь гарчихсан 2011 онд гарчихсан эмзэг байдлаас тогтвортой байдал руу гэсэн илтгэл байж байгаа. Дараа нь хамгийн сүүлд Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас хийсэн зүйлүүд байгаа. Энэ дээр ялангуяа ус болон ойн цаашдын асуудал бас ороод энэ дээр суурилсан зөвлөмж байх ёстой. Энийг өөрөөр хэлбэл, нэмж хийх шаардлагатай байх гэж бодож байна.

*Гуравдугаарх нь*, эрүүл мэнд орсонгүй. Эрүүл мэндийн өнөөдрийн анализаас үзэхэд эрүүл мэнд маань өөрөө ядууралтай шууд корреляцид орчихсон. Тэгээд энэ ерөөсөө Монголын эдийн засаг оролцоотой хөгжлийн, тогтвортой хөгжлийн. Яагаад гэвэл энэ зөвлөмж дээр ногоон эдийн засаг, тогтвортой хөгжлийг цаашдаа Монголын төрийн баримтлах гол шугам гээд зөвлөчихсөн байгаа. Тийм байх аа? Миний уншсанд, би тэгж санаж байна. Энэ чинь угаасаа ойлгомжтой зүйл. Тэрний гол комбинент болох эрүүл мэндийн өнөөгийн байдлын анализ, түүн дээр түшиглэсэн судалгаа 2012 оны байдлаар Удвалын яаман дээр гарчихсан байгаа. Тэрний гол дүгнэлтүүдийг оруулах ёстой. Нэг ийм асуудал байна.

*Дээр нь* ядуурал, эрүүл мэнд, байгаль орчин гэсэн энэ гурав маань ингэж холилдоод, түрүүний эдийн засгийнхаа бодит секторын бодлого зэрэгтэй нийлэхээр цаашдаа тогтвортой хөгжлийн чиглэлээр Монгол улс юу хийх вэ гэдэг ерөнхий дүр зураг, тэрийг зөвлөмж болгосон ийм зүйлүүд гарч ирэх



ёстой. Ерөнхий эдийн засгийн байдал дээр хийсэн анализуудыг хараад байхад үзүүлэлтүүд дутуу байна. Түрүүн би энийг Чимиддагвад хэлчихсэн. Үндэсний нийт орлогыг тооцдог болох. Энэ тооцох бүрэн боломжтой байгаа. Дээр нь ДНБ болон үндэсний нийт бүтээгдэхүүний хоорондын салбарын бүтэц, энэний анализыг 2005, 2011 оны ерөнхий яс тоон дээр ингээд харахад бүтцийн өөрчлөлт Монголын эдийн засагт сүүлийн жилүүдэд хир зэрэг явагдаж байна вэ гэдэг энэ юм нь тодорхой биш байна. Бид ярьдаг макро үзүүлэлтүүдийг л яачихсан байна. Тийм учраас ажлын хэсгийнхэн сая надтай ярьж байхад санал нэгдэж байсан. Энийг нэмж оруулах нь зүйтэй юм байна гэж, тийм үү? Тэгсэн байх аа.

*Дээр нь*, гадаад эдийн засгийн харилцаан дээр хэдийгээр мэдээж хэрэг гадаад дипломат харьцааны хоёр улс орнууд дээр анхаарах ёстой юмнууд тусгагдсан ч гэсэн худалдааны нөхцөлүүд сүүлийн жилүүдэд маш хроник байдалтай байж байгаа. Энийг яах шийдэл нь экспортын, уул уурхайн бус экспортыг хэрхэн яаж хөгжүүлэх вэ, ямар инсентив өгөх вэ гэдэг асуудал гарч ирэх ёстой. Тэрний материал Эдийн засгийн хөгжлийн яам, танхим хоёр хамтарч хийгээд бараг дуусах гэж байгаа. Энэ бол өөрөө *supproduct* нь болох ёстой. Дагалдах бүтээгдэхүүн. Түрүүний ногоон эдийн засаг дээр, одоо энэ дээр ажлын хэсэг сууж байгаа. Ногоон эдийн засгийг хэмжих ажлын хэсэг хамт сууж байгаа. Энэ дээр бас нэг юм гаргана, хоёр дахь *supproduct* нь. Өөрөөр хэлбэл, энэ рекомендацийн дагуу гаргах тодорхой бүтээгдэхүүнд. Рекомендаци гэдэг өөрөө зөвлөмж гэдэг маань хэнд зөвлөөд байгааг бас ойлгохгүй байна. Энэ өөрөө зөвлөмж биш, үйл ажиллагааны төлөвлөгөө маркаар ингэж цаашаа гарах ёстой байх.

Санхүүгийн сектор дээр нэг анхаарах юм байгаа. Бас Эдийн засгийн байнгын хорооны даргын, Эдийн засгийн байнгын хорооны тогтоолоор санхүүгийн секторын реформ ба зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулах альтернатив бодлого боловсруулах ажлын хэсэг гээд гарчихсан. Тэрийг би ахалж байгаа. Бид одоо ерөнхийдөө юмаа хийнэ. Энэ ажлын хэсгийн бүтээгдэхүүн Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк энэ дөрвийн гаргасан албан ёсны албан бичиг байгаа байх. Яагаад гэвэл ийм юм гарах ёстой. Энэ бүхэнтэй харьцуулаад энэ өөрөө гурав дахь *supproduct* болж гарч ирэх ёстой. Өөрөөр хэлбэл, зөвлөмж өглөө, зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө бүхий ийм бодлогын баримт бичгүүд гарах. Би их хүнд юм яриад байгаа юм биш үү. Бараг л бэлэн болчихсон юмнуудыг яриад байгаа юм.

*Дөрөвт нь*, санхүүгийн сектор дээр зээлийн хүү нэг оронтой тоонд орох ямар зөвлөмж байна вэ? Санхүүгийн секторын реформ дээр мэдээж хэрэг Санхүүгийн зохицуулах хороо үнэт цаасны зах зээл, цаашдаа хөрөнгө оруулалтын сан гээд явчихна. Өнөөгийн санхүүгийн секторт байгаа энэ харьцаа эрүүл харьцуу юу, үгүй юу? Энийг цаашдаа яаж засах юм бэ? 95, 5, 5 гэсэн харьцаа. Энэ 10 яаж болгох юм бэ, 15 яаж болгох юм бэ. Тэгсэн мөртлөө банкны сектор нь хүчирхэг, өргөн үйлчилгээтэй. Тэгсэн мөртлөө банк бус санхүүгийн бусад сектор яаж ажиллах. Энэ ямар зөвлөмжүүд энэ дотор тусгагдсан юм бэ гэсэн ийм асуулт буюу цаашдаа анхаарах зүйлүүд байгаа юм.



Хэмжүүрийн хувьд би нэг зүйлийг хэлчихье. Одоо Үндэсний статистикийн хорооны дарга Мэндсайхан сууж байна. Бид ногоон өсөлтийг хэмжих хэмжүүр гээд гаргалаа. Саяын ярьсан зүйлүүд бас танай дээр байж байгаа шүү дээ. Энэ үзүүлэлтүүдийгээ анх удаа энэ илтгэлдээ оруулж өгмөөр байна. Тэгээд энэ дээрээ суурилсан макро анализ хийгээд, GDP-ээс энэ улс нэлээн юм харж болдог. Тэр үзүүлэлтүүд нь бэлэн байгаа юмнуудыг яагаад анализыг жаахан өргөтгөх асуудал болчихож байгаа юм. Тэгэхээр иймэрхүү үзүүлэлтүүдийг нэмж оруулаад, ингэснээрээ энэ комиссын /комисс гэж нэрлэе л дээ/ илтгэл 2014 оны Улсын Их Хурлын үндсэн чиглэл Монгол улсын бусад үйл ажиллагааг дүгнэж байна гэхэд энэ бол их чухал бодлогын баримт бичиг, гарын авлага нь болж байдаг, стратеги нь болж байдаг. Энийг Их Хурлын гишүүд гараад GN, GDP хоёрын зөрүү нь яагаад ингэчихэв гэж анализыг нь сонсож байдаг. Энийг нь холбогдох байгууллагууд нь өөрөө өөрсдийнхөө дүгнэлтийг хийгээд, энэ маань цаашдын хэрэгжүүлэх бодлогод шингэж байдаг ийм зүйлүүдийг, бид түрүүн хэмжүүр гэдэг дээр. Өөрөөр хэлбэл, бид нар макро эдийн засгийн хэвшиж тогтсон стандарт үзүүлэлт, тэрэнд суурилсан сэтгэлгээнээс салах. Тэгээд эндээс бэлэн байгаа үзүүлэлтүүдийг оруулж өгөөд. Доошоо болохоор хүний амьдрал уруу илүү ойртсон, тогтвортой хөгжил гэдгийг харуулсан тэр үзүүлэлтийн систем, тэр секторуудын үйл ажиллагааны анализ хийх хэрэгтэй. Тэр нь одоогийн Монголын төвшинд байгаль орчин, эрүүл мэнд. Энэ хоёрын л гүнзгий анализ. Энэ хоёр анализ нь хийгдчихсэн байгаа. Энэ бүх юмыг манай энэ ажлын хэсгийнхэн аваад дахиад ингэчихвэл их зүгээр болно гэсэн ийм л бодол байна.

**Б.Гарамгайбаатар:** -Баярлалаа...

**С.Дэмбэрэл:** -Түрүүн би ерөнхийдөө та нарт асуулт маягийн орхисон юмыг чинь л хэлсэн. Одоо яг бодитой, тэгсэн мөртлөө судалгааны чинь юуг өргөжүүлэхгүй, дотор нь.

*Нэгдүгээрт*, төрийн зохицуулалт хэт их байна гэж бичсэн. Тэр дүгнэлт зөв. Гэхдээ энэнээс гарах гаргалгаа нь юу юм бэ? Юу байх юм бэ? Энийгээ бичих ёстой. Тэр нь жишээлбэл, миний харж байгаагаар нэгдүгээрт, Төрийн зохицуулалтын тухай хууль яаралтай санаачилж Улсын Их Хуралд оруулах. Энэ хууль тогтоомжийг 2016 он хүртэлх дотор ерөнхийдөө хоёр, гурван хуулин дээр хуваагдаад суучихсан байгаа юм. Тийм учраас энэ талаас нь нэгдүгээрт.

*Хоёрдугаарт*, гадаад харилцаан дээр ярьсан байна. Ганцхан дүгнэлт дутагдаж байна. Монгол улсын гадаад харилцааны нэгдсэн нэг цонхны бодлого алдагдсан гэсэн дүгнэлт байх байсан. Тийм биз дээ? Тийм учраас тэр цонхны чинь бодлого алдагдчихаад байна. Тийм учраас Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж гарсан шүү дээ. Тэр нь зүгээр гадагшаа харьцахдаа нэг цонхоор харьцаж бай гэсэн болохоос, угаасаа энэ улс орнуудтай харьцах юман дээр алдагдчихсан байна. Тэр институци хоорондын уялдаа.

*Гуравдугаарх нь*, тэнд гадаад харилцаан дээр Европын холбоо түшвэл GSP plus. Энэ олон жил ярьсан зүйл. Юу дугаад байна вэ гэвэл одоо GSP авч байгаа улс орнуудынхаа GSP-гийнх нь хөнгөлөлтийн системд анализ хийгээд Монголын экспортын бүтээгдэхүүнийг яаж тэр рүү нь илүү сайн суулгаж өгөх вэ. Мөн түүний дотор GSP өгөхгүй байгаа, тухайлбал,

Солонгос улс байна. Солонгос улс OECD ангиллаар бол өнөөдөр хөгжилтэй орон. Гэтэл Солонгос улсын Японтой адилхан ЕРА буюу чөлөөт худалдааны хэлэлцээр, эдийн засгийн гэдэг шиг тийм зүйл юманд нь яаж тусгаж өгөх вэ гэсэн тийм тодорхой зөвлөмж байх ёстой. Энэ гадаад харилцааны чиглэлээр.

*Дээр нь* ногоон эдийн засгийн хувьд би түрүүн хэлчихсэн. Энд манай ногоон эдийн засгийн багийнхан сууж байна. Эндээс нэг юм гарна. Би түрүүн sub product гэж хэлээд байгаа юм. Дагалдах бүтээгдэхүүн гэж. Энэ дагалдах бүтээгдэхүүн гарахад энэ нь өөрөө үүний нэг юу байх ёстой. Энэ зөвлөмж хэнд зориулагдсан юм бэ гэхээр төрд зориулагдсан. Төр гэж хэн юм бэ гэхээр Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар. Энэ гурав нийлэхээрээ юу болдог юм бэ гэхээр үндэсний аюулгүй байдлын зөвлөл. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл рүү хандсан ийм зөвлөмж маркаар, тэгээд эргүүлээд нөгөө гурван субъект руугаа ингэж цацагдах ийм талаас нь бодож энийг хийх ёстой.

Хүмүүс хэлж байна. Г.Батхүү хэлж байна. Үнэн. Хөдөөгийн хөгжил, тэр талын юм нь орхигдсон байна. Жижиг, дунд бизнес гэдэг дээрээ дотроо анализ нь орхигдож. Өнөөгийн хуваарилж байгаа системийг шүүмжлэх хэрэгтэй шүү дээ. Чимиддагва чи өөрөө энийг маш сайн мэднэ. Төр, хувийн хэвшлийн тэгш, шударга оролцоо байхгүй, өмнөх Засгийн газрын үед. Энийг өөрчлөх тийм рекомундаци байх ёстой шүү дээ. Тийм учраас хуваарилалт чинь шог байна, энийг өөрчил гэсэн рекомундаци өгмөөр байна. Би тэгж өөрөө хэлсэн, хатуу байх ёстой, үнэн байх ёстой. Зөөлхөн байж болохгүй, нялцганасан байж болохгүй, ерөнхий байж болохгүй.

Дээр нь ядуурал гээд. Энэ ядуурлын ганцхан өнөөдрийн манай хандлага ямар байгаа вэ гэхээр “ок, ядууралтай юм байна, ажлын байр бий болгоод байя” гэсэн тийм ерөнхий. Гэтэл бүх энэ гаргачихсан судалгаагаар энэ нь өөрөө олон хэмжүүртэй гэж байгаа юм. Олон хэмжүүртэй нь өөрөө судалгаагаар батлагдаад байгаа юм. Тэр нь эрүүл мэндийн үзүүлэлт. Энийгээ хийсэн. Ядуурлын архагшсан байдлаас дараагийн дунд хугацаанд яаж гарах вэ гэсэн хоёр өгүүлбэр байхад хэрэгтэй.

*Дараагийнх нь*, санхүүгийн тогтвортой байдал ойрын саруудад, дараа жил ямар байх юм бэ. Санхүүгийн тогтвортой байдлыг хангадаг төрийн институцүүдийн хоорондын ажиллагаа ямар байх юм. Энэ жил миний ойлгож байгаагаар хоёр удаа л хуралдсан байх. Тэндээ оролцооны төвшин маш хязгаарлагдмал. Энийг Эдийн засгийн байнгын хороон дээр бид ярьж байсан. Энэ нь цаашдаа энэ дотор орж санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, институцүүдийнхээ хувьд яах юм бэ гэдэг нэг асуудал байна.

*Дараагийн асуудлууд*, Монгол улсын төрийн институцүүдийн хоорондын ажлын уялдаа, чадавх. Энэ өнөөдөр маш муу бөгөөд энэ үйл ажиллагааг тормослох ийм төвшинд оччихсон байгааг энэ дээр ерөнхийдөө хатуугаар дурдаад өгчих хэрэгтэй. Энийг цаашид сайжруулах гол арга зам нь энэ төрийн институци, төр ингэж хамаагүй ордог тэр зүйлүүдээс хязгаарлах ийм зүйл. Яаралтай өөрчлөх хуулиудыг хэлж өгөх ёстой. Жишээлбэл, Засгийн газрын бараа, үйлчилгээ худалдан авах хууль. Эдийн засгийн хөгжлийн сайд өөрөө хэлсэн, эртээд хурал дээр. Тормос болж байгаа хууль байна гэж хоёр удаа хэлсэн. Бүх яамдын сайд нар мэдэж байгаа. 500-

700 өдрөөр энэ ажил чинь явахгүй байна, Монголын сезоны эдийн засагт энэ чинь өөрөө нэмэлт засаглалын садаа болж гарч ирээд байна. Энийг яаралтай өөрчлөх. Жишээлбэл, миний хувийн санал бол тэрбум төгрөгөөс доогуур бол ямар ч тендер эрх байхгүй. Хүнд итгэсэн бол итгэ. Тэгээд шалга. Хөндлөнгийн хяналт шалгалтыг оруулж ирэх ёстой. Ийм зүйлийг рекомундаци хийж болно шүү дээ.

*Үнийн тогтворжуулалт, механизм.* Үнийн тогтворжуулалтын энэ механизм үр дүнгээ өгч байна уу, цаашид яаж сайжруулах гэсэн нэг юм уу, хоёр өгүүлбэр байх. Дэд хөтөлбөрүүд явж байна. Энэ өөрөө явж байгаа. Инфляцийн *surply*, нийлүүлэлтийн тал дээр. Энэ талын юман дээр хоёр өгүүлбэр бас баймаар байна. Институциудыг хэлсэн. Институциуд нь үр ашиггүй бөгөөд хомсдолтой ажиллаж байна. Тийм учраас энэ өөрөө олонх болчихсон. Одоо гэхэд л бид хуулиар шинэ институци байгуулах гээд л явж байгаа. Энийг, энэ апититыг яаж хязгаарлах юм бэ. Энэ асуудал дээр.

*Бонд.* Бондыг зүгээр дурдаад орхичихсон байсан. Энэ дурдсаныг бүгд мэднэ шүү дээ. Гэтэл эртээд Их Хурлын даргын өрөөнд, Их Хурлын дарга юу гэж хэллээ, өвлийн зоорь ч гэдэг юм уу, энэ юман дээр та нар шүүмжлэлтэй ханддаг нүд чинь хаана байна? Дурдах гэж тавиагүй, нүд шүүмжлэлтэй хандаад. Жишээлбэл, энэ дээр одоо Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дэргэдэг Жижиг, дунд үйлдвэрлэлийн хорооноос жижиг дунд бизнест мөнгө хуваарилаач ээ гээд хэлээд байгаа юм. Тэгэхээр энд чиний хэлсэн, өмнөх дөрвөн жилд тавьчихсан мөнгө чинь муу байдлаар хуваарилагдсан ч гэсэн яг одоо бодит байдал дээр тэр чинь хугацаанаасаа болоод эргэж ирэх нь бага байгаа. Эргэж цугларах нь. Тэгвэл механизмаа сайжруулах, дээр нь нэмэлт эх үүсвэрийг бондын мөнгөнөөс дор хаяж 100 сая доллар гэсэн тийм байдалтайгаар тодорхой зөвлөмж өг л дөө. Энэ зөвлөмжийг л бид хүлээж байна. Энэ зөвлөмжийг л өгмөөр байна.

*Монгол Улсын өрийн асуудал.* Дунд хугацаанд Монгол улсын өрийн асуудал хэцүү болно. Одоогийн анализыг чинь харахад. Тийм биз? Энэ чинь төлбөрийн баланстай шууд холбогдож эхэлнэ. Тэгэхээр энэ өрийн асуудлаар цаашдаа энийг яаж тогтвортой байлгах талаар юу байх юм бэ?

*Худалдаа.* Хамгийн орхигдсон юм нь транспорт логистикийн сектор тэр чигээрээ орхигдчихож. Транспорт логистикаар одоо бид нар яг үнэндээ хэлэхэд тодорхой бодлого алга байна шүү дээ. Төмөр зам нь яах гээд байгаа юм, агаарын тээвэр нь. Сүүлийн үед Батбаяр таван чиглэл яриад байдаг. Тэр бол тэнгэрт явж байна. Яг одоо Монгол улс энд хөрш орнуудтай, Хятадын зүүн хойд мужийн Жилинийг сонгох юм уу, бусад боомтуудыг нь сонгох юм уу. Тэгээд НҮБ-ын одоо, Мянганы хөгжлийн зорилтын 8 дугаар зорилтынх нь нэг юман дээр далайд гарцгүй орнуудад тээвэр логистикийн энэ талын юм болон олон улсын конвенц. Энэний олон талын механизмыг гадаад бодлогынхоо юман дээр яаж суулгаж өгөх юм бэ. Энэ асуудал бас ороогүй байна. Түрүүний Мянганы хөгжлийн зорилтын, 2015 онд дуусна. Энэ дээр хэд хэдэн зорилтууд нь тасарна. Одоо ерөнхийдөө тасраад явж байгаа. 8 дугаар зорилт дээр байгаа одоо Монгол улс ялангуяа Эдийн засгийн хөгжлийн яам энийг анхаараарай. Ингэж хэлээд байгаа шүү. Бид одоо Дэлхийн банкны ангиллаар дунд. Гэтэл тэрний 8-ын 5 дээр нь, “г” дээр нь ч билүү ингээд биччихсэн байгаа юм. GNI-г тооцно. ODA авахын тулд GNI-аар тооцсон тэр тооцоог тэгвэл оди эй авч болно гэж.

Бидний өнөөдрийн Монголын бодит байдал бол бид ODA авах төвшинд хэвээрээ л байна. Нийгмийнхээ яг эдийн засгийн бодит амьдрал уруу орвол. Тэгэхээр мэдээж хэрэг, бусад зээлээ авахаас гадна ODA-ээс бас татгалзахгүй байх зөвлөмжийг энэ Мянганы хөгжлийнхөө юун дээр бас уялдуулаад хэлээд өгчихвөл 8-ын хэддүгээр зорилттой уялдуулаад хэлээд өгчихвөл их зүйтэй байх. Транспорт ороогүй байсан.

*Хамгийн сүүлд нь social.* Нийгмийн severity. Хоёрхон өгүүлбэр хэрэгтэй. Тэр нь юу юм бэ гэхээр өнөөдөр Монголд халамжийн нуугдмал систем яваад байна, амь бөхтэй оршсоор байна. Зөв үү, Чука? Тийм учраас аливаа халамжийн бүх систем conditional cash transfer буюу нөхцөлт мөнгөн шилжүүлгийн зарчим болгох ёстой гэсэн ийм зөвлөмж байхад л боллоо. Миний хэлэх зүйлүүд, энэ бүхнийг зөвлөмжиндөө оруулаад ингэвэл ер нь аятайхан юм болчихож магадгүй шүү. Баярлалаа.

**Б.Гарамгайбаатар:** -Үг хэлж дууслаа. Бид нар энэ тайлангийн хүрээнд л ажлаа дүгнэхээс өөр арга байхгүй. Яагаад гэвэл энэ мөнгө байхгүй, хөрөнгө байхгүй. Энэ олон улсуудын юунд бид Эдийн засгийн байнгын хороо өөрийнхөө боломжтой зардлыг гаргаад энийг хийлгэсэн байгаа. Бид нарын гол зорилго бол гишүүдийн саналыг мэдээж авна. Гэхдээ бид бас өргөн дэлгэр утгаар нь гэдэг юм уу, гишүүдийн хэлж байгаа тэр бүх саналыг авах боломж үнэхээр байхгүй.

Өнөөдөр би Энх-Амгалан гишүүний хэлсэнтэй ойролцоо санал хэлэх гээд байна. Нэг ёсондоо бид нар өнөөдөр үндсэн чиглэл, одоо 2016 оныг хүртэлх төлөвлөлт, хөрөнгө оруулалтын чиглэлүүдийг тодорхойлох гээд байгаа учраас энэ зөвлөмж дээр тэр асуудлуудыг яаралтай, энэ яамдуудын хоорондын уялдаа холбоо байхгүй гээд энэ дүгнэлтэд гарчихсан байж байгаа шүү дээ. Энэ уялдаа холбоог сайжруулах асуудал. Дээр нь хоёр талын гадаад, дотоод орчны байдал гэхээр Орос, Хятад хоёр улстай байгуулсан гэрээ, хэлцлүүдийн зогсчихсон байгаа нөхцөлүүдийг бид нар явал хөдөлгөх юм, ингэснээр эдийн засагт ямар ач холбогдол өгөх юм бэ гэдэг энэ асуудал. Төмөр замын асуудал, автозамын асуудал, энэ бүгдийг уг нь задалж, энэ нь эргээд нийгэмд ямар ашигтай юм гээд энэ асуудлуудыг бид энэ тайланд тусгах гэж оролдсон. Тэгэхээр энийгээ бид ажил болгохын тулд аль болохоор энэ тайлангийнхаа энэ дотор байгаа асуудлуудтай уяж явбал дээр байх гэж ингэж бодож байгаа юм.

Гадаад өрийн асуудал ярихаар гадаад өрийн тухай хуулийн асуудал яригдаад эхэлж байгаа шүү дээ. Тэр асуудлуудаа хүртэл бид нар энд оруулчихсан байгаа шүү дээ. Хөрөнгө оруулалтын хуулийг оруулах асуудлыг энд оруулсан байгаа. Энэ бүгдийг бид нэгэнт хийсэн гэж ингэж би үзэж бахйгаа юм. Ажлын хэсгийн даргын хувьд. Бидэнд хугацаа алгуурлаад байх тусам бид нарын хийж байгаа тайлан үр дүнгүй, нэг ёсондоо ач холбогдолгүй болох гээд байгаа юм. Тийм учраас би 5 дугаар сарын 17 гэсэн. Харин 5 дугаар сарын 17-ноос хойш ажлын хэсгийн гишүүдэд материалыг танилцуулаад, үүнтэй сайтар танилцуулаад, дээр нь гишүүд энэ доторх хүрээн дотор саналуудаа боловсруулж өгөөч ээ гэж ингэж хэлж энэ ажлын хэсгийн хуралдааныг зарласан байгаа юм.

Тийм учраас энэ тайлан дотор Дэмбэрэл гишүүний зарим Чимиддагватай ярьсан ярианууд байдаг юм уу, тэр асуудлуудыг орох газар байгаа бол тэр

хэсгүүдэд нь оруулаад энэ тайланг бид нар хамгаалах ёстой. Тэртэй тэргүй чуулганд оруулах ёстой. Энэ дээр гол чиглэлүүд нь, дүгнэлтүүд нь бас заагдчихсан байгаа. Дөрөв, таван дүгнэлт байгаа юм.

Нэгдүгээрт, хамгийн чухал юм бол манай яамдуудын уялдаа, холбоо туйлын хангалтгүй байна гэдэг нэг дүгнэлт гарч ирсэн. Хоёрдугаарт, Орос, Хятад, Орос улсуудтай байгуулсан гэрээнүүд зогсонги байдалд орчихсон байна. Энийг гарах арга замуудыг олох ийм, ийм арга замууд байна гэдэг чиглэлүүдийг өгчихсөн байгаа. Гуравдугаарт, банк, санхүүг сүүлд нэмэх асуудлыг Чулуунбат сайд ярьсан байгаа. Гэх мэтийн энэ асуудлуудаа эхлээд бид нар оруулчихаад дараа нь нэгдсэн том бодлогын шийдвэрүүдийг гаргах асуудлыг дахиад өөр юугаар хийсэн нь илүү оновчтой байх гэж ингэж бодож байна.

**С.Дэмбэрэл:** -Би нэг тайлбар хэлчихье. Саяын миний хэлсэн үг бол ажлын хэсгийнхэнд маш тодорхой ойлгогдож байгаа. Тийм биз? Энэ ерөөсөө юмыг эвдэхгүй.

**Б.Гарамгайбаатар:** -Эвдэхгүй бол эвдэхгүй юмнуудыг нь оруулна шүү дээ.

**С.Дэмбэрэл:** -Энийг баяжуулах юм би хэлээд байна шүү дээ. Өөрөөр хэлбэл, дутуу гэдгээ энэ чинь нөгөө илтгэл дотроо байж байгаа. Рекомендаци гэдэг дээрээ ингээд, ингээд шигтгээд оруулчих асуудал байна. Бусад нь ерөнхийдөө бэлэн байгаа юм. Жишээлбэл, чамд өөрт чинь аравхан минутын ажил. Тийм биз, Чимиддагва аа? Ядуурлын тоо нь, Мэндсайхан тэнд сууж байна. Ингээд л энийг тавьчих, тэрийгээ биччих. Multidimensional болсон байна. Тийм учраас өнөөгийн хандлагаараа өөрчилчих гээд л биччих. Тийм биз дээ, Чука? Би ийм юм хэлээд байгаа байхгүй юу. Тэгээд нөгөө юм нь бас нэг зарчмын зөрүүтэй санал нь юу вэ гэхээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хаяглая гэж хэлээд байгаа юм шүү дээ. Яагаад гэвэл гурван субъект нь байж байгаа юм. Ерөнхийлөгч, Их Хурлын дарга, Ерөнхий сайд гээд. Энэ гурван хүнд л гурвууланд нь хаягласан байвал энэ маань өөрөө иж бүрэн бөгөөд хүчтэй болно. Дараа нь энийг чинь авч үзээд эргээд нөгөө чиглэл, зөвлөмжийн чанартай гаргах юм. Тэгэхээр хэрэгжих магадлал нь их өндөр болно гэсэн үг юм.

Жишээлбэл, бид сая институцүүдийн, өөрөөр хэлбэл, яамдын юм гээд хамгийн түрүүнд хэллээ шүү дээ. Тэр үнэхээр зөв. Гэтэл тэрэн дээр чинь Засгийн газрын бараа худалдан авалт өөрөө нэг гол садаа нь болоод байгаа юм. Тэрийг жишээлбэл, зөвлөмжөөр жаахан дэлгэрүүлээд оруулаад өгчих гэсэн тийм санаа юм.

**Б.Гарамгайбаатар:** - Г.Батхүү дарга аа, Их Хурлын даргын захирамжийг Их Хурлын төвшинд л гаргана биз дээ. Бид судалгааны материалаа тэгж л өгнө шүү дээ. Тэрнээс дээш нь шууд өгч болдог юм уу? Үндэсний аюулгүй байдлын зөвлөл зэрэгт.

**С.Дэмбэрэл:** -Болно.

**Б.Гарамгайбаатар:** -Тэгвэл тэр чиглэлээр өргөтгөж, тэр саналаа явуулах юм байна шүү дээ. Ер нь Засгийн газар, Их Хурал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл гуравт зөвлөмж, саналуудаа өгөөд явах. Одоо Л.Энх-Амгалан гишүүн.



**Л.Энх-Амгалан:** -Нэг зүйл тодруулах гээд байна л даа. Мэдээж, гадаад, дотоод орчиндоо дүгнэлт өгчихлөө, ямар ч байсан нөхцөл байдал ийм байгаа юм байна гээд. Тэгэхээр одоо эндээс чинь гарах үр дүн гэхээр бид нар Улсын Их Хурлын тогтоолын төсөл Улсын Их Хуралд энэ дүгнэлттэй хамт өргөн барих гэж байна уу, эсвэл яах гэж байна вэ? Уг нь миний санаж байгаагаар 2008 онд эдийн засгийн хямралыг даван туулах тухай авч хэрэгжүүлэх арга хэмжээ гээд маш сайн Улсын Их Хурлын тогтоол гарсан шүү дээ. Яг тэрэнтэй адилхан нөхцөл байдал ийм болчихоод байгаа юм чинь энэ нөхцөл байдлаас бид нар яаж гарах юм, яах юм бэ гэдэг дээр Улсын Их Хурлаас авч хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалт гэх үү, тогтоол гэх үү, ийм төсөл л бид бэлдвэл. Та тоймтой дөрөв, таван л юм хэлж байна шүү дээ. Ийм тоймтой дөрөв, таван юман дээрээ л.

**С.Дэмбэрэл:** -Жаахан нэмье л дээ.

**Б.Гарамгайбаатар:** -Энийг бид одоо Эдийн засгийн байнгын хороонд оруулах байх. Энийгээ дуусгаад. Тэгээд Эдийн засгийн байнгын хороон дээр гишүүдэд танилцуулаад, гишүүд Байнгын хорооны хуралдаанаас гарсан тогтоолын төсөл гэдэг юм уу, ямар нэгэн юм гарвал тэрийг Их Хурал руу оруулах ийм л асуудал байна. Тийм биз дээ, Батхүү дарга аа? Туршлагатай хүмүүсээс бас асууя л даа.

**Г.Батхүү:** -Тэгнэ.

**Л.Энх-Амгалан:** -Их Хурлын даргын захирамжаар байгаа ажлын хэсэг шүү дээ. Тийм учраас Их Хурлын даргын захирамжийн тогтоол гэх үү, тэр төслийг бид нар бэлдэх хэрэгтэй гэсэн үг биз дээ?

**С.Дэмбэрэл:** -Гурвууланд нь, Үндэсний аюулгүй байдлын, тэр гурван субъектэд очмоор тийм зүйлүүд байгаа юм.

**Б.Гарамгайбаатар:** -Арга хэмжээний төлөвлөгөө гээд. Өөрөөр хэлбэл, энэ дээр суурилсан.

**Г.Батхүү:** -Зарчмын хувьд ингэнэ шүү дээ. Ажлын хэсэг Байнгын хороондоо асуудлаа оруулна. Байнгын хорооны гишүүд хэлэлцээд.

*Хуралдаан өндөрлөв.*

*Соронзон хальснаас буулгасан: Б.БАТГЭРЭЛ*

## **Яамдын тоог цөөрүүлэх нь асуудлын шийдэл биш**

*Сурвалжлагч Л.Алтаншагайтай хийсэн хэвлэлийн ярилцлага:*

- Намрын чуулган эхэллээ. УИХ-ын дарга бас “Ерөнхий сайдын оруулж ирэх асуудал нь ард түмний хүлээлт цаана нь байж байгаа” гэж хэлж байсан. Түрүүн таньтай ярилцаж байхад та нэг сонин гаргалгаа хэллээ. Засгийн газрын яамдуудыг цөөлөхөөсөө илүү, түүнийг дагалдах тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагуудыг цөөрүүлэх юм бол данхайсан бүтэц нь гайгүй болно гэж байсан, нэгдүгээрт?

Хоёрдугаарт, Энэ байдлаа хадгалах нь Ардчилсан намын пракцуудаас “Эхийг нь эцээхгүй тугалыг нь тураахгүй” хэл амгүй байх юм гэсэн санаа хэлсэн. Энэ тал дээр та саналаа хэлнэ үү?



**С.Дэмбэрэл:** 2012 оны сонгуулиар Засгийн газрын оруулж ирсэн бүтэцийг бид ярих гэж байна. Тэр үед маш их хэцүү болж байлаа. Ардчилсан нам гэхэд дотроо олон пракцуудын хүсэл зоригийн хангасан, дээр нь хамтарч засаг барья гэсэн намуудын санал, оролцоог хангасан бүтэц оруулж ирсэн. Тэр нь нэлээн данхар бүтэц байсан. Одоо үүнийг дөрөв, таван яамаар багасгачихвал Монгол Улсад сайхан болно гэж яриад байна. Миний бодлоор энэ бол асуудлын шийдэл биш. Өөрөөр хэлбэл нийтийн засаг захиргааны асуудал. Public administration гэж ярьдаг. Тэгэхээр эндээс:

1. Монгол Улсад өнөөдрийг хүртэл засаг захиргааны ямар бүтэц, яаж үйлчилж байгаа вэ гэсэн суурь асуулт асуумаар байна?

1997 онд Шинэ Зеландын туршлага гээд тухайн үеийн УИХ-ын гишүүд маш олон удаа Шинэ Зеланд руу явж туршлага судалдаг байсан. Миний ойлгож байгаагаар Энхсайханы Засгийн газрын үед Яам - тохируулагч агентлаг - хэрэгжүүлэгч агентлаг гэсэн бүтэцтэй Монгол Улсад анх орж ирсэн. Тэрнээс хойш сонгууль болгоноор байгуулагдсан засаглалууд дандаа энэ бүтэцээр явсан.

2. Энэ бүтэц Монгол улсад үр ашигтай, цомхон, чадвартай засаглалыг бий болгож чадсан уу гэсэн суурь хоёр дахь асуулт гарч ирж байна. Чи ч, би ч “чадаагүй” гэж хариулна. Яагаад гэвэл, үүнийг судлаачид ч хэлдэг, УИХ-ын гишүүд, улс төрчид ч хэлдэг. Бүгд юу хэлдэг вэ гэжээр, данхар төр бий болсоныг л хэлдэг. Тийм учраас Ухаалаг төр гэсэн яриа гарч ирсэн. Гэхдээ л “энэ бүтэцийг хэвээр нь авч үлд” гээд байх юм. Өөрөөр хэлбэл, нутагшихгүй бүтэцийг механикаар, хүчээр дахиж явуулах гээд оролдоод байна. Миний бодлоор, хэрэв үнэхээр засаг захиргааны бүтэцийг сайжруулья гэвэл, эхний ээлжинд хийх ажил бол “тохируулагч агентлаг, хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн бүтэцүүдийг байхгүй болгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, Яам - тохируулагч агентлаг - хэрэгжүүлэгч агентлаг гэсэн энэ урт бүтэцийг Яам – зах зээл /хувийн хэвшил/ гэсэн бүтэцтэй л болгох ёстой. Яам нь бодлогоо ч боловруулдаг, хувийн хэвшилтэй ажиллах, ард иргэдтэй ажиллах ажлаа шууд хийдэг байх хэрэгтэй. Зах зээл гэж хэлж байгаа нь тэр. Зах зээлд үйлдвэрлэгч, үйлчилгээ үзүүлэгчид, хэрэглэгч гурав л байж байгаа. Энэ талаас нь бодож өөрчлөлт оруулбал нэг талдаа зөв өөрчлөлт болно. Нөгөө талаасаа өнөөгийн байгаа улс төрийн хүчнүүдийн харьцааны тогтсон эмзэг бүтэцийг 2016 он хүртэл аваад явах зүйл болно. Бас, засаглалын үр дүнд их мэдэгдэхүйц үр нөлөө өгнө. Шийдвэр гаргах процесс маань олон шат дамжлагаар дамжихаас илүү, зах зээлийнхээ судсыг нь барьж үзээд, дуу хоолойг нь сонсоод, түүн дээр яам нь бодлогоо гаргаад явдаг болно. Одоо яриад байгаа төр, хувийн хэвшлийн түншлэл гэдэг дээр засаглалын шинэ бүтэц шууд ороод ирэх боломжтой. Үүнийг янз янзаар ярьдаг, шууд ардчилал гэх зэргээр... Засаглалын бүтэцийг өөрчлөхгүйгээр яамдын тоог, тоон утгаар нь 17 байхад нь 14 болгох ч юм уу, 13 болгох ч юм уу, эсвэл үгэн дээр дөрөөлж маргалдаад байх хэрэггүй. Жишээлбэл, өглөөний УИХ-ын даргын үгэнд, “Урт хугацааны Монгол Улсын хөгжлийн стратегийн бодлого боловсруулах ёстой ажлын хэсэг хавар байгуулагдсан. Тэр яасан бэ? Ажлаа хурдан хийгээчээ.” гэсэн нэг мессеж ирлээ. Дээр нь “Монгол улсын засаглалын талаар ард иргэдийн хүлээлт их байгаа шүү.” гээд ерөнхий сайд засгийн газарт мессеж өглөө. Энэ бүхнийг өнөөдөр 17

яамыг 14 болгох ч юм уу 13 болгох ч юм уу энэ бүтцээр шийдэж чадахгүй. Улс төрийн тоглоом болно. Нийтийн засаг захиргааны өөрчлөлт хийе гэж бодож байгаа бол, одоо байгаа Монгол улсад нэвтрүүлэх гээд байгаа, нэвтэрсэн, олон жил болсон, нэвтэрсэн гэж үзээд байгаа тэгсэн мөртлөө дандаа засгийн үр ашиггүй байдал, данхар төр, үр ашиггүй үйлчилгээ энэ бүхнийг төрүүлж байдаг 1997 онд авсан энэ бүтцээ ер нь цаашаа хэрэглэх үү? үгүй юу? гэсэн суурь асуултандаа хариулаад цаашаа явбал зүйтэй.

- Намд фракц гэж байхаас биш, засгийн газарт фракцууд орчихоод, түүнийг нь “тогтвортой байдал” гэдэг үгээр хаацайлаад байх нь зүй бус юмаа гэсэн шүүмжлэл нэлээд гардаг. Үүн дээр та санал юу вэ? Таны үгнээс “Ардчилсан намын француудад нэг нэг суудлыг нь үлдээх хэрэгтэй, фракц болгоноос 1-2 сайд байх хэрэгтэй” гэсэн санаа сонсогдоод байх юм.

С.Дэмбэрэл: - Би ерөөсөө тэгэж хэлээгүй, фракц гэж яриагүй. Засгийн газар анх байгуулагдахдаа л угаасаа, анхнаасаа тийм л байсан. Тийм биз дээ? Нэг нам дотроо өөрийнхөө фракц байдаг нь байдаг уу, байдаг. Тэрийгээ тэд хүлээн зөвшөөрдөг үү, зөвшөөрдөг. Фракцуудын зөвшилдөөний үр дүнд орж ирсэн бүтэц. Энэ нь хэрэв фракц хоорондын зөрчил нэмэгдвэл нурж унах аюултай тий л эмзэг бүтэц. Энэ тохиолдолд, засаглалын бүтцийг хадгалж, улмаар фракцийн тэнцвэрийг хадгалах нь зүйтэй гэж бодоод байгаа юм бэ гэхээр, “Төр маань тогтвортой байгаасай, улс төр маань тогтвортой байгаасай.” гэж бид бүгдээрээ, том жижиггүй, дээр дооргүй ярьдаг шүү дээ. Жишээлбэл, Гадаадын хөрөнгө оруулалтын хууль батлагдлаа. Үүнийг тайлбарлахдаа, хүн болгоны аманд нэг л үг байдаг. “Манай энэ шинэ хууль улс төрийн тогтвортой байдлыг хангах...” гэж ярьдаг. Тэр талаас нь бодож үзэх хэрэгтэй. Ард иргэдэд хэдэн яамтай байх нь сонин биш. Ард иргэдийн хүсэн хүлээж байгаа зүйл бол “надад үйлчилгээ үзүүлдэг, надаас татвар авдаг энэ засаг эргээд надад үйлчилгээ үзүүлэхдээ бизнесийн тогтвортой байдал, таатай орчинг бүрдүүлж чадаж байна уу? Үгүй юу? Зах зээл дээр юмны үнэ тогтвортой байж чадаж байна уу? Үгүй юу? Валютын ханш тогтвортой байж чадаж байна уу? Үгүй юу? Эд нар дотроо учраа ололцож чадаж байна уу? Үгүй юу?” л гэсэн асуудал шүү дээ. Өнгөц харахад, хэрүүл маргаан сонирхолтой байдаг байх л даа. Гэтэл Монгол Улс, Монгол Улсын засаглалын тогтвортой байдал илүү чухал шүү дээ. Энэ бол номер нэг шалгуур. Энэ шалгуурыг ямар ч улс төрч баримтлах ёстой, ямар ч нам баримтлах ёстой. Одоогийн богино хугацааны улс төрийн нэг оноо авах явдал бол 2016 онд үр өгөөж өгөхгүй. Ардчилсан намд ч, Ардын намд ч аль алинд нь үр өгөөж өгөхгүй. Тэр талаас нь бодох юм бол, ард түмний эрх ашиг талаас нь бодвол, засаг захиргааны шинэчлэлийг хийе. Хийх олон вариант байгаа. Миний вариант бол саяных. Дээр нь улс төрийн тогтвортой байдлыг хангая, энэ тохиолдолд эдийн засгийн тогтвортой байдал хангагдана. Эдийн засгийн тогтвортой байдал хангагдана гэдэг маань юмны үнэ тогтвортой байх, валютын ханш тогтвортой байх, энэ бүх микро суурь орчин бүрдэнэ гэсэн үг. Дээр нь “хуулийн өмнө хүн бүр тэгш эрхтэй” гэсэн зарчим буюу хүний эрхийг хамгийн сайн хангасан хууль эрх зүйн орчинг Монгол Улсад бүрдүүлэх ёстой. Яг энэ реформ нь явагдаж байгаа. Реформыг цааш нь тууштай өргөжүүлэх, үүнд бүгд оролцох замаар хангах хэрэгтэй. Монгол улсад гадаадын хөрөнгө оруулагч болон иргэн

хоёрын хэн нь ч хэлсэн нэг л бодол байх ёстой. Энэ бол, “Ямар нэгэн байдлаар миний эрх зөрчигдвөл, энэ улсад тэгш хамгаалагдсан орчин байх ёстой” гэсэн ойлголт төрж байх учиртай. Энэ талаас нь бодож, хуулийн засаглалын номер нэг асуудлаа хийх хэрэгтэй. Энэ бүхэн засаг тогтвортой байхыг шаардаад байна.

**- Шинэ бүтцийн өөрчлөлтийн талаар асуудал орж ирэхээс өмнө Н.Алтанхуяг өөрөө огцрох өргөдлөө давхар оруулж ирэх юм болов уу гэж найдсан?**

**С.Дэмбэрэл:** тэрийг би мэдэхгүй юм байна. Ийм асуудал бас яригдаж байгаа юм уу? Тийм тохиолдол байж болно л доо. Эртээд олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр ард түмэнд хандаж хэлсэн үгэндээ Ерөнхий сайд тийм юм яриагүй. Тэр хүн бол, “бид ийм, ийм юм хийлээ. Цаашдаа ийм, ийм юм хийх гэж байна” гэж л хэлсэн. Энэ бүхнийг авч хэлэлцдэг газар нь УИХ. УИХ маань асуудлыг бодитой, улс төрийн өнгө нь давамгайлалгүй шийдэх учиртай. УИХ дээр ганцхан өнгө давамгайлах ёстой. Тэр нь “ард түмний эрх ашиг” гэж цагаан дээр хараар бичсэн тийм л үг үйлчлэх ёстой. Тэр талаас нь бодож л асуудлаа ярих байлгүй дээ.

**- Ерөнхийдөө та Н.Алтанхуяг цаашаа явсан нь дээр гэж үзэж байгаа юу?**

**С.Дэмбэрэл:** Би бол Засаг тогтвортой байх нь дээр гэж үзэж байгаа. Яагаад гэдгээ маш энгийнээр хэллээ. Өнөөдөр Н.Алтанхуяг байгаа учраас миний амьдрал сайжирлаа, миний амьдрал муудлаа гэхээсээ илүү:

1. Би амьдралаа өөрөө цаашаа аваад явахад надад садаа болохгүй, улс төрийн, эдийн засгийн, хүний эрхийн, нийгмийн орчин бий болоосой” л гэж бодож байна.

2. Зах зээлд юмны үнэ тогтвортой байгаасай л гэж би бодож байна. Түүний дотор талхны үнэ, нүүрсний үнэ, бензиний үнэ, валютын үнэ энэ бүхэн тогтвортой байгаад байвал, дээр нь би том жижиг ямар ч бизнес эрхэлсэн намайг банкнаас зээл авахад санхүүгийн тогтвортой, таатай орчин бүрдээсэй л гэж хүсч байна.

3. Ямар нэгэн бизнес эрхлэх, ТҮЦ ажиллуулъя гэдэг юм уу, эсвэл том бүтээн байгуулалт хийе гэхэд адилхан л хөрөнгө оруулалт хэрэгтэй. Энэ бүхэнд зээл амархан олдоосой гэж л ард иргэд хүсэж байгаа.

Энэ бол ард түмний л хүсэж байгаа зүйлс. Үүнийг хэн бүрдүүлж чадаж байна? Энэ засгийн газар бүрдүүлж чадаж байна уу? Дараагийн гарах ээлж чадах юм уу? энэ мэтийн үнэмшил хүмүүст байгаа цагт олон нийт бол энэ засгийн газар сайн байна эсвэл муу байна гэсэн дүнгээ тавьдаг. Улс төрчид зөвхөн өөрийнхөө тархинд байгаа, эсвэл өөрийнхөө хэсэг хүмүүстэй ярилцсан, эсвэл фракц хоорондын зөрчилдөөнөөс болж үүссэн, өөрсдийнхөө хүмүүсийг үнэлэх тэр системээр яваад байвал буруудна. Аливаа үнэлгээний системд олон нийтийн санал бодол хамгийн номер нэг асуудал байх ёстой.

*Сурвалжлагч: Алтаншагай.*

## Гэмт хэргийн тухай болон холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцэх үеэр

**С.Дэмбэрэл:** Хоёр суурь асуудал байна.

1. Монгол улсад хуулийн засаглалын хомсдол үүссэн байна.
2. Эдийн засгийн эдийн засаглалын илүүдэл үүсчээ. Яг ийм тохиолдолд их чухал хууль орж ирж байна аа. Үүнтэй холбогдуулаад надад хэд хэдэн асуух асуулт байна.

*Нэг дэх нь,* суурин асуулт. Монгол улс өнөөдөр хуулийн засаглал буюу хуулиар түрүү барьдаг буюу хуулийн хүмүүсийн засаглал болоод хувирчихсан байна. Энэ өөрчлөгдөх үү? Үүнтэй холбогдуулаад өнөөдөр Монгол улсад хүний эрх, эрх чөлөөний асуудал ноцтойгоор тавигдаад энэ чиглэлээр хэд хэдэн нийгмийг донслогосон тохиолдол гарч буй яг энэ үед энэ хууль орж ирж байна. Энэ хууль гарснаар хуулийг гажуудалсан тохиолдлууд алга болох уу?

*Хоёрдугаарт,* өнөөдөр хувь хүний хувийн өмч, хувийн нууцлал руу шууд болон шууд бусаар халдсан тохиолдлууд маш их гарч байна. Бүр тодруулж хэлбэл хувь хүний данс руу халдах. Хүмүүсийн банканд итгэх итгэл, тэр битгий хэл эх орондоо итгэх итгэлийг багасгасан, үүнээс улбаалаад хувь хүн хөрөнгөө нуухад хүргэсэн ийм тохиолдолд бий болсон байна. Энэ хууль гарснаар энэ байдал засрах уу? Өөрөөр хэлбэл хувь хүний өмчийн эрхийг сайн хамгаалж өгсөн үү?

*Гуравдугаарт,* өнөөдөр манай хууль тогтоох практикт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг ямар ч хяналтгүйгээр дураараа хэрэглэж байна. Жишээ болгож хэлэхэд хамгийн сүүлд орж ирсэн нэг хуулинд 25 шийтгэл, зөрчил гэж үзээд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хэд дахин нэмэгдүүлнэ гэсэн байсан. Үүнийг болих уу? Энэ дэлхийн ямар улсад байдаг практик вэ? Үүнд тодорхой хариулт өгөөч.

*Дөрөвдүгээрт,* өнөөдөр хууль хийж байгаа процессыг харахад бусад нөхцлүүд нь ижил тэнцүү байх үед гэсэн байдлаар оруулж ирээд тэр нь бодит амьдрал дээр маш их зөрчилтэй гардаг гэх мэт зүйлсээс хэр зэрэг зайлсхийж чадсан бэ? Хүмүүсийн саналыг хэр зэрэг сайн авсан бэ?

*Тавдугаарт,* хуулийн этгээдийн хариуцлага хүлээх зүйлүүдийг энэ хуульд ямар байдлаар шинэчилж, ямар байдлаар хязгаарлаж оруулж ирсэн бэ гэдэг дээр товчхон хариулт хүсч байна.

**Х.Тэмүүжин:** Монгол улсад хуулийн хэрэгжилт ямар хэмжээнд байна вэ гэдэг дээр бид мөн адил хангалттай дүн тавьж чадахгүй ээ. Учир нь хуулийн засаглал бүхий улс оронд гарах ёсгүй, хэрвээ гарвал бараг цочирдож хүлээж авахуйц тийм хэмжээний тохиолдол, үзэгдэл манай улсад цөөнгүй гарч байгаа гэдгийг би хүлээн зөвшөөрч байна. Өөрөөр хэлбэл хууль засаглал биш, хуулийн нэр бариад хуулийн ажил хийж байна гэсэн нэрийн дор хувийн өс хонзон, шунал эсвэл хувийн зан аашаа хэрэгжүүлж байгаа тийм тохиолдолууд бас цөөнгүй байгаа нь нууц биш ээ. Энэ байдал маань юутай холбоотой вэ гэхлээр, гурван үндсэн шалтгаантай байгаа байх гэж бодож байна.

1. Хууль сахиулах байгууллагад ажиллаж байгаа боловсон хүчнийг бэлтгэх тогтолцоо, сургалтын арга барилтай холбоотой байх,
2. Өөрчлөгдөөгүй хуулийн практикаас их шатгаалж байгаа,
3. Практикаа өөрчилж чадахгүй байгаа хуулиас бас маш их шалтгаалж байна гэж үзэж байна.

Одоо оруулж ирж байгаа Гэмт хэргийн зөрчлийн хуулийг яагаад нэг багц болгож оруулж ирж байгаа вэ гэвэл хуучин Захиргааны хариуцлагын тухай хууль, Эрүүгийн хууль хоёр маань нэг үзэгдлийг адилхан бүрэлдэхүүнтэйгээр хоёр хуулинд хоёр өөр хариуцлагатай бичээд түүнийг нь хууль сахиулагч болон хуулийн байгууллагын ажилтанууд хоёр өөр хариуцлагатай нэг адилхан зүйл заалтуудыг барьчихаад өөртөө таалагдсан хүндээ хөнгөнөөр нь өөртөө таалагдаагүй хүндээ хатуугаар нь хариуцлага тооцох боломжийг олгосон байсан. Энэ боломж нь хуулийн засаглал тогтоох биш дур зоргоороо авирлах албан тушаалтны авир бий болох орон зайг нээгээд өгсөн учраас энэ нь хүний засаглал болох аюул байсан. Үүнийг л засахын тулд энэ хуулийг зэрэг оруулж ирж байгаа, хооронд нь ялгаа, зөрөөгүй болгож өгч байгаа юм шүү.

Хувийн өмч болон дансны нууцлалтай холбоотой асуудал бол яах аргагүй асуудал үүсгээд байгаа нь үнэн. Данстай холбоотой асуудлыг шууд хууль сахиулах байгууллага нь оролцохгүйгээр Монголбанк өөрөө хэлэлцдэг байдлаар хийсэн. Гэхдээ хуулийн байгууллагууд тийшээ хандах хүсэлт гаргах, зөвшөөрөл хүсэх процессыг нь Байцаан шийтгэх хуулиар шийдэж өгөхгүй бол дур дураараа очоод байгаа. Энэ асуудлыг зөвхөн шүүхийн шийдвэрээр явдаг болгож хувиргах ёстой. Ингэж байж бид хувь хүний дансруу халдаж байгаа байдлыг таслан зогсоож чадна.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр шалгуур болгоод торгууль ч юм уу арга хэмжээ авахдаа хэрэглээд байгаагийн хувьд гэвэл Гэмт хэргийн хуулинд Монгол банкнаас тогтоодог тооцооны нэгжээр торгуулийг шийддэг тогтолцоо оруулж ирж байгаа.

*2014 оны 10-р сарын 06.*

## **Хэдэн яамтай байх нь чухал биш**

*2014 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээс. Хэлэлцсэн асуудал:*

*Монгол Улсын засгийн газрын бүтцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол улсын засгийн газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, төрийн захиргааны байгууллагын тогтолцоо бүтцийн ерөнхий бүдцүвч батлах тухай, УИХ-ын 2014 оны 14 дүгээр хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл*

С.Дэмбэрэл: За баярлалаа. Яг үнэнийг хэлэхэд, оруулж ирж байгаа асуудлыг дэмжиж байна. Зүгээр л автоматический дэмжнэ. Яагаад гэвэл, асуудал нь өөрөө ач холбогдолгүй асуудал. Ерөнхий сайд бүлгүүд дээр очоод, асуултанд нь хариулаад байх шиг байна. Тэнд юу ярьсан агуулгыг

нь эс тооцоод, нэг ч сайд байхгүйгээр, одоогийн байгаа бүтцийг харахад ямар ч гэм байхгүй. Өнөөдөр юу ярих ёстой юм вэ гэхлээр, төрийн зохицуулалт ба зах зээлийн хоорондын харьцааг л ярих ёстой. Цаад мөн чанар нь энэ. Аливаа нам улс төрийн сонгуульд ороод, тухайн дөрвөн жилд энэ улс орныг авч явахдаа төрийн зохицуулалт нь ямар хэмжээнд байх юм, ямар институциер дамжуулж хэрэгжүүлэх юм бэ, зах зээлтэй яаж харьцах юм гэсэн энэ харьцааг хэрхэн гаргасанаас л төр нь данхайдаг уу, занхайдаг уу, эсвэл ухаалаг болдог уу гэдэг нь тодорхойлогдож байдаг. Өнөөдрийн хуралдаанд хамгийн чухал асуудал бол Монгол Улсын хувьд одоогийн засгийн газрын хийж байгаа реформ буюу хүнд сурталыг халах зорилгоор хийгдээд байгаа, УИХ-ын таван гишүүн оролцож, ажлын хэсэгт нь бүтэн жил ажилласан тэр том реформуудын үр дүнгүүд болон цаашдын үр нөлөө нь хэдэн сарын дараа гарах юм бэ гэсэн асуудлыг хэлэлцвэл энэ нь тэдэн яамтай байна, тэр 2-ыг нийлүүлнэ, ингэчихвэл болох гээд байгаа гэсэн өнгөц юмнаас хамаагүй илүү ач холбогдолтой байхаар байна. Саяхан, хяналтын тоо 8 дахин багассан гэсэн мэдээ гарсан. Тэр бол үнэн. Тусгай зөвшөөрөл, лицензүүдийн тоо хэд болох юм? Энэ бүхнийг хийсний дараа одоогийн байгаа яамдуудын бүтэц болоод л явчихна. Эцсийн дүнд хэдэн яамтай байх нь чухал биш. Төр зах зээлтэй харьцахдаа, хамгийн шуурхай, үр дүнтэй үйлчилгээг үзүүлж чадаж байна уу, үгүй юу гэдгээс л бүтцийн асуудал хамаарах учиртай. Тэр нь тусгай зөвшөөрөл, лиценз, зах зээлтэй харьцах төрийн бодлого зэрэг хэрэгслээр дамжиж явна. Нэгдүгээрх суурь асуулт нь энэ.

Хоёрдугаар суурь асуулт: Хэрэв нэгэнд энэ засаглалын бүтцийг ярьж гэвэл, 1997 оноос эхэлж ярих ёстой. 2014 он хүртэл явагдаж ирсэн засаглалын загвар нь болохоор Яам - Тохируулагч агентлаг - Хэрэгжүүлэгч агентлаг гэсэн бүтэц байсан. Энэ бүтэц Монгол улсад нутагшиж чадсан уу гэсэн суурь асуултыг асуух ёстой. Ингэж ярьвал нэг хэрэг. Гэхдээ энийг хөндөхгүй юм байна гэдэг нь харагдаж байна. Тэгвэл эндээс дараагийн асуудал гарч ирж байна.

Гуравдугаар асуулт: Улаанбаатар хотын засаг Монгол улсын засаглалын одоогийн схемтэй нийцэж чадаж байгаа юу гэдэг асуулттай хамт орж ирэхгүй бол, Улаанбаатар хотын дүүргүүдийн бүтэц маш занхар том болчихсон байна. Энэ бүхэн энд хамрагдахгүй бол үр дүн нь гарахгүй. Эдийн засгийн хөгжлийн яам Сангийн яамыг нийлүүлж салгаад, /хүн болгон янз янзын юм ярьдаг л байх л даа.../ ямарч ач холбогдол байхгүй. Үнэнийг хэлэхэд. Одоо жишээлбэл, Мөнгөний бодлого ороод ирсэн байгаа. Төсвийн бодлого мөн ороод ирсэн байгаа. Гэтэл асуусан чинь 24 жилийн турш энэ 2 нь хоорондоо огт координац байдаггүй явж ирсэн байна. Өөрөөр хэлбэл, мөнгөний бодлогыг засгийн газар луу хүргүүлдэг, Засгийн газар тэгсхийгээд формальдаад, “2 өгүүлбэртэй юм” явуулдаг, харин төсвийн бодлогыг Төв банк руу огт хүргүүлдэггүй юм байна. Ийм координацигүй цагт ямар ч бүтэцтэй байсан макро эдийн засгийн хоорондын зохицолдоо байхгүй л байх болно. Хамгийн сүүлд нь, одоо ирж байгаа сарууд эдийн засгийн хувьд их хүнд сарууд болно. Энэ тохиолдолд гол аргумент нь орон тоо хэмнэх гэж байна гэсэн тийм юм байна л даа. Орон тоо хэмнэх гэхээсээ илүү, одоо байгаа бүтэц чиг үүргийнхаа хүрээнд үйл ажиллагаагаа



уялдуулаад, санхүүгийнхаа бүх нөөцийг хувийн хэвшил руу шилжүүлэх ийм л гол зүйл байгаа. Үүнийг номер нэг асуудал гэж үзээд эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах талаас нь аваад үзэх юм бол өнөөдөр энэ оруулж ирж байгаа асуудлыг би сайн дурын шинж чанараар, реформын дагалдах хэрэгсэл гэж үзэж дэмжих болно.

## **С.Дэмбэрэл гишүүний Засгийн бүтцийн талаар ТБХ хурал дээр хэлсэн үг, асуулт, санал**

*2014 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээс: Монгол Улсын Засгийн газрын бүтэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төсөл, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо бүтэцийн ерөнхий бүдцвч батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2014 оны 14 дүгээр хавсралтад өөрчлөлт оруулах” тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг дээр.*

**С.Дэмбэрэл:** Ерөнхий сайд 2012-2014 он хүртэл ийм бүтцээр ажиллалаа. Одоо 2014-2016 он хүртэл ийм бүтцээр ажилламаар байна гэж оруулж иржээ. Ерөнхий бүтэц нь Ерөнхий сайдын бүрэн эрхэд хамаарч байгаа, тийм учраас энэ бүтцийг дэмжинэ.

Асуух асуулт маань яамдуудыг ингэж нэгтгэсэнээр 2014 онд эхэлсэн “Төрийн хүнд суртлыг багасгах, тусгай зөвшөөрөл лицензийг багасгах”-д хэр зэрэг эерэг үр нөлөө үзүүлсэн бэ? Тоогоор тодруулах арга байна уу? гэсэн нэгдүгээр асуулт байна. Ингэж ийм бүтэцтэй ажилласанаар цаашдаа Засгийн газрын яамдын болон агентлагуудын олон нийт, сэтгүүлчдэд зориулсан ил тод байдлыг хэрхэн яаж хангах төлөвлөгөөтэй байгаа вэ? гэсэн хоёр дахь асуулт байна. За баярлалаа.

**Н.Алтанхуяг:** Тоо байна уу? Хэлж чадах уу? Би шууд тоогоор хариулж чадахгүй юм шиг байна.

**Хууль эрх зүйн хэлтсийн дарга Энхтуяа:** Ерөнхий сайдын болон Ч.Сайханбилэг сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа төрөөс олгож байгаа лиценз, тусгай зөвшөөрөлийн тоог бууруулах ажилд бүтэн нэг жил зургаан сар судалгаа хийсэн. Энэ ажлын хугацаанд нийт 1164 тоон зөвшөөрлийг хоёр удаагийн ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцээд, “Зөвшөөрөлийн болон зөвшөөрлийн жагсаалтын” тухай хуулийг УИХ-д өргөн барьсан. Зөвшөөрлийн жагсаалтын дүгнэлтэд нийт 392 зөвшөөрлийг хуульчилъя” гэсэн тоо байна. 1164-өөс 300 нь л албан ёсоор үлдэнэ гэсэн үг...

41 мин: **А.Бакей:** С.Дэмбэрэл, А.Бакей, Батцогт нарын гишүүд гаргасан нэг санал байна. Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “геологи, уул уурхай, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээн дэх хүнд үйлдвэрийн бодлогын асуудал” гэж нэмэх, үүнтэй холбогдуулан хуулийн төсөлд хуулийн 20 дугаар зүйлийн 5

дугаар хэсгийн 13 дахь заалтын Үйлдвэр Хөдөө Аж Ахуйн сайдын эрхлэх асуудлын хүрээний “хүнд болон хөнгөн үйлдвэрийн бодлогын асуудал” гэснийг “хөнгөн үйлдвэрийн бодлогын асуудал” гэж өөрчлөх. Үндсэндээ хүнд үйлдвэр бол Үйлдвэр Хөдөө Аж Ахуйн яамнаас Уул уурхай, Эрчим хүчний яам руу шилжиж байна гэсэн үг.

**- Яагаад шилжүүлж байгаа юм бэ? үндэслэл нь юу вэ? Аж үйлдвэрийн цогцолбор дээр яах вэ?**

**С.Дэмбэрэл:** Аж үйлдвэрийн ямар нэгэн цогцолбор бий боллоо гэхэд холбогдох яамдууд нь өөр өөрийнхөө эрхэлсэн ажил чиг үүргийн хүрээнд бодлогоо хэрэгжүүлээд л явна. Ер нь Монгол Улсын өнөөдрийн хүнд үйлдвэрийн байдал, хөгжиж байгаа байдал нь хэтийн төлөвлөгөөг харахад, уул уурхай, дэд бүтэц тал руугаа явуулна гээд энэ рүүгээ харъяалуулсан байна. Цаашид явах хүнд үйлдвэржилтийн бодитой тал руу нь дөхүүлэх гэсэн утгаар л орж байгаа юм. шинээр бий болох олон хүнд үйлдвэрүүдийг Үйлдвэр, Хөдөө Аж Ахуйн яамд харъяалуулж, уул уурхайтай холбоотой, эрчим хүчтэй холбоотой, геологитой холбоотой олон асуудлуудыг нь мэргэжилтэн байхгүй ийм яам руу өгчихөөр тасалдал үүсэх, координаци алдагдах явдал гарна байх гэж ярилцаад, тэр утгаар нь л шилжүүлбэ гэж оруулж байгаа юм.

**А.Бакей:** Санал хураалт явуулна. 16-15 энэ санал дэмжигдлээ...

1:07:40 мин **А.Бакей:** С.Дэмбэрэл, Су.Батболд нарын гишүүдээс тогтоолын төсөлд 4 дэхь заалт нэмэх санал ирүүлжээ. Энд “Ерөнхий сайдад 2015 оны эхний хагас жилд багтааж, мэдээллийн ил тод байдлын түвшинг 80% хүргэх” гэсэн байна. Үүнийгээ тайлбарлана уу.

**С.Дэмбэрэл:** Су.Батболд гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны чиг үүрэгт байдаг төрийн байгууллагуудыг зөвхөн тоон утгаар нь биш чанарын талаас нь сайжруулах, сайн засаглал гэсэн утгаар нь асуулга тавиад, тэрний дагуу засгийн газрын мэдээлэл харилцаа холбооны газрын дарга Жадамбаагийн гарын үсэгтэй засгийн газрын бүх яамдуудыг мэдээлэл ил тод байдлаар нь эрэмбэлээд, /агентлагуудын оруулаад/ их чухал мэдээлэл өгсөн байна. Өнөөдрийн бидний ярьж байгаа асуудал болох хичнээн яамтай байх вэ, алийн ингэх вэ гэсэн тоон утгын биш доторх сайн засаглалын гол шинж болсон мэдээлэлийн ил тод нээлттэй засаглалын түвшинг нь гаргаад ирүүлсэн байна. Тэрнээс харахад түвшин нь их доогуур байсан, үүнийг Жадамбаагийн газраас гаргасан байна. Энэ цаашдаа Ерөнхий сайдад их чухал асуудал учраас ингээд оруулчихвал яасан юм бэ? Одоо хэдийгээр нээлттэй байгаа ч гэсэн нээлттэй байдлын түвшин нь 30% байгаа, тэрнээс ч илүү дээшлүүлээд 80% болгочихвол яасан юм бэ гэсэн зүйлийг хэлчихвэл, бидний өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудал зөвхөн тоон утгаараа биш, агуулга талаасаа, чанар талаасаа их ач холбогдолтой болно. Тийм учраас байнгын хорооноос гарах тогтоол олонд нийцтэй, хүртээмжтэй, хүмүүст ойлгомжтой болох болов уу гэж бодоод Су.Батболд гишүүний саналыг дэмжээд бид 2 оруулж байгаа юм.

## Татаас өгч л байгаа бол хэн ч хохирох ёсгүй

*2014 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн Байгаль орчин хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээс: Намрын ургац хураалтын явц болон 2013-2014 оны талаар өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар Үйлдвэр хөдөө аж ахуйн яамны мэдээлэл сонсох цеэр*

С.Дэмбэрэл: Надад хэдэн асуулт байна. *Нэгдүгээрт*, газар тариалангийн салбар бол татаас дээр байдаг салбар. Нийт татаас нь 2013 оны байдлаар хэд байдаг юм бэ? Мөн 2013 оны байдлаар энэ салбарт үйлдвэрлэгдсэн цэвэр өртөг /value added/ нь хэд юм? Тэрний тооцоо байдаг уу? Яг энэ салбарын 2013 оны байдлаар завсрын бүтээгдэхүүний материалын зардал нь нийлээд хэд байдаг юм бэ? Энэ тоо байгаа бол байна гэдгээ хэлчих, байхгүй бол би өөрөө олоод авчихна. Нэгдүгээр асуулт.

*Хоёрдугаарт*. Яагаад би зардлаас нь эхэлж байна вэ гэхлээр, хүнд хэцүү байгаль цаг уурын нөхцөлтэй Монгол Улсад хүнсний аюулгүй байдлаа бодоод, хүн амаа бодоод, энэ улс ард иргэдээ өөрийнхөө үйлдвэрлэлээр хангах нь зөв гэсэн стратегийн шийдэл гаргасан байна. Стратегийн шийдэл гаргах гээд манайхан үүнийг бүүр дээд түвшинд нь тултал хүргэчихсэн юм байна. Хүнсний аюулгүй байдлын хэмжээнд үзэх болтлоо өргөчихөж. Гэхдээ байдал нь тэгтлээ хурцадсан эсэхийг би сайн мэдэхгүй байна. Ямартай ч, Монгол Улсын Ерөнхийлөгч газар тариалангийн салбараар яваад үүрэг даалгавар өгчихсөн байна. Хүнсний аюулгүй байдлын зөвлөл байдаг юм байна. Ерөнхий сайд нь толгойлдог юм байна. Энэ салбар өөрөө Үндэсний аюулгүй байдлын хүнсний аюулгүй байдлын компонентийн гол хэсэг болсон байна. Ийм болчихсон салбар юм уу? Эсвэл төөрөгдөл байна уу? Бид нарын эх оронч хөөрөгдөл байна уу? Бодитой байдал нь энэ мөн үү гэсэн завсрын түргэвчилсэн асуулт байна. Мэргэжлийн хүмүүс та бүхэн тийм, үгүй гэсэн үгээр хариулах бүрэн боломжтой гэж бодож байна.

*Гуравдугаарт*. Нэгэнд бид стратегийн хүнс гэж үзээд, үндэснийхээ үйлдвэрлэлээр хангах зорилт тавьчихсан юм бол асуудлын гол нь тэр үндэсний үйлдвэрлэлүүдийн бодитой зардал нь гарчихсан байгаа байх. Тэгээд бид ийм үнээр зарна гэсэн саналаа хэлсэн байгаа байх. Тэр үнээр нь төр авч байгаа бол, одоо тэрийг авчихад яг юу саад болоод байна? Яагаад, юу саад болоод байгааг би өөрөө бас сайн мэдэж байна. Өөрөөр хэлбэл, Төрийн бодлого чинь зөвхөн үндэсний үйлдвэрлэгч, импортлогч хоёртой харьцаад, хэрэглэгч тал дээр буюу эрэлт тал дээр ямар бодлого барьж байгаа нь мэдэгдэхгүй байна. Үр тарианы салбар, улаан буудайны салбарын үйлдвэрлэлээс авахуулаад, эцсийн хэрэглэгчдэд очих хүртэлх нийлүүлэлтийн хэлхээнд төрийн иж бүрэн бодлого нь буюу механизм нь байхгүй байна. Хэрэглэгчдэд татаас өгдөг юм уу, хэрэглэгчдэд өгсөн татаасны хэмжээгээр яаж үүнийг баланслах юм бэ гэх зэрэг энэ бүх механизм байхгүй учраас ийм болоод байна. Өөрөөр хэлбэл, одоогийн үйлчилж байгаа механизм чинь үйлдвэрлэгч, төр, хүнсний улаан буудай импортлогч нарын хоорондын зөрчлийг төрүүлэх тэр механизм нь болоод

байгаа биш үү? Яагаад бид ингэж хуралдаад байгаа юм бэ гэхлээр шийдлийг нь хэлэх учиртай юм. Шийдэлд нь хэн ч хохирох ёсгүй. "Газар тариалан эрхлэгчдийн холбоо" нь энд ирчихээд, "төр ингээд байна, бид ингэсэн" гэж ярих биш, угаасаа механизм нь зүгширчихээгүй байна гэсэн гол асуудал байгаа юм. Түүрүүн танай яамныхан, "Бид *инфиляцид* нөлөөлмөөргүй байна" гэж гол зорилгоо хэллээ. *Инфиляцид* нөлөөлмөөргүй байгаа бол ингэж ганц талын харилцаагаар биш, бүх оролцогчдын дундаас шийдэл олох боломж бас харагдаад байна. Нэгэнт энэ салбарт татаас өгч байгаа бол хэн ч хохирох ёсгүй. Ганцхан төр өөртөө аваад үлддэг механизм дэлхий даяар байгаа. Дэлхийн бусад улс орнуудад ч бас татаастай салбар байгаа, гэхдээ ингэж хэрэлддэггүй, хэрэлдэхгүйгээр шийдэж болдог. Ингэхийн тулд итгэлцэл гэдэг хамгийн энгийн үгнээс эхэлдэг. Тэр нь бүрэн тэгш эрхтэй талуудын оролцоо бүрэн хангасан, ургац хураалтын үед...

**Төрийн нарийн бичгийн дарга Золжаргал:** 2013 онд 25 тэрбум төгрөгний татаас өгсөн. Гэхдээ 25 тэрбум төгрөгний татаас бол тариаланчдад хүнсний улаан буудайн гурилын үйлдвэрүүд болон тариалан эрхэлдэг дэмжих сандаа ирүүлсэн улаан буудайны тоон тутамд өгсөн урамшуулал байгаа. Өөр хэлбэрийн татаас байхгүй. Танд хариулт болгох Нэмэгдсэн өртөгийн сүлжээ, өртөг нэмсэн судалгаа одоохондоо гаргаагүй. Үйлдвэр хөдөө аж ахуйн төрөөс баримтлах бодлогын болон өртөгийн судалгааг хийж байгаа. Стратегийн хүнс гээд төр өөрөө худалдан авалт хийхэд юу саад болж байна вэ? гэж байна.

1. Төрд худалдан авах санхүүгийн эх үүсвэр байхгүй

2. Бүгдийн худалдан авья гэсэн зорилго тавьж ажиллаагүй.

- Хэрэглэгчдэд татаас өгдөг үү? гэж байна. Хэрэглэгчдэд татаас өгөхгүй.

Бүгдээрэнд нь татаас өгвөл яасан вэ? гэж байна. Үйлдвэр Хөдөө Аж Ахуйн сайдны багц мөнгөний урсгал зардал нь ойролцоогоор 117-120 тэрбум төгрөг байгаа. Үүний 80 гаруй тэрбум нь дандаа урамшуулал.

1. Улаан буудайны урамшуулал

2. Нөөцийн махны урамшуулал

3. Ноосны урамшуулал

4. Арьс ширний урамшуулал гэсэн 4 том урамшуулал байгаа. Өнөөдрийн улсын төсвийн ачааллаар энэнээс илүү эх үүсвэр гаргаж, урамшуулалын бодлого явуулах улсын төсвийн чадвар даахгүй байгаа. Бидэнд баталж өгсөн төсөв нь энэ.

### **30 хоногийн дотор асуудлыг шийдэх ёстой**

**2014 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн Байгаль орчин хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээс: Намрын ургац хураалтын явцын талаар мэдээлэл сонсох цээр:**

С.Дэмбэрэл: Ургацын баланс гэж ярих их дуртай юм байна. Ургацын балансгаас гадна хүн хоорондын харилцааны баланс алдагджээ. Эцсийн эцэст, үйлдвэрлэгчид, төр, импортлогчид хоорондын хэвийн харилцаанд

бүгдээрээ л хожиж байх ёстой. Энэ харилцаа байхгүй байна. Хамгийн түрүүнд хийх зүйл бол, энэ харилцааг л бий болгох ёстой. Өөрөөр хэлбэл нэгэн нь диктаваа алдаг, нөгөөх нь хүлээн авдаг ийм харьцаа байж болохгүй. Нэгдүгээрт.

2. Хэрэв тэр 550 гэдэг зүйл нь бодит зардалтай таарахгүй, үйлдвэрлэл явуулж байгаа газар тариалангийн компаниудын бодит зардал, хэвийн ашгаас нь үүнийг хангаж чадахгүй байгаа бол энийгээ болих хэрэгтэй. Яг ямар бодит зардалтай юм бэ, тэрэн дээр нь тулгуурласан үнээр нь төр авч байгаа л юм бол тэрүүгээрээ төр авах ёстой.

3. Нэгэнт төр байгаад, дээр нь төр улаан буудай үйлдвэрлэгч хоёрын хоорондын харьцаа үүсчихээд байхад, ийм зөрчил гарсан бол стратегийн бүтээгдэхүүний нийт нийлүүлэлтийн гинжин хэлхээг бүгдийг нь хамарсан механизм байхгүй байна л гэсэн үг. Тийм учраас УИХ-аас газар тариалангийн практик мэддэг, эдийн засгийг гадарладаг, улс орнуудын энэ чиглэлийн туршлагыг мэддэг гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг, мөн газар тариаланчдын төлөөлөл, төрийн яамны төлөөлөл бусад инфортлогчид, хэрэглэгчдийн төлөөллийг агуулсан дэд хэсэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж 30 хоногийн дотор энэ асуудлыг шийдэх ёстой. Цаашдаа яах вэ гэдгээ шийдэх ёстой. Стратеги гэдэг маань энэ шүү дээ. Эцсийн эцэст 3 сая хэрэглэгчийг боломжийн үнэтэй гурил идүүлэхийн төлөө нэг хэсэг хүнийг хохироох төрийн бодлого байж болохгүй. Үүнийг шийддэг арга олон байна. Хамгийн сүүлийн үеийн судалгааг харж байх хэрэгтэй. Хэрэглэгчидтэй ажиллах ёстой. Танай яамны чиг үүрэгт энэ байхгүй юм шиг байна. Хэрэглэгчидтэй ажиллах татаасыг яах вэ, газар тариаланчдыг татварын бодлогоор яаж дэмжих вэ гэсэн энэ бүхнийг иж бүрэн оруулж ирэх хэрэгтэй. Одоо маргааны шийдэл бол яг бодит зардал нь хэд гарсан бэ, түүгээр нь л авах ёстой. Гурилын үйлдвэрүүдэд үндэсний үйлдвэрлэгчдийн ургуулсан улаан буудайгаар гурил хийх сонирхлын механизм нь хаана байна? Тэрний дараа, зах зээлд зарах үед, хэрэглэгчид худалдан авах ямар татаас байх юм бэ? сонирхлын механизм нь юу байх юм бэ? Энэ бүх талаас нь бодож юм ёстой. Тэгэхгүй бол зөрчил арилахгүй. Тийм учраас миний байр суурь нэгэнт стратеги нь гарчихсан юм бол үүнийгээ л хурдхан хийгээд явсан нь дээр. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт. Махны талаар дахиад нэг юм хэлбэ. “Нөөцний мах” гэдгээ одоо боль. Хамгийн сүүлийн үеийн судалгаагаар Монгол Улсын Улаанбаатар хотод нийлүүлж байгаа нийт махны 43% -ыг Монгол Улсын малчин өрхийн 13% -ийг эзэлж байгаа хүмүүс өрхүүд нийлүүлж байгаа. Үлдсэн 44% -ийг Монгол Улсын 500 хүртлэх толгой малтай малчид, өрхүүд нийлүүлж байгаа. Энэ 2 тоог хараад үзэхээр махны зах зээлд мах нөөцлөх шаардлага байна уу? гэсэн асуудал байна. Тэрний оронд махны үнийг чөлөөтэй тавь. Зах зээлд үнийг чөлөөтэй өгсөн үед л асуудал зөвөөр шийдэгдэж байдаг. Мэдээж, стратегийн бүтээгдэхүүний салбараараа энд орох нь зөв. Гэхдээ зөв цагт нь, зөв үед нь, зөв арга хэрэгсэлээр л орох шаардлагатай. Гэхдээ бид зөв цагт нь орохгүй байна, зөв арга хэрэгсэлээр орохгүй байна, зөв бодлого гаргаж өгөхгүй байна гэсэн үг. Энд яам анхаарал хандуулах ёстой. Хүн амьтанд хариуцлага тооцно гэхээсээ илүү, нэг сарын дотор ажлын хэсэг байгуулаад тодорхой даалгавар өгье. Гишүүд энэ асуудлыг шийд.

## **Хөрөнгө оруулалтын болон хэрэгжих хугацаа зэргийг тооцоолж чамбай боловсруулж оруулж ир**

*2014 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн Нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс. Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг /хэлэлцэх эсэх/*

**С.Дэмбэрэл:** Хэдийгээр энэ асуудалд шууд хамааралтай биш ч гэсэн гишүүдийн асуусан асуултанд А.Гансүх сайд “бүгдийг нь дэмжиж байна” гэсэн хариулт өглөө. Гэхдээ энд нэг яам асуудлыг оруулж ирж байгаа биш, асуудлыг Засгийн газар оруулж ирж байгаа. Өмнө нь Ч.Улаан сайд нэг асуудал оруулж ирээд, буцаан татаж авсан. Яагаад гэвэл, Засгийн газрын яамдууд нь хоорондоо уялдаагүй, мөн холбогдох байгууллагуудын саналын бүрэн авч, нэгдсэн нэг бодлого гаргаж ирж чадаагүй учраас, гишүүдийн асуусан асуултанд энэ нь илрээд буцаагаад авсан шүү дээ. Одоо яг ийм юм болж байна. Хэдийгээр гишүүдийн зүгээс Гаалийн түр хугацааны журмаас хальсан асуултууд тавьж байгаа ч гэсэн эдгээр нь амьдрал дээр байдаг асуудал. Одоо манай улс Дэлхийн банкны ангилалаар дундаас доош орлоготой орны ангилалд орчихсон, дотоод, гадаадын шууд хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлээд, түүнийг хэрэгжүүлэх олон хэлбэрүүд, түүн дотроо “Төр, Хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиа” батлаад, энэнийгээ урамшуулах, дээр нь Монгол Улсын хөрөнгө оруулалтыг урагшлуулахын тулд “Хөрөнгө оруулалтын тухай хуулиа” батлаад, энэ дотроо хөрөнгө оруулалттай холбоотой, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалттай холбоотой хөшүүргүүдийг суулгаж өгсөн. Энэ хоёр хууль болон хугацааг төсвийн талаас нь хараад хоёр жил гэж хэлэх, хуулийн талаас нь хараад гэрээний хугацаа гэж томъёолдог. Хөрөнгө оруулалтын үргэлжлэх циклийн хугацааг гадаад зээл тусламжийн хүрээнд “grace period” буюу “хөнгөлөлтийн хугацаа”-г уялдуулж тавьдаг болохоос биш, нэг нь хоёр жилийн хугацаа гээд, нөгөөх нь гэрээний хугацаа гээд Сангийн яам болон бодит секторыг төлөөлсөн яам хоёрын хооронд нь өөр өөр саналтай байна. Энэ нь энд орж ирээд, УИХ-ын гишүүд бодит амьдралд гардаг асуудлуудыг тавихаар илэрч гарч ирээд байна. Энийг төдий л чамбай биш боловсруулжээ, А.Гансүх сайдаа. Ч.Улаан сайд бол шууд татаад авчихсан. Хууль эрх зүйн боломж байдаг юм байна. Миний бодлоор гишүүдийн саналыг тусгаад, хугацааны хувьд гэрээний болон хоёрын жилийн хугацааг бодолгүйгээр, хөрөнгө оруулалтын хугацаа, хэрэгжих хугацаа энэ бүхнийг бодолцоод дахиад чамбай боловсруулж оруулж ирвэл яасан юм бэ гэсэн асуулт, саналыг зэрэг тавьж байна.



## **Хувьцаанаас үүдэн хамгийн муу компанийн засаглал бий болно гэдгийг баттай хэлье**

*SHUUD.MN-ийн сэтгүүлч, сурвалжлагч С.Энхзаяа МҮХАҮТ-ын дарга С.Дэмбэрэлтэй 2011 онд хийсэн нэгэн ярилцлага:*

- Сүүлийн үед төрөөс иргэддээ хувьцаа олгоно гэх асуудлыг эрчимтэй ярьж эхэллээ. Энэ хэр зохистой зөв шийдэл вэ?

**С.Дэмбэрэл:** - Иргэдэд хувьцаа тараана гэдэг оновчгүй шийдвэр. Энэ их хуваарилалт юм шиг харагдаж байгаа биз. Байгалийн баялаг ард түмний өмч. Үүнийг хэрхэхийг мэд гээд эрх мэдлийг нь УИХ-д өгсөн. Гэтэл тэндээс бидэнд бүгдэд өгөх гэж байна. Үүнийг компанийн засаглал талаас нь авч үзвэл их буруу хэлбэр. Энэ бол цаашдаа авлига, хээл хахуулийг үүсгэх, хяналтгүй байдал үүсгэх их эвгүй хэлбэр. Ийм учраас манайхтай адил нөхцөлд байгаа, тархи толгой нь ажилладаг улсууд иймэрхүү зүйл хийдэггүй. Компанийн их муу засаглал үүсгэж, ил тод байдал үүсгэж, цөөхөн хэдэн хүний мэдэлд нийт эдийн засаг хамааралтай болох байдал үүснэ. Гаднаа шударга мэт харагдаж байгаа энэ хуваарилалт шударга биш хуваарилалт.

- Яавал шударга хуваарилалт болох юм?

**С.Дэмбэрэл:** - Нийгмийн бүх бүлгүүдийн хүсэл эрмэлзэл, сонирхол, боломжид таарсан нөхцлийг төрийн зүгээс бүрдүүлж өгөхийг шударга боломж гэнэ. Бид өнөөдөр дээр хэлснээр тэгш хуваарилалт хийснээрээ шударга ёсыг үгүйсгэж байна. 140 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эмэгтэйчүүд, жижиг бизнес эрхлэгчид өөр өөр зүйл хүсч байж болно. Тэр бүхэнд зориулсан эдийн засаг, улс төрийн орчинг бий болгохыг тэгш боломж олгож байгаа хэлбэр гэж ойлгож болох юм. Тэгш хуваарилалт гэдэг зүйл социализмын үед байсан. Эцэг маягийн төр социалист маягаар ард түмэнд ийм байдлаар цонхны цаанаас чихэр долоолгох үйл явц явагдаж байна гэж би байнга хэлдэг.

-Аж ахуйн нэгжид нэрлэсэн үнээр Тавантолгойн нийт хувьцааны 10 хувийг олгох асуудал яригдсан. Үүнийг танхимийн тэргүүн хэрхэн хүлээн авч байв?

**С.Дэмбэрэл:** - Манайх үүнийг дэмжиж байсан. Бид хувьцааг худалдан авч, хөрөнгө оруулалт хийе гэсэн. Монголын компаниудад гадны компаниудаас арай илүү боломж олгох асуудал байсан. Ийм асуудал ярьж байгаад зогсоох шиг боллоо. Гэхдээ бүгдийг нь нийлүүлээд ерөнхийд нь тэгшитгэн хуваарилах асуудал яригдаж байна. Энэ асуудал хэдэн жилийн дараа хамгийн муу компанийн засаглалыг бий болгоно. Үүнийг баталгаатай хэлье. Энэ бол шударга ёсны шалгуур биш. Тэгш боломж, тэгш хуваарилалт хоёрын ялгааг бид огт олж харахгүй байна. Харин сүүлийн үед МАН зарим бичиг баримтандаа тэгш боломж олгох гэж ярьдаг болсон байна. Бүх нам ингэж ярих ёстой. Учир нь нийгэм тэр чигтээ нэг ижил цамц, өмд, гуталтай хүмүүсээс бүрддэггүй. Нэг хэмжээний хувцасыг хүн бүр өмсдөггүй шиг хүн бүр өөр өөрийн сонирхол боломжийг хүсдэг. Энэ боломжийг бүрдүүлэх ерөнхий зүйлийг тэгш боломж гэнэ.

**- Монголбанкнаас мөнгөний бодлогыг 2012 онд хатууруулна гэдгээ хэлсэн. Гэтэл он гараагүй байхад л арилжааны банкууд хүүгээ нэмэж, зээл олголтоо багасгаад эхэллээ. Ирэх оны төсөв, мөнгөний бодлогыг та хэрхэн харж байна вэ?**

**С.Дэмбэрэл:** - Үүнийг бид байнга шүүмжилдэг. Монгол Улсад мөнгөний бодлогыг шүүмжилдэг МҮХАҮТ гэдэг ганцхан байгууллага байдаг. Монголбанк инфляцийг онилдог. Тэд эдийн засагт хэтэрхий их мөнгө бий болж, халчихлаа гэдэг. Тиймээс мөнгийг татаж авах буюу мөнгөний бодлогыг хатууруулах гэдэг. Бидний үзэж байгаагаар эдийн засаг халаагүй байна. Зөвхөн уул уурхайн салбарт хэрэгтэй тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн импорт нэмэгдсэн учраас гадаад худалдааны баланс ихэссэн байна. Энэ бол эдийн засаг энд тэндгүй буцлаад компани болгон мундаг болж, өнгөтэй явж байгаагийн үр дүнд үүсээд байгаа зүйл биш. Тиймээс тэдний хамгийн гол нотолгоо нь буруу болж байгаа юм. Манай дээр “Монголын бизнесийн замын зураг” гэдэг ном гарсан байгаа. Үүн дээр цагаан будаа, ноолуур, мах эдийн засагт нийлүүлэгдэхдээ хэчнээн хэмжээний зам туулж, ямар ямар зардал гардаг, хэчнээн хугацаа зарцуулдагийг гаргасан. Энэ бүх замын зургийг хялбаршуулбал, хэрэглэгчид очихдоо илүү хямдаар хүрч, ингэж л инфляцид нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл, нийлүүлэлтийн талын хүчин зүйлүүд манай инфляцид хамгийн ихээр нөлөөлдөг. Сүүлийн үед Монголбанк өөрөө махны судалгаа энэ тэр хийдэг болсон. Энэ бол сурч эхлэж байгаа хэрэг. Гэхдээ болоогүй байна. Эдийн засгаа яах гэж байгааг ч мэдэхгүй байж, мөнгөний бодлогоо хатууруулна гэдэг. Нөгөө талаас мэдээж, валютын ханш нөлөөлж байгаа. Энэ талын хууль, бодлого нь байгаа. Үүний дагуу 2008, 2009 онд Монголбанк баахан интервинц хийсэн. Эдийн засгийг идэвхжүүлж байж валютын ханш тогтвортой байх ёстой. Эдийн засаг гэнэтийн шокинд орсон үед савалгаанд ордог. Жижиг, дунд бизнес гэлтгүй бүгд бужигнаж, идэвхтэй үйл ажиллагаа явуулж байх хэрэгтэй. Монголбанкнаас төрийн бодлогоор дамжуулан бодит секторыг дэмжих, үйл ажиллагааг нь идэвхжүүлснээр нийт эдийн засаг идэвхжинэ. Тэр тусмаа уул уурхайн бус хэсэг нь буюу мөнгө хамгийн их дутдаг хэсэгт нь мөнгө олгох хэрэгтэй. Банкууд хоорондоо, банк бус санхүүгийн байгууллагууд хоорондоо өрсөлдөж, үйлчлүүлэгчээ хэвлэлээр дамжуулж дууддаг, гуйдаг байх нөхцлийг бий болгох хэрэгтэй. Одоо төр нь 60, 200 миллиард төгрөгийг иргэддээ банкуудаар дамжуулан өгөөд байна. Үүнд нь гуравхан банк сонгогдож байна. Гэтэл банк бус санхүүгийн байгууллагуудын дунд уралдаант тендер маягийн зүйл зарлаж, шалгаруулалт явуулж болдоггүй юм бэ? Бидэнд жижиг дунд үйлдвэрийг дэмжих 100 тэрбум төгрөг байна. Үүний 30 тэрбумыг нь та нар дундаа өрсөлдөж, хамгийн сайн нөхцөлтэй нь дамжуул гэж өрсөлдүүлэх хэрэгтэй. Ингэвэл зээлийн нөхцөл сайжирна.

**- Одоо манай арилжааны банкууд ямар байдалтай байна вэ?**

**С.Дэмбэрэл:** -Төв банкныхаа үнэт цаасыг худалдаж авчихаад, төрийн мөнгөний нөөцөөр болон олон жилийн турш харилцсан итгэлтэй компаниудад зээл олгох байдлаар үйл ажиллагаа явуулж байна. Мөнгөний бодлого хатуураад ирэхээр хадгаламжаа татаж эхэлдэг. Энэ үед хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр банкууд хадгаламжийн таатай нөхцөл амалсан сурталчилгаа цацдаг. Хадгаламжийг захиргааны аргаар бууруулж

болохгүй. Гэхдээ өрсөлдөөний аргаар бууруулж болно. Дараа жилийн болон дараа дараагийн Засгийн газрууд ийм зүйл хийх хэрэгтэй. Монголын улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрт мөнгөний бодлогыг эдийн засагт чиглүүлнэ, инфляцийг ингэнэ тэгнэ гээд л дандаа хэвшмэл зүйлүүд байдаг. Одоо үүнийгээ бодитойгоор хэрэгжүүлэх цаг болсон. Өнөөдөр дурын бизнесмэнээс монголд бизнес эрхлэх таатай орчин байна уу гэхээр байхгүй гэж хариулдаг шүү дээ.

**- 2012 оны төсөв, мөнгөний бодлого батлагдсан. Үүнээс үүдэн түрүүлж гарах эрсдэлийг та юу гэж харж байна вэ?**

**С.Дэмбэрэл:** - Энэ жилийн төсөвт бодит сектор руу жаахан мөнгө оруулахаар тусгасан. Гэхдээ энэ хангалттай биш. Өөрөөр хэлбэл, 2012 онд монголын бизнест илүү их мөнгө хэрэгтэй байна. Бүтцийг нь авч үзвэл, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчидэд илүү хэрэгтэй байна. Одоо л дөнгөж зээлийн баталгааны сангийн асуудал яригдаж байна. Өнөөдөр зээлийн баталгааны санд гурван миллиард биш, 30 миллиард байх ёстой. Ингэж байж олон хүн бизнес эрхлэх боломжтой болно. Ийм үед мөнгөний бодлогын хатууруулна гэж яриад явж байна гэдэг бизнесийн идэвхийг бууруулж, хямралыг даллан дуудах болно. Инфляци 13 хувьтай байж болно. Гэхдээ үүнийг зөөлөлдөг арга бий. Бизнес нь маш идэвхтэй явагдаж, барааны эргэлт ихэсч, гаднаас ирэх замын зургийг багасгавал ард түмэнд хэрэгтэй арван төрлийн хүнсний бүтээгдэхүүний үнэнд нөлөөлж байгаа зүйлийг үгүй хийвэл инфляци хөөрөгдөх нь гайгүй. Өөрөөр хэлбэл, инфляцийг удирдаж болох төвшинд барьж болох боломжтой. Үүнийг би заавал нэг оронтой тоо гэж хэлээгүй. Инфляцийг нийгэм, эдийн засгийн байдлыг хүндрүүлэхгүй, тогтворгүй болгохгүй менежмент хийж болох төвшинд барьж болох мөнгөний бодлог байх хэрэгтэй. Мөнгөний бодлогын хамгийн гол зорилт нь эдийн засгийн өсөлтийн тэр дундаа хүмүүсийн оролцоотой, уул уурхайн хөөсний өсөлтийн биш хэлбэрийг бий болгох ёстой. Үүнийг энэ мөнгөний бодлогоор бий болгож чадахгүй. Төсвийн бодлого жаахан тэлсэн, төсвийн бодлого нь татсан энэ бодлого явахгүй. Энэ жил хэтэрхий үрэлгэн хөрөнгө оруулалтын төслүүдээ зогсоож, шууд хүмүүс дээр очих хөрөнгө оруулалтуудыг хийх хэрэгтэй. Монголбанк өөрөө хүмүүсийн оролцоотой, тэдэнд хүртээмжтэй өсөлтийг хангах чиглэлийн эсрэг үйл ажиллагаа явуулж байна. Тэд эдийн засаг хэт халчихлаа. Тиймээс одоо хөргөнө гэдэг.

**- Энэ тохиолдолд арилжааны банкууд яах ёстой юм бэ?**

**С.Дэмбэрэл:** - Арилжааны банкууд үг дуугүй боол биш. Тэд олон жил харилцаж тогтсон харилцагчдынхаа бааз, суурийг алдахыг хүсэхгүй байгаа. Тиймээс тэдэнтэй харьцах даа тусгайлсан байдлаар зээлийн хүүгээ багасгах байдлаар явж байна. Нэг хэсэг байгууллага нь гадны компаниудтай харьцаж байна. Удахгүй ирэх хоёрдугаар сараас Японы хоёр шаттай зээлээр 60 миллиард төгрөг орж ирнэ. Мөн одоогийн 30-40 миллиард, дээрээс нь ноос ноолуурын 100 орчим төгрөгийн бонд орж ирнэ. Энэ бүхэн нийлээд эдийн засагт нөлөөлнө. Гэхдээ эдийн засгийн ихэнхийг бүрдүүлж байгаа бичил, жижиг бизнест нөлөөлөхгүй. Тиймээс энэ үйл явцад бичил санхүүгийг байгууллагуудыг татаж оруулбал, тэд илүү түргэн хурдан шуурхай ажил болгоно. Мөн хэсгийг дэмжихийн тулд Хөгжлийн банк

томоохон төсөл, хөтөлбөр санхүүжүүлэхийн зэрэгцээ бизнесийг дэмжих зээл гаргах хэрэгтэй.

- Засгийн газраас УИХ-д Төсвийн төслийг анх өргөн барих үед нүүрсэн дээр таван хувийн экспортын татвар тавих санал тусгасан байсан. Энэ саналыг танай харъяа аж ахуйн нэгжүүд татуулсан гэсэн. Манай улс нүүрсээ хэдий болтол татваргүй гаргах юм бэ?

С.Дэмбэрэл: - Энэ татварын асуудлыг манайх эсэргүүцсэн. Бид өртөг нэмэх процессыг хийж байна. Энэ талаас нь илүү санаачлагыг нь төрүүлэхийн оронд шууд орлого талаас нь төлөвлөж, мөнгө авах гээд байна. Гэтэл энэ өртөг нэмэх процессууд, татварын хөнгөлөлт үзүүлэх зэргээр нөгөө талаас нь урамшуулбал, илүү үр дүнтэй. Өнөөдрийн нөхцөлд манай улсын экспортын хэмжээ, нэр төрөл хэтэрхий бага байна. Экспортын стратегитай үүнийг зэрэгцүүлж авч үзэх ёстой. Өөрөөр хэлбэл, мах, ноос ноолуур зэрэг хэдхэн төрлийн бүтээгдэхүүнийг бид гадагш гаргаж байгаа. Экспорт маань хув хүрэн өнгөтэй боллоо. Энэ тохиолдолд экспортын солонгорсон олон өнгийг бий болгох ёстой. Тэр стратегийг батлаж байгаад энэ хүрээнд асуудлаа цогц хэлбэрээр нь ярих хэрэгтэй. Түүнээс ганц нэгээр нь ингэж сугалж, ярих нь эцсийн үр дүнг нь алдагдуулж байна.

### **Зээлийн хүүг бууруулахад чиглэсэн тодорхой бодлого хэрэгжүүлэх ёстой**

*“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийг /2012 оны 09-р сард/ УИХ-ын холбогдох байнгын хороогоор хэлэлцэх үеэр УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл ихээхэн шүцмжлэлтэй байр суурьтай байв. “Инфо” сонинь сурвалжлагч тэцүнээс мөнгөний бодлогын талаар зарим асуултад хариулт авлаа.*

- Манай улсын иргэдийн ихэнх нь зээлтэй гэгддэг. Тэгэхээр зээлийн хүүг бууруулахад юуг анхаарах хэрэгтэй вэ?

- Ард түмэн болон бизнес эрхлэгчид санхүүгийн аятайхан орчинд амьдармаар байгаа. Тэд зээлийн хүүг буулгаж өгөөч гэдэг асуудлыг байнга тавьдаг. Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг батлахдаа УИХ зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулж буулгана гэсэн байгаа. Тэгэхдээ 2013-2016 онд буулгана гэсэн. Гэтэл төв банк яг л урьдын адил инфляцийг нэг оронтой тоонд оруулчихвал зээлийн хүү буурчихна гэж үзэж байна. Инфляцийг нэг оронтой тоонд оруулсан ч гэсэн зээлийн хүүд чиглэсэн тодорхой бодлого хэрэгжүүлэхгүй бол бүтэхгүй шүү дээ.

- Төв банкныхан зээлийн хүүг бууруулахад чиглэсэн ажил хийдэггүй хэрэг үү?

- Төв банкинд бодит секторыг дэмжинэ гэсэн байдлаар л томъёолж байна. Энэ нь учир дутагдалтай. Дээр нь Банкны холбооны саналыг авсангүй. Санхүүгийн зах зээлийн бусад операторууд болох банк бус санхүүгийн байгууллагуудын саналыг авахгүй байгаа. Уг нь төр бүхэлдээ

ард түмнээ сонсдог болно гээд байгаа хэрнээ УИХ-ын харьяалалд байдаг нэг байгууллага нь бусдынхаа саналыг сонсохгүйгээр худлаа яриад байгаа юм.

**- Төв банкны зүгээс Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийг тогтмол ажиллуулах санал гаргаж байна. Энэ нь хэр оновчтой шийдэл вэ?**

- Засгийн газрын мөрийн хөтөлбөрт санхүүгийн секторт эдийн засгийн шинэчлэл хийнэ. Үүнийг хийхдээ эдийн засгийн оролцоотой өсөлт, жижиг дунд бизнесийг дэмжих замаар санхүүгийн зах зээл дээрх бусад операторууд болох даатгал, зээлийн батлан даалт зэрэг үйл ажиллагааг хөгжүүлнэ гэсэн заалт бий. Гэхдээ төв банкныхан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийг тогтмол ажиллагаанд оруулъя гэж оруулж ирсэн. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлыг тодорхой болгож өгөх шаардлагатай хэвээр байна. Улирал, хагас жилээр нь тайлагнах байдлаар заагаад өгч болно.

**- Мөнгөний бодлогыг зөв голдиролд оруулахын тулд эн тэргүүнд юу хийх хэрэгтэй вэ?**

- Банкны секторт өрсөлдөөнийг өрнүүлэх замаар хямд эх үүсвэрээс хөрөнгийг татан авч арилжааны банкуудаа дахин санхүүжүүлэх байдлаар ажилламаар байна. Зөвхөн бодлогын хүүг дээш, доош болгох замаар ажилламааргүй байна. Ингэснээр арилжааны банкууд хадгаламжийн төлөө бус зээлийн хүүгээ бууруулахын төлөөх өрсөлдөөнд орно. Үүнийг хэрэгжүүлэх санхүүгийн орчныг бүрдүүлэх нь төв банкны үүрэг. Төв банк үнэхээр бодит секторыг дэмжье гэвэл ингэж ажиллана. Үгүй гэвэл өнгөрөгч жилүүдэд ажиллаж байсан шигээ байж, инфляцийг нэг оронтой тоонд барих гэж оролдоно. Мэдээж жилийн эцэст тэр нь худлаа байна.

**- Инфляцийг нэг оронтой тоонд барих бодлого хэрэгжихгүй байгаа нь ямар учиртай юм бол?**

- Ер нь инфляцийг нэг оронтой тоонд барих гэсэн оролдлого биелсэн жил ганц л байгаа байх. Жилийн эхэнд нэг оронтой тоонд барина л гэдэг. Жилийн эцэст хоёр оронтой тоондоо л байдаг. Энэ жил ч байдал давтагдана. Тэгээд олон жил тогтчихсон мөнгөний бодлогын ар талд зах зээлд оролцогчдын зан төлөвийг удирдах гэж оролддог. Иргэдийн хийх үйлдлийг нь удирддаг юм. Үүний дохио болгож эдийн засгаас мөнгө татдаг. Ингэхээр л үнэ буурчихдаг гэж ойлгодог хэрэг. Гэтэл үнэ нийлүүлэлтийн хүчин зүйл бүх зүйлээс хамаарна. Үүнийг мэдээж Засгийн газар хийнэ. Харин төв банк эрэлтийг нэмэгдүүлэхэд анхаарах ёстой. Жижиг дунд үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажиллагааг банкны үйл ажиллагаагаар дэмжих ёстой.

## **Монголбанкны ерөнхийлөгчид хэд хэдэн хүнийг нэр дэвшүүлэх ёстой байсан**

*Сурвалжлагч П.Нансалмаа УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлийг нэвтрүүлгийнхээ “VIP” буландаа урьж, цаг цөийн асуудлаар ярилцлаа. 2012 оны 09-р сарын 23.*

- Төсөв 500 гаруй тэрбум төгрөгийн алдагдалтай гэж байна. Сангийн сайдын хэлснээр цөмөрсөн гэх төсөвт тодотголыг хэрхэн хийх хэрэгтэй юм болоо?

- Энэ 2012 оны төсвийн төслийг батлах үед гадаад орчин сайн, сонгуулийн жил байсан учраас нэлээд өгөөмөр маягийн төсөв баталсан. Одоо тэр төсвийг бодит хөрс руу буулгах зайлшгүй шаардлага гарч ирлээ. Өнөөдрийн байдлаар гадаад орчин муудлаа, манай эдийн гол тулгуур уул уурхайн секторын бүтээгдэхүүний үнэ унаж байна. Тийм учраас эдгээр болон бусад шалтгаанаар төсвийн тодотгол зайлшгүй хийх шаардлага гарсан. Үүнтэй уялдаад өгөөмөр төсвийнхөө зардлыг танах шаардлага гарсан. Нөгөө талаас төсвийн нэмэлт орлогын эх үүсвэрийг оруулах гарцыг зарим нэгэн бүтээгдэхүүний онцгой татварыг нэмэх замаар тодотгол хийж байх шиг байна. Гэхдээ энэ бол 2012 оныхоо асуудлыг л шийдэж байна. Цаашид 2013 оны төсвийг хэр зэрэг хариуцлагатай батлахаас олон зүйл шалтгаална. Хуулиараа бол 2013 оны нэгдүгээр сарын 1-ээс төсвийн хариуцлагын тухай хууль хэрэгжинэ. Ингэхээр хязгаарлалтууд байгаа. Төсвийн алдагдлыг ДНБ-ний хоёр хувиас хэтрүүлэхгүй гэсэн. Энэ тохиолдолд орлого зарлагын асуудал нэлээд яригдана байх.

- Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд Монголбанкны ерөнхийлөгчөөр яригдаж байгаа Н.Золжаргалыг өрсөлдөгчгүйгээр оруулж ирлээ. Та үүн дээр ямар байр суурьтай байна вэ?

- Юуны өмнө өнгөрсөн дөрвөн жилд Монголбанкыг удирдаж ирсэн Л.Пүрэвдорж гуай болон Н.Золжаргал нарын хүмүүс хуулийн дагуу нэр төртэй бие даасан байдлаар алдахгүй ажиллаж ирсэн гэдгийг онцгойлон хэлмээр байна. Өнөөдөр улс төрийн болон улс төрийн бус шалтгаанаар хүмүүсийг хольж, сольж байгаадаа гол нь биш Монголбанк бол өөрөө их эмзэг институт гэдгээр нь бодож УИХ даргад намын бүлгээрээ хэлэлцүүлэлгүй асуудлыг оруулж ирж байгаа нь сайн хэрэг. Үүнийг би ойлгохдоо цааш цаашдаа УИХ-ын дарга нь Монголбанкны удирдлагыг сонгохдоо итгэл үнэмшлээр, мэргэжил мэдлэгийг харгалзан оруулж ирж байх ёстой гэж үзэж байгаа юм байна. Гэхдээ л хэд хэдэн хүний нэрсийг өрсөлдүүлж оруулж ирсэн бол зүгээр байсан юм. УИХ-ын дарга Монголбанкны ерөнхийлөгчийг сонгож байгааг тендер биш гэж байна лээ. Гэхдээ арилжааны банкуудын саналыг авах, эдийн засгийн онол практик дахь мэдлэгийг харгалзан үзэж дор хаяж хоёр хүн оруулж ирэх нь зүйтэй байсан болов уу. Хоёрдугаарт Л.Золжаргалыг би маш сайн мэднэ.

- Н.Золжаргал зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулна гэсэн итгэл үнэмшилтэй байгаа гэж байна. Үнэхээр энэ боломжтой юу?

- Засгийн газрын мөрийн хөтөлбөрт зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулж, инфляцийг нэг оронтой тоонд барина. Төгрөгийн худалдан авах



чадварыг тогтвортой байлгана гэсэн байгаа. Энэ ажлуудыг хэрэгжүүлэх үү гэдэг асуултыг би Н.Золжаргалд тавьсан л даа. Хэрэгжүүлнэ л гэж байна. Өөрөөр хэлбэл Монголбанкны Ерөнхийлөгч болох гэж байгаа хүнд дараагийн жилүүдийн хүлээлтийг өгч байна. Цаашдаа зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулах боломж байгаа, үүнийг хэрэгжүүлнэ гэж байна лээ. Бид үүнийг л асууна. Нөгөө талаас валютын ханшны талаар ярьж байна. Өнөөдөр 1400 болчихоод байгаа валютын ханшны удирдлагыг цаашид яах вэ. Ингээд л улам цаашаа урсаад байх юмуу. Энэ асуултыг мөн л Н.Золжаргалд тавьсан. Өнөөдрийн хуулийн дагуу Монголбанк валютын ханш дээш доошоо таван хувиар нэмэх хасах давамгайлан хэлбэлзэх үед зах зээлд хөндлөнгөөс оролцож валют зардаг. Үүнийг чөлөөтэй өгөх ханшны дэглэм гэж хуулиараа заасан. Миний хэлээд байгаа санаа нь чөлөөтэй өгөх ханшны дэглэмд валютын ханшны өөрчлөлтийг тогтвортой байлгаж чадах уу, үгүй юу. Эсвэл сэтгэл зүйн хязгаарыг даваад 1400, 1500 гээд л яваад байх юм уу. Үүн дээр валютын ханшны дэглэмийн асуудал гарч ирж байгаа юм. Мөн валютын зах зээл болоод эрдлийн асуудал ч мөн гарч ирнэ.

**- Валютын дотоодын захын үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулах, үр ашгийг нэмэгдүүлэх, төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангах, зах зээлийн зарчмаар тодорхойлох зорилгоор Монголбанкнаас захад оролцоор ирсэн?**

- Монголын валютын зах зээлд оролцогчид нь хязгаарлагдмал. Дөрөв тавхан арилжааны банкууд оролцоно. Банк бус санхүүгийн байгууллага болоод бусад экспорт, импортын валютаар шууд худалдан авах зарах боломж хязгаарлагдмал. Таван банкны валют авна, зарна гэсэн энэ хэрэгцээг цаанаасаа нийт эдийн засгийн хэрэгцээг хангасан гэж хэлэхэд хэцүү.

**- Монголбанкны Ерөнхийлөгч асан Л.Пүрэвдорж инфляцийг барина гэх мэт амлалтуудыг өгч байсныг санаж байна. Тэр хэр сайн ажилласан байна? Үнэхээр инфляцийг тогтоон барих хэцүү байсан юм уу? Цаашид үүнд төрийн оролцоо хэрэгтэй гэж та үзэж байна уу?**

- Монгол Улсын хувьд ганцхан төв банк инфляцийг бариад байна гэдэг бол худлаа гэдгийг олон жил харлаа. Л.Пүрэвдорж гуай бид хоёр ажил хэргийн хувьд тийм ч сайн харилцаатай байгаагүй. Одоо бол би түүнийг магтаж байна. Энэ хүн байр сууриндаа их үнэнч, тууштай байсан. Засгийн газрын эдийн засгийн хэт их хавтгайруулан халамжлах бодлого Монголбанкны мөнгөний бодлогод сөрөг нөлөө үзүүлж байсан учраас аргагүй эрхэнд тодорхой хэмжээнд мөнгөний бодлогыг хатууруулж ирсэн гэдэгтэй санал нийлдэг. Гэхдээ мөнгөний бодлого, сангийн бодлогыг хооронд нь уялдуулж чадахгүй байгаагаас болж бизнес эрхлэгчид хохирох ёсгүй гэдэг үүднээс бид байнга шүүмжилдэг.

**- Та байнгын хорооны хуралдаан дээр санхүү эдийн засгийн тогтвортой байдлын талаар ярьж байсан. Монгол Улс цаашдаа санхүү эдийн засгийн тогтвортой байдлыг яаж хангах ёстой вэ?**

- Хэрвээ санхүү эдийн засгийн байдлыг тогтвортой хангаж чадахгүй инфляци, нийгэм эдийн засгийг донсолгох хэмжээнд хүмүүсийн амьдралд шууд нөлөөлдөг. Ард иргэд болоод бизнес эрхлэгчдэд “За энэ ч өнгөрлөө дөө” гэсэн бодол нь цуу ярианы хэлбэрт гинжин урвалд орох юм бол эдийн засагт асар муу нөлөөлтэй. Тэгэхээр санхүүгийн тогтвортой байдлын

зөвлөл гэдгийг байгуулах хэрэгтэй. Тэгээд энэ зөвлөлийнхөө хийж буй ажлыг УИХ нь улирал бүр авч хэлэлцдэг механизм руугаа орвол цаашдаа маш их хэрэгтэй.

- Уул уурхайд найдсан эдийн засаг хүндэрч эхэллээ. Одоо эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх зүйл юу байна вэ?

- Уул уурхай, уул уурхайн бус эдийн засаг гэсэн хоёр юм байна аа. Тиймээс жилийн дотор уул уурхайн бус эдийн засаг руугаа анхаарах хэрэгтэй. Тийм учраас тэдэнд бодлогоос гадна санхүүгийн сайн орчинг бүрдүүлж өгөх нь чухал.

### **Засгийн газар бүсээ чангалахаас өөр аргагүй боллоо**

*"Монголын үнэн" сонины сурвалжлагч Ц.Жаргалцэцэг УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлтэй уулзаж, Улс орны эдийн засгийн өнөөгийн /2013 оны 9-р сарын 13/ дүр төрх, цаашдын төлөв, хандлагын талаар нийтлүүлсэн ярилцлага*

- Төсвийн алдагдал ДНБ-ий 4.9 хувьд хүрлээ. Гэвч төсвийн тодотголоор хүүхдийн мөнгө зэрэг тооцоолоогүй зардлыг ихэсгэж байна. Энэ талаар Та ямар бодолтой байна вэ?

- Өмнөх жил гадаад орчин сайн байсан учраас өгөөмөр төсөв баталсан. Одоо түүнийг нь бодит хөрсөнд буулгах зайлшгүй шалтгаанууд үүсч эхэллээ. Гадаад орчин ч муудаж байна. Манай улсын эдийн засгийн гол тулгуур гэгддэг уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үнэ унаж байгаа болон бусад зайлшгүй шалтгаан төсөвт хүндрэл учруулж байна. Өөрөөр хэлбэл, өгөөмөр төсвийнхөө зардлыг танах шаардлагатай болов. Нөгөө талаас төсвийн тодорхой орлогыг дайчлах, нэмэлт эх үүсвэр бий болгох гарцыг зарим бүтээгдэхүүний онцгой татварыг нэмэх, үйлчилгээ, барааны зохицуулалтад өөрчлөлт оруулах замаар хайж, төсөвт тодотгол хийж байна. Энэ нь 2012 оныхоо асуудлыг шийдэж байгаа болохоос биш 2013, 2014 оны төсвийн тогтвортой байдал, эдийн засгийн цаашдын идэвхжилтийг шийдэхгүй. Ирэх жилүүдийн ирээдүй Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон 2013 оны төсвийг хэрхэн батлахаас шалтгаална. Ирэх оны нэгдүгээр сарын 1-нээс Төсвийн хариуцлагын тухай хууль хэрэгжиж эхлэх юм. Уг хуульд төсвийн алдагдлыг ДНБ-ий 2.5 хувиас хэтрүүлэхгүй байх зэрэг хязгаарлалтууд бий. Энэ тохиолдолд орлого, зарлагын асуудал нэлээд яригдах байх. Гэхдээ цаашид хөгжлийн болон төсвийн төлөвлөлтөд анхаарах хэд хэдэн гол зүйл бий. Нэн түрүүнд төсвийн орлогыг бий болгодог баялаг үйлдвэрлэгчид, үйлчилгээ үзүүлэгчдийн орлогыг өсгөх, үржүүлэх асуудлыг төсвийн механизмаар яаж хангах вэ. Мөн үржсэн баялгаа яаж шударга хуваарилж, хуваах вэ гэдэг асуудал чухал. Энэ бүхэн өнөөдөр зарчмын хувьд маргаантай байна. Тухайлбал, хүүхэд бүрт 20 мянган төгрөг өгөх асуудал нийгмийн зөвшилцөл мөн үү. Гэтэл өнөөдөр хүүхдийн цэцэрлэг дутагдаж байна. Мөн баялаг бүтээж экспортлох асуудлыг төсөв, мөрийн хөтөлбөрт тодорхой заалт, тоогоор суулгаж өгөх ёстой. Энэ талаас нь бодож төсвийн тодотгол хийгээсэй.

**- Экспортын гол орлогын үнийн бууралт төсөвт ачаалал үүсгэж байна. Эдийн засаг ч хямрах тухай ярьж байна. Үүнээс гарах гарц юу байх вэ?**

- Засгийн газар бүсээ чангалах бодлого барьж, төсвийн хэмнэлт хийхээс өөр аргагүй. Мөн уул уурхайн бус салбарын эдийн засгаа төрөл бүрийн татварын болон бусад механизмаар дэмжих үйл ажиллагааг идэвхжүүлэх ёстой. Үүнд зориулах тодорхой мөнгө бий. Түүнчлэн удаан хугацаанд үр өгөөжөө өгөх дэд бүтцэд зориулсан төсөл, урсгал зардалд зориулсан хэрэглээгээ танаж бүтээгч, ажлын байр бий болгодог салбартаа хөрөнгө оруулах хэрэгтэй. Дээр нь бизнесийн орчныг цэвэрлээд ирэхээр бичил, жижиг, дунд бизнесүүд аяндаа хөгжинө. Хэрэв ингэж чадвал бид санхүүгийн хямралыг туулж чадна.

**- Эдийн засгийн ийм эрсдэлтэй нөхцөлд мөнгө, санхүүгийн бодлого барьдаг Төв банкны бодлого туйлаас чухал. Удирдлага нь ч солигдох бололтой. Та цаашид мөнгөний ямар бодлого хэрэгжүүлээсэй гэж хүсч байна вэ?**

- Өнгөрсөн дөрвөн жилд Монголбанкийг удирдаж явсан Л.Пүрэвдорж гуай болон түүний хамт олон нэр төртэй, бие даасан байдлаа алдахгүй ажиллаж ирсэн гэдгийг онцгойлон тэмдэглэмээр байна. Тодорхой хэмжээнд ханш дээшээ, доошоо хэлбэлзэх үед Монголбанк интервенц хийх буюу зах зээлд хөндлөнгөөс оролцож валют зардаг. Үүнийг чөлөөтэй хөвөх ханшийн дэглэм гэж хуулиар заасан. Чөлөөтэй хөвөх ханшийн дэглэм валютын ханшийн өөрчлөлтийг тогтвортой байлгаж чадах уу, үгүй юу. Энд валютын зах зээл, эрсдэлийн асуудал гарч ирж байгаа юм. Одоогийн чөлөөтэй хөвөх дэглэмийг зохицуулалттай хөвөх валютын ханшийн дэглэмд оруулах талаар ажил хийх үү гэхэд Монголбанкны дэд ерөнхийлөгч Н.Золжаргал "боломжтой" гэж байна билээ. Өөрөөр хэлбэл, зөвхөн интервенц хийх биш, тодорхой хэмжээгээр эдийн засгийн бусад аргаар валютын ханшид нөлөөлж, зохицуулж болдог. Нөгөө талаар валютын зах зээлд оролцогчид хязгаарлагдмал. Дөрөв, тавхан банкны байгууллага, арилжааны банкууд оролцдог. Банк бус санхүүгийн байгууллагууд болон бусад экспорт, импортын үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьд валютаар нь шууд худалдан авах, зарах эрх банк хоорондын зах зээлд хязгаарлагдмал байдаг. Ийм тохиолдолд дөрөв, тавхан банкны валют авах, зарах хэрэгцээг нийт эдийн засгийн бодит хэрэгцээг хангасан гэж хэлэхэд хэцүү. Иймээс валютын ханшийн зохицуулалттай хөвөлтийг эхлүүлж гэж ярьж байгаа. Нөгөө талаар өнөөдөр Төв банк инфляцийг барина гэдэг худлаа. Засгийн газрын хэт их хавтгайруулсан халамжийн бодлого Монголбанкны мөнгөний бодлогод сөргөөр нөлөөлж байсан учраас аргагүйн эрхэнд тодорхой хэмжээгээр мөнгөний бодлогыг хатууруулж байсантай санал нийлдэг. Гэхдээ мөнгөний бодлого, сангийн бодлого хоёрыг хооронд нь уялдуулаагүйгээс бизнесийнхэн хохирох ёсгүй гэж бид байнга шүүмжилдэг. Энэ талаас нь авч үзвэл Монгол Улс цаашдаа санхүү, эдийн засгийнхаа байдлыг яаж тогтвортой хангах вэ гэдэг асуудал гарч байна. Хэрэв инфляц нийгэм, эдийн засгийг донслох хэмжээнд хүрч, хүмүүсийн амьдралд шууд нөлөөлбөл эдийн засагт их сөрөг нөлөөтэй. Ийм тохиолдолд одоо хүртэл хэрэгжиж ирсэн санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн механизмыг сайжруулахад анхаарах ёстой. Санхүүгийн болон

эдийн засгийн тогтвортой байдал яригдаж байгаа учраас УИХ, Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороон дээр нь Эдийн засгийн хөгжлийн яам, хувийн хэвшлийн төлөөллийн байгууллагыг нэмээд Эдийн засгийн санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл гэдгийг байгуулж, үйл ажиллагааг нь УИХ улирал бүр авч хэлэлцдэг байх хэрэгтэй.

- **Монголбанк зээлийн хүүг нэг оронтой тоонд багтааж чадвал уул уурхайгаас бусад салбар хөгжих боломж нээгдэнэ гэж ойлгож болох уу?**

- Уул уурхайн бус эдийн засагт анхаарах хэрэгтэй. Ингэхийн тулд тэдэнд бодлогоос гадна санхүүгийн сайн орчин бүрдүүлж өгөх шаардлагатай байгаа юм. Тиймээс санхүүгийн салбарын шинэчлэлийг хийе. Энэ бол зөвхөн зээлийн хүүг бууруулах асуудал биш. Хөрөнгийн бирж нь ажиллаж эхлээгүй, ганцхан банкнаас хамааралтай санхүүгийн салбар байна шүү дээ. Тэгэхээр арилжааны банкууд, банк бус санхүүгийн, даатгалын байгууллагууд, хөрөнгө оруулалт, даатгалын сан, хувийн тэтгэврийн сан гэх мэт санхүүгийн зах зээл дээр ажилладаг операторуудыг хөгжүүлэх асуудал нь өөрөө шинэчлэл болж байгаа юм. Ингэснээр өрсөлдөөн үүсч зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулах боломж гарна. Нөгөө талаас жижиг, дунд бизнесийг дэмжинэ гэдэг нь Засгийн газраас санхүүгийн зах зээлд оролцож байгаа нэг хэлбэр. Тэгэхээр санхүүгийн зах зээл бол өргөн хүрээтэй.

- **Европ, Хятадын эдийн засгийн хямрал манай улсад нөлөөлөх вий гэсэн болгоомжлол байна. Хэрэв Хятадын хямрал үргэлжилбэл манай эдийн засагт хэрхэн нөлөөлөх вэ?**

- Хятад бол манай улсын түүхий эдийн гол зах зээл. Хятадын эдийн засаг дэлхийг тодорхойлж байна. Хятадын Засгийн газар хямралын эсрэг эдийн засгаа идэвхжүүлэх, дотоод эрэлтээ нэмэгдүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг урамшуулж бүс нутагтаа хөрөнгө оруулах зэрэг иж бүрэн бодлогыг эрчимтэй авч эхэлж байна. Хэдийгээр ийм бодлого хэрэгжүүлж байгаа ч үр дүн ямар байх нь эргэлзээтэй. Учир нь Хятадын экспортын зах зээл доошилж, дотоод эрэлт хумигдсан. Хятадын эдийн засгаас хамаарч Монголын нүүрс, зэсийн үнэ унасан. Нөгөө талаас нефтьийн үнэ нэмэгдэнэ. Бид цэвэр импортлогч улс. Тиймээс Хятадын эдийн засгийн байдал муудаад байвал манай эдийн засгийн байдал ч муудна. Ийм тохиолдолд эртхэн уул уурхайн бус эдийн засгаа олон тулгууртай болгож, солонгоруулан хөгжүүлэх хөрөнгөө эрхтэн шийдэж байхгүй бол болохгүй. Хамгийн гол нь хөрөнгөөр нь дэмжих санхүүгийн орчныг бий болгох хэрэгтэй.

## **Макро болон Улаанбаатар хотын эдийн засгийн бодлого нь хоорондоо уялдахгүй бол ямар Засгийн газар байхав дээ**

*УИХ-ын чуулганы Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны тэмдэглэлээс: Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжцүүлэх Үндсэн чиглэлийн биелэлтийг хэлэлцэх цеэр*

С.Дэмбэрэл: Энэ ч хүний хараа шалгасан их эвгүй л бичиг баримт байна. Үүнийг чинь уншихаас ч дургүй хүрч байгаа. Хүнийг хүндэтгэсэн зүйл тарааж өгч бай, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, би Эрдэнэбат гишүүнтэй маш их санал нэгтэй байна. Утгагүй байна. 70 жил биелэлт ярьж байна. Төлөвлөгөөний биелэлт ийм боллоо, тийм боллоо л гээд байх юм. Үүнээсээ ичээч. Одоо болих хэрэгтэй. Шинэчлэлийн Засгийн газар юм бол ядахдаа үүнээсээ авахуулаад шинэчлээч. Засаглалыг дүгнэдэг энэ аргачлалыг 70 жил мөрдөж байна. Инээдэмтэй болчихоод байна. Үүнийгээ өөрчлөөч гэсэн ийм нэг санал байна.

Дээр нь, Төрийн байгуулалтын байнгын хороогоор орж ирж байгаа институциуд /байгууллагууд/-ын хоорондын уялдаа, чадавхи маш сул байна. Тийм учраас тусгай судалгаа явуулмаар байна. Тэр нь юу вэ гэхээр, энэ засаглалын эргэлтэд орж байгаа бичиг баримтуудын замын зургийг нэг гаргамаар байна. Асар уддаг юм байна. Энэ замын зураг, зам чинь маш урт учраас засаглалын технологи их урт учраас үр дүн нь маш сул байна. Баримт эргэлтийг харахад, зөвхөн Засгийн газрын худалдан авалт төдийгүй ерөөсөө энэ Засгийн газрын тогтоол шийдвэр, хөтөлбөрийг гаргах үйл явц, түүнийг боловсруулах шат, энэ яаман дотроо, яам хоорондын баримт бичгийн эргэлт асар удаан байна. Энэ баримт бичгийн эргэлт гэдэг зүйл чинь засаглалын үр ашгийг харуулдаг маш чухал үзүүлэлт байдаг. Тэр манай Монгол Улсад маш муу байна. Энэ дээр манай Байнгын хороо их анхаармаар байна.

Дараагийн нэг хэлэх зүйл, сүүлийн үед их хүчтэй ажиглагдаж эхэлсэн. Улаанбаатар хотын эдийн засгийн бодлого, Монгол Улсын макро эдийн засгаас хол хөндий бөгөөд тасархай болж эхэлсэн. Асар том том төслүүд ярьж байна. Метроноос авахуулаад, тэр нь хаана, яаж, эдийн засгийн үр ашиг талаасаа ямар юм бэ, яаж хэрэгжих юм бэ гэсэн талын юм ерөөсөө байхгүй байна. Энэ дээр ч байхгүй, хаана ч байхгүй. Хэрэв ингэхгүй л юм бол, нийт Монголын эдийн засгийн идэвхжлийн 90 хувь нь явагдаж байгаа энэ хотын эдийн засгийн орон зайг яах юм бэ? Энэ макро эдийн засгийн бодлого болон Улаанбаатар хотын эдийн засгийн бодлого нь хоорондоо уялдахгүй л юм бол ямар юмных нь Засгийн газар байхав дээ. Энэ тал дээр их онцгой анхаарах хэрэгтэй байна.

Энэ их олон жил яригдаж байгаа зүйл! Хөрөнгө оруулалтын үр ашгийн эрэмбэлэл одоо хүртэл байхгүй байна. Энэ дээр ч мөн л алга байна. Тодорхой объектынх нь ажлын үйл явц тэдэн хувь бэ гэдэг нь чухал биш, ерөөсөө энэ

2012 онд хэрэгжсэн, нийт, хэрэгжихээр төлөвлөсөн эхлэл, түүний хөрөнгө оруулалт өнөөгийн цэвэр өртөг дээр нь суурилсан хөрөнгө оруулалтын үр ашгаар нь эрэмбэлсэн эсэх, цаашдаа эрэмбэлж чадах эсэх, тэгээд эрэмбэлэх юм уу? үгүй юу? 13, 14, 15 он гээд, цааш нь яах юм бэ? Ийм юмнуудыг хийхгүй, ийм байдлаар, ингэж оруулж ирдэг явдал бол зөвхөн энэ Засгийн газрын алдаа биш, угаасаа бүх Засгийн газар ийм л байсан. Тийм учраас үүнийг өөрчлөх хэрэгтэй гэсэн ийм саналтай байна. Баярлалаа.

**А.Бакей:** Дараа нь хэлэлцэх дэгийн тухай асуудлыг би ярьсан. Үндсэн чиглэл болоод институциудын хоорондын ажлын уялдаа чадавхийг бэхжүүлэх талд бас цаашдаа анхаарах хэрэгтэй гэсэн санал хэлж байна.

Мөн Улаанбаатар хотын нийгэм, эдийн засаг гэдэг чинь өөрөө бараг Монгол Улсын эдийн засгийн тал хувь. Гэтэл энэ асуудал Үндсэн чиглэл дээр тодорхой тусгагдаагүй байна гэсэн санал хэлж байна. Би гишүүдийн энэ үнэтэй саналыг үгүйсгэхгүй байна. Авах саналыг авахаас өөр арга байхгүй.

Засгийн газар болоод Аудитын дүгнэлтийг харьцуулах харах боломжоор цаашдаа бас хэлэлцүүлэх шаардлагатай гэсэн санал хэлж байна. Үнэхээр өнөөдөр Аудитын газрын, аудитын харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж өөрөө бас боловсронгуй биш байгаа. Тийм учраас үүнийг ч гэсэн цаашдаа сайжруулж, оруулж ирэх, их шуурхай ажилладаг, төсөв, Үндсэн чиглэл, мөрийн хөтөлбөрийн биелэлт, хэрэгжилтэд тодорхой гүйцэтгэлийн аудит хийж байх ийм үйл ажиллагаа зайлшгүй шаардлагатай. Энэ чиглэлээр ч гэсэн энэ дүгнэлтэд тусгах нь зүйтэй гэж бодож байгаа.

Үндсэндээ ийм чухал саналууд гарлаа. Эдгээр саналуудыг тоймлож Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлье. Тэгээд ер нь бол цаашдаа мэдээж энэ дэгийг ч өөрчлөх хэрэгтэй юм шиг байна. Боловсронгуй болгох. Тэгэхээр ажлын хэсэг байгуулъя. Би өнөөдөр зарчмын хувьд энэ асуудлыг боловсронгуй болгохтой холбоотой ажлын хэсэг байгуулъя гэдгийг тохиръё. Дараа нь ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Эдийн засгийн байнгын хороотой хамтарсан ажлын хэсэг байж таарах байх. Үүнийгээ зөвлөлдөж байж дараагийн хурал дээр ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталъя гэж бодож байна.

**С.Дэмбэрэл:** нэг юм тодруулах гэсэн юм. Түрүүний институциудын хоорондын ажлын уялдаа гэдэг чинь. Би нэг тодорхой санал хэлсэн. Энэ ажлын уялдаа байхгүй, их муу. Ажлын уялдааг сайжруулах гэж давтах бол чухал биш. Хамгийн гол нь яагаад гэдэг цаадах шалтгааныг нь судлах хэрэгтэй байна. Тэнд баримтын эргэлт, цаасны эргэлт маш удаан байдаг юм. Нэг жишээг нь Батбаяр сайд өөрөө хэллээ. Ажлыг хийлгэхгүй гэсэн хууль байнаа. Худалдан авалт. Тэр бол үнэн. Жишээлбэл, 150 сая төгрөгний тендер зарлах гэж одоо 3 сарын өмнө 2 сарын 29-нд тендер нь зарлагдаад, 3 сарын 29-нд нээгдээд, 4 сарын 29-нд ялагч нь тодроогүй байгаа, гуравхан оролцогчоос. Тэгэхээр чинь зөвхөн энэ Засгийн газрын худалдан авалт буюу нийтийн хөрөнгө оруулалт дээр ийм удаан эргэцтэй байж байна. Гэтэл энэ Засгийн газрын дотор болон Засгийн газрын институци хоорондын, энэ ард иргэд, зорилтот группэд хүрдэг тэр баримт бичгийн өөрийнх нь эргэлт үнэхээр инээдэмтэй бөгөөд хамгийн үр ашиггүй байгаа юм. Тийм учраас түүнийг тодруулъя. Өөрөөр хэлбэл баримт, эргэлт



гэсэн томъёоллыг оруулаад, үүнийг хурдасгахын тулд Улсын Их Хурлын дэргэдэх Судалгааны төвд, энд олон улсын туршлага гээд байх юм байхгүй, зүгээр л Монголын засаглалын баримт бичгийн хурдац нь ямар байна вэ гэдгийг гаргаж ирээ гэсэн тийм судалгааг захиалах хэрэгтэй гэж би бодож байна.

### **Эдийн засагт “улсжих” бодлого яваад байна**

*УИХ-ын чуулганы Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны тэмдэглэлээс: Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх цээр:*

С.Дэмбэрэл: Талийгаач Б.Чимид гуай л их хэлдэг байсан юм, тэгээд би их зөв гэж боддог юм. Намууд төрийн дээр гараад байнаа гэж. Тэгэхээр энэ оруулж ирж байгаа юу чинь төрийн дээр гарах, намуудын одоо байгаа байдлыг гүнзгийрүүлэх гэсэн тийм зүйл л байна гэж ойлгогдоод байна. Уг нь бид чинь намуудыг төрийн дээр гаргахгүй байх ёстой, буулгах хэрэгтэй шүү дээ. Тийм л зорилгоор 3 ажлын хэсэг байгуулагдсан гэж би ойлгосон. Эсхүл одоо тэр Гэр бүлийн тухай хуулиндаа өөрчлөлт оруулахгүй юу. Тэгээд тэр хуулиараа /жишээ нь, ийм өөрчлөлт би санаачилж байна л даа/ “Тухайн гэр бүлийн нөхөр нь, эрх баригч намын гишүүн хүн байвал тэр гэр бүлийг намын харьяа гэж тооцно, тэгээд гэр бүлийн хэрүүл гарвал нам рүү явж шийдүүлнэ гэж оруулахгүй юу. Өөрөөр хэлбэл, нийгмийн амьдрал руу улс төрийн намуудын энэ төлөвшөөгүй байгаа харилцааг, тэгээд ч нийгэмд тэр бүр сайн зүйл өгөөд байдаггүй энэ институцийн хэлбэрийг ингэж улам гүнзгий нэвтрүүлэх гэсэн тийм юм орж ирэх гээд байнаа.

Тийм учраас саяны би үг хэлсэн хүмүүстэй санал нэг байна. Тэр ажлынхаа хэсэгт санал болгоод л өгчих, үүнийг. Энэ чинь тэгэх гэж л ажлын хэсгүүд байгуулагдсан. Жишээлбэл, Үндсэн хуульд өөрчлөлт оруулах эсэх талд би жишээ нь Цог гишүүнд хэлж байгаа юм. Шууд тэгж заасан юм бол одоо энэ жагсаалт гэдэг чинь таарахгүй, энэ чинь Үндсэн хуулийг өөрчлөх нэг шалтгаан биш юм уу? Эдийн засаг дээр гэхэд жишээлбэл, сүүлийн үед “улсжчилах” бодлого яваад байгаа нь Үндсэн хуульд заагаагүй шүү дээ, гэх мэтээр шалтгаанууд гарч ирээд байгаа юм.

Тийм учраас бодвол цаанаа их мундаг хууль талаасаа үндэслэл нь байж магадгүй. Наад хууль чинь миний хар ухаанаар ойлгож байгаагаар, нэг л биш байна. Үүнийг ажлын хэсэгтээ өгөөд, ийм заалтыг өөрчлөх ёстой байна гээд, энэ дээр ингэлээ гээд, өнөөдөр үүнийг хэлэлцэхгүй байлаа гээд энэ улсад юу ч болохгүй. Ийм л саналтай байна. Тийм ач холбогдол нь харагдахгүй байна.

## **Хараат бус Үндэсний Зөвлөлийн төсвийг яахаараа ерөнхий захирал баталдаг юм бэ?**

*УИХ-ын чуулганы Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны тэмдэглэлээс: Олон нийтийн радио телевиз дээр зарим хуулийн хэрэгжилттэй танилцсан дүнгийн тухай*

**С.Дэмбэрэл:** Би хоёр асуулт асууя.

1. Олон нийтийн телевизийн Үндэсний зөвлөлийн 2012 оны төсөв гэж байдаг уу? Төсвийг чинь хэн баталдаг вэ гэсэн ийм нэг асуулт байна. Төсөв гэж өөрийн үйл ажиллагаагаа явуулах төсөв гэж байдаг юм болов уу, байдаггүй юм болов уу?

2. Үндэсний зөвлөлөөс бас дахин асуумаар байна. Энэ олон нийтийн радио телевизийн бие даасан байдлыг хангасан, хуулийн дагуу хангасан ямар шийдвэрүүдийг 2013 оны эхний улирлын байдлаар гаргасан бэ? Өөрөөр хэлбэл бие даасан хараат бус тэр байдал нь хуулиар олгогдсон. Гэхдээ түүнийг хэрэгжүүлж байгаа шийдвэрүүд нь мэдээж Засгийн газраас гарахгүй шүү дээ, Үндэсний зөвлөлөөс л гарна. Яагаад гэвэл хараат бус шийдвэр гарах ёстой. Энэ шийдвэрүүд эхний улиралд ч гэдэг юм уу, шинэ Үндэсний зөвлөл байгуулснаас хойших хугацаанд хичнээн ийм шийдвэр гаргасан юм бэ гэсэн ийм тодруулга асуулт байна.

**Үндэсний зөвлөлийн дарга Л.Пүрэвдорж:** Үндэсний олон нийтийн радио, телевизийн тухай хуульд тусгай заалттай байдаг. Үндэсний зөвлөлийн ажиллах боломжийг ерөнхий захирал хариуцна гэсэн ийм заалттай. Оны төсөвт бол Үндэсний зөвлөлийн ажиллах тусгайлан заалт ордоггүй байсан. Энэ жил яриад, тусгай заалт оруулсан байна билээ. Нэг их зардал гээд байх юм байхгүй шүү дээ. Үндэсний зөвлөлийн гишүүд 250 мянган төгрөгний урамшуулал авдаг, хуулиндаа цалин түүнтэй адилтгах орлогын...

**С.Дэмбэрэл:** Би батлагдсан төсөв хэд вэ гэж асуусан юмсан!

**Л.Пүрэвдорж:** Өөр илүү хангамж байхгүй. Олон нийтийн радио телевизийн Үндэсний зөвлөлийн тусгайлсан төсөв гэж жилийн төсөвтөө, дотоод төсөвт тусдаг. Тэгэхдээ голдуу урсгалаараа яваад, ингээд гараад явчихдаг явж ирсэн ийм юутай юм билээ. Хараат бус байдлыг хангах талаар бол, бид нар дүрмээ шинэчилж авч үзсэн, шинэчилсэн бүртгэлтэй холбогдуулаад. Радио, телевизийн дүрэм гэж тусдаа дүрэм байдаг. Тэнд хоёр зүйлийг хуучин дүрмээс хасахаар санал оруулаад, хасагдаад ингээд явж байгаа. Тэр юу байсан бэ гэхээр, хуулиар бол Үндэсний зөвлөл стратегийн төлөвлөгөөг батална гэсэн. Тэгээд хөтөлбөр нь хуульд нийцэж байгааг хянана гэсэн ерөөсөө л ийм заалттай.

Хуучин дүрмэн дотор жилийн төлөвлөгөөг баталсан. Радио телевизийн дотоод журмыг батлахаар дүрмэндээ тусгаад, хэрэгжүүлээд явж байсан юм билээ. Үүнийг нь аваад үзэхээр хууль давсан дүрмэндээ ийм заалт орсон байсныг зогсоосон. Одоо жилийн төлөвлөгөөг батлахгүй байгаа. Дотоод журмыг батлахгүй, өөрснөө батлаад явж байгаа. Ер нь бол хараат байдлын тухай хуульд тодорхой заачихсан байдаг л даа. Ганц үндэсний

зөвлөл ч биш. Ерөөсөө радио, телевизийн удирдлага, ерөнхий захирлаасаа авахуулаад энэ албан тушаалтнууд бол яг нэвтрүүлэгт орохыг үндсэндээ хориглочихсон байгаа шүү дээ, хуулиндаа заалттай.

Жишээлбэл, тодорхой нэвтрүүлгийг эфирт гаргахыг зогсоох эрхийг нь заачихсан байгаа. Уг нэвтрүүлгийг бэлтгэсэн редактор, сэтгүүлч хоёр л нэвтрүүлгээ үзээд, хэрэв бодит байдалд тохирохгүй ч байгаа юм уу, худлаач байгаа юм уу, байвал эфирт гаргахыг зогсоох эрхтэй. Өөр хэн ч энэ эфирт гаргахыг зогсоох эрх байхгүй. Ерөнхий захиралд ч байхгүй, бусад улсуудад ч байхгүй. Тэгэхээр одоо эфирт гарахын өмнө хяналт байхгүй, ерөөсөө. Радиод ч байхгүй, телевизэд ч байхгүй. Тэгэхээр хараат бус байдал сэтгүүлчийнхээ хэмжээнд бүрэн хэрэгжиж байгаа гэж ингэж бодож байгаа.

Захиалга ирэх, тийм юм явуулаач гэсэн юм бол зөндөө ирнэ л дээ, намуудаас. Үндсэндээ хэрэгждэггүй юм шүү дээ. Заримд нь боломжгүй гээд хариу өгдөг, зарим нь хариу өгөхийн хэрэгч үгүй байдаг. Ийм л байдалтай байгаа.

**С.Дэмбэрэл:** Тодруулъя. Би төсвийг чинь л сонирхоод байна. Наранбаатараас асуудаг юм уу? Яг хичнээн төгрөг 2013 онд баталсан юм бэ гэдэг. Энэ өөрөөр хэлбэл хараат бусаар үйл ажиллагаа явуулах Үндэсний зөвлөл шүү дээ. Үндэсний зөвлөл, тэгээд яахаараа Ерөнхий захирал нь төсөв баталж өгдөг юм бэ? Ийм сонин сонин юм байх юм. Тэгээд хараат бус байдлын институци шүү дээ, энэ Үндэсний зөвлөл чинь. Тэгээд би түүнийг л асуугаад байна. Хичнээн шийдвэр гаргачихсан юм бэ? Ямар мониторинг хийсэн юм бэ? Ямар шийдвэр гаргав? Үүнийг асуугаад байхаар сэтгүүлчийн хараат бус байдалтай, сэтгүүлч нь хараат бус байвал тэгээд болно гэсэн үг үү, энэ яг юу гэсэн үг юм бэ?

**Л.Пүрэвдорж:** Ер нь сэтгүүл зүйн хараат байдал бол ерөөсөө сэтгүүлчийн л хараат бус байдал юм. Тийм учраас сэтгүүлчийн хараат бус байдал бол зөрчигдөхгүй байгаа гэж Үндэсний зөвлөл үзэж байна.

Үндэсний зөвлөлөөс олон шийдвэр гарсан л даа. Гол нь хуулиараа бол 20 сая төгрөгнөөс дээших бүх зардлыг гэрээ хэлцэл хийх, нэвтрүүлэг хийх бүх зардлыг гэрээгээр, Ерөнхий захиралтай байгуулсан гэрээгээр Үндэсний зөвлөл баталдаг. 20 саяас дээш бүгдээрээ Үндэсний зөвлөлөөр орж батлагдаж явж байгаа. Би тоолж үзээгүй. Бид нар чинь 4 удаа хурал хийгээд байна, он гарснаас хойш 4 удаа хуралдсан. Үүгээр нэг хурлаас гэхэд доод зах нь 4 тогтоол гардаг. Урсгал ажлын тогтоол. Стратегийн төлөвлөгөө баталсан тогтоол 10 онд гарчихсан, энэ оны сүүлчээр. Ажил хэргийн тийм том тогтоол гардаггүй, ер нь гаргаж бараг болох ч үгүй байх. Өөрөөр хэлбэл Радио телевизийн ажлыг заасан тийм тогтоол гаргах эрх Үндэсний зөвлөлд хуулиар байхгүй байгаа. Ерөөсөө л мөнгө төгрөгтэй холбоотой, гадаад арга хэмжээнд.

## Алтернатив ажлын хэсгийг ахлав

*“Санхүүгийн секторын шинэчлэлийн бодлого болон зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулах бодлогын альтернатив хувилбар боловсруулах Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл: /2013 оны 05 дугаар сарын 06/ Ажлын хэсэг бүрэн бүрэлдхүүнтэй / Ажлын хэсгийн ахлагч УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл, Монголын Банкны холбооны дэд ерөнхийлөгч Б.Найдалаа, Монголын Банк бус санхүүгийн холбооны ерөнхийлөгч А.Алтансүх, Монголын Санхүүгийн зах зээлийн холбооны ерөнхийлөгч О.Ганзориг, МҮХАҮТ-ын Нэгдсэн бодлого, төлөвлөлт, зохицуулалтын газрын дарга Ч.Нэргүй, Монголын Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны ерөнхийлөгч Т.Цогтбаяр, Монголын даатгалын холбооны ерөнхийлөгч М.Бат-Оргил, Хадгаламж зээлийн хоршоодын холбооны ерөнхийлөгч Ш.Гоохүц нар/ хуралдлаа. Ажлын хэсгийн гишүүн тус бүрээс ирүүлсэн саналын материалуудын талаар Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл мэдээлэл, тайлбар хийв. Зохих тоогоор хувилж, үзүүлэв.*

**С.Дэмбэрэл:** - Та бүхний ирүүлсэн материалуудыг механикаар нэгтгэхэд л овоо олон зүйл санал болж байна. Гэвч ирүүлсэн саналууд дээр нэмэлт боловсруулалт хэрэгтэй байна. Хэрэгжих хөтөлбөр, арга хэмжээнүүдийнхээ үр дүнг хэмжих заалт байх хэрэгтэй. Хүлээгдэж байгаа үр дүн, хэмжих хэмжүүр нь тодорхой байх ёстой. Шаардлагуудыг нь хэмжиж болохуйцаар тодорхой гаргаж ирэх хэрэгтэй байна. Үйл ажиллагааны төлөвлөгөө шиг юуг, яаж, хэн, хэзээ хийх вэ гэдэг нь тодорхой харагдах хэрэгтэй. Хэн хийх вэ гэхэд л төрөөс, хувийн хэвшлээс хэн хэн хамтарсан байдлаар байх ёстой вэ гэдгийг харуулмаар байна. Баг байх хэрэгтэй. Санхүүгийн шинэчлэлийг хийх гэж байгаа бол цоо шинэлэг арга барилаар хандах хэрэгтэй.

**Ө.Ганзориг:** - Өнөөдөр мөнгөний асуудлыг Санхүүгийн сектор гэхээсээ илүү Монгол банк л удирдаж байна. УИХ-ын ЭЗ-ын байнгын хороо удирдаж байх ёстой. Монгол банк зөвхөн мөнгөний бодлого л ярьж байна.

**Т.Цогтбаяр:** - Санхүүгийн бодлого алга. Хэдхэн асуулт асуухад л амархан уначихдаг. Инфиляци, үнийн өсөлтийн эсрэг яах вэ гэхэд л хариу өгч чадахгүй байна шүү дээ.

**С.Дэмбэрэл:** - Бид одоогийн Монголын Эдийн засгийн системийг өөрчлөх, шинэчлэх хэрэгтэй байна. Өрсөлдөөн байхгүй байхад ямар чүр дүн гарахгүй. Норвегийн туршлага гээд л яриад байна. Гэвч тэр нь муу засаглалтай үед хэрэгжихгүй. Хөгжлийн банк гэхэд л одоо банк санхүүгийн системээсээ гарч, төсвийн гадуурх санхүүжилт хийдэг, шуудай шиг юм боллоо. Санхүүгийн системд санаа тавьж, юм хийдэг Бодлогын зөвлөл алга. Юм хийгдэхгүй байна.

**Ө.Ганзориг:** - Модель л яриад байна. Хоосон онол яригчид, гадаад дотоодод рh.D хийсэн, ажил амьдралын туршлагагүй хүмүүс энд тэнд том том яриад, бодит юм огт хийгдэхгүй байна.

**А.Алтансүх:** - Хөгжлийн асуудлыг шийдэхэд төрийн болон төрийн бус байгууллага уялдаа холбоо бэх байж, хамтран шийддэг болохын тулд

мэргэжлийн холбоодын оролцоог хуульчилж оруулах зайлшгүй шаардлага байна. Тэгээд мэргэжлийн холбоод зохицуулах, гүйцэтгэх ажлыг ч хариуцдаг болгох шаардлага байна.

**С.Дэмбэрэл:** - Оруулж, оролцуулж байгаа хэлбэр байгаа боловч дандаа хагас дутуу оролцуулж, дулимаг үүрэг гүйцэтгүүлээд байгаа юм.

**Т.Цогтбаяр:** - Нэр зааж оруулбал том дэвшил болно. Эдийн засгийн байдлын тухай хуулинд ч оруулах л хэрэгтэй. Мэргэжлийн холбоод ч өөрсдөө стандартад орох хэрэгтэй. Ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх механизмаа ч бас давхар хийх хэрэгтэй.

**С.Дэмбэрэл:** - Та бүхний бичгээр ирүүлсэн саналууд зарим нь тодорхойгүй байна. Хэн юуг яаж хийх вэ гэдэгийг задлаж тодруулах хэрэгтэй. Маш нарийн зааж оруулахгүй бол бас л ерөнхий тойм байдалтай зүйл бас байна. Төрийн өмчит байгууллагууд байгуулж, экспортыг дэмжих тухай сайдууд, яамд ярьж явна. Гэтэл хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудад ямар хөшүүрэг хэрэглэж үүнийг хийлгэх тухай зүй нь ярьж байх ёстой юм л даа.

**Т.Цогтбаяр:** - Надад нэг санал байна. Засгийн газраас урт хугацааны бонд гаргах, суурь бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээний зээл, үл хөдлөх хөрөнгийг үнэт цаасаар арилжаалах...

**С.Дэмбэрэл:** - Ер нь энэ долоо хоногтоо багтаж ажлын хэсгээрээ дахин уулзая. Ялангуяа яаж хийх вэ гэдгээ нарийвчилцгаая. Гарцыг яаж хэмжихээ тодруулж бич. Төрөөс ялгаатай хувилбар байх хэрэгтэй. Харьцуулах боломж олгох хэрэгтэй. Бид хувийн хэвшлийнхэний хүч, нөөц, ур ухааны онцлогыг харуулахуйц санал, хувилбар дэвшүүлэх хэрэгтэй. Банкны Холбоо илүү тодорхой саналууд өгмөөр байна.

**А.Алтансүх:** - УИХ хууль баталдаг. Эдийн засгийн өөрчлөлтийг ч хуулиар баталгаажуулан хийх хэрэгтэй. Тиймээс санхүүгийн түвшинд ч төр хуувийн хэвшлийнхэний харьцааг хуульчилан баталгаажуулах хэрэгтэй.

**С.Дэмбэрэл:** - Эдийн засгийн байнгын хорооноос энэ бүх байдалд үнэлэлт дүгнэлт хийгээд өгдөг ч гишүүд уншихгүй, ойлгохгүй байна. Гүйцэтгэл дээр нь дандаа л төр хувийн хэвшил хамтарна гээд л оруулаад байгаа. Төр бодлогоо гарга, хяналтаа тавь, хувийн хэвслээр хийлгэ гэж л гаргаж байгаа. Засгийн газрын байгууллагуудаар хийлгэхээр л буруудаад байна шүү дээ.

**Ө.Ганзориг:** - Бид өмнө нь Эдийн засгийн байнгын хороон дээр нэгдмэл санал оруулж байгаагүй. Тиймээс үзүүлэнтэй илтгэл /PPP/ тавих хэрэгтэй.

**Ж.Бат-Орших:** - Бидэнд мэдлэг, чадвар, арга туршлагауд байна. Тиймээс хэний ч өмнө бодит, сайн саналууд гаргах, тайлбарлах, хамгаалах боломжтой гэж бодож байна.

**С.Дэмбэрэл:** - Бид хүлээгдэж байгаа үр дүнг арга замтай нь, өвөрмөц, шинэлэг юм л гаргах хэрэгтэй. Цөөхөн хоногын дараа, даруйхан дахиж уулзацгаая. Ажлын өдөр боломж олдохгүй бол амрадтын өдөр, хагас сайнд, МҮХАТ дээр уулзацгаая. Тэнд эхний бүтээгдхүүнээ базааж авцгаая. Юуг, хэн, ямар арга замаар, хэзээ, яаж хийх юм, Ямар үр дүнд хүрч, түүнийгээ ямар үзүүлэлтээр хэрхэн хэмжиж батлах юм бэ гэдгээ маш тодорхой гаргаж ирэх ёстойг дахин сануулъя. За одоо өндөрлөцгөөе.

## **Төрийн капитализмын хамгийн муу хэлбэр Монголд ноёрхох тийшээ болоод явчихлаа**

**УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2013 оны 05 сарын 14 өдрийн хуралдааны тэмдэглэлээс:**

Хэлэлцсэн асуудал:

1. Үнэт цаасны зах зээлийн тухай /Шинэчилсэн найруулга/ Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах, Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд /анхны хэлэлцүүлэг/
2. "Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл / хэлэлцэх эсэх/
3. "Монгол Улсын хууль тогтоомжийг 2016 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлийг батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ/
4. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны үйл ажиллагааны тайлан
5. Улсын төсвийн болон Хөгжлийн банкны санхүүжилтээр 2013 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлын явц, байдлын талаар Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярын мэдээлэл сонсох
6. "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах тухай" Байнгын хорооны тогтоолын төсөл

С.Дэмбэрэл: Ерөнхийдөө, өмнөх жилүүдэд байсан хууль тогтоомжийн биелэлт, хууль баталж хэрэгжүүлсний үр дүн нь эргээд тэр хуулиудыгаа өөрчлөх, шинэчлэх, засварлах, хүчингүй болгох шаардлагад хүргэж байгаа. Үүнийг зохицуулалтын реформ гэж нэрлэдэг. Яг энэ процесс хууль зүйн баримт бичигт туссан байх ёстой гэж би ойлгодог. Өөрөөр хэлбэл, зохицуулалтын шинэтгэл нь хуулиар зохицуулагдаад явж байна. Гэтэл тэр нь хэтэрсэн зохицуулалт болж хувираад, хүний болон бизнесийн амьдрал руу хэт их орж, эргээд хүнд суртал, хээл хахуул, авилгал үүсгэдэг. Үүнийгээ бид, засгийн газар цөөлөх гээд арван ажлын хэсэг гарсан байна.

Тэгэхлээр асуулт бол. Түрүүн Л.Энх-Амгалан гишүүн асуусан. Ерөөсөө энэ төрийн зохицуулалтанд limit /хэм хэмжээ/ хийсэн, хязгаарласан тусдаа хуультай байж болохгүй юу? Надад "Төрийн зохицуулалтын тухай хууль" гэж байж болохгүй юу гэж дандаа бодогддог. Тэр нь төр ямар үед, хэзээ, яаж, ямар арга хэрэгслээр, хэрхэн эдийн засаг, бизнесийн амьдрал руу орох вэ гэдгийг зохицуулж өгвөл зүгээр санагддаг. Тэгэхгүй бол өнөөдөр, тэр хэлээд байгаа төрийн капитализмын хамгийн муу хэлбэр чинь /гэхдээ зарим хүмүүсийн хэлдэгээр хамгийн сайхан хэлбэр нь/ Монголд ноёрхох тийшээ болоод явчихлаа.



Энэний үр дүн бол хоёр дахь Эрдэнэт, Таван толгой, гэх мэтийн энэ ард түмний гэсэн нэрээр /үнэн хэрэг дээрээ зүгээр л төрийн өмчийн/ компаниуд үүсгэх гэсэн төрийн дуршил-апетит /хорхойсол/ маш их нэмэгдэж байна. Үүнийг яаж 2016 он хүртэлх энэ юмнуудаар чинь, хууль эрх зүйн талаас нь хязгаарлах юм вэ? гэсэн эхний асуулт байна.

*Хоёрдугаарт.* Өдий хүртэл орж ирсэн засаглалын замын зураг буюу баримт бичгийн замын зураг, технологийг үзээд байхаар, /би үүнийг сүүлийн үед их хэлж байгаа/ энэ чинь өөрөө ажлыг асар их удаашруулж байна. Тендерийн хугацаа л гэхэд 50-700 өдөр саатаж байх жишээтэй. Зөвхөн засгийн газрын бараа үйлчилгээний худалдан авалт дээр, дотоод бичиг баримтын эргэлт, засаглалынхаа баримт бичгээ хурдасгах чиглэлээр ямар хууль, тогтоомж, төлөвлөгөө тусгагдаж байгаа вэ? Өөрөөр хэлбэл, засаглалын замын зургийг маш оновчтой болгож, доторх баримтын эргэлтийг түргэн шуурхай болгох замаар шийдвэр гаргах үйл явцыг илүү чанартай бөгөөд хурдан болгох энэ чиглэлд ямар хууль тогтоомж 2016 он хүртэл төлөвлөгдөж байна вэ? энэ хоёрдугаар асуулт.

*Гуравдугаарт,* энийг одоо хэн хийх ёстойг нь бүү мэд. УИХ-ын дэгийн тухай хууль, УИХ-ын тухай хууль, тэгээд нөгөө урт нэртэй хууль зэрэг энэ хуулиудыг чинь хэн өөрчлөх, хэн сайжруулах юм вэ? Тэгэхгүй УИХ-ын болон байнгын хорооны ажлаа хийдэг энэ гишүүдийн маань хууль тогтоох үйл явцад бүрэн бөгөөд өөрийнхөө бүх хүч потенциалыг дайчилж оролцох, мэдлэг мэргэжлээ шингээх явц нь тодорхой дэг, цагт хязгаарлагдаад байна. Энийг зохицуулсан хуулийг УИХ-ын гишүүд өөрснөө санаачлах ёстой юм уу? Аль эсвэл хууль тогтоомжийг хариуцаж байгаа засгийн байгууллага нь санаачлаад оруулах ёстой юм болов уу? Нэг ийм асуулт.

Өөрөө түрүүн **Арбитрын хууль** гэж дурдлаа. Энэ их чухал, маш зөв. Гэхдээ өмнөх засгийн үед 81 хууль дээр Германы технологийн хамтын үйл ажиллагааны тусламжтайгаар үг үсгийн засвар оруулаад, хуулийн их цэвэрлэгээ гэдэг нэрээр явагдсан. Одоо ч явагдаж байгаа гэж бодож байна. Гэхдээ тэр бол үг үсгийн цэвэрлэгээ байсан гэсэн. Одоо агуулгын их цэвэрлэгээ хэрэгтэй. Тэгэхгүй бол, маш олон хөтөлбөр хэрэгжихгүй байна. УИХ-ын баталсан маш олон хуулиуд худлаа хэрэгжиж байна, хэрэгжихгүй байна, эсвэл дутуу хэрэгжиж байна. Энэ бүхнийг нэгтгээд, хуулийн их цэвэрлэгээг энэ төлөвлөгөөн дотор оруулаад, хэрэгжихгүй байгаа хөтөлбөрүүдийг хүчингүй болгох хэрэгтэй, /тийм санал оруулж ирэх ёстой./ эсвэл хэрэгждэг болгох талаас нь юм хийхээр төлөвлөх хэрэгтэй.

Арбитрийн хуулийн хувьд бол, өмнөх парламентийн үед нэг их мундаг орос хэл мэддэг хүмүүс, /аягүй сайн “төгс төгөлдөр” орос хэлтэй хүмүүс/ эдийн засгийн сүүл энэ тэр гэсэн юм яриад, өрсөлдөөн үүсгэнэ барина гэсэн дэлхий ертөнц дээр байхгүй тэнэг юм яриад, ийм байдлаар өөрчлөөд, тэгээд арбитрийг хэд хэдэн газарт байж болохоор тусгасан. Гэхдээ энэ нь арбитрийн цаашдын хөгжилд тус болсон. Гэхдээ өнөөдрийг хүртэл хаана ч арбитр үүсээгүй. Гэхдээ Монголын үндэсний арбитр дотоодын болон гадаадын түвшинд явж л байгаа. Тэгээд Арбитрийн хуулин дээр, шүүх, арбитр хоорондын уялдаа холбоог тогтоосон тэр хуулин дээр нь хүртэл арбитрын заалтууд байдаггүй. Тийм учраас энэ талаас нь та бүхэн анхаараасай гэж хэлж байгаа юмаа. За баярлалаа.

**Х.Тэмүүжин:** С.Дэмбэрэл гишүүний асуултанд хариулъя. Төрийн зохицуулалт, төрийн капитализм үүсээд байна гэдэг энэ шүүмжлэл судлаачдын зүгээс ч олон төрлөөр гарч байгаа. Бид болбол нэг зүйлийг зарчмын хувьд маш зөв ойлгох ёстой. Бидний эрх зүйт, хууль эдлэх зарчим бий болгож байгаа энэ чөлөөт нийгэмд бол төрд зөвшөөрснөөс бусдыг нь хориглох ёстой. Иргэд, бизнес эрхлэгчид бол хориглсоноос бусдыг нь зөвшөөрөх ёстой гэдэг ийм нэг зарчим явж байгаа. Энэ зарчмыг одоо хэрэгжүүлэхийн тулд бизнес эрхлэгчдийн хүрээнд юу гарч ирдэг вэ гэхлээр төрийн зрхицуулалт бол хүний эрхийг хангах, зах зээл дээрх өрсөлдөөн боловч зах зээл дээрх хүний эрхээс дээш тавьсан стандарттай холбоотой асуудал гарах юм бол үүнийг өөрийн зохицуулалтаар хийнэ гэдэг ийм зарчим байгаа. Монголд бол өнөөдөр өөрийн зохицуулалт байхгүй байгаа. Тэр дундаа мэргэжлийн холбоод өөрснөө стандарт тогтоох байдлаар бизнесээ, зах зээлээ, тодорхой хэрэглэгчидтэй найдвартай болгох, найдвартай чанартай үйлчилгээ үзүүлэх ийм чиглэл байхгүй байгаа. Өөрийн зохицуулалтыг бүртгэхдээ холбоотой биш төрөөс манай хууль тогтоомжоор хийж өгсөн Стандарт хэмжил зүйн газар гээд. Тэгсэн чинь стандарт хэмжил зүйн газар нь өөрийн зохицуулалтыг стандарт болгож бүртгэх тухай биш төрөөс тогтоосон стандартуудыг бүртгэж хэрэгжүүлэх байгууллага болоод хувирсан, чиг үүрэг нь алдагдсан байж байгаа. Гэх мэтчилэн энэ алдаатай байгаа зүйлүүдийг яаж зохицоор нь шинэчлэх вэ гэдэг зүйлээ харах ёстой. Засгийн газрын орчинд, бизнес эрхлэлтийн орчинд өөрийн хүлээн зөвшөөрөх, өөрийн зохицуулалтыг өөрсдөө хянах мэргэжлийн холбоодын эрх мэдлийг хүлээн зөвшөөрөх энэ хүрээнд, түрүүн би хэлсэн төрийн тодорхой чиг үүргийг мэргэжлийн холбоод бол нийгмийн байгууллагадаа шилжүүлэн асуудлыг бид зохицоор нь шийдэх ёстой. Энэ бодлого бол засгийн газрын мөрийн хөтөлбөрт орсон байгаа. Энэ бодлого, төлөвлөлт, энэ хууль тогтоомжийг 2016 он хүртэл шийдвэрлэх үндсэн чиглэлд тусгагдсан байгаа. Тийм учраас таны саяны ярьсан аль болох төрийн гар хөл оролцохгүй байх гэдэг бол нэг л зарчимтай. Хоолны газраас иргэд хордлого авахгүй байх гэдэг төрийн тогтоож байгаа стандартын асуудал. Энэ хоолны газар ямар түвшний үйлчилгээ үзүүлдэг вэ, бизнесийн болон зах зээлийн хэр нэр хүндтэй гэдэг вэ бол тэдний холбоо, өөрсдийн бизнес эрхлэгчдийн мэргэжлийнх нь удирдлагатай холбоотой асуудал. Хуулиар бол бид үүнийг хийж байгаа.

**С.Дэмбэрэл:** Ямар хуулиар?

**Х.Тэмүүжин:** үүнийг бид 4 төрлийн хуулиар хийж байгаа. Төрийн зохицуулалтыг гэрээгээр гүйцэтгэх асуудлыг хуулиар хийж байгаа. Захиргааны үйл ажиллагааны ерөнхий хуулиар төрийн үйлчилгээтэй холбоотой хэсгээ нарийвчлаад хуульчилаад өгчихнө. Дээр нь стандартын хэмжил зүйтэй холбоотой нөгөө байгууллагад өөрчлөх замаар стандартыг нь яаж бүртгэдэг юм энэ стандартаа бариад мэргэжлийн холбоо хяналтаа яаж тавьдаг юм. Энэ хяналтынхаа хүрээнд ямар хариуцлага тооцдог, зэрэглэл эн тэр гэсэн өөрийн дүрмээрээ өөрийн зохицуулалтаар юу хийх юм вэ гэдгийг тодорхой болгоод өгчихнө. Энийгээ дагалдуулаад холбоотой маргаан гарвал шүүх рүү явах уу, эсвэл арбитраг очих уу гэдэг хувилбаруудыг нь хийгээд өгчихнө. Дээр нь шүүх, арбитраг очихгүйгээр наана илрүүлэх

зохицуулах систем бас ажиллаж болно. Ийм байдлаар нилээн цогц бодлого төлөвлөж байгаа.

- Засаглалын шийдвэр гаргалтыг яаж хурдан болгох вэ? Үнэхээр энэ засаглалын шийдвэр гаргалт хир зэрэг цэвэр байна, хир зэрэг хурдан байна, хир зэрэг үр ашигтай байна гэдэг төрийн үйл ажиллагаа хуулийн систем хөгжлийг дэмжиж байна уу гэдэг дээрээ чухал болно. Үүнтэй холбоотой бас нэлээд хуулиудыг боловсруулж байгаа. Тэрний гол хууль нь Засаглалын шийдвэр гаргалт ерөнхий зарчмуудыг тодорхойлж өгдөг. Захиргааны үйл ажиллагааны ерөнхий хууль гэдэг хууль гаргаж өгч байгаа. Бид захиргааны шүүхтэй болсон боловч иргэд төрийн үйлчилгээний үйл ажиллагаанаас болоод хохирлоо, шийдвэрээ удаан гаргалаа, эсвэл шийдвэр гаргахгүй бидний бизнесд хохирол учрууллаа гэдэг асуудлыг хэмждэг хуулийг нь гаргаж өгөөгүй байсан. Одоо бол захиргааны ерөнхий хууль боловсруулагдаж байна. Намар гарах байх. Яг энэ хуультай холбоотой хууль зүйн яамаар төвлөрсөн ажлын хэсэг байгуулаад ажиллаж байсан. Энэ бол ерөнхийдөө эцсийн шат уруугаа орсон байгаа. Намар гэхэд ороод ирэх байх. Таны түрүүний асуусан хууль болон бусад УИХ-ын шийдвэрийн төсөл өргөн мэдүүлэх журмын тухай хуулийг хэн сайжруулах вэ гэсэн асуудал хөндөгдсөн. Монгол улсад хууль тогтоомжийн нэгдсэн систем тогтоодог, хоорондоо зөрчилгүй байхад анхаардаг чиг үүрэг бол хууль зүйн яам дээрээ байгаа. Энэ чиг үүргийнхээ хүрээнд, үүнийг яам зөвхөн боловсон хүчнийхээ эсвэл өөрийнхөө үйл ажиллагаагаар хийхээс гадна бас хэмждэг метртэй байх ёстой байна. Яагаад гэвэл, хууль санаачлагч 3 субъект байгаа гэж би түрүүн хэлсэн. Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүдийн зүгээс хууль бас санаачлагддаг. Тэрийг бас яамны нэг аргачлалаар хэмжиж болохгүй юм байна. Энийг хуулиар хэмжих ёстой юм байна гэдэг үүднээсээ УИХ-ын бусад шийдвэрийн төсөл өргөн мэдүүлэх журмын тухай хуулийг өөрчлөөд, бид хуулийн... энүүгээр засгийн газар ч байна уу, ерөнхийлөгч байна уу, УИХ-ын гишүүн ч байна уу, хэрвээ та хууль боловсруулах гэж байгаа бол хэрэгцээ дараалалаар тодорхойлно шүү, хуулиа нэг хэлбэрээр бичнэ шүү, хуулиа бичихдээ энэ хуулинд өртөж байгаа эрх ашиг нь хөндөгдөж байгаа бүлгүүдтэй заавал яриа хэлэлцээнд орно шүү гэдэг ийм дүрмүүдийг тодорхой болгож хууль болгон өгч байгаа. Харин УИХ-ын зохион байгуулалт, дотоод үйл ажиллагаатай холбоотой хуулийг бол засгийн газар санаачилж чадахгүй (болохгүй). Яагаад гэвэл УИХ, засгийн газар хянах гэж байхад, хянагдах гэж байгаа субъект нь “Та нар ингэж ажиллавал зүгээр үү?” гэсэн санал оруулж ирнэ гэдэг бол зохимжгүй. Тийм учраас энэ бол УИХ-ын, гишүүдийнх нь өөрсдийнх нь ажил. Өөрсдийнхөө хийх ажлыг ямар дэгтэй, ямар бүтэцтэй байлгах юм, ямар хэрэгжилтэй байлгах юм, тэр л зохицуулалтаа УИХ-ын гишүүд өөрсдөө хийгээд, хуулийн төсөл өргөн мэдүүлж байх учиртай гэдэг үүднээсээ энэ уруу ороогүй байгаа.

**С.Дэмбэрэл:** Н.Батбаяр сайдаас тодруулья.

Энэ улсын эдийн засгийн хөгжил нь цаашдаа, Таван толгой гэх мэтийн төрийн өмч ч юм шиг, үнэн хэрэг дээр олон нийтийн өмч ч юм шиг байдлаас хамаарсаар явах уу? Иргэд нь хувьцаа эзэмшигч юм шиг мөртлөө, тэр хувьцаа нь энэ дэлхий дээр хаана ч байхгүй. Тэрнийгээ ерөнхий сайд болон та нар тайлбарлахдаа “Өө, гайгүй болно. Хэдэн жилийн дараа...” гэж ярих

юм. Ийм байдлаар 2016 он хүртэл явах уу? Ер нь үүнийг одоо больвол яасан вэ? Ерөөсөө энэ чинь 2008 оноос л үүдэлтэй юмнууд шүү дээ. 1 сая, 1.5 сая төгрөгний амлалтаас л үүдэлтэй. Тэгээд л нөгөө баялаг маялаг гэж ярьсан. Тэгээд үүний чинь өөрийнх нь ерөнхий концепци нь шударга юм шиг харагдаж байгаа мөртлөө үнэн хэрэгтээ маш шударга биш зүйл байгаа байхгүй юу. Баялагийн хуваарилалын маш шударга биш хувилбар байхгүй юу. Өөрөөр хэлбэл, бүгдэд нь тэгшитгэн хуваарилах гэсэн зарчимтай. Энэ улс чинь энэ чигээрээ цаашаа яваад байх юм уу? Тэрийг л би төрийн капитализмын нэг хэлбэр нь гээд байгаа юм. Тэр тусмаа бүр маш муу хэлбэр нь. Тийм учраас би Монгол улс Моголистан болж болохгүй шүү гэж хэлдэг. Тийм учраас энэ нь дээр та нэг өөрийнхөө, хувь хүний бодлыг хариулаад өгөөч. Би үүнд үнэмшдэг гэдэг ч юмуу, ингэж хөгжих нь зөв гэсэн итгэлтэй байна гэдэг ч юм уу, тэр бодлоо нэг хэлээд өгөөч.

**Н.Батбаяр:** Монгол улсын эдийн засгийн хөгжил, ирээдүйн асуудлыг хариуцсан сайдын хувьд энэ асуудалд байнгын хороон дээр мэдээлэл өгье гэсэн бодолтой байгаа. Одоо зөвхөн С.Дэмбэрэл гишүүний асуултанд хариулая гэх юм бол Монгол улс эртнээсээ газар доорх биш, газар дээрх баялагаа ашиглаж амьдарч ирсэн түүхтэй. Сүүлийн хэдэн жилд, өөрөөр хэлбэл сүүлийн зуу хүрэхгүй жилд л газар ухдаг ажил руу орсон. Цаашдаа яах вэ гэдэг дээр бол... Өнөөдөр Монгол улсын тэргүүлэх салбар бол ХАА-н салбар мөн. Түүн дотроо МАА-ын салбар. Хоёрдахь нь уул уурхай, эрдэс баялагын салбар. Гурав дахь нь тээвэр үйлчилгээний салбар гэсэн чиглэлээр бид асуудлыг харж байгаа. Түүхээрээ бид энэ том газар нутагт нүүдлийн МАА-р л амьдарч ирсэн учраас үүнтэйгээ маш их холбоотой. Уул уурхайн хувьд, мэдээж, энэ бол шинэ салбар. Дэлхийн зах зээл дээр эрэлт хэрэгцээ өссөнтэй холбоотойгоор 2006 оноос энэ асуудал гарч ирсэн. Эдийн засгийн эрэлт, ашгаасаа хамаараад 2 бүтээгдхүүн /зэс, төмөрийн хүдэр/ гарч ирсэн. Энэ 2 нь манай экспортын бүтээгдхүүний 1 ба 3 дахь бүтээгдхүүн болчихсон байна. Манай экспортын 85%-ыг зэс, нүүрс, төмрийн хүдэр, нефть, цайр гэсэн 5 бүтээгдхүүн эзэлж байгаа. Энэ нь бидэнд бодох юм их байгааг харуулж байна. Монгол орны газар бүрт уул уурхай эхлүүлээд, ухаад байх юм уу гэдгээ эргэж харах ёстой. Хэрэгцээнийхээ хэрээр ашиглах ёстой болохоос, хүний авъя гэсэн хэрээр өгөөд байж болохгүй гэж боддог.

**С.Дэмбэрэл:** Үгүй ээ, би уул уурхайн асуудалд төрийн оролцоо ингээд ороод явах юм уу л гэж асуугаад байна л даа.

**Н.Батбаяр:** Төрийн оролцоо тодорхой хэмжээнд зайлшгүй байх ёстой гэж би үздэг.

**С.Дэмбэрэл:** Ямар хэмжээнд вэ?

**Н.Батбаяр:** Төрийн хувьд өмчийн болон менежментийн оролцоо гэсэн 2 оролцоо бий. Тэр өмчлөгч байж болноо. Тодорхой хэмжээнд байх ч ёстой байх. Тийм үү? Харин менежмент нь хувийнх байх ёстой гэж үздэг.

## **С.Дэмбэрэл гэдэг хүнийг юуны төлөө явдгийг бизнесийн хүрээнийхэн ихэнх нь мэддэг**

*ТОВСНОО.МН цахим хуудасны сурвалжлагч УИХ-ын гишүүн,  
МҮХАҮТ-ын дарга С.Дэмбэрэлээс дараахь сурвалжлагыг авчээ.  
2013-06-15*

**- МҮХАҮТ-ын шинэ байрны 49 хувь нь таны мэдэлд байдаг юм уу?**

- Энэ байрны тухай тодорхой, сайн ярихгүй бол ямар ч мэдээлэлгүй хүмүүст, хүний ой ухаанд ормооргүй, С.Дэмбэрэл гэдэг хүний бүх амьдралынх нь туршид баримталж ирсэн зарчимд харш мэдээлэл нэлээд гарч цацагдсан. Бичсэн хүнийг нь зэмлэхээсээ илүү би өөрийгөө жаахан зэмлэж байна даа. Яагаад гэвэл манай энэ танхимын байрны тухай албан мэдээлэл олон түмэнд ер байдаггүй, бид ч огт хүргээгүй юм байна. Энэ бол МҮХАҮТ-ын байранд зориулж БНХАУ-аас Монгол улсад өгсөн буцалтгүй тусламжийн барилга. Буцалтгүй тусламж нь хуулиараа 100 хувь төрийн өмчинд байдаг юм. Тэгэхээр яаж ч бодсон танхимын дарга 49 хувийг нь хувьдаа авах үндэслэл байхгүй. Бид Ерөнхий сайд, Сангийн сайд болон ТӨХ-нд хүсэлт гаргачихсан байгаа. Нэгэнт л МҮХАТ-ын байр юм чинь энэ танхимын нэр дээр шилжүүлж, өмчлөлд нь оруулж өгөөчээ гэж хүсэлт тавьчихсан байгаа. Энэ жил манай танхимын 50 жилийн ой болж байгаа. Манай төр засгаас байрны өмчлөлийн асуудлыг шийдээд өгвөл том бэлэг болно гэж горьдож, найдаж байгаагаа танай сониноор уламжлаад хэлчихье. Ер нь хувийн хэвшлийнхэн өөрийн гэсэн ордонтой болсон нь сайн хэрэг. Энд хүмүүс ирдэг, цуглардаг, мэдээлэл авдаг, сургалтанд хамрагддаг, бодлогынхоо өмгөөллийг хийдэг, хурал зөвлөгөөнөө хийдэг ийм сайхан газартай болчихсон. Ямар ч гэсэн МҮХАҮТ-ын 50 жилийн түүхэнд анх удаа өөрийн гэсэн байртай болж байгаа юм. Энэ нь С.Дэмбэрэлийн гавьяа гэхээсээ илүү МҮХАТ-ын бодит байдлыг ойлгож дэмжсэн Хятадын засгийн газарт талархах хэрэгтэй. Бид яахав их хөөцөлдсөн л дөө. Миний мөрийн хөтөлбөрт танхимыг өөрийн гэсэн байртай болгоно гэж амлачихсан байсан. Би амласнаа хэрэгжүүлэх гээд зүтгэдэг нэг “хөгийн” зантай. Амлалтаа хэрэгжүүлж байгаа ухаан маань л энэ.

**- Та танхимыг удаан удирдлаа шүү?**

- 10 гаруй жил болж байна. Нуруугаа автал зүтгэж байна. Сая “Яргуй идсэн ямааны мах” гэсэн махны амталгаа явууллаа. Ямаа проблем болж байна. Тэгэхээр ямааны махны экспортын боломжийн талаар презентаци хийнэ. Танхимын экспортыг дэмжих газар үүнийг дэмжээд явна. Өнөөдөр Тавантолгой гээд л, бүгд халуурцгааж байна. Тэгтэл ард түмний амьдрал хэцүүдэж байна. Одоо Голландаас жижиг тоног төхөөрөмж хонины ноосыг хамгийн нарийн хэсгийг аваад утас хийдэг модон иж бүрдэл тоног төхөөрөмж ирж байна.

**- ДНБ-ий 80 гаруй хувийг хувийн хэвшил бүрдүүлдэг. Та бизнесмэнүүдийг 10 гаруй жил удирдсан хүн өөрөө ямар бизнес эрхэлдэг вэ?**

- Надад бизнес хийх зав ч байдаггүй. Ганц нэг дүүгээ бизнес эрхлэхэд нь зөвлөх маягаар явдаг. Бизнес эрхлэх орчныг нь бүрдүүлдэг байгууллага нь



танхим. Энэ ажил хүнээс асар их цаг, мэдлэг шаарддаг. Монголын хувийн хэвшлийнхэнийгээ гадаадад танилцуулдаг. Зарим дарга нар өөрийнхөө үндсэн ажлаа мартчихаад, өөрийнхөө хувийнхаа бизнесийг хөөгөөд байдаг. МҮХАҮТ-ын дарга гэхээр асар том бизнестэй гэж боддог байх. Тийм юм байхгүй.

- **“Corporate” зочид буудал таных биш үү?**

- Биш, манай дүү болон дүүгийн найз нарын хамтарсан зочид буудал. Тэр 4 одтой мөртлөө үйлчилгээ маш сайтай, гоё зочид буудал. Манай бүх клипүүд тэнд зураг авалт нь хийгдэж байна.

- **Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрийн дарга байсан Ганболдыг таны дүү гэдэг байхаа?**

- Манай төрсөн эгчийн хүүхэд. Багаасаа надтай хамт байсан миний “школа”-тай хүн. Мэдэл боловсрол, хүмүүстэй харилцах соёл, даган дууриах талаас нь би их нөлөөлсөн. Тэр хүн зөв бизнесмэн байх, зөв бодолтой, сайхан сэтгэлтэй байх ёстой гэж их сургадаг байсан. Миний урмыг хугалж байгаагүй. Сайн залуу. Одоо л янз бүрээр бичээд байгаа болохоос Дарханы хар төмөрлөгийн үйлдвэр “0” заачихсан газар байсан. Одоо 10 хэдэн тэрбумын ашигтай үйлдвэр болгосон. Аймаар их юм хийсэн байгаа биз дээ? Одоо гэтэл ямар их хэл ам гарч байна. Ийм залуу хүн мөртлөө “Алтан гадас” аваад, дахиад бас нэг одон авсан шүү.

- **Одоо АТГ шалгаж байгаа гэдэг. Юу болж байгаа бол?**

- Тэр худлаа, шалгаад юу ч гарахгүй. Бид хоёрыг холбохоос өөр аргагүй, ах дүү хоёр юм чинь. Сайнаар холбогдоно, муу юм гарвал ч бас холбогдоно. Азаар Самбуугийн удмынхан одоогоор өдий насалтлаа муу юманд холбогдоогүй л явж байна. Ямар ч гэсэн С.Дэмбэрэл гэдэг хүнийг юуны төлөө явдгийг бизнесийн хүрээнийхэн ихэнх нь мэддэг. Энэ ерөөнд хөдөө орон нутагт жижиг бизнес эрхэлдэг иргэнээс эхлээд манай бизнесийн алдартай томчууд бүгд ирнэ. Манай Монголын хэн ч мэдэхгүй жижиг компанийхан бүгд орж ирнэ. Миний ажлын онцлог амьдралыг бүтээж байдаг, ажлын байр бий болгодог хүмүүстэй л хамгийн их уулздаг газар даа.

- **Та хувийн бизнесгүй, тэгээд гадаад дотоодод Монголын бизнесмэнүүдийг төлөөлж их явна. Хэрэглээгээ яаж зохицуулах вэ. Ажил тань цаанаасаа “өндөр” байхыг шаарддаг биз дээ?**

- Миний сайдын цалинтай л ижилхэн. Сайдын цалинг сайн мэдэхгүй байна. Бодвол 600.000-700.000 төгрөг авдаг байлгүй дээ. Хувцаслалтын хувьд нэг их үнэтэй том брэнд өмсөөд байх шаардлагагүй. Хамгийн гол нь өөртөө тохирсон цэвэрхэн л байх ёстой. Би өөрийгөө мундаг гоё хувцасладаг гэж бодохгүй байна. Миний өмсөж байгаа костюм ямар ч брэнд биш, жирийн л нэг костюм. Гутал маань хөөрхий, сайндаа 100.000 мянгын л үнэтэй. Тааруулж өмсөх соёл их чухал. Би гадныхантай их уулздаг, Танхимын дарга нь гээд навсайсан юм сууж байж болохгүй биз дээ. Эхлээд миний хувцсаар угтана. Дараа нь би Монголынхоо тухай, эдийн засгийнхаа тухай ярина. Тэр хүнийг ангайтал ярьж чадвал, намайг ухаанаар минь үднэ. Ийм л зарчим баримталдаг. Гадаадад бол асар их уригддаг. Монголынхоо нөхцлийг дэлхийн эдийн засагтай холбоод, цаас харалгүйгээр шууд дуржигнуулаад ярьчихдаг учраас хурал удирдах,



модератор хийхээр ялангуяа сүүлийн жилүүдэд их уригддаг болсон. Олон улсын хурал удирдаж байна. Саяхан гэхэд Ази Номхон далайн худалдааг дэмжих перзентаци тавилаа. Сая захиа ирлээ. Ямар ч дүрэмгүй байгууллага л даа. “Мистер С. Дэмбэрэл. Сая болсон хуралд маш сайхан перзентаци тавьсан тул хэрэв татгалзахгүй бол урамшуулалд нь хэдэн доллар өгөх гэж байна. Үүнийг хүлээж авч болох уу” гэсэн утгатай. Одоо олон улсын байгууллагууд хувийн хэвшлийг их сонирхдог болсон. Хуучин үед засаг төртэй их харьцдаг байсан. Ямар ч асуудлаар хувийн хэвшилтэй харьцаж шийдвэр гаргасан нь хамаагүй үр дүнтэй болдог юм байна гэсэн энгийн үнэнийг ойлгочихсон учраас одоо ингэж өөрчлөгдөж байна. Ямар ч гэсэн Монголынхоо нэр хүндийг 100 хувь аваад гардаг хүн дээ. Үүгээрээ харин бардам онгирчихъё. Хүн хувцаслалт, үс, цаг, зангиа нь зохицсон байх ёстой. Би л хээгүй хүн гээд үүндээ анхаарахгүй байж болохгүй. Ер нь Америкууд маш муу хувцасладаг. Европ сайн, Япончууд сайн, Солонгос бүүр сайн. Азийн моод одоо Солонгосоос гарч байна. Гонконг Азийн моодны төв. Ази Европын соёл холилдсон, европжсон Азиуд тэнд байна. Манай Монгол их сайн, яагаад гэвэл даган дууриах чадвар сайн хөгжсөн. Солонгос залуучуудыг дууриагаад дорхноо л үс зүс, хувцсаа өөрчилчихдөг. Юмыг нутагшуулах чадвартай. Ааваараа жишээ авъя л даа. Манай аавын ЗИС-150 гэж модон хаалгатай машины тоормос элэгдээд хутга шиг болчихсон байсан гэсэн. Тэгэхэд л тэр хүн өөрөө янзлаад, 1 сая километр зам явна гэдэг гайхамшиг мөн биз дээ. Монгол залуус цахилгаанаар явдаг машин хийчихлээ. Би тэр машин дотор нь сууж, байшингаа тойрч үзлээ. Дажгүй юм билээ. Маш бага бензин иддэг юм байна. Манайхан бүтээх чадвар сайтай. Хээр талд байгальтайгаа харьцдаг хүний ухаан их тэлдэг. Дээр нь манай Монголын мах маш сайн. Арвайн гурил маш сайн. Би өглөө бүр арвайн гурил иддэг. Одоо арвайн гурилыг чулуугаар тээрэмдэж байна. Тэр нь бүтээмж муутай. Зэвэрдэггүй гангаар хийсэн гар тээрмийг Германаас авчрах гэж байна. Тэрийгээ арвайн гурил хийдэг хүмүүстээ лизингээр өгчихнө.

- **Таныг Топ модель Одгэрэлтэй сайн найз. Орцонд салж чадахгүй уйлалдаж байсан гэж бичигдэж байсан даа.**

- Одоо больё оо. Хэдэн жилийн өмнө нэг сонин дээр гарсан цуу үг байна. Одгэрэл манай шавь. Манай танхимын дэргэдэх Гадаад худалдааны академийг төгссөн л хүн. Ийм юм ярьсны хэрэггүй ээ. Тэр хүн ч тайван амьдраг, би ч тайван амьдаръя л даа. Тэр хүн өөрийнхөөрөө амьдраад яваг л дээ. Хөөрхий эмэгтэй хүн, тэрэнтэй намайг холбоод ч яах юм, хэрэггүй ш дээ. Тэр хүн чинь бодвол гэр бүлтэй, үр хүүхэдтэй хүн байгаа биз. Би ч гэр бүлтэй, ач зээтэй хүн. Эцсийн эцэст худал ташаа мэдээлэл чинь хэн хүнд буруу нөлөө их үзүүлдэг, их хортой зүйл юм шүү дээ.

- **Та архины рекламанд тоглож байсан. Өөрөө хэр хэрэглэдэг вэ?**

- Үнэнээ хэлэхэд, үе үе найз нартайгаа уулзахаараа л архи амсдаг. Виски, вино энэ тэрийг ууж чадахгүй. “Архи экспортонд гаргах гэсэн юм, дэмжээд өгөөч” гэсэн хүсэлтийн дагуу хэдэн үг хэлсэн. Архийг хүмүүс муугаар боддог. Архи гэдэг чинь юу гэсэн үг вэ гээч. Чапигийн хэлсэн нэг үг байдаг юм. Их гоёор тайлбарласан. Архины тухай ойлголтыг төлөвшүүлэх их сайхан үг. “А”-амтат, “р”-рашаан, “х”- хүндэт, “и”-идээ.

Амтат рашаан хүндэт идээ гэсэн үг байхгүй юу. Хүмүүс хэтрүүлэн, буруу хэрэглээд нэрийг нь унагаад байдаг. Архины рекламанд оролцохоор архи үйлдвэрлэгчид дургүйцэхээс гадна намайг мэддэг, хүндэлдэг хүмүүс их дургүйцдэг юм билээ. “Боль доо, та архины рекламанд тоглоод байх даа яадаг юм. Та архи сурталчлахаар бусад нь яах юм” гээд их олон мессеж ирсэн. Тэгээд рекламаа зогсоосон. Би урьд нь “Мобиком”-ын рекламанд оролцоод. Тухайн үед “Скайтел”-ийн Эрдэнэбат их гомдож байсан. “Та одоо МҮХАҮТ-ын дарга хүн. Нэг компанийнх нь рекламанд тоглоно гэдэг шударга бус байна ш дээ” гэсэн. Би ч ойлгож “Би танай рекламанд тоглоё” гэсэн. Гэхдээ тоглоогүй л дээ. Дараа нь уулзаад нэг орой караокед хамт ороод, жаал дуулалдаад, тайвшруулсан. Их сайн залуу байсан даа. “Мобиком”-ын рекламанд тоглоход надаар хэдэн үг магтаж хэлүүлэх гэж байсан л даа. Би өөрөө санааг нь гаргая гээд “Тайхамшигт ертөнц” гэдэг дууг тавиад би босоод явж байгаа олон үг хэлэхгүй реклам хийсэн л дээ. Одоо рекламанд тоглохгүй, танхимынхаа рекламанд л тоглоё.

- **Та рекламанд тоглохоор их зохидог. Шинэ дүр төрх гэдэг шиг. Ер нь рекламанд оролцохдоо хэр их мөнгө авдаг юм бэ?**

- Алинаас нь ч аваагүй. Тэд ч надад мөнгө өгөхөөс ичнэ биз дээ. Би авах ч үгүй.

- **Та унах машиндаа хэр ач холбогдол өгдөг вэ?**

- Танхимынхаа машиныг унадаг. Би жолоочийн хүүхэд. Миний аав Монгол улсын номер нэг жолооч байсан. Саятан жолооч Самбуу гэж хүн. Ямар ч засвар хийлгүй сая километр зам туулж, тээвэр хийсэн хүн шүү дээ. Энэ дэлхийг 22 удаа тойрсонтой адил тийм урт зам. Манайх 15 хүүхэд гараад, 7 нь тэсч үлдээд, 8 нь эндсэн гэдэг юм. Би яг дунд хүүхэд нь. “Хүргэн хүү” киноны Дэмбэрэлийг Санжидын Дэмбэрэл гэдэг дээ. Манай ээжийг Санжид гэдэг. Тийм учраас “Хүргэн хүү”-гийн Дэмбэрэл чинь бас би юм шүү дээ. /хошигнол/ Жолоочийн хүүхэд жолоочийн гентэй, машин мундаг барьдаг байх ёстой байх. Гэтэл би машин барьж чаддаггүй. Манай аав хүүхдүүдээ зориуд машин луугаа ойртуулдаггүй байсан. Энэ хүүхдийг багаас нь машин бариулаад байвал том болоод жолооч болчихно гээд өөрийнхөө мэргэжлийг эзэмшүүлэхгүйн тулд намайг машин руу ойртуулдаггүй, тэгээд машинд огт сонирхолгүй болгоод хүмүүжүүлчихсэн. Одоо машин жолоодож чадахгүй гэхээр хүмүүс гайхдаг. Би машин жолоодож чадахгүй, зүгээр машинд суух л хувь тавилантай хүн. Би хэзээ ч машин барьж сурахгүй. Тийм учраас тэр машины марк мэддэггүй, сонирхдоггүй.

- **Хүмүүсийн үнэтэй хөөргөн дунд таны модон хөөрөг их содон харагддаг?**

- Би хөөрөг сонирхдоггүй, өргөн сайхан бүс, ковбой малгайнд дургүй. Дээлээ цагаан сараар өмсөнө. Намайг олон хүн та хөөрөг бариач гэдэг байсан. Ямар хөөрөг барих вэ гэсэн чинь, ийм үнэт чулуу энэ тэр гээд аймаар үнэ хэлж байнаа. Би өөр хөөрөг барина гээд настай, маш мундаг урлаач сийлбэрч хүнтэй ярьж байгаад танхимынхаа логотой, эвтэй 4 амьтантай модон хөөрөг хийлгэсэн. Маш гоё болсон. Одоо Магван гуай ийм хөөрөг барьж байгаа. Би бэлэглэсэн юм. Хүмүүс маш их сонирхдог. Тайваньд үзэсгэлэнгээ гаргасан Эрдэнэчулуун гэдэг сийлбэрч залуу байдаг юм. Тэр “Би танд хөөрөг бэлэглэхээр шийдлээ” гэсэн. “Намайг модон хөөрөг

барихаар өрөвдөө юу?” гэсэн чинь “Үгүй яалаа гэж дээ. Танай байгууллага надад их тусалсан учраас би сэтгэлийн илэрхийлэл болгож танд бэлэглэж байгаа юм” гэсэн. Цул мөнгөн, аймаар хүнд хөөрөг өгсөн. Нэлээн үнэтэй байх. Одоо хоёр хөөрөгтэй болсон.

- **Мөнгийг хүн болгон шүтдэг. Таны хувьд юу гэж боддог вэ?**

- Дэлхий ертөнцийн хүмүүсийг 3 категорид хувааж болох юм байна. Нэгдүгээрт мөнгөнд удирдуулдаг хүмүүс, хоёрт мөнгийг удирддаг хүмүүс, гуравдугаар категори нь мөнгө ч байхгүй, удирдлага ч байхгүй хүмүүс. Дэлхий ертөнцийн хүмүүсийг хуваагаад үзэхээр пирамид хэлбэртэй. Пирамидийн ёроолд өдөрт 1 доллароос бага орлоготой 2 тэрбум хүн байна. Нэг хэсэг нь дунд хавьд нь байна. Билл Гейтс мэтийн хүмүүс орой дээр нь байна. Өнөөг хүртэл дээр нь сууж байгаа хүмүүс доор нь сууж байгаагаа боддоггүй байсан. Одоо боддог болж эхэлсэн. Компанийн нийгмийн хариуцлага гээд компанийн хөгжлийн шинэ модель гараад ирсэн. Яагаад гэвэл Билл Гейтс пирамидын орой дээр сууж байгаад өөрөө 100 ч хүрэхгүй насална гэдгээ мэдээд “Миланда болон Билл Гейтс” сан байгуулаад мөнгийг буяны байгууллага руу өгч байна. Мөнгийг удирддаг хүмүүс зөв удирдаж байна. Бас мөнгөнд удирдуулчихсан хүмүүс их байна. Ийм хүнийг монголчууд шинэ баян цээж өвчтэй гэж маш онож хэлсэн. Ийм хүмүүс олон байна. Мөнгийг удирдаж сураагүй, хөдөлмөрлөж чаддаггүй, хувь заяагаа бусдад эсвэл хаа нэгэн далдын хүчинд даатгачихсан хүмүүс бас их байна. Мөнгийг удирддаг хүмүүс нь аливааг зоосны нүхээр хардаггүй юм байна. Тэд нь Туул голын хоёр эрэгт нэг нь харшид, нөгөө нь гэрт амьдарч байгаа хүн байна. Тэр хүн нэг л агаараар амьсгална, нэг л замаар явна. Агаарын бохирдол баян хүнийг тойрохгүй. Мөнгийг удирдаж чаддаг байх ёстой гэж боддог. Миний өөрийн зохиосон ганц үг байдаг юм.”100 ч хүрэхгүй наслах байж, зөв амьдарцгаая хүмүүсээ” гэсэн зарчимтай. Бид бүгд 100 наслахгүй. Маш цөөхөн хүн л 100 хүрнэ. Ийм богинохон насанд зөв амьдарчихвал, ядахдаа үхэхэд оршуулган дээр олон хүн ирэх юм даа.

## **Авбал ав, байвал бай**

*УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 5 дугаар сарын 14-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс:*

**Байнгын хорооны дарга Б.Гарамгайбаатар:** - Хоёрдугаарт найруулгын санал, нэг удаа бүгдийг нь уншчих юм байна. ...Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн төслийг дагалдаж өргөн мэдэгдсэн зарим хуулийн төслийн талаар үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагалдан өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг холбогдох мэргэжлийн байнгын хороонд хэлэлцүүлэхээр шилжүүлэх. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль болон хувь хүний орлогын албан татварын тухай хууль ажлын хэсгээс тодорхой саналуудыг оруулахаар бэлтгэсэн байна. Тухайлбал, үнэт цаасны зах зээлд хадгаламжийн бичиг гаргаж арилжсан, хөрвүүлснээс үүссэн

орлого, мөн хувьцаат компанийн хувьцааны ногдол ашиг зэргийг татвараас чөлөөлөхөөр томьёолсон байна. Тус томьёоллыг хуулийн төслийн хамт төсвийн Байнгын хороонд хүргүүлэхээр шилжүүлж байна. Энийг бол зарчмын хувьд дэмжиж байгаа байх гэж бодож байна саналаа өгнө үү. 13 хүнээс 11 нь дэмжлээ.

С.Дэмбэрэл гишүүн зарчмын зөрүүтэй саналууд өгч байгаа юм байна. Энийг дөнгөж сая өгч байгаа учраас боловсруулж оруулахад төвөгтэй байна гээд байна даа. Зарим заалтууд нь давхцаж байгаа юм байна.

**С.Дэмбэрэл:** -Зарчмын зөрүүтэй, зөрүүгүй гэдгийг хэн ч өнөөдөр мэдэхгүй. Наад томьёолол чинь өөрөө утгагүй томьёолол. Тийм учраас наадах чинь энэ хуулинд сайжруулахад хэрэгтэй санал гээд өгч байгаа зүйл. Тэрийг авбал ав. Авахгүй бол орхичих. Тэгээд болоо.

**Б.Гарамгайбаатар:** - Юу гэнэ вэ. Одоо энийг чинь хураалгахаар нэг бүрчлэн хураах болно шүү дээ.

С.Дэмбэрэл: -Зарчмын зөрүүсээд байх юм байхгүй. Энэ дээр найруулгын шинж чанартай зарим зүйлүүд байгаа. Энэ үнэт цаасны зах зээл дээр ажилладаг зарим төрийн бус байгууллагуудыг тодотгосон зарим зүйлүүд байгаа. Өмнө тохиолдож байсан, Анод банкин дээр тохиолдож байсан тийм зүйлүүдээс зайлсхийхийн тулд хурал хуралдуулах асуудлын талаар бас нэг санал байгаа. Гэх мэтийн хэд хэдэн амьдрал дээр гарч ирдэг зүйлсийг санал болгосон юм. Энийг Г.Баярсайхан та нар анхаарсан байх. Гэхдээ тэр саналууд нь дутуу орсон байсан. Өөрөөр хэлбэл энэ хуулийн дараа бол ямар нэгэн тийм хүндрэл бэрхшээлүүд үүсэхгүй байх зорилгоор жоохон тодотгож өгсөн тийм л заалтууд байна.

**Б.Гарамгайбаатар:** - С.Дэмбэрэл гишүүний саналыг тэгвэл хүлээгээд авчихъя. Ажлын хэсэг дээр ярья. Санал хураалт дууссан.

## **Санхүүгийн жилийг 9 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлүүлэхээр санал дэвшүүллээ**

УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл, Ц.Цолмон нар хамтран Улсын нэгдсэн төсвийн тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хуулиудад төсөв, санхүүгийн жилийг 9 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлүүлэх талаар нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг санаачлахаар ажиллаж байна.

Монгол улс төсөв, санхүүгийн жилийг тухайн жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхлүүлж байгаа нь жилийн дөрвөн улиралтай манай орны хувьд бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлын мөчлөгтэй тохирохгүй, төсөл тендер шалгаруулалтын шатанд хугацаа алддагаас хөрөнгө оруулалт он дамжиж, өртөг зардлыг нэмэгдүүлэх сөрөг үр дагаврыг үүсгэж байгааг үндэслэл болгожээ.

УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл, Ц.Цолмон нар Монгол улсын ерөнхий сайд Н.Алтанхуягт хандан УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 3.1.4-д заасны дагуу Засгийн газрын санал, дүгнэлтийг авахаар санал хүргүүлсэн байна.

## **Авлигын хамгийн “шимтэй хөрс” бол хүнд суртал**

**-“CEO Summit -2013” арга хэмжээний хүрээнд ямар ямар асуудлуудыг хөндөж төр, засгийн байгууллагуудад дуулгах гэж байна вэ?**

**С.Дэмбэрэл:** - Компанийн захирлуудын дээд хэмжээний уулзалт “CEO Summit -2013” арга хэмжээний үеэр Монголын эдийн засгийн 2013 оны байдал, бизнесийн орчин Шинэчлэлийн Засгийн газрын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, бизнесийнхэнд хэр зэрэг нийцтэй байна, юу нь болж байна, юу болохгүй байна, өмнөх Засгийн газрын үед ярьж байсан бизнесийн орчны шинэтгэл ямар байдалтай явагдаж байна, санхүүгийн орчин сайжирч байна уу, бизнест хандах тэгш хандлага шударга байж чадаж байна уу, төрийн оролцоо хэр зэрэг байна, түүний саад бэрхшээл нь юу байна гэх мэт бизнест хамааралтай олон олон асуудлыг компанийн захирлууд өөрсдөө ярина. Мөн түүнчлэн төр, засгийн байгууллагын төлөөлөл тухайлбал, гааль болон татвар зэрэг бизнестэй хамгийн ойр ажилладаг байгууллагууд оролцсон ажил хэрэгч зөвлөгөөн болно. Энэ зөвлөгөөний үр дүнд цаашдаа УИХ, Засгийн газарт явагдаж байгаа хууль зүйн, бизнесийн шинэчлэл болон ер нь эдийн засгийн макро түвшний бодлого зэрэгт бизнесийнхний дуу хоолой, санал бодол яаж тусах нь гол асуудал.

Шинэ Засгийн газар байгуулахад Танхимаас 2012-2016 онд УИХ, Засгийн газраас хэрэгжүүлэх тодорхой бодлогуудад санал бодлоо хүргүүлчихсэн. Тэр нь бараг бүхэл бүтэн ном юм бий. Манай саналууд ерөнхийдөө энэ шинэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан. Гэхдээ шинэ засаг гараад нэг жилийн хугацаа өнгөрөхөд үүний хэрэгжилт ямар байна, төр-хувийн хэвшлийн түншлэл бодит байдал дээр яаж хэрэгжиж байгаа гэдэг дээр бодох л хэрэгтэй. Хэдийгээр шинэ засгаас тодорхой асуудлыг барьж аваад газар дээр нь шийдэх хандлагаар ажиллаж байгаа ч ерөнхийдөө макро эдийн засгийн бодлого нь Засгийн газрын хийж, хэрэгжүүлж байгаа бодлогын арга хэмжээ, мэдэгдлүүд нь бизнесийнхэнд итгэл үнэмшил төрүүлж байна уу. Бизнесийнхэн цаашдын бизнес хөрөнгө оруулалтын орчны төлөв байдлаа хэрхэн харж байгааг харуулсан “Бизнесийн итгэлийн индекс” судалгааг бид саяхан гаргаж дууслаа. Уг судалгаанаас үзэхэд бизнесийн итгэл тааруу харагдав. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны далайц хүрээний үр өгөөж талаас харвал бизнес эрхлэгчид сэтгэл дундуур байна. Сайхан зөв зорилт тавьж болно. Гэхдээ стратегиа боловсруулахаасаа авахуулаад хэрэгжүүлэх шатандаа үр нөлөөг нь амсч байдаг хүмүүс буюу бизнес эрхлэгчдийн оролцоог үр дүнтэй хангах шаардлагатай байна.

**- Эдийн засгийн хүндрэл, валютын ханшийн талаарх таны байр суурь юу вэ? Энэ хоёр зүйл бол өнөөдрийн гол сэдэв болоод байх шиг?**

**С.Дэмбэрэл:** -Эдийн засгийн хүндрэл бол байна. Монголд олон жил макро эдийн засгийн хэдэн тоо, макро эдийн засгийн өнцгөөс харж яриад байгаа зүйл ажиглагдлаа. Бодит сектор буюу хувийн хэвшлийн судасны лугшилтыг сонсоод, түүндээ үндэслэн дүгнэлт хийж, арга замаа хамт ярилцан боловсруулдаг бодлогын соёл, технологи дутагдаад байна манайд.



Хэд хоногийн өмнө УИХ-ын ээлжит бус чуулган эхлэхэд эдийн засгийн хүндрэлтэй асуудлаар улс төрийн намууд өөр өөр байр суурьтай байх жишээтэй. МАН эдийн засгийн байдал хүнд хэцүү байна гээд ерөнхийдөө байдлыг жаахан доошлуулах хандлагатай. Гэтэл зарим сайдууд ерөөсөө яагаачгүй, зүв зүгээр гэсэн байр суурьтай байна. Эдийн засгийн байдлыг улстөржүүлээд ирэхээр өнгө нь мэдэгдэхээ больдог, бүдгэрээд ирдэг учраас нэгдсэн байр суурьтай байх нь чухал. Монголын эдийн засгийн хувьд улаан ч биш, цэнхэр ч биш. Харин хүмүүсийн амьдралын асуудал юм. Энэ тохиолдолд эдийн засгийн хүндрэлийг авч үзэх нь зүйтэй. Дашрамд дуулгахад Танхим бизнесийн орчин ямар байна, бизнест хандлага ямар байна, төр яагаад төрийн өмчит үйлдвэрийн газруудыг шинээр байгуулах, тэдгээрийг шүтэх дуршил нэмэгдээд байна гэдэг талаар мэдэгдэл гаргасан байгаа.

Монголын гол нэрийн, бидний орлогыг бүрдүүлдэг тодорхой бараа бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ ханш тааруу байгаа нь үнэн. Гэхдээ бид эдийн засгийнхаа хүндрэлийг ямар нэг улстөржихгүйгээр жинхэнэ мэргэжлийн түвшинд ярих шаардлагатай байна. Тиймээс компанийн захирлуудын чуулганы үр дүн УИХ-ын ээлжит чуулган эхлэхэд их хэрэгтэй мэдээлэл болно.

Валютын ханшны өсөлт бол ганц хөлтэй эдийн засгийн маань өөрийнх нь дүр төрхөөс болж буй үзэгдэл юм. Гадаад орчин, экспортын орлого муудсан учраас валютын ханш ийм боллоо гэж ярихаасаа өмнө дотооддоо бодлого маань зөв явагдаж чадсан уу. Бид гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нарт хандах хандлагаа өөрчилж чадсан уу. Тааламжтай, цоо шинэ орчинд хөрөнгө оруулагчдыг урин дуудсан бодлого явуулсан уу. Эдийн засаг, санхүүгийн болон институцийн боломжийн орчин бий болгож чадсан уу. Эдгээрийг бас л ярилцах хэрэгтэй. Валютын ханшийн өсөлтийн угшлыг аваад үзэхээр бүр 2008 оноос эхлэлтэй байдаг. Өөрөөр хэлбэл, улс төрийн хоёр том нам дааж давашгүй, боломжгүй амлалтыг сонгуульд ялахын тулд өгснөөс болоод эдийн засгийнхаа зөв бодлогын гольдролыг эвдсэн. Ийм буруу бодлого явж, үүндээ барьцаалагдаж, амлалтаа биелүүлэхийн тулд эдийн засгийн олон зөв зохистой харьцааг алдагдуулсан. Энэ нь нийт бүтцийнхээ тэр дундаа валютыг ханшинд шок маягийн асуудал үүсч, огцом хэлбэлзлүүд сүүлийн саруудад бий болов. Өнгөрсөн тавдугаар сараас эхлээд валют өсөх шинж тэмдэг мэдэгдэж, наадмын дараагаас доллар 1700 төгрөг хүртэл өсч, интервенц хийхээс өөр ямар арга хэмжээ авсан юм. Бусад улс орнуудын туршлагаас харахад, интервенц төдийгүй валютын ханш, түүний дэглэмтэй холбоотой бодлогын өөрчлөлтүүд болон төрөл бүрийн уламжлалт болон уламжлалт бус аргыг хослуулж валютын ханшны тогтвортой байдлыг хангадаг. Гэтэл манайхан эдгээр ажлуудыг хийхгүй мөртлөө байдлыг онолын хүрээнд тайлбарладаг. Валютын ханшны өсөлтийн эцсийн үр дүнг ард түмэн, хэрэглэгчдийн худалдан авалтад нөлөөлж, эдийн засагт инфляцийн дарамтыг нэмэгдүүлсэнээр эдийн засгийн өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байна. Ийм учраас зөвхөн Монгол банк төдийгүй, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны бүрэлдэхүүнтэй Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл улирал болгон энэ талаар авч хэлэлцэх ёстой гэсэн даалгаврыг Эдийн засгийн байнгын



хорооноос өгөгдсөөр байтал, үүнийг үл ойшоож байна. Уг хороогоо ч, зөвлөлөө ч хуралдуулахгүй. Интервенц хийсэн нэртэй байж байна. Нэг үгээр хэлбэл, валютын ханшийн өсөлтөө зохицуулж чадахгүй байсаар инфляцийн дарамт бий болгочихлоо шүү дээ.

Уул уурхайн бус экспортыг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх ёстой гэж Танхим олон жил ярьсан. Мөн мөнгөний бодлогыг өөрчлөө гэж олон жил дуугарсан. Харин үүний үр дүнд инфляцид хандах төрийн бодлого одоо өөрчлөгдөж байна. Засгийн газар, Монголбанк инфляцийг нийлүүлэлтийн талд тогтворжуулах дэд хөтөлбөрүүд хэрэгжүүлээд тодорхой хэмжээгээр хурд нь саарч байгаа. Энэ бол зөв. Гэхдээ зээлийн хүүг энэ онд гуравны нэгээр буруулна гэсэн Засгийн газрын бодлого бодитойгоор хэрэгжиж чадаж байна уу гэдгийг захын бизнесчээс асуухад “үгүй” гэж хэлнэ. Гэтэл төрийн хариуцлагатай зарим хүмүүс “ер нь буурч байгаа шүү дээ” гэж байна лээ. Өнөөдөр төрийн алдаатай бодлогоор валютын ханш нэмэгдсэн хүнд хэцүү нөхцөл үүсчихсэн. Ийм учраас хүнд нөхцөл байдлын тодорхойлолт буюу “hardship” гэрчилгээг Танхим өгч байна. Валютын ханшны өсөлтөөс магадгүй дамын наймаачид хожиж байгаа байх. Харин санхүүгийн зах зээл дэх хөөрөгдлийг төр өөрөө бий болгоод байна. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр зөвхөн төгрөгөөр гүйлгээ хийх тухай хууль байдаг. Тэр хууль хэрэгжихгүй байна.

**- Хямралын эсрэг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээнүүдийн талаар Та саналаа хэлэхгүй юу?**

**С.Дэмбэрэл:** - Хамгийн түрүүнд эдийн засгийг идэвхжүүлэх хэрэгтэй. Валютын ханшийг тогтворжуулах, буулгах энэ чиглэлийн арга хэмжээ авах. Дээр нь макро эдийн засгийнхаа уялдааг хангаж өгөх нь чухал.

Миний хувьд бол энэ талаар өөрийн саналаа бэлдчихсэн. Мөдхөн Их хурлаар хэлэлцүүлнэ гэж бодож байна.

**-2013 оны Төсвийн тодотголын тухайд та ямар байр суурьтай байна вэ ? 1,5 их наяд төгрөгөөр алдагдалтай**

-Төсвийг нэг хэсэг нь тодотгох, шаардлагатай гэж үзнэ. Харин нөгөө нь шаардлагагүй гэж үзэж байна. Энэ бол нэг их чухал зүйл биш. Эцсийн эцэст төсвийн тогтвортой байдлын хуулинд заагдсан хариуцлагын шалгуур үзүүлэлтүүд хангагдаж чадаж байна уу, макро эдийн засгийн гол хоёр бүрэлдэхүүн мөнгөний болон төсвийн бодлого сангийн бодлого хоорондоо зохицож чадсан уу. Үүний үндсэн дээр төсвийн төлөвлөлт, төсөв батлах үйл явц, судалгаа, шинжилгээ, бодлогын дүн шинжилгээ энэ бүхэн өөрөө төгс төгөлдөр байж чадаж байна уу. Өөрчлөх зүйл бий эсэх, төсвийн орлого болон зарлага тал дээр төлөвлөлтийн ямар арга хэрэгсэл хэрэглэх, юу нь болохгүй байна зэрэг асуудлыг цэгцлэх хэрэгтэй.

Дашрамд дуулгахад “Бизнесийн итгэлийн индекс”-ийн судалгааны дүнг Ерөнхий сайд болон яамдууд хүргүүлсэн байгаа. Иймд төр, засаг юун дээр алдаж байгаа, юуг засаж залруулах ёстойг ухаарах байх.

**- Шинэчлэлийн Засгийн газрын бизнесийн орчны талаар амласан амлалтууд бодит байдал дээр ямар байна гэж Та дүгнэлт өгөх вэ?**

**С.Дэмбэрэл:** - Бизнесийн орчны шинэчлэл явагдаж байна. Гэхдээ хүмүүст мэдрэгдэхгүй байгаа нь бизнесийн итгэлийн индекс судалгаанаас харагдаж байна. Гадаад худалдааны бичиг баримтыг багасгалаа. Одоо лицензийг 50

хувь бууруулах ажлын хэсэгт Танхимаас ороод ажиллаж байна. Засгийн газар удаан байна, хортой мөөгтэй зүйрлэж болох юм. Хортой мөөгийг тайраад байхад ургаад л байдаг. Үндсийг нь устгах ёстой. Тал талаас нь ухаалгаар цавчиж, дахиж ургахгүй болтол нь цавчимаар байна.

Өнөөдөр гадаад худалдааны бичиг баримт багассан ч, үйл явц багасаагүй хэвээр байна. Жишээ нь гаалийн байцаагчдын субъектив хандлага багасаагүй, хяналт шалгалт багасаагүй. Үнэлгээний олон арга бий. Гэтэл гаалийн байцаагчид ганцхан алибаба.com сайтаас мэдээллээ авч, үнэлгээг хийж байна гэдэг чинь юу гэсэн үг вэ? Бизнесийн орчны шинэчлэл хийгдэж байна. Гэхдээ эрс шинэчлэл хийх ёстой юм. Энэ шинэчлэлийг 2013 оны төгсгөлөөс Засгийн газар бизнес эрхлэгчдийн саналыг сонсох хэрэгтэй.

Авлигын хамгийн шимтэй хөрс нь хүнд суртал. Тийм учраас хүнд суртлын талаар авлигатай тэмцэхээр байгуулагдсан “РАСІ Монгол” сүлжээний 160 гаруй компаниудын авлигалаас ангид байна гэсэн хүсэл сонирхлыг илэрхийлсэн төлөвлөгөө гарчихлаа. Хамгийн түрүүнд хаяглах зүйл бол бизнесийн орчны шинэчлэл. Монгол Улс гаднаас харахад нүүрээ угаачихсан, эсвэл арилгасан сонгино шиг цэвэр цэмцгэр ил тод байх хэрэгтэй. Төр бизнест хэт их оролцож байна. Төрийн өмчийг эргэж харах цаг боллоо гэж Ерөнхийлөгч хэлснийг бид бодох хэрэгтэй. Төрийн оролцоог хязгаарлах, хамгийн зохистой түвшинд байлгахын тулд хууль эрх зүйн талаас нь төрийн оролцоог хязгаарлах шаардлагатай. Зарим улстөрчдийн ярьж байгаа шиг хэтэрхий их яам, агентлаг байна гэдэгт асуудлын гол нь биш. Ерөөсөө зохицуулалтын институтын бүтэц өөрөө зохистой байна уу гэдгийг бодох. Тухайлбал, өнөөдөр агентлагуудын гаргаж байгаа тушаал, шийдвэр нь саад бэрхшээл үүсгэсээр байна. Тиймээс үүнийг таслах хэрэгтэй.

Ярилцлагынхаа эцэст нь Улаанбаатар хотын талаар саналаа хэлье. Нийслэлд манай улсын хүн амын 50 хувь нь амьдардаг. Гэтэл хотод зам, метро барих тухай их ярих юм. Харин бизнесийн орчинг анхаарсан шийдвэрүүд ер харагдахгүй байна. Хотын дарга Э.Бат-Үүлийн хүнд суртлыг багасгах асуудал Ч.Сайханбилэг даргын толгойлж байгаа Шинэчлэл багийнхантай уялдаж өгөхгүй байна. Бизнесийн итгэлийн индексийн судалгаагаар үзэхэд дүүргүүд нэлээд хүнд сурталтай гарч байна. Тэгэхээр нийт эдийн засгийн бүрэлдэхүүнд хамгийн чухал хэсэг нь Улаанбаатарын эдийн засаг байна. Өөрөөр хэлбэл, макро эдийн засгийн нэг бүрэлдэхүүн нь Улаанбаатарын эдийн засаг юм. Хамгийн ариун зарчим бол хувийн өмч бөгөөд үндсэн хуулийн суурь зарчим. Хувийн өмч рүү дайрах нь Улаанбаатар хот, бизнесийн хооронд түншлэлийн харилцаа алга байгааг харуулж байна. Энэ нь төр, хувийн хэвшлийн хоорондын түншлэл дутагдаж байгаа гэсэн үг.

*Сэтгүүлч: Г.Мөнхдэлгэр.  
2013 оны 9 сар.*

## **Эцсийн эцэст, бид өөрсдөө эдийн засгийн алуурчид болоод байна**

*Сурвалжлагч Я.Мөнгөнцэцэгийн 2013 оны 10-р сарын 08-нд УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлтэй хийсэн ярилцлага.*

- Монгол Улсын эдийн засаг муудлаа. Төсвийн данс улайж байна. Засгийн газрыг огцруулах хэмжээнд асуудал хүндэрч байна гэх зэргээр Ардын намынхан яриад эхэллээ. Эдийн засгийн бодит нөхцөл байдал ямар байгаа юм бэ?

**С.Дэмбэрэл:** - Асуудлыг тийм хурц өнгөөр будах шаардлагагүй. Өөрөөр хэлбэл үхлээ, хатлаа, сөнөлөө, буурлаа гэж ярих хэрэггүй. Монголын эдийн засаг бол олон жилийн ужгирсан өрөөсгөл бүтэцтэй, цөөн хэдэн бүтээгдэхүүн дээр тулгуурласан учраас гадаад хүчин зүйлд автамтгай эмзэг байдаг. Тоо талаас нь харахад 17 хувийн өсөлттэй байсан эдийн засаг өнөөдөр уначихсан байгаа нь сайн зүйл биш л дээ. Гэхдээ өнөөдрийг хүртэл бид эдийн засгийн өсөлтийг л яриад шүтээд байснаас биш чанар нь ямар байгааг хараагүй. Өсөлт гэдэг зүйлд суурилж бүх ажлаа төлөвлөж ирсэн учраас одоо гор нь илэрч байна. Гэлээ гээд сандралдаж, тэвдэх хэрэг биш шүү дээ. Эдийн засгийн хагас жилийн статистик үзүүлэлтийг харахад нэлээд олон салбар өсөлттэй байна. Төсвийн орлого тодорхой хэмжээгээр дутаж байгаа. ДНБ-ий өсөлт буурсан. Гэвч эдийн засгийн идэвхжил буурчихаагүй байна. Валютын ханшийн хэт хэлбэлзэл байгаа.

- Валютын ханш өсч байгаа шалтгаан нь юунд байна?

**С.Дэмбэрэл:** - Энэ тал дээр тусдаа яриатай. Харин эдийн засагт тодорхой хэмжээний доголдол гарсан нь үнэн. Гэхдээ энэ нь бодитой, бодит бус гэсэн хоёр шалтгаантай. Бодитой шалтгааныг нь түрүүнд хэлчихлээ. Үүнийг хүн бүхэн л ярьж байна.

- Тэгвэл бодит бус шалтгаан нь юу юм бэ?

**С.Дэмбэрэл:** - Манай засаглалын хэлбэр аливаа шийдвэр гаргахад тус болж өгөхгүй байна. Асуудлыг улстөржүүлж, ажлыг удаашруулж байна. Жишээлбэл, тендерийг нэрлэж болно. Тиймээс Тендерийн хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай болжээ. Засаглалын бусад гажиг, мэргэжлийн бус байдал нь шийдвэр гаргалтын хурд, чанар хоёрт сөргөөр нөлөөлж байна. Нийт хувийн хэвшлийнхнийг харъя. Тэдний тодорхой салбаруудыг төрөөс дэмжээд бүтээн байгуулалт өрнөж байна. Тухайлбал, барилга, уул уурхай, экспортын салбарт ажил явагдаж байгаа. Гэсэн хэдий ч бүхэлдээ санхүүгийн орчин нь сайжирч өгөөгүй учраас компаниудын үйл ажиллагаа суларч байна. Сүүлийн үед шинэчлэлийн алхмууд хийж байна. Гэвч бизнесийн орчин тааруу байна. Дотоодын хөрөнгө оруулагч, жижиг, дунд болон бичил бизнес эрхлэгчээс эхлээд томоохон компаниуд, гадаадын хөрөнгө оруулагчдад бизнесийн тогтвортой бөгөөд тунгалаг орчин хэрэгтэй. Энэ нь манайд дутагдаж байна. Түргэн зуурын тохиолдлоос болж шийдвэр гаргагчид хариуцлагагүй мэдэгдлүүд хийж байгаа нь гадаадын хөрөнгө оруулалтыг сааруулах хандлагатай болж байна. Мөн хуулийн орчин нь өөрөө гадаадын хөрөнгө оруулалтыг үргээх нөхцөл болж байх жишээтэй.

Дээрээс нь валютын ханшийн нөлөөллийг хүмүүс ярьж байгаа. Валютын ханшийн энэ хэлбэлзэл экспортод ашигтай гэх мэтээр тайлбарлаж байна. Энэ бол онол. Сурах бичиг дээр л байдаг юм.

**- Манайд тохирохгүй онол гэж үү?**

**С.Дэмбэрэл:** - Валютын ханшийн хэлбэлзэл Монголд тодорхой хэмжээнд хэрэгтэй юу гэвэл хэрэгтэй. Гэхдээ манай экспорт түүхий эд дээр суурилсан өрөөсгөл бүтэцтэй. Гадагшаа гаргах бүтээгдэхүүнийх нь тоо цөөн, нийт эдийн засгийн идэвхжлийг бүхэлд нь тодорхойлж чаддаггүй учраас валютын ханшийн хэт огцом хэлбэлзэл нь өргөн хэрэглээний барааны үнэд нөлөөлж, инфляцийн дарамт үүсгэж, хүлээлт бий болгодог. Энэ дарамт хэдийнээс үүссэн гээч. 2013 оноос биш. 2012 оноос ч биш. 2008 оноос эхтэй. Тэр жилийн сонгуулиар улс төрийн хоёр нам ямар ч тооцоогүйгээр бэлэн мөнгөний амлалт өгсөн. Энэ нь сүүлийн жилүүдэд Монголын эдийн засгийг идэж байна. Тиймээс өнөөдрийн эдийн засгийн уналтыг улс төрийн шалтгаанаас хайх хэрэгтэй. Нөгөө талаар валютын ханшийн хэлбэлзэлд дамын хүчин зүйл нөлөөлж байна. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр дамын наймаачид гэж ярьдаг даа. Түүнтэй л адил. Манайх шиг эдийн засагтай улс орнуудад хэрэглэгч, бизнесийнхний хүлээлт нь дандаа сөрөг байдаг. Юмны үнэ өсөх нь. Инфляци хөөрөгдөх юм байна. Санхүүгийн орчин тааруу болох нь. Төр засагт итгэх итгэл алга гэж үздэг орчинд валютын ханшаар тоглолт хийдэг тоглогчид байдаг. Би хувь хүмүүсийг хэлээгүй. Институциудын тухай ярьж байна. Ханшийн өөрчлөлт хэнд ашигтай юм. Экспортод, дамын наймаачдад ашигтай байхгүй юу. Өөрөөр хэлбэл, чихнээс чих дамжин яригдсан цуу яриа ханшийг хэлбэлзэлд оруулж байгаа юм. Одоо хар л даа. Хүмүүс "юмны үнэ өснө" гээд аль хэдийнэ яриад эхэлчихсэн байгаа биз дээ. Тиймээс төр хувийн хэвшилтэй ойрхон ажиллаж, шийдвэр гаргах үйл явцдаа бодитойгоор хандах хэрэгтэй.

**- Гэтэл Ардын намыг засаг барьж байх үед эдийн засгийн өсөлт 17 хувьд хүрч, ядуурал буураад сайхан байсан. АН гарч ирээд ийм болгоод хаячихлаа гээд байна л даа?**

**С.Дэмбэрэл:** - Манай намын үед тийм байсан. Тэдний намын үед ийм болчихлоо гэж ярих асуудал биш шүү дээ. Гадаад нөхцөл байдал муудаж, нүүрсний зах зээл тааруу байгаагаас ч эдийн засаг сулраагүй. Бид эдийн засгаа тогтвортой байлгах, түүнийгээ солонгоруулах тал дээр дорвитой ажил хийгээгүй шүү дээ.

**- МАН-ынхны яриад байгаа 17 хувийн өсөлт нь чанаргүй байжээ гэж ойлгож болох нь ээ?**

**С.Дэмбэрэл:** - Эдийн засгийн бүтэц нь ужгирчихсан улсад аль нэг нам засгийн эрх авахаараа хамгийн түрүүнд хардаг ганц хэрэгсэл нь ДНБ-ий өсөлт байдаг. Гэтэл Бурхны авралаар, тухайн үед Монголын эдийн засаг гадаад хүчин зүйл, дэлхийн эдийн засгийн тааламжтай нөлөөллөөр өссөн. Түүнээс биш тухайн үед засгийн эрх барьж байсан нам эдийн засгийн өсгөчихсөн гэвэл өрөөсгөл. Хэрэв тэгж ойлгож байгаа бол хэлэхэд энгийнээр хэлэхэд гэнэн байна. Одоо бид нэг зүйлийг бодох хэрэгтэй. Эдийн засгийн өсөлтийн тоо чухал биш. Энэ өсөлт бүх салбарыг хамарч чадсан байна уу, айл өрх бүрийн үүдээр орсон уу, өсөлтийн үр дүнд бусад эдийн засгийн сектор болох эрүүл мэнд, боловсролын салбар дээшилж байна уу, байгаль

орчинд ээлтэй өсөлт болж чадав уу, улс хот маань ногоорч эхэлсэн үү гэдгээр нь харах ёстой. Бид 2015 онд мянганы хөгжлийн зорилтуудаа дүгнээд дараагийн зорилтоо тодорхойлно. Энэ үед ДНБ-ий өсөлт гэдэг юмаа л яриад байх уу. Эсвэл амьдралын чанар хэр дээшилсэн тухай бодит зүйл ярих уу гэдгээ бодох ёстой. Одоо аль ч нам амьдралын бодит өсөлтийн чанарыг л ярих хэрэгтэй болчихоод байна. Хийсвэр тоо яриа хэрэггүй.

**- Валютын ханшийн өсөлтийг барьж тогтоохын тулд ямар арга хэмжээ авах хэрэгтэй юм бэ, таныхаар?**

**С.Дэмбэрэл:** - Монголбанк интервенц хийх хэрэгтэй. Одоо бид үүнийг л хүлээж байгаа. Гэхдээ интервенц хийх нь цорын ганц хангалттай арга мөн үү гэдгийг бодох ёстой. Банк хоорондын зах зээл өөрөө бодитой бөгөөд эрэлт, нийлүүлэлтийг хамарч чадаж байна уу. Валютыг чөлөөтэй өгөх дэглэм зах зээлийн хөдөлгөөнийг илэрхийлж чадаж байна уу гэх зэргийн зүйлүүдийг анхаарах хэрэгтэй. Дээрээс нь Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл бодитой ажиллаж чадаж байна уу гэдэгт шүүмжлэлтэй хандах цаг болсон. Энэ зөвлөлд Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо багтдаг. Эдийн засгийн хөгжлийн яам гэдэг нэг тоглогч манайд гарч ирээд энэ гуравтайгаа уялдаатай байж чадахгүй бол санхүүгийн тогтвортой байдал бий болоход бүрхэг. Тиймээс энэ зөвлөлийг өргөтгөж, нөлөөллийг нь сайжруулж, асуудлыг авч хэлэлцдэг ажлынх нь хугацааг тогтмол болгох хэрэгтэй байна. Ер нь хэдхэн том компани нүүрс гаргахыг бодит секторын идэвхжил гэж ойлгож болохгүй. Жижиг, дунд бизнес эрхлэгчдээс гадна өөрөө өөрийнхөө амьдралыг дээшлүүлэхээр бичил бизнес хийж байгаа хүмүүст туслах ямар арга байна гэдгийг боддог баймаар байна.

**- Эдийн засаг муудсанаас болоод банкууд эхнээсээ дампуурч байна. Араас нь хэдэн банк дампуурах бол гэдэг үг туршлагатай эдийн засагчдын амнаас ч гарч байна. Энэ тал дээр юу хэлэх вэ?**

**С.Дэмбэрэл:** - Тийм зүйл яагаад ч болохгүй. Ингэж ярьснаас чинь болж нийгэмд дам хүлээлт бий болгож байна. Яагаад ч ийм бодол хүний толгойд орж ирэх ёсгүй. Сая хоёр банкыг нийлүүлсэн явдал бол Монголын банкны секторын өчүүхэн хэсэг. Энэ нь банк санхүүгийн том гинжин хэлхээнд ямар ч нөлөө үзүүлэхгүй. Муу ч гэсэн төв банк байна. Тэд арилжааны банкуудаа хянаж, биетээр байдлыг нь шалгаад явдаг шүү дээ.

**- Тэгвэл Хадгаламж банкыг яагаад өөр банктай нэгтгэсэн юм?**

**С.Дэмбэрэл:** - Ерөөсөө хариуцлагагүй байдлаас үүдэлтэй. Банкны сектор улстөржөөд ирдгийн гор нь тэр. Ийм байдлаас зайлсхийх талаар УИХ, Засгийн газар, Төв банк анхаарах хэрэгтэй. Банкуудын хувьцаа эзэмшигчдийг зарлах нь ийм мэтийн зүйл гаргахгүй байх баталгаа болно шүү дээ. Ер нь банкнуудын өрсөлдөөн хэр шударга явж байгааг О.Магнай гуай очоод шалгах хэрэгтэй.

**- Бондын мөнгө тойрсон шүүмжлэлүүд өнөөдөр ч явж байна. Үр ашигтай төсөлд зарцуулсангүй. Дахиад бонд гаргая гэхээр дэлхийд манай нэр хүнд уначихсан гэх мэтээр ярьж байна...**

**С.Дэмбэрэл:** - Хөрөнгө оруулалтын орчин тогтвортой биш бол Монголын нэр хүнд унана. Тиймээс Монголын шийдвэр гаргах түвшний хүмүүс болчимгүй үг унагахгүй байх хэрэгтэй. Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг тууштай тогтвортой байлгах тухай эерэг дохиог олон улсад өгөх



ёстой. Ийм тохиолдолд бонд цаашдаа үр ашигтай үргэлжилнэ. Бондын мөнгөний ашиглалтын тухайд бол гацаа бий. Энэ нь манай засаглалаас болж байгаа юм. Засаглал удаан байна. Бондын мөнгийг юунд зарцуулах шийдвэрийг гаргадаг зөвлөлийг татан буулгах хэрэгтэй. Бондын мөнгөөр ямар асуудлыг санхүүжүүлэх вэ гэдгийг Засгийн газар оруулж ирдэг. Түүнийг нь УИХ хянадаг зарчмаар явах хэрэгтэй. Бондын мөнгөөр юу хийх вэ гэдэг шийдвэр гаргадаг зөвлөлд УИХ-ын хоёр гишүүн, баахан сайд багтдаг. Тэр дундаа нэг сайд нь голлон оролцдог байдал нь өөрөө сонин механизм. Бондын мөнгийг юунд зарцуулах шийдвэрийг гаргахад хувийн хэвшлийнхний оролцоо байх ёстой. Яагаад гэвэл хувийн хэвшил тэр төслүүдийг чинь гүйцэтгэдэг юм. Өнөөдөр хувийн хэвшлийнхэн “Жижиг, дунд бизнест яагаад бондоос мөнгө өгөхгүй байгаа юм бэ?”, “Мэдээллийн технологийн салбарт яагаад мөнгө өгөхгүй байгаа юм бэ? Энэ бизнес биш юм уу?”, “Аялал жуулчлал, үйлчилгээний салбарт мөнгө өгөхгүй байгаа нь ямар учиртай юм бэ?” гэх мэтээр ярьж байна. Энэ нь зөв шүү дээ. Гэхдээ яая гэхэв эхний удаад авч байгаа бондын мөнгийг дэд бүтэц, зам талбай, тодорхой үйлдвэрлэлд зарцууллаа. Дараагийн бондын мөнгийг зарцуулах шийдвэр гаргах зөвлөлд хувийн хэвшлийнхнийг оруулж, илүү үр бүтээлтэй төслүүдийг сонгох хэрэгтэй.

**- Төрийн оролцоог бизнесээс холдуулах нь чухал гэж үзээд байна уу?**

**С.Дэмбэрэл:** - Бонд гаргаж байгаа улсын төр бизнест хэтэрхий оролцох хэрэггүй. Савраа татах хэрэгтэй. Ийм цадиггүй үйл ажиллагаанаасаа татгалз. Төр ганцаараа ухаантай юм шиг байдгаа болих хэрэгтэй. Төрийн хэт их оролцоотой эдийн засагтай байх нь баялгийн хараалд хүргэнэ. Ийм нөхцөлд авлигатай тэмцэнэ гэж яриад ч нэмэргүй л дээ.

**- Оюу толгойн далд уурхайг хаачихсан нь эдийн засгийг бүр сөхрүүлнэ гээд байх юм. Энэ тал дээр таны байр суурь?**

**С.Дэмбэрэл:** - Энэ тал дээр тайван байна. Оюу толгой гэдэг нэг компанийн тухай ярьж байгаа биз дээ. Энд дэлхийн үндэстэн дамнасан Рио Тинто гэдэг том компани оролцож байгаа. Хөрөнгө оруулалтгүй юм чинь олборлолт нь зогсохоос өөр яахав. Тэглээ гээд сандрах хэрэггүй. Манайхны гадаадад өгч байгаа сигнал гадаадын хөрөнгө оруулагчдыг эргэлзэхэд хүргэж байгаа юм чинь. Гадныхан Монголд Оюу толгой гэж нэг юм байгаа. Тэрийг нь мөлжинэ дөө гэсэн байдлаар хандахгүй байгаа нь мэдээж шүү дээ. Манайхны үндсэрхэг үзэл сүүлийн үед хэтрэх гээд байна. Бид шулуулж байна гэдэг яриа хэтэрлээ. Оюу толгойн хэлэлцээр алдаатай байсан байж болно. Гэхдээ Оюу толгой манайхаас нүүгээд явахгүй. Баялаг нь харагдахгүй алга болчихгүй. Тэнд хөрөнгө оруулах л хэрэгтэй. Үүний тулд мөнгө босгох хэрэгтэй. Анхнаасаа бид 34 хувь гэхийн оронд тэднээс бүх татвараа авах байсан. Тэгээд Монголын болоод гадны компаниуд ажиллаад явах хэрэгтэй байлаа. Харин Монголын төр өөрийн компаниудаараа дамжуулан хар хайрцагны бодлогоо явуулах ёстой байсан. Одоо яахав. Монголын сайд нар болчимгүй мэдэгдэл хийлгүй ил тод тунгалаг эрх зүйн орчин бий болгож өг. Оюу толгойг ашиглаад явах юм бол дотоодын компаниуд ажилтай болно. Монголчууд ч ажлын байртай болно.

**- Монгол Улс Хятадын нүүрсний зах зээл дээр гол тоглогч байж чадахаа болилоо гэж ярьж байна. Энэ тал дээр?**



**С.Дэмбэрэл:** - Хэзээ Монгол Улс Хятадын зах зээл дээр гол тоглогч байсан юм бэ? Хоёр хөршийнхөө асар том зах зээлийг маажиж малтдаг ганцхан замтай улс шүү дээ. Бид үнэ тогтоогч, тулган хүлээлгэгч биш л дээ. Зах зээлийн хуулийг л дагадаг улс. Хоёр хөрштэйгээ харилцааны хамгийн сайн механизм тогтоож чадаагүй л байна. Энэ тал дээр манайхны санаачилга үнэхээр дутагдаж байгаа.

**- Эцэст нь одоо ээлжит бус чуулган хуралдуулах шаардлага бий гэж үзэж байна уу?**

**С.Дэмбэрэл:** - Байгаа. Гэхдээ бид эдийн засаг уначихлаа, үхлээ хатлаа гэж сандраагүй шүү. Эдийн засаг муудах шинж тэмдгүүд мэдрэгдээд эхэллээ. Угаасаа эмзэг эдийн засагтай улс орны эрх баригчид ийм олон сар амрах ёсгүй. Тэгэхээр одоо ажилдаа оръё. Учирч болох хямралт байдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авъя. Монголын эдийн засгийн гадаад болон дотоод орчны чиглэлээр том ажлын хэсэг байгуулахаар УИХ-ын дарга захирамж гаргасан байдаг. Энэ ажлын хэсгийн дүгнэлт гарсан байгаа. Үүнийгээ УИХ-ын ээлжит бус чуулганаар хэлэлцээд Засгийн газарт чиглэл өгье. Валютын ханш, эдийн засгийн гадаад, дотоод орчин, бонд, экспортынхоо тухай ярья. Хөрөнгө оруулалтын тухай хууль бараг бэлэн болчихсон байна. Өөр олон хууль хэлэлцэхэд бэлэн болчихож. Төсвийн тодотголын асуудал яригдах шаардлагатай байна. Цаг үеийн шаардлага байгаа учраас чуулганаа хуралдуулах хэрэгтэй. Тэрнээс биш Монголын эдийн засаг хэцүү болчихоод, улс орон удирдлагагүй болчихоод ээлжит бус чуулганаа хийе гээд байгаа юм биш. Ажил хэрэгч байх үүднээс ярьж байна.

**- Таныг яагаад ХАУТ-ын даргын ажлаа өгдөггүй юм гэж их ярьдаг тал бий. Та өөрөө юу хэлэх вэ?**

**С.Дэмбэрэл:** - Төгсгөлд нь ямар өчүүхэн асуулт тавьж байх юм. Тэгж ярьж л байг. Энэ хүн ажлаа олигтой хийж чадаж байна уу, үгүй гэдэг нь чухал шүү дээ. Тэгээд ч УИХ-ын тухай хуульд УИХ-ын гишүүн төрийн бус байгууллага удирдаж болно гээд заачихсан байгаа. С.Ганбаатарын хувьд тодорхой асуудал, хэл ам гарсан учраас өөрийн хүсэлтээр ажлаа өгсөн гэж ойлгосон.

## **Төсвийн хариуцлагыг тооцоолоход эдийн засгийн үр ашиг болон нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлсэн байх хэрэгтэй**

*2013 оны 10-р сарын 28-нд 15:00 цагт Эдийн засгийн байнгын хорооны “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлээс.*

**УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлийн санал:** Энэ бол Эдийн засгийн байнгын хорооны хуралдаан. Та нар цаг л үрэх гээд байна даа. Яагаад гэвэл, энд юу ч ярьсан төсвийн байнгын хороон дээр очоод л паг болох нь. Тиймээс энэ

бол дээд зэргийг буруу практик байна. Өнөөдөр бид төсвийн бодлого гэж оруулж ирчихээд, дотор нь сангийн бодлогыг орхиод яваад байна. Төсвийн бодлого гэдэг маань орлого, зарлага, орлогыг яаж олох вэ, зарлагыг хэрхэн байршуулах вэ зэргийг хуулинд заасан, ялангуяа төсвийн болон төсвийн хариуцлагын тухай хуулинд заасаны дагуу хэрэгжүүлэх явдал юм. Гэтэл сангийн бодлого гэдэг маань, энэ улс төсвөөрөө дамжуулж, эдийн засгийн өсөлтөнд яаж нөлөөлөх вэ, ямар бодлого явуулах вэ гэдгийг тоонууд дээр хийж, ингэснээр бид төсөв гэж хэлэлцэхээсээ илүү сангийн болон мөнгөний бодлого гэж илүү анхаарах ёстой зүйл юм. Одоо бидний хэлэлцэж байгаа мөнгөний бодлогоо Эдийн засгийн байнгын хороо цэвэр хариуцаад явах ёстой. Гэтэл төсөв гэсэн утгаар Ц.Даваасүрэнгийн хариуцсан хороо руу очоод, Ц.Даваасүрэн гуай баахан зүйл хасдаг байж болохгүй. Ингэснээр та бидний яриад байгаа бодлогын асуудал мөнгөн дүнгээрээ тусдаггүй, өөрөөр хэлбэл сангийн бодлого болж ордоггүй учраас ийм болчихоод байна. Иймээс эхлээд Сангийн бодлогоо ярья. Өөрөөр хэлбэл эхлээд төсвийнхөө тоонууд яриад, дээр нь нэмж, энэ төсвийн хэдэн тоогоор дамжиж ямар бодлого хэрэгжих гээд байгаа юм бэ гэдгийг яриаар байна. Жишээлбэл, дөнгөж саяхан Засгийн газар экспортыг дэмжих хөтөлбөр баталлаа. 2 сар ч болоогүй байна. Тэрийг яаж, ямар байдлаар хэрхэн санхүүжүүлэх гэж байгаа юм бэ? Шийдэл нь алга. Сая бас, жижиг дунд үйлдвэрийн баталгааны сангийн тухай асуулаа. 10 тэрбумыг хаанаас гаргаж тавьдаг юм бэ? Хэн ямар тооцоо хийсэн юм бэ? Энэ хэрэгцээг хэн судалсан юм бэ? Миний тооцоолсоноор, хамгийн багадаа энэ санд 30 тэрбум төгрөг хэрэгтэй байна. Тэр яаж явагдах юм бэ? Үүнийг хэн хэлж өгөх ёстой юм бэ? Д.Ганбат, Г.Батхүүгээс гэж асуугаад, Сангийн яамны нэг газрын дарга хариулж байх ёстой юм уу? Бид үүнийг хийж өгөх ёстой. Гэтэл бид болохоор Ц.Даваасүрэнгийн ахалдаг төсвийн байнгын хороотой учраа ололцдоггүй. Ц.Даваасүрэн гуай тэндээ бяцхан битүү вакум үүсгэчихсэн байна шүү дээ. Тийм учраас сангийн бодлогыг Эдийн засгийн байнгын хороон дээр бодлого талаас нь ярьдаг, төсвийн талаас нь төсвийн байнгын хороон дээр яриад, хоорондоо нэгтгэж, хамтарсан хуралдаан хийж байж энэ Монгол Улсын сангийн бодлого гардаг байх ёстой. *Нэгдүгээрт*, ингэж өөрчлөх хэрэгтэй.

*Хоёрдугаарт*, одоо бид 2014 оны тухай яриад байна. Энэ тоог ярихаасаа илүү, хэдхэн харьцаа л үзэх ёстой. Төсвийн хариуцлагын тухай хуулинд нэг зарчим байгаа. Аливаа төсвийн төслийн хөрөнгө оруулалтын арга хэмжээ нь эдийн засгийн хувьд үр ашигтай, нийгмийн хувьд ач холбогдолтой байх ёстой гээд биччихсэн байна. Эндээс асуулт гарч байна. Эдийн засгийн үр ашгийг нь аль яам, яаж тооцоолоод УИХ-д оруулж ирж байгаа юм бэ? Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалтын дотоодын өгөөжийн коэффициентоор эрэмбэлсэн тэр жагсаалтын ард нэг багана нэмээд, тэр багананд нийгмийн ач холбогдол нь бичигдсэн байхаар хийсэн байх хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл төсөв нь эдийн засгын болон нийгмийн үр ашиг нь давхар харагдахуйц 2 баганатайгаар бүх хөрөнгө оруулалтыг жагсаагаад биччихсэн байдлаар УИХ-д орж ирэх учиртай юм. Хуулийн дагуу ийм л байх ёстой. Тэрийг оруулж ирээгүй учраас УИХ-ын гишүүд шийдвэр гаргаж чадахгүй, янз бүрийн тоо яриад байгаа юм. Тиймээс энэ ажлын хэсгээс үүнийг ингэж

хий гэж шаардах ёстой. Хуулинд байгаа тэр зарчим хаана байгааг, эдийн засгийн үр ашгаараа эрэмблэгдсэн байдал болон нийгмийн ач холбогдолыг нь харуулсан байдлыг шаардах хэрэгтэй. Үүнийг УИХ-ын гишүүд өмнөө тавьж байгаад тал талаас нь ярих ёстой. Жишээлбэл, “Энэ объект эдийн засгийн талаасаа үр ашигтай юм. Гэхдээ нийгмийн ач холбогдлоороо доогуур юм байна. Тийм учраас хөрөнгө оруулалтын хувьд дунд нь тавчихъя.” гэхчилэн шийдвэрлэдэг байх ёстой юм.

*Гуравдугаарт нь*, би сангийн яамнаас дахиад асууя. Төсвийн тухай хуулийн 34.1-ыг та нар яг одоо энд, манай ажлын хэсгийнхэнд тайлбарлаж хэл. 3 хувиар нэмэгдэх гэдгийг 2+3 гэж ойлгож байна уу, 2+1 гэж ойлгож байна уу гэдгээ хариулаад өг. Би бол 3 гэдэгт 100% итгэлтэй байна. Яагаад гэвэл та бүхэн, түүний дотор төсвийн байнгын хорооны дарга нь буруу тайлбарлаж, ингэснээрээ төсвийн хариуцлагын болон төсвийн тогтвортой байдлын тухай хуулийнхаа эрүүл логикуыг алж байдаг юм байна. Энэ байдал чинь олон жил болж байна. За, би Мэндсайханаас асууя. Одоо танай гаргадаг статистикаар жишээлбэл, жил болгоны төсөв дотоодын нийт бүтээгдхүүн төсвийн зардлын харьцаа дандаа 2-оос илүү гарчихсан байна. Тийм биз? Дандаа 2-оос илүү гардаг. Тэгвэл бид 2 гэж баталчихаад 5 – 6, одоо энэ жил 6,8 болгочихсон, ингэж худлаа хуурч явдаг явдлаа хэзээ зогсоох юм бэ? Яах гэж худлаа ярьж 2% гэж баталчихаад, дараа нь 5% болгодог, тэгээд үүнийгээ огт хамаагүй, төсвийн хариуцлагын тухай хуулийн 8-р зүйл буюу энэ улсад гай гамшиг, ган гачиг, онцгой байдал тохиолдсон үед л 5 болон түүнээс дээш байж болно гэсэн тийм зүйл заалтаар аргалж тайлбарладаг байдлаа хэзээ болих юм бэ? Бид төсвийн хариуцлагын тухай ярьж байна. Тэгэхгүй бол, дотоодын нийт бүтээгдхүүн дараа жилийн статистик гарахад төсвийн алдагдал чинь аягүй бол 6% гээд л гараад ирнэ. 2% -а барьж чадаагүй л байх болно. Үүнийг бид яаж зогсоох тухай бид, манай ажлын хэсэг өнөөдөр асуух ёстой. Ингэж байж ажлын хариуцлага сайжирч, “Засгийн газартаа дөрлүүлсэн УИХ” гэдэг хочноосоо салахгүй бол болохгүй. Сайдууд нь хаана байна? Ажил хариуцсан хүмүүс нь хаана байна? Сангийн бодлого ярих гэж байхад тоо яриад сууж байна. Хэзээ ийм байдлаар ажиллаж байсан юм бэ? Энэ чинь та нар биднийг аргалах гэж оролдож байна шүү дээ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулин дээр 4-хөн харьцаа байгаа. Тэр 4 харьцааг би дараа тодруулаад ярина. Тэр харьцаануудыг л надад одоо гаргаад ир. Хасах хоёроос гадна, тэр харьцаанууд л мөрдөгдөж байвал макро тэнцвэрийн хувьд энэ төсөв болж байна гэсэн үг. Ингэж ерөнхий юмаа ярьчихаад, дараа нь эдийн засгийн үр ашгийнхаа эрэмбэлэгдсэн жагсаалтыг гаргаад ир. Ингэж байж энэ жилийн төсөв чинь арай өөр, хариуцлагатай болно. Тэгээд дараа жилийн гүйцэтгэл статистик дүнгээр гарахад, хэрвээ тодотгол хийсэн бол 2%-аа яг л бариад явж байх ёстой. Тэгэхгүй бол 2% гэж баталчихаад, 5%, 6%, 7% болчихсон явж байдаг ийм ужигарсан, олон жилийн буруу практик үргэлжлээд байж болохгүй. Үүнийг л манай ажлын хэсгийнхэн яг одоо анхаарах хэрэгтэй шүү.

## **Санхүүгийн эх үүсвэрүүд Монголоос гадагшилсаар байх юм бол буцааж эргүүлэх арга хэмжээнүүдийг бид авах хэрэгтэй**

*“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах цндсэн цндсэн чиглэл батлах тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсгийн 2013 оны 10 сарын 28-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс:*

**Ажлын хэсгийн ахлагч С.Дэмбэрэл:** -Ажлын хэсгийн хуралдаан одоо ингээд эхэлье. Б.Гарамгайбаатар гишүүн өөр хуралдаанд байж байна. Д.Ганбат хүрээд ирнэ. А.Тлейхан, Л.Энх-Амгалан хоёр байхгүй байна. Гэхдээ тэр хоёр бол Ардын Намын хуралд сууж байгаа юм байна. Манай ажлын дэд хэсэг байна, Ажлын дэд хэсэгт Монголбанкны хүмүүс, Банкуудын холбоо байна, Монголбанкны 3 хүн байна. Сангийн яамны Батхүрэл байна. Ажлын дэд хэсэг нь бидэнд мэргэжил, арга зүйн туслалцаа өгөх ёстой. За өнөөдөр ямар ч гэсэн Б.Гарамгайбаатар гишүүн, Д.Ганбат гишүүн хоёрыг орж иртэл, дэд хэсгийн хүрээнд ажлаа ярьж байя. Дэд хэсгийн гишүүдийн зүгээс одоо мөнгөний бодлогын энэ хүрэн ном баримт бичигт оруулах нэмэлт санал байна уу? Монголын банкны холбооны саналыг ерөнхийдөө авсан. Д.Зориг гишүүн авсан уу? Монголын банкны холбооноос Б.Гарамгайбаатар даргад хандаж ирүүлсэн саналуудыг ажлын хэсгийн гишүүдэд өгөөрэй.

**Л.Болд:** - Б.Гарамгайбаатар даргад ирүүлсэн саналаас гадна, гишүүн С.Дэмбэрэл гишүүнд ирүүлсэн бас нэг санал байгаа.

**С.Дэмбэрэл:** -Тийм надад хандсан бичиг бас бий. Мэдээллийн технологийн талын.

**Л.Болд:** - Тийм, энэ хоёр саналаа өгчихсөн байгаа. Энэ дотроос ямар саналыг ажлын хэсэг авах юм гэдэг талаар бас ойлголт авмаар байна. Дээрээс нь нэг өгсөн санал гээгдчихсэн байх юм. Энэ мөнгөний бодлогын баримт бичгийг нэг жилээр хийгээд байгаа. Гэтэл дунд, урт хугацаанд хийвэл яасан юм бэ гэсэн ийм санал байсан юм. Нэг жилээр хийхээр холын бараа харагдахгүй. Нэг жилийн, түр зуурын, богино хугацааны арга хэмжээг аваад яваад байхаар хангалтгүй юм болов уу л гэж бодож байна. Тэгээд тийм санал байсан, тэр хаягдсан байна лээ.

**С.Дэмбэрэл:** -Юунаас хаягдчихсан юм бэ?

**Л.Болд:** -Манай энэ саналуудаас л хаягдсан юм байна л даа. Холбооны саналаас хаячихаж. Тэгэхээр ажлын хэсгийн гишүүний хувьд тийм санал оруулж болох уу гэж байна.

**С.Дэмбэрэл:** -Болно болно.

**Л.Болд:** -Бидэнд Дунд, урт хугацааны мөнгө зээлийн бодлого гэсэн бичиг баримт хамт гарах юм уу, салангид гарах юм уу, ямар нэгэн тийм зүйл баймаар санагдаад байна.

**С.Дэмбэрэл:** -Өөрөөр хэлбэл нөгөө төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг шиг үү?

**Л.Болд:** - Ядаж 3 жилийн юм уу, 5 жилийн бараа харагдмаар байгаа байхгүй юу. **С.Дэмбэрэл:** -3 жилийн барааг хардаг баримт бичиг Монголбанк гаргадаг уу, Болдбаатар аа. Чи микрофондоо ярь, протокол хийдэг учраас.

**Болдбаатар:** -Энэ нөгөө хуулийн орчинд зохицуулсан зохицуулалтууд нь ирэх оныхыг зохицуулчихсан байдаг учраас бид нар нэг жилийнхээр хийдэг. Тэгэхдээ та бүгд бол ингээд харах юм бол манай тооцоололтууд, ялангуяа тэр нөгөө хавсралт хэсэг дээр орж байгаа тооцоо судалгаанууд бол бүгд 3 жилээр хийгддэг. Хэдийгээр мөнгөний бодлогын тооцоог бол 3 жилээр хийх боломжтой гэж үзэж байгаа боловч манай орны хувьд одоо ажилтнуудын ур чадвар, мэдээллийн өөрийнх нь хүртээмж, системийн тогтвортой байдал энэ тэр гээд энэ олон нөхцөл байдлаасаа шалтгаалаад одоо өмнөх жилүүдэд хийж байсан туршлагаас харахад жил хагас, хоёр жил, тэрнээс цааших нь бол ихээхэн зөрүүтэй ийм нөхцөлүүд бол ажиглагддаг. /Бид нар өмнө нь ч хийсэн тооцоогоо эргэж харахаар/ Тэгэхээр яг тооцоо судалгааг бол одоо жишээ нь Улсын Их Хурлын хууль болж батлахаар ийм түвшинд бол 3 жилээр, 5 жилээр тоо болгож оруулах нь бидний хувьд харьцангуй эрсдэлтэй юм болов уу гэсэн ийм эхний бодол байна.

Дараагийнх нь болохоор зарчмын чиглэлтэй зүйлийг угаасаа стратегийн энэ ийшээгээ хөгжинө гэсэн тийм зүйлийг бол бид нар аль болохоор энэ төрийн бодлогын уламжлалт шинж чанарыг хадгалах хэлбэрээр бас нэлээн ингэж аажимхан багтаагаад яваад байх ийм санааг бол дотроо бас агуулж явж байдаг. Тэгэхээр энэ утгаараа бол бас урт хугацааны юмнууд бол байдаг гэж ингэж боддог. Үндсэн чиглэлийг төдий чиглэлийн хугацааны, дунд хугацааны яах вэ болгож өөрчилнөө гэх юм бол энэнээс өөрөөр татгалзаад юм уу, ийм байгаад байх тийм үндэслэл алгаа. Яг тоон үзүүлэлтүүдийн хувьд бол бид яг тийм баримжаатай сүрхий тоо бол гаргах чадварын түвшинд бол хүрээгүй байгаа гэж ингэж бодож байна.

**С.Дэмбэрэл:** - Болд.

**Болд:** -Банкны холбооноос хэлж байгаа санал бол нэг тоотой бол холбоогүй. Болдбаатар захирлын ярьж байгааг ойлгож байгаа. Илүү банк санхүүгийн орчныг бүрдүүлэх талаасаа дунд, урт хугацааны бодлогын ийм баримт бичиг байх ёстой юм болов уу гэж бодож байгаа. Банк санхүүгийн салбарын үйл ажиллагааг аюулгүй, эрсдэлгүй явуулах, зөөлөн дэд бүтцүүдийг бүрдүүлэх, холбооноос өгсөн тэр санал байгаа шүү дээ. Валютын эрсдлийг бууруулах, удирдах тэр арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх, үе шаттайгаар нэвтрүүлэх, он, сар өдөртэйгээ байж байх, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тэр яригдаад байгаа асуудлыг хэзээ шийдэх юм гэдэг он, сар өдөртэй байж, энэ бол олон жил дараалан яригдаж байгаа зүйл. Гэх мэтчилэн ийм орчныг бүрдүүлэх талаас яригдаж байгаа.

Дээрээс нь бид нарын хамгийн том зорилго бол Монгол Улсын зээлжих гаднаас зээлжих зэрэглэлийг олон улсын түвшинд аваачих. Одоо ВВ хасах гэсэн үнэлгээтэй байгаа шүү дээ. Энэ үнэлгээгээр бол Монгол Улсад хөрөнгө оруулж болохгүй ээ гэсэн ангилалд байж байгаа. Тэгвэл Монголбанк Засгийн газрын нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх ажил бол ядаж 3 ВВВ-д аваачих, 2 АА байдаг юм уу ядаж нэг А-тай болгох энэ зорилтыг ойрын 2 жилд, 3 жилд ингээд тавьбал бүх байгууллагууд Монголбанкны системийн байгууллагууд, Засгийн газрын системийн байгууллага, Их Хурал бүгдээрээ нэг зүйл уруу төвлөрөх ийм боломжтой болох юм.

Дор дороо өөрсдийнхөө хийх ажлыг хийгээд, нэг өдөр Монгол Улсын зэрэглэл, хөрөнгө оруулах олон улсын зэрэглэлд хүрвэл гаднаас зээлжих зээлийн хүү хямдарна. Монгол Улсад хувийн хэвшлээс орж ирэх хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэнэ. Тэгэхээр энэ арай том юм уруу, том асуудал уруугаа хандаж, дунд, урт хугацаанд явбал яасан юм бэ гэсэн тийм л сана байна.

**С.Дэмбэрэл:** -Өөр санал хэлэх хүн байна уу.

**Болдбаатар:** -Би жаахан нэмье. Тийм стратеги бий болгох ч гэдэг юм уу, тэр чиглэл уруугаа бол зүйтэй байх. Тэгэхдээ одоо бодит байдал дээр нэг ийм юм байгаа юм. Бид нар одоо жишээ нь мөнгөний бодлогын үндсэн чиглэл гээд ингээд батлаад, энэ дотроо яг ийм том зорилтыг ингээд оруулаад явчихаар, Засгийн газрын байгууллагууддаа сайн тоогдохгүй байгаа юм. Та эргээд харвал ноднин жилийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг баталсан Их Хурлын тогтоол дотор Засгийн газар хариуцахаар байсан нөгөө мөнгө угаахтай тэмцэх юмны хар жагсаалтаас гаргах гэдэг юм чинь ерөөсөө бид бол бараг л нөгөө нэг шувуу бүхэнд захиа дайгаад гэдэг шиг ингэж оролдоод тэгээд бүтэхгүй, одоо бүр хар уруугаа ингээд орж байгаа юм. Тэгэхээр ийм яг энэ мөнгөний бодлого дээр ийм юмыг оруулах нь жаахан үр дүнд хүрэхгүй байгаад байгаа тийм юмнууд харагдаад байгаа юм.

Тэгэхээр одоо мэдээж хэрэг макро эдийн засгийн үндсэн бодлого бол өөрөө төсвийн бодлого шүү дээ. Мөнгөний бодлого бол нэмэлт засварууд л хийнэ үү гэхээс биш яг ажлыг бол тэнд хийгдэх ёстой. Тэгэхээр төсөв дээр явж байгаа зарчмууд дотор ийм одоо нийгмийн амьжиргааг сайжруулах юм уу, эдийн засгийг тогтвортой байдлыг сайжруулах юм уу, дээрээс нь Монгол Улсад хөрөнгө оруулахад таатай дэлхийн хөрөнгөтэй хүмүүс ирж бизнесээ эрхлэх боломжтой болох ёстой гэдэг юм уу тийм зарчмыг тэр төсвийн тэр юман дээр одоо нэлээн сайн оруулж өгч байж энэ юм бол урагшаагаа хөдлөх юм байна лээ гэсэн тийм нэг санал байгаа юм.

**С.Дэмбэрэл:** -Та хоёрын санал хоёулаа зөв байгаад байна. Яагаад гэвэл, танай дээр гэхэд дунд хугацаанд зээлийн хүүг зах зээлийн зарчмаар нэг оронтой тоонд оруулах хөтөлбөр боловсрогдоод дуусчихаад, холбогдох яамдуудаас санал аваад, одоо санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр орно гэж би ойлгож байгаа, зөв үү? Надад тэгж мэдээлсэн.

Би хоёр дахь асуудал уруу. Өөрөөр хэлбэл мөнгөний бодлогод ч суулгаж өгөх ёстой, сангийн бодлогод ч суулгаж өгөх ёстой зүйлүүд. Ингэснээрээ институт хоорондын ажлын уялдаагаар хамтарч хийх, сая Болдын хэлсэнчлэн, та нарын хэлээд байгаа нэг санаа чинь дунд хугацаанд бол бид тэр орчмоо байх ёстой л доо. Жишээлбэл одоо монголын банкны холбооноос санхүүгийн секторынхон хамтраад банк санхүүгийн салбарын эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөрөө боловсруулъя гэдэг саналыг 2012 онд тавьсан байна. Энэ эрх зүйн шинэчлэл гэдэг чинь урагшаа харсан зүйлүүд шүү дээ. Орчин бүрдүүлэх зорилготой, нэгдүгээрт,

Хоёрдугаарт бол Эдийн засгийн байнгын хорооны тогтоолоор би ажлын хэсгийг нь ахлаад, санхүүгийн секторын шинэчлэл хийх баримт бичиг бараг л дуусчихсан. Энэ бас дунд хугацааных. Дунд хугацааны бодлогын баримт бичгүүд байгаад байна.



Дээр нь танай одоо жил болгон оруулж ирсэн бүх тоонуудаар / ерөнхийдөө, би тэр болгоомжлолыг ойлгож байна./ бол Монгол Улсад хамгийн гайгүй, бусдаасаа арай илүү оновчтой төсөөлөл хийчихдэг нь танайх л байна шүү дээ.

Сангийн яамны, Эдийн засгийн хөгжлийн яамны жишээлбэл одоо төсөөлөл хийж байгаа арга, /өнөөдрийн дөнгөж сая би Төсвийн байнгын хорооноос гарч ирэхэд валютын ханш 1387 энэ дээр яах юм гээд асуухад хариулах хүн олдохгүй л байна./ 2014 оны төсөв ийм байдлаар явах гэж байна шүү дээ.

Тэгэхээр нөгөө төсвийн болон мөнгөний бодлогын уялдаа гээд ярихад дөнгөж саяхан хэдхэн хоногийн өмнө анх удаа монголын түүхэнд анх удаа санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр Сангийн яам төсвийн бодлогоо анх удаа ингэж танилцуулаад, Монголбанк гэж хоорондоо уялдаа хангах анхны оролдлого албажлаа шүү дээ Тийм биз дээ Болдбаатар аа. Албан ёсоор ингэж хийгдлээ. Тэгэхээр энэ бол саяны хэллэг, тэр бодлого бол боломжтой. Харин ч бүр хэрэгтэй. Одоо жишээлбэл тэр хар списокэнд орчихоод ингээд одоо хүртэл тэр саналаа авч чадахгүй энэ маань төсвийн ер нь бид нарын ажлын уялдаа л юм байна лээ.

Тийм учраас жишээлбэл Төрийн байгуулалтын байнгын хорооноос өнөөдөр ажлын хэсэг гараад одоо энэ Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, хэд хэдэн төрийн байгууллагууд дээр шалгалт орох гэж байна. Саяхан Эдийн засгийн байнгын хорооноос ажлын хэсэг гараад 6 яамны шалгалт хийсэн. Гэх мэтээр ингээд энэ бүх ажлын хэсгүүд маань өнөөдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны тэр ажлын хэсгийн гол зорилго нь энэ төрийн институцуудын хоорондын ажлын уялдаа яаж хангагддаг юм гэж. За жишээлбэл одоо үнэ тогтворжуулах дэд хөтөлбөрүүдийн явцыг шалгаад үзэхэд бол Засгийн газрын үгээс одоо мэдээлэл энэ тэрээсээ ирүүлэх, хоцруулж ирүүлэх, ирүүлэхгүй байх, эсвэл ирүүлсэн юм нь чанаргүй байх гэх мэтийн зөндөө юмнууд гардаг.

Тэгээд энэ бүхэн маань дунд хугацаанд бид эдийн засгаа харахгүй байх гэсэн шалтгаан биш л дээ. Бид ямар ч гэсэн мөнгөний бодлогынхоо баримт бичигт суулгаж өгөх ёстой байх. Би бол ерөнхийдөө одоо ажлын хэсгийн гишүүдэд энийг санал болгох гэж байгаа. Энэ дунд хугацааны юм хэрэгтэй юм байна гэж. Энийгээ нэг заалт болгоод оруулчихъя. Одоо энэ 2014 оны төсөв батлаад ирэхэд нь өнөөдөр бид сангийн бодлого талаасаа энэ чиглэлийгээ бас оруулж өгье.

Тэгээд ингээд хоёр талд нь оруулаад өгчихсөний дараа институци нь одоо жишээ нь санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл чинь энэ одоо танай Төвбанкны тухай хуулинд байгаа Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл чинь заалт нь.

Тэгэхээр тэр санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөтгөхөд ямар эрх зүйн акт хэрэгтэй байдаг юм бэ? Заавал хуулинд өөрчлөлт оруулах шаардлагагүй, тийм биз? Ямар ямар байгууллага орно гэж заасан байдаг юм бэ? Санхүүгийн асуудал эрхэлсэн яам гээд нэг тоон дээр заачихсан. Тэгэхээр чинь одоо тэр чинь 2 салчихаад байна шүү дээ. Эдийн засгийн хөгжлийн яамаар Санхүүгийнхээ тогтвортой байдлын зөвлөлийг өргөтгөөд, саяны ярьсан асуудлуудыгаа, тэрэн дээрээ дунд

хугацааныхаа асуудлыг ярьж байдаг л болох ёстой байна. Тийм биз дээ? Тэрнийг бас энэ мөнгөний бодлогынхоо бичиг баримтад тусгаж өгөх ёстой гэж бодоод байна. Өөрөөр хэлбэл тэртэй тэргүй сая шалгалтын явцаас харахад ч гэсэн ерөөсөө энэ санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, тэгээд танай дээр хийсэн шалгалтын явцад бидний тохирч ярьсан зүйл бол ерөөсөө энэ Төвбанкны тухай, тэр санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн тухай хуулийнхаа юмыг нэлээн тодорхой болгоод өгье. Энэ дээр ажиллаж байгаа юу? Хэдхэн заалт л орох юм байна лээ шүү дээ. Өөрөөр хэлбэл, санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн институци гэдэг утгаар нь жаахан хүрээгийг нь өргөжүүлэх, гаргаж байгаа бүтээгдэхүүн нь асуудал авч хэлэлцдэг талаас нь илүү тодорхой болгох ийм заалт. Тийм учраас энэ бол мөнгөний бодлогын 2014 оны зорилт танайд үүрэг байдлаар өгөгдөнө. Тэгээд тийм учраас тэрэн дээр эртхэн бэлтгэж байх ёстой.

**Д.Зоригт:** -Хэдэн зүйл асуумаар байх юм. Өөртөө зөв ойлголттой болмоор байна. Монголбанкнаас энэ бичиг баримтыг боловсруулалцсантай холбогдуулж бас хэдэн асуулт асууж, хариулт авъя гэсэн бодол байна.

Нэгдүгээрт, Монголбанк Засгийн газрын макро эдийн засгийн зарим үзүүлэлтийн уялдаа, өргөн барьсан бичиг баримтан дээр бол зөрчилтэй байгаад байгаа юмаа. *Нэгдүгээрт*, инфляцийн хэмжээг мөнгөний бодлогын төсөлд 2014 оны эцэст 8 хувиар тусгасан байгаа. Төсвийн бичиг баримттай холбогдсон бичиг баримт энэнээс доогуур хувиар тусгасан байгаа тийм ээ. Энэ яагаад ингээд зөрдөг юм бэ. Засгийн газар Монголбанк энэ чухал үзүүлэлтэн дээрээ тохироод нэг тоо Их Хуралд оруулж ирж болоогүй юм уу гэдэг.

*Хоёрдугаарт*, Монголбанкны хийж байгаа судалгаа, төсөөлөл, энэ танилцуулгад 2014 онд манай улсын эдийн засаг, төсвийн байдал бол төдийлөн сайн байхааргүй байгаа, хүндрэлтэй, төлбөрийн балансын алдагдал, энэ ханшид ирж байгаа дарамт бол үргэлжлэхээр байгаа. Гэтэл Засгийн газар улсын төсвийг тооцоолохдоо 1384 гэдэг ханшаар тооцоолоод оруулж ирсэн.

Бид нар энэ талаар ажлын хэсэг дээр ярилцахад бол урд нь бол ийм практик байдаг. Монголбанк, Сангийн яам хоёр тооцоолол тал талаасаа гаргаж байгаад тэгээд нэг тоон дээр тохироод оруулж ирдэг. Энэ жил бол тэгээгүй юм уу гэсэн ийм хоёрдугаар асуулт.

*Гуравдугаар* асуулт бол, ирэх жилд амаргүй байх юм байна. Тэгээд энэ үед Монголбанкны мөнгөний бодлого, тэр зөөлөн бодлого байх юм уу, энэ хатуу бодлого байх юм уу. Бодлогын хүү нь буураад, эдийн засагт оролцох энэ уламжлалт бус арга хэрэгслээр оролцох оролцоо нэмэгдээд, ийм зөөлөн маягийн бодлого явах юм байна аа гэж би ойлгож байгаа, энэ зөв үү.

*Дөрөвдүгээрт*, энэ банкны системд эрсдэл байна уу одоо. Бид нарт ирж байгаа, шалгалтын ажлын хэсэгт ажиллаж байгаа шүү дээ одоо. Зарим нэгэн эрсдэл бол байна. Энэ дотроо банкны системийн бас нэлээн том хувь жинг эзэлдэг аж ахуйн нэгж дээр бас эрсдлүүд бас байгаа.

Энэ дээр Монголбанк бас тууштай арга хэмжээ авч, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх тал дээр их хойрго байдлаар хандаж байгаа гэсэн мэдээллүүд ирээд байгаа. Энэ талаар та бүхэн бас товч мэдээлэл хийх ёстой байх. Хэтэрхий удааширч байгаад юмыг хүндэрсэн хойно нь маш их үнэ

өртөг төлөх болох вий гэсэн ийм болгоомжлол байдаг, одоо ч байна л даа. Дараа нь бид энэ ирэх жил ер нь энэ зээлийн хүү буурах нөхцөл бүрдэх үү, та бүхэн бол зээлийн хүү буурах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор зээлийн барьцаа хөрөнгийн эрх зүйн орчинг шинэчилнээ гэсэн ийм заалт оруулж ирж байна. Энэнээс өөр одоо энэ хүү буурах чиглэлийн дорвитой алхам Монголбанкны зүгээс хийгдэх үү. Энэ бол дөрөв дэх нь.

*Дараагийн асуулт* бол энэ инфляцийг нөлөөлөх энэ уламжлалт бус арга хэрэгслүүд гээд байгаа энэ Монголбанкны интервенц, мөнгөний нийлүүлэлтүүд, энэ дэд хөтөлбөрүүд үргэлжлэн хэрэгжих үү, хэрэгжвэл ямар хүрээнд хэрэгжих юм. Энэ жилийнхээ энэ хүрээнд хэрэгжих юм уу, ирэх жил магадгүй чиглэл, хамрах хүрээ хязгаар нь өөрчлөгдөхөөр байна уу. Энэ чиглэлээр та бүхэн ямар хэмжээний мөнгөний нийлүүлэлт хийхээр урьдчилан төлөвлөж байна вэ. Хэрвээ үргэлжлэх бол. Энэ жил 2.9, бараг 3 их наядын биелүүлэлт хийсэн байгаа. Ирэх жил ямар хэмжээнд хийгдэх юм бэ гэсэн нэг ийм зүйлүүдээр би ойлголт аваад явъя.

*Хамгийн сүүлд нь* бас нэг юм орхичихож. Монголбанкнаас Засгийн газарт санал болгосон байна лээ. Би бол бас зөв зүйтэй сайн санал юм болов уу гэж бодоод байгаа юм. Тэр экспортыг дэмжих тийм ээ. Монголбанкнаас дэмжлэг үзүүлье. Орон нутагт бизнесийг, ажлын байрыг бий болгоход зориулсан бас дэмжлэгийн ийм хөтөлбөрүүд гаргая гэсэн санал, санаачилгаа Засгийн газарт хүргүүлсэн юм байна аа гэж ойлгосон.

Энэ ажил ямар байдалтай яваа вэ. Ирэх жил бодитой ажил болж чадах уу, яг юу хийгдэх юм бэ гэсэн ийм чиглэлүүд дээр бас мэдээлэл өгөхгүй юу гэсэн асуултууд байна. Баярлалаа.

**Болдбаатар** -Хамаатай хамаатайдаа хариулчихъя тийм ээ. Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яаманд Монголбанк өөрийнхөө төсөөллийг нэлээн эрт хүргүүлсэн. Тэгээд тэр бичиг эд нар нь бас сайн дамжаагүй юм уу яасан юм сүүлд одоо бид нар тооцоогоо нэгтгэх шаардлагатай болоход бол бүтэн сайн өдөр хоёр талаасаа сууж байгаад тооцоогоо ингээд өгсөн. Бишээ биш, өргөн барихаасаа хоёр 7 хоногийн өмнөх бүтэн сайн өдөр тийм.

Тэгээд энэ тоонууд нь ингээд өөр ингээд тавигдчихсан байж байгаа. Тэгэхээр тэрийг бол одоо бидэнд Сангийн яам, Засгийн газар чинь одоо тайлбарлахгүй шүү дээ. Нэгэнт одоо тэр боловсруулсан юун дээр нь санал өгөх эрхгүй болохоор одоо тэгээд тэр чигээрээ л тэрүүгээрээ яваад ингээд орчихдог.

Бидний юм бол гол нь эдийн засгийн өсөлтийн хувь, тэрний секторын бүтцийн задаргааг л одоо Эдийн засгийн хөгжлийн яам хуучин Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо, тэрнээс өмнө Сангийн яамнаас авдаг байсан. Энэ жил авч чадаагүй учраас манай эдийн засгийн өсөлтийн томъёолол Засгийн газрынхаас ялгаатай байгаа. Ялгаатай байх бас үндэслэлүүд байж байгаа. Тэрэн дээр нь юу вэ гэхээр бид нар Оюу толгой болон Таван толгойгоос орж ирэх орлогыг төлбөрийн балансдаа эерэгээр тусгаж, ДНБ-ний өсөлтөнд эерэгээр тусгах боловч нөгөө талдаа яг эдийн засагт үзүүлэх нөлөөллийн хувьд бол хасаж тооцож байгаа, мөнгөний үзүүлэлтүүдийн хувьд ч гэсэн.

Энэ маань дандаа нөгөө урьдчилан хэрэглэсэн зээл төлөх хэлбэрээр, нөгөө талдаа буцаад гадаад зээл төлбөрөөр ингээд явчихаж байгаа болохоор

зэрэг тэр өгөгдлийн хувьд бол зөв оруулсан гэж бид нар ингэж тооцож байгаа. Тэгэхээр зэрэг эндээс авахуулаад жаахан тийм ялгаатай зүйлсүүд байх шиг байна лээ. Тэгээд инфляцийн тооцоонууд бол өөрөө.

**Болдбаатар** -Өргөн барихаас хоёр 7 хоногийн өмнө 9 сарын дундуур л явуулсан. Би бол 9 сарын дундуур ням гараг тэрийг нь санахгүй байна. Тэрийг улсуудтай нь бол яг ирээд ийм үзүүлэлтүүд шүү гээд тайлбарлаад явсан. Тэгээд ийм л материал бүгдээрээ байж байгаа угаасаа.

**С.Дэмбэрэл:** - Албажуулсан ямар эрх зүйн баримт бичиг байна вэ? Өөрөөр хэлбэл, энэ хоёр байгууллага мэдээллээ ингэж солилцоно гэсэн зүйл байна уу?

**Болдбаатар:** - Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтарсан тушаал байдаг юм. Батлагдсан журам байдаг юм.

**С.Дэмбэрэл:** -Хэдэн онд вэ?

**Болдбаатар** - Нэлээн хэдэн жил болчихож байгаа, би яг оныг нь санахгүй байна.

**С.Дэмбэрэл:** -Нэлээн эртнийх гэж үү?

**Болдбаатар:** -Тийм. Тэгэхдээ сүүлд сайжруулсан юмаа. Пүрэвдорж ерөнхийлөгчийг байх үед бол нэг сайжруулсан журам байгаа. Инфляцийн тооцооны хувьд бол бид нар өөрсдийнхөө үндэсний энэ тайлбар судалгааны хэсэг дээр энэ 81 дүгээр хуудас, 80, 81 дүгээр хуудсан дээр бол эдийн засгийн өсөлтөөсөө инфляци уруу яаж нөлөөлж байгаагийг нь ингээд ийм яасан тайлбарууд нь байгаа юм. Бид нарын үндсэн тайлбарууд. Гэхдээ энд бол бас их тийм техникжүүлэхгүй утгаар бол яг тооцооллын хураангуй дүнгүүдийг нь тавьчихсан байж байгаа юм.

Шаардлагатай гэж үзэх юм бол дэлгэрэнгүй тооцооллууд бараг аргачлалын хувьд бид нар нэмж. Суурь инфляцийг өөрийнх нь бид нар чинь экспост тооцох боломжтой тийм зүйл шүү дээ. Одоо ерөнхийлөгчийн инфляци гэж. Тийм тэгж экспостоор бол гарсны дараа л тооцох боломжтой байгаад байгаа юм л даа. Тэгэхдээ харин ерөнхийлөгч суурь инфляци уруу анхаарал тавиад байгаа учраас бид нар суурь инфляци уруугаа тооцоо хийх тийм аргачлал уруу орж эхэлж байна. Хамгийн төвөгтэй суурь инфляци тооцдог хэсэг бол нөгөө төрөөс үнэнд нөлөөлдөг бараануудын үнийн прогноз бол нэлээн төвөгтэй асуудал байгаа юм...

**С.Дэмбэрэл:** - Дараагийнх уруу нь орёе. Ирэх оны төсөв, эдийн засгийн орчин энэ тэр ийм хүндрэлтэй байна аа гэсэн төсөөлөл Монголбанкны санал дээр туссан. Тэр бол түрүүн миний хэлсэнчлэн Оюу толгойгоос бий болж байгаа том өсөлт эдийн засгийн өсөлт байгаа. Тэгээд Тавантолгойн нүүрсний борлуулалтын тооцоонууд байж байгаа. Энэ тооцоонуудыг хасахаар зэрэг эдийн засгийн өсөлт маань тийм өндөр биш тийм тоо гарч ирээд байгаа юм. Тэгэхээр тэр тийм өндөр биш тооцоотойгоо уялдаад үүсэж байгаа төсвийн орлого, улмаар бий болж байгаа санхүүгийн секторт хуримтлагдах эх үүсвэр зэрэг нь нээлэн тааруухан. Тэр тусмаа одоо бидэнд бол энэ гадаад валютын дотогшоо урсгалыг нэмэгдүүлэх хэмжээний тийм эрх зүйн өөрчлөлт гарсан гэхэд бас төдийлөн тийм итгэл олсон, тийм хэвийн эдийн засаг харьцангуй бага байна. Сая одоо хуульд гарсан өөрчлөлтийн дараа гарч ирж байгаа гэхэд их гутранги хэлбэртэй болоод явчихаж байна. Тэгэхээр одоо энэ төсөөллийг хийснээс хойш сайжрахаар тийм нөхцөл

байдал үүссэнгүй ээ гэж би хэлэх гэж байгаа юм л даа. Энэ төсөөлөл бол яг л 8 сарын тоон дээр л үндэслэсэн ийм төсөөлөл байгаа. Одоо энэ 9 сар чинь өөрөө том тооны шинэчлэлттэй, яагаад гэвэл ДНБ-ний улирлын тоо гарчихна гэдэг маань өөрөө их том тоо гараад ирж байгаа юм. Тэгэхээр энүүгээр бид нар сайжрууллаа гэхэд сайжрах тийм тооцоо гараагүй байна гэсэн тийм л тайлбар байна. Энэ нөхцөлөөрөө ингэж бодоод, цааш нь явах юм бол мөнгөний бодлогыг хатуу болгох уу, зөөлрүүлэх үү гэсэн энэ хоёрын хооронд нь харьцуулж хэлэхэд их төвөгтэй юм л даа. Хэрвээ санхүүгийн эх үүсвэрүүд Монголоос гадагшилсаар байх юм бол санхүүгийн эх үүсвэрийг буцааж эргүүлэх арга хэмжээнүүдийг бид авах хэрэгтэй болно.

Санхүүгийн эх үүсвэрийг буцааж эргүүлэх арга хэмжээ гэдэг нь нэг хэсэг нь угаасаа төгрөгт хийсэн хөрөнгө оруулалтын хүүний орлого нь бусад валютад хийсэн хөрөнгө оруулалтын хүүний орлогоос харьцангуй өндөр байхтай холбоотой асуудал байдаг.

Тэгэхдээ бид нарын ярьж байгаа энэ цаг хугацааны юман дотор, АНУ-ын мөнгөний хэлбэлзлийг зөөлрүүлэх тэр бодлого харьцангуй шувтрах тал уруугаа орох ёстой учраас одоо дэлхийн санхүүгийн зах зээлийн орчинд хүү өсөх ёстой гэсэн ийм шинэ тийм мэдээлэл орж ирж байгаа. Өөрөөр хэлбэл, америк үргэлжилсэн мөнгөний зөөллөх бодлогоосоо багасгаж ирэхээр долларын хүү өсөж эхэлнэ. Энэ маань олон улсын зах зээлийг... өсгөх ийм нөхцөлийг бүрдүүлнэ.

Тэгэхээр энэ үед төгрөгөөс олж авах санхүүгийн хожоо хэвээрээ байгаа тохиолдолд бол одоо нөгөө төгрөг, гадаад валютын хоорондох хүүгийн зөрөө бол нарийсч, багасч, төгрөгт хөрөнгө оруулалт хийх эрмэлзэл бол багасах учиртай. Тэгэхээр энэ утгаараа бол бид хэдийгээр эдийн засгийн нөхцөл байдал ийм хүндрэлтэй байгааг бид нар мөнгөний бодлогыг сулруулах шаардлагатай байгаа боловч сулруулах гэж байгаа оролдлого маань сулруулахаасаа илүү их том проблем үүсчих тийм нөхцөл бүрдүүлэх үү, үгүй юу гэдгийг хооронд нь жигнэж үзэж байж энэ шийдвэрийг гаргах шаардлагатай байгаа юм.

Яг одоогоор бол ирэх онд ерөнхийдөө мөнгөний бодлого зөөлрүүлэх нь зүйтэй гэсэн ийм ерөнхий тийм хандлагууд байгаа. Энийг дахиад өөрчлөх нөхцөл маань одоо тэр дэлхий дээр гарч ирж байгаа өөрчлөлттэйгээ л холбоотой байх юм. Тэр банкуудын эрсдлийн тухай бол Ганбаа сүүлд нь хариулчих байх.

Зээлийн хүү буурах нөхцөл бүрдэх үү гэдэг дээр тэр нөгөө барьцааны юу байсан Ганбаа чи бас нэмээд хариулчих. Инфляцийн энэ уламжлалт улс... гэж бид нэрлээд байгаа. Одоо энэ манай үнэ тогтворжуулах хөтөлбөрүүдийн хувьд энэ мөнгөний бодлогын хүрээнд тооцогдсон гол зүйл маань өмнөх махны үнийн хөтөлбөр, мах, бензин, гурил, тэгээд дээрээс нь энэ барилгын хөтөлбөр, тэгээд одоо нөгөө нүүрсний аюулгүйн нөөцийн хөтөлбөр гээд ийм хэмжээнд одоо бодож тооцож оруулсан байгаа.

Экспортыг дэмжих хөтөлбөрийн хувьд бол бас нөгөө нэг ложистикийн тийм ээ. Экспортыг дэмжих хөтөлбөрийн хувьд бол одоогоор хийгдсэн яг тооцоонд оруулчихаар хэмжээний тийм түвшинд хүрч бэлтгэгдэж дуусаагүй байгаа. Тэгэхээр энэ бол одоохондоо зарчмын тохироо, ийм л хэлбэртэй байгаа юм байна гээд хэлбэржээд, хэрэгжих механизм нь



тодорхой болоод ирэхээр зэрэг бид нар тухайн үедээ тооцоондоо оруулаад ингээд явах юм. Хэмжээний хувьд бол өмнөх жилийнхээс за бензин ложистикийн хувьд бол ямар байхыг би сайн мэдэхгүй байна. Махны хөтөлбөр, гурилын хөтөлбөрийн хувьд бол өнгөрсөн жилээсээ давахгүй, энэ бол хөтөлбөрийн нийт хэмжээнээсээ давахгүй гэсэн үг. Махных бол хэмжээнээсээ бага байна. Орон сууцны хувьд бол миний одоогийн надад өгсөн мэдээллээр бол тэр цемент, арматурынх нь импортынх нь хэсэг бол үргэлжлэхгүй юм байна. Дотоодын үйлдвэрлэлийг санхүүжүүлж байгаа тэр 36 сарын турш явж байгаа тэр хөтөлбөр бол хэрвээ зээлдэгч нь өөрөө үнэхээр яг зориулалтынхаа дагуу яг нөгөө төсөлд тусгасан хэлбэрээрээ үргэлжлүүлэхийг хэрэглэж байгаа бол тэр хэмжээндээ үргэлжилнэ. Тэрэн дээр нэмэгдэх юм бол харьцангуй бага. Зориулалт нь юу байх юм бол тэр хэмжээгээр зориулалтын дагуу ашиглах юм бол тэр хэмжээгээр буурсан хэлбэртэй ингээд явах юм байна аа.

Зүгээр бидний хувьд өмнө нь тооцсон бас нэлээд их давах төлөвтэй байсан байгаа зүйл бол энэ орон сууцны санхүүжилтийн шинэ тогтолцоог бий болгоход зориулагдсан орон сууцны ипотекийн зээлийн бидний энэ ард олны хэлээд байгаа 8 хувийн хөтөлбөрийн хувьд бол энэ хэмжээнээсээ нэлээн өндөр болох шинжтэй байна. Энэ анхны тооцоо бол 800-1.5 триллион төгрөгөөр тооцоо хийгдэж байсан. Одоо бол 1.4 триллион болчихоод байхад цаана нь зах зээл нэлээн өргөн үлдчихээд байгаа учраас энэ бол анх байсан хэмжээнээсээ нэмэгдэх нь ээ гэсэн ийм тайлбарыг хэлье. Ганбаа үлдсэнийг нь.

**Ганбат:** -Монголбанкны хяналт шалгалтын газар. Банкны системийн эрсдэл ерөнхийдөө ямархуу түвшинд байгаа вэ гэсэн асуулт байна. Ер нь 2011 оноос бол банкуудын эрсдэл даах чадварыг сайжруулах зорилгоор дүрмийн санг хувь нийлүүлсэн хөрөнгийг 2 дахин нэмэгдүүлээд, энэ 2013 онд бол бүх банкууд хангагдсан байж байгаа. Яг энэнтэйгээ зэрэгцүүлээд 2011 онд бас системийн нөлөө бүхий банкууд бол өөрийн хөрөнгийн шаардлагыг бол нэмэгдүүлэн тогтоосон байж байгаа. Бусад банкууд тэр 12 хувиар өөрийн хөрөнгийн шаардлагыг тавьж байгаа бол системийн нөлөө бүхий банкууд дээр бол 14 хувийн шаардлагыг тавиад, мөн 2013 оны 6 сарын 30 гэхэд бол бүгдээрээ хангагдсан байх шаардлагыг бол банкууд тавьсан. Мөн өөрийн хөрөнгөнөөс эрсдэл даах чадварыг үзүүлэх өөрийн хөрөнгийн яг хувь нийлүүлэгчдийн өөрийн хөрөнгийн шаардлагыг бол бас нэмэгдүүлсэн байгаа бүх банкууд дээр. 6 хувь байсныг нь 9 хувь болгоод, энийгээ бол манай банкууд бүгдээрээ ханган биелүүлсэн.

Үүний үр дүнд бол ерөнхийдөө эдийн засгийн нөхцөл сайн байгаа нөхцөлд банкууд маань энэ нөөцөө хуримтлуулсан учраас одоогийн статистик тоогоор хараад үзэх юм бол банкуудын Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлт гэвэл ер нь хангаад явж байгаа. Системийнхээ хэмжээгээр. Өөр өөрийн шаардлага гэхэд бол системийн хэмжээгээр 15.6 хувь буюу Монголбанкнаас тавьсан харьцаанаас нэлээн өндөр байж байгаа.

Гадаад валютын позицыйн юуг бол сүүлийн ялангуяа ханшийн өөрчлөлт нэлээн их өссөн, сүүлийн үед бол банкууд бол Монголбанкн дээр тогтоосон зохистой харьцаа, валютын зохистой харьцааг бол байнга



хангаад явж байгаа. Энэ юу гэсэн үг вэ гэхээр ханшаас үүсэх эрсдлээс бол нэлээн болгоомжтой банкууд бол консерватив байдлаар хандаж байгаа гэдэг нь харагдаж байгаа.

Ер нь бусад зохистой харьцааны хувьд бол зарим нэг банкууд бол яах вэ нэг зээлдэгчийн хязгаарлалтыг зөрчсөн юмнууд бол байх нь бол байгаа. Гэхдээ Монголбанкнаас тухай бүр арга хэмжээ аваад биелүүлэх хугацаатай үүрэг даалгавар өгөөд явж байгаа.

Сая системийн нэг нөлөө бүхий банкуудын нэг банкны талаар асуулт асууж байна. Энэ дээр банкнаас нь ирүүлсэн гомдол, хувь нийлүүлэгч болон ТУЗ-ийн даргаас ирсэн гомдлын дагуу бол Монголбанк энэ жил 5 удаа асуудлуудаар нь бол шалгалт хийгээд явж байгаа. Тэр тавигдсан асуудлуудтай холбоотойгоор бол банкинд нөлөөлөхөөр бол эрсдэл бол алга байна гэсэн тийм дүгнэлтийг бол гаргасан байж байгаа. Одоо хувь нийлүүлсэн, хамгийн гол сүүлийн үед аудитын тайлангийн асуудал бол энэ бараг дараагийн 7 хоногт бол аудитын дүгнэлт гарчихна. Энэнтэй холбоотойгоор хувь нийлүүлэгчдийн хурлаа хийгээд, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэх ажлыг бол банкны зүгээс хийхээр төлөвлөж байгаа юм байна лээ. Өөрөөр хэлбэл маргаантай байгаа талууд маань банкны үйл ажиллагаанд оролцох оролцоогоо ерөнхийдөө нэг хэсэгтээ больчихъё гэсэн тиймэрхүү саналууд явж байгаа юм байна лээ. Энэ нь бол боломжтой эсэхийг сайн хууль эрх зүйн талаас нь бол судалж үзэх хэрэгтэй байх аа гэж бодож байна.

Ер нь банкууд дээр эрсдлийн асуудал бол хэрхэн байгаа вэ гэхээр сүүлийн үед ханшийн өсөлт, ханшийн өөрчлөлттэйгээр бол зээлдэгч дээр очиж байгаа зээлийн норматив бол 300 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байж байгаа. Энэнтэй ч холбоотойгоор ер нь статистик хараад үзэх юм бол чанаргүй зээл уруу системийн хэмжээгээр 2.1 хувь байгаа. 8 дугаар сарын байдлаар. Тэгэхэд бол зөвхөн гадаад валютын зээлийг нь аваад үзэх юм бол чанаргүй зээлийн хувь бол нэг 3.4 хувьтай байж байгаа.

Тэгэхээр тодорхой хэмжээний бас ханшийн өөрчлөлттэй холбоотойгоор зээлдэгчид төлбөрийн чадварт бас хүндрэл учрахыг бас үгүйсгэх аргагүй. Энэнтэй холбоотойгоор бол Монголбанк ер нь өнөөдөр эхлээд явж байна. Одоо валютын орлого муу зээлдэгч нарт ямар санхүүгийн эрсдэл ашиглаж болох вэ гэдэг дээр судалгаа хийгээд. Ер нь өнгөрсөн оны 11 сараас бол нефть импортлогч нарт ийм .. юугий нь бол Монголбанкнаасаа хэрэгжүүлээд явж байгаа.

Энэ боломжтой хувилбарыг бусад зээлдэгчийн хувьд нэвтрүүлэх боломж байна уу, үгүй юу. Эсвэл валютын орлогогүй этгээдүүдэд олгох зээлийг хязгаарлах ямар нэгэн бодлогын арга хэрэгсэл бас байж болох юм гэсэн судалгаа хийж байна. Валютын орлогогүй зээлдэгчдэд. Зарим нь хадгаламжийнхаа хугацааг хүлээж байгаад доллар уруу шилжүүлчихдэг. Тэгээд ийм байдлаар өөрсдийгөө хамгаалдаг. Гэтэл Монгол Улсад гэв гэнэт нэг цөөн тооны юу гэдэг юм сарын юм уу, нэг улирлын дотор банкны баланс дээр баахан доллар бий болчихдог. Одоо нэг 32, 33 орчим хувь нь хадгаламжийн 33 орчим хувь нь доллар уруу болоод явчихсан байж байгаа. Тэгээд нөгөө хүн хадгаламжаасаа доллараа авъя гээд хүрээд ирэх юм бол банкууд өгч чадахгүй. Зүгээр бичилтээр бий болчихсон доллар байгаа шүү дээ. Монгол Улс өөрөө доллар үйлдвэрлэдэггүй. Тэгэхээр энэ

дээр одоо бусад орнууд Капитал контроль гэж яриад байгаа шүү дээ. Энэ капитал контролыг ямар нэгэн хэмжээнд хэрэгжүүлэх, ямар нэгэн түвшинд хэрэгжүүлэх бодлого байх ёстой. Одооны шиг ингээд задгай яваад байж болохгүй ээ гэж. Одоо бол бодлогогүй явж байна л гэсэн үг л дээ. Явал яая гэсэн байдалтай. Энэ дээр мэргэжлийн байгууллага нь тал бүрээс нь судалгаа хийгээд, эерэг сөрөг талыг нь үзээд, ямар нэгэн арга хэмжээ авах хэрэгтэй. Тэгэхгүй бол энэ одоогийнхоос илүү их хямрал тохиолдвол энэ бол бүр маш хэцүү тийм гүнзгий хямрал уруу ороход их ойрхон байгаа. Тэгээд долларын савлагаанаас болоод доллараар зээл авсан хувийн компаниуд хамгийн түрүүн хохирч байгаа. Хувийн компаниуд бол буруугүй шүү дээ. Доллар ингээд савлаж байгаа бол огт буруугүй, бизнес хийж байгаа компаниуд. Төр засгийн юм уу бодлого баригч байгууллагуудын хийсэн алдаанаас алдагдал хүлээж байгаа, өөрсдөө буруугүй. Яахав гадаад хүчин зүйлүүд мэдээж хэрэг байгаа. Гэхдээ гарч байгаа хохирлын нэлээд хэсэг нь бодлого баригч байгууллагуудаас болж гарч байгаа.

Тэгэхээр энэ хохирлыг хувийн компаниуд болон банкууд шууд үүрч байгаа, алдагдал болж байгаа. Эдгээрийн санхүүгийн баланс дээр. Тэгэхээр энэ алдагдал хүлээж байгааг энэ бодлого боловсруулагч байгууллагууд хуваалцах ёстой. Яаж хуваалцах вэ гэхээр ядаж энэ алдагдлыг бууруулах эдийн засгийн арга хэрэгслийг нэвтрүүлэх ёстой. Одооны шиг ингээд зүгээр байгаад байж болохгүй. Бүх юмыг зах зээлд даатгачихаад байгаад байж огт болохгүй. Ядаж энэ арга хэрэгслийг нэвтрүүлэх ёстой. Болж өгвөл ямар нэгэн нөөцийн сангаас энэ алдагдлыг хуваалцах ёстой. Засгийн газар юм уу, Төв банк юм уу энэ алдагдлаас хуваалцах ёстой гэж бодож байгаа. Одоо бол 100 хувь хувийн компаниуд банкууд үүрч байгаа энэ алдагдлыг. Дараагийн санал бол ирэх жилийн үнийн бодлого зөөлөн байх уу, хатуу байх уу гэдэг дээр банкууд бол нэг л бодолтой байгаа. Үйлдвэрлэл, үйлчилгээ дэмжсэн бодлогыг л явуулж өгөөсэй гэсэн ийм саналтай байгаа юм. Урд өмнөх 20-иод жилийнх шиг цэвэр валютын сангийн заавраар хатуу мөнгөний бодлого явуулаад, дотоодын үйлдвэрлэл үйлчилгээ хөгжсөн, дорвитой хөгжсөн юм байхгүй. Зөвхөн хэрэглээний зээлийг дэмжсэн ийм л бодлого 20 жил явсан.

Өндөр хүүтэй, хатуу мөнгөний бодлого явахаар хүү өндөр болдог. Өндөр хүүтэй болохоор зөвхөн хэрэглээний зээл авдаг. Үйлдвэрлэл үйлчилгээ явуулах бололцоо байхгүй. Тийм учраас арай ийм бүтээлч, Төв банк болон төрийн байгууллагууд арай бүтээлч байж, энэ арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх хэрэгтэй. Энэ дээр Монголбанк ер нь ямар бодлого барьж байгаа юм бэ, цаашдаа ер нь энэ зээл яг хэдий хугацаанд дуусах юм бэ. Үргэлжлэх хугацаа ер нь Засгийн газартай тохирсон барьсан юм байна уу гэж. Энэ бол мөнгөний бодлогод ихээхэн нөлөө үзүүлж байгаа эд байгаа шүү дээ. Тэгээд энийг та бүхэн нэг тайлбарлаач ээ гэж.

*Хоёрдугаарт*, сая нөгөө Монголбанкинд орсон ажлын хэсэг аудитын шалгалтын байдал дүгнэлтүүд дотор бас нэг заалт ороод байгаа байхгүй юу. Гадаад валютын албан нөөц одоо 1.4 тэрбум ам.доллараар буурсан. Тэгээд энэ 9 сард бол бүр алдагдсан гэж байгаа юм. Тэгээд энэ одоо нөхөн сэргээгдэж байгаа юу. Хэр их хэмжээгээр одоо нөхөн сэргээлтийн ажил нь явж байгаа юм бэ гэдгийг нэг асуух гэсэн юм. Бас, Монголбанкнаас

өгсөн тайлбар байна. Засгийн газар Улсын Их Хурлаас оновчтой шийдвэр ерөөсөө гаргахгүй байна. Энэнээс болоод бид нарын одоо үйл ажиллагаа бас доголдож байгаа, инфляцид сөргөөр нөлөөлөх байдал үзэгдээд байна гэсэн тайлбар өгсөн байна.

Тэгэхээр яг Засгийн газар хамаа байж уу, Улсын Их Хурлаас ямар оновчтой шийдвэрийг одоо мөнгөний бодлогод тусгуулах гээд байгаа юм бэ. Энэ талынхаа хэлдэг барьдаг юм байгаа бол одоо бас тодорхой хэлчихмээр байгаа байхгүй юу. Тэгэхгүй нэг Засгийн газар уруу бухаад, нэг Их Хурал уруу бухаад үр дүн харагдахгүй болох юм биш биз дээ гэсэн нэг ийм юм ажиглагдаж байгаа. Энэнтэй уялдуулаад тэр эрчим хүчний үнэ нэмэгдсэн асуудал дээр Монголбанк хоёр байр суурь зөрчилтэй байгаа. Тэгээд энэ асуудлыг одоо Засгийн газарт албан ёсоор тавьсан уу, эрчим хүчин дээр бол бас үнэ тогтворжуулах тэр юуг тэрийг бас хэрэгжүүлээд эхэлчихсэн шүү дээ. Тэгээд энэ хоёрын хоорондын зөрчил бас хир их нөлөө үзүүлэх гээд байна аа гэдэг ийм нэг хэдэн асуулт байна.

Дээр нь би тэр банкуудын холбоо Монголбанкны хоорондын зөрчил өө наадаг чинь бол. Та нарын хооронд үргэлж ийм байдал асуудал. Эцсийн дүндээ бол мөнгөний бодлого бол яг одоо энэ аж ахуйн нэгжүүд дээр иргэдийн нуруун дээр яаж тусах вэ гэдэг нь л илүү чухал байгаад байгаа байхгүй юу. Тэрнээс бол арилжааны банкууд өөрийнхөө... хамгаалах гээд нэг өөр юм яриад байдаг, Монголбанк чухам арилжааны банкиг хамгаалах юм уу эсвэл нийт зах зээлээ хамгаалах юм уу гэдэг нь ялгаатай байгаа байх л даа...

**С.Дэмбэрэл:** - Мөнгөний бодлогын зөвлөлд төлөөлөл ороод, 2014 онд яаж хөгжих тухай үе үе тусгайлан харилцан ярианы механизм үүсэх байх гэж найдаж байна. Энэ чиглэлээр ч гэсэн 2014 оны мөнгөний бодлогын чиглэлд санхүүгийн секторыг бэхжүүлэх гэсэн тэр хүрээндээ орох байх аа.

*Хоёрдугаар асуулт.* Валютын ханшны бодлого, хөрөнгийн хяналт энэ чиглэлээр энэ дээр хүрэн номон дээр бичсэн юм нь огт болохгүй зүйл ээ. 2009 онд ингэж байсан, тэгээд ингэсэн тэгсэн гээд, хоёр өөр байр сууриар яваад байна л даа. Тэгэхээр яг бодит факт бол өнөөдөр 1700, яг бодит факт бол инфляцид аль хэдийнэ нөлөөлөөд эхэлчихсэн. Яг бодит факт бол давамгайлах шинж тэмдэг орчих гээд байна. Тэгэхээр нөгөө үндсэн зорилго маань инфляцийг нэг оронтой тоонд оруулах. Инфляци уруу нь, валютын ханшны үүсэлтэй энэ зүйл уруу аль хэдийнэ халдаад, эхлээд энэ гол гол нэрийн барааны үнүүд өсөөд эхэлсэн. Одоо нөгөө дэд хөтөлбөр уруу чинь дайраад эхэлсэн гэсэн үг л дээ. Тэгэхээр яг ийм байдлаар одоо оруулж ирсэн чинь бол 2014 оны мөнгөний бодлогод юу гэж нэмж оруулах юм бэ? “Макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцүүлэн валютын ханш уян хатан тогтох зарчмыг үргэлжлүүлэн баримталнаа” гэхихсэн байгаа. Энэ чинь өмнөх жилд орж ирсэн, тэрний өмнөх жилд ч орж ирсэн. Тэрний өмнөх жилүүдэд ч орж ирж байсан ийм л зүйл заалт юм.

Тэгэхээр Монголбанкнаас асууя даа. Энэ дээр та бүхэн одоогийн байгаа энэ дэглэмийг өөрчлөхгүйгээр валютын ханшны энэ хэт их цочрол, хэлбэлзэлээс болж зээл авсан нэг хэсэг нь хохирч байгаа, тендерт орсноосоо болоод нөгөө хэсэг нь хохироод байгааг яах юм бэ? Тэр нөгөө дэмжих гээд байгаа хувийн хэвшлийн чинь тэр хэсгийн ачааллыг нь зөөлрүүлэхийн

тулд рискээ /эрсдэлээ/ хуваалцъя гэсэн энэ механизмын талаар танайд бол ер нь бодож, төлөвлөж байгаа зүйл байна уу гэсэн нэг ийм асуулт байна.

**Болдбаатар:** - Энэ Монгол Улс бол валютын ханшаа тодорхой хэмжээгээр хамгаалж ирсэн нэлээн тийм бас өмнөх жишээнүүд байдаг ийм улс юм л даа. Тэгэхээр төвөгтэй зүйл нь юу вэ гэхээр гадаад худалдааных нь нийт эргэлт ДНБ-нээсээ их байдаг учраас одоо хэрвээ гадаад худалдаа тэнцүү байна аа л гэхэд ДНБ-ний талаас илүү их хэмжээний төлбөрийг гүйцэтгэх орлого олж авах ийм шаардлагууд тулгардаг. Энэ шаардлагууд нь ханшны их хөдөлгөөний үед бол тэрийг бага хэмжээний юм уу эсвэл нэлээн том нөөцөөр ч юм уу, эсвэл одоо Хонконг шиг ДНБ сайн давсан тийм нөөцөөр хамгаалахаар бусдаар хамгаалах ийм боломж бүрдэхгүй байгаа юм.

1995 онд үүссэн энэ ханшны хөдөлгөөнийг хязгаарласаар яваад л сүүлд нь 1999 онд, 1998 онд үндсэндээ бараг хямралтай шинж чанар уруу орсон. 2008 онд бол одоо энэ ном дээр ч зураг нь байж байгаа бэлнээрээ. Одоо үндсэндээ хамгаалсаар байгаад тэгээд асар том хэмжээний хямрал уруу орсон. Тэгэхээр нэгэнт одоо суурь хүчин зүйлүүд гажчихсан тохиолдол, өөрөөр хэлбэл өнөөдөр жишээ нь 9 дүгээр сарын дугаар гарахад бол сүүлийн 12 сард худалдааны нөхцөл өөрөө ороод доор муудчихаад байж байна. Тэгэхээр энэ нөхцөл үүсчихээд байхад Төвбанк одоо ямар ч нөөцтэй байсан юм энийг хамгаалах боломж бол харьцангуй хязгаарлагдмал байгаа юмаа. Тийм учраас та түрүүн хэлж байсан. Валютын нөөц бол ихээхэн багассан ийм нөхцөл бүрдсэн байсан шүү. Та нар сэргэсэн үү гэж ярьж байна.

Тэгэхээр энэ нөөц алдагдах хэмжээнд хүрсэн ийм зүйл бол үндсэндээ ханшны хөдөлгөөнийг бас хэтэрхий өндөр хүчтэй савалгаатай байлгахгүй байхад л одоо зориулж хийж байгаа Монголбанкны нийгмийн амьжиргааг хамгаалах, бизнесийг хамгаалахад зориулж хийж байгаа үйлдлүүд гэж ингэж үзэж байгаа. Дээрээс нь бид ийм жижигхэн тэгээд их хүч, гадаад эдийн засгаас ихээхэн хамаардаг нээлттэй эдийн засагтай учраас ханшийг хамгаалах гэсэн тийм ямарваа нэгэн амлалт, эсвэл одоо эрх зүйн барьцаанд орох тийм үндэслэл боломж эдийн засгийн хувьд байхгүй ээ. Үндсэндээ 1992 оны, 1993 оны 9 сарын 12-нд Сорос банкныг атакласнаас хойш 1994 онд энэ валютын довтолгооны судалгаанууд нийтлэгдсэнээс хойш энэ бол маш ойлгомжтой зүйл болсон. Өөрөөр хэлбэл бид ханшийг хүчээр хамгаалах нөхцөл байдалд хүрэх юм бол ханшны одоо нөөцийнхөө хэмжээг маш богино хугацаанд валютын бодлогонд алдаад дуусах ийм боломжтой, тийм эрсдэлтэй хүмүүс ч бий. Дэлхий нийтээр ч зөндөө бий, ийм туршлагууд ч их олон болчихсон байна аа. Тийм учраас валютын ханшийг тогтвортой барих гэсэн шахалтууд, дарамтууд, зөвлөмжүүд ямар нэгэн бодлогын хувилбарыг сонгосон тохиолдолд бол одоо дунд хугацаанд нь гэж хүрэхгүйгээр богино хугацаанд эдийн засгийн хүчтэй хямрал уруу орох бүрэн магадлалтай гэж үзэж байгаа. Ялангуяа гадаад худалдааны нөхцөл өөрөө муудсан, макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүд муудсан ийм үед бол энэ боломжгүй зүйл байна аа. Хүлээлт та үүсээд байна гэж дүгнэж байна. Хүлээлтийг нэлээн гайгүй болчихлоо гэж бид тооцож байгаа. Юуны дараа бол одоо 2012 оны 1 сард Монголбанкныг ханшаа хамгаалахыг хүчтэй шахсаны дараа төгрөг суларч, хүлээлт нэлээн өндөрсөж эхэлсэн. Тэгээд энийг бол Монголбанк тэр үеэс л үндсэндээ ханшны хүчтэй хөдөлгөөнийг хязгаарлаж эхэлсэн шүү дээ. Тэгэхээр тэгж явсаар.

**С.Дэмбэрэл:** - За болсон. Ерөнхийдөө наадах чинь миний хувьд бол цээжилчихсэн өгүүлбэрүүд байна. Яг одоо, хэдүүлээ эдийн засаг болж тоглохоо больё. Энэ жилийн валютын ханшны бодлого гэдэг дээр тэр бодлого шиг бодлого орж ирэх ёстой. Тэр нь одоо та нарын хэлээд байгаа макро эдийн засгийн нөхцөлтэй тохируулан валютын ханш зах зээл дээрээ чөлөөтэй уян хатан тогтож байх, энэ олон жил ярьсан зүйл чинь өөрөө бодит амьдралын хувьд учир дутагдалтай гэдэг нь харагдаад байна шүү дээ. Тэгэхдээ энэ маань, валютынхаа нөөцийг шавхаад барчих гэсэн үг бишээ. Танай объект чинь болж байдаг банкуудын холбооны энэ нөхөд, дээр нь санхүүгийн зах зээл дээр ажилладаг хүмүүсийн холбоо нийлээд валютын ханшийн үүсмэл эрсдлээс хамгаалах үүсмэл хэрэгслүүдийн зах зээлийг бий болгоё, хамтарч бий болгоё, энийгээ дунд хугацаандаа, энэ жилийнхээ зорилтонд оруулъя, энэ дунд хугацааныхаа бодлогынхоо юмнуудад суулгаад, жил болгон хийгээд өгье гэдэг ийм зөв зорилт бол энэ 2014 оны бодлогод орж өгнө. Энийг Их хурал дээр ч дэмжүүлэх талаар ч манай энэ ажлын хэсгийн гишүүд дэмжих байх. Өөрөөр хэлбэл та нарын оруулж ирсэн энэ зүйл маань нэлээн их нарийвчлал болж өгнө. Тэгэхдээ орчин үеийн дэлхий дээр явагдаж байгаа хамгийн сүүлийн үеийн хандлагууд болон бодит амьдрал дээр монголын эдийн засаг, тухайлбал худалдааны нөхцөл гэж яриад байгаа тэр Монгол Улсын худалдааны нөхцөл маань 1940 оноос хойш дандаа муу байсан юм. 40 оноос хойш шүү дээ. Худалдааны нөхцөл гэдэгт юуг ойлгодог юм бэ гэхээр, импортын үнийн өсөлт нь экспортыг ашиггүй болгоод, дандаа хасах гарч байгаа шүү дээ. Та нар ойлгож байгаа бол, энэ нөхцөл чинь 60, 70 жил муу явж ирлээ. За энэ валютын ханшны хууль гарснаас хойш ч дандаа ийм явж ирсэн. Тийм учраас тэр бол гол аргумент бишээ. Бас нээлттэй жижиг тэгээд ДНБ-нд нь экспорт нь 2 дахин, 3 дахин, эсвэл 150 хувь болчихдог нь бас гол жишээ бишээ. Бид бол өнөөдөр валютын ханшинд хэрэглэдэг ямар үүсмэл хэрэгслүүдээс гадна, долларын хадгаламж, долларын зээл энэ хоёрын харьцаа /энэ захиргааны гэж хэлж болохоор/ 2009 онд нэлээн хэдэн орнуудад, танай судалгаанд гарсан шиг тийм бас өрөөсгөл дүгнэлт тухайн улс орнуудын эерэг юм өгсөн тийм арга хэрэгслүүд бас байна. Энийг хэрэглэхэд бэлэн байх ёстой. Энэ чиглэлээс нь суулгаж өгөх ёстой гэж би хувьдаа үзээд, ажлын хэсэг дээр бэлдчихсэн байгаа. Жишээлбэл, одоо би та нарт уншаад өгөхөд 5 өгүүлбэр бэлэн байж байна...

**Болдбаатар:** -Тэгэхдээ одоо хэмжээнээс тулчихаад байгаа шүү дээ. Тэрнээс цааш нь давах юм бол энэ чинь тогтворгүй байдалд ордог гэдэг нь аягүй тодорхой байгаа шүү дээ.

**С.Дэмбэрэл:** - Өнөөдөр, одоо жишээлбэл та нар тэр дэд хөтөлбөр дээр, бид нар маргааш 11 цагт нефтийн компаниудтай уулзах гэж байна л даа. Энэ хүмүүс чинь өөрснөө анализаа хийчихсэн байгаа.

**Болдбаатар:** - Миний хэлж байгаа бол үүнтэй хамаагүй, зөвхөн банкуудтай хийсэн хэлцэл өөрөө хэмжээндээ тулчихаад байгаа байхгүй юу.

**С.Дэмбэрэл:** -Тэр ерөөсөө чухал биш. Банкуудтай хийхээсээ гадна, банкуудын клиентүүд гэж байна. Энэ хүмүүс экспортлогч, импортлогч. Жишээлбэл, Монголын банкуудын холбоон дээр одоо яг миний саналтай ижилхэн санал байж байна. Валютын ханшныхаа зах зээлийн оролцогчдын



тоог нэмэгдүүлбэ, ингэснээрээ валютын зах зээл дээрх эрэлт нийлүүлэлтийг илүү тодорхой харж ажиглахад бидэнд тус болно. Жишээлбэл, ийм утгатай заалтууд байгаа. Иймэрхүү байдлууд зөвхөн валютын ханшаар гэхэд л бид нарын хувьд бас зөрүү байна. Түрүүн риск хуваалцах тухай ярилаа. Тэр үнэн шүү дээ. Иргэний хуулийн 218.1-д нь заачихсан байгаа. Хэлцэл хийсэн үнээр нь, анхных нь үнээр тооцноо гээд. Гэтэл өнөөдөр компаниуд хохироод явж байна. Иргэд хохирсон явдал бол бүр тоо томшгүй олон. Энийг бол ярихаа больё гэхэд, зөвхөн компаниудыг л хэлэхэд ийм байна. Сангийн яам нь өөрийнхөө рисковийг ав, Төвбанк нь арилжааны банктайгаа нийлээд зээлжигчтэйгээ нийлээд рискээ хуваалц. Ийм механизм яагаад байж болохгүй гэж? Энийг ядахдаа, яагаад судалж болохгүй гэж?

Дээр нь, зээлийн хүү гээд нэг юм бас байна. Танай оруулж ирсэн юм чинь ганцхан асуудал байна. Тэр нь барьцаа хөрөнгөний асуудал. Гэтэл одоо энэ монголын банкуудын холбоо, санхүүгийн зах зээлийн холбоо, даатгалын холбоо гээд энэ бүгд Д.Гарамгайбаатар даргын тушаалаар ажлын хэсэг байгуулагдаад, уг нь 5 сард оруулж ирэх ёстой байсан. Гэхдээ ерөнхийдөө ингээд асуудлаа шийдээд, дунд хугацаанд 3 жилийн дотор 2014, 2015, 2016 онуудад энэ зээлийн хүүг яаж бууруулах талаар зөвхөн тэр барьцаа хөрөнгө биш, бусад олон эрх зүйн болон бусад институцийн чанартай, эдийн засгийн хөшүүргийн чанартай ийм асуудлуудыг оруулахад бэлэн болчихоод байгаа юм. Энэ маань өөрөө мөнгөний бодлогын юманд бас тусч өгөх нь зүйтэй. Тэндээс гол санаанууд нь энэ юм гэх мэтээр мөнгөний бодлогын асуудлууд өөрчлөгдөх нь байна шүү. Та нарын хөдөлмөрийг үнэлж байгаа боловч, жил болгон ингээд нэг л зүйлийг ерөнхийдөө давтаад байна. Гэхдээ үр дүн маань илүү чухал. Өнөөдөр Монгол Улсын хувьд бол инфляци нэг оронтой тоонд байх нь хэрэгтэй юу гэвэл, үнэхээр хэрэгтэй. Валютын ханш хэлбэлзэхгүй, хохироодоггүй байх хэрэгтэй. Гэхдээ энийг зөвхөн, зах зээл ингэж шийдэж байна аа, одоо зүгээр, энэ экспортонд болон дунд хугацаандаа сайн гэдэг үгээр бичээд, ингээд яваад байж болохгүй ээ.

Тийм учраас, одоо энэ талаас нь бодож бид нар бүр энэ удаад, анх удаа энэ монголын банкуудын холбоо болон монголын санхүүгийн зах зээлийн холбоог албан ёсоор энэ ажлын хэсэгт оруулж байна. Яагаад гэвэл, та бид нарын бодол өөр өөр байна. Тийм учраас энэ олон бодлогууд дундаас зөв шийдвэр л Улсын Их Хурлын шийдвэр дээр тусч гарч ирэх ёстой. Энэ талаас бол бид нар анхаарах ёстой шүү. Ерөнхийдөө би бол хариултуудыг бүгдийг нь бараг цээжээр мэдэж байгаа учраас би дахиж асуулт асуухгүй. Бид болоогүй байна. Тийм учраас Д.Гарамгайбаатар даргад хүсэлт тавихад, маргаашийнхаа хуваариас хасаж өгөөч. Бид одоохондоо энэ мөнгөний бодлогыг УИХ-аар хэлэлцүүлж чадахгүй. Мэдээж, энэ асуудлуудыг оруулна. Энэ дээр миний харж байгаагаар 15-20 өгүүлбэр лав нэмэгдэх юм байна. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл гээд хэдийгээр байдаг боловч, саяны хэлбэлзлүүд дээр Монголбанк үүргээ биелүүлсэн, харин нөгөө хоёр оролцогч нь үүргээ биелүүлээгүй. Муу биелүүлсэн. Сангийн яам тэр тусмаа анхаарах хэрэгтэй. Энэ байдлаараа бол бид нар, Төвбанкны тухай хуулинд байгаа санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийг өргөжүүлэх, үйл ажиллагаагийг нь сайжруулах чиглэлээр мөнгөний бодлогод суулгаж өгөх хэрэгтэй. Үүнийг томьёолох хэрэгтэй, үүнд тодорхой цаг орно.



Тийм учраас ажлын хэсгийн гишүүд та бүхэн бидэнд арга зүйн болон мэргэжлийн туслалцаа үзүүлэх, мэргэжлийн туслалцаа, арга зүйн талаас чинь саналыг чинь сонслоо. Их Хурлын гишүүд та бүхний санал дээр үндэслээд өөрсдийнхөө саналыг нэмэрлээд 2014 оны мөнгөний бодлогыг энэ оруулж ирснээс чинь нэлээн өөрчлөх гэсэн байдлаар хийгдэх байх.

Энийг харин эцсийн дүндээ батлах эсэх нь Их Хурлын өөрийнх нь асуудал. Ямар ч гэсэн ажлын хэсгийн хувьд, манай Эдийн засгийн байнгын хороогоор бас хэлэлцэгдэнэ. Ийм байдлаар явна шүү. За иймэрхүү байна. Тэгээд өнөөдрийн хуралдаанд нөгөө Ардын Намын хурал болж байгаа учраас ажлын хэсгийн маань 2 гишүүн ирж чадсангүй. Жишээлбэл, өчигдөр Ө.Энхтүвшин даргын илтгэлийг Монголбанкныхан та бүгд сонссон байж магадгүй. Маш буруу дүгнэлт хийж байна билээ. Монголбанк бол Засгийн газрын мөнгөний нярав болсон гэсэн тиймэрхүү юмыг бол бас хэлж байна. Тэгээд эртээд Их Хурал дээр 2014 оны мөнгөний бодлогын талаар Ардын намын байр суурь, дүгнэлт гээд тийм юм өгсөн. Тэр нь одоо энэ хавтсанд байж байгаа. Танайд нэг хувь нь очсон байх. Тэгээд өнөөдөр Ардын намын бүлгийн ахлагч М.Энхболд утасдаад, манай 2 гишүүн ирж чадахгүй нь ээ. Наадах чинь одоо бас бид нар маш чухал ач холбогдол өгч байгаа шүү. Манай намын их хурал дээр мөнгөний бодлогыг маш нухацтай авч ярьж байгаа гэж хэлж байна лээ. Гэх мэтээр ингээд улс төр талаасаа ч гэсэн, эдийн засаг талаасаа ч гэсэн бид нар ийм чухал баримт бичгийг батлах гэж байна. Тийм учраас та бүхэн ялангуяа манай энэ гаднаас орж ажиллаж байгаа банкны холбоо, санхүүгийн зах зээлийн холбоо та бүхэн маш идэвхтэй оролцоорой. Нэмэлт саналуудаа өнөөдөр өгөөрэй. Жишээлбэл, би энэ Монголбанкны саналууд байна. Монголын банкуудын холбооны санал байна. Монголын банкуудын холбооны санал Төвбанкинд очсон биз дээ? Та нарын хувьд үүнийг эсэргүүцээд, зарчмын хувьд зөрөлдөөд байгаа юм байхгүй биз дээ? Хэрвээ байгаа гэвэл энийгээ эрт энд ажлын хэсэг дээр гаргаж хэлээрэй. Харилцан тал талаас нь ярилцъя. Тэгж байж бид нар шийдвэр боловсруулах ёстой шүү дээ. Жишээлбэл, Монголын банкуудын холбооны энэ томьёоллуудыг бага зэргийн өөрчлөлт оруулах эсэх талаар харилцан ярилцаад, энэ 2014 оны мөнгөний бодлогын чиглэлдээ суулгачих ёстой. Тэр дунд хугацааны бодлогоос авахуулаад, тэр IT-ийн асуудал байна. Тэр энэ уруу орох ёстой юу? Томьёолж орох юм уу, орохгүй юм уу гэдэг асуудал байна. Бид нар яарч, хугацаанд шахагдаж, түүхий юм гаргахыг бодохгүй байна. Аль болохоор нухацтай ярилцах хэрэгтэй. Жишээлбэл, Санхүүгийн хороо та нар яг ийм байдлаар зүгээр суухгүй шүү. Их тодорхой асуудал оруулж ирнэ шүү. Ажлын хэсгийн энэ удаагийн хуралдааныг үүгээр завсарлая. Баярлалаа.

## Хувийн өмч бол сайн засаглалын хэлбэр

*Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх цеэр:*

**УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл:**

- 3.6.3 дээр Эрдэс баялгийн салбарт ус хэрхэн хэрэглэх тухай байна. Усны бодлого дээр 3R гэж дэлхий нийтээрээ ярьж байгаа. Тэр 3-ыг энэ яамны нөхөд мэдэж байгаа гэж би бодож байна. Энэ “*эргэн хэрэглэх, эргүүлж цэвэрлэх, эргүүлж урсгах*” гэсэн энэ 3R зарчмыг хэрэгжүүлнэ гэдгийг л оруулах учиртай юм. Газрын гүний болон газрын гадаргын усны харьцаа манай улсад нэлээд өөрчлөгдчихсөн байгаа. Тийм учраас аль нэгийг нь хэрэглэхийг заахаасаа илүү “*газрын гүний болон гадаргуугийн усны зохистой харьцааг баримтлан, усны хэрэглээг...*” гэсэн зүйлийг оруулах хэрэгтэй байна. Анх оруулж ирсэн засгийн газрын хувилбар чинь л маш зөв байна. Тэрүүгээрээ л явах хэрэгтэй.

- Төслийн 3.6.5-ыг өөрчлөх тухайд 1 зүйл тодруулмаар байна. Одоогийн байдал бол нэг хэсэг компаниуд нөхөн сэргээлт хийгээгүй хаячихсан газрууд бий. Үүнийг гадаад дотоодын хөрөнгөөр засуулах гэж оролдож байгааг ойлгож байна. Гэтэл бид урт хугацааны баримт бичиг боловсруулж байгаа шүү. Тэгэхээр ингэж орвол нөхөн сэргээлт хийлгүй үлдээх боломжийг энэ баримт бичгээрээ олгочих гээд байгаа юм шиг болчихоод байна. Одоогийн юмыг засах санааг цаашид урт хугацаанд хэрэгжүүлэх зүйлдээ оруулчихаар таарахгүй шүү дээ. Жишээлбэл, энэ бодлогын баримт бичгийг 2025 онд хүн уншаад, нөхөн сэргээлт хийгдэлгүй орхигдсон хуучин газрыг засаад, өөрийнхийгөө нөхөн сэргээлтгүй орхиж болох юм байна гэсэн сэтгэдэл төрөхөөр харагдаад байна. /санал хурааж, найруулгын засвар хийгдэхээр болов./

- “Төрийн өмчийн оролцоотой уул уурхайн аж ахуйн нэгжийн удирдлага менежментийг сонгон шалгаруулж, сайн засаглалыг хэрэгжүүлэх” гэсэн асуудалд анхааралтай хандмаар байна. Төрийн оролцоотой гэдгийн цаана нь хувийн өмчийн оролцоо бас байгаа. Тэр хувийн компаниудын эрх ашиг үүгээр зөрчигдөөд байна. “Төрийн өмчийн компаниудад” гэж л оруулбал оруул. “Оролцоотой” компаниуд гэвэл 5%, 10%, 30%-ын оролцоотой байж болно. Үлдсэн дийлэнх хувийг гаргаж, эзэмшиж байгаа хувийн компаниудын удирдлагын зарчим нь өөр шүү дээ. Төлөөлөн удирдах зөвлөл, Хувьцаа эзэмшигчдийн хурал зэрэг өөрсдөө шийдвэрлэх зарчмаар ажилладаг, бас л сайн засаглалын нэг хэлбэртэй байгаа шүү дээ. Төр өөрийнхөө өмчийг л мэдэхээс, хувийн өмчийг мэдэх ёсгүй. “Төрийн өмчийн оролцоотой” л гэвэл цаана нь байгаа гадаад дотоодын хувийн өмч байна л гэсэн үг. /санал хурааж, дэмжигдэв/

- Төслийн 3.6.2 –д “Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн чадвар, хариуцлагыг эдийн засаг, санхүү, ашигт ажиллагааны түвшин, бүтээмж зэрэг голлох үзүүлэлтээр тогтмол хугацаанд дүгнэж, нийтэд мэдээлэх замаар тэдний хариуцлага, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ”

гэсэн байна. Энэ арай дэндлээ, та минь. Юу яриад байгаа юм бэ? Энэ огт хамаагүй заалт байна, хас! Бид өмнө нь төр бол лиценз, бүртгэл зэрэг ийм ийм юманд оролцоно, харин ийм ийм зүйлд оролцохгүй гэж тогтаж, баталчихаад, тэрнийгээ зөрчсөн баахан зүйлүүдийг хийлгэх гэж нэмж оруулж ирээд байж болохгүй. Төрийн өмчийн харааны хийдэг ажлыг бичээд, хийгээд байх хэрэггүй. Сайн засаглалд нэгэнт орчихсон зүйлийн нэмж дахин дахин бичих бас хэрэггүй. Хасах хэрэгтэй. /дэмжигдэж, үндсэн төслөөс ч бүрмөсөн хасагдав./

- 3.7.5 –д байгаа зүйл бол Засгийн газрын мөрийн хөтөлбөрт байгаа “Уул уурхайн салбараас орж ирсэн орлогоор уул уурхайн бус экспортыг дэмжих” гэсэн утгатай заалт тэр утгаараа орж ирсэн байна. Тиймээс үүнийг дэмжих нь зөв. Энэ бол баялгын сангийн тухай асуудал биш. Үүнийг ажлын хэсгийн оруулж ирснээр батлаж санал хураалт явуулъя. /дэмжигдэв./

- 3.6.5-ыг бүрмөсөн хасах санал оруулж байна. /дэмжигдэв./

### **Хэт төрсөг хандлагаас бушуухан зугатаамаар байна**

**2013 оны 12 дугаар сарын 16-нд “Валютын ханшийг тогтворжуулах, эдийн засгийн идэвхжлийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Байнгын хорооны тогтоолын төсөл боловсруулах” үүрэг бүхий Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлээс:**

С.Дэмбэрэл: - Байнгын хорооны тогтоол гарахдаа ерөнхийдөө эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх гэсэн утгаар л гарчиг нь өгөгдсөн. Эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлнэ гэж гараагүй. Өсөлтийг эрчимжүүлнэ гэсэн ойлголт ч байхаа больсоор 20 жил болж байна. Тэгэхээр, нэгдүгээрт байгаа нэрээрээ л хэлэлцээд явъя. Нэрэндээ, эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх, гадаад валютын ханшны удирдлагын талаар авах арга хэмжээний талаар л тогтоолын эх бэлд гэсэн. Ханшыг бид удирдах талаар л явж байгаа. Ханшны хэт өсөлт, ханш бууруулах, ханшын удирдлагыг сайжруулах талаар ч гэдэг юм уу ийм зүйлээр бид ажиллаагүй.

*Хоёрдугаарт*, Зоригогын хэлсэн 5 саналыг ерөнхийд нь би дэмжиж байна. Гэхдээ яаж томъёолж оруулах вэ гэдэг асуудал байна. Үүнийгээ их зөв томъёолж оруулах хэрэгтэй.

*Гуравдугаарт*, энэ дотор дунд хугацааны зорилтууд орж байна. Энэ дунд хугацааны 32 зорилтуудыг бүгдийг хасъя. Тэр дундаасаа авч, шууд урагүлуулж, богино хугацааны зорилтондоо оруулж болох, ойрын хугацаанд хэрэгжүүлэхүйц тийм юмнуудыг нь л авч үлдэе. Тийм үйлдвэр байгуулна, тэгнэ ингэнэ гэсэн зүйлсийг л үлдээх хэрэгтэй. Энэ чинь засгийн газрын мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлд орсон, зарим нь бүр 2014 оны мөнгөний бодлогод орчихсон тийм зүйлс. Тийм учраас нэг нэгээр нь хөөж уншаад л, хасах хасахгүй гээдгийг шийдээд явмаар байна.

*Дөрөвдүгээрт*, энэ дээр экспортыг нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэр, жижиг дунд бизнесийг дэмжих тэр чиглэлийн зүйлүүд ерөнхийдөө зөвхөн уул уурхайн экспорт дээр орчихсон байна. Экспортын санхүүжилтын заалтан дээр ганцхан тоног төхөөрөмжийн заалт л орсон байна. Гэтэл Эдийн засгийн хөгжлийн яамнаас экспортын хөтөлбөр батлагдчихсан байгаа. Энэ дундаасаа онцгойлж авч үзэх зүйл буюу ойрын хугацаанд хэрэгжүүлэх асуудал нь бол уул уурхайн бус экспортын идэвхжлийг яаж сайжруулах вэ, ялангуяа санхүүжилтийн асуудлуудыг яаж шийдэх гэдэг асуудал юм. 2014 оны мөнгөний бодлогод бичил, жижиг, дунд бизнесийн санхүүжилтийн дэмжиж ажиллана гээд биччихсэн байгаа. Тэгэхээр, энэ 2-ыг уялдуулаад, экспорт ба жижиг, дунд бизнесийн идэвхжлийг ойрын хугацаанд нэмэгдүүлэх талаар Төв банк, Хөгжлийн банк, Эдийн засгийн хөгжлийн яам, Хүнс хөдөө аж ахуйн яам, тэгээд хувийн хэвшлийн төлөөлөл гэсэн энэ байгууллагуудын нэрийг энэ дотроо дурьдаж, оруулж өгмөөр байна.

*Дараа нь*, машин зэрэг тодорхой зарим юмны импортыг багасгаж, валютын гадагш гарах урсгалыг багасгах талаар тодорхой заалтууд орсон байна. Капиталын хяналтыг хэлээгүй л дээ. Ерөнхийдөө эрэлтийг багасгах чиглэлээр л зүйлүүд орсон. Хэрэв машин тэргийг оруулахаар бол бодох зүйлүүд бас бий. Улаанбаатарт явж байгаа 160 мянган автомашины 50% нь амь амьжиргаагаа авч яваа, хувиараа ажиллаж амьдралаа залгуулдаг хүмүүсийн машин байгаа. Энэ бол Улаанбаатарыг асар их бохирдуулна гэхээсээ гадна, ерөнхийдөө эдгээр машины насжилт нь өндөр машинууд л байгаа. Энэ тохиолдолд ийм машин оруулж ирэх эрэлт яаж зогсох юм бэ гээд, тэр талаас нь тодорхой заалт оруулж өгөхгүй бол бас нэг эвгүй юм руу оруулчихаж магадгүй тийм заалт бас байна. Энийг анхаармаар байна.

Түрүүн ярьсан, одоо гадуур татварын төлөвлөгөө биелүүлэх гэж довтолгоо хийгдэж байна. Өнөөдрийн сонин дээр харахад, 13.5 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлээ гээл бичсэн байгаа. 10 сая долларын төлөө эдийн засгийг улам бүр нуугдмал байдалд оруулж байна. Үүнийг ерөөсөө зогсоох ёстой. Өөрөөр хэлбэл, бид эдийн засгийн идэвхжлийг хангах гэж байгаа юм бол эдийн засгийн идэвхжлийг нурааж байгаа энэ төр засгийн үйлдлийг, зөвхөн төлөвлөгөөг оны өмнө аятайхан биелүүлчих гэж зүтгэдэг, биелүүлэхгүй юмаа гэхэд нилээд өндөр гаргахын төлөө гаргаж байгаа ямар ч уялдаагүй энэ бодлогын эсрэг ямар нэгэн зүйл тавьж өгөх хэрэгтэй. 2005 оноос хойш ийм их мөнгө нуугаагүй л байх. Энэ чинь татвар дээр нь нэмээд татварын торгууль, алданга гэж тооцоод ирэхээр нугараад, энэ чинь үндсэн өрнөөсөө ихэсчихсэн байгаа хэрэг шүү дээ. Үүнийг бол татварын ерөнхий газрыхан хүлээн зөвшөөрөхгүй, бид хуулийн дагуу явж байна гэж тайлбарлаж байна. Хуулийн дагуу явж байгаа юм бол, яагаад хэдэн жил хуулиа биелүүлээгүй байж энэ жил биелүүлэх гээд зүтгээд байгаа юм бэ? Энэ дээр бид их онцгой анхаарч, энэ түрэмгийлэлийг зогсоохгүй бол их эвгүй юм болох шинжтэй байна. Өөрөөр хэлбэл, энэ эдийн засгийн идэвхжилийг нураах, хамгийн гол нь эгэл жирийн иргэд, өөрийнхөө болон гэр бүлийнхээ амьдралыг болгох гээд зүтгэж яваа тэр мянга мянган хүмүүсийн бизнесийг нураах ийм нэг аюул нүүрлээд байна. Тийм учраас энэ хэт төрсөг хандлагаас бушуухан зугатаамаар байна.

Энд бас нэг баахан юмнууд байна. “Экспортыг дэмжих замаар гадаад валютын орох...” гэхчилэн олон зүйл байна. Энэ хэсгийн гарчгыг нь л үлдээе. Гэхдээ эндээс яг авах юмнуудаа л оруулъя. Давтагдсан юмнууд зөндөө их байна. Эрдэс баялагын салбарт баримтлах тэр бодлого зэргээс ганц нэг санаануудыг шууд авч, мөн тэр яаралтай хийх хэрэгтэй байгаа санаануудыг тусгаж болно. Дээр нь нэмэх саналуудын хувьд гэвэл надад 5-6 санал байна. Тэднийгээ би уншчихъя.

1. *Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, бичил бизнесийн сан зэрэг тусгай сангууд Төв банкны зүгээс санхүүжилт хийх тогтолцоог бүрдүүлэх, Засгийн газар, санхүүгийн зохицуулах хороотой хамтарч ажиллах.* Энэ бол Төв банкны тухай 2014 оны зорилтонд нь орчихсон байгаа зүйл. Гэхдээ тэрнийг нилээн дэлгэрэнгүй болгож байгаа заалт байгаа юм.

2. *“Засгийн газрын өр, өрийн багц валютын нөөц 2-ыг хооронд нь уялдуулж валютын ханшны эрсдлээс хамгаалах механизм бий болгох талаар”* гээд. Энэ дээр бас валютын ханшны эрсдэл зэрэг SWOT-той зүйл орсон байна. Танайхтай тохирсон юмуу, Н.Золжаргалаа? Энэ талын юмнуудыг бас оруулаад өгчмөөр байна.

3. Яг одоогийн байдлаар ингээд валютын ханш доошоо бууж байгаа байдлыг харахад цөм цөм явагдаж байна. Энэ бол эрүүл бус бууралт. Хэрэв эрүүл байдлаар буурвал яг зах зээлийнхээ жамаар явах ёстой. Гэтэл цөм цөм буураад, яг цөм цөм өсөж байсан үеийнхээ сколектив байдал руу ороод байна. Энэ тохиолдолд, 2014 оны мөнгөний бодлогод ерөнхий өгүүлбэрээр заагдсан зүйлийг бид одоо тодорхой оруулаад бэлэн болгочих юм бол жаахан захиргааны арга хэрэглэх, өөрөөр хэлбэл төгрөг долларын зээл, хадгаламжийн хоорондох зохистой харьцааг төгрөг рүү нь ашигтай байх ийм зүйлийг зөвлөмжийн юм шиг мөртлөө, хуулийн дотор Төв банкны зүгээс хийхээр, бас дээр нь Санхүүгийн зохицуулах зөвлөл, Тогтвортой байдлын зөвлөл ажиллахаар зохицуулах хэрэгтэй байна. Сая энэ асуудлыг оруулж ирэхдээ Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл дээр энэ тухай ярьсан юм байна. Гэхдээ нэгдсэн байр сууриа яг тодорхойлж орж ирээгүй учраас зарим юман дээр бол өөр өөр бодолтой байх жишээтэй байна. Жишээлбэл, хадгаламжийн хуулийг дахин сэргээх санал орсон бол Төв банкны зүгээс хэрэггүй гэж үзсэн байна. Би бол үүнийг хэрэггүй гэж үзэж байгаа. Харин нөгөө хадгаламжийн даатгалын төсөлд даалгавар өгөгдөх ёстой. Арилжааны банкуудад хүндрэл учруулахгүйгээр төлбөрийг нь авах асуудлууд байгаа шүү дээ. Өөрөөр хэлбэл, эхний улиралд тэд, 2-р улиралд тэднийгээ өгчих гэсэн ийм байдлаар заалтууд оруулж өгч болно.

4. Дээр нь үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг ханган ханшийн эрсдлээс хамгаалсан хэлэлцээр байна. Энэ дээр би юм асуумаар байна. 20 тэрбумаар мөнгийг нь нэмэгдүүлье гээд заачихсан. Доллар юаний ханшид нөлөөлж л байгаа бол Бээжин дэх ханш, Монголын ханш 2-ыг зохицуулах гэж мөнгө нэмээд ч утгагүй л болчихно. Тэгэхээр эхний ээлжинд арилжааны банкуудаар дамжуулаад ямар компаниудад яг энэ своп хэлэлцээрт тохирсон ханшаар өгөх юм бэ гэдэг нь их чухал. Өөрөөр хэлбэл, яг тэнд нь жоохон уясан, зохицуулсан ханш байх, оруулах эсэх асуудлыг би өнөөдөр Төв банкттай ярилцаж үзсэн. Тэгж чадвал хэрэгтэй. Түүнээс, мөнгөний дүн бол ОК. Авч болох байх. Авч болно ч гэж байгаа.

Гэхдээ энийг цаашдаа бариад, бодит компаний валютын гүйлгээ, валютын хэрэгцээн дээр нөлөөлөхгүй гэх өөрөөр хэлбэл риск нь бага байхаар зохицуулмаар байна. Тийм учраас, тэрнийг тогтвортой байлгахаар, уясан ханшийг оруулах талаар нэг ийм санал байна.

5. Хөгжлийн банкны асуудлаар энд орсон байна л даа. Гэхдээ сүүлийн үед Хөгжлийн банкыг системийнх нь нэг хэсэг болгох эсэх дээр бид бас нэлээд ярилцаад байгаа. Жишээлбэл, Эдийн засгийн байнгын хорооны протоколоор, үүнийг хэлэлцэнэ гээд заагдчихсан байгаа. Одоогоор Хөгжлийн банк валютыг худалдаж аваад байгаа. Тэгэхээр одоо яг ийм байдлаар цаашаа яваад байх уу, энэ банк системийнхээ гадуур ажиллаад байх уу гэдэг асуудал байна. Өөрөөр хэлбэл банкны системийнхээ интеграл хэсэг нь болохгүй яваад байх юм уу, боллоо гэхэд ямар нөхцөлтэйгээр сисдемдээ орох вэ гэдэг асуудал байна. Өөрөөр хэлбэл, Хөгжлийн банк чинь бусдаасаа шал өөр банк шүү дээ. Шаардагдах шаардлагууд нь ч өөр байгаа. Тэгэхээр энэ талын заалтыг бас оруулж өгөх хэрэгтэй гэсэн иймэрхүү нэг хэдэн саналууд байна.

### **Хувьчлал явуулах хэрэгцээ бас маш их байна**

*12 дугаар сарын 16-нд “Валютын ханшийг тогтворжуулах, эдийн засгийн идэвхжлийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Байнгын хорооны тогтоолын төсөл боловсруулах” үүрэг бүхий Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлээс:*

С.Дэмбэрэл: - Банкны секторын либеральчлалын хувьд:

1. Гадаадын банкнуудыг оруулж ирэх асуудалд юуны түрүүнд хязгаарлагдмал хүрээнд гэдгийг нь тавьж өгөх ёстой болно.

2. Сая О.Чулуунбаатарын хэлсэн 3 саналын нэгийг нь л авах хэрэгтэй. Олон болзол тавих хэрэггүй. Хамгийн гол ганц болзоллоо л тавих нь зөв.

3. Хөрөнгө оруулалтын чиглэлтэй байх ёстой гэдгийг нь оруулах хэрэгтэй. Монгол банкнуудтай холбогдох асуудлыг нь тавих хэрэгтэй. DBRD яаж явагддаг билээ? DBRD-ын талаар төв банкны саналыг бид бас сонсох ёстой.

4. Гадаадад байгаа монгол иргэдийн хөрөнгө оруулалтын талаар бас нэлээд яригдаж байна. Төв банкин дээр гадаадад байгаа монгол иргэд, аж ахуйн нэгжүүдийн данс нээгдэх ёстой. Энэ маань өөрөө өршөөл шаарддаг. Жишээлбэл, татвараас зугтаалгаж, олон жил хуралдчихсан мөнгө байж магадгүй юм. энэ бүхнийг иргэд, аж ахуйн нэгжүүдээс гаргуулъя гэж төр үнэхээр хүсэх юм бол нэлээд мөнгө хөрөнгө орж ирнэ. Гэхдээ үүнийг арилжааны банкууд дээр биш, төв банкин дээр данс нээх замаар баталгааг нь хангах хэрэгтэй. Төрийн зүгээс энэ мөнгөний гарал үүслийг асуухгүй, зөвхөн терроризмыг санхүүжүүлэх хэлбэрээс бусад асуудлыг хөндөхгүй гэх зэргээр нөхцөл бүрдүүлэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, хязгаарлагдмал хүрээнд, жаахан оффшор операци л явуулна гэсэн үг юм даа.



5. Казиногийн хувьд бол ойлгомжтой.
6. Гадаадад байгаа монголын бизнесийг дотогшоо оруулж ирэхэд оншор /Onshore/, монголын бизнес гадагшаа гараад явчихвал оффшор /offshore/ гэж байгаа. Тиймээс “оншор” гэдэг нэр томъёогоор нь, оншир үйл ажиллагаа болон оншор бизнесийг дэмжинэ гэж оруулж өгөх хэрэгтэй. Нэгэнт оффшор гэдэг нэр томъёог олонтоо сонсоод мэдчихсэн хүмүүс энэ үгийг анхаармагцаа л эсрэг утгатай үг болохыг нь шууд ойлгоно.
7. Банк ба банк бус байгууллагуудын хооронд яг өнөөдрийн байдлаар эдийн засгийн харилцаа нь 96:4 байна. Тэгээд банк бус санхүүгийн байгууллагад нь өнөөдөр ямар ч мөнгө алга. Цөөхөн хэдэн зохицуулалт хийх эрх л байна. Тиймхэн эрх мэдэлтэй хүмүүс чинь өөрийн эрхгүй зохицуулалтаа л бодоод байдаг юм байна. Томруулах аргаа л хайдаг юм байна. Тиймээс төв банкны зүгээс дэмжих зохицуулалтаа хиймээр юм байна. Жишээлбэл, зарим банкны салбар байхгүй газруудад жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, зээл олгох ажлыг банк бус санхүүгийн байгууллагад гэрээгээр олгож санхүүжилт хийгээд, төв банк, банк, банк бус байгууллагын хамтарсан үйл ажиллагааг хөгжүүлбэл энэ нь төр болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны их сайхан үлгэр дууриалал, жишиг мэдээлэл болно. тиймээс энэ талаас нь бодолцож нэг зүйл оруулах хэрэгтэй байна. Яг үнэндээ энд банк бус санхүүгийн байгууллага буюу Баярсайханы Санхүүгийн хорооны тухай нэг ч зүйл алга. Ганцхан зүйл нь “Монгол улсын нутаг дэвсгэр дээр төгрөгөөр гүйлгээ хийхэд хяналт тавина.” гэсэн ганц бүдэг заалт л байна. Энэ бол улиг болсон заалт. Банк бус санхүүгийн байгууллагыг дэмжих, зохицуулах талаар эдний хорооны ямар ч санал орж ирээгүй байна...
8. Саяхан Мөнгөний бодлогын хороон доор ярилцаж байх үед З.Энхболд дарга “төр үүнд ямар хамаатай юм бэ, хамаагүй шүү дээ.” гэсэн. Гэтэл энэ хамаатай. Тендэр зарлаад, компаниуд тухайн үеийн валютын ханшаар зээл аваад үйл ажиллагаа явуулж эхлэхдээ валютын ханш ийм түвшинд хүрчихнэ гэж мэдээгүй л авсан шүү дээ. Экспортын зээл байсан бол үүнийг тухайн компанийн эрсдэл гэж үзэхсэн. Тийм учраас эрсдэлийг хуваалцах механизмыг тодорхой хэмжээгээр бий болгоё гэсэн ерөнхий өгүүлбэрээр Төв банкны 2014 оны мөнгөний бодлогод оруулчихсан байгаа. Яг үнэндээ энэ эрсдэл хуваалцах зарчим чинь шударга зүйл байгаа юм. “Миний буруугаас болоогүй эрсдэлийг надад тулгаж үүрүүлээд, намайг хохироогоод байна”. Тиймээс энд орсон заалтыг сайн тодруулж өгөх хэрэгтэй. Арилжааны банкнуудаас асуусан ч, Н.Золжаргал ерөнхийлөгч ч үүнийг сайн хэлэх байх. Валютыг төгрөг рүү шилжүүлж л байна л даа. Гэхдээ шилжүүлдэг гол мотиваци нь алга байна. Арилжааны банкнууд алдагдалд орохыг хүсэхгүй л дээ. Компаниуд ч алдагдалд орохыг бодохгүй. Энэ тохиолдолд гуравдах тал буюу төр, засгийн газар, төв банкны зүгээс энэ процессийг төгрөг рүү шилжүүлэх явдлыг өдөөх тийм зүйл заалтыг л оруулах хэрэгтэй байна.
9. “Татварын төлөвлөгөө биелүүлнэ” гэдэг нэрээр том жижиггүй бүгдэн рүү нь дайрч байгааг зогсоомоор байна. Жишээлбэл, татварын шалгалтаар зөвхөн 2013 оныг шалгана. Түүнээс өмнөх онуудынхыг шалгахгүй гэж зарлах хэрэгтэй. Эс тэгвэл 2005 оноос хойших бүх тооцоог ухаж байна. Яагаад гэвэл, татварын байцаагч нарт “заавал нэг юм олж ир” гэсэн үүрэг

өгөөд гаргачихсан хэрэг. Ийм үүрэг өгөхийн тулд Татварын хуулиндаа татварын байгууллага, байцаагчийн эрхийг хамаагүй илүү өндрөөр тусгаад өгчихсөн учраас татварын маргаан таслах зөвлөл дээр очиж заргалдаад ямар ч нэмэргүй болгочихож байгаа юм. Тиймээс манай Ажлын хэсгээс үүн дээр анхаарч, татварын энэ довтолгоог зогсоомоор байна гэсэн тодорхой саналтай байна.

10. О.Чулуунбатын тэр гадаадын зээл ДНБ-ний 40% биш 20% байгаа гэж бас яриад байна. Гэтэл 40% болчихоод гацаанд орчихсон байгаа нь үнэн. Техникийн туслалцаа зэрэг олон зүйлийг нэг тогоонд хийгээд чихчихээр 40% болж харагдаад байгаа юм. Гэтэл уг нь, Мянганы хөгжлийн зорилтон дээрээ манай улсын гадаадаас тусламж дэмжлэг авах асуудал нь зээлээсээ тусдаа заалттай байдаг. Тиймээс тэр гадаад өр зээлийн хэмжээнээс тусламжуудыг хасах юм бол гадад өр маань ДНБ-ий 20% биш юм гэхэд, 30% болж буурч харагдана. Тэгэх юм бол одоо бэлэн болоод байгаа “Өрийн удирдлагын хууль”-тайгаа хамт 40, 50, 60% болгох асуудал нь чөлөөтэй болж ирнэ. Тиймээс бид энэ асуудлаар ганцхан заалт хийх хэрэгтэй. “Өрийн хэмжээг тооцохдоо, техникийн туслалцаа болон хөнгөлөлттэй зээлийг арилжааны нөхцөлтэй зээлээс салгаж тооцно” гэж оруулах хэрэгтэй. Ийм л заалт оруулъя.

11. Хувьчлал явуулах хэрэгцээ бас маш их байна. Үнэндээ, хувьчлалын процесс зогсчихсон. Энэ янз бүрийн шалтгаантай байж болно. Гэхдээ бид нэг л заалт оруулж өгөх хэрэгтэй. Тэр нь: “ойрын хугацаанд, 2014 оны 1-р улиралд багтаан өмч хувьчлалын өргөн хэмжээний хөтөлбөрийг боловсруулж УИХ-аар батлуул” гэсэн заалт баймаар байна.

## **Уул уурхайн экспортыг нэмэгдүүлэх бүх аргыг хэрэглэх шаардлагатай**

*УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлтэй улс төр дэх цаг үеийн асуудлаар ярилцсан хэвлэлийн мэдээлэл:*

- Засгийн газраас тусгай зөвшөөрлийн реформыг явуулж байна. Одоо нийт хичнээн тусгай зөвшөөрөл байгаагаас хэдийг нь хүчингүй болгох байгаа юм бэ?

С.Дэмбэрэл: - Монгол Улсад хүнд суртал газар авч бизнесийн орчинд дарамт их ирдэг. Ерөнхийдөө тусгай зөвшөөрөл, лицензийн тоо нь 1000 хүрчихсэн. Үүн дээр бүтэн жилийн турш ажлын дэд хэсэг ажилласан юм. Бүх яамдуудаас “Манайд тэдэн ширхэг зөвшөөрөл байна. Тэдийг нь багасгая. Үүнийгээ авч үлдье” гэх байдлаар хамтран ажиллаж байгаа. Шийдвэрлэхэд хүндрэлтэйг нь дээд түвшинд буюу УИХ-ын гишүүдээс бүрдсэн хэсэг рүү оруулж хэлэлцэнэ. Яамдын авч үлдэе гэсэн зөвшөөрлүүдийг гурван үндэслэлээр дахин шалгаж байна. Нэгд, энэ тусгай зөвшөөрлийг гаргах хууль зүйн үндэслэл нь юу болох, хоёрт, энэхүү зөвшөөрөл нь байхгүй болсон тохиолдолд хэрхэх вэ гэдэг талаас нь, эдгээрээс гадна уг зөвшөөрлийг үгүй болгосноор бизнест ямар нөлөөтэй юм гэдгийг нь судлана гэсэн үг. Яамд

энэ гурван үндэслэлээр авч үлдээх итгэл үнэмшил төрүүлэх, хамгаалж чадах эсэхээс хамааран, мөн бизнесийн төлөөллийнхөн уг асуудалд хэрхэн хандаж байгаа зэргээс бидний зөвлөмж гарна.

Энэ бүхний үр дүнд бизнест садаа болдог, бизнес эрхлэх цаг хугацаанаас нь хумсалдаг, авлига руу түлхдэг зүйлс мэдэгдэхүйц хэмжээгээр буурах болно. Зам тээврийн яамныхан л гэхэд жаран хэдэн зөвшөөрлөө авч үлдэе гэж байна. Үүнийг нь бид судалж байгаа. Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны хувьд цөөхөн хэдий ч хэрэггүй зөвшөөрөл бас байна гэж яригдлаа. Бас тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг заавал яаман дээрээ байлгах биш тухайн чиглэлээр мэргэшсэн төрийн бус байгууллагууд руу гэрээний үндсэн дээр шилжүүлэх тухай яригдаж байна.

**- Яг зөвшөөрлийн тооны хувьд хэд юм бэ. Ерөнхийлөгч энэ тоог өмнө хэлэхдээ мянга хэдэн зуу гээд, ажлын хэсэг дээр 900 гаруй гэсэн. Гэтэл өмнө нь зөвшөөрлийн тоо 200 гаруй байдаг тухай ч ярьдаг байлаа?**

С.Дэмбэрэл: - Зөвшөөрөл гэдэг ойлголт өөрөө их өргөн хүрээтэй. Ажлын хэсгийнхэн хуульд байгааг нь тоолсноор 900 хүрсэн. Нэг хэсэг зөвшөөрлийн тоо 1200 давсныг нь хүчингүй болгосоор энэ тоонд авчирсан юм. Одоо бол энэ 900 дээр ажиллаж, талыг нь хүчингүй болгоё гэж байна. Мөн хуульд байхгүй, хуулиас гадуур зөвшөөрлийн үйл ажиллагааг журамласан тохиолдлууд сайдын тушаал, даргын тушаалаар бий болсон гээд олон байна. Зөвшөөрлийн механизм бий болгох шаардлагаа тодорхойлоогүй, үндэслэл гаргахдаа ганц талын саналыг авсан, ингэхгүй л бол болохгүй нь гэж өөртөө ачаалал авсан, бусдад дарамт болсон зүйлийг оруулж ирсэн учраас тусгай зөвшөөрлийн тоо хэлбэлзэж байгаа юм. Түүнчлэн нэг хууль гараас гарахдаа нэг агентлаг, нэг байгууллага, нэг хэсэг зөвшөөрлийг бий болгож байдаг нь ч нөлөөлсөн байх. Тусгай зөвшөөрлүүд яг ингэж хортой ургамал шиг нэмэгдсээр л байгаа юм. Иймд бидний зорилго одоо байгаагаа цэгцлэх, дахин үүсэхээс нь сэргийлэх л зорилготой байна.

**- Дахин үүсэхээс яаж сэргийлнэ гэсэн үг вэ?**

С.Дэмбэрэл: - Хуульд төр оролцох оролцоог хязгаарлаж өгнө гэсэн үг.

**- Дэлгэрэнгүй тайлбарлахгүй юу?**

С.Дэмбэрэл: -Тусгай зөвшөөрлийг багасгана. Таныг бизнес хийх гэж байхад чинь тусгай зөвшөөрөл өгнө гээд, олон баримт бичиг шаардана гэдэг чинь төрийн оролцоо биз дээ. Бие даасан хууль нь байгаа. Тэр хуульд өөрчлөлт оруулна. Мөн дээрээс нь Ерөнхийлөгчийн институцийн зүгээс санаачилсан Төрийн аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах тухай хуулиар зохицуулна. Төр нь адилхан хүрз бариад нүүрс ухаад байх биш, бодлогынхоо зөвлөлд анхаарлаа хандуулаад өөрсдөө бизнес хийхгүй болно. Төр аливаа салбарт бодлогоо гаргаад хувийн байгууллагуудын өрсөлдөх орчинг бий болгохын оронд төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулаад хувийн хэвшлийнхнээс давуу талтай оролцдогоос зайлсхийдэг байдлыг өөрчлөх болно.

**- Хэлэлцүүлгийг ажиглахад, зөвшөөрлөө цуцлуулах гэж байгаа байгууллагуудын байр суурийг харахад, асуудалд хандах хандлага нь дургүйцсэн, эсэргүүцсэн байдалтай байна. Эсэргүүцэл хэр байна?**

С.Дэмбэрэл: - Үнэхээр хандлага дургүй байгаа биз. Манайхны сэтгэлгээ нь ийм болчихсон. Чамайг өөрөөсөө хамааралтай болгох, амыг чинь, хөл гарыг чинь цаасаар скочдох сонирхол нь инстинк байдлаар төрдөг байх.

Төрийн бяр чадал нь хуурамчаар амтагдагдаж, тэр амталсан амтаараа ямар нэг зүйл сэдэж, тэрийг нь сайд дарга нар нь тушаал, тогтоол болгон гаргаж өгдөг систем манайд амь бөхтэй байна.

**- Жишээ нь ямар ямар гэж?**

**С.Дэмбэрэл:** - Хасах гээд байгаа зөвшөөрөл дотор дүүрэн л байна. Замын хөдөлгөөний дүрэм бол хэрэгтэй. Зам дээр жийп болон эксел машин ижил эрхтэй. Зам дээрх зохицуулагч буюу төр нь шүгэлдэх, торгох эрхтэй. Гэхдээ илүү зүйл хийж болохгүй. Хүнээс мөнгө авч болохгүй. Нөгөөдүүл нь техникийн бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй. Гэтэл өнөөдөр техникийн бүрэн бүтэн байдлыг хангах үүргийг нь төр хангах гээд байгааг л хэлээд байгаа юм. Төр өрсөлдөөнийг бий болгох үүрэгтэй болохоос оролцох шаардлагагүй. Өнөөдөр яригдаж буй зөвшөөрлүүдийн 50 хувь нь хэрэггүй, шууд бизнес рүү гар дүрсэн нь их байна. Яагаад төр маань А, Б нарт бөөний худалдаа, эсвэл жижиглэнгийн худалдаа эрхлэхийг заагаад байгаа юм бэ. Хувь хүн өөрийнхөө бизнес төлөвлөгөө, зах зээлээ хараад би энд бөөний худалдаа эрхлэх үү, эсвэл жижиглэнгийн худалдаа эрхлэх үү гэдгээ шийдэх сонголт байх ёстой биз дээ.

**- Ам.долларын ханшийн өсөлтөөс үүдэлтэй эдийн засаг маань хэцүүдэж байгаа шалтгааны талаар асуухгүй өнгөрч болохгүй нь?**

**С.Дэмбэрэл:** - Ам.долларын ханшийн өсөлт өнгөрөгч оны долдугаар сараас эхэлсэн асуудал. Валютын зохицуулалтын тухай хууль гэж бий. Тэр хуульд тодорхой зохицуулалтыг зөвшөөрсөн байдаг. Тодруулбал, валютын ханшийг удирдах тухай заалт бий. Уг нь удирдана гэхээр ганцхан интервенц хийхийг хэлдэггүй л байхгүй юу. 2013 оныг хүртэл валютын ханшны дэглэмийн тухай зохицуулалт байгаагүй. Ганц өгүүлбэр байсан нь “валютын ханш чөлөөтэй, уян хатан тогтоно” гэсэн байсан. Жил бүрийн мөнгөний бодлого дээр дээрх өгүүлбэр нь орж ирээд, хэн ч үүнийг сонирхдоггүйгээр баталдаг байсан. Валютын ханш суларсан, чангарсан гэх асуулт гардаг байсан ч хамгаалах, удирдах механизм нь байхгүй байсан. Харин 2013 оны мөнгөний бодлогод энэ механизмийг нь анх удаа суулгасан бөгөөд “Валютын ханшны эрсдлээс хамгаалах механизмийг улсын хэмжээнд бий болгоно” гэсэн заалтыг оруулж өгсөн юм. Гэвч үүнийг хэрэгжүүлж өгөхгүй байна. Валютын ханшны эрсдэлээс компани, иргэд хохирохгүй байх, бид эрсдэлээ тооцож сурах энэ механизмыг суулгаж өгөх ёстой.

**- Заалтыг хэн хэрэгжүүлэхгүй байгаа юм бэ?**

**С.Дэмбэрэл:** - Төв банк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо. Энэ гурав чинь хамтдаа Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийг бүрдүүлдэг юм. Энэ гурав Монгол Улсын санхүүгийн байдал тогтвортой байхыг, түүний нэгэн хэсэг болох валютын зах зээлийг тогтвортой байна уу, үгүй юу гэдэг дээр байнга дүгнэлт хийж зөвлөлдөж, арга хэмжээ авч байх ёстой. Валютын ханш чангарахад ч сулрахад ч сөрөг, эерэг үр дагавартай. Экспортод сайнаар нөлөөлдөг, импортод сөргөөр нөлөөлдөг гэдэг нь үнэн л дээ. Монгол Улс анх удаа гадаад худалдааны баланс хангагдлаа гэж ярьж байна. Гэтэл энэ баланс бол эцсийн зорилго биш. Валютын ханш нь эцсийн дүндээ инфляцийн түвшинд нөлөөлөхгүй хэмжээнд, эсвэл маш бага нөлөөлөх хэмжээнд удирдлагыг хангах ёстой. Төсвийн орлогын хувьд валютын өсөлт нь ашигтай. Гэхдээ ард түмний орлогод ашиггүй. Аль нь

чухал юм бэ. Инфляци нь чухал уу, төсвийн орлого нэмэгдэх нь чухал уу. Хэдийгээр 2013 онд анх удаа валютын ханшийн бодлогыг өөрчилсөн ч үйлдэл байхгүйгээр, эс үйлдэл давамгайлуулаад сууж байна. Интервенц хийхээс гадна валютын ханшийн эрсдлээс урьдчилан сэргийлэх бодлого явуулах учиртай. Хууль зүйн хувьд ийнхүү боломжийг нь бий болгочихоод байхад юу ч хийсэнгүй.

**- Одоо яах ёстой вэ?**

**С.Дэмбэрэл:** - Ам.доллар 1790 төгрөгт хүрлээ гээд байна. Бусад орнууд зарим үед бүр болохгүй бол зохицуулалт хийж өгдөг. Манайхан долларын зээл авч, долларын хадгаламжтай болсон. Ам.долларын ханш 50-80 төгрөгөөр өсөөд тэгснээ огцом унаж байгаа нь зохицуулалтгүй байсны шинж. Иймэрхүү зах зээлд дамын хүчин зүйлсийн тоглолт нөлөөлдөг. Банк бус санхүүгийн хэдэн байгууллага, найман шарга үүнийг хийгээгүй. Харин манай арилжааны банкуудын зохицуулалт муу байна гэсэн үг. Бүх зүйлийг зах зээлийн ханш гэж хардаг. Валютын худалдаанд өдөр тутам 5-7 банк оролцдог. Эдгээр нь валют зардаггүй. Тэд зөвхөн худалан авах эрэлтийг л тодорхойлдог юм. Валютын эрэлт, нийлүүлэлтийг зохистой хэмжээнд байлгах хэрэгтэй. Бүр болохгүй бол долларын сонирхолыг багасгах хэрэгтэй.

**- Яаж багасгана гэж?**

**С.Дэмбэрэл:** - Долларын хадгаламж нээх, долларын зээл авахад ашиггүй байх ёстой. Мөн монгол орны нутаг дэвсгэр дээгүүр төгрөгөөр гүйлгээ хийх бүх зорилтуудыг биелүүлэх шаардлагатай. Гадаад худалдааны алдагдал, импорт багасахаар дотоодод хомсдол үүсгэж байгаа юм. Өнгөрсөн жилийн валютын ханшийн өсөлт биднийг наадамлаж байхад буюу долоон сарын сүүлчээс өсч эхэлсэн. Наймдугаар сарын сүүл хүртэл, бүр есөн сарын дунд хүртэл дээш явсаар байсан. Гэтэл энэ хугацааны үеийн протоколыг нь харах гэхээр Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл нь амарчихсан байгаа юм. Зөвхөн Төвбанк ажиллаж, бусад нь гадагшаа, дотогшоо амраад алга болчихсон байсан. Тэднийг хуралдсан эсэхийг хэрэв хуралдсан юм бол валютын асуудлыг хэлэлцсэн үү гэдгийг нь протоколоос нь хармаар байна. Өнөөдөр валютын өсөлт иргэдийн амжиргаанд нөлөөлж байна. Үүнээс болж ААН-үүд тендерээс зугтаж эхэллээ. Их хурал дээр валютын энэ байдлыг хэлэхэд дэмжээгүй. Зарим нь яахаараа үүнд төр оролцох ёстой юм гэж байсан. Уучлаарай, үүнд төр оролцохоос өөр аргагүй. Иргэд, ААН-үүдээс хамааралгүйгээр валют өслөө, гадаадын хөрөнгө оруулалтыг төр өөрөө үргээлээ, ханшийн өөрчлөлтийг урьдчилж харж чадаагүй нь хэний буруу юм бэ. Бодлогын түвшинд авч үзэхгүйгээр “За гайгүй болно доо, мөнгө орж ирнэ дээ” гээд хүлээгээд бүтэхгүй л дээ. Валютын ханшийн өөрчлөлтөөс үүдсэн үнийн нэмэгдэл дараа нь бууж байхыг харсан уу. Үгүй л байхгүй юу. Валютын ханшийн өсөлтөд ард иргэд чирэгдэж байгааг төр харах ёстой. Магадгүй энэ асуудлыг ээлжит бус чуулганаар хэлэлцэх ёстой байх.

**- Өнгөрөгч намрын чуулганаар эдийн засгийг дэмжих зорилготойгоор Хөрөнгө оруулалтын болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийг баталсан. Мөн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан нь эдийн засагт дэмжлэг болох өнгө төрх ажиглагдаж байна уу?**



**С.Дэмбэрэл:** - Монгол Улс уул уурхайн бүтээгдэхүүнээс хараат байгаад экспортын бүтээгдэхүүн зогсчихоод ийм байдалд хүрлээ гэж бодож болохгүй. Дотооддоо удирдлага нь муу байна. Хамгийн түрүүнд валютын ханшийн өсөлтийг зогсоох хэрэгтэй. Валютын ханшийг өсгөхгүй байх боломжтой. Уул уурхайн экспортыг нэмэгдүүлэх бүх арга хэрэгслийг ашиглах шаардлагатай. Тэгж гэмээнэ манай 90:10 гэсэн гажиг харьцаа 80:20, 70:30 болох ёстой. Мөн татварын шинэтгэл хийх ёстой. Бизнесийн орчны шинэтгэлээ даруйхан дуусгах ёстой. 10, 10, 10, 10 гэсэн дөрвөн 10-ын зарчмыг бүгдийг нь тав болго. Ингэхээр хүмүүс төсвийн орлого бүрдэхгүй гэнэ. Үүнд яасан их санаа зовдог юм бэ. Данхар болсон төр нь орлого хуримтлуулах дуртай болсон байна. Нийгмийн зардлыг яах вэ гэж асууна. Нийгмийн зардлыг бол зохицуулж болно. Татварын хувь хэмжээ, татвар хураадаг механизмыг боловсронгуй болгох шаардлага байна. Мөн эдийн засгийн өршөөлийн хуулийг гаргах ёстой. Компаниудыг хоёр балансгүй болго. Монгол Улсын албан бус эдийн засаг ДНБ-ий 30-аас илүү хувь байна. Асар их нөөц байна гэсэн үг. Үүнийг ил болгох хангалттай боломжтой. Нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогчийн зүгээс төлдөг 10 хувийг тав болгоход олон олон наймаа эрхлэгчид энэ рүү чинь орчихъё л гэнэ. НӨАТ дээр 50, 200 саяын босгыг ярьж байна. НӨАТ бол Монгол Улсад тохироогүй албан татвар. Аж үйлдвэр өндөр хөгжсөн, аж үйлдвэрийн суурь сайтай орны нарийн механизмыг манайхан оруулж ирээд тавьчихсан. Төсвийн орлого талаасаа их мөнгө орсон нь үнэн. Нөгөө талаасаа асар их орлого дутуу орсон. Мөн ихээхэн хэмжээний орлогоос зугтаадаг. Үүнээс болж албан бус секторын хэмжээг томруулсан. Тиймээс үүнийг борлуулалтын татвар руу шилжүүлээд процетуурыг нь хялбаршуулаад хувь хэмжээг нь таван хувьд хүргэж, зарим хэсэгт нь гурван хувь болохоор бүгд татвар төлнө. Аж ахуй нэгжийн орлогын албан татвар мөн адилхан. Манайхан үүнийг фискал буюу төсөв талаас нь хардаг. Сангийн яамны удирдлагууд түүнийг нь үнэмжшүүлж чаддаг хүмүүс. Нөгөө эффект нь гэхээр авир төрхийн өөрчлөлт буюу үүнийг хийснээр татвар төлөгчдийн авир төрхөд нь ямар өөрчлөлт орох вэ гэхээр татвараа төлөх сонирхолтой болно.

**- Эдийн засгийн байнгын хорооны дарга зургадугаар сараас валютын ханш суларна гэж байсан. Эрчимтэй өсч буй валютын ханш зургадугаар сард буурах уу?**

**С.Дэмбэрэл:** - Би тийм зөнч биш учраас мэдэхгүй.

**- Ер нь буурах боломж байгаа юу?**

**С.Дэмбэрэл:** - Бодлогоо зөв явуулбал боломж байгаа. Валютын ханш нь инфляцид нөлөөлдөггүй тэр түвшинд хүргэх ёстой. Одоо бол инфляцид нөлөөлсөн байна. Бизнесийн сувгуудийн бөглөрсөн хэсгийг нь сайн нээж өг.

**- Хаврын чуулганаар Гэмт хэргийн тухай хуулийг өргөн барина. Уг хуулийн зүйл заалтууд бизнес эрхлэгчдийг хохироосон, цагдан хорьсон, хөрөнгө хураасан чанга хууль гарах нь хэмээн бизнес эрхлэгчид ярьж байна. Таны бодол ямар байгаа вэ?**

**С.Дэмбэрэл:** - Намайг мөнгө угаах терроризмтой холбосон, төрийн ордонд намайг заамдсан гээд шуугьсан нь үүнээс болсон. Манайхан бодит амьдралыг харалгүй хуулийн төсөл оруулж ирдэг. Уг хуулинд



шоронжуулах, эрүүжүүлэх заалтууд байна. 3-5 жил шоронд хорино. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 300-500 дахин нэмэгдүүлж торгоно гэхээр нь юуны төлөө гэсэн чинь Шударга өрсөлдөөний тухай хуулинд байдаг заалтуудыг зүгээр л оруулж ирээд эрүүжүүлэх болгочихсон байсан. Тийм зургаан заалт байсан бүгд хасагдсан. Би энэ асуудлыг өөрийн харьяалалгүй буюу Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцүүлсэн юм. Эрүүгийн хуулийн шинэ өөрчлөлт орж ирнэ. Уг хуульд эдийн засгийн гэмт хэрэг гэж юуг хэлэх вэ гээд үүн дээр нь нарийн ажиллах хэрэгтэй. Аж ахуй нэгжүүд татварын бодлогоос болоод, одоо байгаа хуулиас болоод 2000 орчим аж ахуй нэгж эрүүгийн хэрэг үүсгэгдээд шийдэгдэж чадалгүй явсаар байна.

**- МАН-ыг бүлгээс Худалдааны хуулийн төсөл өргөн барихаар болсон. Уг хуулийг бизнесийнхэн хэрхэн хүлээж авсан бэ?**

**С.Дэмбэрэл:** - Заавал МАН гээд байх шаардлагагүй. Худалдааны хууль 3-4 жилийн өмнө яригдаж эхлэхэд би эсэргүүцэж байсан юм. Яагаад гэхээр тэр хуулийн төсөл дээр бизнес чөлөөтэй явах орон зайг төрийн зүгээс хянах гэж оролдсон байсан. Улс орнуудад худалдааны зохицуулалтын тухай хууль байдаг. Энэ хуульгүйгээр Монгол Улс ячихаад байгаа юм гэж асуух ёстой. УИХ-ын гишүүд олон хууль санаачилах аппараттай болчихсон. Аливаа хууль зах зээл дээр ямар нэгэн нөлөө үзүүлэх ёстой юм. Уг хуулийг оруулж ирэхээр саналаа хэлнэ. Худалдааны чөлөөтэй байдал, бизнесийн эрх чөлөөг хангасан, худалдаа экспортыг нэмэгдүүлсэн байх шаардлагатай. Үүн дотроо гадаад худалдааны бүтцэд эерэг өөрчлөлт оруулах тийм л хууль байгаасай гэж бодож байна. Хэрэв тэгэхгүйгээр нэг яам, агентлагт чихэж өгөх юм бол байгууллагын тухай хуулиас ялгаагүй зүйл болно. Экспортын гэрчилгээ гээд хуулинд байхгүй байна. Ингэхээр л манай хуулиуд хоорондоо зөрөлдөж байна гэсэн үг. Гаалийн тухай хуульд гадаад худалдаатай холбоотой олон зүйл тусгагдсан байдаг тул энэ хуулийн шаардлага байна уу.

*Э.Энхболд*

## **Засгийн газрын Мөрийн хөтөлбөрийн биелэлтэнд 50-иас доош хувьтай зүйл олон байна**

*2014 оны 6 дугаар сарын 18-нд хуралдсан Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлээс:  
“Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт /2013 оны байдлаар../-ийг хэлэлцэх үеэр*

**Байнгын хороон дарга А.Бакей:** Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу? С.Дэмбэрэл гишүүн.

**С.Дэмбэрэл:** - Ерөнхийдөө энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн биелэлтийг мэдэж байна. Тэгэхдээ энд ямар, ямар алдаа байна вэ гэдгийг бид ярьсан шүү дээ.

Тэгэхээр үүнийг бушуухан хэлэлцчихмээр байна. Нэмж ярих юм юу байдаг юм бэ? Яамнаас дуртай дургүй ирүүлдэг нэг тоог нь аваад, чанарын эрс өөрчлөлттэй дүгнэлтийг бид нар гаргах нь юу л бол. Тийм учраас одоогийн байгаа хангалттай мэдээлэл дээр алдаа нь хаанаа байна, алдсан нь юу байна. Цаашид одоо яаралтай арга хэмжээ авах вэ гэдгийг л эхний заалт дээр оруулж өгөөд, хэрэгжүүлмээр байна. Би юу хэлэх гээд байна вэ гэхээр, ерөнхийдөө хөтөлбөрийн биелэлтийг ирүүлсэн байдлыг харж байхад маш саланги. Хэн нэгэн хүн үүнийг агуулгынх нь хувьд уялдуулж, зангидаж явсан процесс их тааруу байсан нь ажиглагдаж байна. Мэдээж хэрэг, 50-иас доош хувьтай олон заалтууд байгаа. Энэ бүхнийг нь зааж өгөөд, дээр нь макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг анхааръя. Энэ дээр хоёрхон л үзүүлэлт байгаа шүү дээ. Инфляци хоёр оронтой тоонд байгаад байна. Валютын ханш өссөн байна. Энэ дээр яг ямар арга хэмжээ авах юм бэ? Хуулиар заагдсан бусад төрийн институциуд хоорондын хамтын ажиллагаа яаж хангагдаж байгаа юм бэ? гэдгийг ярилцъя.

### **Татварын багц хуулийн төсөл гээ**

*2014 оны 6 дугаар сарын 27-нд хуралдсан Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээс: “Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл хэлэлцэх цээр: Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх О.Тунгалаг, Ж.Бямбадулам, референт Б.Хатантуул, Ц.Мөнхтуяа, С.Энхцэцэг нар байлцав. Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн А.Бакей танилцуулав. Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Энхболд, С.Дэмбэрэл нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн А.Бакей хариулж, тайлбар хийв. Улсын Их Хурлын гишүүн М.Энхболд, С.Дэмбэрэл, М.Батчимэг нар санал хэлэв.*

**С.Дэмбэрэл:** - 8-д “Татварын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл гэж байна. Тэр маань одоо Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг энэ татварын тухай бүх хуулиудыг, /дотор нь нэмэлт өөрчлөлт ч биш, шинэчилсэн найруулга ч байгаа/ бүр, тогтолцооны өөрчлөлт хийх тухай ч тийм хуулийн төслүүд орж ирж байна. Тэгэхээр энэ бүхнийг нь томъёолохдоо “*татварын шинэчлэл хийх тухай багц хуулиудыг*” гэсэн тийм томъёоллоор бичмээр байна. Багц хуулиудын төсөл гэсэн ийм томъёоллоор оруулбал, нөгөө Улсын Их Хурлын гишүүдийн өргөн барьж байгаа бүх, татвартай холбоотой бүх хуулиуд энд ингээд тусгагдаад орчихно. Засгийн газрын ч, Их Хурлын даргын захирамжийн ч үзэл санаанд нийцнэ. Тийм учраас ийм байдлаар засуулмаар байна. Үүнийг одоо зарчмын зөрүүтэй санал гэж үзэх үү. Найруулгын шинж чанартай санал гэж үзэх үү?

**А.Бакей:** - Жагсаалтын талаар хууль санаачлагчаас албан ёсоор санал авсан. Ингэхэд бол Засгийн газраас Төсвийн байнгын хорооноос яг ийм томъёоллоор оруулж ирсэн. За энэний зэрэгцээ Улсын Их Хурлын даргын

захирамжаар одоо татварын багц хуульд иж бүрэн шинэчлэл хийх ажлын хэсэг байгуулагдаж бас ажиллаж эхэлж байгаа. За ямар ч утгаар аваад үзсэн одоо ирэх намрын чуулганаар татварын цогц шинэчлэл бол хэлэлцэгдэж эхэлнэ гэж бодож байна. Зүгээр томъёоллын хувьд бол та нар одоо заавал тэгж томъёолно гэвэл санал хураалгах нь зүйтэй гэж бодож байна.

**С.Дэмбэрэл:** - Би өөрийгөө хууль тогтоогч л гэж ойлгодог шүү дээ. Тэгэхээр одоо би энэ төсөл дээр саналаа өгч байна. Тэр 8 дугаар зүйлийг л сая: *Татварын хуулиудад шинэчилсэн найруулга, нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн багц төслүүдийг хэлэлцэх* гэж томъёолчихлоо. Хуулиудын багц төсөл гэдэг юм уу. Тийм томъёоллоор л оруулчихмаар байх юм. Тэгвэл дараа нь ямар нэгэн маргаан гарахгүй. Тэртээ тэргүй одоо ажлын хэсгийн ахлагч сууж байна. Бид эртээд ажлын хэсэг дээрээ ярьсан шүү дээ. Намрын чуулганаар нэлээн дорвитой юм оруулъя. Одоо яах вэ ингээд Засгийн газрын оруулж ирсэн тэр нэмэлт, өөрчлөлтийн хоёр гурван хуулийг ингээд энэ чуулганаар баталж чадвал тэр биз. Баталж чадахгүй бол намрын чуулганаар үүнийгээ хамт оруулаад, татварын тогтолцоондоо иж бүрэн шинэчлэлт хийх. Ажлын хэсгийн гишүүд бүгд санал нэгдсэн байгаа. Тийм учраас томъёоллынх нь хувьд ингээд оруулчихъя. *Нэгдүгээрт.*

*Хоёрдугаарт,* ер нь бол энэ Төсвийн байнгын хороон дээр зөвхөн энэ татварын асуудлыг дангаар нь хэлэлцэнэ гэдэг маань татварын асуудлыг өрөөсгөлөөр буюу пескал талаас нь харж байна гэсэн үг шүү дээ. Эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх. Энэ чиглэлээс нь бизнесийн орчинг сайжруулах чиглэлээс нь дутуу хардаг. Тийм учраас энэ ганцхан Төсвийн байнгын хорооноос татварын тухай хууль санал авчихаад энийг одоо төгсгөлийн эцсийн болсон санал гэж үзвэл учир дутагдалтай. Энэ талаас нь бодож энэ 8 дугаар юуг ингэж томъёолж байгаа юм. Энийг одоо санал хураалгаж өгнө үү гэж.

**А.Бакей:**- С.Дэмбэрэл гишүүнээс зарчмын зөрүүтэй санал ирсэн байгаа. Жагсаалтын 8 дахь заалт буюу Татварын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл гэдгийг татварын хуулиудад шинэчилсэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах багц хуулийн төслийг нэмж оруулах. Томъёолол жаахан юу байна. Тийм ээ. Татварын багц хуульд шинэчилсэн найруулга хийх гэсэн маягаар оруулж өгөөчээ гэсэн ийм хүсэлт тавьсан байгаа. За энэ С.Дэмбэрэл гишүүний саналыг дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан учраас. Санал хураалтаар, зөвшөөрсөн 8, татгалзсан 3, бүгд 11, гишүүдийн олонхын саналаар дэмжигдлээ.

## **Бизнес эрхлэгчдийн олонхынх нь хувьд хамгийн сүүлчийн найдлага**

*2014 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн Эдийн засгийн байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээс: “Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг хэлэлцэх цээр*

**С.Дэмбэрэл:** Бид “Жижиг Дунд Үйлдвэрлэлийн Сан” гээд олон жил ярьсан. Сүүлийн үед хуулийн хэрэгжиж байгаа байдлыг нь харахад хэт **арилжааны банкжаад** байна. 1. Өнөөдрийн Монгол Улс арилжааны банкны дэглэмд хэт их ороод байна. Тэрний үр өгөөж нь бидний анх хүсч байсан тэр хэмжээнд хүрч чадахгүй байна. Хэдийгээр Жижиг Дунд Үйлдвэрлэлийн Сан ажиллаад байгаа боловч, эдийн засгийн орон зайд байгаа эрэлт хэрэгцээг бидний хүссэн хэмжээгээр бүрэн хангах чиглэлд тэр болгон хүрч ажиллаж чадахгүй байна. Ялангуяа үйлдвэрлэл эрхэлдэггүй боловч үйлчилгээ эрхэлдэг, худалдаа хийдэг, улмаар түүнийгээ өргөжүүлэхийн тулд эргэлтийн хөрөнгө шаардагдаж байдаг хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн олонхи болсон бизнесийн хувьд огт хүрэлцэхгүй байна. Үүнийг та бүхэн ч мэдэж байгаа. Уг нь Жижиг Дунд Үйлдвэрийн сан реклам явуулах хэрэггүй байдаг. Өрсөлдөөнт орчинд, хамгийн эрэлт хэрэгцээтэй гэж үзсэн хүмүүс тэртээ тэргүй очиж байгаа. Гэхдээ миний харж байгаа гол дүгнэлт бол хөрөнгө мөнгөний дутагдал. Аймгуудад болон Улаанбаатар хотод салаа мөчрөө түгээсэн байдлаас нь ч харсан энэ бүх дутагдлаас гадна, хамгийн гол нь арилжааны банкны диктатур (дарангуйлагч) дэглэмд орсон байдалтай байна. Тийм учраас цаашид гарах шийдвэр, аливаа өөрчлөлтийг энэ талаас нь бодолцсон зүйл гараасай гэж хүсэж байна.

2. Жижиг Дунд Үйлдвэрийн Сан бол энэ засагт байгаа бусад сул чөлөөтэй байгаа мөнгөн хөрөнгүүдийг төвлөрүүлэх талын эрх зүйн боломж байхгүй. Зөвхөн ноогдсон төсвөөсөө л хамааралтай байдаг. Төсөвт сул чөлөөтэй байгаа бусад сангууд, бусад мөнгөн хөрөнгийг өөртөө татан төвлөрүүлж ашиглах эрх зүйн боломж байхгүй байна.

3. Манай арилжааны банкууд Жижиг Дунд Үйлдвэрт хөрөнгө оруулж болдог билүү, үгүй юу? Энэ бас хэтэрвэл аюултай. Үүний хөрөнгө оруулалтын хязгаарыг тогтоохгүй бол, бусад улс орнуудын туршлагыг харж байхад, арилжааны банкны хөрөнгө оруулалт ихэссэнээс болоод энэ нь өөрөө миний түрүүн хэлсэн зүйлийн нэг шалтгаан нь болж байж магадгүй юм шүү. Жишээлбэл, Улаанбаатар хотод байгаа ЖДҮ-ийн Сангийн үйл ажиллагааг би мэдэж байна. Улаанбаатар хотын сан босоо удирдлагатай юм уу? Яаж холбож байна? Улаанбаатар хотын хамаагүй үрээд байгаа энэ мөнгөн хөрөнгө болон бичил бизнесийг дэмжье гээд байгаа тэр 15 сая ам.доллар нь энэ сангаар дамжин явагдаж байна уу, үгүй юу? Улаанбаатар хотын бизнесийг дэмжих үйл ажиллагаа, үүнтэй холбоотой банкнуудын болон бусад мөнгөн хөрөнгөнүүд энэ Сан руу орж чадаж байна уу, үгүй юу? гэх мэтээр Жижиг дунд үйлдвэрийн Санг орон даяар маш хүчтэй байгууллага болгох хэрэгтэй байна. Тэгэхгүй л юм бол иймэрхүү байдалтай хэвээрээ л цаашаа явна. Одоогийн байгаа байдлаасаа илүү гарч огт чадахгүй. Энэ бол бизнес эрхлэгчдийн олонхынх нь хувьд хамгийн сүүлчийн найдлага юм шүү. Энэ талаас нь бодож өөрчлөх ёстой гэдгийг хэлмээр байна. Баярлалаа.

## **ГУРАВ. Зээлийн хүү, татварын дарамт бага орчин бий болгох нь бүх бизнесийнхэний хүсэл ба хясал юм**

### **Уул уурхайн салбарт авторитари дэглэм тогтоож болохгүй**

*2009 оны 6 сарын 21.*

**С.Дэмбэрэл:** - Одоогийн нөхцөл байдлаас ажиглахад 34 хувь, түүн дээрээ нэмж зээл авна гэх мэт сонин зүйл яриад байгаа. Бидний байр суурь бол алтан хувьцаа гаргаж, цаашлаад Монголын хөрөнгийн бирж дээр арилжих зэрэг зарчмын шинж чанартай асуудал юм. Үүнийг судлаад эцэслэсэн байдлаар байр сууриа илэрхийлэх бодолтой байна. Уул уурхайн салбарт төрийн авторитари гэж хэлж болох тийм дэглэм тогтоож болохгүй. Энэ хэлбэр нь хэзээд үр ашиггүй гэдгийг түүх баталдаг. Тиймээс гол зарчим нь PPP буюу төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бий болгох ёстой. Төр өмчлөгч, үр ашгаа авдаг, гэхдээ бас ганцаараа байна гэж бодож болохгүй. Win win буюу хэн хэн нь ялах тийм шийдлийг олох ёстой.

- Уул уурхайн дэд бүтцийн салбарт таван тэрбум орчим ам.долларын хөрөнгө оруулалттай төслүүд хэрэгжих гэж байна. Үүнийг төр хувийн хэвшилтэй хамтарч хэрэгжүүлнэ гэж яригдаад байгаа. Тэгэхээр төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа шинэ түвшинд гарах нь ээ?

**С.Дэмбэрэл:** - Манай улс PPP буюу төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг одоо л тавих гэж байна. БНСУ-ын PPP-ийн хууль гэхэд олон арван хуудастай том хууль байдаг. Монголд тийм зузаан ном, том хууль хэрэггүй. Үндсэн зарчмуудаа гол концепцдоо тунхаглаад, түүнийгээ хуульчлах байдлаар Засгийн газрын бодлогын баримт бичгийг батлах хэрэгтэй. Case by case буюу тодорхой төслүүд дээр энэ PPP-гийн хувилбаруудыг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тавьж өгмөөр байна. Баахан хууль, дүрэм хэрэггүй. Үүнийг гэрээгээр зохицуулдаг хэлбэр бас байдаг. Зарчмын шинж чанартай суурь концепц болон бусад зарчмыг ерөнхий хуульдаа заагаад, үлдсэнийг нь гэрээгээр зохицуулдаг. Ингэхдээ олон улсын загвар гэрээ гэж гаргаж болно. Загвар гэрээг уул уурхайн ийм салбарын, тийм төсөлд хэрэгжүүлнэ гэдэг ч юм уу тодорхой заагаад өгнө л дөө. Монгол улсын хөгжлийн цаашдын чиг хандлага эрдэс баялгийн нөөцөд суурилсан эдийн засаг болох төлөвтэй байна. Энэ тохиолдолд юуг онцгой анхаарах ёстой вэ гэхээр төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээн дээр суурилсан үйлдвэрлэл явуулах юм. Уул уурхайн том төслүүдээс дотоодын компаниуд үр ашгийг нь хүртэж, гэрээний дагуу зарим ажилбарыг гүйцэтгэдэг байж болно. Цаашлаад ажлын байр бий болох жишээтэй. Энэ бүх зүйлийг зарчмын хувьд ерөнхий хуульдаа зааж өгөх нь зүйтэй юм.

- Та Концессийн тухай хуулийн төсөлтэй танилцав уу? Хэр сайн болсон гэж үзэж байна?

**С.Дэмбэрэл:** - Концессийн хууль нь товчхондоо өмчлөх эрхийг төр гэдэг субъектээс бусад субъектэд тухайн орд газрыг ашиглах, эзэмших, захиран зарцуулах зэрэг эрхүүдтэй уялдуулж өгөх зорилготой хуулийн нэг хэсэг юм. Үүнээс үзвэл концесс нь хөгжлийн эрхийг шилжүүлж буй асуудал билээ. Лизинг нь үйл ажиллагааны эрхийг шилжүүлж буй хэрэг. Харин хөгжлийн эрх гэдэг нь тэнд хөрөнгө оруулалт хийх явдал. Гэхдээ өмчлөгч нь хэвээрээ байна. Ер нь энэ талаарх харилцааг зохицуулсан хуулийн заалт манайд дутмаг хийгдсэн.

### **Төр бизнесмэн болчихоод, компаниудтай өрсөлдөөд байдаг гажиг системээ солих хэрэгтэй**

*Эрхэм уншигч та бүхэнд УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлийн одоогоос 5 жилийн өмнө хэвлэлд өгч байсан нэгэн ярилцлагыг эргэн хүргэж байна.*

*Улс орныг эдийн засгийн хямралаас гарах, цаашлаад эдийн засгийг эрчтэй хөгжүүлэх, “Оюутолгой” гээд цаг үеийн асуудлыг шийдэхэд төр засгаас ямар бодлого баримтлах нь илцү оновчтой байх талаарх саналыг сонсохоор МҮХАҮТ-ын дарга С.Дэмбэрэлтэй ярилцлаа.*

**С.Дэмбэрэл:** - Засгийн газар энэ оныг “Үйлдвэржилтийг дэмжих жил” болгон зарласан. Энэ ажил хэр бодит ажил болж, хэр үр дүн гарч байна вэ? Бизнес эрхлэгчид зарим талаар ялангуяа банкны зээлийн талаар нэлээд шүүмжлэлтэй хандаад байх шиг байна?

**С.Дэмбэрэл:** - “Үйлдвэржилтийг дэмжих жил” гэдгийг ярихын өмнө манай танхим үйлдвэржилтийн газрын зураг гэж гаргасан. Монгол Улсын аль аль бүс нутагт ямар ямар үйлдвэр шаардлагатай байна гэдгийг санал асуулга авч байгаад анх удаа газрын зураг хэлбэрээр гаргасан. Үүнийг санхүүжүүлэхийн тулд зөвхөн банкны санхүүжилт төдийгүй альтернатив буюу зэрэгцээ хувилбар хэрэгтэй гэсэн санал дэвшүүлсэн. Ингээд засаг төр дуншиж дуншиж үйлдвэржилтийн жил гэж зарлаж, 30 тэрбум төгрөгийг энэ ажилд зарцуулахаар боллоо. Ингэхдээ 50 хүртэл сая төгрөгийг жижиг дунд үйлдвэрүүдэд олгохдоо бидний таашаахгүй байсан санхүүжилт буюу банкуудаар дамжуулах хувилбарыг сонгосон. Бизнес эрхлэгчид гомдоллох нь аргагүй. Нэгдүгээрт аль 2008 онд ярьсан юм 2009 оны эхний хагас жил дуусч байхад нэг юм тодорхой болж байна. Хоёрдугаарт мөнгөний хатуу бодлогоос болоод зээл өгөхөө больсон банкуудад дахиад нэмэлт эх үүсвэр санхүүжүүл гэхэд банкууд нэг их сонирхол байхгүй л байгаа болов уу. Яагаад гэвэл эрсдэл өндөр болсон, эх үүсвэр дутмаг байгаа. Тийм учраас банкууд шалгарсан төслүүдийг ямарваа нэг шалтгаанаар буцаах сонирхолтой байна. Угаасаа банк тэгдэг л байсан. Дээрээс нь дээрх нөхцөлд арилжааны чанартай банкууд хөгжлийн шинж чанартай санхүүжилтийг аль болох өөр дээр байлгах гэхээс нэмж зээл гаргах гэсэн хүсэл төрөхгүй л болов уу? Гуравдугаарт ерөөсөө Монгол Улсын жижиг дунд үйлдвэрт байдаг



барьцаа хөрөнгөний дутагдал. Барьцаа хөрөнгийг үнэлэхдээ бодит үнээс хоёр дахин доогуур үнэлдэг. Барьцаа хөрөнгө нь ч дутагдалтай байдаг. Зээлийн баталгаа гаргадаг систем танхимаас өөр газар хаана ч байхгүй. Баталгаагаа гаргаад 400 сая төгрөгийн эх үүсвэрээ тараачихсан. Тэрний эргэн төлөлт арай болоогүй байна. Иймэрхүү шалтгаанаас болоод 2009 оны наймдугаар сараас эхэлж байгаа үйлдвэржилтийн жил ерөнхийдөө жилийн эцэст нэг их сайн олигтой үр дүн гарахгүй байх.

**- Санхүүжилийг ямар хэлбэрээр хийвэл оновчтой байсан бэ?**

**С.Дэмбэрэл:** - Бид альтернатив санхүүжилтийг хийе гэсэн. Нэг хэсгийг нь танхимаар дамжуулж, нөгөө хэсгийг нь мөнгөний бодлогоо зөөллөх замаар хийх. Мөнгө их байгаа учраас инфляци өсч, хямрал болоод байсан юм биш. Мөнгө угаасаа л байнга хэрэгтэй. Одоо бол бүр их хэрэгтэй байна. Банкны салбарт өрсөлдөөн бий болгох замаар энэ төрд байгаа мөнгөний нөөцийг арилжааны банкуудад байршуулаад, бодит сектор буюу жижиг дунд үйлдвэрийг зээлжүүлэх, ингэхдээ заавал хууль энээ тэрээ гээд байлгүй зээлийн баталгааг манай танхимын баталгаан дээр тулгуурлаад хийсэн бол өдийд бодит сектор шоргоолжны үүр шиг бужигнаж байх байсан. 2009 оны нэгдүгээр сард танхим хямралын эсрэг эдийн засгийг идэвхжүүлэх төлөвлөгөө гаргаж УИХ, Засгийн газарт өгсөн. Энд нийлүүлэлт, эрэлтийн талд ямар ямар арга хэмжээ авах талаар маш тодорхой дугаарлаж байгаад тусгасан байгаа. Энэ бүхнийг харгалзаж үзсэнгүй, харгалзаж үзэх соёл ч байсангүй. Ажлын хэсэгтээ оруулсан болоод л явж байгаа нь энэ. Гэхдээ цаг оройтоогүй байна. Энэ үлдэж байгаа саруудад мөнгөний бодлогод өөрчлөлт оруулаад, ээлжит бус чуулганаар зөвхөн Оюултолгой биш, Монголын эдийн засгийн хямрал ямар байна, бодлогын ямар засвар хийвэл эдийн засаг идэвхжих нь вэ, барилгын салбарт хуримтлагдсан өр зээлийн хямралыг яаж давах вэ гэсэн асуудлыг ярих хэрэгтэй гэж бодож байна. Танхимаас "Заяагдмал нөөцийн олдмол хам шинж ба хөгжилд хүрэх зөв замын тухай" 10-аад зүйлтэй маш тодорхой саналуудыг гаргасан. Монголын нийгэмд сүүлийн үед бий болсон ашигт малтмалын нөөцийг тойрсон нийгмийн хийрхэл гэж болох гаж үзэгдэлд дүгнэлт өгөөд ийм нэртэй нийгмийн өвчин байна гэж дүгнэж байгаа юм.

**- Мөнгөний хатуу бодлого бариагүй бол инфляцийг барьж чадахгүй байсан гэсэн тайлбар хэлж байгаа шүү дээ?**

**С.Дэмбэрэл:** - Яст мэлхий шиг засаглалын удаан технологи, дээр нь банкны секторт банкуудын буруугаас биш мөнгөний бодлогын буруугаас болоод банкууд зээл өгөх сонирхол багасчихсан байгаа. Нөгөө талаар бид хэдийгээр шүүмжилдэг байсан ч банкууд рекламдаж байгаад жижиг дунд үйлдвэрийн бизнест зориулсан зээлийн багц гээд л овоо өрсөлдөөд, зээлийн хүү нь ч овоо зах зээлийн журмаар бас багасч байсан. Гэтэл энэ бүх процессийг таслаад мөнгөний хатуу бодлого нэр дор банк ба бизнесийн хооронд байдаг амьд орчлыг тасалчихсан. Үүнийгээ юу гэж зөвтгөдөг вэ гэвэл "хэрэв бид мөнгөний хатуу бодлого бариагүй бол Монгол Улс сүйрэх байсан. Бид валютын ханшийг тогтворжуулж байж инфляцийг барьж чадлаа" гэсэн ийм л юм хэлдэг. Энэ тухай 2009 оны 3 дугаар сард сонины бүтэн нүүр материал бүх сонинд нийтлүүлж, тэрэн дээрээ "тэртэй тэргүй унаж байгаа хувийн хэвшил" гээд албан ёсоор биччихсэн байгаа.

Төвбанк нь хувийн хэвшлийг унаж байгаа гээд зөнд нь орхисон улс орон хаана ч байхгүй. Тэр тусмаа хямралтай энэ үед Төвбанк харин ч хамгийн идэвхтэй хувийн хэвшлээ дэмжиж, хамтран ажиллаж хямралыг боломж болгохоор ажиллах хэрэгтэй. Гэтэл үүнийг нь Засгийн газар нь ч, УИХ нь ч тоохгүй юм. Тэгсхийж яваад гайхамшигтай наадмууд эхэллээ. Тэр наадмууд хэзээ нэгэн цагт дуусна биз. Эдийн засгийн байдал нэлээн тааруу болоод байна. Бизнесийн сектор бартерийн харилцаанд орчихсон, бартерт авч өгөлцдөг зүйл нь ч багасаад ирлээ. Барилгын салбарт гэхэд 380-аад орон сууц зогсчихлоо. Барилгын салбарынхан аргаа тасраад Монголын түүхэнд байгаагүй жагсаал анх удаа хийлээ. Иймэрхүү байдалтай эдийн засгийн хүндрэлтэй үед УИХ-ын гишүүд нь ч, ерөнхий сайд нь ч амардаг юм байна.

**- Танай ганхим эдийн засаг, бизнестэй холбоотой хууль тогтоомжуудад дүн шинжилгээ хийж байгаа гэсэн?**

**С.Дэмбэрэл:** - ХЗДХЯ, МҮХАҮТ, Германы техник туслалцаа, хамтын ажиллагааны нийгэмлэг, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо хамтран Монгол Улсад мөрдөж байгаа бизнес эдийн засгийн хууль тогтоомжуудад дүгнэлт хийхээр "Их цэвэрлэгээ" кампанит ажил өрнүүлж байна. Гол нь эдийн засаг дахь тоглоомын дүрмийг өөрчлөх, хуулиар далимдуулж бизнест ордог төрийн хэт их оролцоог багасгах гэсэн зорилготой. Эдийн засаг бизнесийн чиглэлийн 80-аад хуульд анализ хийгээд, багасгах, өөрчлөх, хүчингүй болгох зэрэг саналуудаа УИХ-д хүргүүлнэ.

**- Үл хөдлөх хөрөнгийн барьцаа, зээлтэй холбоотой хуулиуд батлагдаж байна вэ? Энэ хуулийг элдвээр шүүмжилж байна. Таны хувьд ямар бодолтой байгаа вэ?**

**С.Дэмбэрэл:** - Манайх энэ хуульд тодорхой саналаа өгсөн. Барьцаалагч, барьцаалуулагчийн хоорондын тэгш, шударга харилцааг бий болгох хэрэгтэй. Энэ намрын чуулганаар батлагдах байх. Хуультай болсноор ипотекийн орчин гайхалтай хөгжөөд байна гэж байхгүй. Ямар ч байсан хууль эрх зүйн орчин нь бүрдэнэ. Банкууд бизнес эрхлэгчидтэй хийж байгаа зээлийн гэрээ олон улсын эрх зүйн нэг зарчмаар бол талуудын тэгш байдлыг хангаж өгөх ёстой байдаг. Жишээ нь: Үер усны гамшиг болсон ч мөнгөө төлнө шүү гэсэн заалт гэрээндээ заачихсан. Зээл авах хүмүүс нь мөнгөө авахын тулд зөвшөөрч таардаг. Ипотекийн талын хууль дээр ч зарим банкуудад барьцаалагч этгээдийн эрх мэдлийг дэндүү товойлгоод тавьсан зүйл байсан. Энэ бүхэнд саналаа өгсөн. Гэхдээ батлагдаад хэрэгжээд ирэхээр харагдах байх. Ер нь аливаа хууль хэрэгжээд ирэхээрээ л харагддаг шүү дээ. Тухайлбал: татварын реформ хийсэн гэдэг. Гэтэл эцсийн дүндээ Татварын ерөнхий хууль дээр нэг зүйл орхигдуулчихсан байгаа. Процессийн талыг реформын чиглэлтэй оруулсан. Татварын ерөнхий хуульд татвар төлөгч ба татварын байгууллага хоорондын эрх тэгш байдлыг хангаж чадаж байна уу, дэндүү субъектив хүчин зүйл, татварын байцаагчаас дэндүү хамаарч байна уу гэдгийг бид судалж шинжилж байна.

**- Намуудын амлаад байгаа 1.5, нэг сая амлалтыг ямар хэлбэрээр өгвөл зүгээр вэ?**

**С.Дэмбэрэл:** - Ерөөсөө огт өгөх хэрэггүй гэж бодож байна. "Заяагдмал нөөцийн олдмол хам шинж" гэж яриад байгаа. Энэ нэг юм сануулж байгаа

биз. Дархлал дутагдлын олдмол хам шинж гэдэг дээ. Тэгэхээр Монголын нийгэмд бий болсон "Заяагдмал нөөцийн олдмол хам шинж өвчин"-ий нэг шинж тэмдэг нь алаагүй баавгайн арьсыг аль хэдийн социалсит байдлаар тэгш хуваарилах зарчмаар ард түмнийг системтэйгээр дээрээс нь сатааруулж, ингэсний үр дүнд ард түмэн нь төр лүү харах, төрөөс хүсэн хүлээх, хишиг горьдох ийм психологийн орчинд орж байна. Нийгмийг ийм байдалтай болгож байгаа нь ард түмнийг идэвхгүй болгож, гуйх хүсэх, дээшээ харах байдалд хүргэж байна.

**- Оюутолгойн гэрээг хэлэлцэх явцад 68 хувийн татвар гол гацаа болчих шиг боллоо. Үүнээс болж УИХ-ын ээлжит бус чуулган хуралдуулах төлөвтэй байгаа? 34-51 гэсэн хувь, 68 хувийн татвар гэдэг дээр таны санал ямар байгаа вэ?**

**С.Дэмбэрэл:** - Ээлжит бус хурлыг хуралдуулах гурван шалтгаан бий.

1. Эдийн засгийн хямралын эсрэг цаашид ямар арга хэмжээ авах вэ?
2. Эдийн засгийн хямралын эсрэг цаашид ямар арга хэмжээ авах вэ?
3. Эдийн засгийн хямралын эсрэг цаашид ямар арга хэмжээ авах вэ?

Энэ л гурван шалтгаан бий. Гэхдээ би зориуд нэг шалтгааныг гурав дахин хэлж байгаа юм. Түүний дараа барилгын секторын асуудлыг яаж шийдэх вэ? Оюутолгойг яах вэ гээд ярих. Түүнээс биш өвчтэй юм шиг 4-5 жил гацаачихаж болохгүй ш дээ. Ард түмэндээ 51 хувийг нь ч гэсэн аваад өгчих юмсан, тэгээд л үхэх юмсан, тэгэхгүй бол хохирчих гээд байна гээд байдаг. Тэгсэн мөртөө цаанаа улс төрийн бүлэглэлүүдийн тэмцэл явагдаж байна. Тэр тусмаа хариуцлагаа хүлээж байгаа Засгийн газар байх үед нь гэрээг яаралтай байгуулах ёстой. Гэхдээ Оюутолгойг эзэмшх "Айвонхоу майнз" компанид ч үг хэлэх хэрэгтэй. "Өнөөдөр Монголд хандах та бүхний хандлага буруу байна. Та бүхэн захиа бичээд, эсвэл нэг суманд хэдэн Жийп авч өгөөд байгаа чинь буруу байна. Орчин үеийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй сайн компани, сайн засаглалыг хэрэгжүүлэх компани байх ёстой. Тухайн хөрөнгө оруулж байгаа улс орондоо сайн засаглалын шинжүүд болон компанийн нийгмийн хариуцлагын шинжийг улс орон даяар харуулсан тийм компани байх ёстой" гэж. "Айвонхоу майнз" гэдэг компанийн "Компаний нийгмийн хариуцлагын илтгэл"-ийг би интернэтээс хайгаад олоогүй. Хийдэггүй юм шиг байна. Нөгөө талаас "Айвенхоу майнз" гэсэн нэртэй Виржина аралд бүртгэлтэй тийм компани байдаг юм байна. Гэх мэт эргэлзээтэй зүйл олон байна. Хамгийн гол нь энэ компанийг удирддаг Роберт Фрийдланд гэдэг хүн Нью-Йоркт ч юмуу, Торонтод ч юм уу хөрөнгө босгохын тулд хөрөнгө оруулагчидтай Монголын тухай ярьж байгаа, Монголд хандаж байгаа байдлыг нь харахад үнэхээр бизнесийн соёлгүй, хөгжиж байгаа Африкийн хаа нэг газар авлига хээл хахуультай Засгийн газартай яриад сурчихсан тийм байдалтай хандаж байна. "Монгол бол амархан орон" ч гэх шиг. Юу юу ч гэлээ.

Хэрэв Монгол улсад хөрөнгө оруулах гэж байгаа бол удаан хугацаанд оршин тогтнож, энэ улс нийгмийн нэг эд эс нь болоод явах учраас энэ нийгэмд тулгарч байгаа сорилтууд, нийгмийн асуудлыг шийдэхэд оройлон оролцож, ингэсний дүнд Монголын ард түмний итгэлийг авах юм бол энэ компанийн хамгийн зөв бодлого болно. Энэ талаар энэ компани үнэхээр ажиллаагүй. Зүгээр нэг Ханбогд суманд

хэдэн Жийп авч өгсөн, нэг сургууль засч өгсөн ч гэдэг нь сонин биш. Нөгөө талаасаа 34, 51, 68 гэсэн гурван тоо л ярьж байна. 34, 51 гэдэг бол утга муутай зүйл. Үндсэн хуульд газрын доорх баялаг бол Монголын ард түмний мэдэлд байна гэж маш тодорхой заасан. Хууль эрх зүйн талаас ард түмний мэдэлд байна гэсэн чинь ард түмний өмч гэсэн үг. Үүнийг аль ч улсын хөрөнгө оруулагч ойлгож байгаа. Ард түмний мэдэлд байгаа хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах гэсэн хэлбэрүүдэд хувийн хэвшил Засгийн газрын түншлэлийн арга, концессийн арга гэх мэт төрөл бүрийн хөрөнгө оруулалтын аргууд бий. Үүн дээр суурилан нөгөө компани чинь хөрөнгийн бирж дээр хөрөнгө босгоно. "Та миний пиджакийг түр авчээ. Гэхдээ миний хэвээрээ л байгаа учраас өөр хүнд өгч болохгүй ш дээ. Та түр хугацаагаар ашиглаж байна". Яг тэрэнтэй адилхан. Ард түмний өмчлөлийн эрхийг УИХ, Засгийн газар хадгалж явна. "Би энд ажилтай, завгүй байна. Ногоо тарьж байна гээд" иргэд гараа өргөөд сонгочихсон. Өмчлөх эрхээ мэдлээ дамжуулаад өгсөн болохоос өмчлөх эрх нь хэвээрээ байгаа. Тэгэхээр Засгийн газар цаашаа хөрөнгө оруулагчидтай яриад явах ёстой. Энэ тохиолдолд 34, 51 хувийг авна гэж байгаа. Үүнийгээ "Ийм жишээ жишээ байна ш дээ. 51, 49 хувьтай Эрдэнэт гэдэг" гэж их гоёор зөвтгөдөг л дөө. Хэрэв үнэхээр сайн жишээ юм бол яагаад засаг солигдох болгонд Эрдэнэтийн даргыг солихын төлөө, энэ суудлын төлөө, эдний импортоор оруулж ирдэг юмны төлөө бүгд тэмцэлдэж, гүйдэг юм бэ. Сайн жишээ мөн үү. Биш л байгаа байхгүй юу. Ийм тохиолдолд 34, 51 гэлгүй орчин үеийн эрдэс баялгийн ил тод сайн засаглалтай, компанийн нийгмийн хариуцлагыг сайн өрнүүлсэн энэ компаниуд дотоодын болон гадаадын компаниудад хөрөнгө оруулах орчныг бүрдүүлж өгөх, энэ орчныг бүрдүүлэх явцдаа бүх төрлийн татварыг сунайтал авах хэрэгтэй. Манай танхимын байр суурь эрдэс баялгийн салбарт төрийн авторитор дэглэм тогтож болохгүй. Зөвхөн Ерөнхийлөгч нь бүх юмаа мэддэг зарим нэг орон байдаг. Нэрийг нь хэлэхээ больё. Тийм орон шиг болох гээд байгаа юм уу, эсвэл эрдэс баялгаа хөгжлийн төлөө зориулах гээд байгаа юм уу гэдэг талаасаа сайн бодох хэрэгтэй.

Нөгөө талаар яг одоо Оюутолгойн хувьд нэг асуулт өөрсдөөсөө асуух хэрэгтэй. Говийн дор байгаа гүний ус энэ аймгийг хэдэн жил тэжээх вэ? Оюутолгой ашиглалтад ороод секундэд хэдэн шоо метр ус ашиглах вэ гээд. Асар их ус ашиглах тийм төсөл явж байгаа. Экосистемийг тэр чигээр нь гэмтээн говьд хүн амьдрахын аргагүй, цаашлаад Монголын нийт экосистемд гүний усны дутагдал бий болгож, Монголыг усны гачаалд оруулах түгшүүрийн харанга 2020 биш 2030 биш, 2010 оноос хойш гарах гээд байна. Би заримдаа Өмнөговийн ард түмнийг азгүй гэж боддог. Үүнийг бодож байгаа юу?

Гол мөрөн ширгээд эхнээсээ усны асуудал тулгараад ирлээ. Ийм юм болно гэдгийг чинь манай наймдугаар Жавзандамба гээд хутагтууд хэлчихсэн. Пүрэвбат бурханч лам "Ирээдүйд эш үзүүлэгч бошготууд" гэсэн номондаа биччихэж. НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга сая Монголд айлчлахдаа цаг агаарын дулаарлын талаар онцгой анхаарах тухай тодорхой юм хэллээ. НҮБ өөрөө "Ногоон эдийн засгийн санаачилга" 3 дугаар сард гаргасан. Иймэрхүү байхад ганцхан ашигт малтмал, эрдэс баялгийн

салбар манай хөгжлийн эх үүсвэр гэж байгаа нь утгагүй санагдаж байна. Улс орны нөөц байгаа юм бол Оюутолгой, Тавантолгойг ашиглаж эхлэх хэрэгтэй. Магадгүй 2015 оноос, 2020 оноос хойш дэлхий дээр нөөц баялаг дээр суурилсан хөгжлийн загвар арилсан байж болно. Маш олон шинэ хувилбар гарч ирж байна. Экологи, дулаарлын асуудлаа бодож байхгүй бол зөвхөн энэ хоёр тал руугаа хөлжөөд сайхан амьдрана гэдэг бол хамгийн гэнэн бөгөөд хортой асуудал.

**- Компанийн нийгмийн хариуцлага гэж нэлээн ярих болсон. Үүнийг хуульчилчихвал яасан юм бэ?**

**С.Дэмбэрэл:** - Үүнийг хуульчлах ямар ч шаардлагагүй. Ёс суртахууны ч асуудал биш. Зүгээр компани хөгжих шинэ философи л гарч ирж байна. Урьд компаниуд байгаль орчин, нийгмийн тулгамдсан асуудлыг огт хайхардаггүй, зөвхөн ашгийг максимум зорилтоо болгож тавьдаг байсан бол одоо байгаль орчноо хордуулдаггүй, ээлтэй технологи бий болгох, нийгмийн тодорхой асуудлыг шийдэн зах зээлээ улам тэлэх замаар хөгжиж болох юм гэсэн шинэ философи гарч ирж байгаа юм. Тэрнээс биш аль нэг дүүрэгт юм хандивладаггүй компанийг "Компанийн нийгмийн хариуцлага"-гүй компани гэж хэлж болохгүй. Сүүлийн үед "Алив чи нэг юм хандивлаач. Компанийн нийгмийн хариуцлага шүү" гэх юмуу эсвэл нэг спортын аливаа үйл явдлыг ивээн тэтгэгч гэх гээд байдаг болсон. Ингэснээрээ компанийн нийгмийн хариуцлага бий болж байгаа юм биш. Хүн, гараг ертөнц, ашиг гэсэн энэ гурван зүйлийн /гурван Пи-гийн/ нэгдэл юм. Дэлхий дээр энэ талаар компаниуд бүр тусдаа илтгэл бичдэг болсон. Би түрүүн хэлсэн дээ. "Айвенхоу майнз"-д ийм илтгэл байдаггүй юм байна билээ. Цаашдаа гарах байх гэж найдаж байна.

**- Засгийн газар төрөл бүрийн хөтөлбөр гаргадаг. Зарим нь хэрэгжихгүй, зарим нь бүр сураг тасарчихдаг. Хөтөлбөрөө цагаа олохгүй гаргаад байна уу? Хэрэгжүүлэх аргаа олохгүй байна уу?**

**С.Дэмбэрэл:** - Тулгамдсан асуудалд нийгмийн болон бизнес эрхлэгчдийн анхаарлыг илүү хандуулахын тулд төрөл бүрийн хөтөлбөр гаргаж байгаа юм. Аливаа юм хийхэд оролцоон дээр суурилах ёстой. Тэр хөтөлбөрүүдэд бүгдэд нь байдаг нэг үндсэн дутагдал маш гоё зорилго тавьсан хэрнээ сонирхол нь хөндөгдөж байгаа тэр хэсгээ татаж оруулах, санал бодлыг авах, өөрөөр хэлбэл "Итгэлт"-ийн хэлээр хүнээр ажил хийлгэх талаар манай засаглалын технологи нь хоцрогдсон. Социализмын үеийн дээрээс бүхнийг төлөвлөөд өөрснөө хийх гэж зүтгэдэг, төр өөрөө бизнесмэн болчихсон, төр өөрөө компаниудтай өрсөлдөөд байдаг ийм гажиг системээ солиод төр нь орчноо бүрдүүлж өгдөг, үгийг нь сонсоод, хамтарч ажилладаг засаглалын технологитой болохгүй байгаагаас олон хөтөлбөр, санаа цаасан дээр үлдэж байна. Тэрнээс биш хөтөлбөр дотроо зорилтоо буруу тавиад байгаа юм биш. Компани бүтээмж нь буураад байвал машинаа солих хэрэгтэй, ажилчдаа мэргэжлийг нь дээшлүүлэх хэрэгтэй. Ингээд бүтээмжээ дээшлүүлдэг. Тэрэнтэй адил засаг машинаа солих, ажил хийх технологио солих хэрэгтэй. Тэр технологи нь нь маш энгийн хүмүүсийг сонс, хүмүүсийн оролцоотой хүмүүсийн төлөө хүмүүстэй хамтраад юм хий.

**- Манайд ялангуяа банкны салбарт гадаадын хөрөнгө оруулалт нэлээд их байх шиг байна? Гадаадын хөрөнгө оруулалт дээр бодох зүйл их байх шиг санагдаад байдаг юм?**



**С.Дэмбэрэл:** - Банкны салбарт гадаадын хөрөнгө оруулалт оруулахад болгоомжтой хандах хэрэгтэй. ОХУ гэхэд банкны секторт 50-ээс дээш хувь гадны хөрөнгө оруулалт ороод ирэхэд болгоомжлоод тодорхой арга хэмжээ авч байна. Монгол жижиг эмзэг эдийн засагтай орон. Гэхдээ л банкны секторт гадны хөрөнгө оруулалт хэрэгтэй. Ингэхдээ дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалт хөрөнгө оруулалтыг баланслах ёстой. Унгар асар их реформ хийж байна гээл баахан хувчлал явуулж бүгдийг нь гадныханд өгөөд эцэст нь тэд нь орхиод л гараад явчихсан. Ер нь гадны хөрөнгө оруулалтыг тооны хувьд биш чанарт анхаарах цаг болсон. Өнгөрсөн 18 жил бид үүдээ цэлийтэл нээгээд гадаадын хөрөнгө оруулалтыг урьсан. Эргээд харсан чинь эмх замбараагүй болсон байна. Энэ гэрийн үндэсний шинж тэмдэг алдагдах гэж байна. Нэг хэсэг оёдлын салбарт дурын хүн ирээд л хуучирсан машин авчраад юм оёод л байсан. Тухайн үед би шүүмжилж байлаа. Одоо өдөр нь 2, 3 алхаад л нэг шанаган тогоо, шөнө нь карооке ажиллаж 14-16 насны охид ажиллаж байна. Гадаадын хөрөнгө оруулалтаар зарим тохиолдолд шинэ технологи орж ирэхгүй, технологийн түвшин доогуур юм орж ирж байна. Өнөөдөр 10 мянган доллартай бол орж ирээд л нэг юм түрээслээд, эсвэл Солонгосын комиссын зарж байна шүү дээ. Бид Солонгост хуучин дээлний дэлгүүр ажиллуулж чадах уу? Тэгэхээр аль ч салбарт хөрөнгө оруулахад ямар босго байх вэ гэдэг ялгавартай бодлого бий байх ёстой. Тухайлбал: жижиглэнгийн салбарт гэхэд 500 мянган доллартай байвал хөрөнгө оруулж болно гэх мэт. Цаашдаа чанарыг дээшлүүлэх зорилгоор Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах хэрэгтэй. Бид 2009 оны эхээр энэ талаар саналаа өгсөн.

**- Барилгын салбарыг сэргээх ямар боломж байна вэ?**

**С.Дэмбэрэл:** - 60-аас дээш хувьтай барилгаа тоолох хэрэгтэй. Дараа нь ард иргэдийн худалдан авах чадвар хүрэх нэг, хоёр өрөө байрыг тоолох хэрэгтэй. Эдгээрийг барихад материал дутагдаж байгаа учраас мөнгө хүсээд байгаа. Тэгвэл Засгийн газар санаачлаад бартерийн харилцаагаар барилгуудыг дуусгах хэрэгтэй. Зарж борлуулах бол хоёрдугаар асуудал. Дууссан юмыг зарж болно. Өөр ямар ч арга байхгүй. Тэгэхгүй өнөөдөр бид мөргөж нэг юм яриад, хууль батлаад ч хэрэггүй. Эсвэл банк хөрөнгө босгоно гэж хүлээгээд ч хэрэггүй. Банкууд зээл өхгүй. Юу гэж өгөх вэ дээ. Өөрсдөө хэцүү байгаа юм чинь. Яагаад хэцүү болсон гэхээр Төвбанк хэцүү болгочихсон. Тиймээс Ерөнхий сайд толгойлоод барилгын компаниуд, татвар, гааль, шүүх бүх төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл орсон ажлын хэсэг байгуулаад зөвхөн энэ цаг үед хэрэгжих онцгой схемээр ажиллахгүй бол болохгүй. Үүний нэг тод жишээ байна. "Атрын III аян", Засгийн газарт баталгаа гаргаж пад пад трактор авч өгөөгүй бол хүмүүс авч чадахгүй байсан. Сүүний үйлдвэр ч гэсэн засаг авч өгөөгүй бол сэргэхгүй л байсан. Энэ бол төрийн зүгээс эдийн засагт орж байгаа интервэнц буюу хөндлөнгийн оролцоо. Энэнтэй адил арга л барилгын салбарыг сэргээнэ. Барилгын салбар уначихаад байхад банк хүү бодоод л байна. Гэтэл одоо бол хүү бодох эрх зүйн үндэслэл байхгүй. Буруу бодлогын улмаас барилгын компаниудаас өөрөөс нь болоогүй шалтгааны улмаас бий болсон нөхцөл байдал. Үүнийг олон улсад хүнд хэцүү нөхцөл гэж тодорхойлдог.



Энэ хүнд хэцүү нөхцлийн тодорхойлолтыг танхим гаргаж өгнө. Барилгын компаниудад гаргаж өгч байгаа. Ингэснээр тэр компаниудыг зээлийн хүүгийн өрнөөс чөлөөлнө. Сая үер усны гамшиг болоход ногоо тарьсан хүмүүс өртсөн. Тэр хүмүүс "одоо яахав дээ, зээлээ төлдөг л байх даа" гэж ярьж байна. Төлөх шаардлага байхгүй. Хүмүүс мэдэхгүй байна шүү дээ. Тэр хариуцлагаас чөлөөлөгдөнө. Яагаад гэвэл байгалийн гэнэтийн гамшиг болсон. Үүнийг хуулийн дагуу танхим гэрчилгээг нь гаргаж өгч байна. Өөр нэг жишээ. МАХН-байр шатсан. Тэгэхэд тэнд байсан компаниуд өртсөн. Энэ бол мөн л гэнэтийн гамшиг. Газар хөдлөлт, гал усны аюул гэх мэт. Энэ бүхнийг дэлхий дээр хөндлөнгийн байгууллага олгодог. Тэрэнтэй адил барилгын салбарынх гэнэтийн гамшиг биш ч гэсэн хүнд хэцүү нөхцөл буюу бодлогын өөрчлөлтөөс болж үүссэн хохирол. Банк үхчихгүй байх, барилгын компани үхчихгүй байх амь тариа хийх хэрэгтэй. Амь тариаг амь нь тасарсан хойно хийх хэрэггүй. Амьтай байхад нь хийх хэрэгтэй. Амь тариаг "доктор" Ерөнхий сайд ажлын хэсэг байгуулаад хийх хэрэгтэй байна даа.

**- Чөлөөт бүс байгуулна гээд хууль журам нь гарчихаад нэлээн хэдэн жил боллоо. Бас л нэг их ахицгүй байх шиг байх юм?**

**С.Дэмбэрэл:** - Энэ тухай 19 жил, миний санаж байгаагаар бараг 30 жил ярьж байна. Тэгээд чөлөөтэй бүс байхгүй байна. Бямбасүрэн гуай Ерөнхий сайд байхдаа улс орноо чөлөөтэй бүс болгож, эдийн засгаа либеральчлала гэж байсан. Гэхдээ ийм жижиг эмзэг эдийн засагтай орон асар хурдан либералчлах хэцүү. Гадны нөлөө даадаггүй. Тухайн үед Энхсайхан импортыг тэглээд хэцүү байдалд орж байсан. Дараа нь Жасрай гуай 1994 онд чөлөөт бүсийн үзэл баримтлалыг гаргаж байсан. Тэрнээс хойш түүх үргэлжлээд л явж байна. Одоо яахав Алтанбулаг, Замын-Үүдэд тохирсон зам, Транзит монгол хөтөлбөр гэх мэт юм ярьж л байна. Дан ганц төр чадахгүй ээ. Манайх чөлөөт бүсэд 40 га газар авсан. Түүнийгээ компаниудад хуваарилж байгаа. Орос Хятад гэсэн мөнхийн хоёр хөршийг холбосон, монголчуудад ашигтай тийм л зүйл хэрэгтэй. Чөлөөт бүс удаан боловч явж л байна. Чөлөөт бүс нэг их тулгамдсан асуудал биш, эдийн засгийн хямралаас яаж гарах вэ л гэдэг чухал байна. Тийм ч учраас би "эдийн засгийн хямралын эсрэг цаашид ямар арга хэмжээ авах вэ гэдгийг ярих хэрэгтэй" гэж албаар гурван удаа давтаж элсэн шүү дээ.

**- Цөмийн энергийн тухай хууль батлагдсан. Манай уранаа ямар замаар хэнтэй хамтарч ашиглавал зүгээр вэ?**

**С.Дэмбэрэл:** - Би мэргэжлийн хүн биш учраас мэдэхгүй байна. Ажиглаад байхад улс орнууд их зөв бодлого явуулдаг юм билээ. Тайширын усан цахилгаан станцыг хар л даа. 1500-2000 өрхтэй жижиг газар асар их хөрөнгө гаргах шаардлага байсан юм уу? Буруу шийдэл, буруу хөрөнгө оруулалтын том жишээ. Одоо тэрийг хөшөө болгон үлдээх хэрэгтэй. Хойч үе шоолог! Үүнтэй адил ураны чиглэлээр маш болгоомжтой хандахгүй бол Монгол бол жижиг эдийн засагтай орон. Тэр талаас нь бодож байгаа байх аа.

*Ш.Эрдэнэчимэг*

*2009 оны 08 дугаар сарын August 09.*

## **Жижиг, дунд бичил бизнесийн орчинг дэмжих санхүүгийн орчин үүсгэхийн тулд санхүүгийн секторт реформ хийх ёстой**

*Авлигын эсрэг парламентчдын хуралд С.Дэмбэрэл нарын гишүүд оролцоод иржээ. Тэд авлигын эсрэг монголын парламентчдын МОНПАК нэртэй бүлгэмийг байгуулаад байгаа аж. Энэ талаар болон цаг үеийн бусад асуудлаар УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлтэй ИНФО сонины сурвалжлагчийн хийсэн ярилцлага*

- Авлигын эсрэг парламентчдын хуралд суугаад ирсэн гэж сонслоо. Ямар туршлага судалж ирэв. Авлига хээл хахуульгүй орон болохын тулд ямар ямар ажлуудыг хийх хэрэгтэй вэ?

С.Дэмбэрэл: - Авлигын эсрэг парламентчдын ГОПАК гэсэн нэртэй олон улсын байгууллага гэж байдаг. Тэднийхээс зохион байгуулдаг 60-аад орны 500-аад төлөөлөгчид оролцсон Олон улсын хуралд анх удаа оролцоод ирлээ. Энэ хурлаар дэлхийн парламентчид нийлээд авлигын эсрэг тэмцэх хууль тогтоомжоо сайжруулдаг юм билээ. Өмнө нь манайхаас УИХ-ын гишүүд оролцож байсан юм байна. Тэгээд энэ олон улсын байгууллага орон болгонд салбаруудаа байгуулдаг. Манайд тэр нь байгуулагдаагүй байсан учраас бид ярилцаад авлигын эсрэг монголын парламентчдын МОНПАК нэртэй бүлгэм байгуулсан. Тэгээд саяхан 2013 онд хийх ажлынхаа төлөвлөгөөг гаргасан. Жишээлбэл авлига, аудит, бараа үйлчилгээ худалдан авалт, төсвийн хяналт шалгалтын тухай хуулиуд дээр нэмэлт өөрчлөлт оруулах асуудлууд байна. Засгийн газар Мөнгө угаахын эсрэг хууль боловсруулж байгаа юм билээ. Үүний ажлыг хэсэг орж ажиллана. Мөн парламентчдын ёс зүйн асуудал дээр анхаарч энэ тал дээр ямар ямар идэвхтэй үйл ажиллагаа явуулах хэрэгтэй вэ гэдэг дээр санал нэгдээд ажиллах гэж байна. Жишээлбэл, Төрийн бус байгууллагууд, Иргэний нийгмийн байгууллагууд энэ чиглэл дээр юу хийж байна, компанийн түвшинд юу хийж байна, ОУ-ын байгууллагуудад ажиллах НҮБ-ын Авилгын эсрэг концепцийн хэрэгжилт нь ямар төвшинд байна гэх мэтийн авлигын эсрэг бодитой үйл ажиллагаа явуулахаар 15 гишүүнтэй бүлгэм байгууллаа. Бүлгэм бол нээлттэй.

- Намрын чуулган хаалтаа хийсэн. Хаврын чуулган хүртэл ямар ажлуудыг хийхээр төлөвлөөд байна вэ?

С.Дэмбэрэл: - Юуны түрүүнд Эдийн засгийн байнгын хорооноос гурван хэсэг гараад хөдөө орон нутгаар явах юм билээ. Би Дархан, Эрдэнэтээр явж үйлдвэр объектуудтай танилцана. Мөн энэ хугацаанд Засгийн газрын шинэчлэлийн багцууд байгаа түүн дээр ажиллана. Миний цуглуулсан арван хэдэн нэмэлт өөрчлөлт оруулах хуулиуд байгаа тэр хуулиуд дээрээ мөн ажиллана.

- Аж үйлдвэрийн танхимаас энэ оныг “Зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулах бодлогыг дэмжих жил” болгон зарласан. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт инфляцийг нам дор түвшинд барьснаар зээлийн хүү буурна гэсэн. Танайх ямар замаар зэлийн хүүг бууруулах вэ?

**С.Дэмбэрэл:** - Худалдаа аж үйлдвэрийн танхимаас 2013 оныг “Зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулах бодлогыг дэмжих жил” болгон зарласан. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт зээлийн хүүг инфляцийг нам дор түвшинд барьснаараар буурна гэж яриад байгаа юм. Энэ бол биш. Инфляцийг нам дор төвшинд барих нь сайн. Гэхдээ банкны секторт өрсөлдөөн өрнөхгүй, зээлийн үйл ажиллагаанд банк бус санхүүгийн байгууллагуудыг оруулж өрсөлдөөн өрнүүлэхгүйгээр зээлийн хүү буурахгүй. Тийм учраас энэ талаас бодож зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулах бодлого нь инфляцийг онилох биш, эдийн засгийн өсөлтийг онилох хэрэгтэй. Эдийн засгийн өсөлтийг онилно гэдэг нь зүгээр эдийн засгийн өсөлт биш эдийн засгийн оролцоотой өсөлт юм. Эдийн засгийн оролцоотой гэдэг нь жижиг дунд бичил бизнесийн орчинг дэмжих санхүүгийн орчин үүсгэх юм. Санхүүгийн орчин үүсгэж өгөхийн тулд санхүүгийн секторт реформ хийх ёстой.

**- Санхүүгийн секторын реформууд нь Засгийн газрын мөрийн хөтөлбөр орсон байгаа байх аа?**

**С.Дэмбэрэл:** - Тэр нь зөвхөн үнэт цаасны тухай хууль биш. Энд хувийн тэтгэврийн сан, хөрөнгө оруулалтын сан даатгал гэх мэтийн маш олон зүйлүүд байгаа. Одоогийн байдлаар Монголын санхүүгийн секторын 95 хувийг зөвхөн банкууд. Тэгэхээр энэ 95 хувийг багасгаад бусад санхүүгийн секторуудын орон зайг нэмэгдүүлж өрсөлдөөн үүсгэж байж зээл авагч, үйлчлүүлэгч сонголттой байж зээлийн хүү бууруулах орчин бүрдэнэ. Тийм учраас энэ тэтгэврийн сан, хөрөнгө оруулалтын сан энэ бүхний чинь хууль эрхзүйн үндэс нь байхгүй. Хууль эрхзүйн үндсийг болгох хэрэгтэй байгаа юм. Энэ бол зөвхөн үнэт цаасны зах зээл биш. Үүнийг Монголбанк инфляцийг нам дор төвшинд барьснаар хийнэ гээд байгаа юм. Харин энэ талаас нь бодоогүй илүү өргөнөөр бодож зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулах бодлогыг дэмжих жил болгон зарласан.

**- ШӨХТГ, ОССК-аас орон сууцны нэг метр квадратын үнийг нэг сая төгрөгт багтаана гэсэн мэдэгдлийг хийсэн. Нэгэнт үнэ өссөн өнөөгийн нөхцөлд энэ хэр бодитой вэ?**

**С.Дэмбэрэл:** - Үүнийг би мэдэхгүй. Одоогоор орон сууцны санхүүжилтын схем нь ч гараагүй байна. Энэ бол О.Магнайгийн дангаараа гаргах шийдвэр биш. Үүнийг Засгийн газар, Эдийн засгийн хөгжлийн яам судалгаа хийж, байнгын хороогоор оруулж шийдэх асуудал. Манайхны нэг алдаа байна. Хүлээлт их үүсгэдэг. Одоо 100 мянган айлын орон сууц, хаус гээд л ярьчихдаг. Энэ бүхнийг бодит ажил болгоход наад талын хугацаа нэг жил. Энд хөрөнгө мөнгө, хүн хүч, бичиг баримтын зохицуулалт гээд жил гаруйн хугацаа орно. Гэтэл бид нарын үүсгэсэн энэ хүлээлт чинь “Өө эд нар худлаа ярьсан байна” гэсэн сөрөг хүлээлт болчихно. Ингээд реформ нь ч олигтой явдаггүй. Тэгэхээр энэ тал дээр жаахан болгоомжтой дуугарч баймаар байна. ОССК бол Төрийн эрхийг хэрэгжүүлэгч агентлаг, О.Магнайгийнх бол Хэрэглэгчийн эрх ашиг, шударга өрсөлдөөнийг хариуцдаг газар. Орон сууцны метр квадратыг тэдэд барина гэдэг бол барилгын компаниудын ажил бөгөөд төрөөс энэ чиглэлээр явуулж байгаа бодлогын хүрээнд төр нь татаас юм уу бусад хэлбэрээр орон сууцны метр квадратын үнийг нэг сая төгрөгт барих санхүүгийн болон бодлогын баримт бичгүүдийг гаргасан иж

бүрэн баримттай байж албажих ёстой. Түүнээс таалагдах гээд байгаа ч юм уу, баяртай мэдээг түрүүлж дуулгах гээд хуумгай зүйл хийж болохгүй.

- Ярилцсанд баярлалаа

П.Нансалмаа. info.mn. 2013 оны 02 сарын 13.

## Буруу хууль гаргачих гээд байх юм

*УИХ-ын 2012 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн Нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс:*

1. *Татварын мэргэшсэн зөвлөхийн цйл ажиллагааны тухай, Аж ахуйн цйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг,*
2. *Хадгаламжийн даатгалын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Хадгаламжийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг дээр*

С.Дэмбэрэл: - Би энэ хууль болон бусад хуулиуд дээр дандаа эсрэг санал өгөөд байгаа юм. *Нэгдүгээрт*, ямар тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод төвшинг хууль болгон дээр торгуулийн арга хэрэгсэл болгоод байна вэ? Өөр юм олддоггүй юмуу гэсэн асуулт байна.

*Хоёрдугаарт*, торгуулийн хэмжээнд интерваль тавьж өгнө гэдэг нь хээл хахуулийг бий болгох интерваль болчихдог. Өөрөөр хэлбэл, харж үзэх нөхцөл бий болчихдог. 200-250-ын дотор, 250-300-гийн дотор гээд тодорхой тоон дотор сонголт хийх боломж олгочихоор субъектив хандлага үүсгэх хөшүүрэг болчихоод байгаа юм. Тийм учраас энийг дан ганц 200 юмуу, эсвэл 250 гэж шууд заах нь дээр.

*Гуравдугаарт*, ерөөсөө энэ дөрвөн заалтыг бүгдийг хасаж болоогүй юмуу? Яагаад гэвэл энэ бол тухайн корпораци дээр нь үүсгэн байгуулагч нь төрийн хоёр байгууллага байгаа, арилжааны банкууд байгаа. Энийгээ дотоод дүрмээрээ зохицуулдаг ийм байвал болохгүй юу?

*Дөрөвдүгээр* асуулт нь, энэ хуулин дээр хараад байхад маргаан шийддэг ямар механизм байна вэ? Маргаан гарвал яах юм бэ? Үүсгэн байгуулагчдын хооронд, корпораци ба хадгаламж эзэмшигч, банк ба корпораци гэх мэтээр ингээд маргаан шийдэхэд ямар механизмаар шийдэх юм бэ гэсэн асуулт байна.

З.Энхболд: - С.Дэмбэрэл гишүүний асуултад Б.Жавхлан хариулъя.

**Б.Жавхлан:** - Энэ Байнгын хороон дээр бас яригдсан. Ижилхэн л хариулт байна. Аль болохоор өндөр тавьсан. Бусад Иргэний хууль болон бусад хуулиуд шийдвэр ноогдуулж байгаа тэр жишгээр 200-250 гэж. 250-500 гээд бусад хуулиудын жишгээр л оруулж ирсэн юм.

**З.Энхболд:** - С.Дэмбэрэл гишүүн болсон уу? Зөндөө л их юм асуусан. Өөрөө ажлын хэсгийн гишүүн юм байна шүү дээ.

**С.Дэмбэрэл:** - Ажлын хэсгийн гишүүн заавал ижил саналтай байх албагүй шүү дээ.

**М.Батчимэг:** -Би С.Дэмбэрэл гишүүний хэлсэн интервалийг яахаараа ингэж хол тогтоодог юм бэ гэдгийг бас дэмжиж хэлмээр байна. Энэ бол үнэхээр авлига, хээл хахуулийг гааруулдаг нэг л хүчин зүйл. Энэ дээр тайлбар авмаар байна.

**С.Дэмбэрэл:** - Ажлын хэсэг гээд яахав. Та нар буруу хууль гаргачих гээд байх юм. Ийм юм байна. Хэрэв албан тушаалтанд хариуцлага тооцох гэж байгаа бол энэ хуульд ямар ч хамаа байхгүй. Корпораци ч ялгаа байхгүй. Захиргааны хариуцлагын тухай хууль байна. Хэн нэгэн албан тушаалтан ямар нэгэн гэм гаргавал тэрэнд хариуцлага тооцдог олон хуулиуд байж байна. Эрүүгийн хууль ч бас байж байна шүү дээ. Тэгэхэд дээр нь энэ хуулин дээр тухайн корпорацийн ажилтны тухай хуульчилж өгөх гээд байгаа нь буруу. Тийм учраас энийг хас гэж би хэлээд байгаа юм шүү дээ. Бүгдийг нь хасчих.

**З.Энхболд:** - С.Дэмбэрэл гишүүн, энийг хаслаа гээд 100-150 чинь үлдэнэ шүү дээ. Ерөөсөө хасагдахгүй. Энэ хуулиа дуусгаад, үүний дараа Гаалийн тухай товчхон хууль байгаа. Экспорт, импортыг хөнгөвчилдөг. Тэрийгээ дуусгаад завсарлая. Одоо 18 цаг 10 минут болж байна. Гаалийн жижигхэн хуулиа. Цаг сунгачихъя. 45 дугаар саналаар санал хураая. Хуучин хууль дээр бага байсан торгуулийг нэмж байгаа юм байна. Шинээр оруулж байгаа. Хоосон кнопууд, унаж магадгүй болчихлоо.

**Ц.Даваасүрэн:** - Энэ хуулийг би буцаамаар байна.

**З.Энхболд:** - Өдөржингөө санал хураачихаад уу? Санал хураалтад 41 гишүүн оролцож, 17 гишүүн зөвшөөрч, 41,5 хувийн саналаар 45 дугаар санал унаж байна.

## **Худлаа төсөөлөл оруулж иржээ**

*Монгол Улсын Их Хурлын 2013 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сарын 16-ны өдөр (Пүрэв гараг)-ийн нэгдсэн хуралдааны гар тэмдэглэлээс: “Монгол Улсын 2014-2016 оны төсвийн хүрээний мэдэгдлийн тухай” хуулийн төсөл хэлэлцэх цээр*

**С.Дэмбэрэл:** - За баярлалаа. Энэ бол харахад, хуулийн хүрээнд хийгдсэн, их томоотой мэдэгдэл, төсвийн төсөөлөл байна. Гэхдээ би эднийг бүгдийг нь худлаа гэж харж байна. Яагаад гэвэл энэ дээр задаргаа алга. Дээр нь хэрэв ДНБ-ний бодит өсөлтийг 3 жилээр төсөөлөөд тооцоолсон юм бол ҮНБ энэ хоёрын зөрүү нь ямар хүчин зүйлээс болсон бэ гэсэн анализ нь алга. Дээр нь уул уурхайн бус эдийн засагт бүтээгдэж байгаа нийт цэвэр өртөг буюу

үндэсний орлогын хэмжээ уул уурхайн болон уул уурхайн бус сектороор ялгасан юм алга. Би Ч.Улаан сайдаас ганцхан асуулт асуух гэсэн юм. Бас, Төсвийн байнгын хорооноос нэг асуулт асууна. Хэрэв та инфляцийг ингээд, 6 хувь гэсэн төсөөлөл байгаа юм бол надад бас нэг төсөөлөл хэлж өгнө үү. Хонь, үхрийн цул болон ястай махны 1 килограмм нь 2014, 2015, 2016 онд таны төсөөллөөр хэд байх бол гэсэн нэг ийм асуулт байна. Төсвийн байнгын хорооны даргаас асууя. Би андуураагүй бол Төсвийн тухай хуулийн 12-ын хэд билээ дээ, энэ төслийг оруулж ирэхдээ мөнгөний агрегатууд болон бусад макро эдийн засгийн тооцоонуудтай хамт, дүн шинжилгээтэй нь хамт орж ирж байгаа юм. Та энийг хууль зөрчиж байна гэж үзэж байна уу, үгүй байна уу гэсэн асуултад хариулж өгнө үү. Баярлалаа.

**З.Энхболд:** - Эхлээд Ч.Улаан сайд, дараа нь Ц.Даваасүрэн дарга.

**Ч.Улаан:** - За баярлалаа. С.Дэмбэрэл гишүүний асуултад хариулъя. Төсвийн хүрээний мэдэгдлийг та бүхэнд хэлэлцүүлж байна. Үндсэн чиглэлийн төсөөллийг ирэх долоо хоногт Эдийн засгийн байнгын хороон дээр хэлэлцэхээр ингэж бэлтгэж байгаа юм билээ. Тэгэхээр энэ одоо өсөлтийн задаргаа, тооцоо, түүнд нөлөөлсөн хүчин зүйлийн дүн шинжилгээ, төсөөллийн асуудал бол тэр хүрээнд нэлээн дэлгэрэнгүй яригдах байх. Яригдана гэж бодож байна. Энэ үндсэн дээр гарсан төсвийн хүрээний мэдэгдлийн гол тооцоо үндэслэлийг бид нар одоо Эдийн засгийн хөгжлийн яамнаасаа аваад түүнд нь тааруулж одоо төсвийнхөө хүрээний мэдэгдлийн тооцоо үндэслэлийг хийсэн юм. Инфляцийн хувьд бол 6 хувьд одоо барих бололцоотой. Энэндээ чиглэсэн бодлогоо явуулъя гэж төсвийн хүрээний мэдэгдэл дотор орж ирсэн байгаа. Энэ маань мөн л нөгөө Эдийн засгийн хөгжлийн төсөөллөөсөө урган гарсан. Яг хонь, үхрийн махны үнийн төсөөллийг би одоо шууд өгч чадахгүй байна. Салбар хариуцсан сайд маань илүү өргөн хүрээтэй харж байгаа. Дээрээс нь энэ үнэ тогтворжуулах хөтөлбөр, мөн энэ тодорхой бүтээн байгуулалтын төслүүдийн явц үр дүнтэй уялдуулаад төсвөөс өгөх урамшууллын дэмжлэгтэйгээ уялдуулж байгаад ингээд одоо салбар хариуцсан сайд маань илүү оновчтой хэлэх байх гэж би хувьдаа бодож байна. Ингээд Х.Баттулга сайдыг хариулж өгөөсэй гэж хүсэж байна. Баярлалаа.

**З.Энхболд:** - Ц.Даваасүрэн гишүүн.

**Ц.Даваасүрэн:** - С.Дэмбэрэл гишүүний хоёр дахь асуултад хариулъя. Тэгэхээр таны яриад байгаа одоо бас мэдээллийн хувьд учир дутагдалтай байна гээд байгаа зүйл бол Байнгын хороон дээр хөндөгдсөн. Ер нь Төсвийн тогтвортой байдлын хуулийн 4 дүгээр бүлгээр бол тодорхой зааж өгсөн юм. Төсвийн хүрээний мэдэгдэл гэж одоо юу байх вэ гэж. Тэгэхээр энэ дээр бол нэг заалт нь л яг хэрэгжчихээд байгаа юм. 12.1 нь. Нөгөө тусгай шаардлага, үзүүлэлтүүдийг оруулж ирсэн юм. Харин 12.3-т байх төсвийн хүрээний мэдэгдлийн агуулгуудыг оруулж ирэх асуудал бол учир дутагдалтай байгаа. Тийм учраас би бас хэлбэрдсэн хандлагатай гээд гишүүдийн хэлээд байгаатай нэг талаасаа санал нэг байгаа юм. Цаашдаа бид энийг засах ёстой. Жишээлбэл, ийм ийм зүйлүүд байх ёстой юм. Ер нь нэг ном шиг л юм орж ирэх ёстой. Макро эдийн засгийн тогтвортой байдал, төсвийн бодлогын төлөвлөлтийн талаар хийсэн дүн шинжилгээг оруулж ирсэн байх ёстой. Хэрэглэсэн аргачлал, тооцоолол, үндэслэлүүдийг нь оруулж ирсэн



байх ёстой. Мөн 2 жилийн төсвийн төлөв байдлыг хамааруулсан тооцоо, ДНБ, хэрэглээний үнийн төвшин, мөнгөний бодлогын үндсэн үзүүлэлт, ажил эрхлэлт болон ажилгүйдлийн төвшин, төлбөрийн тэнцэл, гадаад худалдааны урсгал тэнцлийн талаарх макро эдийн засгийн үзүүлэлтүүд мөн бас орж ирсэн байх ёстой. Тооцоо судалгаатай. 12.3.7-д байгаа болзошгүй өр төлбөр, өрийн шинжилгээний асуудал бол яах харьцангуй одоо энэ дурдсан агуулгууд дотроо арай мэдээлэлтэй зүйл орж ирсэн байгаа. Өрийнхөн бол энэ дээр арай тодорхой мэдээллүүд ирүүлсэн. За бусад зүйлүүд дээр бол одоо гишүүдийн хэлээд байгаа мэдээлэл дутагдалтай байна гэдэгтэй би санал нэг байна. Цаашдаа бол энийгээ анхаараад ялангуяа энэ хэлэлцүүлгийн явцад энэ төсвийн тогтвортой байдлын хуулийн 12.3-ыг хангах арга хэмжээ авах хэрэгтэй. Тэгж байж бид нар энэ хэлэлцэх эсэхийг дэмжсэний дараа төсвийн хэлэлцүүлгийг хийх ийм шаардлагатай болоод байгаа юм. Тэгэхээр зөрчсөн гэх нь юу юм. Ер нь бол зарим материалууд бол зарим мэдээллүүдийг нэмж авах шаардлагатай байна, дутагдалтай байна гэж хэлэх байна.

### **Өөрсдийгөө хүндлэх юм уу эсвэл ингэж үхэр шиг хөтлүүлээд явах юм уу**

*Улсын Их Хурлын 2013 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 24-ний өдөр /Баасан гараг/-ийн чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс: Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийн цээр*

С.Дэмбэрэл: - Өчигдөр Байнгын хорооны хуралд дээр яг энэ асуудлаар саяын С.Бямбацогт гишүүний хэлдэг шиг ийм утга агуулгатай зүйлийг зарим гишүүд, үүний дотор би бас хэлсэн. Зарчмын зөрүүтэй нэг санал гаргасан. Тэр нь юу вэ гэвэл ийм байдлаар энэ бодлогын баримт бичгийг батлах гэж байгаа байдлыг “халтуризм” гэж нэрлэдэг. Тийм учраас, энийг ингэж болохгүй ээ. Ер нь сүүлийн үед Улсын Их Хурал дээр эдийн засаг, нийгмийн чухал ач холбогдолтой, түүний дотор үндсэн чиглэл гэх мэтийн ийм баримт бичгийг Байнгын хороод болон Нэгдсэн чуулган дээр хэлэлцэж байгаа байдал нь Улсын Их Хурал аажмаар өөрөө өөрийгөө, сайн дураараа, ажлаас чөлөөлөх гэж байгаа ч юм шиг, эсвэл аажмаар Засгийн газрынхаа мэдэлд орж байгаа ч юм шиг ийм сэтгэгдэл төрүүлж байгаа юм. Энэ нь хэд хэдэн баримт бичгийг хэлэлцэж байгаа байдал, гаргаж байгаа шийдвэр зэргээс тод харагдаж байна.

Би эндээс нэг юм гайхаад байна. Улсын Их Хурлын гишүүн хүний хэлсэн энэ санал бодол агаарт замхраад байх юм. Протоколд тусгагддаг мөртлөө, үйл ажиллагаа болж цаашаа хэрэгждэггүй ийм сонин, гажиг маягийн механизмыг бид хэзээ өөрчлөх юм бэ? Бид хэзээ энэ улсыг дөрвөн жилээр нэг удаа батлаад, жил, жилдээ тодорхой асуудлуудыг араас нь биш, явцынх нь дунд авч хэлэлцэж, сайжруулж байдаг тийм механизм руу

орох юм бэ? Энийг хэн санаачлах ёстой юм бэ? Үндсэн чиглэлийг хэлэлцэж байх явцад ажлын хэсэг байгуулсан гэж байна. Ажлын хэсэг нь болохоор бидэнд санал байхгүй гэж байна. Энэ юу гэсэн үг юм бэ? Яагаад санал байдаггүй юм бэ? Маш олон хүн санал бодлоо хэлээд байхад тэр бүхнийг тусгаад, оруулж ирж байгаа бичиг баримтандаа нэмж хийгээд, чиглэлээ боловсруулаад ингэчих бүрэн боломж байна шүү дээ. Харсаар байтал. Энийг яагаад хийхгүй байгаа юм бэ? Яагаад жишээлбэл, инфляцийг дараагийн жилүүдэд 6 хувьд барина гэхэд бүгд энд үнэмшсэн юм шиг дуугүй суугаад байна? Яагаад энэ чиглэлээр бодлогын ямар алхам хийж, яаж барих юм бэ, 2006 оноос хойш хэзээ ч ингэж барьж үзээгүй шүү дээ гэсэн бодит амьдралын практик байхад энэ дээр яагаад бүгдээрээ дуугүй суугаад байдаг юм бэ? Энэ ийм амархан ажил юм уу? Их Хурлын гишүүний ажил гэдэг чинь.

Тийм учраас би бүгдэд чинь хандаж хэлж, асууж байгаа юм. Их Хурлын гишүүдээс. Та бүхэн одоо кнопоо дарна. Өгч байгаа хариулт чинь тэр болно. Өөрсдийгөө хүндлэх юм уу, эсвэл ингэж үхэр шиг хөтлүүлээд явах юм уу? Ийм асуултыг энд сууж байгаа бүх хүмүүсээс асууя. Яагаад гэвэл бид энд Монгол улсын хөгжлийг ярих гэж, гүйцэтгэх засаглалд зөв бөгөөд цаг хугацаанд нь оновчтой хяналт тавих гэж бодлогын урагш харсан баримт бичгүүдийг гаргах гэж энд сууж байгаа гэж би ойлгож байна. Тийм ч учраас энэ чиглэлээрээ ч ажиллаж байгаа. Ийм байдлаар ингээд ажлыг халтуурдсан байдлаар цаашаа яваад байвал энэ чинь 2014 он боллоо шүү дээ. Дөрвөн жилийн хагас нь боллоо. Гэтэл тэр мөрийн хөтөлбөрт заагдсан чухал, чухал бодлогын баримт бичгүүд ерөөсөө орж ирэхгүй байна. Орж ирсэн ч гэсэн маш муу чанартай юмнууд орж ирж байна. Энэ бүхнийг чинь засаж залруулаад хийх ёстой шүү дээ. Энийг та бүхнээс бүгдээс нь асуух гэсэн юм. Надад Байнгын хороо болон Батбаяр сайдаас асуух зүйл алга. Баярлалаа.

**З.Энхболд:** - С.Дэмбэрэл гишүүн үг хэллээ. Бүх гишүүд хариулах боломжгүй, зөвхөн Байнгын хорооноос асууна. Гишүүд асуулт авч, хариулт дууслаа. Байнгын хороо төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасан байна. Горимын саналыг дэмжье гэдгээр санал хураая.

Санал хураалтад 50 гишүүн оролцож, 28 гишүүн зөвшөөрч, 56.0 хувийн саналаар горимын санал дэмжигдэж байна. Горимын санал дэмжигдсэн тул тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томгёоллоор санал хураая.

Санал хураалтад 50 гишүүн оролцож, 31 гишүүн зөвшөөрч, 62.0 хувийн саналаар дэмжигдэж байна. Тогтоолын төсөл батлагдлаа. Гишүүдэд баярлалаа.

**Ц.Нямдорж:** - Юунд нь баярласан юм бэ. Хариуцлагагүй байсандаа баярлаж байгаа юм уу?

**З.Энхболд:** - Энд баярлалаа гээд биччихэж, тэрийг л уншиж байна. Таныг дарга байхад бас ингэдэг л байсан байх, бодоход.

## **Төрийн бүтэц намуудын бие бие рүүгээ дайрдаг тийм технологи, үзүүлэлт болж болохгүй**

*Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар сарын 07-ны өдөр (Мягмар гариг)-ийн хуралдааны гар тэмдэглэлээс: Монгол Улсын хууль тогтоомжийг 2016 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх цээр.*

**С.Дэмбэрэл:** - 1997 оноос хойш энэ гүйцэтгэх засаглалд автсан, нутагшуулсан яам болон түүнтэй холбогдсон бүтцүүд болох тохируулах, хэрэгжүүлэх агентлагууд гэсэн харилцаа. Сүүлийн үед төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэг ийм нэг сонин юмнууд бас бий болоод байна. Төрийн бүтцэд маань ингээд хэвшээд, тогтоод явж байсан, тэгэхээр манай эндээс шийдвэр гаргах ёстой. Цаашдаа энэ тогтоц хэвээр явах юм уу? үгүй юм уу? Засаг болгон дээр л өөрчлөгдөж байх ёстой юм уу? Тэгээд энэ чинь юуг харуулаад байна вэ гэхээр, хэрэв үүнийгээ цаашаа авч явна гэвэл энэ нь өөрөө хуульчлагдаад, тэгээд эрх барьж байгаа намуудын бие бие рүүгээ дайрдаг тийм технологи, үзүүлэлт болж болохгүй. Танайх олон болголоо, манайх цөөхөн болголоо гэсэн ийм маргааны үзүүлэлт болгож болохгүй. Төрийн энэ институциудын бүтэц бол маш тогтвортой, хэнд ч ойлгогдохуйц зохистой хэмжээнд тогтоогдсон байх ёстой. Яагаад гэвэл энэ улсын чинь эдийн засаг өснө, тэгэхдээ энэ маань агентлагуудыг нэмээд бай гэсэн үг биш, бас хасаад бай ч гэсэн үг биш, *нэгдүгээрт*.

*Хоёрдугаарт*, энэ зохицуулах, хэрэгжүүлэх агентлагуудыг бас одоо сүүлийн үеийн хандлага, тэр шууд ардчилал гэж яриад байгаа. Төр, хувийн хэвшлийн, төр, иргэний нийгмийн хоорондын диалог болон түншлэлийн асуудал энэ бүхэн маань хуулиудад, энэ чиглэлийн юмнуудад бас сайн тусгагдаагүй, уялдаагүй байгаа. Тийм учраас би түрүүн жишээ хэлж байсан. Сумын төсвөө чи мэднэ гээд иргэдийг хэлж байна. Гэтэл сумын төсвийг яаж захиран зарцуулах талын төрийн бүтэц нь байж байна. Энэ хоёрын хоорондын харьцааг жишээлбэл, цаашдаа яах юм бэ? Төлөөллийн болон шууд ардчиллын зохистой харьцаа цаашдаа энэ төрийн институциуд дээр яаж тусах юм бэ гэсэн иймэрхүү засаглалынхаа бүтцийг эргэж хараад, бодоод, ярилцаад тодорхой шийдвэр гаргах ёстой байх гэсэн утгаар хэлж байгаа юм.

**Ч.Сайханбилэг:** С.Дэмбэрэл гишүүний тайлбарыг сонслоо. Ерөнхий санаа, концепцийг хүлээн зөвшөөрч байгаа юм. Ингэж хийж болно. Би гэхдээ ерөнхий явах гэж байгаа процедур нь зөв үү, үгүй юу гэдэг дээр л жаахан эргэлзэж байна. Яагаад гэхээр шууд хууль тогтоох засаглал маань өөрөө санаачлагаараа ингээд гүйцэтгэх засаглалынхаа юмыг аваад ийм байх ёстой гээд ингээд шууд тогтоогоод өгөх нь дахиад нөгөө засаглал хуваах онолоороо, элдэв юмаараа хэр харагдах вэ? Тийм учраас Их Хуралтай холбоотой, шууд ардчилалтай холбоотой энэ юмнуудаа Их Хурал өөрөө хийгээд, С.Дэмбэрэл гишүүн тодорхой саналууд байвал өгөөд, энэ саналаа гүйцэтгэх засаглалын хувьд ийм байх нь зүйтэй гэдгээ Засгийн газар уг нь

өөрөө барьвал зөв явах байх. Шууд эндээс тогтоогоод өгөхөөр чинь засаг хоорондын бие биетэйгээ тэр юм руу нэлээн эдрээтэй сонсогдохоор байна.

**Су.Батболд:** Төрийн захиргааны төв байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын асуудал, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний асуудал гээд дандаа анхаарал татдаг. Би бодохдоо ингэж боддог юм. Жишээлбэл, Монгол Улс жижигхэн эдийн засагтай жижиг орны хувьд бол яамдын тоог хэт их байлгаж болмооргүй санагддаг юм. Манайх ингээд Засгийн газар шинээр байгуулагдангуутаа яамдынхаа бүтцийг гаргаж ирдэг. Үгүй бол үүнийг бүр хуульчлаад тэдэн яам байна гээд. Уг нь онолынхоо хувьд ийм л дээ. Тухайн Ерөнхий сайд гарч ирэхдээ эдийн засгийн байдлаа хараад, юугаа тэргүүн ээлжинд тавьж байгаа юм бэ, ямар юмандаа ач холбогдол өгч байгаа юм бэ, түүнийх нь хүрээнд тухайн Ерөнхий сайд хоёр хүртэл яамыг шинээр байгуулах буюу тэргүүн ээлжинд бий болгох асуудлыг, бусад тохиолдолд яамдын бүтэц нь хэвээрээ байдаг тийм тогтолцоонд орохгүй бол нэг Ерөнхий сайд гарч ирээд хэдэн сар ч болдог юм бэ? 5 сар ч бай, 8 сар ч болдог бай, дараагийн Ерөнхий сайд гарч ирээд дахиад л яам бужигнаж байдаг ийм байдлыг халах бололцоо бүрдэх юм шиг байгаа.

Хоёрдугаарт, С.Дэмбэрэл гишүүнийх дээр хоёр санаа хэлье гэж бодоод байгаа юм. Ер нь бид нар 20 жилийн туршид энэ бүтцээр яваад ирсэн. Тэгэхдээ энэ бүтцийг зөвхөн шинэ Зеландын ч гэдэг юм уу, санхүүгийн удирдлага, менежментийн шинэ тогтолцооны юм гэж бас үзэж болохгүй юм байгаа. Ерөнхийдөө хуучин тогтолцооны үеийн аж ахуйн яамнаасаа бодлого руу шилжээд, бодлогын хэрэгжилтийг хангахын тулд тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг гэсэн тэр бүтцээ ерөнхийд нь авч явмаар юм шиг байгаа юм. Харин саяны шинэ Засгийн газар бол үүнийг нэлээн алдагдуулаад, улсын үйлдвэрийн газар болгоод, яамдын тоог нэмж байгаа нэрээр, энэ тогтоож ирсэн юмаа алдагдуулаад байгаа юм. Уг нь бид нар нэгэнтээ яваад ирсэн, энэ зах зээлийн орнуудад хэрэгжиж байдаг энэ бүтцийг цааш нь хадгалж явах зайлшгүй шаардлагатай юм. Энэ утгаар нь би энэ тогтоолыг маш сайн боловсруулаад, Засгийн газар, Улсын Их Хурлын ажлын хэсэг байгуулагдаж, судлаачдыг оролцуулж байгаад батлах нь зүйтэй.

Хоёрдугаарт, би энэ тогтоол дээр юу анхаарах ёстой вэ гэхээр, энэ уялдаа холбоо байгаа юм. Жишээлбэл, Ерөнхийлөгчийн институци, гүйцэтгэх засаглал, хууль тогтоох засаглал, энэ гурвын чинь хоорондын уялдаа холбоо нь хэр зэрэг байгаа юм бэ? Ерөнхийлөгчийн засаглалаас парламент руугаа ч гүйж ороод, Засгийн газар руу ч гүйж ороод байх юм уу? эсхүл парламент нь Засгийн газрын эрх мэдэл рүү давхиж ороод, чи үүнийгээ тэгж хий, түүнийгээ ингэж хий, би түүнийг чинь очиж шалгана, энэ чинь ч буруу байна гээд байх энэ хоорондын механизм Монголд их сул байгаа юм. Энэ механизмыг илүү боловсронгуй болгохын тулд сонгодог парламентын засаглалтай болох ёстой юм уу? тэр дотор Ерөнхий сайдын эрх мэдэл нь ямар байх ёстой вэ гэсэн энэ юмаа харах талаас нь илүү ажлын хэсэг байгаад тогтоолын төсөл байх юм бол дэмжиж байна.

**С.Дэмбэрэл:** Ерөнхийдөө энэ Их Хурлын энэ хороог бол Монгол Улсын төрийн аль ч түвшний институциудын асуудлыг оруулах хэрэгтэй гэж би ойлгоод энэ асуудлыг би оруулж байгаа юм, нэг талаас.

*Нөгөө талаас*, ер нь засаглалынхаа хэлбэрийг тест хийсэн хэлбэрээр, үе үе ингэж эргэж харж, энэ юу нь болж байна, юу нь болохгүй байна вэ гэдгийг төрийн байгуулалтын талаас нь харж байх ёстой гэсэн хоёрдугаар аргумент.

*Гуравдугаарх нь*, яг өнөөдрийн системийг хараад байхаар их хэцүү, олон шат дамжлагатай, хамгийн гол нь маш их цаг хугацаа авдаг ийм засаглал байгаад байна. Энэ тухайн тэнд ажилладаг хүнээсээ гэхээсээ илүү, хууль эрх зүйн хувьд баталгаажуулсан энэ хуулиудаас хамааралтай гэж үзээд байгаа юм. Ганц жишээ хэлэхэд, Засгийн газрын худалдан авалт нь хуульд заасан хэмжээнээс 50-700 хоногоор хоцорч байна,. Энэ чинь арын ажлыг алж өгч байна шүү дээ.

**Ж.Батзандан:** Захиргааны шинэтгэлийг цогц утгаар нь ярихгүй бол болохгүй байгаа юм. Захиргааны шинэтгэл гэхээр Засгийн газар өөрийгөө ярьж байна гэж ойлгоод байх шиг байгаа юм. Засгийн газар, төрийн захиргааны, нийтийн захиргааны төв байгууллага гэдгийг ойлгож байгаа. Тэгэхдээ Улсын Их Хурал бол төр, нийгэм, эдийн засгийн бүхий л асуудлыг өөрийнхөө эрх мэдлийн хүрээнд, бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэлэлцэх эрхтэй байгууллага. Засгийн газар нь, захиргааны эрх зүйн хуулиуд нь өнөөдөр Монголын хөгжилд садаа болоод байна гэдгийг бид ойлгож байгаа. Хүнд суртал хаанаас эхтэй байгаа вэ? захиргааны байгууллагаас, авлига хаана байгаа вэ? захиргааны байгууллагад байгаа. Захиргааны хурд гэж “0”. Ийм л байгаа. Тэгэхээр Засгийн газар өөрөө энэ захиргааны шинэчлэлийн асуудлаа яаралтай оруулж ирэхгүй бол Улсын Их Хурал зүгээр хараад сууна гэж байхгүй ээ. Засгийн газрыг бид шахна. Засгийн газарт илүү хурдтай ажиллах, хүнд сурталгүй ажиллах, нээлттэй ажиллах, хүний төлөө ажиллах, авлигаас ангид байх тэр бололцоо боломжийг нь хангаж өгөхийн тулд бид Улсын Их Хурал бол реформын саналыг хууль батлах замаар, энэ захиргааны бүтцийг өөрчилж, шинэчлэх асуудлыг хөндөж тавихаас өөр аргагүй гэж би ойлгож байгаа. Өнөөдөр хуулийн төсөл боловсруулаад Засгийн газарт өгөхөд 30 хоног дарж хэвтдэг. Яг 30 хоногийг нь болгоод л өгч байх ёстой. Уг нь 7 хоногийн дотор өгчих бололцоотой л юм байгаа. Засгийн газарт чиглэл өгч байгаа тогтоолын төслийг заавал Засгийн газраас асуудаг системээр л яваад байгаа. Ийм маягаар манай төрийн үйл ажиллагааг гацаадаг, удаадаг, энэ захиргааны хууль, дүрэм, журмуудаа бид эргэн харах ёстой гэж ойлгож байгаа.

Бакей гишүүн ээ, та Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, наад захиргааны эрх зүйн хууль дүрмүүдээ харахгүй бол хоорондоо зөрчилдсөн. Аж ахуйн нэгжийн тухай хууль нь Татварын хуультайгаа очоод зөрчилдөнө. Татварын хуулийг нь бариад авахаар өөр бусад хуулиудтай очоод зөрчилдөнө. Засгийн газраас 200 гаруй хуульд өөрчлөлт оруулна гээд яриад байгаа. Үндсэн хуультайгаа очоод бүгдээрээ зөрчилдөнө. Гол бүхэн далайд цутгадаг гэдэг шиг, хууль бүхэн Үндсэн хуулиас эхтэй байдаг юм. Наад Үндсэн хуулиа эргэж харахгүй бол төрийн захиргааны том шинэтгэлийнхээ асуудлыг ярихгүй бол наад төрийн ажил чинь явахгүй байна. Ганц тендер шалгаруулах гэж 6 сар болж байгаа. Ганц сонгон шалгаруулалт хийх гэж 3 сар болж байгаа. Өнөөдөр аж ахуйн нэгжүүдийн ажил эхэлсэн юм ерөөсөө байхгүй. Мөнгө нь ч шилжээгүй, тендер нь сонгон

шалгаруулалтаа хийж чадахгүй, хоорондоо хэрэлдээд сууж байгаа, ийм л байгаа. Тэгэхээр наад захиргааны шинэтгэлийн асуудлаа бид хурдтай шуурхай ярихгүй бол зүгээр Засгийн газрыг хараад энэ явахгүй юм байна. Бид нэг л Засгийн газартай. Засгийн газрынхаа ажлыг сайжруулах нь, Засгийн газартаа хяналт тавих нь, ташуур өгөх нь энэ Улсын Их Хурлын ч үүрэг. Тийм учраас Улсын Их Хурал энэ Засгийн газрыг шахах чиглэлд, энэ реформыг нь дэмжих чиглэлд, ажлыг нь сайжруулах чиглэлд ярих ёстой. Би Ч.Сайханбилэг даргыг Улсын Их Хурлын гишүүн гэж ойлгож байна. Ганцхан засгийг төлөөлөхгүй. Тийм учраас Улсын Их Хуралтайгаа хамтраад энэ ажлаа эрчимжүүлэх чиглэлд явах ёстой. С.Дэмбэрэл гишүүний гаргаж байгаа саналыг би дэмжиж байгаа юм.

**А.Бакей:** Үндэслэлийг сонслоо. Үнэхээр төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, чиг үүргийн давхардал гэдэг ч юм уу? засаглалыг захиргааны ажлын менежментийг сайжруулах эрэлт хэрэгцээ байгаа. Үүнийг хэн ч гэсэн нүдний өмнө байгаа асуудал учраас энэ тогтоолыг гаргах нь Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал. Ингээд энэ саналыг дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 11-ээс 8 болж, дэмжигдлээ.

## **Хуулийг буруугаар ашиглаж болзошгүйд санаа зовж байна**

*Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын чуулганаар хаалттай хэлэлцэн баталсан. 2013 оны 6 дугаар сарын 1-ний дотор батлахгүй бол манай улс хар жагсаалтад орох байсан учраас ийнхүч яаран баталсан юм. Хуулийн талаар УИХ-ын С.Дэмбэрэлийн байр суурийг тодрууллаа.*

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн талаар та ямар байр суурьтай байна вэ. Дансандаа их хэмжээний мөнгөтэй байх нь мөнгө угааж буйн баталгаа болж чадах уу?

**С.Дэмбэрэл:** - Энэ асуудал миний санааг их зовоож байгаа. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэлэлцэх үед “Санхүүгийн мэдээллийн алба бие даасан, хараат бус ажиллаж чадах уу?” гэж би асуусан. Учир нь, уг хуульд бие даасан, хараат бус гэж заасан мөртлөө хэн нэгнээс хараат, Монголбанкны ерөнхийлөгчийн тушаал шийдвэрээр явдаг байх гэсэн заалт мөн орсон байгаа. Хэдийгээр бүтэц бүрэлдэхүүндээ хараат бус байгууллагыг оруулсан гэж байгаа ч надад эргэлзээтэй санагдсан. Энэ нь мөнгө угаахын эсрэг гэсэн нэрээр хувь хүний нууцад халдах боломж бүрдэнэ гэсэн үг. Тиймээс мөнгө угаахтай тэмцдэг байгууллагуудынхаа хараат бус, бие даасан байдлыг сайтар хангах ёстой. Гэвч уг хуульд энэ асуудлыг тусгаж өгч чадаагүй. Тухайлбал, энэ хэрэгтэй тэмцдэг байгууллага Монголбанкны “мэдэлд” байгаа цагт Монголбанк мөнгө угаахад яаж шалгах юм бэ?



- Хувь хүний дансан дахь хөрөнгөд 20 сая төгрөгийн босго тогтоож, хянах болсон нь хэт явцуу хэмээн иргэд шүүмжилж байна. 20 сая төгрөг босго болох хэмжээний мөнгө мөн үү?

С.Дэмбэрэл: - Хэн нэгний дансаар хоёр жилийн хугацаанд 10 гаруй удаа 20 сая төгрөгийн гүйлгээ хийгдэж л байгаа шүү дээ. Тэр бүхнийг шалгах нь зүйн хэрэг байх. Гэхдээ бид 1930-аад оны арга барил руу л яваад байх шиг. Хүнийг шууд барьж хорих, шүүхээр гэм буруутай нь тогтоогдоогүй байхад дайрч давшлах, нийтэд зарлах асуудал сүүлийн үед цөөнгүй гарч байна. Энэ явдлыг цэгцлэх ёстой. Хувь хүний нууцад халдаж болохгүй шүү дээ. Тиймээс хэзээ, хаана, хэнийг, ямар тохиолдолд шалгах вэ гэдгийг хуулиар нарийвчлан заах ёстой. Үгүй бол Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг буруугаар ашиглаж болзошгүй.

Р.ОЮУН 2013-06-07.

## **60 хувь нь тоть шиг давтсан зүйл байна**

*Улсын Их Хурлын 2013 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 27-ний өдөр /Пүрэв гараг/-ийн чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс: “Монгол Улсын 2012 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн анхны хэлэлцүүлэг дээр*

С. Дэмбэрэл: Баярлалаа. Аудитын газрын тайланг уншиж, сонсож байхад бол хэд хэдэн зүйл ажиллагдаж байна. Үүнд:

1. Аудитын тухай одоо байгаа энэ хуулиар энэ газрын бие даасан, хараат бус байдал нь бүрэн хангагдсан эсэх дээр эргэлзээ төрж байна. Зөвхөн аудит руу томилдог тогтолцоо биш, анализ, дүгнэлт, шинжилгээ хийдэг үйлчилгээ нь, чадвараа бэхжүүлдэг тал дээр нь хуулийн өөрчлөлт оруулах шаардлагатай. Энэнийг анхаараасай гэж хүсэж байна.

2. Бид маш их том том бүтээн байгуулалт ярьж байна. Энэ бол 2012 оных нь өөр засгийн газрынхан байсан гэж орхичих асуудал биш, 2014 онд бид нар энэнийг яриад л сууж байна. Өнөөдрийн байдлаар оруулж ирж байгаа шинжилгээний үр дүн нь 100% гэж үзвэл, 60% нь тоть байна. Тоть шиг давтсан зүйл байна. Тэдэн тэдэн хувиар биелэгдсэн гэхээсээ илүү, юу нь яагаад биелэгдээгүй вэ, тэрийг яаж биелүүлэх вэ, яавал биелэх вэ гэдгийг энэ анализ дүгнэлтэнд оруулж ирж байх хэрэгтэй. Энэ чиглэлээр ажиллаж байгаа хүмүүсийн чадавхийг сайжруулах, туршлагыг нь илүү авах замаар ингэж хийх ёстой юм шиг санагдаж байна. Анхаарах хоёрдугаар зүйл бол энэ.

3. Саяхан би 2 судалгаа хийлгэлээ. Засгийн газарт болон аудитын газарт хэрэгтэй судалгаа. Гэхдээ энэ бол та нарын сайн мэддэг, хүн болгон мэддэг судалгаа. Хагас сайнд, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлууд дотор цаашдаа энэ Засгийн газрын худалдан авалтанд өөрчлөлт оруулах тухай тендерийн замын зургийг гаргасан. Хэрэв тендерийн замын

зургийг өөрчлөхгүйгээр цаашдаа явна гэвэл 2013 онд тавигдсан зорилтууд чинь хамгийн өөдрөгөөр бодоход 50% л биелнэ. Тийм учраас энэ замын зургийн судалгааг, өөрсдийн гаргасан хуулин дээр байгаа тендерийн замын зургийн судалгаан дээр онцгой анхаараач. Хуулийн бууруугаас болж, Засгийн газрын худалдан авалтанд асар их хоцрол, хугацаа алдалт явагдаж байна. Үүний дараагийнх нь 15 хуудастай, бас нэг замын зураг байна. Энэ бол Засгийн газрын шийдвэр гаргах үйл явцын замын зураг гэдгийг судалж үзлээ. Нэг тогтоол гаргах гэж 2 сар болж байна. Зөвхөн Засгийн газар өөрөө тогтоол гаргах гэж 2 сар болж байгаа бөгөөд яамдад тогтоол боловсруулахаас авахуулаад эцсийн байдлаар засгийн газар хуралдаанд орох хүртэл нэг л зарлиг гаргах гэж 2 сар зарцуулж байх жишээтэй. Тэгэхлээр эндээс юу харагдаад байна гэхлээр, бид нарын хийх гэж байгаа ажил маань яаж хийх вэ гэсэн процесс дээр очиж гацаад, цаг хугацаа алдаад байна. Тийм учраас засгийн газрын шийдвэр гаргах процессийг хурдасгах, баримт эргэлтийг түргэтгэх тал дээр ерөнхий сайд та онцгой анхаараач. Цаашдаа энэ институтуудын хоорондын уялдаа, засаглалын шийдвэр гаргах процесс маань энэ төсөв эдийн засгийн бүх үйл ажиллагаанд хэр зэрэг садаа болж байна, эсвэл өөрөгөөр нөлөөлж байна уу гэдгийг харуулсан анализ дүгнэлтийг жил жилд гаргаж байх ёстой. Эцэст нь хэлэхэд, Төрийн байгуулалтын байнгын хорооноос сар гаруйхны өмнө УИХ-д ажлаа тайлагнадаг бүх байгууллагууд, тэдгээрийн үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх тухай аргачилал хүргүүлээд тогтоол гаргуулчихсан байгаа. Энэ дээр УИХ-д тайлагнадаг бүх байгууллагуудад үүнийг зайлшгүй мөрдүүлж, өөрсдийнхөө байгууллагад өөрсдөө болон өрөөлөөр системчилсэн анализ хийлгээд, түүнийгээ УИХ-д ирүүлж байвал, цаашдаа УИХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагааны чанарын түвшин нэг алхмаар урагшилна. Та бүхний үйл ажиллагаа ч бас нэг алхам урагшилна. Энэнийг анхаарч ажиллахыг хүсье. Баярлалаа.

### **Хөрөнгө оруулалтыг ижил хугацаагаар шахаж байгаа нь буруу**

*2013 оны 9 дүгээр сарын 20-ны “Хөрөнгө оруулалтын хуулийн төслийн хөрөнгө оруулалтын хэмжээ, хугацаа гэсэн хүснэгт бүхий заалтуудыг хэлэлцэх цээр:*

**С.Дэмбэрэл:** Бид л зөвхөн үүнийг ярилцаж байгаа юм биш. Энд хэвлэл мэдээлэлийнхэн байна. Олон түмэнд үүний утга учрыг зөв хүргэх давхар шаардлагатай байна. Тиймээс дараа дараагийн хэлэлцүүлэг дээр Ажлын хэсгийнхэн энэ бэлэн сайхан самбар дээр энэ хүснэгт, мэдээлэлээ гаргаад харуулж байх хэрэгтэй байна. Эс тэгвэл зөвхөн бид хараад, бусад нь зөвхөн сонсоод, хүний чихний чадвар шалгаад байж болохгүй. Харагдахуйц байдлаар бусдад үзүүлээд ярилцвал амар байхгүй юу. Аливаа хууль, загвар, ялангуяа ийм тооцоо, хүснэгт ярилцах үедээ дэлгэцэн дээр гаргадаг байвал сайн байна гэсэн санал байна.

**Гол санал маань**, энэ хүснэгтийн хувьд уул уурхай, хүнд үйлдвэр, дэд бүтэцийн салбарыг ингээд хольчихоор утга агуулгын хувьд эвгүй харагдаад байна. үүнийг салгаж харуулмаар байна. Жишээлбэл уул уурхайн салбарт 200 тэрбумаас дээш гэдгээс эхлээд тусад нь ялгарахуйц байх хэрэгтэй. Уул уурхай, дэд бүтцийн салбарт тогтворжуулах гэрээ, хөрөнгө оруулах хугацаа чинь бусад салбараасаа өөр байгаа. Тийм учраас үүнийгээ ангилж оруулаад, хугацааг нь ялгарахуйц байлга. Тухайлбал, уул уурхайн салбарт 3-30 тэрбумын хөрөнгө оруулалт болон 30-100 тэрбумын хөрөнгө оруулж байгаа хөрөнгө оруулалтыг ижил хугацаагаар шахаж байгаа нь буруу юм. Тийм учраас энэ капитал багтаамж ихтэй салбаруудаа тусад нь ялгаж өгвөл илүү ойлгомжтой бөгөөд утга агуулгын хувьд зүйтэй болно.

**Хоёрдугаарт**, хөрөнгө оруулах хугацаа гэж яг юуг хэлээд байгаа юм бэ? Эдийн засагт бол “хөрөнгө оруулалтын цикл буюу мөчлөг” гэсэн ойлголт бий. Энэ мөчлөгийн хугацааг хэлж байна уу? эсвэл анхны хөрөнгө оруулалт зэрэг өөр юм хэлж байна уу? Хөрөнгө оруулалтын мөчлөг дотор өмнөх, явцын, дараах хөрөнгө оруулалт гээд олон ойлголт, ухагдхуунууд бас бий. Хөрөнгө оруулалтын үе шатууд бий. Тэгэхээр энд эдгээр хөрөнгө оруулалтын аль үеийг нь хэлсэн бэ? Investment base буюу анхны хөрөнгө оруулалтыг хэлж байна уу? Тэр үед бол бүтээгдхүүн өгөхгүй. Хөрөнгө оруулалтын гол юмнууд нь дуусдаг боловч, хөрөнгө оруулалтын цикл дуусаагүй байгаа үе юм. Энэ бүхнийг яаж харгалзсан юм бэ? гэдгийгээ тодруулах шаардлагатай харагдаад байна. Үүнийг бид ярилцах ёстой шүү.

**Б.Гарамгайбаатар:** С.Дэмбэрэл гишүүний саналуудыг ойлголоо. Хүлээж авлаа. Би бас ангилах гэдэг дээр санал нэг байна. Техникийн боломж нь байгаа юм чинь дэлгэц дээр үзүүлэх нь ч бас зөв юм.

## **Эдийн засгаа идэвхжүүлэхийн тулд өрийн хэмжээг нэмж болно**

*2013 оны 10-р сард “Улс төрийн тойм” сонины сурвалжлагч Н.Санжаасүрэн УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлийг “Ярилцах танхим”-даа урьж, хийсэн ярилцлага:*

- УИХ өрийн хэмжээг ДНБ-ий 60 хувьд хүргэх Засгийн газрын саналыг хүлээж авсангүй. Гэвч Засгийн газар ойрын үед 2.1 тэрбум ам.долларын зээл авахаар судалж байна. Засгийн газрын зарим гишүүн бонд босгохгүй бол манай улсын эдийн засаг хүндэрнэ гэж ярьж эхэллээ. Ер нь одоогийн нөхцөлд ирэх онд бонд гаргах нь хэр оновчтой зүйл вэ?

**С.Дэмбэрэл:** - Би жилийн өмнө Монгол Улсын эдийн засаг “экономикс” гэдэг хэлбэрээс “бондономикс” хэлбэрт орлоо гэж ёжилж хэлж байснаа санаж байна. Өөрөөр хэлбэл, манай эдийн засаг зөвхөн бондоор тэжээгдэж байгаа учраас бондын зах зээлийг сайн судлах шаардлагатай байгааг л хэлсэн юм. Манай улсын зээлжих зэрэглэл тааруу байна. Энэ нь маш эрсдэлтэй болно гэсэн үг. Бондын жилийн өмнөх болон одоогийн нөхцөл нэлээд өөрчлөгдсөн. Үүнээс гадна гадаад зээл, өрийн харьцаа, өрийн үйлчилгээ

гээд ирэх жилүүдэд хүндрэл гарч болзошгүй. Гэхдээ Засгийн газар, УИХ нэг зүйлийг ойлгох хэрэгтэй. Манай улсын өрийн хэмжээ ДНБ-ий 40 хувь, 60 хувь байна гэхээс илүү эдийн засгаа ерөнхийд нь идэвхжүүлэхийн тулд яах ёстой вэ, бонд гаргах нь гадаад өрийн зохистой харьцаанд хэр зэрэг нөлөөлөх вэ гэдгийг сайн бодож тооцоолох хэрэгтэй. Тэр утгаар нь бодвол ирэх онд эдийн засгаа идэвхжүүлэх хэрэгтэй байна.

**- УИХ Хөрөнгө оруулалтын тухай хуулийг баталсан. Энэ нь эдийн засгийг идэвхжүүлж хөрөнгө оруулалтыг татахад хэр нөлөөтэй болсон бэ?**

**С.Дэмбэрэл:** - Хөрөнгө оруулалтын тухай хууль батлагдлаа гээд гадны хөрөнгө оруулалт хурдан хугацаанд нэмэгдэнэ гэсэн үг биш. Манай экспортын гол орлогыг бүрдүүлдэг түүхий эдийн зах зээл ирэх онд өөрчлөлтгүй байх шинжтэй байна. Энэ тохиолдолд эдийн засгаа идэвхжүүлэхийн тулд нэмэлт хөрөнгө шаардлагатай. Үүнээс өмнө одоо байгаа хөрөнгийнхөө хэмжээнд тааруулан хэмнэлт хийж чадаж байна уу, хөрөнгөө бүтээлч секторуудыг дэмжихэд зориулж чадаж байна уу гэдгийг бодох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл бизнесийг дэмжих зээлд хөрөнгө зарцуулж байна уу, эсвэл дан дэд бүтэц, зам барих ажилд хөрөнгө оруулж байна уу гэдэг харьцаа нь чухал. Энэ хоёрын хоорондын харьцаа зохистой байх ёстой. Дэд бүтэц болон үр өгөөж нь урт хугацаанд шууд болон шууд бус байдлаар эргэж нөхөгдөх зүйл рүү нийт хөрөнгийг оруулбал урсгал дансанд дунд болон богино хугацаанд эерэгээр нөлөөлөх, үр өгөөжөө түргэн өгөх төслүүдэд зарцуулах мөнгө дутна. Тиймээс хамгийн түрүүнд энэ хоёрын балансыг маш сайн тодорхойлох ёстой. Дараа нь ДНБ-нд эзлэх өрийн харьцааг нэмэгдүүлэх эсэхээ ярих хэрэгтэй. Манай улсын орлого ойрын зургаан сард нэг их нэмэгдэхгүй учраас бонд гаргаж болно гэж үзэж байна. Гэхдээ ингэхийн тулд одоо байгаа болон хойшид орж ирэх хөрөнгийг баялаг бий болгодог бүтээлч салбар руу илүү хандуулах, үр өгөөжөө илүү түргэн хандуулах төсөлд оруулах нь чухал. Энэ зарчмыг тохирч чадвал өрийн хэмжээг нэмж болно.

**- ДНБ-тэй харьцах өрийн хэмжээг нэмэгдүүлэхийн тулд УИХ-ын гишүүдийн гуравны хоёр нь санал өгсөн байх ёстой. Өр нэмэгдүүлж байгааг ялангуяа сөрөг хүчний гишүүд эсэргүүцэж байгаа. Ийм үед УИХ-ын гишүүд үүнийг зөвшөөрч кноп дарах болов уу?**

**С.Дэмбэрэл:** - Засгийн газар хэр зэрэг үндэслэл тооцоотой тайлбар өгөхөөс хамаарна. Бүтээн байгуулалтын төслүүдэд дахин хөрөнгө оруулах хэрэгтэй байна гэж яриад байвал дэмжихэд хэцүү байх. Тиймээс дунд болон богино хугацаанд үр өгөөжөө өгөх төслүүдэд зарцуулж байгаа хөрөнгө урт хугацаанд шууд болон шууд бусаар өгөөжөө өгөх төслүүдэд оруулсан хөрөнгийн хэмжээний алтан дундажийг олсон тооцоо судалгаатай тайлбар өгвөл УИХ хүлээж авна гэж бодож байна. Энэ бол цэвэр эдийн засгийн асуудал. Мэдээж хэрэг олон хүн өр зээлийн асуудалд санаа зовж байгааг ойлгож байна. Гэхдээ үүнийг зохицуулж болно. Яагаад гэвэл удахгүй өрийн тухай шинэ хуулийг УИХ батлах гэж байна. Одоогийн байдлаар Засгийн газар энэ хуулийн төслийг боловсруулж байгаа. Өрийн менежмент буюу өрийн хэмжээг хамгийн зохистой байдлаар удирдах, эдийн засгийн балансыг зохистой хэмжээнд авч явах боломжтой эрх зүйн орчин бүрдэх гэж байна.

**- “Чингис” бондын хөрөнгийн зарцуулалтын баланс ямар хэмжээнд байна гэж та хэлэх вэ?**

**С.Дэмбэрэл:** - Сайн биш байна. Би өнгөрсөн жил л хэлж байсан. Анх “Чингис” бондын хөрөнгө орж ирэхэд л жижиг дунд бизнес эрхлэгчдэд 200 сая ам.доллар хуваарилах ёстой байлаа шүү дээ. Тэгсэн бол өдийд олон бизнес эрхлэгчид ажлын байр бий болгож, бараа үйлчилгээний хангамж, нийлүүлэлт сайжирна. Ингэснээр эдийн засагт инфляцийн дарамтыг багасгах боломж байсан. Эдийн засгийн байнгын хорооны дэргэдэх Жижиг дунд үйлдвэрлэлийн дэд хороогоор энэ асуудлыг хэлэлцээд 500 сая ам.долларыг жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хуваарилах хэрэгтэй гэж хэлж байсан. 500 сая ам.доллар биш юм гэхэд ядаж 200 сая ам.долларыг Жижиг дунд бизнесийг дэмжих сангаар дамжуулаад өгсөн бол маш хэрэгтэй юм. Энэ нь зээлийн хүү буурахад ч нөлөөлнө. Уг нь одоо ч ийм боломж байсаар байна. Гэтэл бондын хөрөнгийг том төслүүдэд л зарцуулаад байгаа. Хэдийгээр томоохон төслүүдийг санхүүжүүлж байгаа боловч нийт эдийн засгаа бүхэлд нь харахаар олонхи болсон жижиг дунд бизнес эрхлэгчдэд өндөр хүүний дарамт, богино хугацаа садаа болсоор байгаа. Гэтэл Засгийн газар энэ ажлыг хийхгүй байна. Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлнэ гэж байсан. Ерөнхий сайд ч ингэж хэлсэн. Гэхдээ одоог хүртэл энэ ажлаа хийхгүй л байна.

**- Ирэх оны мөнгөний бодлогод энэ талаар заалт оруулсан биз дээ?**

**С.Дэмбэрэл:** - Тийм. Ирэх оны мөнгөний бодлогод жижиг дунд бизнесийн салбарын санхүүжилтэд төв банкны оролцоог хангах чиглэлээр тодорхой заалт оруулж өглөө. Өөрөөр хэлбэл аливаа хүндрэл, хямрал, бэрхшээлээс гардаг ганц арга нь бизнесийн идэвхжил. Бизнес нь идэвхтэй байхын хэрээр эдийн засаг идэвхтэй байна. Энэ нь нийт эдийн засгийн идэвхжилд нөлөөлдөг. Ингээд эдийн засгийн эргэлтийг хурдасгаж дотоод зах зээл дээр бараа бүтээгдэхүүний үнэ өсөхгүй байх нөхцлийг бүрдүүлж байдаг. Хэдийгээр оройтсон ч гэсэн энэ ажлыг хийх хэрэгцээ шаардлага нь одоог хүртэл байсаар байна. Ялангуяа ирэх онд энэ чиглэлээр дорвитой арга хэмжээ авахгүй бол эдийн засгийн хүндрэлтэй байдал гарна. Одоо ч гэсэн ийм хүндрэл гарч эхэлж байна. Ийм тохиолдолд манай эдийн засгийг Ерөнхийлөгчийн дарлагдсан ард хэмээн нэрлэсэн бизнесийнхэн л авч явдаг. Бизнесийн салбарынхандаа бондын болон бусад эх үүсвэрээс санхүүгийн тусламж үзүүлбэл зээлийн хүү буурах нөхцөл бүрдэнэ, бодит сектор идэвхжинэ. Ингээд бараа хангамж буюу нийлүүлэлт нэмэгдэнэ. Энэ нь үнэд нөлөө үзүүлнэ. Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн нийт үр дүн ингэж л гарах юм.

**- Одоогийн байдлаар бондын хөрөнгөөс хуваарилаагүй хөрөнгө байгаа шүү дээ?**

**С.Дэмбэрэл:** - Багахан хэмжээний мөнгө бий. Үүнийгээ л бизнес эрхлэгчдэд шууд өгчих хэрэгтэй. Би үүнийг ярилцлага болгондоо дурддаг. Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр болон Ерөнхий сайд бизнесийнхнийг дэмжинэ, мөнгө хуваарилна л гэдэг. Ер нь хүмүүсийн нийт эдийн засгаа харах өнцөг нь өөр байх шиг байна. Эдийн засаг аливаа шокийг даван гардаг ганц зүйл нь бизнесийн идэвхжил л байдаг. Бизнесийн идэвжлийг л сайжруулчихвал бүх зүйлийн шийдэл тэр болно.

- “Чингис” бондын дараагийн 3.5 тэрбум ам.долларыг зээлэхээсээ өмнө хөрөнгөө аль салбаруудад ямар харьцаатай оруулах вэ гэдгээ тооцох хэрэгтэй юм байна даа.

С.Дэмбэрэл: - Миний саяны хэлсэн байдлаар л зохицуулах хэрэгтэй.

- Өмнөх Засгийн газрын үед манай улс Японд “Самурай” бонд гаргах санал тавихад япончууд “танай эдийн засгийн нөхцөл байдал одоохондоо бонд гаргахад тохиромжгүй байна” гэсэн хариу өгч байсан гэдэг. Одоо удахгүй “Самурай” бонд гаргана гэж ярьж байна. Үнэхээр манай улс Японд бонд гаргах боломж бий юу?

С.Дэмбэрэл: - Бонд гаргах боломж байгаа.

- Олон эдийн засагч ам.долларын төгрөгтэй харьцах ханшийг ирэх онд 2000 дөхнө гэж таамаглаж байгаа. Монголбанк бол үүнийг нэлээд өөдрөгөөр харж байх шиг байна. Ер нь одоогийн явуулж буй бодлого үргэлжилбэл ам.долларын ханш тогтвортой байх боломжтой юу?

С.Дэмбэрэл: - Монголбанкны өдийг хүртэл явуулж ирсэн бодлого өөрчлөгдсөн. Би сая мөнгөний бодлогын ажлын хэсгийн ахлагчаар ажилласан. Өмнө нь мөнгөний бодлогод “валютын ханш нь макро эдийн засгийн нөхцөлтэй нийцсэн уян хатан, тогтох зарчмыг баримтална” гэсэн ганц л заалт байдаг байлаа. Ирэх оны мөнгөний бодлогын төсөл ч УИХ-д ийм л байдлаар орж ирсэн. Би ирэх оны мөнгөний бодлого боловсруулах ажлын хэсгийн ахлагч болоод үүнд нэмж найман заалт оруулсан байгаа.

- Ямар заалтуудыг нэмж оруулсан байгаа вэ?

С.Дэмбэрэл: - Гол нь валютын ханшийг ингэж сул орхиж болохгүй. Ер нь бол валютын ханш хамгийн зохистой байх ямар нэгэн тоог хэн ч хэлж чадахгүй. Гэхдээ үүнийг тооцоолж болдог. Өөрөөр хэлбэл ханшид нөлөөлж байгаа бүх хүчин зүйлийг судалж байгаад тооцоонд оруулдаг шүү дээ. Жишээлбэл, Эдийн засгийн хөгжлийн яам ам.долларын ханшийг 1384 гэж тооцсон байна. Одоо бол энэ валютын ханш 1700 гарчихлаа. Эрх баригчид үүнийг валютын дотогшлох урсгал нэмэгдчихвэл аяндаа буурна гэж тайлбарлаж байгаа. Тийм биш. Аливаа улс оронд валютын ханшийн бодлого гэж байдаг. Манай улс бол валютын ханшийн зохицуулалттай хөвөх дэглэмтэй улс. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл валютын ханш зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн хэмжээгээр тогтоно. Гэхдээ валютын ханшийн эрсдлийн хэлбэлзлээс хамгаалах механизмыг төвбанк болон Засгийн газар хамтран боловсруулж валютын ханшийн бодлогодоо суулгаж өгөх ёстой. Мөн валютын ханшийн зах зээл дээр таваас долоон банк оролцдог. Тэд зөвхөн Монголбанкны санал болгож байгаа валютыг худалдан авах буюу эрэлтийн талыг л төлөөлдөг. Нийлүүлэлтийн тал нь манай валютын нөөц байгаа. Тэгэхээр үүнийг ирэх оноос өөрчлөхөөр болж байгаа. Тэр нь юу вэ гэхээр валютын ханшийн зах зээлд оролцогчдын тоог нэмэгдүүлэхээр болж байгаа. Банк бус санхүүгийн байгууллагууд, томоохон экспортлогчид, импортлогчид энэ зах зээлд оролцохоор заалт орсон байгаа. Үүнээс гадна бид хөрш орнуудтайгаа үндэснийх нь мөнгөн тэмдэгтээр гүйлгээ хийж ам.долларын хэт хэлбэлзлээс хамгаалдаг. Үүнийг своп хэлэлцээр гэж нэрлэдэг. Манай улс Хятадын төвбанктай своп хэлэлцээр хийсэн байгаа. Гэхдээ одоогийн нөхцөл байдалд ам.долларын ханш өсөхөөр дагаад юанын ханш хөдөлчихдөг. Тэгэхээр нэг их ялгаагүй болж байна. Монголын бизнес



эрхлэгчид Хятадын бизнес эрхлэгчдээс ашиггүй нөхцлөөр юан авч байна. Энэ тохиолдолд хамгийн энгийн арга бол Хятадын бизнес эрхлэгчид ямар ханшаар юан авч байна вэ тэр ханшаар манай бизнес эрхлэгчид авна. Өрөөр хэлбэл своп хэлэлцээрээр тогтож байгаа ханшин дээр арилжааны банкуудын зардлыг нэмээд стратегийн гол экспортлогчиддоо өгөөд эхэлбэл ханшийн хэлбэлзлийн эрсдлээс хамгаалж болно. Бүр болохгүй бол стандартын бус аргуудыг ч хэрэглэж болдог. Валютын ханшийн удирдлага, хэлбэлзэл нийт эдийн засагт инфляцийг өөгшүүлэх, дотоодын зах зээл дээр бараа бүтээгдэхүүний үнийг өсгөж байгаа бол энэ сайн ханш биш. Тиймээс ам.долларын ханшийг тогтвортой байлгахын тулд дээр хэлсэн бодлогын арга хэмжээнүүдээс гадна хэрэглэж болох стандарт бус аргууд байна. Энэ нь ам.долларын зээл, хадгаламж, төгрөгийн зээл, хадгаламжийн хоорондын харьцааг төгрөгөөр зээл авч, хадгаламж хийх нь ашигтай байх зохицуулалтыг төвбанк, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яамтай нийлээд зургаан сарын хугацаанд хийх хэрэгтэй. Ингээд ам.долларжилтын төвшнөө бууруулах хэрэгтэй. Ингэснээр ам.долларын ханшийг буулгах, тогтворжуулах бүрэн боломжтой. Энэ аргыг гадны орнууд нэг их хэрэглээд байдаггүй. Гэхдээ энэ бол ам.долларын ханшийн өсөлтийг уях арга юм. Энэ мэтчилэн яриад байвал ам.долларын ханшийг тогтвортой байлгах арга бий. Энэ бүхэн ирэх оны мөнгөний бодлогод суусан байгаа. Саяхан УИХ-ын Эдийн засгийн байнгын хороон дээр Монголбанк, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, УИХ-ын зарим гишүүн оролцсон ажлын хэсэг байгуулагдсан. Энэ ажлын хэсэг ойрын хугацаанд ам.долларын төгрөгтэй харьцах ханшийг тогтворжуулах, улмаар буулгах жагсаалтыг гаргаж байгаа. Мөн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр төгрөгөөр гүйлгээ хийх хуулийн зарим заалтыг өөрчлөх, энэ хуулийн хэрэгжилтийг чанд сахиулах, энэ чиглэлийн шалгалтын үр нөлөөг сайжруулах зэрэг олон үүрэгтэй ажлын хэсэг байгаалагдаад арванхоёрдугаар сарын 15-ны дотор Эдийн засгийн байнгын хорооны тогтоол гарах ёстой.

**- Ам.долларын ханш сүүлийн үед нэлээд өслөө. Эрх баригчид үүнийг манай экспортлогчдод ашигтай гэж тайлбарладаг. Ер нь одоогийн ханш хэр зохистой байна вэ?**

**С.Дэмбэрэл:** - Энэ ханш импортлогчдод дарамт болж байна. Тиймээс энэ ханшийг буулгах ёстой. Гэхдээ ханшийг хэт буулгах нь бас буруу. Ингэвэл экспортыг урамшуулахаа больчихно. Одоогийн өнөөгийн байдал экспортлогчдод ч ашиггүй. Яагаад гэвэл манай дотоодын компаниуд эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд импортын орцыг хэрэглэдэг. Жижиг дунд бизнес эрхлэгчдэд ч хохиролтой. Тиймээс энэ бол сайн ханш биш. Ам.долларын ханшийн асуудал өнөөдөр манай эдийн засгийн хамгийн эхний асуудал болчихоод байна. Бид үүнийг л онцгой анхаарах ёстой.

**- Энэ жилийн төсөвт ам.долларын ханшийг хэт өөдрөгөөр төсөөллөө. Үүнээс гадна нүүрс, алт зэрэг экспортын түүхий эдийн хэмжээг ч нэлээд өөдрөгөөр төсөвт тусгасан байгаа. Ингэж өөдрөг төсөөлөх нь эргээд эдийн засагт ямар сөрөг нөлөө авчрах вэ?**

**С.Дэмбэрэл:** - Хэдийгээр төсвийн алдагдлын хэмжээг ДНБ-ий хоёр хувьд барьж чадсан ч гэлээ ирэх оны төсвийг хариуцлагагүй баталлаа. Төсвийг ирэх оны дөрөвдүгээр сард тодотгох гэж байна. Төсвийн доторх хариуцлага

муудаж байгаа учраас тодотгохоос өөр аргагүй. Манай экспортын орлого гаднаас хамааралтай нь үнэн. Гэхдээ үүний эсрэг эдийн засгаа солонгоруулж бизнесээ л дэмжих хэрэгтэй. Төсвийн орлого бүрдүүлдэг хэсгүүдийнхээ идэвхжлийг нэмэгдүүлэхгүйгээр төсвийг зохистой гэж хэлэх нь хүндрэлтэй. Бид төсвийг зөвхөн нэмэх ба хасах гэсэн үйлдлээр харж болохгүй. Үүнээс гадна үржүүлэх хуваах үйлдэл байдаг шүү дээ. Төсвийн орлогыг нэмэхийн тулд үржүүлэх үйлдлийг хийх хэрэгтэй. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл баялаг бүтээгчдийг баялгаа үржүүлэх боломжийг нь төсвийн бодлогоор хангаж өгөх хэрэгтэй. Мөн хамгийн хэрэггүй зардлыг танаж хасах үйлдлийг хийх хэрэгтэй. Дээр нь татварын дарамт нэмэхгүйгээр орлого бүрдүүлэх аргыг хайх ёстой. Төсвийн хөрөнгийг хуваах үйлдлийг хамгийн сүүлд хийх ёстой юм. Төсвийн захирагч бүрийн хариуцлага нэмэгдэх, төсвийг хөндлөнгөөс хянадаг байх хэрэгтэй. - **Ярилцсанд баярлалаа.**

## **Хүнийг шууд хорьдог байдлаа болих уу, үгүй юу?**

*Мөрдөх албаны тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Хууль зүйн байнгын хорооны ажлын хэсгийн 2013 оны 11 дүгээр сарын 21-ний хуралдааны тэмдэглэлээс*

С.Дэмбэрэл: - Баярлалаа. Миний хувьд хэдийгээр ажлын хэсгийн гишүүн боловч, мэргэжил хол, бас анх удаа оролцож байгаагийн хувьд танин мэдэхүйн чанартай байх магадлалтай асуултуудыг ажлын хэсгийн ахлагчаас асуумаар байна.

1. Энэ хуульд хичнээн удаа, хаана хаана хүний эрхийн тухай орсон бэ? Мөрдөх албанаас хүний эрхийг хүндэтгэх, хангах талаар ямар заалтуудаар, яаж орсон бэ?

2. Мөрдөх албыг улс төрийн харьяалалаас, улс төрийн захиалгаас, түний дотор бүлэглэлийн эрх ашгаас ямар байдлаар, яаж хамгаалсан юм бэ?

3. Өнөөгийн тогтсон практик бол, мөрдөх албанаас гэмт хэргийг мөрдөхийн тулд хүнийг нийгмээс тусгаарлан, шоронд хийж хорьдог энэ үйл явц хэвээрээ үлдэх үү? Эсвэл өмгөөлөгчийнх нь болон тухайн мөрдөгдөж байгаа хүний үг хэрэгжин биелж, ингэснээрээ мөрдөх албыг хуучин аргаар гэмт хэргийг илрүүлэх буюу хүнийг хорьж цагдах, сэтгэл зүйн дайралт хийх замаар хувь хүнийг хохироодог арга барилаас яаж хамгаалсан бэ?

4. Нэмж асуухад “шаардлагатай тохиолдолд” гэсэн үг их олон тааралдаж байна. Энэ их субъектив үг юм. “Шаардлагатай тохиолдол” гэж хэн ч, хэзээ ч тодорхойлж болно. Энэ юу гэсэн үг вэ? “public interest” гэж юу гэхээр хэлж чаддаггүйтэй төстэй санагдаад байна. Бид, хууль болж мөрдөгдөх зүйлийн тухай ярьж байна. Тиймээс энэ үгийг яг, яаж тодорхойлсон юм бэ?

5. Хэрэгт сэжиглэгдсэн хүний өмгөөлөгчийн өмгөөлөх эрх, мөрдөх ажиллагаанд оролцох оролцооны эрх хэр хангагдсан бэ? Хэрэг мөрдөх явцад өмгөөлөх ажиллагаа яаж явагдах юм бэ гэдгийг бас тайлбарлана уу.

6. Мөн “тухайн байгууллага нууц биш гэж үзсэн бол”, жишээлбэл “харилцагчдын нууцад шаардлагаар, хүссэнээр” гэсэн заалтууд бичигдсэн байна. Яг үүнийг л яриад байна. Мөнгөө хадгалуулсан хүний хувьд хувийн нууц /privacy/-ыг хадгалах, хангах асуудлыг шийдэж чадсан эсэхийг хүмүүс мэдэхийг хүсч байгаа. Үүнээс болоод данснаас бэлэн хэлбэр рүү мөнгөө татах асуудал бас үүснэ. Тийм зүйлс гарч байгаа байх. Тэгэхээр банкнуудаас мэдээлэл гаргуулж авахдаа банкны тогтвортой ажиллагаанд нөлөөлөхгүй, хүний эрхийг зөрчихгүй, мөн хүний хувийн нууцийг задруулахгүй байх талаар хэрхэн бодож зохицуулсан бэ?

... Би эдгээр асуултыг хэзээ ч, хаана ч асууна. Би нэг жишээ хэлье. Сүүлийн үед засгийн газраас орж ирж байгаа хууль, тогтоолуудыг бид маш их өөрчилж байгаа. Өөрчлөхөөргүй юм орж ирвэл уг нь хамгийн сайн байгаа юм. Өөрөөр хэлбэл чанартай хууль, тогтоолын төсөл орж ирвэл сайн байгаа юм. Гэтэл “Хөрөнгө оруулалтын хууль”, “эрдэс баялагын бодлого, баримтлал” зэрэг орж ирж байгаа зүйлс маш их өөрчлөгдөж байна. Өөрчлөлт их шаардаж байна. Зарим нь бүр 80 гаруй зүйл заалт, зарчмын зөрүүтэй юмнууд гарч ирж байна. Х.Тэмүүжингийн хариуцсан Хууль зүйн Яамыг сайн чанартай юм хийсэн байх гэж найдаж байна. Бага юм өөрчлөгдөөсэй гэж хүсч байна. Гэхдээ л миний дээрх хэдэн суурь асуултанд хариулж чадаагүй бол энэ төсөл чинь биш юмаа л гэсэн үг. Эдгээр асуултанд хангалттай хариу өгөөд, цаашид энэ хуулийг хэрэгжүүлэхдээ айлын гэрт хүч түрэн орж нэгжлэг хийдэггүй, хүний хувийн эрхэнд халддаггүй, улс төрийн захиалгаар хүмүүсийг “агнадаггүй” тийм л мөрдөх ажиллагаа явагддаг болох ёстой. Ийм нөхцөл хангагдсан бол энэ сайн хууль болно гэсэн үг. Тиймгүй бол энэ хууль чинь ямар нэг хүний, эсвэл аль нэг хүчний нөлөөн дор ашиглагдаж явна л гэсэн үг болно. Тийм учраас энэ албаны хүмүүсийн хараат бус байдал нь цалин пүнлүүгээсээ гадна хэр хангагдсан юм бэ гэдгийг ч нэмж асуумаар байна. Эдний цалин хөлсийг тусад нь томъёолох ёстой биз дээ? Үүнийг хэн томъёолох юм бэ? Байгууллагыг нь институцийнх хувьд хараат бус байдлыг хэрхэн хангасан юм бэ гэдэг ч чухал байна. Аль нэгэн улс төрийн нөлөөлөлд орохгүй гэсэн ийм баталгааг л би асуугаад байна.

**Х.Тэмүүжин сайдын хариулт:** - С.Дэмбэрэл гишүүний асуусан, хүний эрхтэй холбоотой асуултууд зөвхөн ганц энэ “Мөрдөх алба”-ны хуулиар шийдэгдэхгүй юм. Олон хуулийн цогц системээр шийдэгдэнэ. Өнөөдрийн бидний ярьж байгаа хууль бол зөвхөн, тодорхой нэг төрлийн хэргийг мөрдөн шалгадаг институцийн л хууль юм. Харин хүний эрх, үйл ажиллагаатай холбоотой асуудлыг “Гэмт хэргийг хянан шийдвэрлэх” болон “хууль сахиулах үйл ажиллагааны тухай” гэсэн өөр 2 хуулиар зохицуулж байж хүний эрх нь хангагддаг. Хүний хувийн эрхтэй холбоотой асуудлуудыг хөндөхгүй байх, хүний хувийн орон зайд байгаа мэдээллийг тэр бүр дуртай байдлаараа задлахгүй байх, тэгэхдээ өөрийг нь буруутгасан бүх юмыг задалчихаад, цаад өөр баримт гарч ирвэл тэдгээрийгээ нь задлахгүй байх, хаахаар иргэн үүнийгээ задла гэж шаардахаар дуугардаггүй зэрэг байдлуудыг шийдвэрлэхтэй холбоотой нэлээд олон зохицуулалтуудыг хийсэн. Гишүүний хэлсэнчлэн Мөрдөх алба 2 зүйлээс ангид байх ёстой. Үүнд, нэгдүгээрт Улс төрөөс, хоёрдугаарт эдийн засаг, мөнгөний

бүлэглэлүүдээс ангид байх учиртай юм. Энэ ангид, хараат бус байдлыг хангахын тулд бусад улсуудын туршлагаас 3 зүйлийг хэрэгжүүлэхийг зорьж байна.

1. Мөрдөх албаны даргаас ихээхэн хамаардаг юм байна. Энэ нь улс төрөөс ангид хүн л байх ёстой. Олон улсын туршлагаас бол сүүлийн хэдэн жил улс төрд ажиллаагүй хүн байна гэсэн шаардлага тавьсан байна. Бид дунджаар 5 жил гээд тавьчихсан байгаа. Хууль тогтоогчид энэ хугацааг дээшлүүлж 8 жил болгож ч болно.

2. Дэд даргын ажлыг цэвэр мэргэжлийн хүмүүсээс бүрдүүлдэг. Ямар нэг байдлаар улс төрд орсон хүнийг энэ албан тушаалд тавьдаггүй юм байна. 10-20 жилийн өмнө улс төрөөр оролдож байсан ч энэ албан тушаалд огт тавьдаггүй юм байна. Бид ч энэ шаардлагыг баримталж байгаа. Харин бизнес эрхэлж байсан хүнийг оруулах эсэх талаар тодруулга бий. Бид одоогоор ийм хэмжүүр тавиагүй. Хууль тогтоогчоос хүсвэл ийм шаардлага оруулж болно.

3. Улстөржихгүй байх баталгааг нь хангахын тулд мөн парламентаар оруулж хэлэлцүүлдэг. Манай хуулийн төсөл дээр Мөрдөх албаны даргыг Засгийн газар томилоно гэж байгаа. Бусад орнуудын хувьд парламентийн харьяа байнгын хороогоор хэлэлцүүлнэ гэж бас заасан байдаг. Тэрийг хууль тогтоогчоос оруулах нь нээлттэй. Бид хийгээд оруулъя гэж ярилцаж байгаа. Одоо ажлын хэсэг л үүнийг боловсруулна.

**С.Дэмбэрэл:** - Би та нараас амьдралд гарч байгаа зүйлийг л асууж байгаа. Хүнийг шууд хорьдогыг байдлаа болих уу, үгүй юу?

**Х.Тэмүүжин сайдын хариулт:** - энэ системийг хийж байгаагын нэг гол агуулга нь үүнтэй холбоотой юм. Ер нь аль ч улс оронд, гарч байгаа гэмт хэргийг 2 үндсэн хэсэгт хувааж байгаа. Статистикийн дүнгээр, манайд гарч байгаа нийт гэмт хэргийн 93% нь ил үйлдэгддэг, ахуйн шинжтэй, хохирогч нь тодорхой, шийдвэрлэх асуудлыг хуулийн хүрээнд бүрэн тодорхойлох боломжтой гэмт хэргүүд эзэлж байгаа юм. Ийм хэргийг мөрддөг, шалгадаг арга барил нь үндсэндээ... нэг талаас иргэн “манайд хулгай орчихлоо. Үүнийг бариад өгөөч” гэж гомдол гаргадаг. Нөгөө талаас хуулийн байгууллага хууль сахиулж, гэм буруутныг олж, хариуцлага тооцох зорилготой 2 чиглэл явж байдаг. Ийм төрлийн гэмт хэрэг 93% эзэлдэг гэсэн үг. 7% гэмт хэрэг нь далд үйлдэгддэг, хохирогч нь шууд, тодорхой биш боловч, гэмт хэрэг үйлдэгдсэний дараа маш их хэмжээний хохирол учирч, олон тооны хохирогч гарах магадлалтай байдаг. Ийм гэмт хэрэг далд үйлдэгдэхээс гадна, эдийн засгийн хувьд нэлээд ашигтай байдаг учраас, зохион байгуулалтанд ороод, өөрийгөө хамгаалах хэрэгслүүдийг бий болгодог. Зэвсэглэх, албан тушаалын хамгаалалт хийх, улс дамнасан зохион байгуулалтанд орох зэргээр даамжирдаг гэмт хэрэг 7% байна.

**С.Дэмбэрэл:** - Тэрийг ойлгож байна. Тэрэнгэйгээ холбогдоод хорьж цагдах асуудал нь өөр болно гэдгийг ч мэдэж байна. Миний асуугаад байгаа зүйл бол...

**Х.Тэмүүжин сайдын хариулт:** - Таны асуултанд одоо яг хариулах гэж байна. 7% гэмт хэрэг нь далд үйлдэгддэг, зохион байгуулалттай хэрэг учраас тагнаж, чагнах шаардлага гардаг. Мөн гэмт хэрэгтнүүд ихэвчлэн гэрч, хохирогчийг устгах гэж оролддог учраас хүч хэрэглэх үйл

ажиллагааг нь таслан зогсоох шаардлага гарч ирдэг. Зохион байгуулалтыг нь задлах зорилгоор цагдан хорих, нийгмээс тусгаарлаж хэргийг мөрдөх шаардлага тулгардаг. Нөгөө 93% гэмт хэрэг нь ил тод гэмт хэрэг учраас, тагнах, хүч хэрэглэх шаардлага тэр бүр гардаггүй, иргэнийг хорьж байцаах шаардлагагүй байдаг юм. Энэ 2 гэмт хэргийг 1 байгуулагад хариуцуулчихаар, нөгөө 7% -д хэрэглэдэг аргаараа 93%-ыгаа “зодчихдог”. Юм л болбол тагнана, барьж хорино, тусгаарлана, хүч хэрэглэнэ гээд байдаг сул талтай байгаа юм. Тэгэхээр энэ 2 хэргийг салгаж, 93%-тай цагдаа, 7%-тай нь мөрдөх алба ажиллана гэж ангилах гэж байгаа юм. Цагдаа бол иргэнийг барьж хорихгүй.

**С.Дэмбэрэл:** - энэ 7% чинь Мөрдөх албаны хуулиар зохицуулагдах юм уу? Үүнд авилгалын хэрэг орох уу?

**Х.Тэмүүжин сайдын хариулт:** - Тийм.

**С.Дэмбэрэл:** - Бид хуулийг яарч хийж болохгүй. Тэгвэл чанаргүй юм гарна. Тийм учраас сайн сонсож бай. Би бас нэг зүйл асуумаар байна. 5.1 – 5.3 заалтыг хар даа. Үндсэн зарчим гэнээ. 5.3 нь *“Шинжлэх ухаан, техникийн орчин үеийн технологийн ололтыг ашиглах зарчим”* гэж байна. Ийм зарчим байдаг юм уу? Энэ чинь зарчим биш. 5.2-ыг хар. *“Нууцлалыг хангах, үйл ажиллагааг ил болон далд арга хэрэгслийг хослуулах зарчим”* гэнэ. Энэ чинь ч бас зарчим биш байна. Мөрдөх албаны үйл ажиллагааны үндсэн зарчим чинь:

1. *“Хууль сахиулах үйл ажиллагааг бие даан, хараат бусаар явуулна.”* гэж байх ёстой. Энэ бол зарчим.

2. *“Хүний эрхийг дээдлэх...”* гэх мэтчилэн бусад зарчим орох ёстой. Түүнээс биш *“Шинжлэх ухаан, техникийн орчин үеийн технологийг ашиглах”* гэдэг чин бол үйл ажиллагааны зарчим байгаа юм.

**Х.Тэмүүжин сайдын хариулт:** - С.Дэмбэрэл гишүүнээ, “Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийг бид бас хэлэлцүүлж байгаа. Мөрдөх алба бол хууль сахиулах байгууллагуудын нэг нь. Тэр хуулин дээр цагдаа, мөрдөх алба, шүүхийн шийдвэр хэрэгжүүлэгч байгуулага зэрэг хууль сахиулах байгууллагуудаа биччихээд, тэр дотроо “хүний эрхийг хамгаалах” зэрэг суурь зарчмуудаа биччихсэн байгаа. Ямар байгууллага байхаас үл шалтгаалан тэдний яах ёстойг нь бичсэн. Харин эн хуулинд бол цагдаа, шүүхийн шийдвэр хэрэгжүүлэгч байгуулагад байхгүй ялгаатай зарчмыг нь л бичиж өгч байгаа юм. “Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хууль”-д байгаа зарчмыг давхардуулж бичиж болохгүй учраас эндээс хасагдсан юм. Мөрдөх албаны мөрдөгч, ажилтан, дарга нар нь өөрсдөө хууль сахиулагч учраас “Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хууль”-д байгаа суурь зарчмуудаа мөрдөнө.

**С.Дэмбэрэл:** - ойлголоо. Иргэн, байгууллага, аж ахуйн нэгж эь Мөрдөх албаны үйл ажиллагаанд оролцоходоо эрх эдэлж, үүрэг хүлээж оролцоно. Тийм үү? 5-р бүлэг дээр зөвхөн үүрэг л гэсэн үг байна. Эрх нь хаана байна? Иргэний эрх нь хаана байна вэ? Байгууллагынх нь эрх хаана байна вэ? Албан тушаалтных нь эрх хаана байна вэ? Эрх үүрэг 2 нь тэгш хангагдаж байж л оролцоо нь тэгш болохгүй гэж үү? Тэрнээс биш, одоо байгаагаар бол “үертэй үед дайчлан гаргуулах” гэдэг шиг л зүйл болчихсон байна шүү дээ.



**Х.Тэмүүжин сайдын хариулт:** - Салбарын шинэчлэл бол зөвхөн энэ хуулин дээр биш юм. Бид жижиг, нарийвчилсан хуулин дээр ярилцаж байна. Жишээлбэл, үний эрхийг зөрчил үүсгэдэг байсан прокурорын зарим эрхийг бид шүүх рүү шилжүүлж байгаа. Шүүх дээр ч бас шүүгч дангаараа энэ эрхийг эдлэхгүй, шүүх процессийн явцад, шүүн таслах ажиллагаанд иргэн өөрөө оролцож, гэм буруутай эсэх талаараа тайлбар гаргаж ярьж байж, намайг цагдан хорино, миний өмчийг хураана, миний эрхийг хязгаарлана гэдэг тэр бүхэн орж яваа. Энэ бол зөвхөн нэг институцийн тухай хууль учраас таны ярьсан бүх зохицуулалтууд өөр хуулиар зохицуулагдаж байгаа юм. “Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийг өөрчлөн шинэчилсэнээр прокурор, өмгөөлөгч 2 анх удаа ижил хэмжээний эрхтэй болсон. Өмнө нь прокурор өмгөөлөгчийн дээр гарчихсан, өмгөөлөгч нь зөвхөн мөрдөн байцаагчтай л очиж “зодолддог” байсан бол одоо өмгөөлөгч мөрдөн байцаагчтай “зодолдохоо” больсон. Өмгөөлөгч бол хүний эрхийг хэмгаалдаг хүн болсон.

**С.Дэмбэрэл:** - ойлголоо. би сүүлчийнхээ асуултыг Хууль зүйн төрийн нарийн бичгийн даргаас асууя. “Бие даасан”, “хараат бус” гэсэн 2 ойлголтын зөвхөн нэг нь буюу “бие даасан” байдал гэдэг нь л энэ хуульд суужээ гэж ойлгож болох уу? Өөрөөр хэлбэл Мөрдөх алба бол институцийнхээ хувьд бол бие даасан байх юм байна. Харин “хараат бус” байдал гэдэг нь мөрдөн байцаагч нартаа хамаарах уу? Институцидээ хамаарах уу? “Бие даасан” байдал бол ойлгомжтой боллоо. Х.Тэмүүжин сайд санал болгоод, засгийн газар томилох юм байна. Энэ бол засгийн газраас хараат гэсэн үг. Гэхдээ үйл ажиллагааны зарчимдаа бол бие даасан байдалтай үйл ажиллагаа явуулах юм байна. Х.Тэмүүжин сайд оролцож болохгүй гэсэн үг, тийм үү? “Хараат бус” байдал гэдэг маань арай илүү өргөн ухагдхуун, миний бодлоор бол. Манай хуулиудад үүнийг холиод л оруулаад байна. “бие даасан” гэхихээд таслал тавиад “хараат бус” статус гэж зарим хуулинд орчихсон байна. Гэтэл жишээлбэл, “төв банкны тухай” хууль дээр зөвхөн “бие даасан байдалтай” гээд оруулчихсан байна. Үүн дээр ямар нэг нюансууд байна уу, үгүй юу?

**Баярцэцэг:** - “бие даасан байдал, хараат бус зарчим” бол манай үндсэн хуулийн тайлбар дээр бий. Манай сайдын болон таны хэлсэнчлэн илүү институцид хамаарна. Байгууллагын бие даасан байдал гэж институци дээр ярьдаг. “хараат бус байдал” бол үйл ажиллагаан дээр яригддаг. Жишээлбэл шүүхийн хараат бус байдал байна. Нэг агуулгатай боловч, 2 тусдаа заалт. “хараат бус байдал” бол зөвхөн энэ хууль дээр биш, өөр, процессийн тухай хуулиуд дээр баталгаажуулдаг. Зөвхөн зарчим заахаас гадна тэр зарчмыг хангахын тулд ямар ямар шат дараалалтай арга хэмжээ авах вэ гэдэг нь тусгагдсан байгаа.

**С.Дэмбэрэл:** - ойлголоо. Одоо Х.Тэмүүжин сайдаас хамгийн сүүлчийнхээ асуултыг асуумаар байна. Та миний асуултанд сая хариулахдаа бүхэл бүтэн реформ явж байгаа. Энд зөвхөн гинжин хэлхээний нэг нэгж нь яригдаж байна. Бусад хуулинд концепцийн хувьд бүгд орчихсон байгаа гэж тайлбарлалаа. *“Таны асуугаад байгаа зүйл бусад бүх хуулиудад хангалттай бөгөөд ямар нэгэн эргэлзэх зүйлгүйгээр туссан. Тийм учраас таны асуусан бүхэн энэ хуулин дээр давхцах учраас оруулсангүй. Бусад хуулинд цөм тусгагдсан.”* гэж хэлсэн гэж би ойлгож болох уу?



Х.Тэмүүжин сайдын хариулахын өмнө нэг зүйл хэлье. Үндсэн зарчим нь өөр хуулин дээр байгаа юм бол Мөрдөх албаны хуулиас үндсэн гэдэг үгээ авах хэрэгтэй. Үйл ажиллагааны зарчим гэж хэлээд явчихвал, яг энэ ажилд хэрэглэгдэх тодорхой зарчим болж байгаа юм. Тиймээс:

1. Гарчгийг нь өөрчилмөөр байна.

2. Энэ 3 зарчмаас “бие даан үйл ажиллагаа явуулах, хууль сахиулах” гэдэг нь зарчим байж болно. Харин “Нууцлалыг хангах, үйл ажиллагааг ил болон далд арга хэрэгслийг хослуулах зарчим” гэдэг бол арга болохоос биш, зарчим биш байна. Хэрвээ үүнийг зарчим болгоё гэж байгаа бол “үйл ажиллагааны ил тод байдал болон далд арга хэрэгслийг хослуулахдаа нууцлалыг хангах зарчмыг баримтална” гэж найруулан оруулж болно.

3. “Шинжлэх ухаан, техникийн орчин үеийн технологийн ололтыг ашиглах зарчим” гэдэг бол үнэхээр зарчим биш, зорилт байна. Хэрвээ үүнийг зарчим болгоё гэж байгаа бол “Шинжлэх ухаан, техникийн орчин үеийн технологийн ололтыг ашиглахдаа хүний эрх, эрх чөлөөг алдагдуулахгүй байдлаар хэрэглэнэ.” гэсэн байдлаар томъёолох нь зөв.

Эдгээрийг ингэж өөрчлөхгүй бол гишүүдийн шүүмжлэл салахгүй гэж бодож байна.

**Х.Тэмүүжин сайдын хариулт:** - зарчим дээр аргачилалыг зааж өгөх явдал бас бий. Ингэснээр тухайн байгуулга үйл ажиллагаандаа заавал мөрдөх зарчим болоод явдаг онцлогтой. Танай үйл ажиллагааны тулгуур зарчим чинь энэ шүү гэж зааж өгч байгаа хэрэг юм. Эхнийх нь байгууллагын онцлогтой холбоотой зарчим юм. 2-р зарчим нь мөрдөж байгаа хэрэгтэй нь холбоотой гарч байгаа зарчим юм. Тухайлбал, мафитай тэмцэж байгаа, мафийн дунд тусгай ажилтанаа оруулчихсан байгаа үед нууцлалыг сайтар хангахгүй бол тухайн ажилтан амь насаараа эрсдэлтэй ажиллаж байгаа юм. Хүн худалдаалах болон хар тамхитай холбоотой хэсэгт тэр ажилтан мэдээлэлээр юм уу, дотор нь орж ажиллаж байж задална. Зөвхөн энэ байгууллагад зарчмаа дагаж дүрмээ тогтооно. Дүрмүүдээ дагуулж, хэм хэмжээнүүдээ тогтооно шүү гэж тогтоож өгөх принцип нь байгаа юм.

**С.Дэмбэрэл:** - “Бие даасан” гэдэг зарчим ойлгогдчихлоо. “Хараат бус” байдал, ялангуяа мөрдөн байцаагчдынх нь хувийн хараат бус байдлыг энэ хуулинд яаж тодорхойлсон юм бэ? Энэ хүмүүс чинь хараат байгаа учраас улс төрийн нөлөөнд, ямар нэгэн шахалт дарамтанд, захиалганд автаад байна. Тэгвэл хэн нэгэнээс хараат бус байхыг нь энэ хуулинд зааж өгсөн юм уу, үгүй юу гэдгийг л тодорхой мэдэхийн тулд асуугаад байна.

**Х.Тэмүүжин сайдын хариулт:** - Энэ нь өөрөө цогц, том систем байгаа юм. Тодорхой хэрэг маргаан гарахад, түүнийг нэг хэсэг хүмүүс, тухайлбал мөрдөгчид мөрдөн шалгаж, нотлох баримтуудыг нь бэхжүүлж, бүрдүүлээд, түүн дээрээ үндэслэж маргааныг шийдвэрлэх үндсэн суурь нь бүрэлдэж байгаа юм. Тэдгээр нотлох баримт, шинээр бүрдсэн үйл баримт дээрээ түшиглэж, энэ хуулийн ямар зүйл заалтаар заагдсан гэмт хэрэг гэж үзэж байгаа, яагаад гэм буруутай гэж үзэж байгаагаа тодорхойлдог, эсвэл үүнийг гэм хэрэг биш гэдгийг өмгөөлдөг яллагч, өмгөөлөгч 2-ын ажил явагдана. Үүн дээр нь үндэслэн шийдвэр гаргадаг шүүгчийн ажил нэмэгдэнэ. Ингэж бүхэл бүтэн нэг систем бүрддэг. “Хараат бус” гэдэг зарчмын 100% хангалтыг хийх ёстой ганц мэргэжилтэн бол шүүгч юм.

Шүүгч хүн дотоод итгэлээрээ, дэнсэн дээр ирсэн зүйлсийг эрэмбэлж байгаад, шийдвэр гаргана. Энэ шийдвэр гаргалтанд хөндлөнгийн нөлөөлөл гэж байж болохгүй. Үүнд шүүгчийн өөрийнх нь хувийн байр суурь орж болохгүй. Шүүгчээр хамгаалуулж байгаа юм. Систем нь өөрөө, шүүгчийн хараат бус байдлыг хамгийн түрүүнд шаарддаг. Шүүгч хараат бусаар ажиллана гэдгийг хараат бусаар хийгээд өгөхөөр, прокурор нэг дэнсэн дээр нь, өмгөөлөгч нөгөө дэнсэн дээр нь юм тавьж өгдөг. Прокурорын буруу авсан бүх мэдээлэл энэ дэнсэн дээр тавигдвал алга болдог. Шүүгч хараат бусаар шийдвэр гаргахдаа ямар ч прокурор, тэр нь нийгэмд алдартай эсэхээс үл хамааран түүний яллаж байгаа үндэслэлийг хүчингүйд тооцох боломжтой болдог. Тиймээс энэ шүүгчийн хараат бус эрхийг хэрхэн мөрдөн байцаалтын явцад оруулж ирэх вэ гэдэг нь манай гол бодлого юм. Мөрдөн байцаагчийн хараат бус байдлын тухай асуудал биш. Мөрдөн байцаагчийн бүрдүүлсэн нотлох баримт нь хууль ёсоор бүрдүүлсэн материал эсэх, мөрдөн байцаагч улс төрийн захиалгаар ажилласан эсэхийг шүүх хуралдааны хойно биш өмнө нь шийдэх ёстой. Тэгэхийн тулд бид шүүх процессийг задлаад, одоо шүүгчийн оролцоог урагш оруулж ирж байгаа. Хэн нэгэнийг баривчлах бол шүүх хурал хийе, ямар нэгэн нотлохо баримтыг хууль ёсоор авсан эсэхийг шийдэх гэж байгаа бол шүүх хурал хийе, хэн нэгэнийг гэм буруутай гэж үзэх байгаа бол шүүх хурал хийе, хэн нэгэнд ял оноох гэж байгаа бол шүүх хурал хийе гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл 4 шүүх хурлаар дамжиж байж тухайн шүүгч процесст орж ирдэг тийм системийг бид одоо хийж байна. Өмнө нь манайх шүүгчийг тээр хойно тавьчихаад, шүүх хурлаас өмнө баахан нөхөд бужигнуулж бужигнуулчихаад, хүний эрхээр тоглож, тогловичоод, шүүх рүү ч аваачилгүй хүнийг зовоож зовоочихоод “заа за, хэрэг биш болчихлоо” гээд хаагаад хаячихдаг байсан. Одоо баригдсан, шоронд суусан, мөрдөгдсөн тэр хүмүүсийн хэд нь шүүхэд очсон юм бэ гэхээр нэлээд нь шүүхэд огт очоогүй байдаг. Шүүхэд очихгүйгээр наана нь “бүгдийг алж байгаа” юм. Тийм учраас, тэгэхгүйн тулд нөгөө “хараат бус шүүх”-ийг наана нь буюу хүнийг баривчлах, хорих гэж байгаа бол шүүхэд авчир. Хэн нэгэн мөрдөн байцаагч үүнийг шийдэхгүй шүү гэдэг системийг хийж байгаа учраас “хараат бус” гэдэг зарчим маань шүүгч дээрээ төвлөрөөд, мөрдөгч нарт бол “бие даасан”, захиалгат бус баталгаануудыг нь орчинд нь хангаж өгч байгаа юм. Түүнээс бус, шүүгчтэй өрсөлдөхүйц хараат бус мөрдөгчийн тухай ойлголт байхгүй.

## **Даажинтай асуулт**

*2013 оны 11-р сарын 21-нд УИХ-ын Чуулганы нэгдсэн хуралдаанаар “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явагдах цээр УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлийн асуусан асуулт:*

- Ажлын хэсгийн ахлагчаас асуух зүйл байна. Өчигдөр “Эрдэс баялгын салбарт баримтлах бодлого” хэлэлцэж байх үед энэ танхимд ардчилсан социалист болон ардчилсан патерналист үзэлтэй уур амьсгал зонхилж байсныг та харсан байх. Тийм учраас, та энэ хуулийн үг үсэг, үзэл санаа нэг бүрт “агуу монгол төр” гэсэн үзэл санааг шууд болон шууд бус байдлаар хийж өгсөн үү? Тэгэхгүй бол энэ хууль чинь батлагдахгүй шүү гэдгийг анхааруулъя гэсэн нэгдүгээр асуулт байна.

*Хоёрдугаарт*, та энэ хуулиндаа, түгээмэл тархацтай ашигт малтмалыг хариуцсан 100% төрийн өмчит томоохон үйлдвэрийн газрыг байгуулж өгч, “дарлагдсан ард түмэн” болох хувийн хэвшлийнхэнд жижигхэн хувь хэмжээ тараах байдлаар зохицуулалт хийж өгсөн үү?

*Гуравдугаарт*, хэрвээ та ийм зохицуулалт хийгээгүй бол, энэ хуулийгаа энэ хэлэлцүүлэг дээр унахгүй гэсэн баталгааг нь яаж гаргах юм бэ?

**Д.Батцогт:** - хариулах юм алгаа...

## **Эрдэс баялгын салбарт улс төр орчихоод, амлалтын дарамтанд байна**

*“Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай”  
Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх  
цүрэг бүхий Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсгийн 2013  
оны 11 дүгээр сарын 25-ны хуралдааны тэмдэглэлээс:*

**Д.Одонтуяа:** - С.Дэмбэрэл гишүүнээ, бид одоо 2.1.8 –ыг “Төрийн оролцоог бүртгэл, зөвшөөрөл, хяналтын тэвшинд чадавхижуулж” гэхийн оронд боловсронгуй болгож гэж үг өөрчлөх тухай ярилцаж байна.

**С.Дэмбэрэл:** - “Төгөлдөржүүлэх” гэдэг албан ёсны нэр томъёо байж болно. Оросоор совершенство гэдэг. Энэ нэлээн эртний, тогтчихсон хэллэг... Гэхдээ үүний дараа нэг ийм санаа байна. “Эрдэс баялагын салбар дахь төрийн өмчит аж ахуйн нэгж нь ерөнхий гэрээлэгчийн зарчмаар ажиллаж, төр хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрцүдийг хөгжүүлнэ.” Энэ бол төрийн өмчит компани гадаад, дотоодын хувийн хэвшлийн компани, хөрөнгө оруулагчидтай ерөнхий гэрээлэгчийн хувиар контракт хийж ажиллаад, төрийн стратеги бодлогыг түүгээр дамжуулан, хууль эрхзүйн хүрээнд хэрэгжүүлдэг явдал нь өөрөөр хэлбэл Монгол Улсын ерөнхийлөгчийн “ухаалаг төр” гэдгийн илрэл болж энэ заалт орж болох уу?

2. 1072 хувьцааг өгөх үү, үгүй юу? Таван толгойг Public company болгоно гээд байсан. Уначихсан. Тэгэхээр төр ямар ч ордын эдийн засгийн үйл ажиллагаа явуулаагүй, үр ашгийг нь олоогүй мөртлөө урьдчилан, популист байдлаар ард түмэнд бэлэн юм амлаад, тэрийг нь бид нар араас нь хөөцөлдөөд яваад байна л даа. Тийм учраас нэг ийм заалт байж болохгүй юу? Ерөөсөө, төр ингэж аливаа стратегийн болон аливаа орд газрыг эдийн засгийн үйл ажиллагаа явагдаагүй, үр ашгаа олоогүй байхад нь урьдчилж, нийтийн компанийн хэлбэрт оруулах зорилгоо тунхаглах явдал байж болохгүй шүү дээ. Үүнийг өнөөдөр нийт намуудын, улс төрийн хэмжээнд,

бодлогын хэмжээнд заагаад өгчихвөл, Монгол улсын эрдэс баялгын салбарт баримтлах энэ бодлого чинь яг хэрэгцээтэй заалт болж, орчин үеийнхээ утгыг олно. Одоо бол энэ эрдэс баялгын салбарт чинь улс төр орчихоод байна. “Амлалтын дарамтанд” байна. Тийм учраас Таван толгой хэзээ ч үр ашигтай ажиллаж чадахгүй. Тийм биз дээ? 1072 гэдгийг хэзээ гаргаж, яаж олгох юм бэ? Хэзээ зах зээлээ олж, яаж тогтворжих юм бэ? Бид нар өөрсдөө засаглалаа сайжруулаагүй байхад, одоо ингээд шууд “Нийтийн өмч” гээд, ард түмний хувьцаа эзэмшдэг компани болгох гээд байдаг. Энэ хэзээ ч үр ашигтай ажиллаж чадахгүй. Тиймээс энэ 2 заалтыг л оруулмаар байна.

1. Төрийн өмчит компаниар дамжуулан гэрээ байгуулж ашиглуулна. Тэр нь PPP, концесс зэрэг янз бүрийн хэлбэрээрээ байж байг.

2. Төрөөс орд газруудыг урьдчилж амаар ашиглаж, үр ашгийг нь урьдчилж хуваагаад, тэрнийгээ хүртээмжтэй болгож байгаа нь энэ гэж “1072” зэрэг элдэв хувьцаа болгоод ... ингэж улс төрийн тоглоом болгож, эдийн засгийн ямар ч үр ашиггүй болгож хаяж болохгүй.

Үүнийг л энэ “Төрөөс эрдэс баялгын салбарт баримтлах бодлого”-д заавал оруулж өгөх хэрэгтэй байна. Энэ л үзэл баримтлалын хамгийн чухал зүйл болно шүү. Төр эрдэс баялгын салбарт оролцож болно л доо. Тэр нь баялгын сан, улсын нэгдсэн төсөв, бусад сангуудаар дамжуулан баялгыг ард түмэнд хуваарилан, үр шимийг нь хүртээж болно шүү дээ...

Мөн дээр ярилцаж байгаа хэсэг дээр “...Ашигт малтмалын хайгуул, олборлолтын цйл ажиллагаанд шууд оролцохыг хязгаарлах” гэж найруулга нэмэх хэрэгтэй. Төрөөс тодорхой нутаг дэвсгэрт эрдэс баялгын тойм судалгаа хийвэл, түүний дараа төсөл хэрэгжих үе шатууд эхэлнэ. Тэр төслүүд хэрэгжих үе шатны эхний хэсэг нь эрэл хайгуул хийх явдал орно. Тэгээд олборлох гээд явчихна. Энэ бол амьдралын үе шат мөчлөгүүд юм. Үүний бүр эхний тойм судалгаанд л төр оролцоод бусдад нь шууд оролцохгүй байхаар л зохицуулах тухай асуугаад байгаа юм...

Энэ бодлогын нэг гол зорилго нь тогтвортой уул уурхайг хөгжүүлэхэд чиглэж байгаа. Тогтвортой уул уурхай гэдэг маань ирээдүйн болон өнөөгийн хэрэгцээг эдийн засаг, нийгэм, байгаль орчны гэсэн 3 салбарт хэрэгжүүлж байгаа компаниудыг дэмжих ёстой гэсэн үг. “Нийгмийн хариуцлагатай” гэдэг маань үүнийг л оруулах гээд байгаа хэрэг шүү дээ. Тэгэхээр ийм заалт байхгүй бол энэ чинь зүгээр л энэ компаниудад тулгасан зүйл болчих гээд байна. Үгүй ядахдаа “бодлогоор дэмжих” гэсэн нэг үг байх хэрэгтэй. Нийгмийн гэдэг маань хүний хөгжилд хэрэгтэй зүйлс байдаг. Тийм учраас “Бүс орон нутагт байгаль орчны болон нийгмийн дэд бүтцийг өөрийн хөрөнгөөр барьж байгуулсан тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг бодлогоор дэмжинэ.” гэж оруулъя. Татварын дэмжлэг гэхээр бас болохгүй. Учир нь бүх юм ерөнхий хуулиасаа салбарлах ёстой учраас бидний заалт хориглогдчихно. “Бодлогоор дэмжинэ” гэхээр татвар ч орж болно, юу ч орж болно л гэсэн үг шүү дээ. Удахгүй ногоон хөгжлийн бодлого бас бас гарна. Тэрэн дотор үүнтэй холбоотой заалтууд маш их орсон байгаа. Тэдэнтэйгээ үзэл санааны хувьд зөрч болохгүй. Нийгмийн дэд бүтцээс гадна, байгаль орчны дэд бүтэц гэж бас байгаа шүү дээ. Худаг, ус, геологи, биологийн төрөл зүйлүүдтэй холбоотой юм бий болгож, барьж бүтээж бас болно. Уул

уурхайн компаниуд нийгмийн хариуцлагаа ухамсарлаад, олон зүйл хийж бүтээн байгуулж болно шүү дээ. Монгол гэр бүлийн амьдрах орчныг алга болгохгүй тулд хийж болох ажлуудыг бид тусгах хэрэгтэй. Тиймээс миний хэлээд байгааг хүмүүс нэг их эсэргүүцээд байхгүй байх гэж бодож байна. Татварын дэмжлэг гэвэл гол эсэргүүцэлтэйгээ тулгарна...

**Д.Одонтуяа** : - “Байгаль орчны” гэдэг үг байх хэрэг байна уу? Хасая л даа...

**С.Дэмбэрэл** : - Байгаль орчны гэдгийг би харин онцолж хэлж байна шүү. Ногоон бүлэг, ногоон үзэл гэж юм байна шүү дээ. **Environmental** буюу байгаль орчны хамгаалал, хөгжил, нөхөн төлжилт, биологи экологийн төрөл зүйл гээд олон зүйл бий. Ус, агаар, ой мод зэрэг чинь бүгд л дэд бүтэц шүү дээ...

Орон нутгийн Community development program /Нийгмийн хөгжлийн хөтөлбөр/ гээд уул уурхайн компаниудын хүлээх ёстой хариуцлагууд бий. Эрдэс баялгын салбарт ажиллах компаниудад тавигдах шаардлагууд гэж бас бий шүү дээ. Тухайлбал, байгаль орчныг бохирдуулж болохгүй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө бага үзүүлэх гэх мэтчилэн шаардлагууд тавьчихсан байгаа шүү дээ. Ийм нөхцөлд компаниудын хийх ажлыг нь заачихсан. Энэ чинь компаниудад хөнгөлөгдчихсөн зүйл биш. Төр, компани, ард иргэд 3-ын гурвалсан харилцааг бид өмнө нь хийгээд өгчихсөн. Орон нутгийг бид community буюу хүмүүсийн нэгдэл, олонлог гэж ойлговол энэ заалт маань орон нутгийг хөгжүүлэх гэрээ байгуулж ажиллана гэж заасан. Компаниудад тухайн орон нутагт ажиллаж байгаагынхаа хувьд орчин үеийн бизнесийн философи, соёлын хүрээнд, зөвхөн өөрийнхөө ашгийг максимум түвшинд хүргэхийн төлөө биш, үйл ажиллагаа явуулж байгаа энэ орон нутгийн байгаль орчин, хүн ард, орон нутгийнх асуудалд хувь нэмрээ оруулна шүү, ингэхийн тулд Иргэдийн төлөөлөгчдийн хурал, иргэдийн оролцоотойгоор гэрээ байгуулж ажиллана шүү гээд заасан...

Би бас нэг зүйл хэлье. Хувиараа уурхай эрхлэгчдийн “дээвэр” байгууллага нь гарчихсан юм байна. Бичил уурхайнууд байна. Тэд Хоршооны хэлбэрт орчихсон юм байна. Тэдний санал нь “*Хувиараа олборлогч, бичил аж ахуй эрхлэгч 2-ыг салгаж ойлгооч. Бичил аж ахуйн нэгж нь төрийн бодлогын дагуу юм шүү. Үүнийг цаашид дэмжээд өгөөч.*” гэж хэлээд байгаа юм. Өөрөөр хэлбэл, “*манай хэсэг нөхөд замбараагүй байна. Бид бол замбараатай болчихсон. Бид аж ахуйн нэгж, хоршооны хэлбэрт орчихсон. Тийм учраас бидний энэ дээвэр байгууллагыг хүлээн зөвшөөрч, харгалзаж үзээрэй.*” гээд бичиг ирүүлчихсэн байна. Эндээс 2 асуудал гарч ирж байна.

- Хууль бус юм байгаа бол хууль бус явдлыг хязгаарлана гэсэн асуудал байхгүй. Хууль бус юмыг таслан зогсоодог. Ингэхийн тулд огт заалт оруулж болохгүй гэсэн үг.

- Нөгөөх нь төрийн зүгээс тэдний зохион байгуулалтанд орохыг нь дэмжинэ гэсэн заалт орж ирж байгааг анхны хувилбараар нь хүлээн зөвшөөрөх гэж байгаа бол засгийн газрын оруулж ирсэнээр нь л явуулъя.

Бид энэ жижиг уурхай эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд Монгол улсын төрөөс баримтлах бодлогоороо адил зарчим баримтална гэдгийгээ буюу ил тод, хариуцлагатай уул уурхайг та нар ч бас адилхан явуулах ёстой



гэдгийг л ойлгуулах учиртай. Компаниудад ил тод, хариуцлагатай үйл ажиллагаа явуул гэж шаардчихаад, бичил аж ахуйн нэгжүүдэд шаардлага тавихгүй байж болохгүй.

## **Хасах гэж оролдож байхад нэмж хууль үйлдвэрлэх гээд байх юм**

***УИХ-ын чуулганы 12 сарын 05-ны нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс:  
“Монгол Улсын хууль тогтоомжийг 2016 он хүртэл боловсронгуй  
болгох Үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын  
төсөл хэлэлцэх цээр***

**С.Дэмбэрэл:** - Би энэ бичиг баримтыг дэмжихгүй байхаар шийдлээ. Учир нь энэ үзэл баримтлал дээрээ техникийн хувьд хийгдсэн боловч агуулгын чанартай юм юу ч байхгүй байна. Хууль тогтоогчдын санал бодлыг механикаар тусгасан ийм үндсэн чиглэл болох гээд байна. Тэгэхээр юуны өмнө энэ үндсэн чиглэл ийм байдлаар бидэнд хэрэгтэй зүйл биш байна. Учир нь үүний дагуу бол Монголын төр улам олон хууль, тогтоол үйлдвэрлэх, тэдгээр нь хэрэгждэггүй болох урьдчилсан жагсаалтыг биднээр батлуулах гэж байна. Бид одоо байгаа хуулиудаа боловсронгуй болгох зорилгоор засгийн газар болон УИХ-ын 4 гишүүнийг оролцуулсан ажлын хэсэг байгуулагдаад “төрийн зохицуулалтын реформ” хийхээр оролдож байгаа. Ажлын хэсэг маань “guillotine” буюу цаазаар авах хандлага, “Jacobs and Associates” гэдэг хуулийн компаний бэлэг тэмдэг нь болсон “guillotine approach” гэгддэг арга барилаар энэ гарчихсан байгаа хуулиудын зохицуулалтуудыг “цаазалж”, цавчиж устгах зорилт тавиад ажиллаж байна. Үүнд яам агентлагуудын олгодог 1100 тусгай зөвшөөрөл лицензүүдийг 50% буюу хоёр дахин бууруулах зорилт ч бас орчихсон байхад бүр эсрэгээр, ямар зохицуулалт хийлгүй, хууль журам нэмэгдүүлэх зүйл ороод ирэх юм. Энэ жагсаалтан дээр шалгуур тавих хэрэгтэй. Өөрөөр хэлбэл энэ хууль яагаад хэрэгтэй юм бэ, зайлшгүй шаардлага нь юу юм бэ, нийгмийн эрэлтийг бүрэн тодорхойлж чадаж байгаа юу гэсэн анализ хийж үзвэл энэ жагсаалтаас маш цөөхөн хууль үлдэнэ. Гэтэл зарим секторт зайлшгүй хэрэгтэй байгаа тийм хуулиуд нь энд алга байна. Мэдээлэлийн технологийн салбарт гэхэд л 10 орчим хууль хэрэгтэй байгааг мэргэжилтэнүүд нь хэлж байна. Тэр хуулиуд энэ жагсаалтан дээр хаана байна? Энэ салбарын эрэлтийг тодорхойлсон юм уу, үгүй юу?

Эдийн засгийн хөгжлийн яам гэхэд л 5-6 хууль оруулах юм байна. Энэ ямар хуулиуд оруулах гэж байгаа юм бэ? Эдгээр хуулиудын үр дүнд Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг ямар загварт оруулах гэж байгаа юм бэ? Хууль эрх зүйн ямар орчин бүрдүүлэх гээд байгаа юм бэ? Энэ чинь төрийн инстинктээрээ улам том төрийг бий болгох жагсаалт л батлах гэж байна шүү дээ. Нөгөө “ухаалаг төр” чинь хаана байна? “Ухаалаг төр” чинь зөвхөн мэдээлэл технологийн асуудал биш. Цөөн хуультай, тэр хуулиуд нь хэрэгждэг байх тухай хэлж байгааг санах хэрэгтэй. Одоо УИХ-ын баталсан



300 орчим тогтоолуудын хэрэгжилтийг хэрхэн анализ хийж, энэ үндсэн чиглэлд яаж тусгасан юм бэ? Одоо байгаа мөртлөө хэрэгждэггүй хууль, тогтоолууд дээрээ үнэлэлт дүгнэлт хийгээгүй, тэрнийгэ цэвэрлэх, шүүрдэх ажил буюу “хуулийн их цэвэрлэгээ”-гээ хийгээгүй, тэгээд хамгийн гол суурь хуулиудын нэг болсон “хуулийн тухай хуулиа” хийгээгүй, Х.Тэмүүжин гишүүн “идеал ертөнцөөр, хараахан бий болоогүй байгаа, ирээдүй цаг” дээр ярьж байхад өнөөдөр бид замбараагүй хуулиудын жагсаалт оруулж ирчихээд ярьж байж болох уу? Энэ чинь логикийн болон хууль эрх зүйн талаасаа таарч байгаа юм уу? **Таарахгүй байна.** Ийм нөхцөлд, ийм зүйлийг батлаад, үүнийгээ хэрэгжүүлэх гээд явбал утгагүй юм болно. Энэ бол хатуухан хэлбэл, зүгээр л механикаар жагсаасан хүсэл мөрөөдлүүдийн жагсаалт байна. Тийм учраас үүнийгээ татаж аваад, агуулга төдийгүй хэлбэрийг нь хүртэл өөрлөх шаардлагатай санагдаж байна. Тухайлбал, энэ хуулиуд яагаад хэрэгтэй юм бэ, бусад нийгмийн харилцаанд оролцогсдын бодол, саналыг тусгасан юм уу, үгүй юу? Тусгагдаж болох юм уу, үгүй юу, хүмүүст хэрэгтэй юм уу, хэрэглэх үү, түүнийгээ асуусан юм уу? Ард түмнээс, нийгмээс асууж судлаагүй мөртлөө, ийм хууль хэрэгтэй гэж өөрсдийнхөө жижигхэн хүрээнд яриад оруулж ирээд байгаа юм биш биз? Сүүлийн үед сонин сонин хуулиуд орж ирж байна. Эцсийн дүнд том толгойтой, том төр л үлдэх гээд байна. Үүнийг та бүхэн анхаарна уу. Тийм учраас би энэ үндсэн чиглэл гэгчийг чинь дэмжиж чадахгүй нь. Үүнийгээ буцаан татаж аваасай гэсэн хүсэлтийг тавьж байна.

## **Олонхи, цөөнхийн алинд нь ч шийдэл байхгүй**

*“Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг огцруулах тухай” асуудлыг хэлэлцсэн УИХ-ын Чуулганы Нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс: /2013 оны 12-р сарын 24/*

С.Дэмбэрэл: - “Том төрийн” хүмүүс, хоёр “том сайд”-ыг /Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, уул уурхайн сайд Д.Ганхуяг/ огцруулах тухай ярилцаж байна. Огцруулах үндэслэлүүд болон хэлэцэж байгаа байдлыг харахад 2 тийшээ хэт туйлширч байна. Төгс төгөлдөр, эсвэл адгийн муу 2 сайдын тухай бид ярилцаж байгаа юм биш. 2 хувь хүн гэхээсээ илүү, удирдаж байгаа 2 институцид нь маш их алдаа байдаг. Алдаатай бодлогууд ч явуулж л байдаг. Цөөнхийн гишүүдийн өмнө байгаа цааснууд бол үнэн бодит баримтууд. Оны эхэнд үнэ ямар байсан. Одоо ямар болсон бэ гэдгийг л харуулж байгаа цааснууд. Гэтэл үүний шийдлүүд нь хаана байна вэ? Шийдлийг гарган ирж байгаа хэн байгаа юм бэ? Тухайлбал, инфляцийг тогтворжуулахын тулд юу хийх талаар УИХ-ын олонхи болон цөөнх болсон Улс төрийн намуудын нөхөд та нарт ямар нэг улс төрийн шийдэл байна уу? Байхгүй байна. Ийм нөхцөлд нэг зүйлийг анхаарах ёстой. Тэр яригдаад байгаа 3-4 хуулийг УИХ өөрөө зөрчсөн. УИХ өөрөө тэрийг нь баталж өгсөн. Засгийн газар тэрийг нь хэрэгжүүлдэг. Гэхдээ

бас сайн ажилладаггүй. Энд төгс төгөлдөр ажилладаг нэг ч институци байхгүй. Яагаад гэвэл бид өөрсдөө дөнгөж саяхан алдаагаа олж мэдсэн нь “бид том төр байгуулчихсан юм байна” гэдэг ухаарал. Тэгээд одоо эхнийхээ алхмыг хийх гэж байна. Том төрөө өөрчлөх гэсэн замын зургыг гаргах гээд будилж явна. Энэ тохиолдолд, огцруулах гэж байгаа энэ 2 сайдыг сайн муу ажилласан гэхээс илүү, улс төрийн том асуудал болж хувирч байна. Монгол улсын эдийн засагт хөрөнгө оруулсан гадаад дотоодын бүх хөрөнгө оруулагчид “энэ улсын төр, засаг нь тогтвортой байгаасай, урт хугацааг харсан, миний хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн шийдлүүд гарч байгаасай гэж харж байгаа. Үнэхээр том төрийг бус, ухаалаг төрийг хүсч байгаа хүмүүс л юм бол, энэ утгаар нь эдгээр сайдыг огцруулах, эс огцруулах асуудалд бид хандах ёстой.

Нөгөө талаас, олонхи цөөнхийн алиных нь ч бай, бүгдийнх нь эдийн засагт хандах хандлага үнэхээр хоцрогдсон байна. Ганцхан зүйлийг ажиглачих. Та бүхний гаргаж тавьсан зөв, буруу бүх аргуудын ард зөвхөн “эдийн засгийн өсөлт” гэсэн ганц л зүйл явж байна. Өнгөрсөн хугацаанд байсан бүх засгийн газрууд эдийн засгийн энэ хоосон өсөлтийг шүтэж байсан. Үүний үр дүнд инфляци буурдаггүй бөгөөд “хамгийн их дарлагдсан ард түмэн” болох бизнесийнхэн одоо хүртэл зовсоор байна. Тийм учраас одоо хийгдэх гэж байгаа реформ чинь үүний эсрэг чиглэж байгаа юм. Зах зээлийн харилцаанд орсоноос хойш, ямар ч засгийн үед юмны үнэ бууж байгаагүй. Энэ зах зээлийн нийгэмд төр оролцох тусам л мөнгөний ханш унаж, юмны үнэ өсч байсан. Үүний илрэл нь төсвийн хариуцлагаар тодорхойлогдож байна. Тухайлбал, би Ч.Улаан сайдын саяын хариултанд гайхаж байна. Ямар ч логикоор бодсон,  $(2+1)=(3-)$  байсан үед л төсвийн тодотгол хийх ёстой байтал,  $(2+1)=(-5)$ -ийн үед тодотгол хийнэ хэмээн дүгнэж, 3 хувийн хариуцлагагүй байдлыг өөгшүүлж байгаа нь буруу. Та өөрөө үүнийг сайн ажиглаж, судлаарай. Тэгээд үүнийг анх хийж байсан хүмүүстэйгээ сайтар зөвлөлдөөрэй. УИХ-ын Эдийн засгийн байнгын хороон дээр үүнийг авч хэлэлцээсэй гэж би хүсч байна. Ийм байдлаар төсвийг хариуцлагагүй байдал руу оруулж байгаа бол энэ нь инфляцийг л хөөрөгдөнө. Өнгөрсөн 20 жилийн турш, валютын ханшны талаар нэг л бодлоготой явж ирсэн. Тэр нь зүгээр л “тэвчье” гэсэн бодлого. Энэ жил л өөрчлөгдөж байна шүү дээ. Үнэнийг нуугаад байх хэрэггүй. Бид энэ жилээс л валютын ханшийг удирдах гэж дөнгөж “оролдож эхэлж” байна. Байдал ийм л байна. Тийм учраас битгий эдийн засаг ярьж уралдаад бай. Тэр улс төрөө л ярьцгаа. Тэгээд та бүхний “зөвшилцөл” мэднэ.

## **Туйлшралгүй, дундын хувилбар байна**

*Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 12 сарын 18-ний өдрийн хуралдааны тэмдэглэлээс: Монгол улсын засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Монгол Улсын ерөнхийлөгчөөс 2013 оны 6 сарын өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх цээр*

**С.Дэмбэрэл:** - Улсын их хурлын гишүүн засгийн газрын гишүүн болж ажиллахад сөрөг тал байдаг л юм байна л даа. Давуу тал байна уу, үгүй юу? Миний харж байгаагаар олон улсын талаас нь давуу талууд байх шиг санагдаад байх юм. Жишээлбэл, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин сайд болчихоод бидний ажлыг яаж саатуулаад байна? Ч.Сайханбилэг сайд яаж саатуулаад байна, яг юу нь болохгүй байна? Бид нөгөө талаас нь бас харах ёстой биш билүү? Өөрөөр хэлбэл, УИХ өөрөө үйл ажиллагаагаа явуулах институцийнхаа бүтцийг сайжруулаагүй, менежментээ сайжруулаагүй болохоор чинь энэ асуудал гарч ирээд байгаа юм биш үү? Нэг л талаас нь харж яригдаад байна. Нөгөө талаас нь харах цонх байна уу? Яаж харж байгаа вэ? Бид зөвхөн хууль санаачлагч төдийгүй бодлого гаргагчид шүү дээ.

2. 2016 он гэдэг үндэслэлийг тайлбарлаж өгнө үү?

**Х.Тэмүүжин:** - Бид нар судалгаа хийж үзсэн. Улсын их хурлын тамгын газрын судалгааны төвөөс авсан судалгаагаар ер нь энэ засгийн газрын гишүүний хавсран гүйцэтгэж байгаа гишүүдийн чуулганд сууж байгаа байдал, байнгын хорооныхоо хуралдаанд тогтмол оролцож байгаа байдал ирц нь маш муу гарсан. Өнгөрсөн жилийн судалгааг харахад тодорхой байгаа. Энэ нь парламент хэвийн, тасралтгүй үйл ажиллагаа явуулах зарчим алдагдахад тодрой хэмжээний нөлөө үзүүлж байна гэж харагдаж байгаа. Хууль тогтоох үйл ажиллагаа тасралтгүй явагдах ёстой. Нөгөө талаасаа давуу тал бас бий. Ер нь бол шүүх эрх мэдэлтэй харьцуулахад хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэл бол ерөнхийлөгчийн засаглалтай улс ч бай, парламентийн засаглалтай улс ч бай илүү нягт хамтын ажиллагаа шаарддаг. Энэ утгаараа болвол үнэхээр давуу талууд байна. Гэхдээ суурь зарчимтайгаа зөрчилдөхгүй байх ёстой. Таны хэлээд байгаа тэр Герман ч гэдэг юм уу өөр парламентийн засаглалтай улсуудад парламентэд үзүүлэх нөлөөлөл нь бага байдаг юм. Бид нар үүнийг судалж үзсэн. Нөгөө талаасаа манайх шиг орны хувьд бол үүнийг өөр арга механизм болгох арга байгаа. Салгачихаад, парламент нь парламентийнхаа хяналтыг сайжруулдаг өөр механизмуудаар дамжуулаад сул талыг нь нөхөөд явах бас боломж байгаа. Нөгөө талаас бид нарын оруулж ирсэн төсөлд засгийн газрын бүх гишүүд биш, ерөнхий сайд бас байж болно, тэр нь бас бодлоготой юм. Кабинетийг ерөнхий сайд бас зангидаж байгаа гэсэн утгаараа засгийн газрын бодлогыг зангидаж байгаа ерөнхий сайд бол дотроосоо байж болох юм гэсэн байр суурьтай байгаа. Бусад сайд нарын хувьд хавсран гүйцэтгэх нь монгол шиг цөөхөн гишүүдтэй дээрээс нь 39 гишүүн ирц бүрдүүлээд 20 гишүүн хууль батлах бололцоотой. Энэ бол зохимжгүй юм гэдгийг хэлэх гэж байгаа. Яагаад гэвэл тэр үндсэн хуулийн нөгөө нэг суурь зарчимтайгаа үндсэн зарчимтайгаа зөрчилдөөд байгаа учраас...

**С.Дэмбэрэл:** - Энэ асуудлыг хоёр тал руу хэт их явуулгүйгээр дундын вариант одоогийн байгаа байдлаар харагдаад байна. Практикаас, Монголын бодлого боловсруулж хэрэгжүүлдэг энэ үйл явц, институци хоорондын уялдаа, энэ чиглэлийн өөрчлөлт тогтож ирсэн бодлого энэ тэрийг хараад байхад, ерөнхий сайд, улсын их хурлын гишүүн байх нь их чухал ач холбогдолтойгоос гадна, ерөнхий чиглэлийн яамдын сайд нар үнэхээр УИХ-ын гишүүн байх хэрэгтэй юм. Нөгөө талаасаа, парламент

өөрөө гишүүдийгээ, өөрийнхөө институцийг ажиллуулдаг механизмаа төгөлдөршүүлээгүй байна. Энэ чиглэлээр эрс дорвитой өөрчлөлт хийгдэхгүй байгаа байдлыг энэ хуулыг хэлэлцэхдээ холбогдуулж авч хэлэлцэх ёстой. Мөн түүнчлэн Монгол улсын ерөнхийлөгч нэг хууль өгөөд, 6 сар болдог юм бол, С.Дэмбэрэл гэдэг жирийн гишүүн би нэг хууль өргөн баривал 2 жил болох юм байна. УИХ-ын даргын зөвлөлийн 7 хоног болгон өгдөг зүйлийн ард талын хавсралтанд тийм хууль 2010 онд орсон, 2011 онд санаачилсан гээд яваад байгаа. 2008 онд байгуулагдсан парламентийн хуулиуд шүү. Энэ мэтийн утгагүй зүйлийг цэглэх цаг нь болсон байна. Тийм учраас Дэгийн тухай хуулинд юм уу, ямар хуулинд байна аливаа хууль орж ирэхэд сарын дараа л тодорхой шийдэл гарч байдаг баймаар байна. Цааш явах юм уу, үгүй юм уу? Дараад суугаад байх юм уу, субъективизм орох юм уу гэсэн энэ бүх асуудлуудыг цэгцэлсэн байх хэрэгтэй. Бас дэгийн тухай олон санал ирсэн байгаа, энэнийг цэгцэлж замбараанд нь оруулахгүй бол болохгүй нь. Энэ маань л нөгөө парламентаа сайжруулъя гэсэн саналуудын маань нэг хэсэг нь шүү дээ. Энэ талаас нь бас бодож төрийн байгуулалтын асуудлыг хариуцдаг байнгын хороо маань цаашдаа энэ чиглэлээр тодорхой ажилуудыг санаачлаад хийх байх. Ялангуяа Дэгийн талаар, хууль орж ирчихээд хүн хууль санаачилчихаад байхад тэр нь удаад суугаад байдаг. Иймэрхүү хуулийн тэргүүчлэлийг тэр болгон зөв тогтоодоггүй. Гэнэт, гэнэт **хажуунаас буталзаад** гэнэтийн хуулиуд орж ирдэг. Иймэрхүү сонин зүйлүүдийг цаашдаа яаралтай байхгүй болгох чиглэлээр юм хиймээр байна. 2014 оны эхний улиралд багтаан Дэгийн тухай болон бусад холбогдох хуулиудад парламентийн үйл ажиллагааг, түүний бүтцийн институцуудыг сайжруулах чиглэлээр төрийн байгуулалтын байнгын хорооноос шаардлагатай бол бусад байнгын хороотой нийлээд, тодорхой өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай байгаа. Ганцхан жишээ хэлье, төсөв баталдаг. Одоо ингээд засгийн газрын 2 гишүүнийг огцруулах тухай ярьж байна. Өөрсдийнхөө төсөв батлах үйл явцаа хараарай. Яг бодит амьдрал дээр төсвийн байнгын хорооны дарга нь тухайн жилийн төсвийг оруулах ажлын хэсгийн ахлагчийг тойрч гүйгээд байгаа шүү дээ. Асуудал өөрөө ийм субъектив хандлагатай болчихсон. Гэтэл энд чинь процедурын алдаа байгаа. Иймэрхүү зүйлээс болж асуудал их үүсээд байгаа. Үүнийг цаашдаа анхаарах ёстой гэж үзэж байна

### **Бизнест нэмэлт дарамт учруулах, эрүүжүүлэх хандлагатай зүйлсийг хуулиас бүхэлд нь хасах хэрэгтэй**

*Эрцүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Монгол улсын хуулийн зарчмын зөрцүтэй саналын талаар анхны хэлэлцүцлэг дээр:*

*2 дугаар зүйл. Эрцүгийн хуулийн 166<sup>+</sup>, 178 дугаар зүйлийг дараах байдлаар дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:*

**1/166<sup>1</sup> дүгээр зүйл:****“166<sup>1</sup> дүгээр зүйл. Мөнгө угаах**

166<sup>1</sup>.1. Гэмт хэргээс хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж тцүнийг авсан, эзэмшсэн, ашигласан, эсхүл тцүний хууль бус эх үүсвэрийг нь нуух, далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, эсхүл тцүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эсхүл эд хөрөнгийн эрхийг нуусан, далдалсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавиас нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

166<sup>1</sup>.2. Энэ гэмт хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан, эсхүл албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн, эсхүл зохион байгуулалттай гэмт бцлэг үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурван зуугаас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

166<sup>1</sup>.3. Энэ гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол тодорхой төрлийн цйл ажиллагаа явуулах эрхийг хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурван зуугаас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.”

**С.Дэмбэрэл:** Энэ талаар УИХ дээр миний хэлж байсан үгийг анхааралтай сонссон байх гэж найдаж байна. Миний оруулж байгаа зарчмын зөрүүтэй санал бол 166.2-166.4 хүртэлх хэсгүүдийг энэ хуулийн төслөөс бүхэлд нь хасах хэрэгтэй гэсэн саналыг минь та бүхэн дэмжээсэй гэж хүсч байна. Яагаад гэвэл энэ хуулийн төслийн тэдгээр заалтууд нь өөр хуулиудаар зохицуулагдсан. Эрүүгийн хуульд хамааралгүй, эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой, “Шударга бус өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг” гэж нэрлэдэг төрөөс түүнийг зохицуулдаг тусгай институцитай, даргынх нь дайчин болон дайчин биш чанараас нь хамааралгүй үйл ажиллагаа нь хэрэгжиж байдаг зүйл юм. Хамгийн гол нь бүх юм нь хуулиараа бие даан зохицуулагддаг зүйл.

2. Х.Тэмүүжин сайдын яам манлайлан хэрэгжүүлж байгаа шинэтгэлийн үзэл санаанд шууд эсрэг зүйл байна.

3. Монгол улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачилсан Ухаалаг төрийн үзэл санаанд шууд харшилсан заалт байна.

4. Бизнес т нэмэлт дарамт учруулах, дээр нь бизнесийн үйл ажиллагааг эрүүжүүлэх хандлагатай зүйл байна. Тийм учраас саяны аргументийн үндэслэлүүдийг онцгой анхаарч, энэ хуулийн төслөөсөө 166.2-166.4 гэсэн хэсгийг бүхэлд нь хасаж, энэ хуулийн шууд хэлэлцэх ёстой асуудал болох терроризмтай тэмцэх, мөнгө угаах заалтуудад илүү анхаарах хэрэгтэй. Дашрамд хэлэхэд, иймэрхүү бизнесийн цаашдаа эдийн засгийн байнгын хороонд ямар механизм байдаг саналыг нь авдаг байвал зүгээр юм. Бид нар янз янзын байнгын хороонд харьяалагддаг. Бүгд өөр өөрийн хэсгээр төрөлжсөн. Тийм учраас харилцан бие биенийгээ дэмжиж явбал хууль

маань сайн гарах юм гэсэн үндэслэлээр энэ зарчмын зөрүүтэй саналыг оруулж байна.

## **Хүний эрх ба хувийн нууцад халдвал яах вэ?**

*Мөрдөх албаны тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Хууль зүйн байнгын хорооны ажлын хэсгийн 2013 оны 12 дугаар сарын 23-ны хуралдааны тэмдэглэлээс:*

**С. Дэмбэрэл:** Энэ хуулийн төслийн 38.3-т УИХ-ын тусгай хяналтын дээд хороо Мөрдөх албаны тусгай нууц арга хэрэгсэл, арга хэрэгсэл гэж тусдаа юм шиг байна. Хэрэгсэл ашиглан явуулах, мөрдөн шалгах хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн зарцуулалтад хяналт тавина гэсэн байна. Тусгай, нууц арга хэрэгсэл ашиглаад, тэр нь хүний эрхийг зөрчсөн, хүний эрхэнд халдсан тиймэрхүү нууц тусгай арга хэрэгсэлүүд /технологи талаасаа/-ээр үйл ажиллагаа явуулсан нөхцөлд хүний эрх зөрчсөн байхад тусгай хяналтын дэд хороо тэрнийг яагаад хянахгүй байгаа юм вэ? Тэрнийг ёстой хянаж баймаар юм. Өөрөөр хэлбэл мөрдөх албаны тусгай нууц арга хэрэгсэл ашиглан явуулсан үйл ажиллагаа нь хүний эрхийг зөрчсөн эсэхийг шалгах гэсэн өгүүлбэр байх ёстой юм шиг санагдаад байна. Энэнийг тодруулж өгнө үү?

2. Халхавчийн байгууллага гэсэн нэг юм гараад ирэх шиг боллоо. Бодвол umbrella гээд байгаа тийм уу? Халхавч гэдэг нь юу юм вэ? Энэ нь ямар хууль зүйн томъёолол вэ? тодруулж өгнө үү.

**Х.Тэмүүжин:** Эхнийх нь болохоор хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавина гэж байгаа. Хүний эрхийг хууль тогтоомжоор заагаад өгчихөж байгаа. Үндсэн хууль болон бусад хуулиараа хүний эрх бол ингэнэ тэгнэ гээд заагаад өгсөн байгаа. Хуулиараа бүх юмыг хэмжчихээр тэр хуулиар хэмжигдэж байгаа зүйлэндээ хяналт тавьж байж хүний эрхийг баталгаажуулж байгаа байхгүй юу. Тэгэхгүй эрхийг нь тавьчих юм бол хүний эрх хаана яаж баталгаажсан вэ гэсэн маргаан гарч эхлэх юм. Ямарч байсан мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж байгаа тусгай техник хэрэгсэл ашиглаад энэ чиглэлээр ажиллаж байгаа бол яг энэ байгууллага өөрөө хуулийн хүрээнд ажиллаж байна уу, үгүй юу гэдгийг хууль тогтооох тусгай хяналтын дэд хороо шалгах юм.

**С.Дэмбэрэл:** Тодруулъя. Жишээ нь, хүний e mail-ийн нууц кодыг мэдэх ч юм уу, тусгай арга хэрэгслийг нэвтрүүлээд хүний утасны яриаг чагнах гэдэг ч юм уу, бүр тэрнээс илүү юм болоод тэр нь өөрөө хүний эрхэнд халдсан гэдэг нь мэдэгдээд, энэ тохиолдолд тусгай хяналтын дэд хороо чинь тусгай хэрэгсэл ашиглан явуулах мөрдөн шалгах үйл ажиллагаа хууль тогтоомж хэрэгжилт тэдгээртэй энэ тусгай арга хэрэгсэлүүд нь технологийн талаасаа хүний эрхэнд халдаад, намайг мэдэхгүй байхад миний Үндэсний Хуулиар олгогдсон эрхэнд халдаад байхад тусгай хяналтын дэд хороо чинь энэнийг бас тодруулж хэлэлцэх ёсгүй юм уу? Мөрдөн шалгах үйл ажиллагааны



хууль тогтомж ашиглан явуулах гэж арга хэрэгсэл нь өөрөө цаанаа шууд хүний нууцад нэвтэрдэг байвал яах вэ? Надаас асуулгүйгээр миний бүх юманд нэвтэрдэг байвал яах вэ?

**Х.Тэмүүжин:** С.Дэмбэрэл гишүүний асууж байгаагаар бол зөвхөн үйл ажиллагаа биш тоног төхөөрөмж ч хууль ёсных уу гэсэн асуулт байна. Энэ нь хууль тогтоомж багтаагаад ойлгож байгаа. Тоног төхөөрөмж хууль ёсных уу, явуулсан үйл ажиллагаа хууль ёсных уу, энд зарсан мөнгө, тэгээд бас үнэхээр зарцуулж чадсан уу, үгүй юу гэдгээ бүрэн хянах бололцоотой болж байгаа. Үүнийг манай тусгай хяналтын дэд хороо мөрдөн шалгах үйл ажиллагаатай холбоотой хяналтыг тэр болгон явуулж үзээгүй. Энэ хуулиар тодорхой болгож өгч байгаа. Дэгийн тухай хууль бол тусгай хяналтын дэд хороотой холбоотой асуудлуудаар үүнийгээ хэрхэн яаж хэрэгжүүлэх вэ гэдгийг бас детальный нарийн зааж өгөх ёстой болж байгаа. С.Дэмбэрэл гишүүний түрүүний Халхавчын байгууллага гэдэг нь ил байдлаараа бол өөр чиглэлтэй байгууллага юм шиг харагдах боловч далд байдлаар мөрдөн шалгах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг байгууллагыг хэлж байгаа юм. Хүний наймаатай холбоотой гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд зуучлал юм уу зар сурталчилааны юм уу тийм нэг компани байгуулаад, тэрний ард тэр зуучилж байгаа үйл ажиллагааг хянахад зориулж, хянагдаж байгаа зохион байгуулалтыг хараад хууль сахиулах байгууллага гэдгийг нь мэдэхгүй байх ёстой. Ард нь бол хууль сахиулах үйл ажиллагаа явагдаж байх ёстой.

**С.Дэмбэрэл:** Ажлын хэсгийн ахлагчаас тодруулъя. Энэ санал хураалтанд оролцдог юм уу, үгүй юу эргэлзээ төрөөд явчихаа. Санал өгч байгаа хүмүүсийн саналаа өгч байгаа үндэслэлийг харахаар Монгол улсад 3 институци эрх ашгаа хамгаалахын тулд томилгоог хувааж авдаг гэсэн юм яриад байна. Энэ нь үнэн юм уу, худлаа юм уу? 3 институцийн эрх гэж юу вэ? Монголын ард түмний эрх ашиг гэдэг нэг л эрх ашиг баймаар юм. Тэр нэг эрх ашгийн ард бүх юм зангидагддаг. Хариуцлагатай хэлэх өгүүлбэрүүд гэж би ойлгож байна. Ажлын хэсгийг ахалж байгаа хүний хувьд та энүүн дээр ажлын хэсэг энэ чиглэлээр ийм юм байгаа юу гэдгийг хэлж өгөөч. 3 эрх ашиг гэж байдаг юм уу? Нэг л эрх ашиг байдаг гэж би гэнэн бодоод байдаг юм уу? Хэрэв 3 эрх ашиг байгаа юм бол би аль нэг талд нь орох гэж энэ ажлын хэсэгт ороод байгаа юу? Эсвэл би энэ ажлын хэсгээс гаръя. Тийм болохоор тодорхой хариулт хүсье. Тэгээд тэрний дараа энэ ажлын хэсэгт байх эсэхээ шийдье.

**Х.Тэмүүжин:** - Монгол Улс бол нэгдмэл нэг улс, нэг төртэй. Төр нь салаа мөчиртэй. Аливаа асуудалд улс төрийн өнцгөөс хандах, хардах, сэрдэх гэдэг үүднээсээ асуудалд хандаж байгаа хандлага нь нилээн өөр байна уу гээд бодож байна. УИХ-аасаа юу, засгийн газараасаа томилогддог байна уу, сайд нь томилдог байна уу? Энэнээсээ үл хамаараад ерөнхийлөгч нь сонгодог байна уу үүнээсээ үл хамаараад нэг л нэгдмэл Монгол төрийн үйл ажиллагааг сайжруулж, ялангуяа мөрдөх албатай холбоотой асуудал болвол Монголын нийгэмд иргэдээ амгалан тайван амьдруулахаар хийгдэж байгаа ажлуудын нэг гэж үзэж байгаа.

## **Хүний эрх чөлөөнд халдсан, бизнесийн хязгаарлагдмал байгаа өчүүхэн эрх чөлөөг нэмж боймилсон юмыг битгий оруулж ир**

*УИХ-ын намрын ээлжит чуулганы 2014 оны 1-р сарын 9-ны өдрийн Нэгдсэн хуралдаанаар “Эрцүгийн хууль, Эрцүгийн байцаан шийтгэх тухай, Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, цйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд”-ийг УИХ-аар хэлэлцэх эсэх тухай асуудал яригдах үед:*

С. Дэмбэрэл: Аюултай заалтууд орж ирсэн байна. Юуны өмнө үүнийг хэн оруулж ирсэн бэ? Монголбанк оруулсан байх гэж би таамаглаж байна. Ийм балай зүйл орж болохгүй. 166-р зүйлийг бүгдийг нь хасах хэрэгтэй. Энэ бол өвчлөл, юу ч мэддэггүй хүмүүсийн өвчлөл. “Хамгийн их дарлагдсан ард түмэн” болох бизнесийнхэний талаар ямар мэдээ өгч байгаа юм бэ? Нөгөө ухаалаг төр чинь хаана байна? Ийм балай юм оруулж ирэхээ боль. Тийм учраас үүнийг би эсэргүүцэж байна. Дөнгөж сая Х.Тэмүүжин сайдтай ярилцсан чинь, сайд бас үүнийг эсэргүүцэж байна. “Үүнийг Монголбанк оруулсан юм шиг байна” гэж байна. Алдаа гаргаж болно, ойлгоод хасах ёстой. Ялангуяа Эдийн засгийн байнгын хороо болон бусад хороодод ч энэ хамаарна. Ийм чанаргүй, эсрэг зүйл оруулж ирдэг ийм юмыг ер нь таслан зогсоё. Х.Тэмүүжин сайдыг сая би магтсан. Буруугаа дор нь ойлгоод, үүнийгээ больё гэж байна гэж магтаж байгаа юм. Энэ зөв. Гэхдээ энэ ямар байнгын хороогоор орох юм бэ? Цаашид иймэрхүү балай юм оруулж ирэхгүй байх хэрэгтэй. Монголбанкинд хатуу хэлмээр байна. Дахиж ийм хүний эрх чөлөөнд халдсан, бизнесийн хязгаарлагдмал байгаа өчүүхэн эрх чөлөөг нэмж боймилсон юмыг битгий оруулж ирж байгаарай. Тэгсэн мөртлөө мөнгө угаах, терроризмтэй тэмцэх тэр заалт маань банкны системийн тогтвортой байдлыг хангах гэсэн болохоос биш, өрсөлдөөний тухай хуулинд тодорхой байж байдаг хуулиараа зохицуулагддаг зүйлүүдийг эрүүгийн хуулинд авчирж оруулаад эрүүгийн гэмт хэргийн шинэ зүйлүүдийг тусгаж, эрүүжсэн Монгол улс болгох заалтуудыг оруулж ирж байгаа бол маш буруу. Тийм учраас хуулийг цаашид хэлэлцэхийг ерөнхийд нь дэмжиж байна. Гэхдээ эсэргүүцэж байгаа зүйлүүдийгээ зүйл заалтаар нь хэллээ шүү. Өөрөөр хэлбэл, эсэргүүцэн дэмжиж байна гэсэн томъёололоор. 166-гийн мөнгө угаахтай холбоотой асуудлыг бид сайн ярилцаж байгаад дэмжиж болно. Нэг зүйлийг сануулъя. Саяхан бид маш их эв санааны нэгдэлтэйгээр Монгол Улсад маань хөрөнгө оруулалт хэрэгтэй байна гээд, Хөрөнгө оруулалтын тухай хууль баталсан. Гадаад дотоодын хөрөнгө оруулагчдад иймэрхүү төслийн хэмжээнд орж байгаа энэ заалтууд хүртэл ямар ойлголт төрүүлэх вэ? Юу гэж бодох вэ? “Энэ улс чинь ганцхан арга л мэддэг юм байна, шоронд оруулах эсвэл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 300-500 дахин нэмэгдүүлэх гэсэн ийм л заалттай, ямар сонин, хөгийн улс вэ” гэж бодохоор байна. Дотоодын бизнес эрхлэгчид нь “биднийг улам дарлах гэж байна, ерөнхийлөгч нь худлаа хэлдэг юм байна, Ухаалаг

төр нь ч худлаа юм байна...” гэж бодохоор ийм заалтуудыг оруулж ирж байна. Цаашид иймэрхүү юмыг хуулинд оруулж ирэхдээ өөрийнхөө хийж байгаа юмны эсрэг битгий юм хийгээч. Ухаалаг төрийн төлөө, засгийн газраас хэрэгжүүлж байгаа төрийн зохицуулалтын реформ, хүнд суртлыг арилгах, үүнд садаа болж байгаа зүйлсийн эсрэг байх хэрэгтэй. Сүүлийн үед Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар яг ийм заалтуудаар ерөнхий сайдын толгойг эргүүлж эхэлсэн. Ерөнхий сайдын сүүлийн 3-4 удаагийн ярилцлагаас үзэхэд ерөөсөө хамгийн гол аюул бол шударга бус өрсөлдөөн гэж үзээд байгаа. Энэ бол буруу ойлголт. Хамгийн зөв ойлголт бол, Монгол улсад шударгаар өрсөлдөх орчин нөхцлийг төр нь өөрөө бүрдүүлж өгөхгүй, төр нь өөрөө бизнес хийгээд, түмэн олныхоо бизнесийг дарамтлаад эхэлсэн. Тийм учраас бид Ухаалаг төр лүү шилжье гэсэн. Ийм байдалтай байхад иймэрхүү зүйлүүдийг зүгээр төсөл маягаар оруулж ирж байгаа нь маш буруу юм биш үү? Баярлалаа.

Төсөлд орж ирсэн заалт:

### **3/166<sup>2</sup> дугаар зүйл.Зах зээл дэх давамгайл байдлаа хууль бусаар ашиглах**

166<sup>2</sup>.1.Зах зээлд дэх давамгайл байдлаа хууль бусаар ашиглаж өрсөлдөөнийг хязгаарлах, устгахад чиглэсэн хэлцэл хийж, цэгсэн хуйвалдаж зохиомлоор тухайн бараа бүтээгдэхүүний хомсдол бий болгосон, бараа бүтээгдэхүүний цйлдвэрлэл, борлуулалтыг зогсоосон, хэмжээг хязгаарласан, бараа бүтээгдэхүүнд үндэслэлгүйгээр хэт өндөр үнэ тогтоосон, бусад аж ахуй эрхлэгч зах зээлд гарч ирэхэд саад учруулах, тэдгээрийг зах зээлээс шахан гаргах зорилгоор бараа бүтээгдэхүүнээ бодит зардлаас хэт доогуур үнээр борлуулсан, өрсөлдөгч аж ахуйн нэгж, иргэний аж ахуйн цйл ажиллагааг зах зээлд оруулахгүй хясан боогдуулж бусдад онц их хэмжээний хохирол учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавиас нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

166<sup>2</sup>.2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээд цйлдсэн бол тодорхой төрлийн цйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурван зуугаас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

### **4/166<sup>3</sup> дугаар зүйл.Зах зээлийн үнэ хөөрөгдөх**

166<sup>3</sup>.1.Бараа, бүтээгдэхүүн, эд хөрөнгө, түүхий эд, цйлчилгээ, мөнгө, валют, үнэт цаасны зах зээлийн үнийг зохиомлоор өсгөх, эсхүл бууруулах зорилгоор худал мэдээлэл тараасан, эсхүл бараа, бүтээгдэхүүн, эд хөрөнгө, түүхий эд, цйлчилгээ, мөнгө, валют худалдсан, худалдан авсан, гүйлгээ хийсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавиас нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

166<sup>3</sup>.2.Энэ гэмт хэргийг албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж цйлдсэн, зохион байгуулалттай гэмт бүлэг

цйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавиас гурван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

166<sup>3</sup>.3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээд цйлдсэн бол тодорхой төрлийн цйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурван зуугаас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

#### **5/166<sup>4</sup> дүгээр зүйл. Аж ахуйн цйл ажиллагааны нууцад халдах**

166<sup>4</sup>.1.Хувьцаа нь олон нийтэд нээлттэй арилжаалагддаг хувьцаат компаний нийтэд зарлаагүй мэдээллийг ашиглан уг компаний хувьцаа, үнэт цаасыг борлуулсан, худалдан авсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2 дугаар зүйл.Эрцүгийн хуулийн 166<sup>4</sup>, 178 дугаар зүйлийг дараах байдлаар дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/166<sup>4</sup> дүгээр зүйл:**

#### **“166<sup>4</sup> дүгээр зүйл. Мөнгө угаах**

166<sup>4</sup>.1.Гэмт хэргээс хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж тцүнийг авсан, эзэмшсэн, ашигласан, эсхүл тцүний хууль бус эх ццсвэрийг нь нуух, далдлах, гэмт хэрэг цйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжцүлсэн, эсхүл тцүний бодит шинж чанар, эх ццсвэр, байришил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эсхүл эд хөрөнгийн эрхийг нуусан, далдалсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавиас нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

166<sup>4</sup>.2.Энэ гэмт хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан, эсхүл албан тушаалтан албаны чиг цүрэг, бцрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж цйлдсэн, эсхүл зохион байгуулалттай гэмт бцлэг цйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурван зуугаас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

166<sup>4</sup>.3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээд цйлдсэн бол тодорхой төрлийн цйл ажиллагаа явуулах эрхийг хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурван зуугаас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.”

**Жич:** энэхүү чуулганы хуурлын дараа уг хуулийн төслийн тухайн зүйл заалтыг санаачлан оруулж ирсэн албан тушаалтан УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлийг үгээр дайран басамжилж, “багалзуурдах” гэж оролдсон бөгөөд энэ тухай нэг хэсэгтээ хэвлэл мэдээлэлээр багагүй шуугиан дэгдсэн билээ.

## **Яасан ч бие биенийгээ шоронд хийх дуртай юм бэ?**

*УИХ-ын Намрын ээлжит чуулганы 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс: Эрцүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрцүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг дээр*

С.Дэмбэрэл: Энэ хуулийг анх Чуулганы Нэгдсэн хуралдаанд оруулж ирэхдээ асуудлыг сайн ойлголгүй, буруу, хольж оруулж ирсэн байсан. Тиймээс ч би эсэргүүцэж үг хэлсэн. Тэр нь хасагдсан гэсэн боловч, мэргэжлийн үг хэллэгээр дахин орж ирж байна. Гэхдээ Монгол хэлэнд энэ нь огт бууж сонсогдохгүй байна. Insider /албаны байр суурийнхаа хүчээр нууц мэдээллийг олж авсан хүн / trading /худалдах/ гэдэг чинь legal, illegal /хууль ёсны, хууль бус/ гэсэн хоёр өөр хэлбэртэй. Энэ “хууль бусаар” гэдгийг нь л энэ хуулинд оруулах гээд байгаа шүү дээ. Тиймээс “хууль бус” гэдэг үгээ л оруулах хэрэгтэй. Энэ хэрэг нь нотлогдсон байх ёстой. Гэхдээ үүнээс өмнө явагдах процесс нь хөрөнгийн биржийн зөвлөл мэргэжлийн түвшинд үүнийг нь авч хэлэлцдэг үйл явц бас байх ёстой. Үүнийг манай байнгын хорооныхон болон ажлын дэд хэсгийнхэн бодолцмоор байна. Ажлын хэсэгт саяхан Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга, Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооныхныг дуудсан. “Танай мэргэжилтэй холбоотой асуудал хуулинд орох гэж байна. Ийм заалтыг та нар зөвшөөрч байна уу?” гэж лавлаж гэж байна. Ийм байдлаар лавлаад асууж байх нь зүйтэй шүү. Цаашид ажлын дэд хэсэгт албан ёсоор орох эсэхийг нь мэдэхгүй байна. Эртээдийн хурлууд дээр лав харагдаагүй.

2. Market manipulation буюу Үнийг өсгөх, буруулах эсэх талаарх “хөрөнгийн зах зээл дээрх нууц мэдээллийг хууль бусаар ашиглах” тухай асуудлыг бас хөндөж ярьмаар байна. Өөртөө байсан нууц мэдээллийг ашиглаад, хувьдаа давуу байдал үүсгэхээр хийж байгаа үйлдлийг үнийн манипуляци гэдэг. Manipulation гэдгийг урвуулан ашиглах гэх юм уу, үнийг хөөрөгдөх, буруулах гэх юм уу гэдгээ тогтмоор байна. Ер нь энэ заалтыг тодорхой зааж өгсөн хууль бусад улс орнуудад цөөхөн байх шүү. Америкийн Нэгдсэн Улсад тусгай хуулиар зохицуулсан ч гэсэн маш их хэрүүл маргаантай байдаг бөгөөд үүнийг батлах гэж маш олон процедур болдог. Энэ процедурыг нь үл хайхран, бодит туршлагыг сайн анхааралгүйгээр, шууд ингээд “эрүүжүүлээд” /эрүүгийн гэмт хэрэг болгоод/ заачихаж болж байгаа юм уу? Яасан ч бие биенийгээ шоронд хийх дуртай юм бэ? Үүнийг анхаарвал яасан юм бэ? Эртээд ямар хууль орж ирсэн билээ, тэгээд больсон биш үү? Одоо Монгол хэл зүйн үүднээс болон гэмт хэргийн зүйл заалтын доторх агуулгынх нь талаас давхар бодоод үзээч. Яг ингэж заах ёстой юм уу? Энэ талаар та нар хороондоо дахиж нэг ярьвал зүгээр байх гэж бодож байна.



**С.Баярцогт:** С.Дэмбэрэл гишүүний хэлж байгаагаар анх орж ирэхдээ 66.2 бол зах зээл дахь давамгайл байдлаа хууль бусаар ашиглах гээд маш өргөн утгатай, эдийн засгийн харилцаанд орж байгаа субьектэд бүхэлдээ хамаарахаар байсан. Одоо бол цэвэр үнэт цаасны зах зээлд, дотоод мэдээллээ ашиглаж, шунахай сэдлээр, хууль бус үйлдэл хийж байгаа асуудлаар хязгаарлаж байгаа. 66.3 бол анх орж ирэхдээ зах зээлийн үнэ хөөрөгдөх гээд бүхэлдээ эдийн засгийн бүх салбарт хамаарагдахаар байсныг үнэт цаасны хуулинд нийцүүлээд, үнэт цаасны зах зээлд хуурамч арилжаа хийх, үнэт цаасны ханшийг зохиомлоор тогтоох, үнэт цаасны зах зээлд оролцогч харилцагчийг хууран мэхлэх замаар арилжаанд орох гэсэн яг энэ хэлбэрт тааруулж, багасгасан зүйлүүд байгаа. Хэллэгийн хувьд бол өмнө М.Энхболд, Ц.Нямдорж нарын гишүүдийн хэлээд байсан зүйлүүдийг бид ажлын хэсэгт бас ярьсан. Нэгэнт өмнө гарсан хуулиудад ийм нэрээр нэрлэгдээд орсон байгаа учраас үүгээр нь хэрэглээд явья гэж шийдсэн. Цаашдаа анхаарах нэг зүйл бол эрүүгийн гэмт хэргийн субьект нь хуулийн этгээд байгаа явдал бол туйлын эргэлзээ төрүүлж байгаа. Зарим улсууд энэнийг үндсэн хуулиараа хаасан байна. Холбооны Бүгд Найрамдах Герман улс бол “Эрүүгийн гэмт хэргийн субьект нь хуулийн этгээд байж болохгүй” гээд хаачихсан. Манайх тусгай ангиараа нээж байгаа. Энэнийг маш их хэмжээгээр хязгаарлахгүй бол болохгүй ийм зохицуулалт байгаа. Цаашдаа анхаарах ёстой. С.Дэмбэрэл гишүүний санаа зовж байгаа зүйлтэй би яг ижил санаатай байгаа. Тийм учраас нилээд нарийвчилж, хязгаарлаж, зохицуулалт хийсэн.

## **Нэмэгдсэн өртгийн албан татварын зөв системийг бид сонгож авч чадсан юм уу**

*УИХ-ын Чуулганы 2014 оны 01 дүгээр сарын 24-ны нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс: “Аж ахуйн албан татварын тухай хууль нэмэлт оруулах тухай нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг хэлэлцэх цээр*

**С.Дэмбэрэл:** Татварыг хялбаршуулах, татварын хувь хэмжээг багасгах асуудалд миний хувьд байнгын дэмждэг байр суурь баримталдаг. Өнөөдрийн ороод ирсэн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг дэмжиж байна. Гэхдээ ганц зүйл хэлмээр байна. Одоо Монгол улсад 80:20, 90:10, 96:4 гэсэн буруу харьцаатай бүтцийн гажигууд, эдийн засгийн буруу бодлогын илэрхийллүүд тогтчихсон байгаа. Энэ бүхнийг өөрчлөх том шинэтгэл хэрэгтэй. Энэ шинэтгэлийн нэг хэсэг нь татварын шинэтгэл. Татварын шинэтгэл нь дотроо 2 зүйлийг гол болгодог. Нэг нь цаг хугацаа, нөгөөх дэс дараалал. Энэ талаасаа, миний хамтарч боловсруулсан хуулийн төслийг хэлэлцэхээр болсон шүү дээ. Даргын зөвлөл дээр дараагийн удаад хамтруулаад хэлэлцэхээр ярьсан гэдийг та бүхэнд мэдээлэл өгье. Б.Чойжилсүрэн гишүүний гаргаад байгаа тэр зүйл бол бодит амьдралын үндэслэл. Өнөөдрийн бодит амьдрал дээр Нэмэгдсэн өртгийн татвартай холбоотой 10 төрлийн хүндрэл байдаг. Эдгээрийг нэг бүрчлэн гаргаж



ирээд, тэрэнд зарцуулдаг хугацаа, зардлыг нэг бүрчлэн гаргаад үзэхээр, нэмэгдсэн өртгийн албан татварын зөв системийг бид сонгож авч чадсан юм уу гэсэн суурь асуулт гарч ирдэг. Яагаад гэвэл, манайх маш их аж үйлдвэржсэн, зах зээл өндөр хөгжсөн улс орнуудын маш нарийн, нийлмэл, хэцүү нэмэгдсэн өртгийн татварын НӨТ-ийн системийг хуулж авчиргаад тавьчихсан байдаг. Энэ нь бүх судалгаагаар нотлогддог. Тийм учраас хэлэлцэх явцад 2 - 3 асуудал ярих ёстой.

1. Босго нэмэгдүүлэх асуудал эдийн засгийн бодит амьдралд хэр зэрэг гажуудлуудыг яаж үүсгэж байсан бэ, яаж үүсгэх вэ гэсэн нэг асуудал.

2. Нийт татварынхаа түвшингээ багасгаж, 3-5% болгоод, бүгдээрээ татвар төлөх. Тэгээд аж ахуйн нэгжүүдэд хамгийн их хүндрэл учруулдаг 10 төрлийн гацаанууд буюу садаа бэрхшээлүүдийг, /жишээлбэл, нягтлан бодох бүртгэл дээр гэхэд л олон төрлийн дансаар явдаг.../ арилгах зүйлийг иж бүрнээр нь хамт хийе. Сайн ярилцаад, иж бүрэн шинэчлэлийн маягаар үүнийг хийж чадвал, цаашдаа аж ахуйн эрхлэгчдэд жам ёсоороо өсөж дэмжихэд нь маш чухал хэрэгцээтэй татварын шинэчлэл болно. Тийм учраас төслийг дэмжиж байгаа юм.

3. 90% -ийг буцааж олгох гэдгийг бас дэмжиж байгаа. Гэхдээ бас нэг зүйл бодох хэрэгтэй. Төлсөн татварынх нь 90%-ийг буцааж олгодог системийг үүсгэхээсээ илүү, 5% татвар луу шилжих явдлыг зэрэг бодож болохгүй юу? Татварын хувь хэмжээг 10% -аар хийж болсон юм чинь, 5% болгож бас болно шүү дээ. Нэгэнт авсан татварынхаа 90% -ийг буцааж өгч чадна гэж үзэж байгаа юм бол авах татварынхаа хувийг багасгах нөхцөл бололцоо, нөөц байна гэсэн үг. Энэ талаас нь бодож татварын реформыг иж бүрэн хийвэл яасан юм бэ? Нэмэгдсэн өртгийн татварын хувьд бол бүх намууд оролцсон, мэргэжлийн хүмүүсийг оролцуулсан маш том ажлын хэсэг байгуулаад ярилцмаар байна. Сангийн яам оруулж ирээд, зөвхөн төсвийн байнгын хороон дээр үүнийг хэлэлцэнэ гэдэг бол physical талаас нь буюу төсвийн талаас хараад байгаа хэрэг. Гэтэл эдийн засгийн хөгжлийн яам, эдийн засгийн байнгын хороо хаачихсан юм бэ? Энэ бүх юмыг оролцуулсан татварын реформ гэдэг талаас нь хандмаар байна. Энэ бол зөвхөн physical шинжтэй, төсөв бүрдүүлэх арга хэрэгсэл бишээ. *Эдийн засгийн хөшүүрэг гэдэг талаас нь бодсон реформыг хийе* гэсэн саналтай байна. Энэ чиглэлээр ажлын хэсэг байгуулагдаасай гэсэн бодолтой байна. Баярлалаа.

## **Зөвшөөрлүүдийн 50 хувь нь хэрэггүй**

*NEWS.MN-ын сурвалжлагч УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлтэй уулзаж, бизнесийн байгууллагуудад чиглэсэн зарим зөвшөөрөл лицензүүдийг хүчингүй болгож байгаа ажлынх нь талаар ярилцлаа. Мөн ярианыхаа төгсгөлд ам.долларын ханшны өсөлтийн буруутны талаар товч тайлбар авсан юм.*

- Энэ Засгийн газрын үед, одоогоор хүчин төгөлдөр үйлчилж буй зөвшөөрөл лицензүүдийн бараг талыг нь хүчингүй болгох нь гэсэн сураг сонсогдож байгаа. Энэ яг ямар учиртай ажлын хэсэг байгуулагдаж, хэчнээн зөвшөөрлийн хэдийг нь хүчингүй болгохоор ажиллаж байгаа юм бэ?

**С.Дэмбэрэл:** - Монгол Улсад хүнд суртал бизнесийн орчинд дарамт ихээр үзүүлдэг. Ерөнхийдөө тусгай зөвшөөрөл, лицензийн тоо нь 1000 хүрчихэж. Үүн дээр бүтэн жилийн турш ажлын дэд хэсэг ажилласан. Бүх яамд “Манайд ийм тооны зөвшөөрөл, лицензүүд байгаа. Эдгээрийг нь хасч, багасгая. Үүнийг нь үлдээе.” гэсэн байдлаар хамтран ажиллаж байгаа. Гэхдээ шийдвэрлэхэд хүндрэлтэй зөвшөөрөлүүдийг нь дээд түвшинд буюу УИХ-ын гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг рүү оруулж ирж шүүнэ. УИХ-ын гишүүн Ч.Сайханбилэг, С.Дэмбэрэл, Д.Гарамгайбаатар, Д.Зоригт, С.Бямбацогт нар энэ хэсэгт багтаж байгаа. Энэ хэсэг, яамдын авч үлдэе гэсэн зөвшөөрлүүдийг нь гурван үндэслэлээр дахин шалгаж байна.

1. Энэ тусгай зөвшөөрлийг гаргах хууль зүйн үндэслэл нь юу вэ?
2. Энэ зөвшөөрөл нь байхгүй болсон тохиолдолд яах вэ?
3. Уг зөвшөөрлийг үгүй болгосноор бизнест ямар нөлөөтэй вэ?

Гэсэн асуултуудад тулгуурлан шийдвэрлэнэ гэсэн үг. Яамд энэ гурван үндэслэлээр тухайн зөвшөөрөл лицензүүдийг авч үлдээхүйц итгэл үнэмшил төрүүлэх, хамгаалж чадах эсэхээс хамааран, мөн бизнесийн төлөөллийнхөн уг асуудалд хэрхэн хандаж байгаа зэргийг харгалзан бидний зөвлөмж гарна. Энэ бүхний үр дүнд бизнест садаа болдог, бизнес эрхлэх цаг хугацаанаас нь хумсалдаг, авлига руу түлхдэг зүйлс мэдэгдэхүйц хэмжээгээр буурах болно. Жишээлбэл, Зам тээврийн яамныхан жаран хэдэн зөвшөөрлөө авч үлдэе гэж байна. Үүнийг нь бид судалж байгаа. Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны хувьд цөөхөн хэдий ч хэрэггүй зөвшөөрөл бас байна гэж яригдлаа. Бас, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг заавал яаман дээрээ байлгах биш тухайн чиглэлээр мэргэшсэн төрийн бус байгууллагууд руу гэрээний үндсэн дээр шилжүүлэх тухай яригдаж байгаа.

- Яг зөвшөөрлийн тооны хувьд хэд юм бэ? Ерөнхийлөгч энэ тоог өмнө хэлэхдээ мянга хэдэн зуу гээд, ажлын хэсэг дээр 900 гаруй гээд, бүр өмнө нь зөвшөөрлийн тоо 200 гаруй байдаг тухай ч ярьдаг байсан. Энэ бүх тооны зөрүү нь зөвшөөрөл гэдгийг ойлгох ойлголтын зөрүү байгаагаас холбоотой юу?

**С.Дэмбэрэл:** - Зөвшөөрөл гэдэг ойлголт өөрөө их өргөн хүрээтэй. Ажлын хэсгийнхэн хуульд байгааг нь тоолсноор 900 хүрсэн, Нэг хэсэг зөвшөөрлийн тоо 1200 давсан байсныг нь хүчингүй болгосоор энэ тоонд авчирсан юм. Одоо бол энэ 900 дээр нь ажиллаж, талыг нь хүчингүй болгоё гэж оролдож байна. Мөн хуульд байхгүй, хуулиас гадуур, зөвшөөрлийн үйл ажиллагааг журамласан тохиолдлууд сайдын тушаал, даргын тушаалаар бий болсон гээд олон байна. Зөвшөөрлийн механизм бий болгох шаардлагаа тодорхойлоогүй, үндэслэл гаргахдаа ганц талын саналыг авсан, ингэхгүй л бол болохгүй нь гэж өөртөө ачаалал авсан, бусдад дарамт болсон зүйлийг оруулж ирсэн учраас тусгай зөвшөөрлийн тоо хэлбэлзэж байгаа юм. Түүнчлэн нэг хууль гараас гарахдаа нэг агентлаг, нэг байгууллага, нэг хэсэг зөвшөөрлийг бий болгож байдаг нь ч үүнд нөлөөлсөн байх. Тусгай зөвшөөрлүүд маань яг ингэж, хогийн ургамал шиг нэмэгдсээр байгаа юм. Иймд бидний зорилго бол одоо байгаагаа цэгцлэх, дахин үүсэхээс нь сэргийлэх л зорилготой байна.

- Дахин үүсэхээс яаж сэргийлнэ гэсэн үг вэ?

**С.Дэмбэрэл:** - Хуульд, төрийн оролцох оролцоог хязгаарлаж өгнө гэсэн үг.

**- Ойлгосонгүй?**

**С.Дэмбэрэл:** - Тусгай зөвшөөрлийг багасгана. Таныг бизнес хийх гэж байхад чинь тусгай зөвшөөрөл өгнө гээд, олон баримт бичиг шаардана гэдэг чинь төрийн оролцоо биз дээ. Бие даасан хууль нь байгаа. Тэр хуульд өөрчлөлт оруулна. Мөн дээрээс нь Ерөнхийлөгчийн институцийн зүгээс санаачилсан, “Төрийн аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах тухай” хуулиар зохицуулна. Төр нь адилхан хүрз бариад нүүрс ухаад байх биш, бодлогодоо анхаарлаа хандуулаад өөрсдөө бизнес хийхгүй болно. Төр аливаа салбарт бодлогоо гаргаад, хувийн байгууллагуудын өрсөлдөх орчинг бий болгохын оронд, төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулаад, хувийн хэвшлийнхнээс давуу талтай оролцдог байдлыг өөрчлөх болно.

**- Хэлэлцүүлгийг ажиглахад, зөвшөөрлөө цуцлуулах гэж байгаа байгууллагуудын байр суурийг харахад, асуудалд хандах хандлага нь дургүйцсэн, эсэргүүцсэн байдалтай байна. Эсэргүүцэл хэр байна?**

**С.Дэмбэрэл:** - Үнэхээр хандлага нь дургүй байгаа биз? Манайхны сэтгэлгээ нь ийм болчихсон. Чамайг өөрөөсөө хамааралтай болгох, амыг чинь, хөл гарыг чинь цаасаар скочдох сонирхол нь инстинк байдлаар төрдөг байх. Төрийн бяр чадал нь хуурамчаар амтагдагдаж, тэр амталсан амтаараа ямар нэг зүйл сэдэж, тэрийг нь сайд дарга нар нь тушаал, тогтоол болгон гаргаж өгдөг систем манайд амь бөхтэй байна.

**- Жишээ сонсмоор байна. Энэ газраас олгодог ийм зөвшөөрөл ямар ч хэрэггүй гэж нэрлэх жишээ байна уу?**

**С.Дэмбэрэл:** - Хасах гээд байгаа лицензүүд дотор дүүрэн л тийм жишээ байна. Замын хөдөлгөөний дүрэм бол хэрэгтэй. Зам дээр жип болон эксел ижил эрхтэй. Зам дээрх зохицуулагч буюу төр нь шүгэлдэх, торгох эрхтэй. Гэхдээ илүү зүйл хийж болохгүй. Хүнээс мөнгө авч болохгүй. Нөгөөдүүл нь техникийн бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй. Гэтэл өнөөдөр техникийн бүрэн бүтэн байдлыг хангах үүргийг нь төр хангах гээд байгааг л хэлээд байгаа юм. Төр өрсөлдөөнийг бий болгох үүрэгтэй болохоос биш оролцох шаардлагагүй. Өнөөдөр яригдаж буй зөвшөөрлүүдийн 50 хувь нь хэрэггүй, шууд бизнес рүү гар дүрсэн зүйл их байна. Яагаад төр маань А, Б нарт бөөний худалдаа, эсвэл жижиглэнгийн худалдаа эрхлэхийг заагаад байгаа юм бэ? Хувь хүн өөрийнхөө бизнес төлөвлөгөө, зах зээлээ хараад би энд бөөний худалдаа эрхлэх үү, эсвэл жижиглэнгийн худалдаа эрхлэх үү гэдгээ шийдэх сонголт байх ёстой биз дээ.

**- Хүмүүсийн хамгийн их мэддэг жишээ нь барилга барихтай холбоотойгоор авдаг зөвшөөрлийн тухай. 128 гарын үсэг тамга даруулах гэж 128 өдрийг зарцуулж байхын оронд хоёр давхар барилга барьчих боломж байсан гэж ярьдаг шүү дээ. Энэ жишээн дээр ярьвал 128 зөвшөөрөл хэд болж буурч байгаа вэ?**

**С.Дэмбэрэл:** - Наад асуудлыг чинь 2010 оноос хойш ярьсан. Худалдаа аж үйлдвэрийн танхимаас анх удаа барилга барихын тулд 128 гарын үсэг зуруулдаг тухай асуудал дэвшүүлсэн юм. Тухайн үеийн ерөнхий сайд, барилгын асуудал эрхэлсэн сайдад харуулахад ийм зүйл байдаг юм уу гэж гайхаж байсан. Тухайн үед багасгасан. Энэ удаад ч улам бүр багасна. Ер нь 70 орчим зөвшөөрөл байна даа. Үүний заримыг нь болих, заримыг нь мэргэжлийн төрийн бус байгууллагуудад өгөх тухай ч яригдаж байна.

Тусгай зөвшөөрөл байх ёстой гэж хамгаалаад байгаа талууд гол зөвтгөлөө “аюулгүй байдал”-тай л холбоод байдаг. Жишээ нь алим оруулж ирэхэд зөвшөөрөл авах ямар шаардлагатай юм. Тухайн компани хортой алим оруулах гэвэл шалгадаг мэргэжлийн хяналтын байгууллага байна, мөн компани яагаад стандартаа бариад явахыг, зах зээл дээрх нэр хүндээ алдахгүйн тулд ажиллана гэж бодохгүй байгаа юм. Ер нь нэг л стандарттай болоод, түүнийгээ л мөрдөө л дөө.

**- Төгсгөлд нь, ам.долларын ханшийн өсөлтөөс үүдэлтэй эдийн засаг маань хэцүүдэж байгаа шалтгааны талаар асуухгүй өнгөрч болохгүй нь...**

**С.Дэмбэрэл:** - Уг нь бүр долоон сараас эхэлсэн асуудал шүү дээ. Валютын зохицуулалтын тухай хууль гэж бий. Тэр хуульд тодорхой зохицуулалтыг зөвшөөрсөн байдаг. Тодруулбал, валютын ханшийг удирдах тухай заалт бий. Уг нь удирдана гэхээр ганцхан интервенц хийхийг хэлдэггүй л байхгүй юу. 2013 оныг хүртэл валютын ханшны дэглэмийн тухай зохицуулалт байгаагүй. Ганц өгүүлбэр л байсан нь “валютын ханш чөлөөтэй, уян хатан тогтоно” гэсэн зүйл л байсан. Жил бүрийн мөнгөний бодлого дээр тэр өгүүлбэр нь орж ирээд, хэн ч үүнийг сонирхдоггүй, шууд л баталдаг байсан. Валютын ханш суларсан, чангарсан гэх асуулт гардаг байсан ч хамгаалах, удирдах механизм нь байхгүй байсан. Харин 2014 оны мөнгөний бодлогод энэ механизмийг нь анх удаа суулгасан бөгөөд “Валютын ханшны эрсдлээс хамгаалах механизмийг улсын хэмжээнд бий болгоно” гэсэн заалтыг оруулж өгсөн юм. Гэвч үүнийг хэрэгжүүлж өгөхгүй байна.

**- Хэн хэрэгжүүлэхгүй байна?**

**С.Дэмбэрэл:** - Төв банк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо. Энэ гурав чинь хамтдаа Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийг бүрдүүлдэг юм. Энэ гурав чинь Монгол Улсын санхүүгийн байдал тогтвортой байхыг, түүний нэгэн хэсэг болох валютын зах зээлийг тогтвортой байна уу, үгүй юу гэдэг дээр байнга дүгнэлт хийж зөвлөлдөж, арга хэмжээ авч байх ёстой. Валютын ханш чангарахад ч сулрахад ч сөрөг, эерэг үр дагавартай. Экспортод сайнаар нөлөөлдөг, импортод сөргөөр нөлөөлдөг гэдэг нь үнэн л дээ. Монгол Улс анх удаа гадаад худалдааны баланс хангагдлаа гэж ярьж байна. Үүнд нь та нар бүгд үнэмшээд л сайхан гээд л бичээд явж байгаа. Гэтэл энэ баланс бол эцсийн зорилго биш л байхгүй юу. Валютын ханш нь эцсийн дүндээ инфляцийн түвшинд нөлөөлөхгүй хэмжээнд, эсвэл маш бага нөлөөлөх хэмжээнд удирдлагыг хангах ёстой. Төсвийн орлогын хувьд валютын өсөлт нь ашигтай. Гэхдээ ард түмний орлогод ашиггүй. Аль нь чухал юм бэ. Инфляци нь чухал уу, төсвийн орлого нэмэгдэх нь чухал уу. Хэдийгээр 2013 онд анх удаа валютын ханшийн бодлогыг өөрчилсөн ч үйлдэх байхгүйгээр, эс үйлдэл давамгайлуулаад сууж байна. Интервенц хийхээс гадна валютын ханшийн эрсдлээс сэргийлэх бодлого явуулах учиртай. Хууль зүйн хувьд ийнхүү боломжийг нь бий болгочихоод байхад юу ч хийсэнгүй. Өнгөрсөн жилийн валютын ханшийн шокон дээр, биднийг наадамлаж байхад буюу долоон сарын сүүлчээс өсч эхэлсэн. Наймдугаар сарын сүүл хүртэл, бүр есөн сарын дунд хүртэл дээш явсаар л байсан. Гэтэл энэ хугацааны үеийн протоколыг нь харах гэхээр Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл нь нэг ч хуралдаагүй, бүгд амарчихсан байгаа юм. Зөвхөн

Төвбанк ажиллаж, бусад нь амраад алга болчихсон байсан. Тэднийг хуралдсан эсэхийг, хуралдсан юм бол валютын асуудлыг хэлэлцсэн үү гэдгийг нь протоколоос нь л хармаар байна. Өнөөдөр валютын ханшны өсөлтөөс болж иргэдийн амжиргаанд нөлөөлж байна. ААН-үүд тендрээс зугтаж эхэллээ. Үүнд төр оролцохоос аргагүй биз дээ? Иргэд, ААН-үүдээс хамааралгүйгээр валют өслөө, гадаадын хөрөнгө оруулалтыг төр өөрсдөө үргээлээ. Ханшийн өөрчлөлтийг урьдчилж харж чадаагүй нь хэний буруу юм бэ? Бодлогын түвшинд авч үзэхгүйгээр за гайгүй болно доо, мөнгө орж ирнэ дээ гээд хүлээгээд суух юм бол юу ч аяндаа бүтэхгүй л дээ. Магадгүй энэ асуудлыг ээлжит бус чуулганаар хэлэлцэх ёстой л байх.

*Б.Мандах*

### **С.Дэмбэрэл, танхим хоёр овоо доо**

“Зуд болохоор нохой зоолдог” гэгчээр эдийн засаг хямарч, төгрөгийн ханш ул болсон өнөө цагт Монголд валютаар зээл өгсөн банкууд, зээлийн төвүүд “бурзайж” байна. Тэднээс гадаад мөнгөн дэвсгэртээр зээл авсан иргэд, аж ахуйн нэгжүүдийн хэтэвч нимгэрч, данс улайжээ. Өнгөрсөн оны долдугаар сараас хойш ам.доллар өнөөг хүртэл 300-400 төгрөгөөр өсч огт буураагүйн хохирогчид хэдэн зуугаараа байхад хожлын эзэд нь дэндүү цөөн байна. Ийм л болохоор жижиг, том гэлтгүй компанийн захирлууд хямралаас гарах гарцаа цомхотгол хэмээн харж, үр дүнд нь хэдэн мянган хүн ажилгүй болохдоо туллаа. Ханш өсгөсөн буруутныг хайж олоод олны өмнө хариуцлага тооцно гэж амласан Засгийн газар нь таг чиг. “Бүх юмыг сайхнаар бод” гэж сургадаг Эдийн засгийн хөгжлийн сайд хаана байгаа юм, бүү мэд. Хөрөнгө оруулалт буурч, валютын урсгал татрахад жанжины үүрэг гүйцэтгэсэн хуулиар наадагчид ч хариуцлагаас холуур өнгөрч одлоо. Хариуд нь үндэстнийхээ эд эс болсон иргэд, эх орны эдийн засгийг нуруун дээрээ авч яваа үйлдвэрлэгчид өөрсдийнхөө буруугүйгээс, тааж тааварлах боломжгүй хариуцлагагүйн зуднаас болж өссөн ханшийн хохирогч болон үлдэв. Анхнаасаа 1384 төгрөгт валютын ханшийг барина гэж амласан Эдийн засгийн хөгжлийн сайд, түүнийг дэмжсэн Засгийн газар ч, тэрнийг нь баталсан хууль тогтоогчдын хэн нь ч хариуцлагаа хүлээе хэмээн нэг удаа дуугарсангүй.

Иргэн таны төлөө гүйе, харайя, бараг л галд ч хамаагүй оръё гэж сонгуулиар баахан шоуддаг парламентчид, төр, засгийн эрхмүүд нүүрээ буруулсан энэ үед МҮХАҮТ-ынхан болон УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл зах зээлийн цоорхойгоор монжигчдыг илчлэх бодит “газрын зураг”-ийг дэлгэн тавилаа. Энэ бол Иргэний хуулийн 218 дугаар зүйлд заасан Гэрээний үүргийг гэрээ байгуулсан үеийн ханшаар тооцож төлөх тухай хууль зүйн үндэслэл байсан юм. Нэг үгээр хэлбэл, бизнесийнхний буруугүйгээс, тааж тааварлах боломжгүй хүнд нөхцөл байдалд ханш унах, эсвэл өсөхөд зээл олгосон арилжааны банкууд анх гэрээ хийсэн үеийн ханшаар эргэн төлөлтийг тооцох тухай хуулийн заалт энэ байв. 2002 онд батлагдсан Монгол Улсын Иргэний хуулийг одоо хэр нь банкууд,



санхүүгийн байгууллагууд мэдсэн ч мэдээгүй юм шиг царайлж, гэрээ хэлэлцээртээ багтаалгүй ирсээр өнөөг хүрчээ. Зах зээлийн шударга ёс, хүнд нөхцөл байдлыг тэнцвэржүүлэх учиртай энэ хуулийн алтан заалтыг иргэд ч мэддэггүй байсны гороор монголчууд санхүүгийн зах зээлийн “боолчлол”-д өртсөөр ирсэн нь энэ байлаа.

Монгол Улсын Иргэний хуулийн 218 дугаар зүйлд мөнгөний ханш хэмээн юуг тодорхойлов. Энэ хуулийн 218.1-д “Төлбөр гүйцэтгэх хугацаа болохоос өмнө мөнгөний ханш өссөн, буурсан бол үүрэг үүсэх үеийн ханшаар тооцож төлбөрийг төлнө” гэжээ. Тэгвэл биднээс хол, тэгсэн хэр нь бидний санхүүгийн аюулгүй байдлыг сахин хамгаалахад чухал нөлөөтэй энэ хуулийг хууль, шүүхийн байгууллагууд өөр өөрийнхөөрөө тайлбарлаж буй нь байдлыг улам тодорхойгүй болгож буйг МҮХАҮТ-ынхан мэдэгдэлдээ дурдсан байлаа. Ингэхдээ чухам мөнгөний ханш, үүрэг үүсэх үе гэж юуг хэлэх вэ гэсэн хамгийн чухал ойлголтын үнэн мөнийг энэхүү мэдэгдэлд онцгойлон тэмдэглэжээ. “Энэхүү заалтаар төлбөр гүйцэтгэх хугацаа болохоос өмнө мөнгөний ханш өөрчлөгдсөн тохиолдолд үүрэг гүйцэтгэгч үүрэг үүсэх үеийн ханшаар тооцож үүргээ гүйцэтгэхийг маш тодорхой, ойлгомжтой заажээ. Өөрөөр хэлбэл энэхүү заалтаар мөнгөний ханш өссөн, буурсан бол төлөх өдрийн бус, харин гэрээ байгуулсан өдрийн ханшаар тооцохоор заасан” хэмээн тодорхойлжээ. Тэгвэл үүрэг үүсэх үе гэж юуг хэлэх вэ гэвэл Иргэний хуулийн 187 дугаар зүйлийн 187.1-д “Үүрэг нь энэ хуулийн наймдугаар зүйлд заасан үндэслэлээр үүснэ” гэжээ. Тухайлбал, Иргэний хуулийн наймдугаар зүйлийн 8.1.1-д “Хуульд заасан болон заагаагүй боловч агуулгын хувьд хуульд үл харшлах хэлцэл”-ийн үндсэн дээр үүрэг үүснэ гэсэн байна. Хэлцэл гэдэг нь Иргэний хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-ийн дагуу иргэний эрх үүргийг үүсгэх, өөрчлөх, шилжүүлэх, дуусгавар болгох зорилгоор илэрхийлсэн иргэн, хуулийн этгээдийн үйлдэл, эс үйлдлийг хэлдэг. Иргэний эрх зүйн хэлцэл байгуулагдсан үеийг үүрэг үүсэх үе гэж үзэх ба гэрээнд гарын үсэг зурж үүрэг хүлээсэн өдрийн ханшаар төлбөрийг төлнө, харин талууд гэрээгээр төлбөр төлөх үүргийг дараа гүйцэтгэхээр тохирсон бол тэр үеийн ханшаар үүргийг гүйцэтгэнэ гэсэн ойлголт эндээс гарч байгаа юм. Тэгэхээр өнөөдөр ханш ийнхүү чангарсан энэ нөхцөлд бид энэ хуулийн заалтаар санхүүгийн хүнд нөхцөл байдлыг даван туулах боломж олдож байна. Анх ам.долларын зээлээ 1357 төгрөг байхад авсан хүмүүс Засгийн газрын 1384 гэсэн амлалтад найдаж хүлээхийн зуурт зээлээ одоогийн 1790 төгрөгөөр бодож төлөх шаардлагагүй юм байна. Үүний оронд анх гэрээ хийсэн 1357 төгрөгөөр зээлээ төлөх боломжийг хууль бидэнд ийнхүү олгожээ. Одоо энэ заалтыг нь хэрэгжүүлэх, хэрэгжилтийг нь шаардах эрхээ эдлэх л үлдэж байна.

Ийм чухал хуулийн заалтыг нийгэмд хямралыг давах гарц болгон мэдэгдэж, ил хэр нь дарагдсан үнэнийг дахин илчилсэн МҮХАҮТ, С.Дэмбэрэл хоёр овоо доо.

*Ж.Цогзолмаа*

*2014 оны 04 дүгээр сарын 02. “Зууны мэдээ” сонин*



## Хариуцлага нь дэндүү их биш үү?

*2014 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдааны тэмдэглэлээс: “Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төсөл, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл” хэлэлцэх үеэр:*

С.Дэмбэрэл: - Бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн тухай маш их гомдол мэднээ. Би өөрөө Улсын их хурлын гишүүн болоод жил болсоны дараа Улсын Их Хурлын Тамгын газарт захиалга өгч бараа үйлчилгээний хуулийн замын зураг ямар байна вэ гээд авч танилцсан. Түүн дээрээс харахад одоогийн байгаа хуулийн схем нь маш хэцүү. Миний асуух гээд байгаа асуулт маань нэгдүгээрт энэ хуулинд хичнээн процедур байсан бэ, одоо хэд болсон бэ, үүнд зарцуулах хоног нь яг хэд болж байгаа вэ, яагаад ингэж асуугаад байна вэ гэвэл одоогийн хуулийг уншаад үзсэн чинь хууль маань хялбаршсан байна уу, үгүй юу гэдэг дээр эргэлзэх гээд байна. Тендерийн хэлбэр болгон өөрөө дандаа процедур дагуулдаг. Одоогийн хуулинд байгаа нийт процедур багассан тохиолдолд түүнд зарцуулах цаг хугацаа бодитойгоор багасах ёстой, нэгдүгээр асуулт маань энэ. Хоёрдугаарт, бизнес эрхлэгчдийн олон жил ярьж байгаа тендер шударга биш байна, хаалттай байна, ил тод биш байна, хээл хахуулийг дагуулж байна гэх мэт шалтгаанууд энэ шинэ хуулинд яаж хангагдсан бэ?, өөрөөр хэлбэл аливаа зүйлийг тунхаглаад хуулинд зарчмууд оруулж болно. Энэ зарчмуудын маань үзэл санаа нь дараагийн хуудсандаа хуулиндаа шингэсэн байх ёстой. Манай хуулиудын нэг дутагдал болохоор, би их олон хууль дээр сүүлийн үед ажиглаад байна л даа, зарчмуудаа их сайхан гаргаж өгчихөөд цааш нь уншаад явахаар нөгөө зарчмуудын үзэл санаа нь арын хуудсандаа шингээгүй (тусгагдаагүй) байдаг. Жишээ нь, өнөөдрийн энэ хууль дээр хамгийн гол зүйл болох хөндлөнгийн хяналтын механизм гэж байхгүй байна. Хөндлөнгийн хяналт байхгүй бол энэ хууль яаж ч гараад нэмэр байхгүй. Энэ асуудлыг цаашид хэрхэн шийдэх гэж байна вэ? Хуулиндаа тусгаж өгөх юм уу, үгүй юу? Гуравдах асуулт маань, одоо амьдрал дээр бодитоор яригдаад байгаа нэг асуудал байна. Гэрээ гэж байна. Гэрээний агуулгад валютын ханшны эрсдэлийг тооцох механизм нь яаж тусгагдсан бэ? Эцэст нь нэмж асуухад нэг чухал юм байна. Хуулийн төгсгөлд хариуцлага гээд бүтэн хоёр хуудас, 25 шийтгэл, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг бараг нэг их наяд хүргэхээр болсон байна. Манай хуулиудын сүүлийн дутагдал бас үүнтэй холбоотой. Хоёр хуудас дүүрэн бичсэн 25 ширхэг шийтгэлээ болио. Энэ бол арай дэндэж байна. Тэгсэн мөртлөө захиалагчийн эрх үүрэг гэж биччихээд, гүйцэтгэгчийнх нь эрх үүрэг байхгүй. Өөрөөр хэлбэл иргэний хуульд ч байгаа шүү дээ оролцогч талуудын эрх үүргийн тэнцвэрийг хангаагүй хууль ороод ирсэн байнаа Батбаяр сайд аа. Үүнийгээ засахгүй бол болохгүй шүү. Энэ маань асуулт биш санал шүү.

**Н.Батбаяр:** Нэгдүгээр асуултын хувьд бид схем зураг хийсэн байгаа. Тэр схем зургаа та бүхэнд тараагаад өгье. Хоёрдахь асуултын хувьд аливаа зүйл маань олон нийтийн хяналт дор орж байж л ил тод болно. Ингэхийн тулд бид бүхэн юу хийсэн бэ гэхлээр шалгарсан болон ер нь шалгаруулалтанд оролцож буй бүх компанийн мэдээллийг нийтэд ил тод болгож байгаагаараа онцлог. Бүх мэдээллийг цахим хэлбэрт оруулна. Өөрөөр хэлбэл манай улс аливаа зарлагдсан тендерт оролцож байгаа компаниудын талаарх мэдээллийн нэгдсэн сантай болж байна гэсэн үг. Дараагийн асуултын хувьд бол хариуцлагын асуудал байх ёстой. Огт байхгүй болгож болохгүй. Гэхдээ би таньтай нэг зүйл дээр санал нэг байна. Хариуцлага хоёр талдаа байх ёстой гэдэг дээр. Тэр талаар санал оруулсан байгаа. Бидний оруулсан зүйлийг хангалтгүй гэж үзэж байгаа бол хуулийг хэлэлцэх явцын дунд нэмж оруулах бол нээлттэй шүү. Валютын ханшны зохицуулалтыг хэрхэн хийх талаараа хуулийн хэлэлцүүлгийн үед бүгдээрээ ярилцъя. Хэнд ямар санал байна.

**С.Дэмбэрэл:** Нэг зүйлийг тодруулья. Гомдол гаргах эрхгүй, захиалагчийн шийдвэр эцсийнх байна гээд Үндсэн хуулийн заалттай зөрчсөн гомдолтын талаар хэдэн зүйл заалтууд байна. Би хариуцлага байхыг зөвшөөрч байгаа. Хэтэрхий их болсон байна гэж хэлээд байна. Тэгсэн мөртлөө төрийн буюу захиалагчийн эрх үүргийг маш сайн тодорхойлж өгсөн. Нөгөө гол ажил хийж байгаа гүйцэтгэгчийн томъёолол нь байгаа мөртлөө эрх үүрэг байхгүй болчихоод байгаа. Үүнийг л би хэлээд байгаа. Цаашид маш сайн анхаарах хэрэгтэй шүү. Маргаан шийдвэрлэх механизм чинь бас байхгүй байна шүү. Энэ бүхнийг сайн анхаараарай.

## **Татварын өршөөл үзүүлэх нь хамгийн чухал**

*2014 оны 06 дугаар сарын 13-нд “Бизнес таймс” сонинд өгсөн ярилцлага:*

- УИХ-аар татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх асуудлыг хэлэлцэж байна. Энэ нь эдийн засгийг эрчимжүүлэхэд нэлээд түлхэц болно гэж үзэж байгаа. Харин аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг үзүүлснээр гарах үр дүн юу байх бол?

**С.Дэмбэрэл:** - УИХ-ын эдийн засгийг идэвхжүүлэх тухай тогтоолын төслийн анхны санаачлагч би, мөн Зоригт гишүүн. Энэ асуудлыг дөрвөн сар ярилцаж, хэлэлцэж байж гарлаа. Харин үүний дараа Засгийн газраас эдийн засгийг эрчимжүүлэх тухай 100 хоногийн төлөвлөгөө, "Эзэн 100" хөтөлбөрийг гаргасан. Үүн дотор УИХ-ын эдийн засгийг идэвхжүүлэх тухай тогтоолын гол үзэл санаа бүгд орсон байгаа. Тэгэхээр үүн дотор гурван гол зүйл бий. Нэгдүгээр асуудал бол татварын өөрчлөлт, шинэчлэл. Ерөнхийдөө татварын шинэчлэл хийе гэсэн нэг үзэл санаа байгаа. Хоёрдугаарт, эдийн засгийн өршөөл үзүүлэх. Гуравдугаарт, бизнесийн орчныг цэвэрлэе гэдэг үзэл санаа явж байгаа. Өөрөөр хэлбэл, элдэв бусын хүнд суртал, тусгай зөвшөөрөл, лицензийн асуудлыг цэгцлэе гэж үзэж байгаа юм. Засгийн

газраас татварын шинэчлэлтэй холбоотой хэд хэдэн хуулийг өргөн барьж, УИХ-аар ороод ирж байна. Харин УИХ-ын дарга "Бүх хуулийг нэгтгэж байгаад татварын шинэчлэл хийх зорилго бүхий ажлын хэсэг байгуулах ёстой" гэж үзээд захирамж гаргасан. Ажлын хэсэгт есөн гишүүн багтаж, ахлагчаар нь С.Баярцогтыг томилсон. Ажлын хэсэгт надаас эхлүүлээд бүх намын төлөөлөл багтсан. Харин УИХ-ын дарга яагаад ач холбогдол өгч, тусгай захирамж гаргасан гэвэл, Засгийн газраас орж ирсэн хуулиудад засвар, өөрчлөлт хийх биш. Иж бүрэн шинэчлэл хийе гэдгээр тусгасан байгаа.

**- Засгийн газрын мөрийн хөтөлбөрт татварын шинэчлэлийн хоёр дахь үе шатыг хэрэгжүүлэхээр тусгасан. Харин УИХ-аас захирамж гаргаж, ажлын хэсэг гарсан нь Засгийн газартаа үүрэг өгөх бүхий асуудал уу?**

**С.Дэмбэрэл:** - Засгийн газрын оруулж ирсэн хуулийн дагуу, бодсон үзэл баримтлалын хүрээнд явуулна гэдэг учир дутагдалтай. Яагаад гэвэл, Засгийн газраас өөрөөр бодож байгаа хууль санаачлагч гэвэл, жишээ нь би байна. Тиймээс Засгийн газар, гишүүдээс өргөн барьсан татварын хуулиудыг шинэчлэлийн уур амьсгалтай болгох, энэ дотор Ч.Улаан сайдын яриад байгаа 250 гаруй хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг оруулах. Нөгөө талаас босго, хэмжээг нэмэгдүүлэх, эвсэл татварын 90, НӨАТ-ын хоёр хувийг буцааж олгох зэрэг элемент орж ирнэ. Энэ бүгдийг бүхэлд нь аваад үзэхээр шинэчлэл биш.

**- Тухайлбал, татварын шинэчлэлд юу дутагдалтай байгаа хэрэг үү?**

**С.Дэмбэрэл:** - Шинэчлэл хийхийн тулд олон жил явж ирсэн тогтолцоо, Монголын эдийн засгийнхаа бодит байдлыг харах хэрэгтэй. Монголын эдийн засаг, татварын оршин байгаа дэглэмийн орчинд хоёр хуваагдсан. Өөрөөр хэлбэл, албан, албан бус эдийн засаг гэж болсон. Албан бус дотроо сүүдрийн эдийн засаг гэсэн өөрөөр бус зүйл тогтол бий болсон байгаа. Мөн бүх компани татварын хоёр баланс гаргадаг. Нэг нь худлаа хэлдэг, нөгөө нь өөрсдөдөө үзүүлдэг жинхэнэ баланстай. Тэгэхээр эдийн засгийг ийм байдлаар үргэлжлүүлээд явна гэвэл цөөхөн татвар төлдөг компанийг дарамтлах, шалгах, торгох, хүү торгууль бодох замаар явна гэвэл явцгүй. Тиймээс учраас үүнээс болж хүмүүс шоронд ороод байгаа юм. Энэ тохиолдолд үүнийг анхааралтай, онцгой, иж бүрэн хандах ёстой. 250 гаруй хөнгөлөлт, чөлөөлөлтийн ихэнх хэсэг нь хүн амтай холбоотойгоос гадна талдаа бизнес, импорттой нөлөөлж байх жишээтэй.

**- Хэтэрхий их хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх нь эргээгээд татвараа бүрдүүлэх асуудалд хүндрэл гарах юм биш үү?**

**С.Дэмбэрэл:** - Ер нь олон улсын татварын онол, практикийн дагуу хэтэрхий их хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх нь буруу. Танхим, ажил олгогч эздийн холбоо, хувийн хэвшлийн үндэсний зөвлөл ч гэдэг юм уу, хувийн хэвшлийн ерөнхий нийтлэг бодлого нь хөнгөлөлт, чөлөөлөлт гэхээс илүүтэй нийт татварынхаа хэмжээг багасгах асуудал тавьдаг. Хэдийгээр Монгол Улсад 4/10 бодлого, дээр нь уул уурхай, үл хөдлөхтэй холбоотой олон татвар бий. Түүнээс гадна төрөл бүрийн гувчуур, хураамж байдаг. Энэ бүхэн нийлээд 2,9 сая хүнтэй жижиг зах зээлд том, хурдан эргэлт хийх боломжийг олгохгүй. Ерөнхийдөө компаниуд өсөж чадахгүй давжаа биетэй, архиттай хүүхэд шиг байгаад байна. Томчуул нь болохоор мөнгөө

гадагшаа гаргаж хадгалаад байна. Өөрөөр хэлбэл, бүх компани татвараас зугтаж байгаа.

**- Татварын бодлого буруу байгаагаас зайлсхийдэг алхам байгаа хэрэг биз?**

**С.Дэмбэрэл:** - Татварын бодлого буруу яваад байгаа. Ийм тохиолдолд хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлнэ. Хоёр хувийг буцааж олгоно гэдэг энэ бүхэн бүхэлдээ явахгүй. Тийм учраас татвараа шударга байх зарчмаар бүгдээрээ төлөх ёстой. Ингэснээр сүүдрийн эдийн засгийг ил гаргаж, албан бус секторыг албан болгох явдал. Харин татварыг бууруулахаар төсвийн орлого яах бол гэж боддог. Гэтэл төлдөггүй хэсэг нь ил гарч ирээд төсвийн орлого ихэнх тохиолдолд нэмэгддэг.

**- НӨАТ-ыг худалдааны татвар болгоё гэдэг зүйл яригдаж байсан. Энэ тухайд...?**

**С.Дэмбэрэл:** - Энэ хоёрын ялгааг ойлгохгүй байгаа юм. НӨАТ, худалдааны албан татвар угтаа нэг зүйл. Гэхдээ хэлбэр өөр. Одоо Монголд нутагших гэж, хүмүүсийг шоронд оруулж, хуурамч падан бичүүлээд байгаа НӨАТ-ын системийг аж үйлдвэр өндөр хөгжсөн улс оронд хэрэглэдэг. Манайх шиг ажил үйлдвэр нь хөгжөөгүй, дээр нь хөдөө аж ахуй, үйлчилгээний салбар давамгайлсан үед хялбаршуулах, давхардаггүй болгох зорилгоор худалдааны буюу бараа үйлчилгээний татвар гэдэг хэлбэр рүү орох ёстой. Энэ нь давхардахгүй, нэг л удаа авдаг байх юм. Татварын шинэчлэлийг зөвхөн төсвийн орлого талаас биш хүмүүсийн тархины сэтгэлгээг өөрчлөх талыг бодож хийх ёстой. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг нэг хувь, зарим тохиолдолд тэглэх. Томоохон аж ахуйн нэгжийг эдийн засгийн бодлогоор дэмжээд татварын хэмжээг өндөр байдлаар тавьж болно. Тэгэхээр энэ бүхнийг хийе гэж бодоход үүнийгээ дагалдуулаад өршөөл үзүүлэхийг оруулах хэрэгтэй. Зөвхөн татварын өршөөл биш. Гадаадад хөрөнгөө нууж, татвараа шударга төлдөгт нь урамшуулах үзүүлэх эдийн засгийн өршөөлийг нийт аж ахуй нэгж, иргэнд нэг удаа эдлүүлж болох юм. Ингэснээр цаашлаад нэг эдийн засагтай болж, татвараа нуух шаардлагагүй болно. Нөгөөтэйгүүр компаниуд зөв баланстай болсноор Хөрөнгийн бирж дээр үнэн зөв хувьцаа гардаг. Үүнээс нь Хөрөнгийн бирж хөгжихөд түлхэц болж, санхүүгийн бусад арга хэрэгслүүдэд хөрөнгө оруулалтын сан үүснэ.

**- Манайхан нийлүүлэлтийн талаар дэмжлэг үзүүлэх зүйл ажиглагдаж байна. 100 хоногийн дараа эдийн засаг сайжрах уу гэдэг нь асуудал?**

**С.Дэмбэрэл:** - Иргэд худалдан авах чадваргүй боллоо. Зах зээлийн нэг тал байхад нөгөө тал нь байхгүй байна. Орон сууцны зээл авсан залуус төлбөрөө яаж төлөх вэ гэхээс бусад зардлаа нөхөж чадахгүй байгаа юм. Энэ чинь эдийн засгийн эргэлтийн тал дээр идэвхжил байхгүй болж байгаа хэрэг. Тэгэхээр хүн амын орлогын албан татвар, дээр нь нийгмийн даатгалын шимтгэлийг хөнгөлөхөөр хүмүүсийн худалдан авах чадвар нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл, зах зээлийн нийлүүлэлтийн талын нэмэгдэх ч энэ тал дутагдаад байгаа. Тиймээс татварын шинэчлэл, өршөөл үзүүлэх нь хамгийн чухал зүйл.

**- Энэ ажлыг хэзээнээс хэрэгжүүлэх боломжтой вэ?**

**С.Дэмбэрэл:** - Долдугаар сарын 1 гэхэд гаргачих боломж байгаа. Гэхдээ шинэчлэл үү, өнгөн засвар хийх үү гэдгийг ажлын хэсэг дээрээ нэгдэж,

нэг дуу хоолойтой байх нь чухал. Миний харж байгаагаар ажлын хэсгийн гишүүд шинэчлэл хийе гэсэн бодол байгаа. УИХ үүнийг шинэчлэл хийх сэтгэлгээтэйгээр өөрчлөх хэрэгтэй. Тиймээс МАН, АН, "Шударга ёс" эвслийнхэн Монгол Улсыг зөв голидролд оруулахын тулд татварын иж бүрэн шинэчлэл хийх хэрэгтэй гэдэгт нэгдсэн дуу хоолойтойгоор хурдан батлах хэрэгтэй. Гэхдээ Засгийн газрын оруулж ирснээр явбал шинэчлэл биш. Өнгөн засвар явж байгаа. Одоогийн татварын дэглэмийг улам гажуудуулах юм.

- Ярилцсанд баярлалаа.

### **Зээлийн хүүг нэмэгдүүлж байгаа бүх хүчин зүйлүүдийг арилгах талаар бодмоор байх юм**

*2014 оны 06 дугаар сарын 19-ны Пүрэв гарагт болсон УИХ-ын Нэгдсэн чуулганы хурлын тэмдэглэлээс: "А" хуулийн төсөл / Засгийн газар 2014.06.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, бондын хүүцгийн орлогын татварыг 10 хувь болгох тухай/ хэлэлцэх үед:*

**С.Дэмбэрэл:** - Тайлбаруудыг нь сонсоод, энэ хуулийг маш чухал зорилготой юм байна гэж би ойлголоо. Гэвч зорилго болон оруулж ирж байгаа төсөл хоёр хоорондоо төдий л сайн авцалдахгүй байна. Тиймээс нэг асуух зүйл байна. Үүнийг ер нь байхгүй болгочихож болдоггүй юм уу? Хэрвээ бид, нийт бизнес эрхлэгчидэд зээлийн хүүгийн тааламжтай, 1 оронтой тооны орчин үүсгэе гэж бодож байгаа юм бол, зээлийн хүүг нэмэгдүүлж байгаа бүх хүчин зүйлүүдийг арилгах талаар бодмоор байх юм. Д.Зоригт гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг дээр бид бас ажиллаж байна. Банкны нийт зардлыг нэмэгдүүлдэг, ингэснээрээ зээлдэгчдэд нэрмээс болж очдог тийм зүйлүүдээс зоригтой татгалздаг байх хэрэгтэй. Ийм алхам хийж болдоггүй юм уу? Үүний тулд энэ татварыг байхгүй болговол яасан юм бэ? гэсэн асуулт байна.

**Ч.Улаан:** - С.Дэмбэрэл гишүүний асуултанд хариулъя. Ер нь сүүлийн үед, аливаа татварыг байхгүй болгоё гэдэг асуудал нэлээд гарч байна. Энэ санал хүмүүст их л сайхан сонсогдож байгаа байх. Гэхдээ бодит амьдрал дээр ийм боломж байхгүй. Үүнийг сайн бодох ёстой. Тэр тусмаа гадаадын зээлийн хүүгийн татварыг байхгүй болгоно гэж асуудалд хандвал Монгол Улс гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдээс ашиг орлого, татвар авч чадахгүй болох тийм нөхцөл байдалд хүрч болзошгүй юм. Бид энэ урьдчилан харах аргагүй сөрөг үр дагаварыг тооцож байж асуудалд хандахгүй бол болохгүй. Бид бас тал талаас нь багагүй судалж, тооцоолж үзсэн. Ингээд, засгийн газрын хувьд, үүнээс өөр арга алга гэж үзсэн.

## **Ийм байдлаар цаашаа явбал реформ ч хийгдэхгүй, би ч Ажлын хэсгээс гарна**

*2014 оны 06 дугаар сарын 17-ны Мягмар гарагт болсон УИХ-ын Нэгдсэн чуулганы хурлын тэмдэглэлээс: А /Засгийн газар 2014.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, татварын 90 хувийг буцаан олгох тухай/ анхны хэлэлцүүлгээс*

С.Дэмбэрэл: - Би дахиад л 2 намд хандах болоод байна. МАН-ын гишүүн Ч.Хүрэлбаатарын хэлж байгаа маш зөв байна. Энэ хүн болон бусад нь “Реформ /шинэчлэл/ хийе.” гээд байна шүү дээ. Сөрөг хүчин чинь реформ хийе гээд байхад, ард түмэндээ амлалт өгч, Засгийн газрынхаа мөрийн хөтөлбөрт “реформ хийнэ” гэж оруулсан эрх барьж байгаа хүчин болох Ардчилсан намынхан нь: “Реформ хийхгүй ээ. Энэ мэт зүйлсээр ингэхийгээд аргалаад явуулчихъя.” гэсэн байдал гаргаад байх юм. Тэр “1-10% татвартай болж, НӨТ = 5%, Хүн амын орлогын албан татвар = 5%, борлуулалтын татвар...” гэх зэрэг гарч байгаа асуудлуудаа нийлүүлээд ярья л даа. Ярихдаа бүр Татварын ерөнхий хуультай нь ярьмаар байна. Тухайлбал, тэнд чинь байгаа хамгийн их маргаантай заалтууд, тэр байтугай хүмүүсийг шоронд оруулдаг тийм заалтууд байгаа шүү дээ. Татвар төлөгч болон Төр 2-ын хоорондын тэгш харилцаа алдагдчихсан байгаа шүү дээ. Энэ бүх асуудлуудаа иж бүрнээр нь ярихгүй, Ажлын хэсэг байгуулагдчихаад байхад яагаад ингээд хажуугаар нь элдэв юмнууд цувуулж оруулаад байгааг л гайхаад байна. Энэ бүхэн чинь нөгөө Реформыг чинь үгүйсгээд байна шүү дээ. Энэ талаасаа бодож юмаа хийвэл яасан юм бэ? Үүн дээр намчирхаад байх зүйл байхгүй шүү дээ. “Реформ хийе” гээд 2012-2016 оныхоо Мөрийн хөтөлбөрт заачихсан, бүх намууд нь үүнийг хүсдэг. Энэ өөрчлөлтийг хамгийн ихээр хүсэн хүлээж байгаа манай бизнес эрхлэгчид байж байна. Тэд нар маань “Бага татвартай, бага дарамттай, бага торгуультай, бага алдангитай, хүнд суртал багатай, эрцл, хэвийн орчинд ажлаа хиймээр байна.” гэж хэлээд байдаг. Тэрийг нь хаа хаанаа дуулсан бид нар энд бөөнөөрөө сууж ярилцаад, нэг олигтойхон юм хийгээд өгчихмөөр байх юм. Гэтэл “Чоно борооноор” гэдэг шиг ийм нэг “сэмхэн сэмхэн юмнууд” оруулж ирээд, хийх ёстой юмаа хийгүй юм. Нөгөө Реформын чинь утга нь алдагдаад байна. Үүнийг сайн бодооч ээ. Үүнийгээ зүгээр буцааж аваад, тэр 1%-ын татвартай асуудлаа оруулж ирвэл яасан юм бэ? “Томчууддаа” харин яах юм бэ? Огт орхих юм уу? Энэ зүв зүгээр байна гэж ойлгох юм уу? “Үндэсний манлай аж үйлдвэрүүдийг дэмжих хөтөлбөр” гэж бас байх ёстой. Тэрийг жич боловсруулаад, түүн дотроо татварын болон татварын бус дэмжлэгүүдийг оруулчихсан байх хэрэгтэй. Гэх мэтчилэн бизнесийнх нь хэмжээ болгонд таарсан зүйлийг хийж өгч болно шүү дээ. “Манай Монгол Улс Азидаа татварын орчин хамгийн гайгүй улс” гэсэн нэг их худлаа юмыг яриад байх юм. “Уучлаарай”, үүн шиг худлаа юм байхгүй. Бид хэцүү байдалд байдаг. Манай улсын хүн ам буюу зах зээлийн багтаамж нь 2,9- хөн сая. Ийм жижигхэн зах зээл дээр эргэлт хийж болдоггүй юм. Тэр тусмаа түргэн эргэлт бүр чадахгүй. Тийм



учраас татварын дарамт их байгаа юм. Тийм учраас татварын дарамтыг бууруулахын тулд хувь хэмжээгээ багасгах, татварынхаа процедурыг бууруулах, дээр нь 2 баланстай 20 жил явсан энэ явдлыг эцэс болгоё гээд байна шүү дээ. Ингэж байж, эдийн засгийн өршөөл, ил тод байдлын өршөөл гэсэн 2 зүйл чинь хоорондоо нийлж байж ажиллана. Үр дүнгээ өгнө. Түүнээс биш ийм байдлаар цаашаа явбал реформ ч хийгдэхгүй, би ч цаашдаа Ажлын хэсэгт үлдэхгүй, гарна. Реформ хийе гэж хүсч байгаа хүмүүстэй хамтраад тусдаа хууль өргөн барина. Энэ тал дээр та бүхэн анхаараасай гэж хүсч байна. Энэ бол үнэхээр чухал асуудал. Бид хамтдаа тал талаас нь ярилцаад, иж бүрнээр нь шийдэх бүрэн боломж байна. Уг нь та бүхэнд энэ боломж нь байна. Энэ боломжоо ашиглаач гэж л хүсч байна. Баярлалаа.

### **Зах зээлийг хөнддөггүй, хүндрүүлдэггүй, харин хүндэлдэг тийм хяналт байгаасай**

*2014 оны 06 дугаар сарын 19-ны Пүрэв гарагт болсон УИХ-ын Нэгдсэн чуулганы хурлын тэмдэглэлээс: X6 болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд / Улсын Их Хурлын гишүүн А.Бакей нар 2014.06.10-ны өдөр өргөн мэдүүлсэн/ хэлэлцэх цээр*

С.Дэмбэрэл: - Намайг энэ хуулийг өргөн барихад оролцох уу гэж асуухад би маш дуртай оролцсон. “Би энэ хуулийг өргөн барихад төдийгүй ажлын хэсгийг нь ахлаж оролцоё” гэж хэлж орсон. Яагаад гэвэл сүүлийн 15 жил Мэргэжлийн хяналтын байгууллагын талаар монголын бизнесийнхэний хэлж ярьдаг бүхнийг сонсож ирлээ. Энэ байгууллагын дарга нь байсан зарим хүмүүс ч энд сууж байна. Энэ бол маш их шүүмжлэл, маргаан гардаг, хамтран ажиллах гэж оролдож, урьд өмнөх Засгийн газруудтай ч хамтран ажиллах гэж хичээж зүтгэж ирсэн эволюци юм. Тухайлбал 2010 онд Сү.Батболдын толгойлсон Засгийн газар “Бизнесийн орчны шинэчлэл” гэж том төлөвлөгөө гаргасан. Тэр үед энэ Мэргэжлийн хяналтын газар, тусгай зөвшөөрөл, лицензийн асуудлыг М.Энхболд хариуцаад тодорхой хэмжээний, тухайлбал 300-400 лиценз, тусгай зөвшөөрлүүдийг үгүй хийж байсан юм. Өөрөөр хэлбэл, энэ бол МАН, АН-ын олон жилийн турш мөрийн хөтөлбөрт нь ордог, засаг барих бүртээ амладаг, ярьдаг, бизнес эрхлэгчиддээ хэлдэг тэр зүйл байсан. Цоо шинэ, төгс төгөлдөр, хөндөж болохгүй, гайхамшигтай, Монгол төрийн дархлаа болчихсон нэг институцийг сөнөөх гээд байгаа юм биш. Та нарын хүсдэг, та нартай уулздаг ард иргэд, бизнес эрхлэгчид, сонгогчдын чинь хүсдэг, хэлдэг, гуйдаг тэр зүйлийг чинь л хийх гэж байгаа юм. Буруу юм байж магадгүй. Жишээлбэл, түрүүн ярьсан тэр яамдын эрх мэдэл юу ч биш болох, давхар хяналт алдагдах гэх зэрэг асуудал байж болох юм. Магадгүй юм. Гэхдээ үүнийг бид хуулийг хэлэлцэх явцдаа ярилцаад засах, зохицуулах боломж, нүхнүүд дүүрэн байна. Энэ хуулийн төслийг би нэлээд анхаарч, маш

сайн уншсан. Засах шаардлагатай зүйл нэлээд олон харагдсан. Гэхдээ энэ маань Олон улсын санхүүгийн корпораци гэгддэг, Дэлхийн банкны хувийн хэвшлийг санхүү хийгээд бодлогын хувьд дэмждэг тэр байгууллагатай 3-4 жил хамтарч хэрэгжүүлсэн төслийн үр дүн болж гарч ирж байгаа юм. Энэ яамдуудын хяналт шалгалтанд би бас төдий л итгэдэггүй. Гэхдээ хяналт гэдгийг ойлгож байсан бидний хуучин чиг үүргээсээ татгалзаж, зах зээлийг хөнддөггүй, хүндрүүлдэггүй, харин хүндэлдэг тийм хяналт байгаасай л гэж хүсч байгаа юм. Зах зээлийн харилцаанд өөрсдөө оролцдог, зах зээл маань өөрөө өөрийгөө хянадаг гэдгийг ухаардаг, салбарын холбоод нь харилцаанд оролцож, та бидний хүсээд байгаа төр, хувийн хэвшлийн түншлэл бүхий хяналт байгаасай л гэж хүсч байна шүү дээ. Энэ бүхэн энд орсон шүү дээ. Эхлээд үүнийг дундаа унш л даа. Уншаагүй байсан ч хэлэлцүүлгийн явцад өөрсдийн санаа бодлыг оруулаад явж болно шүү дээ. Хэрвээ энэ хяналт бизнест давхар болон дахин хүндрэл учруулахаар зүйл болоод эхэлбэл, би тэр дор нь ажлын хэсгийн гишүүн болон ахлагч, санаачлагч хэн ч байсан, аль ч шатанд эсэргүүцээд л явчихна. Та бүхэн энэ асуудлыг бүгдээрээ сайн мэдэж байгаа. Маш олон бизнес эрхлэгчид үүнийг та нарт хэлдэг. Энд байгаа бүх хүнд тэд дахин дахин хэлдэг. Өмнө нь 2 удаа унасан гэнэ. Яагаад ч уначихсан юм бэ, бүү мэд. Одоо 3 дахь удаагаа орж ирж байгаа байдал нь энэ. Тэгээд би өөрөө үүнд оролцоё гэж гуйгаад орж ирж байгаа минь энэ. Тиймээс ч би өөрөө уншсан. Хоосон юм яриад байгаа юм биш. Дээр нь үүнийг практик амьдрал дээр дэндүү сайн мэднэ. Үүнийг сайн мэддэг хүмүүс энэ дотор бас сууцгааж байна. Шууд жадлахаасаа өмнө юу оруулж ирсэнийг сайн үзэхийг хүсч байна.

- Түрүүн ОУ-ын Санхүүгийн Корпорацийн төслөөр хийгдсэн гэж хэлэхдээ, тэндээс санхүүжүүлсэн гэдэг утгаар хэлээгүй юм шүү. Олон улсад хяналтын талаар маш сайн туршлагууд байдаг юм байна. Энэ бүх туршлагуудыг таниулахын тулд хичнээн олон экспертүүдийг авчирч, хичнээн ч олон семинарууд хийж, хичнээн олон туршилт судалгаанууд хийсэн юм бэ дээ. Улс орнуудын бүхий л сайн гэсэн туршлагуудыг авчираад, бизнес эрхлэгчдийн саналуудыг аваад хийсэн ажлын гол үр дүн юм шүү дээ. Д.Зоригт гишүүний асуусан бүх асуултууд энэ хуулинд орсон. Тэр байтугай төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналтуудын харьцааг нь зааж өгөөд, “төлөвлөгөөт бус” гэдэг нэрээр дуртай үедээ аж ахуйн нэгжүүд дээр явж ордог, дээжийг нь авдаг, дарамталдаг, хармааны мөнгө авдаг, хоол иддэг зүйлс алга болно. Гэхдээ Ё.Отгонбаяр гишүүний хэлээд байгаа тэр яамдын хяналт, өөрийн хяналт зэрэг нь ч бас энэ дотор орчихсон байгаа. Мөн олон жил оруулах гээд чадахгүй байсан “Зах зээл өөрөө өөрийгөө хянадаг зүйл рцү хөндлөнгийн хяналт оруулахгүй” гэдэг зарчим ч бас энэ дотор орчихсон байгаа. Зах зээл чинь өөрөө өөрийгөө хянадаг юм. зах зээл бол мангар тогтолцоо огт биш. Хэрэглэгч гэж оюун ухаантай хүн байгаа. Үйлдвэрлэгч, борлуулагчид чинь ч ухаантай. Тэд хоорондоо харьцдаг, хэрэглэгчийн төлөө өрсөлдөж байдаг, тэр нь хяналт болдог тогтолцоо оршин байдаг юм. Үүнийг нь хүндэтгэе, үүн рүү нь төр битгий хамаагүй хөндлөнгөөс хөлөө жийж бүү ор гэдгийг хэлчихсэн байгаа. Ийм нэг аятайхан хууль ороод ирчихсэн байна. Гэхдээ яамдын аппетит /юм идэх дур сонирхол. тайлбар/ нь хэт их хөдлөөд, өөрсдийгөө

хянуулахгүй гэж бодож байвал бас эндүүрэл. Тэрийг хэлэлцүүлгийн явцад бид тодорхой тодорхой салбарууд дээр нь ярьж, засч, нэмж, бас өөрчилж болно. Нүх цоорхой биш, орон зай нь байгаа гэсэн үг. Зарчмын зөрүүтэй санал гаргаад зарим зүйлийг өөрчилж болдог шүү дээ. Гэх мэтчилэн энэ орж ирсэн хуулийг хэлэлцээд гаргавал сайн юмсан. Мэдээж, энэ УИХ гэдэг байгууллагаас хууль төслүүд үргэлж сайжирч гардаг юм байна билээ. Би муудсан бүтээгдхүүн хараагүй. Засгийн газар муу хууль оруулж ирдэг үү гэвэл, оруулж ирдэг. Тэрийг нь сайжруулаад гаргаж байсан олон тохиолдол бий. Энэ хууль ч гэсэн анх харахад тийм л санагдаж байгаа. Тиймээс ч 2 удаа уначихсан бололтой. Хамгаалж чадаагүй ч юм билүү. Одоо энэ хуулийг бардам хамгаалж болохоор хууль болсон. Гэхдээ төгс болчихоогүй л дээ. Хуудас болгон дээр нь засвар хийх юмнууд харагдаж л байна. Тэр нь бид төгс биш гэдгийг харуулж байгаа хэрэг. Олж харж байгаа бүхнээ явцын дунд, тухай бүрт нь хийгээд л явах хэрэгтэй.

### **Цөөнх маань ахлаасай**

*2014 оны 06 дугаар сарын 19-ны Пүрэв гарагт болсон УИХ-ын Нэгдсэн чуулганы хурлын тэмдэглэлээс: Хбболон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд / Улсын Их Хурлын гишүүн А.Бакей нар 2014.06.10-ны өдөр өргөн мэдүүлсэн/ хэлэлцэх цээр*

**Л.Энх-Амгалан:** - Асуух зүйл байна. Бидний болгоомжилж байгаа гол зүйл бол, “Сахил хүртээд шал дордов” гэдгийн үлгэр болох вий л гэдэгт байгаа юм. Одоогийнхоосоо муудчих вий. Учир нь амьдрал дээр ийм зүйл болоод буучих нөхцөл байдлууд бас байна. Одоо байгаа энэ хяналтын тогтолцоо маань юуны өмнө, жинхэнэ утгаараа, үнэхээр зөв шинэчлэл болж тогтоосой, хоёрдугаарт хяналтын байцаагч нарын ашиг сонирхлын зөрчил, сахилга бат, ёс суртахууны асуудлууд нь шинэчлэгдэж чадсан өөрчлөлт болоосой гэсэн хүсэл байна. Таны хэлснээр, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа 60.000 аж ахуйн нэгжийн 76% нь буюу 46.800 нь жил бүр ямар нэгэн шалгалтанд өртөж байна. ААН-үүд жилд 40 гаруй нэр төрлийн тайлан баланс /татвар, гааль, нийгмийн даатгал... гэх мэт/ гаргаж өгч байна. Энэ дарамт мөн үү, гэвэл мөн байна. Энэ бол ил дарамт. Амьдрал дээр, далд дарамтууд бас нэлээд олон байна. Нэг байцаагч нь ажилд хүн авахыг шаарддаг, нөгөө нь өөрийнхөө хувь эзэмшдэг компаниас бараа, үйлчилгээ авахыг шаарддаг, эсвэл үнэгүй хоол, хүнс авах, идэх зэргээр дарамталдаг явдал түгээмэл байна. Бүүр тэр байтугай, шинэ цайны газар нээгээд, хажууд нь үйл ажиллагаагаа явуулж байсан өөр цайны газрыг 6 сар ямар ч шалтгаан, үндэслэлгүйгээр хааж байсан тохиодол ч байна шүү дээ. Яагаад гэвэл энэ нь бизнесийн өрсөлдөөнд нь хүчээр нөлөөлж, өөрийнхөө ажил, албан тушаал, эрхийг ашиглаж байгаа явдал юм. Хүнсний захын эзэн хүн Аймгийн хяналтын газрын дарга болчихоод, бусад хүнсний захуудыг хаадаг, дарамталдаг, хорьдог явдал амьдрал дээр олонтоо гарч

байна. Энэ хууль чинь гарч ирвэл ийм асуудлуудыг яаж зохицуулах юм бэ? Ийм зүйлийг хааж чадах уу?

- Ерөөсөө, төрийн буруугаас, буруу шийдвэрээс, байцаагчийн үзэмжээс шалтгаалсан хохиролууд ААН-үүд дээр цөөнгүй тохиолдож байна. Ингээд ААН-үүд дээр олон тэрбум төгрөгийн, жижиг ААН-үүд дээр 5 сая төгрөгний торгууль тавьж байна. Жирийн нэг өчүүхэн жижиг цайны газрыг үндэслэлгүйгээр 6 сар хаахад тэр хүний бизнес, ашиг орлого зогсож, гэрээ түрээс болон банкны өр зээл, хүүг төлж чадахгүй дампуурч, амь амжиргаа нь унаж, асар их дарамт зовлонд орж байгаа юм. Энэ бүх гай байцаагчаас болж үүсч байна. Үүний хариуцлагыг төр хүлээх л учиртай. Тиймээс ийм буруугаас болж үүссэн ААН-ын хохиролыг яаж барагдуулж байх ёстой юм бэ? Тэр, ашиг сонирхлын зөрчилтэй байцаагчаас болж үүссэн хохиролд төр ямар хариуцлага хүлээж, буруутай албан тушаалтантайгаа хэрхэн хариуцлага тооцох юм бэ? Энэ хариуцлагын тогтолцоо энэ хуулинд яаж орсон юм бэ?

- Жил бүр С.Дэмбэрэл даргын удирддаг МҮХАҮТ “Шилдэг 100 ААН”-ыг шалгаруулсаар байдаг. Жил болгон диплом, гэрчилгээ өгөөд л байдаг, өгөөд л байдаг. Гэтэл үндэсний аж ахуйн нэгжүүд маань өнөөдөр татварын хөнгөлөлт, чөлөөлөлт ерөөсөө гуйгаагүй. Харин төрөөс учирч байгаа дарамт шахалтуудыг л арилгаж өгөөсэй гэж хүсч байгаа. Төлөвлөгөөтэйгөөр хянаж шалгах гээд байна. Ядаж тэр, “Шилдэг ААН”-дээ 3 жил шалгуулахгүй байж болохгүй юу?

**З.Энхболд:** - С.Дэмбэрэл гишүүн хариулна уу.

**С.Дэмбэрэл:** - Баярлалаа. Гишүүдийн асууж, хэлж байгаа зүйлүүд их зөв л дөө. “Хууль бус шахалт дарамт байна” гэж хашгираад байгаа нь үнэн. Бүр ийм болчихсон байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ оруулж ирж байгаа хууль маань төгс төгөлдөр юм биш. Би өөрөө 2 удаа уншихад л нэмэх зүйл олон харагдсан. Нэлээд олон зүйлийг хасмаар санагдсан. Гэхдээ үүнийг хэлэлцүүлгийн явцад л хийгээд явчихмаар юуны түрүүнд санагдаад байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Л.Энх-Амгалан гишүүний асуулт их тодорхой байна. Бид 150 ААН-үүдийг жил болгон шилдэгээр шалгаруулдаг. 9 шалгуураар, олон ч жил шалгаруулж байна. Нэг өргөмжлөл л өгдөг юм шүү дээ, хөөрхий. Тэглээ гээд, энэ өргөмжлөл маань нөгөө байгууллагуудад моралийн /ёс суртахууны/ л дэмжлэг болохоос биш, материаллаг болон бодлогын ямар ч дэмжлэг болдоггүй. Олон жил ийм л байдлаар хийж ирлээ. Арга ядахдаа, Эдийн засгийн байнгын хорооны ажлын төлөвлөгөөнд нь “*Үндэсний манлай аж ахуйн нэгжцүдийг дэмжих хөтөлбөр боловсруулна.*” гэж оруулсан, ард нь хариуцах хүний нэр дээр нь “*С.Дэмбэрэл, Л.Энх-Амгалан*” гээд бичихсэн байгаа. Чамайг мэдээгүй байхад чинь л ингээд оруулчихсан. Энэ хөтөлбөр одоо боловсруулагдаж дууссан. Энэ хөтөлбөрт, янз янзын хяналт шалгалтаас эдгээр компаниудыг чөлөөлөх тэр асуудал тодорхой хэмжээгээр туссан. Гэхдээ үүнийгээ энэ хуулиа хэлэлцэхдээ хэдүүлээ бас давхар оруулж өгөх хэрэгтэй юм байна. Үүнийг саначихъя. Ер нь бид бичил бизнесийг дэмжиж байна. Жижиг бизнесийг хагас дутуу сан байгуулаад, дэмжих гэж оролдож байна. Гэтэл том ААН-үүдийгээ элдэв нэр хоч өгөөд, хаячихсан байгаа шүү дээ. тийм учраас эдгээр үндэсний манлай аж ахуйн

нэгжүүдийн төлөө ЭЗБХ-оос боловсруулсан энэ хөтөлбөрийг “100 хоног” дотроо батлаад, хэрэгжүүлээд явчих боломжтой байхаа. Үүнийг бүр Засгийн газар ч баталж, хэрэгжүүлээсэй гэж би бодож байгаа. Гэхдээ түүн дотор та бүхнээс гарч байгаа энэ санаанууд орж нэмэгдэх хэрэгтэй. Тэр дундаа, гадаадаас мөнгө санхүү босгох болон хяналт шалгалтаас чөлөөлөх, гааль дээр “Дэлхийн худалдааны байгууллагад байдаг шиг “authorized economic agents” буюу “Эдийн засгийн итгэмжлэгдсэн агентууд” гэдэг ойлголт ч бас бий. Тэр мартагдсан юм шиг байна. Мөн эрсдэлд суурилсан заалтууд ч бас байх ёстой. Тэр нь болохгүй байх шиг байна. Энэ бүхнийг энэ хуулинд тодорхой хэмжээгээр оруулах гэж оролдсон. Гэхдээ үүнийг хэдүүлээ тал бүрээс нь нухмаар байна. Мэдээж, та бүхэн тал бүрээс нь асууж, шалгаах нь зөв. Асуултууд чинь мартагдсан зүйлсүүдийг хэлж өгч байгаа хэрэг. Тиймээс хууль санаачлагч бид үүнийг их зөвөөр хүлээж авах ёстой. Энэ талаас нь би саяын асуултуудыг хүлээн авч байна. Тийм ч учраас асуулт асууж байгаа гишүүн бүрийг хэлж байгаа санааг хуулиндаа оруулж, тусгах нь зүйтэй гэсэн байр суурьтай байна. Ялангуяа МХГ-ыг задлаад, яамдад тараасны улмаас “олон мангас” гараад ирэх вий гэдэгтэй би бас санаа нийлж байна. Гэхдээ мангас гарах эсэхийг бид л шийднэ. Тиймээс үүндээ л их идэвхтэй оролц. Олонхиороо түрээд батлуулчихна гэж айх хэрэггүй. Олонхиор түрүүлэхгүй. Бид үүнийг хэлэлцээд л явах ёстой. Тэр байтугай, энэ ажлын хэсгийг УИХ дахь цөөнх маань ахлаад яваасай гэж би хүсч байна. Миний санал энэ байна. Цөөнхөөр толгойлуулаад, ажлын хэсэгт нь бүгдээрээ ороод, хэлэлцээд, хийгээд явсан нь дээр. Энэ нь шударга бөгөөд, илүү сайн үр дүнд хүрнэ гэж бодож байна. Буцаах хэрэггүй.

### Миний нэмэх зүйлс

*2014 оны 06 дугаар сарын 19-ны Пүрэв гарагт болсон УИХ-ын Нэгдсэн чуулганы хурлын тэмдэглэлээс: Хбболон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд / Улсын Их Хурлын гишүүн А.Бакей нар 2014.06.10-ны өдөр өргөн мэдүүлсэн/ хэлэлцэх цээр*

С.Дэмбэрэл: - Энэ хуулийн төсөл дээр миний нэмэх зүйлийг сонирхож байгаа бол, 30 хуудастай энэ төслийн сүүлийнхээс бусад бүх хуудсан дээр асуулт, анхаарлын тэмдэг тэмдэглэгээ хосолсон зүйлсийг биччихсэн байна. Жишээлбэл, эхний хуудсан дээрээс харахад л хөндлөнгийн 3-дагч этгээд гэж хэн юм бэ? гэдэг дээр тодорхойлолт нь буруу байсан. Үүнийг би эхний ярилцлага дээр л засуулсан байна. Мөн, Хяналтын зарчим дээрх: “Хяналт нь хараат бус байх” гэсэн зарчим арын хуудсууд дээрээ яаж тарж, баталгаажсаныг хөөгөөд харж байна. Хөндлөнгийн хяналтыг “байж болно” гэсэн сул үгээр орсон байсан дээр асуултын тэмдэг тавьчихсан байгаа. “Зах зээл өөрөө хяналт тавих, цр дүнг нь тооцох боломжтой зүйл дээр төр хөндлөнгөөс хяналт тавихгүй байх” гэсэн их зөв заалт орчихсон байна. Гэхдээ “бараг хяналт” гэдэг ойлголт бас бий. Зах зээл дээр



үйлдвэрлэгч, худалдаалагчид, хэрэглэгчид өр өөрсдийхөө харилцаагаар хяналтаа тавьдаг. 3-дагч буюу хөндлөнгийн хяналт тавих төрийн бус байгууллагуудад хяналтын ямар чиг үүрэг орж болох вэ, яаж хяналт тавьж болох вэ гэдэг нь ардаа мөн л тодорхой биш байгаа. энэ талын өгүүлбэр нь байгаа мөртлөө түүнийг хэрэгжүүлэх механизм, заалтууд нь тэр бүр сууж өгөөгүй байгаа тал ажиглагдаж байна. Тиймээс үүн дээр нь анхаарлын болон асуултын тэмдэг тавьчихсан байх жишээтэй.

Бас “Төрөөс тавих хяналт” гээд 7-р зүйлийн 7.3.1 дээр “*Хүнсний аюулгүй байдлын хяналт - хүнсний сүлжээнд хамрагдах бүх үйл ажиллагаа...*” гээд биччихсэн байгаа юм. БҮХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЯНАНА гээд л биччихвэл нөгөө бүгдийг нь хянадаг, хянах гэж зүтгэдэг байдал хэвээрээ үлдэнэ. Тийм учраас манай гишүүдийн шүүмжилж, энд тэндээс нь лавлаад байгаа зүйлүүд бүгд үндэслэлтэй. 15 толгойтой Атгаалжин хар мангас гаргахгүй байхын тулд бид бүгдээрээ тал талаас нь сайтар нягтлан хамтдаа үзэж, ярьж боловсруулах хэрэгтэй. Атгаалжин хар мангасыг дарах зүйлсийг хамтраад хийе.

Би энэ төслийг эргүүлээд, зүйл зүйлээр нь яриад л баймаар байна. Жишээлбэл, “ГУРАВДУГААР БҮЛЭГ. Хяналттай холбогдсон иргэн, хуулийн этгээдийн эрх, цэрэг” гэсэн бүлэг дээр “15.1.6. Шалгалтад биечлэн оролцох буюу төлөөлөгчөө оролцуулах, шалгалтад хамаарах асуудлаар тайлбар хийх” гэсэн зүйл орсон байна. Гэтэл өөрийнхөө үндэслэл нотолгоог гаргаж үзүүлэх, түүнийгээ батлах ёстой тэр процедур нь хаана байна вэ? Үүн дээр баримт, нотолгоогоо гаргаж тавих ёстой. Өөрөөр хэлбэл хяналт шалгалтын процесс бол нэг талыг барьсан, ялангуяа “**энэ ямар нэг буруутай л байх ёстой**” гэсэн байр суурьнаас ханддаг сэдлээр биш, “*Энэ хүмүүсийн үйл ажиллагаанд тусална. Зөв явж чадаж байна уу, явал илцэ зөв болгох вэ*” гэдгийг харилцан ярилцаж, зөвлөлдөх хэлбэртэй байх хэрэгтэй. Тийм учраас **зөвлөлдөх үйл ажиллагаа** гэсэн бас нэг үг оруулчихсан байгаа. Хуулийн этгээдийн хүлээх эрх, үүргийг нэлээд гайгүй биччихсэн юм шиг байгаа юм. Гэхдээ “17 дугаар зүйл. Үйл ажиллагаа анхлан эрхэлж буй иргэн, хуулийн этгээдийн тусгайлсан эрх” гэсэн бас нэг тусдаа зүйл байх юм. Тэнд “*зөвлөгөө өгч болно*” гэхчхэн байна. Гэтэл анхлан эрхэлж байгаа гэдгийг яаж тодорхойлох юм бэ гэдэг асуулт бас гарч ирнэ. 1 жил, 6 сар, 3 жил юм уу гэдгийг яаж мэдэх вэ? Үүн дээр бас субъектив юм орчих магадлалтай учраас үүнийг тодруулах асуулт тавьчихсан байгаа. Тэрчлэн, “*Дотоод хяналт нь хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга, бодитой байх зарчимд тулгуурлана*” гэхчхэн байна. Тэгэхээр хэнээс хараат бус байх юм бэ, юунаас хараат байх юм бэ, энэ нь дараагийнхаа заалтууд дээр яаж илрэх юм бэ гэхчилэн анхаарч, тодруулан тусгаж явах ёстой юм байна. Мөн “*Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт*” гэдгийг энд оруулчихсан байна. Энд харьцааг нь бичсэн боловч, яг юу юм бэ гэдэг нь бас л бүдэг байна. Дуртай үедээ төлөвлөгөөт бус хяналт хийнэ гэдгийн баталгааг хэр хангасан юм бэ гэдгийг ч бас хөөж үзэх л хэрэгтэй болж байна. “*Улсын байцаагчийн нийтлэг цэрэг*” гэсэн хэсэг байна.



## **ДЭД БҮЛЭГ.**

### **БАЙГАЛЬ БА НОГООН ХӨГЖИЛ**

#### **НЭГ. Эх нутгаа хайрлах сэтгэл – Ногоон үзлийн тухай**

##### **УИХ дахь Ногоон бүлэг**

Монгол Улсын Их хуралд олон бүлэг ажилладаг. Тэдний нэг нь “Ногоон бүлэг” юм. Байгаль орчинд ээлтэй хууль, тогтоол, бодлого, шийдвэр гаргахыг дэмжигч парламентын гишүүндэд энэ бүлгийн хаалга нь нээлттэй байдаг. “Ногоон бүлэг”-ийг өмнө нь УИХ-ын гишүүн Г.Баярсайхан ахалж С.Оюун, Д.Эрдэнэбат нарын гишүүд багтаж байсан. Г.Баярсайхан Байгаль орчин, хүнс, ХАА-н байнгын хорооны дарга болсон тул бүлгийн ахлагчийг шинээр сонгохоор болсон юм. Тэрээр өөрийнхөө зүгээс УИХ-ын гишүүн, Иргэний Зориг Ногоон Намын дарга С.Дэмбэрэл гишүүнийг санал болгосныг, УИХ-ын гишүүдийн олонх дэмжиж, “Ногоон бүлэг”-ийн ахлагчаар ажиллахаар болсон билээ.

Ногоон бүлгийн зорилго нь Монгол орны байгаль орчин, экологийн тэнцвэрт байдлыг хамгаалахад төр - иргэний нийгмийн хамтын ажиллагааг сайжруулах, ногоон хөгжлийн үзэл баримтлалыг хууль тогтоомж болон Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгах, мөн салбарын хуулийн хэрэгжилтэд гол анхаарлаа хандуулахад чиглэх юм. Мөн ногоон сэтгэлгээ, ногоон эдийн засаг, ногоон хөгжлийн асуудлаар УИХ-д нөлөөлж, парламентийг ногоон үзэл сэтгэлгээнд оруулахад анхаарна. Тус бүлгийг 2012 онд шинээр бүрэлдсэн УИХ-ын гишүүдээс 34 гишүүн нь дэмжиж байгаа юм. Бүлэг нь УИХ-аас гаргаж байгаа Монгол Улсын бүх хууль тогтоомжууд нь зайлшгүй, ногоон үзэл болон тогтвортой хөгжлийн зарчмыг харгалзаж үзсэн байхад анхаарлаа чиглүүлнэ. Ялангуяа цаашдаа манай улсад хөгжлийн дагуу олон төрлийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлууд хийгдэх гэж байгаа нөхцөлд, нөгөө талаасаа УИХ-аас гаргаж байгаа хуулиуд нийгмийн амьдралыг зохицуулдаг учраас нийгэмд ногоон амьдралын хэм хэмжээг тогтоох явдал чухал болоод байна. Энэ тал дээр бизнесийн байгууллагуудад хууль зүйн ногоон орчин бий болгох буюу гаргаж байгаа хууль тогтоомж “Ногоон хөгжлийн болон тогтвортой хөгжил”-ийн үзэл баримтлалуудыг шингээж тусгадаг дадал заншил үүсгэх хэрэгтэй. Одоогоор бүлгийн хувьд шинэ, хийх ажил их байна. УИХ-ын Байгаль орчин, ХАА-н болон Төрийн байгуулалтын байнгын хороон хандаж, гаргаж байгаа хууль тогтоомжинд тогтвортой, ногоон хөгжлийн үзэл баримтлалыг шингээх талаас нь ажиллаж байна. “Ногоон бүлэг”-т

хамааралгүй хууль гэж байхгүй. Төрийн байгууламжийн асуудлаар ч, мөн Монгол Улсын гадаад бодлого, аюулгүй байдалд ч шууд хамааралтай. Ялангуяа, хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр гээд бодит бүх салбаруудад энэ хамаатай. Тэр ч байтугай мөнгөний бодлогод ч хамааралтай. Монголбанк мөнгөний бодлогоор арилжааны банкуудыг ногоон санхүүжилт рүү түлхэж чадвал сайн байна.

Дэлхийн олон улс орон энэ чиглэлээр үйл ажиллагаа явагдаж байна. Манай орны хувьд УИХ-аас эхлэн Байгаль орчинтой холбоотой асуудалд онцгой анхаарч, багц хууль батлагдан гарсан. Дээр нь энэ удаагийн УИХ-аас энэ асуудлыг анх удаа ногоон хөгжлийн асуудал хариуцсан төрийн бүтэц бүрэлдхүүний түвшинд гаргаж ирж хөгжүүлэх гэж байгаад олон улсын байгууллагууд их нааштай хандаж байна. Тухайлбал, НҮБ-ын Байгаль орчны болон Хөгжлийн хөтөлбөр, Дэлхийн банк, Азийн Хөгжлийн Банк зэрэг манайхтай хамтарч ажилладаг олон хувь хүн, байгууллага, улс орнуудыг дурдаж болно. Энэ чиглэлээр идэвхтэй ажиллаж байгаа Голланд, Герман, Япон, Өмнөд Солонгос улсууд манай улсын энэ шийдвэрийг нааштай хүлээж авч цаашдаа ногоон хөгжил, байгаль орчинтой холбоотой асуудлаар бидэнтэй хамтран ажиллах нилээн өргөн үүд нээгдэж байна. Бидэнд дэлхийн бусад улсуудын туршлагыг судлах хэрэгцээ их байгаа. Зарим оронд “Ногоон өсөлтийн институт” гэсэн байгууллага байна. НҮБ-ын Ази Номхон далайн комисс, манай Ногоон хөгжлийн яамтай хамтарсан хурал хийхэд Өмнөд Солонгосын ийм институцийнхан ирж, энэ чиглэлээр хамтарч ажиллахад бэлэн байна гэдгээ илэрхийлээд байна. Бид ч ижил үзэл, зорилготой байгууллага, хүмүүстэй холбоо тогтоох, танилцах, мэдлэг туршлага судлах, харилцаа хамтын ажиллагаа хөгжүүлэхийг хүсч байгаа. Улмаас ногоон үзлийг улс орондоо төдийгүй, дэлхий нийтэд бүх нийтийн үйлс, тэргүүний үзэл санаа байлгахыг зорьж байна. Монгол Улсад ногоон хөгжил, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн асуудлаар голлон анхаарч байгаа төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, бизнесийн байгууллагууд байна. Төрийн бодлогыг энэ асуудал руу чиглүүлэхэд нөлөөлөх, нөгөө талаас УИХ дахь манай бүлэг болон иргэд, бизнес эрхлэгчидээр энэхүү үүсгэл санаачлагыг дэмжүүлж, хөгжүүлж, төр, засгийг энэ чиглэлээр нь ажиллуулах зэрэг олон аргаар ажиллаж, хууль тогтоомж болон бусад арга хэлбэрүүдийг өргөн ашиглах зорилт бидэнд тулгараад байна. Бидэнтэй хамтран ажиллахыг та бүхнээс уриалж байна.

## **Байгаль орчны бодлого бол Монгол улсын хөгжлийн “Мөнхийн тэргүүлэгч чиглэл” байх ёстой**

*МҮХАҮТ-ын дарга, гавъяат эдийн засагч С.Дэмбэрэлтийн 2009 оны 10 дугаар сарын 03-нд хэвлэлд өгсөн ярилцлага*

- Сайн байна уу? Таньд энэ өдрийн мэнд хүргэе. МҮХАҮТ, ПЕТРОВИС ХХК, ХАСБАНК нар “Амьдрал Үргэлж Сайхнаараа-ОРГАНИК МОНГОЛ” хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж байгаа. Уг хөтөлбөрийг ямар зорилгоор хэрэгжүүлэх болсноос яриагаа эхлэх үү?

**С.Дэмбэрэл:** - Таньд бас энэ өдрийн мэнд хүргэе. Монголын нийгэм хийрхэл, шизофренистэй болж, бүх зүйлийг дээрээс нь шийднэ гэсэн ойлголтыг ард түмэнд өгснөөр манай улс төрчид болон ард иргэдийн толгойд бэлэнчлэх, хүний гар харах сэтгэлгээ бий болоод удаж байна. Заяагдмал нөөцийн олдмол хам шинж буюу нөөцөн дээр суурилж эрдэс баялагаа устгадаг байдал, баялгийн хараал, Голланд өвчин гэх мэтдэлхийн олон улсад бий болж байсан эдийн засгийн нөхцөл байдал манай нийгэмд маш хүчтэй илэрч байгаа. Манай улс төрчид нэг хүнд ноогдох цэвэр агаар, газар, нутаг, ус гэх мэт экологийн амин чухал үзүүлэлтүүдийг анхаараасаа илүү 1 хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг 5000 ам долларт хүргэнэ гэсэн хий мөрөөдөлтэй тэрнээрээ ард иргэдийн толгойг угааж алаагүй баавгайн арьсыг хуваана гэдгийн үлгэр болж байна.

Дэлхий нийтээр Green Economy Initiative гэсэн хөгжлийн модель гаргаж ирж энэ чиглэл рүү хандаж байгаа өнөө үед манай улс унаган байгаль экологийн тэнцвэр, экологийн цэвэр байдлыг ярихаасаа илүү Оюу Толгой, Таван Толгой гээд хэдэн толгой яриад л хэрэлдээд байхаас өөр улсын хөгжил цаашлаад хүний амьдран суух цэвэр орчны талаар, амин чухал асуудал болох ширгэж буй гол мөрөн, цөлжиж байгаа газар нутаг, цэвэр агаарын талаар хий л ярихаас хийж байгаа нь маш цөөхөн байна. Иймд байгаль орчин ногоон хөгжил гэсэн сэтгэлгээг хүмүүсийн дунд үүсгэх ёстой. Ногоон амьдрал шүтэх, ногоон амьдрал руу тэмүүлэх, бидэнд заяасан эко системээ үр хойчдоо үлдээх, аварч үлдэх сэтгэхүйг хүмүүст суулгах хэрэгтэй. Мөн байгалийн цэвэр хүнсийг үйлдвэрлэх бий болгох, өөрсдийн болон бусдын эрэлт хэрэгцээг хангах нөхцөлийг бий болгосноор эрүүл мэнд, амьдрах зуршилдаа том өөрчлөлтийг авчрах ёстой юм. Ийм л олон шалтгаанаар бид ОРГАНИК МОНГОЛ хөтөлбөрийг санаачилсан. МҮХАҮТанхим, Петровис ХХК, Хасбанк нарнэгэн зорилгоор Ядуурлын Эсрэг Хамтдаа Сангийн дор нэгдэн нийлж эхлүүлсэн ОРГАНИК МОНГОЛ хөтөлбөр нь дотоодын зах зээлээ тэр дундаа хүнсний салбараа гадны импортын хараат байдлаас гаргах, өөрсдийнхөө эрүүл мэндэд том хөрөнгө оруулалт хийгээд зогсохгүй эдийн засагтаа ч хувь нэмэр болох цаашлаад 21-22 р зууны иргэдийн амьдрах гол арга нь экологийн цэвэр хүнсний үйлдвэрлэл болох үндэс суурийг одооноос тавих стратеги ач холбогдолтой юм.

- **Амьдрал үргэлж сайхнаараа - ОРГАНИК МОНГОЛ гэж нэрлэсний учир юу вэ?**

**С.Дэмбэрэл:** - Ирээдүйгээ өөдрөгөөр харах цаашдаа амьдралд итгэх итгэлийг хүмүүст өгч ногоон хөгжилд хувь нэмрээ оруулах гэсэн утгатай юм л даа. Нэрнээсээ л бараг ойлгомжтой байгаа биз дээ манай хөтөлбөрийн зорилго нь. Уг хөтөлбөрт хамрагдсан цаашид ч хамрагдах олон нөр их хөдөлмөрч иргэдийн бий болгосон Органик бүтээгдэхүүнүүд ирээдүйд магадгүй манай улсын эдийн засагт стратегийн өндөр ач холбогдол бүхий байр суурь эзлэхийг үгүйсгэх аргагүй. Уг хөтөлбөр нь ядуурлыг бууруулахад ч нэмэр болж тэгш боломжуудыг хүмүүст олгож байна. Тиймээс ч бид энэ хөтөлбөрийг эхлүүлэн цаашид улам өргөжихэд төр засгийн болон хувийн хэвшлийн байгууллагууд дэмжин оролцоно гэдэгт итгэж байгаа.

- **Төр засгийн байгууллагуудаас дэмжлэг ямар байна?**

**С.Дэмбэрэл:** - Засгийн газар, ХХААХҮЯам, Байгаль Орчны Яамны сайд нар дэмжих хэрэгтэй. Хүнс хөдөө аж ахуйн сайд Бадамжунай манай

хөтөлбөрийг дэмжихээ илэрхийлсэн. Байгаль орчны сайд Гансүх ч гэсэн дэмжих ёстой гэж бодож байна. Ирээдүйн суурийг тавих асуудал учраас төр засгийнхан оролцох ёстой. Хоёр жилийн өмнө МҮХАҮТ-аас УИХ-д санал тавьсан боловч дэмжихгүй, хариу өгөхгүй болохоор бид өөрсдөө бие даан хийж эхэлсэн.

Шинэ ерөнхийлөгчид үндсэн хуульд *“Байгаль орчны бодлого Монгол улсын хөгжлийн “Мөнхийн тэргүүлэгч” байх ёстой”* гэсэн заалт оруулж өгөхийг хүссэн захидал илгээсэн. Мөн байгаль орчны асуудлыг ямагт анхааралдаа авч дэмжихийг хүссэн. Монголын ард түмний төлөөлөл болсон гол хүн ард түмнээ төлөөлөн биднийг дэмжиж ард түмэндээ буян хураана гэдэгт итгэж байна.

Хэрвээ энэ санал дэмжигдвэл улсын нэгдсэн төсвөөс хамгийн бага хэсэг нь байгаль орчинд зарцуулагддаг тийм тогтолцооноос салах юм. Ингэж чадвал Байгаль Орчны сайд болон Хүнс Хөдөө Аж Ахуйн үе үеийн сайд нар мөнгө байхгүй шалтгаанаар дорвитой ажил хийдэггүй үр дүн гардаггүй нөхцөл байдлаас сална. Засгийн газар стратегийн орд хэдн толгой байгаа жаахан юмаа ухаж гаргаад байгалаа сүйтгэхээ ярихаасаа өмнө хайлан уйлавч одохгүй байгаль орчиноо, экологийн асуудлаа анхааралдаа нэн тэргүүнд авах ёстой. Ерөнхийлөгч байгаль орчны бодлогийг тэргүүлэх чиглэл болгохыг дэмжвэл энэ нь гадаад болон дотоод олон ач холбогдолтой. Эдийн засгийн тэргүүлэх чиглэл Байгаль орчин болсноор бид үндсэн хуульдаа өөрчлөлт оруулах хэрэгтэй болно. Мөн цааш цаашдаа хууль батлахдаа тэргүүлэх чиглэлээ хамгийн түрүүнд анхаардаг болно. Ингэснээр ногоон хуулийн засаглалтай болж бүх хууль ногоон хуульд захирагдана. Үүний дараа бид олон улсын тавцанд НҮБ –ийн индэр дээрээс нүүр бардам өөрсдийн туршлага ярьна. Энэ нь цаашлаад олон улсын туршлага болно.

**- ОРГАНИК МОНГОЛ хөтөлбөрийг талаар тодруулга танилцуулга өгөөч ?**

**С.Дэмбэрэл:** - За, уг хөтөлбөрийг Ядуурлыг бууруулах сангийн хүрээнд МҮХАҮТ, Хас банк, Петровис гэсэн гурван компани зохион байгуулж хамтран ажиллаж байна. Өнгөрсөн жил болсон *“Амьдрал Үргэлж Сайхнаараа”* бизнес реалитид ч гэсэн энэ гурван байгууллага хамтран оролцож амжилттай дуусгаж байсан. Органик Монгол хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг бид хөтөлбөрийг дэмжигч Өдрийн сониноороо дамжуулан хүргэх болно.

**- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зохион байгуулагчид төр засгийн болон хувийн хэвшлийн олон байгууллагуудад хамтарч ажиллах санал тавьсан гэсэн ямар хариутай байна ?**

**С.Дэмбэрэл:** - Бид хөтөлбөрийг эхлүүлснээс хойш гадаадын төслүүд, төрийн байгууллагууд, хувийн хэвшлийн томоохон компаниуд руу хамтран оролцохыг хүсэж хандсан. Байгууллагууд маань ОРГАНИК МОНГОЛ хөтөлбөр гэхээр өмнө нь сонсогдож байгаагүй учраас хүмүүст ямар зорилготой юу хийх гээд байгаа нь ойлгомжгүй санагдсан байх л даа. Явцын дунд олон олон компаниуд бидэнтэй нэгдэн орж ирнэ гэж бодож байгаа. Байгаль орчны сайд хамгийн түрүүнд оролцох хэрэгтэй. Энэхүү хөтөлбөр зөвхөн дээрхи гурван компаний өөрсдийгөө сурталчлахад зориулсан биш ирээдүйн төлөө, ирээдүйн ногоон эдийн засгийн үндэс

суурийг тавих том зорилготой юм шүү дээ уг нь. Би түрүүн хэлсэн хэдэн толгой ярихдаа малчны хотонд элс дүүрсэн байна уу? Ус гол ширгэж байна уу? гэдгийг анхаарч авч хэлэлцдэггүй. Алт зэсийг бид идэхгүй. Байгаль, гол мөрөн, усаа хайрлаж хамгаалдаггүй улс орны эдийн засаг явцгүй. Хэрвээ бид НҮБ-ын индэрт “Байгаль орчны бодлого аливаа улсын хөгжлийн “Мөнхийн тэргүүлэгч” байх ёстой” гэсэн санаагаа хэлвэл Монгол улсын санаачлага гэж хэлнэ.

Компанийн нийгмийн хариуцлагыг гол философоо болгосон олон компаниуд удахгүй бидэнтэй нэгдэн орж ирнэ. Энэ их хийрхэлийн фон дээр ОРГАНИК МОНГОЛ нь ЭРҮҮЛ ХӨДӨЛГӨӨН ногоон эдийн засгийн суурийг тавих ач холбогдолтой юм. Миний санаж байгаагаар засгийн газрын мөрийн хөтөлбөрт энэ талаар байсан санагдаж байна, гэвч 2 жил өнгөрөхөд дорвитой үр дүнтэй ажлууд харагдсангүй. Үндсэндээ хэдэн хүн Дорж Дулмаа ногоо тарьж байгаа нь нэг их сонин зүйл биш ч энэ нь ногоон эдийн засгийн суурийг тавьж байгаагаараа ач холбогдолтой юм.

**- Танай төслийн бусад ногоон хөтөлбөрүүдээс ялгарах ялгаа болон онцлог нь юу вэ?**

**С.Дэмбэрэл:** - Нэг их ялгараад байх юу байхав. Ногоон эдийн засаг, ногоон хууль, хүмүүс бизнес эрхлэхдээ хамгийн түрүүнд байгаль орчноо анхаардаг ашгаа ногоон эдийн засгаас олдог байх ёстой гэсэн үзэл санаан дээр л ОРГАНИК МОНГОЛ гэсэн томъёололыг гаргаж ирсэн. Ногоон хөгжил, Ногоон Монгол, ОРГАНИК МОНГОЛ гэсэн ойлголтууд хамгийн эхэнд шийдвэр гаргах түвшинд цаашлаад нийгмийн бүх түвшинд нэвчих ёстой. Энэ талаар Үндсэн хуульд оруулах хэрэгтэй гэж би дээр хэлсэн. Алтан, зэсэн, нүүрсэн эсвэл хар Монгол байснаас НОГООН МОНГОЛ больё. Байгалаа баялаг ашиглах нэрээр хайр найргүй устгаж байгааг бид харж байна. Бид одоо хөгжлийн номлолоо өөрчлөх хэрэгтэй байна. Монгол улс аль замаар нь явах вэ? гээд ацан шалаанд орчихсон байна.

**- Байгалиа аварч үлдэх үү, Эсвэл уул уурхай ярьсаар сүйтгэх үү?**

**С.Дэмбэрэл:** - Малчид хүртэл асуултын тэмдгэн дунд амьдарч байна. Яахаа мэдэхгүй. Малаа хаяад зугтаах нь зугтааж байна. Малчид цөлжиж байгаа нутгаа хараад нүдэнд нь нулимс цийлэгнэж байна. Бид өөрөөр амьдарч чадна гэсэн итгэлтэй байх хэрэгтэй. Эко системээ аврах, бичил бизнесийн сэтгэлгээг хөгжүүлэх нь органик хөдөө аж ахуйн хөгжлийн суурь юм. Зарим хүмүүс хэдэн төмс, лууван тарьчихаад хурдан ургуулах гэж хятад бордоо хэрэглэж байхад зарим нь органик аргаар ядаж өөрсдөө идэхээ тарьж байна. Тиймээс бид ОРГАНИК МОНГОЛ гэсэн сэтгэлгээг нийгэмд сайн нэвчүүлэх хэрэгтэй. Саяхны статистик үзүүлэлтээр Монгол улс дундаж орлоготой улс гэсэн судалгаа гарсан. Гэвч манайд ядуурал 36%-тай байна. Тиймээс ядуурлыг багасгахын тулд бичил бизнесийг дэмжих хэрэгтэй. Ядаж өрх бүрийг өөрийн хэрэгцээгээ хангах хэмжээнд амжиргаагаа авч явах суурийг тавих, амжиргааг нь дээшлүүлэх, ядуурлыг бууруулахад хувь нэмрээ оруулах зорилгоор ОРГАНИК МОНГОЛ хөтөлбөрийг эхлүүлсэн. ОРГАНИК МОНГОЛ хөтөлбөрийн гол үндэс суурь нь гурван Ц буку ЦЭВЭР ОРЧИН, ЦЭВЭР ҮЙЛДВЭРЛЭЛ, ЦЭВЭР ХҮНС юм.

**- Монгол улсын одоогийн эдийн засгийн байдлыг та юу гэж боддог талаар товчхон хариулна уу?**

**С.Дэмбэрэл:** - Яг одоо уул уурхай юу, байгаль орчин уу гэдэг сонголт монголчуудын өмнө байна. Энэ 2 хүчин зүйл нь бие биенийхээ эсрэг байна. Үүнийг маш зөв сонгож шийдэх хэрэгтэй. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх засгийн газрын зардал, ядуурлын түвшин зэрэг нь албан болон албан бус секторын эзлэх хувиас маш өндөр байгаа нь статистик үзүүлэлтүүдээс харахад тодорхой байна. Энэ бүдүүн байгаа засгийн газар, ядуурал гэсэн хоёр секторыг гурааж, хувийн хэвшлийн албан болон албан бус секторыг таргалуулах ёстой ингэснээр эдийн засагт ач холбогдолтой. Бидний хөтөлбөрийн гол зорилго нь ядуурлыг бууруулах, хүмүүсийг тэгш боломж, тэгш хуваарилалттай болгож, бизнес сэтгэлгээг нь хөгжүүлэн бичил бизнес рүү оруулах, амьжиргааг нь дээшлүүлэхэд оршиж байгаа юм.

**- Одоо эргээд Органик Монгол хөтөлбөрийнхөө талаар ярилцъя. Оролцогчдоо ямар шалгуураар сонгож авсан вэ?**

**С.Дэмбэрэл:** - Хөтөлбөрт хамруулахаар бид анх аймаг олон нутгаас болон УБ, Дархан хотуудаас тухайн салбартаа арвин туршлагатай хийж бүтээх хүсэл эрмэлзлэлтэй иргэд хоршооний нийт 200-гаад төслийг хүлээж авсан. Тэдгээрээс 45-ийг нь манай зохион байгуулах багийн гишүүд шалгаруулалт явуулж газар дээр нь очиж танилцан сонгосон. Өнгөрсөн таван сард багийн гишүүд хөдөө орон нутгаар явж судлаад 150 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгоод байна. Уг зээл нь 1-1,5% ийн хүүтэй, барьцаагүй, элдэв дарамт хүндрэлгүй олгодог зээлийг зохион байгуулагч байгууллагуудын хамтын хуримтлуулсан сангаас олгосон. Төслүүдийн үр дүн 8-9 сараас харагдана. Тэр үеэр бид үзэсгэлэн худалдаа гаргах, иргэдийн борлуулалтыг дэмжихэд томоохон хүнсний сүлжээ дэлгүүрүүдтэй хамтрах зэргээр ажиллахаар төлөвлөж байна. Мөн хөтөлбөрийн талаар цуврал нэвтрүүлгүүдийг бэлдэж манай хөтөлбөрийн мэдээллийн ивээн тэтгэгч болох NTV ТВ-ээр нэвтрүүлнэ. Мөн мэдээллийн дэмжигч Oloo.mn, Их харанга, Өдрийн сонин зэргээр дамжуулж хөтөлбөрийн талаар мэдээллийг олон нийтэд түгээнэ. Манай төслүүдийн хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлж сургалт мониторинг хийх тал дээр АДРА ОУБ хамтран ажиллаж дэмжигчээр оролцож байгаа.

Анхны ажил гэхэд их өөдрөг эхэлсэн мөн сайн үр дүнг хүлээж байна. Биднийг дэмжин оролцож байгаа дээрх бүх байгууллагууддаа талархлаа илэрхийлье.

**- Цаг заваа гарган, өөрсдийн хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийнхөө талаар мэдээлэл өгч бидэнтэй санал бодлоо хуваалцсан танд баярлалаа. Та бүгдийн саналыг шинэ ерөнхийлөгч, засгийн газар бусад олон хувийн хэвшлийн болон төр засгийн байгууллагууд магадгүй хувь хүмүүс ч гэсэн дэмжинэ гэдэгт итгэж байна. Та бүгдийн энэ гэгээн, буянлаг ажилд амжилт хүсье.**



## Модны хулгайг яаж зогсоох вэ?

*Монгол Улсын Их Хурлын 2013 оны хаврын ээлжит чуулганы Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс: Байгаль орчны төлөв байдлын тайлан хэлэлцэх цээр*

**Байнгын хорооны дарга Г.Баярсайхан:** - За одоо 2011 оноос 2012 оны хооронд байгаль орчны төлөв байдлын тайлан. Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайд С.Оюун тавина. Өнөөдрийн хуралдаанд Төрийн нарийн бичгийн дарга Ж.Батболд оролцож байна.

**С.Оюун:** - Байнгын хорооны даргад баярлалаа. Гишүүдэд Байгаль орчны төлөв байдлын тайланг 2005 оноос хойш Их Хуралд танилцуулж, Байнгын хороонд танилцуулж ирсэн юм билээ. 2011-2012 оны төлөв байдлын тайланг та бүгдэд товчхон танилцуулъя. Нэгэнт дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн учраас би товчхон слайдуудаар тайлбарлаж танилцуулаад, та бүгдийн сонирхсон асуултуудад манай яамны газар, хэлтсийн холбогдох дарга нар хариулахад бас бэлэн байгаа. Би ч гэсэн бас хариулахад бэлэн байна. 4, 5 чиглэлээр төлөв байдлын тайланг бэлтгэдэг. Эхнийх нь уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын төлөв байдал. Та бүгд мэдэж байгаа дэлхийн хэмжээнд ч гэсэн тулгараад байгаа, Монгол Улсад ч гэсэн тулгараад байгаа хамгийн тулгасан асуудлуудын нэг бол уул амьсгалын өөрчлөлт. Ер нь өнгөрсөн 100 гаруй жилийн хугацаанд дэлхийд 0.7 хэмээр дэлхийн дулаарал явагдсан бол Монгол Улсад 70 гаруй жилийн хугацаанд, анхны хэмжилт явуулснаас хойш 2.1 хэм градусаар дулаарсан. Энэ бол дэлхийн дундаж дулаарлаас 3 дахин илүү эрчимтэй явагдаж байна. Бид нар бас нэг тоймлоод буюу яг дулаарч байгаа видео үзүүлэх гэсэн чинь манай энэ компьютер маань, манай энэ Тамгын газрын компьютер бас болохгүй байх шиг байна. Тэр видео дээр ч гэсэн маш тодоор харагдаж байгаа. Ялангуяа сүүлийн 30 жилийн хугацаанд Монгол Улс маш их эрчимтэйгээр дулаарсан нь цөлжилт, бэлчээрийн талхлалт, за тэгээд нөгөө гол нууруудыг маань хуурайшуулах гээд олон сөрөг үзэгдлүүдийг маш их дагуулж байгаа. Мөнх цэвдэг бас хайлж байгаа...

**Г.Баярсайхан:** - С.Дэмбэрэл гишүүн асуулт асууя.

**С.Дэмбэрэл:** - Би чинь одоо С.Оюуныгаа загнах хэцүү. Ямар ч гэсэн хэдэн асуулт асууя.

Ерөнхийдөө би энэ байгаль орчны төлөв байдлыг сайн мэдэж байгаа. Тэгэхээр хамгийн эхний асуулт бол, ихэнх нь Монгол Улсад мөрдөгддөг стандартуудаас хэтрээд гарчихсан байна. Менделеевын үелэх системийн нэлээн хүнд хүнд элементүүдийн хувьд Монгол Улсад мөрддөг стандарт гэдэг нь хүний биед сөргөөр нөлөөлөхгүй байх стандарт шүү дээ. Тэрнээс илүү гарсан төлөв байдалтай байна. Тэгэхээр энэ төлөв байдал дээр үндэслэсэн, 2011, 2012 дээр дүгнээд 2013 оны төсөвт энэ чинь сууж чадаагүй. 2014 оны төсөвт бодит төлөв байдал дээр үндэслэсэн хөрөнгө оруулалтын хэмжээг гаргах хэрэгтэй. Тэгээд энийг хамгийн хүнд хүнд газар руу, өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалтын чинь чиглэл гарах ёстой. Жишээлбэл ой мод, ус, биологийн зарим төрөл зүйлүүд... Мөн хөрсний бохирдол зэрэг асуудлаар хөрөнгө оруулалтынхаа бодлогыг гаргаж ирэх хэрэгтэй. Энэний дараа та, манай яам 500.0 сая л төгрөгтэй гэж ийм сул дорой дуугаар дуугарахаа болино. Энийг л одоо хийх нь зүйтэй. Яагаад

гэвэл, нөгөө тогтвортой хөгжлийн бодлого чинь байгаль орчныхоо төлөв байдал дээр суурилсан, тэр дээр үндэслэсэн хөрөнгө оруулалтын бодлогыг гаргаж ирэх ёстой. Энийг 2014 оны төсөл, төсөвт хийх үү гэсэн *нэгдүгээр асуулт*.

*Хоёрдугаарх нь*, үндэсний хэмжээнд одоо нийт хэдэн байгаль орчинтой холбоотой хөтөлбөр байна вэ? Хэдэн хороо байна вэ? Хэдэн зөвлөл байна вэ? Тэгээд энэ хэдийг хараад байхад, нэг хэсэг нь хэрэгждэг, нэг хэсэг нь хэрэгждэггүй хөтөлбөр байна. Нэг хэсэг хороо нь формаль ажилладаг. Нэг хэсэг хороо нь ингээд ажиллах гээд оролдоод байдаг. Зөвлөл ялгаагүй. Тэгэхээр энийг надад нэг тодруулж өгөхгүй юу.

*Гуравдугаарх нь*, Энэ Ц.Банзрагч гуайг байгаа дээр нь бас асууя. Энэ модны хулгайг одоо яг яаж зогсоох вэ? Энэ 2013 онд, 2014 онд хүмүүст мэдрэгдтэл нь ямар арга хэмжээ авах юм бэ? Танай яам чинь бодлогын яам гээд байдаг, тэгтэл та нарыг өдөр шөнөгүй л бодлого бодож байх хооронд машин машинаар хулгай орсоор л байна. Мэдээж хэрэг, энэ чинь ганцхан яамны асуудал биш шүү дээ. Энэ чиглэлээр одоо яг юу хийгдэж байна вэ гэдэг нэг ийм асуулт байна.

*Дөрөвдүгээр асуулт нь*, энэ цэвэр үйлдвэрлэл, цэвэр технологи, ногоон бизнесийг хөгжүүлэх талаар өнөөдрийн байгаа бүх хууль тогтоомжууд хэдэн ширхэг, хичнээн **incentive** /шагнал урамшуулал/ буюу хүмүүст хөшүүрэг, эдийн засгийн хөшүүрэг болж байгаа заалтууд байна вэ? Энийг та бүхэн цаашдаа энэ хууль, тогтоомжууд болон Засгийн газрын тогтол шийдвэрээр яаж нэмэгдүүлэх гэж байна вэ?

*Тавдугаар асуулт нь*, Мянганы хөгжлийн зорилтууд дээр байгаа байгаль орчны талын зорилтууд 2015 оны сүүлч гэхэд хэрэгжих магадлал хэдэн хувьтай байна вэ?

*Зургадугаар асуулт нь*, ногоон аймгууд гарч ирж байна. Танай яамны идэвхтэй явуулж байгаа бодлогын хүчинд Архангай, Булган, Хөвсгөл аймгууд, цаашид мөдхөн нэмэгдэх шинжтэй. Энэ ногоон аймгуудын хөгжлийг ногоон хөгжлийн жишиг, загвар аймаг болгох гэсэн энэ орон нутгийн санаачлагыг Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас яаж дэмжих вэ?

*Эцсийн асуулт*. Ерөнхий сайдын удирддаг Тогтвортой хөгжлийн үндэсний хороо гэж бий. Ерөнхий сайд бас удирддаг Усны үндэсний хороо гэж бий. Усны үндэсний хорооны ажил бол ерөнхийдөө яам хоорондын координаци /зохицуулалт/ хийх юм билээ. Гэхдээ эртээд усны зөвлөгөөн хийж байхад энэ усны асуудалд маш хэцүү олон асуудал шийдэх ёстой юм билээ.

Тэгэхээр би С.Оюун сайдаас асууж байна л даа. Засгийн газар байгуулагдаад 8 сар болж байна. Би одоо хоёр дахь удаагаа энэ асуултыг асууж байгаа. Гэхдээ би та бүхэнд С.Оюун сайдыг хэлээсэй гэж бодож байгаа юм. Энэ яам хэдийгээр үндсэн чиглэлийн чиг үүргийн яам ч гэсэн миний одоо ингээд ажиглаж байгаагаар ганцаархнаа л үзээд байна. Бусад яамдууд энэ ногоон хөгжлийн чиглэлээр, энэ чиглэлээр маш сул байна. Ийм учраас Байгаль орчны, хөдөөгийн хөгжлийн байнгын хорооноос тогтоол гарсан шүү дээ. Ногоон хөгжлийг дэмжих жил гэж зарлаад. Та бүхнийг дэмжихийн тулд. Ерөнхий координацийг чинь хангахын тулд би төлөвлөгөө баталж өгсөн. Тэгэхээр Ерөнхий сайдаас би энэ дөрөв дэх өдөр асуух гэж байгаа юм. Ерөнхий сайд танай яамыг ер нь яг бодлогын приоритет тэргүүн ээлжинд авч үзэж байна уу, үгүй юу? Эсвэл өмнөх бүх Ерөнхий сайдуудад байсан хандлагаар, үлдэгдлийн зарчмаар буюу зөвхөн санхүүжилтийн хувьд төдийгүй бодлогын хувьд сүүлд нь авч үздэг

хандлага хэвээрээ байна уу? Хамгийн энгийн, хүний хэлээр асуух юм бол та ганцаардаж байна уу гэсэн асуулт байна. Энд хариулж өгнө үү.

**Ж.Батболд:** - За баярлалаа С.Дэмбэрэл дарга аа. Би нэг юм нэмчих үү. Энэ бол манай яамны ажил биш.

**С.Дэмбэрэл:** - Ингэж хамаагүй ярьж байж энэ телевизээр гарав, **Ж.Батболд** минь. Танай яамны асуудал. Хэдийгээр хуулинд байхгүй ч гэсэн. Та нар өөрсдийнхөө, яамныхаа, нэрнийхээ утга учрыг бодоод энэ асуултад ингэж хариулах юм бол энэ бол зарчмын хувьд маш буруу асуудал. Битгий ийм явцуу институцийн үүднээс хариул. Ингэж би зөвлөмөөр байна.

Зүгээр миний тодруулах юм бол хэзээ гэж би асуугаад байна шүү дээ. Хэзээ модны хулгайтай тэмцэх тэгвэл бодлого гарах юм бэ? Өөрөөр хэлбэл сая эрэлтийн талын юм ярилаа шүү дээ. Эрэлтийг нь багасгах. Өөрөөр хэлбэл хулгайлдаггүй эрэлтийг. Тийм ээ. Бий болгох. Эрүүл зөв ашигладаг эрэлтийг бий болгох. Ингэсний үндсэн дээр модны нийлүүлэлт, ойн нийлүүлэлт нь ингээд тийм ээ бодлогын хувьд тэнцвэржиж байдаг энэ бодлогыг л асуугаад байна шүү дээ. Тэгэхээр энэ хэзээ 2013 онд бэлтгэгдээд 2014 онд мөрдөгдөж эхлэх юм байна шүү дээ. За за би энийг л асуугаад байгаа байхгүй юу.

**Г.Баярсайхан:** - Тэгэхээр сая одоо бас манай С.Дэмбэрэл гишүүн их чухал асуулт асууж байна л даа. Модны хулгайтай яаж тэмцэх вэ гэж. Улсын Мэргэжлийн хяналтын газар, хүчний байгууллага үүнийг хариуцна гэж хариулж байна. Манайд хамаагүй гэж. Яамны удирдлага. За яах вэ зүгээр энд одоо манай Байнгын хорооныхон ярьж байгаа юм. Энэ бол одоо огцрох дайны хариулт шүү. Би бол ийм үгийг бол дахиж одоо хариуцлагагүй үг хэлэх юм бол би хариуцлага хүлээлгэх асуудал тавина шүү... С.Дэмбэрэл гишүүний ахалж байгаа ажлын хэсэг байгуулсан байгаа. За А.Бакей гишүүн, Ц.Цолмон гишүүн, Г.Баярсайхан гишүүн миний бие орсон байгаа. За хүрэн эдийн засгаас ногоон эдийн засагт шилжих үндэсний хөтөлбөрийг баталсан байгаа. Үүнийг хэрэгжилтийг одоо бас шалгана. Ногоон эдийн засгийн өсөлтийг хэмжих талаар холбогдох яам, төрийн бус байгууллага, эрдэмтдийн төлөөллийг оролцуулан дүгнэлт гаргана. За энэ бол одоо манай Байнгын хорооноос гаргасан ажлын төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа ажил гэдгийг хэлмээр байна.

## **Манай улс маш эмзэг ойн эко системтэй**

*2013 оны 05 дугаар сарын 15-ны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээс: Импортын мод, модон материалын талаар баримталж байгаа бодлого, арга хэмжээ нь Монгол Улсын ойн нөөцийг хамгаалахад үзцүлэх нөлөөллийн талаар Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюуны мэдээлэл сонсох. Импортын барилгын модон материалыг нийлцүлэх талаар авч хэрэгжцүлж байгаа арга хэмжээний тухай Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайханы мэдээлэл сонсох цээр*

С.Дэмбэрэл: Өнөөдөр энэ Байнгын хороогоор их чухал асуудлыг хэлэлцэж байна. Түрүүнээс хойш бүх гишүүдийн асуусан асуултууд, хариулж байгаа байдал дээр асар их зөрөө гарч байна. Гишүүд бол маш сайхан, тал талаас нь асууж байна. Бодит амьдралтай зүйл асуугаад, өөрөөр хэлбэл байхгүй байгаа зүйлийг асуугаад байна л даа. Эндээс хариулт өгөхөөрөө судалж байгаа, ингэж байгаа, тэгэж байгаа л гэх юм. Тэгэхлээр Байнгын хороогоос гарах эхний дүгнэлт бол ой модны салбарт төрийн бодлого нойл түвшинд байгаа юм байна. Өөрөөр хэлбэл юу ч хийгдээгүй юм байна. Худлаа ярьж байна. Ингэх гэж байгаа, тэгэх гэж байгаа гэж худлаа амлалт маягийн юм өгч байна. Ийм байдлаар маш эмзэг ойн эко системтэй, тэгээд энэ өвөрмөц нутаг дэвсгэртэй... Түрүүн Л.Энх-Амгалан гишүүний хэлсэн үгийг анзаарсан уу, үгүй юу? Судалгаа байгаа шүү. Одоо ойрын 3-10 жилд Монгол Улсын 8 аймагт огт модны нөөцгүй болно. Дээр нь ойгоор баялаг Хэнтий, Хөвсгөл аймаг гэх мэтийн аймгуудад модны хулгай, модыг зүй бусаар ашиглах нь бол улам бүр нэмэгдэж байна. Ойн түймэр энэ бүхнийг ярихгүйгээр зөвхөн модны хулгай, одоо бид ярьж байхад л өнөө шөнө Улаанбаатар луу 4 талаас нь орж ирж байгаа. Энэ асуудлыг тавихаар эртээдийн хурал дээр манайх модны асуудал хариуцдаггүй гэснийг санаж байна уу? Ийм хариулт өгч байсан. Эндээс юу хэлэх гэж байна вэ гэвэл, одоо бид юу хийх ёстой гэхээр сонсолоо шүү дээ, бодлого байдаггүй байна. Тэгвэл одоо сарын хугацаатай, хаврын чуулганы хугацаанд, энэ саяны гишүүдийн асуусан ой модны нөөц, ой модны арчилт хамгаалалт, ой модны үржил шим, хууль бус хулгай, дээр нь мод, модны үйлдэрлэл, модон эдлэл хэрэглэл гэх мэтийн импорт энэ бүх асуудлыг багтаасан яаралтай бодлого гаргаж ирэх нэг сарын хугацаатай үүрэг өг. Тэгэхгүй бол ингэж дахин дахин сонсож сууж, цагаа үрэх ямар ч шаардлага байхгүй. Нойл түвшинд байна шүү. Харамсалтай нь С.Оюун гараад явчихлаа. Би одоо өөрийнхөө намын хүнийг шүүмжлэхээс өөр арга байхгүй. Энэ сууж байгаа хүмүүс, Ногоон хөгжлийн яам ямар юм хийгдэхгүй байгаа байна барилгын материал асуудал хариуцсан яамны, жишээлбэл Алтанбулагийн чөлөөт бүс энэ тэр гэснийг дэмжих хэрэгтэй. Гэхдээ энэ бүхэн маань иж бүрэн, цогц байх ёстой. Энэ өнөөдрийн оруулж ирж байгаа 2 асуудал байна, ерөөсөө эндээс маш тодорхой даалгавар өгөх хэрэгтэй, энэний даалгаварынхаа биелэлтийг дараагийнхаа хурлаар л шалгах ёстой. За баярлалаа.

## **Байгаль хамгаалах хүчийг иргэдийн оролцоогоор нэмэгдүүлэх хэрэгтэй болжээ**

*2013 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээс: Ойн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлэлцэх цээр*

**С.Дэмбэрэл:** Ойн хамгаалалтанд сумын албан тушаалтанаас гадна иргэдийн оролцоо яаж хангагдах юм бэ? Та нар энэ тухай бас бодооч гэсэн саналтай байна. Асуулт биш шүү. Орон нутагт байгаль хамгаалагч гээд ганц хүн байдаг. Тэр өөрөө нөлөөнд байдаг. Улс төрийн нөлөөнд ч байж болно, эсвэл тухайн засаг дарга, иргэдийн дарга нарын нөлөөнд байдаг. Хамгаална гэхэд маш хэцүү. Энэнийг би тодорхой аймгийн, тодорхой суман дээр жишээтэй ярьж болно. Гэхдээ энэ байгаль хамгаалах нь зөв боловч, энүүний хүчийн нэмэгдүүлэх, өөрөөр хэлбэл энэ нь нөхөрлөлийн оролцоо, иргэдийн оролцоо, бусад өөр сумуудын ч гэдэг юм уу аймгийн байгаль орчны байцаагчдийн нэгдсэн зөвлөлийн үндсэн дээр эрхийг нь олгодог бол тэр хүн ганцаардахгүй бөгөөд шийдвэр нь илүү хэрэгжих боломжтой. Ийм л санал байна. Үүнийг хууль санаачлагч Л.Энх-Амгалан гишүүн бас бодоод, энүүн дээрээ оруулж өгвөл сайн байна. Одоогийн энүүгээр чинь яваад энэ хуулинд нэг их өөрчлөлт гарахгүй шүү. Үүн дээр зүгээр нэг албан тушаалтанаасаа нөгөө байгаль хамгаалагч гэсэн нь хамгийн гоёоор бодоход итгэл үнэмшдэг нөлөө л өгч байгаа хэрэг. Энэний эрх мэдэл, шийдвэр гарах процесст нөлөөлөх нөлөөлөл нь маш их байгаа.

**Г.Баярсайхан:** Ямар хэмжээнд хязгаарлах вэ гэдгийг та яриад байна. Тийм ээ?

**С.Дэмбэрэл:** Тийм. Энэ шийдвэр гаргах, өөрөөр хэлбэл зөвшөөрөл өгнө гэж байна шүү дээ. Үүнийг хамтын шийдвэрийн нөлөөнд, ингэж оруулж өгвөл тухайн орон нутгийн хүмүүсийн нөхөрлөлийн шийдвэр болж, ганцхан тэр хүний үзэмжийн юм байхаа болино. Тийм байдлаар л өөрчлөх хэрэгтэй.

**Л.Энх-Амгалан:** Энэ зөвхөн хэрэглээний модных гээд, тэрнээс биш одоо үйлдвэрийн зориулалтаар байгаа нойтон модны бүх гожингуудыг засаг даргынхаа шийдвэрээр олгодог. Энд зөвхөн хийж байгаа өөрчлөлт нь хуурай ой цэвэрлэж байгаа, хэрэглээний модны зориулалтаар ирж байгаа модны тухай асуудал юм.

**С.Дэмбэрэл:** Энэ ойтой холбоотой ямар ч хууль гарсан, тэр нь нэг л зорилготой. Ойн хууль бус, хулгайг яаж багасгах вэ гэсэн олон талын үзүүртэй л хууль байх ёстой. Хэрэглээ ч бай, үйлдвэрлэл ч бай ялгаагүй. Тийм учраас энэ мод чинь... Даргаа өөрөөс чинь тодруулах юм байна. Цагдаагийн Ерөнхий Газрын Улсын мөрдөн байцаах газар гэж байдаг юм байна. Тэрний дарга нь Ц.Батсүх гэдэг хүн байдаг юм байна. Тэр хүнээс эртээдийн манай хуралдаан дээр хэлэлцсэн асуудлын талаар захидал ирсэн байна. Эртээд манай байнгын хороогоор нэг асуудал авч хэлэлцэж байх үед ойн асуудалд эдний 7 санал байна. Зөвхөн санхүүтэй хобоотой юм байна. Энэ асуудлыг үргэлжлүүлээд ярих гэхээр, мөрдөн байцаах газар нь байгаль орчны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах хөрөнгө байдаггүй юм байна. Багаж хэрэгсэл нь ч байдаггүй. Иймэрхүү 7 шалтгаан, өөрөөр хэлбэл, хуулинд цаашдаа оруулах 7 шалтгаан байна. Төсвийн хүндрэлтэй байдал л

байна. Тооцоог нь хийгээд, гаргачихсан байна л даа. Өөрөөр хэлбэл өмнөх хуралдааны мөрөөр, цаашдаа асуудлыг гүнзгийрүүлэн шийдэхийн тулд надад хаяглаад, ийм захидал ирүүлсэн байна. Энийг байнгын хорооны хуралдаанаар авч хэлэлцэх үү? Өмнө нь тэднийг байнгын хороон дээр ярьж байхад нь би бас сонссон. Гэмт хэрэгтэй тэмцэх гэхээр хөрөнгө мөнгө нь хүрэлцэхгүй байна. Бүх шалтгаануудыг, жишээлбэл ийм ийм хуулинд, ийм ийм заалтууд садаа болж байна гэсэн саналууд байсан. Үүнийг одоо яах вэ? Миний хувьд, байнгын хорооны даргад өгмөөр санагдаад байна.

Мөн техникийн ухааны доктор И.Бодий гэдэг хүн агаар, хөрс болон гүний усны асуудлыг судлаад, үнэхээр прагматик, тодорхой, бодит ажил болохуйц бүтээл хийж, төсөл боловсруулсан байна. Сайн дэмжээд явбал, цаашид ус, хөрс, агаарын бохирдлыг эрс бууруулахад маш тодорхой үр дүн гарахуйц, арилжааны маягийн, өөрийгөө нөхөн сахүүжүүлээд явчихаар бодит санал санаачилга боловсруулсан байна. 1 л жилийн дотор бүтээчихуйц, тэрнээс биш 4-5 жилийнх биш, тэгээд хямд өртөгтэй, ард иргэд худалдан аваад, хашаандаа тавиад, ил жорлон гэсэн муухай ойлголтоосоо салаад, хөрс, ус, агаараа бохирдуулахгүйгээр эрчим хүч, дулааны асуудлаа давхар шийдчих ийм нэг ач холбогдолтой төсөл ирүүлсэн байна. Ийм 2 асуудлыг яах вэ?

**Г.Баярсайхан:** Эхний асуудал бол байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх тасаг байдаг. Улсын мөрдөн байцаах газарт бас энэ байгаль орчинтой холбоотой мөрдөн шалгах хэсэг бий. Хөрөнгө мөнгөний асуудал бол үнэхээр яригддаг. Бид хөдөө гадаа, ажлын хэсэг байгуулаад, томилолтонд явна гэхээр хөрөнгийн асуудлаас болоод олон асуудал гарч ирдэг. Гэхдээ энэ асуудлыг байнгын хороогоор хэлэлцээд, тухайн төсвийн асуудал яригдах үед Төсвийн байнгын хороонд шилжүүлээд явах нь зүйтэй байхаа гэсэн ийм байр суурьтай байна. С.Дэмбэрэл гишүүнээ, И.Бодий доктортой би бас уулзсан. Энэ оруулж ирсэн асуудлыг сайн мэднэ. Бие организмгаас гарсан ялгадаснаас газ гаргаад, түүнийгээ ахуйн хэрэгцээг хангахад ашиглах санааг бүгд дэмжих байх, байнгын хороогоор хэлэлцүүлэх гэж байгаа бол та хурлын эхэнд, хэлэлцэх асуудлуудын жагсаалтанд оруулаад хэлэлцүүлээд явах ёстой. Байнгын хороогоор, Улаанбаатар хотын байгаль орчин ногоон хөгжлийн чиглэлээр дэмжигдсэн ажил болгон, энэ оны эхний 6 сарын байдлаар ямар гүйцэтгэлтэй, юу хийж байгаагаа, цаашид юу шаардлагатай байгаа талаар сонсож болох уу гэсэн санал байна.

**Г.Баярсайхан:** Нээлттэй та санал болгож байгаа бол дараагийн хуралд асуудлыг хэлэлцэж болно. Зохих албан тушаалтануудыг дуудъя. Байнгын хорооноос зохих албан тушаалтануудад албан тоот явуулья.



## Ойгоо барчих вий гэсэн түгшүүрийг яаж арилгах вэ

*Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2013 оны 6 сарын 28-ны хуралдааны тэмдэглэлээс: Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээс*

**С.Дэмбэрэл:** Ойн тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтөөр модны хулгайг яаж зогсоох вэ? Ойгоо барчих вий гэсэн түгшүүрийг яаж арилгах вэ гэсэн асуултыг асуух гэсэн юм. Яагаад гэвэл энэнийг маш олон хүмүүс хүлээж байна. Үүнд тодорхой хариулт өгнө үү?

**Л.Энх-Амгалан:** Энэ хуульд өөрчлөлт оруулж байгаа 3 үндэслэл байгаа.

1. Үндсэндээ одоогийн байгаа баталсан ойн тухай хуулин дээр хөдөө амьдарч байгаа иргэд түлшний модоо бэлтгэхэд заавал сумын төв орж, сумын засаг дарга болон түүний томилсон албан тушаалтанаар дамжуулан гоожин авч байгаа. Ийм зохицуулалт байж байгаа. Бүр хуучин хуулиар байгаль орчны хамгаалагчид өөрсдөө гоожингоо өгдөг байсан тийм зохицуулалттай олон жил болсон тогтолцоо байсан байна лээ. Шинэ хуулиар засаг дарга түүний томилсон албан тушаалтан өгдөг болсон. Энэ нь нилээд чирэгдэл учруулж байна. Үүнийг засаж залруулъя. Энэ бол амьдралаас үүсч гарч байгаа нөхцөл байдал.

2. Түймэрээс урьдчилан сэргийлэх ажилд хүмүүсийг, иргэдийг татан оролцуулчихаад ямар нэгэн урамшуулалын механизм байдаггүй. Үүнд анхаарахыг хичээж байна.

3. Ойд түймэр тавьсан, байгаль орчинд хохирол учруулсан этгээдэд ямар эрх зүйн хариуцлага хүлээлгэх нь тодорхой бус байсан. Энэнийг маш тодорхой болгож өгч байгаа.

4. Ойг цэвэрлэж байгаа, нөхөн сэргээж байгаа, шавьжтай тэмцэж байгаа, түймэртэй тэмцэж байгаа улсуудад эдийн засгийн хөшүүрэг нь байх ёстой юм байна. Төрөөс ийм улсуудыг урамшуулалд хамрагдуулах зүйлүүдийг тусгасан байгаа. Тэгэхлээр С.Дэмбэрэл гишүүний асууж байгаадаа энэ хуулийн энэ заалтаар ойн хулгайтай тэмцэх зохицуулалтууд байгаа. Үүн дээр засгийн газар илүү тайлбар өгсөн нь дээр байхаа.

**С.Дэмбэрэл:** Та өгч чадахгүй юм уу?

**Банзрагч:** За эрхэм гишүүдээ, би ганцхан зүйл нэмье. Одоогийн энэ санаачилсан хууль нь ойн хулгайг бууруулахад ямар нэгэн дэм өгнө гэж засгийн газар, манай яам дэмжсэн л дээ. Энэ нь юу вэ гэхлээр одоо зөвхөн сумын төв дээр мод бэлтгэх зөвшөөрөл өгөөд байхаар их холдоод байгаа юм. 60 км, 120 км хол байгаа сум багуудад хүрч зөвшөөрөл авна гэдэг хүндрэлтэй. Хуучин баг орохгүйгээр байцаагчаас авчихдаг байсан зөвшөөрлөө авч чадахгүй болохоор хулгай болчихоод байсан. Одоо хажуу талд нь эрхийн бичгийг нь өгөхөөр ямар ч гэсэн гоожин хулгайлахгүйгээр ойн тухай хууль нь 2.1.4 зааснаар эрхээ хэрэгжүүлэх боломж нээгдэж байгаагаараа нутгийн иргэдэд бас л дэм болно гэж үзэж байна. Бусдыг нь сая гишүүн хэлсэн. Урамшуулалын механизмууд орж ирж байгаа.

## **Агаарыг бохирдлыг арилгах цогц бодлого хэрэгтэй**

*2013 оны 11 дүгээр сарын 27-нд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар “Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг /Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн/ хэлэлцлээ. Байнгын хорооны хурлыг УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл удирдаж, хурал бүтэн цаг хагас үргэлжилж, олон асуулт гарч, хариу авч, санал шүүмжлэлцүүд өрнөлөө. Хуралдааны төгсгөлд хуралдаан даргалагч, УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл ингэж дүгнэжээ.*

Бид өнөөдөр маш чухал зүйл ярилцлаа. Тэр байтугай бид өнөөдөр орж ирсэн төслөөс ч хальсан, өргөн хүрээнд асуудлыг хөндлөө. Гэхдээ үнэхээр бидэнд тодорхой харагдсан зүйл бол Д.Арвин, Л.Эрдэнэчимэг нарын гишүүдийн хэлээд байгаа шиг нэг зүйл бодохгүй бол болохоо байсан байна. Өнөөдрийн оруулж ирж байгаа хуулийн төслийг би яриад, янзлаад, сайхан хууль болгочихож болно. Гэхдээ асуудал үлдэж байна. Өөрөөр хэлбэл УТАА ҮЛДЭЖ байна. Одоо хамгийн гол нь, энэ хуулиасаа гадна дараагийн байнгын хорооны хурал дээр, Г.Баярсайхан даргыг ирэхээр бид хамтраад нэг асуудлыг тавьмаар байна. Жишээлбэл, энэ агаарын тухай хуулинд өөрчлөлт оруулах тухай яримаар байна. Өнөөдрийн авсан хариултуудаас харахад хуулинд оруулах өөрчлөлтүүд маш их байна шүү дээ. Тэгж байж л байдал өөрчлөгдөх юм байна. Энэ хуулинд өөрчлөлт оруулаад, бохирдол үүсгэж байгаа бусад эх үүсвэрүүдийн талаар нарийвчлан үзэж, эдгээрт зориулсан төрийн бодлого, хууль журмууд нь ямар байх юм бэ, Монгол улс өөрөө өмчлөлөө буюу санаачлагаа алдчихсан юм байна шүү дээ. Тэгээд Дэлхийн банк, энэ тэр гэсэн газраас мөнгө зээлж авчихаад, гадаадаас зуухнуудыг гадаадынханаар бэлэн мөнгөөр худалдаж авч, үнэгүй тараачихаад л, хуралдаад сууж байдаг. Ийм хөгийн юм байж болох уу? Тийм учраас саяны ярилцсаны дагуу, иж бүрэн цогц байдлаар асуудалд хандахыг та бүхнээс уриалж байна. Үнэхээр бид санаа зовж байгаа учраас энэ хууль явдгаараа яваад өнгөрсөн ч дээр нь олон хуульд, жишээлбэл, Яамдын эрх зүйн байдлын тухай хуулинд өөрчлөлт оруулах хэрэгтэй. Тухайн яамны чиг үүрэгт нь нийт үндэсний хэмжээнд гамшиг болсон асуудалтай тэмцэх чиг үүргийг бүгдэд нь тэнцүү оруулж, үүрэг болгож өгөх хэрэгтэй. Тэгэхээр, Батлан хамгаалах яам, Гадаад харилцааны яамны чиг үүрэгт ч агаарын бохирдолтой тэмцэх чиг үүрэг ноогдож эхэлнэ. Ингэсэн тохиолдолд Яамдуудын ажил, бодлогын уялдаа өөрийн эрхгүй сайжирна. Тэгээд үүнийгээ яаж сайжруулах юм бэ, институцүүд яаж оролцох вэ, зуухнаас гадна машины бохир утааг яах вэ, уурын зуухнуудыг яах вэ, бусад бохирдлын эх үүсвэр тус бүр дээр ямар ямар арга хэмжээнүүдийг хэн хэн авах вэ гэдгийг тодорхой болгож, иж бүрэн хандлагаар тэмцэх тийм л шаардлага тулгараад байна гэж ойлгогдлоо. Энэ тал дээр байнгын хорооны гишүүд та бүхэн саналаа маш зүйтэй хэлцгээлээ. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны энэ удаагийн хуралдаан дууссаныг мэдэгдэж байна.

## Газар бол эко системийн гол бүрэлдэхүүн хэсэг

*2014 оны 01 дүгээр сарын 07-нд УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны “Газрын тухай” хуулийн ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлээс:*

С. Дэмбэрэл: Энэ бол багц хууль. Нэг хуулиас бусад нь газрыг эдийн засгийн талаас нь л авч хэлэлцэж байгаа гэж би ойлгож байна. Тэр нэг хууль нь газрын тухай ерөнхий хууль. Хэнд харьяалуулах вэ гэсэн асуудал яриад байгаа учраас удаж байгаа бололтой. Хэрэв энэ асуудал 2004 оноос хойш Барилгын яамны харьяанд явж байсан, тус яам газрыг хариуцдаг байсан л юм бол бид барилгын яамнаас “Цөлжилтийн талаар юу хийсэн бэ? Биологийн төрөл зүйлийн талаар юу хийсэн бэ? Ойн талаар юу хийсэн бэ” гэдгийг асуух ёстой. Мэдээж тэд хариулж чадахгүй. Тэгэхээр харьяалал нь утгагүй байна гэсэн үг. **нэгдүгээрт.**

**Хоёрдугаарт,** Газрыг хоёр талаас нь авч үзэх ёстой.

1. Газар бол эко системийн гол бүрэлдхүүн хэсэг. Эко систем гэдэг нь та биднийг тэжээж байдаг газар, ус, ой мод, биологийн төрөл зүйл. Эко системийн талаас газар гэдэг ойлголтонд агаар хүртэл орж байдаг.

2. Газрыг эдийн засгийн орон зай гэдэг талаас нь харах бол түүнийг хүний нөлөөллийн замаар өөрчлөх процесс болно.

Өнгөрсөн хугацаанд ногоон эдийн засаг, тогтвортой хөгжил гэж ярьдаггүй байх үед эдийн засгийн орон зай гэдэг талаас нь зөвхөн хараад, Барилга, хот байгуулалтын яамны харьяалалд өгсөн байна. Одоо орчин үеийн чиг хандлага буюу бидний хамгийн их ярьдаг болсон эко системийн бүрэлдхүүн талаас нь авч үзээд Байгаль орчин ногоон хөгжлийн яамны харьяаллын асуудал болгосон.

**Гуравдугаарт,** Иймэрхүү маргаан гараад байгаа учраас одоо, бүх юмыг ерөнхий сайдад аваачиж наадаг болчихоод байна. Ерөнхий сайдын хариуцаж байгаа асуудлыг нь харахаар маш олон үндэсний хороог ахалж байгаа. Энэ бол шийдэл олохгүй болохоороо хүн рүү чихдэг вариант байна. Миний бодлоор газрын асуудал бол орчин үеийн суурь зарчмаараа эко системийн асуудал юм. Эко системийн асуудал учраас үүнийг хариуцсан төрийн яам нь энэнийгээ үндсэндээ хариуцаад, эдийн засгийн хувьд хөдөө аж ахуй, барилга, дэд бүтцийн талаас нь ашиглах асуудлууд нь энэхүү суурь асуудлаасаа ургаж гарсан буюу суурь институтци-ээсээ харьяалалтайгаар шийдэх нь зөв. Өөрөөр хэлбэл газрыг эко систем талаас нь эхлэн харж байж, дараа нь эдийн засгийн ажилбарууд буюу эдийн засгийн орон зай болгож ашиглах эсэхийг шийддэг институтцийн бүтэц байх гэдэг талаасаа хандсан вариант нь хамгийн зөв. Бид орчин үеийн хандлагыг харуулж, энэ талаас нь л бодох ёстой. Тэгээд нийт газар нутгийн хэмжээг бодоод үз. Хичнээн ой цөлжиж байгаа вэ гэж бодоод үз. Биологийн төрөл зүйлүүд ямар байдалд орсон байгааг, газрын деградаци /бохирдол, доройтол, эвдрэл.../ ямар түвшинд явж байгааг бод. Энэ бүхнийг харгалзан үзвэл энэ 3-р вариантаас аль нь ч бүтэхгүй. Ийм хууль гаргавал Монгол улсын эсрэг хууль болно. Бодлогынх нь эсрэг зүйл болно. Ийм зүйлүүдийг цаашдаа их анхаарах хэрэгтэй.

## **Ногоон хөгжлийг бохир агаартай Улаанбаатар хотод хэрэгжүүлж чадахгүй**

*УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2013 оны 12 сарын 25-ны хуралдааны тэмдэглэлээс: Хэлэлцсэн асуудал: Байнгын хорооны даргыг сонгох.*

С.Дэмбэрэл: Өнгөрсөн нэг жилийн хугацаанд энэ байнгын хороонд орж, Г.Баярсайхан даргатай ажиллав. Ажиллах чадвар сайтай, асуудлыг гярхай олж хардаг, цаг хугацаа алдуулдаггүй, гаргасан шийдвэрийнхээ араас тууштай биелэлтийг нь шахдаг гэсэн хэдэн сайн шинж чанаруудыг олж харсан. 2014 оны хувьд, агаарын бохирдлын асуудлыг онцгой анхаарч, дэд хороогоо маш их дэмжиж, номер нэг асуудал болгон ажиллах нь зүйтэй байх. Яагаад гэвэл, бид мөдхөн ногоон хөгжлийн бодлогыг батлана. Ногоон хөгжлийг бид бохир агаартай Улаанбаатар хотод хэрэгжүүлж чадахгүй нь ойлгомжтой. Тийм учраас ногоон үзлийн суурь асуудлын нэг болсон агаарын бохирдлын асуудал дээр 2014 оныхоо байнгын хорооны үйл ажиллагааг чиглүүлж, тус байнгын хорооны доор ажиллаж байгаа дэд хорооныхоо үйл ажиллагааг маш их дэмжиж ажиллаасай гэж хэлэх байна. Г.Баярсайхан даргын цаашдаа үргэлжлүүлж ажиллах энэ асуудлыг УИХ дахь ИЗНН-ын хамгийн “гом бүлэг” “маш их нухацтай авч хэлэлцээд”, Ардчилсан намаас гаргасан шийдвэрийг дэмжиж байгаа гэдгийг илэрхийлэхэд таатай байна.

## **Бид өөрсдөө шийдвэрлэх ажил хийх ёстой**

*УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2013 оны 12 сарын 25-ны хуралдааны тэмдэглэлээс: Ус болон уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр БОНХЯамны 2013 оны жилийн төсөв, үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх тайланг хэлэлцэх цээр*

С.Дэмбэрэл: С.Оюун сайдаас биш орлогч сайд, төрийн нарийн бичгийн дарга, газрын дарга, хэлтсийн дарга нараас асуух асуулт байна.

1. Яг энэ 2013 онд та нар өөрсдөө санаачлаад хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж байгаа ганц, ганц ажлуудаа товчхон, товчхон хэлээд өгнө үү.

2. Санхүүжилтийн талаар А.Бакей гишүүн хөндөж байна. Тэр санхүүжилт чинь үнэхээр бага байна. Ерөнхий чиг үүргийн яамны хийж байгаа болон хийх ёстой үйл ажиллагаанд огт хүрэлцэхгүй санхүүжилт байна. Үүнийг шулуухан, түс тас хэлчихмээр байна. Санхүүжилт чинь хүрдэггүй юм байна. Угаасаа, түүхээрээ Байгаль Орчны Яамны санхүүжилт дандаа үлдэгдлийн зарчмаар явж байна. Энэ хандлага өнөөдөр ч огт арилаагүй байна. Тэр тусмаа байгаль орчны асуудал дээр Ногоон хөгжил гэдэг асуудлаар санхүүжилтийг нэмэгдүүлэх, ялангуяа манай байнгын хорооноос болон Төсвийн байнгын хорооноос дэмжлэг аваад, 2014 оны санхүүжилтийг нэмэгдүүлэх талаар юу хийх вэ? Тухайлбал, агаарын бохирдлын асуудалд 20-хон тэрбум төгрөг төсөвлөсөн байна. Монгол улс чинь агаарынхаа бохирдлыг Мянганы хөгжлийн санд даалгачихсан биш шүү дээ. Бид өөрсдөө шийдвэрлэх ажил хийх ёстой. Ингэхийн тулд

мөнгө, төсөв хэрэгтэй. Хамгийн энгийн тооцоогоор үзэхэд л 20 тэрбум байтугай, 200 тэрбум шаардлагатай. Ийм тохиолдолд яаж санхүүжилтийг нэмэгдүүлэх вэ? гэдэг асуудал тулгараад байна.

3. Сүүлийн үед Хөгжлийн банк нь “Хөгжлийн сан нэртэй хогийн сав” болох гээд байна. Концефцийн үйл ажиллагаа гэдэг нь бас л хэн ч хийдэггүй, төр хийхээс залхуурдаг тийм ажлуудаа шиддэг бас нэг хогийн сав болох гээд байна. Тэгсэн мөртлөө концефци нь өөрөө хувийн хэвшлийнхний итгэлийг алдчихсан, мөнгөө төлдөггүй, тодорхой биш, гэрээний сахилга бат байхгүй байна. Ийм тохиолдолд концефциор юм хийлгэх гээд асуудал шийдэгдэхгүй. Тийм учраас концефцээр шийдүүлчихье гээд байгаа зүйлүүдийнхээ санхүүжилтүүдийг нэмээд, 2014 оны санхүүжилтийг төсөвт тусгах талаар юм хийж болдоггүй юм уу гэсэн санал маягийн асуулт байна.

4. Байгаль орчны сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга нь ороод Ерөнхий сайд нь ахалдаг Тогтвортой хөгжлийн үндэсний хороо байгууллагдаад бүтэн жил боллоо. Үүнийг санаачлаад, байгуулуулаад, анхны хуралдаанд нь оролцсоноос хойш хэдэн сар өнгөрлөө. Энэ чиглэлээр 2014 онд дорвитой өөрчлөлт хийх ямар нэгэн зүйлийг БОНХЯ-аас төлөвлөгдөж байна уу?

**Б.Тулга /БОНХЯ-ны дэд сайд/:** Маш товчоор нэг л ажлыг нэрлэе. НҮБ-ын Байгаль орчны хөгжлийн хөтөлбөр болон НҮБ-ын бусад 4 байгууллагатай хамтраад PAGE гэдэг хөтөлбөрийг зарласан байгаа. Тэр хөтөлбөрийн зорилго нь 2020 он гэхэд 30 орчим улсыг Ногоон эдийн засгийн загвар улс болгоё гэж зорьж байгаа. Бүх үйл ажиллагаагаа тухайн сонгосон улс орнууд руугаа чиглүүлэх санаачлага гаргасан. Энэ санаачлагад Монгол улсыг бол хамгийн анхны 7 улсын нэгээр бүртгүүлэхэд голлон хичээж ажилласан.

**Ж.Батболд /БОНХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга/:** Нэлээд олон ажлууд дээр ажилласан. Төр хувийн хэвшлийн түншлэлийг байгаль орчны салбарт бий болгоё гэдэг дээр анхаарч, энэ ажлыг 5 сараас эхлээд, 11 сард үндэсний чуулган хийж дуусгасан байгаа. Одоо бид нарын өмнө нэлээд олон ажил байгаа. Төрийн үйлчилгээг боловсронгуй болгох, зөвшөөрөл лицензүүдийг цэгцлэх, түншлэлийн жагсаалтуудаа бий болгох гэх мэтчилэн хууль эрх зүйн өөрчлөлт гээд энэ ажлыг С.Оюун сайдын тушаалаар дахин ажлын хэсэг гараад, би ахалж ажиллаж байгаа.

**Газрын дарга Банзрагч:** Ойн талаар хийсэн сайдын дурдсан бүх ажлууд манай хэлтсээр орсны дотор, яг өөрийн санаачлагаар хийсэн зүйл гэвэл ойжилтийн аж ахуйн арга хэмжээнд хувийн хэвшлийг оруулах зорилгоор таримал ойг худалдаж авах, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх зэрэг асуудлыг санаачилж боловсруулсан.

**Газрын дарга Оюунсүвд:** Усны нөөцийн чиглэлээр 2013 онд нэлээн хэдэн ажил хийсэн. Яг өөрөө сэтгэл хангалуун байгаа ажлаа нэрлэе. 1964 оноос хойш улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг нь тогтоогоод, тухайн үедээ газрын зурагт нарийн тэмдэглэгдэж чаддаггүй байсан бүх зураглалуудыг архиваас авч, дижитал зурагболгон хувиргаад газрын зурагт буулгаж, Монгол орны усны нөөцийг тогтоогдсон газрын зургийг хийсэн. Үүндээ их сэтгэл хангалуун байгаа.

**Газрын дарга Дашдаваа:** Тусгай хамгаалттай газрын сүлжээний хүрээнд олон ажил хийсэн. Тэр дотроос бид нарын хувьд өөрсдөө санаачилж хийсэн ажлыг сайд хэллээ. Засгийн газрын хөтөлбөрт орсон тусгай хамгаалттай газар нутагт аялал жуучлалыг хөгжүүлэх ажлыг цэгцтэй болгож явья гэсэн санааны хүрээнд “Тусгай хамгаалттай газарт байрлах эко гэр сууц



үйлчилгээнд тавигдах стандарт”-ыг боловруулж саяхан батлуулсан. 2014 оноос стандартын шаардлагыг тавиад, хэрэгжилтийг нь хангуулах боломж бүрдэж байгаа гэж үзэж байна.

- Манай газрын тухайд амьдралд хэрэг болох нэг асуудлыг сайдаараа дамжуулаад шийдвэрлэж байгаа. Арьс ширний анхан шатны боловсруулалтын үйлдвэрүүдэд одоо хэрэглэгдэж байгаа химийн бодисуудыг хааж, бактерийн бэлдмэлийг оруулах технологийн дамжуулалт хийж байгаа. Энэ ажлыг зэрэгцүүлээд явна. Ирэх жил үр дүн нь гарах байх.

- Тусгай хамгаалалттай газар нутагт ажиллах байгаль хамгаалагч, байцаагчдыг чадавхижуулах чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалт зохион байгуулсан. Үүн дээрээ үндэслээд, бүх хамгаалагчыг хамруулсан Үндэсний форумыг Төрийн ордонд зохион байгуулсан.

- Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр 2011 онд батлагдсан. Засгийн газар төлөвлөгөө гаргасан. Харамсалтай нь үүнийг хэрэгжүүлэх санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй учраас хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй байгаа. Тиймээс гадаадын санхүүжилтыг авч энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар өнгөрсөн жил нэлээн олон ажил хийсэн. Япон улстай түншлэл тогтоосноор энэ жил 10 гаруй сая ам.долларын төсөл хэрэгжиж байгаа. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлээр Олон улсын дасан зохицох сангаас 5,5 сая америк долларын төсөл хэрэгжиж байгаа. Энэ бол манай хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нэлээн бодитой санхүүгийн эх үүсвэр болж байгаа гэж бодож байна.

**С.Оюун:** 2012 оны сүүлээр С.Дэмбэрэл дарга бас яг энэ асуудлыг бидэнд тавьж байсан. *“Сайдаа, мөнгө төгрөгөө хөөцөлдөхгүй юм уу? мөнгөгүйгээр яаж ажлаа хийх гэж байгаа юм бэ?”* гээд асууж байсныгаа дахин сануулж байна. 2014 оны төсөв үнэхээр бага орлоготой байхаар байгаа учраас “та нар ямар нэгэн байдлаар төсвөө нэмж болохгүй” гэж Засгийн газраас бүх салбарууддаа даалгавар өгсөн учраас бид ч төсвөө олигтой нэмээгүй. Гэхдээ Дагвадорж гуайн хэлсэнчлэн, олон улсын байгууллагуудаас ямар нэгэн санхүүгийн дэмжлэгийг ирэх 3 жилийн хугацаанд нэлээд авахаар байгаа. Монгол улс одоо ядуу буурай орон биш, дунд орлоготой орон болчихсон учраас буцалтгүй тусламж тэр болгон ирэхгүй байгаа. Харин Байгаль орчны салбарт хамтран ажиллах боломж бас нэлээд байгаа. Дагвадорж гуайн төслүүдээс гадна Германы KfW банкнаас буцалтгүй санхүүжилтээр 11 сая евро, дээрээс нь улсын төсөвт жил болгон үүний Монголын талын санхүүжилт гээд 20% нь сууж байгаа. Тусгай хамгаалттай газар нутагт дэмжих хөрөнгө оруулалт хийх гээд нийтдээ 11 сая гэдэг чинь 5 жилд 20 тэрбум төгрөг зарцуулахаар ийм төсөл эхэлж байгаа юм. Тэрний 20% нь жил бүр улсын төсөвт сууж байгаа. Ирэх жил бид ойн тооллогыг олон улсын стандартын хүрээнд ШУ-ы үндэстэйгээр анх удаа хийх юм. Тэрэнд 3 орчим сая ам.долларыг JST-ээс гаргуулж байгаа. Төсөвт 1 тэрбум төгрөг суусан. Хүн амьн тооллогыг 10 жилдээ нэг хийдэг шиг энэ улс даяар ойн тооллого хийж, нүүрстөрөгчийг шингээх чадварын талаар болон бусад олон үзүүлэлтүүдийг нь хэмжих тооллого ирэх жил хийгдэх юм. Энэ тооллого хийгдсэний дараа уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх хөтөлбөрүүдийн хүрээнд хамтран ажиллах боломж бий болох юм. 2015 онд төсвөө өөр маягаар боловсруулахыг хичээнэ. Дашрамд хэлэхэд орон нутагт байгаль орчны чиглэлээр нэлээд төсөв хуваарилагдаж байгаа. Үйлдвэрлэл явагдах юм бол тэрнээс орох орлого нь шууд орон нутгийнхаа төсөвт нэмэгдэх шаардлагатай. Тэр үйлдвэрлэлийг нөхөөд байгаль хамгаалахад зарцуулах ёстой.



Тогтвортой хөгжлийн Үндэсний зөвлөлийн талаар С. Дэмбэрэл гишүүний асуултанд хариулъя. Ногоон Хөгжлийн үзэл баримтлал 2014 оны 1-р сард батлагдчихвал, Тогтвортой хөгжлийн Үндэсний зөвлөлөө Ногоон Хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх гол бүтэц болгож авах бодолтой байна. Учир нь салбар хоорондын зохицуулга маш их байгаа. Учир нь Ногоон хөгжилд зөвхөн манай яам биш, бүх салбарууд хамрагдаж байгаа учраас Ерөнхий сайдаар ахлуулсан Тогтвортой хөгжлийн Үндэсний зөвлөл дээрээ л Ногоон Хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, асуудлуудаа шийдвэрлүүлдэг болох нь зөв гэж үзэж байгаа. Бас Мянганы хөгжлийн зорилтууд нь 2015 оноос Тогтвортой хөгжлийн зорилтууд болно. Тэрийг манай улс Ногоон хөгжлийн зорилтуудаа шинээр боловсруулахад ашиглах нь зөв гэж үзэж байгаа.

### **Ойн менежментийг шинэ аргаар, шинэ хандлагаар явуулах хэрэгтэй**

*УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2013 оны 12 сарын 25-ны хуралдааны тэмдэглэлээс: “Монгол орны ойг цэвэрлэх, арчлах асуудлыг судалж, дүгнэлт гаргах цэрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлтийг сонсох, Тогтоолын төсөл батлах тухай” хэлэлцэх цээр:*

С. Дэмбэрэл: Нэг тогтоол гаргах гэж байх шиг байна. Танилцуулгын төгсгөлийн хуудасны өмнөх хуудас дээр ойн нөөцийн судалгаа хийх ажлыг яамуудаар нь хуваарилан хариуцуулж өгсөн байна. Ойн менежмент нь орчин үеийн нийлүүлтийн гинжин хэлхээ болон өртгийн гинжин хэлхээ (value chain) -тэй уялдахгүй байна. Үүн дээр шинэ менежментийн бүтэц хийе. Тэгэхгүй бол энэ чинь мөнхийн ингэж явах болно шүү. Зам тээврийн яам болохоор зам, тээврийн асуудлыг нь хариуцсан байна. Ц.Баярмаагийн яам бас нэг юмыг хариуцсан байх жишээтэй. Гэтэл эд нар чинь хоорондоо ямар ч уялдаагүй байна. Модны хулгай байдгаараа байж л байна. Улаанбаатар хотын захиргаа бас нэг зүйлийг нь хариуцмар аядана. Тэгэхээр шинэ менежментийн бүтэц хийж, БОНХ Яам өөрөө энэ ажлыг базаж байхгүй бол болохгүй. Нөөц талаас нь тооцоолоод үзсэнийг нь харахаар 5,8 их наяд гэсэн асар том үнэлгээтэй ойн нөөц байна. Энэ талаас нь бодож, цаашдаа ойн менежментийг шинэ аргаар, шинэ хандлагаар явуулахаар тогтоолынхоо төсөлд оруулахгүй бол ингэж нэг тогтоол гаргаад хэрэгжсэн ч юм байхгүй өнгөрнө. Араас нь хэрэгжүүлж байгаа эсэхийг хардаг хүн ч байхгүй, тэгсхийгээд дараа жилийн тайланд дутуу хагас мэдээлэл л орж ирэх болно. Гэтэл үр дүн чухал шүү дээ. Үр дүн гарахад менежментийн чинь арга барил хоцрогдсон байна. Энэнийгээ шинэчилж гэсэн гол санал өгч байна.

Мөн ойн баялагийг ашиглах компаниудын тухай асуудал байна. Шинжлэх ухаан, технологийн янз бүрийн арга хэрэглэх юм байна. Гэтэл Шинжлэх ухааны ганцхан төв байна. Тухайлбал, Химийн хүрээлэн, Биологийн хүрээлэн зэрэг Шинжлэх Ухааны байгууллагуудыг энэ чиглэлээр, тухайлан, ойн менежментийн асуудалд, ой нөөцийг зохицтой ашиглах асуудалд судалгаа, шинжилгээний хүчийг нь яаж ашиглах юм вэ гэдэг маань хоёрдахь гол чиглэл байх ёстой. Энэ талын юм дутуу байдаг юм

байна билээ. Энэ талаас нь их анхаарч, тогтоолынхоо төсөлд тусгахгүй бол болохооргүй том асуудал шүү. Энэ чинь бас давхар цэвэр агаарын асуудал. энэ талаас нь бодож ажиллах ёстой...

Зарчмын зөрүүтэй санал байна. Ийм тогтоолыг би анх удаа үзэж байна. Би бол хэзээ ч ийм тогтоол гаргахгүй. Уучлаарай, энэ бол дээд зэргийн муу боловсруулалттай тогтоол байна. Ийм тогтоолыг гаргаж байснаас, гаргахгүй байсан нь дээр. Эсвэл олигтойхон тогтоол гаргая. Судалгаа чинь нэлээн тоо баримт авсан, хийх алхмуудыг нь бичсэн их аятайхан болсон мөртлөө, тогтоол нь хэтэрхий сул юм гарах гээд байна. Ингэж тогтоол гаргадаггүй. Шоолуулах зүйл болох гээд байна. Н.Алтанхуяг ерөнхий сайд чиглэл болгож байгаа юм байна. Хуулийн хоёр заалтыг бэлэн хэлчихсэн байна. Бас л хэрэгжүүлэх ёстой зүйл шүү дээ. Тийм учраас миний зарчмын зөрүүтэй санал бол үүнийг буцаах санал байна. Маш сайн боловсруулалт хийлгэе. Яараад байх юм байхгүй. Тэгээд бүх яамдуудаас, эрдэм шинжилгээний байгууллагуудаас, мэргэжлийн холбоодуудаас саналыг нь авъя. Тэгээд дорвитойхон шиг юм гаргавал гаргая. Энэ тогтоолыг С.Оюунд хэрэгжүүл гээд өгье гэж бодъё. Яах юм бэ? Угаасаа хийх ёстой ажлуудыг нь л биччихсэн байна шүү дээ. Гэтэл энэ яам дутагдалтай ажилласан байж болно шүү дээ. Эрдэмтдээс, компануудаас, ойн чиглэлийн холбоонуудаас санал аваагүй байж болно шүү дээ. Ийм саналууд зайлшгүй шаардлагатай. Эд өөрсдөө дутуу ажилласан байж бас болно шүү дээ. Гэтэл бид илүү сайн ажилласан, илүү сайн боловсруулалттай тийм материал, тийм тогтоолыг өгөхгүй бол болохгүй шүү дээ. Тиймээс миний санал ийм байна.

Тогтоолын төслийг батлах асуудал хойшилсон.

### **Санаачилгатай ажиллаасай**

*2014 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн Байгаль орчин хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээс: “Монгол орны ойн цэвэрлэгээний талаар авах арга хэмжээний тухай” Байнгын хорооны 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар мэдээлэл сонсох цээр*

С.Дэмбэрэл: Ойн асуудал юу болж байна, сонсёе гэсэн хүсэлт маань байнгын хороогоор дэмжигдээд, хэлэлцэгдэж байгаад талархал илэрхийлэе. Би нэг юм асуумаар байна. Бид бүгдээрэ Монгол Улс маань сайхан ойтой байгаасай, үүнийгээ ургуулаад илүү их болгох юмсан гэж бодож явж байгаа. Модны хулгай бол одоогийн байдлаар салбар дундын асуудал болчихсон байна. Уг нь Монгол хүн болгоны асуудал. Гэтэл энэ асуудалд ахиц нь ямар байгаа юм бэ, модны хулгайтай тэмцэх талаар, модны хулгай хийдэггүй болгох талаар, эсвэл минимум /доод/ хэмжээнд нь хүргэх талаар ямар арга хэмжээг, хэн толгойлоод, ямар ямар байгууллагууд оролцоод, ямар үр дүнд хүрч байгаа юм бэ гэдэг хариулт нь тодорхой биш байна. Эртээд танай яаман дээр болсон төрийн болон төрийн бус байгууллагуудын нэг хуралдаанд санаандгүй орсон л доо. Тэрнээс харахад Улаанбаатар хотын захиргаа, Яам, Цагдаагийн газар гээд цөөнгүй газрууд асуудлыг ярьдаггүй биш, ярьдаг юм байна. Арга хэмжээ авдаггүй биш, авдаг юм

байна. Гэхдээ яагаад ийм олон жил энэ асуудал хэвлэл мэдээлэл олон нийтээр байнга ярьдаг мөнхийн сэдэв хэвээрээ байна вэ? Яагаад хэвлэл мэдээлэл олон нийт энэ чиглэлээр ийм зөв зүйл боллоо, ингэлээ, тэглээ шүү гэсэн эерэг мэдээлэл гарахгүй, тэр байтугай хулгайн арга нарийсаад байна, Улаанбаатар хотод орж ирдэг тийм тийм замууд байна, нэг арга нь харуулын функт байгуулах ёстой, тэрний мөнгө нь хүрэхгүй байна гэх мэтээр янз янзын юм хэлдэг. Шийдэл нь яг юу болох гэж байна вэ? Салбар хоорондын төлөөлөл оролцсон ажлын хэсэг маань энэнийг шийдэж чадах зөв шийдэл нь мөн үү? Шаардлагатай мөнгө төгрөгийг Цагдаагийн газар ч гэдэг юм уу, Улаанбаатар хот хэдийг гаргадаг юм? Цагдаагийн газарт хэдийг өгдөг юм? Эко цагдаа гэж байна уу? Ийм тал бүрээс нь бодсон шийдэл гарсан уу? гарах уу? гэсэн асуултанд маш тодорхой хариулт авмаар байна.

**С.Оюун:** Энэ маш чухал асуулт. С.Дэмбэрэл даргаа, бид Ойн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Байгаль орчны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нийт 10 гаруй нэмэлт өөрчлөлтийг өргөн барьсан. Засгийн газарт өнгөрсөн 7 хоногт хэлэлцэгдээд батлагдсан. Ямар учиртай нэмэлт, өөрчлөлт вэ? гэхлээр Модны хулгайтай тэмцэхэд зориулаад юу хийх ёстой вэ гэдгээр Ерөнхийлөгчийн зарлиг 4 дүгээр сарын 15-нд гарсан. Түүнийг нь дагаад төлөвлөгөө гарсан. Тэр төлөвлөгөөний дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нэг ажил байгаа. Хуулийг хэлэлцэх явцад Ойн тухай бодлого ч ирэх 7 хоногт УИХ-аар хэлэлцэгдэх юм. Тэр үеэр хулгайн модны асуудал тэртээ тэргүй их яригдах байх л даа. Нэгэнт хулгай юм чинь тэрийг Цагдаа хариуцана. Хяналт нь Мэргэжлийн хяналтын албанд байгаа, бодлого нь манай яамд байгаа. Нэгэнт гэмт хэрэг учраас цэрэг цагдаагийнхан ганцаараа хянаж дийлэхгүй байгаа учраас "иргэний хяналтыг нэмэгдүүл" хэмээн зарлигт санал тавигдсаны дагуу хулгайн мод тээвэрлэж байгаа тээврийн хэрэгслэл, тоног төхөөрөмжийг иргэн хүн мэдээлээд, тэр нь хулгайн мод гэдэг нь илэрвэл борлуулсаны орлогын 70 хувийг иргэнд өгнө гэсэн заалт орсон. Тэгэж байж, иргэний хяналтаа нэмэгдүүлнэ гэж үзсэн. Модны захуудад камер байршуулах зэрэг өөр юмнууд ч байгаа. Яам бид нар хууль бодлогыг хариуцаж байгаагийн хувьд хуулиа, журмуудаа оруулж ирж байгаа. Жишээлбэл, эрэлт нийлүүлэлт хоёр хоорондоо зөрүүтэй учраас бодлогоор өнгөрсөн жил гаднаас оруулж ирэх мод модон материалыг бүх төрлийн татвараас чөлөөлсөний үр дүн гарч байна. Өнгөрсөн 6 сард УИХ-аас батлагдсан бодлогын үр дүнд, энэ жилийн эхний 8 сарын байдлаар гаднаас орж ирж байгаа мод модон бүтээгдэхүүний хэмжээ 18 дахин нэмэгдсэн байна. Үнэтэй байсан учраас эхэндээ орж ирж байгаа мод бага байсан. 5 орчим мянган шоометр байж байгаад, одоо 90 шоометр болж байгаа. Цаана нь бидний хийсэн тооцоо судалгаагаар эрэлт бол жилдээ 3 сая орчим шоометр байгаа. Урьд нь сая шоометрийг зөвшөөрдөг байсан. Хэрэглээний бөгөөд түлээний модны зөвшөөрөл /“код” гэж ярьдаг/ яамнаас гаргадаг. Энэ жил хэрэглээний модоо, нойтон модоо нэмэхгүйгээр зүгээр арчилгаа цэвэрлэгээний зориулалтаар бэлтгэх модны кодыг нэмсэн. Тэр нь ойн цэвэрлэгээний хөтөлбөрийн хүрээнд, санхүүжилтээс болж түр зогссон байгаа. 3 сая эрэлт 1 сая нийлүүлэлт байгаагийн зөрүүг хооронд нь ойртуулахын тулд, гаднаас орж ирж байгаа мод, модон материалыг

нэмэгдүүлье, дотооддоо эдийн засгийн хөшүүргүүдийг дэмжих хэрэгтэй гээд УИХ болон засгийн газрын тогтоолуудаар “Таримал ой худалдаж авах” журам гарсан. Ойжуулалтын тариф нь нэмэгдсэн зэрэг эдийн засгийн хөшүүрэгүүд бий болсон. Энэ 2-ыг хооронд нь ойртуулахаас нааш амаргүй. Өнгөрсөн 5 жилийн судалгааг Мэргэжлийн хяналт болон Цагдаагаас авсан. Гарсан гэмт хэргүүдийн талаар Мэргэжлийн хяналтын шалгасан актын хэмжээгээр хулгайн мод 30 орчим хувиар буурсан байна. Пост байгуулна гээд Байгаль хамгаалах сангаас 10 сая төгрөг авсан. Харамсалтай нь үүнийгээ дагалдаад пост дээр зуух байхгүй, түлш байхгүй, ажиллах цалин байхгүй гээд байнгын маргаан дагалддаг. Нарийн эрх үүргээ заасан гэрээтэй байх юм бол бид нар ажиллаад явья гэдэг. Ингээд хоёрын хооронд гагцхисан байгаа. Ядаж постыг ажиллуулахын тулд нарийн гэрээ байгуулж байгаад урагшлуулна. Дараагийн 7 хоногт Хулгайн модтой холбоотой хуулийн төсөл орж ирэх учраас гишүүд илүү их зүйл асуух байх. Хамгийн сайн ашиглаж байгаа улсуудын жишээнүүд нэг нь Финлянд Улс. Гэхдээ тэнд хурд тундасын хэмжээ манайхаас 4, 5 дахин илүү байдаг. Тэгэхээр манайд модны ургаж байгаа хугацаа нь хамаагүй удаан. Ирэх 7 хоногт оруулж ирэх гэж байгаа Ойн бодлогын хуулийг гишүүд та нар засвал засна биз. Бидэнд арчилгаа цэвэрлэгээ хийж байгаа нойтон мод, хэрэглээний модоо дотооддоо ашиглалтаа нэмэхгүйгээр гаднаас оруулж ирэх тэр хөшүүргүүдээ л сайн дэмжмээр байгаа юм. Донсков сайд ирээд Монгол Оросын Засгийн газрын комисс дахин хуралдана. Тэрүүн дээр манай Яамнаас тавьж байгаа ганц асуудал бол Оруулж ирэх модны асуудал юм.

**С.Дэмбэрэл:** Зөв зөв ажлууд их л хийгдэж байгаа юм байна. Иргэдэд хөшүүрэг байхгүй учраас тэр болгон модны хулгайн асуудалд оролцож чадахгүй байна. Танай яамнаас гадна, Улаанбаатар хотын Цагдаагийн газар, Улаанбаатар хотын захиргааны зүгээс Улаанбаатар хотыг тойрсон ногоон уулнуудаас хийгдэж байгаа модны хулгайн чиглэлээр юу хийж байгаа вэ? Нэгдүгээрт энэ талаар тодруулж асуумаар байна. Модны хулгайн статистик хаана нэгтгэгдэж гардаг юм бэ? Нийт хичнээн га газар хамрагдсан бэ гэдгийг асуумаар байна.

2. Ойн цэвэрлэгээтэй холбогдуулаад, “Ойн холбоо”-ны хэсэг хүмүүс хэсэг тоног төхөөрөмж үзүүлж байсан. Тэр төхөөрөмж нь арван хэдэн мянган доллар орчим үнэтэй, жижиг үйлдвэр маягаар ажилладаг, ойн цэвэрлэгээ хийх үеэр түүнийг шууд ашиглаад шахмал түлш хийх асуудал ярьж байсан. Тэр хэр зэрэг бодитойгоор хэрэгжих вэ? Анхны ч гэдэг юм уу, ийм ийм газар ингэж, ингэж хэрэгжинэ, бид ийм ийм юм төлөвлөсөн байгаа гэсэн зүйл байвал тодорхой юм хэлж өгөөч!

**Нийслэлийн засаг даргын эколог, Ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч дарга Т.Бат-Эрдэнэ:** Улаанбаатар хотыг тойрсон ойн байгууламжийн ойг хамгаалсан 29 ойн байцаагч байдаг. Тэд нараар дамжуулж ойг хамгаалах ажиллагааг явуулдаг. Хулгайн модтой хэрхэн тэмцэж байна вэ гэвэл, Улаанбаатар хот руу албан бус замаар орж ирдэг чиглэлүүд байдаг. Ам амандаа байгаа чиглэлүүдэд пост хяналтаа идэвхжүүлж байна. Хоёрдугаарт, Энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, орон нутгийн иргэдтэй хамтарч ажилладаг. Гэхдээ гүйцэд

хааж чадахгүй байгаа. Ямар нэгэн байдлаар орж ирээд л байна. Ер нь мод хулгайлаад ачаад, бараа бүтээгдэхүүн болгоод явж байгаатай нь тэмцэх биш, модыг тайраад байгаа эх үүсвэр дээр нь хамгаалах ёстой. Нэгэнт гоожинг аваад, ачаанд ачаад, бүтээгдэхүүн болгоод явж байгаа хүмүүсийг барьж хориод байгаа нь хэр зохимжтой вэ гэсэн тал дээр бодох ёстой. Ойг сийрэгжүүлэх, цэвэрлэх ажиллагааг яамны тогтоолоор нь үйл ажиллагаа явуулж байгаа. Зарим иргэд санал тавьдаг юм. Тухайн ойд нь очоод жижиг оврын машин тавиад сайжруулсан түнш гаргая, хусны нүүрс гаргая гээд, хийж байгаа ганц нэг туршилт бий. Тэрийг хот нэг их дэмжихгүй байгаа. бодитой дэмлэг үзүүлж чадахгүй байгааг нуухгүй.

**Гантулга:** С.Дэмбэрэл гишүүний хоёрдугаар асуултанд хариулъя. Ойн модны үйлдвэрлэгчдийн холбооныхон, энэ чиглэлийн бизнес эрхэлдэг аж ахуйн нэгжүүд, гаднаас импортоор тоног төхөөрөмж оруулж ирдэг байгууллагуудтай хэд хэдэн удаа уулзалт хийгээд тоног төхөөрөмжийн судалгаа хийсэн. Цэвэрлэгээнээс гарах түүхий эдээс шахмал түлш их хэмжээгээр гарна. Тэрнийгээ борлуулах, дараа нь юу болох тэр тал дээр бодмоор юм бас байна. Шахмал түлшийг Цэвэр агаар сангийнхан авахаа больсон. Цэвэрлэгээнээсээ түлээний мод дийлэнхдээ гарч ирнэ. Тэрийг хотын хэрэгцээнд оруулж ирнэ. Ложистикийн асуудлыг боловсруулсан байгаа.

**БОХХААБХ-ны дарга Г.Баярсайхан:** Санал хэлэх гишүүд. С.Дэмбэрэл гишүүн.

**С.Дэмбэрэл:** Тэр *хулгайн модны асуудлаар* С.Оюун сайдын дараагийн 7 хоногт оруулах зүйл бол их чухал асуудал. Тал бүрээс нь, Ерөнхийлөгчийн зарлиг төдийгүй ерөнхийдөө УИХ-ын бодлогын үзэл санаанд ч тохируулж орж ирсэн байх гэж бодож байна. Гэхдээ хууль батлагдана энэ тэрээ гээд их юм болно шүү дээ, бас. Энэ хооронд Мэргэжлийн хяналтын байгууллага, Яам, Улаанбаатар хот, Улаанбаатар хотын Цагдаагийн байгууллага, холбогдох бусад байгууллага, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг нь илүү сайн уялдуулах, модны хулгайтай тэмцэх талаар, ялангуяа Улаанбаатар хот санаачлагатайгаар Эко цагдаа бий болгох асуудал шууд тавьж болно шүү. Ногоон Хөгжил хариуцсан тусгай нэгж, орлогч дарга нь энд сууж байна. Энэ бол цэвэр санаачлагын асуудал. Хуулийг хүлээлгүйгээр санаачлагатай ажиллах шаардлагатай байна. С.Оюун сайдын хэлсэн механизмыг хотын даргын хүрээнд, Сайдтай хамтарсан тушаал шийдвэрээр, бас урамшууллын механизмыг түр хугацаагаар мөрдүүлээд хийх боломжтой санагдаж байна. Холбогдох газар хэлтсүүд нь С.Оюун сайдад өөрсдөө санаачлагаараа оруулж ирж батлуулах асуудал шүү дээ. Улаанбаатар хотын орлогч дарга нь сууж байна, энэнийг өөрөө дэмждэг хүн, хамтраад ажиллах бүрэн боломжтой гэж би бодож байна.

**Хоёдугаар асуудал:** Ойн цэвэрлэгээний үеэр шахмал түлш хийх асуудлыг Улаанбаатар хоттойгоо яриад, холбогдох холбоодыг нь оролцуулаад, тодорхой шийдэл гаргаад, зарим нэгэн газар нь туршилтын журмаар, Улаанбаатар хотоос олгогдож байгаа зээл, хөрөнгө оруулалт эсвэл Жижиг Дунд Үйлдвэрийн зээлэнд оруулах байдлаар шийдээд явчих арга замууд бүрэн харагдаж байна. Миний харснаар 18-24.000 ам.долларын, Тайваниас худалдаж авах юмнууд голцуу байсан. Үүнийг шийдэж болохгүй



юу? Ийм байдлаар хийгээд эхэлчихвэл, энэ их чухал ажил болно. Та бүхэн санаачлагатай ажиллаасай гэж, бас манай байнгын хорооноос ч гэсэн чиглэл өгвөл сайн байна гэсэн ийм санал байна. Баярлалаа.

## **Туулын голын бохирдлын асуудлаар яаралтай Ажлын хэсэг байгуулж, би өөрөө ахалж ажилламаар байна**

*2014 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн Байгаль орчин хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээс: Туул голын бохирдлын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлэл сонсох цээр.*

С.Дэмбэрэл: Энэ бол маш чухал асуудал. Тийм учраас миний асуултууд их тодорхой бөгөөд цаашдын шийдэл руу хандсан асуултууд байх болно.

1. Улаанбаатар хотын иргэд бид Туул голынхоо төлөө, агаарын төлөө маш их санаа зовж байгаа. Бидний санаа зовж байгааг ойлгоод, агаарын чанарын индекс гээд өдөр болгон Twitter, Facebook дээр агаарын чанар ямар байна, утаа ямар байна гэдгийг гаргадаг болсон. Иргэн хүний хувьд яамнаас, холбогдох хотын захиргаанаас, холбогдох байгууллагуудаас, Туул голын захиргаанаас, сав газрын захиргаанаас шаардах зүйл бол, Туул голын усны чанарын индексийг өдөр болгон хэзээ мэдээлдэг болох вэ? Өөрөөр хэлбэл, энд байгаа мэдээллээс харахад одоогийн байгаа технологийн түвшинд үүнийг гаргаад олон нийтэд мэдээллээд байх, өөрсдийнхөө ямар ус ууж байгааг, гол ус нь ямар болж байгааг тогтмол харуулж, ингэснээрээ олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх утга учиртай юм.

2. Туул голын бохирдлын асуудлаар 6 хүчин зүйл байна. Эхнийх нь, саяны цэвэрлэх байгууламжын хүчин чадал, хоёр дахь нь Улаанбаатарт 2014 оны байдлаар 27 арьс шир, 27 ноос ноолуур, 16 өлөн боловсруулах үйлдвэр ажиллаж, эд нар нь гол бохирдуулах 2 дугаар хүчин зүйл болж орж ирсэн байна. 2-рх гэж байгаагийн учир нь та бүхнийг Туул голыг бохирдуулж байгаа зэрэглэлээр нь ингэж ангилсан гэж би ойлгож байгаа учраас дугаарлаж ярьж байгаа юм шүү. Хамгийн их бохирдуулагч нь нэгдүгээрт “Харгиа” цэвэрлэх байгууллагуудын хүчин чадал дутуу байгаа учраас голын бохирдлыг цэвэрлэж чадахгүй байна. Хоёдугаарт, арьс ширний үйлдвэрүүд Туул гол руу бохир усаа хийж байгаа учраас гэж ойлгогдож байна. Үүнтэй холбогдуулаад яамнаас асуух асуулт байна. Арьс шир, ноос ноолуур, өлөн боловсруулдаг компаниуд энэ чиглэлээрээ үйлдвэрлэлийн үйл ажиллага явуулахдаа, цэвэр, эко технологи хэрэглэхэд нь дэмжлэг үзүүлэх эрх зүйн ямар зүйл заалтуудыг, ямар хуулинд, хэзээ оруулж санаачлах гэж байна?

3. Арьс ширний үйлдвэрүүдийг хотоос нүүлгээд, Дархан хотод байршуулна гэсэн Засгийн газрын тогтоол гарсан. Одоо Эмээлт рүү нүүлгэнэ гэж яриад байдаг. Хичнээн хугацаа алдах юм бэ? Урт хугацаа гэж ярихаа боль, дунд хугацаанд хийх юмаа хэл. Монгол Улсын шийдвэр гаргадаг байдал, тэрний хэрэгждэг байдал нь нилээн хол сонсогдоод байна. Энэ тохиолдолд арьс шир, ноос ноолуур, өлөн боловсруулдаг аль ч компаниуд нь ялгаагүй, энэ бизнесийг хийхдээ цэвэр эко үйлдвэрлэл явуулдаг хөшүүрэг, эрх зүй, зээлийн асуудлуудыг яаж хууль эрх зүйн



талаас нь яаралтай байдлаар юу оруулах гэж байна? Энэ тал дээр 3-р зүйлийн шийдвэрлэх асуудал гэдэг дээр оруулж өгөөгүй байна. Энэ тал дээр БОНХЯ болон Улаанбаатар хотын байр суурь ямар байна?

4. Элс, хайрга олборлодог 29 аж ахуйн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон гэж байна. Инфиляци нэмэгдэх гэж байна. Инфиляцид нөлөөлдөг барилгын компонент нь яах гэж байна гээд больсон юм байна. Гэвч энэ нь үр дүн өгөхгүй байгаа юм байна. Өнгөрсөн хавар бид Уул Уурхайн талаар төрөөс баримтлах, Эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг батлаад, аливаа бизнес хийж байгаа компаниудын тогтвортой бизнесийн үйл ажиллагаа явуулах буюу байгаль орчныг бохирдуулалгүй ажиллах эрх зүйн үндсийг нь тавиад өгчихсөн. Хуулинд бас тавиад өгсөн. Эндээс гарах миний асуулт бол, үүнээс хойш Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн яам Уул Уурхайн яам хоёрын хамтарсан ямар шийдвэр гарсан вэ? Өөрөөр хэлбэл, 84 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг цуцлахаар санал өгөхөөсөө илүү, Уул уурхайн яам, БОНХЯ тэдгээр 84 аж ахуйн нэгж болон 29 аж ахуйн нэгжийн асуудлаар хамтарсан ямар шийвэр гаргах боломж байна вэ? гэсэн дараагийн асуулт байна.

5. “Барилгын хог хаягдал их хэмжээгээр асгаж байгаа... асуудлын шийдэл” гэдэг хэсэг дээр, Усны тухай хуулинд нэг заалт байсаар байтал, бүх шатны засаг дарга нар үүнийг огт хэрэгжүүлдэггүй юм байна. Хуулийг хэрэгжүүлдэггүй гэж байна. Яагаад хууль хэрэгжүүлдэггүй юм вэ? гэсэн асуултыг Улаанбаатар хотын Засаг даргаас асуумаар байна.

**С.Оюун сайд:** Арьс ширний үйлдвэрүүдийн техник технологи дээр дэмжих урамшуулах дээр юу байна вэ гэхлээр, ямартай ч УИХ “Бондоос зээл өгөх ёстой” гэсэн шийдвэр өнгөрсөн жил гаргасан. Хөдөө Аж Ахуйн Яаманд бондоор зээл өгөхдөө “Техник технологич сайжруулсан тохиолдолд” бондын зээл өгнө гэсэн шүү шийдвэр гарсан. Энэ шаардлагыг Засгийн газарт ч, УИХ-д ч бичгээр ч хүргүүлж байгаа. Бидний зүгээс Жишээлбэл, бохир ус цэвэрлэх төхөөрөмжийг хэрэв борлуулах юм бол ашгийн татвараас чөлөөлөх шийдвэрийг Засгийн газраас гаргуулсан. Гаалийн код нь 84212100 гэсэн кодтой. Өөрөөр хэлбэл, бохир ус цэвэрлэх зориулалттай бага болон дунд хэмжээний төхөөрөмжүүдийг борлуулах юм бол татвараас чөлөөлөх чиглэлийн юмыг 303-р тогтоолоор цэвэр технологийн 41 тоног төхөөрөмжийг ашгийн татвараас чөлөөлөхөөр оруулсан. Өнгөрсөн 7 долоо хоногт, Засгийн газарт “Хог хаягдлын үндэсний хөтөлбөр” гэдгийг Засгийн газраар хэлэлцүүлээд батлуулсан. Яамдуудаас санал оруулсан. Түүний хүрээнд Барилгын яаманд “Барилгын хог хаягдлын менежментын төлөвлөгөө” гаргах ёстой гэсэн зүйлийг бас хүргүүлсэн байгаа. Бүх салбарууд орон нутаг ч бай, өөрсдийнхөө хог хаягдалын менежментийн төлөвлөгөөтэй болохгүй бол энэ зүгээр хотын, нэг яамны асуудал биш. Салбар бүр өөрсдийн хог хаягдлын менежменттэй байх ёстой. БХБЯ Налайхад барилгын хог хаягдлыг боловсруулах үйлдвэр байгууллахаар судалгаа хийгээд, газрын зөвшөөрлөө авч байгаа гэсэн мэдээлэл өгсөн байгаа. Барилгын хог хаягдалтай холбоотойгоор Туул голын сав газраас Мэргэжлийн Хяналтын Байгууллагатай хамтран эргүүл хийсэн. Тэрний үр дүнг Газрын дарга мэдээлнэ үү.

**Г.Ганбат:** - С.Дэмбэрэл гишүүний асуултанд тодруулга өгье. Цэвэрлэх байгууламжын тоног төхөөрөмжүүдийг татвараас чөлөөлснөөр нааштай дэвшлүүд гараад эхэлсэн. Тодорхой тооны Арьс ширний үйлдвэрүүд өөрийн урдчилсан цэвэрлэх байгууламжтай болсон. Түүндээ анхан шатны цэвэрлэгээ хийгээд, дараагийн шат руу шилжүүлж байна.

**ҮХААЯ-ны Долгорсүрэн:** - Өнөөдрийн байдлаар үйлдвэр технологийн паркийн эрх зүйн байдлын хуулиар бол арьс ширний үйлдвэр цогцолбор хэлбэрээр хөгжихөөрөө тусгай зөвшөөрөл авна. Тусгай зөвшөөрлийн нөхцөл дотор “экологид ээлтэй, цэвэр үйлдвэрлэл” гэсэн шаардлага байгаа. Нэгдүгээрт.

*Хоёрдугаарт:* Өнгөрсөн жилээс эхлээд ноосны үйлдвэрүүд тодорхой хэмжээний хөнгөлттэй зээлийг авч байгаа. Энэ зээлүүдийг өгөхдөө ноосны анхан шатны боловсруулах үйлдвэр орон нутагт үйл ажиллагаа эхэлсэн тохиолдолд л өгнө гэсэн байгаа. Энэ ажлын хүрээнд өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотын ноос угаах үйлдвэр Баянхонгор аймагт, “Нэхээсгүй эдлэл”-ийн ноос угаах үйлдвэр Архангай аймагт... Одоо олгоод байгаа зээлүүдийг дандаа Орон нутаг руу үйл ажиллагаа явуулж байгаад нь олгож байгаа. Манай яамнаас “Үйлдвэр, хөдөө аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлого” боловсруулаад, чиглэлийн яамдаас санал аваад явж байгаа. Үүн дээр арьс шир, ноос угаах үйлдвэрийн бодлого нь тусдаа “Цэвэр үйлдвэр” гэдгээрээ туссан байгаа.

**Мэргэжлийн хяналтын газар:** Манай Мэргэжлийн хяналтын газраас арьс шир, ноос ноолуурын үйлдвэрийн “Харгиа” цэвэрлэх байгууламжийн болон төв цэвэрлэх байгууламжид цэвэршүүлсэн усанд шинжилгээтэй хяналт шалгалтыг хагас жилд нэг удаа хийж байгаа. “Харгиа”-д бохирдлын үзүүлэлтүүд нь шаардлага хангахгүй байгаа. Төв цэвэрлэх байгууламжид бохирдлын үзүүлэлтүүд нь мөн л шаардлага хангахгүй байдлаар Туул голд нийлүүлж байгаа. Туул голын 8 цэгээс шинжилгээ авч шинжилдэг. Үүнийг цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлсэн бохир усыг нийлүүлдэг Сонгины гүүрээс эхлээд, Туул гол их бохирдолтой байдаг нь илэрсэн. Хамгийн цаад цэг бол Туул овоотын гүүр байдаг, энэ гүүрэн дээр голын өөрөө цэвэршилт ажиглагддаггүй. Энэ хэсэгт Туул гол маань их бохирдолтой гэсэн үзүүлэлтэй хэвээрээ байгаа. Жил болгон хяналт шалгалт хийдэг, хяналт шалгалтын дүнгээ холбогдох газрууд, яам, Энэ жилийн хувьд ерөнхий сайдад мэдээлсэн. Иймэрхүү байдлаар бид хяналт тавьж ажиллаж байна... хяналт шалгалтын дүнгээ мөн Нийслэлийн Засаг даргад тавьдаг. Дээрээс нь БОНХЯам, Эрүүл мэндийн яаманд хяналт шалгалтынхаа дүнг болон цаашдаа авах арга хэмжээний саналаа тавьдаг. Хэрэгжилт үнэхээр хангалтгүй байдаг. Жил ирэх тусам Туул голын бохирдол ихсэх хэмжээнд байгаа. Цэвэрлэх байгууламжийн цэвэршилтийн зэрэг ерөөсөө ахидаггүй. Ерөнхийдөө бохирдолын 3-4 үзүүлэлтээрээ дандаа их бохирдолтой гэсэн ангилал руу ордог. Энэ бохирдол нь дандаа Сонгины гүүрээс эхэлдэг. Энэ жил ундны усны чанар, аюулгүй байдалд хийсэн хяналт шалгалтын дүнг ерөнхий сайдад танилцуулсан. Яагаад Туул голын асуудал энд хүрч яригдсан бэ гэвэл, Ундны усны эх үүсвэрийн /гүний худаг/ 174 худаг Туул гол дагуу байрласан байдаг. Тийм учраас манайх Туул голыг хяналтандаа авч явдаг. Туул гол нь гүний усыг бохирдуулах боломжтой учраас энэ асуудлыг хөндөж ярьж, Ерөнхий сайдад танилцуулсан байгаа. Эндээс Засгийн газрын хэрэг эрхлэх газраас зөвлөмжүүдийг гаргаж бүх нийслэл, аймгуудын засаг дарга нарт хүргүүлсэн байгаа.

Гол бохирдуулагч байгууламж нь /эх үүсвэр/ төв цэвэрлэх байгууламж. Тийм учраас төв цэвэрлэх байгууламжийн технологийг бүрэн шинэчлэх асуудал хэрэгтэй байна. Төв цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгээний үр дүнд нөлөөлж байгаа “Харгиа”-гийн асуудлыг шинэчлэх шаардлагатай байна.

**Нийслэлийн засаг даргын эколог, Ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч дарга Т.Бат-Эрдэнэ:** Арьс ширний үйлдвэрийг нүүлгэх талаар мэдээлэл өгье. Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу Эмээлт орчимд хөнгөн үйлдвэрийн парк байгууллахаар тусгагдсан байгаа. Яг энэ газар нутагт нийслэлийн засаг даргын 2010 онд 411 тоот захирамжаар Хан-Уул дүүргийн 13-р хороонд 56 га газрыг үйлдвэр технологийн парк байгуулж, арьс шир буюу малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн парк байгуулья гэсэн шийдвэрийг гаргасан байдаг юм. Энэ ажилд тодорхой хэмжээний зардал гаргаад, хөрөнгө оруулалт хийгээд явж байтал Засгийн газраас тодорхой байршил солих асуудал ирсэн. Энэ тохиолдолд ч үүнийг Улаанбаатар хотын захиргаа зүгээр хаяагүй. Төлөвлөгөөнийхөө дагуу үйл ажиллагаагаа явуулж байсан. 2012 онд 56 га газрыг 214 га газар болгож тээлээд, тэнд үйлдвэр технологийн парк болон мөн дээр нь нэмээд малын гаралтай түүхий эдийг боловсруулах хөнгөн үйлдвэрийн паркийг байгуулж болно гэж төлөвлөгөөндөө оруулаад, тодорхой хэмжээгээр зардал гаргаад явж байгаа. Өнөөдрийн байдлаар Европын сэргээн босголтын банкттай хамтарч ажиллахаар гэрээ зурагдаад, энэ онд багтааж техник, эдийн засгийн үндэслэлийг нь дуусгана. Хавар барилгын ажил эхлэх үед нь сонгон шалгууралт явуулаад хамгийн түрүүнд өдөрт 20 мянган метр куб бохир технологийн ус цэвэрлэх чадалтай орчин үеийн дэвшилтэт технологийг агуулсан үйлдвэрийг барьж байгуулах юм. УИХ-ын 2012 оны 72 дугаар тогтоолын дагуу 2017 оны 12 сарын 31-ний дотор “Нүүлгэн шилжүүлэх ёстой” гэсэн энэ даалгаврын хүрээнд нийслэлийн засаг даргын хувьд алхам алхамаар хугацаандаа багтаахаар явж байгаа. Тооцоолсноор, дараа жилийн 6 сард барилгын ажил эхлүүлэхэд 18 сар үргэлжлэх ёстой.

Урт нэртэй хуулиа хэрэгжүүлэхгүй байна, Барилгын хог хаягдал их хаяж байна гэсэн гомдол маш их ирдэг. Ямар түвшинд явж байна вэ гэхээр үүнийг зохицуулахын тулд өнгөрсөн долоо хоногт Нарангийн энгэрт Солонгосын 100% -ийн хөрөнгө оруулалттай Барилгын материалын хог хаягдлыг боловсруулах үйлдвэр байгуулах шав тавьж байна. Хэрэв энэ үйлдвэр ашиглалтанд орвол барилгын хог хаягдлыг худалдаж авах менежмент бүрдэх учраас энэ асуудал зогсох байх. Хуулийг биелүүлж байгаа гэж ойлгож байна.

**Ус сувгийн удирдах газрын дарга Үнэн:** Төв цэвэрлэх байгууламжийн хувьд буруу ойлголт яваад байна. Төв цэвэрлэх байгууламж маань өөрөө бохирдуулагч үйлдвэр биш. Цэвэрлэж байгаа цэвэрлэх байгууламж юм. Ус сувгийн удирдах газрын харьяанд байдаг үйлдвэрийн газар. Бохирдлыг хүлээж аваад, энэ үйлдвэрийн өөрийнх нь технологийн хүчин чадалын хүрээнд цэвэрлэж, гаргасан усаа байгальд нийлүүлж байгаа үйлдвэрийн газар юм. “Харгиа” үйлдвэр нь манай Төв цэвэрлэх байгууламжийн албаны нэг нэгж. Уг нь нийслэлийн өмчтэй үйлдвэрийн нэгж байж байгаад өнгөрсөн онд ус сувгийн удирдах албаны нэг нэгж болсон. Туул голын бохирдлын асуудал цэвэрлэгээний хүчин чадал шаардлагатай хэмжээнд хүрэхгүй байна, шаардлагатай хэмжээндээ хүрэхгүй байна. Гол авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барьж байгуулъя гэсэн шийдвэр гаргасан явж байгаа. “Харгиа” байгууламжийг авснаас хойш тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт, шинэчлэлүүдийг хийсэн байна. 13.000 шоо метр бохир усыг хүлээж аваад, тодорхой хэмжээнд цэвэрлэж гаргасан. 1998 онд 3 яамны сайдын тогтоож өгсөн нормативийн хэмжээнд цэвэрлээд, Төв цэвэрлэх байгууламжид нийлүүлнэ

гэсэн ийм шаардлагын дагуу баригдсан үйлдвэр байдаг. Өнөөдрийн байдлаар үйлдвэрийг ажиллуулж байна. Бидний үзэж байгаагаар 6-8 мянган шоометр бохир усыг л авч цэвэрлэх бололцоотой. Нэгдүгээрт

**Хоёрдугаарт.** Технологийн хувьд маш хүнд байдалтай ийм үйлдвэр байна. Арьс ширний үйлдвэрүүдийн энэ “Харгиа” цэвэрлэх байгууламжид нийлүүлж буй усны стандарт хэмжээ огт мөрдөгддөггүй. Маш өндөр хэмжээний бохирдолтой байдаг. Бид энэ дээр энэ үйлдвэрийг Ус сувгийн удирдах газарт нэгтгэж хүлээж авснаас хойш, бизнесийн орчныг нь өөрчилье, тэгэхгүйгээр энэ асуудал явахгүй нь, нэг үгээр хэлбэл “Харгиа” цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгээний зардлыг арьс ширний үйлдвэрүүд өөрсдөө нөхөж гаргах, тэгснээрээ өөрсдийнхөө арьс боловсруулах үйл ажиллагаанд хэрэглэж байгаа химийн хорт бодисууд болон бусад нөлөөллийг өөрсдөө багасгах, тэдний оролцоог нь нэмэгдүүлэх зорилготой. Үүгээрээ С.Дэмбэрэл гишүүний асууж байгаа гол утга санааг нь гаргаж хэлмээр байна.

“Харгиа” цэвэрлэх байгууламжаас Төв цэвэрлэх байгууламжид нийлүүлж байгаа усны маань шаардлагууд дүрэм, нормдоо хүрэхгүй байгаагаас төв цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгээний түвшин нь унаад байдаг юм. Яагаад гэвэл, нэг нь химийн цэвэрлэгээ хийдэг, нөгөө нь биологийн болон механик цэвэрлэгээ хийдэг байгууламжууд. Хоорондоо ийм зөрчил, ялгаатай талаар С.Оюун сайд түрүүн хэлсэн. Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барьж байгуулах концессийн асуудал дээо яг концессээр хийх гэдэг асуудалд гадны нэг л санал хүлээж авсан байгаа. Төв цэвэрлэх байгууламжийг ямар нэгэн аргаар сайжруулъя тэр тусмаа хөнгөлттэй зээлээр сайжруулъя гэдэг дээр бид нэлээд олон гадны саналыг авсан байгаа. Хот болон Ус сувгийн удирдах газрын хувьд Төв цэвэрлэх байгууламжийг концессийн аргаар шийдэх нь тийм ч оновчтой биш гэж үздэг. Үүнийг шулуухан хэлэхэд бид шийдвэрийг гаргадаг хэмжээнд ажилдаг ийм хүмүүс биш.

**С.Оюун:** С.Дэмбэрэл даргаа концессийн жагсаалтанд орж зарлагдаагүй учраас сонирхож байгаа байгууллагуудыг шууд хэлэхэд хэцүү ч гэсэн Францын болон Солонгосын компани урьдчилсан байдлаар сонирхсон байдаг. Хотын байр суурь бол, ямар ч байсан ажлын зураг, техник эдийн засгийн үндэслэлээ дуусгачихъя, тэрний дараа хувийн хэвшлийн концессийн замаар явах уу, хөнгөлттэй зээлээр явах уу гэдгээ ирэх хавар шийдье. Тэр болтол ажлын зургаа дуусгачихъя гэсэн байдлаар явж байгаа юм байна билээ.

**Г.Баярсайхан:** Үг хэлэх гишүүд. За С.Дэмбэрэл гишүүн.

**С.Дэмбэрэл:** Түрүүний асуултандаа хариу аваагүй. Энд бичсэнээр Туул голын асуудал “Онц их бохирдсон” гэсэн түвшинд байгаа цагт өнөөдрийн хуралдаанаас шийдвэртэй юм гаргах ёстой. Миний гол санал бол ажлын хэсэг байгуулах гэхээсээ илүү Байнгын хорооны тогтоол гаргамаар байна. Үүнийг төлөвлөхийн тулд Ажлын хэсэг байгуулаад Байнгын хорооны тогтоолын төсөл боловсруулмаар байна. Энэ бол эхний санал.

**Хоёрдугаар санал:** Агаарын бохирдлын индекс гэдэг шиг Туул голын усны чанарын индекс гэдгийг одоо нэг сарын дотор боловсруулаад, /яагаад гэвэл, мэдээлэллийн эх үүсвэрүүд иргэд, олон нийтэд үнэнийг үе үе мэдээлж байдаг тул/ тодорхой интервалтайгаар ийм зүйлийг хамгийн түрүүнд гаргаж байх ёстой. Энэ бол маш чухал.

Оруулж ирсэн танилцуулга материалд чинь /Үнэн-гийн хэлсэнээр/ “Хамгийн гол бохирдлын шалтгаан нь цэвэрлэх байгууламж болсон” гэсэн

зүйл байсан учраас, эхнээсээ нэгдүгээрт гээд миний андуурдаг чинь тэр. Хамгийн гол шалтгаан нь Төв цэвэрлэх байгууламжаас дутуу цэвэрлэгдэн Туул голд хоног тутам 170-190 мянган шоометр бохир ус! Тэр шоометр бохир усыг хэн, хэн гаргаж байгаа юм бэ гэдэг дээр ангилал чинь өөрөө дутуу байна. Үндсэн шалтгаан нь буюу нөхөн сэргээлт хийхгүй орхиж байгаа, элс хайрга олборлож байгаа, энэ бүхнийг эрэмблээр гаргаж ирээд Байнгын хорооны шийдвэр гарахад дөхөмтэй болгож өг.

*Гуравдугаар санал:* Төв цэвэрлэх байгууламжийн асуудлыг зэрэглэлээр нь авч үзэх юм бол урт хугацааны ч биш, дунд хугацааны ч биш, богино хугацааны ч биш **энэ бол яаралтай гэсэн зэрэглэлд орох асуудал** байна. Өөрөөр хэлбэл, энд хандах хандлагаа илүү эрчимжүүлье гэсэн ийм зүйлийг төв цэвэрлэх байгууламж, холбогдох яам энэ асуудлын зэрэглэлийг нэмэгдүүлэх тал дээр УИХ-аас дэмжлэг аваач гэсэн санал байна.

*Дөрөвдүгээр санаа:* Бидний хамгийн их орхигдуулаад байгаа асуудал бол бохирдуулагчийн төлөх зарчим. Хууль эрхийн актанд байсаар байтал /түрүүн Үнэнгийн үгэнд гарлаа./ “бохирдуулагч нь төлөх зарчмаа бүрэн хэмжээгээр хэрэгжүүлэх саналаа бэлтгэх хэрэгтэй” гэж байна. Яаж бэлтгэх юм? Бохирдуулагч нар нь тодорхой байж байна. Энэ бохирдуулагч ийм юм бохирдуулж байгаа, энэ бохирдуулагчаас ийм механизмаар дамжуулж ингэж байгаа гэдгээ хэл. Яамнаасаа эхнээсээ төрөл бүрийн хөшүүрэг хэрэглээд байна. Туул голын асуудал дээр өөр ямиар хөшүүрэг байна вэ? Өөрөөр хэлбэл, бид хувийн хэвшилтэй ажиллахдаа зөвхөн торгохоосоо илүү дэмжих, бас хажуугаар нь хариуцлага гэсэн хоёр зүйлийг хослуулсан байх ёстой. Координаци илт дутагдаж байна. Улаанбаатарын хотын хувьд ч тэр. Үйлдвэр Хөдөө Аж Ахуйн Яамыг онцгой хэлмээр байна. Танай оролцоо их муу байна. Туул голын бохирдлын асуудал дээр, цэвэр үйлдвэрлэлийн тал дээр ажил чинь их удаан явж байна. Хамгийн гол нь хувийн хэвшилтэйгээ энэ чиглэлээр сайтан ажиллах хэрэгтэй байна. Өнөөдрийн хэлэлцсэн асуудлуудаар Байнгын хорооны тогтоол гаргая. Байнгын хорооны тогтоолын нэр нь “Туул голын талаар яаралтай, богино болон дунд хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” гэсэн тогтоолын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулмаар байна. Ажлын хэсэгт би өөрөө ороод, эсвэл ахлаад ажиллая. За баярлалаа.



**ХОЁР. Эзний ёсоор хандах ухаан – Ногоон хөгжлийн тухай “Жаргалын түлхүүр, хөгжлийн тулгуур”. Байгалийн болон үндэсний нөөц баялаг, брэнд, бүтээгдхүүнээ зүй зохистой ашиглах тухай**

**2013 оныг “Ногоон Хөгжлийн бодлогыг дэмжих жил” болголоо**

*“Монголын мэдээ” сонин УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлээс авсан ярилцлага: 2013 оны 03 дугаар сарын 25-нд*

**ММ:** - Хаврын чуулган тун удахгүй хуралдах гэж байна. Намрын чуулган завсарлах түр хугацаанд хаагуур юу хийж, ямар ажил амжуулж байна вэ?

**С.Дэмбэрэл:** - Чуулганы завсарлагаар нэлээн олон зүйл амжуулж л явна. Ямар ч гэсэн бизнес эрхлэгчидтэй уулзах, тэдний саналыг авахын зэрэгцээ одоо хэлэлцүүлэхэд бэлэн байгаа 15 хуулийн нэмэлт өөрчлөлтийг бэлдэж дуусч байна. Сууц Өмчлөгчдийн Холбооны тухай иргэдийн дунд судалгаа хийж, бусад улсын сайн туршлагауудыг судласаны үр дүнд өөрийн боловсруулсан шимнэ хувилбарыг удахгүй өргөн барихаар бэлдээд байна. Мөн Монголын ард түмэнд маш их хэрэгцээтэй байдаг мөртлөө хууль зүйн ямар ч зохицуулалтгүй нэг асуудал болсон ломбардын тухай бодож, боловсруулж байгаа зүйл ч бас бий. Энэ чиглэлээр бусад орны туршлагыг мэдэх зорилгоор УИХ-ын Тамгийн газрын судалгааны албанд зохих хариу мэдээлэл авлаа. Их аятайхан судалгаа хийж хүссэн мэдээлэлийг минь бүрдүүлж өгсөнд энэ хамт олонд талархал илэрхийлмээр байна. Ломбардын тухайд хуулинд маш ерөнхий заалт л байна. Гэтэл иргэний эрх ашгийг хамгаалах, барьцаалан зээлдүүлэгч ба зээлдэгчийн эрх үүргийг тусгайлан заасан, энэ салбарын бизнесийг зохицуулсан стандартыг мөрдүүлэх чиглэлээр огт ажил хийгдээгүй юм байна. Тиймээс энэ харилцааг зохицуулсан хууль санаачлах зорилгоор ажиллаж байна. Мөдхөн дуусах байх. УИХ завсарласан ч Байнгын хороод нь ажилласаар байдаг болохоор өөрийн харьяалагддаг 3 байнгын хороодын чиглэлээр хэд хэдэн тогтоолын төсөл боловсруулж батлууллаа. Жишээлбэл, Байгаль орчин, Хүнс, Хөдөө аж ахуйн байнгын хорооноос 2013 оныг “Ногоон Хөгжлийн бодлогыг дэмжих жил” болгон зарлаж, хийх ажлын тусгай төлөвлөгөө баталсан. Уг төлөвлөгөөг миний бие санаачилан боловсруулсан бөгөөд байнгын хорооны гишүүд, УИХ дахь Ногоон бүлгийн гишүүд маань дэмжсэн. Энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ногоон хөгжлийг хэмжих асуудал бас маш чухлаар тавигдаж эхэлсэн тул саяхан байнгын хорооны бас нэг тогтоолын төсөл санаачилж, ажил болгох гэж байна.



**Төрийн институциудын бүтэц маш тогтвортой,  
хэнд ч ойлгогдохуйц зохистой хэмжээнд  
тогтоогдсон байх ёстой**

*УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар сарын 07-ны хуралдааны тэмдэглэлээс: Нэг. Монгол Улсын хууль тогтоомжийг 2016 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Улсын Их Хурал, Засгийн газрын байгууллагуудын бүтэц, менежментийг сайжруулах тухай С.Дэмбэрэл гишүүний боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулах тухай*

**Ч.Сайханбилэг:** Энэ ямар учиртай юм бэ, С.Дэмбэрэл гишүүн ээ.

**С.Дэмбэрэл:** 97 оноос хойш гүйцэтгэх засаглалд нутагшуулсан байгаа яам, агентлаг гэсэн ийм нэг харьцаа байна. Түүнтэй холбогдсон бүтцүүд, тэгээд тохируулах, хэрэгжүүлэх агентлагууд байна. Сүүлийн үед төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэг бас нэг сонин юм бий болоод байна. Төрийн бүтцэд маань энэ хэвшээд, тогтоод явж байсан, тэгэхээр эндээс шийдвэр гаргах ёстой. Цаашаа энэ тогтоц явах юм уу, үгүй юм уу? Засаг болгон дээр л өөрчлөгдөж байх ёстой юм уу? Тэгээд энэ чинь юуг харуулаад байна вэ гэхээр, хэрэв үүнийгээ цаашаа авч явна гэвэл энэ нь өөрөө хуульчлагдаад, тэгээд эрх барьж байгаа намуудын бие бие рүүгээ дайрдаг ч гэх юм уу, тийм технологи, үзүүлэлт болж болохгүй. Танайх олон болголоо, манайх цөөн болголоо гэсэн ийм үзүүлэлт болгож болохгүй. Төрийн энэ институциудын бүтэц бол маш тогтвортой, хэн ч ойлгогдсон зохистой хэмжээнд тогтоогдсон байх ёстой. Яагаад гэвэл энэ улсын чинь эдийн засаг өснө, тэгэхдээ энэ маань агентлагуудыг нэмээд бай гэсэн үг биш, бас хасаад бай ч гэсэн үг биш, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ зохицуулах, хэрэгжүүлэх агентлагуудыг бас одоо сүүлийн үеийн хандлага, тэр шууд ардчилал гэж яриад байгаа, төр - хувийн хэвшлийн, төр - иргэний нийгмийн хоорондын диалог болон түншлэлийн асуудал энэ бүхэн маань хуулиудад, энэ чиглэлийн юмнуудад бас сайн тусгагдаагүй, уялдаагүй байгаа. Тийм учраас би түрүүн жишээ хэлж байсан. Сумын төсвөө чи мэднэ гээд иргэдийг хэлж байна. Гэтэл сумын төсвийг яаж захиран зарцуулах талын төрийн бүтэц нь байж л байна. Энэ хоёрын хоорондын харьцааг жишээлбэл цаашдаа яах юм бэ? Төлөөллийн болон шууд ардчиллын зохистой харьцаа цаашдаа энэ төрийн институциуд дээр яаж тусах юм бэ гэсэн иймэрхүү засаглалынхаа бүтцийг эргэж хараад, бодоод, ярилцаад тодорхой шийдвэр гаргах ёстой байх гэсэн утгаар хэлж байгаа юм.

**Ч.Сайханбилэг:** С.Дэмбэрэл гишүүний тайлбарыг сонслоо. Ерөнхий санаа, концепцийг хүлээн зөвшөөрч байна. Ингэж хийж болно. Би гэхдээ ерөнхий явах гэж байгаа процедур нь зөв үү, үгүй юу гэдэг дээр л жаахан эргэлзэж байна. Яагаад гэхээр шууд хууль тогтоох засаглал маань өөрөө санаачлагаараа ингээд гүйцэтгэх засаглалынхаа юмыг аваад, ийм байх ёстой гээд ингээд шууд тогтоогоод өгөх нь дахиад нөгөө засаглал хуваах онолоороо, элдэв юмаараа хэр харагдах вэ? Тийм учраас Их Хуралтай холбоотой, шууд ардчилалтай холбоотой энэ юмнуудаа Их Хурал өөрөө хийгээд, С.Дэмбэрэл гишүүн тодорхой саналууд байвал өгөөд, энэ саналаа

гүйцэтгэх засаглалын хувьд ийм байх нь зүйтэй байна гэдгээ Засгийн газар уг нь өөрөө өргөн баривал зөв явах байх. Шууд эндээс тогтоогоод өгөхөөр чинь засаг хоорондын бэрхшээл гарах болов уу.

**С.Дэмбэрэл:** Ерөнхийдөө энэ Их Хурлын энэ хороог бол Монгол Улсын төрийн аль ч түвшний институциудын асуудлыг оруулах эрхтэй гэж би ойлгоод энэ асуудлыг оруулж байгаа юм, нэг талаас.

Нөгөө талаас, ер нь засаглалынхаа хэлбэрийг тест хийсэн хэлбэрээр, үе үе ингэж эргэж харж, энэ юу нь болж байна, юу нь болохгүй байна гэдгийг төрийн байгуулалтын талаас нь харж байх ёстой гэж, хоёрдугаар аргумент.

Гуравдугаарх нь, яг өнөөдрийн системийг хараад байхаар асар их хэцүү тэгээд нэг их олон шат дамжлагатай, хамгийн гол нь маш их цаг хугацаа авдаг ийм засаглал байгаад байна. Энэ тухайн тэнд ажилладаг хүнээсээ гэхээсээ илүү хууль эрх зүйн хувьд баталгаажуулсан энэ хуулиудаас хамааралтай гэж үзээд байгаа юм. Ганц жишээ хэлэхэд, Засгийн газрын худалдан авалт 50-700 хоногоор хоцорч байна, хуульд заасан хэмжээнээс. Энэ чинь ар дахь ажлыг алж өгч байна шүү дээ.

Дараа нь Улсын төрийн намын санхүүжилтийн тухай хууль. 2013 онд шийднэ Улсын Их Хурлын даргын захирамжаар Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа. Намын тухай хууль нь энэ жагсаалтад орчихсон байна. Энэ нь хоцорсон байгаа учир үүнийг бас оруулах нь зүйтэй байх гэж бодож байна.

*Хоёр. Байгууллагын цйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх тухай Байнгын хорооны тогтоолын төсөл хэлэлцэх цээр:*

**А.Бакей:** Байнгын хорооны тогтоолын төслийг С.Дэмбэрэл гишүүн санаачилсан байгаа. Тогтоолын төслийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл танилцуулна. С.Дэмбэрэл гишүүнийг урьж байна.

**С.Дэмбэрэл:** Баярлалаа. Энэ Системчилсэн үнэлгээ хийх тухай гээд их энгийн мөртлөө их чухал ач холбогдолтой тогтоолын талаар та бүхэнд танилцуулгыг тараасан байнаа. Би энгийн хар үгээр хэлье. Монгол Улс гадаадын зээл тусламж аваад маш олон төрлийн мэргэжилтнийг урьж ирүүлээд, янз янзын гоё номнууд, аргачлал, зөвлөмж боловсруулдаг. Ихэнх нь ерөнхийдөө орхигдоод явдаг. Нөгөө талаас Улсын Их Хуралд ажлаа шууд тайлагнадаг байгууллагуудын ирүүлж байгаа тайлан, мэдээллийг үзээд байхад Улсын Их Хурлын үйл ажиллагааны шаардлагад таарахгүй дутуу боловсруулсан, эсхүл ерөнхийд нь мэдээлэл өгөх гэж байгааг нь мэдээлэл өгөхийн тулд өгч байгаа маягаар тэгж ханддаг хандлага шинэ гишүүний хувьд ирээд хэдэн сар байхад ажиглагдаад байна. Өөрөөр хэлбэл бид шийдвэр гаргах гэж бидэнд өгч байгаа мэдээлэл нь их сул бөгөөд системтэй биш юм. Тэгэхээр бэлэн ийм аргачлал байдаг юм байна. Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг туслаад, тэгээд Хууль зүйн яамнаас боловсруулсан ийм сайхан аргачлал байдаг юм байна. Тэгэхээр энэ аргачлалыг Их Хуралд шууд ажлаа тайлагнадаг 5-6 байгууллага байдаг шүү дээ. Тэр байгууллагуудын хүрээнд хэрэгжүүлэх ийм тогтоолын агуулгатай. Ингэснээр ямар ач холбогдолтой юм бэ гэхээр, бидэнд ирүүлдэг тэр мэдээ материалууд нь, репорт нь сайжирна, чанар нь сайжирна. Бид илүү чанартай бүтээгдэхүүн уншдаг болоод эндээсээ үндэслээд бид илүү сайн шийдвэр гаргах ийм боломж бүрдүүлнэ. Нөгөө талаас энэ байгууллагууд өөрснөө институцийнхаа хувьд бэхжиж эхэлнэ. Өөрийгөө системтэйгээр үнэлдэг, өөрсдөө үнэлдэг, хөндлөнгөөс үнэлүүлдэг, эсхүл хосолж, хольж үнэлүүлдэг гэсэн ийм аргачлал нь бэлэн. Бэлэн сайхан аргачлалыг Байнгын

хорооныхоо энэ ажилд хэрэглээд явчихбал яасан юм бэ гэсэн. Тийм учраас шинэ гишүүний анхны санаачилж байгаа зүйл учраас та бүхэн минь шууд баталчихыг хичээнгүйлэн хүсье.

**А.Бакей:** С.Дэмбэрэл гишүүнд баярлалаа. Ингээд тогтоолын төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд байна уу? Батзандан гишүүн, Сүхбаатарын Батболд гишүүнээр тасалсан шүү.

**Ж.Батзандан:** Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх тухай Байнгын хорооны тогтоолын төслийг С.Дэмбэрэл гишүүн оруулж ирж байгаад талархалтай хандаж байна. Үнэхээр Улсын Их Хуралд харъяалагддаг байгууллагуудын ажилд үнэлэлт, дүгнэлт өгөх, хариуцлага тооцох систем өнөөдрийг хүртэл хангалтгүй байсан. Тийм учраас ийм системтэй болох юмсан гэж бид их бодож байсан. Харин өнөөдөр тогтоолын төсөл хэлбэрээр орж ирж байгаад баяртай байна. Гэхдээ энэ тогтоолын төсөлд нэг зүйлийг орхигдуулсан байж магадгүй гэдэг үүднээс асуух гэсэн юм. Бид Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг мэдээж дээд шатны байгууллагууд нь үнэлнэ, дүгнэнэ. Гэхдээ төрийн байгууллагыг үнэлэхдээ төрийн байгууллагаас үйлчилгээ авч байгаа этгээдүүдээр үнэлүүлдэг систем рүү орно. Иргэдээр үнэлүүлдэг системийг ашиглана гэж манай Ардчилсан намынхан мөрийн хөтөлбөртөө тусгасан. Энд таны оруулж ирж байгаа юман дээр иргэдээс асууж, Аудитын байгууллага байгаа, Санхүүгийн зохицуулах хороо байгаа, Хүний эрхийн комисс байгаа. Тэгэхээр Хүний эрхийн комиссоор олон иргэд үйлчлүүлж байгаа. Аудитын байгууллагаар бас олон байгууллага, хувь хүмүүсүүд үйлчлүүлж байгаа гэх мэт ийм олон иргэд үйлчилгээ авч байгаа бас. Иргэдээс нь асуудаг тэр системийг асуулга авах зохицуулалтыг оруулж өгсөн үү гэж асууя.

**С.Дэмбэрэл:** Энэ маш чухал асуулт асуулаа. Яг наадах чинь шууд энд ороогүй, гэхдээ аргачлал дотор нь байж байгаа. Тухайн байгууллага эхлээд энэ аргачлалын үндсэн дээр өөрийгөө үнэлнэ, дотоод хяналтын хэлтэс, өөрсдийнхөө дотоод бүтцээр өөрсдийгөө үнэлнэ. Энэ үнэлэхдээ арай илүү систем талаас нь үнэлэх нэгдүгээрт.

Хоёрдугаарх нь, гадны байгууллагаа, хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлнэ гэсэн тийм юм байгаа.

Гуравдугаарх хувилбар нь, энэ хоёрын хослолоор, холимог хувилбараар гэсэн ийм 3 хэлбэр орсон байгаа. Ж.Батзандан гишүүний саяны асуудаг үнэхээр зөв. Одоо жишээлбэл, үүнийг хангахын тулд манай тамгын газарт энд нь хяналт тавьж ажиллах гэж, жишээ нь энэ байгууллага Аудитын газар өөртөө үнэлгээ хийсэн байна уу? экспертизийн үнэлгээг холимог байдлаар хийж ирүүлсэн байна уу? гэдгийгээ тухайн тухайн байгууллага нь өөрсдөө хэлэлцээд шийддэг байх. Ямар ч гэсэн энэ хөндлөнгийн үнэлгээ хийх нь дотроо суучихсан байгаа.

**Сү.Батболд:** С.Дэмбэрэл гишүүн ээ, зөвхөн Их Хурлын харъяа байгууллагуудад нэгдүгээрт хамааралтай юу? Хоёрдугаарт, энэ маань Засгийн газар, Засгийн газрын харъяа байгууллагууд, түүний үнэлгээ хийж байгаа энэ зарчимтай гэдэг юм уу, стандарттай ижил төстэй юу, эсхүл өөр байна уу? Гурав дахь нь, сая би асуух гэж байсан зүйл л дээ. Хөндлөнгийн үнэлгээг та хариулчихлаа. Дүгнэлтийг нь яаж байх юм бэ? өөрсдөө үнэлгээ хийгээд өгчихдөг, дараа нь үүнийг нь дүгнэдэг, хянадаг, үнэлдэг байгууллага нь Их Хурлын Тамгын газар юм уу? Хаана яаж зангидагдаж, үнэлэгдэж, сайн бол сайн, мөн саар бол саар нь яаж дүгнэгдэж, зөвлөмж нь гарч байх ёстой болох вэ?

**С.Дэмбэрэл:** Энэ бол шууд Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагуудын хувьд эхлээд зориулагдсан. Гэтэл үүний гаргасан хэрэглэдэг хэлбэр нь гүйцэтгэх засаглал ер нь аль аль түвшинд хэрэглэдэг юм билээ, Хууль зүйн яам өөрийнхөө системийн байгууллагуудад бас үүнийг хэрэгжүүлэх үүрэг өгсөн юм билээ. Энэ системчилсэн үнэлгээ хийх нь Засгийн газрын бүх шатны байгууллагуудад хэрэгтэй. Гэхдээ бид Засгийн газрын байгууллагуудад үүнийг хий гэхээсээ илүү хамгийн түрүүнд эхлээд Улсын Их Хуралд өөрийнхөө ажлыг тайлагнадаг энэ байгууллагууд дээрээ үүнийг нэвтрүүлэх нь зүйтэй гэсэн нэгдүгээр ийм юм байгаа.

Хоёрдугаарх нь, энэ их чухал асуудал. Энэ тогтоолыг бид гаргаж байгаа юм чинь уг нь бол энэ Байнгын хороо дүгнэх ёстой л доо. Нөгөө байгууллагууд чинь тайлангаа ирүүлнэ шүү дээ, үүний дагуу. Тэгээд тэгэхэд нь манай Байнгын хороон дээр энэ системчилсэн үнэлгээ хийх тухай Улсын Их Хурлын тогтоолын үүнийг яаж хийсэн юм бэ? танайх өөрснөө үнэлсэн юм уу? бусдаар үнэлүүлсэн юм уу? эсхүл хосолсон юм уу? тэгээд үүнээс чинь ямар үр дүн гарсан бэ гэдгийг бид нар өөрснөө хянах ёстой байх. Энд Тамгын газар Болдбаатар гээд Их Хурлын бидний ажлыг хариуцдаг, зохион байгуулладаг байгууллагынх нь хувьд эдний газарт оруулсан 3 дугаар заалт байж байгаа. Гэхдээ мэдээж хэрэг тогтоолоо угаасаа байнга хянаж байх ёстой шүү дээ. Тэр талаасаа хамгийн түрүүнд энэ Байнгын хороон дээр хянагдана.

**А.Бакей:** Нэмж хариулахад, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 47.1-д ийм заалт байна. Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага жилийн ажлынхаа тайланг дараа оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд гишүүдийн тоогоор ирүүлнэ гээд тэгээд харъяаллынхаа дагуу Байнгын хороод жилийн ажлын тайланг жил болгон хэлэлцдэг шүү дээ. Тэр үедээ энэ үнэлгээг давхар дүгнээд, хэлэлцээд явах ёстой. Тийм учраас холбогдох Байнгын хороодод хамааралтай тогтоол гэж ойлгох хэрэгтэй. Зөвхөн Төрийн байгуулалтын байнгын хороо биш.

**С.Дэмбэрэл:** Системчилсэн үнэлгээ гэдэг маань, 4 төрөлтэй. Нэг нь байгууллагын чиг үүргийн үнэлгээ, хуулиар тогтоосон. Хоёрдугаарх нь, үйл ажиллагааны процессын үнэлгээ, гуравт, хүний нөөцийн, дөрөвт, санхүү. Энэ байгууллагууд чинь тэртэй тэргүй санхүү гээд ингээд. Тэгэхдээ системчилсэн үнэлгээнийхээ үндсэн дээр л хийж ирүүлэх ёстой гэсэн тийм юм явж байгаа.

**А.Бакей:** Ингээд асуулт хариулт дууслаа. Санал хэлэх гишүүд байна уу? Батхүү, Батчимэг.

**Г.Батхүү:** Ерөнхийдөө үнэлгээний зарчмыг дэмжиж байгаа, тогтоол гарч болно. Тогтоол гараад хэрэгжих ёстой гэж ойлгож байна. Энэ бол өнөөдөр Улсын Их Хурлын буюу Улсын Их Хурлын Тамгын газрын гол хариуцаж, дүгнэж явуулах ёстой үйл ажиллагаа. Сая Улсын Их Хурлын Тамгын газрын бүтцэд яг энэ үнэлэлт, дүгнэлт хийдэг, аудитын чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг ийм алба, хэлтэс шинээр байгуулагдсан. Хяналт, үнэлгээний хэлтэс гэж шинээр байгуулагдсан. Тэгэхээр Хяналт, үнэлгээний хэлтэс мэдээж хэрэг энэ дүнг гаргаад, дүнгээ Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулдаг ийм хэлбэрээр хийж өгөх юм бол илүү хэрэгжих магадлал, ажил хэрэгч болох байх гэж бодож байна. Дэмбэрэл гишүүнд бас талархаж байна, энэ үнэхээр хүний ажлыг үнэлдэг, дүгнэлт өгдөг, бодитой ийм зүйл бий болжээ. Яагаад гэвэл Улсын Их Хурлын дэргэдэх байгууллага гээд бид нарт дархлагдсан хэдэн байгууллага байдаг

шүү дээ. Тэгээд тайлан бичээд ирүүлчихдэг, тэгээд л боллоо. Бүрэн эрхийн хугацаа нь дуусахаар даргын асуудал ярьдаг. Өнөөдөр Улсын Их Хурлын Тамгын газрын шинэ бүтцэд миний ойлгож байгаагаар, би зөвлөх байхдаа энэ дээр нэлээд анхаарч ажилласан. Энэ бол Улсын Их Хурал хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих хоёр гол үүргийг ижил тэнцүү гүйцэтгэх энэ чиглэлд нэлээн их анхаарсан байгаа. Бид нар хууль үйлдвэрлээд л гаргаад байдаг. Энэ хууль маань амьдралд яаж хэрэгжиж, нийгэмд ямар сайн үр дагавар өгч байна вэ? эсхүл ямар муу үр дагавар өгч байна вэ гэдэг дээр анхаардаггүй. Хуулийн хэрэгжилтэд хяналт их муу тавьдаг байсан. Хий тооны хойноос хөөцөлдсөн ийм чиглэлд ажиллаж байсан бол илүү өнөөдөр хэрэгжилт дээр нь хяналт тавьдаг үүргийг бид нар илүү авч үзэх ёстой. Яг энэ утгаар нь би цаг үеэ олсон ийм асуудал байна гэж бодож байна. Саналын хувьд миний түрүүний хэлдгээр схем нь байвал зүгээр байхаа.

**А.Бакей:** Энэ тогтоолын төслийг санаачлагч С.Дэмбэрэл гишүүн бид нар энэ тогтоолын төслийг боловсруулахдаа нэлээд зөвлөлдсөн. Тогтоолын төслийн хоёрдугаар заалтан дээр ийм байгаа. Энэ тогтоолын 1-д заасан байгууллагууд, жилийн ажлын тайлангаа ирүүлэхдээ системчилсэн үнэлгээ хийж ирүүлсэн эсэхэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Тамгын газарт даалгасугай гэж байгаа. Тэгээд тэр дотроо Батхүү гишүүний хэлсэн тэр хэлтэс ажиллах ёстой. Тэгээд бас дүгнэлтээ ирүүлж байх нь.

**М.Батчимэг:** Би бас мэдээж С.Дэмбэрэл гишүүний өргөн барьж байгаа тогтоолын төслийг дэмжиж байна. Энэ бол манайд засаглалыг сайжруулах гэдэг бол үнэхээр тулгамдсан асуудал байгаа. Тэгээд бид нар засаглалыг сайжруулах тухай яриад байх биш, ийм шалгарсан үнэхээр зөв арга технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх нь чухал гэж үзэж байгаа. Тийм учраас үүнийг дэмжиж байна. Саналын хувьд сая Г.Батхүү гишүүний гаргасан саналтай санал нэгтэй байгаа. Эхлээд Тамгын газар дээр энэ үнэлгээ хийх ёстой үүрэгтэй байгууллага учраас Тамгын газар дээр энэ үнэлгээнд тулгуурлаж дүгнэлт ирүүлээд, дүгнэлтийг нь бид нар Төрийн байгуулалтын байнгын хороон дээр авч хэлэлцэнэ. Түүнээс бүх Байнгын хороод гэхээр би бас хариуцлага сулрах, эргээд гишүүд сонсоод өнгөрчих нэг тийм хэрэгжилт, хяналт талаас нь суларчих магадлалтай юм болов уу гэж бодоод байна. Тийм учраас тогтоолын төсөл дээр шууд Тамгын газар дээр үнэлгээ хийгээд, Тамгын газар тэр үнэлгээ хийсэн тайлангаа танилцуулдаг маягаар явбал яасан юм бэ гэсэн ийм саналтай байна. Хоёрдугаарт, дэмжиж байгаатай холбоотой хэлэхэд, зөвхөн энэ Их Хурлын харъяа байгууллага биш, би бол манайх өөрсдөө Их Хурлын чадавхийг бэхжүүлэх ажил, Тамгын газрын чадавхи, Байнгын хороодын чадавхийг бэхжүүлэх ажил өөрөө их чухал. Түүнийг системтэй үнэлэх асуудал их чухал байгаа учраас би бас магадгүй Төрийн байгуулалтын байнгын хороо санаачлага гаргаад, ер нь Их Хурлын өөрийнх нь үйл ажиллагаанд ч гэсэн бас системчилсэн үнэлгээ хийх ийм системийг нэвтрүүлэх талаар бас цаашдаа ярилцах нь зүйтэй юм биш үү. Энэ бол дэмжиж байгаагийнхаа сацуугаар шинэ санаа гаргаж байгаа зүйл л дээ.

**А.Бакей:** Тогтоолын төслийн 2 дугаар заалтан дээр Г.Батхүү, М.Батчимэг гишүүдийн саналаар системчилсэн үнэлгээ хийж, ирүүлсэн эсэхэд хяналт тавьж, санал дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороод, эсхүл холбогдох Байнгын хороонд ирүүлж байхыг Улсын Их Хурлын Тамгын газарт даалгасугай гэж найруулгаар авъя.



**С.Дэмбэрэл:** Г.Батхүү, М.Батчимэг гишүүдийн санал их зөв. Гэхдээ ер нь бол одоо ингээд та бүхэн харж байгаа байх. Үлбэгэр байгаа шүү. Тайлагнамар аяддаг, бид нар уншмар аяддаг, тэгээд хэлэлцмээр аяддаг. Тэгээд нэг шийдвэр гаргамаар аяддаг иймэрхүү үлбэгэр байгаа. Сая Г.Батхүү гишүүний хэлснээр шинэ бүтэцтэй болж байгаа. Хяналт, мониторингийн хэлтэстэй болж байгаа юм байна. Энэ хяналт, мониторингийн бүтэц нь хийж өгч байгаа, өөрөөр хэлбэл та бүхнийг зангарагтай ажилла гэсэн үг. Энэ долоон байгууллага байгаа байх. Энэ 7 байгууллагатайгаа зангарагтай ажилла. Тэгээд энэ Төрийн байгуулалтын байнгын хороон дээр ирээд тухайн жилдээ нөгөөдүүл чинь жилдээ нэг удаа цаас шиддэгээ болино. Яг энэ системчилсэн үнэлгээгээ хийнэ, хажуугаар нь тайлангаа тавина гэсэн ийм л юм гэж би ойлгоод байгаа шүү дээ.

**А.Бакей:** Саяны найруулгаар тогтоолын төслийг авъя. Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх тухай Байнгын хорооны тогтоолын төслийг батлах саналтай гишүүд гараа өргөнө үү. 13-аас 11. Дэмжигдлээ. Манай Байнгын хорооны шинэ гишүүн С.Дэмбэрэл анхныхаа тогтоолыг амжилттай хэлэлцүүлж батлууллаа. Тийм учраас урам хайрлаж, С.Дэмбэрэл гишүүндээ баяр хүргэе.

## С.Дэмбэрэл гишүүний үнэтэй саналууд

*Монгол Улсын Их Хурлын 2013 оны хаврын ээлжит чуулганы Эдийн засгийн байнгын хорооны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс: Улсын төсвийн болон Хөгжлийн банкны санхүүжилтээр 2013 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлын явц, байдлын талаар Зам, тээврийн сайд А.Гансүхийн мэдээлэл хийх цээр*

**Б.Гарамгайбаатар:** - С.Дэмбэрэл гишүүн асууя.

**С.Дэмбэрэл:** - За миний бие хэдэн асуулт асууя. Нэгдүгээрт, энэ жижигхэн төрийн байгууллага 02 дугаар сарын 28-нд 150 сая төгрөгийн тендер зарлажээ. Тэгээд 3 дугаар сарын 28-нд тэр тендер нь нээгдэж, 04 дүгээр сарын 28-нд гурван компани орсон байгаа юм. Ингээд тэр нь шалгарах юм шиг байгаа юм. Энэ хооронд гурван сар явчихаж байна л даа. Тэгэхээр А.Гансүх сайдаас ямар асуулт асуух гэж байна гэхээр, танай салбарт Тендерийн хуулийн хэрэгжилт, хугацааны хувьд тендерийг зарлахаас авахуулаад эцсийн шалгаруулалт хүртэл бодит байдал дээр дунджаар хичнээн хугацаа авч байна вэ гэсэн *нэгдүгээрт асуулт*.

Үүнтэй холбогдуулаад бас тэр тендертэй холбогдуулсан нэг зүйл байна. Би бордюр гэж юу байдгийг нарийн сайн мэдэхгүй л дээ. Явган хүний тэр хашлагыг аваад хаячих юм, тэр нь яагаа ч үгүй зүгээр зүйл байх юм. Тэгээд шинийг хийх юм, хуучныг нь тухайлбал, надад өгчихөж болох уу? гэсэн *хоёрдугаар асуулт*.

*Гуравдугаарт нь*, метроны асуудал, танай яамны Улаанбаатар хотод метро барих талаар албан ёсны байр суурийг тов тодорхой, эдийн засгийн үр ашиг, нийгмийн үр ашиг талаас нь харьцуулаад хэлж өгнө үү?

*Дөрөвдүгээрт*, PPP буюу төр хувийн хэвшлийн түншлэл танай салбарт одоогоор хэдэн хувийг эзэлж байна вэ? Цаашид энэ ирэх 4 жилд хэдэн хувийг эзлүүлэх бодол байна вэ?



*Тавдугаарт*, хамгийн сүүлчийн асуулт нь, “Транзит монгол” гэдэг хөтөлбөр амьд уу, үхсэн үү? Энэ дээр амьд, эсвэл үхсэн гэсэн товчхон хариулт өгнө үү.

**А.Гансүх:** - Тендерт бол 60 хоног зарцуулж байгаа. Яг нарийвчилсан хугацаа тоог нь манай хүмүүс тодруулаарай. Хэрэв маргаан гарах юм бол энэ хугацаа нь сунаад, тендер нь зогсчихдог. Шүүхийн маргаан бол дунджаар зургаан сараас 1 жил зургаан сарын хугацаанд үргэлжилдэг. Бордюрын хувьд бол хот хариулах байх, метроны хувьд бол Улаанбаатар хот дээр явж байгаа. Улаанбаатар хотынхон энэ дээр хариулна.

**С.Дэмбэрэл:** - Үгүй, би Улаанбаатар хотоос асуухгүй, танаас асууж байгаа байхгүй юу. Монгол Улсын Зам, тээврийн сайдын хувьд Улаанбаатар нийслэлд тавигдах метроны асар их хөрөнгө оруулалт шаардсан энэ хөрөнгө оруулалтын төслийн талаар танай яамны албан ёсны байр суурь юу вэ гэж зориуд асууж байгаа юм.

**А.Гансүх:** - Яах вэ, эхлээд энэ дээр тодруулъя. Зам, тээврийн яам бол олон улсын чанартай орон нутгийн чанартай замыг хариуцдаг. Улаанбаатар хотын замыг бол Улаанбаатар хот хариуцаж байгаа. Энэ утгаараа бол Улаанбаатар хотын дотоодын нийтийн тээврийн асуудал бол Улаанбаатар хот дээрээ явдаг учраас метроны асуудлыг Улаанбаатар хот зангидаад явж байгаа. Ер нь зам тээврийн салбарын хувьд бол метроны төслийг дэмжиж байгаа. 1.5 орчим тэрбум долларын хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжихээр төлөвлөж байгаа ийм төсөл байгаа. Эдийн засгийн үр өгөөжийн тооцоог нь үзсэн. Нэг хүн 600 орчим төгрөгөөр явахад эдийн засгийн үр өгөөжөө өгөх тооцоо гарсан байгаа, үүнийг дэмжиж байгаа.

**Б.Гарамгайбаатар:** - Үлдэнийг нь Хотынхон хариулах юм байна.

**Н.Гантөмөр:** - Бордюр дээр бол өмнө нь хийгдэж байсан ажлуудаар ингээд уламжлал болоод явчихсан. Энэ ажлыг бол зогсоож байгаа. Тэгээд зогсоохоос гадна замын арчилалтын асуудал давхар яригдаж байгаа. Манай хот дээр зам засвар, арчилалтын компаниуд байдаг. Тийм учраас тэр замын эвдэрсэн, хэмхэрсэн, өнгө зүсээ алдсан, шаардлага хангахаа байсан юмыг их хэмжээгээр биш ер нь бол тэр дор нь солих ийм хариуцлагыг Нийслэл хот хүлээж байгаа. Үүнийг бусдад шилжүүлж болохгүй. Энэ манай өмчид байдаг учраас хуулийнхаа дагуу шийдэгдэнэ. Метро дээр би...

**С.Дэмбэрэл:** - Метро дээр хариулт авахгүй. Хариулах хэрэггүй. Би асуудаг юмаа асуучихсан, би асуултаа тодруулъя. Тэр ямар утгаар гуйж байгаа юм шиг ёжилж байна вэ гэхээр, зүгээр байсан явган хүний замыг хуулж хаяад, дахин дахин солиод байгааг хэлж байна шүү дээ. Жил л болсон тэр бордйоруудыг дахиад, бараг тоосыг нь арчаад л буцаагаад тавьчих. Авах шаардлагагүй юмыг хийгээд байгаа байхгүй юу. Тэрийг л би ёгтолж асуусан юм. Тэгэхээр энэ хариултаас би нэг юм тодруулах гэсэн юм. Нэгэнт хэрэв 60 хоног ч энэ хуулийн хугацаа, амьдрал дээр энэ тендерүүд 3 сар болох гэж байна. 150 сая төгрөгийн тендер шүү дээ. Гэтэл танай салбар дээр яг би тэр маргааныг оролцуулалгүйгээр /Де факто/ бодит амьдрал дээр хэдэн хоног болоод байнаа? Энэ чинь ажлыг маш их саатуулж байна шүү дээ. Энэ чиглэлээр танай яам болон ер нь Засгийн газарт, Эдийн засгийн байнгын хорооноос Тендерийн хуулийн хэрэгжилтийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр анализ хийж, бүх яамны хэмжээнд, бүх тендерүүд дээр дүгнэлт хийгээд, тэгээд энэ чиглэлээр хуулийг өөрчлөх, шуурхай болгох талаас нь л би сонирхож асуугаад байна. А.Гансүх сайд та миний нөгөө нэг асуултад үргэлжлүүлээд дуусгачихаач. Сүүлийн 2 асуултыг маань хариулаад дуусгачих.

**А.Гансүх:** - Тэгсэн байна, дутуу хариулчихаж. PPP буюу төр хувийн хэвшлийн түншлэлийн хувьд бол Концессын хууль 2010 онд гарсан. Ингэснээр төр хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн. Үүний дагуу Засгийн газар 2011 онд 198 дугаар тогтоол баталж гаргасан. Энэ тогтоолоор бол, төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх нийт арга хэмжээний төлөвлөгөө, жагсаалтаа баталж гаргасан байгаа. Тогтоолд орж батлагдсан арга хэмжээнүүд дээр төр хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэхээр ажиллана. Энэ хүрээнд төмөр зам, авто зам бол ихэнх нь төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламж, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа учраас энэ бол ямар нэгэн төр хувийн хэвшлийн түншлэл хэрэгжүүлээд би ажил гүйцэтгэх гэрээгээр явчих болов уу, төр хувийн хэвшлийн түншлэлийг шинээр барих төмөр зам дээр хэрэгжүүлнэ. ВОТ нөхцөлөөр, агаарын тээврийн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн маш олон ажил байна. Ялангуяа шинэ нисэх буудлын менежментийг төр хувийн хэвшлийн гэрээгээр хийе гэж байгаа. Одоо байгаа Чингис хаан олон улсын нисэх буудлыг төр хувийн хэвшлийн түншлэлээр менежментийг нь өгөхөөр Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орчихсон байна гэх мэтчилэн ажлуудыг бид нар хэрэгжүүлнэ.

“Транзит монгол хөтөлбөр”-ийн хувьд бол үргэлжилж байгаа. Юуны өмнө бол Улаанбаатар төмөр замын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор арга хэмжээ авч байгаа. Засгийн газар Улаанбаатар төмөр замын дүрмийн санг нэмэгдүүлэх 250 сая долларын хүрээнд Улаанбаатар төмөр зам дохиолол холбоотой системийг хамгийн орчин үеийн евро стандартаар хийхээр шийдвэрлэсэн. Үүний үр дүнд Улаанбаатар төмөр замын нэвтрүүлэх чадвар 30 хувь нэмэгдэнэ. Өнөөдөр Улаанбаатар төмөр зам 25 сая тонн ачаа нэвтрүүлэх чадвартай, энэ төслийг хэрэгжүүлсний үр дүнд 30 сая тонн ачаа нэвтрүүлэх чадвартай болно. Дээр нь хамгийн орчин үеийн дохиолол холбооны системээр тоноглогдох учраас транзит тээвэр өснө гэж бид тооцож байгаа. Оросын тээврийн стратеги батлагдаж гарсан. Энэ тээврийн стратегид, 2015 он гэхэд Улаанбаатар төмөр замыг нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлнэ гээд бас орчихсон байгаа. Үүний дагуу бид нар ОХУ-тай хамтраад ажиллах, Улаанбаатар төмөр замын шинэчлэлийн төлөвлөгөөг гаргаж байна. Энэ дээр тооны зөрөө байгаа. Манай мэргэжилтнүүдийн тооцоогоор бол Улаанбаатар төмөр замын шинэчлэлийг хэрэгжүүлэхэд 1.7 тэрбум долларын хөрөнгө оруулалт шаардлагатай юм байна гэж тооцсон. Энэ бол урт хугацаандаа буюу 10 орчим жил үргэлжлэх ийм ажил байгаа. Оросын мэргэжилтнүүд бол 2.4 тэрбум долларын хөрөнгө оруулалт шаардлагатай юм байна гэсэн тооцоо гаргасан. Ингээд 2 тал мэргэжилтнүүдээ хамтарсан ажлын хэсэг дээр үүнийг нэгтгэх юм. Энэ ажлууд хийгдээд Улаанбаатар төмөр замыг шинэчлэх төлөвлөгөө тодорхой болно. Үүний үр дүнд транзит тээвэр нэмэгдэнэ. “Транзит монгол хөтөлбөр” хэрэгжинэ гэж би үзэж байгаа юм.

**Б.Гарамгайбаатар:** - За одоо үг хэлэх гишүүд хэлнэ үү... С.Дэмбэрэл гишүүн.

**С.Дэмбэрэл:** - За энэ саналыг сонслоо. Ер нь ажил хийгдэж байгаа л юм байна. Эдийн засгийн байнгын хороонд хэлж байгаа миний саналууд бол манай хорооны ажилд хандсан тийм санал юм шүү.

*Нэгдүгээрт*, энэ А.Гансүх сайдын тавьсан презентацийг сайн үзэж чадсангүй. Тэнд маш олон, тодорхой системтэй мэдээлэл өгөх юмнууд байх шиг. Тэр нь маш хурдан дурдагдаад явчих юм. Тийм учраас Эдийн засгийн байнгын хорооны веб сайтад иймэрхүү авч хэлэлцэж байгаа зүйлүүдийг урьдчилан байршуулж байх хэрэгтэй.

*Хоёрдугаарт*, тендерийн асуудлаар түрүүн би саналаа хэлсэн. Энэ Тендерийн хууль салбар болгонд хэрэгжиж байгаа байдлын талаар анализ хийх тийм үүргийг засгийн газарт өгөөд, үүнийхээ үндсэн дээр хуульд өөрчлөлт оруулахгүй бол түрүүн миний анх ярьсан шиг, 150-хан сая төгрөгийн төлөө ингэж хугацаа алдан явж байна. Тийм учраас хуулийн гарц хайгаад, Хөгжлийн банкны шууд гэрээ энэ тэр гэж яриад байлаа шүү дээ. Тэгтэл харин байхгүй юм байна, тэгэхээр энэ Тендерийнхээ хуулийг өөрчлөөч. Тийм учраас л би түрүүн асуугаад байгаа нь тэр шүү дээ. Улаанбаатар хот дээр ямар байгаа юм, яамууд дээр байгаа энэ тодорхой салбарууд дээр энэ тендерийн зүйл гээд, тэрийг хамгийн төгс төгөлдөр шийдэл олчихсон юм шиг, энэ нь хэзээ ч өөрчилж болохгүй зүйл юм шиг бодоод байгаа юм. Энэ чинь худлаа. Жишээлбэл, Баян-Өлгий аймгийн сумын сургуулийн дэврийг засах тендер зарлаж байгаа *infra currentment* гээд зарлаж байгаа юм. Өнгөц харахад гоё шударга юм шиг мөртлөө яг бодит амьдрал дээр энэ чинь худлаа байна. Тийм учраас тендерийн энэ тал дээр ажил хийхэд садаа болж байна. Дээр нь хүмүүсийг сэжиглэх үндэслэл бий болгож байна. Тийм учраас үүнийг хүмүүст, хэрэв дарга гээд тавьчихсан бол, итгээд эрх чөлөөг нь өг. Санхүүжилтийг нь шууд хийдэг болох хэрэгтэй. Тодорхой хэмжээний үлдсэн хэсэг дээр нь тендерийн хөндлөнгийн хяналттай байх энэ системийг оруулж өгөхгүй бол олон жил засгийн бүх байгууллагууд ингэж явчихсан байна. Тийм учраас, энэ бол танай яамны буруу биш, угаасаа Тендер гэдэг хууль нь ийм. Тэр хэрэгжихгүй байгаа нь үүнтэй холбоотой. Тийм учраас манай Байнгын хорооноос үүн дээр:

*Нэгдүгээрт*, анализ хийгээд, Засгийн газраас мэдээллийг нь аваад, энэ чиглэлээр цаашид хуулийг өөрчлөх ажлын хэсэг байгуулах хэрэгтэй байна.

*Хоёрдугаарт*, би түрүүн асуусан, метро гэхэд та дэмжиж байна лээ. Энэ бол танай яамны гэхдээ үүнийг Улаанбаатар хотын эдийн засаг, Монгол улсын макро эдийн засагтай хэр зэрэг холбогдож байгаа гэдгийг том хэмжээнд яриад, түүний дотор зам тээврийн салбарт яаж холбогдож байгаа гэдгийг харахгүй бол энэ чинь салчихаад байгаа шүү. Тийм учраас би тэр метроны проектын талаас хэр зэрэг зохистой байх талаас эдийн засгийн төдийгүй нийгмийн талаас нь, өөр альтернатив хувилбарууд байсаар байхад яагаад зөвхөн үүнийг л сонгож байгаа юм бэ гэдэг талаас нь асуусан. Тийм учраас үүнийг цаашдаа та анхаарвал, нэлээн сайн анхаарах ёстой.

*Гуравдугаар* санал нь, түрүүн Б.Гарамгайбаатар гишүүний саналуудыг дэмжиж байгаа юм. Би өөрөө мэргэжлийн хүн биш ч гэсэн маш тодорхой юм хэлчихсэн. Түүний дотор стандарт байсан, тэр нэг инженерийн холбогдолтой саналууд байна шүү дээ. Энэ бүхнийг болоод бусад гишүүдийн хэлсэн саналуудыг нэгтгээд Байнгын хорооны протоколд яаж тусдаг юм, үүнийг манай зөвлөх мэдэж байгаа байх, эсвэл Байнгын хорооны тийм зөвлөмж, тогтоол гаргадаг юм уу, яадаг юм ийм шийдэл нь байж, асуулт асуугаад, саналаа хэлж байгаа миний энэ оролцоо үр ашиггүй үрэгдэхгүйгээр шийдэл нь гарч, цаашдаа ажил болж байх ёстой шүү. Үүнийг л та бүхэн анхаараарай. Тэгэхгүй бол бид нар энд яриад суугаад байдаг, би жишээлбэл өлсөж байна өглөө нөгөө цахилгаан ус байхгүй байсан учраас хоол идэж чадаагүй. Тэгсэн мөртлөө энэ дээр саналаа хэлээд, үгээ хэлчихье гээд хүлээгээд суугаад байдаг. Тэгэхээр үүнийг анхаараад бид нарыг би байнгын хороон дотроо л ярьж байна шүү дээ. Үүнийгээ үр дүнтэй болох талаас энэ нэг тодорхой шийдэл, чиглэл зөвлөмж өгсөн ийм юм хийгээсэй гэж бодож байна, баярлалаа.

**Б.Гарамгайбаатар:** - Гишүүдэд баярлалаа. Үг хэлж дууслаа. Тэгээд Байнгын хороо бол мэдээж хэрэг Зам, тээврийн яамны мэдээлэл болоод хотын дэд бүтцийн асуудал хариуцсан хүмүүсийн мэдээллийг сонссон. Тэгээд мэдээлэл протоколд тэмдэглэгдсэн байгаа. Гишүүдийн хэлсэн үг болгон тэмдэглэгдсэн. Бид нар дараа нь яамд, хотын удирдлагуудад энэ асуудлаар тодорхой чиглэлүүдийг өгнө. Өгсөн чиглэлүүдийнхээ хариуг бид нар авч вэб сайтаар тараана. Гишүүд бол энэ хэлсэн ярьсан үгийнхээ хариуг нэхэх байх, тэгээд нэхэх асуудлыг Байнгын хороо зохион байгуулна. Ер нь бол бид нар иймэрхүү ажлуудыг ойр ойрхон хэрэгжилт ямар байгаа вэ гэдгийг бас мэдээлнэ гэдгийг хэлье.

**С.Дэмбэрэл:** - Байнгын хорооны дарга аа, би ганцхан санал мартчихаж. Би нөгөө Хөгжлийн банкны талаар ярих гэж байсан юм. Манай Байнгын хороо Хөгжлийн банкны асуудлаар ойрын хугацаанд энэ асуудлыг яг мэдээлэл хийлгэхгүй бол, өнөөдрийн Хөгжлийн банк нэг талаасаа хэрэггүй хогоо хаядаг шуудай болж хувирч байна. Тийм учраас үүнийг тусгайлан авч хэлэлцье гэсэн нэмэлт санал байна.

**Б.Гарамгайбаатар:** - Уг нь энэ удаагийн мэдээлэл дээр би Зам, тээврийн яам, хотын удирдлагуудын, Хөгжлийн банкиг гээд Төрийн өмчийн хороо гээд бүгдийг нь байлгаж байж гишүүдэд тодорхой мэдээлэл өгөөд, энэ хүмүүсийн хооронд байгаа тэр зөрчлүүдийг нь ойлголцуулья гэж бодсон. Тэгээд харамсалтай нь Төрийн өмчийн хорооны дарга ирээгүй. Хөгжлийн банкнаас хүмүүс ирээгүй учраас иймэрхүү юмнууд доголдоод байгаа. Хойшид үүнийг Байнгын хороо аль болохоор тарааж өгөх гээд оролдоод байгаа. Дээр нь Байнгын хороо бол бас нэг шинэ юм Байнгын хороогоор хязгаарлахгүйгээр бүх гишүүдийг сонирхсон асуудлуудаа оруулж ирж асууж, мэдээлэл ав гэсэн байр сууриар хандаж ажиллаж байгаа. Тэгээд гишүүд бас энэ дээр анхаарна биз дээ гэж хэлье.

**С.Бямбацогт:** - Б.Гарамгайбаатар дарга аа, наана чинь сая та сонин юм хэлж байна л даа. Хөгжлийн банк ирсэнгүй, нөгөөдөх нь юу билээ, Төрийн өмчийн хороо ирсэнгүй гэж байна. Ирэхгүй бол яах юм, хаях юм уу, ингээд өнгөрөх ёстой юу?

**Б.Гарамгайбаатар:** - Бид бол албан ёсоор ирэх шаардлага тавьсан, ирсэнгүй. Тэгэхээр тэр хүмүүстэй эргээд тэр асуудлаараа ярья. Уг нь Н.Батбаяр сайд сууж байсан шүү дээ. Н.Батбаяр сайдын байх үед нь тэр Хөгжлийн банкны асуудлууд нь яригдахгүй өнгөрчихлөө шүү дээ. Яг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг бид нар авчир гэсэн байсан юм. Тэгээд ирсэнгүй. За Ц.Оюунгэрэл гишүүн.

**Ц.Оюунгэрэл:** - Ц.Оюунгэрэл гишүүн. Би энэ С.Дэмбэрэл гишүүний саяын гаргасан санал дээр санал хураалт явуулах боломжтой юу гэж асуух гэсэн юм. Нөгөө энэ Тендерийн хуулийг шинэчлэх ажлын хэсэг Байнгын хорооноос ажлын хэсэг байгуулах нь их зөв юм шиг санагдаад байгаа юм л даа. Манайх шиг улирлын чанараар ажилладаг. Тэгээд түрүүн Ц.Нямдорж гишүүн ч хэлж байсан. Манай тендер бол хэн хамгийн муу барилга барих вэ, хэн хамгийн муу зам барих вэ гэдэг ийм уралдаант шалгаруулалт болдог гээд энэ бол соёлын салбар дээр яг адилхан болчихоод байгаа юм. Бид нар соёлын сайхан барилга байгууламж бариулах, одоо ингээд соёлын өвийг сэргээн засварлах гээд Монгол улсад дахиад хэзээ ч олдошгүй ховор соёлынхоо өвийг хамгаалах асуудал болдог. Тэгэхэд бид нар мэргэжлийн компаниудыг урихаасаа илүү дахиад тендер зарлаад хамгийн хямдхан нь гээд ингэх юм бол бас л замаас дутуугүй их л асуудал гарах гээд байдаг юм. Тэгэхээр зэрэг зам дээр гарч байгаа асуудал бол зүгээр бүх салбарт гарч

байгаа асуудлын нэг дүр төрх нь. Тийм учраас ийм одоо улирлын чанартай эдийн засагтай нийцсэн ийм сонгон шалгаруулалтын, хамгийн гол нь сонгон шалгаруулалтаас гадна энэ **С.Дэмбэрэл гишүүний саяын хэлдэг санал маш үнэтэй зүйл байгаа байхгүй юу**. Сонгон шалгаруулалт бол хялбархан, тэгээд энгийн, хүмүүст нээлттэй байдлаар хийгддэг. Дээр нь хийж байх явцад нь олон нийтийн хяналт шалгалт, олон нийтийн тэр мониторинг нь илүү их сайн нээж өгсөн тийм улирлынхаа чанарт нийцсэн ийм хуультай болмоор байх юм. Манай хууль бол үнэхээр сонгон шалгаруулалт нь нэг их урт хугацаанд зарладаг, маргаан гарахаар урт хугацаанд үргэлжилдэг, тэгсэн мөртлөө яг барьж байх үед нь олон нийтийн хяналт шалгалт хийх ямар ч боломжгүй ийм л хууль байдаг л даа.

**Б.Гарамгайбаатар:** - За энэ талаар Эдийн засгийн байнгын хороо анхааралдаа авъя. Тэгээд гишүүдийн энэ санал дээр тулгуурлаад бид бас зохих ажиллагаа хийе гэж бодож байна. Албан ёсоор Зам, тээврийн сайдын мэдээллийг сонсож дууслаа. Гишүүдэд баярлалаа.

## **Дэлхийн Ногоон Хөгжлийн Хүрээлэнгийн 19 дэхь гишүүн**

Монгол улс Global Green Growth Institute /GGGI/ буюу Дэлхий дахины Ногоон Хөгжлийн Хүрээлэнгийн 19 дэхь гишүүнээр элслээ. УИХ-ын гишүүн, Байгаль орчин, ногоон хөгжлийн Яамны сайд, Иргэний зориг ногоон намын дарга С.Оюун, УИХ-ын гишүүн, Иргэний зориг ногоон намын дарга С.Дэмбэрэл нар 2013 оны 06 дугаар сарын 12-нд Сөүл хотноо болсон Олон Улсын Чуулга уулзалтанд оролцох үеэрээ энэхүү гишүүнчлэлийг албан ёсоор хийж, баталгаажуулжээ. Энэ Хүрээлэнгийн гишүүн болсноор Монгол Улс ногоон хөгжил, өсөлтийн талаар олон улсын хамгийн шилдэг тэргүүний арга туршлагаас суралцаж, мэдээлэл авч, харилцаа хамтын ажиллагаа нь бэхжин хөгжиж, Ногоон Хөгжлийн талаарх ИЗНН-ын бодит бодит амьдралд хэрэгжихэд ихээхэн тустай болох юм хэмээн УИХ-ын гишүүн, Иргэний зориг ногоон намын дарга С.Дэмбэрэл онцлон тэмдэглэлээ.

### **Үйлдвэржилт**

Сүүлийн үед үйлдвэржилтийн тухай бид их ярьж бичих боллоо. Танхим энэ чиглэлээр маш тодорхой байр суурьтай, маш тодорхой бодлого, саналтай байгаа. Үүнийгээ ч урьд өмнө нь олонтаа илэрхийлж байсан бөгөөд бодитой /бага хэсэг нь/ болон бодитой бус шалтгаанаас төр, засгийн зүгээс олигтой дэмжилгүй өдий хүрсэн. Танхимын байр суурийг товч илэрхийлэхээс өмнө өнгөрсөн жилүүдийн зарим түүхийг сөхөө. 1990 он. Ардчилал ид “хөөрхөн” романтик үедээ бас нийгэм тэр чигээрээ зах зээлийн эдийн засгийн талаар хамгийн гэнэн, сурах бичгийн хүрээний ойлголт дөнгөж авч байсан үе. Хүндрэл бэрхшээл, үл итгэх, эргэлзэх, хомсдол, инфляц, өөдрөг гэнэн сэтгэл, хялбар төсөөлөл, реформын анхны алхмууд...Яг ийм үед (1990 оны 3 дугаар сарын 17-нд) “эдийн засагчдын” гэж нэрлэгддэг Монголын Үндэсний Дэвшлийн намын анхдугаар их хурал улсын циркэд сүр дуулиантай эхэлж байсныг санаж байна. Миний өмнө “МҮДНамын эдийн засгийн үзэл баримтлал хэмээх хавсралт илтгэл. Эвийн нөхөр



С.Дэмбэрэл” гэсэн нэртэй илтгэлийн шарласан хуудсууд байна. Бас эвийн нөхөр С.Дэмбэрэл” гээд биччихжээ. /тэр үед намын гишүүдийг нь “журмын нөхөр” нам бусыг нь “эвийн нөхөр” гэдэг байсан юм/. Үйлдвэржилттэй холбоотой бичсэн зүйлүүдийг нь уншъя:

”Юуны түрүүнд бид үйлдвэржилт гэдгийг аж үйлдвэрийг хөгжүүлэх бодлогоос өргөн хүрээтэй ойлгож байна гэдгийг тэмдэглэе. Үйлдвэржүүлэлтийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд дор хаяж дараах тулгуур угтвар нөхцөлүүд хэрэгтэй болов уу. Үүнд:

1. Онолын үзэл баримтлал
2. Гадаадын туршлага, ялангуяа Азийн орнуудын туршлага
3. Хувийн /хэвшлийн/ санаачлага, гадаад тааламжтай орчин
4. Хүчтэй, чухамдаа мэдлэгээрээ хүчтэй Засгийн газар.

1,2,3-рх нь манайд хараахандаа алга, бүрэлдүүлэх хэрэгтэй. 4-ийн хувьд маш чухал хүсүүштэй нөхцөл... Үйлдвэржүүлэлтийн бодлогын онолын үзэл баримтлал нь хөгжиж буй орнуудын үйлдвэржүүлэлтийн ерөнхий загварын хүрээнд, өөрөөр хэлбэл, импорт орлох үйлдвэржүүлэлтээс түүний дараах шат, түүнээс экспортын чиг баримжаатай үйлдвэржүүлэлт гэсэн ерөнхий загварын хүрээнд хүртэлх боловч түүхэн хөгжлийн эдгээр дараалал нь тухайн орны онцлог хэрэгжүүлж буй бодлогоос хамааран хоорондын шилжилтийн хугацаа нь өөр өөр, хослож явагдах, аль нэгийг нь алгасах зэрэг олон хувилбартай байж болох бөгөөд бие биендээ үгүйсгэгдэлгүй нягт хамааралтай болно. Монголын үйлдвэржүүлэлтийн стратегийг тодорхойлоход дээрх загваруудын онолын суурийг бүрдүүлэх нь чухал байна. Үүний тулд туйлын ба харьцангуй давуу талын онол, эдгээр дээр үндэслэсэн шинэ сонгодог сургууль, чиглэлийн онолууд, хамаарлын болон үндсэн хэрэглээг хангах онол зэрэг хөгжиж буй орнуудын үйлдвэржилтийн үйл явцын ололтын суурь дэвсгэрийг судлаж Монголын үйлдвэржилтийн бодлогын стратегийг тодорхойлох шаардлага тулгарч байна.” 18 жилийн өмнө үйлдвэржилтийн онолын үзэл баримтлал, загварын талаар бид ингэж бичиж байж... Өнгөрсөн хугацаанд энэхүү үзэл баримтлал, загварууд дэлхийн эдийн засгийн сэтгэлгээний хүрээнд үндсэндээ өөрчлөгдөөгүй харин улс орнуудын үйлдвэржилтийн үйл явцаар улам баяжиж ирсэн бөгөөд харамсалтай нь Монголд өдий хүртэл манай орны нөхцөлд тохирсон бодлого нь байхгүй, “Худалдаа, үйлдвэрийн яам” эсвэл “Үйлдвэр худалдааны яам” гэсэн үгийн дараалалыг нь л солих, “Үндэсний үйлдвэрлэлээ дэмжигч” гэж улиг болтол ярихаас хэтэрсэнгүй... Харин манай хувийн хэвшлийнхэн энэ хооронд өөрсдийн бор зүрх” “тархины саарал эдийн” хүч боломж, зах зээлийн соргог, нүд, чих, “өөрсдөд нь байгаа “*entrepreneurship*” мэдлэг, мэдрэмжээрээ үйлдвэржилтийг хэрэгжүүлж” Монголд үйлдвэрлэл эрхлэмээр!” гэж заримдаа хараатлаа адлагдан, төрөл бүрийн хүнд суртал, хүлээсийн дор гүрийж ирэх шивдээ. Энэ бол өнгөрсөн 18 жилийн бодит дүр зураг... За одоо эргээд 1990 онд юу гэж бичсэн лүүгээ ороё.

“...Импортыг орлох үйлдвэржилтийг цаашид хэрэглээний, түүний дотор удаан хэрэглээний бүтээгдэхүүн, завсрын бүтээгдэхүүн, зарим капитал багтаамж ихтэй бүтээгдэхүүний үйлдвэржилтийн чиглэлээр дотоод зах зээл, экспорт аль алинд нь зориулах чиглэлээр хөгжүүлэх, импортыг зохицуулах программ боловсруулж түүний хүрээнд төрийн зохицуулалтын арга хэрэгслийн тусламжтайгаар ойрын 8-10 жилд ганц орны импортоос хэт хамааралт байдлаас аль болох гарах, ...импортыг орлох, импорттой өрсөлдөх жижиг, дунд үйлдвэрлэлийг өргөнөөр зохион байгуулах нь зүйтэй.



...экспортын шинэ бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд экологийн хувьд цэвэр орчин, байгалийн өвөрмөц шинж чанартай, хүнсний, эмийн болон бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн реклам сурталчилгааг гадаадын алдартай том пүүсүүдээр дамжуулж явуулах, тодорхой зах зээлийг эзлэж авч чадах “эрүүл мэнд ариглагч” шинэ бүтээгдэхүүн бий болгох аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгч экологийн давуу талыг хадгалан үлдэх бодлого хэрэгжүүлсний үндсэн дээр Монголын “экодолларын” шинэ урсгал бий болгох...

...Үндсэн хэрэгцээг хангах үзэл баримтлалын үндсэн дээр хөдөөгийн үйлдвэржүүлэлтийн бодлогыг хэрэгжүүлж, жижиг дунд, үйлдвэрүүдийг хөгжүүлэх...”

Энд дурьдсан үндсэн хэрэгцээг хангах үзэл баримтлал гэдгийг бяцхан тодруулая. Энэ бол олон улсын хөдөлмөрийн байгууллагын зүгээс хөгжиж буй орнуудын хөгжлийн практик, түүний дотор хөдөөгийн үйлдвэржүүлэлтийн үйл явцыг судалж дүгнэх үндсэн дээр боловсруулсан концепц бөгөөд тэр үед би Монголын хөдөөд тохирно гэж үзээд санал болгож байсан хэрэг.

Үнэндээ өнгөрсөн 18 жилд бид зөв бодлого хэрэгжүүлж чадсан бол үйлдвэржүүлэлтийн хувьд чамлалтгүй зүйл хийж болох байсан бөгөөд нөөц хөрөнгө, дэд бүтэц дутуу байсан, Одоо л бололцоотой болох нь гэх мэт үг яриагаар бодлогын алдаагаа өмөөрөх нь учир дутагдалтай юм. Үйлдвэржилт ардчилсан хувьсгалын 2 дахь шат гэх мэт гоё хэллэгийг улс төрчдөд үлдээгээд Монгол улсын хувьд “Хөгжилгүй өсөлт” давамгайлсан энэ үеэс “хөгжилтэй өсөлт” буюу эдийн засгийн засгийн сүүлийн үеийн нэр томъёолол болох “inclusive economic growth буюу энгийнээр хэлбэл хүмүүст наалдацтай эдийн засгийн өсөлтийн бодлого руу орох цаг болсон. Энэ үе шатны гол агуулга нь үйлдвэржүүлэлт байх учиртай. 2008-2012 онд болон цаашдын үе шатанд Монгол улсад үйлдвэржүүлэлтийг хэрхэн хөгжүүлэх вэ? Сүүлийн үед Ардчилсан намаас энэ асуудлыг маш хүчтэй дэвшүүлж нийгэмд үүнийг дэмжсэн уур амьсгал, санал, санаачилга бий болж байна. Н.Батбаяр, Д.Зоригт нарын дэвшүүлж буй 100 үйлдвэрийн санал /тоондоо чухал биш гэдгийг уншигчид ойлгож байгаа биз дээ/ гэх мэт үйлдвэржүүлэлтэнд хандсан төр, хувийн хэвшлийн арга барил, хандлага тодорч эхэлсэн нь дэмжүүштэй зүйл юм. МАХНам энэ чиглэлээр бас тодорхой санал боловсруулж буй гэж сонссон. 2006 оноос эхлэн Танхим энэ чиглэлээр хэд хэдэн бодлогын санал дүгнэлт, зөвлөмж боловсруулан төр, засагт илгээсэн бөгөөд одоо “үйлдвэржилтийн газрын зураг” боловсруулж дуусаад байна. Энэхүү газрын зурагт дараагийн 4 жилд хэрэгжүүлэх боломжтой үйлдвэржилтийн төрөл, чиглэлүүд тусгагдсан. Цаашдаа Монголд үйлдвэржүүлэлтийн бодлого дорхи төрөл, чиглэлүүдээр хэрэгжих боломжтой юм. Үүнд:

1. Аймаг, бүс нутгийн зах зээлд баримжаалсан, тэдгээрийн тэлэлт, гүнзгийрэлт, төрөлжилтийг хангахад чиглэгдсэн, аймгуудын газрын дээрх болон дорхи нөөц, боломжид суурилсан, үндсэн хэрэгцээг хангах, тодорхой хэмжээгээр импортыг орлох, экспортын баримжаатай хөдөөгийн үйлдвэржүүлэлт. Энэ нь их төлөв жижиг, дунд үйлдвэрлэл байна. Одоогийн байдлаар бид бүх аймгуудын эрэлтийг судалдсаны үндсэн дээр хөгжүүлж болох ЖДҮ-дийн мэдээллийн санг үүсгэж бэлэн болгоод байна.

2. Хөдөө орон нутгийн иргэдийн үндсэн хэрэгцээг хангах, мал аж ахуй, газар тариалангийн анхдагч бүтээгдэхүүн, нэмэгдсэн өртөг үйлдвэрлэх чиглэлтэй өрхийн болон бичил аж ахуй дээр суурилсан “бичил үйлдвэржүүлэлт”.

3. Өргөн хэрэгцээний түүний дотор удаан хэрэглээний бүтээгдэхүүн, тодорхой салбаруудын эцсийн бүтээгдэхүүн болон завсрын бүтээгдэхүүн, зарим капитал багтаамж ихтэй бүтээгдэхүүн зэргийн импортыг орлох, импорттой өрсөлдөх үйлдвэржүүлэлт.

4. Органик хөдөө аж ахуй, цэвэр байгаль орчны хосолсон хөгжил дээр үүссэн, цэвэр бүтээгдэхүүн, мэдээллийн технологийн outsourcing дээр түшиглэсэн экспортын диверсифицац, бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн үе шат бүр дээр суурилсан бүтээгдэхүүний хөгжлийн үндсэн дээр бий болох уламжлалт бус, шинэ бүтээгдэхүүний экспортын баримжаатай үйлдвэржүүлэлт /уламжлалт экспортын зах зээлийн өргөжилт болон өртөг нэмж бүтээх үйл явц зэрэгцэн явагдана/

5. Аялал жуулчлалын сектор дахь нэмэгдсэн өртөг бүтээх үйл явц, үйлчилгээний секторын орчин үеийн технологи дээр суурилсан, энэ секторын улирлын шинж чанарыг хамгийн бага болгоход чиглэгдсэн аялал жуулчлалын үйлдвэржүүлэлт.

6. Эрдэс баялгийн салбарын анхдагч бүтээгдэхүүний гүнзгий боловсруулалт, стратегийн том ордуудын ашиглалт, хөгжлийг дагалдан үүсэх субконтрактын харилцаан дээр үүсэж бий болох болон био-, нано-, hitech дээр суурилан хөгжих капиталын болон мэдлэгийн багтаамж ихтэй үйлдвэржүүлэлт.

7. Гадаадын орнуудад ажиллаж амьдарч байгаа монголчуудынхаа, ялангуяа үйлдвэржүүлэлтийг амжилттай хэрэгжүүлсэн улс орнуудад ажиллаж буй монголчуудынхаа мэдлэг, мэргэжил, туршлага, дадлагыг ашиглах үндсэн дээр тэдэнд зориулсан аж үйлдвэрийн тусгай парк байгуулах замаар хэрэгжүүлж болох үйлдвэржүүлэлт буюу монголын диаспора дээр түшиглэсэн үйлдвэржүүлэлт. БНСУ-д гэхэд л монголчууд эрчимжсэн хаа-гаас гадна 20 илүү төрлийн үйлдвэрийн салбаруудад ажиллаж байна. Тэнд гахайн фермд 5 жил ажилласан залуу өнөөдөр Монголдоо ирчихсэн гахайн аж ахуй амжилттай эрхлээд л явж байна. Солонгосын нэгэн их сургуульд био, нано технологийн чиглэлийн лаборатори удирдаж буй монголын иргэн монголдоо энэ чиглэлийн компани байгуулан томоохон зорилтууд тавиад ажиллаж л байна. Япон улсад нанотехнологи судалсан багш өнөөдөр Монголдоо нанотехнологийн үндэсний төв санаачлаад л явж байх жишээтэй. Иймэрхүү үүсгэл санаачилгыг дэмжээд төрийн зүгээс хөрөнгө мөнгө, бодлого, үйл ажиллагаагаар дэмжээд үйлдвэрийн тусгай парк яагаад байгуулж болохгүй гэж? Монголдоо байгаа эрдэмтдийгээ үйлдвэржүүлэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд яагаад зориудаар дэмжиж болохгүй гэж? Монголдоо байгаа “оюун ухаан дайжиж зугтах” үйл явцыг яагаад зогсоож болохгүй гэж?

Маш нарийн мэргэжил эзэмшсэн мөртлөө шал -өөр ажил эрхлээд явж байгаа хүмүүс зөндөөн байна. Яагаад тиймэрхүү нарийн мэргэжлийн хүмүүсийг үйлдвэржилтийн үйл явцад ашиглаж дэмжиж болохгүй гэж? Одоо тэр “удаан дуншсан” аж үйлдвэрийн паркуудын тухай эрх зүйн баримт бичгүүдээ яаралтай батлах хэрэгтэй байна.

Замын үүдийн эдийн засгийн чөлөөт бүсийн асуудлыг яаралтай нэг мөр болгож шийдмээр байна. Муу засаглалын сонгодог жишээ болохоор энэ асуудалд дэндүү хойрго, дэндүү хариуцлагагүй хандсан. М.Энхболдын Засгийн газрын үед л стратегийн хөрөнгө оруулагч хайж, Монгол улс “хулихдуулж” байх үед л бид энэ бүсийн менежментийг манай танхимд хариуцуулахыг хүсэж хоёр ч удаа захиа-санал Засгийн газарт явуулж байсан. Ирсэн хариу нь инээдэмтэй бөгөөд өрөвдмөөр: танай танхимд хариуцуулах хууль эрх зүйн үндэслэл алга байна...

Цаашид үйлдвэржүүлэлтийн санхүүжилтийг яаж хийх вэ гэдэг асуудал нэн чухал болж тавигдана. Өнгөрсөн жилүүд шиг зөвхөн хувийн хэвшлийнхний мөрөн дээр бүх ачааг үүрүүлэх үү эсвэл үйлдвэржүүлэлт, бизнесийн тааламжтай орчны бодлого гаргаж хөрөнгө санхүүгийн томоохон дэмжлэг төрийн зүгээс үзүүлэх ёстой юу? Мэдээж хэрэг, төрийн бодлого, санхүүгийн дэмжлэг нэн чухал. Гэхдээ өнөөгийнх шиг бус, үйлдвэрлэл эрхлэгчид жинхэнэ тааламжтай орчинг хувийн хэвшил-Загийн газрын түншлэлийн механизмаар дамжуулан бий болгох ёстой. Санхүүжилтийн хувьд зөвхөн банкны зээл, гадаадын хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламж төдийгүй Монголын хөгжлийн сангаас дор хаяж 30-40 млрд төгрөгийг үүнд зориулан гаргах хэрэгтэй. Энэхүү хөрөнгийг өнөөдрийн практикт хэрэгжиж буй арилжааны банкны зээлийн хүүний зөрүүг нөхөн олгох байдлаар бус, банкны бус, альтернатив санхүүжилтийн эх үүсвэр болгон ашиглах энэ эх үүсвэрийг МҮХАҮТанхимд 5-7 жилийн хугацаатайгаар, хөнгөлөлттэй нөхцөлөөр зээлдүүлэхийг бид санал болгоод байгаа. /Сүүлийн үед яриад байгаа хөгжлийн банк байгуулах асуудал явцгүй бөгөөд үр дүнгүй гэдэг нь хөгжиж буй олон оронд батлагдчихсан зүйл яагаад гэвэл муу төр оролцсон үед их төлөв “буруу замаар будаа тээдэг”. / Дээрх эх үүсвэрийг бид гишүүн байгууллагууд, мэргэжлийн чиглэлийн төрийн бус байгууллагуудтай хамтран альтернатив санхүүжилтийн аргаар шаардлагатай жижиг, дунд үйлдвэрүүдийг өөрсдөө оруулж ирэн тухайн аймаг, сумдын бизнес эрхлэгчдийн дунд нээлттэй тендер зарлах замаар /болон бусад арга хэрэгслээр/ тухайн үйлдвэрийг аваад явчих боломжтой, тухайн үйлдвэрийн үнийн 30 хувийг төлөх боломжтой эсвэл тодорхой бусад нөхцөлүүдийг хангаж чадах компани, иргэдэд 3-5 жилийн хугацаатайгаар санхүүгийн лизингийн аргаар шилжүүлэх, мөн тодорхой хэмжээний эргэлтийн хөрөнгийн зээлийн санхүүжилтээр үйлдвэрийн ашиглалтын эхний 1,2 жилд хангах замаар ашиглах юм. Альтернатив санхүүжилтийг өмнө дурдсан үйлдвэржүүлэлтийн 1, 2 дугаар төрөл чиглэл, тодорхой хэмжээгээр 3,4-р төрөл чиглэлүүд хэрэгжүүлж болно гэж үзэж байна. Түүнчлэн энэ санхүүжилтийг Улаанбаатар хотын алслагдсан дүүргүүдэд аж үйлдвэрийн парк байгуулахад ч хэрэглэж болно. Дэлхийн банк, Герман, Японоос сүүлийн жилүүдэд хувийн хэвшлийг дэмжих зориулалт бүхий 40.50 сая долларын зээл олгож арилжааны банкуудаар дамжуулан хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж байгаа. Гэхдээ эдгээр зээлийн хүртээмж, болзол нөхцөл нь нийт ЖДҮ эрхлэгчдийн хувьд хүндрэлтэй бөгөөд боломжгүй байгаа нь бодит үнэн. Чухам иймээс л бид альтернатив санхүүжилтийн энэхүү арга, ЖДҮ-ийн зээлийн баталгааны тогтолцоог санал болгоод зогсохгүй тодорхой хэмжээгээр хэрэгжүүлээд эхэлчихсэн. Гагцхүү үүнийг ойлгож дэмжих төр засаг хэрэгтэй байна. Тийм ч учраас МҮХАҮТанхимаас дараагийн 4 жилд хэрэгжүүлэх эдийн засгийн бодлого, түүний дотор үйлдвэржүүлэлтийг хэрхэн хэрэгжүүлэх санал бүхий баримт бичгийг боловсруулаад МАХНам, Ардчилсан намд “Санамж бичиг”-ийн хэлбэрт оруулаад санал тавьчихсан байгаа. Ойлгон хүлээн авч сонгуулиас өмнө гарын үсэг зурна байх гэж найдаж байна. Учир нь тэрхүү бодлогын баримт бичигт Монгол улсад эдийн засгийн ямар ямар бодлого хэрэгжүүлэх, хувийн хэвшил, ЖДҮ-ийг яаж, ямар арга замаар хөгжүүлэх, дэмжих талаар цэгцтэй бөгөөд тодорхой томъёологдсон байгаа. Үйлдвэржүүлэлтэд шаардлагатай бусад асуудлууд, түүний дотор мэргэжлийн ажиллах хүчний асуудал гэх мэтийн талаар олон зүйл бичиж болох хэдий ч одоо цэглэе. Цаашдаа үйлдвэржүүлэлтийн талаар олон зуун хуудас цаас үйлдвэрлэгдэж

“цаасан дээрх үйлдвэржүүлэлт” болохгүй байгаасай гэж хүсэж байна. Би лав энэ сэдвээр дахин бичихгүй, МҮХАҮТанхим тодорхой үйл ажиллагаагаа л үргэлжлүүлнэ. Засаг төр ч тэгэхгүй байгаасай гэж хүсч байна.

С.ДЭМБЭРЭЛ. МҮХАҮТ. 2008 он.

## Судалгаанд үндэслэж, шийдвэрээ гаргая

*Улсын Их Хурлын 2013 оны ээлжит бус чуулганы Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороодын 9 дүгээр сарын 17-ны өдрийн хамтарсан хуралдааны тэмдэглэлээс: Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бус, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаар*

С.Дэмбэрэл: - Өнөөдрийн энэ хэлэлцэж байгаа асуудал маань өөрөө логик утгаа алдчихжээ. Улсын Их Хурлын ээлжит бус чуулганд бид хамгийн түрүүнд юу хэлэлцэх ёстой байсан бэ гэвэл Улсын Их Хурлын даргын өөрийнх нь захирамжаар байгуулагдсан Монгол улсын эдийн засгийн дотоод, гадаад орчин, түүнд өгөх үнэлэлт, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний талаар Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан ажлын хэсгийн, нэгэнт бэлэн болчихсон баримт бичгийг буюу энэ бодлогынхоо шүхэр бодлогоо ярьчихаад энэний нэг бүрдэл хэсэг болох 20 асуудлын зөвхөн нэг нь болох гадаадын хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын тухай гэх мэтээр ингэж логик дарааллаар явах байсан. Гэхдээ одоо яг миний гаргах гэж байгаа нь, тэгвэл энийгээ шууд хэлэлцье. Яагаад гэвэл энэ зун хүмүүс нэг хэсэг нь амарлаа, нэг хэсэг нь ажлаа хийсэн. Судалгаа гарсан. Их Хурлын ажлын хэсгээс зузаан гэгчийн судалгаа гарсан. Дээр нь олон улсын байгууллагаас Монгол улсын эдийн засгийн дотоод, гадаад орчинд өгсөн судалгаанууд гарсан. Энэ олон судалгаануудыг үндэслэн бусад олон нийтийн санал бодлыг үндэслэн Улсын Их Хурлын ажлын хэсгээс бэлэн хэлэлцээд шууд явахад бэлэн шийдлүүд байна. Бид өнөөдөр шийдлүүд ярих ёстой. Тэр гол шийдлээ эхлээд ярья. Тэрний дараа бусад асуудлаа ярья. Энэ бол хамгийн горимын санал шүү.

**Б.Гарамгайбаатар:** - С.Дэмбэрэл гишүүний горимын саналыг сонслоо. Тэгэхээр С.Дэмбэрэл гишүүн ээ, Эдийн засгийн байнгын хороо дараа нь үргэлжлүүлээд тусдаа хуралдаанаа явуулна. Энэ бол Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороотой хамтарсан хуралдаан явж байгаа учраас таны асуудал дараагийн асуудалд орж байж ярих асуудал байна.

## Өрсөлдөх чадвартай хууль байх ёстой

*Улсын Их Хурлын 2013 оны ээлжит бус чуулганы Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороодын 9 дүгээр сарын 17-ны өдрийн хамтарсан хуралдааны тэмдэглэлээс:*

**С.Дэмбэрэл:** - Би эхлээд даргаас асууя. Сая түр гараад, ороод ирсэн чинь энэ хооронд үүний өмнөх 2 байнгын хорооны хамтарсан хуралдаан дээр хэлсэн горимын саналыг маань та хэлэлцэх асуудалд оруулаагүй байна. Тийм учраас одоо гишүүд байгаа дээр хэлэлцэх асуудал дээр нэмэлт асуудал оруулъя. Тэр нь юу вэ гэхээр, 5 дугаар сард Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан “Монгол Улсын эдийн засгийн дотоод гадаад орчин, түүнд өгөх дүгнэлт, цаашид авах арга хэмжээний талаар” ажилласан манай байнгын хорооны ажлын хэсгийн боловсруулсан санал дүгнэлт, судалгааны үр дүнг энэ Эдийн засгийн байнгын хороон дээр хэлэлцэхгүй бол өөр хаана хэлэлцэх юм бэ? Энэ өөрөө тулгамдсан асуудал буюу миний түрүүний хэлснээр одоогийн хэлэлцэх гэж байгаа асуудлууд чинь шүхэр нь, үүнийгээ хажуугаар нь хамт хэлэлцээд явъя. Тийм учраас үүнийг нэгдүгээрт шийдье. Н.Батбаяр сайдаас би энэ юмнууд ингэсэн байна гэхээсээ илүү асуулт маягаар ийм зүйлүүд дутаж байна гэдгийг хэлье. Асуулт маягаар. Яагаад гэвэл асууж байгаа учраас. Саналыг би асуултын хэлбэрт оруулж байна. Тэгш байдлыг оруулж иржээ. Дотоод гадаадын хөрөнгө оруулалт, тэгээд уншаад байсан чинь тэгш байдал бол зөвхөн аливаа гадаадын хөрөнгө оруулалтын хуулийн өрсөлдөх чадварыг нь тодорхойлдог хоёрхон зүйл л байдаг дэлхий даяар тэр нь нэг нь тогтвортой байдлыг хэр зэрэг хангаж чадаж байна, нөгөөдөх нь incentive буюу урамшуулал хөшүүргийн тогтолцоог хэр зэрэг оруулж өгсөн гэдгээр улс орнууд уралддаг. Үүнийг та бүхэн нэлээн судалсан байх гэж бодож байна. Тэгээд энэ талаас нь үзэхээр хууль дээр чинь сүүлийн хэсгүүд дээр дан гадаадын хөрөнгө оруулалт гээд явчихаж байгаа юм. Татварын тогтвортой орчин дээр ОК - болж байна, үүнийгээ цаашаа яриад явна биз. Тэгвэл яах юм бэ, жишээлбэл хөдөө хөрөнгө оруулбал яах вэ юм бэ? 999 сая төгрөг оруулбал яах юм бэ? Шинэ технологи, өндөр технологи руу хөрөнгө оруулсан дотоод гадаадын компаниудад ямар урамшуулал өгөх юм бэ? Татвараас гадна, яриад байна л даа. Зөвхөн татварыг л яриад байгаа байхгүй юу, бусад хөшүүргүүд байна шүү дээ, бусад улс орнуудын хуулиудыг судлаад үзэхээр энэ талаас нь бодсон, өөрөөр хэлбэл хөшүүргийн систем маань хоёр хөлтэй байх ёстой. Хуулийн маань нэг хөл нь аятайхан гарчихаад, нөгөө хөл нь тодорхой бус байна. Үүнийг хийх үү гэсэн *нэгдүгээр асуулт*.

*Хоёрдугаарт нь*, цахим нэг цонх гэж ойлголт байна, өмнөх хууль дээр ер нь бол өнгөрсөн 20 жил 1990 оноос хойш Монгол Улс анхны хөрөнгө оруулалтын хууль батлагдсанаас хойш, юу болсон бэ гэхээр Монгол Улсыг гадаадын хөрөнгө оруулалтын тооны хувьд дэвшил гарсан ч гэсэн, чанарын хувьд олигтой дэвшил гарч чадаагүй. Одоо та бүхэн хөрөнгө оруулалтын бүтцийн болон газар зүй, салбарын бүтцийг нь хараарай. Хаашаа хөрөнгө хамгийн их орсон байна гэдгийг хар. Тэгэхээр энэ улс чинь хөрөнгө оруулалтыг татах гэж байгаа юм бол тэр бодлогоо гаргаж ирдэг юм. Тийм учраас салбарыг ингээд бүхэлд 100 мянган доллароор тэгш байдлаар үзэх нь дээр үү, эсвэл аль салбарт Монгол Улс, монголчууд чадахгүй тэр хөрөнгө оруулалтыг яаж татах вэ гэдэг тэр асуудал дээр incentive буюу урамшуулал хөшүүрэг гэдгийг оруулж өгч болох уу?

*Гуравдугаарт нь*, цахим нэг цонх гээд би Бүртгэлийн газрыг бүгдийг нь мэднэ. Тэгэхээр бид нар болно invest Mongolia гэдгийг бол тэр байгууллагуудын чинь дотор нэг функц байдаг юм. Ялангуяа та нар судалж байгаа бол Солонгосыг сайн судал, Котра гэдэг байгууллагыг судал, Жетро байгууллага, майтрейд гэдэг байгууллагуудыг судал. Дандаа энэ хөрөнгө оруулалтыг нь дэмжин урамшуулах үйл ажиллагаанд нэг юм байдаг юм.



Тэр нь омбуцмены үйлчилгээ гэж. Энэ хуулийн хэллэг өөрөө хуульд чинь сууж өгөх ёстой. Омбуцмены үйлчилгээг бий болгоно гэж байгаа юм. Түүнээс биш бизнес, хөрөнгө оруулалтын агентлаг ФИФТА гэж байж л байсан шүү дээ. Яагаад гэвэл байхгүй болчихсон юм бэ? Түүнийгээ яагаад харж чадаагүй юм бэ? Хөрөнгө оруулалтыг ганцхан жилээр хардаг юм уу? Урт хугацаагаар гэвэл институцийг бодох ёстой байсан шүү дээ, одоо байгуулж болно, орон тоо тэр нь чухал биш, хамгийн гол нь омбуцмены үйлчилгээг цахим нэг цонхны үйлчилгээ гэсэн хууль зүйн хувьд нь хэллэгийг нь оруулж өгөхгүй бол энэ хууль чинь явахгүй. Тийм учраас үүнийг оруулж өгч болох уу гэсэн гуравдугаар асуулт.

*Дөрөвдүгээрт нь,* Дүрмийн сан 100 мянган доллар гээд олон жил явлаа. Өнөөдөр 100 мянган долларынхоо үнэ цэнийг бодоод үз. Өнөөдөр Солонгосын ч гэдэг юм уу, хаа нэгэн газраас өөрийнхөө орны санхүү зээлийн тааламжтай орчныг ашиглаад 100 мянган долларыг чинь зээлж аваад 25 мянган долларт нь гадаадын хөрөнгө оруулалт гэж бүртгүүлээд ингээд явж байгаа. Тэгэхээр үүний үр дүнд би түрүүн хэлсэн чанарын асуудал буюу монголын эдийн засгийн салбаруудад entertainment, жижиглэн худалдаа, үйлчилгээнд хөрөнгө оруулалт их орсон. Гэхдээ дандаа жижиг хөрөнгө оруулалт. Зарим нь хуучин хувцас зардаг хөрөнгө оруулалт байна. Компаниудтай уулзаад явахад жижиглэнгийн секторт, аялал жуулчлалын секторт солонгосын хоолонд ордог, солонгос ресторандаа ордог, солонгос зочид буудалдаа буудаг, ингээд онигоо шиг юм байгаа. Тэгэхээр энэ бүхний чинь хөрөнгө оруулалтынхаа босгыг 100 мянгаар үлдээх юм уу, эсвэл ялгавартайгаар, зарим салбаруудад өндөр байхаар, тухайлбал: жижиглэнгийн салбар дор хаяж нэг сая доллар орж байж 4 давхар байшин барина. Түүнээс биш хаа нэгэн газар түрээс аваад юм хум зараад байдгаа гадаадын хөрөнгө оруулалт гээд явж болмооргүй байна. Вьетнам авто засварын газар 1000 вьетнам ажиллаж байгаа бүртгэлтэй гэж байгаа. Караоке-г монголчууд байгуулж чадах уу, энэ бүхэн гадаадын хөрөнгө оруулалт мөн үү, энэ секторт яах юм бэ? Entertainment секторын босго яах юм бэ? Аялал жуулчлал, жижиглэнгийн худалдаа гээд WTO-дэлхийн худалдааны байгууллагын өмнө улс орнууд нөгөө commitment авахдаа энэ жижиглэнгийн худалдаа, санхүү дээрээ маш хатуу нөхцөлтэй байдаг. Тэгвэл санхүүгийн секторт гадаадын хөрөнгө оруулалт яагаад одоо орж ирэх юм бэ? Яаж энэ хуулиар зохицуулах юм бэ? Дээр нь энэ бүхнийг оруулж өгч болох уу?

*Тавдугаарт нь,* Дээр нь хамгийн түрүүнд тодорхойлолт өгсөн байна л даа. FTI буюу гадаадын шууд хөрөнгө оруулалт гээд тодорхойлолтоо зөв өгчихөж. Тэгсэн мөртлөө дараа нь тэр хуулийнхаа ар талд нь юу ч дурдаагүй мөртлөө шууд бус буюу Institutional investment гэдгийг оруулж өгчихөөд, энэ хуульд байх шаардлагагүй юм ороод ирчихэж. Тийм учраас энэ тодорхойлолтыг хасаж болох уу гэсэн дараагийн асуулт. Өөрөөр хэлбэл би саналуудаа асуултын хэлбэр оруулаад байна шүү дээ.

*Зургадугаарт* буюу хамгийн сүүлчийнх нь, энэ хуулиар гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг тэгш авч үзэж байгаа юм бол муудуулж болохгүй гэж Л.Энх-Амгалан хэлээд байна. Сайжруулсан тийм орчин бий болгох ёстой. Би хэлээд байна шүү дээ, дотоодын хөрөнгө оруулалтын өмнө яагаад нэг ч юм оруулаагүй юм бэ? гэсэн асуулт байна л даа. Дандаа гадаадын хөрөнгө оруулалт гээд хуучин хуулийнхаа юмнуудыг тавьчихсан, тэгэхээр энэ хуулийг цаашдаа ер нь саяын хэлсэн болон явцын дунд гарч ирэх асуудлууд. Тухайлбал: бид нэг хөлтэй эдийн засаг, тэр нь хөл нь доголж



байна одоо нөгөө хөлөө бий болгоно гээд ярьчихсан. Түүнийгээ бид нар “солонгоруулна” гэж ярьж байгаа юм. Экспортын солонгоруулалт буюу диверсификацийг энэ хуулиар яаж урамшуулах юм бэ? Экспортын өртөг нэмэгдүүлсэн шинэ бүтээгдэхүүн ямар нэгэн дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалт Баянхонгор ч юм уу, Архангай аймагт хийгээд гаргаад ирвэл энэ хөрөнгө оруулалтын хуулиар татварын тогтвортой орчноос гадна бусад ямар өөр incentive буюу урамшууллын хөшүүрэг үйлчлэх юм бэ? Иймэрхүү асуултуудыг тавимаар байна. Түрүүн хамгийн эцэст нь хэллээ, хуучин бол сууж байдаг байсан, одоо очно гэж. Уучлаарай, тийм биш, өмнө нь дандаа явдаг байсан. Investment семинар гээд энд тэндгүй хийдэг байсан. Гэхдээ ямар ч семинар байсан олон улсын туршлагад дотоод хуулийн эрх зүй чинь өрсөлдөх чадвартай байж чадахгүй, хэн бэ гуай ч яваад тэрийг чинь дуудаж чаддаггүй юм. Тийм учраас энэ үнэхээр тэр институт байгуулаад тэр нь явдаг, урьдаг тийм юм болох гэж байгаа бол түүний чинь ганц суурь шалтгаан нь энэ хуулийн өрсөлдөх чадварт байгаа юм. Тийм учраас бидний гол баримтлах зарчим бол энэ хуулийг харах гол цонх бол өрсөлдөх чадвартай хууль болж чадах уу гэдгийг харах ёстой. Энэ чиглэлээр энэ хуулийг өөрчилж болох уу гэсэн сүүлчийн асуулт байна. Баярлалаа...

... Би тодруулчихъя. Тэгээд хууль дээр ийм юм байгаа юм, үүнийг бас анхаарчихвал зүгээр байна. Нийтийн эрх ашиг гэдэг эвгүй үг байгаа шүү. Тэрийг олон улсын эрх зүйн системд ерөөсөө одоо хүртэл тодорхойлоогүй байгаа. Хаана тодорхойлчихсон бэ гэхээр Ancestral гэж байгууллага нэгдсэн үндэстний түүний public interest гэдэг дээр үүнийг оруулахгүй бол зүгээр нийтийн эрх ашгийн үүднээс дайчлан, нөхөн гаргуулна. Нийтийн эрх ашгийг Хууль зүйн яамнаас олон улсын хэмжээнд юу гэж тодорхойлдог вэ гэсэн хоёр гурван тодорхойлолт байдаг юм. Түүнийгээ тэр нийтийн эрх ашиг гэдэгтээ оруулаад өгөхгүй бол энэ чинь өөрөө нөгөө хөрөнгө оруулагчдад public interest – нийтийн эрх ашиг гэдгийн дор гэсэн сэжиг төрүүлэх бас нэг заалт байна лээ шүү гэдгийг бас би түрүүн мартчихаж. Ерөнхийдөө бол миний хэлсэн саяын асуултууд маань дандаа санал байсан шүү. Яагаад гэвэл, би дэгээ зөрчихгүйн тулд асуулт хэлбэрээр хэлээд байгаа юм. Дандаа санал шүү.

### **УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлийн шаардлагын дагуу УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн мэдээлэл, судалгааны тайланг хэлэлцжээ**

*2013 оны 9 дүгээр сар 24-ны Эдийн засгийн байнгын хорооны хурлын тэмдэглэлээс: “Монгол Улсын эдийн засгийн гадаад, дотоод орчин, хөгжлийн явц байдалд судалгаа дүгнэлт хийх, цаашид баримтлах чиг хандлага, даруй авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох” үүрэг бүхий Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн мэдээллийг хэлэлцэх үеэр:*

Монгол Улсын эдийн засгийн гадаад, дотоод орчин, хөгжлийн явц байдалд судалгаа дүгнэлт хийх, цаашид баримтлах чиг хандлага, даруй авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох үүрэг бүхий Улсын Их Хурлын

даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн мэдээллийг сонслоо. УИХ-ын даргын 2013 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг болон дэд хэсгээс холбогдох яамдын асуудал хариуцсан газар, хэлтсийн дарга, мэргэжилтнүүд болон эрдэмтэн, судлаачдын оролцоотойгоор “Монгол Улсын эдийн засгийн гадаад, дотоод орчин, хөгжлийн явц байдалд хийсэн судалгаа, цаашид баримтлах бодлогын асуудлууд” гэсэн судалгааг өнгөрсөн 5 дугаар сарын байдлаархи мэдээлэлд тулгуурлан хийжээ. Судалгааны явцад ажлын хэсэг 3 удаа, ажлын дэд хэсэг 10 удаа хуралдаж, гишүүдийн санал болон нэмэлт мэдээллийг тусган Эдийн засгийн байнгын хороонд танилцуулахаар бэлтгэсэн боловч цаг хугацааны хувьд хэлэлцүүлэх боломжгүй болсон тул ажлын хэсгийн гишүүд болон УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлийн хүсэлтийн нь дагуу уг судалгааны тайлантай таницлах боломж олгосон гэдгээ байнгын хорооны дарга В.Гарамгайбаатар хэллээ.

Судалгааны үр дүнд УИХ-ын даргын захирамж, судалгааны удирдамжид заасан чиглэлийн дагуу Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тухайн үеийн байдал /энэ оны 5 дугаар сар/-д үнэлгээ хийж, өнөөгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэж болзошгүй тулгамдсан асуудлууд болон бодитой шалтгаанууд байгааг 5 чиглэлээр гаргаж Засгийн газарт хүргүүлсэн юм байна. Тухайлбал,

**Улс орны эдийн засгийн гадаад орчин, гадаад харилцаа чиглэлээр:**

- Эдийн засаг бүхэлдээ уул уурхай, импортоос хэт хамааралтай, зэс, нүүрс, төмрийн хүдрийн дэлхийн зах зээлийн үнэ төдийлөн өсөхгүй, экспортын хэмжээ буурах зэрэг эрсдлээс шалтгаалан эдийн засагт цэвэр дүнгээр орж ирэх валютын хэмжээ буурч, улмаар гадаад худалдааны алдагдал нэмэгдэж болзошгүй;

- Урсгал дансны алдагдал тогтмол өндөр, бууралт ажиглагдахгүй байгаа нь дотоодын эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлж, санхүүгийн тогтворгүй байдлыг үүсгэж болзошгүй; Урсгал дансны алдагдалтай зэрэгцэн, гадаад өрийн түвшин нэмэгдэж байгаа нь урт хугацаандаа эдийн засгийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай;

- Монгол Улсын олон улсын зээлжих зэрэглэл буурсан;

- Манай улсын эдийн засаг цөөн тооны зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай байгаа нь бодит хүндрэл дагуулж, БНХАУ-тай хөгжүүлж буй худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа хэт давамгайлж байгаа

- Сүүлийн үед гуравдагч хөрш орнуудын дунд манай хөрөнгө оруулалтын орчин тогтворгүй, эрсдэлтэй болсон гэсэн ойлголт бий болсон.

**Эдийн засагт нөлөө бүхий томоохон төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн тухайд:**

- Монгол Улсын уул уурхайн салбар нь дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангах гол хүчин зүйл болж байгаа хэдий ч уул уурхайн салбарыг цаашид хөгжүүлэхэд тэвэр, эрчим хүч, ус хангамж зэрэг дэд бүтцийн асуудлыг одоог хүртэл шийдээгүй байгаа нь хүндрэл үүсгэж байна;

- Уул уурхайн салбарт хийгдэж байгаа борлуулалтын болон хөрөнгө оруулалтын гэрээнүүдтэй холбоотой асуудлууд ихээр гарч, тэдгээрийг сайжруулах чиглэлээр ажиллахад олон хүндрэл учирч, үүнээс шалтгаалж төслийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх үзэгдэл цөөнгүй гарч байна;

- Томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд хөрөнгө санхүүгийн нөөц маш их шаардлагатай байгаа тул хуваарилалтыг оновчтой хийх;

- Хөрөнгө оруулалтын төслийн судалгаа, тооцоо, зураг төсөв муу хийгдэж байгаагаас хөрөнгө оруулалтын төлөвлөлт алдаатай болох, хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үзэгдэл гарч байна;

- Уул уурхайн томоохон ордуудыг түшиглэсэн төмөр замын сүлжээ одоог хүртэл баригдаж эхлээгүй байгаагаас гадна одоогийн сүлжээ ачаа нэвтрүүлэх хүчин чадал бага, төмөр замын суурь бүтэц эзэмшигчдийн зүгээс тээвэрлэлтэд тавьдаг хориг саад их, төмөр замын тээврийн тарифын бодлого, тогтолцоо төлөвшөөгүй, үндсэндээ төмөр замын тээвэрлэлтийн үйл явцыг нарийн зохицуулсан эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй байна

#### **Гадаадын шууд хөрөнгө оруулалтын тухайд:**

- Монгол Улс руу чиглэсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт 2000 оноос аажмаар өсөх хандлагатай явж ирсэн боловч дэлхийн болон бүс нутгийн хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан, Монгол улсад орж ирж байсан уул уурхайн томоохон төслүүдийн хөрөнгө оруулалтын үе шат дууссан, эрх зүйн орчинд өөрчлөлт оруулсан зэрэг тодорхой шалтгааны улмаас 2012 оноос буурч эхэлсэн;

- Гадаадын хөрөнгө оруулагчдыг татах тал дээр ихээхэн хүчин чармайлт гаргаж байгаа хэдий ч хариуцлагагүй үг, үйлдэл, мэдээлэл буруу ойлгогдож байгаа зэргээс шалтгаалан хөрөнгө оруулалтыг үргээх явдал гарч байна;

- Гадаадын шууд хөрөнгө оруулалтын бүтэц ихээхэн ерөөсгөл, нийт шууд хөрөнгө оруулалтын 85 орчим хувь нь уул уурхайн салбарт оногдож байгаа нь улсын эдийн засаг, экспорт нь цөөн нэр төрлийн бүтээгдэхүүнээс хамаарсан бүтэцтэй болсныг харуулж байна;

- Манай Улсад хөрөнгө оруулалтыг дэмжсэн, урамшуулсан эсхүл хөнгөлөлт олгосон эрх зүйн цэгцтэй орчин бүрдээгүй, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг шаардлагатай салбар, үйлдвэрт болон хөдөө орон нутагт ялгавартай татах “урамшууллын” тогтолцоо байхгүй;

- Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих стратеги, хууль эрх зүйн орчныг сайжруулах, гадаадын хөрөнгө оруулалт нэн шаардлагатай салбар, бүс нутагт оруулах хөрөнгө оруулалтыг урамшуулах тогтолцоог бий болгох.

#### **Макро эдийн засгийн байдлын хувьд:**

- 2012 онд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт болох төлбөрийн тэнцэл, төсвийн алдагдал өмнөх жилүүдэд байгаагүй өндөр түвшинд хүрсэн нь мөчлөг дагасан төсвийн бодлого, ирээдүйн экспортын орлогоо барьцаалж авсан богино хугацаатай зээлээр санхүүжүүлсэн нийгмийн хавтгайрсан халамж буюу бэлэн мөнгө тараалт, гадаад секторын эрсдэлд өртөмтгий эмзэг байдал, эрдэс баялгийн салбараас хэт хараат байдал зэргээс шалтгаалсан.

- Эдийн засгийн өсөлт 13-16 хувь өсөхөөр байгаа боловч эдийн засгийн тодорхойгүй байдал давамгайлж байгаагаас эдийн засгийн төлөв нэлээд тогтворгүй байна.

- Сүүлийн 3 жилд уул уурхайн салбарын өсөлтийн улмаас гадаад худалдааны эргэлт ДНБ-ий хэмжээнээс давж, экспортын орлогын 93% -ийг эрдэс бүтээгдхүүний орлого бүрдүүлэх болсноор манай эдийн засаг гадаад гэнэтийн шоконд улам өртөмтгий болж байна.

- Бондын хөрөнгийг ашиглан хэрэгжүүлэх томоохон төслүүдийн хувьд төлөвлөлтийн бэлтгэл ажлыг хангаж, техник эдийн засгийн үнэлгээ хийхэд хугацаа шаардлагатай байгаа тул их хэмжээний хөрөнгө оруулалт түрүүлж

гарах магадлал бага байна. Өсөлтийн хурдац эдийн засгийн үйлдвэрлэх хүчин чадлаас түрүүлж байгаа учраас Чингис бондын эх үүсвэрээр улсын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг нэмж санхүүжүүлэх нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг шахаж, эдийн засгийн өсөлтөд үзүүлэх үр нөлөө нь хязгаарлагдахын зэрэгцээ инфляцийн дарамт үүсгэж болзошгүй.

- Төсвийн бодлого байнга тэлж, мөчлөг дагасан шинжтэй байгаа нь эдийн засаг тууштай, тогтвортой өсөхөд эрсдэл болсон хэвээр байна. Төсвийн алдагдал ихээр хуримтлагдаж эхэлсэн энэ үед эрдэс баялагийн зах зээл дээр гэнэтийн цочрол үүссэн тохиолдолд Сангийн яам асуудлыг зохицуулан шийдвэрлэх боломж хязгаарлагдмал байна;

- Нөгдсөн төсвийн орлогын хэт өндөр төсөөлөл, гадаад орчны таагүй орчноос шалтгаалж тасарсан тохиолдолд төсвийн алдагдал 6-8 хувь болох магадлалтай байна. Энэ нь өндрөөр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө тасрах эрсдлийг дагуулж байна.

- Үнэ тогтворжуулах хөтөлбөр, Хөгжлийн банкны санхүүжилт, мөн Чингис бондын зарцуулалт төсөвт дарамт учруулахаар байна.

- Тогтворжуулалтын санд хангалттай хэмжээний эх үүсвэр бүрдээгүй байгаа нь түүхий эдийн бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэлээс хараат хэвээр байгааг харуулж байна.

- Санхүүгийн зах зээлийн тэнцвэрт байдал алдагдсан, банкны салбар хэт давамгайлсанаас санхүүгийн зах зээл нь эдийн засгийн эрчимт өсөлтөө гүйцэлгүйгээр саад тотгор болох төлөв ажиглагдаж байна.

- Валютын захыг хямралаас сэргийлэх үндэсний механизмыг бий болгох шаардлагатай болж байна.

- Эдийн засгийг хямралаас хамгаалахын тулд дотоодын эдийн засгийн хүчин чадлыг нэмэгдүүлж, салбар, гадаад худалдаа, валютын урсгалыг тэнцвэржүүлэх шаардлагатай.

- Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээр дамжуулан эдийн засагт оролцож буй төрийн оролцоо өндөр үр ашиг харьцангуй бага, менежмент сул байна гэж дүгнэжээ.

Мөн бусад асуудлын хүрээнд байгаль орчин, ногоон хөгжил, эрүүл мэнд, ядуурал, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлого, худалдан авах үйл ажиллагаа, эдийн засаг дахь төрийн оролцоо зэрэг асуудлуудыг авч үзсэн байна.

Дараа нь Ажлын хэсгийн мэдээлэл, судалгааны тайлантай холбогдуулан олон гишүүд асуулт асууж, үг хэлсэн бөгөөд УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл ажлын хэсгийн дүгнэлт, судалгааны тайлантай холбогдуулан Засгийн газраас санал авахгүйгээр 3-5 байнгын хорооны хамтарсан тогтоол гаргаж цаашид хийж хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Засгийн газарт чиглэл өгөх нь зүйтэй байна гэсэн санал хэлж байв. Ажлын хэсгийн мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж тодруулсан гишүүдийн ихэнх нь энэ мэдээлэл, судалгааны тайланг эргэн хэлэлцэж байсан юм, гэхдээ хожуу ч гэлээ, С.Дэмбэрэл гишүүний шаардлагын дагуу хэлэлцэж улс орны эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд дүгнэлт өгч байгаа нь чухал юм гэдгийг онцолж байлаа.

**С.Дэмбэрэл:** - Энэ Ажлын хэсгийн хийсэн зүйлийг монгол улсын өнөөгийн түвшинд ерөнхийдөө болсон гэж үзэж байгаа. Эндээс өөр юм гарч чадахгүй байна. Гэхдээ энэ маань үүнийг хийсэн хүмүүсийн хөдөлмөрийг үгүйсгэж байгаа хэрэг биш. Өнөөгийн монголын эдийн засгийн бодлогын байгаа сэтгэлгээний түвшинд иж бүрэн хийгдэж чадсан гэж би үзэж байгаа юм. Гэхдээ дутагдал байгаа. Тэр дутагдалыг хэлье.

Монгол улсын эдийн засгийн гадаад дотоод анализыг их өргөн хэмжээнд, Ялангуяа УИХ-ын гишүүдээс тухайн үед санал болгож байсан зүйлүүдийг бүгдийг нь аваад, сүүлийн жилүүдэд манайд мартагдсан шинжилгээнүүдийг сэргээж хийгээд, эдийн засгийн сэргэлт төдийгүй, хөгжлийн асуудлуудыг гаргаж тавьсан ийм сайн, иж бүрэн, анхны оролдлого гэж хэлж болно. Гэхдээ, яг иймэрхүү юман дээр гардаг, ялангуяа түгээмэл дутагдал байдаг нь цаашид юу хийх вэ гэдэг асуудлыг гаргаж ирэх тал дээр их үлбэгэр болсон. Үлбэгэр гэдэг нь бид энэ асуудлыг хэлэлцээгүйтэй холбоотой. Ажлын хэсгийнхэн дэд хэсгүүдээс орж ирсэн материалууд дээр анализ хийгээд, цаашид юу хийх вэ гэдгийг тэр хүмүүсээр хийлгэчихээд тэрнийг нь Засгийн газарт өгсөн байсан. Гэтэл тэр хийсэн юмыг нь үзсэн чинь, Засгийн газар 30 хоног болж байж хийсэн гэхэд маш сул зүйл болсон байсан. Сайн материал өгчихөөд байхад, тэрэн дээр цаашид авах бодлогын чиглэлүүдийг 5 төрлөөр нь маш оновчтой бөгөөд бодит амьдрал дээр, богино болон дунд хугацаанд хийх тийм арга хэмжээнүүдтэй нь хийх шаардлагатай байна. Энэ одоо дутагдаж байна. Гэхдээ *Ажлын хэсгийн гишүүний хувьд, өөрөө сайн дураараа цүрэг аваад, одоогийн байдлаар тэр дутагдаж байгаа зүйлийг чинь 14 хуудсанд багтаагаад 65 заалттайгаар хийчихсэн байгаа. Энийг уншаад, энүүнтэй маргалдах хүн байвал гараад ирээрэй. Өөрөөр хэлбэл өнөөдрийн энэ Монгол улсын эдийн засагт тулгарч байгаа валютын ханшаас авахуулаад, төрийн оролцоо зэрэг бүх зүйлүүдэд нь тодорхой хариулт, цаашид яах ёстойг нь хэлчихсэн байгаа.* Бид ийм л юм хүсч байгаа. Ийм юм хүсээд, ийм юм хийлгэх гэхээр хангалттай бус байна. Яагаад гэвэл, жишээлбэл өнөөдөр тэр Засгийн газарт өгчихсөн юм хаа нэгэн газар, сайдын ширээн дээр хэвтэж байж магадгүй юм. Өөрөөр хэлбэл УИХ-аас гаргасан тэр баримт бичгийг хүлээн авах, тэрэнд хүндэтгэлтэй хандах, эргэж хариу урвал үзүүлэх ийм байдал ерөнхийдөө их суларчихсан юм байна. УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо гэдэг бол энэ улсын эдийн засгийг бодлогыг тодорхойлж, анхаарч байдаг төрийн хамгийн том институци юм. Энэ институцээс гаргасан бодлогын баримт бичиг бол бараг л хуулийн хэмжээнд маш хүндэтгэлтэй бөгөөд, маш анхааралтай судлагдаад, маш яаралтайгаар энэ Засгийн газар эргүүлж хариулах ёстой. Энэ чиглэлийн юм нь байхгүй учраас бид өнөөдөр зүгээр л мэдээлэл сонсоод сууж байна. Энэ мэдээллийн дагуу цаашдаа УИХ-ын тогтоол гарах ёстой гэж ярьж байна. Гэтэл тогтоол гаргах асуудал чинь бас хүндрэлтэй. Намрын ээлжит Чуулганаар хэлэлцэх асуудалд чинь энэ ороогүй байна. Тэгэхээр аягүй бол Эдийн засгийн байнгын хорооны тогтоол л сайндаа гарна. Гэтэл байнгын хорооны тогтоолыг ямар хэмжээнд авч үздэг вэ? Үнэнийг ний нуугүй ярьцгаая. Нэг их тоодоггүй юм байна лээ. Ийм тохиолдолд ганцхан арга үлдэж байгаа нь Засгийн газраас үүнд санал авах шаардлагагүй. Засгийн газраас санал авбал УИХ-ын тогтоол гаргахгүй болно. 5 байнгын хорооны хамтарсан тогтоол гаргаж, яг хийх ёстой зүйлүүдээ Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яам, бүх засгийн газрын байгууллагууд, УИХ-ын байнгын хороод өөрсдийн хийх ёстой зүйлээ мэдэж авах хэрэгтэй. Энэ бол хоосон чалчаа үг биш. Хэрвээ бид эдийн засаг хүндрэлтэй байна, хүндрэлгүй байна гээд маргаад байх юм бол цаг дуусахгүй. Хүндрэлтэй байна гэдгийг гудамжинд гараад асуу. Хүндрэлгүй байна гэж хэлэх гэж байгаа бол хацар дээрээ алгадуул. Ийм л бодит амьдрал байгаа. Эдийн засгийн макро үзүүлэлтүүд дээр өсөлт байгаа нь үнэн. Гэхдээ эдийн засгийн өсөлтийг ард түмэн дээр мэдрэгддэг болгохын тулд өнөөдөр бид эдийн засгийн бодлого дээрээ засвар өөрчлөлт



оруулах шаардлагатай байгаа юм. Ямар өөрчлөлт оруулах гэдэг нь уг нь миний боловсруулсан санал дээр байж байгаа. Тэгэхээр би ер нь ийм юм боловсруулсаны хэрэг байна уу? Би Засгийн газрыг өөрийнхөө ажилтан гэж үзээд даалгавар өгөх гэж байгаа бол ажилтныхаа үгийг сонсоод, өөрийнхөө шийдвэрийг бие дааж гаргадаг байх учиртай. Гэтэл дэгийн тухай тэр сонин хуулиар би Н.Батбаяр сайд болон Засгийн газарт үүрэг өгөхдөө, эргээд Батбаярын саналыг авч, эдний даалгавараар шийдвэр гаргана гэж ер нь юу байдаг юм бэ? Хэзээ ингэж удирдаж байсан юм бэ? Ийм тохиолдолд УИХ-ын 5 байнгын хороо, эсвэл 3 нь хамтарсан тогтоол гаргах хэрэгтэй. Одоо энэ Монгол улсын эдийн засгийн гадаад дотоод байдлын талаар гаргасан бидний санал дүгнэлтийг энэ намар УИХ-аар хэлэлцэхгүй юм байна. Надад тэгж ойлгогдлоо. Тэгэхээр одоо сүүлчийн арга хэмжээ бол Эдийн засгийн байнгын хорооны тогтоолыг бусад байнгын хороод, тухайлбал, Төсвийн байнгын хороо, Байгаль орчины байнгын хороо, төрийн байгуулалтын байнгын хороо, тэр байтугай Аюулгүй байдлын байнгын хороо оролцож хамтрах хэрэгтэй. Яагаад гэвэл, монгол улсын эдийн засгийн гадаад бодлого /гадагшаа харсан цонх/ энд тэнд хийгдэж байна гэсэн дүгнэлт бидний судалгаагаар гарсан байгаа. Валютын ханшин дээр ярьж. Энэ засгийн газар валютын ханшийг тогтоон барина гэж ярьж байгаа. ЯАЖ? Валютын ханшныхаа дэглэмийг мэдэхгүй байгаа улс шүү дээ. Төв банк чинь өөрсдөө мэддэггүй. Энд сууж байгаа хүмүүсээс асуухад тодорхойлж мэдэх хүн хэн байна? Түрүүн О.Чулуунбат нэг юм хэлсэн. Буруу юм ярьж байна лээ. Ямар дэглэмтэйг нь өөрсдөө мэдэхгүй байж, тэр нь хууль эрх зүйн хүрээндээ гараагүй мөртлөө валютын ханшийг тогтворжуулна гээд байх юм. Валютын ханш манайх шиг иймэрхүү нөхцөлд ингэж чангарч сулрахараа хэзээ ч эргэж нөхөгддөггүй. Энэ нь инфляцид шингээд явчихдаг. Ийм л юм болж байна. Энэ тохиолдолд бид нэгдүгээрт валютын ханшныхаа дэглэм, хоёрдугаарт бэлэн байх арга хэмжээнүүдийг авах ёстой. Тэгж байж бид цаашдынхаа арга хэмжээнүүдийг тодорхойлно. Үүн дээр 10 санал байна. Зөвхөн эдийн засгийн гадаад харилцаан дээр 10 санал байна. Энэ мэтээр дүгнэлт гаргаж, санал сонсож, тодорхой арга хэмжээнүүдийг авах ёстой. Тэгэхээр одоо 3-5 Байнгын хорооны хамтарсан тогтоол гаргая. Энэ тогтоолын талаар Засгийн газраас асуух шаардлагагүй. Яагаад гэвэл бид Засгийн газарт ус болох гэж байгаа биш, тус болох гэж байгаа. Эсвэл энэ боловсруулсан зүйлээ сонинд хэвлүүлчихье. Анхаарал тавьсанд баярлалаа.

### **Байгальд ээлтэй технологи, тогтвортой ажлын байр хэрэгтэй**

**Л.Энх-Амгалан гишүүн:** “Байгаль орчны үнэлгээ хийх шаардлагагүй салбарт, тухайлбал харилцаа холбооны салбарт хөрөнгө оруулахад заавал үнэлгээ хийлгэх ёстой юу?”

**Ажлын хэсгийн ахлагч С.Дэмбэрэл:** Бүх технологид байгаль орчны үнэлгээ хийгдэнэ. Шаардлагагүй салбар гэж байхгүй. ИТ-д хүртэл байна. Би эртээд хэлж л байсан даа. Та нар асуугаад, би хариулсан шүү дээ. Байгаль орчинд ээлтэй технологи гэж тодорхойлдог. Л.Энх-Амгалангийн хэлж байгаа салбарт байгаль орчны ерөнхий үнэлгээ хийлгэх шаардлагагүй байхад, тухайн оруулж ирж байгаа технологи нь өөрөө байгаль орчинд ээлтэй байх олон улсын стандарт буюу байгаль орчинд хор хөнөөлгүй байх стандартыг ханчихсан байхад л болох юм байхгүй юу. Энэ дээр ерөнхий

үнэлгээ хийж, мөнгө төлөх хэрэг байхгүй. Тийм учраас байгаль орчны ерөнхий үнэлгээ шаардлагатай тохиолдолд энэхүү үнэлгээг хийлгэсэн байх ёстой ба технологи нь байгаль орчинд ээлтэй байх ёстой, өөрөөр хэлбэл ногоон технологи байх ёстой гэсэн үг юм шүү. Тийм шаардлага хангасан технологи гэдгээ л тодорхойлсон байх хэрэгтэй.

Харин шинээр ажлын байр бий болгох гэдэг дээр анхаарах ёстой зүйл байна. Монгол улсад байхгүй цоо шинэ ажил мэргэжлийг бий болгох гэж л тодорхой ялгаж оруулахгүй юм бол үүнийг хасах хэрэгтэй. Эс тэгвэл ийм ерөнхий юм ямар ч хэрэггүй. Сая бид эндээ ярьж байгаад тогтвортой ажлын байр гэж оруулчихвал яасан юм бэ гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл түр ажлын байр биш, ажилчдаа түр зуур майханд суулгаж байгаад ажиллуулдаг биш гэсэн үг. Ерөнхийдөө тогтвортой гэдэг маань олон улсын хэмжээнд хамгийн их хэрэглэгддэг, хөдөлмөрийн байгууллагуудын тодорхойлдог тэр байнгын, урт хугацаагаар ажиллах ажлын байрыг л зааж өгөх хэрэгтэй.

### **Хүний хөгжилд зориулсан ямар хөрөнгө оруулалт төлөвлөж байна вэ?**

*2013 оны 10 дугаар сарын 10-ны УИХ-ын Нэгдсэн Чуулганы хуралдааны тэмдэглэлээс:*

*Монгол Улсын 2014 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн тухай хэлэлцэх цээр УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлийн тавьсан асуулт:*

1. Эхний асуултаа Сангийн яамнаас асуух гэсэн юм. Энэ оруулж ирсэн материалууд дээр татварын ачаалал 1,8 функтээр нэмэгдчихсэн юм шиг байх юм. Татварын ачаалал яагаад нэмэгдэв гэсэн эхний асуулт байна.

2. Дараагийн асуултыг мөн Сангийн яамнаас асууж байна. Валютын ханшны тооцоог жилийн эцэст хэд байхаар тооцсон бэ гэсэн хоёрдугаар асуулт байна.

3. Н.Батбаяр сайдаас асууя. Дотоодын нийт бүтээгдхүүний дефляторийг тооцсон уу? Дотоодын нийт бүтээгдхүүн ба хэрэглээний индекс, үнийн индекс хоёрын зөрүү хэд байгаа вэ? Үүнийг ямар тооцоогоор авсан бэ?

4. Ерөнхий сайдаас асууя. Ерөнхий сайд бол тогтвортой байдлын үндэсний хороог удирддаг. Эдийн засгийн хөгжлийн бодлого маань тогтвортой хөгжил гэдэг руу орсон. Та өөрөө үүнийг хариуцдаг. Тэгэхээр та, тогтвортой хөгжлийн талаар, эдийн засгийн хөгжлийн бодлого дээр 2014 онд хийх ямар шинэ ахиц, ямар хөрөнгө оруулалтыг тогтвортой хөгжил гэдэг талаас нь бодлогын хувьд оруулж өгсөн бэ?

5. Сангийн яамнаас асууя. Ч.Хүрэлбаатар гишүүн бас асуусан, мөнгөний ба төсвийн бодлогын хоорондын уялдааг ямар замаар, хэдэн удаа Төв банктайгаа уулзаж, протокол хөтлөн оруулж ирсэн бэ? Үүнийгээ тодорхой хэлж өгнө үү.

6. Ерөнхий сайд болон Сангийн яамнаас хоёулангаас нь асуух хоёр зүйл байна. Монгол улс хувьчлал хийх үү? Ялангуяа төсөв дутагдаж байгаа одоогийнх шиг ийм үед чухал хэрэгтэй байдаг хувьчлал хийгдэх үү? Хувьчлал хийгдэх бол нийт төсөвт хувьчлалын орлого хэдээр туссан бэ?

7. Мөн сангийн яамнаас нэмж асууя. Эдийн засгийн бүх секторуудад олгож байгаа нийт татаасын хэмжээг тоогоор нь нэрлэж өгнө үү.

8. Эцсийн асуулт, эдийн засгийн хөгжил гэж яриад байгаа хэрнээ нэг юм мартагдчихаад байх юм. Тэр нь маш бага үнийн дүнтэй яваад байна. Эмнэлэг сургуулиас бусад, хүний хөгжилд зориулсан ямар хөрөнгө оруулалт төлөвлөж байна вэ? Ялангуяа ядууралыг ямар хувиар бууруулах гэж байна вэ? С.Эрдэнэ сайдын хариуцсан салбарын төсөвт үүнийг яаж тусгаж өгсөн юм бэ? Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих гэж хичнээн хэмжээний, төсвийн ямар механизмыг яаж тусгасан юм бэ? гэсэн асуултууд байна.

**Сангийн дэд сайд С.Пүрэв:**

- С.Дэмбэрэл гишүүний эхний асуулт, татварын ачаалал нэмэгдсэн талаар хариулъя. Дотоодын нийт бүтээгдхүүний өсөлтөнд татварт нөлөө бүхий уул уурхайн салбарын өсөлт нь түрүүлж өсч байна. Үүнтэй уялдан татварын ачаалал нэмэгдсэн харагдаж байгаа боловч татварын хувь хэмжээ нэмэгдэж, татварын ачаалал нэмэгдээгүй, хэвээрээ байгаа. Өөрөөр хэлбэл, бүтцийн өөрчлөлтөөс хамаарч өөрчлөгдсөн.

- Төсөвт валютын ханшыг 1384 төгрөгөөр авч тооцсон. 1384 бол жилийн дундаж ханш байгаа юм.

- Өмч хувьчлалын орлогоор 26 тэрбум төгрөг орохоор ирэх жилд төлөвлөсөн байгаа.

**Н.Батбаяр:**

- Бизнесийг дэмжих, бодит салбарыг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх гэдэг бол мэдээж хэрэг, бидний тавьж байгаа гол зорилго. Тэр хүрээндээ, та бүхэн анзаарч байгаа бол, урьд жилүүдэд төсвийн хууль орж ирэхэд заавал татварын хууль хамт орж ирдэг байсан. Ноднингоос эхлээд, төсвийг батлахад тавар нэмэгдүүлэх, өөрчлөхтэй холбоотой зүйл оруулж ирэхээ больсон. Энэ жил бас тэр дагуу орж ирж байна. Ер нь бид татвар дээр илүү тогтвортой бодлого баримталж байгаа. Тэр ч утгаараа хөрөнгө оруулалтын хуулийг баталж, түүн дотроо гол 4 татвар болох болох аж ахуйн нэгжийн орлогын татвар, гаалийн татвар, нэмүү өртөгийн татвар, ашигт малтмалын нөөц ашигласны татварыг тогтворжуулах асуудлуудыг тусгасан.

- Өрхийн бизнес дэмжих хүрээнд бид үндсэндээ жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор гол нь бизнесийн таатай орчин бүрдүүлэх, түүн дотроо томоохон төсвийн худалдан авалтуудыг жижиг бизнесээр дамжуулан хийдэг энэ тогтолцоог бий болгох тал дээр анхаарал хандуулна гэж үзэж байна. Тухайлбал, батлан хамгаалах салбар, Хилийн цэрэг, Шүүхийн шийдвэр биелүүлэх газар зэрэгт хийгдэж байгаа багагүй худалдан авалтуудыг бид жижиг бизнесээр дамжин хийх асуудлыг шийдвэрлэх цаг болсон гэж үзэж байгаа юм. Эс тэгвэл бид одоо голдуу урдаас импортоор юм оруулж ирээд, худалдан авалт хийгээд байна. Үүнийгээ бид арай өөрөөр зохион байгуулдаг болъё гэсэн хандлага бий. Энэ нь зохион байгуулалтын холбоотой асуудлаар илүү хөндөгдөнө. Нөгөө талдаа, бизнесийг дэмжих гэсэн утгаараа экспортыг дэмжих хөтөлбөр саяхан батлагдсан. Тэр хүрээндээ экспортонд гаргах, импортыг орлох бизнесийг дэмжих гэсэн үндсэн чиглэл рүү хандаж байгаа. Тэр хүрээндээ ойрын үед 1 тэрбум доллартай тэнцэх хэмжээний хөрөнгийг энэ салбарт чиглүүлнэ гэж үзэж байна. Энэ бол хөгжлийн банкны шугамаар хийгдэх ажил болно.

- Дотоодын нийт бүтээгдхүүнтэй холбоотой асуудлыг аваад үзэхэд, ерөнхий бид том утгаараа аваад үзвэл, жил болгон бид 2 оронтой тооны өсөлттэй байна. Энэ онд ч бас 2 оронтой тооны өсөлттэй гарна. Ингэснээр

бид зах зээлийн харилцаанд шилжсэн 20 гаруй жилийн хугацаанд 5 дахь удаагаа 2 оронтой тооны өсөлттэй явах гэж байгаа хэрэг юм. Дараалсан 3 дахь жилдээ ДНБ ийм өндөр үзүүлэлттэй гарах гэж байна. Цаашдаа ч гэсэн энэ өсөлтийг хангаж явна. Тэр хүрээндээ үүнийхээ цар хүрээ, өгөөжийг дээшлүүлэхтэй холбогдсон асуудлуудыг анхаарч явна. Тэр дотроо үйлдвэржүүлэлтийн хэсэг дээр түлхүү анхаарсан бодлогыг тусгасан байгаа.

- Мөн орон нутагт илүү эрх мэдэл өгөх, илүү бодит бүтээн байгуулалтыг хийх бололцоог орон нутагт, тэр тусмаа хувийн хэвшлийнхэнд өгье гэсэн утгаар нь ажиллаж байна. Тэр хүрээндээ эдийн засгийн хөгжлийн багц хууль гэж орж ирнэ. Түүн дотор бид өнөөгийн дагаж мөрдөгдөж байгаа тендерийн хууль, концессийн хууль, төсвийн тухай хууль болон бусад хуулиудыг өөрчлөхөөр оруулж ирнэ.

### **Амьдралаас тасархай дүнгээр ирэх оныхоо төсвийг тооцоолоод явж болдог юм уу?**

*2013 оны 10 дугаар сарын 11-ны УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс:*

*Монгол Улсын 2014 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн тухай хэлэлцэх цед УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл-ийн хэлсэн санал:*

Өнөөдөр энд Ерөнхий сайд болон дөрөвхөн хүн л сууж байх юм. Уг нь бусад сайдууд нь бүгд ирвэл зүгээр л юм. Энийг их анхаармаар юм. Өчигдөр ярайтлаа сууж байсан хүмүүс алга болчихсон байна. Асуудалд хандаж байгаа хандлага нь ийм байж болмооргүй байх юм. Өчигдөр ямар ёслолын өдөр байсан биш. Ажил хэрэг ярьж байна шүү дээ. Эндээ ядаж, дүүрэн сууж л байх ёстой шүү дээ. Ер нь манай байдал нэг иймэрхүү л байгаа юм.

- Эхний асуудал, өчигдөр би 6 асуулт асуусан. Яг үнэндээ 6 асуултандаа хариу аваагүй. Би үнэндээ, хариу авна ч гэж нэг их хүлээгээгүй. Одоо бид төсвийн хариуцлагын асуудлыг ярилцаж байна. Гэтэл та нар төсвийн хариуцлагын хууль энэ тэр гээд яриад байгаа боловч, дотоодын нийт бүтээгдхүүний дефицит /алдагдал/ 2 хувь байгаа боловч дотроо улаан цайм, маш хариуцлагагүй байна шүү дээ. Жишээлбэл, өчигдөр, валютын ханшийг хэд байхаар тооцоолсон бэ гэж асуухад л одоо байгаа валютын ханшнаас хо зөрүүтэй бүр энэ оны эхэнд байсан тэр ханшийг хэлж байх жишээтэй. Үнэн хэлсэн үү, үгүй юу? 1,384 төг гээд хэлчихэв үү? Ийм амьдралаас тасархай дүн аваад, тэрүүгээрээ 2014 оны /ирэх оны/ төсвийг тооцоолоод явна гэж ер нь байдаг юм уу, энэ улсад чинь?

- Дээр нь, татварын ачаалал нэмэгдчихлээ, татварын нийт орлого, дотоодын нийт бүтээгдхүүний харьцуулсан харьцаа /тоон дээр чинь/ нэмэгдчихсэн байна гэхэд нэмэгдээгүй гээд нэгдүгээр ангийн хүүхдээс дор юм ярьж байна. Энэ одоо юу болж байгаа юм бэ? Энийг цаашдаа нэг анхаарахгүй бол болохгүй нь.

- Өчигдөр би Дотоодын нийт бүтээгдхүүний дефлятор гэж асуусан. Дефлятор гэж! Өөрөөр хэлбэл нэрлэсэн ба бодит Дотоодын нийт бүтээгдхүүний

зөрүү болон хэрэглээний үнээр тооцсон инфляци хоёрын зөрүү хэд байна гэж асуусан чинь хэлдэг хүн байхгүй байх юм. Тэр Н.Батбаярын яриад байгаа дээд зэргийн тооцоо нь хаана байгаа юм бэ? Тийм сайн тооцоо, хариуцлагатай төсөв хийж ирсэн л юм бол үүнийгээ батлаач. Та бүхэн санаж байгаа байх. Би тухайн үедээ Ч.Улаан сайдаас 2014 онд махны үнэ хэд байх вэ хэмээн жаахан ёжтой асууж байсан. Үүгээрээ би юу хэлж байсан бэ гэвэл, энэ тооцоонууд чинь үндэслэл муутай байна шүү гэдгийг л илэрхийлж байсан юм.

- Дараа нь мөнгө төсвийн бодлогын уялдаа яаж хангагдсан бэ, хоорондоо хэдэн удаа уулзаж ярилцсан юм бэ, юуг хэрхэн тохиролцсон бэ гэдгийг асуусан чинь байдаггүй ээ. Иймэрхүү байдалтай л байна.

- Хүмүүс дотоод, гадаад өрийн асуудлыг ярьж байна. Энэ бол ярих л ёстой асуудал. Хэмжээнээсээ ихэдсэн, зөвхөн тооны хувьд биш, ерөнхийдөө дарамт нь маш их байна шүү дээ. Төсвийн үүсэл, өрийн үйлчилгээний асуудал их дарамттай болж эхэлж байна.

- Хувьчлалын орлогыг асуусан чинь 26 тэрбум гэж хэлсэн. Энэ улсад чинь хувьчлал хийхээ больчихсон юм уу? 2000 оны өмнө хойно явагдаж байсан хувьчлалууд яасан бэ? Тэгсэн мөртлөө улсын үйлдвэрийн газрууд нь алдагдал хүлээгээд байдаг. Ийм тохиолдолд хувьчлал яагаад явуулахгүй байгаа юм бэ? Хувьчлалыг оруулж ирмээр байна. Тэгж байж төсөвтөө нэмэлт орлого хийнэ. Энэ чинь нэмэлт орлогын асар том эх үүсвэр болно шүү дээ.

- Өчигдөр албан бус секторын асуудлаар Н.Батцэрэг гишүүн асууж байсан. Бас хариулт байхгүй үлдсэн. 1997 оны юм яриад сууж байна шүү дээ. Одоогоор нэг их наяд төгрөг /Үндэсний статистикийн газрын 2011 оны тооцоогоор/ байгаа шүү. Үүний 650 нь далд эдийн засаг гэж тооцогдож байна. Энэ бол хамгийн даруухан тоо. Ийм зүйлс дээр тооцоогоо сайн хийхгүй бол оруулж ирээд байна шүү. Ийм болчихмооргүй байна. Үүн дээр цаашдаа анхаараарай.

- Өчигдөр тогтвортой хөгжлийн талаар миний асуусан бас нэг асуулт бий. Дэлхий нийтийн хандлага тогтож, ерөнхий сайдын хариуцах ажил болоод орчихсон зүйл шүү дээ. Үүн рүү хэрхэн хөрөнгө оруулалт хийж байгаа вэ, энэ талаар баримталж байгаа бодлого чинь юу вэ гэхээр ерөнхий сайд, сангийн сайд, эдийн засгийн хөгжлийн сайд нар хариулахгүй байна. Нэг иймэрхүү л байдалтай байна. Үүнийгээ цаашид анхаарч ажиллаарай.

## **Мөнгөний зөв бодлого баримталбал эдийн засаг сайжирна**

*УИХ-аар 2014 оны Улсын төсвийн тухай хууль, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэл батлахаар 2014 оны Улсын төсвийн тухай хууль, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай тогтоолын төслийг ид хэлэлцэж байна. Энэ асуудлаар “Өглөөний сонин” УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлээс дараах зүйлийг тодруулжээ.*

- Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай тогтоолын төслүүдийг хэлэлцэж эхэллээ. Уг төсөлд тусгаснаар ирэх онуудад инфляцийг 7-8 хувьд барьж, валютын ханшаа макро эдийн



**засгийн суурь нөхцөлтэй нийцүүлэхэд анхаарна хэмээн Монголбанкнаас үзэж байна. Энэ талаарх таны байр суурийг сонирхож байна?**

**С.Дэмбэрэл:** - Өмнөх жилүүдэд Төвбанк эдийн засгаас мөнгө татаж авах замаар инфляцийг удирдаж байв. Ерөнхийдөө Монгол Улс 2007 оноос хойш ийм зарчмаар явж ирсэн. 2007 оноос өмнө бол мөнгөний эргэлтийг зохистой байлгах чиглэлд түлхүү анхаарч байлаа. Харин мөнгөний бодлогод байсан дээрх байдлыг өнгөрсөн жил баталсан мөнгөний бодлого үндсээр нь өөрчилсөн гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл зөв бодлого гарч ирснээр нэг жилийн хугацаанд эерэг байдал нийгэмд үүсээд байгаа. УИХ-ын гишүүд тойрогтоо ажиллахад сонгогчид зээлийн хүүг нэг орон руу оруулаад өгөөч, ажлын байр бий болгож, бизнесийн орчныг сайжруулахад анхаараач гэх зэрэг хүсэлтийг 2013 оны мөнгөний бодлогод тусгаж чадсан. Харин одоо 2014 оны мөнгөний бодлогыг ид хэлэлцэж байна. Ирэх оны бодлогод бодит секторын идэвхжилийг нэмэгдүүлэх нь чухал. Төрийн мөнгөний бодлого тодорхой секторуудад хэрэгжиж үр дүнд хүрэх нь инфляцийн нам дор байх түвшин тодорхой хэмжээгээр хангагдана гэсэн үг. Энэ бодлого 2014 онд үргэлжлэх төлөвтэй. Нийт эдийн засгийг бүрдүүлж байгаа салбаруудад анхаарал хандуулах нь зүйтэй. Ингэхдээ зөвхөн уул уурхайн бус эдийн засгийн солонгоролд анхаарч олон хөлтэй болгоё гэсэн уян хатан мөнгөний бодлого чухал гэдгийг УИХ, Засгийн газар мэдэрч хэрэгжүүлсэн нь сайн хэрэг. Гол нь үүнийгээ зөв томъёолоод, зөвхөн инфляцийг биш, ажил эрхлэлт болон эдийн засгийн оролцоот өсөлтийг онилдог загварыг мөнгөний бодлогод оруулж ирснээрээ ач холбогдолтой болох юм.

**- Энэ зун, намар валютын ханш огцом өслөө. Валютын ханшийн огцом өөрчлөлт нь манай улсын эдийн засагт сөрөг нөлөөтэй. Тиймээс одооны ханшийг хэт өсгөлгүй барих боломж бидэнд байна уу?**

**С.Дэмбэрэл:** - Энэ оны нэгдүгээр сарын 25-нд Монголбанкны мөнгөний бодлогын зөвлөл байгуулагдсан. Эл зөвлөл валютын ханшийг оны эцэст 1450 байна хэмээн тухайн үеийн параметрээр тодорхойлж байв. УИХ-аас явцын дунд Санхүүгийн тогтвортой байдлыг хангах институци байгуулсан юм. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн чиг үүрэг нь эдийн засгийн тогтвортой байдал ялангуяа валютын зах зээл дээр ханшийн тогтвортой байдлыг ханган ажиллах явдал юм. Үүнийг хийхэд зөвхөн нэг тоглогч биш төрийн гурван институци хамтран хийх үүргийг УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооноос баталсан. Саяны валютын ханшийн огцом хөдөлгөөнийг аваад үзвэл Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл ажлаа хийгээгүй нь бүх баримтаар нотлогдож байгаа. Тиймээс ирэх оны бодлогод дээрх баримтыг түшиглэн цаашид авах арга хэмжээгээ тусгах ёстой.

**- Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийг байгуулснаар эдийн засагт ямар үр дүн гарав?**

**С.Дэмбэрэл:** - Сайн тал ч байна. Сөрөг тал ч бий. Энэ зөвлөл өмнө нь огт байгаагүй. Үнэндээ 2009 он буюу хямралын үед хувийн хэвшлийг золиослох замаар бодлого явж ирсэн. Харин одоо л байдал өөр тийшээ эргэлээ. Хоёр талын амьд холбоо, уялдааг бий болгохын тулд санамж бичгүүд байгуулсан. Мөн 1.5 тэрбум бондыг байршуулах санхүүгийн хэлцэл хийсэн. Одоо Засгийн газрын зүгээс үүнийг яаж дэмжиж, хэрхэн биелэлтийг нь гаргав гэдгийг дүгнэнэ. 2014 оны мөнгөний бодлогод дээрх

ажлыг гүнзгийрүүлэх, нийт эдийн засгийн идэвхжилд анхаарах хэрэгтэй. Уул уурхайн бус эдийн засгаас илүүтэйгээр жижиг, дунд, бичил бизнес болон иргэдэд тулгамдаж буй асуудлуудыг тусгаж хэрэгжүүлэх нь гол гарц болно. Ингэхдээ ажлын хэсэг байгуулан асуудлыг нухацтай авч үзэх нь чухал юм.

**- Өмнөх жилүүдийн мөнгөний бодлогод тодорхой алдаа гарч байсан нь ойлгомжтой. Харин ирэх жилийн тухайд эдгээр алдааг багасгах боломж байна уу?**

**С. Дэмбэрэл:** - Тэгэхээр, өмнөх жилүүдийн мөнгөний бодлогыг хамгийн товчоноор сануулах нь зүйтэй. 2007 оноос хойш Төв банк “Эдийн засгаас мөнгийг татаж авах замаар инфляцийг удирдаж болно” гэдэг бодлогыг байнга баримталсаар ирсэн. 2007 оноос өмнө мөнгөний агрегатуудыг зохистой байлгах чиглэлээр бодлого явсан. 2012 онд шинэ УИХ, шинэ Засгийн газар, Монголбанкны шинэ ерөнхийлөгч гарч ирсэн. 180 градус өөрчлөгдсөн шинэ зөв бодлого гарч ирсэн. Өөрөөр хэлбэл, УИХ-ын гишүүдийг тойрог дээрээ очиход нь байнга сонсож байдаг “Зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулаад өгөөч”, “Зээлийн олдоцыг нэмэгдүүлээд өгөөч”, “Зээлийн орчныг сайжруулаад өгөөч”, зэрэг сонгогч бүрээс, ялангуяа бизнес эрхэлдэг сонгогч бүрээс хэлдэг үгийг 2013 оны мөнгөний бодлогод суулгаж өгсөн. Үүнийг бид нэлээд сайн ярилцаж байгаад, 2013 оны мөнгөний бодлогодоо хийж өгсөн юм. Энэ бодлого хэрэгжиж эхлээд жил ч болоогүй байна. Одоо бид дараагийн оных нь бодлогыг ярилцаж байна. Энэ тохиолдолд, саяны ярьсан бодит секторын идэвхжилийг нэмэгдүүлэх, төрийн мөнгөний бодлого тодорхой секторуудад хэрэгжээд, тэр нь тодорхой үр дүн гаргаад, үүнийхээ хажуугаар эдгээр бодит секторууд идэвхжсэний дүнд инфляцийн нам дор байх түвшин тодорхой хэмжээгээр хангагдсан бодлогын цоо шинэ, өмнөхөөсөө шал өөр бодлогыг л бид ярьж байна. Бидний хүсдэг юм маань л энэ шүү дээ. Энэ бодлого 2014 онд үргэлжлэхдээ, тодорхой секторуудын төдийгүй, нийт эдийн засгийн, түүний дотор нийт эдийн засгийг бүрдүүлж байдаг, ялангуяа уул уурхайн бус эдийн засгийг бүрдүүлж байдаг, “Эдийн засгийг солонгоруулъя, олон хөлтэй болгоё” гэж бидний яриад байдаг тэр бодлогыг мөнгөний бодлогоор дэмжих ийм бодлого орж ирлээ гэж би ойлгож байна. Үүнийгээ харин зөв томъёолоод, тодорхой хэлмээр байна. Одоо орчин үеийн Төв банкуудын бүгдийнх нь хийж байгаа арга барил буюу зөвхөн инфляцийг төдийгүй ажил эрхлэлтийг онилдог, эдийн засгийн оролцоотой өсөлтийг онилдог тэр загвар энд сууж байгаа. Эдийн засгийн дархлааг сайжруулна гэдэг нь угтаа, цаад санаагаараа бол энэ юм. Үүнийг нь бид цаашдаа үргэлжлүүлэх ёстой. Энэ талаас нь бодож мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх тийм зүйлийг бид хийх ёстой. Нөгөө талаас валютын ханшийн талаар ярьж байна. Огцом өссөн нь ч үнэн. УИХ явцын дунд санхүүгийн тогтвортой байдлыг хангах институцийг байгуулж өгсөн. Харин өнгөрсөн 7-8 дугаар сард болсон ханшийн хөдөлгөөнтэй холбоотой бүх протоколыг нь аваад үзэхээр, бидний ажил хийгээрэй гэж байгуулсан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл маань ажиллаагүй, зөвхөн Монголбанкийг үлдээгээд явчихсан. Бүх баримтаар ингэж нотлогдож байгаа. Тэгэхээр энэ бодитой баримт фактуудыг бид харж байж, энэ талаар цаашдаа авах арга хэмжээнүүдийг 2014 оны мөнгөний бодлогодоо суулгаж

өгөх ёстой. Дутагдалтай талууд байна. Сайн талууд ч байна. Өөрөөр хэлбэл урьд өмнө нь огт байгаагүй, тэр байтугай 2009 оны хямралын үед хувийн хэвшлийг золиослох замаар эдийн засгийг аварна гэж байсан тэр бодлого 2010-2011 онд үргэлжлээд, ерөнхийдөө хатуу мөнгөний бодлого хэрэгжиж байсан тэр үеийг эргээд нэг санаад үзээрэй. Мөнгөний бодлогыг хэрэгжүүлдэг институци, Засгийн газар хоёрын хоорондын уялдаа тааруу байсан. Энэ уялдааг бий болгохын тулд санамж бичгүүд гаргаж эхэлсэн. Дээр нь 1.5 тэрбумын бондыг байршуулах санхүүгийн хэлцэл хийсэн. Санамж бичиг байгуулсан. Институцийн хувьд хоёр тал үүрэг хүлээсэн. Одоо үүнийг Засгийн газрын зүгээс яаж дэмжсэн бэ, яаж биелэлтийг нь хангасан бэ гэдгийг гаргаж ирээд, үүний дараа 2014 оны мөнгөний бодлого дээр хэрэгжиж ирсэн тэр бодлогыг гүнзгийрүүлэх, нийт эдийн засгийн идэвхжилийг, түүний дотор уул уурхайн бус эдийн засаг, жижиг дунд бизнес, тэр байтугай бичил бизнесийн зэрэг санаануудаар л мөнгөний бодлогоо цаашид хэрэгжүүлэх ёстой.

2013-10-14, Мэдээний дугаар: #1234604

## **Үнэ тогтворжуулах гэдэг маань үнийн өсөлтийн хурдцыг сааруулах бодлого гэж ойлгомоор байна**

*УИХ-ын Чуулганы 2013 оны 10 дугаар сарын 17-ны нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс: Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /нэг дэх хэлэлцүүлэг/ Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Н.АЛТАНХУЯГ танилцуулсан..*

**С.Дэмбэрэл гишүүний асуулт:** - Баярлалаа. Би *эхний асуултаа* Д.Ганхуяг сайд, А.Гансүх сайд, Ц.Баярсайхан, М.Сономпил сайд нараас асуумаар байна. Та бүхний хариуцсан салбарт хувийн хэвшлийн бизнес эрхлэгчдээс 2013 онд оруулсан хөрөнгө оруулалтын статистик дүн ямар байна вэ? 2014 онд хэд болох талаар ямар төсөөлөлтэй байгаа вэ?

*Хоёрдугаарт*, Ч.Улаан сайдаас асуух асуулт. 2013 оны 06-р сарын дундаас өнөөг хүртэл Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн нэг оролцогчийнхоо хувьд валютын ханшны хэлбэлзлийн чиглэлээр танай яамнаас ямар санаачилга гаргаж, ямар асуудлыг тус зөвлөлөөр оруулж хэлэлцүүлсэн бэ?

*Гуравдугаарт*, мөн Ч.Улаан сайдаас асууя. Монгол Улсын хэмжээнд 2013 болон 2014 онд концессийн хэлбэрээр хийгдэх хөрөнгө оруулалтын хэмжээ ойролцоогоор хэд байх вэ?

*Дөрөвдүгээрт*, Э.Бат-үүл даргаас, 2013 оны эхний 3 улиралд Улаанбаатар хотод концессийн хэлбэрээр хийгдсэн хөрөнгө оруулалт яг одоогоор ямар хэмжээнд байна вэ? 2014 онд хүлээгдэж байгаа төсөөлөл ямар байгаа вэ?

- *Тавдугаарт*, Эдийн засгийн хөгжлийн яамны холбогдох хүнээс нь асууя. 2013 оны байдлаар гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ, 2014 оны төсөөлөл ямар байна вэ?

- *Зургаадугаарт*, Ерөнхий сайдаас асуух хоёр асуулт байна. Тендэрийн хуулийг хэзээ оруулж ирэх вэ? Би өмнө нь олон удаа хэлж байсан. Тендэрийн хууль чинь энэ бүх хөрөнгө оруулалтанд гацаа үүсгээд байна шүү.

- Монгол Улсын санхүүгийн жилийн хугацааг өөрчлөх талаар УИХ-ын 2 гишүүн саналаа өргөн барьчихсан байгаа. Энэ талаар засгийн газрын байр суурь ямар байна вэ?

- Эцэст нь, зарим нэг томъёололын талаар бид цаашдаа нэлээд тодорхой ярьж байхгүй бол болохгүй байна. Жишээлбэл, инфляци, үнэ тогтворжуулах зэрэг зүйлийг дандаа абсолют /туйлын, төгс/ утгаар яриад, ард иргэдийг төөрөгдөлд оруулаад байна. Үүнээс болоод ард иргэд болон нийгмийн мэдээ мэдээлэл дээр “Эд нар худлаа ярьж байна.” гэж хэлэгддэг болчихсон. Тэгэхээр нэг зүйлийг хаа хаанаа их сайн ойлгомоор байна. Бид, юмны үнэ өсөлтийг сааруулах тухай ярьж байгаа. Өөрөөр хэлбэл үнэ тогтворжуулах гэдэг маань үнийн өсөлтийн хурдцыг сааруулах бодлого л гэж ойлгомоор байна. Би бол тэгж ойлгодог. Зорилго нь ч тийм л байгаа. Тэгэхээр үнийн өсөлтийн хурдац нэмэгдсэн ба буурсан гэж ярихаас биш, инфляци өслөө, буурлаа гэж ярих нь буруу юм. Үнийн өсөлт хурдтай байгааг ярьж энэ хурдыг бууруулах тухай ярьж байгаа болохоос биш, зарим тодорхой бараан дээр мөлхөө байдлаар, аажим буурч байгааг бид яриагүй шүү дээ. Тиймээс нэг томъёололоор ярьж сурмаар байна. Тухайлбал, эдийн засгийн хөгжлийн сайд “Инфляци 2 дахин буурсан” гэж хэлчихээд хэвлэл мэдээлэлээр зөндөө баалуулсан шүү дээ. Энийг анхаарцгаана уу. За баярлалаа.

**УИХ-ын дарга З.Энхболд:** Сайд нар С.Дэмбэрэл гишүүний асуултанд хариулна уу.

**Уул уурхайн сайд Д.Ганхуяг:** - Хөрөнгө оруулалтын талаар С.Дэмбэрэл гишүүн өмнө нь бас асууж байсан. Энэ дүнг жилд 1 удаа гаргадаг юм байна. 07 сарын 01-нд дүнгээ гаргасан. Хувийн хэвшлийн бизнес эрхлэгчдээс 863 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт орсон байна. Оны эцсийн дүнгээр гараагүй байна. Оны эцэст дүнг дахин гаргана. Ирэх онд эдийн засгийн өсөлтөөс багагүй хэмжээгээр нэмэгдэх байх. Одоо ирэх оны үндсэн чиглэл, төсөв зэргийг батлахаар бүх зүйл тодорхой болно гэж бодож байна. Монгол Улсын хувьд хөрөнгө оруулалтыг жилд 1 л удаа гаргадаг тул ийм асуултанд хариулахад жаахан хэцүү байна. Нөгөө талаас манай салбарт нэг асуудал байгаа. Манай улсад тусгай зөвшөөрөл эзэмшдэг компанийн толгой компани нь гадаадад IPO хийж хөрөнгө босгодог. Тэр хөрөнгөний хэдэн хувь нь Монгол дахь үйл ажиллагаанд зарцуулагдаж байна вэ гэдэг судалгааг одоо хийж байна. Удахгүй та бүхэнд танилцуулна.

**Эрчим хүчний сайд М.Сономпил:** - Манай эрчим хүний салбарт сүүлийн жилүүдэд гадаадын, ялангуяа хувийн хэвшлийн байгууллагуудын хөрөнгө оруулалт нэмэгдэх нөхцөл боломж их нэмэгдсэн гэж хэлж болно. Энэ чиглэлээр компаниуд нэлээд их сонирхож байгааг тэмдэглэж хэлмээр байна. 2012-2013 онд Салхитийн 50,000 ваттын салхин цахилгаан станц барихад хувийн хөрөнгө оруулалтаар нийт 170 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт орж ирсэн. Энэ оны 06 сарын 20-нд ашиглалтанд орсон. Мөн 08 сарын 26-нд олон жил яригдсан 5-р цахилгаан станцын сонгон шалгаруулалт явагдсан. Одоо засгийн газартай гэрээ хэлэлцээр хийгдэж

байна. 2014 оноос цахилгаан станцын ажил явагдаж эхэлвэл 1,5 тэрбум доллартай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэх боломжтой. Мөн Тавантолгой дээр баригдах 900 сая – 1 тэрбум ам.долларын өртөгтэй цахилгаан станцын хөрөнгө оруулалт хийгдэнэ. Ер нь эрчим хүчний салбарт хууль дүрмэн дээр нь жаахан жаахан өөрчлөлт хийгээд, дэмжээд өгвөл, хувийн хөрөнгө оруулалт өсч байгаа салбар мөн гэж хэлж болно. Баярлалаа.

**Зам тээврийн сайд А.Гансүх:** - Зам тээврийн салбар дахь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг 2 хувааж авч үзэх хэрэгтэй гэж би үздэг. Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт ороогүй. Учир нь Засгийн газрын мөрийн хөтөлбөртөө хэрэгжүүлэхээр оруулсан зорилтуудыг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх ажлуудыг Эдийн засгийн хөгжлийн яам дээр төвлөрүүлж байгаа. Концессийн газар Эдийн засгийн хөгжлийн яаманд үйл ажиллагаагаа явуулж байгаа. Үүнтэй холбоотойгоор Зам тээврийн яам бол төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар хөгжүүлэх засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийг Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлсэн байгаа. Тухайлбал, Баянзүрх – Налайхын зам, Олон улсын шинэ нисэх буудал руу тавигдах хурдны зам, Алтанбулаг – Замын Үүдэн хоорондох 990 км хурдны зам зэрэг замуудын хөрөнгө оруулалтын Эдийн засгийн хөгжлийн яам дээр төвлөрүүлээд явж байна. Ер нь энэ салбарт хувийн хэвшлийнхэн өөрийнхөө хөрөнгө оруулалтаар ямар ажил хийж байгаа вэ гэвэл, голдуу уул уурхайн компаниуд өөрсдийнхөө олборлосон бүтээгдхүүнийг тээвэрлэх замд хөрөнгө оруулалт хийж байгаа. Тухайлбал, Петрожайна компани, Оюутолгой, South Gobi Sands, Алтайн хүдэр компаниуд өөрсдийнхөө хөрөнгөөр зам тээврийн салбарт өөрсдийнхөө бүтээгдхүүнийг тээвэрлэх замуудыг бариад явж байгаа. Яг одоогоор энэ бүгд нийлээд 400 орчим км зам болж байгаа юм. Төсөвт өртөгийг нь яг одоогоор би хэлж чадахгүй байна. Тодруулаад, дахин ажлын шугамаар мэдэгдье.

**Сангийн сайд Ч.Улаан:** - Баярлалаа. Энэ он гарсаар Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл сар бүр тогтмол хуралдаж байгаа. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг тогтворжуулахад бид анхаарч байна. Ялангуяа төгрөгийн ханш унасан үед ханшийг тогтворжуулахтай холбоотой асуудлаар зарим сард 2 удаа хуралдаж, зөвлөлдөж байсан. Бидний оруулсан тодорхой санал гэвэл, бүх төлбөр тооцоог Монгол улсын нутаг дэвсгэр дээр төгрөгөөр гүйцэтгэх тухай асуудлыг оруулж танилцуулсан. Татварыг валютаар авч байгааг өөрчлөх хуулийн санал оруулж танилцуулагдсан. Хамгийн сүүлд, төсөв мөнгөний бодлогыг өргөн барихын өмнө уулзаж, харилцан уялдааг нь хангах асуудлаар мөн зөвлөлдсөн. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг тогтворжуулахад бид анхаарч байна. Баярлалаа.



## **Төрийн байгууллагуудын давхардал ба ажлын уялдаа холбоонуудыг сайтар тодруулах хэрэгтэй байна.**

*УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын хэсгийн 2013 оны 10 дугаар сарын 22-ны хуралдааны тэмдэглэлээс:*

**Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл:** - Төрийн байгуулалтын байнгын хорооны Ажлын дэд хэсгийн уулзалт. Ажлын хэсгийн удирдамж гээд юм байна. Төрийн байгууллагууд өөрт ногдуулсан чиг үүргийг хэрэгжүүлэхдээ үйл ажиллагаагаа хэрхэн уялдуулж байгаа нэгдүгээрх нь энийг шалгана. Хоёрдугаарт нь бүтэц зохион байгуулалт оновчтой эсэхийг судлан дүгнэлт гаргах ийм л хоёр үндсэн чиг үүрэгтэй Ажлын хэсэг. Ажлын хэсгийнхээ дараах асуудлыг судалж танилцана гэдэг дээр ярилцъя. Хуулиар оногдуулсан чиг үүргийнхээ хүрээнд бол энэ байгууллагууд, төрийн байгууллагууд ялангуяа эдийн засгийн гол шийдвэрийг гаргадаг, эдийн засгийн хөгжлийн яам, сангийн яам, уул нь бол ногоон хөгжлийн яам тэр чинь ерөнхий чиг үүргийн яам шүү дээ. Ногоон хөгжлийн яам бусад салбарын яамдууд, энэ хэдэн гол гол яамдын үйл ажиллагаа нь Засгийн газрын тухай хуулиараа уялддаг байх. Тэгэхдээ бодит амьдрал дээр жишээлбэл, төрийн мөнгөний болон сангийн бодлого хоорондоо яаж уялддаг юм бэ гэдэг нь тодорхой биш байгаа. Төсөв боловсруулах, төсвийг батлах энэ процесст төрийн байгууллагуудын уялдаа, төсвийн хэрэгжилтийн шатанд төрийн байгууллагуудын уялдаа зэрэг асуудлууд байна. Манай хүмүүс газартай холбоотой асуудал бичсэн байна. Устай холбоотой асуудал ч бас байна. Усны хувьд бол замбараагүй юм их байгаа. Усны үндэсний хороо гэдэг усны асуудлуудыг уялдуулах байгууллага байна. Энэ Усны үндэсний хороо хичнээн удаа хуралдсан бэ, ямар асуудлуудыг шийдвэрлэсэн бэ гэдгийг мэдэх ёстой. Нарийн бичгийн дарга нарын газарт Тогтвортой хөгжлийн үндэсний хороо гэж байгаа. Нэг л удаа хуралдсан. Дахиж хуралдах ёстой. Төлөвлөгөөгөө хүртэл батлаагүй явж байгаа. Ерөнхий сайд ахалдаг. Иймэрхүү зүйлүүдийг баримтаар нь гаргаад ирэх хэрэгтэй.

Мөн, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам бол Засгийн газрын хуулиараа бол ерөнхий чиг үүргийн яам гэдэг. Энэ бусад ногоон хөгжлийн болон байгаль орчинтой холбоотой асуудлаар ялангуяа ногоон хөгжил гэдэг асуудлаараа бусад яамдуудтай, тухайлбал Эдийн засгийн хөгжлийн яамтай, Сангийн яамтай яаж уялддаг юм бэ, энэ нь Эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалт, Сангийн яамнаас бол төсвийн төсөл зэрэг энэ бүхэнд ногоон хөгжлийн бодлого нь яаж туссан юм бэ, үүнийгээ яаж уялдуулдаг, ямар институцийн механизм байгаа юм бэ гэдгийг тодруулмаар байна. Бид өнөөдөр Ажлын хэсэг гэсэн нэг зүйлээр л бүх юмыг тагладаг. Ажлын хэсгийн үр дүнтэй, засаглалд түргэн шуурхай шийдвэр гаргах энэ механизм нь үеэ өнгөрөөсөн үү, болж байна уу? Болж байгаа юм бол юу нь болж байна, юу нь болохгүй байна? Өөрөөр хэлбэл, яам хоорондын ажлын уялдаа дээр дандаа л одоо сайд нарын хамтарсан тушаал гаргаад, тэгээд Ажлын хэсэг гаргаад ингээд явж байгаа. Иймэрхүү зүйлүүдийг эхний гол зорилтынхоо хүрээнд, хоёр чиглэлтэй шүү дээ. Өөрт ногдуулсан чиг үүргээ хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа хэрхэн уялдуулах,

энэ нь одоогийн байдлаар яамд хоорондын, яамдын тушаал эсвэл Засгийн газрын холбогдох тогтоол ч гэдэг юм уу энэ чиглэлээр. Тэгээд хамгийн гол нь институц хоорондын уялдаа буюу яамдууд хоорондоо байнгын тодорхой асуудлыг, тодорхой бодлогын асуудал хийхдээ тодорхой Ажлын хэсэг гаргаад яваад байна. Тэгтэл байнгын ажлын уялдаа нь мэдээллийн орчинд яаж уялддаг юм бэ, Засгийн газрын байгууллагуудын хоорондын мэдээлэл солилцох өнөөдрийн технологи нь ямар байдаг юм бэ гэдгийг ч тодорхой болгох хэрэгтэй.

Жишээлбэл, цахим Засгийн газар гэдэг нэрээр янз янзын юм хийгээд, дата центр хүртэл байгуулсан. Энэ талын юмнаасаа бас эхлэх хэрэгтэй байх. Үйл ажиллагааных нь уялдаа бодлогын орчинд төрийн нарийн бичгийн дарга нар, сайд нар, мэдээж засгийн газрын хуралдаан бол энэ уялдааг хангадаг нэг гол байж байгаа хэлбэр нь. Энэ Засгийн газрын хурлаас гарсан шийдвэр болон эсвэл хуралдаанд орж байгаа шийдвэр гарах энэ хооронд ямар уялдаа байдаг юм бэ? Энэ нь муу уялдаатай, уялдаа хангагдахгүй байна гэдгийг маш олон жил ярьдаг. Тийм учраас механизм нь юу юм бэ? Жишээлбэл Их Хурлын Тамгын газраас Засгийн газрын шийдвэр гаргалтын замын зургийг гаргасан байгаа. Тэр манай Норовдондог хийсэн. Шийдвэр гаргалтын замын зураг нь жаахан сулавтар болсон. Гэхдээ тэндээс ерөнхий суурь шийдвэр гаргалтууд ямар явагддаг вэ, өөрөөр хэлбэл орцоос авахуулаад гарц хүртэлх шийдвэр гаргалтын энэ процесст энэ ямар замын зураг харагдаж байгаа юм гэдгийг бид нар гаргаж, түүнийг тодруулаад илүү сайн нарийвчлаад тодорхой амьд жишээнүүд дээр энэ ажлын хэсэг баяжуулаад, арга зүйн хувьд шүү дээ. Ингээд цаашдаа явах ёстой байх. Энд жишээ авсан байна. Газрын нэгдмэл сангийн ангилал гээд. Ашигладаг яам байна уу? Энэ мэтийн юмнууд яг ингэж схем зурж болдоггүй. Тэгсэн мөртлөө Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яамны өнөөдрийн уялдаа яг яаж хангагдаж байгаа юм. Жишээлбэл, валютын ханш дээр яаж хангагддаг юм бэ? Валютын ханш төсвийн тодотгол дээр янз янзын юм яригддаг. Өнөөдөр 1700-тай байгаа. Эдийн засгийн хөгжлийн яамнаас 1384-өөр оруулсан байгаа. Сангийн яам түүнийг нь шууд хүлээж авдаг. Ямарваа нэгэн засваргүйгээр. Гэтэл Монгол банк дээр төсөөлөл хийхдээ 1450-иар авсан байгаа. Бодит ханш дээр одоогийн байдлаар 1700 байгаа. Энэ Монгол Улсын эдийн засгийн дараа жил болон дунд хугацааны төсөөлөл хийхдээ нэг л тодорхой ханш байх ёстой. Нэгл адилхан параметрууд байх ёстой. Энэ яагаад ингэдэг юм. Би түрүүн хэлсэн. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл. Энэ дээр 3 институц орж байгаа. Монгол банк. Монгол банк дээр шалгалт дуусаж байна. Ажлын уялдааны байдал харагдана. Энийг гаргаад ирчихсэн. Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам. Одоо цаашдаа энд Эдийн засгийн хөгжлийн яамыг бас оруулах ёстой. Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яам хоёрын хоорондын ажлын уялдаа хангалтгүй байна. Хөрөнгө оруулалтын төслүүд дээр Сангийн яам шинэ бүтцээр хоёрдугаар асуудал уруугаа орж байна. Шинэ бүтцээр бүтэц зохион байгуулалтаа Эдийн засгийн хөгжлийн асуудлыг хариуцсан тэдний чиг үүргийг Засгийн газрын хурал дээр Сангийн яамнаас тодорхой хүн хүч, институцийн нөөцийг нь аваад Эдийн засгийн хөгжлийн яам дээр очсон. Одоо хөрөнгө оруулалтын санхүүжилт Эдийн засгийн хөгжлийн яамнаас

гарч байгаа. Төлөвлөлт, бодлого нь. Өнөөдөр Төсвийн хариуцлагын тухай хууль байж байна. Тэрний заалт дээр аливаа төсөвт оруулж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүд бол хоёр шалгууртай байна.

Нэг нь эдийн засгийн үр ашиг, нөгөөх нь нийгмийн ач холбогдол. Өнөөдөр эдийн засгийн үр ашгаар нь энэ төсөл, хөтөлбөрүүдийг хэн эрэмбэлэх ёстой юм. Ямар арга зүйгээр эрэмбэлэх ёстой юм. Тэрний дараа нь хоёр дахь багана нь нийгмийн ач холбогдолоор нь гэж ангилаад. Ингээд Улсын Их Хурлын гишүүдийн өмнө бүх хөрөнгө оруулалтын төслүүд бол эдийн засгийн үр ашгаараа эрэмбэлэгдчихсэн, нийгмийн ач холбогдлоороо бас эрэмбэлэгдээд хоёр баганатай орж ирээд энэ дээр нь Улсын Их Хурлын гишүүд ажиллаад эцсийн дүндээ орон нутгийн лобби, өөрийн тойрогын лобби ямар ч гэсэн энэ чиглэл дээр Төсвийн тогтвортой байдлын хоёр хувийн хариуцлагын асуудал маань өөрөө дотроо хоёр хувьтай багтаасан хариуцлагагүй байдал үүсчихсэн байгаа. Энэ нь бол институт хоорондын харилцан ажлын уялдаа муу байдгаас болж байгаа юм. Энийг бид шалгах ёстой.

Тодорхой яамдууд, жишээлбэл төсөл, хөтөлбөрүүд байгаа. Жишээлбэл саяхан экспортыг дэмжих хөтөлбөр гэж гарсан байгаа. Энэ дээр аль яамдууд ямархуу байдлаар уялдаж байгаа юм. Энэ нь Монгол Улсын 2014оны төсөвт яаж тусгагдах юм. Эсвэл санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл валютын ханшны асуудал дээр шалгалтын үр дүнгээс харахад хэдийгээр Сангийн яамны удирдлага өөр зүйлийг Улсын Их Хуралд миний асуултад хэлсэн ч гэсэн харж байхад бол албан ёсоор санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл валютын ханш ид өсөж байсан тэр үеүдэд бол огт хуралдаагүй, протокол байхгүй. 1 сард нэг хуралдсан, 3 сард хуралдсан, сая хамгийн сүүлд 10 сард хуралдсан. 10 сард анх удаа Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр, сайн зүйл нь төсвийн болон мөнгөний бодлого хоорондын ажлын уялдааг хангахын тулд харилцан мэдээлэл хийсэн, тийм үү. Тэгээд төсөв үүнээсээ төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангах анхны оролдлого, институт хоорондын анхны оролдлого ингэж хэрэгжлээ.

Гэхдээ энийг яаж цааш нь сайжруулах юм, яаж бие биедээ мэдээлэх юм бэ гэдгийг ч гаргаж ирэх хэрэгтэй. Валютын ханшин дээр харилцан ямар байдлаар, жишээлбэл эдийн засгийн хөгжлийн яамны хүн бол манайд жижиг, нээлттэй эдийн засгийн загварын дагуу бид үүнийг тооцоолж гаргасан гэж байсан. Ямар загвараар, яг эконометр гэсэн ямар аргачлалаар, тэр нь Монголбанк дээр ямар байгаа юм, энд ямар байгаа юм, Сангийн яаман дээр ямар байгаа юм. Сангийн яам дээр ямар байгаа билээ. Түрүүлэлтийн индикатор гэж байгаа бил үү. Бас гаргадаг байгаа. Албажаагүй тийм ээ. Иймэрхүү зүйлүүд байгаа байхгүй юу.

Өөрөөр хэлбэл бид яах гэж энэ ажлыг шалгаж байгаа юм гэхлээр Монгол Улсын макро эдийн засгийн бодлого маань аль болохоор зөв тооцоололтой, инстутц хоорондын сайн уялдаатай, ингэснээрээ хэрэгжих үйл явц нь, мөн хяналт тавих үйлэвцнь өөрөө зүй зохистой хэрэгждэг ийм л бодлого боловсруулах, хэрэгжүүлэх энэ үйл явцыг л хангахын тулд энэ шалгалтыг хийж байгаа юм. Ингэж ойлгож болно. Тийм ч учраас 2 үндсэн зүйлтэй байна.

Энэ яам ба agency агентлаг хоёрын хоорондын уялдаа ямархуу түвшинд явагдаж байна. Жишээлбэл, хэчнээн агентлаг, хэчнээн төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулав. Одоо энэ төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулах дуршил их нэмэгдэж байна. Хууль орж ирэнгүүт л нэг төрийн өмчит үйлдвэрийн газар, агентлаг гэж хэлэхлээр алергитнэ гэж бодоод төрийн өмчит үйлдвэрийн газрыг байгуулахдаа заримдаа Их Хурлаас аль эсхүл Их Хурал батлалгүйгээр Засгийн газраар оруулаад батлуулах ийм юм байна. Ингэсний эцсийн үр дүн нь хэт нүсэр бүтэц бий болох ч гэдэг юм уу. Ингэхлээр ямар үед нь Их Хурлаар оруулдаг, ямар үед нь Засгийн газраар батлаад байна. Тодорхой жишээ ярья.

Экспортыг дэмжих хөтөлбөр гээд батлагдсан. Түүнийг санаж байгаа хүн байна уу. Засгийн газраар. Тэрэн дээр жишээлбэл ямар институт үүнийг хэрэгжүүлэх юм гэдгийг яаж заасан юм. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг Их Хурлын гишүүд маш их шүүмжлэлтэйгээр нэлээн сайн чиг үүргийг нь өөрчлөх зориулалтаар Invest Mongolia гэдгийг хуучин FIFTA-ын оронд тавьлаа. Тэр одоо ягтэр байдлаар цааш ажиллах уу, үгүй юу. Эсвэл нөгөө л ижилхэн фифта болоод л тэгээд л. Засаглалын технологи буюу нэг цэгийн үйлчилгээ явагдаж чадаж байна уу. Инстутц хоорондын үйлчилгээ уялдаа online буюу цахим хэлбэрт орж чадаж байна уу. Тэр яриад байгаа нэг цэгийн үйлчилгээ гэдгийг биет утгаар нь хэчнээн төрийн институцыг хамруулахыг хэлээд байгаа юм уу? Ерөөсөө төрийн байгууллагуудын мэдээллээ солилцох шийдвэр гаргахад нь шаардлагатай орц, завсарын бүтээгдэхүүнүүдийг эцсийн шийдвэр буюу эцсийн бүтээгдэхүүн гаргахад нөлөөлөх энэ хурдац ямар байгаа юм.

Өнөөдөрбиднар тендерийн замын зураг байгаа. Бас тийм судалгаа хийлгэсэн байгаа. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын худалдан авалтын замын зураг, тэрний эхний хуудсыг хараад та бүхэн маш цочирдон гайхаж магадгүй. Асар тийм хэцүү нөхцөл байна. Тийм учраас Засгийн газрын худалдан авалтын агентлаг, салбарын яам хоёрын хооронд Засгийн газрын худалдан авалтын чиглэлээр ажлын уялдаа яаж хангагдаж байна, гол саатал нь хаана гараад байна. Хуулинд байна гэж үзээд хууль өөрчлөх гэж байгаа юм. Ямар чиглэлээр өөрчлөх гэж байгаа юм гэх мэтээр ийм тодорхой, тодорхой эцсийн үр дүнд энэ ажлын хэсгийн үр дүн бол гарна.

За Монгол улсад бол засаглалын технологи өнөөдрийн байдлаар ийм, ийм хуулийн хүрээнд ингэж хэрэгжиж байна. Ийм, ийм дутагдал ажиглагдаж байна. Ийм ажлын уялдаагүй байдал, үрашиггүй байдал, цаг хугацаа их авдаг байдал, иймэрхүү зүйлүүд их гарч байна. Тийм учраас одоогоор ийм чиглэлээр арга хэмжээ авч байна. Иж бүрэн ямар арга хэмжээ авах вэ. Ингэсний үр дүнд бол төрийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх үйл явц хурдан шуурхай, үр дүнтэй, өгөөжтэй болох ямар арга зам байна гэдгийг л гаргаж ирэх ёстой.

Статистик жишээлбэл яагаад статистикийн мэдээлэл бол өнөөдөр хангалттай сайн гарч байна. Энэ мэдээллийн хангалттай сайн байдлыг төрийн институциуд ашиглаж чадаж байна уу, үгүй юу. Жишээлбэл эртүүд Улсын Их Хурал дээр би дотоодын нийт бүтээгдэхүүний дифляторыг яаж тооцоонд оруулдаг юм. Өнөөдөр жишээлбэл үл хөдлөх хөрөнгийн үнэ дээр хөөс үүссэн гээд байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний дифлятор,

хэрэглээний үнийн индекс энэ хоёрын хоорондын ялгаа, энэ хоёрын зөрүү хаана ямар байдлаар илэрхийлэгдэж байна вэ? ДНБ-ний дифляторыг ямар байдлаар хаана хэрэглэж байна, тооцоололд, за мөнгөний бодлого дээр хэрэглэдэг юм. Сангийн яаман дээр хэрэглэдэг байх. Бодит ДНБ-ийг тооцож гаргадаггүй, статистикээс аваад хэрэглэдэг тиймээ. Танай статистик юу хоёрын задгай мэдээллийн солилцоо яаж явагддаг юм. Танайх хоорондоо санамж бичигтэй юу. Банк, статистик. Статистик, банк, сангийн яам ч гэдэг юм уу. Статистик чинь Улсын Их Хурлын байгууллага, бие даасан, хараат бус. Эдний байгууллагуудын яаж бодлогын дүн шинжилгээ, бодлого боловсруулах явцдаа яаж байна. Бодлого дээр бас нэг зүйл. Ялангуяа төсөв, мөнгөний бодлоготой уялдаатай юм. Өнөөдөр бид 2014 оны төсвийн бодлогыг ярих гэж байна.

Тэр нь бол орлогонь ямар байх юм, зарлага нь ямар байх юм, алдагдал нь ямар байх юм гэдгээ 2 хувьдаа багтаана. Ийм цикл. Гэтэл нөгөө сангийн бодлого нь яригдахгүй. Төсвийн бодлогоо өөртөө агуулдаг сангийн бодлого нь буюу энэ төсвийн бодлогоор ямар бодлого явагдах гэж байгаа юм. Циклийн эсрэг юм уу, мөнгөний бодлоготойгоо яаж уялдах юм. Төсвийн хариуцлагын тухай хуулинд инфляцийг хязгаарлахад Засгийн газрын үүргийг тодорхойлчихсон байгаа юм. Гэх мэтээр ийм бодлогын юм та бүхэнд санаа өгч байгаа юм. Иймэрхүү зүйлүүд дээр л 12 сарын 01 хүртэл хугацаатай юм байна.

За ногоон хөгжлийн хувьд бол ерөнхийдөө ажиглаад байхад бол ногоон хөгжлийн бодлогыг бол хуулинд нь нэлээн ялангуяа ерөнхий чиг үүргийн яам юм бол Ногоон хөгжил, би байгаль орчин яриагүй шүү. Ногоон хөгжлийн талаар буюу өөрөөр хэлбэл Батбаярын Эдийн засгийн хөгжлийн яам энэ хоёрын уялдаа, Монгол Улсын эдийн засгийн хөгжил нь яаж ногоон хөгжлийн чиглэж байгаа юм гэдгийг эрхзүйн хувьд нь яаж зааж өгсөн байна. Энэ талаас нь их харах хэрэгтэй. Энэ яг бодит амьдрал дээр хэчнээн удаа Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас ногоон хөгжлийн асуудлаар холбогдох яамдуудын дунд координаци, уялдаа болгох ямар бодлогын асуудлууд хэлэлцэгдэж, одоо ямар институциудын хооронд ямархуу зүйлүүд яаж явагдаж байна. Жишээлбэл, Улсын Их Хурлаар одоо мөдхөн 11 сар гэхэд Засгийн газраар оруулчихсан ногоон хөгжлийн бодлого батлагдана. Энэ цаашаа батлагдаад ирэхлээр энэ институц хоорондын уялдаа яаж хангагдах вэ. Гоё нэртэй, том нэртэй тэгсэн мөртлөө, жишээлбэл Эдийн засгийн хөгжлийн яам чинь ерөнхий чиг үүргийн яам биш биз дээ. Хуулиараа. Чиглэлийн яам. Гэтэл уншихлаар бүгдийг нь координаци хийнэ гэхчхэн байгаа юм. Ерөнхий чиглэлийн яамны чиг үүрэгтэй байгаа. Тэгвэл ерөнхий чиглэлийнхээ яамны чиг үүрэг гэдгийг бас тодруулж өгөх хэрэгтэй шүү дээ. Тэгээд Ногоон хөгжлийн яам ерөнхий чиг үүргийн яам. Энэ ногоон хөгжлийн яам ерөнхий чиг үүргийн яам маань чиг үүргийн биш чиг үүрэгтэй, ерөнхий чиг үүрэггүй тэр яамныхаа далбаан дор, нөмөр дор нь орчихсон юм биш биз дээ гэсэн ийм таамаглал байгаа. Үүнийгбас та бүхэн энэ явцад гаргаад ирвэл, тэгээд түрүүний хэлсэн ганц хоёр юмыг яагаад ерөнхийдөө л нэг цаашдаа шийдвэр гаргах гэж бөөн цаг авдаг, ажлын хэсэг байгуулаад бөөн цаг авдаг, за тэгээд энэ бүхний чадавхи ямар байна энэ бүхнийг уялдуулах институцийнчадавх маань ямар байна өнөөдөр. Монгол



улсын хэмжээнд энэ шалгагдаж байгаа объектуудийн хүрээнд хичнээн хүн, ямар дадлагатай, ямар чадвартай хүмүүс энэ улсын төрийн бодлогыг боловсруулж байна. Энэ нь хир зэрэг үр дүнтэй бас зөв тархацтай байршиж чадаж байна. Жишээлбэл, Их Хурал дээр гэхэд Төсвийн байнгын хороогоор энэ төсвийг хэлэлцэж байна. Гэхдээ бусад байнгын хороондээр орж ирсэн юмнууд ихэнх нь хасагддаг. Үүнтэй адилхан яамдууд жишээлбэл, төсөв ихтэй Сангийн яаманд өгөөд, Эдийн засгийн хөгжлийн яаманд өгөөд, Эдийн засгийн хөгжлийн яам төлөвлөлтийн баахан хууль оруулж ирнэ гээд байгаа шүү дээ тийм ээ. Хэд хэдэн хууль. Энэ хуулиуд ямархуу юм, ямархуу явцтай байгаа юм. Цаашдаа эдгээр хуулийг баталчихаар яах юм. Иймэрхүү зүйлүүдийг бас нэг шалгалтын явцад харвал зүгээр шүү. Ерөнхийдөө ингээд боллоо. Асуух асуулт байна уу? Ложистик тээврийн хувьд ганцхан юм хэлье. Г.Батхүү гишүүний ахалсан тээвэр, ложистикийн үндэсний бодлого хэрэгжүүлэх ажлын хэсэг ажлаа хийгээд дуусаж байгаа.

С.Одонтуяа гишүүний ахалсан Эрдэс баялагийн талаар төрөөс баримтлах бодлого гэдэгт тээвэр, ложистикийн асуудал бас тодорхой хэмжээгээр тусаад явж байгаа байх. Хамгийн гол нь бол ложистик тээврийн асуудлыг зохицуулсан талаар Г.Батхүү гишүүнээс мэдээлэл аваад энэ чиглэлийн юмнуудыг бас оруулчихсан нь дээр байх. Хэрэгжилттэй нь танилцах хуулиудын жагсаалт гэдэг дээр та бүхэняж шалгалт хийдэг юм. Бид нар бол жишээ нь Монголбанк болонбусад байгууллагууд дээр шалгалт хийсэн. Нууцын зэрэглэлтэй материалууд байдаг. Үүнтэй танилцсан. Хүний нөөцийн хүмүүстэй нь уулзаад хүний нөөцийн чиглэлээр ямархуу бодлого явуулдаг юм гэдгийг нь сонирхсон. Дараа нь институт, яамдуудын, эд нар нэг жишиг л бүтэцтэй байгаа. Энэ талаас нь судлаад Монголбанк энэ тэр дээр ерөнхийдөө нэг ийм байдлаар шалгасан. Ажлын хэсэг бол нэлээн ажиллаж байгаад нэлээн зузаан юм гаргачихаад байж байна. Гурван байгууллагыг шалгасан. Нэлээн шахуу хугацаатай ажилласан. Иймээс энэ Ажлын хэсэг бол хугацааны хувьд гайгүй учраас нэлээн сайн юм гарах байх гэж бодож байгаа шүү та бүгдээс. Удирдамжийн хувьд ерөнхийдөө болох юм байна. Миний хэлсэн юмнаас зарим нэгэн санаа аваад үүнийгээ батлуулчих тэгэх үү.

**Ажлын албаны зөвлөх О.Тунгалаг:** -Хаана, хаана шалгалт хийх вэ?

**С.Дэмбэрэл:** -Миний хувьд бол сая бид тодорхой объектууд дээр шалгасан. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам дээр нь 4 яамны шалгалт явсан. Тэр 4 яамны шалгалтын материалыг Эдийн засгийн байнгын хорооноос авчих. Одоо ингээд гишүүдэд тараана. Өөрөөр хэлбэл ажил давхардуулж илүү шалгахгүйн тулд. Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Ногоон хөгжлийн яам энэ гурван яам гол нь. Дээр нь хоёр яам л хэрэгтэй байх даа. Барилга, хот байгуулалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам энэ хоёр. Ингээд 5 яам байхад болно биз дээ. Дахиж өөр яам нэмэх юм уу. Өөрийн яам нэмсэн байгаа юм.

**О.Тунгалаг:** -Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хийх үү?

**С.Дэмбэрэл:** - Ер нь бол Нийслэл их онцгой. Шалгах ёстой. Яагаад гэвэл, өнөөдөр Улаанбаатар хотын эдийн засгийн бодлого, УБ хотын парламентаас гаргаж байгаа шийдвэр, Монгол Улсын парламентаас гаргаж байгаа шийдвэр, Улаанбаатар хотын Засгийн газар, Монгол Улсын Засгийн

газар хоёрын хоорондын уялдаа ямар хуулиуд дээр яаж зохицуулагдаж байна. Жишээлбэл, метро барина гээд ерөнхийдөө лобби маягаар явах гээд байна уу, үгүй юу. Тэгээд Улаанбаатар хотыг бас оруулчих. А.Зангад дарга орж ирснээс, эднийх бол маш их аятайхан, удирдамжаа аваад өөрсдийнхөө багийг томилчихдог. Сая хэдэн яам дээр шалгалт хийчихлээ.

**Ерөнхий аудитор А.Зангад:** - 6 яам дээр хийсэн.

**С.Дэмбэрэл:** - Би энэ 6 яам дээр хийсэн шалгалтын материалыг авчих гээд байна л даа. Иймээс А.Зангад дарга багаа томилчих байх. Ингээд 6 яам дээрээ шалгалцсан хүмүүсээсээ оруулчихвал. Гол нь ажлын уялдааг, чиг үүргээр оногдсон ажлын уялдаа, тэгээд бүтэц зохион байгуулалт нь ямар байна. Үүнтэй холбоотой шалгалт хийх гэж байгаа.

**А.Зангад:** - Тогтоолын агуулгыг үзсэн л дээ. Тэгээд хоёр хэсэг ажил болсон. Нэг нь юу вэ гэхлээр, Эдийн засгийн байнгын хорооны шийдвэрээр 6 яам дээр Үндсэн чиглэлийн биелэлт тал дээр, манай дээр бол Засгийн газар, агентлагийн бүтэц, зохион байгуулалтын аудит хийгээд одоо дуусаж байгаа. Тэрний материал их хэрэг болох байх. Яагаад гэвэл бүрэн хэмжээгээр мэдээлэлээ татаад авчихсан байж байгаа.

**С.Дэмбэрэл:** - Энд бас төрийн алба ороод байсан. Энэ бүх төрийн бодлого боловсруулагдах, хэрэгжих орцоос гарц хүртэлх процесст хүний нөөц, хөгжил талаасаа үүнийг хийдэг хүмүүсийнх нь яг одоо зохион байгуулалтад энэ чиглэлээс нь бас ингэж хийж байгаа. Энэ талаас танай шалгалт дээр байхгүй байх тийм ээ.

**А.Зангад:** - Тийм. Манай зохион байгуулалтын бүтэц дээр болчиг үүргийн давхардал байна уу, үгүй юу. Орон тоо ямар байна гэдэг талаас нь материал цуглуулсан байж байгаа.

**С.Дэмбэрэл:** - За тэгэхлээр ерөнхийдөө гоё болох нь. Эдний материал бол хангалттай байна. Түрүүний 6 яамны юм. Мөн саяны хэлсэн удирдамж дагуу явахад бол их иж бүрэн болох нь.

**А.Зангад:** - Сая С.Дэмбэрэл гишүүний ярьж байгаа зүйлд бас анхаарал, цаг зарах хэрэгтэй. Яагаад гэвэл орон нутгийн удирдлагын бүтэц, орон нутгийн удирдлагын чиг үүрэг гээд салбарын удирдлага, орон нутгийн удирдлагыг яаж хослуулах юм бэ гэдэг дээр хэн ч анхаардаггүй, хэн ч уялдуулдаггүй юм байдаг юм. Тэгээд нил давхардал. Ягтаа бол улсын нийт ажлыг 100 хувь гэж авч үзвэл, нийслэлийн ажил 60 хувь нь заавал байж байдаг. Гэтэл институцийн уялдаа нь байхгүй. Тэр дээр давхардал гэдэг юм нь яг тэр чигээрээ. Ухаан нь үйлдвэрийн гэхэд л үйлдвэр үйлчилгээний, үйлдвэрийн яам гээд л параллель байх жишээний.

**С.Дэмбэрэл:** - Саяны тэр Улаанбаатар хот гэдэг дээр нэлээн анхаарал тавиарай. Би жишээ ярья. Метро зургаан зуун хэдэн сая төгрөгөөр энэ Засгийн газар дээр ч юм уу, ямар нэгэн байдлаар хэлэлцэгдэхгүй, Их Хурал дээр ч орж ирэхгүй тэр хавьдаа. Бүр бараг л Японы Жайка гээд Олон улсын тусламж авах гээд л ингээд яваад байгаа ч гэдэг юм уу, ингээд том том хөрөнгө оруулалтын асуудлууд байж байна. Төсөв дээр яаж холбогддог юм. Улаанбаатар хотынхон яг төсөв батлагдах үе дээр лобби хийх гэж ирж байна. Гэтэл энэ улсын чинь хуралдаантай яаж уялдаж байдаг юм. Их тодорхой биш байгаа.

**Төрийн албаны зөвлөлийн гишүүн Хадхүү:** - Асуулт асуух гээд. Нэгдүгээрт дэд ажлын хэсгээ толгойтой болгомоор байна. Хоёрдугаарт,

долоо хоног болгон тогтмол нэг өдөр уулзахгүй болбол С.Дэмбэрэл гишүүний хэлдэгээр ажлын хэсгийн үр ашиг гэдэг юм байгуулагдаад мартагддаг. Ингэмээргүй байна. Хоёрдугаарт ажлын хүрээ нь их өргөн юм. Асуудлуудаа жаахан фокуслаж өгвөл яасан юм. А.Зангад дарга дээр бас хийсэн юмнууд байгаа юм байна. Удирдамжаа арай цомхон, тодорхой хүрээгээ тодорхойлж өгмөөр байна. Хоёрдугаарт судалгааны ямар арга хэрэглэх гээд байна. Энд харахад, газрын зураг хийчихвэл хамгийн хямдхан, шийдвэр гаргахад бодлогын юу л гаргах гэж байх шиг байна л даа. Судалгааных нь арга хэрэгслийг тодорхой болгомоор байна.

**С.Дэмбэрэл:** - Харин тийм учраас, би өөрөө та нарын хэн нь хэн бэ гэдгийг сайн мэдэхгүй учраас, А.Бакей гишүүнтэй ярьж байгаад ажлын дэд хэсгийнхээ даргыг томилуулчих. Дээр нь замын зураг байдлаар бид нарын шалгах гэж байгаа юмнуудыг харахад бол амар, схемчилсэн тийм л юм хийх гээд байгаа.

Тийм учраас миний түрүүний хэлдэг хоёр жижигхэн судалгаа байгаа. Арваадхан хуудас. Би өөрөө захиалж хийлгэсэн. Тендерийн замын зураг байгаа. Нөгөөдөх нь Засгийн газрын шийдвэр гаргалтын замын зураг гээд. Одоо байгаа хуулийг жаахан хөнгөвчилчихсөн. Үүнийгээ та нар өөрсдөө бас олон жил энэ чиглэлийн ажлыг хийсэн, өөрсдөө бас мэдэж байгаа. Ер нь бол Төрийн байгуулалтын байнгын хороо гэдэг маань институт талаас нь судлах гэж байгаа. Энэ бол бараг анхны гэж хэлж болохоор шалгалт. Тийм учраас энэ дээр ярьж байгаад, Хадхүү чи бас сууж байгаад аятайхан юм гаргааддэд хэсгийнхээ удирдамжаа А.Бакей даргаар батлуулчих. Өөр ямар асуулт байна.

**О.Тунгалаг:** - Ерөнхийдөө төрийн байгууллагуудыг зангидаж байдаг гэдэг утгаараа Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Цогоог Ажлын дэд хэсгийн даргаар тавих саналтай байна.

**С.Дэмбэрэл:** - За Цогоог тавья. Ажлын хэсгийн тэмдэглэлээ Ажлын хэсгийн гишүүддээ тарааж өгөөрэй. Өөр асуулт байна уу. Өөр асуулт байхгүй бол тарья. За баярлалаа.

## **Хараат бус тоонуудыг харьцуулж үзээд, дүн шинжилгээ хийдэг байгуулгыг байгуулах хэрэгтэй**

*УИХ-ын Чуулганы 2013оны 11 сарын 01-ны өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс: “Төсвийн албаны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хэлэлцэх цөд*

**УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлийн тавьсан асуулт:**

1. Би Америк явж туршлага судлаагүй ч гэсэн, хэдэн ном уншиж байхад ийм “Төсвийн шинжилгээний алба” гэсэн ийм алба байх нь чухал ач холбогдолтой юм байна гэж санагдсан. УИХ нь Засгийн газартаа тоо, бодлогоор дөрлүүлж, үхэр шиг байхгүй юмсан гэж бодвол ийм алба хэрэгтэй. Гэхдээ бодох зүйл бас байна. Тухайлбал, “Мөнгөний бодлого”-

ыг яах вэ? Эдийн засгийн байнгын хороо цаашид ийм хүсэлт тавьбал яах вэ? Хэдийгээр энэ албыг төсвийн шинжилгээний алба гэж нэрлэж байгаа ч гэсэн, төсвийн хэдэн тоон дээр анализ хийх ажлаар эдний албыг хязгаарлагдмааргүй байна. Сангийн бодлогыг энэ албаны хүмүүс судлах юм уу, үгүй юу? Төсөв болон мөнгө, сангийн бодлогын хоорондын уялдааг хангасан эсэхийг судлах юм уу? гэсэн эхний асуулт байна.

2. Эртээд, хэсэг хүн төсвийн тухай ярилцлага хийж байгааг зурагтаар үзлээ. Их сургуулийн хэсэг професорууд төсвийн талаар гайхалтай их зүйл хийснээ танилцуулж, харамсалтай нь бүтээлүүдийг нь уншдаг хүн байдаггүй гэдгийг ярьж байна. Тиймээс төрийн гадна байгаа, төсөв, мөнгөний бодлогод анализ дүгнэлт хийх чадвартай хүмүүс, эх үүсвэрүүдийг төсвийн шинжилгээнд хэрхэн хамруулах талаар ямар бодол төлөвлөгөө байгаа вэ?

3. Төсөв орж ирээд хэлэлцүүлэх үед, тухайлбал, сангийн яамныхан УИХ-д зөвхөн өөрсдийнхөө байр сууринаас, хараат бус дүн шинжилгээ хийсэн байдлаар хариулж чадахгүй байна. Уг нь парламентад тийм байр сууринаас хариулт өгөх ёстой. Жишээлбэл, төсвийн хариулага, тогтвортой байдлын тухай хуулийн нэг заалт буюу (+3) эсэх тухай асуудал дээр хэн нэгэн хүн, хараат бусаар хариулт өгөх л учиртай. Гэтэл үүнийг өгч чадахгүй л байгаад байна. Мөнгөний бодлого дээр бид 20 гаруй жил Монгол банкны амыг харлаа. Энэ жилийн батлуулах гэж оруулж ирж байгаа зүйл нь ганцхан хуудас зүйл л байгаа. Хараарай. Ямар нэгэн анализ дүгнэлт хийхгүй бол үүнийг тэр чигээр нь л батална. Энэ тохиолдолд, цаашдаа макро эдийн засгийн шинжилгээ, түүний дотор төсөв, мөнгөний шинжилгээг энэ алба чинь хийх юм уу, үгүй юу гэдгийг хууль тогтоомжиндоо яаж тусгасан юм бэ? Үүнийг лавлаж асуумаар байна.

4. Эцэст нь асуухад, УИХ маань судалгаа шинжилгээнийхээ ажлыг бууруулах тийм бүтэц рүү орчихоод байна. Судалгаа, шинжилгээний хэлтсээ багасгаж, судлаач, шинжээчдийнхээ орон тоог цөөрүүлчихлээ. Ийм тохиолдолд Үндэсний статистикийн газар, УИХ-ын Тамгын газар, одоо энэ байгуулагдах гэж байгаа “Төсвийн шинжилгээний газар”, Монгол банкны судалгаа шинжилгээний алба зэрэг бүтцүүд хоорондоо хэрхэн уялдаж ажиллах юм бэ гэсэн асуултууд байна. Баярлалаа.

**Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн:** - С.Дэмбэрэл гишүүний асуултанд хариулъя. Энэ албаны төсвийг 900 сая байхаар шийдсэн байсан. Энэ төсвийнхөө хүрээнд гаднаас өндөр мэргэжсэн шинжээчдийг гэрээгээр хөлслөн авч, зөвлөмж авсан. Өндөр мэргэжсэн ийм гадаадын судлаач шинжээчидээс гадна төрийн гадна байгаа дотоодын эрдэмтэн судлаачдыг авч ажиллуулах боломж бас бий. Судалгааны байгууллагуудтай ч бас хамтарч ажиллах ёстой. Мөн засгийн газар болон төв банкнаас оруулж ирээд байгаа асуудлууд дээр шийдвэр гаргахад, тэдний оруулж ирсэн судалгаа, дүгнэлтүүд нь үнэн, бодит эсэх дээр үнэлэмж, дүгнэлт гаргаж ажиллана. Макро эдийн засгийн асуудлууд дээр ч мөн адил анхаарч ажиллана. “Мөнгөний бодлого хариуцна” гэж байхгүй байгаа. Үүнийг нэмж оруулъя. Макро эдийн засаг дотроо багтсан гэж ойлгоод яваад байсан юм. Эдийн засгийн томоохон хөтөлбөрүүд, дунд хугацааны бодлогууд, тэдгээр бодлогуудад туссан хөтөлбөрүүдийг үр ашигтай байх тал дээр нь /одоо үүнд анхаарал хандуулахгүй байгаа/ энэ алба итгэл үнэмшил төрүүлэх

үүднээс тооцоо судалгаа хийж, үр дүнгийн үзүүлэлтүүдийг нь гаргаж УИХ-ын гишүүдэд болон байнгын хороонд танилцуулж ажиллах юм.

**УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлийн нэмэлт асуулт:** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хамгийн эхний зүйл заалтан дотор нэг зарчим бий. Тэр нь УИХ руу орж ирж байгаа аливаа хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүд нь эдийн засгийн хувьд үр ашигтай, нийгмийн хувьд ач холбогдолтой байх ёстой гэсэн заалт бий. Өнөөдрийн оруулж ирж байгаа практикаар эдийн засгийн үр ашгаар нь тооцоолоод, эрэмбэлчихсэн төсөл хөтөлбөрүүд орж ирдэггүй. Үүнийг хаана ч, хэн ч хийхгүй байна. Ийм тохиолдолд энэ шинжилгээний алба Засгийн газрын оруулж ирж байгаа энэ замбараагүй олон тоонуудыг замбараатай болгож, УИХ-ын гишүүний ширээн дээр эдийн засгийн үр ашиг болон Нийгмийн үр ашгаар нь эрэмбэсэн жагсаалт гаргах юм уу, эсвэл Засгийн газарт “та нар үүнийгээ ийм болго” гэж хэлэх чадавхтай алба л байх хэрэгтэй байна.

**Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн:** - С.Дэмбэрэл гишүүний нэмэлт асуултанд хариулъя. Энэ алба бол зөвхөн УИХ-д зөвлөмж өгч, тусалцаа үзүүлж ажиллах учиртай юм. Түүнээс биш Засгийн газартай ажиллах байгууллага биш. Таны хэлээд байгаа хөрөнгө оруулалтын томоохон хөтөлбөрүүд, төслүүд, арга хэмжээнүүдийн үр дүнд нь судалгаа шинжилгээ хийж, зөвлөмж гаргана гэж л оруулсан байгаа. Жишээлбэл, татварын хуулийн өөрчлөлт орж ирэхэд зүгээр яриад л өнгөрчихөж байна. Гэтэл тэр хуулийн өөрчлөлтөнд ямар давуу болон сул тал байгааг судалж зөвлөмж өгөх зэргээр байнга ажиллах алба юм.

**УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлийн дэмжиж хэлсэн үг:** - Өнөөдрийн байгаа бодит байдал бол төсөв мөнгөний бодлого орж ирэх үед, тэрийг асууж, тодруулах, хэлэлцэх явцад хардаг, асуудаг, лавладаг ганц газар нь Засгийн газар л байдаг явдал олон жил үргэлжилж ирлээ. Үүнийг өөрчилж, УИХ-ын өөрийнх нь чадавхийг дээшлүүлэх, дархлааг нь сайжруулах зорилгоор оруулж ирж байгаа гэдэг талаас нь би үүнийг дэмжиж байна. Ц.Даваасүрэн гишүүний хэлж байгаа шиг татварын бодлого орж ирэхэд анализ хийгээд, зөвлөмж өгдөг болно гэдэг нь зөв. Яагаад гэвэл өнөөдрийн байдлаар татварын хуулийн өөрчлөлтийг Сангийн яам, эдийн засгийн хөгжлийн яам юм уу, татварын алба нв өөрсдөө санаачлан боловсруулаад, түүнийгээ оруулж ирж тайлбарлаад, тэрийг нь л хэлэлцсэн болоод баталчихдаг. Гэтэл түүнд нь татварын бодлогын анализ хийдэг тийм чадавхи УИХ-д байдаггүй. УИХ-ын гишүүдийн зөвлөх, шадар туслахууд нь ч тэр бүр тийм чадвартай байдаггүй. Энэ тохиолдолд УИХ-ын гишүүн хувь хүн өөрсдөө л энэ чиглэлээр ажиллах хэрэгтэй болдог. Энэ хуулийн оруулж ирж байгаа гол санаа нь УИХ-ын гишүүд олуулаа судалгаа шигжилгээний үнэлэлт дүгнэлтийг олж авах боломж олгож байгаа явдал юм. Ингэснээр бидний хууль батлах үйл ажиллагааны чанар дээшлэх юм. Улмаар УИХ-д оруулж ирдэг төсвийн болон мөнгөний бодлогын чанар нь ч дээшилнэ. Чанаргүй зүйл оруулж ирвэл, тэр судалгаа шинжилгээний албаныхан төсвийн болон эдийн засгийн байнгын хороонд бие даасан санал дүгнэлтээ ирүүлэх учиртай. Жишээлбэл, “энэ төсвийг хэлэлцэх боломжгүй байна. Учир нь оруулж байгаа хөрөнгө оруулалтуудыг үр ашгаар нь эрэмбэлээгүй байна. Хууль зөрчсөн байна...” гэхчилэн тайлбарладаг болно гэж найдаж байна. Би ийм байгаасай л гэж хүсч байна. Гэвч ийм байж чадах уу? Энэ албыг байгуулчихаад, дөнгөж эдийн засгийн мэдлэг олж авсан жаахан залуучууд ирээд суучихвал ашиг байхгүй. Тийм учраас аль болох гаднаас орсон, чадвартай хүмүүсийг дайчлан ажиллах тийм механизмыг хуулиндаа



хийгээд өгчихвөл, энэ алба цаашдын ач холбогдол ихтэй. Гэхдээ энэ алба зөвхөн төсвийн байнгын хороонд төдийгүй УИХ-д байгаа бас нэг том байнгын хороо болох Эдийн засгийн байнгын хороонд тусалж, энэ 2 институцийг засгийн газраас хараат бусаар, байнгын бодлогыг, хууль тогтоох байгуулагуудын гаргасан шийдвэрийг гаргаж чадаж байгаа бол ийм байгуулга байгуулсаны ач холбогдол гарна гэж бодож байна. Энэ талаас нь сайтар бодож, хуулиндаа тусгаж ажиллавал зүйтэй гэж үзэж байна. Нөгөө талаас, Үндэсний статистикийн хороо, аудитын газар байсаар байтал бид яагаад ийм албыг тусад нь байгуулах гээд байна вэ гэдгийг зөв тайлбарлах хэрэгтэй байна. Үндэсний статистикийн газрыг энэ улсын макро эдийн засгийг тоо баримтанд тулгуурлан хараат бусаар гаргаад, УИХ болон олон нийтэд гаргаж өг гэж хуулиар ажлыг нь заж өгсөн. Аудитын хуулийг саяхан өөрчилж, санхүүгийн хараат бус байдлыг нь нэмэгдүүллээ. Энэ бүхэн бол хараат бус тоонуудыг авахын тулд л хийгдэж байгаа ажлууд юм. Энэ бүх тоонууд болон Сангийн яам болон засгийн газрын бусад байгуулагуудын ирүүлсэн тоонуудыг харьцуулж үзээд, дүн шинжилгээ хийдэг ийм байгуулгыг л байгуулах гэж байгаа юм. Энэ талаас нь үүнийг дэмжих нь зүйтэй. Гэхдээ ганцхан УИХ-ын Тамгын газартай холбоотой, УИХ-ын бусад байгууллагад тайлагнадаг, бусад байгууллагуудтай холбоотой байдаг байдлаар ажлыг нь зохион байгуулж өгвөл зүйтэй. Мөн энэ чиглэлийн мэргэжлийн төрийн бус байгуулагууд, Мэргэжлийн их дээд сургуулиудтай холбоотой ажилладаг байдлаар ажлыг нь зохион байгуулж өгвөл энэ алба цаашаа сайн явна. Ингэхгүй бол ажил нь явахгүй. Тийм учраас энэ талаас нь сайтар бодож хийгээсэй гэж хүсэж байна.

### **Гурилдсан, хуурамч төсөв баталж байгааг төрийн байгуулалтын институцийнх нь талаас анхаарч дүгнэх хэрэгтэй**

*УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан 09.00 цагаас “Б” танхимд хуралдаж, Монгол Улсын 2014 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хуулийн төслүүд /хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/, Төсвийн албаны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд /анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/ хэлэлцэх цээр УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлийн хэлсэн үг:*

Өнөөдөр Төрийн байгуулалтын байнгын хороо төсвийн асуудлаар ярьж байна. Мөн Сүхбаатар аймгын Халзан сумын Засаг даргын тамгын газрын барилгыг барих асуудлыг ярих юм байна. Үүнийг манай байнгын хороо ярих шаардлага бий юу? Төрийн байгуулалтын байнгын хороо Төсвийн тухай авч хэлэлцэхдээ:

1. Юуны өмнө институци талаас нь харж ярилцах ёстой байх. Хэд хэдэн байгууллагын тоног төхөөрөмжийг нэмэх эсэх тухай ярихаасаа

илүү, төсөв ерөнхийлөн захирагчдын хоорондын ажлын уялдаа буюу төрийн институциудын хоорондын ажлын уялдаа, төсвийг боловсруулах, хэрэгжүүлэх, зохиох бүх шатанд болж байна уу, үгүй юу гэдгийг ярих ёстой.

2. Төсвийн тухай хуулинд байгаа нэг заалтын дагуу, одоо засгийн газар хийх гэж байгаа 9 хүний бүрэлдхүүнтэй нэг институцийн тухай яримаар байна. Ерөнхий сайдаар ахлуулсан, Төрийн бус байгууллагууд, эрдэмтэдийн хамтарсан бүтэцтэй, өөрөөр хэлбэл төр, хувийн хэвшил, олон нийтийн байгууллага хамтран төсвийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх бүх шатанд нь үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор байгуулж байгаа институци юм. Энэ тухай бид ярих ёстой.

3. Төсвийн болон мөнгөний бодлого институцийн талаасаа хэр зэрэг уялдаж байна вэ, яагаад бид жил бүр төсвөөс их хэмжээгээр хасч, танаж байна вэ, яагаад үргэлж тодотгол хийж байдаг юм бэ, институци хоорондын гажиг нь юундаа, хаана байна вэ, яагаад ингээд яваад байгаа юм бэ гэдгийг бодож, ярьж, дүгнэлтээ хийдэг байх ёстой.

Тийм учраас өнөөдрийн байнгын хорооны дүгнэлтэнд миний оруулах санал бол:

1. Төсвийг боловсруулж, батлах, хэрэгжүүлэх шатанд төрийн байгууллагуудын, түүний дотор засгийн газар болон УИХ, төсөв ерөнхийлөн захирагчдын хооронд, түүний доод байгууллагуудын хооронд уялдаа холбоо муу байна. Энэ уялдаа холбоо муу байгаагын нэг илрэл нь бүх төрлийн хөрөнгө оруулалтуудын төслийг хэлэлцүүлэхээр оруулж ирэхдээ эдийн засгийн үр ашгийнх нь тооцоог хийж, үүгээр нь эрэмбэлэхгүй байна. Үүнийг ингэж оруулж ирж байхыг Төрийн байгуулалтын байнгын хорооноос шаардлага тавих ёстой.

2. Нөгөө нь хэдийгээр хуулинд төслүүдийг нийгмийн ач холбогдлоор нь үнэлнэ гэж заагдчихсан байгаа боловч, яг хэн нь, яаж үнэлэх нь тодорхойгүй, энэ нийгмийн ач холбогдлыг нь баталж нотолсон жагсаалт огт байдаггүй явдал юм. Эдийн засгийн үр ашгаар нь ч, нийгмийн ач холбогдлоор нь ч, энэ 2 үзүүлэлтийг нийлүүлээд эрэмбэлчихсэн жагсаалт хаана ч байхгүй байна. Тийм учраас ТББХ маань цаашдаа, бүх төрлийн төсөв захирагч нарт энэ жилийнхээ төсвийн эхний жилд ядаж 50%-ыг нь эхлээд эдийн засгийн үр ашгийг нь тооцоолж, коэффициентоор нь эрэмбэлээд, арын багананд нь нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлж, үүний дараа институци талаас нь энэ гажгийг арилгах боломж бүрэлдэнэ гэж үзэж байна. Энэ талаас нь энэ байнгын хороо бодож, ярьж байх нь зүйтэй. Би өөрөө эдийн засгийн байнгын хорооны гишүүнийхээ хувьд энэ талаар тэр байнгын хороон дээр юм ярьдаг боловч, төслүүдээ оруулах өрсөлдөөн явагдаж, бүгдийг нь төсвийн байнгын хороо руу оруулаад, тэнд вакуумжсан нөхцөлд ороод бүгдээрээ хасагддаг. Монгол орныг ингэж засаглах хэрэг байна уу? Ийм байдлаар төсвийг гурилдаж, хуурамчаар баталж, эцэстээ дотоодын нийт бүтээгдхүүний (-2)-оос хэтрээгүй, хариуцлагатай байгаа юм шиг харагдах мөртлөө дотроо асар хариуцлагагүй төсөл, төсөв баталдаг явдал давтагдаж байна. Энэ бүхний институцийн бүрэлдхүүн нь юу байна вэ гэдгийг хэлж өгсөн тийм л дүгнэлт манай хорооноос гараасай гэж хүсч байна.

**ТББХ-ны дарга А.Бакей:** - Таны гаргасан саналыг бид дүгнэлтэндээ тусгая. Энэ дашрамд хэлэхэд, танаар ахлуулсан “Төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах” үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж байгаа. Тэр хүрээндээ таны ярьж байгаа эдгээр асуудлуудыг бид анхаарах болно.

### **Манай ажлын хэсэг дээр гарсан санаануудыг тогтоолын төсөл, үндсэн чиглэл болон ажлын төлөвлөгөөнд тус тус оруулсан**

*“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсгийн 11 дүгээр сарын 11-ний хуралдааны тэмдэглэлээс:*

**С.Дэмбэрэл:** Би дөнгөж сая Монгол банкны ерөнхийлөгч, ерөнхий эдийн засагч нартай 2 цаг гаруй уулзаж, ярилцлаа. Тэгээд та бүхэнд тараагдсан материалыг дотор задалж ярилцаад, ганц нэг зүйл хасч, нэлээд зүйлийг тогтоолын хэсэгт орууллаа. Та бүхэнд тараагдсан зүйлс тогтоолын хэсэг, үндсэн чиглэл, ажлын төлөвлөгөө гэсэн 3 хэсэгтэй байгаа. Тогтоол жаахан уртсаж, үндсэн чиглэл арай багассан. Нэлээд зүйлийг ажлын төлөвлөгөө рүү оруулж өөрчилсөн. Түүнийг хараахан томъёолж бичээгүй байна. Удахгүй ирнэ. Өнгөрсөн амралтын өдрүүдэд Монгол банкныхан манай ажлын хэсгийн гаргасан саналууд дээр ажиллаж, өчигдөр шөнө 03:00 цагт боловсруулж дуусгасан байна. Манай ажлын хэсэг дээр гарсан санаануудыг тогтоолын төсөл, үндсэн чиглэл болон ажлын төлөвлөгөөнд тус тус оруулсан байна. Үүнийг сая сууж ярилцаад, засвар хийж ярилцсан. Маргааш өглөө бэлэн болно гэсэн. Гэвч өнөөдөр бэлэн болгож, ажлын хэсгийн гишүүдэд тараах хэрэгтэй байна. Манай ажлын хэсэг үүн дээрээ дахин нэг хамт сууж ярилцаад, тэгээд байнгын хороогоор оруулах хэрэгтэй. Цаг хугацаа бий. Шахаж яаруулах хэрэггүй л байгаа юм. Гэтэл төсвийн өмнө батлуул гээд яаруулаад байх юм. Гэвч төсвийн өмнө батлуулах ёстой гэсэн хууль байхгүй шүү дээ. Маргааш байнгын хорооны хурлын дараа ажлын хэсэг хуралдаад, нөгөөдөр юм уу, түүний дараа өдөр л байнгын хороогоор оруулмаар санагдаж байна.

**Б.Гарамгайбаатар:** - Нэгэнт маргаашийн байнгын хорооны хэлэлцэх асуудалд орчихсон учраас өглөө тайлбараа хэлээд, хойшлуулъя. Өөр арга байхгүй. Дэг нь тийм юм. Одоо энэ гар дээр байгаа зүйл хэр өөрчлөгдсөн бэ?

**С.Дэмбэрэл:** - Үндсэн чиглэлд нэлээд олон санаанууд нэмэгдсэн. Одоо Монгол банк дээр сүүлчийн байдлаар эмхэтгэгдэж байна. Тогтоол руу орох хэсгүүд нь ороод маргааш өглөө тогтоолын төсөл байдлаар гараад ирнэ. Үндсэн чиглэл төслөөрөө ирнэ. Мөн Монгол банкны ажлын төлөвлөгөө ч хамт бэлэн болчихно.

**Б.Гарамгайбаатар:** - Тэгвэл өнөөдөр бэлтгээд, маргааш тогтоолын төсөл дээрээ нэг бүрчлэн санал хураагаад, нөгөөдрийн байнгын хорооны хуралд оруулж болох юм байна.

**С.Дэмбэрэл:** - Бид л тохирч чадвал болно гэж бодож байна.

**А.Тлейхан:** - Манай намын бүлэг дээр С.Дэмбэрэл гишүүний гаргасан саяын санал дээр ярилцсан. МАН-ын саналыг авч тусгах юм бол цаашдаа саатуулах зүйлгүй, нэг мөр шийд гаргах боломжтой гэж үзэж байна. Бидэнд 5 санал л байна.

1. Мөнгөний бодлогын талаар манай намын бүлгээс 10 сарын 10-нд гаргасан 6 заалттай санал дүгнэлт байгаа. Түүнээс нэг заалт нь энд орхигдоод байна. Тэр нь, *“үнэ тогтворжуулах төслийн хөрөнгийн хэмжээ, дэмжих салбар, чиглэлийг нь гаргаж, УИХ-ын батлах тогтоол, шийдвэр дотор орох ёстой”* гэсэн зүйл юм.

2. Мөн УИХ-аас хэрэгжилтэнд нь хяналт тавих механизм байх ёстой гэж үзэж байна. Үүнийг ямар нэг хэмжээгээр тусгах хэрэгтэй байна. Эс тэгвэл манай намын гишүүд, үүнийг шаардаад, тогтоолыг батлахаас татгалзах магадлалтай.

3. Ажлын хэсгийн ахлагч С.Дэмбэрэл гишүүний бэлдсэн зүйл дээр 3 санал байна.

1) 1.5 дээр нэлээд хэдэн сангууд үүсгэж, тэр сангуудад Монгол банкнаас санхүүжилт оруулъя гэсэн санаа бий. Үүнийг манай намын бүлэг дэмжихгүй байна. Эдийн засгийн аль нэг бодит салбарыг дэмжих хэлбэрээр явсан нь дээр байх. Монгол банк сангууд руу мөнгө хийх нь зохимжгүй гэж үзэж байна.

2) 1.11 дээр *“төрийн өмчийн томоохон аж ахуйн нэгжүүдийн гадаад, дотоод төлбөр тооцоо, хадгаламжийн дансны гүйлгээнд Монгол банкнаас хяналт тавих механизм бий болгоно”* гэсэн байна. Энэ хэрэггүй байхаа. Монгол банк бол макро түвшний бодлого явуулдаг тул ийм жижиг зүйл рүү оруулмааргүй байна. Үүнийг хяналт тавьдаг бусад байгууллагуудад хариуцуулах нь зүйтэй гэж үзэж байна.

3) 1.12 дээр *“валютын ханшны өөрчлөлтөөс болж аж ахуйн нэгж, байгууллагуудад үцсэн алдагдлыг төв банк, засгийн газар хуваалцах тухай”* заасан байна. Энэ бас буруу байхаа. Ингэж хэт жижиг түвшин рүү орж ирж болохгүй. Ингэвэл жижиг наймаа эрхлэгч хүртэл нөхөн төлбөр авна гэдэг асуудал гарч ирнэ. Тиймээс энэ хэрэггүй гэж үзэж байна.

Эдгээр 4 саналыг анхаарч хүлээн авахыг хүсч байна.

**Б.Гарамгайбаатар:** - Манай байнгын хороо “үнэ тогтворжуулах талаар” төслийн хэрэгжилтэнд хяналт тавьдаг шүү дээ.

**А.Тлейхан:** - Байнгын хороо албан ёсоор хариуцдаггүй, шаардлага гарвал л ажлын хэсэг томилдог. Энэ гарч байгаа Мөнгөний бодлогын хэрэгжилтийг хянах асуудалд заавал заалт байх ёстой. Тэгж байж энэ зөв хэрэгжинэ гэж үзэж байна.

**С.Дэмбэрэл:** - Яг эдгээр асуудлыг Монгол банктай сая ярилцсан. Жишээлбэл, үнэ тогтворжуулах хөтөлбөрийг бүр нарийвчлан авч үзээд, дэд хөтөлбөр болгон оруулж, тэрний хэрэгжилтэнд анализ дүгнэлт хийх, хяналттай, ил тод байлгах талаар дэлгэрэнгүй заалт байдлаар хийгээд өгчихсөн байгаа. Яг танай намын бүлгийн дүгнэлтийн дагуу боловсруулж оруулсан. Хангалттай сайн зааж өгсөн. Тогтоол дотор нь орчихсон байгаа. Ерөнхийдөө мөнгөний бодлогыг манай байнгын хороо хянаад л яваа шүү гэсэн Б.Гарамгайбаатар гишүүний хариутай санаа нэг байна. Бүр яам болгоноор нь ярьж байгаа. Үүнийгээ улам сайжруулах л хэрэгтэй гэж бодож байна. 1.5 –ын хувьд, бас одоо байгаагаас арай өөрөөр хийхээр болсон. Үүнийг Н.Золжаргал тайлбарла даа.

**Н.Золжаргал:** - 1.5 –ыг УИХ-ын тогтоолын төсөлд ингэж томъёолсон. “Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэгжүүлэх ажлыг дэмжих” гэсэн байдлаар томъёолсон. Монгол банкнаас санхүүжилт хийх гэсэн томъёолол байхгүй.

**Б.Гарамгайбаатар:** - Энэ 1.5-ыг “Баялагын сан” зэрэг олон сангуудыг нэгтгэх бодлого барьж байгаатай уялдахгүй юм уу?

**С.Дэмбэрэл:** - 1.5-ыг тэгж уях хэрэггүй. Угаасаа тусгай сангуудын журам тусдаа байгаа. Харин энэ заалт нь тухайлбал, Засгийн газар хэрвээ “Жижиг дунд үйлдвэрүүдийг дэмжих сан”-г дэмжих бодлого баримталбал Монгол банк бас дэмжиж ажиллана гэсэн санаа болж өөрчлөгдсөн. Тэгж байж гарч байгаа элдэв гомдлууд шийдвэрлэгдэнэ. Жишээлбэл, “үнэ тогтворжуулах хөтөлбөр” дээр “хэдхэн секторуудыг л дэмждэг, бусдыг нь орхичихдог, шударга өрсөлдөөн үүсэх нөхцөл алга...” гэхчилэн гардаг гомдлуудыг хэрхэн зохицуулах талаар заагаад оруулчихсан байгаа. Засгийн газарт энэ чиглэлээр даалгаварыг нь өгчихсөн. Засгийн газар, Монгол банк 2-ыг хамтраад, ийм чиглэлээр нь анхаараарай, Засгийн газар нийт секторуудад эдийн засгийн тэгш орчин үүсгэхийг бодоорой гэж заасан. Мөн нөгөө талаас, эдийн засгийн нийт идэвхжлийг хангахын тулд Монгол банк, Засгийн газрыг дэмжээрэй гэж заасан. 1.11 –ыг бүр авчихсан.

**Н.Золжаргал:** - 1.12 –ын хувьд “гадаад валютын ханшийн эрсдлийг зээлдэгч, банк, засгийн газар хооронд харилцан хуваах замаар бууруулах тогтолцоогоо бүрдүүлэх” гэсэн байдлаар оруулсан. Үндсэн чиглэлд ч ингэж орсон. Өөрөөр хэлбэл, заавал ээлжтэй явдаг гэсэн санааг л гаргасан юм. Түүнээс, дурын хүнд нь ханшийн зөрүүг май гээд нөхөн төлбөр байдлаар өгөөд байх тухай заалт биш. Үндсэн санаа нь банк, харилцагч, засгийн газар эрсдлээ хуваах үндсэн зарчим, журмаа гаргаж өг гэсэн утгатай.

**С.Дэмбэрэл:** - Ингээд, МАН-ын гаргасан саналууд бүгд ингэж туссан байна. Сүүлийн хувилбарт тодорхой харагдана.

**Н.Золжаргал:** - “Үнэ тогтворжуулах” хөтөлбөрийн хэрэгжилтийг бид 2013 оны 04 сард тайлан тавьж байсан. Цаашид тогтмолжуулж болно. Үнийн дүн, чиглэл, салбар зэрэг мөнгөний бодлогын дотор байгаа компонент тус бүрээр зааж гаргаж бид чадахгүй. Өөрөөр хэлбэл мөнгөний бодлогын хэрэгсэл тус бүр рүү орсон үндсэн чиглэлийн заалт байж болохгүй. Үүнийг тогтоолоор зааж өгөх боломжгүй юм. Тухайлбал, Монголд энэ сард тэдэн төгрөгтэй байна шүү гэдгийг зааж тогтоох боломжгүй юм.

**С.Дэмбэрэл:** - “Үнэ тогтворжуулалтын хөтөлбөр”-т манай байнгын хорооны саяхны нэг ажлын хэсгийн шалгалтаар гарсан гол зөвлөмжүүд, Аудитын газрын зөвлөмж зэргийг бүгдийг тусгачихсан байгаа. Хөтөлбөрт хяналт тавьдаг механизм нь байгаа учраас түүнийг төгөлдөржүүлэх асуудлыг л ярилцъя. Хяналт тавих механизм, чиглэлүүдийг нь тодорхой болгоод заалт болгоод оруулчихсан. Анхны төсөл дээр хяналтыг “үргэлжлүүлнэ” гэсэн байсан бол одоо нэлээд дэлгэрэнгүй заалт болоод орчихсон. Сүүлийн хувилбар дээр ийм ийм чиглэлээр, энэ энэ субъект, ингэж хяналт тавина, ингэж анхаарна гээд тодорхой заачихсан учраас одоо нэмж оруулах хэрэггүй болсон. Тэр тогтоолд орчихсон. /Н.Золжаргал холбогдох заалтыг уншив./

**Л.Энх-Амгалан:** Яагаад санамж бичиг гэж байгаа юм бэ? Гэрээ байх ёстой биш үү?

**Н.Золжаргал:** - Гэрээ байж болохгүй. Тэгэх юм бол Монгол банк, Засгийн газар 2 ёстой та нарын хэлдгээр “нэг хөнжилд” орчихно. Монгол банк бие дааж үйл ажиллагаа явуулж, шийдвэр гаргаж байх ёстой. Бид



уян хатан хэлбэрээр үйл ажиллагаа явуулахын тулд гэрээ биш, санамж бичиг байдлаар хамтарч ажиллах сонирхолтой байгаа... Гэрээ хийчихвэл өөрчлөх аргагүй, зарим хөтөлбөрийн мөнгийг буцаан татах боломжгүй болчихно. Харин хөтөлбөрт өөрчлөлт орвол буцаан татдаг байх сонирхол бидэнд бий.

**С.Дэмбэрэл:** - Гэрээ хийж болохгүй үндэслэл бий. Бид төв банкны бие даасан, хараат бус байдалд нь нөлөөлөхүйц гэрээ хий гэж тулгаж болохгүй. Энэ институци ямар түвшинд Засгийн газартай хамтран ажиллахаа өөрсдөө шийдэх эрхтэй шүү дээ. Санамж бичгээр үү, гэрээгээр үү гэдгээ бие дааж шийдэх ёстой. Энэ чинь хуулиараа бие даасан, хараат бус институци. Түүнд нь халдаж болохгүй. Энэ бол санамж бичиг. Харилцан ойлголцлын бичиг ч биш, гэрээ ч биш. Тодорхой ажил дээ, эдийн засгийн тодорхой секторууд дээр дэмжлэг үзүүлэх зорилгоор явуулж байгаа хамтын ажиллагааны бичиг шүү дээ.

**Л.Энх-Амгалан:** - Санамж бичиг гэдэг чинь юу юм бэ? Гэрээ байгуулахын өмнөх шат биш үү?

**С.Дэмбэрэл:** - Заавал гэрээ болох албагүй л дээ. 3 жилийн хугацаатай байгуулсан санамж бичиг дотор хөтөлбөрийг хэрэгжүүлэх үед тавих хяналтууд маш хангалттай хийгдчихсэн байгаа.

**А.Тлейхан:** - Хөтөлбөр дотор чинь тоо алга байна л даа. Ерөнхийд нь заачихсан учраас тодорхой бус байна гэж үзээд байгаа юм. Хэмжээ, чиглэл нь тодорхой биш байна. Хэдэн их наяд төгрөгөөр юуг санхүүжүүлнэ гэж заагаагүй байна шүү дээ.

**Н.Золжаргал:** - Тооны хувьд нэг л тоо хэлж болно. УИХ-аас нийт М2-ынхоо дүнг тогтоочихвол бидэнд мөнгөний бодлого боловсруулах ч шаардлагагүй болчихож байгаа юм. Мөнгөний бодлого дотор байдаг 1 компанентыг бид авчиргаад тоо заагаад, хатуу чиглэл заагаад явчихаар мөнгөний бодлого маань уян хатан чанараа алдчихна. М2 маань 20%-оос илүү гараад явчихвал бид хөтөлбөрүүдээ аяндаа татна.

**С.Дэмбэрэл:** - Монгол улсад мөнгөний бодлогын дэглэм маань мөнгөний агрегатуудыг онилдог дэглэм биш юм шүү. Энэ улс орнууд аль хэдийн орхичихсон дэглэм. Тийм учраас ийм байна ч гэж бас хэлж болохгүй. Манайх бол инфляцийг онилох чиглэл рүүгээ явж байгаа л улс орон. Чиглэл бол маш тодорхой байгаа. Энэ чиглэлүүд маань л үргэлжилнэ. Дэд хөтөлбөрүүдээрээ үр дүнг нь хэмжинэ. Тэрнийхээ үндсэн дээр ямар ололтууд гарсан, ямар дутагдал гарсан юм бэ, тэгэхээр дараа жилдээ зах зээлийн зарчмаар үе шаттай шийднэ гэж ярьж байна шүү дээ. Зах зээлийн зарчмаар үе шаттай шийднэ гээд өгүүлбэрээр хэлчихсэн юмыг заавал тоогоор илэрхийлнэ гэдэг бол маш буруу зарчим юм шүү.

**А.Тлейхан:** - Тэгэхээр, та нарыг тоо, чиглэл зааж болохгүй гэсэн хуулийн заалтаа аваад ир гэвэл юу гэж хэлэх улс вэ? Тийм заалт байхгүй шүү дээ. Тиймээс тэр 4 үндсэн чиглэлийнхээ нэрийг, 3 их наяд төгрөг хүртэл гэдгээ л оруулаад биччих л дээ. Энэ чинь юу нь хүнд байгаа юм бэ? Манайх шиг ийм том намын саналыг хүлэж авахгүй байж болохгүй шүү дээ. Үгүй гэвэл, би намын бүлэг дээрээ очоод, ажлын хэсгийн дарга С.Дэмбэрэл манай намын саналыг хүлээж авахгүй байна гээд л хэлчихье. Бидэнгүйгээр хийх гээд байгаа юм бол бид оролцохоо больчихье.

**С.Дэмбэрэл:** - Та тайвшир. Ийм юман дээр бухимдаад яах вэ. Би тэр чиглэл гэдгийг чинь ойлгохгүй байна. Миний ойлгож байгаагаар, энэ хөтөлбөр дотор тэр тэр секторуудад гээд заачихсан байгааг нь би чиглэл гэж ойлгож байна. 4 чиглэл бий. Түүнийг дэлгэрэнгүй болго л гэж ойлгож

байгаа юм байна. Өөрөөр хэлбэл, “*үнэ тогтворжуулах хөтөлбөрүүдийг ... тэр, тэр секторуудад 2014 онд үргэлжлүүлнэ*” гээд дэлгэрэнгүй өгүүлбэрээр давтаад бич гэж байгаа юм байна.

**Б.Гарамгайбаатар:** - Тлейхан гишүүн ээ. Өмнө нь УИХ жил бүр мөнгөний бодлогоо зөндөө л баталж байсан биз дээ. Стандартаар хийгддэг өмнөх зүйлсээс чинь юу нь өөрчлөгдөө вэ? Тогтоолд ганц нэг онцлог зүйл л өөрчлөгддөг биз дээ? Зөвхөн манайд ч биш, нийтдээ л тийм практиктай биш үү?

**А.Тлейхан:** - Өмнө нь “Үнэ тогтворжуулах хөтөлбөр” гэдэг хэлбэрээр Монгол банкнаас ийм их хэмжээний мөнгө гаргаж байгаагүй. Тийм учраас шинэ зүйлд шинээр л хандах ёстой гэж бодож байна.

**С.Дэмбэрэл:** - За ойлголоо. Хэдийгээр саяхан чиглэл тус бүрээр нь ярьчихсан ч гэсэн, чиглэлүүдийг дэд хөтөлбөр тус бүрээр нь биччихье... Та нарын тавьсан бүх саналыг сонслоо. Та нар улстөржихөөр улсууд биш шүү дээ. 2013 оны мөнгөний бодлого батлах үед та нар УИХ-ын гишүүний эрхтэй байсан ч байнгын хороонд хуваарилагдаагүй байсан. Тэр үед Монгол банк та нарын харуулаад байгаа шиг зүйлийг үзүүлээд, түүн дээрээ үндэслэн мөнгөний бодлогоо боловсруулаад оруулаад ирсэн юм. Тэр нь “*Инфиляцийн нийлүүлэлтийн гаралтыг ихэсгэнэ...*” гэсэн үгээр илэрхийлэгдэж байсан юм. Үүний үндсэн дээр 4 дэд хөтөлбөр хэрэгжүүлсэн байна. Зээлийн тасалдал 2013 онд болж магадгүй гэдгийг урьдчилан тооцоолсон учраас арилжааны банкнуудыг татан оролцуулсаныгаа үргэлжлүүлэх л бодлого явж байна.

**Б.Гарамгайбаатар:** - Тлейхан гишүүний намаасаа оруулж ирсэн саналуудыг хүлээж авлаа шүү дээ. Одоо цаашаа явъя.

**А.Тлейхан:** - 4 санал хэлсэн. 3-ыг нь оруулахаар болсон. Одоо ганцхан манай намын бүлгээс тавьсан “*үнэ тогтворжуулах хөтөлбөр цаашид хэрэгжих юм бол, хэдий хэмжээний мөнгөөр ямар салбарыг дэмжих юм бэ, үүнийг эргэж хянах механизм нь ямар байх ёстой юм бэ гэдгийгээ илүү тодруулж өгөөч*” гэсэн зүйлийг л шаардаад байна л даа. Үүнийгээ тодорхой болгохгүй бол манай намын нөхдүүд маргана гэж анхааруулаад байгаа юм.

**С.Дэмбэрэл:** - Чиглэл бол тодорхой. УИХ-аас хоорондоо санамж бичиг байгуулчихсан энэ 2 субьектэд “та нар энэ жилийг тэдийг зарцуул гэж хэлж болохгүй биз дээ? Нэг нь Засгийн газар, нөгөөх нь бие даасан хараат бус байгууллага шүү дээ. Эсвэл энэ 2-ын аль нэг нь дангаараа шийд гаргаж болохгүй биз дээ. Энэ чинь үргэлжилж байгаа процесс учраас, “энэ жил ийм ийм зүйлүүдийг анхаараад, үүн дээр тухайлбал нефть компаниудад ийм зүйл болсон байна. Арилжааны банкнуудад ийм ийм зүйл хэрэгтэй байна...” гэхчилэн хоорондоо яриад гарцаа гаргаад явах ёстой зүйл шүү дээ. Бид юунд нь оролцох юм бэ?

**А.Тлейхан:** - Бид зарцуулах дээд хэмжээг нь тавьж өгөх ёстой юм. Харанхуйгаар юм баталж болохгүй шүү дээ. Ямар нэг хэм хэмжээ байх ёстой биз дээ?

**С.Дэмбэрэл:** - Мөнгөний бодлого явуулна гэдэг чинь мөнгө гаргана л гэсэн үг шүү дээ. Бид Монгол банкинд мөнгөний нийлүүлэлтийг 2014 онд тэд болго гэж хэлдэггүй биз дээ? УИХ-ын түүхэнд хэзээ ч тэгж хэлж байгаагүй. Тэрэнтэй л адилхан шүү дээ... Тэгэхээр бид ойлголцлоо. Маргааш өглөө бүх зүйл бэлэн болохоор дахин ярилцъя. өнөөдөр ажлын хэсгийн гишүүдэд тараамаар байна. Аль болох эрт тараагаарай. Ажлын хэсгийн хурал амжилттай боллоо. Та бүхэнд баярлалаа.

## 100% экотехнологи бий

**“Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн Эдийн засгийн байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээс:**

**УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл:** - ... 3.1.9 болгож байгаа хэсэг дээр зүйл бол “*value accounting* буюу *үнэ цэнийг нь үнэлэх*”, “*wealth accounting* буюу *баялгыг үнэлэх*” гэдэг Олон улсын 2 үндсэн томъёолол болон “WAVE” гэсэн нэртэй Дэлхийн банкнаас хэрэгжүүлж байгаа, улс орон болгон байгалийн ашиглалтаа зөв үнэлж, бүртгэх асуудал юм. Тэр бүр улс орнууд “*capital accounting* буюу *хөрөнгийнхөө бүртгэл, үнэлгээ*” -гээ хийж чадахгүй байгаа учраас одоо дөнгөж яригдаж байгаа асуудал л даа. “*Ашигт малтмалын ордыг үнэлэх*” гэх юм бол одоогийн бид нарын ойлголт. Харин баялгын үнэлгээ, бүртгэлийн олон улсын стандартыг нэвтрүүлэх гэвэл сая орчин үеийн дэлхий нийтийн чиг хандлагатай тохирно. Би мэргэжлийн хүн биш ч гэсэн үүнийг мэргэжлийн хүмүүсээс дутахгүй мэдэж байна.

**Баатарцогт (Ажлын хэсгийн гишүүн, уул уурхайн яам):** энэ хэсэгт ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал гэж бий. Өөрөөр хэлбэл “*mineral resource, mineral reserve*” гэдгийг олон улсын жишгээр нь Монголд нэвтрүүлбэ гэдэг санаагаар энд орж ирж байгаа. Тэгэхээр ашигт малтмалын баялаг, ордын нөөц гэсэн үгээр хэрэглэвэл мэргэжлийн хэллэг болно гэж бодож байна.

**С.Дэмбэрэл:** - үүнийг чинь орчин үеийн жинхэнэ хэллэгээр нь бол “*байгалийн буюу natural capital*” гэж нэрлэдэг. Одоо бүх дэлхий даяар ингэж яриад явж байна.

**Б.Гарамгайбаатар:** за тэгвэл, “*Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийг үнэлэх олон улсын стандартад шилжих...*” гэж өөрчилцгөөе. /**Санал хурааж, дэмжигдлээ.**/

3.1.11-ыг нэмэх тухай. “*Эрдэс баялгын мэргэжлийн зөвлөлийн өнөөгийн тогтолцоог өөрчилж, олон улсын жишигт нийцүүлэх үүргийг мэргэжлийн холбоод, мэргэшсэн шинжээчдэд шилжүүлэх чиглэл баримтлах*”

**С.Дэмбэрэл:** - “*чиглэл баримтлана*” гэж юу гэж байгаа юм бэ? Энэ чинь хуурамч өгүүлбэр байна. “*шилжүүлэх*” гээд л бич. Нэг их чиглэл гаргаад, тэрнийгээ баримтлаад 10-20 жил явах уу? Тэр илүү үгнүүдээ хас. /**Санал хурааж, дэмжигдлээ.**/ ...

- 3.2.1.2 дээр зөвшөөрөл олгох талаар орсон байна. Хайгуулийн тусгай зөвшөөрлийг хэн олгодог юм бэ? Нэг байгууллага олгодог байх тийм үү? Тэр Кадастрын байгууллагын ил тод байдлыг л хангах тухай заалт байна. Түүнээс биш хууль зөрчих асуудал байх ёсгүй. Түрүүлж ирсэн нь зөвшөөрөл авдаг явдал бол олон улсын жишиг, өрсөлдөөнт зарчим. Энд байгаа гол санаа нь үүнийг эсэргүүцсэн явдал биш, харин ил тод бус байдлын улмаас мэдээлэлд ойрхон байдаг хүмүүс нь зөвшөөрөл авчихаад байна гэсэн утгатай бололтой. Тиймээс кадастрын байгууллагынх нь нээлттэй, ил тод ажиллах зарчмыг хангана гэсэн утгаар л оруулбал илүү тохиромжтой. Тэрнээс одоо байгаа байдлаараа бол хууль зөрчсөн заалт болчих гээд байна. /**Санал хурааж, дэмжигдлээ.**/ ...

- 3.3.3 -дээр “*байгаль орчин, хүний эрцл мэндэд сөрөг нөлөөлөл багатай*” мөртлөө “*тэргүүний технологи*” гэж ер нь байж болох уу? Ийм

юм дэлхий дээр байхгүй болчихсон. Үүнийг “сөрөг нөлөөгүй” эсвэл “*эерэг нөлөөтэй*” гэдэг үгээр л солих хэрэгтэй. Сөрөг нөлөөлөлгүй технологиуд бий. Ийм технологи байхгүй гэж ярьж болохгүй. Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй технологиудыг хүн төрөлхтөн өнөөдөр гаргаад, хэрэглээд явж байна. /*Санал хурааж, дэмжигдсэнгүй. Хэвээрээ батлагдлаа*/ ...

- 3.3.5 –дээр Олон шалгалт, хураамжийн давхардал үүсч байгааг зохицуулахад ийм хэн ч тоохгүй, сулбагар заалт байж болохгүй. Уг нь их зөв санаа байна. Тиймээс үүнийг тодорхой хэлж өгөх хэрэгтэй. Жишээлбэл, “*уул уурхайн цйл ажиллагаанд төв, орон нутгийн зүгээс хяналт тавихдаа, давхардуулахгүй байх зарчим баримтална.*” гэж болно. Ингэж хүчтэй, тод зааж өгөх хэрэгтэй. /*Санал хурааж, дэмжигдсэн*/ ...

- Сүүлийн үед, бүх юманд “*өртөг шингээнэ*” гэж яриад байдаг болчихлоо. Үүн шиг худлаа юм байхгүй шүү. Бүх юманд нэмэгдсэн өртөг шингээж үйлдвэрлэж чадахгүй шүү дээ. Хүүхдийн бодлого шиг юм яваад байна. Улс даяараа л “*нэмцү өртөг шингэсэн юм бүтээгээд л ёстой сайхан хөгжинө*” гэсэн юм боддоогоо болих хэрэгтэй. Улс орнуудад тэгж хөгжсөн түүх тэр бүр байдаггүй юм шүү.

- Бид өмнөх заалтуудаараа “*хариуцлагатай, ил тод уул уурхай байх, бүх компаниуд хүний эрцүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй технологитой байх*” гээд шаарлага тавьчихлаа. 3.5 –ын гол зорилго бол орон нутаг ба уул уурхайн компаниудын харилцааг л тодорхойлох гээд байна. Тэгэхэр орон нутаг маань бас өөрсдөө тогтвортой хөгжих зорилт тавьж байгаа. Үүнд нь тухайн уул уурхайд гадаад, дотоодоос хөрөнгө оруулагч тал маань хувь нэмэр оруулах үүрэгтэй болохоос биш, хатуу тогтоосон гэрээгээр үүрэг хүлээнэ гэхээр арай болохгүй болчих гээд байна.

- 3.5.1 дээр “*уул уурхайн олборлолт эхлүцлэхээс өмнө эрх зүйн орчныг боловсронгуй болгох*” гэдэг чинь бас юу гэсэн үг вэ? Ийм юм байж таарахгүй. Хууль дүрмийг хүлээж байгаад эхлэх юм уу? Уул уурхай эхлэхээс нь өмнө хууль хийх гээд байгаа юм уу? Энэ дээр байгаагаар бол орон нутаг тус бүрт нь уул уурхайтай холбогдсон нэг нэг эрх зүйн орчин бүрдүүлэх юм шиг бас ойлгогдоод байна. Энэ их утга муутай өгүүлбэр байна. Уул уурхайгаас олсон орлого нэмэгдэхийн хэрээр орон нутагт үзүүлэх хувь нэмэр ихсэж байхаар зохицуулга хийх заалт, нөгөө талаар “*орон нутгийг хөгжүүлэх гэрээг*”, хөрөнгө оруулагч тал болон нутгийн өөрөө удирдах байгууллага энэ чиглэлээр хамтран ажиллана эсвэл хамтран ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлнэ гэсэн байдлаар оруулж болох юм. Эс тэгвэл нэг их шахсан юм болчих гээд байна.

## **Мөнгөний бодлого ярьж байхад, ямар нэгэн улс төр ярьмааргүй байна**

*Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүцүлгийг хийсэн УИХ-ын Чуулганы 11 сарын 13-ны Лхагва гарагийн Нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс:*

*Илтгэл: “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах Үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүцүн, Ажлын хэсгийн ахлагч С.Дэмбэрэл уншиж танилцуулав. Төсөлтэй холбогдуулан УИХ-ын гишүцүд асуулт асуулаа.*

**А.Бакей:** – Ажил хэрэгч хандаж ажилласан байдал харагдаж байна. Гэхдээ асууж тодруулах зүйл байна. Валютын захад тогтворгүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна гэсэн дүгнэлтийг байнгын хороон дээр хийж байгаа юм байна. Валютын захад банк санхүүгийн байгууллага, санхүүгийн зах зээлийн бусад оролцогчдыг идэвхтэй оролцуулна гэсэн байна. Тэгэхээр өнөөдрийн байдлаар валютын зах зээл тогтворгүй байдал байна. Үүнд олон шалтгаан байгаа. Гол шалтгаан нь юу байна. Түүн дотроо валютын зах зээлд оролцож байгаа банк бус байгууллага, бусад оролцогчид нөлөө үзүүлж байгаа юм байна гэж үзээд энэ дүгнэлтийг хийсэн үү, эсвэл өөр үндсэн шалтгаан бас байна уу? Өөр ямар шалтгаан байна вэ? Валютын зах зээлд банкны бус байгууллагуудыг, тухайлбал бидний хэлэлцэж суралцсанаар ченжүүдийг идэвхтэй оролцуулна гэсэн байна. Чухам яаж идэвхтэй оролцуулах талаар хариулт авмаар байна.

**С.Дэмбэрэл:** - А.Бакей гишүүний асуултанд хариулья. Та бүхэн санаж байгаа бол валютын ханшны талаар анхны төсөлд нэг заалт байгаа. Одоо УИХ-ын тогтоолд болон 2014 оны мөнгөний бодлогын үндсэн чиглэлд валютын ханшны талаар хэд хэдэн заалт орсон. Үүний гол шалтгаан бол 1-рт, өнгөрсөн сард болсон валютын ханшны хэт хэлбэлзлийн уг шалтгаан, хүчин зүйлүүдийг судлахаас гадна ер нь монголд валютын ханшны бодлогыг сайжруулах чиглэлээр институци хоорондын хамтын ажиллагаа, харилцан уялдааг хангах, валютын зах зээлийг боловсронгуй болгох шаардлага тулгарч байна. Тийм ч учраас энэ валютын зах зээлийн чиглэлээр ажилладаг санхүүгийн зохицуулах хороо, Төв банк болон төрийн бус байгууллагуудын төлөөллүүдийн саналыг авсны үндсэн дээр энэ саналыг оруулж ирж байгаа юм. Валютын санхүүгийн зах зээл бол өөрөө нарийн нийлмэл бүтэцтэй, монголд үүсэн эрчтэй хөгжиж байгаа ийм зах зээл. Тийм учраас санхүүгийн зах зээлийн бүрэлдэхүүн болсон валютын зах зээлийг цаашид төгөлдөржүүлэх чиглэлээр институцийн хэмжээнд төдийгүй, валютын захын үүсмэл хэрэгсэл гэх мэт бусад валютын захаас үйл ажиллагааг нь сайжруулах энэ чиглэлийн заалтыг оруулж өгсөн. Түүний дотор валютын системийн тогтолцоог үүсгэнэ гэдэг маань, валютын зах зээлийн оролцогчдыг төдийгүй валютын зах зээлд хэрэглэгддэг үүсмэл арга хэрэгслүүдийг валютын зах зээл дээр хөгжүүлэх замаар иж бүрэн, тал талаас нь авч, цааш цаашид валютын зах зээл дээр урьдчилсан төсөөлж болохуйц, эрсдлүүдээс нь хамгаалж болохуйц арга хэрэгсэл бүхий, валютын зах зээлд дэх эрэлт нийлэлтийг илүү бодитой тодорхойлж чадах оролцогчид болон субъектүүдийн хамтын ажиллагааг хангасан, тухайлбал банкууд, банк бус санхүүгийн байгууллагууд, томоохон экспортлогч, импортлогч гэх мэт төлөөллүүдийг оролцуулсан байдлаар энэ үйл ажиллагааг байдлаар төгөлдөржүүлэх юм. Өнөөдөр бид бүхэн ганцхан шалтгаан буюу яагаад валют ингэж өсчихвөө гэдэг ганц шалтгааныг л их төлөв яриад байгаа. Ажлын хэсэг олон талаас нь судалж үзээд, Монголбанктай олонтоо зөвлөлдсөний эцэст энэ асуудлыг оруулсан юм.

**Д.Ганбат:** - Мөнгөний бодлого маш чухал. Өмнө би байнгын хороон дээр асууж байсан. Одоо чуулган дээр тодруулж асуумаар бна. 2013 онд мөнгөний бодлого яаж хэрэгжиж байсныг бид нар нэг дүгнээд хэлчимээр байна. 2013 онд Монгол улсын мөнгө, банкны зах зээл дээр нилээд хүндрэлтэй асуудал байсан. Би Монголбанкныг нилээд сайн чадварлаг ажиллав уу гэж дүгнэж байгаа. Энэ оны 7-8 сарын Хадгаламж банкны асуудал байна. Үүнийг нэг их хүндрэлгүйгээр ганц өдрийн дотор Төрийн банк боллоо.



Гэхдээ бид нарт бас шүүмжлэлтэй хандах юм байна. Тухайн үед УИХ, Засгийн газар маань юу хийж байсан бэ? Энэ асуудал бол тодорхой байсан. Хоёр гурван жил үргэлжилсэн ийм ноцтой асуудал байсан. Тэр үед манай ширээний 3 л байсан, бусад нь амраад явсан байсан. Монголбанк яаж ажиллаж байна, яахав ийхэв гэсэн ийм ноцтой асуудалд УИХ, Засгийн газар ийм хариуцлагагүй байж болохгүй. Цаашид Монголбанкны явуулж байгаа арга хэмжээнүүдээс дотроос онцолж хэлэхэд, урьд өмнө хэзээ ч байгаагүй, дундаж давхаргаа дэмжих 8%-ийн хүүтэй зээл гаргасан. Энэ бол нилээд ард түмэндээ хүрсэн ажил байсан. “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-ийг би нилээд шүүмжлэлтэй ханддаг байсан. Гэтэл ажиглаад байхаар, манай Монгол улс бол 70-80 жил социализмаар явсан, бас 2000 оноос хойш 1 нам дангаараа эрх барьж байсан /манай АН ч бас хамтраад орж байсан байх/. Гэхдээ бараг социализм байгуулах шахуу халамж өгөөд сургачихсан байсан ард түмэндээ. Тийм учраас гэнэтхэн татаж болохгүй 30-40% ядууралтай ,ажилгүйдэлтэй байгаа энэ улс оронд иймэрхүү байдалтай явуулах нь зүйтэй юм байна. Үүнийг шат дараалалтай явуулж байгаа нь зүйтэй. Гол асуух зүйл маань, Хадгаламж банк маань Төрийн банк боллоо. Ер нь цаашдаа манай мөнгөний бодлогоор арилжааны банк маань төрийн банк болоод байх уу, хувийн банкаараа байх ёстой юу? 2014 онд хөрөнгө оруулалт маань нилээд хүндрэлтэй болж байна. УИХ, Засгийн газраас ч болж байгаа байх. Цаашдаа яах нь мэдэгдэхгүй байна. УИХ-ийн хувьд хуулийг хугацаанд нь баталж чадахгүй байна гэж шүүмжлэх гэж байна. Засгийн газрын хувьд хөрөнгө оруулалтыг татаж чадахгүй байна гэж шүүмжлэх гэж байна. Монголбанк ийм хүнд нөхцөлд 2013 онд Засгийн газартайгаа нилээд сайн хамтарч ажиллаж байна. 2014 онд яаж ажиллах вэ? Дахиад Хадгаламж банк шиг эрсдэлтэй банк байна уу? Засгийн газартайгаа хамтарч ажиллах уу? Өнөөдөр 2014 онд арай өөр байдал бий болж эхэлж байна. Үүнийг бодолцож үзсэн үү гэсэн ийм 2 асуултыг тавьж байна.

**С.Дэмбэрэл:** - Би хариулчихъя. Н.Золжаргал ерөнхийлөгч нэмээд хариулаарай. Монголбанк 2013 онд яаж ажилласан талаар, УИХ-аас Эдийн засгийн байнгын хорооноос миний ахалсан өөр нэг ажлын хэсэг гараад Монголбанк, Санхүүгийн хороо, Үндэсний статистикийн газрын ажлыг шалгаад, Аудитын газар нь дүгнэлтээ гаргасан. Мөдхөн байнгын хорооныхоо хурлаар хэлэлцүүлнэ. Эхний үр дүн бол Монголбанк 2013 онд тавьсан зорилгоо хэрэгжүүлжээ гэж хэлж болно. Гэхдээ валютын ханштай холбогдсон асуудлыг бид зөвхөн Монголбанкттай төдийгүй, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн бусад 2 субьекттэй холбоотой хариуцлагын асуудлыг бид ярих ёстой. Тэр нь юу вэ гэхээр, саяхан болсон, одоо хүртэл өндөр хэвээрээ байгаа валютын ханшны хэлбэлзлийн үед энэ байгууллага институцийнхэн хувьд тогтвортой ажиллаж чадаагүй. Үүнийг шалгалтын явцад протоколын үндсэн дээр тогтоосон. Хэдийгээр шуурхай байдлаар Засгийн газар, Монголбанкны хооронд үйл ажиллагаа явагдаж байсан боловч, яг энэ процесст Монголбанк л голцуу, ганцаараа ажилласан гэдгийг онцолж хэлэх нь зүйтэй байхаа. 2014 оны мөнгөний бодлогын хувьд, анх орж ирсэн төсөл нилээд их өөрчлөгдсөн. УИХ-ийн тогтоолын төсөлд 2014 онд, Монголбанкныг, түүний дотор мөнгөний бодлогыг ямар байдлаар явуулах талаар концепцийн хувьд илүү гүнзгийрүүлсэн, “Гол нэрийн барааны үнэ тогтворжуулах хөтөлбөр” дээр шалгалтын явцад болон

ажлын хэсгийн хуралдааны явцад гарсан алдаа, ололтыг нэгтгэж ярилцаад, тодорхой тодорхой өгүүлбэрүүдээр бодлогын томьёоллуудыг гаргасан байгаа. Энэ зарчмын зөрүүтэй зүйлсийг санал хураагаад ирэхээр та бүхэнд мэдэгдэх болно. Одоо та бүхэнд тараагдсан материал дотор байгаа.

**Н. Золжаргал:** – Хариуцлагатай хэлмээр зүйл бол Хадгаламж банкны проблем бол 2-3 жилийн өмнөөс эхэлсэн асуудал байсан. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ нь бусад банкнуудаас 2-3 дахин бага хэмжээнд 2-3 жил гаруй явсан байсан. Энэ хугацаанд өөрийнхөө активыг нэмээд байсан боловч, хөрөнгөө нэмж чадахгүй явсаар байсан тул өөрийн хөрөнгөө хангалтгүй, нэмж чадахгүй болсон гэдэг үндэслэлээр энэ банкыг татан буулгах арга хэмжээ авсан. Одоо Монголын банкны систем анх энэ хөтөлбөрийг хэрэгжүүлж байхад 3 банк байсан. Хадгаламж банк маань ганцаараа үлдсэн байсан учраас сая энэ арга хэмжээнд аргагүй орсон. Бусад банк бол өөрийн хөрөнгийн хүрэлцээ хүрэлцээтэй байгаа. Яг одоо монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа банкууд маань Монголбанкнаас явуулдаг шалгаруулалтыг хангаж байгаа. Бүх банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ хангалттай байгаа. Энэ жил дүрмийн сангийн цэсээ 2 дахин нэмсэн боловч банкнуудын үзүүлэлтүүд сайн байгаа. Саяны Хадгаламж банкны асуудал бол онцгой тохиолдол. Олон жилийн өмнөөс эхэлсэн байсан. Сая бид нар зах зээлд доргион багатай, хадгаламж эзэмшигч, харилцагчидад нь алдагдалгүй, ялангуяа Хадгаламж банканд ажиллаж байсан 3000 ажилчдын нэг нь ч ажлын байраа алдалгүйгээр, богино хугацаанд хийх зайлшгүй шаардлага гарсан. Бид нараас нилээд их ажил, хөдөлмөр, ажилбарууд шаардагдсан. Төрийн өмчийн банк Монголын Эдийн засаг дотор, банкны систем дотор онолын хувьд байж болох хэдий ч, зохистой засаглалын шалгуур үзүүлэлтээр ч, зах зээлийн өрсөлдөөн, зохицуулалтаар ч, Монголын банкны системд байх нь зохимжгүй юм гэдэг үүднээс, Монголбанкны зүгээс сүүлийн 2-3 жил /төрийн банкыг байгуулагдсан цагаас нь хойш/ хувьчлах жагсаалтанд оруулж өгөөч гэсэн саналыг гаргасан. Энэ жил ч гэсэн бид нар шийдээ өгсөн хэвээр байгаа. Мэдээж шийдвэр Засгийн газар, УИХ-ийн түвшинд гарах учраас манай Монголбанкнаас гаргадаг санал маань ерөнхийдөө нэг жигд төрийн өмчийн банк гээд зохистой засаглалын шаардлагагууд дээрээс нь зах зээлийн өрсөлдөөнд тавьдаг шаардлагууд, банканд дээр тавьдаг өөр өөрийн бусад шалгуур үзүүлэлэлтүүд яг адилхан үйлчилж байгаа. Монголбанкны зүгээс ялгаварлалгүй, нэг төрлийн шалгуур үзүүлэлтүүдээр бүх банкуудаа хянахыг хичээдэг. Энэ түвшинд авч явахыг хичээж байгаа. Д.Ганбат гишүүний асуултанд товч хариулья гэвэл, ер нь Монголбанкны хувьд төрийн өмчийн банк эдийн засаг дотор байх нь зохимжгүй юм гэсэн дүгнэлттэй байгаа.

**С.Дэмбэрэл:** - Би Д.Ганбат гишүүний асуултанд бас тодруулж хариулья. Өчигдөр орой ажлын хэсэг дээр төрийн өмчийн банк, хөгжлийн банкны хоёрын талаар ярилцсан. Төрийн өмчийн банкыг цаашид, сайн засаглалын, банкны сектор, 2014 онд хэрэгжих Монголбанкны 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд, эдийн засгийн байнгын хорооны протоколоор тусгагдах сайн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэх энэ үйлд ажиллагаанд Төрийн өмчийн банк мэдээж хамрагдана. Түүнээс гадна хувьчлалын асуудал зохистой эсэх талаар ярьж гэдэг протоколоор үүрэг өгөгдсөн байгаа. Дээр нь,

хамгийн гол нь, Хөгжлийн банк өнөөдрийн нөхцөлд, Монголбанк болон Монголд байгаа банкны системийн гадна оршиж байна. Банкны системийн бүрэлдэхүүн хэсэг болгох нь зохистой эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар ярих талаар бас протоколоор тэмдэглэгдсэн байгаа.

**Д.Дэмбэрэл:** - “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-ийг УИХ-ийн тогтоолоор үргэлжлүүлэе гэсэн заалт орж ирж байгаа юм байна. Энэ “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-ийг анх эхлэхдээ, УИХ-аас огт асуугаагүй зүйл шүү дээ. Тэгээд одоо хуучныгаа цайруулах гэж байгаа юм шиг дараачийн “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-ийг УИХ-аас тогтоолоор зөвшөөрөл авах гээд байх шаардлага байхгүй гэж бодож байна. Ерөөсөө энэ үнэ тогтворжуулах хөтөлбөрийн цаана 3 тэрбум ам.доллар зарцуулсан гэдэг байгаа? Ийм их мөнгийг төсвөөс гадуур явж байгаа юм шиг байдал руу орж байгаа. Хөгжлийн банкаар дамжаад явж байна. Тэгэхээр УИХ ийм зүйлийг мэдэхгүй өнгөрүүлж байгаа ч юм шиг, эсвэл одоо мэдчихээд залруулах гээд байгаа юм шиг ийм байдал орчихоод байна.

Хоёрдугаарт, үүний цаана зохисгүй яриа их гарч байгаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ улс төрчдийн ар талыг бэхжүүлэхийн тулд цөөн тооны компаниудад очдог гэдэг яриа гарсныг ЭЗ-ийн байнгын хороон анзаарсан уу үгүй юу? Энэ үнэхээр тийм байдалтай болж байгаа. Цөөхөн компаниудад өгчихдөг. Ямар компанид өгсөн бэ гэхээр, тендер шалгаруулсан юмуу, үгүй юу, бүү мэд. Энэ их зохисгүй юм болж байгаа. Бид нар мах, сүү, ноолуурын асуудлыг дэмжлэг үзүүлэхдээ бүгдэд нь, нийтэд нь дэмжлэг үзүүлэх байдлаар явдаг болохоос биш, ганц нэгээр нь салгаж урамшуулдаггүй. Тэгж дэмжинэ гэдэг нь буруу болоод байна. Энэ нь шудрага өрсөлдөөнд муу нөлөө үзүүлж байна. Шудрага өрсөлдөөнөөр тогтдог үнийг захиргаадан, урамшуулал байдлаар зарим хэсгийн дэмжлэгтэйгээр ийм компаниудыг гаргаж, үнэ тогтворжуулах үйл ажиллагаа явагдаж байгаа учраас үүнийг цаашид УИХ дэмжих шаардлагагүй гэж үзэж байна. 2-рт, үнэ тогтворжуулах, валютын ханшийг тогтворжуулахтай холбоотой асуудал л даа. Монголбанк хичнээн хэмжээний валютыг, төгрөг долларын ханшийг тогтворжуулахад зориулан гаргасан юм бэ? Одоо манай дотоодод валютын нөөц хичнээн байгаа юм бэ? Одоо 1700 болчихоод байгаа валютын ханшийн төгрөгийн уналтыг цаашид зогсоох юмуу ийм байдлаар үргэлжлээд байх юмуу? Үүнд хариулт өгч байж, банкны, мөнгөний бодлогын асуултыг шийдэх ёстой л гэж би бодож байна. Үүнийг Байнгын хороо хариулах юмуу, Монгол банк хариулах юмуу? Ер нь яагаад Монголбанк энэ асуултыг сонирхоод байгаа юм бэ? Энэ бол Засгийн газрын ажил. Тэнд ярьж байгаад, УИХ-д асуудлаа тавиад шийдвэл шийддэг юм байгаа биз. Хариулт сонсох бодолтой байна.

**Б.Гарамгайбаатар:** - За би асуултанд хариулъя. Ажлын хэсгийн ахлагч С.Дэмбэрэл гишүүн, Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргал нар нэмж хариулна байгаа. 2013 оны мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд бол Засгийн газартай Монголбанк хамтран гэрээ байгуулж, гол нэрийн бараан бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах тухай асуудал байгаагүй юм. Харин энэ удаагийнхад энэ орж ирж байгаа юм. Энэ нь яагаад орж ирж байна вэ гэхээр, Монголбанканд сүүлийн 19 жилийн хугацаанд хийгдээгүй тийм хяналт шалгалтын ажлыг ЭЗ-ийн байнгын

хороо саяхан хийсэн. С.Дэмбэрэл гишүүн ахлаад шалгалт хийсэн. Энэ хийсэн шалгалтанд бид ЭЗ-ийн байнгын хорооны гишүүд, УИХ-ын тамгын газрын дэргэдэх мэргэжлийн хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ажилтнуудыг татан оролцуулсанаас гадна ерөнхий аудитад хүсэлт тавьж, давхар шалгалт оруулсан. Энэ шалгалтын явцад гол бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийн хувьд хамтран ажилласан ажиллагаа нь үр дүнтэй болсон байна гэсэн дүгнэлт гарсан. Үүнийг удахгүй эдийн засгийн байнгын хороогоор оруулж хэлэлцэнэ. Тиймээс бид нар 2014 оны үндсэн чиглэлд оруулж ирж байгааг нь дэмжиж, цаашдаа тодорхой хэмжээгээр хэрэгжүүлэхэд ач холбогдол нь буураагүй юм байна гэж үзэн үүнийг оруулж ирж байгаа юм. Таны хэлж байгаа шиг тодорхой компаниудын юмуу, улс төрчдийн ар талыг бэхжүүлэх, баталгаажуулах тийм ажиллагаа хийгдээгүй гэдэг нь шалгалтаар нотлогдсон. Яах аргагүй монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа, тодорхой чадвартай болсон, том аж ахуйн нэгжүүдэдтэй энэ гэрээнүүд хийгдэж, дэмжлэг туслалцаа үзүүлэх, ард иргэдийн нуруун дээр ирж байгаа ачаалалыг багасгахын тулд үр дүнтэй ажилласан гэж байнгын хороо үзсэн. С.Дэмбэрэл гишүүн нэмж хариулна биз.

**С.Дэмбэрэл:** - Миний ахалж байгаа ажлын хэсэгт хөтөлбөрийг дэд хөтөлбөр бүрээр нь нарийн шинжилгээ хийсэн. Мөн хөтөлбөрийн хэрэгжилтийн дутагдалтай болон ололттой талуудыг олж гаргасан. Үүний үндсэн дээр 2014 оны мөнгөний бодлого дээр Д.Дэмбэрэл гуайн саяны хэлсэн хөтөлбөрийн хяналтыг сайжруулах талаар заалтууд нэмж орж ирсэн. Сайжруулж, мөн шударга бус өрсөлдөөн үүсэхээс сэргийлэх гэсэндээ яг энэ заалтынхаа ард нийт эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зорилгоор, түүн дотроо бичил, жижиг, дунд бизнесийн санхүүжилтийн чиглэлээр Монголбанк, Засгийн газар хамтран ажиллах бас нэг заалт оруулсан. Валютын ханшны хувьд бол, анхны төслөөр макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэн, валютын ханш уян хатан тогтоно гэсэн заалт маань одоо 5-6 заалт болоод институци талаас нь, валютын ханшны зах зээлийг сайжруулах, бас хяналтыг тавих, валютын орох гарах урсгал дээр төрийн институцүүдийн хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр, санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийг хуулийн дагуу, төв банкны хуулинд өөрчлөлт оруулах гэх мэтийн иж бүрэн анализ дүгнэлтээр суурилсан заалтууд энэ 2014 оны мөнгөний бодлогын чиглэлд туссан гэдгийг хэлэх нь зүйтэй байхаа.

**Ч.Хүрэлбаатар:** - Би 3 асуулт асууя гэж бодсон юм. Эхний асуултыг нь төсвийн байнгын хороон дээр, төсвийн 2-р хэлэлцүүлэгийн үеэр асууя гэж бодож байсан боловч, тэр үед асуух боломж өгөөгүй. Тэгэхээр, сая бидний 2-р хэлэлцүүлгийн үед хэлсэн улсын төсөв дээр ам доллартай харьцах төгрөгийн ханшыг 1384 гэж засгийн газрын оруулж ирсэнээр нь баталсан. Валютын ханшийг 1 ам.доллор 1384 болно гэдэгт итгэж суугаа хүн энэ зааланд байгаа юу? Байхгүй шүү дээ. Тэгсэн мөртлөө төсвийн тухай хуулиараа үнэн зөв гарганаа гэж баталчихаад бүгд хуйвалдаад, кноп дараад баталчихлаа. Тэгээд 2-р хэлэлцүүлгээ хийчихлээ. Тэгэхээр би одоо Монголбанкнаас асууя гэж бодож байна. За яахав төсвөө ингээд худлаа баталчихдаг юм байж. Ингэхэд Монголбанк тооцоогоо дотооддоо валютын

ханшийг хэд гэж авч байгаа вэ? Мэдээж тооцоондоо нэг ханш ашиглаж байгаа байлгүй. Бүр нууц юм бол, 1386-р илүү авч байгаа юу, дутуу авч байгаа юу гэдгийгээ л хэлчих. Эхний асуулт нь энэ.

2-р асуулт нь, “Үнэ тогтворжуулах хөтөлбөр” гэдэг юмаа болимоор байна. Яагаад гэвэл энэ чинь хууль бус шүү дээ. Монгол улсын төсвийн тухай хуулийн 49-ын 3-р зүйл дээр та бүхэн үзээрэй. “Өр цэцгээж бий болгосон хөрөнгөөр, зөвхөн төсөвт тусгасан төсөл, арга хэмжээнцүдийг санхүүжүүлнэ” гээд заачихсан. Гэтэл бид нар энэ заалтыг баталсанаараа монгол улсын хуулийг зөрчих болж байна. Бүх юм төсвөөс гадуур явж байна. Эцэстээ бид нар юу алж байна гэхээр эдийн засгаа алж байна. Төсөвт оруулахгүй байна гээд өөрсдийгөө хуураад, дотоодын нийт бүтээгдэхүүний алдагдал 2 хувьдаа хүрээгүй байна гэдгээр өөрсдийгөө хуураад яваад байгаа. Үнэн хэрэг дээрээ ард иргэдийг, нэн ялангуяа аж ахуйн нэгжүүдийг хуурч байгаа. Төсвийн алдагдал чинь дотоодын нийт бүтээгдэхүүний 20-30 хувь хүрэхээрээ долларын ханш чинь өсдөг. Эргээд энэ өссөнөөрөө ард түмний идэж байгаа, валютаар орж ирдэг цагаан будаа, ургамлын тос, элсэн чихэр гэх мэтийн барааг чинь ард түмэн кармаанаасаа төлж байгаа шүү дээ. Тэгэхээр хууль зөрчсөн энэ зүйлийг мөнгөний бодлого дээрээсээ авч хаямаар байна. Одоо яахав үнэ тогтворжуулна гээд л үнэн хэрэг дээрээ томоохон аж ахуйн нэгжүүд хувааж авч байгаа шүү дээ. Ард түмний олонход нь ажлын байр бий болгодог жижиг дунд хэвшлийнхэнд хаана нь ч хүрэхгүй байгаа шүү дээ. Тэгэхээр энэ булхай хийдэг, зах зээлийг номоор нь явуулдаггүй, гажуулдаг, ийм хөтөлбөрийг яах гэж үргэлжлүүлэх гээд байгаа юм бэ? Үүнийг болимоор байна.

Өөр нэг зүйл бол С.Дэмбэрэл даргаа, валютын савлагааны үр дүнд үүссэн эрсдлийг компани, банк, Засгийн газар хувааж төлөх нь. Нэг том компани валютын зээл авчихаад, түүн дээрээ алдагдал гаргавал компани, банк, Засгийн газар 3 хувааж төлөх нь л дээ. Агуулга нь, угтаа бол тэр компани зах зээлийн горимын дагуу, эрсдэл байвал даатгалд даатгуулаад явдаг болохоос биш, энэ үнэндээ Засгийн газарт хамаагүй. Тэгэхээр валютын ханшны өөрчлөлтөөс болоод, жишээлбэл цагаан будааны үнэ 1 кг нь 400 төгрөгөөр нэмэгдсэн тохиолдолд ард түмэн аваад хэрэглэж байгаа шүү дээ. Тэгвэл тэрийг нь ард түмэнд буцааж өгөх юмуу? Тэгэхээр зөвхөн аж ахуйн нэгжүүдийн талд, тэр тусмаа томоохон аж ахуйн нэгжүүдийн эрх ашигт нийцсэн мөнгөний бодлогын энэ 2 том заалтыг авч хаямаар байна. Энэ дээр байр сууриа илэрхийлж өгөөч.

**С.Дэмбэрэл:** - Монголбанк миний үгэн дээр нэмж хэлнэ биз. Одоогийн байдлаар 1384-ын тухай Монголбанкнаас асуусан шүү дээ. Тэрнийг яах юм? Валютын хашны талаар ирэх жилийн төсөөллийн талаар төрийн институциуд өөр өөрийн байр суурьтай. Өөрөөр хэлбэл 1380. Тийм учраас энэ дээр ямар заалт оруулж ирсэн бэ гэвэл, нэгдсэн нэг аргачлал, мэдээллийн нэг эх сурвалжаар валютын ханшны дараа жилийн төсөөллийг хийж бай гэсэн ийм үүргийг өгч байгаа. Миний хувийн байр суурь энд чухал биш байх. Хамгийн гол нь, ажлын хэсгийн байр суурь бол нэгдсэн нэг аргачлалаар, өөрөөр хэлбэл Эдийн засгийн хөгжлийн яаман дээр жижиг, нээлттэй эдийн засгаар тооцдог гэдгийг болих хэрэгтэй. Монголбанканд олон жил энэ валютын ханшийн төсөөллийг хийдэг, тусгай, өөрийнх нь



бүтэц байдаг. Энэ бүтэц дээр нь тулгуурлаад, ноднин жилийн төсөөлөл буюу 2013 оны 1 сарын 23-нд хийсэн төсөөллөөр бол валютын ханшийг 1450 аар тооцож байсан байна. Мөнгөний бодлогын зөвлөлөөр ярьж байсан протоколыг нь би уншсан. Ийм байдлаар тооцоолж явсан байна. Процесс явагдсан. Одоо тэгэхэд таны хэлдэг бол үнэн. Үнэхээр хариуцлагагүй төсвөө баталж байна. 1387 гэж хэн, хаанаас, яаж гаргаж ирсэн, ямар аргачлалаар гаргасан гэдэг нь тодорхой биш байна. Тийм учраас мөнгөний бодлогод та бүхэн төрийн институцүүд, УИХ-д ажлаа шууд тайлагнадаг Монголбанк, Засгийн газар та бүхэн үүнээс хойш, түүнээс цааш валютын ханшны талаар УИХ-ын гишүүд болон ард түмнээ битгий төөрөгдүүл. Тийм учраас тогтсон нэг аргачлалтай, нэгдсэн нэг аргачлалтай, мэдээллийн нэг эх сурвалжтай байх ёстой гэсэн заалтыг оруулж өгөх саналтай байгаа.

2-р асуултын хувьд, *“Үнэ тогтворжуулах хөтөлбөрийг зогсоомор байна.”* гэж байна. Энэ талаар хүн бүр янз бүрээр ярьж байна. Хууль зөрчөөгүй. Энд ямарч хууль зөрчсөн зүйл алга. Ажлын хэсэгт маань олон гишүүд байгаа. Бид ярилцсан. Түүний дотор МАН-аас орсон хүмүүс ч байгаа. Гэхдээ, *энэ мөнгөний бодлого ярьж байхад, ямар нэгэн улс төр ярьмааргүй байна. Надад энэ чухал биш.* Цэвэр эдийн засгийн байдлаас, энэ хууль талаас нь үзэхэд, хууль зөрчөөгүй. Тэгээд дээрээс нь УИХ өөрөө даалгавар өгчихсөн байгаа. Монголбанк анх удаа 2013 оныхоо мөнгөний бодлогод, энэ улсад явагдаж ирсэн мөнгөний бодлого дээр нэмээд, инфляцийн нийлүүлэлтийн гаралтай юм их байна гэдгийг судалгаа шинжилгээгээр тогтоосон байна. Энэ бодлогын онолын үндэс нь ингэж гарч ирсэн. Тиймээс энэ маань үргэлжлэх нь зүйтэй гэж үзэж байгаа. Гэхдээ би түрүүн хэлсэн, энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд алдаа их гарсан байна. Жишээлбэл, валютын ханшны эрсдэл дээр зарим бүтээгдэхүүнийг бүхэлд нь хангаж чадаагүй. Энэ бол нэгдүгээрт, тухайн компанийн буруу. Зөв. Банкны энэ чиглэлээр нь засгийн газар өөрөө механизм бүрдүүлээгүй, тогтолцоо бүрдүүлээгүй байгаа нь бас бидний буруу, төрийн буруу. Ийм учраас рисковийг хуваалцах механизмыг тогтолцоо гэсэн утгаар нь бичсэн болохоос биш, шууд компенсаци өгөх утгаар бичсэн юм биш. Ер нь цаашдаа, 2014 онд, дунд хугацаанд, монголчууд бид ханшийг 1700 болохоор нь сандарч гүйгээд, 1800 болохоор нь улс төржүүлээд, 1900 болохоор нь бослого гаргах гээд ингээд ард иргэдийгээ цагаан будаагаар нь ч, шар будаагаар нь ч, элсэн чихрээр нь ч тэр ингэж зовоож байдаг тогтолцоог бид эс үйлдлээрээ бариад байх юмуу, ямар нэг юм бодлогоор хэлж өгөх ёстой юу гэдэг дээр нь хэлээд, энэ бодлого дээр нь суулгаж өгчихсөн. Тэр бодлого нь хир үр дүнтэй хэрэгжихийг бид... Ерөнхийдөө та 3 асуулт асуусан би бараг хариулчих шиг боллоо. Гэхдээ энд санал зөрөх юм гарч ирнэ. Гэхдээ та бүхэн, таныг ялангуяа бас энэ чиглэлээр ажилладаг хүний хувьд томьёоллуудыг маш их уншаад, маш их гүнзгийрүүлж нарийвчилж асуугаарай гэж хичээнгүйлэн хүсье.

**Б.Гарамгайбаатар:** - Ч.Хүрэлбаатар гишүүний асуултанд нэмж хариулья. С.Дэмбэрэл гишүүн сая гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд тогтолцооны хөтөлбөр бол хууль зөрчөөгүй гэдгийг хэлчихлээ. Энэ дээр бид нар том, жижиг олон компаниудтай уулзсан. Жишээлбэл, шатахууны томоос гадна, жижиг компанийн эзэдтэй уулзсан.

Энэ хүмүүс юу гэж ярьж байгаа вэ гэхээр, “Энэ бол бидэнд маш их дэмжлэг туслалцаа үзүүлсэн. Ялангуяа жирийн хэрэглэгчдийн авдаг шатахууны үнэ буурсан. Бөөний үнийн нийлцүлэлт нь тухайн компаниудын ашигт нөлөөлсөн. Үр дүнгээ өгсөн. Хувь хүн дээр ачаалал багасаж очсон” гэсэн юм. Энэ талаар тэд нар өөрсдөө хэлсэн. Үүнийг зогсоох уу гэхээр, зогсоолгүй үргэлжлүүлээч гэж хүсэлтээ гаргасан. Ингэхлээр энэ бол тодорхой хэмжээгээр үр дүнгээ өгсөн гэж бид үзэж байна.

2-рт, Засгийн газар Монголбанк хамтарч, валютын эрсдэл үүрэх асуудал ч өчигдөр байнгын хороон дээр мөн яригдсан. Энэ нь тэр аж ахуйн нэгжид юмуу, тэд нарт ханшийн зөрүүг өгөх гээд байгаа юм биш л дээ. Яагаад гэвэл, жишээлбэл, бүтээн байгуулалтын ажлууд их хэмжээгээр хийгдэж байгаа. Аж ахуйн нэгжүүд томоохон бүтээн байгуулалтанд оролцохдоо эрсдэлээ тооцоолж ордог боловч, эрсдэл бидний тооцоолсоноос өөрөөр гарах юм бол, магадгүй засгийн газрын буруугаас юм уу, эсвэл санхүүгийн байгууллагын буруугаас болох юм бол тухайн аж ахуйн нэгжүүдийн эрсдэлийг тодорхой хэмжээгээр өөрсдөө хариуцлагаа тооцож хүлээдэг байх зарчим руу оруулах гэсэн ийм оролдлогыг л бид хийж байгаа юм. Бид нар бол арай өөр, сонгодог зах зээлийн гэдэг ч юм уу, хэрэглэгч, нийлүүлэгч, хяналт тавьж байгаа байгууллагууд харилцан бие биенийхээ өмнө хариуцлага хүлээдэг байх гэсэн зарчмыг л бий болгоход чиглэсэн оролдлогыг хийж байгаагаараа давуу талтай гэж үзэж байна.

**3.Энхболд:** - Ч.Хүрэлбаатар гишүүн ханшийн асуудал ярьж байна. Жил болгон төсөв батлахдаа байгаа ханшаар нь баталдаг. Хэрвээ төсвийн хууль хэрэгжих явцад дараа жил ихээхэн хэмжээний хөдөлгөөн гаргах бол тодотгол хийдэг энэ журмаараа явах хэрэгтэй. Тэр ханшийг Засгийн газар оруулж ирсэн. УИХ олон жил төсөв баталж ирсэнийгээ 3-р хэлэлцүүлэг дээрээ өөрчлөх боломжтой гэж үзэж байгаа. Ханшинд нөлөөлдөг хэд хэдэн тоонуудаа засаад, тэрний үйлчлэлээр нөгөө хэдэн тоогоо засахад цэвэр техникийн ажил байгаа. Түрүүн Ж.Энхбаяр гишүүнийг асуухад би бас ингэж хариулсан. Монголбанк Ч.Хүрэлбаатар гишүүний асуултанд нэмж хариулья.

**Н.Золжаргал:** - Ханш болон валютын ханш ирэх жил 2014 он гэхэд хэд байх бол гэдэг дээр, энэнээс өөр бусад макро эдийн засгийн бүх үзүүлэлтүүдээр Монголбанк бүх төсөөллүүдээ гаргадаг. Энэ төсөөллөө бид нар мөнгөний бодлогын зөвлөл дээр, шийдвэр гаргаж байх явцдаа, олон нийтэд ил тодоор ярьдаг. Энэ төсөөллийнхөө хүрээнд үйл ажиллагаа, бодлогоо хэрэгжүүлдэг. Олон нийтэд ханшид нөлөөлдөг нөлөөллүүдээ ярьдаг болохоос биш, хүлээлт төсөөлөлүүдээ, ханшын тоогоо ярьдаггүй. Учир нь хүлээлтийг удирдах нь зохимжгүй гэдэг үүднээс, тэгээд ч энэ өөрөө хуулиараа хориотой байдаг учраас энэ тухай ярьдаггүй. Үнэ тогтворжуулах хөтөлбөрүүдийн тухай С.Дэмбэрэл гишүүн, Б.Гарамгайбаатар гишүүн нар тайлбарласан болохоор үүнийг орхиё. Тодруулаад хэлэхэд, түрүүн Д.Дэмбэрэл гишүүний асуултан дээр ч гэсэн гараад байна, нэр томъёоны зөрүү гараад байна. “Үнэ тогтворжуулахад 600-н тэрбум төгрөг, эдийн засгийг тогтворжуулахад нийт мөнгө нь” гэсэн ийм нэр томъёогоор ойлговол зүгээр байна. Урьд нь, бид Байнгын хороон дээр ч, олон нийтэд ч бас ийм нэр томъёогоор тайлбарлаж байгаа. Эдийн засгийг тогтворжуулахад гурван их наяд төгрөг,

үүн дотроо үнэ тогтворжуулахад 600 тэрбум төгрөг гэдэг ийм нэр томъёоны хүрээнд хөтөлбөрүүдээ боловсруулдаг. Ингэж ч бүлгүүддээ танилцуулсан байгаа. Тоо задаргаанууд нь ингэж явж байгаа. Тэгээд дахиад нэг буруу ойлголт явж байгаа. Хөтөлбөрүүд маань Засгийн газарт өгсөн аливаа төрлийн зээл биш, эдийн засгийн идэвхжилт, бодит сектороо дэмжсэн шууд арилжааны банкнудаас эрсдэлээ үүрээд, компаниуд маань цаашаа явж байгаа. Арилжааны банкууд маань зээл өгөхөд аливаа төрийн улс төржилт байдаггүй. Арилжааны банкууд маань цаашаа цэвэр бизнесийн байх ёстой шалгавар үзүүлэлтээр нь шалгаад, тэгээд зээлээ өгдөг тогтолцоо руу бид орсон. Монголбанкны арилжааны банканд зээл өгөх асуудал нь зээлээ тодорхой чиглэлээр, салбараар, зүйл ангиар нөхцөлүүдийг тавих нь болохоор Монголбанкны хуулийн бүх зүйл ангийн үндсэн санаа, олон улсын мөнгөний бодлогын практик, зах зээлд шилжсэн улсуудын төв банкны бодлогод бүрэн нийцсэн хуулийнхаа хүрээнд монголын аль ч хуулийг зөрчөөгүй ийм л алхамууд буюу бодлогын шинж чанартай ажлууд хийгдсэн юм.

**Ч.Хүрэлбаатар:** - З.Энхболд даргаа, валютын ханшийн өөрчлөлтийг 3-р хэлэлцүүлгээр хийчихэд болно гэж байна. Тэр боломжгүй. Яагаад гэвэл, төсвийн байнгын хороон дээр, төсвийн хэлэлцүүлгийн үеэр, валютын ханшийг бодитойгоор нь тооцож бай гэхээр санал хураалгаагүй. Хураалгачихвал ний нуугүй хэлэхэд, их өөрчлөлт орохгүй. Орлого талдаа жаахан өөрчлөлт 2-р хэлцүүлгээр хийгээд, тодорхой орлогууд өснө шүү дээ. Зардал дээр орлого ороод бас зардал өснө. Үүнийг хийх боломжтой байсан. Одоо бол 3-р хэлцүүлгийн үед энэ санал хураалгаж болохгүй. Ингэвэл бид нар хууль зөрчсөн болох гээд байна. Дараагийн асуудал 3-р хэлэлцүүлэг дээр болохгүй. 3-рт, үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд, энэ хууль бус шүү. Олон удаа анхааруулж байгаа. Нэг өдөр хариуцлага тооцох өдөр ирэх байлгүй. Б.Гарамгайбаатар даргаа, Компаниудад ашигтай болоод л тэд үргэлжлүүлье гэж байгаа юм. Ард түмэнд ашиггүй. Үр дүн гараагүй. Инфиляци 2 оронтой тоонд орчихсон.

**Ж.Энхбаяр:** - Нэгдүгээрт, Мөнгөний бодлого хэлэлцэхээс өмнө бид Монголбанк, Хөгжлийн яам, Үнэ тогтворжуулах хөтөлбөртэй холбоотой УИХ-аас ажлын хэсэг гараад шалгасан дүнг хэлэлцэх ёстой байсан. Тэрний дүн орж ирээгүй байхад, бид энэ хөтөлбөрийг сайн, муу гэж хэлэлцэх нь хир зохистой вэ гэдгийг УИХ-ын даргаас асууя.

Хоёрдугаарт, Ажлын хэсгээс асууя. Ажлын хэсгийн төсөл дээр, Монгол төгрөгийн ханштай холбоотой том заалт /1.2/ дээр *“Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийнхаа суурь нөхцөлтэй нийцэж, уян хатан тогтоно”* гэдэг саналыг Монголбанк оруулж ирсэн. Ажлын хэсгээс, *“төгрөгийг тогтвортой байлгах”* гэж орж ирсэн байна. Энэ хоёр маань логикийн хувьд зөрчил үүсэж байна. Энийгээ яаж тайлбарлах вэ? Ноднин бол мөнгөний бодлого дээр валютын ханшийг уян хатан байлгана гэсэн. Өнөөдөр монгол төгрөгийн ханш 1 жилийн дотор яг 30 хувь суларсан байна. Гэтэл мөнгөний бодлого дээр бид тогтвортой гэж оруулж өгөх юм бол энэ асуудал хэрэгжихгүй. Тогтвортой байлгах бодлого баталж өгөх юм бол жаахан байгаа валютынхаа нөөцийг шавхаад дуусна гэдэг нэг ийм сөрөг нөлөө байгаа. Үүнийг яаж тооцоолсон бэ?

Гуравдугаарт, Монголбанкнаас асуулт асууя. Монголбанкинд 2013 онд баталж өгсөн мөнгөний бодлого, 2014 оны мөнгөний бодлого дотор танд мөнгөний бодлогын зорилтын хүрээнд инфляцийг барь гэдэг үүрэг өгсөн. Тэр хүрээнд нилээн их хөтөлбөрүүд хийлээ гээд 3 их наяд төгрөгийн энэ мөнгөний нийлүүлэлттэй тойрсон маргаан үүсээд байгаа. Орон сууцны хөтөлбөрт 1,6 их наяд төгрөг өгөөд байгаа. Энэ орон сууц нь өөрөө инфляци мөн үү? Нөгөө Монголбанкны тавьсан зорилтын хүрээнд инфляцийн бодлогод орох уу? Таны хэвлэлээр өгсөн тайлбарыг харахад, энэ бол хуримтлалын бодлого, хуримтлал гэсэн нэр томъёог их ашиглаж байна лээ. Тэгэхээр хуримтлал буюу барилгын салбар чинь өөрөө инфляцийг өдөөсөн, учир нь юу гэвэл гэвэл барилгын салбар маань үндсэндээ 80 хувь нь импортоос хараат. Импортын бараа түүхий эдээр үйл ажиллагаагаа явуулдаг. 154 хувийн барилгын салбарын өсөлт чинь өөрөө жаахан валютын нөөцийг чинь асар хүчтэй шавхчихлаа шүү дээ. Тэгээд энэ жил дуусаагүй, ирэх жил барилгын ажлын үлдэгдэл, бараг 70 хувь нь санхүүжинэ, дотоод засал орно. Тэр нь үндсэндээ 100 хувь импортоос хамаатай. Энэ чинь эргээд ханш. Монголбанк хуулиар хүлээсэн үндсэн үүрэг монгол төгрөгийн тогтвортой байдлыг хангах нь Монголбанкны үндсэн үүргийн нэгд байгаа. Энэ чинь яагаад хангагдахгүй талдаа орж байна вэ? Нөгөө талаас Монголбанкны алдагдлын асуудал байгаа. Монголбанкны хуулийн монгол банкны пассив нь актив хөрөнгөнөөсөө хэтэрсэн тохиолдолд Засгийн газар үнэт цаас гаргах замаар уг зөрүүг нөхөж өгөх ёстой. Энэ асуудал улсын төсөвт суугаагүй. Үүнийг хэзээ яаж шийдэх вэ? Дараагийн томоохон улс төрийн зөрчилтэй шийдэл буюу бид нарын зохицуулж чадаагүй зүйл бол бонд. Бас дээрээс нь тогтворжуулалтын хөтөлбөрийг Монголбанкны нийлүүлэлт төсвийн гадуур яваа зохицуулалтыг яаж ойлгох вэ? Одоо орж ирсэн хөтөлбөрөөр бол энэ жил 2013 оных явж байгаа. Энэ бодлого үргэлжилнэ. Үр дүнг нь дараа жил үзэх байх. Үр дүн дараа жилийн өдийд тооцогдоно шүү.

**С.Дэмбэрэл:** - Шалгалтын хувьд, логик дарааллаар, шалгалтаа хийчихээд дараа нь мөнгөний бодлогоо ярих ёстой гэсэн тийм санаа хэлж байна. Нэг талаар зөв юм шиг. Гэхдээ бодит байдал дээр 20 жил шалгаагүй юмыг эдийн засгийн байнгын хороон дээр санаачлаад, тогтоол гаргаад, бүх намын төлөөлөл оролцуулсан ажлын хэсэг гаргаж ажиллуулаад, энэ 3 институцийг шалгасан. Тэр шалгалтын үр дүн энэ мөнгөний бодлоготой уялдсан уу гэвэл уялдсан. Өөрөөр хэлбэл, хэдий шалгалтын үр дүнгээ яриагүй ч гэсэн аудитийн болон бусад дүгнэлтүүд нь гарчихсан байгаа учраас мөнгөний бодлогоо сайжруулахын тулд 3 газар суулгаж өгсөн.

1. УИХ-ийн тогтоолд

2. Үндсэн чиглэлд

3. 2014 оны Монгол банкны үйл ажиллагааных нь төлөвлөгөөнд /Та бид үүнийг батлах ёсгүй/ хуваагаад ажил хэсгийн саналууд орчихсон байгаа. Тийм учраас нь би тэр талаас нь ингэж хариулья.

2-рт, ханш гэж хариулахаас нь өмнө сая Ч.Хүрэлбаатар гишүүн “Цаана чинь бүх юмны цнэ өсчихөөд байхад юун цнэ тогтворжих...” гэж ярилаа. Үнэн. Инфляци зугуухан өсөж байгаа юу гэвэл өсч байгаа. Гэхдээ үнэ тогтворжуулах хөтөлбөрийн чинь гол санаа нь үнийн өсөлтийн хурдцыг

нь сааруулах явдал болохоос биш, абсолют утгыг нь бууруулах гэсэн утга биш шүү дээ. Тэр талаас нь учраас зах зээлийнх нь зарчимд нь шилжүүл, захиргааны аргаар үнийг нь битгий тогтоож бариад бай гээд байгаа юм. Тийм учраас түүрүүн Б.Гарамгайбаатар дарга хэлсэн. Бид том, жижиг, дунд оролцуулсан нефтийн 13 компанитай уулзсан. Зөвхөн ганц жишээ болгоод хэлэхэд. Тэр 13 компаниудын жишээн дээр бол, энэ үнэ тогтворжуулах хөтөлбөрөө үргэлжлүүлж өгөөч гэж хүсэлт тавьсан. Дээр нь бас Эдийн засгийн байнгын хорооны хурал дээр, төрийн 4 яам оролцож, энэ үнэ тогтворжуулах хөтөлбөрийн үр дүн ингэж ингэж манай салбарт гарлаа. Манай салбарын хувийн хэвшлийнхэн ингэж ярьж байна гэж хэлсэн. Гэхдээ бид шалгалтын хэсэг ажлын хэсэг юу гэж үзсэн бэ гэхээр, энийг бүр илүү сайжруулах хэрэгтэй юм байна, энэ өөрөө шудрага бус өрсөлдөөн тухайн салбарт үүсгэчих вий гэж сэрэмжлүүлэг өгье нэгдүгээрт, хоёрдугаарт энэ хоосон сэрэмжлүүлэг биш мөнгөний бодлогын чиглэлд нь бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих тогтолцоог Засгийн газартай хамтарч дэмжиж ажиллана гэдэг зүйлийг **мөнгөний бодлогын тцүхэнд нэг ч орж байгаагүй энэ өгцүлбэрцүдийг оруулж өгсөн**. Тийм учраас миний ярьж байгаа зүйл бол Ц.Нямдорж гишүүнээ, ганц миний бодлого биш, ажлын хэсгийн бодлого. Цаашдаа ярих асуудал бол, шалгалтын үр дүнд бас таны бодлого оролцчихсон явж байгаа. Ханшийн хувьд Ж.Энхбаяр гишүүн “1-р зүйл” гээд их зөв хэллээ. Гэхдээ Монголбанкны тухай хуулийн 4-р зүйл, 22-р зүйл, валютын зохицуулалттай хуулийн 7,8,17-р зүйлд Монгол улсын нутаг дэвсгэр дээр төгрөгөөр гүйлгээ хийх тухай хуулийн Монголбанканд олгогдсон 4 бүрэн эрх байгаа. Энэ бүхний хүрээнд харахад Монголбанк төрийн мөнгөний бодлого бол:

1-рт монгол төгрөгийн тогтвортой байдлыг хангана.

2-рт үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжинэ гэсэн 2 хосолмол зорилготой байж байгаа. Энэ зорилгын хүрээнд энэ жилийн мөнгөний бодлого хийгдээд, энэ зорилгын хүрээнд агуулга нь тэгж гарч ирсэн гэж хэлмээр байна.

3-рт, төсвийн гадуурх бондын асуудал бол манай ажлын ... Гэхдээ өчигдөр би та бүхэнд хэллээ. Хөгжлийн банкыг банкны системд холбоотой, харилцан уялдаатай нэг бүрэлдэхүүн хэсэг болгох асуудлыг бид шийдэхгүй бол, энэ төсвийн гаруурх гэдэг юм маань Хөгжлийн банкаар дамжиж хэрэгжээд, цаашдаа хяналт алдагдаж болох эрсдэл байгаа учраас энэ асуудлыг эдийн засгийн байнгын хороогоор ярья гэж өчигдөр протоколоор тэмдэглэсэн гэдгийг дахин хэлье.

**Н.Золжаргал:** - Тэгэхээр энэ орон сууц... /урд нь яриад л байхад, санаатай ингээд байгаа юмуу/ 3 их наяд төгрөг маань эдийн засгийг тогтворжуулахад, үүнээс 600 тэрбум нь үнэ тогтворжуулахад зориулагдсан. Эдийн засгийг тогтворжуулахад энэ эх үүсвэр зарцуулагдаагүй байсан бол Эдийн засаг дотор ... моделээр эргээд, бид нар энэ оноо дүгнэхэд 170-аад мянган ажлын байр байхгүй болох буюу эдийн засгийн өсөлт маань хасах болох байжээ гэсэн судалгааны тоонууд гарч байгаа. Энэ судалгааны тоонуудыг бид нар урьд нь танилцуулсан. Монголбанкны хувьд эпотек моргежийн тогтолцоо гэдэг маань өрх гэр, дундаж давхарга маань өөрөө хуримтлал руу олж байгаа орлогныхоо талыг хуримтлуулдаг ийм тогтолцоо учраас үүнийг бид



дэмжээд байгаа юм. Дэлхийн бүх банк үүнийг дэмждэг. Бүх эдийн засаг үүнийгээ дэмждэг. Хэрэв үнэхээр эдийн засгийн урт хугацааны өсөлтийн суурь нь дундаж давхаргын хуримтлал юмаа гэдэг ийм онолын ойлголтон дээрээ нэгдэж байгаа тохиолдолд төв банкных нь хийдэг гол бодлого нь энэ байдаг. Иргэдийнхээ, ялангуяа дундаж давхаргынхаа хуримтлалыг дэмжих. Хэрэв олж байгаа орлогынхоо 50 хувийг хуримтлуулаад байгаа тохиолдолд үүнийг дэмждэг бодлого явуулах хэрэгтэй. Энэний хамгийн зохимжтой бодлого нь моргежийн бодлого байдаг. Энэнээс өөр мэдээж олон хэрэгсэл бий. Үүнийг шат дараатайгаар бид нар хэрэгжүүлнэ. Эдийн засгийн тогтвортой өсөлтийн моделийнхоо зүгээс энэ бид нарын хувьд хуримтлалын бодлого. Энэ монгол улсын дундаж давхаргын, ер нь монгол улсын эдийн засгийн тогтвортой урт хугацааны өсөлтийнх нь суурь нь болох ёстой юмаа. Жилийн өмнө 20000 өрх нийт орлогынхоо 50 хувийг хуримтлуулдаг байсан бол энэ жил 40000 өрх хуримтлуулдаг болсон. Үүнийг бид цаашид нэмэх ёстой. Энэ цаашдаа нэмэгдсээр байгаад монгол улсын нийт GDP /дотоодын нийт бүтээгдэхүүн/-ий 50 хувьтай тэнцэх моргежийн багцтай болбол энэ бол дундаж давхарга маань иргэд маань хүчтэй болж байна, тэнд хуримтлал бий болж байна гэсэн үг бөгөөд тэр иргэд маань тэр хэрээрээ бэлэн мөнгөө, орлогоо шууд бараа руу, лангуу руу оруулж, тэр тухай бүрд нь инфляци үүсэх тийм нөлөөлөл багасдаг юм. Энэ бол өөрөө шинжлэх ухаан, онолын, судалгааны хувьд дэлхий нийтэд бий болчихсон зүйл болохоор Монголд ч ялгаагүй. Энэ, хуримтлалыг дэмжиж байгаа бодлогыг урьд нь хэрэгжүүлж байгаагүй. Одоо Монголбанк энэ моргежийн хөтөлбөрийг дэмжиж байгаагаараа хуримтлалыг дэмжиж байгаа бодлого явуулж байна. Үүгээрээ дараагийн шатанд инфляци хүрэхийн чөлөөт үлдэгдэл нь инфляцид нөлөөлөх нөлөөллийг багасгаж байгаа юм. Огцом нөлөөлөл байгаа юу гэвэл байгаа. Гэхдээ урьд нь үүнийг бэлэн мөнгө тарааж нэмдэг байсан бол, одоо бэлэн мөнгө тараах нь багассан тохиолдолд харин цалин, бодит орлогынх нь тодорхой хувийг хуримтлал болгон хувиргаж байгаа ийм бодлого юмаа. Энэ эдийн засгийг тогтворжуулах хөтөлбөрүүдийн хүрээнд импорт огцом өсч, валютын хэрэгцээ улам нэмэгдлээ гэсэн таны энэ дүгнэлт статистик тоогоор нотлогддоггүй. Барилгын салбарын импортын тоо бол энэ жил 5-хан хувиар өссөн байдаг. Барилгын салбарын маань нийт эдийн засаг дотроо эзлэх байр суурь, өөрийнх нь өсөлт урьд өмнө үзэгдэж байгаагүй ийм байр суурьтай байгаа. 2014 оны барилгын салбарын нийт нийлүүлэлтээ бол энэ 2013 онд хийж эхэлсэн гэдгийг гишүүн бол сайн мэдэж байгаа. Энэ бол бидний хувьд нэг жил хэдэн сараар хийгддэг хөтөлбөр биш. Ялангуяа барилгын салбарт бол урдчилсан жил барилга маань 18 сарын дотор баригддаг. 24 сар, тэгээд цаашаа явдаг учраас энэ хөтөлбөр бол дунд хугацааны хөтөлбөрүүд, барилгын салбарын үнэ тогтолт, үнэ бүрдэлт, үнэ өсөлт, үнэнд хэрхэн компонентууд нь нөлөөлж байгаа талаарх тооцоонуудаа хийхийн тулд ганц хоёр сараар хийдэггүй, нилээн урт хугацаагаар хийдэг. Үүнийг хэмжих зорилгоор барилгын салбар дээр 4 төрлийн индекс энэ 11 сараас гаргаж, зах зээлд нийлүүлэгдэж эхэлнэ. Үүний үр дүнд энэ тоо бол тодорхой болох болов уу гэж бодож байна. Монголбанкны алдагдлын хувьд бол жил болгон, сүүлийн 3-н жилд УИХ дээр хүсэлтээ тавьдаг. Шийдвэрлэх эрх нь УИХ дээр байдаг учраас алдагдлаа

аяж шийдвэрлэх тухай УИХ-д саналаа тавьж асуудаг. Энэ жилийн 8-р сард албан тоот хүргүүлсэн байгаа. Одоо байгаа энэ алдагдал бол 1 сарын дотор, нэг жилийн дотор бий болчихсон юм биш. Олон жилийн хуримтлагдсан алдагдал маань 300 тэрбум төгрөг дээр байгаа. Гэхдээ энэ маань өөрөө эдийн засгийн аливаа нэг өсөлтөнд ч юмуу, эдийн засагт ямар нэгэн нөлөө байхгүй. Хэрэв улсын төсвөөр дамжиж, аливаа нэг өр юмуу, аливаа нэгэн бэлэн мөнгөөр энэ хаагдах тэр шийдвэрийг УИХ гаргах юм бол харин энэ нь эдийн засагт нөлөөтэй. Одоогийн байгаагаар, эдийн засагт аливаа нэг сөрөг юмуу, эерэг нөлөөлөл байхгүй. Аливаа төв банкыг балансан дээр алдагдал гэж ойлголт байдаг. Тийм түвшиндээ явж байгаа. Эдийн засгийн шууд нөлөө байхгүй.

**Ж.Энхбаяр:** - Ирэх онд барилгын салбарыг дэмжих хөтөлбөр үргэлжилнэ гэж ойлголоо. С.Дэмбэрэл даргаас миний асуугаад байсныг Монголбанк хариулаач. Нэг талдаа ханшийг уян хатан тогтооно гэж байгаа. Нөгөө талдаа төгрөгийн тогтвортой байдал гэдэг маш том зөрчилтэй хоёр зүйлийг нэг юманд багтаачихаад байна. Энэ дээр Монголбанк юу гэж үзээд байгаа юм бэ. Та нарын оруулж өгсөн төслөөр бол макро эдийн засгийнхаа суурь нөхцөлтэйгээ нийцүүлээд уян хатан тогтох ёстой гэдэг зарчим байна. Ажлын хэсгээс болохоор төгрөгийн тогтвортой байдал гэдэг зарчим ороод ирэхээр наадах чинь маш их зөрчилтэй болоод байна. Бид нар дараа нь таньтай ажлаа яаж тооцох вэ? Тогтвортой байлгасангүй гэж үзэх үү, уян хатан байлгасан гэж үзэх үү, гээд ойлгомжгүй, хэмжих юмгүй болчихоод байна үүнийг Монголбанк юу гэж үзэж байгаа вэ?

**Н.Золжаргал:** - Төгрөгийн тогтвортой байдал гэдэг маань төгрөгөөр илэрхийлэгдэж байгаа бараа, үйлчилгээний үнийн тогтвортой байдал гэж томъёологддог. Сурах бичиг дээр ч гэсэн, онолоороо ч гэсэн нэр томъёо маань ингэж тодорхойлогддог учраас бид ингэж ойлгодог. Хууль маань гэсэн энэ түвшинд л гарсан. Түүнээс биш нэг ханшийг тогтвортой байлгаж бай гэж Монголынбанкны тухай хуульд бичигдээгүй. Харин ч бүр 22-р зүйл дээр эсрэгээрээ уян хатан тогтоож бай гэж бичигдсэн байдаг. Энэ бол хоорондоо зөрчилтэй ойлголт биш, 2 өөр ойлголт. Тэр тогтвортой байдал гэдэг та бид нарын ярьж заншсанаар бол инфляцтайгаа илүү холбоотой ойлголт. Бараа үйлчилгээний үнэ хэрхэн өөрчлөгдөж байна, тэрийг худалдаж авч байгаа төгрөг нь өөрөө үнэ нь хэрхэн өөрчлөгдөж байна гэдгийг тэрүүгээрээ хэмжих нь зүйтэй юм. Энэ өөрөө онолын хувьд ч бай, эдийн засгийн нэр томъёоныхоо хувьд ч бай ингэж томъёологддог юм. Ханшийн тухай ярьж байгаа тохиолдолд энэ бол монгол улсын бараа бүтээгдэхүүний үйлчилгээний гадаад бараа үйлчилгээний үнэтэйгээ харьцуулсан ойлголт учраас асуудал нэр томъёоныхоо хувьд ханшийг хатуу зохицуулах гэж оролдох нь буруу. Таньтай 100 хувь санал нэгтэй байна. Ханшийг хатуу тогтоох гэж хамаг нөөцөө гөвөөд байж болохгүй. Энэ бол гадаад орчин, макро эдийн засгийн орчноос шалтгаалж аль төвшинд байлгахыг бид нар зохицуулдаг. Одоогийн байдлаар монгол төгрөгийн ханш америк доллартай харьцах ханшин дээр гарсан өөрчлөлтийн үр дүнгээр гадаад худалдааны тэнцэл дээр импортын нийт хэрэглээ маань одоогоор он гарснаас хойш 500 сая доллароор буусан байна. Он дуусахад 600-700 саяар импорт маань танагдах болов уу гэж бид нарын тооцоо байна. Ханш гэдэг бол цэвэр валютын гадаадтай харилцдаг харилцаагаа зохицуулдаг механизм юм. Энийг хатуу тогтооно гэж юу байхав дээ. Төгрөгийн тогтвортой байдал гэж төгрөгөөр илэрхийлэгдэж байгаа, /Америцад байгаа бараа үйлчилгээ

биш/ яг Монгол улсад илэрхийлэгдэж байгаа бараа үйлчилгээний үнийн тогтвортой байдал. Тэрийг хэмждэг нэгж маань хэрэглээний үнийн индекс байдаг. Тэр хэмжээгээрээ бид ойлгож явдаг. Хууль, Монголбанкны тухай хууль, энэ зохицуулалтыг хийж байгаа Монголын бүх санхүүгийн зохицуулалт дотор яг энэ нэр томъёогоор ойлгогдож заншиж явсан юм. Тэрнээс, тогтвортой байдал гэдэг маань ханшийг нэг хэмжээнд барьсан хатуу ханш гэж ойлгохгүй байгаа юм.

**Б.Бат-эрдэнэ** – Баярлалаа. Юуны өмнө манай гишүүд, Д.Оюунхорол бид нар жишиг үзүүлсэн, сайн жишиг гэж үзэж байгаа. Салбарын ашиг сонирхолын зөрчилтэй бол чуулганы хэлэлцэж байгаа асуудлаар оролцдоггүй гардаг. Тийм учраас гишүүд маань энэ хэлэлцэж байгаа асуудлаар ямар нэг ашиг сонирхолын зөрчил байвал энэ хуралдаанд оролцдоггүй, оролцуулахгүй байлгадаг энэ зарчмыг УИХ-ын дарга тогтоож өгөөрэй гэж юуны өмнө хэлье. Надад З асуулт байна.

1-рт, Ерөөсөө өнөөдөр улс орны эдийн засгийн амьдрал гэхээр эцсийн дүндээ дэвэн дэлхийн юм тойрч, нилээн дээгүүр юм ярих шаардлагагүй, бодит амьдрал дээр тулгамдсан юмыг ярих ёстой гэж үзэж байна. Өнөөдөр энэ валютын ханшны өсөлт хүн болгоны амьдралд хүндээр тусч байна. Хүмүүсийн авч байгаа цалин, тэтгэвэр, хадргаламжинд байгаа мөнгө хөрөнгө байдаг ч юмуу, энэ бүх зүйл 30% алга болчихлоо. Валютын ханшны энэ уналт буюу монгол мөнгөний ханшны сулралтыг хүмүүс маш тодорхой яриад байгаа шүү дээ. Монголын ард түмэн чинь бүгдээрээ нүдтэй, чихтэй, боловсролтой хүмүүс шүү дээ. Одоо энэ засгийн газрын хэрэгжүүлж байгаа үнэ тогтворжуулах хөтөлбөр буюу улсын төсвөөс гадуур З их наяд төгрөг тараачихсан. Энэ чинь нэг шалтгаан нь болоод байна. Олон шалтгаан тоочих юм байхгүй. Нөгөөдөх нь ер тавиад оруулж ирсэн энэ 1.5 тэрбум ам.долларын нийлүүлэлт чинь энэ валютын ханшийг алдчихаад байна шүү дээ. Тэгэхээр энэтэй санал нийлэх үү? Ажлын хэсэг юу гэж үзсэн бэ гэдгийг та их тодорхой хариулж өгөөч.

2-рт, Монголбанкнаас асуух асуулт байна. Үнийн өсөлт, ханшны уналт 2 зэрэг 2 талдаа эрчимтэй явагдаад байгаа. Тэгтэл инфляцийг 2014 онд 8 хувьтай байлгана гэсэн ийм зорилт тавих юм. Энэ зорилт амьдралд хэрэгжих үү? Миний санахад ямар ч боломжгүй юм шиг санагдаад байна.

3-рт Үнэ тогтворжуулах хөтөлбөрийг ирэх жил бас үргэлжлүүлэн хэрэгжүүлэх гээд байна. Энэ хөтөлбөр чинь иргэд бидний зүгээс үзэх юм бол, үр дүнг нь бид үзсэнгүй. Сая хариулж байгаа хүмүүс болохоор, том компаниуд үүнийг хүсээд байгаа гэх юм. Тэгэлгүй яах юм бэ? Хэдхэн том компанид хуваагаад өгчихсөн юм чинь. Олон түмэнд наалдах үр өгөөж нь хүрсэнгүй. Үр дүнгий нь дүгнэсэн юм байхгүй, энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцдаа хянадаг шалгадаг тогтолцоо байхгүй, УИХ-аас гадуур, нэг үгээр хэлэх юм бол төсвөөс гадуур, асар их мөнгө зарцууллаа. Монголбанкны үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хойш хамгийн эхэнд хэлэх дуртай үг бол “*бэлэн мөнгө хэвлээд нийлүүлнэ*” гэдэг энэ санааг л хэлээд байна. Алт авна гээд л яриад байна. Цаанаа баталгаагүй, бэлэн мөнгө хэвлээд л авах тухай яриад байх юм. Ийм хууль бус юм яриад байх юм. Үүн дээр ажлын хэсэг ямар дүгнэлт хийсэн бэ гэсэн ийм 3-н асуултанд хариулж өгөөч.

**С.Дэмбэрэл:** – Эхний асуултанд хариулья. Ханшийн өсөлтийн тухай. Таньтай би санал нэг байна. Та бид нар бүгдээрээ л юмны үнэ өсч байгааг, ард түмний амьдралд сөрөгөөр нөлөөлж байгааг харж байгаа. Нэг хэсэг харахгүй тэнгэрийн юм яриад, нөгөө хэсэг нь хараад байгаа зүйл огт биш.

Тийм учраас л бидэнд 2 сонголт байсан. Нэг нь, мөнгөний бодлогыг орж ирсэн тэр чигээр нь, урьд өмнөх практик шигээ, дуугүйхэн батлах сонголт байсан. Нөгөө нь, энэ дээр нугацтай, суурьтай хандаад, яагаад юмны үнэ өсөөд байна, яагаад валютын үнэ 1700 хүрчихэв? Энэ үнэ тогтворжуулах хөтөлбөр дээр ямар алдаа гарав, ямар ололт гарав? Цаашдаа мөнгөний бодлогыг, түүний бүрэлдэхүүн хэсэг болсон валютын ханшны бодлогыг хууль тогтоомжийнх нь хүрээнд яаж сайжруулах талаар бид яриад, одоо танд хариулт өгч байна. Тэр хариултынх нь нэг нь бол, ханшийн өсөлтийг удирдах, валютын ханшийг удирдах зэх зээлийг бий болгоё, институтүүдийг нь сайжруулья, ханшийг эрсдэлээс хамгаалах үүсмэл хэрэгслийн зах зээлийг бий болгоё, энэ чиглэлээр зөвхөн төв банк биш, санхүүгийн зах зээлийн бусад оролцогчид, төрийн институтууд идэвхтэй ажиллая, энийг хууль тогтоомжийнх нь хүрээнд өөрчилж өгье гэсэн үүднээс хийсэн зүйл байгаа юм. Ханшийн өсөлт ба инфляци хоорондын харилцан хамаарлын талаар онолын төдийгүй, практик амьдрал дээр та бид бүгд харж байгаа, Ж.Энхбаярын гишүүний хэлж байгаа, таны энэ бодит амьдралын жишээнээс яриад байгаа чинь эцсийн дүндээ хуулиндаа тодорхойлогдчихсон байна. Энэ хуулинд та бүхэн мөнгөний бодлогыг ярихдаа, төгрөгийн тогтвортой байдлыг хэрэглээний үнээр илэрхийл, энийг нэг оронтой тоон дээр барь, гэхдээ ингэж барихдаа эдийн засгийн идэвхжлийг сайн бий болго, зөвхөн хэдэн компаниуд төдий гэдэг чинь хангалттай биш байна, үүнийг илүү сайжруул, нийт эдийн засгийнхаа идэвхжлийг хангахын тулд урьд өмнө мөнгөний бодлогод тэр болгон хамрагддаггүй байсан бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих санхүүжилтийг сайжруул, энэ чиглэлээр ажилжааны банкууддаа дохио өг, энэ чиглэлээр засгийн газартай хамтран ажилла гэдэг ингээд хэлчихсэн байна. Тийм учраас таны асуултанд ийм байдлаар хариулмаар байна.

Гуравдугаарт нь, 8 хувьд барих гэдэг асуулт маань яг одоо үнэндээ хэлэхэд 2007 оноос хойш Монголбанк зорилтоо болгоод, /үүнийг инфляцийг онилох гэдэг юм байна лээ албан ёсны нэр нь/ инфляцыг онилох төдийгүй инфляцид 2013 оноос хойш Монголбанк өөрийнхөө үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийгээд инфляцийн эрэлтийн тал дээр голцуу анхаарал хандуулаад байлгүй, эрэлт нийлүүлэлтээр нь адилхан анхаарал хандуулья. Нийлүүлэлтийн гаралтай инфляцийн садаа болж байгаа хүчин зүйлүүдийг арилгах чиглэлээр засгийн газартай хамтран ажиллая гэдэг хөтөлбөрүүд, одоо энэ хөтөлбөрүүдээ өшөө сайжруулаад, дээрээс нь бичил жижиг дунд бизнесүүдийг дэмжих хөтөлбөрүүдийг боловсруулаад цаашаа яваад байя гэж байгаа юм. Энэ чиглэлээр Ажлын хэсэг Монголбанктай хэд хэдэн удаа харилцан ярилцаж, маш сайн зөвлөлдсөний үүднээс энэ тоонуудыг оруулж ирж байгаа гэдгийг хэлмээр байна. Эцсийн дүнд энэ 8% хувьдаа барьж чадах эсэх нь энэ бол зөвхөн Монголбанкны асуудал биш, төсвийн тогтвортой байдлын тухай хууль хир зэрэг тогтвортой бөгөөд хариуцлагатай батлагдах нь вэ, энэ дунд хугацаандаа ард иргэдэд бизнес эрхлэгчдэд ямар дохио өгөх нь вэ, дээр нь тэр төсвийн тогтвортой байдлын хуулийн заалт нь болох энэ засгийн газар инфляцийг хязгаарлах гэсэн тэр заалтыг засгийн газар, Монголбанк хоёр хамтарч хэрэгжүүлж байж, монголын ард түмэнд инфляцийн дарамтыг амсуулахгүй, амсууллаа гэхэд бага хэмжээгээр нимгэлэх тухай ярьж байгаа юм.

**Б.Бат-эрдэнэ:** - Хурлын даргаа, таниас асуух асуулт байна. Хуулийн дагуу валютыг бодитой ханшаар нь тооцож тусгах ёстой гэж та түрүүн хэллээ. Энэ төсөвт бодит ханшаар нь тусгаад оруулж чадах уу?

**З.Энхболд:** - Төсвийн хэлэлцүүлэг дээр хэлсэн. Одоо үүнийг ярьдаг цаг нь биш. Төсвийн хэлэлцүүлэг дээр хэлсэн зүйлээ хэлсэн болохоор, одоо тэгээд төсвийн байнгын хороонд шилжүүлсэн байгаа шүү дээ. Хэдхэн газар ханштай холбоотой хэсгийг нь өөрчлөөд 3-р хэлэлцүүлэг дээр оруулж ир гээд үүрэг өгчихсөн.

**Ж.Батзандан:** – Төрөөс мөнгөний бодлогыг баримтлах баримт бичгийг бид нар жил болгон баталж байгаа. Хуулийн дагуу 2013 онд үндсэн чиглэлээ баталсан. 2013 оны үндсэн чиглэлийнх нь хэрэгжилт ямар байгаа вэ гэдгийг ганц өгүүлбэрээр Монголбанкныханд сануулаадхая. 2013 оны эцэст, хэрэглэний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 8%-аас хэтрүүлэхгүй байлгаж, 2014- 2015 оны инфляцийг 5-7%-ийн түвшинд байлгана гэсэн ийм нөхцөлийг бүрдүүлнэ гэж 1-1-д заасан. Одоо 2014 оны мөнгөний бодлого дээр ямар зорилт дэвшүүлж байна вэ гэхээр, 2014 оны эцэст 8%, 2015-2016 онд 7% хэтрүүлэхгүй түвшинд байлгана гэж энэ хоёр зөрүүтэй байгаа. 2013 оны мөнгөний бодлогын зорилт маань 2014 онд инфляцийг 5-7% байлгана гэсэн бол одоо 2014 онд 8% байлгана гэж, 2015-2016 онд 7%-иас хэтрүүлэхгүй гэж. Иймэрхүү зөрүүтэй орж ирж байгаа. Энийг бид нар бас жаахан ойлгож байгаа. Гадаад нөхцөл байдал, төсвийн бодлогын алдаа, цоорхойтой холбоотойгоор Монголбанк бодлогоо бүрэн дүүрэн хэрэгжүүлж чадаагүй юм байна гэдгийг би бол хувьдаа дүгнэж байгаа. Ажлын хэсэг яаж дүгнэж байгааг мэдэхгүй байна. Цаашид анхаараарай гэж хэлэх хэдэн үг, асуулт байна.

1. Санхүүгийн зах зээлд хэд хэдэн шудрага өрсөлдөөнийг ил тод өрсөлдөөнийг бий болгох ёстой. Манай банкны салбарт монополь байдал бий болсон гэдгийг хүн болгон анхаарч байгаа. Санхүүгийн зах зээл заримдаа улс төрөөс хэт хамааралтай байгаа. “5 банканд л хуваарилана шүү” гэдэг үг улс төрийн хүрээнд байдаг шүү. Монголбанк мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ цаашид, санхүүгийн зах зээл дээр чөлөөт өрсөлдөөнийг бий болгох, монополь байдлыг задлах шудрага өрсөлдөөнийг бий болгох чиглэлд ажиллах ёстой. Энэ чиглэлийн асуудлыг мөнгөний бодлого дээрээ яаж тусгасан бэ гэж асуумаар байна.

2. Жил болгоны мөнгөний бодлого дээр зээлийн хүүг бууруулна гэж орж ирдэг. Барьцаа хөрөнгийн эрх зүйн орчныг шинэчилнэ гэж бас орж ирдэг. Бид өнгөрсөн онд барьцаа хөрөнгийн эрх зүйн орчныг шинэчлэхтэй холбогдсон “Зээлийн баталгааны тухай хууль” гэдэг хууль гаргасан. Энэ хуулийн хэрэгжилт ямар түвшинд байна гэж асуумаар байна.

3. Монголбанкны дэргэд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл гэж байгаа. Энэ зөвлөл 7,8 сард валютын ханш огцом өөрчлөгдөх үед нэг ч хуралдаагүй гэсэн мэдээдэл бидэнд ирсэн. Цаашид энэ “Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл”-ийг хуулийн хүрээнд, шинэ зохион байгуулалт, бүтцэд оруулж, үр дүнтэй ажиллах нөхцөл бололцоог нь бүрдүүлэх чиглэлд ямар арга хэмжээ авах гэж байна вэ?

4. Мөн 2014 оны мөнгөний бодлого дээр “Мөнгөний бодлогын зөвлөл” байгуулна гэж оруулж ирсэн байгаа. Энэ мөнгөний бодлогын зөвлөлийг цаг хугацааны хувьд хэзээ байгуулах гэж байгаа вэ? Энийг надад хэлмээр байна.

5. Сүүлийн асуулт, валютын ханшийн өөрчлөлтөөс болж иргэд, аж ахуйн нэгжүүдэд олон тэрбум төгрөгийн хохирол учирч байгаа. Цаашид энэ валютын өөрчлөлтөөс иргэд, аж ахуйн нэгжүүдийг хамгаалах тогтолцоог хэзээ бүрдүүлэх гэж байна вэ? Үүнийг надад хариулна уу? “Валютын зохицуулалтын хууль” гэж байгаа. Түүнийг өөрчлөх үү? Өөрчилвөл, яаж өөрчлөх вэ гэдэг талаар надад хариулт өгмөөр байна.



**Н.Золжаргал:** – Валютын зохицуулалт, валютын ханшийн зохицуулалт, валютын зах зээлийн оролцогчид, энүүнтэй холбоотой нилээн их юмыг манай ажлын хэсэг ахалж байгаа С.Дэмбэрэл гишүүн нэлээн дэлгэрэнгүй тайлбарлачихсан гэж бодож байна. Миний бодлоор анх орж ирсэн төсөл, сая та бүхэнд тараагдаад хэлэлцүүлэгдэж байгаа хооронд зарчмын том зөрөө бол валютын зохицуулалтын хэсэг дээр байгаа. Энийг ил тод болгох, менежментээ сайжруулах, зах зээлээ илүү өгөөжтэй болгох, оролцогчдын шудрага байдал, оролцогчдын цар хүрээг нэмэх, хэрхэн энийгээ зохицуулах, дерватив болон бусад бүтээгдэхүүнийг хэрхэн зах зээл дээр нэвтрүүлэх, олон жил эдийн засаг дотор байсан, валютын зах зээлд байсан тогтож чадаагүй, түг яг хийсэн ганц бэлэн кэш валютын тухай наймаа явдаг энэ юмаа зохицуулж өөрчилье гэсэн саналыг ажлын хэсэг нилээд дэлгэрэнгүй ярилцаад, энийг Монголбанк ажлын хэсэг дээр тавьсан. Тэр саналыг дэмжээд энийг энэ жил хэрэгжүүлэх ёстой юм байна гэдэг санал гарсаныг Монголбанк хүлээж аваад ийм үүрэг авахаар УИХ дээрээ энэ саналыг зөвшөөрч байгаа юм.

Энэ хэрэглээний үнийн индекс дээр орсон хүлээлтийн өөрчлөлтүүдийн хувьд, таньтай бид 100% санал нэгтэй байна. Мэдээж макро эдийн засаг болсон зөвхөн төсөв дээр гэхэд 1,5 их наядын өөрчлөлтүүд, дээрээс нь гадаадын хөрөнгө оруулалтын тоон дээр бид нарын хүлээлтүүд огцом өөрчлөгдсөн байгаа. 2013 оны бид нарын анхны хүсэн хүлээж байсан тоо 2013 оны гүйцэтгэл хоёр хоорондоо 50% зөрж байгаа. 2013 онд Монголын эдийн засаг дээр бараг тэрбум гаруй долларын далд ачааллууд байсан. Үүнийг ноднин энд мөнгөний бодлого хэлэлцүүлж байх явцдаа харж чадахгүй, мэдэхгүй тоонууд байсан. Яг аль зэрэг валютын ачаалалтай эдийн засгийг бид нар энэ 2013 ондоо менежлэх гэж байгаа юм бэ гэдэг тоонууд маань он дөнгөж гараад, ажлууд явагдаж эхлэх үед ил далдаар гарч ирсэн. Ийм ийм олон үндэслэлүүдээс, макро эдийн засгийн бодит үндэслэлүүдээс болоод төслүүд маань нилээд өөрчлөгдсөн. Явцын дунд одоо явж байгаа инфляци маань 8,10%-д дөхөөд байгаа маань, энэ олон тоонууд маань зөрсөнөөс болсон юмаа. Тийм ч учраас, энэ дараа дараагийн хүлээлтүүдийг маань нилээн өөрчилж байгаа. Түүнээс бодлогын хувьд, хэрхэн энэ бодлогоо авч явах вэ гэдэг дээр УИХ-ын тогтоол, УИХ-аас батлах үндсэн чиглэл бол ирэх жилийн хийх ажлын төлөвлөгөөний цар хүрээг томъёолж өгөх учиртай гэж бид үзэж байгаа.

Түрүүн “Зээлийн батлан даалтын хууль”-ийг асуучих шиг боллоо. Энэ нь Санхүүгийн зохицуулах хороо”-ны харьяалах ажлын хүрээнд байдаг. Энэ маань өөрөө микро санхүүжилтийн тухай асуудал учраас Монголбанк дээр энэ асуудлыг бид нар тусгайлан хэлэлцдэггүй. Ханшийн эрсдлийн тухайд бол түрүүн хэлсэн иргэд аж ахуйн нэгжүүд зах зээл дээр сарын валютын эргэлт 3 жилийн өмнөхтэй харьцуулахад 3-4 дахин томорчихсон байгаа. Ийм тохиолдолд, мэдээж валютын зэх зээлд оролцож байгаа оролцогчдын эрсдэлийн ойлголт бол шинээр авч үзэх ёстой эрсдэл юм. Энэ дээр Монголбанк бол ерөнхийдөө дүрэм, журмыг нь буюу нэг үгээр хэлбэл дархлааг нь сайжруулах, компаниудынхаа, оролцогчдын дархлаа, хэрхэн энэ зах зээл дээр оролцож байх ёстой, хэн хэн хэрхэн ямар хэйч дээр ямар эрсдэлүүдээ хааж явах ёстой тухай дүрмийг нь гаргаж өгье гэдэг саналыг энэ 2014 оны мөнгөний бодлогодоо тусгаад өгчихсөн байгаа.

**С.Дэмбэрэл:** - **Ж.Батзандан** гишүүн 5 асуулт асуулаа. Үүнд хариулъя.

1. 8%-д хүрч чадах уу гэж асуусан. Өмнөх жилүүдийг харж байхад, та бүхэн батлаад өгсөн ч, хүрч чаддаггүй зорилт байсан. Яагаад гэвэл, эдийн засгаасаа мөнгөө татаж аваад, ямар нэгэн нэмэлт нийлүүлэлтийг

урамшуулсан тийм арга хэмжээ авдаггүй байсан учраас 8% гэсэн зорилт тавиад ч оны эцэст 2 оронтой тоонд хүрчихдэг байсан. Энэ 2014 оны мөнгөний бодлогын хувьд 8%-ийн инфляцийг онилох зорилгыг эдийн засгийн өсөлт, эдийн засгийг идэвхжүүлэх үйл ажиллагаатай, зорилттой уялдуулж өгсөн. Энэ маань ямар нэгэн хууль зөрчөөгүй. Монгол улсын төв банкны тухай хууль болон бусад хуулиудад ханш болон мөнгөний тогтвортой байдлын үндэсний мөнгөн тэмдэгтийн, төгрөгийн тогтвортой байдлын хоорондын хамаарлыг хуулиар заагаад өгчихсөн байдаг.

2-р асуултын хувьд, зээлийн хувь буурах гэдгийн тухайд ноднин 2013 оных бол ганцхан заалттай уягдаж орж ирсэн. Тэр нь барьцаа хөрөнгөтэй л холбоотой гэсэн. Энэ жил яг тэгж орж ирсэн. Ажлын хэсэг дээр юу гэж ярьсан бэ гэвэл, энэ зөвхөн барьцаа хөрөнгийн асуулт бишээ, зээлийн, зээл хүүгийн зардлыг өсгөж байдаг маш их олон өөр хүчин зүйлүүд байдаг, энэ олон зүйлүүдийг хамтад нь иж бүрнээр нь авч үзэж, зээлийн хүүг бууруулах төдийгүй энэ чиглэлээр 2010 - 2013 онд хэрэгжүүлж эхэлсэн зээлийн хүү зах зээлийн замаар аяндаа буурах гэсэн дэд хөтөлбөрийг УИХ-ын тогтоолоор 2014-2016 онд хэрэгжүүл, энэ чиглэлээр Засгийн газарта хамтарч ажилла гэсэн даалгаврыг тогтоолын төсөлд суулгачихсан байгаа.

3-р асуултын хувьд, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд ордог байгууллагууд саяны валютын хэт хэлбэлзэл почролын үед тодорхой хэмжээгээр инстиуци болгон, өөр өөрийн утгаар ажиллаж байсан ч гэсэн, яг протоколыг нь үзэхээр наадмын амралтын үе таарсан гэдэг юмуу, энэ чиглэлээр албан ёсны протокол байхгүй, муу ажилласан. Хангалттай ажиллаж чадаагүй. Муу ажилласан. Хангалттай ажиллах эрх зүйн үндэс ч байхгүй. Тийм учраас 2014 оны мөнгөний бодлогод Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийг инстиуци талаас нь өшөө сайжруулах, тодорхой ямар ямар чиглэлээр, яаж сайруулах тухай тодорхой заалтууд орж ирж байгаа.

4. Мөнгөний бодлогын зөвлөлийн хувьд, Монголбанкны ерөнхийлөгчийн тушаалаар төв банкинд ийм зөвлөл ажиллуулж байгаа юм байна лээ. Гаднаас 5 хүн, дотроосоо 7 хүн, ингээд 12 хүн байдаг юм байна. Энэ жил сая шалгалтын явцад ажлын хэсгийн зөвлөмжөөр Монголын банкуудын холбоо, Монголын санхүүгийн зах зээлийн холбооны төлөөллийг нэмж оролцуулсан. Гэхдээ энэ маань өөрөө хууль ёсоор, бие даасан байдал нь баталгаажаагүй байна гэж үзээд, энэ жилийн мөнгөний бодлогын УИХ-ын тогтоолын хэсэг үндсэн чиглэлд Монголбанкны мөнгөний бодлогын зөвлөлийг төв банкны тухай хуульд өөрчлөлт оруулах замаар хараат бус статусыг нь дээшлүүлж өгье, энэ чиглэлээр хуулийн төсөл боловсруул гэдэг үүрэг өгөгдөж байгаа.

5. Эцэст нь, валютын ханшны эрсдлийг хуваалцах механизмийн хувьд, ийм тогтолцоо хийх ёстой. Гэхдээ эс үйлдэл гаргаад, валютын ханшийг зүгээр чөлөөтэй тогтож байна гэж үзээд байж болохгүй. Валютын ханшны эрсдэлээс хамгаалах механизмыг зөвхөн Монголбанк төдийгүй арилжааны банкууд, валюттай харьцдаг аж ахуйн нэгжүүд өөрсдөө хамтарч, энэ чиглэлээр, энэ тогтолцоог монгол улсад бий болгох чиглэлээр Монголбанканд, мөн санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд үүрэг өгөгдөж байгаа

**Д.Арвин:** - Төрөөс мөнгөний бодлого баримтлах энэ асуудлыг жил болгон л ярьдаг. УИХ-д суухдаа 13 жил шахуу ярьж байна. Жил болгон энийг ярихдаа валютын ханшийг ярьж байх юм. Хэзээ ч дуусах юм билээ. Манайх шиг, дандаа валютын ханшаа ярьдаг ийм улс орон цөөхөн л байх. Бидний зовлон байгаа л даа. Хүн ам бага, гэхдээ энийг хэзээ төгсгөл болгох юм бэ?

Валютын ханш өслөө гээд л улс төр хийнэ, валютын ханш өслөө гээд л улс орноо самардаг. Энэ чинь нөгөө талаараа эмгэнэл байгаа шүү дээ. Тийм учраас энэний гол юм нь, ядаж үндэснийхээ үйлдвэрлэлийг дэмжье гэхээр бүх юм банкнаас хараат, хамгаалалттай байна. Өнөөдөр, миний бодлоор, би ч яахав банкны тухай сүүлийн 10-аад жил их л юм ярьдаг. Хөгжлийн банк байгуулна гээд байгууллаа. Байгуулаад ч нэмэр алга. Хийж байгаа ч юм алга. Нөгөө банкнууд нь хэвээрээ. Валютын ханш өслөө гэхэд, ядаж мах, сүү, хоол, өргөн хэрэглээний юмаа бариад сууж байх улс орон болох юмсан гэж олон жил ярьлаа. Энэ ерөөсөө бүтэхгүй юм. Сая 2013 оны үндсэн чиглэл, төсөв дээр нааштай юм гарсан л даа. Жишээлбэл, томоохон дүүргүүдэд мах, төмс, өргөн хэрэглээний гурил, үндэсний бүтээгдэхүүний зоорь баригдана гээд ХАА-ны яамны сайдын төсөвт тавьчихсан. Энэ бол маш том бүтээн байгуулалтын ажил байсан. Энийг бид нар улсын төсөвт мөнгө хийчихсэн байхад, заавал банкаар шалгаруулаад дамжуулна гээд ХАА яам бүх хөтөлбөрөө хэрэгжүүлээд, тендерээ зарлахаар банкин дээр гацчихсан. Банкны захирлууд юу гэж байна гэхээр, тэр тендер хөтөлбөр, яам сонин биш шүү дээ. Бид нар л үр дүнгийн нь тооцно. Банкны юугаар л бүх юмаа хийгдэнэ гээд байх юм. Банк гэдэг чинь бизнесийн байгууллага шүү дээ. Бид нар үндэсний үйлдвэрлэгчдээ дэмжиж чадахгүй, тоотой хэдэн томоохон бизнесүүд нь л мөнгө авч байгаа болохоос биш, яг өргөн хэрэглээний зүйлийг хийнэ гээд зөв бодлого яваад ирэхэд, ХАА яам дээр байсан хөтөлбөрүүд өнөөдөр Монголбанканд дээр очоод л зогсчихсон байгаа шүү дээ. Тэгээд бид нар намар баахан ногоо авна, тэрийгээ зоорилоод энэ 4 жил идэх юмаа хийж чадахгүй л байгаа шүү дээ. Ганц удаа хийе гээд ХАА яам бүх юмаа хийчихээд байхад, банк нь гацаачихаад байдаг. Улсын төсөвт мөнгө нь суучихсан байдаг. Эцсийн дүнд юу гэхээр, ерөөсөө л гаднаас монголчуудыг бэлэн юм идүүлэх бодлого л явагдаад байгаа шүү дээ. Үүний цаана банкны захирлууд байгааг би мэдэрдэг. Тэгээд үндэсний үйлдвэрлэлээ дэмжие гэхээр яг амьдрал дээр хөрөнгө мөнгөө өгдөггүй шүү дээ. Үүнээс хэзээ салах юм бэ? Хөгжлийн банк хаана байна? Энэ хөтөлбөрүүдийг хөгжлийн банкаар хэрэгжүүлнэ гэж, Хөгжлийн банкаа байгуулах гэж хэдэн жил бахирч чарлаж байж байгуулсан банк өнөөдөр чив чимээгүй л байгаа шүү дээ. Тэгээд ичихгүй, парламент дээр валютын ханшийг бүгд яриад суугаад байгаа байхгүй юу. Ийм улс орон гэж бараг байхгүй шүү дээ. Тийм учраас, үйлдвэрлэлээ дэмжих зөв бодлого руугаа хэзээ орох юм бэ? Яагаад тэр өнгөрсөн 2013 оны төсөвт суугдсан, ХАА яамны тендэрт зарласан хөтөлбөрүүдийг банк өнөөдрийг хүртэл яагаад санхүүжүүлэхгүй байгаа юм бэ? Яагаад төсөвт тавьсан хөрөнгө мөнгийг банк мэддэг болчихсон юм бэ? Тийм учраас, энэ зүйлүүд дээр 2013 оны төсөвт тавьсан үндсэн чиглэл бол маш сайн бодлого байсан гэж боддог. Гэтэл үүнийг хэрэгжүүлээгүй шүү дээ. Энэ дээр банк ямар бодолтой байгаа юм бэ? Нэгдүгээрт.

2-рт сүүлийн үед банкууд бизнес хийх мөртлөө, төрийн юманд маш их хутгалдаж байна. Яагаад гэвэл, төрийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа мөртлөө төрийн хэрэгжүүлсэн юмыг санхүүжүүлэхгүй, зөвхөн өөрсдөө мэдэж санхүүжүүлээд байна. Тэгэхлээр бидний тогтолцоо болохгүй байна. Тийм учраас, энэ дээр Монголбанкны захирал ямар бодолтой байдгийг би асуумаар байна.

**Н.Золжаргал:** - Монголбанк болон банкуудын тухайд бол маш ойлгомжтой. Харин хөтөлбөрүүд маань гол мөн чанаруудын нэг нь бол өөрөө энэ. Эдийн засгийг тогтворжуулахад зориулсан 3 их наяд төгрөг

маань улсын төсөв дээр, эсвэл татвар төлөгчдийн дарамт болохгүй. Тэгж бид нар энэ бүгдийг зохицуулаагүй. Харин ч, зөвхөн банкууд дээр, банкууд өөрсдөө эрсдэлээ тооцоод, энэ мөнгийг цаад эдийн засаг руугаа оролцогчиддоо хуваарилах гэсэн. Засгийн газрын зүгээс, төрийн зүгээс бол энд цэвэр зохицуулалтан дээр нь, хяналтан дээр нь ажиллахаар ингэж хөтөлбөрүүдээ зохицуулсан учраас үнэхээр арилжааны банкууд тэр хатуу хөтүү өндөр эрсдлийн шалгаруулалтаа энэ хөтөлбөрийн оролцогч дээр тавиад байгаа нь үнэхээр бодитой юм. Энэ ч өөрөө зөв юм. Аливаа төрлийн мөнгөний бодлогоороо биднийг дэмжиж байгаа салбарын өсөлт юмуу, тодорхой салбарын тухайн жилийн өсөлт, жишээ нь барилгын салбар дээр жишээ аваад хэлэхэд, энэ дээр өсөлтийг банкууд яг өөрөө өөрсдийнхөө эрсдэлийг даагаад, цаашаа зээлээ өгөөд явах нь зөв юмаа. Энийг сая улсын төсвөөс санхүүжиж байгаа юман мэдээж засгийн газар, яам, УИХ үндсэн эрхээ эдлээд явах нь зүйтэй байх. Зүгээр, банкууд өөрөө өөрсдийнхөө эрсдэлээрээ энэ зээлийн эрсдэлийг нь дааж байгаа тохиолдолд өөрийнхөө хөрөнгөөр банкууд нь өөрсдөө голлох шийдвэрийг гаргаж явж байгаа. Нийт хөтөлбөр, энэ 3 их наяд төгрөг бүгд ингэж зарцуулагдсан. 3 их наяд төгрөгнөөс нэг ч төгрөгний зээл засгийн газарт очоогүй, засгийн газар маань татвар төлөгчдийн мөнгийг энэ эрсдэл рүү оруулаагүй. Түрүүн, бас нэг асуулганд дутуу орхисон сэдэв тэр байсан. Энэ бол төрийн нуруун дээр аливаа төрлийн өр үүсч байгаа, үүсгэж байгаа тийм хөтөлбөрүүд ерөөсөө биш, тийм зээл мөнгөний харилцаа ерөөсөө биш. Энэ жил нийт эдийн засаг маань нилээд хүндрэлтэй, хямралын аюултай GDP маань 10%-иар агших ийм нөхцөл байдалтай, гадаад нөхцөл байдал ийм байхад харин энэ хөтөлбөрүүдийн үр дүнд бид нар нийт эдийн засгаа 10%-ийн өсөлттэйгээр авч гарч байгаагаас гадна, бид нарын тэр зээлийн /түрүүн Ж.Батзанзан гишүүний асуусан/, нийт зээлийн жигнэсэн дундаж хүү маань эдийн засагт 2013 онд өмнөх жилийнх 19% байсан бол одоо өнөөдрийн байдлаар 16% д ирчихсэн байгаа. Ирэх жилдээ эдийн засгийн нөхцөл байдал сайжирсан тохиолдолд, зээлийн нийт жигнэсэн дундаж хүүгээ буулгах бүрэн боломжтой. Энэ нь харин цаашдаа банкуудын зээл олгох боломж, эх үүсвэрээ даалгах боломжоор дамжаад 2014 онд аж ахуйн нэгжүүд болон эдийн засагтаа шууд эерэгээр нөлөөлнө гэсэн төсөөлөлтэй байгаа юм. ХАА-н яамны энэ хөтөлбөрүүдийг бид цааш хэрэгжүүлнэ. Энэ одоо УИХ-аас саая үндсэн чиглэл дээр ч гэсэн орчихлоо. Хөтөлбөрийнхөө хүрээнд авах ёстой арга хэмжээнүүдээ аваад, эх үүсвэрүүдээ банкууддаа байршуулаад, цаашаа эдийн засаг руу гаа хөтөлбөрүүдээ хэрэгжүүлээд явна. Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байх явцад, Д.Ариун гишүүний дээр эдийн засгийн хороон байнгын хороон дээр ч, шалгалтын явцад ч бид нарын гол харж байгаа, Монгол ардын намын бүлгээс гарсан санал санаанд дотор ч бас яваад байгаа, дутуу хараад байгаа зүйл бол бид нар энэ хөтөлбөрүүдэд оролцож байхдаа эдийн засгийн дэмжих идэвхжлийг дэмжих буюу нийт M2 хэмжээг аль түвшинд барьж байх вэ гэдэг нарийн балансыг нь барьж явдаг. M2 огцом өсвөл, мэдээж инфляцийн аюултай, ханшийн нөлөөлөлтэй. M2 болон гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний хувьд бол түрүүн Б.Бат-эрдэнэ гишүүний асууснаас эсрэгээрээ, гүйлгээнд байгаа бэлэн мөнгө бол өмнөх жилийн өсөлттэй харьцуулахад хамаагүй багаар өссөн байгаа. Ханшийн нөлөөлөл эндээс гараагүй. Энэ нөлөөлөөсөө шалтгаалж, бид нар хөтөлбөрүүдээ хэзээ, хаана, ямар цаг хугацаанд, аль зэрэг дүнтэйгээр явуулах вэ гэдгээ харуулсан байгаа. Энэний танилцуулгыг мөнгөний бодлогынхоо үндсэн чиглэлийнхээ хэлэлцүүлэг дээрх танилцуулган дээр хийсэн байсан. Одоо

бид макро эдийн засгийн боломж нь олдох юм бол, энэ эдийн засгийн тэр тохирсон хөтөлбөрүүдээ Монголбанк цаашдаа санхүүжилтээ хийгээд, нийлүүлээд явах юмаа.

**Д.Арвин:** - Монголбанкны ерөнхийлөгчийн хариултыг сонслоо. Засгийн газартай хамтарч ажиллаж байна, эрсдэлээ даана гээд сайхан хариулт өгч байгаа ч гэсэн цаана чинь амьдрал хэцүү байгаа шүү дээ. Махны үнэ нэмэгдээд, бүх өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдээнд байна гэдгээр чинь та нарын ажлын үзүүлэлтийг дүгнэнэ. Өнөөдөр банкаа өмөөрч ярих биш, цаана чинь үйлдвэрлэл явахгүй байна, хүмүүс юм хийж чадахгүй байгаа ийм нөхцлийг бүрдүүлээд байна гэдгээ та анхаараарай.

2-рт, одоо тэр хөтөлбөр хэрэгжинэ гэж та хариулт өгч байна. хэрэгжих хугацаа нь, 2013 он чинь дууслаа. Намар нь, бүх ногоонуудаа аваад, энд тэнд хямдхан зараад дуусчихлаа. Тэрний дараа, одоо ингээд нэмэр байна уу? Би энийг хавар хэрэгжүүлнэ гэж бодоод ХАА-н яамыг хурдлаач хурдлаач гээд байсан. Одоо ингээд 11 сар болчихоод байхад, банк нь өгөхгүй л байна шүү дээ. 2013 оны ажил байхгүй болчихсон байна. Иймэрхүү л явж байгаадаа та дүгнэлт хийгээрэй.

**З.Энхболд:** - Гишүүд байнгын хорооны дүгнэлтээс асууж дууслаа. Одоо санал хурааж эхэлнэ. 12 санал хураалт байна. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Монгол улсын их хурлын тогтоолын төслийн төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооны зарчмын зөрүүтэй саналын томъёолол, Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналууд байна.

1. Дэмжсэн эхний санал: Тогтоолын төсөлд дор дурьдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

*“3. Дор дурьдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол улсын засгийн газар /Н.Алтанхуяг/, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/ -д тус тус даалгасугай.*

1. Санхүүгийн зах зээлийн бүтцийг олон тулгуур бүхий зохистой болгох, чөлөөт өрсөлдөөний орчин бүрдүүлэх, санхүүгийн олон төрлийн бүтээгдэхүүн бий болгох, санхүүгийн жуучлалыг гүнзгийрүүлэх чиглэлээр 2014 - 2016 онд хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх.

2. Эдийн засгийн бодит салбарын идэвхжлийг дэмжих зорилгоор зээлийн хүүг буурах орчинг бүрдүүлэх хөтөлбөрийг цргэлжлүүлэн хэрэгжүүлэх.

3. Жижиг дунд бизнесийн болон бичил санхүүжилтийг дэмжиж ажиллах

4. Валютын захад тогтворгүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах

5. Валютын захад банк бус санхүүгийн байгууллага санхүүгийн зах зээлийн бусад оролцогчдыг идэвхтэй оролцуулах, ханшийн эрсдэлээс хамгаалах санхүүгийн үүсмэл хэрэгсэлийг зах зээлд нэвтрүүлэх зорилгоор валютын арилжааны системийг бий болгох

санал гаргасан УИХ-ийн гишүүн С. Дэмбэрэл, Б.Гарамгайбаатар, Д.Зоригт, А.Тлейхан, Л.Энх-амгалан

Санал хураах, санал хураалтанд 63 гишүүн оролцож 45 гишүүн зөвшөөрч 71,4%-ийн саналаар эхний санал дэмжигдэж байна.

Тогтоолын төсөлд дараах агуулга бүхий дор дурьдсан 4 дэх заалт нэмэх тухай ажлын хэсгийн 2 дахь санал:



“4. Дор дурьдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/ -т даалгасугай.

1. Монгол улсын засгийн газар, Монголбанкны хооронд 2012 оны 10 сарын 22-нд өдөр байгуулсан гол нэрийн бараа бүтээгдэхүүний цнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санал бичгийг хүрээнд, хэрэгжүүлж байгаа хөтөлбөрт иж бүрэн дүн шинжилгээ хийх, хөтөлбөрийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, арга хэрэгслийг зах зээлийн механизмд суурилсан хэлбэрт шат дараатэй шилжүүлэх, хяналтын тогтолцоог сайжруулах, хөтөлбөр хэрэгжиж байгаа салбарт өрсөлдөөний шудрага биш орчин бий болохоос сэргийлэх, хөтөлбөрөө ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллах.

2. Улсын гадаад өр, түүний эргэн төлөлтийн гадаад валютын ханшийн эрсдлийг бууруулж, эрсдэлээс хамгаалах механизм бий болгох

3. Төсвийн төсөл, төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулахад ашиглах төгрөгийн гадаад валюттай харилцах ханшийн төсөөлийг тогтсон аргачлал, эх сурвалжид үндэслэн боловсруулах

Санал гаргасан ажлын хэсэг.”

Асуулттай гишүүд нэрээ өгье. Ц.Нямдорж гишүүнээр таслая. За асуугаарай.

**Н.Энхболд:** - 2013 оны төсвийн тодотгол хэлэлцэх үеэр манай бүлгээс дүгнэлт гаргаад, энэ үнэ тогтворжуулах хөтөлбөрийн үр дүн хангалтгүй байна гэж үзээд үүнийг цааш нь хэрэгжүүлэх шаардлагагүй гэсэн байр сууриа илэрхийлсэн. Одоо энэ тогтоол гарахаар, дахиад үргэлжлээд явах нь л дээ. Үүнийг байнгын хороон дээр ярих үеэр манай бүлгийн тэр дүгнэлтэн дээр гарч байсан саналыг авч ярьсан уу, үгүй юу? Олон тэрбум төгрөг зарцуулж байж, энэ арга хэмжээг хэрэгжүүлж байгаа ч үр дүн гарахгүй байгаа. Үнэ нэмэгдээд байгаа, тэр ч байтугай зарим хөтөлбөрийн үргэлжлэл цаашдаа мухардалд хүрчих гээд байгаа шүү дээ. Тийм түвшинд хүрч байгаа шүү дээ. Ингээд үргэлжлээд явах юмуу? Энэ талаар манай бүлгээс гарсан дүгнэлтэнд илэрхийлсэн байр суурийг хэр тойруулж ярьсан бэ? 1-рт.

Хоёрдугаарт, хөтөлбөрийн арга хэрэгсэлийг зах зээлийн механизмд суурилсан хэлбэрт шат дараалалтай шилжүүлэх гэсэн ийм үг байна энэ зах зээлийн механизмд суурилсан хэлбэр гэдэг нь яг юугаа хэлж байгаа юм бэ шат дараалалтай шилжүүлнэ гэдэг нь цаашдаа энэ хөтөлбөрийг байхгүй болгоно гэсэн үг үү, бүр үргэлжлүүлнэ гэсэн үг үү? Аль тал руугаа явах гэж байгаа юм бэ? Энэ тал дээр хариулт өгөөч.

**С.Дэмбэрэл:** – Н.Энхболд гишүүний асуултанд хариулья. МАН-ын бүлгийн гишүүд болох Л.Энх-амгалан, А.Тлейхан гишүүн гээд ажлын хэсэг бид нар ярилцсан. Анх ер нь, мөнгөний бодлогын талаар 2 нам зарчмын зөрүүтэй 2 мэдэгдэл хийж байхад тэр бичсэн зүйлийг нь ажлын хэсэг урьдчилж аваад, ажлын хэсгийн санал дүгнэлтийг боловсруулах явцдаа энэ хоёр, түүний дотор МАН-аас шүүмжлэлтэй хандсан зүйлүүдийг авч хэлэлцэж байсан. Дээр нь Л.Энх-амгалан гишүүн, А.Тлейхан гишүүн 2 өчигдөр орж ирж, манай бүлгээс 5 зүйлийн саналыг хэлж байна гэснийг, санал болгон дээр нь нэг бүрчлэн ярилцаад, хөтөлбөрийн гол нэрийн бүтээгдэхүүний энэ томъёоллыг оруулж ирж байгаа юм. Энэ дотор /цаашдаа мэдээж ярилцах биз/, хөтөлбөрийн ил тод, нээлттэй байдлыг хангана, хяналтыг сайжруулна, хөтөлбөрийг зах зээлийн үе шаттай байлгана гэдэг энэ бол ямар нэгэн инкубацийн хөтөлбөр биш, энэ өнөөдөр

монголын тодорхой секторуудын үйл ажиллагааг төрийн зүгээс мөнгөний бодлого болон сангийн бодлогоор хамтруулж дэмжиж байгаа институци хоорондын хамтын ажиллагаа. Гэхдээ энийг нийт эдийн засгийн секторыг идэвхжүүлэх замаар буюу зах зээлийн харилцаанд үе шаттайгаар хэрэгжүүлнэ гэдэг маань, хөтөлбөр хэрэгжүүлэх 3 жилийн туршид үүнийг улам бүр боловсронгуй болгоно гэсэн утгаар энэ өгүүлбэр орж ирж байгаа юм. Дээр нь энэ компаниудтай уулзаад, хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгаад, энэ чиглэлээр яриад ирэхээр хөтөлбөрийн хэрэгжиж байгаа салбаруудад шударга бус өрсөлдөөн үүсэх магадлал гарч магадгүй байгаа учраас үүнээс сэргийлэх талаар, цаашдаа хөтөлбөрийг хэрэгжүүлэх шатанд, Монголбанк, засгийн газар хоорондын холбогдох байгууллагууд онцгой анхаарах ёстой. Тийм учраас, анхны хувилбар дээр үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ гэсэн байсныг одоо 7-8 өгүүлбэр нэмж, өгүүлбэр болгоны ард /энэ өөрөө хууль болж батлагдах учраас зайлшгүй хэрэгжүүлэх ёстой./ тэр талаас нь бодож, хөтөлбөрийн механизмыг сайжруулж оруулж ирсэн.

**Н.Энхболд:** - Би С.Дэмбэрэл гишүүний хариултыг ойлгосонгүй. “Зах зээлийн механизмд суурилсан хөтөлбөрт шат дараатай шилжцүлнэ” гэдэг нь 3 жил хэрэгжээд, дахиад хэрэглэхгүй болно, бүхэлд нь зах зээлийнх нь механизмын дагуу тэр зарчмаар нь явуулна гэсэн үг үү, улам боловсронгуй болгож хүрээг нь нэмээд байна гэсэн үг үү? энэ дээр л хариулт авмаар байна.

**С.Дэмбэрэл:** - Энэ хөтөлбөр маань өөрөө дунд хугацааны хөтөлбөр шүү дээ. 3 жил л хэрэгжинэ. Тийм учраас цаашдаа гэдгийг дараа дараагийн жилийн мөнгөний бодлогоор хэрэгжинэ гэж ойлгох байх. Миний бодлоор, гишүүн хүний саналыг асууж байгаа бол, энэ ингээд 3 жил хэрэгжээд дуусах ёстой. Тэр нь зохистой.

**Ц.Нямдорж:** - Монголбанканд явагдсан ажлын хэсгийн эцсийн ойлголцсон тохиролцсон дүгнэлт одоо хүртэл гараагүй байгаа. Шалгалтын дүнгээ нэгтгэж, эцсийн бичиг баримтан дээр гарын үсэг зурж, УИХ байнгын хороонд танилцуулсан ажил хийгдээгүй байгаа. Тэгэхээр энэ шалгалтын ажлын хэсгийн нэрийг барьж асуудал ярих нь зохистой бус. Энийг С.Дэмбэрэл гишүүн анхаармаар байна.

2-рт, гол юм энэ шалгалтын явцад “Үнэ тогтворжуулах хөтөлбөр” гэдгийг үзсэн. Яг өнөөдөр мөрдөж байгаа Монголбанкны хуулиар бол энэ “Үнэ тогтворжуулах хөтөлбөр” гэдэг юмыг Монголбанк хийх эрх, үүрэг байхгүй. Энэ хууль бус гэдгийг Монголбанкны ерөнхийлөгчөөр 6 жил ажилласан О.Чулуунбат саяхан хэлсэн. Энэ хажууд маань ерөнхий сайд байсан С.Батболд сууж байна. Ерөөсөө л нэг иймэрхүү юм хийж байгаа дуулдаад байна шүү. Тэгээд үнэ тогтворжуулах хөтөлбөр боловсруулаад, бүх юмныхаа үнийг бариад, одоо бүх юмаа тавьж туугаад байгаа юм сая хэлнэ лээ. Энэ хөтөлбөрийн хэрэгжилтийг, жишээ нь, бензиний компаниуд дээр авч үзэхэд бүх юм сөрөг болчихоод байгаа юм. 40 тэрбум төгрөг авсан компани нэг жилийн дараа гэхэд, тэрбум төгрөг хүрэхгүй мөнгө хариу төлсөн байдаг. Тэр компани өмнө нь жилд 7 тэрбумын ашигтай ажиллаж байсан бол, энэ жил 3 тэрбумын алдагдалд орсон байдаг. Дээрээс нь литр бензин бүрээс 210 орчим төгрөг алдаад байгаа. Бензины бүх компаниудад ийм болчихоод байгаа. Өөрөөр хэлбэл энэ хөтөлбөрийн хэрэгжилт эдийн засагт хэрэгтэй юм юу ч авчрахгүй байгаа байхгүй юу. Үнэ өсдөгөөрөө өсөөд, ийм юм болж байхад хууль бус юмыг цааш нь үргэлжлүүл гээд УИХ тогтоол гаргаад, бүр “эмээлийг нь гэдсэнд нь эвхээд тавьлаа” л даа. Ядаж л энэ засгийн газар, Монголбанкны хооронд байгуулсан санамж бичгийг

хэрэгжүүлж барь гэдэг юмнаас зайлсхийж болохгүй юу, гишүүдээ? Энэ Н.Золжаргал олон удаа хэлээд байгаа нэг юм байгаа нь “*Валюттай харьцах ханш Монголбанканд хамаагүй, Төгрөгийн тогтвортой байдал гэдгийг гол нэрийн барааны үнийн тогтвортой байдал гэж үзэж байгаа*” гээд худлаа хэлээд, ер бусын адал балмад юм яриад яваад байгаа байхгүй юу. Яг ерөнхий сайд шиг юм яриад яваад байгаа. Хэрэв энэндээ хүрч байгаа бол, Монголбанк валютын ханш зарладагаа болих хэрэгтэй. Төгрөг, мах, сүүний үнийг нийтэд зарладаг болох хэрэгтэй. Долларын ханшны уналтаас ашгийн 30% зүгээр л янданд идүүлж байгаа шиг байхгүй болж байгааг бүх хүмүүс харж байгаа. Нийт экспортын 90% нь гадаадаас орж ирж байгаа. Мөнгөө дандаа валют болгож аваад, гадагшаа явж, юм худалдаж авч орж ирж байгаа. Эдийн засгийн бүх юмыг валютын ханш идээд дуусч байхад, гол нэрийн барааны үнэ тогтвортой байх явдал бол Монголбанкны гол асуудал гээд ярьж байгаа ийм ерөнхийлөгчтэй юу ярих юм бэ? Байж боломгүй юм. УИХ-ын гишүүдийг юу гэж ойлгоод байгаа юм бэ? Энэ ганц Монголбанкны ерөнхийлөгч энэ хугацаанд ажиллаагүй л дээ, миний мэдэхийн. Хэдэн ийм юм орж гараад л байж байдаг ш дээ. Одоо Н.Золжаргалаа төгрөг, мах, сүүний..

**З.Энхболд:** - Байр сууриа илэрхийллээ. Ж.Энхбаяр гишүүн асууя.

**Ж.Энхбаяр:** Ялангуяа энэ 4-р зүйлтэй холбоотой асуудлууд байна л даа. Үнэхээр тэр нийгмийн чанартай, зорилготой, бодлогын, зээлийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх үнэхээр шаардлагатай юм бол улсын төсвөөр дамжиж хэрэгжээд засгийн газар, Монголбанканд хүсэлт тавиад, үнэт цаасаа гаргаад, Монголбанк мөнгөжүүлээд хэрэгждэг учиртай.

2-рт, сая Ц.Нямдорж гишүүний яриад байгаа зүйл. Манай хүн ажлын хэсэгт орсон. би түрүүн 2 удаа шаардсан. Ажлын хэсгийн дүн үнэлгээ гараагүй байхад, дүгнэлт өгөөгүй байхад, асуудал үргэлжлэхээр орж ирж байгаа нь маш том бодлогын алдаа болж байна. Суурь нь тавигдаагүй байхад багана босгож байгаатай яг адилхан болж байна. Үнэхээр шалгалтын дүн гараад, хууль зөрчөөгүй, үнэ тогтворжих хөтөлбөр нь зөв зүйтэй гэж үзэх юм бол хэрэгжээд яваг. Эс тэгвээс, ямар нэг зөрчилтэй зүйл гарвал, УИХ өөрөө мухардалд орж байна. Би хурлын даргад хэлэх хүсэлт байна. Энэ шалгалтын дүн гараад, УИХ танилцаг. Мэргэжлийн байгууллага сонсог. Тэрний дараа энийгээ хэлэлцүүлж болдоггүй юмуу? Үнэхээр бид хэлээд байгаа юм биш, гадна талд сигнал өгөөд байна. Дэлхийн банкны өгсөн тайлангуудыг хараад сууж байна. Бас л энэ асуудлыг зүйл бүрээр задлаад тооцсон байна. Үнэхээр нөхцөл байдал чинь хүндрээд байна шүү. Уул уурхай, зах зээл чинь 20 жил хангалтгүй, хүндрэх нь байна шүү, энүүнтэй холбоотойгоор Монгол улсын эдийн засаг нилээд сулрах нь байна шүү, явуулсан мөнгөний бодлого чинь сул байна шүү, ханшны асуудал чинь жолоодлогогүй болж байна шүү, ялангуяа нэг салбарыг онцлон хэт /барилгын салбарыг/ дэмжсэн сул зээлийн бодлого, зээлийн эрс нэмэгдэл чинь инфляцид чинь нилээн ихээр нөлөөлөөд байна шүү гэсэн бодитой юмнууд гарч ирээд байдаг. Гэтэл бид энэ дээр нь ямар нэгэн дүгнэлт сигнал гаргахгүй, ядахдаа УИХ-аас гаргасан ажлын хэсгийнхээ дүнг ч сонсохгүйгээр асуудлыг шахаад байгаа нь УИХ өөрөө ажиллах чадавхаа алдаад байгаа шинж болоод байна. Ядахдаа нэг дүнгээ сонсмоор байна. Үнэхээр зөв болсон бол дэмжээд явъя, үнэхээр нөхцөл байдал алдаатай гарсан бол залруулга хийгээд явчихмаар байна. Бид залруулах бололцоогүй болчихлоо. Төсвийн 2-р хэлэлцүүлгээр нилээд юм явчихлаа. Одоо ингээд мөнгөний бодлого явчихвал, хойноос нь шалгалт хийгээд яах вэ дээ.

**З.Энхболд:** - Санал хураах гэж байгаа. Тэрнээс ажлын хэсгийн дүгнэлт сонсох сонсохгүй тухай яваагүй байгаа. Энэ асуулт дээр кнопоор байр сууриа илэрхийлцгээ. АН-ын бүлгээс 2 гишүүн орсон байгаа. А.Тлейхан гишүүн, Л.Энх-амгалан гишүүн гарын үсэг зураад, одоо энийг яаж шийдэхээ хувь гишүүн өөрсдөө шийдэцгээ. Би одоо санал хураалгалаа.

**Санал хураалтанд 65 гишүүн оролцож, 45 гишүүн зөвшөөрч, 69,2% саналаар 2 дахь санал дэмжигдэж байна.**

**З.Энхболд:** Ажлын хэсгийн 3 дахь санал - Тогтоолын төсөлд доор дурьдсан агуулгатай 5 дахь заалт нэмэх

*“5. Дор дурьдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монголбанк /Н.Золжаргал/-д даалгасугай.*

1. Монгол улсын зээлжих зэрэглэл, түүний өөрчлөлт, нөлөөлсөн хүчин зүйлийн шинжилгээг тогтмол хийж, зээлжих зэрэглэлийг сайжруулах чиглэлээр зөвлөмж боловсруулан, УИХ-ын эдийн засгийн байнгын хороо болон Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд танилцуулж байх

2. Монголбанкны хараат бус байдлыг бэхжүүлэх, засаглалын бүтэц, зохион байгуулалтыг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор хараат бус гишүүд бүхий Мөнгөний бодлогын зөвлөлийг бий болгох чиглэлээр төв банк /Монголбанк/-ны тухай хуульд холбогдох нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах

3. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааны үр дүн, шийдвэр гаргах механизм, хариуцлагын тогтолцоог сайжруулах, зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөтгөх, санхүүгийн салбарт үүсч болох эрсдэлийг үнэлэх, түүнээс хамгаалах, бодлогын уялдааг хангах үр дүнтэй институци болгох чиглэлээр төв банк /Монголбанк/-ны тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг боловсруулах.

Санал гаргасан ажлын хэсэг: С.Дэмбэрэл, Б.Гарамгайбаатар, Д.Зоригт, Л.Энх-Амгалан, А.Тлейхан”

**Санал хураалтаар 63 гишүүн оролцож 52 гишүүн зөвшөөрч 82,5% -ийн саналаар 3 дахь санал дэмжигдлээ.**

**З.Энхболд:** Ажлын хэсгийн 4 дэх санал. Тогтоолын хавсралтанд заасан үндсэн чиглэлд эхний өгүүлбэрийг дор дурьдсанаар өөрчлөн найруулах:

*“Мөнгөний бодлогын гол зорилт нь инфляцийг болон санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх, бодит салбарын идэвхжлийг мөнгөний бодлогоор дэмжих замаар эдийн засгийн дархлааг сайжруулахад чиглэнэ.”*

**Санал хураалт явагдаж: 63 гишүүн оролцон, 48 гишүүн зөвшөөрч, 76,2% -ийн саналаар 4 дэх санал дэмжигдлээ.**

**З.Энхболд:** Ажлын хэсгийн 5 дахь санал. Тогтоолын хавсралтанд заасан үндсэн чиглэлийн 1.1 дэх заалтыг дор дурьдсан байдлаар өөрчлөн найруулах:

*“1.1 хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2014 оны эцэст 8%, 2015-2016 онд 7%-аас хэтрэхгүй түвшинд байлгана. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу инфляцийг хязгаарлах, мөнгө төсвийн бодлогын харилцан уялдааг хангах чиглэлээр Засгийн газартай хамтран ажиллана. Эдгээрийн үр дүнд, дунд болон урт хугацаанд макро эдийн засаг тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлнэ.”*

**Санал хураалт явагдаж, 63 гишүүн оролцож 49 гишүүн зөвшөөрч 77,8% -ийн саналаар 5 дахь санал дэмжигдлээ.**

**З.Энхболд:** Ажлын хэсгийн 6 дахь санал. “Тогтоолын хавсралтанд заасан үндсэн чиглэлийн 1.2 дахь заалтыг дор дурьдсанаар өөрчлөн найруулах:

*“1.2 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь, макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж, уян хатан тогтох, төгрөгийн тогтвортой байдал болон үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих зарчим баримтлана.”*

Санал хураалт явагдаж, **63** гишүүн оролцож **51** гишүүн зөвшөөрч, **81%**-ийн саналаар **6** дахь санал дэмжигдлээ.

**З.Энхболд:** Ажлын хэсгийн 7 дахь санал. Тогтоолын хавсралтын үндсэн чиглэлд заасан 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 1.3 дахь заалт нэмэх:

*“1.3 Гадаад валютын ханшийн эрсдэлийг зээлдэгч, банк, засгийн газар хооронд харилцан хуваах замаар бууруулах тогтолцоог бүрдүүлнэ.”*

**З.Энхболд:** Н.Энхболд гишүүн асууя. Хүрэлбаатар гишүүн дараа нь асууна.

**Н.Энхболд:** Аль зээлийн тухай ярьж байгаа юм бол оо? Би нөгөө орж ирсэн төслийг олохгүй байна. Хаанаас авсан, ямар зориулалтаар авсан зээлийн тухай яриад байгаа юм бол? Яагаад Засгийн газар заавал эрсдэлийг нь хуваалцах тухай санал энд ороод ирэв? Энийг хуучин орж ирсэн төслийнх нь заалттай холбоод тайлбарлаад өгөөч. Ханшийн эрсдэлийг бизнесийнх нь байгууллага хариуцна биз. Яагаад засгийн газрыг энд татаж оруулж байгаа юм бол?

**З.Энхболд:** - Шинэ нэмэгдэж байгаа заалт уу? Би үүнийг хуульд нийцэх заалт уу, үгүй юу гээд хараад сууж байна л даа. Банкны тухай хуулинд *“Ханш хөвөгч байна. Тэр нь зах зээлээрээ зохицож явна.”* гэж биччихээд, хэн нэгний эрсдэлийг засгийн газар хуваалцдаг нь ямар учиртай юм бэ гэдэг асуулт зүй ёсны дагуу гарч ирж байна. Энэ хэрвээ хуультай зөрчилдөж байгаа бол, санал хураалгахгүй байх ёстой л доо.

**С.Дэмбэрэл:** - Ямар нэгэн хуультай зөрчилдсөн гэж үзэхгүй байна. Ажлын хэсэг дээр ч ингэж яригдаагүй. Ер нь засгийн газар эдийн засагт, түүний дотор ханшийн зах зээлийн нэг оролцогч нь мөн үү гэвэл, мөн. Засгийн газар өөрийнхөө худалдан авалтынхаа хөтөлбөрөөр валютын ханштай холбоотой зах зээлд оролцдог. Бусад зээлжих бүх зүйлээрээ бас оролцдог. Засгийн газраас тусдаа байна гэж байхгүй. Тийм учраас, олон улсын практик ёсоор, гадаад ханшны эрсдэлээс хамгаалах механизмыг бүрдүүлэх чиглэлээр Засгийн газар нь ч оролцдог. Валютын зээл авсан, эсвэл Засгийн газрын худалдан авалтын хөтөлбөрийг буюу тендерийг хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгжүүд импортын чиглэлээр гадаад үйл ажиллагаанд бас оролцож байгаа учраас энэ тал дээр оролцдог. Мөн түүнчлэн банк, зээл олгож байгаа банк нь эрсдэл хуваалцдаг олон улсад тогтсон механизмыг, тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр Монголбанк ажиллах ёстой гэсэн утгаар энэ 3 субъект орж байгаа юм. Тэрнээс биш эрсдэлээс гарсан хохирлыг гэж бичээгүй байна. Эрсдэлийг хуваалцах олон улсын тогтсон механизмийн гэсэн ийм утгаар орсон юмаа. Н.Золжаргал ерөнхийлөгч нэмээд хариулчих.

**Н.Энхболд:** - Ямар зээлийн тухай яриад байгаа юм бэ гэж би асуусан. Зээлдэгч, банк, засгийн газар 3-ын хооронд харилцан хуваах зарчим орж байна. Банкууд өөрсдөө, өөр газраас арилжааны зээл авч байгаа бол, тэрлүү заавал засгийн газар гүйж очоод, тэрний эрсдэлийг хуваалцах ямар шаардлага байгаа юм бэ? Тэгэхээр би ямар зээлийн тухай вэ гэж асуусан шүү дээ. Аль зээлийн тухай вэ гэдгийг нь тайлбарлахгүй бол таны хариулт ойлгомжгүй дууддаж байна.



**С.Дэмбэрэл:** - Банк болон компанийн хооронд валютын зээлийн харилцаа үүсдэг. Мөн банк, засгийн газар, компанийн хооронд, худалдан авалтын хөтөлбөрөөр дамжуулан бас зээлийн харилцаа үүсдэг. Энийг л хэлсэн. Үүнээс болоод бодит амьдрал дээр өнөөдөр

**З.Энхболд:** - Бүх төрлийн зээл юмуу? 100-н долларын зээлээс эхлээд, 100-н саяын зээл хүртэл явах юмуу?

**С.Дэмбэрэл:** - Зээлийнх нь үнийн дүн гэхээсээ илүү, зээлийн эрсдэл гаргах механизмыг Монгол улсад, дунд хугацаанд бий болгох ёстой. Тогтолцоог бий болгох хэрэгтэй байгаа юм. Тэрний суурийг тавих утгаар л орж байгаа юм. Монголбанкны ерөнхийлөгч энэ асуудлыг ажлын хэсэг дээр анх яриад, бид Монголбанктай нилээд ярилцсаны үр дүнд бүрэн дэмжиж байгаа юм. Тэрийгээ Монголбанкны ерөнхийлөгч хэлчих байх гэж бодож байна.

**З.Энхболд:** - Би зээл авсан. Шатчихлаа. Засгийн газар төл гээд нэхэмжлэл тавина шүү дээ. Монголбанк үүнийг юу гэж үзэж байгаа юм бэ? Би энүүгээр, шүүхэд очино л гэж хэлэх гээд байна. “Өрөө төлөхгүй байна.” гээд л шүүхэд очино шүү дээ.

**Н.Золжаргал:** - Тэгэхээр энэ дээр саналаа хэлье. Гишүүд маань буруу ойлгоод байх шиг байна. Сайн уншчихмаар л санагдаад байна. “Гадаад валют ханшийн эрсдэлийг” гэж бичсэн байгаа. Зээлдэгч нь валютаар зээл аваад байна л даа. Эсвэл Засгийн газар нь валютаар зээл авдаг ч байгаа юмуу, банк нь валютаар зээл авдаг ч юмуу, энэ харьцаан дээр үүсэх эрсдэлийг зохицуулдаг, бууруулдаг тэр тогтолцоог бий болгохгүй бол Монгол улс 20 жил ингэж явлаа л даа. Энэ дээр анх удаа ингэж орж ирж байна. Н.Энхболд гишүүн асуулсан дээр хэлье л дээ. Хэн, яг ямар зээл авсан гэдэг дээр тайлбарлая. Засгийн газар Японоос тусламжийн зээл авчихсан. Тэрийгээ аж ахуйн нэгжүүдэд, цаашаа иенээр нь өгчихсөн. Гэтэл иен долларын ханшаас болоод, УБ төмөр зам дээр жилд зөвхөн ханшийн ачаалал гэхэд л 40 тэрбум төгрөгийг үүрүүлж байна. Тусламжийн зээл гэж засгийн газар авчирч өгчихөөд байдал ийм л байна. Энэ Монголын эдийн засгийг ухаад үзвэл, ийм юм маш олон юм байгаа. Энэ болгон дээр дүгнэлтийг нь эргээд бид нар л бичих болчихдог. Тэгээд алдаанууд нь гардаг. Зүй нь, анхнаасаа энэ валютын иенээр авч байгаа зээлийнхээ долларын орлоготой, Монгол улс ханшийнхаа эрсдэлийг хааж явах ёстой. Тэгээд засгийн газрын орлого нь төгрөгөөр байдаг учраас энэ эрсдэлүүдээ тогтмол хэйчилж байх ёстой. Банкууд ч гэсэн долларын зээл авчихаад, төгрөгийн орлоготой тохиолдолд энэ зохицуулалт руу орно. Дээрээс нь аж ахуйн нэгжүүд, төгрөгийн орлоготой мөртлөө долларын зээлтэй аж ахуйн нэгжүүд бол бас энэ зохицуулалт руу орох ёстой. Энэ зохицуулалтыг хийж өгсөн тогтолцоог бий болгох тухай заалт юм л даа. Аливаа нэг боловсронгуй зэх зээл дээр, валютын арилжаа нь нилээд хүчтэй болчихсон, ялангуяа манайх шиг, гадаад худалдаа нь дотоодын нийт бүтээгдэхүүнээс илүү өндөр тоон дээр явдаг, гадаад эдийн засгийн хамаарал нь ийм өндөр эдийн засгийн хамаарал дээр зайлшгүй хийгдэж явахгүй бол болохгүй. Бид нар нийт хэрэглэгчиддээ ханшийн эрсдэлийг тогтмол үүрүүлж яваад байгаа. Одоо тэр 50 тэрбум төгрөгийн ачаалал гэдэг бол төмөр замын өртөг болоод төмөр замын тээврийн хөлсөнд шингээд, цэвэр хэрэглэгчид дээр бууж ирээд байгаа. Зүй нь бол, засгийн газар өөрөө валют төгрөгийнхөө орлогынхоо энэ эрсдэлийг хааж явж байх ёстой. Иен долларынхаа хэйчийг хийж явах ёстой. Үүнийг өмнөх Монголбанкны ерөнхийлөгч нар мэддэг байсан зүйл. Мэддэггүй зүйл ерөөсөө биш. Одоо нийт эдийн засгийн

хэмжээ томроод, валютын урсгал томроод, эдийн засгийн гадаад хамаарал маань багасахгүйгээр, улам бүр нэмэгдэж байгаа үед энэ маань Монголын эдийн засагт, санхүүгийн салбарт том эрсдэлийг авчраад байгаа юм. Хэн нэгний зээлийг, өөр хэн нэгэн, хаа нэг газарт хаах гээд байгаа ойлголт ерөөсөө бишээ. Энэ бол тогтолцоог нь бүрдүүлж өгөх л асуудал. Тогтолцоо буруу зөрүү гэдэг нь бол дараагийн асуудал.

**З.Энхболд:** - С.Дэмбэрэл, Н.Золжаргал хоёрын ярьсан томъёолол 2 зөрж байна. Би бол ингэж томъёолохгүй. Хэйч хийхийг ойлгож байна. Томъёолол бол шүүхэд очихоор томъёолол болсон байна. Ж.Энхбаяр гишүүн олон удаа гар өргөсөн Ж.Энхбаяр гишүүнийг нэг сонсоодхоё.

**Ж.Энхбаяр:** - Энэ асуудалтай холбоотой. Уучлаарай. Хүрэлээ, манайхаан анхаараадхая. “Засгийн газар” гэж орж ирэхээр төсөв дээр аюул учирч байгаа юм. Яагаад гэвэл, төсөв өөрөө 1,5 их наяд төгрөгний худалдан авалт хийнэ. Ихэнх нь импортын бараа авна. Тэрэн дээр, ханшийн өөрчлөлт гарах юм бол, төсөв дээр нэмж, ханшийн эрсдэл гэсэн зардал засгийн газарт гэж бууж ирж байгаа юм. Засгийн газар чинь өөрийн гэсэн мөнгө байхгүй. Татвар хураагчдын мөнгөөр, төсвөөр хариуцлагаа хүлээнэ. Тэгэхээр /санаа нь бол маш сайхан санаа байна./ бид нэг болгоомжтой алхам хийгээд, эхний ээлжинд арилжааны банкнаас зээл авч байгаа зээлдэгч болон зээл олгогч банк 2 л эрсдэлээ хувааг. Засгийн газар ороод ирэх юм бол төсвийн өөрийн худалдан авалт, төсвийн хөрөнгө оруулалтаар хийж байгаа ажил чинь өөрөө зээлийн эрсдэлд маш их нөлөөлж байгаа учраас ирэх жилийн төсөвт ялангуяа 2014 онд их дампуу юм болох талдаа гарах бий гэсэн болгоомжлол төрөөд байна. Тэгэхээр санаа л бол зөвхөн арилжааны чиглэлээр авч байгаа зээл, зээлдэгч арилжааны банкууд хоёр эрсдлээ хоорондоо хуваагаад, хэйчээ хийнэ биз. Засгийн газрыг битгий татан оруулаач гэдэг саналыг би өчигдөр гаргаад бараагүй юм л даа. Тэгэхгүй бол төсөвт нөлөөлнө. Төсвийн асуудал хүндэрнэ.

**Ч.Хүрэлбаатар:** Энэ дээр Н.Золжаргал ерөнхийлөгч бас буруу тайлбар хэлж байна. Би бас төмөр замын ТУЗ-ынх нь гишүүн байсан. Төмөр замын тайлан баланс гарахаар, заримдаа яадаг вэ гэхээр, юаных нь ханш чангараад, сулрахаар заримдаа ашигтай гардаг, заримдаа алдагдалтай гардаг. Алдагдалтай хэсгийг нь авчихаад баахан юм яриад байвал утгагүй л байхгүй юу. Тийм учраас цаг хугацааны туршид үүнийг аваад үзэхэд, саяны тайлбар бол үндэслэлгүй тайлбар гэдгийг хэлмээр байна. Хамгийн гол нь юу вэ гэхээр, гадаад валютын ханш, манай бид нарын батлах гэж байгаа бодлогоор чөлөөтэй, уян хатан хэлбэлзэнэ гээд хэлчихлээ шүү дээ. Нэг дээшээ явахаар нь л эрсдэлийг нь засгийн газар, банк бид нар хувааж төлөөд байх юмуу? Валютын ханшийн өөрчлөлтийг иргэд, бид нар хүртэл биен дээрээ мэдрээд л явж байна шүү дээ. Цагаан будааны үнэ дээр, ургамлын тосныхоо үнэ дээр, элсэн чихрийнхээ үнэ дээр, бүгдэн дээр нь, биен дээрээ мэдрээд явж байна. Яг ингэж бичсэн агуулгаараа бол, уг нь С.Дэмбэрэл намайг “сайн унш” гээд байна лээ. Би танд уншаад өгчихье. “Эрсдлийг зээлдэгч, банк, Засгийн газрын хооронд харилцан хуваана” гэжээ. Н.Золжаргал ерөнхийлөгчийн хэлж байгаагаар нь бол зах зээлийнх арга хэрэгслүүдийг ашиглая гэж хэлж байх шиг байна. Тийм учраас З.Энхболд даргаа, үүнийг ингэж бичмээр байна. “Гадаад валютын ханшийн эрсдэлийг холбогдох санхүүгийн арга хэрэгслээр нь ашиглан бууруулах тогтолцоог бүрдүүлнэ” гэж оруулахгүй бол бид нар энэ дээр маш том бодлогын бөгөөд ёс зүйн алдаатай зүйл хийх гэж байна. С.Дэмбэрэл даргын хариуцсан байгууллага дотор иймэрхүү асуудал тавиад

байгаа хувийн хэвшлийнхэн байж магадгүй. Үүнийг нь бид шийдэж өгч болохгүй шүү дээ. Тийм учраас УИХ-ын гишүүд минь, нэн ялангуяа хувийн компани эзэмшиж байгаа гишүүд минь, энэ дээр санал өгч болохгүй шүү. Б.Бат-эрдэнэ аврага шиг картаа сугалаад, гараад яваад өгчих нь дээр шүү.

**З.Энхболд:** - Томьёололоо ажлын хэсэг ингээд өөрчилбөл яасан юм бэ? Зээлдэгч, банк харилцан хуваах гэсэн тэр үгнүүдээ авч хаяад, *“Гадаад валютын ханшийн эрсдлийг бууруулах тогтолцоог бүрдүцлнэ.”* гэвэл ямар вэ? Ийм хэйч хийх тогтолцоо үгүйлэгдээд байгаа нь үнэн. Засгийн газар ч бас маш их зээл авч байна. Үүний менежментүүдийг хийдэг, санхүүгийн үйлдлүүдийг нь Сангийн яам өдий хүртэл хийж ирсэн байхгүй юу. Одоо энд Монголбанкныг татан оруулж, өөр ямар хэрэгслүүдийг нэмж болж байна, арай боловсронгуй болгоод яв гэсэн үг л дээ. Гадаад валютын зээл авдаг хэмжээ чинь өөрөө 10-20 дахин өсчихөөд байна. Компаниуд ч авч байна, Засгийн газар ч авч байна. Би бол энэ өгүүлбэрээрээ *“миний авсан зээлийн ханшны эрсдэлийг нь дааж, хуваалц”* гээд л хүрээд ирнэ гэж бодогдоод байна.

**Н.Энхболд:** - Энэ ерөнхийдөө ойлголцчих шиг болоо гэж бодож байна. З.Энхболд даргаа, энэ саяын өөрийн чинь хамгийн сүүлд хэлсэн санааг тусгаад, ер нь ийм тогтолцоо байх ёстой гэдэг зарчмаараа санал хураалгаад, томьёолохыг нь эцсийн хэлэлцүүлэг дээрээ оруулж ир гээд явуулчихвал яасан юм бэ? Яг энүүгээр бол болохгүй. Ойлголцохгүй. Санааг нь ойлгож байна. Гэхдээ энэ томьёоллоор бол болохгүй.

**З.Энхболд:** - Энэ тогтолцоо нь байгаа юм. Манай хэмжээ бага байгаа учраас Сангийн яамны ажилладаг нөгөө хэрэгсэл нь маш бага байхгүй юу. Харин одоо Монголбанкныг татан оруулцуулж, илүү боловсронгуй болгох гэж байгаа юм. Ажлын хэсгийн саналыг нь өөрчлөөд л санал хураачихъя л даа, миний хэлснээр хураачихъя. *“Гадаад валютын ханшийн эрсдлийг бууруулах тогтолцоог бүрдүцлнэ.”* Агуулга нь зөв л дөө. Угаасаа манай улсад байнга хийгддэг юм. Бууруулах тогтолцоо бүрдүүлнэ гэдэг зарчмаар нь хураачихъя. Үүнээс өөрөөр, харилцан хуваах зээлдэгч, банк, Засгийн газар гэдэг үг орж болохгүй нь байна шүү. Банкны тухай хуулийн хөвдөг ханштай зарчмаа хадгална. Түүнээс хэн нэгний эрсдэлийг өөр нэг нь хүлээхгүй шүү дээ. За саналаа хураагаарай. Санал хураалт зассанаар уншиж байгаа шүү.

**Санал хураалтанд 62 гишүүн оролцож, 52 гишүүн зөвшөөрч, 83,9%-аар 7-р саналыг өөрчилсөн хэлбэрээр дэмжлээ.**

**З.Энхболд:** - Ажлын хэсгийн 8-р санал. Тогтоолын хавсралтанд заасан үндсэн чиглэлийн 2.1 дэх заалтыг дор дурьдсан байдлаар өөрчлөн найруулах:

*“2.1 Банкуудын төлбөрийн чадварыг хадгалж, системийн шинжтэй эрсдэлээс хамгаалах чадавхыг нэмэгдүцлнэ.”*

**Санал хураалтанд 62 гишүүн оролцож, 47 гишүүн зөвшөөрч, 75,8%-ийн саналаар 8 дахь санал дэмжигдэв.**

**З.Энхболд:** - Ажлын хэсгийн 9 дэх санал. Тогтоолын хавсралтан заасан үндсэн чиглэлийн 2.2 дахь заалтыг дор дурьдсан байдлаар өөрчлөн найруулах:

*“2.2 Олон улсад мөрддөг хяналт, шалгалтын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын цйл ажиллагаатай уялдуулан, эрсдлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтыг сайжруулна.”*

Хяналт шалгалт гэдэг үг 2 удаа орж байна. Найруулгын хувьд жаахан тийм л юм байна. Найруулгаа сайжуулах боломж байвал энийг дахиж нэг хараарай.

Санал хураалтанд 62 гишүүн оролцож, 51 гишүүн зөвшөөрч, 82,3%-ийн саналаар 9 дэх санал дэмжигдэв.

**3.Энхболд:** - Ажлын хэсгийн 10 дахь санал. Тогтоолын хавсралтанд заасан үндсэн чиглэлийн 2.3 дахь заалтыг дор дурьдсан байдлаар өөрчлөн найруулах:

*“2.3 Банкны эрсдэл, зээлийн хцү буурах нөхцөл бүрдүцлэх зорилгоор банкны зээлийн барьцаа хөрөнгийн болон зээл, хцүгийн зардлыг нэмэгдүцлж байгаа бусад хцүн зүйлийн нөлөөллийг бууруулах эрх зүйн орчныг шинэчилнэ.”*

Байнгын хороо дэмжсэн байна. Санал хураая.

Санал хураалтанд 62 гишүүн оролцож, 52 гишүүн зөвшөөрч, 83,9%-ийн саналаар 10-р санал дэмжигдлээ.

**3.Энхболд:** - Ажлын хэсгийн 11 дэх санал. Тогтоолын хавсралтанд заасан үндсэн чиглэлийн 3.3 дахь заалтыг дор дурьдсан байдлаар өөрчлөн найруулах:

*“3.3 Мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагаа, арга хэрэгслийн ил тод, нээлттэй байдлыг хангах, гаргасан шийдвэрийг олон нийт, бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй хүргэх замаар бодлогын үр нөлөөг сайжруулна.”*

Санал хураалтанд 62 гишүүн оролцож, 49 гишүүн зөвшөөрч, 79%-ийн саналаар 11 дэх санал дэмжигдэв.

**3.Энхболд:** - Ажлын хэсгийн 12 дахь санал буюу найруулгын санал байна. найруулгын 4 санал байна.

1. Тогтоолын төслийн 4 дэх заалтыг 3.6 дахь заалт болгон өөрчилж, *“Монгол улсын засгийн газар /Н.Алтанхуяг/, Монголбанк /Н.Золжаргал/, Санхцүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-д тус тус даалгасугай.”* гэснийг хасах.

2. Тогтоолын төслийн 5,6,7 дахь заалтыг 7,8,9 дэх заалт болгон дугаарлалтыг өөрчлөх

3. Тогтоолын төсөлд байгаа *сектор* гэдэг үгийг *салбар* болгон өөрчлөх

4. Тогтоолын 5 дахь заалтын *хяналт тавих* гэснийг *хяналт тавьж ажиллахыг* гэж өөрчлөх

Санал гаргасан ажлын хэсэг. Найруулгын саналаар санал хураая.

Санал хураалтанд 62 гишүүн оролцож, 53 зөвшөөрч, 85,5%-ийн саналаар зарчмын зөрүүтэй саналуудаар санал хурааж дууслаа.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлбэ.

## **Хариуцлагатай бичил уурхайг тогтвортой дэмжих**

*УИХ-ын чуулганы 2013 оны 11-р сарын 21-ны нэгдсэн хуралдаанаар “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн анхны хэлэлцүцлэг дээр УИХ-ын гишүцүн С.Дэмбэрэлийн хэлсэн үг:*

- Одоогийн байдлаар хувиараа ашигт малтмал олборлогч гээд нэг хэсэг иргэд, нөгөөх нь зохон байгуулалтанд ороод хоршоололын хэлбэрээр ашигт малтмал олборлож байгаа “бичил уул уурхай эрхлэгчид” гэсэн 2 субъект байна. Энэ 2 эрхзүйн ялгаатай өөр өөр субъект юм. Тийм учраас бичил уул уурхайг хөгжүүлэх чиглэлээр нь л заалт орж болохоос биш, байгаа бүх хэлбэрийг хэвээр нь оруулна гэвэл бас тохиромжгүй байж магадгүй. Бичил уул уурхай эрхлэгчид ч бас томуудтайгаа адилхан хариуцлагатай байх ёстой. Мөн тогтвортой ажиллах боломжоор ч хангагдсан байх ёстой. Тийм учраас *“тогтвортой ба хариуцлагатай бичил уурхайг дэмжих”* гэсэн заалт орох ёстой. Эдийн засгийн аливаа салбар, түүний дотор дэд салбаруудад “илүү хурдацтай” гэдэг үгийг түгээмэл хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл, энд байгаа “түлхүү хөгжүүлэх” гэхийн оронд “илүү хурдацтай хөгжүүлэх” гэдэг үг хэрэглэх нь илүү тохиромжтой. Тухайн салбарын өсөлтийнх нь хурдац дотор өөр нэг дэд салбар илүү хурдацтай хөгжиж байж, нийт салбарын хурдац сайжирна гэсэн утгаар найруулгын засвар оруулах хэрэгтэй.

### **Хариуцлагагүй компанийг хариуцлагатай ажиллана гэж итгэж гэрээ байгуулдаггүй**

*11 дүгээр сарын 19-нд “Газрын тосны тухай” хуулийн /шинэчилсэн найруулга/ төсөл болон холбогдох бусад хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлээс:*

С.Дэмбэрэл: - Асуух зүйл байна. “Эрдэс баялгын салбарт төрөөс баримтлах бодлого” дотор, төрөөс эрдэс баялгын салбарт, түүн дотроо газрын тосны салбарт оролцох оролцооны тухай тодорхой заалт орж байгаа. Өөр заалтууд ч нэмэгдэнэ. Төр бол зохицуулах үүргээ л голлон гүйцэтгэхээс биш, олборлох, боловсруулах үйл ажиллагаанд оролцохгүй гэсэн байдлаар тусгагдаж байгаа. Саяхан Ерөнхийлөгчийн маань хэлсэн тэр “ТОМ ТӨР”-өөс “УХААЛАГ ТӨР” рүү гэж хэлсэн тэр санааны дагуу бол төрийн байгууллагууд цаашид хуулийн ферм буюу ерөнхий гэрээлэгчийн үүрэг л гүйцэтгэдэг байхаар тусгагдаж байгаа. Би үүнийг их зөв гэж бодож байгаа. Өөрөөр хэлбэл төр байгаа баялагыг ухдаггүй, юм зөөж зөөвөрлөдөггүй, боловруулах гээд чаддаггүй, ажил нь явдаггүй. Харин үүнийг дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид, хувийн салбарынхан хийнэ. Төрийг төлөөлж байгаа төрийн өмчит газар юм уу, агентлаг нь “grantor or contractor” буюу “зөвшөөрөл олгогч, ерөнхий гэрээлэгч байх” гэсэн суурь ойлголт орж ирсэн. Харин энэ хуулинд энэ байдал яаж туссан бэ? Үүнийг хэрхэн тусгасанаас шалтгаалж, энэ төсөл чинь “урагшаа харсан хууль” уу, “арагшаа харсан хууль” уу гэдэг нь тодорно. Төрийн оролцоог бэхжүүлэх гэж болсон болоогүй юм хийдэг байж болохгүй.

“Эрдэс баялгын салбарт баримтлах бодлого”-ын 2 дахь зарчим бол мөн л газрын тосны салбарт шууд хамаатай. Энэ нь “ил тод, хариуцлагатай” газрын тосны бизнесийг хөгжүүлэх тухай зарчим юм. Энэ зарчим хаана, яаж, ямар үгээр, хэрхэн туссан бэ? Ил тод байдал нь яаж явагдахаар орсон бэ, хариуцлагатай уул уурхайн байдал нь хэрхэн хангагдах юм бэ? Энэ 2 суурь зарчмыг сайн, тодорхой тусгаж чадсан бол энэ бодлогод нийцсэн,



удаан ашиглахаар сайн хууль болно. Тэгж чадаагүй, зөвхөн аль нэг байгууллагын, тухайлбал газрын тосны асуудал эрхэлсэн газрын хууль эрх зүйн байдлыг л хуульчилж өгөөд, тэр нь нэг юм зохиож яриа, тэр нь нэг юм хийх гэж оролдоод, өөрсдөө бизнес явуулах гэж ноцолдоод эхэлвэл олигтой юм болохгүй. Хууль эрхзүйн орчныг нь сайтар бүрдүүлээд, түүн дээрээ бусдаар юм хийлгэх, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдаар юм хийлгэх асуудлыг л энэ сайтар тусгаж чадвал орчин үеийн хууль болно.

Газрын тосны салбарт бүтээгдхүүн хуваах гэрээнээс гадна өөр ямар ямар хэлбэрүүд орж байгаа вэ? Энэ зөвхөн бүтээгдхүүн хуваах асуудлыг зохицуулсан хууль юм уу, эсвэл газрын тосны салбарт яг адилхан эрдэс баялгын салбар гэсэн утгаар явна уу? Төр хувийн хэвшлийн түншлэлийг хэрхэн зохицуулсан юм бэ гэсэн ийм 3 асуултанд хариулна уу.

**Хариулт:** - Одоо байгаа газрын тосны салбарт хэрэгжиж байгаа хууль болон практик маань угаасаа хувийн хэвшилд тулгуурласан хэлбэртэй байгаа. Үүнийг хэвээр нь хадгалсан төсөл. Учир нь ихэнх талбайд бүтээгдхүүн хуваах гэрээ байгуулагдчихсан байгаа тул одоогийн жишиг цаашид ч явагдана. Төрийн оролцоог бид хүнд сурталгүй болгоё гэсэн чиглэлийг нэлээн баримталж, оруулсан. Одоо бол “Бүтээгдхүүн хуваах гэрээ” байгуулах гэж засгийн газраар 4-5 удаа дамждаг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр ордог. Үүнийг нэлээд багасгаж төслийг боловсруулсан. Газрын тосны газар маань өөрөө хяналтаа давхар хийдэг. Энэ хуулиар хяналтыг нь салгаад, илүү мэргэжлийн, хөндлөнгийн хүмүүсээр хийлгэдэг болгохоор заасан. Газрын тосны газрын чиг үүргийг багасгасан. Ерөнхийдөө бүртгэдэг, үйл ажиллагааны төлөвлөгөөг нь хүлээж авдаг байдалтай болж байгаа. Ил тод, хариуцлагатай байдал бол угаасаа энэ дээр тодорхой заагдсан. “Захиалга хүлээж авах болон гэрээ нь нээлттэй, ил тод байна” гэж заачихсан байгаа. дээр нь бодлого гарсаны дараа бид, “Олборлох салбарын ил тод байдлын тухай хууль” гээд бие даасан хууль өргөн барихаар бэлдэж байна. Тэр хууль дээр ямар ямар асуудлыг байгууллагын нууц гэж үзэх юм бэ, ямар нь ил байх ёстой вэ гэдгийг зааж өгөх болно. Гэрээний хувьд, одоогийн бүтээгдхүүн хуваах гэрээгээрээ явна. Газрын тосны хуулийг батлуулж байгаагийн нэг онцлог нь занар, битани зэрэг урьд нь аль хуулиар явагдах нь тодорхой бус байсан шинэ төрлийн эрдэс баялгуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулах цоо шинэ эрх зүйн орчныг бий болгож байгаа явдал юм. Эд нар нь нэлээд эрсдэлтэй байдаг учраас заавал бүтээгдхүүн хуваах гэрээ байгуул гэж шахахгүй. Концессийн гэрээ, эрсдэл хуваах гэрээ, үйлчилгээний гэрээний аль нэгийг хийж болно.

**С.Дэмбэрэл:** - Тийм гэрээнүүдийг чинь л би тодруулж асуугаад байна л даа. Өөрөөр хэлбэл концессийн гэрээ болон бусад гэрээ чинь төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрүүд шүү дээ. Хувийн хэвшлийнхэний дангаараа болон холимог хэлбэрээр ажиллах маш олон янзын гэрээний хэлбэрүүд бий шүү. Орчин үеийн газрын тосны хуулиудад энэ чиглэлийн хэлбэрүүд хэрэгжих боломжийг хэр заасан байна вэ? Үүнийгээ хэр тодорхой оруулсан юм бэ?

Дараагийн нэг асуулт бол, нэг хөрөнгө оруулагч компани, жишээлбэл, Вержиния аралд бүртгэлтэй компаниудыг дэлхий даяараа шахаж байна. Ил тод биш, маргааш нь алга болчихдог компаниудыг хуулинд яаж зааж оруулж байна вэ? Офшор бүсэд бүртгэгдсэн компаниуд яах вэ? Хариуцлагыг нь яах вэ? Орчин үеийн гэрээний хариуцлагад ийм компаниуд ордоггүй. Хэзээ ч алга болчихдог ийм кампаниудтай гэрээ байгуулдаггүй байх ёстой. Тийм биз? Тэгэхээр энэ утгаараа хариуцлагатай уул уурхай гэдэг утгаар нь асуудлыг яаж тусгаж өгсөн бэ гэдгийг би лавлаад байна.

Мөн үүнээс гадна “тогтвортой уул уурхай” /Sustainable/ гэж ярьж байгаа. Тогтвортой газрын тосны олборлолт, ашиглалтын тухай, ялангуяа байгаль орчны үнэлгээ дүгнэлт хийх тухай эрдэс баялагын салбарт баримтлах бодлого дотор орж байгаа тэр бүх үзэл баримтлал, ерөнхий зарчмуудыг энэ хуулиндаа тусгаж, оруулахгүй бол бид тийм бодлогын баримт бичиг, үзэл баримтлал гаргах хэрэггүй болно. Тийм биз? Тэгэхээр тэр бүхнийг оруулж байгаа юу гэдгийг л би маш тодорхой мэдэх гэж асуугаад байгаа юм. Яг сайн оруулж чадаж байгаа юу? Гэрээний тэр олон янзын хэлбэрүүдийн яг аль аль нь газрын тосны салбарт хийгдэх юм бэ? Алийг нь хийхгүй юм бэ? Тэгээд хариуцлагатай, тогтвортой, ил тод газрын тосны бизнес эрхэлнэ гэдгийг нэг бүрчлэн заасан тэр заалтууд байна уу? Тийм юм байх уу? Үүнийг тусгай хуулиар зохицуулна гэж бодож байгаа бол худлаа. Жишээлбэл, Хууль зүйн байнгын хороон дээр “Мөрдөх албаны тухай” хуулийг хэлэлцэж байх үед зарим зүйлийг тусад нь хууль боловсруулж, зохицуулна гэж ярьж байгаад, дөнгөж өчигдрийн хурлаар “Давтагдаж болно. Үзэл санаа нь энд заавал суусан байх ёстой” гэдэг дүгнэлтэнд хүрлээ шүү дээ. Тэгж салбар хууль бүхэн дээр үзэл санаа, зарчим бүхнээ суулгаж байж гадаад дотоодын хөрөнгө оруулагч нар чинь үүнийг уншаад, “энэ хуулиар Монгол улс ийм бодлого баримталж байгаа юм байна. Бид хариуцлагатай байх ёстой юм байна. Ил тод үйл ажиллагаа явуулж, нээлттэй мэдээлэх ёстой юм байна. Нийгмийн хариуцлага хүлээх юм байна. Сайн засаглалтай болох гэж байгаа юм байна. Хөрөнгө оруулалтын ийм ийм хэлбэрүүдийг хүлээж авах юм байна. Тэгж байж тогтвортой ажиллах боломжоор хангагдах юм байна...” гэхчилэн ойлголт аваад “миний компани Вержиния арал дээр бүртгэлтэй учраас энд ажиллаж болохгүй юм байна. Дурын компанид зөвшөөрөл олгохгүй юм байна” гэдгийг мэдэж авч байх ёстой. Тэр Вержиния арал дээр бүртгэлтэй компаниуд чинь татвараас зайлсхийдэг, зугтдаг компаниуд гэсэн үг. Тэр бол татвараас зугтаах хэлбэр юм шүү дээ. Энэ чинь хариуцлагагүй гэсэн үг. Хариуцлагагүй компанийг хариуцлагатай ажиллана гэж итгэж гэрээ байгуулдаггүй. Ийм асуудлуудыг бүгдийг нь оруулж тусгасан уу? **Өнгөрсөн жилүүдэд цйл ажиллагаа явуулсан газрын тосны компаниуд ил тод байж чадаагүй шүү дээ. Хариуцлагатай байж чадаагүй. Тийм байхад хуучнаа цргэлжлүүлнэ гэж байж болох уу? Одоо реформ хийх шаардлагатай.** Тийм реформыг энэ хуулиар хийх нөхцөлийг хангасан уу гэдгийг би асууж байна. Ийм юмнууд орсон бол энэ сайн хууль. Үгүй бол зүгээр нэг байгууллагын хуульчилсан журам болно.

**Хариулт:** - Обшор бүсэд бүртгэлтэй байгаа компаниудын тухай заалт орсон байгаа. “Оюу толгой” зэргийг харж байхад манайх энэ уул уурхайн компаниудаас татвар авчихаад, ноогдол ашгаас нь давхар татвар авдаг юм байна. Офшор руу зугтаж байгаа компаниудын ихэнх нь ноогдол ашгийн татвараас зугтдаг юм байна.

## Шинэ, сайн, сайхан туршлагыг тусгах хэрэгтэй

*“Газрын тосны тухай” хуулийн /шинэчилсэн найруулга/ төсөл болон холбогдох бусад хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсгийн 2013 оны 11 дүгээр сарын 19-ны хуралдааны тэмдэглэлээс:*

**С.Дэмбэрэл:** - Та нар газрын тосны тухай хуулиа боловсруулахдаа 20 орчим улс орны сайн туршлагыг судалсан юм байна. Тэгээд тэр судалгааныхаа үр дүнд аль улсын, ямар ямар сайн туршлагуудыг та на энэ хуулийнхаа хаана хаана, яаж оруулсан юм бэ? Үүнийгээ бүр тодорхой хэлээд өг.

**Хариулт:** - Жишээлбэл, Вьетнам улсад үйл ажиллагаа явуулдаг 30 орчим компаний 20 гаруй нь бүтээгдхүүн хуваах гэрээгээр ажилладаг юм байна. Бүтээгдхүүн хуваах гэрээний үндсэн зарчим нь олон улсад тодорхой болчихсон, хуваалт, өртөг нөхөлт, олборлолтын урамшуулал, сургалтын урамшуулал зэрэг зүйлс байдаг юм байна. Бүтээгдхүүн хуваах гэрээ хийхдээ юу юун дээр анхаарах тухай бид хуулиндаа заачихсан...

**С.Дэмбэрэл:** - Бүтээгдхүүн хуваах гэрээ чинь хамгийн эртний, хөгширсөн, хуучин хувилбар шүү дээ. тэрнийг бараг заагаад байх ч шаардлага байдаггүй. Би та нараас шинэ, авчихмаар, энэ улс оронд ашигтай тийм туршлага олов уу гэж асуугаад байна шүү дээ. Бүтээгдхүүн хуваах гэрээ бол угаасаа цаг хугацааны үйл явцад арай жаахан сайжруулаад, Засгийн газрууд, хөрөнгө оруулагчтай гэрээ хийхдээ засварлаад яваад байдаг л хувилбар шүү дээ. Өөр ямар сайхан туршлага байгааг л асуугаад байна.. Жишээлбэл байгаль орчинд ээлтэй, тогтвортой бизнес хөгжлийн чиглэлээр олон улсад хэрэгжүүлэхээр баримталж байгаа зүйлийг эндээ хэрхэн оруулсан юм бэ гэдгээ л хэл. Энэ хууль бол тусгай хууль биш. Нэг их ид шидтэй, маш онцгой, гоё өнгөтэй бүтээгдхүүн хийх гээд байгаад зориулсан хууль ч биш. Энэ бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгаа “газрын тос” гэдэг нэртэй нэг эрдэс баялгыг олборлож ашиглах, үүнтэй холбоотой харилцааг зохицуулж байгаа л хууль шүү дээ. Тийм учраас би дахин давтан хэлье. Одоо УИХ дээр яригдаж байгаа “Эрдэс баялгын салбарт төрөөс баримтлах бодлого, үзэл баримтлал”-д энэ хууль чинь нийцэхгүй бол юуны өмнө хууль буруу хууль болно. Хоёрдугаарт, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль журмууд дотор, жишээлбэл, түрүүлж ирсэнд нь түрүүлж үйлчил гэсэн зарчим үйлчилж байгаа юу, үгүй юу, цаашид тэгж үйлчлэх юм уу, үгүй юу, эсвэл тусгай зөвшөөрөл олгох гэж баахан ажил болгодог явдлаа яах юм бэ гэдгээ бодох ёстой. Түрүүн хэлсэн шиг “хүнд суртлыг багасгах” гэж хэлээд хүнд суртал багасдаггүй учраас механизмыг нь зааж өгсөн хэсгийг л хайгаад байна. Миний асууж байгаа асуултууд бол ерөнхий зүйл биш шүү, маш тодорхой тусгаж өгөх зүйл шүү. Ийм зүйлүүдийг хийхгүйгээр цаашаа явбал их хэцүү шүү. Одоо ингээд зүйл заалт бүрээр нь багтаад явах байх. Гэхдээ энэ хууль маань өөрөө харагдахдаа, хэрэгжихдээ үзэл санаа нь ийм байх ёстой шүү гэдгийг анхааруулж байна... Саяхан батлагдсан Монгол Улсын “Хөрөнгө оруулалтын тухай” хууль дээр хөрөнгө оруулалтын тогтвортой орчныг бий болгоно гэсэн байгаа. Тогтвортой орчин гэдэг маань өмнө байгуулагдсан гэрээний тодорхой заалтуудыг хөндөхгүй гэсэн утгатай юм. Хуулийнхаа үзэл санаанаас тусгай гэдэг үгийг авах нь зөв. Тусгай хууль гаргах гээд байх хэрэггүй шүү дээ.

## **Байнгын хороо бол хамгийн хүчтэй институци байх ёстой**

*2013 оны 12 дугаар сарын 10-нд Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан болж, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ Ажлын хэсэг байгуулах тухай асуудлыг хэлэлцэв.*

С.Дэмбэрэл: - Энэ хуулийн төслийг оруулж ирсэн Д.Ганбат гишүүнийг дэмжих сонирхол, субъектив талаасаа их байгаа боловч, объектив талаасаа өөрчлөлтийн утга учир нь надад сайн харагдахгүй байна. Үндэслэл нь жаахан дутмаг гарсан юм шиг санагдаад байна. Харин нэг зүйл маш сайн ойлгогдож байна. Байнгын хороо бол хамгийн хүчтэй институци байх ёстой. Тиймээс энэ талаасаа бодож, цаад аргуудыг нь харах гэхээр энэ байнгын хороог хүчтэй байлгах иж бүрэн арга хэмжээ буюу нэлээд томоохон өөрчлөлтийг УИХ-ын дэгд оруулмаар санагдаад байна. Энэ төслийн дагуу Байнгын хороог 2 жил болгосноор хүчтэй болж чадахгүй шүү дээ. Энэ хуулиар байнгын хороог хүчтэй болгож, удирддаг хүнийг нь тогтвортой ажиллуулдаг болгох цаад санаатай юм бол өөр олон асуудлуудыг нэмж тусгах зайлшгүй шаардлагатай. Дэгээ сайтар янзлах хэрэгтэй. Миний бодлоор, төрийн байгуулалтын байнгын хороо маань төрийн институциудын асуудлыг хариуцдаг хорооныхоо хувьд дэгийн тухай хуулинд өөрчлөлт оруулах, мөн үүнтэй холбоотой асуудлуудад цогц өөрчлөлт, шинэчлэл хийх ажлын хэсэг байгуулаад, иж бүрэн санад дүгнэлт оруулж ирэх хэрэгтэй. Нэгдүгээрт энэ. *Хоёрдугаарт*, байнгын хороодын бүрэлдхүүнд орж, оролцож явахдаа ажиглахад, нэг хэсэг нь маш их идэвх санаачлагатай оролцож, мундаг ажиллаж байна. Гэтэл нөгөө нэг хэсэг нь юм хийж байгаа шинж ажиглагдахгүй байна. Би гэхдээ тэр, тэр ажил хийхгүй байна гэж нэр зааж хэлэхгүй. УИХ-ын ажлыг хамгийн гол нугалдаг институци бол байнгын хороо. Тиймээс энэ байнгын хороодыг хүчтэй, идэвхтэй, үр дүнтэй ажиллаж, төр засгийн ажлыг авч явдаг, бусдад хөтлөгддөггүй институци болгох, тийм байлгах зайлшгүй шаардлага байгаа. Үүнийг бүгд мэдэж байгаа. байнгын хороодын дарга нар бүгд үүнийг хүлээн зөвшөөрдөг, ярьдаг. Тэр байтугай УИХ-ын даргад ч санал, хүсэлтэй тавьсан хүмүүс ч бий. Бид үүнийг л ярьж байна. Тийм учраас Д.Ганбат гишүүний оруулж ирсэн зүйлээс, цаана нь байгаа тэр өөрчлөлтийн зарчмыг нь, үзэл санааг нь илүү дэмжиж байна. Сая гишүүдээс ч бас олон санаанууд гарч байна. Тиймээс энд гарч байгаа олон санаануудыг оруулж нэгтгээд бүтээгдхүүн гаргах ажлын хэсэг байгуулъя. Даргыг нь 2 жил байлгах уу, ер нь юуу юу өөрчилж, нэмж, хасч, явал энэ байнгын хороодыг хүчтэй байлгах вэ, институци хоорондын үйл ажиллагааг хэрхэн уялдуулах вэ гэдгийг л ярилцъя. Заримдаа эдийн засгийн байнгын хороон дээрээс засгийн газрын оруулж ирсэн тулгамдсан хэд хэдэн асуудлыг ч хэлэлцэж чадахгүй хойшлуулж, дарга нь ч бухимдаж, уурлаж явна шүү дээ. Ажил хэрэг ингэж явагдах ёстой юм уу? Яг хуулиндаа ингэж, тэгж оруулснаар байнгын хороо хүчтэй ажиллах механизмыг бүрдүүлнэ гэж ярилцах ёстой.

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн гэхэд л яадаг билээ? Төсвийн байнгын хороог хүчтэй байлгахын тулд ийм юм баталж өгөөч гээд л гүйж яваа шүү дээ. Тэгэхээр нь бид, Эдийн засгийн байнгын хороотой хамтарч хийе гэж ярьж байгаа. Энэ бүхний цаана байнгын хороодыг л институцийн хувьд хүчтэй болгох, бэхжүүлэх гол зорилго л агуулагдаж байна. Тийм учраас би энэ төслийг биш, үүний цаана байгаа гол санаа, зорилгын дагуу л юм хийе гэж уриалж байна.

## Хурдан сайн ажиллая

*“Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг судлах” цүрэг бүхий Улсын Их Хурлын даргын захирамжаар /2013 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 27 дугаар/ байгуулагдсан ажлын хэсгийн 12 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс:*

С.Дэмбэрэл: - За, Үндсэн хуулийг бараг л бүтнээр нь уншиж үзээгүй хүн ярих гэж байна. Унших нь уншсан боловч, бүтэн уншиж мэдсэн гэж хэлж чадахгүй л дээ. Энд “эцсийн тайлангийн бүтэц” гээд нэг аятайхан зүйл байх юм. Би сая лавлаад асуусан чинь хийгдэж байгаа зүйл юм байна. Тус тусдаа хийгээд, базаж нийлүүлэх ажил нь дутуу, ийм бүтээгдхүүн гарч байгаа юм байна. А.Бакей бас сая англи хэл дээрх нэг бүтээл бас сонирхуулж байна. Ингээд 2 ч бүтээл гарчээ. Энэ ажлын хэсэг маань Үндсэн хуульд өөрчлөлт оруулах, эсэх болон тийм шаардлага байгаа эсэхийг тодруулах ёстой. Одоо хамгийн эхнийхээ асуултанд хариулах ёстой. **Шаардлагатай юм уу, үгүй юу?** Сая ерөнхийлөгч энэ ажлын хэсгийг байгуулагдах гэж бүтэн жил болж байгааг зарласан. **Бүтэн жил!** Их удаж байна гэдгийг анхааруулж байгаа хэрэг. Би үүнтэй санал нэг байна. Түргэтгэх хэрэгтэй. Бидэнд бэлэн бүтээгдхүүнүүд байна. Миний сайн таньдаг, чадвартай хуульчид энд сууж байна. Энэ хүмүүсээс юм гарна гэдэгт эргэлзэх юм алга. Гэхдээ УИХ-ын гишүүдийн дунд өөр өөр бодол бас байна. Жишээлбэл, С.Баярцогт гишүүн “*Өмнө нь оруулсан 11 өөрчлөлтийн 7-д нь би хүргэхгүй шүү, маш зөв өөрчлөлтүүд болсон*” гэж өнөө өглөө мэдэгдэж байна билээ. Тэгэхээр энэ мэтчилэн зарим зөрүүтэй, өөр саналууд ч бий, бас гарч ирнэ. Бид наад зах нь 2 хувилбар бэлтгэх ёстой. 3-4 гээд хэдэн ч хувилбар гарч мэднэ. Энд байгаа бүтээгдхүүнүүдээс харахад урьдчилсан байдлаар зарим зүйл заалт дээр хувилбарууд гарчихсан байна. “Өөрчлөлтийн хувилбарууд” гэж байгааг би зөв ойлгож байна уу? Энэ чинь өөрөө өөрчлөлт хийх шаардлагыг харуулж байгаа юм. Тэгэхээр үүнийгээ хурдавчилъя. Үүнийг нэгтгэх ажлаа түргэтгээд, тэгээд тэр нэгдсэн хувилбар дээрээ ярилцъя. Бидний шийдвэр гаргах зүйл маань л энэ шүү дээ. Шаардлагатай эсэх нь судалгааны түвшинд тодорхой болчихсон байна. Бид үүн дээр юу нэмэх юм бэ? Бараг л нэмж чадахгүй болов уу гэж санагдаж байна. Судлаачдын гаргаж ирсэн энэ бүх нарийвчилсан судалгаа шинжилгээн дээр санаандгүйгээр “өөрчлөлтийн хувилбарууд” гэж бичдэггүй. Тэгэхээр хувилбарууд бэлэн байна. Одоо тэднийгээ нэгтгэж зангидаад оруулаад ир. Тэрэн дээр нь ажлын хэсэг нухацтай ажиллая. Тэгэхдээ оруулж болох хязгаарлалтууд байгаа шүү гэдгийг манай ерөнхийлөгч дахин дахин сануулж байсныг ч бас мартаж болохгүй. Юу юун дээр өөрчлөлт оруулах нь ч бас чиглэл өгөгдчихсөн



байгаа. Тийм биз? Хязгаарлалт нь байна. Бүх боломж байна. Одоо ганцхан боловсруулсан бичиг баримт нь л хэрэгтэй. Түүнийгээ боловсруулж, ярилцаад, иж бүрэн зүйл өргөн барьцгаая... Туршлагатай гишүүд, олон зүйл ярьж байна. Тэгэхээр шийдвэр гаргах үүрэгтэй хүнийхээ хувьд “аль болох хурдан гар дээр маань тэр хувилбаруудаа тавиад өгөөч” л гэж гуйж байгаа юм. Ганц уншихад хүртэл засчихмаар зүйл харагдаж л байдаг. Жишээлбэл, одоо хүртэл маргалддаг тэр 5, 6-р зүйлүүд байна. “Ард түмний мэдэлд байна” гэсэн нь яг юу гэж байгаа юм бэ? Яаж мэдэлд нь байлгах юм бэ? Хууль зүйн сайд нь хүртэл хариулж чаддаггүй асуулт шүү дээ. Надад салаа утгагүй, ойлгомжтой нэг л хариулт хэрэгтэй байна. “Ард түмний мэдэлд байна” гэдгийг бид яаж батлах юм бэ? Энэ чинь одоо маргааны сэдэв болоод байна шүү дээ. “Үгүй ээ. Ард түмний мэдэлд юу ч алга” гэж ярьдаг хэсэг ч бас байна. Ийм зүйлсийг л тодруулмаар байна... Би одоо яах вэ гэдэг талаар л яримаар байна. Сонсоод байх нээ, надад тэр судалгаа нь хэрэггүй юм байна. Тэгэхээр надад гар дээр минь тавих зүйл хэрэггүй болчихлоо. Хэлэлцэх явцын дунд нэг нэгээрээ гараад ирэх юм байна гэж ойлгогдлоо. Одоо тэгвэл надад Үндсэн хууль дээр оруулж болох өөрчлөлтийн заалт нэг бүр л хэрэгтэй болж байна. Тэгэхээр, тэ заалт нэг бүр дээр нь л яриад л явъя. Д.Дэмбэрэл гуай ажлын хэсэг байгуулаад, 3 жил ажилласан гэж хэлж байна. Хийсэн бүтээгдхүүн нь байж байна. Д.Лүндээжанцан гишүүн ч бас маш тодорхой зүйлүүдийг ярьж байна шүү дээ. Хуулиар хориглогдсон хөндөж болохгүй зүйлийг нь үлдээгээд л, засч болох зүйлсээ жагсааж байгаад л ажиллая. Тэрийгээ л гаргаад ир. Тэгээд заалт болгоноор нь л ярья. “Үүнийг хөндөж болох уу? Болно. Тэгвэл өөрчлөх үү? Өөрчилье, эсвэл үгүй” гээд л шууд хийгээд явъя. Хажууд энэ судлаачид маань сууж байг. Тэгээд хажуунаас зөвлөгөө, сануулгаа өгөөд хамт яваг. Бид тэр бүх судалгааг унших албагүй юм байна. Гэхдээ та бүхний саналыг асууж, мэдээлэл авна. Судлаачид, эрдэмтэдийнхээ санаа дүгнэлтийг ч сонсоно. Гадаадынханы юмыг ч сонсох ньзөв. Би өдөр бүр гадаадын хүмүүстэй уулзаж, ярилцаж, юм сонсож, мэдээлэл авдаг. Яагаад гэвэл, тэдэнд энэ ардчилсан нийгмийн талаар манайд байгаа мэдлэг, мэдээлэлээс хамаагүй илүү мэдлэг, мэдээлэл, 200 жилийн туршлага, үзсэн, сонссон зүйл байдаг. Манайх 20 жилийн л туршлагатай. Хуулинд хүртэл “УИХ хууль боловсруулахдаа Олон улсын туршлага ашиглана” гээд заачихсан байгаа шүү дээ. Энэ ардчилал энэ тэр гэдэг чинь нарийндаа гадны л юм шүү дээ. Тэгэхээр асуух л хэрэгтэй. Гэхдээ мэдээж, бид өөрсдийнхөө хөрсөнд тохирсон бүтээгдхүүн гаргах ёстойгоо бас мартаж болохгүй. Энэ хуулийг хийсэн хүмүүс чинь нөр их хөдөлмөрөөр, хөрсөндөө тохирсон бүтээгдхүүн гаргасан гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Гэхдээ түүнээс хойш он жилүүд өнгөрөөд, зарим зүйл нэлээд өөрчлөгдсөн байна. Энэ өөрчлөлтөнд тохируулах шаардлага ч бас байгааг мэдэж байгаа хүмүүс нь ч бас бэлэн байна. Гурван жил судлаад, цээжээрээ мэддэг болчихсон хүмүүс сууж байна шүү дээ. Тэгэхээр одоо ингээд ажлаа хийе. Хүлээх хэрэг юу байна. Болно гэсэн зүйлүүдээ гаргаж ирээд л шууд ярилцъя. Ажлын хэсгийн гишүүдэд ийм л зүйл хэлэх байна. “Ийм ийм зүйл дээр та юу бодож байна” гээд л бариад ир. Тэгвэл би “би ингэж өөрчилье боддог юм” гэж энэ хуульч, судлаачиддаа хэлээд, асууж, мэдээлэл аваад, саналаа хэлье л дээ. Хоорондоо хамтраад л ажлаа хийе. Тэгж байж л ажлынхаа ард гарна. Тэгэхгүй бол хэдэн сар хүлээж нэг судалгаа гаргуулаад, тэрийгээ гадаад хэл рүү орчуулж, санал аваад, дахиж боловсруулж, нэг бүтээл гаргаад тараахад хүн бүр унших ч юм уу бүү мэд. Тийм учраас үүнийгээ процесс болгож, менежмент хийж, хурдан сайн явуулмаар байна.

## 2030 он хүртэлх Монгол улсын тогтвортой хөгжлийн бодлого

*“Хөгжлийн бодлого төлөвлөлтийг боловсронгуй болгох тухай”  
Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг  
хэлэлцсэн 2014 оны 01 сарын 10-ны УИХ-ын Чуулганы нэгдсэн  
хуралдааны тэмдэглэлээс:*

С.Дэмбэрэл: - Бид нэг юм хийх болохоороо Засгийн газарт үүрэг өгдөг. Засгийн газар нь сайн, муу нэг зүйл хийгээд ирдэг. Тэрийг нь бид засна. Эцэст нь бас нэг хэрэгждэггүй хөтөлбөрүүд гараад ирдэг. Урт хугацааны хөтөлбөр гэхээрээ хэдэн жилээр байх юм бэ? Лав, 2050 он биш. 2030 он гэвэл энэ хамгийн их төсөөлж болох хугацаа. УИХ-ын даргын захирамжаар, бүх улс төрийн намуудын төлөөлөл орсон, мэргэжлийн түвшинд, Монгол улсыг хэрхэн хөгжүүлэх талаар бичиг баримт боловсруулахын тулд, бид юуны өмнө өнөөдрийн дэлхий нийтийн чиг хандлага болоод байгаа ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-ийн тухай ярих хэрэгтэй болно. 1992 онд анх энэ тухай яриа гараад, дараа нь сейфэнд ороод мартагдчихсан. “Үндэсний хөгжлийн цогц бодлого нь болохоор хэт тунхаглалын шинж чанартай, хэмжиж болдоггүй, тодорхой бус, бүтцийн хувьд хэт ерөнхий зүйл болсон. Энэ бүх талаас нь харж байгаад, “2030 он хүртэлх Монгол улсын тогтвортой хөгжлийн бодлого” гэсэн баримт бичиг байвал оновчтой юм болов уу гэсэн бодол байна. Тогтвортой хөгжлийн Эдийн засаг, Нийгэм, Байгаль орчин гэсэн 3 үндсэн тулгуур бий. Тэр нь аяндаа хөгжлийн бодлогын маань бүтэц болчихно. Энэ баримт бичгийн олон үр хөврөлүүдийг энд тэндхийн байнгын хороон дээр нэг нэгээр нь яриад, батлаад л байна. “Ногоон хөгжлийн үзэл баримтлал” батлагдах гэж байна. Эдийн засгийн хөгжлийн яамнаас “Хөгжлийн төлөвлөлт” гээд л ороод ирнэ. НХХАХЯ-аас “Хүний хөгжил” гэсэн бас нэг бичиг ороод ирчихсэн л байна. Бичиг баримтууд бол үнэндээ хангалттай байна. Тиймээс энэ бүхнийг нэгтгээд, Засгийн газраас хамаардаггүй, цаг алдаж хүлээдэггүй, Улс төрийн намууд, УИХ-ын гишүүдийнхээ мэдлэг, чадвар, арга туршлагыг аваад, мэргэжлийн туслалцаа үзүүлэх баг, эрдэмтэн судлаачдыг оролцуулан ажиллаж, бусдын бичсэн зүйл дээр засч суух биш, өөрсдөө голлож суугаад бүтээх хэрэгтэй. Олон хуудастай нуршуу зүйл биш, хэмжиж болохуйц, үйл ажиллагааны удирдамж байж чадахуйц, уян хатан хэрэгжих бүтээл боловсруулан гаргах хэрэгтэй. Энэ ажилд би хувьдаа цаашид бусад нөхдүүдтэйгээ, тухайлбал Ардчилсан Нам, Ардын нам, “Шударга ёс” эвслийнхэний аль алиных нь оюун ухаан, мэдлэг чадварын хандив, туслалцааг авч, хамтран ажиллахад бэлэн байна. Цомхон, бодит, хэмжиж болохуйц, хэт нарийвчлан зааварчлаагүй, 2030 он хүртэлх хөгжлийн төсөөлөлийг бий болгосон зүйлийг томъёолон бичихэд боломжтой гэж бодож байна. Жишээлбэл, энэ уул уурхайн асуудал байна. Зарим нь Монгол улс Чили шиг байх ёстой л гэнэ. Зарим нь Кувейт шиг болно ч гэж ярьж байх шиг. Энэ бүхний үндсийг өнөөдөр тавиад, орчихоод л явж байна. Эрдэс баялгын салбарт баримтлах бодлогод хүртэл концепцийн шинж чанартай зүйл орчихсон л байгаа. Энэ бүхнийгээ л нэгтгэж боловсруулсан нэг зүйл хиймээр байна.

## **Эрх нь байгаа мөртлөө, үүрэг нь байдаггүй доголон хуультай нийслэлд, гамшгийн нөхцөлд бид амьдарч байна**

*УИХ-ын Чуулганы 2014 оны 01-р сарын 09-ний өдрийн Нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс: Хотыг дахин хөгжүүлэх тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх цээр*

С.Дэмбэрэл: Миний хувьд 100% эсэргүүцэж, үг хэлмээр байна. Эсэргүүцэх хэд хэдэн шалтгаан байна.

Энэ хуультай хамт “Нийслэлийн эрх зүйн байдлын тухай” хуулинд нэмэлт өөрчлөлт орж ирэх ёстой байсан. Яагаад гэвэл өнөөдрийн байдлаар, үндсэн хуульд заагдсан “Монгол улсын иргэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй” гэсэн заалт Улаанбаатар хотод хангагдахгүй байна. Улаанбаатар хот агаарын бохирдлоороо гамшгийн хэмжээнд очсон, онцгой нөхцөлд байгаа. Өрөөр хэлбэл бид одоо гамшгийн нөхцөлд амьдарч байна. Гэтэл Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг үзэхээр Улаанбаатар хотод амьдардаг иргэдийн өмнө хүлээх хотын удирдлагын үүрэг гэж байдаггүй. Бүрэн эрх нь байгаа мөртлөө үүрэг нь байдаггүй, ийм доголлон хуультай байна. Энэ гажигуудтай, доголлон хуулиа сайжруул. Малгай хуулиа сайжруулсаны дараа дагалдах хууль буюу дахин хөгжүүлэх тухай хуулийг маш өөр утгаар оруулж ирэх ёстой байсан. Гэтэл оруулж ирж байгаа байгууллага, оруулж ирж байгаа ажлын хэсгийн бүэлдхүүнийг хаахад барилга барьдаг хүмүүс байна. Барилга, зам, газрын талаас нь бодсон юм байж. Гэхдээ хүний талаас нь бодоогүй байна. Хэдийгээр тайлбарт нь Үндсэн хуулийн заалтаас дурдаж байгаа ч энэ хуулийн гол агуулга нь “дахин хөгжүүлэх” гэдэг үгийг механикаар хуулж тавих биш, энэ хуулийн гол үзэл санаа нь Монгол улсын нийслэл Улаанбаатар хотыг тогтвортой хөгжлийн замд эргэлт буцалтгүй оруулах талаар хууль байх учиртай юм. Бусад улс орнуудын жишиг болон орчин үеийн хотуудын хөгжлийн чиг хандлагууд, Дэлхийн банкнаас явуулж байгаа хотын хөгжлийн талаархи бодлогын бүх баримт бичгүүдийг харахад тогтвортой хөгжсөн хотын тухай л ярьж байна. Гэтэл тогтвортой хөгжлийн 3 хууль байдаг.

1. Эдийн засгийн хууль
2. Нийгмийн хууль
3. Байгаль очны хууль

Энэ бүх зүйлүүд, орчин үеийн хот төлөвлөлт, хотыг дахин хөгжүүлэх ойлголтууд нь саяхан, манай хотын практикт нэвтэрсэн мөртлөө хотын эрх зүйн байдлын тухай хуулинд огт тусгагдаагүй байна. Энэ талаасаа бодож хуулиа татаж аваад, хотын эрх зүйн байдлын тухай хуулинд Улаанбаатар хотын иргэдийнхээ өмнө хүлээх үүргийг, мөн онцгой нөхцөлд байсан байдлыг нь харгалзаж үзэж байж, энэ бүх асуудлаа оруулж ирэхгүй бол болохгүй байна. Өчигдөрийн телевизын нэвтрүүлгээр гнарсан ярилцлагыг харж байхад, Улаанбаатар хот агаарын бохирдлын эсрэг яг ямар үүрэг хүлээдэг вэ гэсэн асуултанд хариулт байхгүй сууж байна. Бүрэн эрхтэй мөртлөө нэг ч үүрэг байхгүй сонин хууль хэдэн жилийн өмнө баталсан байна. Энэ зүйлүүдийг засаад, үүнийхээ дараа энэ хуулиа “Улаанбаатар хотын тогтвортой хөгжлийн тухай” хууль гэж нэрлээд саяны миний хэлсэн

тогтвортой хөгжлийн 3 хуулийг энэ хуулийнхаа үзэл санаанд оруулчихаад, дараа нь хуулиа оруулж ирвэл энэ чинь сая нэг хууль шиг хууль болно. Түүнээс энэ бол барилга барих хууль биш, хүний үл хөдлөх хөрөнгийг хүчээр авчихаад, оронд нь мөнгө өгөх асуудал биш. Дээр нь, 80% дэмжиж байгаа гэж хэлчихээд, 20% нь хүний эрх чөлөөг зөрчөөд явах хууль биш. Бүтцийн гажиг, концевцийн гажиг хуулинд чинь орсон учраас энэ хуулийг огт хэлэлцэх шаардлагагүй, буцаах ёстой гэсэн саналыг минь дэмжээсэй гэж хүсэж байна. Баярлалаа.

*Монгол Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганы Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 11 дүгээр сарын 06-ны өдөр (Лхагва гараг)-ийн хуралдааны тэмдэглэлээс: “Монгол Улсын 2014 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хуулийн төслиүдийн хоёр дахь хэлэлцүүлэгийн цээр*

С.Дэмбэрэл: -Энэ Сангийн яамнаас л асууя даа. 2014 онд байгаль орчин, ногоон хөгжилд дотор нь 2 хуваагаад маш тийм нарийн яг тодорхой хариулт өгнө шүү надад. Байгаль орчинд хичнээнийг төлөвлөж байгаа юм. Ногоон хөгжилд хэдийг нь төлөвлөж байгаа юм бэ? Төсөвт, хөрөнгө оруулалт гэсэнугаар. Энийг надаа хэлээд өгчих. Яагаад вэ гэвэл Их Хурлаар мөдхөн ногоон хөгжлийн бодлого батлагдах гэж байна шүү дээ. Энэ чинь 2014 оноос эхэлж хэрэгжих ёстой. Тэрэнд мөнгө суулгасан уу л гэж асуугаад байна.

Г.Баярсайхан: - С.Дэмбэрэл гишүүний асуултад хариулъя Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам.

Эдийн засгийн хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын хэлтэс. О.Бат-Эрдэнэ: - 2014 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг нийтдээ төсвийн хязгаарт багтаагаад төсвийн ерөнхийлөн захирагчдын захиалгынх нь дагуу бол одоо Засгийн газраар хэд хэдэн удаа хэлэлцээд Их Хуралд өргөн барьсан. Энэ дундаа Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын төсвийн багцын хөрөнгө оруулалтын зардлыг 8.5 тэрбум төгрөгөөр хөрөнгө оруулалтын зардлыг баталсан. Энэ дотроо бол хөрөнгийн зардал, тоног төхөөрөмж, их засвар гэж ингэж технологийн бүтцийн хувьд нь бол ангилж байгаа. Ер нь бол одоо их засвар, тоног төхөөрөмж, барилга байгууламжийг барих ийм технологийн бүтцээр бол жил болгон Их Хурлын жагсаалтыг баталдаг хуультай. Тэгээд энэ хэрэгцээгээ бол одоо төсвийн ерөнхийлөн захирагчид тодорхойлж ирүүлдэг. Энэ асуудлуудыг нь бол Эдийн засгийн хөгжлийн яаман дээр боловсруулж, нэгтгээд ингээд өргөн барьдаг журамтай. Тэгээд энэ хүрээнд бол барилга байгууламж дээрээ бол нийтдээ 5.1 тэрбум төгрөг, их засварын зардалд бол 800 сая төгрөг, сайдын багцын тоног төхөөрөмжийн нийт зардлыг 2.5 тэрбум төгрөгөөр баталсан.

С.Дэмбэрэл: - Наадахыг чинь би мэднэ. Би асуугаад байна шүү дээ. Ногоон хөгжилд нь яг хэдийг, байгаль орчинд нь яг хэдийг юм бэ?

О.Бат-Эрдэнэ: -Тэгэхээр энийг бол төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуух ёстой. Бодлогын хүрээндээ одоо төрийн бодлогын баримт бичгээ дагуулаад энийгээ яаж тодорхойлж байгааг бол төсвийн ерөнхийлөн захирагчид бол тодорхойлох ёстой. Ирүүлсэн хөрөнгийн зардлуудын энэ хүрээнд нь бол нэгтгээд боловсруулаад өргөн барьдаг журамтай. Ер нь

С.Дэмбэрэл гишүүний Байнгын хороодууд дээр хэлж байгаа таны саналыг бол бид анхааралдаа тусгаж байгаа л даа. Ерөнхийдөө эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлуудаар нь бол эрэмбэлэх ёстой, дүгнэх ёстой, тооцох ёстой гэж. Ер нь өнөөдрийг хүртэл бол манай хөрөнгө оруулалтын тогтолцооны хүрээнд энийгээ ингэж ангилж, шинэчилж чаддаггүй явж ирсэн. Энэ нь бол цаанаа олон хүчин зүйлтэй холбоотой. Ер нь өнөөдөр ч гэсэн Засгийн газар Их Хуралд төсвийн төслөө өргөн барихдаа нийтдээ энэ төсөл арга хэмжээнүүдийг бол Их Хурал дээрээ нэлээн нарийн ярих ёстой гэдгийг Ерөнхий сайд илтгэлдээ дурдаж ингэж хэлэлцэж байгаа гэж ингэж ойлгож байгаа.

**С.Дэмбэрэл:** -За больё. Хүмүүс хариулж,.. асуултаа татаж авлаа.

**Д.Арвин:** - Гаднын хүчээр монголын үндэсний дотоодын үйлдвэрлэлийг зогсоосон том бодлого яваад байна шүү дээ та нар. Тэгээд та нар энийгээ мэдэрч байх хэрэгтэй шүү дээ. Харин тэгээд манай Байнгын хороо өөрсдөө энэ ажлыг нь явуул л даа. Өнгөрсөн жилийг чинь энэ жилийнхээ, ирэх жилийнхээ төсвийг хийж байна. Гэтэл одоо энэ өнгөрсөн жилийн төсөв чинь зогсчихсон сууж байна шүү дээ. Тэгээд дандаа үндэсний үйлдвэрлэгчдээ дэмжсэн юмыг ингээд хаагаад боочихсон. Энэ бол маш том мафи одоо ингэж орж үндэсний үйлдвэрлэгчдийг зогсоож, тэгээд одоо гаднын шууд наймаачдыг дэмжсэн ийм бодлогыг монголын төр явуулаад байгааг манай Байнгын хороо анхааралдаа авах хэрэгтэй. Жилийн жилд явдаг ийм бодлого. Тэр өндгөн дээр ч тэр, сүүн дээр ч тэр дандаа ингэж Их Хурлын гишүүдээр дамжиж ийм муухай бодлого орж ирдэг. Яагаад гэвэл манай Баянзүрх дүүрэг бол 300 гаруй мянган хүн амтай, маш их олон хүнсний ногоо тарьж, өөрсдийгөө одоо ногоогоор гэсэн ийм том зорилт яангуут хэдэн зоориуд болох болтол аваачаад одоо бүгдийг нь зогсоочихсон. Харин тэгээд л энийг чинь Их Хурлын гишүүд шалгана гээд зогсоочихоод байна шүү дээ. Одоо энийгээ яагаад энийг шалгах болж, энэ төслийг зогсоосон юм өнгөрсөн жилийн одоо энэ. Тэгээд бид нар төсөв батлаад ямар нэмэр байдаг юм. Төсөв батлаад өөрсдөө тэрийг зогсоогоод байдаг ийм Их Хурал байдаг юм уу. Тэгэхэд ард түмэн одоо юу гэж байна вэ гэхээр ерөөсөө үндэснийхээ үйлдвэрлэгчдийг дэмжихгүй гээд. Тэгээд ирэх жилийнхээ төсвийг бид өнөөдөр баталж өмнөх жилийнхээ төсвийг Их Хурал нь өөрөө зогсоочоод, гишүүд нь зогсоочоод одоо ингээд суугааг юу гэж үзэх юм. Одоо манай Их Хурлын, одоо наад С.Дэмбэрэл гишүүн тэргүүтэй улсууд шалгана гээд тэр ажлыг зогсоочхож байгаа байхгүй юу. Тэгээд ер нь ярих хэрэгтэй шүү дээ. Энэ чинь бол гадаадын энэ том бүлэглэлийн үгээр одоо гадаадын ногоон хоолыг ...

**Г.Баярсайхан:** - Д.Арвин гишүүн ээ, ерөнхийдөө таны ярьж байгаа саналыг бас анхааралдаа авъя тийм. С.Дэмбэрэл гишүүнтэй нэг их хамаагүй байх аа. Та Монголбанкин дээр ажлын хэсэг ахалж байгаа биз дээ.

**С.Дэмбэрэл:** - Юу яриад байгаа юм бэ дээ. Би одоо ойлгохгүй байна л даа. Энэ надад ерөөсөө хамаа байхгүй. Харин тэр ч байтугай ОРГАНИК МОНГОЛ гээд хөдөлгөөнийг үүсгээд 5 жил боллоо. Олон түмнээр ногоо тариулаад, одоо хичнээн мянган хүн амьжиргаа залгаж байна. Энэний чинь бүр эх үүсвэрийнх нь эзэн хүн болоод сууж байна. Тэгээд одоо би наадахыг чинь ерөөсөө мэдэхгүй юм, Д.Арвин аа.

**Г.Баярсайхан:** - Х.Туваан сайд аа, Д.Арвин гишүүний ярьж байгаа асуултад хариулъя. Арвин гишүүн ээ, одоо та болоо.

**Х.Туваан:** - Д.Арвин гишүүний асуулт нь бол Монголбанкнаас хэрэгжүүлсэн нөгөө зорийн аж ахуйг дэмжих, үнэ тогтворжуулах дэд хөтөлбөрийн хүрээтэй холбоотой юм байх шиг байна. Тэгээд энийг бол Их



Хурлаас ажлын хэсэг ажиллаад, одоо дүгнэлт нь гараад энэ ажил цаашаа явнаа гэсэн мэдээллүүд надад өгсөн байгаа. Ер нь бол Монголбанкны үйл ажиллагаа болон энэ хэрэгжүүлсэн үнэ тогтворжуулах дэд хөтөлбөрүүдтэй холбоотой ажлын хэсэг гарч шалгалт орсон. Тэгээд энэ бол хэсэг нь ороод дуусаад, дүгнэлт.

**С.Дэмбэрэл:** -Ажлын хэсгийн зүгээс ямарваа нэгэн байдлаар энэ хөтөлбөрийг одоо дэд хөтөлбөрүүдийг зогсоо гэж огт тийм үүрэг өгөөгүй, үүрэг өгөх эрх ч байхгүй. Тийм учраас зүгээр Монголбанк л яасан гэхээс, манай ажлын хэсэгт ийм юм байхгүй шүү.

**Г.Баярсайхан:** - Д.Арвин гишүүн ээ, таны яриаг ойлголоо. Монголбанкин дээр манай С.Дэмбэрэл гишүүний ахалж байгаа ажлын хэсэг ажиллаж байгаа. С.Дэмбэрэл гишүүний ажлын хэсгээс таны ярьж байгаа төсөл хөтөлбөрүүдийг ямарваа нэгэн байдлаар зогсоох ийм зүйл ерөөсөө явагдаагүй. Зүгээр Монголбанк шалгалт орж ирсэн учраас, УИХ-ын ажлын хэсэг ажиллаж байгаа учраас зарим ажлууд нь давхардаад, жаахан удааширсан тал байгаа байх гэж ойлгож байгаа. Түүнээс биш яг бодлогоор Их Хурлын гишүүд төрөөс бид нар бодлого гаргаад, дэмжээд явж байгаа зүйлийг зогсоосон асуудал албан байхгүй гэдгийг би танд албан ёсоор хэлье.

- УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл, Я.Содбаатар, С.Оюун, Ц.Дашдорж, Ж.Энхбаяр, А.Бакей нарын гаргасан “Төрөөс ногоон хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхтэй холбогдох зардлыг Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 19 дэх хэсгийн байгаль орчин хөгжлийн. Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын багцын хөрөнгө оруулалтын болон урсгал зардалд тусгах” тухай санал байна. Дэмжиж байгаа гишүүд 14-өөс 8 байна.

## Хуулийн зүйл бүр дээр

*Монгол Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганы Эдийн засгийн байнгын хорооны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс: “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг дээр.*

**Б.Гарамгайбаатар:** Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын төслийн /цаашид “төслийн” гэх/ нийтлэг үндэслэлийн 1-3 догол мөрийг нэгтгэн дор дурдсанаар өөрчлөн найруулах:

*1.1.Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого нь хувийн хэвшилд түшиглэсэн ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжцүлж, ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн бие даасан хөгжлийг хангах олон тулгуурт олон тулгуурт бүтцийг бий болгож, цндэсний язгуур эрх ашгийг хангахад чиглэгдэнэ.*

Энэ дээр асуулт байна уу. С.Дэмбэрэл гишүүн.

**С.Дэмбэрэл:** Олон тулгуурт, бие даасан гэсэн ийм томъёолол байхгүй л дээ. Тэнцвэртэй гээд томъёолчихвол яасан юм. Энэ хуульд ч байгаа, бас. Бүх хуульд голдуу эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, эсхүл тэнцвэртэй бөгөөд тогтвортой хөгжлийг хангах гэсэн. Бие даасан гэдэг маань хойд Солонгос шиг сонсогдоод байна л даа.

**Б.Гарамгайбаатар:** бие даасан гэдэг бол болохгүй байна л даа. Бие даасан хөгжлийг хангах гэдэг буруу байгаад байгаа юм. Олон тулгуурт гэдгийг тэнцвэрт гэж үзэх гээд байна уу. Бие даасан гэдгийг хасъя гэсэн ийм санал гаргаж байна. Тэгвэл Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого нь хувийн хэвшилд түшиглэсэн ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн олон тулгуурт олон тулгуурт бүтцийг бий болгож, үндэсний язгуур эрх ашгийг хангахад чиглэгдэнэ гэдгийг дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 11-аас 8... Бие даасан гэдгийг хасахаар боллоо.

Төсөлд дор дурдсан агуулгатай 1.3 дахь заалт нэмэх:

*“1.3.Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлоготой тээвэр, логистик болон холбогдох бусад салбарын бодлогыг уялдуулан хөгжцүлж, олон улсын тавцанд өрсөлдөх чадварыг бэхжцүлнэ.”*

**С.Дэмбэрэл:** Сая дөнгөж бид нар бие даасан гэдгийн оронд тэнцвэртэй гээд сольсон. Тэнцвэртэй гэдэг маань энэ дотроо гарч ирэх ёстой. Тэгэхээр аливаа нэг салбарыг жишээлбэл тэргүүлэх чиглэл гээд хуульчичаар тухай тухайн явц, эдийн засгийн хөгжлийн явцад тэр чинь мөнхийн юм шиг болчихно. Гэтэл Монголын хөгжлийн явцад түүхэн тодорхой хугацаануудад энэ тэргүүлэл чинь өөрөө биш болж болно. Бид дараа дараагийн хуулиудад жишээлбэл хөдөө аж ахуйг тэргүүлэх салбар гээд бүх салбарыг тэргүүлэх салбар болгочихсон. Тэгэхээр үүнийг тэргүүлэх гэхээсээ илүү эрдэс баялгийн салбарт баримтлах төрийн бодлого нь тээвэр, логистик гэж тодорхой салбар дурьдахаасаа илүү эдийн засгийг солонгоруулах үйл явцтай нягт уялдаа, холбоотой хөгжүүлнэ гэсэн утгаар оруулчихвал болчих гээд байна л даа. Өөрөөр хэлбэл хоорондоо уялдаатай, холбоотой гэсэн утгаар. Түүнээс биш энэ бол тэргүүлэх гэсэн утгаар биш. Бусад салбар нь үүнийг дагаж хөгжинө гэсэн утга орчихоод байна шүү дээ, энэ дээр. Гэтэл энэ чинь хоорондоо нягт уялдаа холбоотой хөгжинө л гэсэн үг. Түүнээс биш уул уурхайг дагаж бусад салбар тээвэр, логистик нь дагаж хөгжинө гэсэн үг биш байхгүй юу. Бид бол нөгөө гол зорилго маань эдийн засгийн солонгоруулах гээд албан ёсны томъёолол болсон.

**Б.Гарамгайбаатар:** Одоо бол уул уурхайг дагана гэсэн юм байгаа.

**С.Дэмбэрэл:** Одоо бол тийм юм байгаад байгаа юм. Түүнийг нь саяны эдийн засгийг солонгоруулах үйл явцтай нягт уялдаа холбоотой хөгжүүлнэ гээд оруулчихвал болох юм шиг байгаа.

**Б.Гарамгайбаатар:** Энэ чинь баримтлах бодлоготой тээвэр логистик болон гэж байгаа юм. Тэгэхдээ онцгойлж тэр хоёрыг заачихаад, болон гэхчээд дараа нь холбогдох бусад салбар гэхээрээ бусад салбараа оруулж ирж байгаа юм.

**С.Дэмбэрэл:** Энэ чинь тэгээд нэг их ач холбогдол байхгүй байгаа. Жишээлбэл, тээвэр, эрдэс баялгийн салбар чинь тээвэр логистиктойгоо уялдан гээд тэгээд үүнийг нэг онцолж заагаад байх, зүгээр гол зорилго бол энэ салбарын бодлого нь Монгол Улсын бүр үүнээс том бодлого болох эдийн засгаа солонгоруулах бодлоготой л нягт уялдаа холбоотой хөгжинө гэсэн санааг хэлэх гээд байгаа шүү дээ, гол нь бол. Гарамгайбаатарын санал тийм байсан, тийм биз дээ. Түүнийгээ л оруулчих л даа. Бодлоготой тээвэр логистик болон гэхчээд эдийн засгийг солонгоруулах талаарх төрийн бодлоготой гээд л явчихбал яг таарах гээд байна. Эрдэс баялгийн салбар дахь төрийн бодлого нь тээвэр, логистик болон холбогдох биш эдийн засгийг солонгоруулах бодлоготой.

**Б.Гарамгайбаатар:** Тэгвэл дахиад уншъя.

1.3. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг тээвэр, логистик болон холбогдох бусад салбарын бодлоготой уялдуулан хөгжүүлж, олон улсын тавцанд өрсөлдөх чадварыг бэхжүүлнэ гэсэн саналаар санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 11-ээс 7. Энэ тэгвэл засвар хийх нь байна шүү. Бодлогыг гэдэг хоёр үгийг нэг нь бодлогыг, нэг нь бодлоготой гэж байрыг солих нь байна.

4.Төслийн “Нийтлэг үндэслэл”-ийн 4 дэх догол мөрийг дор дурдсанаар өөрчлөн найруулж, 1.4 дэх заалт болгох:

*1.4.Энэхүү бодлогын баримт бичиг нь төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах зарчим, хөгжлийн чиглэлийг тодорхойлж, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоход чиглэгдэх бөгөөд салбарын хууль тогтоомж, дунд, урт хугацааны хөтөлбөр, дэд хөтөлбөр төсөлд тусгагдан хэрэгжинэ.*

Би дахиад энэ дээр бас нэг юм асууя гэж бодоод байгаа юм. Надад болохоор би ингээд уншихаар 1.1, 1.4 хоёр л давхцаад байх шиг санагдаад байгаа юм.

**С.Дэмбэрэл:** Мянга, мянган цаас үйлдвэрлэхийг хэд байна шүү дээ, Монгол улс чинь. Хэрэгждэггүй мянга, мянган цаас үйлдвэрлэхийг хэд, дараа нь дахиж нэмж, үүнийг бас хуульчилж ямар хэрэгтэй юм. Нийтлэг үндэслэлд орчихсон, нийтлэг үндэслэлд орчихоод тодорхой хүүрнэн өгүүлсэн ийм юм хэрэггүй ээ. Энэ эхний саяны Гарамгайгийн хэлээд байгаа энэ дээрээ л ганц нэг өгүүлбэр нэмнэ, за энэ баталчихсан юм чинь ерөөсөө үүнийг хасчихад юу ч болохгүй.

**Б.Гарамгайбаатар:** 1.4.Энэхүү бодлогын баримт бичиг нь төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах зарчим, хөгжлийн чиглэлийг тодорхойлж, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоход чиглэгдэх бөгөөд салбарын хууль тогтоомж, дунд, урт хугацааны хөтөлбөр, дэд хөтөлбөр төсөлд тусгагдан хэрэгжинэ гэсэн саналыг дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 13-аас 7.Дэмжигдэж байгаа юм байна.

5.Төслийн “Эрдэс баялгийн салбарт баримтлах зарчим” гэсэн хоёр дахь хэсгийн эхний догол мөрийг дор дурдсанаар өөрчлөн найруулж, 2.1 дэх заалт болгох:

*2.1.Эрдэс баялгийн салбарын хөгжлийн хэтийн төлөв, тус салбараас эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр өгөөжийг иргэдэд хүртээмжтэй байлгах зорилгоор эрдэс баялгийн салбарт баримтлах үндсэн зарчмуудыг дараах байдлаар тодорхойлно:*

Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 13-5. дэмжигдэхгүй байна шүү дээ. 5-ыг дэмжиж байгаа гишүүд. 2.1 дэх заалт болгож өөрчилсөн. Тэгээд 2.1 нь Эрдэс баялгийн салбарын хөгжлийн хэтийн төлөв, тус салбараас эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр өгөөжийг иргэдэд хүртээмжтэй байлгах зорилгоор эрдэс баялгийн салбарт баримтлах үндсэн зарчмуудыг дараах байдлаар тодорхойлно гэж байна.

**С.Дэмбэрэл:** Та нар, боль л доо, Монгол хэлээр бичээч. Би үүнийг чинь гараа өргөөд явуулчихвал амархан. Гэхдээ жаахан ичээд байна. Эрдэс баялгийн салбарын хөгжлийн хэтийн төлөв тус салбараас гээд энэ ямар ч илүү үгнүүдээ хасаад, *хөгжлийн хэтийн төлөв, эдийн засаг, нийгэм дэх үзүүлэх үр өгөөжийг нь...* гээд явчихаач дээ. Үүнийгээ жаахан янзалчихаач дээ. Хичнээн хэлүүлэх гэсэн юм бэ.

**Б.Гарамгайбаатар:** Найруулгын асуудал яриад байна. Сул үгнүүдээ авч хая гэсэн үг хэлээд байна. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 13-аас 7. Дэмжигдлээ.

18.Төслийн 3.1.9 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулж, 3.1.7 дахь заалт болгох: “3.1.7.“олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”, “хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх санаачилга”, “нийгэм, эдийн засаг, байгаль орчны стратегийн нөлөөллийн цнэлгээ”-тэй холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгох;”

**С.Дэмбэрэл:** Энэ 3 юм байна шүү дээ. Олборлох үйлдвэрлэлийн ил тод тэгээд хариуцлагатай уурхай, нөгөө дэх нь стратегийн үнэлгээ гээд. Энэ маань уул уурхайн салбарт орчин үеийн уул уурхайн салбарт их төлөв сайн компаниудын үлгэрлэн дуурайх жишээгээр сайн дурын үндсэн дээр сайн жишээг дагах замаар явж байгаа олон улсын зарчим л даа. Түүнээс биш үүнийг учир зүггүй эрх зүйн орчинтой холбоно гэдэг ойлголтыг би сайн мэдэхгүй байгаа юм. Энэ чинь өөрөө зайлшгүй байхыг хуульчилж өгөх юм уу? Үгүй юм уу гэдэг дээр улс орнууд, НҮБ-ээс бол энэ чиглэлээр бүгдийг нь хуульчил гэсэн юм байхгүй. Зарим орнуудад ганц нэг орнуудад бид энэ салбар, энэ үзэл баримтлалдаа тусгаж өгснөөрөө өөрснөө бид харин үүний чинь хамгийн том дэвшил нь. Энэ өөрөө эрх зүйн баримт бичиг, энэ бодлого чинь, одоо бидний ярьж байгаа. Тэгээд үүнийг нэмж, дахиж эрх зүйн орчин гэдгийг би ойлгохгүй байгаа юм. Үүнийг энэ бодлогод тусгасан маань өөрөө эрх зүйн орчин болоод бид батална шүү дээ. Энэ чинь өөрөө эрх зүйн орчин нь болчихож байгаа юм. Өөрөөр хэлбэл, энэ төрөөс баримтлах эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичигт энэ 3 зарчим олон улсын 3 санаачлага тусч өглөө гэдэг маань өөрөө Монгол Улс энэ замаар явна гэсэн үг. Түүнээс биш үүнийг хууль санаачлах гээд энэ буруу шүү. Энэ худлаа шүү. Энэ чинь өөрөө ингээд орчихож байгаа юм. Тийм учраас тэр эрх зүйн гэхээсээ илүү үүнийгээ найруулгынх нь хувьд энэ 3 баримт бичгүүдийг уул уурхайн салбарт хэрэгжүүлнэ ч гэдэг юм уу? Хэрэгжүүлэх үйл явцыг дэмжинэ ч гэдэг юм уу? Энэ чиглэлээр гэдэг юм уу, иймэрхүү утгатай л юм байх ёстой. Эрх зүйн орчин гэдэг энэ талаасаа нэлээн төөрөлдсөн юм байна шүү.

19.Төслийн 3.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3.1.9 дэх заалт болгох: “3.1.9.ашигт малтмалын ордыг цнэлэх олон улсын стандартад шилжих;”

**С.Дэмбэрэл:** Энэ дээр үнэ цэнийг үнэлэх, баялгийг үнэлэх гэж олон улсын хоёр томьёолол болоод дэлхийн банкнаас хэрэгжүүлж байгаа, өөрөөр хэлбэл улс орон болгон байгалийн ресурсээ сайн үнэлж, үүнийгээ бүртгэж ингэж капиталын бүртгэл гэж тийм юм хийж чадахгүй учраас одоо дөнгөж яригдаж байгаа асуудал. Үүнийг Ашигт малтмалын ордыг үнэлэх гэхээр энэ бол зүгээр л одоогийн бид нарын ойлголт. Түүнээс сая Содоогийн хэлдэг түүнийг оруулбал баялгийн үнэлгээ, бүртгэлийн олон улсын стандартыг гэвэл одоо яг орчин үеийн хандлагатай тохирно.

**Б.Баатарцогт:** Энэ дээр ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал гэж байгаа. Өөрөөр хэлбэл, ашигт малтмалын баялаг, ордын нөөц гэсэн хэлбэрээр орж ирвэл яг мэргэжлийн хэлбэрээр орж ирнэ.

**С.Одонтуяа:** За тэгье. Тэгвэл ашигт малтмалын баялаг гэдэг үг нэмэх юм байна.

**Б.Гарамгайбаатар:** Тэгээд 3.1.9 чинь, ашигт малтмалын баялаг гэх юм уу.

**С.Дэмбэрэл:** Үүнийг чинь орчин үеийн жинхэнэ хэллэгээр нь байгалийн капитал буюу натураль капитал гэж нэрлэдэг юм. Одоо бүх дэлхий дээр ингэж явж байна.

**Б.Гарамгайбаатар:** Баялаг гэдэг үгийг нэмж оруулах юм байна. 3.1.9.Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийг үнэлэх олон улсын

стандартад шилжүүлэх гэсэн саналыг дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 13-аас 9.

20.Төсөлд доор дурдсан агуулгатай 3.1.11 дэх заалт нэмэх: “3.1.11. эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өнөөгийн тогтолцоог өөрчилж, олон улсын жишигт нийцүүлэн эрх, үргийг мэргэжлийн холбоод, мэргэшсэн шинжээчдэд шилжүүлэх чиглэл баримтлах;”

**С.Дэмбэрэл:** Чиглэл баримтална гэж юу гэж байгаа юм, энэ чинь хуурамч өгүүлбэр байна шүү дээ. Зөвхөн шилжүүлэх гээд л биччих л дээ. Чиглэл гаргаад, тэгээд түүнийгээ баримтлаад 10 жил явах уу? 20 жил явах уу.

**Б.Гарамгайбаатар:** Тэр чиглэл баримтлах гэдэг нь илүү байна гэж байна. Шилжүүлэх гэдгээр дуусаад, дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү.

23.Төслийн 3.2.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах: “3.2.1.1.уул уурхайн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг хангах зорилгоор геологи хайгуулын салбарыг түрүүлэн хөгжүүлэх бодлого баримтлах;”

**С.Дэмбэрэл:** “Түрүүлэн хөгжүүлэх” гэдэг дээр тусгай үг байгаа л даа. Олон улсад хэрэглэдэг юм. Угтуулан хөгжих гэж. Энэ явж байхад энэ чинь аль хэдийн оччихсон гэсэн үг.

**Б.Гарамгайбаатар:** Түрүүлэн гэдэг нь бараг зөв юм биш үү. Энэ түрүүлэн гэдгийг тэр хэл шинжээчдээс тодруулга аваарай, дараа нь. Тэгээд үүгээр нь санал хураалт явуулъя.

“3.2.1.1.уул уурхайн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг хангах зорилгоор геологи хайгуулын салбарыг түрүүлэн хөгжүүлэх бодлого баримтлах;” Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 13-аас 8.

24.Төслийн 3.2.1.2 дахь заалтын “гүйцэтгэх,” гэсний дараа “хайгуулын тусгай зөвшөөрлийг ил тод олгох,” гэж нэмэх.

**С.Одонтуяа:** Энэ манай ажлын хэсгийн С.Ганбаатар гишүүний санал. Одоо бол ерөөсөө хайгуулын тусгай зөвшөөрлүүд ил тод олгогдохгүй байна аа. Яагаад гэхээр одоо бид хугацаагаар нь, үүний ард өрсөлдөөнтэй гэж байсныг нь бүр хассан. Өөрөөр хэлбэл эхэлж мэдээлэл авсан хүмүүс нь нийтэд ил тод биш учраас мэдээлэлд ойрхон хүмүүс нь энэ хайгуулын тусгай зөвшөөрлийг олж аваад байна гэсэн ийм санаагаар ажлын хэсэг дээр орж ирсэн байгаа. Энэ дээр өрсөлдөөн гэж байсныг хассан. Энэ дээр ямар нэгэн хүмүүсийг өрсөлдөх тийм юм бол байхгүй. Хамгийн түрүүнд өргөдлөө өгөөд авсан хүн нь авъя гэсэн зарчмаар хасагдсан.

**С.Дэмбэрэл:** Хайгуулын тусгай зөвшөөрлийг хэн олгодог юм бэ? Нэг газар олгодог байх. Тэр кадастрын албаны ил тод байдлыг л хангана гэсэн үг шүү дээ. Түүнээс биш энэ хуулиа зөрчөөд энэ чинь хуулийн гол зарчим нь болохоор түрүүлж ирсэн нь, түрүүлж үйлчлүүл гэсэн олон улсын өрсөлдөөнт зарчмыг оруулчихсан. Тэр чинь хуулиндаа байдаг. Тэгэхээр энэ дээрх гол санаа нь энэ ингээд ил тод биш учраас ингээд мэдээлэлд ойрхон нь илүү авчихаад байна гэсэн санаагаар оруулсан юм шиг байна. Тийм учраас цаад объект нь болохоор нөгөө кадастрын байгууллагын нээлттэй, ил тод ажиллах зарчмыг хангана гэсэн тийм л утгаар оруулж болох юм. Түүнээс биш яг энэ заалтаар орохоор чинь хуулиа зөрчих гээд байна л даа.

**С.Одонтуяа:** Зарчим дээр бүгд ил тод гээд орчихсон учраас үүнийг хасаж болно.

**Б.Гарамгайбаатар:** Төслийн 3.2.1.2 дахь заалтын “гүйцэтгэх,” гэсний дараа “хайгуулын тусгай зөвшөөрлийг ил тод олгох,” гэж нэмэх. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 13-аас 1. Дэмжигдсэнгүй.



**26.Төслийн 3.2.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**  
*“3.2.2.2.геологийн зураглал, ерөнхий эрэл, агаарын геофизикийн ажлын улсын төсвийн санхүүжилтийг жил бүр тогтвортой өсгөж Монгол орны геологийн судалгааны түвшинг дээшлүүлэх;”*

**С.Дэмбэрэл:** Үүнийг *“санхүүжилтийг жил бүр тогтвортой өсгөж, Монгол орны геологийн судалгааны хамрах хүрээ, чанарыг дээшлүүлнэ.”* гэж өөрчиллө.

**Я.Содбаатар:** Тэгье, тэгье. Тэгж оруулъя.

**Б.Гарамгайбаатар:** Геологийн зураглал, ерөнхий эрэл, агаарын геофизикийн ажлын улсын төсвийн санхүүжилтийг жил бүр тогтвортой өсгөж, Монгол орны геологийн судалгааны хамрах хүрээ болон чанарыг дээшлүүлнэ. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 13-аас 9. Дэмжигдлээ.

**32.Төслийн 3.3.3 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулах:**  
*“3.3.3.байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатай тэргүүний техник, технологийг ашиглаж ил тод, хариуцлагатай уул уурхайн зарчимд нийцсэн цйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг дэмжих;”*

**С.Дэмбэрэл:** Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатай, тэгсэн мөртөө тэргүүний технологи. Зүгээр л байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, эсхүл байгаль орчин хүний эрүүл мэндэд эерэг нөлөөтэй ч гэдэг юм уу? Сөрөг нөлөөлөл багатай гэхээр, тэгсэн мөртөө тэргүүний гэх юм бол өнөөдөр дэлхий дээр байхгүй.

**С.Одонтуяа:** Сөрөг нөлөөлөлгүй байхгүй гэсэн.

**С.Дэмбэрэл:** Сөрөг нөлөөлөлгүй байдаг юм. Байдаг юм. Эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй технологи гэдгийг хүн төрөлхтөн хийгээд, гаргаад, одоо ашиглаад явж байна, байгаль орчинд.

**С.Одонтуяа:** энэ анхны хувилбар нь эрүүл мэндэд халгүй гэж байсан юм. Энэ дээр маш олон эрдэмтэд, мэргэжлийн хүмүүс үзээд, энэ бол худлаа. Халгүй огт байхгүй. Сөрөг нөлөөлөл багатай гэж оруулах ёстой гэсэн.

**С.Дэмбэрэл:** Бид нар энэ дэлхий дээр байгаа ийм зүйлийн дефакттай байгаа зүйлийг дэлхий дээр бид сөрөг нөлөөтэй ертөнцөд амьдарч байгаа.

**Б.Гарамгайбаатар:** Санал хураалтаа явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 13-аас 8. Дэмжигдлээ.

**33.Төслийн 3.3.5 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулах:**  
*“3.3.5.уул уурхайн цйлдвэрлэлийн цйл ажиллагаанд төр, орон нутгийн зүгээс тавих хяналт, төлбөр, хураамжийг хүнд суртал, давхардалгүй болгох;”*

**С.Одонтуяа:** Энэ дээр ингэсэн юмаа, Содбаатар гишүүн ээ. Та өөрөө ажлын хэсгийнхээ хуралд сууж бай л даа. Энэ яаж гарсан бэ гэхээр, одоо ингэд нэг компани үйл ажиллагаа явуулах гэхээр маш олон шалгалт очдог. Мэргэжлийн хяналтаас, орон нутгаас, татвараас гээд. Энэ нь маш их хүндрэл учруулдаг. Мөн төлбөр хураамж дээр их олон давхардал гардаг. Тийм учраас энэ асуудлыг ажлын хэсэг дээр яриад гол нь их зөв заалт гэсэн. Бид бодлогоороо ер нь хөрөнгө оруулагчдыг аль болохоор нааш нь татах, дэмжих.

**С.Дэмбэрэл:** Ийм шолбойсон заалт байж болохгүй шүү дээ. Энэ санаа нь зөв. Гэхдээ энэ бол зүгээр л хэн ч тоохгүй заалт байна. Жишээлбэл, үүнийг тодорхой хэлж өгөхгүй бол. Жишээлбэл, уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд төв, орон нутгийн зүгээс хяналт тавихдаа давхардуулахгүй байх зарчмыг баримтална ч гэдэг юм уу ингэж хэлэхгүй бол давхардалгүй, хүч оруулъя л гэж байгаа юм. Энэ чинь үнэндээ хэлэхэд шолбойсон заалт байна л даа. Тод хэлээд өгчих арга байхгүй юу.

**Б.Гарамгайбаатар:** “3.3.5.уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд төр, орон нутгийн зүгээс тавих хяналт, төлбөр, хураамжийг хүнд суртал, давхардалгүй болгох;”

Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 13-аас 9.

**35.Төслийн 3.3.8 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулж, 3.3.7 дахь заалт болгох:** “3.3.7.олборлох салбарт шинжлэх ухаан, техник, технологийн ололтыг нэвтрүүлэх замаар уул уурхайн үйлдвэрлэлийн бүтээмжийг өсгөн нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийг дэмжих.”

**С.Дэмбэрэл:** Бусад нь ордоггүй юм уу. Геологи, уул уурхайд эд нар чинь ордоггүй юм уу. Боловруулах салбарт энэ чинь ордоггүй юм уу.

**Я.Содбаатар:** Олборлох салбарын хүрээнд гэдэг юман дотор явж байгаа.

**С.Дэмбэрэл:** яахаараа ингэдэг юм. Эрдэс баялгийн салбарт л гэсэн тийм зарчим байгаа шүү дээ. Бүгд л орно шүү дээ.

**Б.Гарамгайбаатар:** Байрлалыг солих асуудлыг яриад байна. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 14-өөс 8.

**38.Төслийн 3.4.1 дэх заалтын “цэвэр катодын зэс, төмөр хийц, ураны шар нунтаг, цэвэршүүлсэн алт, газрын ховор элементийн баяжмал зэрэг” гэснийг хасч, 3.4.3 дахь заалт болгох:**

**С.Дэмбэрэл:** Энэ манай монголчууд ийм юм яриад байгаа л даа, сүүлийн үед. Бүх юмыг л өртөг шингээнэ гээд. Үүн шиг худлаа юм байхгүй шүү. Бид бол бүх юмыг өртөг шингээж үйлдвэрлэж чадахгүй шүү дээ, нэмэгдсэн өртөг шингээх. Үүнийг л ингээд ийм хүүхдийн бодлого яваад байдаг байхгүй юу. Одоо улс даяараа ярьдаг, тэр нь юу юм бэ гэхээр, нэмэгдсэн өртөг шингээгээд ёстой сайхан хөгжинө гэж боддог. Гэтэл энэ чинь улс орнуудын бас тэгж хөгжсөн түүх байдаггүй байхгүй юу.

**С.Одонтуяа:** Таньтай санал нийлж байна аа.

**Б.Гарамгайбаатар:** 38-ыг дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 14-өөс 11.

**Б.Гарамгайбаатар:** 3.5.1.тухайн нутаг дэвсгэрт уул уурхайн олборлолт эхлүүлэхийн өмнө нутгийн иргэдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах, хамтын шийдвэр гаргахад тэдний оролцоог хангахтай холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

**3.5.2.уул уурхайн олборлолтын хугацаанд орон нутгийг тогтвортой хөгжүүлэх зорилгоор “Орон нутгийг хөгжүүлэх гэрээ”-г хөрөнгө оруулагч нутгийн удирдлагын байгууллагатай байгуулах.**

**С.Дэмбэрэл:** Яг одоо энэ заалтыг ингээд энэ чигээр нь баталчихвал болохгүй байна л даа. 3.5-д, гол зорилго бол би түрүүн заачихсан байгаль орчин, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөлтэй гээд бүх компаниудынхаа шаардлагыг тавьчихлаа. Тэр компаниуд нь өөрөөр хэлбэл хариуцлагатай, ил тод уул уурхайг эрхэлнэ гээд өмнөх заалтууддаа бид хийгээд өгчихлөө. Одоо бид нутгийн, орон нутгийн болон энэ хариуцлагатай ил тод ажилладаг компаний хоорондын харилцааг л энд тодорхойлох гээд байна. Тэгэхээр өөрөө энэ чинь орон нутаг маань өөрөө тогтвортой хөгжих ийм, энд л тухайн хөрөнгө оруулагч, гадаад, дотоодын хөрөнгө оруулагч хувь нэмэр оруулах үүрэгтэй болохоос биш, хувь нэмэр оруулах тэр хариуцлагынхаа хүрээнд ийм чиглэлээр л оруулах ёстой болохоос үүнийг яг ийм хатуу тогтоосон гэрээгээр хийчихээр нэг тийм юу болчих гээд байна. Гэхдээ жишээлбэл, 3.5.1 дээр ингэсэн. Уул уурхайн олборлолт эхлүүлэхийн өмнө эрх зүйн орчныг боловсронгуй болгох гэдэг чинь юу гэсэн үг юм бэ? Ийм юм байж

таарахгүй ээ. Уул уурхайн олборлолт эхлэнэ үү? Энэ эхлэхээс өмнө угаасаа л Монгол Улсын хууль тогтоомж гэж эрх зүйн орчин нь эхэлсэн, эхлээгүй л, тэр хаашаа юм, эхлэхийг нь хүлээж байгаад нэг хууль өөрчлөх юм уу? Хаашаа юм. Нэг ийм л утга байна шүү дээ. Тэгэхээр чинь энэ дээр тус тусад нь орон нутагт ийм эрх зүйн орчин бий болгох юм шиг ийм утга гарчихаад байна. Энэ угаасаа их өөрөө утгагүй өгүүлбэр байна л даа. Түүний оронд түрүүн Нямдорж гишүүн хэлсэн, Баярсайхан хэллээ. Орон нутагт энэ уул уурхай, эрдэс баялгийн үйл ажиллагаа явуулснаас орох орлогын хэмжээг тогтмол нэмэгдүүлэх замаар орон нутгийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх нэг ийм заалт.

Нөгөө дэх нь уул уурхайн олборлолтын хугацаанд орон нутгийн тогтвортой хөгжүүлэх зорилгоор орон нутгийг хөгжүүлэх гэрээ гэдгийг зүгээр хөрөнгө оруулагч тал нутгийн өөрөө удирдах байгууллагын хооронд энэ чиглэлээр хамтран ажиллана. Хамтран ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлнэ ч гэдэг юм уу. Ийм байдлаар л оруулбал юу юм гэхээс, тэгэхгүй бол энэ чинь нэг их шахсан л юм болчих гээд байна даа.

**46.Төслийн 3.5.4 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулж, 3.6.2 дахь заалт болгох:** “3.6.2.уурхайн нөхөн сэргээлт, хаалтын стандарт, журмыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, хариуцлага, хяналт, мониторингийн ажлыг гүйцэтгэхэд иргэд, орон нутгийн байгууллагын эрх, цэргийг нэмэгдүүлэх.”

**С.Дэмбэрэл:** Энэ дээр чинь эрх, үүргийг нэмэгдүүлэх гээд дахиад л хуульчилсан л юм хийх гээд байна шүү дээ. Энэ чинь хамтран ажиллах л процесс шүү дээ. Өөрөөр хэлбэл нөхөн сэргээлт хийх, хаалтын стандарт журмыг боловсруулах, иргэдийн саналыг авах гээд, түүнээс эрх, үүргийг нэмэгдүүлэх гэж одоо яг юу нь дутаад, юуг нь яг нэмэгдүүлэх гээд байгаа, яг ямар эрхийг нэмэгдүүлж, ямар үүргийг хасах, хамтран ажиллах л гэсэн утгаар оруулчихаач. Хөндлөнгийн хяналт, мониторинг гэсэн. Олон улсын жишиг ийм байна шүү дээ.Хөндлөнгийн хяналт, мониторинг л хийдэг. Өөрөөр хэлбэл сонирхлын зөрчилгүй.

**Б.Гарамгайбаатар:** Тэгвэл уурхайн нөхөн сэргээлт, хаалтын стандарт журмыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, баталж мөрдүүлнэ.

**С.Дэмбэрэл:** Уурхайн нөхөн сэргээлт, хаалтын стандарт журам, хяналт, мониторингийн ажлыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулна.

**Б.Гарамгайбаатар:** Уурхайн нөхөн сэргээлт, хаалтын стандарт журмыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлж ажиллана. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 14-өөс 11. дэмжигдлээ

**47.Төслийн 3.5.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3.6.3 дахь заалт болгох:**

*“3.6.3.эрдэс баялгийн олборлох, боловсруулах үйлдвэрлэлд газрын гүний усыг хэмнэлттэй ашиглах орчин үеийн дэвшилтэт технологийг дэмжиж, газрын гадаргын усыг түлхүүц ашиглах.”*

**Л.Энх-Амгалан:** Энэ дээр би бас С.Дэмбэрэл гишүүнийхтэй адил байна. Усыг дахиж эргүүлэн ашиглах, саарал ус. Гол нь тэр шүү дээ.

**Б.Гарамгайбаатар:** эрдэс баялгийн олборлох, боловсруулах үйлдвэрлэлд газрын гүний усыг хэмнэлттэй ашиглах орчин үеийн дэвшилтэт технологийг дэмжиж, газрын гадаргын усыг түлхүү ашиглах.

**С.Одонтуяа:** Хэмнэлттэй болон дахин ашиглах гээд.

**С.Дэмбэрэл:** Яг энэ усны бодлого дээр өнөөдөр ЗР гэж явж байгаа. Тэр З юмыг мэднэ байх гэж бодож байна, энэ яамны хүмүүс. Энэ ЗР буюу түрүүний хэлдэг зарчмыг хэрэгжүүлж саарал ус, энэ бүхнийг ингэж оруулна гэсэн усны зарчмаа л хэлэх гээд байгаа юм байна л даа. Газрын

гадаргуугийн болон гүний усны, манайд чинь пропорц нь их өөрчлөгдсөн байгаа шүү дээ. Тийм учраас түлхүү ашиглах, нэг усыг их ашиглах гэхээсээ илүү газрын гадаргуугийн болон гүний усны зохистой харьцааг баримтлан ингэнэ гэсэн утга.

**Б.Гарамгайбаатар:** 3.6.3-аар санал хураалт явуулъя, тэгээд найруулга дээр хараарай гэж хэлье. Хэмнэлтгэй ашиглах технологи гэхээр буцаагаад саарал ус ашиглах юм чинь орж байна гэж би бол ойлгоод байна шүү дээ.

**Я.Содбаатар:** Эсхүл Засгийн газраас орж ирсэн 3.5.5-ыг нь шууд явчихбал яадаг юм. Энэ нь зүгээр юм байгаа.

**Б.Гарамгайбаатар:** Тэгвэл мэргэжлийн улсуудаар тайлбарлуулъя.

**Я.Содбаатар:** Засгийн газрын оруулж ирсэн санал, эрдэс баялгийн олборлох болон боловсруулах үйлдвэрлэлд гадаргын усыг түлхүү ашиглах, холбогдох хуульд заасны дагуу хэрэглэсэн усыг дахин ашиглах, уул уурхайн салбарын ахуйн хэрэглээнд саарал усыг ашиглах, газрын гүний цэнгэг усыг аль болох ашиглахгүй байх орчин үеийн дэвшилтэт технологийг дэмжин ажиллана гээд. Энэ саарал ус, гадаргын ус гэсэн нарийн юмнуудыг бүгдийг нийлүүлээд дэвшилтэт.

**С.Дэмбэрэл:** Яг саяны Засгийн газрын бодлого чинь маш зөв байна. Үүгээр л явуул.

49.Төслийн 3.5.8 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулж, 3.6.5 дахь заалт болгох:

*“3.6.5.уурхайн эвдрэлд орсон талбайг бүртгэлжцүлж, өмнө нь нөхөн сэргээлтгүй орхисон талбайг нөхөн сэргээх ажлыг гадаадын болон дотоодын санхүүгийн эх үүсвэрээр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;”*

**Г.Батхүү:** Тэр эх үүсвэрийг нь зааж өгөх ямар хэрэг байна вэ? Гадаадынх байна уу? Дотоодынх байна уу. Зүгээр л мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ гээд.

**С.Дэмбэрэл:** Энэ чинь урт хугацааны баримт бичиг шүү дээ. Тэгсэн чинь одоогийн байдал бол яах вэ нэг хэсэг компаниуд нөхөн сэргээлтгүй орхичихсон юм байна л даа. Тэгээд түүнийг л хэлэх гэж байгаа юм байна л даа. Гэтэл энэ чинь цаашдаа баримтлах бодлогын урт хугацааны баримт бичиг. Тэгэхээр чинь нөхөн сэргээлтгүй үлдээх гэсэн боломжийг үлдээгээд байна шүү дээ. Тэгж байгаа биз дээ, урт хугацааны баримт бичиг мөртлөө. Одоогийн байдлыг засах гэсэн тийм л юм хийчихээд, тэгсэн мөртлөө урт хугацаанд хаашаа юм бэ? Үүнийг чинь хүн уншвал 2050 онд уншъя гэж бодъё, 2024, 2025 онд, тэгэхээр чинь ингэж ойлгогдох нь байна шүү дээ, тийм биз дээ. Өөрөөр хэлбэл нөхөн сэргээлтгүйгээр үлдээж болох юм байна гэж, тийм логик гараад байна шүү дээ наана чинь.

**Б.Гарамгайбаатар:** Санал хураалтаа явуулчихъя, тэгээд дэмжих, дэмжихгүй нь гишүүдийн асуудал. *“3.6.5.уурхайн эвдрэлд орсон талбайг бүртгэлжцүлж, өмнө нь нөхөн сэргээлтгүй орхисон талбайг нөхөн сэргээх ажлыг гадаадын болон дотоодын санхүүгийн эх үүсвэрээр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;”* Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 14-өөс 0. Дэмжигдсэнгүй.

**С.Одонтуяа:** Тэгэхээр хуучнаараа үлдэнэ. Хуучин нь бол бүр дордсон л байхгүй юу.

**Я.Содбаатар:** Энэ бол ийм л зүйл. Нэгдүгээрт, мэргэжлийн аж ахуйн нэгжээр энэ нөхөн сэргээлтийг хийхгүй бол одоо нөхөн сэргээлт нэрээр зүгээр аж ахуйн нэгжүүд аваад алт ухаад байгаа юм. Тэгэхээр мэргэжлийн нөхөн сэргээлт хийдэг, байгаль орчноос зөвшөөрлөө авсан, нөхөн сэргээлтийн тодорхой тийм байгууллагыг нэгдүгээрт оруулъя гэж. Хоёрдугаарт, энэ

уурхайн эвдрэлд орсон талбайнууд Монгол Улсад олон байгаа. 100 жилийн өмнө хийсэн Бороо гоульд хайсан мөнгөн усыг одоо бид нар Байгаль орчны яаман дээр төсөл гаргаад Европоос мөнгө аваад янзалж байгаа. Тэгэхээр энэ чинь өөрөө ганц бид нар өнөө маргаашийн хоёр, гуравхан юм биш байгаа юм. Дэмбэрэл даргын нэг санааг би тэнд оруулах нь зүйтэй байх гэж бодож байна. Тэр нь одоо яг өнөөдөр үүсчихсэн, өнөөдрөөс цааш биш шүү, үүгээр энэ бодлого гарснаас цаашихыг нь биш, түүнээс өмнө үүссэн Монголд уул уурхай хөгжсөн 100 гаруй жилийн түүхийн юмнууд бүгд үлдчихээд байгаа маш их юм байгаа. Тэгэхээр энэ юмыг бид нар оруулах нь зайлшгүй. Хоёрт нь, үүний дотор байгаа гол агуулга нь мэргэжлийн байгууллага гүйцэтгэхгүй бол одоо нөхөн сэргээлт нэрээр хувийн зүгээр компани ороод алт ухаад байгаа юм, үүнийг болиулъя гэдэг ийм хоёр санаа.

**С.Дэмбэрэл:** Тэгвэл энэ чинь ийм л юм байна шүү дээ. Уурхайн эвдрэлд орсон талбайг бүртгэлжүүлэх, нөхөн сэргээх ажлыг гадаадын болон дотоодын санхүүгийн эх үүсвэрээр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ гэсэн л санаа юм. Тэр өмнө нь яасан байна, тэр нь ямар хамаа байна. Тэртэй тэргүй л нөхөн сэргээхийг мэргэжлийн байгууллага хийх юм байна шүү дээ. Өмнө нь нэг компаниуд орхичихсон юм байна, тэр чинь хууль ёсныхоо дагуу, тэр чинь хуулийн дагуу явах ёстой зүйлүүд. Энэ дээр гол санаа нь мэргэжлийн байгууллагаар л гүйцэтгүүлье гэж байгаа юм байна.

**Б.Гарамгайбаатар:** Санал хураагаад дэмжлэг авсангүй шүү дээ, сая. Тийм учраас дараагийн хэлэлцүүлгээр тэгвэл нөхөж оруулж ирье, хуучин нь байж л байгаа юм чинь. Цааш нь үргэлжлүүлье.

**52.Төслийн 3.6.1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулж, 3.7.3 дахь заалт болгох:** *“3.7.3.төрийн өмчийн оролцоотой уул уурхайн аж ахуйн нэгжийн удирдлагыг мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн оролцоотойгоор сонгон шалгаруулах, компанийн худалдан авалт, борлуулалт болон үйл ажиллагаанд ил тод байдлыг бүрдүүлэх байдлаар компанийн сайн засаглалыг сайжруулах, төслүүдийн хангамж, худалдан авалтыг үндэсний аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэхийг дэмжих;”* Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 14-9. Энэ чинь компаний засаглал, компаний тухай хууль бүгд байгаа шүү дээ.

**Я.Содбаатар:** Наадах чинь нэг л ойлгомжгүй юм болчихлоо. Юун иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгжийн холбоо болчихов оо. Мэргэжлийн холбоо гэдэг чинь иргэний нийгмийн байгууллага.

**С.Дэмбэрэл:** Төрийн өмчийн оролцоотой уул уурхайн аж ахуйн нэгжүүд чинь одоо хуулиар бол нөгөө хараат бус гишүүд л гэж байгаа шүү дээ. Хараат бус гишүүдийг л гэж байгаа. Хараат бус гишүүд байхгүй юу. Хоёрдугаарх нь юу вэ гэхээр, нэг их илүү дутуу өгүүлбэр байна шүү дээ. Худалдан авалт, борлуулалт, үйл ажиллагаа. Зүгээр л сайн засаглалыг л гэхихье. Энэ дээрээ найруулгын алдааг нь л харчихъя л даа. Сайн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэх гээд л явчихъя л даа. Заавал дахиад л анхных. Тэгээд нөгөө анхны хувилбар нь хөгийн юм байдаг. Тэгээд товчлоод, илүү дутуу үгнүүдийг хасъя. Борлуулалтыг нь яах гэсэн юм бэ? Бас хасъя.

**Б.Гарамгайбаатар:** Төрийн өмчийн оролцоотой уул уурхайн аж ахуйн нэгжийн удирдлага, менежментийг сонгон шалгаруулахдаа ил тод байдлыг бүрдүүлэх байдлаар Компаний сайн засаглалын зарчмыг баримтлах.

**С.Дэмбэрэл:** Түүнээс гадна төрийн өмчийн оролцоотой гэдэг чинь жишээлбэл, 34.60 хэд гэхэд хувийн жишээлбэл компани байлаа гэхэд хувийн компаний эрх ашгийг үүгээр чинь зөрчөөд байна. Төрийн өмчийн компаниудыг л гэж оруулбал оруул. Төрийн өмчийн оролцоотой гэвэл наадах чинь 10 хувь, 20 хувь, 30 хувь, үлдсэн 70 хувь дээрх тэр эрх ашгийн



юмыг яагаад энд тэгээд шууд үүгээр ингэж зааж өгч байгаа юм. Тэр чинь компаниуд өөрснөө төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчид өөрснөө шийдэх, сайн засаглалынхаа асуудлыг өөрснөө шийдэх. Төр бол өөрийнхөө өмчийг л мэднэ. Хувийн өмчийг мэдэх ёсгүй. Төрийн өмчийн оролцоотой гэхивэл цаана нь хувийн өмч байна гэсэн үг. Тийм байж болохгүй. Тийм учраас төрийн өмчийн гэж.

**Б.Гарамгайбаатар:** Дахиад уншъя. Төрийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгжийн удирдлага, менежментийг сонгон шалгаруулахдаа Компаний сайн засаглалын зарчмыг баримтлах гэж өөрчлөх юм байна. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. Тэгж өөрчиллөө шүү, тэмдэглээд аваарай. Санал хураая. 14-өөс 10.

**53.Төслийн 3.6.2** дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулж, 3.7.4 дэх заалт болгох: *“3.7.4.төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн удирдлагын чадвар, хариуцлагыг эдийн засаг, санхүү, ашигт ажиллагааны түвшин, бүтээмж, зэрэг голлох үзүүлэлтээр тогтмол хугацаанд дүгнэж, нийтэд мэдээлэх замаар тэдний хариуцлага, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;”*

**С.Дэмбэрэл:** Энэ одоо дэндлээ. Энэ чинь Төрийн өмчийн хорооны одоо хэрэгжүүлж байгаа дунд хугацааны хөтөлбөрөөс тэр чигээр нь аваачиж, юу ярьж байгаа юм бэ, бид нар чинь өнөөдөр. Энэ огт хамаагүй заалт, хас. Бид өмнө батлахдаа төр бол лиценз, бүртгэх бүртгэлд оролцоно, ийм юманд оролцохгүй хязгаарлана гэж хэлчихээд, одоо түүнийгээ бүр зөрчөөд, өө ингэнэ, тэгнэ гээд ийм заалт хийж өгөөд байна шүү дээ. Төрийн өмчийн хорооны л хийдэг ажил шүү дээ. Үүнийг хасах хэрэгтэй, тэр чигээр нь.

**С.Одонтуяа:** Одоо стратегийн ач холбогдол бүхий ордуудад төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд байгаа л даа. Тэд нараа яах вэ л гэж байгаа юм. Эрдэнэт, Таван толгой.

**С.Дэмбэрэл:** Тэд нар яах юм. Хэлэлцэнэ шүү дээ, паблик /public/ компани болгоно гээд үе шаттайгаар хэлчихсэн байгаа.

**Л.Энх-Амгалан:** Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөх үе шаттайгаар хэрэгжүүлнэ гээд заачихсан шүү дээ.

**С.Одонтуяа:** Тэгвэл удирдлагын чадвар, хариуцлагыг дээшлүүлнэ гээд оруулчихъя.

**С.Дэмбэрэл:** Сайн засаглалд орчихсон шүү дээ.

**С.Одонтуяа:** Анх орж ирсэнтэй нь шууд хасчихъя. Үндсэн төслөөс хасъя.

**Б.Гарамгайбаатар:** 3.6.2 дахь заалтыг өргөн барьсан төслөөс ч хасаж байгаа юм байна.

Өргөн барьсан төслөөс 3.6.2 дахь заалтыг хасъя гэсэн саналаар санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 14-өөс 10.

**54.Төслийн 3.6.3** дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулж, 3.7.5 дахь заалт болгох:

*“3.7.5.эрдэс баялгийн салбарын үйлдвэрлэлээс улсын төсөвт төвлөрсөн орлогын тодорхой хэсгээр зорилтот санг байгуулан эдийн засгийг төрөлжүүлэн, экспортын чиглэлийн үйлдвэрийг дэмжих, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг хангах, үндэсний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;”*

**С.Дэмбэрэл:** Энэ чинь Засгийн газрын мөрийн хөтөлбөрт байдаг заалт. Уул уурхайн салбараас орж ирсэн орлогоо уул уурхайн бус экспортыг дэмжих гэсэн тийм утгатай заалт Засгийн газрын мөрийн хөтөлбөрт байж

байгаа, тэр утгаараа орж ирсэн байна. Тийм учраас үүнийг дэмжиж байна. Одоо аль нэг яамны мэдлийн сан гэж байхгүй. Энэ бол баялгийн сангийн тухай асуудал биш. Энэ бол Засгийн газрын мөрийн хөтөлбөрт байгаа уул уурхайн экспортын орлогоос уул уурхайн бус экспортыг дэмжих гэсэн заалтыг хэрэгжүүлж байгаа юм. Ийм учраас энэ зөв заалт. Үүнийг ажлын хэсгийн оруулж ирснээр нь л батлах хэрэгтэй байх. Саналаа л авчихъя л даа.

**Б.Гарамгайбаатар:** Санал хураалгая. Гэхдээ энэ чуулган дээр энэ хэсэг унана шүү. 54-ийг дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 14-өөс 8. Дэмжигдлээ.

**63.Төслийн 4.1.1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулах:**

*“4.1.1.төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын хүрээнд бие даан хөгжих боломж бүхий ашигт малтмалын чиглэл бүрээр “Зэс”, “Нүцрс”, “Төмөр”, “Газрын ховор элемент”, “Хайлуур жонш”, “Барилгын ашигт малтмал” зэрэг, тухайлсан асуудал бүрээр “Улсын геологийн зураглал”, “Эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчин” зэрэг хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.”*

**С.Дэмбэрэл:** Жинхэнэ жонхуу гэж үүнийг хэлж байгаа юм. Нэг хэсэг нь бие даан хөгждөг юм байна, нөгөө хэсэг нь хөгждөггүй юм байна, монголоор үүнийг нэгдүгээрт унших юм бол. Тийм учраас үүнийгээ хас. Хоёрдугаарт, ингэж нэрлэх ямар ч шаардлагагүй. Энэ чинь зорилтот хөтөлбөрүүд гэсэн үг. Тэгээд зорилтот хөтөлбөрүүд гээд явчихъя.

**С.Одонтуяа:** Ашигт малтмалын асуудлаар хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

**Б.Гарамгайбаатар:** 63 дугаар заалт. Төслийн 4.1.1-ийг үндсэн болоод оруулж ирж байгаа төслөөс бүрэн хасъя гэсэн саналаар санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 14-өөс 10.

## **Хэрэлдэхийн оронд бодитой зүйл хийвэл жижиг эдийн засаг маань дорхноо л сэргэнэ**

*“Улстөрийн тойм”-ын сурвалжлагч, УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлийг “Ярилцах танхим”-даа урьж ярилцсан ярилцлагыг уншигч та бүхэндээ хүргэж байна.*

**- Чуулган байнгын хорооны хуралдаанаар Ногоон хөгжлийн үзэл баримтлалын эцсийн хэлэлцүүлгийг хийж байгаа. Гол үзэл санаа нь юу вэ?**

**С.Дэмбэрэл:** - Саяхан би санаачлаад А.Бакей нарын зарим гишүүдтэй хамт агаарын бохирдлын талаар ганцхан өгүүлбэртэй хуулийн нэмэлт санаачилсан. Засгийн газрын тухай хуулинд зөвхөн Байгаль орчин, ногоон хөгжлийн яам бус бүх яам эрхэлсэн ажлынхаа хүрээнд агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа явуулна гэсэн заалт оруулсан. Агаарын бохирдлыг үгүй хийх нь төрийн бүх яамны асуудал байх ёстой. Одоо ногоон хөгжлийн үзэл баримтлал, бодлогыг бүтэн нэг жилийн турш хэлэлцэж байж батлах гэж байна. Энэ бол Монгол Улс хөгжлийн цоо шинэ замыг сонгож байгаагийн нэг хэлбэр.

**- Ногоон хөгжлийн асуудлыг одоо л ярьж байгаа юм биш. Таны удирддаг МҮХАҮТ ч энэ талаар ярьдаг л байсан. Яриад л байдаг. Монголд эдийн засаг нь “ногоорсон” газар, салбар байна уу?**

**С.Дэмбэрэл:** - Одоогоор ногоорчихсон юм алга. Гэхдээ энэ үзэл санаа аль хэдийнэ түгсэн. Ногоон хөгжил, бизнес, тогтвортой хөгжил гээд хэдэн жилийн өмнөөс ярьж эхэлсэн. Төрийн бодлогод анх удаа сууж байгаа нь энэ. Урьд нь ихэвчлэн байгаль орчин гэдэг утгаар нь ярьж байсан бол одоо хөгжлийн бодлогыг түлхүү ярьж байгаа. Зөвхөн уул уурхайгаа түшиж амьдрах биш байгалийнхаа заяасан нөөц баялгийг хамгийн үр ашигтай, эргээд байгалийг “гомдоохгүй” ашиглах, хүн хүч, технологи, капитал, энэ бүхнийг нэгтгэсэн цогц үйл ажиллагааг Монгол Улсад бий болгох, ингэхийн тулд хууль тогтоогчид нь энэ чиглэлийн асуудлыг улсын хөгжлийн бодлогод байнга тусгаж явах гэсэн агуулгаар ногоон хөгжлийн бодлого батлагдаж байна. ДНБ аль болох ногоон байх, хөрөнгө оруулалт, хэрэглээ, хуримтлал үүсгэх зэргээр байгалаас авч байгаа үйлчилгээ, баялгийг хамгийн үр ашигтайгаар ашиглаж, хойч үеийнхээ эрх ашгийг хохироохгүйгээр өнөө үеийнхэн хөгжих асуудлыг цогцоор нь бий болгодог, одоо хүн төрөлхтний замнаж байгаа замыг ерөнхийдөө ногоон хөгжил гэж нэрлэж байгаа юм. Хөгжлийн урт хугацааны үзэл баримтлал байхгүй гэж яриад байгаа. Мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн бодлого гэж бий. УИХ-ын захирамжаар бүх намын төлөөлөл үндэсний хөгжлийн стратегийг боловсруулах гээд явж байна. Тэр бүхэнд ногоон хөгжлийн үзэл баримтлал гол суурь нь болох учиртай. Тиймээс зарчмын бараг түүхэн гэж хэлж болмоор тийм л баримт бичиг батлагдах гэж байгаа гэж хэлэх байна.

**- Одоо Монгол Улс ямар эдийн засагтай байна вэ. Хүрэн гэж ярьдаг байх аа?**

**С.Дэмбэрэл:** - Тийм. Хүрэн эдийн засагтай орон. Энэ нь байгаа бүх нөөц баялгийг дээд зэргээр, бүх бололцоогоороо үр ашиггүй ашигладаг бүтэц. Эхлээд уул уурхайгаа хөгжүүлэе. Дараа нь байгалаа нөхөн сэргээе, цэвэрлэе гэдэг зарчим баримталдаг. Тодорхой технологи орж ирэхэд их хэмээний ус, эрчим хүч ашигладаг. Үр ашгийг чухалд тооцсон, байгаль орчинд халтай тийм л бодлогыг баримталдаг юм. Харин бүх нөөц баялгийг байгаль орчинд хамгийн үр ашигтайгаар, ээлтэйгээр ашигладаг капитал, хүн, технологи энэ бүхний хосолсон үйл ажиллагааг агуулсан бодлогыг бид ногоон хөгжлийн бодлогоор гаргаж ирсэн. Маш олон цоо шинэ ойлголт ч гарч ирж байгаа. Жишээлбэл, эко систем гэж юу вэ. Ногоон аж үйлдвэр, ногоон татвар, худалдан авалт гэж юу гэх мэт. Дээр нь 2020 он гэхэд эрчим хүчний үр ашгийг дээшлүүл гэх мэт тодорхой зорилтуудтай. Үүнд хүрэх санхүүгийн арга механизмыг заачихсан. Жишээлбэл, Засгийн газрын худалдан авалдыг 5-6 жилийн дараа 20 хувьд хүргэх гэх мэт том том зорилт тавьсан. Энэ мэтээр Монгол Улсын ирээдүйн хөгжлийг маш тодорхой заасан. Үүн дээр суурилоод, эдийн засаг, нийгэм, байгаль орчин гурваа хослуулаад Монгол Улсын тогтвортой хөгжлийн урт хугацааны зорилт бэлэн болно. Ийм л ач холбогдолтой бодлого баталж байна.

**- Дагалдах хуулиудыг бас батлах ёстой юу?**

**С.Дэмбэрэл:** -Хамгийн эхэнд Засгийн газар асар том төлөвлөгөө гаргах ёстой. Тэрийг нь жил болгон баталдаг нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, бодлогын баримт бичигтээ тусгах талаар заагаад өгчихсөн. Улмаар 2014 оноос цааш 2020 он хүртэл монголчуудын ерийн сэтгэлгээ, зөвхөн уул уурхайд дулдуйдсан сэтгэлгээ, байгаль орчинд мөнх юм шиг ирээдүйгээ боддоггүй сэтгэлгээнд өөрчлөлт

орж эхэлнэ. Гэхдээ энийг лоозогнох замаар биш санхүүгийн эх үүсвэртэй, тодорхой зорилттой, эдийн засгийн хөшүүрэгтэйгээр хөгжүүлэхийг суулгаад өгчихсөн. Энэ дээр суурилад Засгийн газар төлөвлөгөө гаргаж шаардлагатай хуулийн өөрчлөлтийг хийж эхэлнэ. Цаашдаа иймэрхүү ажил хийгдэнэ.

**- Эдийн засгийг идэвхжүүлэх тогтоолын үр дүн хэзээнээс мэдрэгдэж эхлэх бол. Одоо бол уналтад орсон, цнэ нэмэгдсэн, цүд хаалгаа барьсан гэж мэдээлэл ар араасаа гарсаар байна?**

**С.Дэмбэрэл :** - Эдийн засгийг идэвхжүүлэх тогтоолд заасан үг, үсэг, өгүүлбэр бүрийг хэрэгжүүлж, эдийн засгийн өмнө нь сайн ашиглаж байгаагүй нөөц бололцоог ашиглах замаар бодлогын өөрчлөлтөөр татварын шинэчлэлт хийх хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл татварын хэмжээг багасгаж, татвар төлөлтийн суурь хэмжээг ихэсгэж, хүн бүр бага хэмжээний татвараа бүрэн төлдөг, дээр нь эдийн засгийн өршөөлийг төлдгүүд нь хохирохгүйгээр үзүүлж, ямар нэг шалтгаанаар төлөөгүй нуугдсан хэсэг нь ил гарч, далд эдийн засаг эгэл хэлбэрт орох шаардлага ч байна. Дээр нь бизнесийн орчныг гадаад, дотоод хөрөнгө оруулалт гэж ялгалгүйгээр хүнд сурталгүй, ойлгомжтой, тогтвортой болгоод өгчихвөл заавал бонд авна гэлтгүйгээр Монгол Улсын эдийн засаг сэргэх боломж байна. Үүний тулд эдийн засгийг сэргээх хүч юу вэ гэдгийг тооцоолох ёстой.

**- Одоо буруу ажиллаад байна уу?**

**С.Дэмбэрэл:** - Том том төсөл хэрэгжүүлээд тэрэндээ зориулж бонд гаргаад байвал хэцүү. Монголын уул уурхайн бүтээгдэхүүний дэлхийн ханшийг горьдон харж, хүлээж байна. Гэтэл далд байгаа эдийн засгийнхаа нөөцийг ашиглаж, бүх бизнес эрхлэгчдэд засгаас явуулж байгаа бодлого эерэг тусгаад эхэлбэл оны эцэс гэхэд эдийн засгийг идэвхжүүлэх арга хэмжээний үр дүн гарч эхэлнэ. Энэ хооронд гадаад зах зээлийн байдал тогтворжоод сайн мэдээ дуулдаад эхлэх байх. Гэхдээ хүлээгээд сууж бол болохгүй. Энийг л хүлээгээд, бодлогоо чиглүүлээд, үүнд зориулт төсвөө тодотгоод яваад байвал урьд жилүүдэд явж байсан тэр жишиг рүү орно. Дэлхийн зах зээлийн байдал сайжрангуут аархаж, мөнгөө хамаагүй цацаад, муудангуут нь төсвөө танаж, сандралддаг цикл хэвээрээ л байна. Тийм учраас эдийн засгийг эдийн засгийг идэвхжүүлэх арга хэмжээний гол зүйл нь татварын шинэтгэл рүү чиглэх ёстой. Татварын орчноо шинэчлэх гэдэг нь одоо орж ирсэн хоёр хуулийг өөрчлөх асуудал огт биш. НӨАТ-ын босгыг өөрчлөх, эсвэл 90 хувийг буцааж олгох биш.

**- Чухам яаж шинэчилнэ гэж?**

**С.Дэмбэрэл:** - Татварын ерөнхий хуулийг өөрчлөхөөс авахуулаад, татвар төлөгч, төр хоёрын харьцааг тэнцвэртэй болгох, бие биенээ хүндэтгэдэг болгох, бүгд татвараа төлдөг, татвар төлөх үйл ажиллагаа нь дарамттай биш, явц нь хялбар, хүмүүсийн цаг, зардлыг хэмнэдэг байх чиглэлийн арга хэмжээг авах ёстой. Дээр нь жижиг, дунд бизнес, том аж ахуйн нэгжүүдийг тусад нь дэмжих, үнийн өсөлтөд нөлөөлж байгаа бичил, өрхийн бизнесийг дэмжих талаас нь төсөл арга хэмжээ авч болно. Валютын ханшийг тогтворжуулж ч болно. Үнийг зорилтот бүлэг, бичил бизнес эрхлэгчдийг идэвхжүүлэх замаар бууруулах боломж ч бий. Цалин, тэтгэвэр, тэтгэмжийг ч тодорхой хэмжээгээр нэмэх хэрэгтэй. Мөн хүн амын орлогын татвар, нийгэм, эрүүл мэндийн даатгалыг зарим хэсэгт нь тодорхой хугацаагаар тэглэж, зарим хэсэгт нь багасгаад өгчих. Ингэвэл хүмүүсийн гар дээр тодорхой хэмжээний бэлэн мөнгөний хуримтлал үүснэ ээ дээ. Энэ талаас нь бодож зах зээлийн эрэлт нийлүүлтийг аль аль талаас нь анхаарах хэрэгтэй. Нийлүүлэлт байлаа гээд эрэлтийг орхивол хүмүүсийн худалдан

авах чадвар нэгэнт муу учраас ямар ч ач холбогдолгүй. Энэ талаас бодож иж бүрэн бодлого хэрэгжүүлбэл Монголын эдийн засаг болно оо. Нэг их хүнд, 10 сая хүнтэй эдийн засаг биш шүү дээ. Ердөө 2.9 сая хүнтэй эдийн засаг. Нэг сая нь ажил хийдэг, нэг сая нь ажил хийдэггүй гээд бодоход хөдөлмөрийн чадвартай ажил хийдэг 800 мянгаад хүн байна. Хувийн хэвшилд нь 400-аад мянган хүн ажиллаж байна. Дээр нь тэтгэвэр, тэтгэмж авдаг хүмүүстээ чадах чинээгээрээ тусалж дэмжээд, хөдөлмөрлүүл. Ингээд явахад болно. Бичил, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тусгай сан байгуул. Ломбардны хүүг багасгах эдийн засгийг хөшүүрэг хэрэглэж болж байна. Эсвэл банк бус санхүүгийн байгууллагуудад жижиг, дунд бизнесүүдэд үйлчлэх санхүүжилтийг Засгийн газраас хийж, санхүүгийн секторт зээлийн хүүг бууруулах гэх мэт арга хэмжээг авч болно. Ингэвэл тодорхой үр дүн гарна.

**- Одоо бичил, жижиг, дунд салбарыг гэхээс илүү томоохон салбараа дэмжих тогтолцоогоор ажиллаж байгаа гэсэн шүцмжлэл бий?**

**С.Дэмбэрэл:** - Дэндүү том төсөл ярьж байгаа. Яах вэ, зам, гудамж сайхан уу сайхан. Дуртай шүү дээ. Аймгуудыг холбох зөв үү зөв. Жишиг сум байгуулах нь ч зөв. Гэхдээ бараа, бүтээгдэхүүний үнэ өндөр байна. Бичил, өрхийн бизнест санхүүгийн таатай нөхцөл алга, санхүүжилтийн таатай механизм байхгүй, хэцүү байна. Томоохон аж ахуйн нэгжүүдийг бүгдийг нь “цоллочихсон”. Уг нь тэд нийт татварын 90 хувийг төлдөг. Тэд татварын алба эсвэл шоронгийн хаалга татдаг байж болохгүй. Тиймээс зорилтот бүлэг бүрт чиглэсэн бодлогын болон санхүүгийн механизм бий болгоод өгчих. Нийт бизнесийн ихэнх нь сэтгэл хангалуун байвал эдийн засаг идэвхжинэ. Түүнээс бус зөвхөн барилга, зам гээд тус тусдаа яваад байвал хөгжихгүй. Бодлогын үр шимийг жигд хүртэхгүй, хоёр оронтой зээлийн хүүгээр үйлчлүүлдэг, олон шат дамжлагаар явж, олон хяналт шалгалтад өртдөг ч бизнес нь өсөхгүй, тэрүүхэн хавьдаа аргалаад яваад байвал яваад л байна. Гаднаас орж ирж байгаа бараа нь ч гэсэн өрсөлдөх чадваргүй. Учир нь бид бүгд импорт баба, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ гээд хэлчихсэн. Гэхдээ цагаан будааг өөрсдөө үйлдвэрлэж чадахгүй биз дээ. Тиймээс цагаан будаа оруулж ирдэг компани олон болог л дээ. Энэ эдийн засагт гадаад, дотоод хоёр суваг чөлөөтэй өрсөлдөж байх ёстой. Тийм учраас би гадаад худалдаанд их ач холбогдол өгдөг. Гадаад худалдаа ч гэсэн хөнгөвчлөлтэй байх ёстой. Олон сувгаар орж ирдэг байг. Энэ мэтээр Монголын эдийн засгийг том хар. Тодорхой бодлого хэрэгжүүл. Ингэх боломж байна. Хийнэ гэж бодож байна. Холбогдох бодлого нь хэрэгжиж эхэлсэн үү гэвэл эхэлсэн. Хоорондоо хэрэлдээд нэг нь ДНБ-ий өр яриад, нэг нь мөнгөгүй яаж явах юм бэ гээд яваад байсан. Ингэхийн оронд миний ярьсан шиг бодитой зүйл хийж, бодлогоо хэрэгжүүлбэл Монголын эдийн засаг сүртэй, том биш учраас амархан сэргэнэ дээ.

**- Аж ахуйн нэгжүүд хаалгаа барилаа, хэцүүдлээ гэж байна. МҮХАҮТ-аар дамжуулаад танд энэ талаарх мэдээлэл ирж байна уу?**

**С.Дэмбэрэл:** - Компаниуд валютын ханшийн эрсдэлийг тооцоолдог. Жилдээ мэдээж тодорхой хэмжээгээр хөдөлнө. Тэд ингэж бизнесийн төлөвлөгөөгөө хийдэг. Гэтэл тэр нь тооцоолоогүй, төсөөлж байгаагүй төвшинд очихоор тэд яах юм бэ. Өөрсдөөс нь биш валютын ханшийн огцом хөдөлгөөнөөс болоод санхүүгийн үйл ажиллагаанд нь хохирол учирч байгаа нь яалт ч үгүй болж байгаа үйл явдал. Шүүхэд хандах ч хэцүү тийм л байдалд орчихсон байгаа.



## **Ногоон хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөтөлбөрийн танилцуулга**

Монгол улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт “Ногоон хөгжлийн бодлогыг улс орны хөгжлийн тулгуур бодлогын нэг болгох”, ногоон хөгжлийн үндсийг бүрдүүлэн “Ногоон соёл иргэншил” үзэл баримтлал, хөтөлбөрийг боловсруулж, загваруудыг бий болгохоор заасан билээ.

Дэлхийн улс орнууд, Рио-де-Жанейро, Йоханнесбург болон Рио+20 даян дэлхийн тогтвортой хөгжлийн зарчим, үзэл баримтлал, тунхаглалыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл болгон “Ногоон хөгжил”-ийн замыг сонгохыг улс орнуудаас уриалж, “Бидний хүсч буй ирээдүй”-баримт бичгийг гаргаж, 2015 оноос дэлхий нийт Тогтвортой хөгжлийн зорилтуудыг шинэчлэн тодорхойлж хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн юм.

Энэхүү бодлогын чиглэл, зөвлөмжийн дагуу боловсруулсан “Ногоон соёл иргэншил” хөгжлийн үндэсний стратегийн төслийг 2013 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Эдийн засгийн хөгжлийн яамтай хамтран ажиллаж бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах үүрэг өгсөн билээ. Энэ хугацаанд Монгол Улсад Дэлхийн байгаль орчны өдрийн хүрээнд Ногоон хөгжлийн үндэсний чуулганаар тус баримт бичгийн төслийг хэлэлцүүлж, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, НҮБ-ын Ази Номхон Далайн эдийн засаг, нийгмийн комиссоос тодорхой санал, зөвлөмж авсан. Эдийн засгийн хөгжлийн яамны саналын дагуу уг баримт бичгийг Ногоон хөгжлийн үзэл баримтлал, Ногоон хөгжлийн дунд хугацааны хөтөлбөрийн төсөл гэсэн хоёр баримт бичиг болгон өөрчлөхдөө дээрх санал, зөвлөмжийг харгалзан тусгаж, Засгийн газарт оруулж байна.

Ногоон хөгжлийн бодлогыг улс орны хөгжлийн урт хугацааны бодлого, төлөвлөлтөд тусган хэрэгжүүлснээр байгалийн нөөц баялгийг илүү зохистой удирдан улсынхаа эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулахад гүйцэтгэх шууд болон шууд бус үр нөлөөг дээшлүүлнэ.

Ногоон хөгжлийн үзэл баримтлалд өнөөгийн нөхцөл байдал, боломж, давуу талд түшиглэсэн бодлогын зорилго, зорилтуудыг 2030 он хүртэл тодорхойлж, харин дунд хугацааны хөтөлбөрт эдгээр зорилтыг хангах зорилгоор 2020 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх бодлогын болон эдийн засгийн арга хэрэгслийг тодорхойлон тусгасан болно. Эдгээр арга хэмжээг манай орны нөхцөлд тохируулан тэргүүлэх ач холбогдолтой, богино хугацаанд эерэг үр дүнг авчрах, ажлын байр нэмэгдүүлэх, ашиглалтын зардал хэмнэлттэй байх арга хэмжээний чиглэлийг тодорхойлон тусгалаа.

Засгийн газраас хууль эрх зүйн зохицуулалт, санхүүгийн арга хэрэгслийг шинээр гаргах, зах зээлийг шинэчлэхэд нөлөөлөх замаар салбаруудын байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл хөгжлийн хандлагыг тогтвортой болгох боломжтой байна. Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд ногоон хөгжлийн үзэл баримтлалыг эдийн засгийн салбаруудын бодлого, хөтөлбөрүүдэд тусган хөрөнгө оруулалтыг чиглүүлэн хэрэгжүүлнэ. Түүнчлэн орон нутагт төсвийн удирдлага, төлөвлөлтийн бодлогыг ногоон хөгжил рүү чиглүүлэхэд энэхүү дунд хугацааны хөтөлбөр удирдамж

болох ач холбогдолтой юм. Байгаль орчин болон нийгэм, эдийн засгийн харилцан бие биенээсээ хамааралтай болохыг санхүүгийн болон хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тооцоолдог байх нь ногоон хөгжлийн бодлогын нэг чухал асуудал юм. Байгалийн баялгийн ашиглалтад тулгуурлан эдийн засгийн өндөр өсөлтийг бүрдүүлсэн боловч өнгөрсөн хугацаанд байгальд эргүүлээд зарцуулсан хөрөнгө оруулалт хэтэрхий бага байсан хандлагыг өөрчлөн:

- Байгаль орчинд халтай бараа, үйлчилгээний үйлдвэрлэл, хэрэглээг бууруулах зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгох;

- Байгалийн нөөц, орчныг доройтуулж хомсдуулах чиглэлд Засгийн газрын хөрөнгө, зардлыг хязгаарлах;

- Байгаль хамгаалал, цэвэр технологи, хүний хөгжилд хөрөнгө оруулалт, санхүүжилтийг нэмэгдүүлэн, ногоон эдийн засгийг дэмжих эрх зүйн зохицуулалт, санхүүгийн хөшүүргийг бүрдүүлэх зорилт, чиглэлийг тусгалаа.

**Ногоон хөгжлийн үзэл баримтлал нь нийгмийн ядуурлыг бууруулах хүний аж байдлыг сайжруулах асуудлыг хөгжлийн гол цөм болгон хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах, хөгжлийн шийдвэр гаргахад оролцох, үзэл бодлоо илэрхийлэх, шударга ёсны эрхийг хангах зарчмыг хэрэгжүүлэхэд ихээхэн үүрэгтэй.** Байгалийн нөөцөөс хамааралтай амьдардаг нутгийн иргэдийн байгалийн нөөц баялгийг хамгаалах үүрэг, үр өгөөжийг хүртэх эрхийг тодорхой болгохын хамт нийгмийн хамгааллын суурийг өргөжүүлснээр хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжилт, хөдөлгөөнийг зогсоох, байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хямралыг даван гарах чадварыг бий болгодог байна.

Иргэдийн өргөн хэрэглээний хүнс, бараа, бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын түүхий эд, нөөцийг боловсруулах үндэсний үйлдвэрлэлээр хангах ашигт малтмалын бус эдийн засгийн салбарыг төрөлжүүлэн хөгжүүлж, ус хангамж, ариун цэврийн болон байгальд халгүй эрчим хүч, зам тээвэр, барилга зэрэг дэд бүтцийн хангамжийг эрс сайжруулснаар нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэх хөгжлийн зорилт, бодлогын чиглэлийг тусгаж байна. Эрчим хүчийг хэмнэх, сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, байгальд ээлтэй хөдөө аж ахуйг хөгжүүлснээр ногоон эдийн засагт шилжих ажлын байрыг нэмэгдүүлэх боломжтой. Энэ нь иргэдийн хүнсний хангамжийн аюулгүй байдлыг хангах, боловсрол, ур чадвараа дээшлүүлэн амьдралын чанараа сайжруулах ижил тэгш боломжийг бүрдүүлнэ. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангахад чиглэсэн газар төлөвлөлт, хот суурингийн хөгжлийн ногоон төлөвлөлтийн зарчмыг хэрэгжүүлэх, үндэсний байгаль, соёлын өв газар нутгийг тогтоон ногоон хөгжлийг дэмжих бүс нутаг болгон хөгжүүлэх, нүүдлийн уламжлалт соёл заншлын давуу талыг ашиглан хөгжүүлэхэд чиглэсэн бүс нутгийн хөгжлийн бодлогоор энэхүү үзэл баримтлал, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Энэхүү үзэл баримтлал хөтөлбөрийг баталснаар гадаад, дотоодын хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг тогтвортой хөгжилд хүрэх нэгдсэн стратеги, зорилтын хүрээнд үр өгөөжтэй зарцуулах боломжтой бөгөөд салбар дундын бодлогын уялдааг ханган ногоон хөгжлийн үндсийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Түүнчлэн Ази, Номхон далайн бүс нутагт эдийн засгийн ногоон өсөлтийн хөтөлбөрийг дэмжин олон улсын хамтын ажиллагаанд идэвхитэй хамтран ажиллах боломж улам өргөжинө гэж үзэж байна.

***УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 1 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс: “Ногоон хөгжлийг дэмжих жил-ийг батлах тухай***

**Байнгын хороон дарга Г.Баярсайхан:** 2013 оныг “Ногоон хөгжлийг дэмжих жил” болгон зарлах санал байгаа юм. Хийх ажлын жагсаалтыг батлах уу? Энэ саналыг манай Их Хуралд байдаг Ногоон бүлгийн дарга С.Дэмбэрэл гишүүн санаачилсан юм. Та бүхний гар дээр 2013 онд хийх ажлын төлөвлөгөө байна. Би хувьдаа энэ зөв зүйтэй зүйл санаачилсан байна. Энэ хийгдээд явах асуудал. Энэ бол Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орсон асуудал дийлэнх нь байгаа. Үүнийг ажил хэрэг болгохын тулд Байнгын хорооноос ямар ч тохиолдолд арга хэмжээ авч, төлөвлөгөөгөө батлах юм байна. Санал хэлэх гишүүд байвал саналаа хэлчих. Би бол саналгүйгээр дэмжээд явмаар байна. Их чухал асуудлууд байна.

**С.Дэмбэрэл:** Ерөнхийдөө Байнгын хороодын дундаас анх удаа ингээд тодорхой бодлогын асуудлыг дэмжих жил болгоод зарлаж байгаа анхны тохиолдолд тийм учраас Ногоон хөгжлийг дэмжих жил гээд. Яагаад гэвэл Байгаль орчны яам энэ жилийг экологийн боловсролыг дэмжих жил гээд зарласан байгаа. Гэтэл одоо хэдийгээр Засгийн газрын бүтцэд Ногоон хөгжлийн институци байгуулагдсан ч гэсэн хуулиараа хэдийгээр энэ салбар хоорондын зохицуулалт хийх байсан ч гэсэн энэ дээр Улсын Их Хурлын яг энэ асуудлыг хариуцдаг Байнгын хорооноос бодлогын дэмжлэг их шаардлагатай гэдэг нь сүүлийн үйл явц, бодлогын хэрэгжилтийн үйл явцыг харж байхад ажиглагдаад байсан, нэг талаас.

Нөгөө талаас бол ерөөсөө энэ дээр оруулсан зүйлүүд нь Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орсон ч юм байгаа, бас ороогүй ч юм байгаа. Ороогүй гэдэг нь нөгөө Их Хурлаас цаашаа энэ чиглэлүүдээр гаргах хууль, тогтоомж тэгээд бодлогын баримт бичгүүд дээр энэ гол толгой Байнгын хорооноос системтэй ингэж оруулж өгөхгүй, одоогийн байдлаар жишээлбэл, ганцхан байгаль орчноо анхаараад, ногоон хөгжлийнхөө асуудлыг ганцхан яаманд орхичихоод, Эдийн засгийн хөгжлийн яаманд бас байдаггүй, бусад холбогдох яамдуудад байхгүй байна. Жишээлбэл, энд ногоон худалдан авалт гээд орчихсон байгаа, нэг ажил. Гэтэл өнөөдөр ногоон худалдан авалтыг энэ хорооноос ногоон худалдан авалт гэдэг талаас нь зохицуулж, дэмжиж, бодлогын хувьд чиглэл өгөхгүй бол яг тэр ногоон худалдан авалтыг нэг газар нь хэрэгжүүлээд явна гэхэд бас их хэцүү байна.

Тийм учраас иймэрхүү 18 заалт бүхий төлөвлөгөө боловсруулаад, Байнгын хорооныхоо даргаас даалгавар аваад, 14 хоногийн өмнө. Тэгээд үүнийг хүмүүстэй нэлээн зөвлөж байгаад хийсэн ийм төлөвлөгөө оруулж ирсэн юм.

**Г.Баярсайхан:** Бат-Эрдэнэ гишүүн саналаа хэлчих.

**Б.Бат-Эрдэнэ:** С.Дэмбэрэл гишүүний санаачлагыг бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Энэ бол зөв зүйтэй байна. Манай Байнгын хороо дэмжээд, албан бус бүлэг өмнөх Парламентын хугацаанд нь ч гэсэн ажиллаж байсан, бид

бас тодорхой ажлууд хийсэн. Тийм учраас бүрэн дүүрэн дэмжиж байна гэдгийг хэлье.

*Хоёрдугаарт*, Бид нар хүрэн эдийн засгаас ногоон эдийн засаг руу шилжих, тэгээд ногоон хөгжлийн тухай асуудал дэвшүүлэхэд хамгийн гол чухал юм бол газар улс оршихуйн үндэс гэдэгтэй адилхан энэ бүх юмны чинь эх үндэс нь бид нарын баталсан экологийн хууль, урт нэртэй гэж нэрлэгддэг. Энэ хуулийн талаар нэлээн дорвитой ажил болгож, үр дүнд хүргэхийн төлөө бид хамтарч ажилламаар байгаа юм. Тийм учраас энэ ажлын төлөвлөгөөн дээр сайхан билэг дэмбэрэлтэй тоо байна. 18-ыг 19 болгоод оруулах бололцоо байна уу гэсэн ийм саналыг хэлмээр байна.

**Г.Баярсайхан:** Энэ асуудлыг дэмжье.С. Дэмбэрэл гишүүн ээ, Б.Бат-Эрдэнэ гишүүний 19 дүгээр зүйлд нь Гол усны хуулийн хэрэгжилтийг түргэтгэх асуудал орж байгаа юм байна шүү. Та үүнийг улам дэлгэрүүлээд ажил хэрэг болгоод яваарай. Дэмжигдлээ гэж ойлголоо. 10-аас 9.

**Х.Болорчулуун:** Цагаан хэрэг шиг ногоон хэрэм говийн урдуур татах хөтөлбөр байсан. Тэр бол будаа болсон. Эдийн засгийн хөшүүргийг хэрэглэхгүйгээр энэ ногоон хувьсгал явагдахгүй. Ногоон худалдан авалт гэж хувийн хэвшлийнхэн мод тариад, бойжуулаад, хятад бол тэгж эдийн засгийн хөшүүрэг хэрэглэсэн шүү дээ. 1000 мод тариад, модных нь тоогоор улсаас бойжуулсан хойно нь, эрийн цээнд хүрсэн хойно нь мөнгө өгдөг. Ногоон худалдан авалт гэж үүнийг хэлж байна уу?

**С.Дэмбэрэл:** Төсвийн хөрөнгө оруулалт, бараа үйлчилгээг худалдан авах тухай нийт тендерийн тодорхой сайдын багц нь 100 хувь байлаа гэхэд зайлшгүй 20 хувийг нь ч юм уу? 10 хувийг нь зайлшгүй ногоон худалдан авалт руу чиглүүлж байдаг ийм олон улсын туршлага байна. Тийм учраас үүнийг хэлж байгаа юм. Тэгэхдээ чиний хэлээд байгаа зүйл чинь бас зөв л дөө. Эдийн засгийн хөшүүрэг байхгүй. Энэ ямар нэгэн юманд нь оруулаад хийчихэж болно л доо.

**Х.Болорчулуун:** Дорнодын цаадах Өвөрмонголын хошуу гэхэд ингээд ногоон болгочихдог яг эдийн засгийн хөшүүргээр, талыг нь ногоон болгочихсон. Бид нар ойн хуучин 8 хувьтай байсан, одоо бүр бага болчихсон, тэгэхээр ийм хөшүүрэг зайлшгүй хэрэгтэй байхгүй юу? Энэ хууль тогтоомжид, цаашдаа анхаарах ёстой.

**Г.Баярсайхан:** Анхааралдаа авъя. Чухал санаа хэллээ. Байнгын хорооны хурал хаагдсаныг мэдэгдье.

**ГУРАВ. Дээлийн чинээ нутагтаа, дэлхийн дайтай  
сэтгэх нь Олон улсын худалдаа, эдийн засаг,  
гадаад харилцааны менежмент**

**Монголын эдийн засгийн өнөөгийн байдал**

*Самбуугийн ДЭМБЭРЭЛ. 1991 онд.*

Монголын эдийн засгийн хямралт байдлын уг сурвалжийг захиран тушаах эдийн засгийн хуурамч таваарын аж ахуйн бүтцийн болон түүнээс урган гарсан мөнгө, санхүү, зээлийн тэнцвэрт бус харьцаа, өртөйгээр хөгжих үзэл баримтлалыг буруу хэрэгжүүлсэн болхи хувилбар, ганц орноос хэт хамааралт байдалд хүргэсэн бодлого механизмаас эрж хайхыг эдийн засгийн өнөөгийн бодит байдал шаардаж байна.

1980 - 1989 онд нийгмийн үйлдвэрлэлийн хэмжээг үндэсний нийт бүтээгдэхүүний үзүүлэлтээр тооцоход 1980 онд 6755,1 сая төгрөг, 1985 онд 9371,9 сая төгрөг болсон буюу 38,7 хувь өсчээ. 1980 оныг 1989 онтой харьцуулахад 14,5 хувиар буюу 1980-1989 онуудад жилд дунджаар 3,6 хувийн өсөлттэй байсан байна. Улсын төсвөөр дамжсан хөрөнгө оруулалт 1980-1985 онд 43,6 хувь, 1985-1989 онд 74,2 хувиар тус тус нэмэгдэж, түрүүлэлтийн коэффициент /хөрөнгө оруулалт, үндэсний нийт бүтээгдэхүүний харьцаа/ нь 1,03, 1,52 тус тус болжээ. Үндэсний нийт бүтээгдэхүүнд хөрөнгө оруулалтын эзлэх хувийн жин нь /дээрх онуудад/ 1980 онд 9,6 хувь, 1989 онд 14,7 хувь болсон байна. Улсын төсвийн алдагдал дээрх онуудад 536,0 саяас 1,2 тэр бум буюу 2,3 дахин нэмэгдэж жилд дунджаар 2,9 хувиар өсчээ. Үндэсний нийт бүтээгдэхүүнд төсвийн алдагдлын эзлэх хувийн жин 1980-1985 онд харьцангуй тогтмол хэмжээнд хэлбэлзэж байсан боловч 1985 оноос хойш эрс өсөж 1988 онд 19,5 хувь, 1989 онд 16,4 хувь болов. Улсын төсвийн зарлагад төсвийн алдагдлын эзлэх хувь 1980 онд 13,4 хувь, 1986-1989 онуудад эрс өсөж 25-30 хувийн хооронд хэлбэлзэж байв. Энэ бол хямралын ноцтой шинж мөн. Манай өнөөдрийн банк, санхүү, статистикийн байгаа үзүүлэлтүүдэд түшиглэн мөнгөний нийт хэмжээг тодорхойлж гол макро үзүүлэлтүүдтэй харьцуулахад дараах байдалтай байна.

Дээрх үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг сүүлийн 20 шахам жилийн хугацаанд /1970-1989/ зэрэгцүүлэлт хийхэд нийт мөнгөний массын өсөлтийн хурдац 1970-1980 онуудад үндэсний орлого, бараа эргэлтийн өсөлтийн хурднаас түрүүлж харин хадгаламжийн өсөлтөөс ихээхэн хоцорч байсан ерөнхий хандлага ажиглагдаж байгаа бөгөөд мөнгөний нийт эргэлтийн бүрэлдэхүүн хэсэг /МӨ, МЦ1, МЦ2/ дотроо өөр өөр хандлагатай байна. Тухайлбал дээрх хугацаанд МӨ буюу хүн амын гар дээр болон үйлдвэрийн газрын касет буй мөнгөний өсөлт үндэсний орлогынхоос 6 хувиар хоцорч харин бараа гүйлгээний өсөлттэй бараг адилхан хурдацтай байжээ. Харин банкин дахь хугацаат хадгаламжийн болон үйлдвэрийн газрын харилцах дансанд буй



мөнгөний хэмжээ М1, М2 үзүүлэлтүүд үндэсний орлого, бараа эргэлтийн өсөлтөөс ихээхэн хэмжээгээр түрүүлсэн хандлага тогтвортой хадгалагдаж байна. Сүүлийн 20 гаруй жилд энэхүү мөнгөний хэмжээний /М1, М2-ын/ цэвэр өсөлтийн хурдац үндэсний орлого, бараа эргэлтийнхээс ихээхэн түрүүлсэн, ялангуяа үйлдвэр, албан байгууллагын харилцах дансанд буй мөнгөний хурдац сүүлийн жилүүдэд эрс нэмэгдсэнтэй холбогдон дээрх ялгаа өсчээ.

Ийнхүү үндэсний нийт бүтээгдэхүүнд мөнгөний нийт эргэлтийн хувийн жин эрс нэмэгдэж /1980-32,3 хувь, 1985-43,6 хувь, 1989 онд 40,6 хувь/, харин бэлэн мөнгөний хувийн жин харьцангуй тогтмол байлаа. Энэ бүх байдал нь дээрх үеүдэд улс ардын аж ахуйн хэмжээгээр мөнгөний болон барааны массын зохицолдоо байнга алдагдаж, зөрүү нэмэгдэж ирснийг харуулж буй түгшүүртэй баримт бөгөөд эцсийн дүндээ төгрөгийн худалдан авах чадвар ихээхэн унасан гэсэн хэрэг юм.

Үүний хамт хүн амын хадгаламж үндэсний орлогын өөрчлөлтөөс харахад манай хүн амын хадгаламж улам бүр аргагүйдсэн шинж чанартай өөрөөр хэлбэл, барааны чанар муу, тоо хэмжээ бага байгаагаас хүн ам мөнгөө аргагүй хадгалахад хүргэж байна. Ингэхлээр мөнгөний болон татварын масс хэмжээний хоорондын зохицолдоо алдагдах явдал зөвхөн мөнгөний гаргалт, түүний дотор бэлэн бус мөнгөний өөрчлөлт, хадгаламжийн аргагүйдсэн шинж чанартай холбоотой төдийгүй хамгийн гол нь улс ардын аж ахуйн бүтцийн зохисгүй тогтолцоо, түүнд нөлөөлөх банк санхүүгийн уян хатан бодлого, механизм үгүйлэгдэж байгаатай дээрх бүх зүйл холбогдох бөгөөд Монголын эдийн засгийн өнөөгийн нөхцөл нийгмийн шинж чанар зөвхөн бэлэн мөнгөний гүйлгээтэй холбоотой бус, гол нь салбар хоорондын бүтцийн зохисгүй байдлаас үүдэн гарсан барааны хомсдлын шинж чанартай инфляцийн даралт цаашид үүсэн гарах бодит нөхцөл бүрэлдсэн байгааг ойрын 2-3 жилд арилгах шаардлагатай байна.

### **Дотоодын зээл**

Дотоодын зээлийн өнөөгийн байдлыг авч үзэхэд тэр нь өөрийнхөө шинж чанарыг алдаж өглөгийн шинж чанарыг агуулж захиран тушаах эдийн засгийн тогтолцооны дуулгавартай зарц болж хувирсан гэж хэлж болно. Үүнийг дараах тоо баримт гэрчилж байна. 1970 онд Үндэсний орлогод зээлийн эзлэх хувийн жин 79,1 хувь зээлийн үлдэгдэл олгосон зээлийн нийт дунд эзлэх хувийн жин 6,9 хувь тус тус байсан бол 10 жилийн дараа 103,5 хувь, 19,8 хувь, 1985 онд 109,1 хувь болтлоо өссөн бөгөөд 80-аад оны дунд үеэс энэ харьцаа тогтвортой хадгалагдсаар 1989 онд 9,4 хувь, 27,3 хувь тус тус болсон байна.

Эдийн загийн өнөөгийн байдлыг тодорхойлоход эдийн засгийн гадаад харилцааны байдал манай орны хувьд онцгой ач холбогдолтой. Гадаад худалдаа, зээлийн бодлого нь олон жилийн турш эдийн засгийг бүтцийн хараат байдалд оруулах алдаатай бодлогын идэвхгүй тусгал болж, түүний алдагдал улам бүр архаг шинж чанартай болж байна. “Худалдааны нөхцөл” буюу экспорт, импортын үнийн харьцаанд 70-аад оны дунд үеэс тогтвортой муудах хандлага хадгалагдсаар ирэв. Бид өнөө хүртэл дэлхийн эдийн засгийн хэлхээ холбоонд оролцох зохистой механизм, харьцангуй давуу талаа шинжлэх ухааны үндэстэй тодорхойлж чадахгүй л байна.

Өнөөдөр засгийн газрын ч, ард түмний ч сэтгэл санааг ихээхэн зовоож байгаа нэг асуудал бол өр төлбөрийн тухай юм. Монгол улс яагаад их хэмжээний өрөнд орсон шалтгааныг гадаад, дотоод хүчин зүйлтэй холбон авч үзэх нь зүйд нийцэх бөгөөд дотооддоо зээлийг туйлын үр ашиггүй ашиглаж байсан, зээлийн техник технологийн бүтэц, түвшин, үнийн өсөлт, удирдлагын бүх түвшинд зээлд дулдуйдах сэтгэлгээ хүчтэй нэвчсэн зэрэг хүчин зүйлийг өнөөдөр ард түмэн тал бүрээс нь шүүн хэлэлцэж байна.

МоАН нь гадаад өрийн өнөөгийн байдлыг “өр төлбөрийн хямрал” гэж үзэж байгаа бөгөөд Засгийн газраас дэлхийн практикт хэвшиж тогтсон бүхий л механизмыг эрж хайж, практик алхмуудыг хийнэ гэдэгт найдаж байна.

Эдийн засгийг зах зээлд шилжүүлэх хөгжлийн цаашдын үзэл баримтлалыг боловсруулахад бидэнд онц анхаарах асуудал бол оюуны хөгжил болж байна. Монголын эдийн засгийн хөгжлийн цаашдын төлөвийг тодорхойлоход шинжлэх ухаан техникийн дэвшил шийдвэрлэх ач холбогдолтой гэдэг нь маргаангүй Үндэсний технологийн чадвар сул хөгжсөн технологийн хувьд давхар хамааралтай манай орны хувьд түүний хөгжлийн үндэсний бодлого илт үгүйлэгдэж байгаа нь Засгийн газрын мөрийн хөтөлбөрөөс ч харагдаж байна. Тиймээс дэлхийн эдийн засаг, түүний дотор бид араас нь замнах гээд байгаа баруудын технологийн хөгжлийн бодлогод өргөн хэрэглэгдэж буй зохицсон технологийн үзэл баримтлал, онолын чиглэлүүдийг сайтар судлах, технологи дамжуулах гол суваг болдог үндэстэн дамнасан корпорациудыг Монголд оруулах бэлтгэл ажлыг НҮБ-ын холбогдох зөвлөлтэй хамтран гүйцэтгэх, хөрөнгө оруулалтыг баталгаажуулах, олон улсын агентлагт элсэх, жижиг, дунд үйлдвэрийн дэлхийн холбоотой нягт хамтран ажиллах зэрэг ажлуудыг Засгийн газрын түвшинд боловсруулах шаардлагатай байна.

Олон арван жилийн турш ноёрхсон эдийн засгийн өнөөгийн тогтолцоог макро түвшинд хүчтэй чадварлаг Засгийн газар, микро түвшинд үйлдвэрлэгчдийн эрх чөлөөг бүрдүүлж чадах эдийн засгийн засаг, эрх зүй зохион байгуулалтын тааламжтай хөрс дэвсгэр бий болгон хөгжүүлж байж үндсээр нь эвдэх бөгөөд чухам энэ үйл явц бол зах зээлийн баримжаат эдийн засаг гэсэн томъёололд илүү тохирч байна. МоАН энэ томъёоллыг хэрэглэхдээ эдийн засгийн шинэчлэлийг хэрэгжүүлэх эхний шатанд аль ч үзэл баримтлал, тухайлбал, үе шаттайгаар шилжих, эсвэл цочир анагаах аргын алиныг ч хэрэглэсэн эцсийн үр дүнгийн хувьд манай эдийн засаг төгс боловсорсон зах зээлийн харилцаанд шилжихгүй, харин зах зээлийн эдийн засгийн үндсүүд тавигдах, эдийн засаг бүхэлдээ либералчлагдах суурь, дэвсгэр тавигдах болно гэсэн байр сууринаас хандаж байна.

МоАН эдийн засгийн үзэл баримтлалаа эдийн загийн хөгжлийн хандлага, дорнод европын орнуудад өрнөж буй шинэчлэлийн үйл явцыг анхааралтай судлан Монгол орны эдийн засгийн өнгөрсөн хөгжлөөсөө үүдсэн бодит сургамж, дэлхийн эдийн засагт интеграцчилагдан түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болоход манай эдийн засгийн хэв шинжит төрх нь бага бөгөөд нээлттэй эдийн засаг байх ёстой гэсэн ерөнхий зарчимд тулгуурласан болно.

Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг олон намын гишүүдээс бүрдсэн бага хурлаар баталснаар Засгийн газарт олгох итгэлийг олон намууд хуульчлан

баталж өглөө гэсэн хэрэг юм. Гэхдээ өнөөдөр энэхүү мөрийн хөтөлбөр огт өө сэвгүй, бидний үзэл баримтлалтай яг таг тохирч байна гэсэн үг биш гэдэг нь ойлгомжтой. Гол нь эрс шийдэмгий шинжтэй шилжилтийн хугацааг аль болох багаар баримжаалсан болон аливаа намын улс төр, үзэл суртлын нөлөөнд автагдаагүй харьцангуй бие даасан шинжтэй прагматик байр сууринаас хандсан нь энэхүү мөрийн хөтөлбөрт итгэл найдвар өгөх эрхийг бидэнд олгож байна. Тэгээд ч итгэл найдвар олгохыг шаардсан улс төр, нийгэм-эдийн засаг, нийгэм-сэтгэл зүй уур амьсгал өнөөдөр манай нийгэм бүрэлдсэн байгааг манай нам харгалзан үзэж байна. Засгийн газрын мөрийн хөтөлбөрөөс хийх дүгнэлт болон МоАН-ын үзэл баримтлалын үндсэн чиглэлүүдийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

### **1. Өмч хувьчлах талаар**

Өмчийг хувьчлах үйл явыг МоАН бодлого, стратегийн зорилт гэж үзэж байгаа бөгөөд түүний агуулга нь нэг талаас улсын болон түүнтэй адилтгах өмчийг задлах буюу олон улсын практикт денационализац гэж нэрлэгддэг үйл явцыг хэрэгжүүлэх, нөгөө талаас хувийн секторыг үүсгэн хөгжүүлэх, хөл дээрээ тогттол нь дэмжин урамшуулах замаар эдийн засгийн хөгжилд нөлөөлөх үүрэг, ач холбогдлыг нь эрс дээшлүүлэх, түүнчлэн улсын секторын үйл ажиллагааг зах зээлийн нөхцөлд зохицуулан төгөлдөржүүлэх талаар төрийн зүгээс зорилго чиглэлтэй авч явуулж буй арга хэмжээний цогц нийлбэр байх ёстой гэж үзэж байна. Өмчийг хувьчлах үйл явцыг хэрэгжүүлэх Засгийн газрын тусгай мөрийн хөтөлбөр зайлшгүй байх ёстой.

Өнөөдөр өмч хувьчлах үйл явцыг хэрэгжүүлж эхлэхэд нийгэм-сэтгэл зүйн тааламжтай уур амьсгал бүрэлдэж чадсан эсэх, түүнийг ганц хоёр сарын дотор бүрэлдүүлэх боломж байгаа эсэх, хувьчлалын үйл явцыг ил, далд шууд болон тойруу замаар эсэргүүцэж буй нийгмийн хүч, хуучинсаг уур амьсгал хэр зэрэг хүчтэй байна вэ гэдэг дээр онцгой анхаарах ёстой.

Ялангуяа өмч хувьчлах үйл явц, зах зээлд шилжин орох асуудлыг дан ганц сөрөг талаас нь дэвэргэн сурталчлах, захиран тушаах эдийн засгийн тогтолцооны гол гажуудлыг зах зээлд нялзаах, “хадны мангаагаар” ард түмнийг айлгаж, нийгмийн сэтгэл зүйн уур амьсгалыг тогтворгүй болгох, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр асуудлын мөн чанарыг буруу сурталчлах, худал мэдэмхийрэх явдал сүүлийн үед ихсэх хандлагатай байгаа, нөгөө талаас өмч хувьчлах, зах зээлд шилжих болон зах зээлийн эдийн засгийг дан ганц цагаан талаас нь хэт амархан дүрслэх зэрэг туйлшрах хандлага хоёрын аль аль нь аюултай гэдгийг онцлон тэмдэглэмээр байна.

Засгийн газрын тэргүүн мөн түүнчлэн тэргүүн дэд шадар сайдын сүүлийн үед хэлсэн үгнүүдэд ч зарим талаар эргэлзээтэй зүйлүүд байгааг тэмдэглэх хэрэгтэй. Тухайлбал ард түмэнд хөрөнгө оруулалтын эрхийн бичиг олгон хувьцаа эзэмшигч болгосноор бид ард түмнээ хөлсний хөдөлмөр, хөлсний ажилчин, мөлжлөгөөс хамгаалж байна, манайд зах зээлийн нөхцөлд хөлсний ажилчин-эзэн Засгийн газар гэсэн түгээмэл гурвалжин бага үүснэ гэх мэтээр Засгийн газрын тэргүүн мэдэгдэж байна. Өнөөдөр бид хөлсний хөдөлмөр, хөлсний ажилчин, мөлжлөг гэсэн ойлголтуудаа нэр томьёоны хувьд төдийгүй агуулгын хувьд ч шинээр авч үзэх хэрэгтэй байна.

Хэрэв бид үнэхээр зах зээлийн эдийн засагт шилжих гэж байгаа бол дээрх ойлголтуудыг дэлхийн эдийн засгийн хөгжлийн байр сууринаас

авч үзэн айж цэрвээд байх хэрэггүй юм. Эдгээр ойлголт нь өмч хувьчлах, хөдөлмөрийн зах зээл, капиталын зах зээл болон ажиллах хүч, таваар гэх мэтийн зах зээлийн эдийн засгийн ойлголттой, эцсийн дүндээ зах зээлийн эдийн засгийн философитой зөрчилдөх юм. Хөдөлмөрийн зах зээл дээр ажил олгогч, ажилчин гэсэн хоёр субъект хөдөлмөрийн харилцагаа хамтын гэрээгээр зохицуулдаг бөгөөд ажилчдын эрх ашгийг хамгаалдаг, хөдөлмөрийн харилцааг хянаж цалингийн доод хэмжээг тогтоон, хөдөлмөрчдийн амьдралын нийгмийн баталгааг хамтран хангадаг Үйлдвэрчний Эвлэл, Засгийн газрыг оролцуулсан гурвалжин манайд ч үүсэх нь гарцаагүй.

Энэ бол зах зээлийн эдийн засгийн хууль, бид үүнийг тойрч гарахгүй, харин урьд өмнө ярьж байсан “ард түмэн-өмчийн эзэн”, “нийт ард түмний өмч” гэх мэтийн хийсвэр ойлголтыг ард түмэн бүгдээрээ хувьцаа эзэмшигч эзэн болоод аз жаргалтай хувьцаат эдийн засгийг байгуулах гэх мэтийн гэнэн маягийн шинэ марксист томъёоллоор сольж хэрэглэвэл багаар бодоход ёс суртахууны хувьд ч алдаатай юм. Түүнчлэн бид хамт олон гэсэн үгийг ч өнөөдөр арай өөрөөр ойлгох, ялангуяа улсын өмчийг хувьчлах явцад ихээхэн анхаарах хэрэгтэй байна. Хөдөлмөрийн хамт олон гэсэн ойлголтыг үйлдвэрлэлийн хэрэгслийг, эд зүйлсийг өмчлөгчийн хувьд биш харин хамт ажиллагсад хөдөлмөрийн гэрээ хийх утгаар нь хуульчлан зааж өгөх хэрэгтэй байна.

Ард түмэнд хувьцааны эрхийн бичиг тарааж өгөх үзэл санаа нь нийгмийн шударга ёсны шалгуурыг давамгайлүүлсан, хувьчлалыг эрс шийдэмгий хэрэгжүүлэх зорилгод хөтлөгдсөнөөрөө дэвшилттэй шинж чанартай боловч хувьчлалыг хэрэгжүүлэх гол шалгуур болох эдийн засгийн үр ашгийн шалгуур тодорхой биш байна.

Хувьцаа гаргаж үнэт цаасны зах зээлийг эн тэргүүнд хөгжүүлэх банк, санхүүгийн тогтолцоог эрс өөрчлөх монетарист хандлага, үзэл санаа нь учир шалтгааны хувьд зөв бөгөөд чухамдаа захиран тушаах эдийн засгийн тогтолцоог энэ чиглэлээс нь эхэлж үндсээр нь өөрчлөх хэрэгтэйг бусад орны туршлага харуулж байна. Гэхдээ үнэт цаасны зах зээлийг үүсгэн хөгжүүлэх бодит бололцоо, ялангуяа үнэт цаасны хоёрдогч зах зээл үүсэн хөгжих цаг хугацаа, орон зайн хүчин зүйлийг Засгийн газар онцгой анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

Монголын эдийн засгийн бодит нөхцөлд хувь нийлүүлсэн нийгэмлэг хичнээн үүсэж болохыг нягтлан судлах хувьчлалыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, эрх зүй-зохион байгуулалтын утгаар нөхцөлүүд хэр зэрэг бэлтгэгдсэн хувьчлалын гадаад тааламжтай орчин баталгаатай бүрэлдэх зэрэг асуудал нь энэ үзэл санааг хэрэгжүүлэхэд шийдвэрлэх ач холбогдолтой. Хувьчлалын сонгодог арга гэж байхгүй, харин дэлхийн практикт түгээмэл аргууд байна. Эдгээрийг манай эдийн засгийн нөхцөлд тохируулан хэрэглэх, ард түмэнд хөрөнгө оруулалтын эрхийн бичиг олгох үзэл санааг эдгээртэй хэрхэн хослуулах энэ талаар бусад оронд гарч буй үзэл санааг маш анхааралтай судлах шаардлагатай.

Хөдөө аж ахуйд ялангуяа мал аж ахуйд хувьчлалын бодлогыг хэрэгжүүлэх зарчмын талаар Засгийн газрын байр суурьтай МоАН үндсэндээ санал нэг

байна. /Гэхдээ энэ нь уг үйл явцыг хөдөө аж ахуйн салбарт өөрт нь даатган урсгал байдлаар хэрэгжүүлэх, эсвэл хэрэгжүүлэхгүй гэсэн хэрэг огт бишээ/ Энд Засгийн газрын нэгдмэл, зохицуулсан бодлого нэн чухал гэж үзэж байна. Ялангуяа хөдөөд хувьчлалын бодлогыг хэрэгжүүлэх нийгэм – сэтгэл зүйн тааламжтай уур амьсгалыг бүрэлдүүлэх, хувийн малтай малчдыг онцгойлон дэжих, төрөл бүрийн хөнгөлөлт, тусламж үзүүлэх, зарим нэгдэл сумдыг тусгайлан авч хувийн аж ахуйг голлон хөгжүүлэх тусгай бүс байгуулах, одоогийн нэгдлүүдийг зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөн төгөлдөржүүлэх зэргээр хувь нийлүүлсэн малчдын жинхэнэ холбоо болгон хувиргах, хөдөөд зах зээлийн дэд бүтцийг түүний дотор малын биржийн үндсийг тавих зэрэгт Засгийн газрын нэгдмэл бодлого шаардлагатай.

Хөдөө аж ахуйн нэгдлийн холбооны дээд зөвлөлийг удирдлага зохион байгуулалтын хувьд ч өөрчлөх ёстой. Энэ байгууллагыг шинэчлэгдэн зохион байгуулагдсан, “Хөдөө аж ахуйн нэгдэл, хувийн өмчит малчдын холбооны зөвлөл” болгож хувьчлалын бодлогыг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх үүргийг нь эрс нэмэгдүүлбэл зохино.

Улсжсан өмчөөс түрээсээр дамжин хувийн өмчид шилжих зорилгоор түрээсэлж буй нь ойлгомжтой. Тэгвэл түрээсийн “хамгийн хөнгөлөлттэй нөхцөл” гэж зүйрлүүлэн нэрлэж болох хувьчлах үйл явцыг чухам ямар учраас өргөнөөр хэрэгжүүлэхийг эсэргүүцэн болгоомжлоод байгаа нь хачирхалтай байна. Засгийн газраас боловсруулсан мөрийн хөтөлбөр болон өнөөг хүртэл бага хурлаас баталж гаргасан хуулийн багцад ихээхэн анхаарал хандуулах ёстой.

Ялангуяа өмч хувьчлах үйл явцын гол үзэл санаа нь болох учиртай нэг асуудал бол цаашдаа зах зээлийн нөхцөлд бид аж ахуйн үйл ажиллагаагаа хууль эрхийн ямар шинэ үндсэн зохион байгуулалтын хэлбэрүүдэд тулгуурлан хэрэгжүүлэхийг зааж өгөх ёстой аж ахуйн үйл ажиллагааны тухай хууль юм. Гэтэл энэ талаар засгийн газрын мөрийн хөтөлбөрт зөвхөн дурдах төдий, бага хурлаас ойрын үед баталж гаргах хуулиудад ч алга байна. Бид зах зээлийн эдийн засагт шилжих үеийн хууль эрхийн үндсийг бүрдүүлэх ажлыг хооронд нь логик холбоо бүхий багц хууль боловсруулах энэ үндсэн дээр улсын өмчийг хувьчлах учиртай. Чухамдаа аж ахуйн үйл ажиллагааны хууль энэ үйл явцын үндэс нь болж хувьчлалын арга зам бодлогын чиглэлийг тодорхойлох ёстой.

Хувиараа аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх хязгаарлагдмал ба хязгаарлагдмал бус хариуцлагатай нөхөрлөл, пүүс, хамтарсан пүүс, нэгтгэл гэх мэтийг байгуулахгүй бол зах зээлийн эдийн засагт шилжих, хувьчлалын үйл явцыг хэрэгжүүлэхэд саад болно гэдгийг засгийн газар, бага хурал онцгой анхаарах ёстой. Энэ хуулийн дагуу хувь хүн, хуулийн этгээдийн аж ахуйн ижил нөхцөл бололцоог хангах зорилгоор БНМАУ-ын Үндсэн хуулиар хуулийн этгээдийн статусыг жинхэнэ ёсоор баталгаажуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Түүнчлэн энэ хуулийн дагуу одоо үйлчилж буй үндсэн хууль, улсын үйлдвэрийн газрын хууль, хоршооллын хууль, хөдөлмөрийн хууль, иргэний хууль зэрэг хууль тогтоомжуудад хэсэгчлэн буюу бүхэлд нь нэмэлт өөрчлөлтүүдийг шуурхай хийх шаардлага урган гарч байна.



Энэ бүхнээс үндэслэн шинээр зохион байгуулагдан гарч ирсэн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа хэвшиж улмаар эдгээр субъектуудын хооронд зах зээлийн хурилцааны бодит орчин дахь амьд уялдаа холбоо тогттол хувьцааны зах зээлийг зохион байгуулахаас түдгэлзэх нь зүйтэй гэж үзэж байна.

Аж ахуйн нэгжүүдийн зохион байгуулалт, тэдгээрийн тогтвортой ажиллагааг хангах үйл ажиллагааныхаа үр дүнг зах зээлийн шалгуураар үнэлэхэд нягтлан бодох бүртгэлийн тухай хууль боловсруулан гаргаж зах зээлийн харилцааны нөхцөлд ажиллаж чадах нягтлан бодогчдыг бэлтгэх шаардлага чухал байгааг тэмдэглэх нь зүйтэй. Хувьчлалын гадаад тааламжтай орчинг бүрэлдүүлэх зорилгоор НҮБ-ын хөгжлийн программд тулгуурлан хувьчлалын тусгай хөтөлбөр хамтран боловсруулах шаардлагатайг дэлхийн туршлага харуулж байна. Түүнчлэн эдийн засгийн тусгай бүсийг манай улсад байгуулахад нь энэ программын хүрээнд ихээхэн арга хэмжээ авч болно гэдгийг засгийн газар анхаарах ёстой.

## **2. Олон улсын хамтын ажиллагаа, эдийн засгийн гадаад харилцааны талаар:**

МоАН эдийн засгийн нээлттэй бодлого гэдгийг тус орны хөгжлийн стратегийг гадагшаа харсан бодлогод зохицуулан хөгжүүлэх, экспортын баримжаатай үйлдвэр, худалдааны бодлогыг, импортыг орлох, түүнтэй өрсөлдөх зорилттой ухаалгаар хослуулан хэрэгжүүлэх зорилгоор эдийн засгийг бүхэлд нь либеральчлах цогц арга хэмжээ гэж үзэж байна.

Энэ үүднээс үзвэл засгийн газрын мөрийн хөтөлбөрт энэ бодлогын гол томьёолол үзэл баримтлал хангалтгүй тусгагджээ гэж дүгнэж болно. Бид гадаад харилцааны бодлогыг хэрэгжүүлэхэд хоёр их хөрш, түүнчлэн ноён Бейкерийн хэлснээр гуравдагч хөрш болох тухай үзэл санаан дээр тулгуурлан адил талт гурвалжингийн зарчмыг тууштай баримтлах нь зүйтэй гэж үзэж байна.

Манай эдийн засгийн гадаад харилцааны бодлогод гуравдагч хөрш гэсэн үзэл санааны ард манай орны зүгээс эдийн засгийн бодит баталгааг бүрэлдүүлэх алхмуудыг шийдвэртэйгээр хийх нь чухал гэж үзэж байна.

Олон улсын байгууллагууд тухайлбал, олон улсын валютын фонд, дэлхийн банк, худалдаа тарифын ерөнхий хэлэлцээрт нэгдэн орох бодит нөхцлийг одооноос эхлэн бүрэлдүүлэх хэрэгтэй байна.

Олон улсын валютын фондын эрэлтийн бодлого, нийлүүлэлтийн бодлого, тухайн орны өрсөлдөх байр суурийг хүчтэй болгох бодлого гэж 3 хуваан үзэж болох цогцолбор арга хэмжээг агуулсан зөвлөмжийг бид фондын гишүүнээр элсэн орсноор өөрийн нөхцөлд тохируулан хэрэглэх эдийн засаг, эрх зүй-зохион байгуулалтын угтвар нөхцөлүүдийг одооноос эхэлж бэлдэх, бүтцийн зохицолдооны программын үзэл санааг зах зээлийн баримжаат эдийн засгийн үндсийг бүрэлдүүлэх, эдийн засгийг либеральчлах бодлогыг хэрэгжүүлэхэд зайлшгүй харгалзан үзэх шаардлагатайг үндэслэн одооноос цаг алдалгүйгээр энэ талын мэргэжилтнүүдийг дээрх байгууллагуудын шугамаар бэлтгэж хэлэлцээрийн ширээний ард мэдлэгтэйгээр ажил хэргийг явуулах бэлтгэлээ хангах нь чухал болж байна.

Эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлэхэд төгрөгийн хөрвөх чадварыг хангах, ингэхдээ эхлээд дотоод, дараа нь гадаад хөрвөлтийг хангах гэсэн үзэл санаа, хандлага бүх түвшинд яригдаж, албан ёсны баримт бичгүүдэд ч тусгагдах боллоо. Олон улсын валют санхүүгийн практикт хэвшиж тогтсон ёсоор бол валютын дотоод хөрвөлт гэдгийг тухайн орны мөнгийг гадаад валютаар солих эрх чөлөөг тухайн орны хуулийн этгээдүүд, иргэд эдэлдэг валютын дэглэмийг л хэлдэг. Энэ үүднээс авч үзвэл манай төгрөгийг дотооддоо хөрвөдөг болгоно гэсэн одоогийн ойлголт нь буруу бөгөөд валютын хөрвөдөг чанарыг хангах асуудал нь ихээхэн холын зорилт болох нь ойлгомжтой.

Чухамхүү иймээс бид төгрөгийн бүрэн буюу хэсэгчилсэн, дотоод, гадаад хөрвөлтийн асуудлыг тавих нь өнөөдөр эртдэх бөгөөд алс хэтийн зорилт гэж үзэж байна. Харин эдийн засгийн гадаад харилцааг либеральчлах бодлогын үндсийг тавих, тухайлбал гадаад эдийн засгийн харилцааны улсын монополийг эвдэх, үйлдвэрлэгчдийг гадаад зах зээлд гаргах жинхэнэ эрх чөлөөг олгох, худалдаа үйлдвэрийн яамны харьяалалд буй гадаад худалдааны нэгдлүүдийг уг харьяаллаас нь гаргаж хэсэгчлэн хувьчлах зэрэг практик алхмуудыг хийх шаардлагатай гэж үзэж байна.

### **3. Татварын бодлогын талаар**

Шинээр батлагдан гарсан БНМАУ-ын Албан татварын хууль нь логикийн хувьд аж ахуйн үйл ажиллагааны хуультай уялдан нийцэж гарч ирэх ёстой байсан гэж үзэж байна. Энэхүү хууль, төсвийн бодлогын чиглэлийг бид шилжилтийн шинж чанартай бөгөөд ойрын хоёр жилийн дотор өөрчлөгдөх ёстой гэж үзэж байна.

Давхар татвар ногдуулах, орлого ашиг гэсэн ойлголтыг зах зээлийн нөхцөлд ажиллах аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлд зохицуулаагүй хөнгөлөлтийн талаар ихээхэн учир дутагдалтай, түүнчлэн үйлдвэрийн газар, байгууллагын орлогоос хураах татвар нь одоо үйлчилж буй үлдэгдлийн арга гэгчээр үйлдвэрийн газрын цалингийн фонд байгуулах зарчмыг хадгалсан нь зах зээлийн баримжаатай эдийн засгийн харилцааг бүрдүүлэхэд харшлах юм.

Татварын тогтолцооны татвар өөр нэг сул тал нь гүйлгээний татвар болсон хэвээр байна. Энэхүү татварыг тооцоолох үндэс нь Сангийн яамны мэдлийн хэрэг болсон хэвээр, шинжлэх ухааны үндэслэлгүй янз бүрийн аргаар дураар тогтоох практик цаашид ч хадгалагдах төлөвтэй байна.

Тиймээс ойрын 2 жилд эдийн засгийн хувьд үндэслэлтэй, нийгмийн хувьд шударга шууд бус татвар болох нэмэгдсэн өртгийн татварт шилжих үндэс тавигдсан байх ёстой. Аж ахуйн үйл ажиллагааны хуультай татварын хуулийн уялдах үндэс нь нөхөрлөл, хувийн аж ахуйгаас хүн амын орлогоос хураах татвар, хуулийн этгээдийн статустай пүүс, нэгдэлд үйлдвэрийн газар байгууллагын орлогоос хураах татвар тус тус ногдуулснаар хангагдах болно.

Нэмэгдсэн өртгийн татварын зэрэгцээ архи, тамхи, бензин бусад нефтийн бүтээгдэхүүн алт мөнгөн болон бусад эрдэнэсийн чамин эдлэл болон зарим төрлийн импортын бараанд акцизын татвар хэрэглэх нь зүйтэй.

Дэлхийн олон оронд экспортлогчдыг урамшуулах зорилгоор тэдний таваарын өртөг нэмэгдсэн өртгийн татварыг буцааж олгох журам, түүнчлэн энэхүү татварыг импортыг зохицуулахад хамгаалалтын хэрэгсэл болгон өргөн ашигладаг практикийг манайд мөн нэвтрүүлэх нь зүйтэй.

#### **Хөгжлийн төлөвлөлтийн талаар**

Төлөвлөлтийн салбарын өнөөгийн байдлыг хуучин машинаа солиод шинэ машинаа асааж чадахгүй гайхшран зогсож буй хүнтэй зүйрлэж болно. Төвлөрсөн удирдлагын шинжтэй төлөвлөлтөөс индикатив буюу зөвлөмжийн шинж чанартай төлөвлөлтөнд шилжих гэж буй өнөө үед индикатив төлөвлөлтийн орчин үеийн арга хэрэгслийг макро түвшинд яаралтай эзэмших, хөгжлийн тухай ойлголтыг орчин үеийн хөгжлийн эдийн засгийн үзэл баримтлал, арга хэрэгслийн хүрээнд авч үзэж хөгжлийн стратегийг боловсруулах шаардлага цаашид ихээхэн ач холбогдолтой болно.

Энэ ажлыг хэрэгжүүлэх бодлого боловсруулах ёстой хоёр яам, үндэсний хөгжлийн яам, худалдаа үйлдвэрийн яам зөвхөн нэрээрээ төдийгүй авч хэрэгжүүлэх бодлогоороо өөрсдийгөө хэрэгтэй гэдгээ батлах зорилт тулгарч байна. Энэ чиглэлийн боловсон хүчнийг НҮБ-ын үйлдвэр, худалдааны байгууллагын дэмжлэгээр хурдавчлан бэлтгэх нь зүйтэй.

#### **4. Мөнгө санхүүгийн хүрээнд авах арга хэмжээ**

Тус орны мөнгө санхүү, өнөөгийн байдал, захиран тушаах эдийн засгийн тогтолцоог үндсээр нь хааж зах зээлийн баримжаат эдийн засгийн угтвар нөхцөлүүдийг ойрын 2-3 жилд бүрэлдүүлэх шаардлагаас үүдэн дараах цогц арга хэмжээг авах нь зүйтэй. Үүнд:

- Зээл мөнгөний шинэчлэлийг өргөн хэмжээнд хэрэгжүүлж банкны тогтолцоог эмиссийн механизм мөнгөний нийт эргэлтийн удирдлагыг дэлхийн практикт ойртуулах алхмуудыг хэрэгжүүлэх,

- Банкны хүүгийн бодлогыг манай орны мөнгөний нийт эргэлтийн өнөөгийн байдал, ойрын жилүүдэд хүчтэйгээр илэрч гарч болзошгүй инфляцийн даралтаас хамгаалах гол хэрэгслийн нэг болгох, төв банк, арилжааны болон хөгжлийн банк, үнэт цаасны зах зээлийн харилцан холбоотой тогтолцоог бүрэлдүүлэхэд шаардлагатай эдийн засаг, эрх зүй, техник боловсон хүчний бодлогыг гадаад донорын туслалцаа, зөвлөмжийг үндэслэн 1991 оноос эхлэн хэрэгжүүлж ойрын 3 жилд үнэт цаасны 2-догч зах зээлийн үндсийг тавих, хувийн банк үүсэхийг дэмжих,

- Зардал, үр дүнгийн тооцооны орчин үеийн нягтлан бодох статистик эдийн засгийн үр ашгийг гол шалгуураа болгодог худалдааны тооцооны зарчмыг бичил түвшинд хэрэгжүүлэхэд нягтлан бодох, статистик бүртгэлийн өнөөгийн тогтолцоог 1991-1993 онд дэлхийн практикт нийцүүлэн өөрчлөх, банк санхүүгийн статистик бүртгэлийг ил тод болгож үзүүлэлтүүдийн хамрах хүрээг өргөжүүлэх,

- Төгрөгийн нэгдсэн ханшийг дэлхийн валют, санхүүгийн өнөөгийн байдал, цаашдын төлөвийг харгалзан эдийн засгийн бүтцийн өөрчлөн байгуулалт, санхүү-эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад идэвхтэй нөлөөлөх хэрэгсэл болгох зорилгоор эхний үед гол валюттай “уях” зарчмаар

тогтоох, улс орны эдийн засаг санхүү-мөнгөний байдал тогтворжиж дэлхийн санхүү, банкны гол төвүүдтэй холбогдон гадаад эдийн загийн харилцааны чөлөөт байдал нэмэгдэхийн хэрээр уян хатан зарчмаар тогтоох бодлогод шилжих,

- Төгрөгийн эдийн засгийн үндэслэлтэй зөв ханш тогтоох, зах зээлийн эдийн засгийн угтвар нөхцөлүүдийг бүрэлдүүлж бичил түвшинд эдийн засгийн гадаад харилцааг либеральчлах үр ашгийг нь дээшлүүлэхэд валютын зах зээлийг зохион байгуулах асуудал чухлаар тавигдаж байна. Валютын үнэ хаялцуулах худалдааг цаашид техник-зохион байгуулалт, санхүүгийн хувьд төгөлдөржүүлж улсын валютын сан, гадаад валютын зээлээр санхүүжүүлэх, хувь хэмжээг нь нэмэгдүүлэхийн хамтаар экспортлогч үйлдвэрүүдийн валютын тодорхой тогтоогдсон хэмжээг үнэ хаялцуулан худалдах, худалдаа явуулах хоорондын хугацааг богиносгох.

- 1991 оноос аймаг хотуудын банкны нэгжүүдийг техник зохион байгуулалт, боловсон хүчний хувьд шинэчлэн өөрчилж 1992 оноос 2-4 аймгийн дунд болон том хотуудад худалдаа, хөгжлийн банк нэгжээдийг байгуулах ажлыг гүйцэтгэх,

### **Нийгмийн баталгааны талаар**

МоАН зах зээлийн баримжаат эдийн засгийн үндсийг бүрдүүлэх үед хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалах, тэдний амьжиргааны түвшинг дээшлүүлэх, улс орны хэмжээнд ажилгүйдэл, ядууралтай тэмцэж орлогын хуваарилалтын шударга зарчмыг тогтоохын төлөө тууштай тэмцэх болно. Ялангуяа хөдөлмөрчдийн орлогын түвшин, цалингийн доод хэмжээг баталгаажуулан инфляцийн өсөлттэй уялдуулан засварлах, орлогын хуваарилалтын эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөллийг судлан цаашдын чиглэлийг тодорхойлох, цалингийн доод хэмжээг тогтоох талаар олон улсын хөдөлмөрийн байгууллагын Тунхаглал, Конвенцийн үзэл санааны дагуу хүлээн зөвшөөрөгдсөн техник, арга хэрэгслийг ашиглах, түүнийг макро эдийн засгийн бодлогын үр нөлөө бүхий хэрэгсэл болгох зэргээр мэдлэгтэйгээр тэмцэх хамтран ажиллах замыг чухалчилж болно.

*/Илтгэлийг товчлон нийтлэв./ АРДЧИЛАЛ сонин  
1991 1-р сарын 8-14 №-2 /29/*

## **ХҮН БА БАЙГАЛЬ ХЭМЭЭХ ХАВСРАЛТ АЙЛТГАЛ**

*/Уншин сонордуулсан журмын Нөхөр Ч.Сайнбаяр/*

“ЭХ” байгалийн үр хөврөл болох хүмүүс ээ, Бидний өвөг дээдэс байгаль эхээ хайрлан дээдэлж, түүнд шүтэн амьдарч ирсэнийхээ ачаар эсгий туургатны элэнц хуланцаас заяатай эх нутгаа эдүүгээгийн бидэндээ бүрэн бүтнээр нь өвлүүлэн үлдээжээ. Харин бид, ертөнцийн жам ёсыг даган уул ус, уудам талдаа шингэн одсон эцэг өвгөдийнхөө аж төрөх ёсны хосгүй арга ухаанаас өвлөн авч амьдрал ахуйгаа зөвөөр зохиож чадсангүй.

Монголчууд байгалийнхаа зан араншинг гүнзгий мэдэж, аж ахуйн аливаа үйл ажиллагаагаа түүнд зохицуулж иржээ. Манай монголын уламжлалт үйлдвэрлэлийн арга нь ХҮН-МАЛ-БАЙГАЛЬ гурвын амьд шүтэлцээнд үндэслэсэн аж ахуйн өөртөө тохирсон өвөрмөц хэвшил байжээ. Нүүдэлчин Монголчууд малаа даган оторлохдоо гэрийнхээ босгон дорхи зүлгийг халцарч эхлэнгүүт нутаг сэлгэн нүүдэг байв. Ингэж бэлчээр сэлгэдэг байсан нь байгалтайгаа зохицон аж төрдөг байсны нэг жишээ юм. Уул усаа дархладаг ариун ёс эзэн Чингисийн үеэс тогтож, их цэргийн хуаранг гоо үзэсгэлэнт газар байрлуулахыг хориглодог байсан байна. Түүнчлэн эх болсон байгалиа шүтэж уул овоо нутаг усаа тайж тахин, их ёслол үйлдэж байгалиа баярлуулан сүлд хийморио сэргээдэг байжээ.

Олон зуун жилийн амьдралын шалгуураар шүүн тунгаагдсан Монгол ахуйд дэвшилт өв уламжлал их байсан юм. Төв Азийн байгаль цаг уурын өвөрмөц нөхцөлд нэн зохицож, төлөвшин тогтсон монгол амьдралын хэмнэлийг хоцрогдсон хэмээн ад үзэн намын үгүйсгэлийн үзэл суртлаар таслан хаасан нь байгаль дэлхийтэйгээ харьцаж ирсэн өвөг дээдсийн баялаг өв уламжлалын ариун ёсноос биднийг салгажээ. Харанхуй бүдүүлэгт тооцогдсон өвөг дээдсийн маань байгаль эхийнхээ тэнцвэрт байдлыг алдагдуулдаггүй байсны нууц нь амьдралын гүн ухаандаа байжээ. Байгальдаа харш Европын том аж ахуйн нүсэр техник, түүнд тохирсон аж ахуйн зохион байгуулалтын хэлбэрийг хүчээр нэвтрүүлж, бусдыг сохороор хуулбарлан улс орны үйлдвэржүүлэлтийн бодлогыг буруу явуулж ирснээс үе залгамжлагдан ирсэн монгол амьдралын дүр төрх гажуудаж, хүн байгалийн амин шүтэлцээ эвдэгдэхэд хүрчээ.

Техникийн хүчээр байгалийг эзэгнэж эрхшээлдээ оруулах, баялагийг булаан авах үзэл дэлгэрснээс байгаль дэлхийтэйгээ хайр найргүй харьцах хандлагыг бий болгож, түүнийг эвдэж сүйтгэх боллоо. Ингэснээр манайд “байгаль хамгаалал” гэдэг цоо шинэ ойлголт гарч ирсэн юм. Энэ нэр томъёо монголчуудын сэтгэлгээнд урьд өмнө хэзээ ч байсангүй. Ой мод, уул усыг буу, дуран агссан харуул биш бидний үе улиран шүтэн ирсэн өлийн их “ОВОО” манадаг байсан монгол оронд байгаль хамгаалах үүрэгтэй өдий төдий байгууллагууд бий боллоо. Өөрөөр хэлбэл, байгальд учирсан гунигт гамшгийг далимдуулан дулдуйлагчид гарч, өөрсдийнхөө эрх ашгийн үүднээс түүнийг үйлчлүүлэх таатай нөхцлөө болгож байна. Эрх ямбаа алдахгүйг хичээсэн “БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ” унаатай сайд, дарга нар байгалиа уугуул төрхөөр нь хадгалахыг бодно гэж үү.

Хэрэв байгаль сүйдэхээ больчихвол зохиомлоор бий болгосон хүнд суртал, захиргаадлын албан тушаал алга болоход хүрч ямбатнуудын язгуур эрх ашигт харшлах болно. Иймд байгаль хэлмэгдэж л байвал тэд баяртай байх болно шүү дээ.

Нөгөө талаар үйлдвэрлэлээ байгальдаа зохицолдуулан явуулж чадахгүй байгаа өнөөгийн нөхцөлд дээрх байгууллагууд байсан байгаагүй байгаль эвдэрдэгээрээ эвдэрсээр л байх болно. Харин эдгээр байгууллагуудын оронд байгаль орчныхоо шинж байдалд хяналт ажиглалт хийж, өөрчлөлтийн төлөв байдлыг тодорхойлон шуурхай мэдээлж байх улсын албыг байгуулах хэрэгтэй юм.



Манай оронд томоохон үйлдвэр, аж ахуйн газрууд зөвхөн сүүлийн 15 жилд эрчимтэй “хөгжсөнөөс” үзэхэд Монгол нутгийн байгалийн тогтолцоо гадны хүчний нөлөөнд хялбар өртдөг, туйлын эмзэг болох нь харагдлаа. Үйлдвэр, аж ахуйн газрын хэт төвлөрөл, хүн амын бодлогогүй шилжин суурьшилт, цөөнхийн хэт тусгаар байдал зэрэг нь Монгол хүний түүхэн үеийн туршид дасаж ирсэн экологийн орчиндоо нийцэж амьдрах зохицол холбоог эвдэж, өөрийн гэсэн уугуул орчингүй үр удам бий болоход хүргэж байна. Өвөг дээдсээс үе залгамжлуулсаар өнөөг хүргэсэн монгол түүний үндэс угсааг цэвэр ариунаар нь үр удамдаа өвлүүлж үлдээх нь өнөөгийн бидний түүхэн хариуцлагатай үүрэг билээ. Хүнээ боддоггүй нийгмийн тогтолцоо байгалиа хэзээ ч хайрлаж чаддаггүйг амьдрал өөрөө харуулж байна.

Байгаль орчныхоо уугуул төрхийг хэвээр хадгалах талаар явуулах төрийн бодлогод доор дурдсан зарим чиг баримтлалыг дэвшүүлж байна.

1. Байгаль орчиндоо элдэв уршигт нөлөөлөл учруулахгүй, эдийн засгийн хувьд хамгийн үр ашигтай байх хөгжлийн чиг баримтлалыг экологи-эдийн засгийн загварын үндсэн дээр тодорхойлох.

2. Засаг захиргаа - нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг шинэчлэн сайжруулах, хот төлөвлөлтийн үндэслэл судалгаанд эскологи - газар зүйн зохистой нутагшлын хэмийг алдагдуулахгүй байх байгаль - нийгмийн зохицол уялдааг хангасан, шинжлэх ухааны арга зүйн зарчмыг урьдал болгох.

3. Говийн бүсийн нутгийг цөлжих аюулаас аврах, зөв зохистой эзэмших ашиглах тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, говийн бүсэд онцгой эрх дарх тогтоох.

4. Байгалийн бүх төрлийн нөөц баялгийг хам бүрдлээр нь судалж, тэдгээрт иж бүрэн үнэлгээ өгөх. Түүний үндсэн дээр газар, ус, ой, болон газрын хэвлийн баялгийг ашиглахдаа энэ чиглэлийн эрдэм шинжилгээний байгууллагуудын хүчийг нэгтгэн, ажлын нь уялдааг сайжруулж, тэдгээрийн олон арван жил хуримтлуулсан судалгаа, шинжилгээний байгууллагуудын хүчийг нэгтгэн, ажлын нь уялдааг сайжруулж, тэдгээрийн олон арван жил хуримтлуулсан судалгаа, шинжилгээний материалуудад тулгуурлан гүнзгий үндэслэлтэй хандах. Түүнчлэн нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг арвижуулж тэтгэсэн аж ахуйн салбар, байгууллага, хувь хүнийг урамшуулдаг журамд шилжих.

5. Улс төр, соёл урлаг, шинжлэх ухаан, шашин мөргөлийн төв болсон жинхэнэ нийслэл хотын шинэ төрхийг төгс бүрдүүлсэн цэвэр цэмцгэр хотыг өнө мөнхийн Хар-хориндоо зохион байгуулах, тэнд төрийнхөө үйл ажиллагааг явуулах “Түмэн Амгалан” ордонг сэргээн босгох.

6. Манай нутаг дэвсгэр нь дэлхийн усан хагалбарыг зааглаж байдгаараа цэнгэг усны ундрагын орон болж байдаг. Өөрөөр хэлбэл, манай орны уул нуруудаас эхээ авч буй гол мөрөн, нуур цөөрөм бүгд бусад орны усан судлыг сэлбэн тэтгэж, олон ард түмнийг цэвэр тунгалаг усаараа ундаалж байдаг билээ. Иймд модыг хядчин сүйтгэх нь дэлхий нийтийн өмнө хүлээх гэмт хэрэг юм. Хүрээлэн байгаа байгаль орчны асуудал хэлэлцсэн 1972 оны НҮБ-ын бага хурлаас аливаа улс гүрэн, бусад орон, бүс нутгийн байгаль орчинд уршигт нөлөөлөл үзүүлэхгүй байх, энэ талаар хариуцлага хүлээж

байх тухай шийдвэр гаргажээ. Үүнтэй уялдуулан эх нутгийнхаа нөхцөл байдлыг улс түмэнд учирлан ойлгуулж, өөрийн орны модны зайлшгүй хэрэгцээг холбогдох орнуудаас зохих журмаар хангуулах асуудлыг НҮБ-ын хүрээлэн байгаа орчны хөтөлбөр /ЮНЕП/-т оруулж шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Ухаант дээдсээсээ өвлөн авсан онгон байгалиа үр хойчдоо үлдээх юмгүй болтол эвдэж сүйтгэх эрх бидэнд байхгүй, Байгаль дэлхийдээ хорлолгүйгээр амьдрал ахуйгаа зохиож ирсэн эцэг өвгөдийн хосгүй арга ухаан, нарийн дэг ёсноо суралцан, эх болсон байгальтайгаа болгоомж судалгаатай харьцах соёлыг эзэмшицгээе. Эс тэгвээс бид хаашаагаа тэмүүлж байгаагаа урьдчилан төсөөлж чадахгүй байсаар хэн ч хязгаарлан зогсоож үл чадах аймшигт сүйрэлд орох нь байна. “Ишиг эврээ ургахаар эхийгээ мөргөнө” гэгчийн үлгэрээр өврөөсөө өндийлгөсөн эх байгалиа эргэж хөнөөхөө зогсоож, ангир шар уургийг нь хөхөж өссөн эхдээ энэрэлт, үрийн хайр хүндэтгэлийг үзүүлж, хишиг буяныг нь дээлэн хүртэх ариун сэтгэлийг эрхэмлэнэ.

Өлзий хутгийн цог бадран дэлгэрэх болтугай.

МоАН-ын эдийн засгийн үзэл баримтлалын Хавсралт илтгэл.

### **Батлан хамгаалах салбар бол эдийн засгийн нэг хэсэг**

*Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга  
С.Дэмбэрэлтэй манай суралжлагч уулзаж, зах зээлийн нийгэм  
хийгээд эдийн засгийн аюулгүй байдлын талаар ярилцлага  
өрнүүлснийг нийтэлж байна.*

**Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжээд 20 гаруй жил улиран оджээ. Энэ нийгэмд Та өнөөгийн өндөрлөгөөс ямар үнэлэлт, дүгнэлт өгөх вэ?**

**С.Дэмбэрэл:** -Зах зээлийн харилцаа гэдэг нь зах зээлийн зохицуулалтаар удирдагддаг ихэнх эдийн засгийн үйл ажиллагаа юм. Төр оролцох үедээ оролцдог, оролцохдоо үр ашигтай оролцдог, үйлдвэрлэгчид, үйлчилгээ үзүүлэгчид, хэрэглэгчдийн өдөр тутмын харилцаа нь зах зээл гэдэг тэр газар тогтож, энэ нь үл үзэгдэх хууль учраас зах зээлээр зохицуулагдаж байдаг ийм харилцааг л хэлээд байгаа юм. Монгол Улсын зах зээлийн харилцаанд шилжсэн 22 жилийн хугацаанд янз бүрийн дүгнэлт хийж болно л доо. Өөрөөр хэлбэл 1990-1995, 1996-2010, түүнээс хойших он гэх мэтээр хуваачихаж бас болно. Гэхдээ яг ингэж хуваасан юм бол байхгүй. Миний харж байгаагаар 1990-1996 он бол “Гэнэн зах зээл”-ийн үе байсан гэж болно. Энэ нь юу байв гэвэл зах зээл гэж нэг сайхан ногоон хөндий байдаг юм байна. Шилжилт гэдэг тэр уулыг нь давчихвал нөгөө ногоон хөндий нь их сайхан харагдана. Нөгөө уулаа бушуухан давчихвал зах зээл гэдэг нийгэмд хурдхан орчих юм байна гэсэн, зах зээлийг өнгөц ойлгосон гэнэн сэтгэлгээ реформын эхний жилүүдэд төрийн ч, улс төрийн намын ч, зах зээлд оролцогч тоглогчдын сэтгэхүйд ч байсан нь үнэн юм. Тухайн

үед реформ нь таван зуун өдөр ч гэх юмуу, эсвэл цочир анагаах эмчилгээ ч гэх юмуу, тийм маягаар явж ирсэн. Өөрөөр хэлбэл реформын эхний зургаан жилийг иймэрхүү хэлбэрээр төсөөлж болох. Зах зээл гэдэг нь өөрөө барилгатай адил суурь, тоосгуудыг өрөх шаардлагатай шүү дээ. Тийм учраас эхний жилүүдэд либералчлах бодлогыг түлхүү барьсан. Тухайлбал, “4L+1P” гэж би тухайн үедээ хэлж байсан юм. Энэ нь үнийг чөлөөлөх, валютын ханшийг чөлөөлөх, гадаад худалдааг чөлөөлөх, санхүүгийн зах зээлийг чөлөөлөн, дээр нь privatization-хувьчлал гэх мэтээр будилж явсаар 1996-2000 онд эрчим хүчний үнийг бас чөлөөлөх оролдлогууд хийгдсэн. Ийнхүү өнгөрсөн 20 жилийг харахаар зах зээлийн суурь тоосгонуудыг, институцууд, байгууламжуудыг бол барьчихсан. Харин түүнийгээ хооронд нь уялдуулах, зүгшрүүлэх ажил одоо л дөнгөж эхэлж байна. Гэхдээ энэ хооронд ард иргэдийн болон бодлого боловсруулагчдын сэтгэхүйд нэг өөрчлөлт орсон. Тэр нь юу байв гэвэл, зах зээл гэдэг тэр зүйлд эргэлт буцалтгүй орсон гэсэн нийгмийн сайн сэтгэхүй байсан. Хоёрдугаарт, энэ зах зээлийг чинь бас дан ганц дураар нь тавьчихаж болдоггүй юм байна. Төр их оролцох ёстой юм байна гэсэн хоёр дахь сэтгэхүй байсан. Харамсалтай нь хоёр дахь сэтгэхүй сүүлийн жилүүдэд хэт их давамгайлаад, төр хөндлөнгөөс хэтэрхий ихээр оролцох болсноор жам ёсных нь урсгалыг алдагдуулах зэрэг зохисгүй үзэгдэл ажиглагдах болсон. Ингэснээр хүнд суртлын асар том багуудыг, асар том хүлээсүүдийг үүсгэсэн. Өөрөөр хэлбэл зах зээлийн операторуудын амыг нь скочдоогүй ч, хөл, гарыг нь скочдсон. Ингээд өнөөдрийн өндөрлөгөөс харахад төрийн зохицуулалтаар хэт их гажуудсан зах зээлийн эдийн засагтай орон болсон байна. Тийм ч ураас 2010 онд бизнесийн орчинд шинэтгэл хийх гэж оролдож үзлээ. Тэр нь юу юм бэ гэвэл, зах зээлийг зохицуулж буй бүх төрлийн дүрэм, журмуудыг цөөрүүлэх, ингэснээр хээл хахууль, авилгыг гаргахгүй байх, багасгах зэрэг юм. Энэ бүхнийг эцэст нь нэгтгэж хэлэхэд тааруу гэсэн үнэлэлттэй, дундаас доошхи дүнтэй улс л 22 жилийн дараа харагдаж байна даа.

**- Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн чадавхийг Та хэрхэн үздэг вэ? Бид “Азийн бар” болох тухай яриад 20 гаруй жил боллоо. Ер нь улс орны хөгжилд гох дэгээ болсон ямар асуудлууд байна вэ?**

**С.Дэмбэрэл:** - Ер нь аль ч улс орны иргэд нь, төр нь зайлшгүй мөрөөддөг, алсын хараа, эрхэм зорилготой байж зорилтоо тодорхойлдог л доо. “Азийн бар” гэдэг томъёолол нь зүүн өмнөд Азийн улс орнуудын л хөгжлийн загвар шүү дээ. Ер нь бар болох, чонон эдийн засаг босгох зэрэг янз бүрийн томъёолол сүүлийн үед гарсан. Миний хувьд энэ талаар нэг их ярьдаггүй. Харин мэргэжлийн бус хүмүүс, сэтгүүлчид л голчлон ярьдаг юм. Монгол Улсын эдийн засгийн өнөөдрийн загвар нь ямархуу байдалтай явж ирэв, яаж харагдаж байна гэвэл өнөөдөр эрдэс баялгийнхаа нөөц дээр суурилсан, түүн дээр тулгуурласан, гадагшаа чиглэсэн бүтэцтэй, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох бодлого явж байна. Гэхдээ тэр бодлого нь алдаатай байна. Тэр алдаа нь юу юм бэ гэвэл, эдийн засгийн өсөлтөөс бий болсон баялгийг шударга хуваарилах гэдгийг буруу ойлгоод байна. Өөрөөр хэлбэл тэгшитгэн хуваарилна гэсэн зарчмаар явж байна. Гэтэл дэлхийн эдийн засаг ямар чиг хандлагатай байна гэдгийг харах ёстой. Тэгвэл дэлхий өнөөдөр тогтвортой хөгжил, оролцоотой хөгжил,

тэнцвэртэй хөгжил гэж ярьж байна. Энэ гурван үг өнөөдөр дэлхийн эдийн засгийн өсөлтийн бодлогын, хөгжлийн бодлогын тулгуур гурван зарчим болоод байна.

**- Манай улс хоёр хөршөөсөө эдийн засгийн хувьд хараат гэдгийг Та хүлээн зөвшөөрөх байх. Энэ байдал хэдий хугацаанд үргэлжлэх вэ. Аль эсвэл мөнхийн хараат байсаар байх уу?**

**С.Дэмбэрэл:** - Бид өнөөдөр харилцан хамааралтай ертөнцөд амьдарч байна шүү дээ. Өнөөдөр импортоор ч гэх юмуу, ганцхан зах зээлтэй байх нь тийм сайн биш. Монголчууд үйлдвэржилтийн бодлогыг тууштай баримтлах хэрэгтэй. Үйлдвэржилт нь гадаад зах зээл рүү чиглэхээс гадна Хятад, Оросын зах зээлээс авч байгаа төрөл бүрийн хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүнийхээ үйлдвэрлэлийг дотооддоо хөгжүүлэхэд төрийн бодлогыг сайн чиглүүлэх шаардлагатай байна. Жилдээ гучин миллиард төгрөгөөс жаран миллиард төгрөг бус, бүр хоёр зуугаас дээш их мөнгө төвлөрүүлэх бодлого явж байх ёстой юм. Дээр нь экспортыг хөгжүүлэх, дэмжих, экспортын салаалалтын хөтөлбөрүүдийг гаргаж ирэх ёстой. Үүнийг сүүлийн үед “Солонгоролт” гэсэн уран зохиолын хэллэгээр нэрлэх болсон. Энэ нь юу гэсэн үг вэ? гэвэл харилцан хамааралтай байж л энэ ертөнцөд эдийн засгийн шинж төрхөө авч үлдэнэ гэсэн үг. Тийм учраас ганцхан орноос хараат байж болохгүй. Аюулгүй байдал гэж яриад байгаа нь зөвхөн цэргийн талаас нь том юм ярихдаа бус, эдийн засгийн тусгаар тогтнол, эдийн засгийн аюулгүй байдал зэргийг ярина. Энэ бүхэн нь тус, тусдаа өөр, өөр ойлголт. Хамааралтай эдийн засгийг аль болох хамаарлыг нь багасгах, гэхдээ битүү цагариг үүсгэж болохгүй. Бид тэртээ тэргүй энэ хоёр хөрштэйгээ худалдаа наймаа, бизнесээ хийсээр байх болно. Үүнээсээ давж Япон, Солонгос, Европын холбоо гээд явна. Европын холбоо Монголд 7200 бүтээгдэхүүнийг татваргүй оруулах эрх өгчихөөд хэдэн жил болов. Тийшээ 72 бүтээгдэхүүн ч гаргаж чадахгүй. Энэ нь экспортыг дэмжих, хөгжүүлэх, гэхдээ уул, уурхайнх бус шүү. Хоёр жилийн өмнө бидний боловсруулаад өгсөн үндэсний хөтөлбөр одоо хүртэл батлагдаагүй байна. Тийм учраас бодлогын л алдаа харагдаж байна, бодлогоо л гарга. Бодлого гарсан цагт хувийн хэвшилүүдэд баримжаа үүсээд бүтээгдэхүүнээ гаргаж эхэлнэ. Жишээлбэл, Эрээнд манай нэг компани 4 тонн бууз гаргаад дорхноо л зарчихаж байна. Гэтэл Монголын мах дэлхийд танигдаагүй, брэнд болж чадаагүй, органик мах гэдгийг дэлхий мэдээгүй л байхад шүү дээ. Бид саяхан Японд чацарганы ажлаар яваад ирлээ. Хүмүүс амсаж үзээд ийм ундаа монголд байдаг юмуу гээд л гайхаж байх. Гэтэл үйлдвэрлэлийн боломж нь өнөөдөр экспортод гаргах хэмжээнд хүрээгүй байна. Айл өрх, компаниуд өөрсдийнхөө дотоод зах зээлийн хэрэгцээг хангах хэмжээнд л байна шүү дээ. Тийм учраас энэ бүхнээ яаж экспортод гаргах, дотоод зах зээлдээ энэ чиглэлээр яаж өрсөлдөөн үүсгэх вэ гэдгийг л бодолцох хэрэгтэй болоод байна.

**- Манай улс газрын тосны баялгаар тэргүүлэх орны тоонд орох болсон. Гэтэл бензин шатахуунаа гадаадаас авсаар л байна. Ийм сайхан баялагтай орон боловсруулах үйлдвэр барьж болохгүй юу. Эсвэл зориудаар хойшлуулшсаар байна уу?**

**С.Дэмбэрэл:** - Үнэнийг хэлэхэд манай орон газрын тосны баялгаараа, нөөцөөрөө тийм их мундагт орохгүй, ямар ч байсан дотоод хэрэгцээгээ хангаад, тодорхой хэмжээгээр экспортлох нөөц байж магадгүй юм. Одоо хүртэл газрын тосны салбарт явуулж ирсэн бодлого хэд хэдэн алдаатай байсан. Нэгдүгээрт, сэтгэл санааны хувьд, оросоос мөнхийн хамааралтай гэсэн он жилүүд давамгайлж байсан. Тийм учраас эдийн засгийн дипломатын үйл ажиллагаа авдаг, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нь явдаг, оросуудын Засгийн газарт гуйлт хийж, нөгөөдүүл нь харж үзье гэсээр явж ирсэн. Хоёрдугаарт, газрын тосыг дотооддоо үйлдвэрлэе гэсэн асуудал эхлээд байгаа эсэхийг нь мэдэх ёстой байсан. Тэгсний эцэст нөгөө “Дачин Тамсаг”-ын асуудал яригдах байтал нөгөө бүтээгдэхүүн өгөх гэрээ нь энэ талыг бодолцож хийгээгүй гэрээ. Одоо тэр нь нууц гэж явдаг. Саяны бензиний үнийн өсөлт биднийг шоконд оруулж, их зүйлийг мэдрүүлж өглөө шүү дээ. Тийм учраас хамааралт байдлаасаа яаж гарахав гэдэг талаар илүү буурь суурьтай ярьж байх жишээтэй. Гэтэл энэ чиглэлээр хөрөнгө оруулах хувийн компаниудын эрх чөлөө бас хаагдсан. Одоо л дөнгөж газрын тосны үйлдвэр байгуульа гэсэн дуу хоолой гарч байна. Гэтэл энэ нь эдийн засгийн үр ашгийн түвшинд байж чадах уу, үгүй юу гэдэгт бас маргалдаж л байна. Гэхдээ эдийн засгийн үр ашигтай гэхээсээ, улс төрийн үр ашигтай гэдгийг илүү харах ёстой. Тэртээ тэргүй бид ганцхан гол нийлүүлэгчтэй. Оросын Засгийн газар Монгол Улсыг юу гэж харна, бид түүгээр л явна шүү дээ. Оросын улс төрийн бодлого явж байна. Гэхдээ тусгаар улс юм бол, энэ улс орноос бага хараатай байя гэж бодож байгаа юм бол, заримдаа эдийн засгийн үр ашиг нь тааруу байсан ч улс төрийн үр ашиг нь, нийгмийн үр ашиг нь сайн бол өөр бодлого явуулж болдог. Иймэрхүү бодлого цаашдаа явагдах байх. Хамгийн гол нь төр өөрөө зөв чиглүүлж өгөөд, эрх зүйн болоод удирдлага, зохион байгуулалтын орчныг нь бүрдүүлээд өгвөл хувийн компаниуд, гадны хөрөнгө оруулагчид хамтран ажиллах нөхцөл боломж бүрдэх юм. Тийм төсөл, хөтөлбөр ч байна. Ер нь таван жилийн дараа Монгол Улсад энэ чиглэлээр нэлээд ахиц гарсан байх болов уу гэж бодож байна.

**- Оюу толгой, Таван толгойн зүг гадна, дотногүй хүмүүс анхаарлаа хандуулах болсон. Хамаг сайхан баялгаа гадныханд бараг зүгээр шахуу тавиад туучихлаа гэж халаглах хүмүүс ч цөөнгүй байна. Энэ тухайд Таны бодол ...?**

**С.Дэмбэрэл:** - За яахав дээ. Миний хувьд тэр гэрээ, хэлэлцээрийнх нь тухайд сайн, мууг нь мэдэхгүй. Одоогийн байдлаар Монгол Улсад асар их ажлын байрыг бий болгож, асар их мөнгийг төсөвт өгч байгаа. Цаашдаа ч их мөнгө өгөх юм гэнэ лээ. Монгол Улсын Засгийн газар 34 хувийг нь эзэмшиж байгаа гэсэн иймэрхүү мэдээлэлтэй. Гэхдээ стратегийн орд газрууд гээд 34, 51 хувь гэж яриад байх нь зөв юмуу. Энэ тал дээр бүх төрлийн татвар, түүний дотор экспортын татвар, байгаль орчны доройтолд оногдуулсан татвар зэргийг маш сайн аваад, энэ дээр нь төр алтан хувьцаа эзэмшигч байдлаар хяналтынхаа чиг үүргийг хэрэгжүүлээд явах нь зүйтэй юу, эсвэл төр өөрөө бизнес болоод, төр өөрөө хувьцаат компани байгуулаад, тэгээд олон түмэнд 1072 хувьцаа олгох нь компаний сайн засаглалын хэлбэр мөн үү гэдэгт би эргэлздэг. Тийм учраас үүнд үнэмшдэггүй. Харин



ямар юманд үнэмшдэг вэ гэвэл хувийн болоод дотоодын, гадаадын хөрөнгө оруулагчид, компаний нийгмийн хариуцлага, уул, уурхайн ил тод байдлын зарчмууд, нээлттэй байх зарчим зэрэг энэ бүхнийг төрийн хатуу хараа хяналтын дор хуульчилсан байдлаар лицензийн торонд хэрүүлчихэлгүй шиг төр өөрөө оролцохгүй хянаад явдаг ийм л бодлого цаашаа явбал Монголд ядахнаа хээл хахууль, компаний муу засаглал үүсэхгүй байх боломжтой гэж боддог. Хэрвээ ийм байдлаар яваад байвал манай улс нэг их үр дүнд хүрэхгүй байх. Таван толгойн хувьд гэвэл 536 хувьцаа гээд л, 2008 оноос үүдэлтэй эрдэнэсийн хувь, эх орны хишиг ч билүү, энэ бүхнийг би буруу гэж боддог. Ард түмэнд хувьцааг тэгшитгэх байдлаар хуваарилж байгаа нь танд хүлээлт үүсгэхээс гадна өөрөө шударга биш зүйл. Яагаад гэвэл нийгмийн бүлгүүд, жишээлбэл хөгжлийн бэрхшээлтэй 130 мянган хүн байна. Дунд нь сан байгуулаад өгчихвөл хувьцаа эзэмшсэнээс хамаагүй илүү юм. Цэргийн хүмүүсийн хувьд сайн мэдэхгүй юм. Гэхдээ цэргийн хөгжлийн сан байгуулаад өгчихвөл өөрсдөө менежментээ хийгээд аваад явчих жишээтэй. Ийнхүү нийгмийн бүлэг хүмүүст, бүлэг бүрт нь тохирсон, тэдний хэрэгцээ шаардлага, сонирхол, хүсэл эрмэлзэлд нийцсэн бодлогыг явуулах шаардлага байна.

**- Ер нь хоёр хөрштэйгээ цаашид ямар харьцаатай байвал зохилтой гэж Та үздэг вэ?**

**С.Дэмбэрэл:** - Хөлд нь сууж, хүссэнээ ав гэсэн жижиг орны том дипломат бодлого байх ёстой. Өөрөөр хэлбэл хамгийн дээд зэргээр найр тавьсан уян хатан дипломат бодлого явуулах гэсэн үг. Ингэж байж л бидний тусгаар тогтнол баталгаажина. Өнөөдөр бид хий хоосон цээжээ балбаад үр дүнд хүрэхгүй. Монголын эдийн засгийг өөрчлөх чадвартай байх тусам хоёр хөрштэйгээ бидний өрсөлдөх чадавхи нэмэгдэнэ. Дэлхийн хэмжээний асар том хоёр эдийн засаг шүү дээ. Энэ хоёр том зах зээлийн боломжийг л дээд зэргээр авах ёстой.

**- Эдийн засгийн аюулгүй байдлыг яаж хангах ёстой вэ?**

**С.Дэмбэрэл:** - Маш товчоор хэлэхэд эдийн засгийнхаа өрсөлдөх чадварыг дээшлүүлж байж л хангана. Өнөөдөр Монгол Улсын өрсөлдөх чадвар зуу гаруй орноос маш доогуур явж байгаа. Эдийн засгийнхаа өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж гэвэл үйл ажиллагаа явуулж байгаа операторуудынхаа эдийн засгийнх нь эрх чөлөөг хангаж өгөх ёстой. Түүнээс бус эдийн засгийн аюулгүй байдлыг нүүрс хамгийн их гаргаснаар, эсвэл зэс хамгийн их гаргаснаар хангана гэдэг бол хамгийн, хамгийн гэнэн бодол.

**- Та Монгол Улсын Зэвсэгт хүчний Олон улсын ажиллагаанд оролцдогийн ач холбогдлыг цэгнэж үздэг үү?**

**С.Дэмбэрэл:** - Миний хувьд цэргийн алба хаагаагүй. Гэхдээ оюутан байхдаа цэргийн бэлтгэл сургуульд оролцож, карантинд гарч байсан. Олон улсын ажиллагаанд Монгол цэрэг оролцож байна гэдэг чинь бас л нэг экспорт шүү дээ. Өөрөөр хэлбэл сайн юман дээр Монгол орны имижийг бүрдүүлж байгаа хэрэг. Миний дээр ярьсан үндэсний брэндэнгийн гэсний нэг хэсэг нь Монголын цэргүүд Олон улсын хэмжээнд мэргэжлийн хувьд өндөр чадвартай, авхаалжтай сэргэлэн зэрэг нь ерөөсөө Монгол Улсыг харах бас нэг цонх юм. Хамгийн гол нь Монголын цэргүүд гадаадад экспортлогдож байна гэсэн үг. Тэр улс төрийнх нь тухайд бол би яаж мэдэхэв.

- Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний шинэчлэлийн талаархи Таны бодлыг сонсмоор байна. Цаашдынх нь чиг хандлагыг ямар байгаасай гэж боддог вэ?

С.Дэмбэрэл: Мэдээжийн хэрэг Зэвсэгт хүчний шинэчлэл нь хангамжаасаа эхлээд харагдах ёстой байх. Тухайн салбарт ажиллаж байгаа хүмүүс бол нийгэмд хэрэгтэй. Тэр нь мянган өдөр тэжээж ... гэдэг биш. Хамгийн гол нь тэнд хүн гэдэг талаасаа их хөгжсөн байх ёстой. Өөрөөр хэлбэл цэрэгт явж байгаа залуус бүтэн жил идэх хоолон дээр очих биш, биеийнх нь хөгжлийг сайжруулахаас гадна боловсрол мэдлэгт нь их зүйлийг хийх хэрэгтэй. Энэ бол шинэчлэлийн нэг хэсэг болох байх. Залуучууд хөрвөх чадвартай болох ёстой. Ер нь цэрэгт явсан хүн маш их зүйлд суралцаад ирдэг байх ёстой. Цэрэг бол мэргэжлийн боловсролын үргэлжлэл байх ёстой. Бүтээн байгуулалтын ажилд цэргийг хөлсгүйгээр оролцуулдаг бол буруу. Хоригдол, цэрэг хоёрт мөнгө бага өгөөд ажиллуулчихдаг юм шиг байна лээ. Тэр бол биш. Цэрэг, арми бол Монголын эдийн засгийн бас нэг салбар байх ёстой. Өөрөөр хэлбэл бас өрсөлдөх чадвартай байна гэсэн үг. Талхны ч юмуу маш олон жижиг үйлдвэрүүдийг байгуулж, чөлөөндөө гараад тэр үйлдвэртээ очиж ажилладаг байж болох шүү дээ. Түүнээс биш, цэл залуугаараа тэтгэвэрт гарчихаад гэртээ зүгээр хэвтээд байж болохгүй биз дээ.

*Дэд хурандаа Гомбын БААТАРНУМ. 2012 оны 4-р сарын 30.*

### **Анх төлөвлөж байсан урам зоригтой, өөдрөг төсөв нь худлаа болоод эхэллээ**

*Упеп.тп –ы сурвалжлагчид УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлийн өгсөн ярилцлага:*

- Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн байдал ямархуу байна вэ? Зарим хүмүүсийн хэлж буйгаар их л хүндхэн байгаа гэх юм?

С.Дэмбэрэл: - Засгийн газар байгуулагдаад найман сар болж байна. Энэ хооронд анх төлөвлөж байсан урам зоригтой, өөдрөг төсөв нь худлаа болоод эхэллээ. Өөрөөр хэлбэл, найман сарын өмнө өөдрөг баталсан төсөв маань бодит амьдралын хүчин зүйлүүдээс хамааран нурж байна. Мэдээж урд хөршийн эдийн засагт өрнөж буй зарим нэг зүйлээс хамаарч байгаа. Манай улсын эдийн засгийн өсөлт 17 хувь байснаа 10 боллоо гээд л яриад байна. Өмнөх Засгийн газрын үед тийм өндөрт хүрчихээд одоо ингэж унаж байгаа нь бидэнд сургамж болж байгаа хэрэг. Учир нь эдийн засаг маань ганцхан хөл дээр догонцож байгаа учраас ингэж савласан гэсэн үг. Манай улсын экспортын 85 хувийг дан ганц уул уурхайн бүтээгдэхүүн эзэлдэг нь тэр ганц хөл нь юм шүү дээ. Энэ жил нүүрсний үнэ их унасан. Уг нь 2013 оны төсөвт нүүрсний үнийг нэлээн өндрөөр тооцсон юм. Энэ бүхэн биднийг дан ганц уул уурхайн бүтээгдэхүүн дээр бүү тулгуурла гэдгийг сануулж байгаа хэрэг юм. Үнэхээр үүнийг өөрчлөхгүй бол болохгүй байна шүү дээ. Сэтгүүлч та бүхэн биднээс эдийн засгийн хямралын тухай асууна,

тэр болгонд бид нүүрс, нүүрс л гэж хариулах болно. Ерөөс эдийн засгийн өсөлтийг уул уурхайн салбараас хангана гэсэн бодлого л явж байгаа. Энэ бол үнэхээр буруу, өрөөсгөл хандлага. Эд нар ярихдаа энэ бодлогоос өөр ямар ч арга зам байхгүй гэдэг. Гэтэл өөр арга зам байна шүү дээ. Өөрөөр хэлбэл, эдийн засгаа олон салаа мөчиртэй, олон хөлтэй болгох бодлогыг хүчтэй явуулах хэрэгтэй.

**- Гэхдээ шинэчлэлийн Засгийн газар бусад салбаруудыг хөгжүүлнэ л гэж ярьж байгаа шүү дээ. Тэр бодлого биш гэж үү?**

**С.Дэмбэрэл:** - Зөвхөн уул уурхайн бус, экспортын бүтээгдэхүүнүүдийн борлуулалт, худалдаа зэрэг үйл явцыг төрөөс сайн дэмжиж өгөх хэрэгтэй байна. Ганц нэг удаа экспортод гараад, удалгүй зогсчихсон гэх 40 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнүүд байна. Экспортод гаргах уул уурхайн бус экспортын бүтээгдэхүүнийг дэмжих үндэсний хөтөлбөр нь батлагдаагүй байна. Уг нь Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орчихсон.

**- Инфляци буурсан гэж албаны хүмүүс мэдээлдэг. Гэтэл иргэдийн худалдан авах чадвар улам дордож байх шиг?**

**С.Дэмбэрэл:** - Инфляцийг бууруулахын тулд төрөөс мах, бензин, шатахуун гэхчилэн тодорхой салбаруудад тусгайлсан санхүүжилтийн хөтөлбөр хэрэгжүүлж байна л даа. Энэ бүхний үр дүн хараахан гараагүй ч гэсэн эерэг үзүүлэлт бий. Гэхдээ инфляцийг 9.8 хувиас доош бууруулж чадахгүй байна шүү дээ. Манай улсын нийт бизнес эрхлэгчдийн 90 гаруй хувь нь 20 хүртэлх ажилчидтай жижиг дунд бизнесийнхэн байгаа. Тэдний маш өчүүхэн хэсэгт нь жижиг, дунд бизнесийн зээл гэж өгч байна. Жижиг, дунд бизнесийн батлан даалтын сангийн тухай хууль бодит утгаараа хэрэгжээгүй байна. Бизнес эрхлэгчдэд тохирсон нөхцөлтэйгээр зээл өгдөг банк санхүүгийн систем байхгүй. Ийм тохиолдолд инфляци яаж буурах юм бэ, зээлийн хүү яаж нэг оронтой тоонд очих вэ. Ерөөс эдийн засгийн эргэлт байхгүй гэсэн үг. Эдийн засгийн эргэлт явагдахгүй байгаа учраас бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт сайн хийгдэхгүй байгаа юм. Мэдээж нийлүүлэлт муу учраас юмны үнэ доошилж өгөхгүй. Нийлүүлэлтэд саад болж байгаа бэрхшээлийг арилгах төрийн бодлого гарахгүй байна.

**- Үнэхээр инфляц буурсан юм бол өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ яагаад буухгүй байгаа юм бэ?**

**С.Дэмбэрэл:** - Яг үнэн. Хэдий инфляц буурсан ч гэсэн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ яг л хэвээрээ. Энэ л хамгийн гол асуудал болчихоод байна. Нийгмийн давхарга болгонд юмны үнийн өсөлт янз янзаар мэдрэгдэж байгаа юм. Хамгийн их мэдрэгдэх хэсэг нь ядуу болон дунд орлоготойгоос доош хүмүүс шүү дээ. Ерөөс нийлүүлэлт болоод өрсөлдөөн муу байгаа газар юмны үнэ өсдөг. Иймээс нийлүүлэлтийг чөлөөтэй байлгаж өрсөлдүүлэх ёстой. Өрсөлдөөнд жижиг дунд бизнесийнхэн л оролцох ёстой. Тэдэнд зориулсан санхүүгийн орчин нь дарамтгүй л байвал жижиг, дунд компаниуд идэвхжилд орно. Бас нэг гаргалгаа нь инфляцийг бууруулья гэвэл зээлийн хүүгээ нэг оронтой тоонд оруулах бодлогыг тусгайлан боловсруулж, УИХ-аар батлуулах хэрэгтэй байна. Ингэхдээ, зөвхөн нийлүүлэлтийн талд л анхаарч, хэдэн санхүүгийн схем хэрэгжүүлчихээд одоо л инфляци буурна гэвэл үнэхээр худлаа. Банкны монополь байдлыг халах, санхүүгийн салбарт реформ хийх гэх мэт олон зүйлийг хэлж, шаардаж байгаа боловч

хэрэгжүүлэхгүй л байна. Монголын банкуудын холбоо, Даатгалын холбоод санаачлага гарган санхүүгийн салбарын реформыг хийх, зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулах хувилбарыг судалж байна. Тавдугаар сарын 15 гэхэд нэг чиглэл гарна. Түүнийгээ Монголбанк, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яаманд танилцуулна.

**- Инфляцийг бууруулахад нийлүүлэлт чухал. Гэхдээ махны нийлүүлэлт гайгүй шүү дээ. Ийм байхад л үнэ өсөөд байдаг нь юуных вэ?**

С.Дэмбэрэл: - Нийлүүлэлтийн гинжин хэлхээ гэж ярьдаг шүү дээ. Малчны хотноос хэрэглэгчийн гарт очих хүртэлх махны замын зургийг гинжин хэлхээ гэж хэлж байгаа юм. Замын зургийн мөчлөг бүрт ямар саад бэрхшээл байна вэ гэдгийг маш сайн судлах ёстой. Уг нь хөдөө аж ахуйн бирж гээд байгуулагдсан юмсан. Даанч тэр нь сайн ажиллахгүй байна л даа.

**- Засгийн газраас махны үнийг буулгахын тулд 87 тэрбум төгрөг зарцуулчихаад байгаа. Энэ ажлыг хэр үр дүнд хүрсэн гэж бодож байна вэ?**

С.Дэмбэрэл: - Махны замын зургийг бүрэн хийгээгүй. Ард нь байгаа нийгэм, эдийн засгийнхаа үйл явцад анализ хийгээгүй, худалдан авдаг ард түмнийхээ яаж амьдрах гэж байгаа аргыг хайхраагүйгээс болоод хийж хэрэгжүүлж байгаа ажил нь олон нийтэд хүрч чадахгүй байна. Үр дүн нь мэдрэгдэхгүй байна гэсэн үг.

**- 2012 онд болсон эдийн засгийн чуулганаас Монголын эдийн засгийг солонгоруулах зорилт тавьсан. Одоо тэр зорилтоо хэр биелүүлж байна вэ?**

С.Дэмбэрэл: - Яг томъёололд нь “солонгорох” гэсэн гоё нэр байхгүй л дээ. Би жаахан бүдүүлгээр орчуулаад байгаа юм. Эдийн засгийн салаалалт гэвэл оновчтой. Хэрвээ мод олон салаалж ургавал их гоё, саглагар, том болно шүү дээ. Манай эдийн засгийн бүтэц ганцхан уул уурхайд суурилсан. Уг нь уул уурхайн бус экспортыг дэмжиж, хөгжүүлэх үндэсний хөтөлбөрөө боловсруул гэж Ерөнхий сайдад хэлж байсан удаатай. Бид аль болох хоёр хөршөө мөлжиж амьдрах ёстой. Учир зүггүй Европ, Америк гэж мөрөөдөөд яахав. Тэр бол үнэхээр хэцүү. Стандарт нь хүртэл таарахгүй шүү дээ. Би хүмүүстэй уулзаад явж байхад экспортод гаргах боломжтой олон бүтээгдэхүүн байдаг юм билээ. ОХУ-ын Сибирийн бүс нутгуудад манай бүтээгдэхүүнүүд сайн зарагддаг. Мөн Хятадын зүүн хойд мужууд манайхтай ижил уур амьсгалтай учраас аль болох их зүйлийг экспортлох хэрэгтэй. Үүнийг л эдийн засгийн солонгорол, салаалалт гэдэг юм.

**- Та төрийн бодлого хэрэгтэй гэдгийг дахин дахин хэлж байна. Гэтэл тэр төрийн бодлого гарахгүй, хэрэгжүүлэхгүй байна шүү дээ?**

С.Дэмбэрэл: - За даа, таван жилийн дотор хийгдчих л ажил л даа. Гэхдээ маш идэвхтэй байвал шүү дээ. Төрийн бодлого цаасан дээр гарч болно. Хамгийн гол нь цаасан дээр бичсэн зүйлээ хэрэгжүүлэх засаглалын технологи нь удаан байдаг байхгүй юу. Удаан, үр дүнд чиглэдэггүй, ерөнхийдөө буцаад тайлан бичихэд зориулагдсан байдаг учраас бодит үр дүнд хүрдэггүй. Би ямар сайндаа УИХ-ын судалгааны төвд судалгаа захиалах гэж байна. Ерөөсөө энэ засгийн бичиг баримтуудын эргэлт нь хэр зэрэг удаан явдаг юм гэдгийг мэдэх гэж байгаа хэрэг. Өөрөөр хэлбэл, УИХ-ын гаргасан хуулийн дагуу Засгийн газрын тогтоол гарч, тэр тогтоол нь ямар шат дамжлагатай цааш явж байна, үүнд хэдий хэр хугацаа

зарцуулагдаж байна гэхчилэн судлах юм. Махны замын зураг гэдэг шиг засаглалын замын зураг гэсэн үг.

**- Гадаадын хөрөнгө оруулалт буурсан талаар их шуугиж байна. Энэ асуудлыг та бас судалсан байх даа?**

**С.Дэмбэрэл:** - Монгол Улсын эдийн засгийн идэвхжлийн гол хэсэг нь гаднын хөрөнгө оруулалт. Манайд хөрөнгө оруулсан хөрөнгө оруулалтын ихэнх нь гадаадынх. Гэтэл одоо хөрөнгө оруулалт багасчихлаа. Уг нь хөрөнгө оруулалтыг урамшуулах хууль гаргах ёстой. Гаднын хөрөнгө оруулалт багассан нь хэт улстөржилттэй холбоотой. Сонгуулийн өмнө гаргасан зарим хуультай ч холбоотой. Зарим нэг сайд гадаадын хөрөнгө оруулалт үргэчихлээ гэх зүйлгүй гэж ярьж байна. Энэ буруу. Ямар ч улс гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг хүндэлж байж, тэр хөрөнгө оруулалтаа урамшуулж, идэвхжүүлж байж эдийн засгаа өсгөдөг. Энэ бол түүх. Үүнийг хэнбугай ч, ямар ч улс зөрчиж чадахгүй. Хөрөнгө оруулалтыг үргээж, садаа болоод байгаа тодорхой бус байдлаа яаралтай арилгах ёстой.

**- Төсвийн гадуурх зардал нэмэгдсэнээс болж, төсвийн тодотгол хийх сураг гараад байна. Энэ талаар юу хэлэх вэ?**

**С.Дэмбэрэл:** - Хуулийнхаа дагуу хийнэ л биз. Гэхдээ төсвийн тодотгол хийх болоогүй байлгүй дээ. Ер нь бодит байдалтай уялдуулаад төсвийн тодотгол хийдэг шүү дээ.

**- Та өмнө нь парламентын гадна байсан. Тухайн үеийн УИХ, засгийн газрыг байнга шүүмжилдэг байсан. Одоо шүүмжилж чадаж байна уу?**

**С.Дэмбэрэл:** - Илүү сайн шүүмжилж, илүү сайн амьдралыг хардаг л юм байна.

**- ИЗНН дотооддоо жаахан асуудалтай байна уу?**

**С.Дэмбэрэл:** - Ерөнхий нарийн бичгийн даргадаа итгээд явж байсан чинь дандаа арагшаа харж ажилласан юм байна.

**- С.Оюун сайд та хоёрыг намынхаа мөнгө төгрөгийг хуваагаад авчихдаг гэсэн яриа гарсан. Үүнд ямар тайлбар хэлэх вэ?**

**С.Дэмбэрэл:** - Тийм үндэслэлгүй зүйл ярьж болохгүй биз дээ. Тэр С.Жаргал гэгч их аюултай нөхөр байна. Тэгээд ч нам, хамт олныхоо итгэл, хүндэтгэлийг хүлээж чадаагүй. Одоо ажлаасаа халагдчихсан. Одоо өөр нам байгуулна гээд л явж байгаа юм билээ.

**- Д.Энхбат дарга байгаа юу?**

**С.Дэмбэрэл:** - Аль хэдийнэ намаас хөндийрсөн шүү дээ.

**- Ерөнхийлөгчийн сонгуульд танай нам дангаараа орох уу?**

**С.Дэмбэрэл:** - Ирэх долоо хоногт Үндэсний хорооны хуралдаан болно. Түүгээр л эцэслэн шийдэх байх. Манай намынхан АН болон бусад намыг судлах ажлын хэсэг байгуулсан. Тэд маань АН-ынхантай ч саяхан уулзсан.

**- Хамтарч оролцох тухай ярих гэж үү?**

**С.Дэмбэрэл:** - Мэдээж ярилцана шүү дээ. Түүнийхээ дараа Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцэнэ. Хоёр намын хооронд гарын үсэг зуралцсан гэрээтэй зүйл байгаа шүү дээ.

**- Ярилцсанд баярлалаа.**

*Д.МЯГМАРСҮРЭН*



## **Хөгжлийн талаасаа бүгд стратегийн ач холбогдолтой салбарууд мөн**

*УИХ-ын 2013 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн Чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс: Улсын Их Хурлын дэд дарга С.Баярцогтыг цүрэгт ажлаас чөлөөлөх тухай асуудал хэлэлцэх цээр*

С.Дэмбэрэл: - Баярлалаа. Дэлхийн 30-аад орны 40 хэдэн сэтгүүлчдийг оролцуулсан 3 жил үргэлжилсэн нэг ийм төсөл явсан юм байна. Тэгээд дуусч байгаа юм байна. Тэгээд түүний гол зорилго нь офшёр бүсүүдэд татвараас зайлсхийх буюу татвараас зугатаах биш, хуулийн хүрээнд татвараас зайлсхийх тийм асуудлыг судлахаар ийм сэтгүүлчдийн төсөл хэрэгжсэн юм байна. Түүний үр дүнд 3000 хүний нэр гаргаж ирсэн юм байна. Тэр дундаас ганцхан хүн нь би ёс суртахууны алдаа хийжээ гээд түүнийгээ хүлээн зөвшөөрөөд, өнөөдөр Улсын Их Хурлын дэд даргаас ёс суртахууны хувьд энэ албан тушаал дээр байж болохгүй юмаа гээд бидний дунд сууж байна л даа, *нэгдүгээрт*.

*Хоёрдугаарт*, улс төрийн жудаг гэж би томъёолол мэдэхгүй. Хүний жудаг гэж нэг томъёолол мэднэ. Хүний жудаг ёсоор бол хүн төрөлхтөний ямар ч хуульгүйгээр хүлээн зөвшөөрсөн хуулиар бол унасан хүнийг зоддоггүй юмаа. Би бол унасан хүнийг зоддог хүн бишээ. Та бол Баярцогт оо, 3000 хүний дундаас ёс зүйн хариуцлагаа хүлээж байгаа анхны хүн. Та өөрөө ямар ч хууль зөрчөөгүй гэж хэлж байна. Би түүнд чинь үнэмшиж байна. Тийм учраас ёс зүйн хариуцлагаа өөрөө хүлээж байгаа хүний, би бусад хүмүүсийн тэр хэлснийг буруутгахгүй. Гэхдээ ямар ч гэсэн хүний ёс жудаг гэж юм бий.

Тэр тусмаа гэр бүл нь хүнд тохиолддог хамгийн хэцүү байдалтай байгаа үед нь энэ хүнийг өөрөө ёс зүйн алдаагаа ухамсарлаад та бидний дунд ингээд сууж байхад нь дээрээс нь нэмж өшиглөж, батлагдаагүй янз янзын таамаглалаар булах нь хэр зэрэг зохистой юм бол доо гэсэн бодол төрж байна. Энэ үгийг хэлсний дараа магадгүй намайг олон хүн үзэн ядаж магадгүй. Гэхдээ эцсийн эцэст хүн хоорондын харьцаанд хамгийн түрүүнд ялдаг зүйл нь ёс жудаг гэж юм байдаг юмаа. Тийм учраас би таныг 3000 хүний дундаас өөрөө ёс зүйн ухамсраа гаргаад ажлаасаа чөлөөлөгдье гэж байгаад чинь би гайхаж байгаа.

Гэхдээ таны энэ бол таны асуудал. Гэхдээ би кноп дарахдаа таны энэ асуудлыг чинь би дэмжихгүй. 5 удаа Монгол төрийг төлөөлж, хар залуу наснаасаа маш их туршлага хуримтлуулсан энэ хүнийг иймэрхүү ёс зүйн алдаа гаргасных нь төлөө тал бүрээс нь маш олон янзын дээд зэргийн мөрдөн байцаагч нарт байдаггүй таамаглалыг гаргаж, тал талаас нь зодож байгаад би хүний хувьд бол харамсч байна. Тийм учраас Ёс зүйн хороо нь хуралдаад, ямар асуудлаар ёс зүй гэдгээ өөрсдөө шийднэ биз. Ямар ч гэсэн танд би харин баяр хүргэж байна. Баярлалаа.

*Стратегийн ач холбогдол бүхий салбарт цйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг дээр*

С.Дэмбэрэл: - Баярлалаа. Энэ хууль Монгол Улсад сайн юм авчрахаасаа илүү саар юм авчирсан хууль. Сонгуулийн өмнө батлагдсан, одоо орчин үед хэлээд байгаа төрийн капитализмын хамгийн муу хэлбэрийг биежүүлсэн

нэг хууль. Тийм учраас яагаад ийм ганц заалттай юм оруулж ирснийг би мэдэхгүй. Бүхэлдээ энэ хуулийг хүчингүй болгох шаардлагатай гэж үздэг. Энэ хуулийг хүчингүй болгоод одоо байгаа Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиа салбаруудаар нь босго хэмжээг нь өөрчлөөд, босго хэмжээгээр өөрчлөхдөө Монголын өнөөдрийн дотоодын хөрөнгө оруулагчдын тухайн тодорхой салбаруудад хийж өөрснөө биеэ даагаад авч явах салбаруудаа харгалзсан тийм ялгавартай босгуудаар гаргасан нь хамаагүй ашигтай бөгөөд гадаадын хөрөнгө оруулалтыг зөв секторууддаа дуудаж авчрах ач холбогдолтой. Түүнээс гадна стратегийн гэж бид нар их ярьж байгаа. Стратегийн салбар гэж ер нь юу юм бэ, стратегийн бус салбар нь тэгвэл юу юм бэ? Одоо жишээлбэл стратегийн гэж нэрлэсэн бол логикоороо стратегийн бус гэдэг салбарууд гарч ирнэ. Гэтэл бүх салбар хөгжлийн концепци талаасаа бол стратеги. Бүр тодруулаад хэлбэл орчин үеийн телекоменикаци өнөөдөр либеральчлагдсан байгаа. Энэ дээр төрийн оролцоо гээд байх тэр хуучин үзэл баримтлал, номлол өнөөдөр больсон гэх мэтээр уул уурхайг жишээ нь стратегийн гэж ярьдаг. Стратегийн салбар юм уу? Эсхүл стратегийн бүтээгдэхүүн гэж гаргаж ирэх ёстой. Стратегийн бүтээгдэхүүн гэдэг талаас нь оруулаад, одоо тэр 92,94 онд батлагдсан билүү? Тэгээд засвар орсон Гадаадын хөрөнгө оруулалтад саяны босгуудыг тавиад дотор нь нэг тодорхой бүлэг стратегийн бүтээгдэхүүн гэдэг талаас нь оруулаад ийм шинэ хууль Засгийн газар оруулж ирэх хэрэгтэй. Тэгж байж бид нар өнөөдөр гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдын итгэлийг дахин сэргээх, энэ үндсэн дээр Монгол Улсад хөрөнгө оруулалтын тааламжтай орчин зөвхөн 4 жилд биш урт хугацаанд бүрэлдэх эх үүсвэр тавигдана. Тийм учраас энэ хуульд хандахдаа Засгийн газар энэ талаас нь биш, богино хугацааны эффект талаас нь биш урт хугацааных нь талаас бодоод хамгийн гол нь өнөөдөр хувь процент эзэмшсэнээсээ илүү алтан хувьцааг эзэмших ийм байдлаар тухайн улс орны стратеги хэрэгжих бүрэн боломжтой, төр өөрийнхөө оролцохгүй, ер нь энэ төрийн оролцоо гэдэг зүйлийг хуулиар баталгаажуулдаг энэ сүүлийн үед хүчтэй болоод байгаа энэ хандлагаасаа татгалзах замаар энэ хуулиа бүхэлд нь хүчингүй болгоод цоо шинэ орчин үеийн хандлагад тохирсон, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг урин дуудсан, үргээсэн бус ийм урт, дунд хугацаанд үр дүн нь эерэг байх ийм хууль оруулж ирээсэй гэж бодож байна. Энэ талаас нь бодож аль ч Байнгын хороон дээр энэ асуудал талаас нь бодож ажиллаасай гэж бодож байна. Баярлалаа.

## **Гадаад худалдааны цахим нэг цонхны үйлчилгээ нэвтрүүлэх хэрэгтэй**

*Хилийн боомтын тухай болон дагалдах бусад хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Аюулгүй байдал, гадаад бодлогын болон хууль зүйн байнгын хорооны хамтарсан ажлын хэсгийн 2013 оны 5 дугаар сар 13-ны хуралдааны тэмдэглэлээс.*

**С.Дэмбэрэл:** Эртээд хуралдаад хоёр даалгавар өгсөн. Концефцийн тухай таарахгүй байна. Хил дээр ажилладаг байгууллагуудыг нэгтгээд дундаас нь дахиад нэг байгууллага гараад ирсэн. Тэрийг больсон уу?

**Хариулт:** - Таны ярьсан худалдааг хөнгөвчлөх, эдийн засгийн харилцаа хөгжүүлэх талаар концепцийн чанартай мэдээллүүдийг Гаалийн байгууллага дэлгэрэнгүй хийсэн. Үүнтэй холбоотой саналуудыг зарчим дээр бол оруулсан байгаа. Мөн хилийн боомтын удирдлагын асуудал дээр бол наад саналууд чинь хөнгөвчлөх тал руугаа тусгагдсан. Аюулгүй байдал талаасаа Тагнуулын болон хууль сахиулах байгууллагуудын хувьд анхаарах зүйлс ч бас бий.

**С.Дэмбэрэл:** Улам тодорхой болох үүднээс яг тодорхой асууцхъя. Энэ хилийн боомт дээр ажилладаг байгууллагуудыг дээрээ нэг даргатай тийм бүтэцтэй болгох тийм санаа явж байсан. Боомтын захиргаа ч билүү? Тэр байгаа юу? больсон уу?

**Хариулт:** - Төсөл дээр бол байгаа. Засгийн газрын өргөн баригдсан хууль дээр ч бас байгаа. Яг байлгах эсэх асуудлыг эцэслэж шийдээгүй байгаа.

**С.Дэмбэрэл:** тэгвэл яг одоо тэрнийгээ та бүхнээс асууцхъя. Байгууллага болгоноороо, яг өөрийнхөө байгууллагыг танилцуулаад, бидний бодлоор бол ийм байгууллага байх ёстой, эсвэл байх ёсгүй гэсэн тэр тайлбараа хийцгээчих. Товчхон товчхон, болж байна уу? тийм учраас л бид чинь энд ингээд бүгдээрээ хамт сууцгааж байгаа шүү дээ.

**Мэргэжлийн хяналтын ерөнхий газар Төгсбаяр:** Боомтын нэгдсэн захиргаа бий болох нь зүйтэй гэж үзэж байгаа. Энэ байгууллага маань хяналт шалгалтын байгуулгуудын өөрсдийнх нь хуулиараа хүлээсэн чиг үүргэд нь оролцохгүй. Харин Боомтын дэд бүтэц, ажиллаж амьдрах бололцоог нь хангах чиглэлээр ажиллана гэж хуулийн төсөл дээр явж байгаа. Төрийн бусад байгууллагууд ачааллаа хөнгөлөөд, хилийн боомтын захиргаа руугаа дэд бүтэц, барилга байгууламж, аж ахуйн талын ажлаа хариуцуулах юм.

**С.Дэмбэрэл:** Мэргэжлийн хяналтын албан ёсны санал гэж үзэж болох уу?

**Мэргэжлийн хяналтын ерөнхий газар Төгсбаяр:** - Болно

**Гадаадын иргэн харьят эрхлэх газар Мөнхбат:** Энэ саналыг дэмжиж байгаа. Энэ байгууллага нь бас боомтынхоо менежментийг хариуцаад явах юм. Орос Холбооны Улсад Росграница гэдэг байгууллага байдаг. БНХАУ-д тухайн боомтыг хариуцсан орон нутагт нэгж нь байдаг. Үүнтэйгээ холбогдуулаад, байгууллага хоорондын харилцаа, дэд бүтэц, цаашдын хандлагыг нь тодорхойлж өгч байх ийм байгууллага яг өнөөдрийн байдлаар алга. Одоогоор боомт дээр ажиллаж байгаа хяналтын байгууллагууд өөр өөрсдөө жижиг жижгээр хариуцаад явж байгаа учраас үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх боломж нь илүү нээгдэнэ. Нэвтрүүлэх хүчин чадал нь нэмэгдэнэ гэж үзэж байгаа.

**Засгийн газрын хэрэг эрхлэх газар Мөнх-Эрдэнэ:** Хуулийн төслийг дэмжиж байгаа. Манай оруулсан төсөл л дөө.

**Өмнөговь аймаг дахь засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч, ажлын албаны ажилтан Батсүх:** Хуулийн төслийг дэмжиж байгаа.

**Барилга, хот байгуулалтын яамны стратеги бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Дондогмаа:** Манай Яам хэдэн боомтын асуудал дээр ажилласан. Хуулийн төсөл, ийм байгууллага байгуулахыг дэмжиж байгаа.

**Хот байгуулалтын хөгжлийг дэмжих төв Шархүү:** - Асуудлыг бид судалж үзээд, хуулийн төсөл, төлөвлөгөөг боловсруулсан. Боомтууд нь инженерийн дэд бүтэц байхгүй, аж ахуйн асуудлуудыг хариуцсан байгууллага, бүтэц төсөв байхгүй, хил гааль дээр ажиллаж байгаа хэдэн

хөөрхий байгууллага ээлжлээн нэгийгээ томилон, нөгөөдүүл нь нааш цаашаа явж, энд тэндээс юм гуйж, царайчилж жаахан юм хийдэг ийм л байдалтай байна. Тийм учраас ерөнхий төлөвлөгөөний судалгааны үндсэн дээр, хилийн цэрэг болон бусад байгууллагуудтай ярилцсаны үндсэн дээр орчин үеийн түвшинд хүрсэн хилийн боомтыг хөгжүүлэх нь зүйтэй гэж үзсэн. Саналыг зөвшөөрсөн.

**Хот байгуулалтын хөгжлийг дэмжих төв Хуягбат:** Манайх Боомтын ажлыг ажлын гүйцэтгэл хийсэн компани. Яамнаас зургын даалгавар аваад судалгааны ажлыг боомт дээр гүйцэтгэсэн. Бидний ажиглалтаар хил дээр үйл ажиллагаа 4 байгууллагаас өөр боомтын аж ахуйн асуудал хариуцсан эзэнгүй байдаг юм байна. Халаалт, зам талбай зэрэг олон асуудал байна. Голлон үйл ажиллагаа явуулдагаараа Гааль, Хил хамгаалах албаныхан түлхүү анхаардаг юм билээ. Манай хот байгуулалтын баримт бичгүүдэд хил дагасан хотхоны асуудал шинээр орж ирж байгаа. Үүнтэй холбогдуулан хилийн боомт дагасан суурьшилын бүсийг бид төлөвлөсөн. Энэ нь боомтын байдал, нутаг дэвсгэрийн онцлогоос хамааран 1000-5000 хүн амтай янз бүрийн суурингуудын асуудал байгаа. Иймээс тэр боомтын захиргааны асуудал хариуцсан нэгж байх шаардлага гарч ирж байгаа юм билээ. Хилийн боомт бол улсын онцгой объект. Засаг захиргааны хувьд сум орон нутагтаа хамаарах эсэх асуудлыг ч бас анхаармаар санагдсан. Бид зураг төсөлдөө суурьшлын бүс нь тусдаа, хилийн боомтын хяналтын хэсэг нь тусдаа байхаар төлөвлөн хийж байгаа.

**Гаалийн ерөнхий газрын дэд дарга Уугангэрэл:** Дэлхийн гаалийн байгууллагаас “21 зууны гааль” гэсэн багц гаргасан юм. 10 зүйл төлөвлөсний нэг нь “Хилийн хяналтын зохицуулга бүхий удирдлага” гэж бий. 9 сарын 11-ны үйл явдлаас хойш үүнийг илүү хүчтэй тавьж байгаа. Гадаад худалдааг хөнгөвчилөх, аюулгүй байдлыг хангах гэсэн 2 талаасаа энэ чухал болж байгаа юм. Хил дээр өөр өөр чиг үүрэгтэй олон байгууллага бие даан ажилладаг нь шат дамжлагыг нэмэгдүүлж, хүнд суртал бий болгодог. Мөн төсөв мөнгийг хэмнэлтгүй зарцуулж байна гэдэг үүднээс “Хилийн хяналтын зохицуулга бүхий удирдлага” гэсэн ерөнхий нэг удирдлагад нэгтгэх гэж байгаа юм. Улсууд янз бүрээр шийдсэн байна. Гаальдаа бусад байгууллагаа захируулан нэгтгэж хийсэн нэг хэсэг байна. Зарим нь нэгдсэн захиргаа гаргаж шийдсэн байна. Энэ байгууллага нь аж ахуй, барилга байшингийн асуудлаа хариуцаж, тусгай байгууллагуудаа энэ талын ачаанаас чөлөөлж, хүнд суртал, давхардалгүйгээр, хурдан шуурхай үйлчилж, гадаад худалдааг хөнгөвчлөхөд үйл ажиллагаагаа чиглүүлэх юм. Манай улсын хувьд энэ нэгдсэн захиргааны байгууллагыг байгуулахыг Гаалийн байгууллага дэмжиж байгаа.

**Татварын Ерөнхий газар:** Манайх саналыг дэмжиж байгаа.

**Тагнуулын ерөнхий газар, тасгийн дарга Мөнхбат:** Манайх дэмжиж байгаа.

**С.Дэмбэрэл:** Энэ хилийн боомтын нэдсэн захиргаа гэж, миний ойлгож байгаагаар бол тухайн хил дээр ажиллаж байгаа байгууллагын хуулиар заагдсан бие даасан үйл ажиллагаанд нь оролцохгүйгээр, эдгээр байгууллагуудын хөгжлийн асуудал, түүний дотор нийгмийн хөгжил, хөрөнгө оруулалт энэ бүхнийг нэгтгэж оруулж байх, байгууллага тус бүрийн өөр өөрсдийнх нь тухайн жилийн төлөвлөгөөг нэгтгээд, энэ байгууллага төлөөлөн оруулж ирнэ гэсэн үг үү? Жишээлбэл, одоо Гаалийн ерөнхий газар гэхэд Сангийн яам уруу өөрийнхөө хөрөнгө оруулалтыг шууд өгчихөж байгаа биз дээ? Цаашдаа яах юм бэ? Нэгдсэн байдлаар оруулж байх юм уу? *нэгдцгээрт.*

*Хоёрдугаарт*, энэ захиргаа нь хилийн боомтыг хөгжүүлэх янз янзын зураг төсөл боловсруулаад, хөгжлийн төслүүд гаргаад, энэ төслийг хэрэгжүүлэхэд бодлогынх нь хувьд нэгтгэж базсан ийм институтци байх уу? Хуулийн төсөл дээр тэгж байгаа юу?

*Гуравдугаарт*, Сая худалдаа хөнгөвчлөх гэж ихэнх нь ярилаа. Худалдаа хөнгөвчлөх талаар яг яаж энэ хуулийн үзэл санаанд тусгагдсан юм бэ? Худалдаа хөнгөвчлөх асуудлаа байгууллагуудын хоорондын, Гаалийн байгууллагуудын их олон жил ярьж байгаа integrated border management буюу хилийн интегралчлагдсан менежмент нь энэ хилийн боомтын захиргаагаар хамгийн хөнгөвчлөлтэй нөхцөлөөр, түргэн шуурхай явагдана гэсэн ийм заалт, үзэл санаа нь энд туссан уу? Энийг та нэг тодорхой хэлээд өгөөч.

**Хариулт:** - Засгийн газраас өргөн барьсан хуулийн төслийн үндсэн концепци нь энэ. Одоогийн шалгалтын үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын чиг үүрийг бол багасгаж, нэгтгэж байгаа. Тэгэхээр давхардал арилна гэсэн үг. Нөгөө талаас бол хуулийн төсөл дээр боомтын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу боомтыг барьж байгууллана, ажиллуулна гэж заасан байгаа.

**С.Дэмбэрэл:** Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу боомтыг барьж байгууллана гэхээр, хилийн боомтын нэгдсэн захиргаа үүнийг хариуцана гэсэн үг үү?

**Хариулт:** - Тийм, тэгнэ. Ерөнхий төлөвлөгөөний дагуу, боомтын барилга байгууламж, техник хэрэгсэл сайжраад ирэхээр үйлчилгээ, нэвтрүүлэх чадвар нэмэгдэнэ. Боомт дээр удаан хүлээж гацдаг бизнес эрхлэгчдийн хүндрэлүүд арилна гэж үзэж байгаа. Нөгөө талаасаа, үйлчилгээний стандарт гэж гарч ирнэ. Энэ стандартыг Боомтын нэгдсэн захиргаа баталж хэрэгжүүлнэ. Үүн дээрээ хяналт тавина. Мөн нэг цонхны үйлчилгээ нэвтрүүлэхийг төлөвлөж байгаа. Ерөнхий сайд ч Замын-үүдэд очих үеэрээ 06 сарын 1-ны дотор ийм үйлчилгээ нээх чиглэл өгсөн. Энэ мэтчилэн Нэг талаасаа хяналт шалгалтын давхардлыг цөөлж, оновчтой болгоно. Нөгөө талаасаа дэд бүтэц, ажиллах нөхцлийг сайжруулна. Цахим тоног төхөөрөмж, программ хангамжийг нэвтрүүлнэ. Энэ бүхний үр дүнд таны хэлж байгаа худалдаа хөнгөвчлөх асуудал гайгүй сайн болох байх гэж найдаж байна. Гэхдээ зөвхөн энэ биш, цөөнгүй хууль тогтоомжид өөрчлөлт орно. Жишээлбэл, бид саяхан гаалийн болон татварын хуулинд өөрчлөлт хийж, бүрдүүлэх бичиг баримтын тоог цөөлсөн.

**С.Дэмбэрэл:** Мэргэжлийн хяналтын тухай хуулинд, хилээр бараа бүтээгдхүүн оруулахад зайлшгүй бүрдүүлэх шаардлагатай материалуудын тухай засгийн газрын хэддүгээр тогтоол билээ, /бүүр өмнө гарсан/ импортоор оруулж байгаа бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлэхэд зайлшгүй шаардлагатай гэсэн хавсралттай /173 тоот тогтоол билүү? 2002 оных байна уу?/ тэр тогтоол одоо хүчинтэй хэвээрээ байгаа юу? Дээр нь шинэ хууль батлагдсантай холбогдоод хүнсний тухай хуулинд орсон тэр заалтуудыг хэрэгжүүлэх тийм шаардлагууд оруулсан. Тэгэхлээр энэ бүхэн өөрчлөгдөөгүй байхад яаж тэр хилээр чинь хяналт шалгалтын процедур багасаж, яаж тэр бизнес эрхлэгчдэд худалдаа хөнгөвчлөгдөх юм бэ гэдгийг л би асуугаад байна. Тэгэхлээр энийг нэгтгэж багтаасан хилийн нэгдсэн менежмент, худалдаа хөнгөвчлөх нь л энэ бүх байгууллагуудын олон үйл ажиллагааг тусгасан энэ хуулийн гол амин сүнс л байх ёстой. Тийм биз? Тийм байдлаар засгийн газраас оруулж ирсэн байх гэдгийг лавлаж л би асуугаад



ийм юм асуугаад байна л даа. Энд цахим ч гэж алга. Нэг цонхны үйлчилгээ гэдэг, одоогийн тэр ажилладаггүй, худлаа юмыг авчраад тавьчихсан байна. Өнөө хирнээ ажилладаггүй, бодит байдлаар байгууллагуудыг хамтруулаад суулгачихдаггүй мөртлөө, “Нэг цонхны үйлчилгээ” гэгддэг тэр юмыг Швейцараас тусламжаар хуулж аваад, дүүргүүд дээр хийгээд байгаа. Ийм юмыг хил дээр аваачаад тавина гээд байх юм, энэ чинь худлаа. Энэ цахим нэг цонхны үйлчилгээг л би хэлээд байгаа юм. “Гадаад худалдааны цахим нэг цонхны үйлчилгээ” гэж олон улсын нэрээр нэрлэгддэг худалдаа хөнгөвчлөх үйл ажиллагааны шийдэл энд тусгагдаж уу гээд харахаар л, энд байхгүй байна л даа. Хил дээр ажилладаг энэ байгууллагуудын хамгийн гол үзэл санаа нь энэ л байх ёстой. Энэ рүү нь л энэ хуулийг чиглүүлж гаргаад, энэ хуулийг хэрэгжүүлэхэд хүнд суртал багасна, гадаад худалдааны үйл ажиллагааны зардал багасана, ингэснээрээ барааны эргэлт хурдасна, барааны эргэлт хурдасанаар зах зээл дээрх бүтээгдэхүүн үйлчилгээ түргэн орж ирнэ, ингэснээрээ инфляцын өсөлтөнд эерэгээр нөлөөлөх ёстой. “Гадаад худалдааны цахим нэг цонхны мастер төлөвлөгөө” гэж байгаа. “Гадаад худалдааны цахим нэг цонхны үндэсний хороо” гэж байгуулагдсан байгаа. Тэр хорооны, мастер төлөвлөгөөний дагуу энд байгаа бүх байгууллагууд цахим төхөөрөмжтэй, тийм хүчин чадалтай болсон байх ёстой. Энэний эрх зүйн үндэс нь энэ хуулинд тавигдсан байх ёстой гэж л би үзээд байгаа юм. Энэнийг л би асуугаад байгаа юм л даа. Гэтэл ийм юм ороогүй юм шиг л санагдаад байна. Энийг дахин сайжруулахгүй бол болохгүй шүү. За ажлын хэсгийн бусад гишүүдэд ярих боломжийг нь олгоё.

## **Одоогийн анализыг чинь харахад, дунд хугацаанд Монгол улсын өрийн асуудал хэцүү байдалтай болно**

*Монгол Улсын эдийн засгийн гадаад, дотоод орчин, хөгжлийн явц байдалд судалгаа дүгнэлт хийх, цаашид баримтлах чиг хандлага, даруй авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох цэрэг бүхий ажлын хэсгийн 2013 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс*

**Б.Гарамгайбаатар:** - Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Монгол улсын эдийн засгийн гадаад орчин, гадаад өр, тулгамдаж буй асуудлуудаар судалгаа хийж, ажилласан ажлын хэсэг хуралдаж байна. Товч мэдээлэлийг О.Чулуунбат өгнө.

**О.Чулуунбат:** -Их Хурлын даргаас өгсөн үүргийн дагуу ерөнхийдөө өнөөдрийн манай эдийн засагт үүсээд байгаа байдалд бид дүгнэлт өгөх ёстой. Ийм зорилгоор яам, тамгын газруудаас нэлээн том хүчтэй ажилласан. Мөн хувийн судлаачдыг мөн их дайчилсан. Тэдний судалгаа, тооцооны ажлыг авсан. Нийт энэ ажилтай холбогдуулан 100-аад том тайлан гарсан байгаа. Тэрийг хэрэгтэй гэвэл та бүхэн өөрсдөө харж үзнэ биз. Үндсэндээ дүгнэлт хийгээд 10-аад хуудас тайлан гарсан байгаа. Энэ та бүхний ширээн дээр байгаа. Бүгдийг нь базаад энэ л дээ. Өнөөдөр эдийн засаг яагаад ийм байдалд орчихов, яагаад бизнесийн идэвхгүй үйл ажиллагаа байгаад байна, яагаад хөрөнгө оруулалт явахгүй байна. Энд жишээлбэл, манай

гадаад орчин нөлөөлөв үү, гадаад хөршийн худалдаа, эдийн засгийн байдал маань манай өнөөдрийн хэрэгцээг хангаж байна уу, үгүй юу? Хятадтай юу болж байна, ОХУ-тай яаж байна, дотооддоо Хөрөнгө оруулалтын хууль болж байна уу, үгүй юу, дотоодын манай засгийн төвшин хир байгаа вэ? Засаглал ер нь хэтэрхий төрийн өмчинд ороод байна уу, үгүй юу. Бид нар төрийн өмчөөс гаръя гэсэн том бодлого явуулах гээд оролдоод байдаг. Гэтэл өнөөдрийн алхам маань дандаа буцаад төрийн өмч болох гээд байдаг. Төрийн өмч болж болно л доо. Болохгүй юм юу байх вэ, хэрэгтэй чухал юм нь төрийн өмч байх л ёстой. Гэтэл төрийн өмчөөрөө дамжуулаад дандаа хувийн бизнес, хувийн ах, дүү, хамаатан саднаа шахдаг, төрийн өмчөөр дамжуулаад тийш нь ямар ч хэрэгтэй, хэрэггүй бараа шахдаг. Энэ үйл явдал маань өнөөдөр хүртэл үргэлжлээд байгаа юм. Төрийн зохицуулалт гэдэг чинь өнөөдрийн бидний хэрэгцээнд байна уу, үгүй юу. Гааль, татвар, мэргэжлийн хяналт гээд баахан байцаагчид өөрсдөө дангаараа очиж хүн торгох эрхтэй. Тэгээд ганцаараа очоод тэрбум төгрөгийн торгууль сонсгочихоод 500 болгож буулгаж өгье, тэгэхээр 100-г өгчихөөч гэдэг юм уу ийм наймааны бизнес болчихсон. Өнөөдрийн сонин, хэвлэлээр гараад байгаа том шүүмжлэл бол ерөөсөө яг энэ схемийн төрийн зохицуулалтын наймааны бизнес болчихсон. Татвар дээр ч тэр, гааль дээр ч тэр, мэргэжлийн хяналт зэрэг бүгд иймэрхүү байдалтай байж байна. Энэ бүгдийг дүгнэсэн ийм дүгнэлтийн тайлан гаргачихсан байгаа. Та бүхэн энэ дээр үгийг нь бид сул хийсэн байна уу, тэгвэл бас чангалмаар хэрэгтэй бол тэгж санаа гаргаж болно. Эсвэл бид хэтэрхий шууд хатуу үгээр хэлчихсэн байж болох юм. Ямар, ямар тоо баримтаар нэмж баталгаажуулах хэрэгтэй байна вэ. Яахав, том тайлан дээр ерөнхийдөө бүх тоо баримтууд нь байгаа. Бодвол бидний ширээн дээр байгаа арваадхан хуудас материал бол олон нийтэд ч гарч болох ийм бүрэн бололцоотой. 11 гишүүнтэй Их Хурлын ажлын хэсэг л шийднэ. Товчхондоо ийм л мэдээлэл байна. Үүнтэй холбогдуулан би эндээс асуух бөгөөд ажлын хэсгээс асуух асуулт гарвал хариулъя.

**С.Дэмбэрэл:** - Надад ганц хоёр асуулт байна. Гол нь санаануудаа л хэлчихье. Энэ материалын дэлгэрэнгүй болон хураангуйн аль алинтай нь би танилцсан. Энд дутуу байгаа юм юу байсан бэ гэжээр ядуурлын анализ байхгүй байсан. Энэ чинь Монголын нийгэмд архагшсан үзэгдэл шүү дээ. Энийг хөндөхгүйгээр аливаа эдийн засгийн юм явагдаж болохгүй. *Нэгдүгээрт энэ.*

Сая ажлын хэсгийн дэд хэсгийн хүмүүстэй ярилцаж байхад энэ дээр ойрын хугацаанд хийхэд боломжтой. Үндэсний статистикийн газар олон жилийн бүх материалууд нь байж байгаа. Тийм ээ, Мэндээ? Энэ дээр хийгдсэн дүгнэлт нь байж байгаа. Тийм учраас энэ архагшсан ядуурлыг яаж боломж болгох вэ гэдэг тал дээр л зөвлөмж гаргах хэрэгтэй. Мөн үүнтэй шууд холбоотой хоёр сектор байгаа. Нэг нь, байгаль орчны доройтол гэж орсон байна. Гэхдээ байгаль орчны доройтол дээр материалууд бас дутуу байна. Өмнө нь, 2011 онд гарчихсан эмзэг байдлаас тогтвортой байдал руу гэсэн илтгэл байж байгаа. Дараа нь хамгийн сүүлд Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас хийсэн зүйлүүд ч байгаа. Үүн дээр ус болон ойн цаашдын асуудал заавал нэмэгдэж ороод, энүүн дээр суурилсан зөвлөмж байх ёстой. Үүнийг нэмж хийх шаардлагатай гэж бодож байна.

*Гуравдугаарх нь,* эрүүл мэнд орсонгүй. Эрүүл мэндийн өнөөдрийн анализаас үзэхэд эрүүл мэнд маань өөрөө ядууралтай шууд корреляцид /хамааралд/ орчихсон. Тэгээд бас Монголын эдийн засаг, оролцоотой хөгжлийн, тогтвортой хөгжлийн асуудал ч байх ёстой. Яагаад гэвэл энэ

зөвлөмж дээр ногоон эдийн засаг, тогтвортой хөгжлийг цаашдаа Монголын төрийн баримтлах гол шугам гээд зөвлөчихсөн байгаа. Тийм байх аа? Миний уншсанаар, би тэгж санаж байна. Энэ чинь угаасаа ойлгомжтой зүйл. Тэрний гол компинент болох эрүүл мэндийн өнөөгийн байдлын анализ, түүн дээр түшиглэсэн судалгаа 2012 оны байдлаар Эрүүл мэндийн яаман дээр гарчихсан байгаа. Тэрний гол дүгнэлтүүдийг оруулах ёстой. Нэг ийм асуудал байна.

Дээр нь ядуурал, эрүүл мэнд, байгаль орчин гэсэн энэ гурав маань ингэж холилдоод, түрүүний эдийн засгийнхаа бодит секторын бодлого зэрэгтэй нийлэхээр цаашдаа тогтвортой хөгжлийн чиглэлээр Монгол улс юу хийх вэ гэдэг ерөнхий дүр зураг, тэрийг зөвлөмж болгосон ийм зүйлүүд гарч ирэх ёстой. Ерөнхий эдийн засгийн байдал дээр хийсэн анализыудыг хараад байхад үзүүлэлтүүд дутуу байна. Түрүүн би энийг Чимиддагвад хэлчихсэн. Үндэсний нийт орлогыг тооцдог болох. Үүнийг тооцох бүрэн боломжтой байгаа. Дээр нь ДНБ болон үндэсний нийт бүтээгдэхүүний хоорондын салбарын бүтэц, энэний анализыг 2005, 2011 оны ерөнхий яс тоон дээр харахад, бүтцийн өөрчлөлт Монголын эдийн засагт сүүлийн жилүүдэд хир зэрэг явагдаж байна вэ гэдэг нь тодорхой биш байна. Бид ярьдаг макро үзүүлэлтүүдийг л тавьчихсан байна. Тийм учраас ажлын хэсгийнхэн сая надтай ярьж байхад санал нэгдэж байсан. Энийг нэмж оруулах нь зүйтэй юм байна гэж, тийм үү?

Дээр нь, гадаад эдийн засгийн харилцаан дээр хэдийгээр мэдээж хэрэг гадаад дипломат харьцааны хоёр улс орнууд дээр анхаарах ёстой юмнууд тусгагдсан ч гэсэн худалдааны нөхцөлүүд сүүлийн жилүүдэд мөн л маш архагшсан байдалтай байж байгаа. Энийг яах шийдэл нь экспортын, уул уурхайн бус экспортыг хэрхэн яаж хөгжүүлэх вэ, ямар инсентив өгөх вэ гэдэг асуудал гарч ирэх ёстой. Тэрний материалыг Эдийн засгийн хөгжлийн яам, танхим хоёр хамтарч хийгээд бараг дуусах гэж байгаа. Энэ бол өөрөө *subproduct* нь болох ёстой. Дагалдах бүтээгдэхүүн. Түрүүний ногоон эдийн засаг дээр, одоо энэ дээр ажлын хэсэг сууж байгаа. Ногоон эдийн засгийг хэмжих ажлын хэсэг хамт сууж байгаа. Энэ дээр бас нэг юм гаргана, хоёр дахь *subproduct* нь. Өөрөөр хэлбэл, энэ рекомендацийн дагуу гаргах тодорхой бүтээгдэхүүнд. Рекомендаци гэдэг, зөвлөмж гэдэг маань өөрөө хэнд зөвлөөд байгааг нь бас ойлгохгүй байна. Энэ өөрөө зөвлөмж биш, үйл ажиллагааны төлөвлөгөө маркаар цаашаа гарах ёстой байх.

Санхүүгийн сектор дээр нэг анхаарах юм байгаа. Бас Эдийн засгийн байнгын хорооны даргын, Эдийн засгийн байнгын хорооны тогтоолоор санхүүгийн секторын реформ ба зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулах альтернатив бодлого боловсруулах ажлын хэсэг гээд гарчихсан. Тэрийг би ахалж байгаа. Бид одоо ерөнхийдөө юмаа хийнэ. Энэ ажлын хэсгийн бүтээгдэхүүн Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк энэ дөрвийн гаргасан албан ёсны албан бичиг байгаа байх. Яагаад гэвэл ийм юм гарах ёстой. Энэ бүхэнтэй харьцуулаад энэ өөрөө гурав дахь *subproduct* болж гарч ирэх ёстой. Өөрөөр хэлбэл, зөвлөмж өглөө, зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө бүхий ийм бодлогын баримт бичгүүд гарах. Би их хүнд юм яриад байгаа юм биш шүү. Бараг л бэлэн болчихсон юмнуудыг яриад байгаа юм.

*Дөрөвт нь, санхүүгийн сектор дээр зээлийн хүү нэг оронтой тоонд орох ямар зөвлөмж байна вэ? Санхүүгийн секторын реформ дээр мэдээж хэрэг Санхүүгийн зохицуулах хороо үнэт цаасны зах зээл, цаашдаа хөрөнгө оруулалтын сан гээд явчихна. Өнөөгийн санхүүгийн секторт байгаа энэ*

харьцаа эрүүл харьцуу юу, үгүй юу? Энийг цаашдаа яаж засах юм бэ? 90, 5, 5 гэсэн харьцаа. Энэ 10 яаж болгох юм бэ, 15 яаж болгох юм бэ? Тэгсэн мөртлөө банкны сектор нь хүчирхэг, өргөн үйлчилгээтэй. Тэгсэн мөртлөө банк бус санхүүгийн бусад сектор яаж ажиллах вэ? Энэ ямар зөвлөмжүүд энэ дотор тусгагдсан юм бэ гэсэн ийм асуулт буюу цаашдаа анхаарах зүйлүүд байгаа юм.

Хэмжүүрийн хувьд би нэг зүйлийг хэлчихье. Одоо Үндэсний статистикийн хорооны дарга Мэндсайхан сууж байна. Бид ногоон өсөлтийг хэмжих хэмжүүр гээд гаргалаа. Саяын ярьсан зүйлүүд бас танай дээр байж байгаа шүү дээ. Энэ үзүүлэлтүүдийгээ анх удаа энэ илтгэлдээ оруулж өгмөөр байна. Тэгээд энэ дээрээ суурилсан макро анализ хийгээд, GDP-ээс энэ улс нэлээн юм харж болдог. Тэр үзүүлэлтүүд нь бэлэн байгаа юмнуудыг яагаад анализыг жаахан өргөтгөхөд л асуудал болчихож байгаа юм. Тэгэхээр иймэрхүү үзүүлэлтүүдийг нэмж оруулаад, ингэснээрээ энэ комиссын /комисс гэж нэрлэе л дээ/ илтгэл 2014 оны Улсын Их Хурлын үндсэн чиглэл Монгол улсын бусад үйл ажиллагааг дүгнэж байна гэхэд энэ бол их чухал бодлогын баримт бичиг, гарын авлага нь болж байдаг, стратеги нь болж байдаг. Энийг Их Хурлын гишүүд гараад GN, GDP хоёрын зөрүү нь яагаад ингэчихэв гэж анализыг нь сонсож байдаг. Энийг нь холбогдох байгууллагууд нь өөрөө өөрсдийнхөө дүгнэлтийг хийгээд, энэ маань цаашдын хэрэгжүүлэх бодлогод шингэж байдаг ийм зүйлүүдийг, бид түрүүн хэмжүүр гэдэг дээр. Өөрөөр хэлбэл, бид нар макро эдийн засгийн хэвшиж тогтсон стандарт үзүүлэлт, тэрэнд суурилсан сэтгэлгээнээс салах хэрэгтэй. Тэгээд эндээс бэлэн байгаа үзүүлэлтүүдийг оруулж өгөөд, хүний амьдрал уруу илүү ойртсон, тогтвортой хөгжил гэдгийг харуулсан, тэр үзүүлэлтийн систем, тэр секторуудын үйл ажиллагааны анализыг хийх хэрэгтэй. Тэр нь одоогийн Монголын төвшинд байгаль орчин, эрүүл мэнд. Энэ хоёрын л гүнзгий анализ. Энэ хоёр анализ нь хийгдчихсэн байгаа. Энэ бүх юмыг манай энэ ажлын хэсгийнхэн аваад, дахиад ингэчихвэл их зүгээр болно гэсэн ийм л бодол байна...

**С.Дэмбэрэл:** - Түрүүн би ерөнхийдөө та нарт асуулт маягаар, орхисон юмыг чинь л хэлсэн. Одоо яг бодитой, тэгсэн мөртлөө судалгааны чинь хүрээг өргөжүүлэхгүйгээр, дотор нь хийх зүйлс байна.

*Нэгдүгээрт*, төрийн зохицуулалт хэт их байна гэж бичжээ. Тэр дүгнэлт зөв. Гэхдээ энэнээс гарах гаргалгаа нь юу юм бэ? Юу байх юм бэ? Энийгээ бичих ёстой. Тэр нь жишээлбэл, миний харж байгаагаар нэгдүгээрт, Төрийн зохицуулалтын тухай хууль яаралтай санаачилж Улсын Их Хуралд оруулах. Энэ хууль тогтоомжийг 2016 он хүртэлх төлөвлөгөөн дотор ерөнхийдөө хоёр, гурван хуулинд хуваагдаад суучихсан байгаа юм. Тийм учраас энэ талаас нь нэгдүгээрт.

*Хоёрдугаарт*, гадаад харилцаан дээр ярьсан байна. Ганцхан дүгнэлт дутагдаж байна. Монгол улсын гадаад харилцааны нэгдсэн нэг цонхны бодлого алдагдсан гэсэн дүгнэлт байх байсан. Тийм биз дээ? Тийм учраас тэр цонхны чинь бодлого алдагдчихаад байна. Тийм учраас Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж гарсан шүү дээ. Тэр нь зүгээр гадагшаа харьцахдаа нэг цонхоор харьцаж бай гэсэн болохоос, угаасаа энэ улс орнуудтай харьцах юман дээр алдагдчихсан байна. Тэр нь институци хоорондын уялдаа.

*Гуравдугаарх нь*, тэнд гадаад харилцаан дээр Европын холбоо түшвэл GSP plus. Энэ олон жил ярьсан зүйл. Юу дугаад байна вэ гэвэл одоо GSP авч байгаа улс орнуудынхаа GSP-гийнх нь хөнгөлөлтийн системд анализ хийгээд Монголын экспортын бүтээгдэхүүнийг яаж тэр рүү нь илүү сайн

суулгаж өгөх вэ. Мөн түүний дотор GSP өгөхгүй байгаа улс, тухайлбал, Солонгос улс байна. Солонгос улс OECD ангиллаар бол өнөөдөр хөгжилтэй орон. Гэтэл Солонгос улсын Японтой адилхан ЕРА буюу чөлөөт худалдааны хэлэлцээр, эдийн засгийн гэдэг шиг тийм зүйл юманд нь яаж тусгаж өгөх вэ гэсэн тийм тодорхой зөвлөмж байх ёстой. Энэ гадаад харилцааны чиглэлээр.

*Дөрөвдүгээрт*, ногоон эдийн засгийн хувьд би түрүүн хэлчихсэн. Энд манай ногоон эдийн засгийн багийнхан сууж байна. Эндээс нэг юм гарна. Би түрүүн subproduct гэж хэлээд байгаа юм. Дагалдах бүтээгдэхүүн гэж. Энэ дагалдах бүтээгдэхүүн гарахад энэ нь өөрөө үүний нэг юу байх ёстой. Энэ зөвлөмж хэнд зориулагдсан юм бэ гэхээр төрд зориулагдсан. Төр гэж хэн юм бэ гэхээр Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар. Энэ гурав нийлэхээрээ юу болдог юм бэ гэхээр үндэсний аюулгүй байдлын зөвлөл. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл рүү хандсан ийм зөвлөмж маягаар, тэгээд эргүүлээд нөгөө гурван субъект руугаа ингэж цацагдах ийм талаас нь бодож энийг хийх ёстой. Хүмүүс хэлж байна. Г.Батхүү хэлж байна. Үнэн. Хөдөөгийн хөгжил, тэр талын юм нь орхигдсон байна. Жижиг, дунд бизнес гэдэг дээрээ дотроо анализ нь бас орхигдож. Өнөөгийн хуваарилж байгаа системийг шүүмжлэх хэрэгтэй шүү дээ. Чимиддагва чи өөрөө энийг маш сайн мэднэ. Төр, хувийн хэвшлийн тэгш, шударга оролцоо байхгүй, өмнөх Засгийн газрын үед. Энийг өөрчлөх тийм рекомендаци байх ёстой шүү дээ. Тийм учраас хуваарилалт чинь шог байна, энийг өөрчил гэсэн рекомендаци өгмөөр байна. Би тэгж өөрөө хэлсэн, хатуу байх ёстой, үнэн байх ёстой. Зөөлхөн байж болохгүй, нялцганасан байж болохгүй, ерөнхий байж болохгүй.

*Тавдугаарт* ядуурал гээд. Энэ ядуурлын ганцхан өнөөдрийн манай хандлага ямар байгаа вэ гэхээр “ок, ядууралтай юм байна, ажлын байр бий болгоод байя” гэсэн тийм ерөнхий. Гэтэл бүх энэ гаргачихсан судалгаагаар энэ нь өөрөө олон хэмжүүртэй гэж байгаа юм. Олон хэмжүүртэй нь өөрөө судалгаагаар батлагдаад байгаа юм. Тэр нь эрүүл мэндийн үзүүлэлт. Энийгээ хийсэн. Ядуурлын архагшсан байдлаас дараагийн дунд хугацаанд ааж гаргах вэ гэсэн хоёр өгцүлбэр байх хэрэгтэй.

*Зургаадугаарт*, санхүүгийн тогтвортой байдал ойрын саруудад, дараа жил ямар байх юм бэ. Санхүүгийн тогтвортой байдлыг хангадаг төрийн институцүүдийн хоорондын ажиллагаа ямар байх юм. Энэ жил миний ойлгож байгаагаар хоёр удаа л хуралдсан байх. Тэндээ оролцооны төвшин маш хязгаарлагдмал. Энийг Эдийн засгийн байнгын хороон дээр бид ярьж байсан. Энэ нь цаашдаа энэ дотор орж санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, институцүүдийнхээ хувьд яах юм бэ гэдэг нэг асуудал байна.

*Дараагийн асуудлууд*, Монгол улсын төрийн институцүүдийн хоорондын ажлын уялдаа, чадавх. Энэ өнөөдөр маш муу бөгөөд энэ үйл ажиллагааг тормослох ийм төвшинд оччихсон байгааг энэ дээр ерөнхийдөө хатуугаар дурдаад өгчих хэрэгтэй. Энийг цаашид сайжруулах гол арга зам нь энэ төрийн институци, төр ингэж хамаагүй ордог тэр зүйлүүдээс хязгаарлах ийм зүйл. Яаралтай өөрчлөх хуулиудыг хэлж өгөх ёстой. Жишээлбэл, Засгийн газрын бараа, үйлчилгээ худалдан авах хууль. Эдийн засгийн хөгжлийн сайд өөрөө хэлсэн, эртээд хурал дээр. Тормос болж байгаа хууль байна гэж хоёр удаа хэлсэн. Бүх яамдын сайд нар мэдэж байгаа. 500-700 өдрөөр энэ ажил чинь явахгүй байна, Монголын сезоны эдийн засагт энэ чинь өөрөө нэмэлт засаглалын садаа болж гарч ирээд байна. Энийг яаралтай өөрчлөх хэрэгтэй. Жишээлбэл, миний хувийн санал



бол тэрбум төгрөгөөс доогуур бол ямар ч тендерийн эрх байх хэрэггүй. Хүнд итгэсэн бол итгэ. Тэгээд шалга. Хөндлөнгийн хяналт шалгалтыг оруулж ирэх ёстой. Ийм зүйлийг рекомендаци хийж болно шүү дээ.

*Үнийн тогтворжуулалт, механизм.* Үнийн тогтворжуулалтын энэ механизм үр дүнгээ өгч байна уу, цаашид яаж сайжруулах гэсэн нэг юм уу, хоёр өгүүлбэр бас байх хэрэгтэй. Дэд хөтөлбөрүүд явж байна. Энэ өөрөө явж байгаа. Инфляцийн supply, нийлүүлэлтийн тал дээр. Энэ талын юман дээр хоёр өгүүлбэр бас баймаар байна. Институциудыг хэлсэн. Институциуд нь үр ашиггүй бөгөөд хомсдолтой ажиллаж байна. Тийм учраас энэ өөрөө олонхи болчихсон. Одоо гэхэд л бид хуулиар шинэ институци байгуулах гээд л явж байгаа. Энийг, энэ апититыг яаж хязгаарлах юм бэ. Энэ асуудал дээр.

*Бонд.* Бондыг зүгээр дурдаад орхичихсон байсан. Энэ дурдсаныг бүгд мэднэ шүү дээ. Гэтэл эртээд Их Хурлын даргын өрөөнд, Их Хурлын дарга юу гэж хэллээ, өвлийн зоорь ч гэдэг юм уу, энэ юман дээр та нар шүүмжлэлтэй ханддаг нүд чинь хаана байна? Дурдах гэж тавиагүй, нүд шүүмжлэлтэй хандаад. Жишээлбэл, энэ дээр одоо Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дэргэдэх Жижиг, дунд үйлдвэрлэлийн хорооноос жижиг дунд бизнест мөнгө хуваарилаач ээ гээд хэлээд байгаа юм. Тэгэхээр энд чиний хэлсэн, өмнөх дөрвөн жилд тавьчихсан мөнгө чинь муу байдлаар хуваарилагдсан ч гэсэн яг одоо бодит байдал дээр тэр чинь хугацаанаасаа болоод эргэж ирэх нь бага байгаа. Эргэж цугларах нь. Тэгвэл механизмаа сайжруулах, дээр нь нэмэлт эх үүсвэрийг бондын мөнгөнөөс дор хаяж 100 сая доллар гэсэн тийм байдалтайгаар тодорхой зөвлөмж өг л дөө. Энэ зөвлөмжийг л бид хүлээж байна. Энэ зөвлөмжийг л өгмөөр байна.

*Монгол Улсын өрийн асуудал.* Дунд хугацаанд Монгол улсын өрийн асуудал хэцүү болно. Одоогийн анализыг чинь харахад. Тийм биз? Энэ чинь төлбөрийн баланстай шууд холбогдож эхэлнэ. Тэгэхээр энэ өрийн асуудлаар цаашдаа энийг яаж тогтвортой байлгах талаар юу байх юм бэ?

*Худалдаа.* Хамгийн орхигдсон юм нь транспорт логистикийн сектор, тэр чигээрээ орхигдчихож. Транспорт логистикаар одоо бид нар яг үнэндээ хэлэхэд тодорхой бодлого алга байна шүү дээ. Төмөр зам нь яах гээд байгаа юм, агаарын тээвэр нь. Сүүлийн үед Батбаяр таван чиглэл яриад байдаг. Тэр бол тэнгэрт явж байна. Яг одоо Монгол улс энд хөрш орнуудтай, Хятадын зүүн хойд мужийн Жилинийг сонгох юм уу, бусад боомтуудыг нь сонгох юм уу. Тэгээд НҮБ-ын одоо, Мянганы хөгжлийн зорилтын 8 дугаар зорилтынх нь нэг юман дээр далайд гарцгүй орнуудад тээвэр логистикийн энэ талын юм болон олон улсын конвенц. Энэний олон талын механизмыг гадаад бодлогынхоо юман дээр яаж суулгаж өгөх юм бэ. Энэ асуудал бас ороогүй байна. Түрүүний Мянганы хөгжлийн зорилтын, 2015 онд дуусна. Энэ дээр хэд хэдэн зорилтууд нь тасарна. Одоо ерөнхийдөө тасраад явж байгаа. 8 дугаар зорилт дээр байгаа одоо Монгол улс ялангуяа Эдийн засгийн хөгжлийн яам энийг анхаараарай. Ингэж хэлээд байгаа шүү. Бид одоо Дэлхийн банкны ангиллаар дунд. Гэтэл тэрний 8-ын 5 дээр нь, “г” дээр нь ч билүү ингээд биччихсэн байгаа юм. GNI-г тооцно. ODA авахын тулд GNI-аар тооцсон тэр тооцоог тэгвэл ODA авч болно гэж. Бидний өнөөдрийн Монголын бодит байдал бол бид ODA авах төвшинд хэвээрээ л байна. Нийгмийнхээ яг эдийн засгийн бодит амьдрал уруу орвол. Тэгэхээр мэдээж хэрэг, бусад зээлээ авахаас гадна ODA-ээс бас татгалзахгүй байх зөвлөмжийг энэ Мянганы хөгжлийнхөө юман дээр бас уялдуулаад хэлээд өгчихвөл 8-ын хэддүгээр зорилттой уялдуулаад хэлээд өгчихвөл их зүйтэй байх. Транспорт ороогүй байсан.

*Хамгийн сүүлд нь social. Нийгмийн security.* Хоёрхон өгүүлбэр хэрэгтэй. Тэр нь юу юм бэ гэхээр өнөөдөр Монголд халамжийн нуугдмал систем яваад байна, амь бөхтэй оршсоор байна. Зөв үү, Чука? Тийм учраас аливаа халамжийн бүх системийг conditional cash transfer буюу нөхцөлт мөнгөн шилжүүлгийн зарчим болгох ёстой гэсэн ийм зөвлөмж байхад л боллоо. Миний хэлэх зүйлүүд, энэ бүхнийг зөвлөмжиндөө оруулаад, ингэвэл ер нь аятайхан юм болчихож магадгүй шүү. Баярлалаа.

**Б.Гарамгайбаатар:** - Үг хэлж дууслаа. Бид нар энэ тайлангийн хүрээнд л ажлаа дүгнэхээс өөр арга байхгүй. Яагаад гэвэл энэ мөнгө байхгүй, хөрөнгө байхгүй. Энэ олон улсуудын юунд бид Эдийн засгийн байнгын хороо өөрийнхөө боломжтой зардлыг гаргаад энийг хийлгэсэн байгаа. Бид нарын гол зорилго бол гишүүдийн саналыг мэдээж авна. Гэхдээ бид бас өргөн дэлгэр утгаар нь гэдэг юм уу, гишүүдийн хэлж байгаа тэр бүх саналыг авах боломж үнэхээр байхгүй. Өнөөдөр би Энх-Амгалан гишүүний хэлсэнтэй ойролцоо санал хэлэх гээд байна. Нэг ёсондоо бид нар өнөөдөр үндсэн чиглэл, одоо 2016 оныг хүртэлх төлөвлөлт, хөрөнгө оруулалтын чиглэлүүдийг тодорхойлох гээд байгаа учраас энэ зөвлөмж дээр тэр асуудлуудыг яаралтай, энэ яамдуудын хоорондын уялдаа холбоо байхгүй гээд энэ дүгнэлтэд гарчихсан байж байгаа шүү дээ. Энэ уялдаа холбоог сайжруулах асуудал. Дээр нь хоёр талын гадаад, дотоод орчны байдал гэхээр Орос, Хятад хоёр улстай байгуулсан гэрээ, хэлцлүүдийн зогсчихсон байгаа нөхцөлүүдийг бид нар яавал хөдөлгөх юм, ингэснээр эдийн засагт ямар ач холбогдол өгөх юм бэ гэдэг энэ асуудал. Төмөр замын асуудал, автозамын асуудал, энэ бүгдийг уг нь задалж, энэ нь эргээд нийгэмд ямар ашигтай юм гээд энэ асуудлуудыг бид энэ тайланд тусгах гэж оролдсон. Тэгэхээр энийгээ бид ажил болгохын тулд аль болохоор энэ тайлангийнхаа энэ дотор байгаа асуудлуудтай уяж явбал дээр байх гэж ингэж бодож байгаа юм. Гадаад өрийн асуудал ярихаар гадаад өрийн тухай хуулийн асуудал яригдаад эхэлж байгаа шүү дээ. Тэр асуудлуудаа хүртэл бид нар энд оруулчихсан байгаа шүү дээ. Хөрөнгө оруулалтын хуулийг оруулах асуудлыг энд оруулсан байгаа. Энэ бүгдийг бид нэгэнт хийсэн гэж ингэж би үзэж байгаа юм. Ажлын хэсгийн даргын хувьд. Бидэнд хугацаа алгуурлаад байх тусам бид нарын хийж байгаа тайлан үр дүнгүй, нэг ёсондоо ач холбогдолгүй болох гээд байгаа юм. Тийм учраас би 5 дугаар сарын 17 гэсэн. Харин 5 дугаар сарын 17-ноос хойш ажлын хэсгийн гишүүдэд материалыг танилцуулаад, үүнтэй сайтар танилцуулаад, дээр нь гишүүд энэ доторх хүрээн дотор саналуудаа боловсруулж өгөөч ээ гэж ингэж хэлж энэ ажлын хэсгийн хуралдааныг зарласан байгаа юм. Тийм учраас энэ тайлан дотор С.Дэмбэрэл гишүүний зарим Чимиддагватай ярьсан ярианууд байдаг юм уу, тэр асуудлуудыг орох газар байгаа бол тэр хэсгүүдэд нь оруулаад энэ тайланг бид нар хамгаалах ёстой. Тэртэй тэргүй чуулганд оруулах ёстой. Энэ дээр гол чиглэлүүд нь, дүгнэлтүүд нь бас заагдчихсан байгаа. Дөрөв, таван дүгнэлт байгаа юм.

Нэгдүгээрт, хамгийн чухал юм бол манай яамдуудын уялдаа, холбоо туйлын хангалтгүй байна гэдэг нэг дүгнэлт гарч ирсэн. Хоёрдугаарт, Орос, Хятад, Орос улсуудтай байгуулсан гэрээнүүд зогсонги байдалд орчихсон байна. Энийг гарах арга замуудыг олох ийм, ийм арга замууд байна гэдэг чиглэлүүдийг өгчихсөн байгаа. Гуравдугаарт, банк, санхүүг сүүлд нэмэх асуудлыг Чулуунбат сайд ярьсан байгаа. Гэх мэтийн энэ асуудлуудаа эхлээд бид нар оруулчихаад дараа нь нэгдсэн том бодлогын шийдвэрүүдийг гаргах асуудлыг дахиад өөр юугаар хийсэн нь илүү оновчтой байх гэж ингэж бодож байна.

**С.Дэмбэрэл:** - Би нэг тайлбар хэлчихье. Саяын миний хэлсэн үг бол ажлын хэсгийнхэнд маш тодорхой ойлгогдож байгаа. Тийм биз? Энэ ерөөсөө хийсэн юмыг эвдэхгүй.

**Б.Гарамгайбаатар:** - Эвдэхгүй бол эвдэхгүй юмнуудыг нь оруулна шүү дээ.

**С.Дэмбэрэл:** - Энийг эвдэх биш, баяжуулах юмыг нь л би хэлээд байна шүү дээ. Өөрөөр хэлбэл, дутуу гэдгээ. Энэ чинь нөгөө илтгэл дотроо байж байгаа. Рекомендаци гэдэг дээрээ ингээд, ингээд шигтгээд оруулчих асуудал байна. Бусад нь ерөнхийдөө бэлэн байгаа юм. Жишээлбэл, чамд өөрт чинь аравхан минутын ажил. Тийм биз, Чимиддагва аа? Ядуурлын тоо нь, Мэндсайхан тэнд сууж байна. Ингээд л энийг тавьчих, тэрийгээ биччих. Multidimensional болсон байна. Тийм учраас өнөөгийн хандлагаараа өөрчилчих гээд л биччих. Тийм биз дээ, Чука? Би ийм юм хэлээд байгаа байхгүй юу. Тэгээд нөгөө юм нь, бас нэг зарчмын зөрүүтэй санал нь юу вэ гэхээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хаяглая гэж хэлээд байгаа юм шүү дээ. Яагаад гэвэл гурван субъект нь байж байгаа юм. Ерөнхийлөгч, Их Хурлын дарга, Ерөнхий сайд гээд. Энэ гурван хүнд л гурвууланд нь хаягласан байвал энэ маань өөрөө иж бүрэн бөгөөд хүчтэй болно. Дараа нь энийг чинь авч үзээд, эргээд нөгөө чиглэл, зөвлөмжийн чанартай гаргах юм. Тэгэхээр хэрэгжих магадлал нь их өндөр болно гэсэн үг юм. Жишээлбэл, бид сая институцүүдийн, өөрөөр хэлбэл, яамдын юм гээд хамгийн түрүүнд хэллээ шүү дээ. Тэр үнэхээр зөв. Гэтэл тэрэн дээр чинь Засгийн газрын бараа худалдан авалт өөрөө нэг гол садаа нь болоод байгаа юм. Тэрийг жишээлбэл, зөвлөмжөөр жаахан дэлгэрүүлээд оруулаад өгчих гэсэн тийм санаа юм.

**Б.Гарамгайбаатар:** - Г.Батхүү дарга аа, Их Хурлын даргын захирамжийг Их Хурлын төвшинд л гаргана биз дээ. Бид судалгааны материалаа тэгж л өгнө шүү дээ. Тэрнээс дээш нь шууд өгч болдог юм уу? Үндэсний аюулгүй байдлын зөвлөл зэрэгт.

**С.Дэмбэрэл:** -Болно.

**Б.Гарамгайбаатар:** -Тэгвэл тэр чиглэлээр өргөтгөж, тэр саналаа явуулах юм байна шүү дээ. Ер нь Засгийн газар, Их Хурал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл гуравт зөвлөмж, саналуудаа өгөөд явах.

**Л.Энх-Амгалан:** -Нэг зүйл тодруулах гээд байна л даа. Мэдээж, гадаад, дотоод орчиндоо дүгнэлт өгчихлөө, ямар ч байсан нөхцөл байдал ийм байгаа юм байна гээд. Тэгэхээр одоо эндээс чинь гарах үр дүн гэхээр бид нар Улсын Их Хурлын тогтоолын төсөл Улсын Их Хуралд энэ дүгнэлттэй хамт өргөн барих гэж байна уу, эсвэл яах гэж байна вэ? Уг нь миний санаж байгаагаар 2008 онд эдийн засгийн хямралыг даван туулах тухай авч хэрэгжүүлэх арга хэмжээ гээд маш сайн Улсын Их Хурлын тогтоол гарсан шүү дээ. Яг тэрэнтэй адилхан нөхцөл байдал ийм болчихоод байгаа юм чинь энэ нөхцөл байдлаас бид нар яаж гарах юм, яах юм бэ гэдэг дээр Улсын Их Хурлаас авч хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалт гэх үү, тогтоол гэх үү, ийм төсөл л бид бэлдвэл. Та тоймтой дөрөв, таван л юм хэлж байна шүү дээ. Ийм тоймтой дөрөв, таван юман дээрээ л.

**С.Дэмбэрэл:** -Жаахан нэмье л дээ. Энэ дотор байгаа юмнууд чинь гурвууланд нь, Үндэсний аюулгүй байдлын, тэр гурван субъектэд очмоор тийм зүйлүүд байгаа юм.

## **Амьдралаас жаахан тасархайдуу хууль болох байх**

*Монгол Улсын Их Хурлын 2013 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс: Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай (Шинэчилсэн найруулга), Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Терроризмтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх цээр.*

**Х.Тэмүүжин:** - Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль 2006 онд батлагдсан бөгөөд уг хуулиар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар зохицуулалтыг тусгасан. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй хууль зүйн салбарын цогц бодлогын хүрээнд шударга ёсыг хамгаалах тогтолцооны шинэчлэх хуулиудыг боловсруулж байгаатай холбогдуулан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох зүй ёсны шаардлага урган гарч байна. Монгол Улсад банк, санхүүгийн тогтолцоо хурдацтай хөгжиж, гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэхийн хирээр сүүлийн жилүүдэд зохион байгуулалтын шинжтэй нууц далд аргаар үйлдэгддэг мөнгө угаах гэмт хэргийг үйлдэх арга хэлбэр улам нарийсч үндэстэн дамнасан зохион байгуулалтын шинжтэй болж байна. Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллага болон Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага ФАТФ [The Financial Action Task Force FATF]-ын гишүүн орны хувьд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр олон улсын гэрээ, конвенциэр хүлээсэн үүрэг улам өргөн хүрээтэй болж байна. НҮБ-ын Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенци, 2005 онд Авлигын эсрэг конвенци, 2008 онд үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенци болон санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын байгууллагын зөвлөмжид тусгагдсан шаардлагад Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрх зүйн орчин бүрэн нийцээгүй байгаа нь манай улсын банк, санхүүгийн үйл ажиллагаа, мөнгө угаах болон бусад гэмт хэргийн үйлдэлд өртөх эрсдэл хэвээр байгааг харуулж байгаа бөгөөд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр олон улсын байгууллагатай цаашид хамтран ажилладаггүй орны тоонд буюу хар жагсаалтад орж болзошгүй байна.

Иймд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх талаарх хяналтын тогтолцоог сайжруулах, төрийн байгууллагуудын үүргийг нарийвчлан тодорхой болгох, нэр томъёог жигдлэх, олон улсын стандартад хэрэгжүүлэх чиглэлээр мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгнө үү.

**З.Энхболд:** - Гишүүд асуулт асууж хариулт авлаа. Үг хэлэх гишүүд байвал нэрээ өгнө үү. Дэмжсэн 3, эсэргүүцсэн 3, нийт 6 гишүүн үг хэлнэ.

**С.Дэмбэрэл:** - За баярлалаа. Энэ хуулийн төслийг хараад, тэгээд ер нь бусад улс орнуудын энэ чиглэлийн хууль, тогтоомж энэ мөнгө угаахын талаарх ойлголт, мөнгө угаах аргууд, хэлбэрүүд гэдгийг ингээд харьцуулаад үзэхээр надад юу санагдаад байна вэ гэхээр манай энэ хуульд зөвхөн нэг хэлбэр нь орчихсон, нэг арга нь л орчихсон, харин бусад олон улсад түгээмэл байдаг зүйлүүд нь ороогүй юм шиг санагдаад байх юм. Тэгэхээр энэ бол амьдралаас жаахан тасархайдуу хууль болох байх гэж бодогдоод байна. Энийг цааш цаашдаа анхаарна байх гэж найдаж байна.

*Хоёрдугаарт нь, Санхүүгийн мэдээллийн албыг бие даасан хараат бус гэж тодорхойлчихоод, яг доор нь бүх зүйл Төв банкнаас хараатай, хамааралтай байхаар, цалин нь ч хамааралтай байхаар ингэж хуульчлах гэж байгаа юм байна л даа. Тэгэхээр ямар юмных нь хараат бус бие даасан байдал байх вэ дээ. Тэр байтугай энэ чинь өөрөө сонирхлын зөрчилтэй. Потенциал байдлаар бол Төв банк ч гэсэн энэ мөнгө угаахад оролцож болох ийм зүйлтэй. Тэгэхээр өөрийнхөө нэг объектын харъяалалд санхүүгийн мэдээллийн албанд байна гэхээр жаахан бас амьдралгүй санагдаад байна л даа. Түрүүн би хэлсэн зөвхөн банк хоорондын гүйлгээ, банкинд явагдаж байгаа энэ гүйлгээг оруулаад энэ бол нэг арга нь юм байна л даа. Тэгээд нэг хэлбэр нь. Гэтэл сая одоо ингээд хүмүүс энэ бараа, үйлчилгээг худалдан авахыг энэ мөнгө угаахын эсрэг төгс төгөлдөр шийдэл юм шиг яриад байна л даа. Харин ч эсрэгээрээ. Энэ маань өөрөө өнөөдрийн Монголын хууль тогтоомж хэдийгээр e-procurement гэж гараад байгаа ч гэсэн энэ өөрөө тэр мөнгө угаах потенциал буюу боломжит эх үүсвэр, арга болсоор л байгаа шүү дээ. Энэ талаас нь бодож бас энэ хэлбэрүүдийг нь, хэлбэр бүр дээр нь, олон улсад тохиолддог хэлбэр бүр дээр нь хуульд бас нэг тодорхой тодорхой юм заагаад өгчихвөл зүйтэй байх гэсэн саналтай байна. Баярлалаа.*

**З.Энхболд:** - Дэмжиж үг хэлсэн үү. С.Дэмбэрэл гишүүн дэмжиж үг хэллээ.

### **Зээлийн өрийн менежментийг УИХ-ын зүгээс цаашдаа онцгой анхаарах асуудал гарах байх шүү**

*Монгол Улсын Засгийн газар, Японы Олон улсын хамтын ажиллагааны банк хооронд байгуулсан экспортын зээлийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг УИХ-аар 2013 оны 06-р сард хэлэлцэх цээр:*

**С. Дэмбэрэл:** За баярлалаа.

*Нэгдүгээрт, одоогийн байдлаар манай гадаад өр ба дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа /би андуураагүй бол/ 42 хувь буюу нилээн өндөр түвшинд очсон байсан. Гэтэл бид нарын дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоо өөдрөг байдлаар хийсвэр хийгдсэн. Өр бол бодитой байдлаар авагдана. Энэ тохиолдолд иймэрхүү зээлийн өрийн менежментийг УИХ-ын зүгээс цаашдаа онцгой анхаарах асуудал гарах байх шүү.*



*Хоёрдугаарт*, Жибек болон түүнтэй холбогдуулаад мөн энэ Японы зээл тусламжын талаар нэг зүйлийг тодруулахгүй бол болохгүй байна. Мянганы хөгжлийн зорилтын наймдугаарх зорилт билүү дээ, тухайн улс орон тусламж буюу ODA - хөгжлийн албан ёсны тусламж авахдаа, дотоодын нийт бүтээгдэхүүнээрээ биш, JNA буюу үндэсний нийт орлогоор тооцсон байдлаар авна гэсэн тийм заалт байж байгаа. Энийг Эдийн засгийн хөгжлийн яам цаашдаа анхаарч, ялангуяа ODA-гийн хувь хэмжээг нэмэгдүүлэх тал дээр бас ажиллавал зохино байхаа гэж бодож байна.

Гуравдугаарт, УИХ-ын даргын захирамжаар эдийн засгийн дотоод, гадаад байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар судлах ажлын хэсэг гараад, энэ чиглэлээр УИХ-ын намрын чуулганд тодорхой асуудал орох ёстой. Үүний нэг гол бүрэлдэхүүн нь өрийн менежмент юм. Энэ тал дээр цаашдаа анхаарч, өрийн менежментийн асуудлыг УИХ-аас гаргах санал дүгнэлт бэлтгэлд дэлгэрэнгүйгээр оруулж өгч байх нь зүйтэй гэсэн санал байна. Ерөнхийдөө сая бол экспортыг дэмжих гээд явчихаж байна. Гэтэл яг тэр процесс нь дотроо ямар экспортыг дэмжих вэ гэсэн асуудал байна. Жибекийн зээл болон Жайкагийн зээл хоёрын хоорондын зохистой харьцааг яаж тогтоох вэ? Жишээлбэл Жайкагийнх хоёр шаттай зээл байгаа, жижиг дунд бизнесд илүү ээлттэй. Жибекийнх томоохон хөрөнгө оруулалт байгаа. Японоос авах нийт зээлийн бодлого дээр энэ асуудлыг бас хооронд нь зохицуулж, зохистой харьцааг нь гаргаж явах нь зүйтэй байх. Мөн Японтой байгуулж байгаа эдийн засгийн түншлэлийн гэрээ гэж байгаа. Энэ түншлэлийн гэрээнд Монголоос Япон руу гаргах экспортыг нэмэгдүүлэхийн тулд энэ зээл чинь яаж хөшүүрэг нь байх юм гэсэн тал дээр цаашдаа бас анхаарах нь зүйтэй гэж бодож байна. Энэ зээлийг авах нь зүйтэй гэж үзэж байна.

## **“Ногоон хот” Эрээнээс суралцах зүйл их байна**

2013 оны 8-р сарын 19-нд БНХАУ-ын Эрээн хотод Хятад, Монгол, Оросын эдийн засаг худалдааны хамтын ажиллагааны чуулга уулзалтын нээлтийн өмнөхөн, ӨМӨЗО болон Шилийн гол аймаг, хотын удирдах албаны хүмүүс Монгол, Оросын хүндэт зочидтой уулзсан байна. Оройн 17 цаг 30 минутад “Эрээний чуулга уулзалт” -д оролцохоор хүрэлцэн ирсэн ӨМӨЗО-ны улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн дарга Рэнь Япин, ӨМӨЗО-ны худалдааны тэнхмийн дарга Ли Ваньжүн, ӨМӨЗО-ны худалдааг дэмжих нийгэмлэгийн дарга Лю Тэншань, ӨМӨЗО-ны үйлдвэр худалдааны нэгдсэн холбооны намын үүрийн гишүүн Хао Зинүн, ӨМӨЗО-ны засгийн газрын гадаад ажил хариуцсан тамгын газрын дарга Юй Шиешунь, ӨМӨЗО-ны худалдааны тэнхимийн орлогч дарга, боомтын хэрэг эрхэлсэн дарга Гөүган, Шилийн гол аймгийн намын хорооны нарийн бичгийн дарга Юй Юнчуань, Шилийн гол аймгийн улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн дарга Цэцэг, Шилийн гол аймгийн намын хорооны гишүүн, Эрээн хотын намын хорооны нарийн бичгийн дарга Мэн Шяньдүн, Эрээн хотын намын хорооны нарийн бичгийн даргын орлогч, хотын дарга Бао Чүнмин нар Монгол

улсын УИХ-ын гишүүн, Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга С.Дэмбэрэл тэргүүтэй Монголын талын төлөөлөгчид болон Оросын Улаан-үүд хотын засаг даргын тамгын газрын дарга Пронькинов тэргүүтэй Оросын талын төлөөлөгчидтэй уулзжээ. Рэнь Япин Хятадын талыг төлөөлж хүрэлцэн ирсэн зочдыг хүрэлцэн ирсэнд талархал илэрхийлжээ. Тэрээр хэлэхдээ, ӨМӨЗО бол Хятадын умард зүг рүү нээлттэй чухал цонх, мөн умард зүгийг нээлттэй болгох чухал бааз юм. Эрээн хот Өвөр монголын чухал боомт хот. Гурван орны хамтын хүчин чармайлтаар, "Эрээний чуулга уулзалт" улам өндөр зиндаа, цар хэмжээнд өргөжин тэлж, үр дүн нь улам бэхжин, баялаг амжилтад хүрлээ. Та бүгдийн нааштай оролцоо болон хүчин чармайлтаар Эрээн хотын 5 дах чуулга уулзалт бүрэн дүүрэн амжилттай болохыг хүсэн ерөөе гэжээ.

**С. Дэмбэрэл хэлэхдээ:** "Чуулганаас өмнө танилцаж байхад Эрээн хот "Ногоон хот" болсныг олж харлаа, эрчим хүчийг нээх, дэд бүтцийн байгуулалтын талаар Монгол улс суралцах юм их байна. Ирэх жилийн "Эрээний чуулга уулзалт" ногоон аж үйлдвэр, ногоон эдийн засгийг хөгжүүлэхийг илүү анхаарна гэдэгт найдаж байна. Энэ нь гурван талын эдийн засаг худалдааны хамтын ажиллагааны найрсаг харилцааг улам ахиулна." гэжээ.

Пронькинов хэлэхдээ, "Эрээний чуулга уулзалт" -аар тогтоосон гурван орны найрсаг хамтын ажиллагааны харилцаа бол бүхий л улс орнуудын найрсаг харилцаа, эрх тэгш хамтын ажиллагааны үлгэр жишээ юм. Чуулга уулзалт баялаг үр дүнд хүрэхийг хүсэн ерөөхийн зэрэгцээ Эрээн хотын эдийн засаг нийгэм цэцэглэн хөгжиж, гялалзсан амжилтад хүрэхийн өлзийтэй ерөөлийг дэвшүүлье гэжээ.

Уулзалтын дараа, ӨМӨЗО-ны худалдааг дэмжих нийгэмлэг болон Оросын бүгд найрамдах Буриад улсын үйлдвэр худалдааны холбоо хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурах ёслол хийсэн байна. ӨМӨЗО-ны худалдааг дэмжих нийгэмлэгийн дарга Лю Тиншань Оросын бүгд найрамдах Буриад улсын үйлдвэр худалдааны холбооны дарга нар хоёр талыг төлөөлөн хэлэлцээрт гарын үсэг зурсан байна.

## **С.Дэмбэрэл, Ч.Амраа хоёр хөөрөлдсөн нь...**

Гурван улсын худалдааны чуулга уулзалтад Монголын талаас оруулах асуудал их байна. Ирэх наймдугаар сарын 20-22-нд манай урд хөршийн Эрээн хотноо Хятад, Монгол, ОХУ-гурван улсын худалдаа, эдийн засаг, хамтын ажиллагааны "Эрээн-2013" чуулга уулзалт уламжлал ёсоор тав дахь удаагаа болох гэж байна. Хөрш хоёр оронтойгоо хамтын ажиллагаа, худалдааны нягт холбоотой манай улсын хувьд энэхүү чуулганд ихээхэн ач холбогдол өгч оролцдог. Чуулганыг Монголын талаас МҮХАҮТ бизнес эрхлэгчдээ зохион байгуулан оролцдог билээ. Энэ удаагийн чуулга уулзалтын өмнө УИХ-ын гишүүн, МҮХАҮТ-ын дарга С.Дэмбэрэл, "Барс групп"-ын Ерөнхий захирал Ч.Амарбаатар хоёр уулзаж бизнесийн орчны

талаар ярилцсан юм. Энэ нь нэгд, Эрээний чуулга уулзалтын өмнө давхцаж, мөн манай бизнес эрхлэгчдэд ямар мэдээлэл хэрэгтэй байгаа талаар байнга ярилцаж, санал солилцож байх, хувийн хэвшлийнхэнд ямар бэрхшээл саад учирч байдгийг байнга мэдээлэх үүднээс “Бизнесийг өмгөөлөхүй” нэрийн дор бизнес эрхлэгчдийн дуу хоолойг нийгэм, олон нийт, төр, засагт хүргэж байя гэсэн санал өвөрлөн ирснээ Ч.Амарбаатар захирал дуулгасан юм. Тэрээр МҮХАҮТ бол бизнесийн өмгөөлөл явуулдаг, бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалдаг байгууллага, иймээс “Бизнес таймс” сониноор дамжуулан ярилцаж байя гэсэн. Ингээд “Бизнесийг өмгөөлөхүй” булангийн анхны хоёр ярилцагч С.Дэмбэрэл болон Ч.Амарбаатар нарын яриаг хүргэж байна.

**Ч.Амарбаатар:** - Манай урд хөрш Хятад улс бол манай хамгийн том худалдааны хамтрагч гэдэг нь гарцаагүй мөн. Хятадын Эрээн хот, манай Замын-Үүдээр гол худалдаа наймаа дамжиж байгааг хүн бүр мэднэ. Өдөрт 6000-7000 хүн нааш цааш гарч бизнесээ эрхэлж байна. Гэтэл Хятадын талд бид хил гарах гэж нэг машинд 2500-3000 юань төлдөг. Нэг жижиглэн худалдаачин 500-1000 юань төлж байна. Гэвч манайхан энэ мөнгөө яг юунд төлдөгөө мэддэггүй. Тэгэхээр бид Хятадын талаас яг ямар ямар татвар авдаг вэ, ямар ямар шимтгэл, хураамж, суутгал энэ тэр байдаг юм, юу юу хурааж аваад байдаг вэ гэдгийг эх хэлээрээ, Монгол хэл дээр бичүүлмээр байна.

**С.Дэмбэрэл:** - Тэр их амархан, МҮХАҮТ-аас Эрээн хотод суугаа төлөөлөгч Б.Энхзаяад хэлээд монголчуудаас авдаг бүх төрлийн татварыг ямар хуулиар, ямар зориулалтын татвар авдаг гэсэн жагсаалтыг бэлэн болгож боловсруулаад гурван улсын чуулган дээр танилцуулахад бэлдэх хэрэгтэй. Үүнийг нэг асуудал болгож ярья. Ийм ийм асуудлыг Монголын талаас хэлэлцүүлнэ, үүнийгээ форумын үр дүн болгож гаргана.

**Ч.Амарбаатар:** - Бас нэг чухал зүйл байгаа нь бид Шинжань ч юм уу Хонгконгтой хиллэж байгаа Гуандонд Монголоор бичээч гэсэнгүй л дээ. Эрээнээр монголчууд хил гарч байгаа учраас ямар үндэслэлээр Монгол машин Хятадын тал руу орохдоо тийм мөнгө төлж байгааг монголоор бичмээр байгаа юм. Тэд бичихгүй бол бид нар тэр гарын авлагыг монголоор бичээд Эрээн гарч бизнес эрхэлж байгаа иргэддээ нэг хуудас цаас болгож өгмөөр байна.

**С.Дэмбэрэл:** - Энэ бол манайхны хийчих л ажил байна ш дээ.

**Ч.Амарбаатар:** - Хийчих ажил байхгүй юу.

**С.Дэмбэрэл:** - Манай төлөөлөгч Б.Энхзаяад хоёр дахь даалгавар нь болгоод Эрээн гарч байгаа Монголын бизнес эрхлэгчид, түүн дотор чинь жижиг, том, дунд бүгд байгаа. Тэдэнд зориулан Эрээнд бизнес хийхэд ийм ийм зүйлүүдийг анхаарах хэрэгтэй гэсэн зөвлөмжийг боловсруулаад нааш нь явуулья. Энэ бол боломжтой зүйл.

**Ч.Амарбаатар:** - Ингэвэл манай Танхимд хэрэгтэй, бизнест хэрэгтэй. Хоёр дахь асуудал нь жин тонны хэмжээ байна. “Портланд” цемент нэг уутандаа 50 кг байх ёстой. Өнөөдөр хилээр орж байгаа портланд цемент 46 кг байна. Энд дөрөвхөн кг-ын асуудал юм шиг санагдаж магадгүй. Гэтэл нэг машин 60 тонн цемент ачдаг бол 56 тонн орж ирнэ гэсэн үг. Тээврийн зардал нь 60 тонноороо, үнэ, гааль нь 60 тонноороо шингэнэ гэсэн үг.

**С.Дэмбэрэл:** - Үүний зөрүүгээс болж ямар алдагдал хүлээж байна? Тооцоо байна уу?

**Ч.Амарбаатар:** - Одоо тооцоог нь хийх хэрэгтэй байна.

**С.Дэмбэрэл:** - Энийг чи хариуцаад хийгээрэй, хийгээд манайд өгөөрэй.

**Ч.Амарбаатар:** - Хамгийн аймаар нь 250 маркын бетоноор бид үйлдвэрлэл карказ хийх ёстой ш дээ. Цемент дутуу орж ирснээс болоод 220 л болно. Тэгэхээр бид яах ёстой билээ.

**С.Дэмбэрэл:** - Тэгэхээр жингийн зөрүүгээс болж бизнест алдагдал учирч байна. Энийг тооцоог нь гаргаж өгөөд, баримт жишээгээр батлаад, энэ асуудлыг бид Гурван улсын чуулга уулзалт дээр мөн хэлэлцүүлэх сэдэвт оруулья. Өөрөөр хэлбэл бид Эрээний Засгийн газарт тавих их тодорхой асуудлуудтай боллоо. Би энэ жилийн сэдвийг нь харсан. Өмнөх жилүүд шигээ ерөнхий байсан. Тодорхой болгох хэрэгтэй гэж хэлсэн.

**Ч.Амарбаатар:** - Энэ хугацаанд би өөрийнхөө хөрөнгөөр терминаль байгуулсан. Орж ирж байгаа цементийг эхлээд задлаад, дараа нь саванд хийгээд бетон үйлдвэрлэдэг газрууд руу зөөдөг. Тэндээс манайх 1000 тонн багтаамжтай үйлдвэр хийсэн. Яг тэгэж байхад энэ асуудал босч ирсэн. Мөнгө алдагдаад байдаг. Тэгэхээр нь шалгасан чинь шуудайтай, баримттай, хэнээс ямар хүнээс авсан гээд бүгдийг нь шалгалаа.

**С.Дэмбэрэл:** - Жингийн зөрүүг тэгэхээр Хятадын талд тавих асуудал мөн үү?

**Ч.Амарбаатар:** - Энийг би аль алинд нь тавимаар байна.

**С.Дэмбэрэл:** - Хоёр улсад адилхан л жинлэгдэж байгаа биз дээ?

**Ч.Амарбаатар:** - Яг зөв, Монгол хүн аливаа зүйлийг нэг бүрчлэн анхаарахгүй, бүдүүн баараг хүмүүс. Манайхан жишээ нь, 60 тонн гэсэн бол 60 тонн л гээд авчихдаг. Нэг шуудайтай цемент 50 кг гээд түүгээр нь л бодож авдаг. Гэтэл тэр Монгол хүн чинь 1990 онд бидэнд өгсөн эрх чөлөөгөөр худалдаа наймаа эрхлэх, компани байгуулах эрх чөлөөгөө эдлээд явж байгаа хүн, уг нь. Компанид нь гадаад худалдаа эрхлэх эрх нь байна. Тэгэхээр бид бараагаа шалгасангүй гэж худалдаачдад буруу өгч болохгүй байгаа юм. Стандарчилал хэмжил зүй, Хилийн хяналт гээд байдаг хүмүүс яагаад дутуу кг-тай цемент оруулаад байгаа юм бэ? “Портланд” цементийн чанар нь маркандаа хүрч байна уу, үгүй юу гэдгийг нь шалгаж чадахгүй байж болно. Дүүрч гэхэд ядахдаа жин хэмжээндээ хүрэхгүй байна гээд зогсоох ёстой байхгүй юу?

**С.Дэмбэрэл:** - Шинэ хуулиар хил дээр гааль, стандартын төлөөллийн байгууллага байж байгаад одоо больсон. Өөрөөр хэлбэл, Гаалийн тухай хуулинд өөрчлөлт орлоо, урьд нь гадаад худалдаа эрхлэхэд 11 бичиг баримт бүрдүүлж байсан бол одоо дөрвөн бичиг баримт бүрдүүлж байна. Гадаад худалдааны хөнгөвчлөл явагдсан уу, тодорхой хэмжээгээр мэдрэгдсэн үү, та бүхэнд?

**Ч.Амарбаатар:** - Бага зэргийн хөнгөвчлөлт бол байна. Гэхдээ ачаалал нь хөнгөлөлтөө мэдрүүлэхгүй болчихоод байна.

**С.Дэмбэрэл:** - Ачаалал бол ойлгомжтой. Бууруулахын тулд логистик болон дэд бүтцийг хөгжүүлэх ёстой. Цаашдаа төлөвлөгдөөд хийгдэнэ. Тэгсэн хэр нь ачаалал ихтэй ч гэсэн, наана нь бол саяхан хуулиар худалдааг хөнгөвчлөхийн тулд хил дээр шалгуулдаг Гадаад худалдааны бичиг

баримтуудыг экспорт, импортын тал дээр багасгалаа. Энэ импортлогчдод тодорхой хэмжээгээр мэдэгдсэн үү гэдэг асуудал үлдээд байна. Хэрэв тоо нь цөөрсөн ч гэсэн доторх үйл явц нь хэвээрээ байгаа бол хэцүү. Тэгэхээр чиний тавьж байгаа жингийн зөрүүний асуудлын тухайд, манай улсын аль байгууллагад тавих ёстой вэ, Эрээн хотын аль байгууллагад тавих ёстой вэ гэдэг асуудал байна. Энийг чи сайн бэлдэж чадах уу?

**Ч.Амарбаатар:** - Би яг бодит байгаа зүйлээ баримтаар нь л авчирч өгье. Харин бэлдсэн мэдээллээ тодорхой самбар дээр сэрэмжлүүлэг маягаар Гурван улсын уулзалтын үед ажиллуулах ёстой.

**С.Дэмбэрэл:** - Ерөнхийдөө, манай тал Эрээний гурван улсын чуулганд оролцохдоо их тодорхой сэдвүүдтэй л очих ёстой. Энэ жил тав дахь удаагаа хийх гэж байна. Анхны удаа зохион байгуулж байхад нь бид хамтдаа оролцож байсныг санаж байгаа байх. Тэгэхэд ерөнхий л зүйл ярьж байсан. Анхны уулзалтаар Эрээн хотынхон юу гэж бодсон гэхээр Эрээн хотоо стратегийн хувьд том болгох гэж бодсон. Монголчууд юу гэж бодсон гэхээр Эрээн хотоос наймаа, худалдаа бүх юмаа зөөдөг. Энийгээ аль болох хөнгөвчлөх, хүнд сурталгүй, болох юмсан гэсэн утгаар ингэж л анх энэ уулзалт эхэлсэн юм. Түүнээс хойш таван удаа хуралдлаа. Энэ жилийн хувьд сэдэв гарсан, ерөнхий байсан. Би хэлсэн. Ерөнхий байна шүү анхаараарай гэсэн. ОХУ-тай бол ярих юм байхгүй. Хэл амаа ололцож чадахгүй байна. Эрээнд оросууд очиж уулзалтанд оролцож өгөхгүй байна. ОХУ-ын дарга нар нь оролцохгүй, хэдэн бизнес эрхлэгч нь л очиж байна. ОХУ-ын дарга нарыг нь энэ жил оролцуулах гэж манай Танхимын Ерөнхий нарийн бичгийн дарга Э.Оюунтэгш, хятадуудтай хамт яваад ирсэн. Энэ жил дарга нар нь сонгууль гээд очихгүй гэсэн байна. Энэ жил бас оросууд их цөөхөн очно. Тэгэхдээ оросууд гэлтгүй монголчуудын асуудал бас байна. Бид энэ асуудлаа энэ дэс дарааллаар цэгцтэй, танилцуулж байх ёстой. Тэгэхэд ядахдаа тэнд сууж байгаа Хятадын бизнес эрхлэгчид баярладаг. Хятадын бизнес эрхлэгчдийг бол тэнд албаар авч ирээд суулгачихдаг. Дарга нарынхаа урт илтгэлийг аргалах гэж. Намайг илтгэлдээ Монголын бизнесийн зовлон гээд ярихад завсарлагаанаар Хятадын бизнес эрхлэгчид орчуулагчтайгаа хүрч ирээд та их тодорхой зүйл ярилаа, танай улс шиг ийм тодорхой зүйл ярьдаг болмоор байна гэж байсан. Энэ жилийг мөн тодорхой асуудал ярьсан чуулга уулзалт болгомоор байна. Тийм учраас үүнд бэлдэе, бэлтгье. Чиний хувьд тоо баримт, бодит амьдралынхаа жишээнүүдийг өгөөрэй. Түүнийг нь бид хурал дээр нь танилцуулна.

**Ч.Амарбаатар:** -Бас нэг жишээ байна аа. Карказ хийлгүүлээд Алтанбулаг дээр угсарлаа. Хятадын компанитай ажил эхлээд хийж байхад төмрөө жин тонныг нь 5500 юаниар тохироод тэдний тооцоогоор 106 тонн гэж гарлаа. Өмнө нь асуудал үүсч байсан болохоор бид төмрөө жигнэж авна гэхэд барааг хүлээж авахад жигнэж авна, жигнэсэн дүнг үндэслэл болгоно нэг тонн карказ төмрийг 6000 юаниар өгнө гэж байгаа юм. Тухайлбал, энэ хоёр үнээс л бодит жингийн зөрүү гарна гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа юм. Гэтэл бодит жин дээр болоод ирэхээр төмөр маань Хятадын пүү дээр 88 тонн боллоо. Бид 88 тонноор төлбөрөө төллөө. Монголын хил дээр нөгөө карказ маань 84 тонн болж байгаа юм.

**С.Дэмбэрэл:** -Дөрвөн тонн нь хаачив?



**Ч.Амарбаатар:** - Энэ хоёрын хооронд зөрүү гараад байгаа юм. Дөрвөн тонн шүү дээ, огт хөдөлгөөнд ороогүй, тэгэхэд л дөрвөн тонн төмөр алга болж байгаа, тэгэхээр нэг бол Монгол пүү алдаад байна уу, нэг бол Хятад пүү алдаад байна уу?

**С.Дэмбэрэл:** -гүй, үгүй эсвэл аль ч пүү алдахгүй, хулгайлагдаад байна уу? Тийм байж болох уу?

**Ч.Амарбаатар:** - Тийм байх боломжгүй, яагаад гэвэл тоо ширхэгээрээ очиж байгаа болохоор. Хэн ч буулгаж аваагүй

**С.Дэмбэрэл:** -Тоо ширхэгээр аваад, тоолоод хүлээгээд авчихсан. Хоёр талаасаа гарын үсгээ зураад?

**Ч.Амарбаатар:** - Харин тийм, машин машинаа жигнээд жин гарсан бүх дүн нь байж байгаа юм. Тэгтэл ийм асуудал үүсэж байгаа юм. Энийг бид яах ёстой юм.

**С.Дэмбэрэл:** - За тэгвэл 88 тонн гэж авсан төмөр 84 тонн болчихлоо. Одоо яах вэ?

**Ч.Амарбаатар:** - Үгүй одоо 84 тонныг бол яах ч үгүй. Бидний төмөр Алтанбулаг руу явж байгаа болохоор Гаалийн татвар төлөөгүй асуудал үүсээгүй. Гэтэл миний хэлээд байгаа бизнесийг өмөөрөхүй нь юу вэ гэхээр Монголын Гааль аль өндөр жинтэйг нь л авдаг. Өндөр пүүгийн дүнг авдаг болохоос биш, өөрийнхөө пүүгээр жигнэдэггүй.

**С.Дэмбэрэл:** -Тэгэхээр 88 тонноор авах нь байна тийм үү?

**Ч.Амарбаатар:** - Тэгнэ, тэгэлгүй яах вэ. 88 тонноор авна. Гэтэл ОХУ яадаг вэ гэхээр чиний хийсэн гэрээнд 106 тонн гэж бичсэн байна. Чи энэ гэрээнийхээ дагуу л төмрөө гарга гээд бүгдийг нь буцаадаг. Хятад, Монгол хоёр бол харьцангуй уян хатан байна л даа. Энэ буруу биш. Гэхдээ ийм л байна. Ингэснээрээ эцсийн бүлэгт энэ нь бүх юмны өртөгт нөлөөлж байгаа нэг хэлбэр юм.

**С.Дэмбэрэл:** -Барилгын өртөг тэр алдагдсан дөрвөн тонноор л нэмэгдэж байна гэсэн үг үү?

**Ч.Амарбаатар:** - Дөрвөн тонн гээд зогсохгүй, ингээд л луйвардуулаад, луйвардуулаад явчихаж байгаа юм.

**С.Дэмбэрэл:** - Үгүй, үгүй, тэгэхээр 88 болон 84 тонн гээд зөрүү гарч ирлээ. Монголын гааль бол 88 тонноор авах сонирхолтой. Яагаад?

**Ч.Амарбаатар:** - Татвараа илүү авах л сонирхолтой. Илүү мөнгө авна.

**С.Дэмбэрэл:** - Илүү мөнгө аваад эрх биш төрийн дансанд ордог байх тийм ээ?

**Ч.Амарбаатар:** - Тийм.

**С.Дэмбэрэл:** -Тэгээд Гаалийнхан төлөвлөгөөгөө давуулан биелүүллээ гэж Ч.Улаан сайдад тайлан бичдэг байх.

**Ч.Амарбаатар:** - Тийм, тэгээд тэдэн их наяд татвар төллөө гэж хөөрцгөөдөг. За яагаад ийм зөрүү гарав, Хятадын ийм том үйлдвэрүүд яагаад новширч байна вэ гээд судлаад үзсэн том үйлдвэрүүд ерөөсөө новшроогүй байна. Тухайлбал, манайд бол 40 см өндөртэй, 8 мм зузаантай, доод талын суурь нь 10 см-ын зузаантай төмөр байдаг юм байна. Манай стандарт буюу Оросоос орж ирсэн стандарт. Тэр стандарт нь Хятадад 39.8 см өндөртэй, 7 мм зузаантай, суурь нь 9 см гэсэн стандарт байдаг юм байна. Бүр тэр стандартаа бичээд наагаад ирдэг юм байна. Тэрийг Эрээнд байгаа

үйлдвэрлэгч тэр жингээр нь бодолгүйгээр нөгөө манайд байгаа стандарт буюу 40, 8, 10 гэсэн хэмжээгээр бодоод үзэхээр уртаас нь метр болгонд 7.8 кг төмөрийн зөрүү гарч байгаа юм. Ердөө л энэ.

**С.Дэмбэрэл:** - Ойлголоо, энэ яригдсан асуудлаар Монголын талд болон Хятадын талд хандах хоёр санал бэлдэх хэрэгтэй болж байна.

**Ч.Амарбаатар:** - Тийм, би Хятадын талтай зөндөө маргалдаад, өчнөөн олон маргаан хийгээд байна.

**С.Дэмбэрэл:** - Гэрээ байгуулахдаа маргаанаа хэрхэн шийдвэрлэнэ гэж оруулж байгаа вэ?

**Ч.Амарбаатар:** - Тэрнээс хойш Монголын Арбитраар орно гэж заалт оруулж байгаа юм. Яг ингээд оруулчихаар зөвхөн бид Эрээнд бизнес хийж байгаа биш цаашаагаа явахаар Монголын Арбитраар орно гэдгийг бол ойлгохгүй.

**С.Дэмбэрэл:** - Ойлгохгүй

**Ч.Амарбаатар:** - Манайх нэгэнт Хятадад худалдаа хийж байгаа учраас улсынхаа буюу Хятадын Арбитраараа л орно гэдэг асуудлыг нөгөө тал тавьдаг.

**С.Дэмбэрэл:** - Тэр бол ойлгомжтой. Замын-Зүдийн асуудал ийм байгаа юм байна. Одоо Алтанбулагын чөлөөт бүс дээр юу болж байна вэ?

**Ч.Амарбаатар:** - Тэнд ямар ч байсан манайх үйл ажиллагаагаа эхлүүлэх гээд байж байна.

**С.Дэмбэрэл:** - Чөлөөт бүсийн асуудал бараг 10-20 жил яригдлаа. Мөн ч олон Засгийн газрын үед ярилаа. Энэ Засгийн газрын үед хөдөлж байгаа зүйл байна уу?

**Ч.Амарбаатар:** - Манай хувьд бол тэнд барилгын сууриа тавиад орхичихсон байсан. Тэнд 400- гаад мянган ам.доллар зарчихсан байгаа. Тэгсэн манай газрын гэрээг цуцалчихлаа. Яагаад газрын гэрээ цуцалчихваа гэсэн, би төлбөрөө төлөөгүй байжээ. Тийм учраас цуцлах эрх тэднийд байна. Гэтэл Чөлөөт бүсийн байдлын тухай хуульд эхний гурван жил газрын төлбөрөөс чөлөөлнө, дараагын гурван жил 50 хувь хөнгөлнө гэсэн заалт байж байхад тэд тэр хуулийг хэрэгжүүлээгүйгээр гэрээ цуцалсан учир би энэ асуудлаа хуулийн дагуу шийдүүлнэ гэж Чөлөөт бүсийн дарга Сэмэрт тавьсан. Сэмэр тэрийг авч хэлэлцэлгүйгээр шууд цуцалсан.

**С.Дэмбэрэл:** - Одоо тэр хүн ажлаа хийж байгаа юу?

**Ч.Амарбаатар:** - Одоо ажиллахгүй байгаа. Алтанбулаг, Чойр, Цагааннуур гэсэн гурван чөлөөт бүсийн даргыг ажлаас нь халж Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр өөрийнхөө Төрийн нарийн бичгийн дарга Шинэбаатар гэж хүнийг болгосон.

**С.Дэмбэрэл:** - Төвлөрүүлчихсэн. За ойлголоо.

**Ч.Амарбаатар:** - Шинэбаатар нь асуудал шийдэхгүй, юугаа ч мэдэхгүй.

**С.Дэмбэрэл:** - Шинэбаатарт хандах юу байна?

**Ч.Амарбаатар:** -Төмрөө оруулж ирэхийн тулд би дөрөвдүгээр сарын дундаас Алтанбулагын чөлөөт бүсийнхэнтэй холбогдож, ажлаа хөөцөлдлөө. Балжмаа буюу Алтанбулагын чөлөөт бүсийн ерөнхий менежер нь дэмжээд байдаг. Тэгээд явж явж, яаман дээр очиж гацаж байгаад наадмын өмнө буюу долдугаар сарын 9-нд гэрээ байгуулах шинжтэй болсноо алга болчихлоо.

**С.Дэмбэрэл:** - Шинэбаатарт хэлэх юм байна, тийм үү?

**Ч.Амарбаатар:** - Үгүй ээ, Шинэбаатар бол зөвшөөрсөн.

**С.Дэмбэрэл:** - Тэгээд яагаад байгаа юм?

**Ч.Амарбаатар:** - Процесс нь буюу үйл явц нь маш удаан юм билээ.

**С.Дэмбэрэл:** - Яагаад?

**Ч.Амарбаатар:** - Ерөөсөө шийдэгддэггүй юм билээ.

**С.Дэмбэрэл:** - Өөрөөр хэлбэл, хаа нэгэн газар, аль нэгэн хэлтсийн даргаар яваад, тэрний дараагийн дарга дээр очоод тэндээсээ виз аваад л ингээл явдаг гэсэн үг үү?

**Ч.Амарбаатар:** - Тийм. Гэхдээ бид Шинэбаатарт тавдугаар сарын сүүлээр танилцуулаад, Чөлөөт бүсийнхэн дэмжээд, манай төмөр хилээр орж ирээд ажил яваад угсраад ямар ч байсан бид нар карказаа угсраад барилгын ажлаа эхлүүлчихсэн. Нөгөө захирагчийг хамаарч байгаа нөхөр бол асуудлаа юугаа ч мэдэхгүй байгаа юм.

**С.Дэмбэрэл:** - Танайхаас өөр Алтанбулагын чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байна уу?

**Ч.Амарбаатар:** - Байхгүй. Нэг бетоны үйлдвэр үйл ажиллагаагаа явуулах гэсэн чинь Гааль нь дарамтлаад цементийг нь оруулахгүй байна л гэсэн. Би 30 минутын өмнө утасдахад л тэгж хэлж байсан.

**С.Дэмбэрэл:** - Мод, модон бүтээгдэхүүн, банз оруулж ирдэг “Экас” ХХК-ийн Ж.Жаргалсайхан гээд залуу байна. Би санал оруулаад УИХ-ын байнгын хороонд энэ хүнээр яриулаа гээд яриулж байнгын хорооны шийдвэр гаргуулсан тэр юу болж байгаа вэ?

**Ч.Амарбаатар:** - Байнгын хорооны шийдвэр гарсан, тогтоол гарсан. Ямар ч байсан чөлөөлчихөөд байгаа.

**С.Дэмбэрэл:** - ОХУ-аас мод оруулах талаар сая УИХ-аас шийдсэн асуудлуудыг хэрэгжүүлэх, гол нь Алтанбулаг дээр төвлөрөг гэсэн утгатай тогтоол гарсан. Тэр хэрэгжиж байна уу?

**Ч.Амарбаатар:** - Яг одоо хэрэгжээгүй байгаа.

**С.Дэмбэрэл:** - Гэхдээ шийдвэр гарсан. Энэ зөв биз?

**Ч.Амарбаатар:** - Энэ хамгийн чухал шийдвэр байсан.

**С.Дэмбэрэл:** - Харин би энэ чиглэлд бизнес эрхэлж байгаа Ж.Жаргалсайханг байнгын хорооны дарга Г.Баярсайханд хэлж байгаад яриулсан юм. Энэ хүмүүсээ сайн яриулаа гээд, дандаа яамны хүмүүс яриад байхаар нь тэгсэн юм.

**Ч.Амарбаатар:** - Дээр нэг зүйл бий. Тэр бол ОХУ-ын талын асуудал. ОХУ-д татвар их өндөртэй. Тэгэхээр татварыг квотлох хэрэгтэй.

**С.Дэмбэрэл:** - Би Сэлэнгэ аймагт судалгаа хийлгэсэн. Тэгэхэд бол Хятадын Эрээн рүү ОХУ-аас гарган очиж байгаа модыг хэдэн хятадууд л ОХУ-д атгаж байна. ОХУ-ын Засгийн газрын бодлого нь болохоор аль болохоор өртөг нэмэгдүүлсэн бүтээгдэхүүнээ л гадагшаа гаргах буюу банз экспортлох сонирхолтой. Банз нь бусдыгаа бодвол арай хямд. ОХУ-д тэр квотыг нь хятадууд мэддэг юм байна. Тэгэхээр энийг Монгол Улс, ОХУ-ын Засгийн газрын хооронд дэд комисс байгаа, тэрнийг сая бид УИХ-ын гишүүн олонхийн бүлгийн ахлагч Б.Эрдэнэбатаар ахлуулах санал гаргаад ахалдаг болсон. Нарийн бичгийн дарга нь манай Танхимын Ерөнхий нарийн бичгийн дарга Э.Оюунтэгш ажиллаж байгаа. ОХУ-аас мод оруулж ирэх

асуудлаар УИХ-ын байнгын хорооноос гаргасан тогтоолыг хэрэгжүүлэх талаар цаашдаа юу хэрэгтэй вэ гэдгийг “Экас”-ийн Ж. Жаргалсайхан захирлаас асуугаад мэдээлэл авах хэрэгтэй. Энэ асуудлыг мөн Гурван улсын чуулга дээр хэлэлцэж болно. Жишээлбэл, өчигдөр манай “Хаан бууз” компанийнхан орж ирж байна. Танхим дэмжээд хоёр жил хөөцөлдсөн. Ямар ч гэсэн Хятад улсад гаднаас бараа нийлүүлдэг компанийн жагсаалтанд ороод, бас гаднаас бараа хүлээж авдаг зөвшөөрөлтэй компанитайгаа гэрээ байгуулаад Монгол Улс албан ёсоор Хятад улс руу бууз гаргаж эхлэх гэж байна. Зөвшөөрлийнх нь талаар бид мөн энэ чуулган дээр ярих юм. Тэр үеэр “Хаан бууз” ХХК хамтрагч компанитайгаа гэрээнд гарын үсэг зурна. ОХУ руу бас бууз гаргах ямар боломж байгааг энэ чуулга уулзалтын үеэр ярилцах гэх мэт иймэрхүү тодорхой асуудлыг ярьж байх ёстой. Чамаас асуух өөр бас нэг асуудал байна. Хүнсний аюулгүй байдлын тухай хууль, Хүнсний тухай хуулиар бол хүнсийг иргэд импортлохоо больсон. Энэ юу болж байна вэ?

**Ч.Амарбаатар:** - Тэр иргэд бүгдээрээ компаниа байгуулаад аж ахуйн нэгжийнхээ хувиар хүнсээ оруулж байгаа. 17 жил тогтсон механизм учир явдагаараа яваад л байгаа.Тав. Манай Монголын С.Дэмбэрэл: -Бас нэг асуулт байна. Манайд иргэдийн дунд ЭМЯ, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас судалгаа явуулжээ. Манай хүүхдүүд витаминжилт муутай байна. Ихэвчлэн хөдөө орон нутгын хүүхдүүд тэжээл, витамин дутуу байна. Үүний гол шалтгаан нь жимс, жимсгэнэ иддэггүйтэй холбоотой. Тэгэхээр бид жимс, жимсгэнийг яаж ихээр нь, мөн шинэ байдлаар оруулах вэ гэдэг асуудал гарч ирж байна. Тийм биз? Монголд хамгийн гол зах зээлийг хангадаг нь танайх байна. Гэтэл танай жимсийг миний сонссоноор шинэ жимсийг долоо хоног хил дээр саатуулчихдаг гэж байна. Хэд хоног саатаж байна вэ? Хятадууд бол Монгол руу хамаг муу жимсээ явуулахгүй байгаа биз дээ?

**Ч.Амарбаатар:** - Муу жимс стандартыг хангахгүй, тээвэрлэлийн ая даахгүй. Тийм болохоор хүн муу юм худалдаж аваад, өчнөөн зардал гаргаж авч ирлээ гэж бодоход хямд зүйлийг хямд л зарна. Монголын бизнес эрхэлж байгаа хүмүүс энэ ажлыг 10 гаруй жил хийсэн учраас хамгийн сайныг нь авч ирдэг.Энэ бол бодит зүйл.

**С.Дэмбэрэл:** - Гэхдээ энийг яаж нийтэд хүртээмжтэй болгох вэ?

**Ч.Амарбаатар:** - Энэ бол үнийн л асуудал. Үнэд юу нөлөөлж байна гэхээр тээвэр л нөлөөлж байна.

**С.Дэмбэрэл:** - Жишээлбэл, 500 малтай малчин гурван хүүхэдтэй байна. Би Өвөрхангайд уулзлаа. Тэр айлын нэг нас гарантай хүүхэд миний өгсөн жимсийг маш дуртай идэж байна. Би гэрийн эзнээс асуулаа, хүүхэддээ жимс өгдөг үү? гэж. Хааяа нэг сумын дэлгүүрээс очиж алим авах юм даа л гэж хариулсан. Тэр айл мөнгөтэй байна. Хэрвээ сумын дэлгүүрт бүх төрлийн жимс, дотоод гадаадаас авч ирсэн жимс байвал тэр хүн хүүхэддээ авч өгнө биз дээ.

**Ч.Амарбаатар:** - Энд нэг асуудал байна. Би өөрийнхөө ач хүү дээр харахад жимс, ногоо иддэггүй. Монгол хүн бол идэхгүй байна. Бид нар бол байцаа, сонгиноо иднэ. Миний ач хүү идэхгүй байна.

**С.Дэмбэрэл:** - Миний зээ хүү идэж байна. Сургах л асуудал. Энд чи бид хоёрын ач, зээгийн асуудал яриагүй байна. Бид хүүхдүүддээ жимсийг нь өөрсдөө авч өгч байна. Гэтэл Монголын дараагийн үе нь их сульдаатай болох гээд байна л даа. Тэрний нэг илрэл буюу судалгаагаар жимс, жимсгэнэ дутагдаж байна гээд гараад ирж байна.

**Ч.Амарбаатар:** - Гэхдээ бол “Барс”-ыг бүх л механизмаар доош нь хийхийг оролддог. Гэтэл жимсний ач холбогдол бол байгаа.

**С.Дэмбэрэл:** - Би тэр ач холбогдлыг нь хэлээд байна шүү дээ. Манай Монголын хүүхдүүд жимс жимсгэнээр дутагдаж байна. Жимс жимсгэнийг Монгол Улсад оруулж ирэх гол ажлыг анх эхэлсэн компанийн захиралтай би ярьж байна тийм үү? Тэгэхээр Монголын хүүхдүүдэд жимс хэрэгтэй байна, чи сайныг нь оруулж ирж байна. Гэхдээ чи хэллээ ш дээ, бүх л байдлаар намайг доошоо хийхийг боддог гэлээ. За, би тэрийг мэднэ, жишээлбэл, танай дээр шалгалт байнга ирдэг гээд хэлж байсан. Гэхдээ би танай лабораторийг үзэж байсан. Орчин үеийн лаборатори. Өөрөөр хэлбэл, чамд итгээд, чи өөрийнхөө лабораторит шалгаад үйл ажиллагаагаа явуулчих ажлыг дахин дахин шалгалт явдаг нь үнэн үү? Хэвээрээ юу?

**Ч.Амарбаатар:** - Үнээн, хэвээрээ

**С.Дэмбэрэл:** - Эцэст нь чи бид хоёрын энэ ярианаас ямар гаргалгаа, юу гарч байна гэхээр Монголын хүн амд хэрэгтэй, шаардлагатай хүнсний зүйлийг оруулж ирдэг компаниудыг болон Монгол Улсдаа олон жил тогтвортой, найдвартай үйл ажиллагаа явуулсан компаниудад зориулсан тодорхой хөтөлбөр хэрэгтэй. Чи санаж байна уу? Бизнес эрхлэгчдийн шинэ жилээр Ерөнхий сайд Н.Алтанхуяг юу гэж хэлсэн гэхээр Үндэсний манлай компаниудаа дэмжих хөтөлбөр, ЖДҮ-ийг дэмжиж эхэлж байна. Тодорхой ажил хийчихлээ, схем боловсруулчихлаа. Баталгааны сан бий болголоо, одоо том компаниуд, үндэсний манлай, Монгол Улсад хэн их татвар төлдөг, улс орны эдийн засагт хувь нэмэр оруулж байгаа энэ компаниуддаа зориулсан хөтөлбөр боловсруулах ёстой. Энэ хөтөлбөрийг Танхимтай хамтарч боловсруулна гэж олон нийтийн өмнө хэлсэн. Тийм хөтөлбөр, бодлогын хэрэгцээ л гараад байна гэдгийг би жимс, жимсгэнэ дээр жишээ авч хэллээ.

Экспорт дээр би юуг жишээ авч байна гэхээр бууз. Бид ноос, ноолуураа гаргачихаж байна, мах, арьс ширээ экспортлочихож байна. Гэхдээ өртөг нэмэгдүүлсэн бүтээгдэхүүн гаргах хэрэгтэй байна. Гэтэл бууз бол хамгийн сайн өртөг нэмэгдүүлсэн бүтээгдэхүүн, тийм биз дээ. Хүний хөдөлмөр ороод бүгдийг бэлдсэн. Хорин минут жигнэх л асуудал. Энэ бэлэн бүтээгдэхүүнээ хоёр хөршдөө гаргах боломж байна. Энэ ажил, энэ бизнес өнөөдөр эхэлж байна. Амраагийн хэлснээр “Бизнесийг өмгөөлөхүй” нэртэй буланг “Бизнес таймс” сонинд ажиллуулж, бизнес эрхлэгчид тулгамдаж буй асуудлаа ирүүлж олон нийтэд хүргэж байгаарай гэдгийг эцэст нь хэлье.



## Гол заалтууд нь уначихсан хууль утгагүй

*УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар “Хилийн боомтын тухай хуулийн төсөл, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх үеэр Ажлын хэсгийн гишүүн С.Дэмбэрэлийн хийсэн тайлбар:*

С.Дэмбэрэл: - “Худалдаа хөнгөвчлөх” гэдэг маань дэлхийн худалдааны байгууллагын 4 том бодлогын нэг нь байгаа юм. “Trade facilitation” гэж нэрлэгддэг, монголоор манай бүх баримт бичгүүдэд “худалдаа хөнгөвчлөх” гэдэг үгээр тэмдэглэгддэг юм. Оросоор бол “упрашение торговых процедур” гэж ярьдаг. Худалдаа хөнгөвчлөх, цахим нэг цонх, боомтын нэгдсэн менежмент гэсэн энэ 3 гол концепцийн чанартай зүйлүүд энэ хуульд ороод, энэ хууль маань шинэчилсэн найруулга болчихсон юм. Тийм учраас энэ худалдаа хөнгөвчлөхтэй холбоотой, үүнтэй уялдаад гадаад худалдааны цахим нэг цонх, тэр дотроо зураасан код гэх мэт энэ бүх зүйлсийн тодорхойлолтууд нь дандаа олон улсад байдаг тэр л тогтсон ухагдхуунуудаараа энд орж ирсэн байгаа.

“Эрсдэлд суурилсан зохистой хяналтын тогтолцоо” гэдэг үг бол бас л олон улсын л нэр томъёо байгаа юм. “Risk based management” буюу гааль дээр, “Азийн хөгжлийн банк” зэрэг хяналтын байгууллагууд болон Олон улсын санхүүгийн байгууллагууд дээр хэрэгжүүлж байгаа тэр л удирдлагын хяналтын тогтолцоо юм шүү дээ. Үүнийг одоогоор тодорхойлсон өөр монгол үг, нэр томъёо байхгүй учраас үүгээрээ л орж ирсэн. Түүгээр нь тавьж, тодорхойлолтыг нь мөн тэгж өгсөн байгаа.

Ер нь би одоо ойлгохоо больж эхэлж байна. Ажлын хэсгийн ахлагч М.Батчимэг гишүүн бид нарыг шөнийн 23:00 цаг хүртэл суулгаж, түргэн хоолоор хооллож байгаад боловсруулж, засч янзлаад, өөрчлөөд л оруулж ирээд байгаа зүйл шүү дээ. Үүнийг бид одоо яах ёстой байсан юм бэ? Байсан чигээр нь оруулж ирэх ёстой байсан юм уу? Тэгвэл бид УИХ-ын гишүүн байж, энд ингэж ажиллах суух ямар хэрэг байна? Муу юм орж ирвэл мууг нь засаад, сайжруулаад л явж байгаа ажил шүү дээ. Бидний өөрчилж янзалсан бүхнийг чичлээд байх юм.

Асуултанд хариулаад утгагүй болж эхэлж байна. Бид бүх зүйлийг мэддэг байх албагүй л дээ. Нэг хэсэг нь тодорхой асуудал дээр ажиллаад, тодорхой мэдээлэл аваад, тэрнийгээ хийгээд өгчихсөн байхад, тэр нь уначихаж байна л даа. Тэгэхээр энэ хуулийн чинь өөрийнх нь үзэл санаа үхчихэж байна шүү дээ. Ямар ч байсан энэ хууль одоо үргэлжлүүлж хэлэлцэх хэрэггүй болчихлоо. Би ажлын хэсгийн гишүүний хувьд тийм л бодол төрж байна.

Ийм байдлаар хуулийг батлаад, мэдэхгүйн улмаас олонхиороо гар өргөөд, хамгийн гол үзэл санааг нь тээж яваа заалтуудыг унагаачихвал энэ хууль утгагүй болно. ийм жижиг сажиг, шальдар булдар асуултуудад хариулах бүр ч утгагүй болно. Зарчмаа л ярьцгаая.

**З.Энхболд:** - Шинэчилсэн найруулга гэж хэлж байна. Энэ чинь шинэ хууль биш үү? Тэгээд энэ дотроо С.Дэмбэрэл гишүүний хэлж байгаа зүйлсийг дэлгэрэнгүй оруулаад ирэхгүй яасан юм бэ? Тэгсэн бол бусдад нь ойлгоход амархан байх байжээ... Маш муу хууль орж ирээд, хэт олон зүйл дээр санал хураахаар байвал буцаах ёстой л доо. С.Дэмбэрэл гишүүн ээ,

### **Гадаадад данстай, гадаад гэр бүлтэй хүн яах вэ**

*11 дүгээр сарын 26-ны Мягмар гарагт Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан 09.00 цагаас “А” танхимд болж, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандангаас өргөн мэдүүлсэн/-ийг хэлэлцэх цед УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлийн хэлсэн үг:*

**С.Дэмбэрэл:** - Offshore / олон улсын санхүүгийн төвцүдийг дүгнэхэд хэрэглэгддэг ухагдахуун бөгөөд гадаад, хилийн чанад дахь гэсэн утгатай үг. цаашид офшор гэж бичнэ./ гэдэг энэ дэлхий нийтийн практик ойлголтонд Монгол улсын зүгээс хандах хандлага, бодлого алга байна. Бид өмнө нь офшор бүсэд бүртгэлтэй компанитай гэрээ байгуулж л байсан. Миний бодлоор, том, чухал зүйлийг хэт жижиг хэмжээнд барьж авсан байна. Монгол улсын маань офшор бүсэд хандах үндсэн хандлага нь алга. Тийм учраас юуны өмнө үүнийг нь оруулж ирсэн, хоёрдугаарт энэ бусад нөхдийн хэлж байгаа шиг, бүх тодорхойлолтуудыг нь өгсөн байх хэрэгтэй. Жишээлбэл, төрийн өмчит компани, эсвэл Монголын төр цаашдаа, ямар нэгэн офшор бүсэд байгуулагдсан, бүртгүүлсэн компанитай хөрөнгө оруулалтын гэрээ хийх үү, үгүй юу? гэдгийг шийдсэн байх ёстой. Энэ нь өөрөө их том асуудал юм шүү. Энэ асуудлаа бид тодорхойлж байж цаашдынхаа юмыг ярина.

Би Ж.Батзандан гишүүнд, үүнийг яг ийм байдлаар нь оруулж ирээч гэж хүсмээр байна. Өөрөөр хэлбэл, ерөөсөө Монгол Улсын ерөнхий хандлагыг оруулж ирвэл өөрийн чинь одоо энэ барьж яриад байгаа зүйлс түүний нэг хэсэг нь болоод л явчихна гэж би бодож байна. Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүлчдийн холбооны цахим хуудас руу ороод, /энд байгаа сэтгүүлчдийн хэн нэг нь, ер нь хэн ч орж үзэж болно л доо./ “Самбуугийн Дэмбэрэл” гээд хайгаад үзвэл, тэнд нэг мэдээлэл гараад ирлээ гэж бодъё. Тэр бол дэлхийн олон нийтийн зүгээс сайн дурын үндсэн дээр нийтлээд, ингэснээр

нөлөөлөлөө тодорхой засгийн газрууд дээр “сайн засаглалыг” хөгжүүлэхэд нь нөлөөлж байгаа сэтгүүлчдийн хүчин чармайлт юм. Энэ нь өөрөө banding буюу олон улсын ямар нэг конвенцээр нэгтгэгчихсэн зүйл одоогоор байхгүй.

Гэхдээ үүн дээр Монгол Улс санаачилга гаргаж, хууль гаргая гэж байгаа нь энэ хуулийн үзэл санаа юм. Энэ талаасаа бас зөв. Нөгөө асуудал нь Би нэг хятад эмэгтэйтэй гэрлэгчихсэн, Н.Батцэрэг маань Африкийн Зааны ясан эрэг улсын нэг хүнтэй гэр бүл болчихсон байна гэж бодъё. Тэгвэл бид 2 яах вэ? Энэ бол хүний эрхийн асуудал. Энэ талаасаа бодож, болгоомжтой хандаасай гэж бас хүсч байна. Харин тэр офшор гэдэг дээрээ гол цохилтоо хийгээд, илүү өргөн хүрээнд, бүр бодлогын хэмжээнд аваад үзвэл энэ хуулийг би дэмжихэд бэлэн байна. Энэ их хэрэгтэй. Яагаад гэвэл, Монгол улс маань үүнийгээ тодорхойлоогүй байна шүү.

### **Эдийн засгийг саармагжуулах биш, дэмжих хандлагатай зүйлсийг л оруулбал сайн байна**

*“Валютын ханшийг тогтворжуулах, эдийн засгийн идэвхжлийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Байнгын хорооны тогтоолын төсөл боловсруулах” цүрэг бүхий Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлээс:*

С.Дэмбэрэл: - Манай улс бол маш жижиг зах зээл. Гэтэл хүний нөөцийн дэлхийн хэмжээний том компаниуд сүүлийн үед манайд салбараа нээгээд байна. Энэ яах гэж байгаа юм бэ гэхээр, том юмны л үнэр аваад байгаа хэрэг шүү дээ. Тэр нь “банкны том гүйлгээ хийгдэх юм байна, том transaction явагдах нь” гэдэг үнэр авсан гадаадын 3 банк л байгаа юм байна. Энэ 3-т тэр өгөөшийг нь нэг өгүүлбэрээр л өгөх ёстой. Өөрөөр хэлбэл, түрүүний ярилцсан ёсоор, “Оюутолгой” гэсэн нэр заавал орох ёстой. Жишээлбэл, “Монгол улсад салбар болон төлөөлөгчийн газраа нээсэн банкуудад...” гэсэн зүйл байх хэрэгтэй юм шүү. Тэдэнд proposal олгох хэрэгтэй. Тэгвэл тэд орж ирнэ. Идэвхжинэ. “Оюутолгой”- д ч бас нэг мессеж өгмөөр байна. Гэхдээ үүнийг би Н.Батбаяр сайдаас юм асууя.

- “Оюутолгой”-г бид одоо яах вэ? Бид ямар мессеж өгөх вэ? Энд оруулах нэг л өгүүлбэр нь юу байвал таарах вэ?

- 2013 оны 11 сард улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэх талаар Татварын ерөнхий газрын даргын тушаал гарсан байна. Тэр тушаал дээр шууд биш утгаар үүрэг өгсөн нь бүх сонин болон интернетээр цацагдсан байгаа. Татварын байгууллагынхан их гэгээн сайхан тайлбар өгч байна. Энэ нь ч зөв. Үнэхээр хуурамч падаан үйлдэж байгаад олж илрүүлж байгаа нь буруу биш. Яагаад гэдгийг та нар мэдэх үү? Шалтгаан нь аль аль талдаа байдаг юм. Хуулиндаа ч асуудал нь бий. Энэ бол олон жилийн асуудал. Компаниуд асуудлаа хөнгөвчлөхийн тулд бушуухан л тэр хуурамч падаануудыг худалдаж аваад байгаа. Та нар эрсдэл талаасаа бодоод,

түүвэрлэн шалгаж байгаа нь зөв. Гэхдээ та бүхэнтэй хамтарч шалгаж байгаа байгууллагууд чинь шалгагдаж байгаа байгууллагууд дотроос чинь “том үнийн дүнтэй хэргүүдийг нь над руу өгчих” гэсэн хандлаг гараад, тэр нь аль хэдийн нийгэмд тодорхой болчихоод байна. Ямар сайндаа шинэ хуулиар “аж ахуйн нэгж байгууллагуудыг дарамталдаггүй, зөвлөгөө өгөх байдлаар ханддаг, шалгалт хийхдээ эрсдэл дээр суурилж шалгадаг” байх ийм дүрэм тогтоох асуудал Татварын байгууллагын хувьд ч хамааралтай явагдаад, нэлээд дэвшил гарч байгаа. Тийм учраас би энэ талаасаа бодож асуугаад байгаа болохоос танай татварын байгууллагын сайн зүйлсийг үгүйсгээгүй юм шүү. Гэхдээ бодит амьдрал дээр компаниуд ийм байдалтай байна. Энэ Ажлын хэсгийн гол зорилго бол Монголын эдийн засгийг идэвхжүүлэхийн тулд хувийн хэвшлийг идэвхжүүлэе, хувийн хэвшлийг идэвхжүүлэхийн тулд өмнө нь стандарт сэтгэлгээгээр хандан болохгүй гэж хориглож байсан зүйлсээ хүртэл өөрчлөн сэргээе гэсэн байдлаар ажиллаж байна. Тийм учраас бидний идэвхжүүлэх гэж байгаа ажлын жагсаалтан дотор энэ зорилгыг саармагжуулах биш, дэмжих хандлагатай зүйлсийг оруулж тусалбал сайн байна.

### **Хоёр хөршийнхөө зах зээлийн сегментийг эээлж авах бодлого явуулах хэрэгтэй**

*2014 оны 01-р сарын 14-ны сурвалжлага:*

- Жижиг дунд үйлдвэрийн /ЖДҮ-ийн/ тухай хуулийг өөрчлөх шаардлагатай гэдгийг та өмнө нь хэлж байсан. Энэ удаад тус хуулийг өөрчлөхөөр ажиллаж байгаа гэж сонссон. Чухам юуг нь яаж өөрчлөхөөр шийдэв?

С.Дэмбэрэл: - Маш их өөрчлөх шаардлагатай. Нэгдүгээрт зөвхөн ЖДҮ эрхлэгч гэсэн тодорхойлолт биш, хуулинд бодит амьдралд хэрэгжихэд хэцүү “тэнгэр”-ийн заалтууд орсон. Яг одоо би хуулин дээр ажиллаж байна. Засгийн газар бас ажиллаж байгаа учраас бидний зам нийлэх байх. Бичил, жижиг дунд үйлдвэр гээд туйлшралгүй жижиг дунд бизнесийн асуудлыг оруулж өгөх ёстой. Үйлчилгээ үзүүлж буй хүн, өөрийн гэсэн үсчин салонтой хүн зээл авч болох уу, болно. Тэд ажлын байр бий болгож, өртөг бүтээдэг. Өнөөдөр мянга мянган хүмүүс бичил бизнес хийж байна. Тиймээс бичил бизнест тохирсон зээлийн сан, баталгааны сан байх ёстой. Мөн ЖДҮ-ийг дэмжих зорилготой зээлийг хэдхэн арилжааны банкаар олгох нь өрөөсгөл. Банк бус санхүүгийн байгууллагыг оролцуулж, санхүүжилтийн хэлбэрүүдийг өргөтгөх хэрэгтэй. Тэднийг арилжааны банкуудтай өрсөлдүүлэх замаар санхүүгийн секторыг босгож болно.

- Бодит болон санхүүгийн секторын өнөөгийн байдлыг та хэрхэн дүгнэдэг вэ?

С.Дэмбэрэл: - 96х4 гэсэн бүтэцтэй. 96 хувь нь банк, 4 хувь нь банк бус санхүүгийн байгууллагууд гэсэн нэг хөлтэй гажгийг бий болгочихсон.

Энэ бол бүтцийн гажуудал. Бүтцийн гажгийг улам муутгахгүйн тулд уул уурхайн салбараас өөр бусад салбарын экспортоо дэмжих ёстой. Экспортын бүтэц маань бас 96х4. 96 хувь нь уул уурхай, 4 хувь нь бусад. Энэ бол хоёр дах гажиг. Хэдийгээр хувийн хэвшил импортыг орлох бүтээгдэхүүнийг хийхээр хүчин чармайлт гаргаж байгаа ч гадаад худалдааны балансыг барихгүй бол хэцүү. Тиймээс үйлдвэржилтийн аргуудыг ашиглах нь зөв. Тухайлбал суурь хэрэгцээгээ хангах үйлдвэржүүлэлтийн хангах. Үүнд аймаг сумдын нутаг дэвсгэрт байгаа түүхий эд завсарын жижиг бүтээгдэхүүнийг ашиглаад жижиг үйдвэрлэл явуулах, эсвэл хүнсний үйлдвэр талхны цех гэх мэт. Түүнчлэн импортыг орлох, импорттой өрсөлдөх экспортод баримжаалах, эрдэс бус баялгийн экспортыг дэмжих, инноваци, шинэ технологийг нэвтрүүлэх гэх зэргийн долоон аргаар үйлдвэржилтийг дэмждэг.

**- Манай улсад үйлдвэржилтийн бодлогын баримт бичиг батлагдчихсан. Тус бодлогыг хэрэгжүүлэхгүй байна гэсэн үг үү?**

**С.Дэмбэрэл:** - Баримт бичиг батлагдсан ч гэсэн өмнөх засгийн газрынхаа ажлыг залгамжилдаггүй учраас шинэ бодлогууд гаргах шаардлагатай. Хөгжүүлнэ гэж гоё ярьдаг ч санхүүгийн тохирсон механизмыг дэмждэггүй. Өнөөдөр бодит сектороос санхүүгийн сектор нь хоцорчихоод байна. Санхүүжилтийн нэг л эх үүсвэр байгаа зэрэг гажгийг санхүүгийн секторын реформоор өөрчилнө.

**- Засгийн газар ЖДҮ-ийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрт санал авч байгаа. Та МҮХАҮТ-ын даргынхаа хувьд ямар санал орох ёстой гэж бодож байна вэ?**

**С.Дэмбэрэл:** - Саяхан МҮХАҮТ Хөдөлмөрийн яаманд Жижиг дунд бизнесийг хөгжүүлэх саналаа иж бүрнээр нь өгчихсөн. Үүнд миний дээр ярьсан асуудлууд орсон байгаа.

**- Үйлдвэржүүлэлтийн бодлогод яах аргагүй өндөр технологи инновацийн асуудал тусгагдсан байдаг. Энэ талаар та юу хэлэх вэ?**

**С.Дэмбэрэл:** - ЖДҮ эрхлэгчид одоохондоо зохицсон технологийг ашигладаг. Цаашдаа хөгжлийнхөө замаар өндөр технологийг оруулж ирэх нь ойлгомжтой. Хувийн хэвшлийнхэн орчин үеийн технологийг ихээр оруулж ирж байгаа шүү дээ. Харин үүнд төрийн зүгээс инновацид суурилсан судалгаа ба хөгжил, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ёстой. Саяхан төрийн шагнал авсан Н.Нацагням шиг /Инженер Н.Нацагням “Синхрон генераторын реактив чадлын автомат тохируулга болох NaNyam-AX12 болон түүний виртуал лаборатори” бүтээлээрээ олон тэрбум ам.долларын инновацийн импортыг орлуулж чадсан юм/ залуус олон бий. Нэг талаар судалгаа, хөгжлийн орчноор нь төр хангаж өгөх ёстой ч нөгөө талаар өрсөлдөөнөөс савраа татах ёстой. Зарим бизнесийг скочоор баглаж болохгүй. Чөлөөт, эрүүл өрсөлдөөний дүнд инноваци ч гарч, жам ёсны хөгжлийн гольдриллоо орно.

**- Жижиг дунд бизнес эрхлэгчдэд Орос улс руу бүтээгдэхүүнээ гаргаж, худалдаа хийх боломж бага багаар нэмэгдэж байгаа. Зарим хүмүүс монголын зах зээлийг жижиг хэмээн голдог. Уг нь Европын холбооны улсууд руу 7200 нэр төрлийн бүтээгдэхүүнийг гаргах боломжтой байгаа шүү дээ?**



**С.Дэмбэрэл:** - Тэр 7200 яах вэ. Хамгийн практик талаас үзвэлхоёр хөршийнхөө асар том зах зээлийг маажиж, малтаж амьдрах ёстой.Өөрөөр хэлбэл тэдний зах зээлийг эзэмдэж, эзэлж авах бодлогыг явуулмаар байна. Мэдээж Хятадын зах зээлийг бүтнээр эзэлж чадахгүй. Гэхдээ, Монгол улс зах зээлээ тэлэх бодлогыг гаргаад үзвэл Оросын Сибирийн хотууд болох Омск, Томск, Иркутск, Чита, Хятадын зүүн хойд хэсэг болох Өвөрмонгол рүү харсан төрийн бодлого дутагдаад байна. Хятадуудын бас нэгэн ихээр иддэг хоол нь бууз, банш бөгөөд 25 төрлийн бууз хийдэг зоогийн газар ч бий. Эдгээр хотууд манай улстай цаг агаарын хувьд ойролцоо бүс нутаг учраас экспортоо хөгжүүлэх боломжтой. Би энд алт, зэсийг яриагүй. Уул уурхайн бус экспортыг хэлж байна.

МҮХАҮТ Эрээн хотын засаг захиргаатай яриад бүхэл бүтэн дэлгүүрийн том талбай авч, компаниудад түрээслүүлсэн. Манай нэг компани буузаа экспортолж байна. Бууз бол өртөг нэмэгдүүлсэн бүтээгдэхүүн. Хятадууд өгөөжийн боорцогонд их дуртай. Монголд хийсэн өвлийн малгай, монголын хивс, лаазалсан бүтээгдэхүүн, элэгний нухаш эрэлттэй байдаг. Энэ бүхэн бидний зах зээл. Тиймээс Европын холбоо руу гаргаж чадахгүй байгаа 7200 гэж ярихаас илүү хоёр хөршийнхөө зах зээлийн сегментийг эзэлж авах бодлого явуулах хэрэгтэй. Түүнчлэн Хятад, Оростой хил залгаа аймгуудад бодлого хэрэгтэй. Увс аймагт Тувагийн зах зээлийг эзлэх бодлого, Сэлэнгэ Буриад руу гаргах гэх мэт.

- **ЖДҮ эрхлэгчид бүтээгдэхүүнээ гаргах нэг үндэс нь экспорт. Тиймээс Худалдааны хууль эрх зүйн орчныг зайлшгүй сайжруулах шаардлагатай.**

**С.Дэмбэрэл:** - Худалдааны хуулиас илүү худалдааны дэглэм нь чөлөөтэй байх ёстой. Бид одоо дөнгөж ноднин жил экспортын 12 бичиг баримт, импортын 12 бичиг баримтыг 4 болгож хүнд суртлыг бууруулсан. Одоо эрс реформыг хийх үүднээс гелотин (Францын хувьсгалын 19 дүгээр зууны үед хүнийг цаазлахад хэрэглэж байсан том сүх)-ийн хандлагатай том багт ороод ажиллаж байна.

Бид гадаад худалдааны процедурыг багасгах, тусгай зөвшөөрөл, хүнд суртлыг 50 хувиар бууруулах, хүнд суртлыг тас цавчиж, эрс реформын хандлагыг бий болгоно. Хүнд суртлын толгойг авахын тулд үндсээр нь устгах ёстой. Манай улсад одоогоор төрийн зохицуулалтын шинэтгэл эхэлчихсэн. Ухаалаг төр маань төрийн зохицуулалтын, эдийн засгийн оролцоотой өсөлтийг дэмжих гэсэн хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй байх учиртай.

- **Хүний хөгжлөө хаясан учраас Хүн ам нийгмийн хамгааллын хөгжлийн яамыг байгуулж, Хүний хөгжлийн бодлогын баримт бичгийг боловруулж байгаа. ЖДҮ эрхлэгчдэд нэг тулгардаг асуудал нь тогтвортой, чадварлаг ажиллах хүчин байдаг. Гэтэл ажиллах хүч аль ч салбарт тулгамдсан асуудал болчихоод байгааг хэрхэн зохицуулах вэ?**

**С.Дэмбэрэл:** - Одоо хөгжлийн бодлогоо ярьж байгаа нь үнэн. Хүний хөгжлөө хаячихсан. Нүүрс, зэсийг шүтсэн. Үүний дараа, тэрний дараа хүнээ бодно оо гэдэг бодлого л явж ирлээ. Өөрөөр хэлбэл эдийн засагт суурилсан хүрэн эдийн засгийн бодлогоор амьдарч иржээ. Бид дэлхийн чиг хандлагыг дагаад тогтвортой хөгжлийн бодлогыг ярьж байгаа ч сэтгэхүй нь өөрчлөгдөхгүй байна.

Тогтвортой хөгжил нь эдийн засаг, хүн нийгэм, байгаль орчин гэсэн гурван зүйлтэй. Эдийн засаг, нийгэм байгаль орчны шүтэн барилдлага, зохилдлогоог сонгож, хойч үедээ баялгийг үлдээх зорилготой. Энэ бол манай малгай бодлого. Хүнээ хөгжүүлнэ гэхээр хүмүүст мөнгө өгөхийг хэлэхгүй. Илүү сайхан амьдрах чадавхийг улс төр, эдийн засаг, нийгмийн боломжоор хангах орчныг хэлнэ.

Бид халамжит эцгийн дүрээр олон жил явж, хүмүүсээ эвдэлсэн. Бэлэнчлэх сэтгэлгээд хэт орж, өөрсдөө санаачлага гаргаж, инновацийг бий болгодог, овсгоо самбаачлагатай уур амьсгал алдарчихсан. Буруу бодлогын уршгаар цэрэгт тэнцдэггүй залуучуудтай, маш олон төрлийн өвчтэй хүүхдүүдтэй болсон.

**Ярилцсанд баярлалаа.**

## **Дипломат харилцааны том ялалтанд баяр хүргэв**

*УИХ-ын намрын ээлжит чуулганы 2014 оны 1-р сарын 9-ны өдрийн Нэгдсэн хуралдаанаар “Монгол Улсаас гадаадын зарим улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл” хэлэлцэх үед:*

С.Дэмбэрэл: Миний асуух гэж байгаа асуултаас өмнө оршил маань дандаа “...” хашилтанд хэлж байгаа гэдгийг анхаарна уу. Монгол улсаас Антигуа Барбуда улстай, Бүгд Найрамдах Бурунди Улстай, Бүгд Найрамдах Вануату Улстай, Бүгд Найрамдах Палау Улстай, Бүгд Найрамдах Суринам Улстай, Бүгд Найрамдах Сьерра Леон Улстай, Бүгд Найрамдах Того Улстай, Эритри Улстай, Ямайка Улстай дипломат харилцаа тогтоосон. Энэ чиглэлээр Монгол улсын дипломатын том ялалт хийж байгаад юуны өмнө баяр хүргэе.

2. Мөн энэ асуудлыг маш нухацтай авч хэлэлцэж, санал нэгтгэйгээр баталсан УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга болон гишүүдэд бас баяр хүргэе. Ганцхан зүйл асуух гэсэн юм. Монгол Улсын дипломат харилцаа, гадаад бодлогын тэргүүн чиглэл нь 2 хөрш, 3 дахь хөрш мөн гэсэн концепци бий. Нилээд доор хэсэгт НҮБ-ын үйл ажиллагаа дотор “77-гийн бүлэг”-тэй ажиллах нь чухал байр сууринд тавигддаг. Тэр үнэн. Монгол улсыг Геннисийн номонд бичигдэхийн тулд ийм дипломат харилцаанууд тогтоох үйл ажиллагаа явуулж байна гэж би бодохгүй байна. Өөрөөр хэлбэл дэлхийн бүх улстай дипломат харилцаа тогтоосон 2 дахь орноор тодорч, Геннисийн номонд бичигдэхийн тулд хийж байгаа гэж бодогдохгүй байна. Гэхдээ энэ дипломат харилцаа тогтоож байгаа хэдэн улстай дипломат харилцаа тогтоосны улс төрийн шалтгаан, эдийн засгийн шалтгаан, хүмүүнлэгийн шалтгаан нь яг юу юм вэ гэдгийг маш тодорхой хэлж өгөхийг хүсье. баярлалаа.

Л.Болд: С.Дэмбэрэл гишүүнийг баяр хүргэсэнд баярлалаа. НҮБ-д дэлхий дахины олон чухал асуудлаар байнга санал хураадаг. Тэнд бүх улс орон дипломат харилцаатай төдийгүй бүх улс элчин сайдын яам төлөөлөлтэй гэдэг утгаараа ч биш, бүх улс орнууд адилхан, нэг л саналын эрхтэй байдаг. НҮБ болон олон улсын үйл ажиллагаанд их чухал чиглэл.

З дахь хөрш гэж ярьдаг ч НҮБ-ын үйл ажиллагаа бол З-д бичигдэж байгаа гэдэг асуудлаар З дахь ач хобогдолтой гэж хэлж болохгүй. Бүх улс орнуудтай НҮБ-ын хүрээнд, цаашдаа үйл ажиллагаагаа эрчимжүүлэх, хамтран ажиллах зайлшгүй шаардлага байгаа. Ялангуяа Монгол Улс өнөөдөр хэд хэдэн асуудлаар олон улсын анхаарлын төвд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа. Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэг, Далайд гарцгүй орнуудын дэлхийн хамтын нийгэмлэг чиглэлээр тодорхой хөгжиж байгаа орнуудын цаашдын хөгжлийг энэ чиглэлээр олон улсын энэ орнуудтай зүгээр ёс төдий дипломат харилцаа тогтоох биш, эдгээр бүх улс орнуудыг нэгтгэсэн дэлхийн хэмжээний хөдөлгөөн, үйл ажиллагааг өрнүүлэх зайлшгүй шаардлага байгаа. Тийм учраас бид идэвхтэй гадаадын бодлогын баримталдгын хувьд хэрэгжүүлэх ёстой нэг алхам гэж үзэж байгаа. Дэлхий дээрх бүх улстай ёс төдий дипломат харилцаатай олон улс бий. Бидний гадаад бодлогыг УИХ-аар зөв шийдвэрийн хэрэгжилт гэж танилцуулах нь зүйтэй байхаа гэж бодож байна.

## **Шинжлэх Ухаанд хөрөнгө оруулалт хийх хэлбэр талаас нь дэмжиж байгаа**

*УИХ-ын Намрын ээлжит чуулганы 2014 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс: “Монгол судлалыг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл анхны хэлэлцүүлэг дээр:*

**С. Дэмбэрэл:** Энэ асуудлыг би их дэмжиж байна. Шинжлэх Ухаанд мөнгө хөрөнгө оруулалт хийх хэлбэр талаас нь дэмжиж байгаа юм. Гэхдээ, нэг зүйлийг лавлаж асуумаар байна.

1. Монгол судлал гэдэг дотор Монгол улсын эдийн засгийн бодлогыг судалдаг, эдийн засгийн орчныг судалдаг, хууль эрх зүйн орчныг судалдаг, хөрөнгө оруулалтын талаас нь судалдаг, ингэснээрээ Монгол улсыг хөрөнгө оруулалтын орон зай, эдийн засгийн орон зай гэдэг талаас нь шууд болон шууд бус байдлаар сурталчилж байдаг судалгаа шинжилгээний чиглэлүүд хэр зэрэг хөгжиж байна вэ?

2. Энэ чиглэлээр цаашдаа олон улсын Монгол судлалын холбооноос гадаад улс орнуудад байгаа Монгол судлалын төвүүд болон хувь хүмүүст Монгол судлалыг ийм ийм чиглэлээр хөгжүүлэх нь зүйтэй гэсэн удирдамж маягийн юм өгч болох уу? Монгол улсын үндэсний брендинг /бараа бүтээгдэхүүн биш, Монгол улсыг таниулан сурталчлах асуудлыг өргөн утгаар нь ингэж хэлж байна/ гэдэг талаас нь бодож удирдамж өгдөг, Монголыг энэ талаас нь судалж, сурталчилбал судалгаа шинжилгээний тэтгэлэг /scholarships/ өгье гэдэг ч юм уу, иймэрхүү дэмжлэг байдаг уу? Энэ талаар тодруулж өгнө үү?

**Д.Батцогт:** С.Дэмбэрэл гишүүний асуултанд хариулъя. С.Дэмбэрэл гишүүнтэй санал нэг байна. Энэ тогтоолын төслийг батлах шаардлага байна уу гэвэл байна гэдэг нь харагдаж байгаа. Монгол судлал бол үндэсний хөтөлбөр гээд батлаад, дээрээс нь сан гэж байгуулаад ч ер нь дорвитой үйл ажиллагаа явуулахгүй, эзэнгүйдсэн байдалтай хэвээрээ байгаа. Ерөнхий сайд үндэсний зөвлөл байгуулаад, эрдэмтэн докторуудаас нь оролцуулаад,

Хүрээлэнгийн захиралуудаас оролцуулаад хөгжүүлэх юм бол эзэнтэй болгоод, дээрээс нь байнгын хороо нэхэл дагал болоод шалгаад ажиллах юм бол энэ нь бас л бодитой үр дүнд хүргээд, дэмжээд ажиллах боломж бололцоо бий гэж үзэж байгаа. С.Дэмбэрэл гишүүний асуусан баримтлах гэж байгаа чиглэлтэй холбоотойгоор манай ажлын хэсгийн 2 гишүүн нэмж хариулна.

**Ажлын хэсгийн гишүүн:** Одоогийн байдлаар гадаадын Монгол судлаачдыг дэмжихэд академич Б.Ренчин, академич Ц.Дамдинсүрэн нарын нэрэмжит тэтгэлэг л байгаа. Энэ тэтгэлэгээс одоохондоо өөр тэтгэлэг байхгүй.

## **Америк Монголын худалдаанд ямар ахиц гарах вэ?**

*УИХ-ын Намрын ээлжит чуулганы 2014 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс: “Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг дээр:*

С.Дэмбэрэл: 2005 оны 01 сарын 01-нээс манай улсын оёдлын секторын хамгийн том худалдан авагч зах нь Америкийн Нэгдсэн Улс болсон. Тухайн үедээ Монгол улсын энэ салбар 30 мянган ажлын байртай буюу 30 мянган ажилтантай байсан. Ноднин жилээс эхлэн энэ секторыг дахин сэргээх бодлого явуулж байгаа. Саяхан манай Засгийн газраас Монголын экспортыг уул уурхайн бүтээгдхүүн болон уул уурхайн бус бусад бүтээгдхүүний экспортонд эзлэх харьцаа нь 90:10 байгаа гэсэн бүтэцтэй байгаа гажиг тогтолцооноос нь гаргая гээд хөтөлбөр баталсан. Асуух зүйл бол, энэ хэлэлцээрийг баталсанаар болон өмнө нь Америкийн Нэгдсэн Улсаас Монголын 15 нэр төрлийн бараанд өгсөн хөнгөлөлт энэ бүхнийг эдлээд Америк Монголын худалдаанд, ялангуяа Монгол улсаас АНУ руу экспортлох энэ шинэ том зах зээлээр дамжуулаад, бусад зах зээлтэй харилцах энэ асуудалд ямар тодорхой ахиц гарах юм вэ? Тооцоо судалгаа байна уу? гэсэн эхний асуулт байна.

*Хоёрдугаарт:* Бид хөтлүүлэх байдлаар явдаг баймгүй байна. Жижиг орны гадаад харилцаа, гадаад эдийн засгийн бодлого нь их идэвхтэй байх ёстой. Тэр талаасаа үзвэл энэхүү бодлого маань, тухайлбал Мянганы зорилтын сантай цаашдаа хамтран ажиллах эсэхтэй хэр зэрэг уялдах вэ? Чөлөөт худалдааны хэлэлцээрийн нэг бүрэлдхүүн хэсэг юм бол, чөлөөт худалдааны чиглэлээр юу тусгагдаж байгаа юм бэ? Жишээлбэл, Японтой хийж байгаа Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн зарим протоколыг нь уншаад үзэхээр, Японоос орж ирж байгаа “Second hand car” буюу ашиглагдсан, хуучин машиний асуудлыг ярьсан байна. Тийм том хэлэлцээрт, ийм жижигхэн юм ярьдаг байдал ажиглагдсан. АНУ-тай хийх гэрээ хэлэлцээр гэж ийм юм оруулж ирчихээд, ард талд нь Монголын экспорт болон чөлөөт худалдаанд хандах төрийн хандлага нь ямар байх нь тодорхой биш байна. Бас үүнийг огт эдийн засгийн асуудал биш юм шиг хандаж, тухайн асуудлыг хариуцдаг тусгай байнгын хороогоор нь ч

оруулахгүй өнгөрөх гэж байна. Гадаад харилцаа, аюулгүй байдал талаас нь хараад баталмар аялдаг, тэрнийг нь УИХ-ын чуулганаар ингэсхийгээд ярилцсан болж, хоорондоо ярилцсан болоод, кнопоо дардаг ийм л “бодлого” орж ирээд байна. Монгол улсын гадаад харилцааны бодлогод, ялангуяа эдийн засгийн гадаад харилцаанд нь чөлөөт худалдааны бодлого албан ёсоор яаж явагдаж байгаа юм бэ? Яг ямар байгаа юм бэ? “Үүний бүрэлдхүүн хэсгүүд нь “ингэж, ингэж” явж байгаа. АНУ-тай энэ хэлэлцээрийг байгуулсанаар “ийм, ийм” үр дүнгүүд гарахаар урьдчилсан байдлаар тооцоолоод гаргачихсан байгаа. Эдийн засгийн үр ашиг нь “ийм” юм. УИХ-ын Эдийн засгийн байнгын хороогоор “ингэж, ингэж” хэлэлцэгдэж, санал дүгнэлт авсан.” гэсэн зүйлүүд байхгүй бол болохгүй. Зээл тусамжийн талаарх зүйлс иймэрхүү л янзтай орж ирдэг юм байна. Энэ талаас нь бодож, Эдийн засгийн хөгжлийн яам, Гадаад хэргийн яам хоорондоо ярилцаж хийсэн зүйл УИХ-ын чуулганд оруулж ирж байгаа энэ зүйл дээрээ тодорхой танилцуулах юм байна уу гэсэн асуулт байна.

**Х.Тэмүүжин:** Энэ бол чөлөөт хуралдааны хэлэлцээр хийхтэй холбоотой хууль эрх зүйн нөхцөл нь болж орж ирж байгаа юм. Ил тод байдлын хэлэлцээр. Ил тод байдлын гол шаардлага нь:

1. Бизнесийн орчноо ил тод болго
2. Бизнес, санхүүгийн хөрөнгө оруулалттай хууль тогтоомж боловсруулж, батлах гэж байгаа бол хэлэлцэхээс өмнө асуудлаа ил тод байлга.
3. Боловсруулах, батлах гэж байгаа хууль тогтоомжуудаа англи хэл дээр гарга
4. Эрх ашиг нь хөндөгдөж байгаа нөгөө талтайгаа санал солилцсон байх

гэсэн үндсэн зүйлүүдийг тавьж байгаа хэлэлцээр юм. Яг энэ хэлэлцээртэй холбоотой асуудал нь Гадаад хэргийн яам, Эдийн засгийн хөгжлийн яамд илүү төвлөрсөн. Харин хэлэлцээрийн үр дүнгээр дотоодынхоо хууль тогтоомжийг энэ хэлэлцээртэй нийцүүлэн өөрчлөх тэр асуудал нь Хууль зүйн яамд төвлөрч шийдэгдэж байгаа.

### **Зээлийн хүүг бууруулах манай өөрсдийн маань, дотоод нөөц боломж байна**

*БНХАУ-ын томоохон банк болох “Bank of China”-ийн салбар Монгол Улсад нээгдэхэд УИХ-ын гишүүд гар бие оролцож байгаа гэсэн мэдээлэл хэвлэлээр гарсан. “Bank of China”-ийн салбарыг оруулж ирэхийг дэмжиж, оролцож байгаа гишүүдийн дотор УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл байгаа юм. Тиймээс энэ талаар С.Дэмбэрэл гишүүнээс зарим зүйлийг тодрууллаа.*

- Зарим хэвлэлээр таныг “Bank of China”-ийн салбарыг Монголд байгуулахад гар бие оролцож байгаа гэсэн мэдээлэл яваад байна л даа. Энэ талаар та тайлбар өгөөч?

С.Дэмбэрэл: - Харин миний инээд хүрээд л сууж байна. Монголд одоогоор “Bank of China”-ийн салбар нь биш төлөөлөгчийн газар



нь л бүртгэгдсэн. Одоогоор Монголд гадаадын таванбанкны төлөөлөгчийн газар л бүртгэгдсэн байгаа юм билээ. Хуулийн дагуу, Монголбанкны ерөнхийлөгч гадаадын банкны салбар нээх эсэхийг шийдвэрлэдэг. Одоогоор Монголд салбараа байгуулах гэсэн аливаа улсын банк алга гэсэн тайлбарыг Монголбанк өгсөн. Гадаадын банкны салбар байгуулагдахдаа Монгол Улсын хуулиар тодорхой шалгууртай. Тодруулбал, дэлхийн шилдэг 100 банкны нэгд орох, рейтингээрээ олон улсын зэрэглэлтэй байх зэрэг хуулиар тогтоосон шалгууруудтай байдаг юм шүү дээ.

**- Тэгвэл яагаад ийм мэдээлэл гарах болов?**

**С.Дэмбэрэл:** - Би болон бүх намын төлөөлөл багтсан гишүүд УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан Зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулах ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа. Ажлын хэсгийн ахлагчаар Д.Зоригт гишүүн ажиллаж байна. “Bank of China” гэх мэт гадаадын банкны талаархи мэдээлэл ажлын хэсгийн ярилцлагын явцад гарч байсан. Өөрөөр хэлбэл, зээлийн хүүг яаж нэг оронтой тоонд барих вэ, хүүг бууруулахын тулд банкуудын дунд өрсөлдөөн өрнүүлэх боломж байна уу гэдэг талаар ажлын хэсэг ярилцаж байсан. Ажлын хэсэгт бүх намын төлөөллөөс бүрдсэн гишүүд байхад яагаад цөөхөн хэдэн хүний нэр яриад байна вэ гэдэг нь цаанаасаа зорилготой юм болов уу гэж харж байна. Ер нь бол ажлын хэсгийн гишүүд нэгдсэн нэг байр суурьтай байгаа. Тодруулбал, гадаадын банкны салбар нээх нь хуулиараа нээлттэй байгаа ч 2016 оноос хойш ярих асуудал байна гэсэн байр суурьтай байгаа. Харин ажлын хэсгийн зүгээс зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулах ямар боломжууд байгааг судалж байна. Ажлын хэсэг, төр өөрөө зээлийн хүүг нэмэгдүүлэхэд нөлөө үзүүлж байна гэсэн дүгнэлтэд хүрсэн. Тиймээс долоон хуульд өөрчлөлт оруулж, төрийн өмчит бүх байгууллагууд арилжааны банкуудад байгуулсан дансанд байршуулахын тулд төрийн байгууллагууд хүү авч байна. Энэ хүүг авахаа болих юм бол арилжааны банкуудын зардал багасах боломжтой. Монгол Улс 23 жилийн турш зээлийн хүүг хоёр оронтой тоонд барьж ирсэн. Зээлийн хүүг бууруулах тал дээр манай ажлын хэсэг ажиллаж байна.

**- Ер нь “Bank of China”-ийн салбар Монголд орж ирснээр банкны салбар болон эдийн засагт ямар өөрчлөлт гарах юм бэ?**

**С.Дэмбэрэл:** - Энэ асуудлыг ярьвал улстөржүүлээд явчихна. Бид дотоод нөөц бололцоогоо харж, ашиглах боломжтой байна. Төв банкны тухай хуульд, гадаадын банкны салбарыг оруулж болно. Энэ салбарын тодорхой шаардлагын дагуу Монголбанкны ерөнхийлөгч шийдвэрлэнэ гэж заасныхаа дагуу явна. Зээлийн хүүг бууруулах манай өөрсдийн маань дотоод нөөц боломж байна. Түүнийгээ эхлээд ашиглая л гэж байгаа.

**- “Bank of China”-ийн салбар байгуулахыг төмөр замын царигийн асуудалтай холбож тайлбарлаад байгаа шүү дээ?**

**С.Дэмбэрэл:** - Би анхнаас нь энэ асуудлыг огт сонирхоогүй. Яагаад гэвэл би төмөр замын инжежнер биш. УИХ дээр Засгийн газар бодлогоо тодорхойлоод одоо л орж ирж байна. Төмөр замын цариг нь өргөн, нарийн байна уу би мэдэхгүй. УИХ олонхи юу гэж шийднэ, тэрүүгээр л явна.

**Ш.Оч**

**Эх сурвалж: <http://www.news.mn>**

## **Монгол Улсад Нэгдсэн эдийн засгийн гадаад бодлого гэсэн нэг л хоолой байх ёстой**

*Монгол Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулганы Эдийн засгийн байнгын хорооны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдааны гар тэмдэглэлээс: Монгол, Японы эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд сэдвээр Монгол Улсаас Япон Улсад суугаа Элчин сайдын мэдээллийг сонсох цээр.*

**Эдийн засгийн байнгын хорооны дарга Б.Гарамгайбаатар:** Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо миний бие тэргүүтэй манай Байнгын хорооны гишүүд 3 сарын 3-наас 7-ны өдрүүдэд Япон Улсад айлчилсан. Тэгээд ажлын гол зорилго бол Монгол, Япон хоёр орны стратегийн түншлэлийг эрчимжүүлэх, мөн ялангуяа эдийн засгийн салбарын хамтын ажиллагааг идэвхжүүлж, хөрөнгө оруулалтыг дэмжих, бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, мөн Улсын Их Хурлаар батлагдсан хөрөнгө оруулалтын тухай хууль, эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичиг, хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиудыг бас сурталчлах зорилгоор бол Япон Улсад айлчилсан. Айлчлал нэлээд үр дүнтэй болсон гэж ингэж Байнгын хорооны даргын хувьд үзэж байгаа. Яг энэнтэй холбогдуулаад бас Монгол, Японы хамтын ажиллагааны тухай Элчин сайдаас нь бас өөрсдөө мэдээлэл авч, гишүүдэд энэ мэдээллийг бас тэнцвэртэй олгох нь зөв юмаа гэсэн ийм саналаа бид нар ярилцаж байгаад, ингээд Элчин сайдыг өнөөдөр Япон улсаас дуудаж авчраад бас энэ талын мэдээллүүд өгч байгаа зүгээр. Энэ бол бас бидэнд хэрэгтэй мэдээлэл болох байх аа гэж ингэж бодож байна. Тэгээд мэдээллээ сонсьё.

**С.Дэмбэрэл:** - Нэг юм тодруулчих уу. Би ганцхан юм тодруулчихъя. Танай, таны бие тэргүүтэй хүмүүс явахын өмнө бас Одноогийн бие тэргүүтэй хүмүүс бас айлчилсан л даа. Тэр Одноогийн бие тэргүүтэй хүмүүсийн бүрэлдэхүүнд би явах завшаан олдсон. Тэгээд бас энэ асуудал дээр бас их анхаарсан юм гэдгийг бас та Байнгын хорооны даргадаа хэлчихье.

**Б.Гарамгайбаатар:** - Сайдын мэдээллийг сонсьё.

**С.Хүрэлбаатар:** -Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Тэгээд Монгол, Японы эдийн засгийн хамтын ажиллагаа, тэрэнд тавигдаж байгаа тулгамдаж байгаа асуудлын талаар миний мэдээллийг сонсох ийм боломжийг гаргаж өгсөн явдалд би Эдийн засгийн байнгын хорооны удирдлага, гишүүдэд эхлээд талархал илэрхийлье. Би тавих мэдээллийнхээ, хийх мэдээллийнхээ тухай нэлээн дэлгэрэнгүй материалыг урьдчилаад тараачихсан. Гишүүд бол танилцсан байгаа байх. Тийм учраас цаг авч бүгдийг одоо уншиж та бүгдийн цагийг их авмааргүй байна аа гэж ингэж бодогдож байна. Хэдэн гол зүйлүүд нэг их удиртгал товчхон хийгээд тэгээд анхаарал хандуулах ёстой, шийдүүлэх ёстой гол ганц хоёр асуудал байвал түрүүн акцент хийж мэдээллээ хийе гэж бодож байна. Монгол Японы хооронд дипломат харилцаа тогтоогоод энэ жил 42 дахь жилдээ явж байна. Энэ 42 дахь жилийн эхний хагас бол хоёр орны хооронд харилцаа, хамтын ажиллагаа өргөжиж хөгжих тийм боломж та бидэнд тодорхой байгаа шалтгааны улмаас бол хомс байсан. Тэгэхдээ дэлхий ертөнц хоёр

том системд хуваагдчихаад, өрнө, дорнодын харилцаа их сэргөлдөөнтэй, хүйтэн дайны үе байсан гэдгийг бодоход харин ч Монгол, Японы харилцаа бол эхний 20 жилдээ аажим, тогтвортой, дараа дараачийн харилцаа хөгжих суурь бол тавигдаж явж байсан юм байна аа гэж ингэж ойлгодог юм. Монгол Улсад ардчилсан хувьсгал ялж, бэхэжсэнээс хойш хоёр орны харилцаа бол үсрэнгүй хөгжсөн, өргөжсөн. 1990-ээд оны дунд үеэс хойш иж бүрэн түншлэлийн харилцаагаар хоёр орны харилцаа ийм зарчмаар салбар бүрд хоёр орны харилцаа өргөжиж явсан. 2010 оны 11 дүгээр сард Ерөнхийлөгч Элбэгдорж Япон Улсад айлчлах үеэр иж бүрэн түншлэлийн энэ харилцааг дараачийн шинэ шатанд гаргая, стратегийн түншлэлд шилжье гэдэг ийм зарчмыг тохирсон юм байна. Одоо бол стратегийн түншлэлийн харилцааг хэрэгжүүлэх чиглэлээр хоёр орны харилцаа идэвхтэй, сайн явж байгааг тэмдэглэж хэлье. Та бүхэн санаж байгаа байх. Өнгөрсөн оны 3 дугаар сард Японы Ерөнхий сайд Абэ Монгол Улсад айлчилсан. Манай Ерөнхий сайд Н.Алтанхуяг 9 сард айлчилсан Японд. Хагас жилийн дотор хоёр орны Засгийн газрын тэргүүн харилцан айлчлаад, энэ айлчлалын үр дүнд стратегийн түншлэлийг хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр баталсан. Стратегийн харилцаа гэдгийг бид нар бол 5 баганаар харж үзэж байгаа.

*Нэгдүгээрт*, улс төрийн яриа хэлэлцээ. Энэ дээр бол харилцан ойлголцлыг нэмэгдүүлэе, итгэмжилсэн ийм одоо улс төрийн харилцаанд хүрье гэсэн ийм зорилтыг улс төрийн салбарт тавьж байна. Энэ хүрэн дотроо бол батлан хамгаалах, аюулгүй байдал, бүс нутгийн хамтын ажиллагааг бас хамруулж ойлгоё гэж ингэж явж байгаа. Энэ бол маш сайн явж байна. Дээд өндөр хэмжээнд уулзалт болж байгаагаас гадна одоо ФИМ2 дээр нэмэх нь 2 гэж сүүлийн үед томьёолж байгаа politics and military гэж улс төр, цэргийнхний хамтарсан ийм одоо яриа хэлэлцээг Монгол, Япон хоёрын хооронд хийгээд хоёр дахь жилдээ болж байна. Япон Улс ийм хэлэлцээг 16-хан оронтой хийдэг. Тэгвэл манайх тэр 16 оронд нь багтаж байгаа. Энэ жил хоёр дахь удаагийн уулзалт ирэх зун яамдын газрын дарга нарын хэмжээнд үргэлжлэхээр ийм тохиролцоотой явж байгаа. Батлан хамгаалахын салбарт стратегийн гэдгээрээ хамтын ажиллагааны асуудал нэлээн сайн яригдаж байна. Одоо манай Батлан хамгаалахын сайд энэ сарын 15-наас Япон Улсад албан ёсоор айлчлах гэж байгаа ийм байдалтай явж байна. Бүс нутгийн салбарт сайхан амьдарч ажиллаж байгааг та бүхэн харж байгаа байх. Зүүн хойд Азийн талаар бид нар идэвхтэй санал солилцож байна, бодлогоо зохицуулж байна, хамтарч ажиллаж байна. Солонгосын хойгийн тогтвортой байдлыг хангах, энэ хойг дээр үүсээд даамжраад хэсэг байдалд орж байгаа цөмийн асуудлыг шийдвэрлэхэд 2 орон хамтарч ажиллаж хувь нэмрээ оруулах, Японы хулгайлагдсан иргэдийн асуудлыг шийдвэрлэхэд Монгол Улс бас яриа хэлэлцээнд нь дэмжлэг үзүүлж ажиллаж байгаа гэх мэтээр бүс нутгийн хамтын ажиллагаа сайн явж байгаа юмаа.

*Хоёрдугаар* багана бол эдийн засгийн багана. Стратегийн түншлэлийн. Энэ дээр бол хуучин Монгол, Японы эдийн засгийн харилцаа бол Японы зээл тусламжид дулдуйдаж, өгөөч өгөөч гэдэг ийм характертай хамтын ажиллагаа явж байсан бол одоо харилцан ашигтай, бие биеийг нөхсөн байхуйц ийм хамтын ажиллагаанд явъя гэдэг ийм зарчмыг тохирсон.

*Гуравдугаарт нь бол соёл, боловсрол, шинжлэх ухаан, спорт, олон нийтийн байгууллагууд, орон нутгийн байгууллагуудын хоорондын шууд хамтын ажиллагааг өргөжүүлэх гэсэн ийм нэг чиглэл явж байна. Эцсийн нэг том багана бол олон улсын тавцан дээр бие биеийг харилцан дэмжсэн хамтын ажиллагаа явуулнаа гэсэн ийм одоо 5 баганатай. Энийгээ ойрын, дунд хугацааны гэж хэлж байгаа. 2017 оныг дуустал хэрэгжүүлэх ийм хөтөлбөрийг өнгөрсөн онд Ерөнхий сайд нар харилцан айлчлахдаа төлөвлөгөө баталсан. За энэ хөтөлбөрийн үндсэн агуулгыг товчлоод гишүүдэд танилцуулчихсан байж байгаа. Энэ бол одоо хоёр орон ойрын 5 жилдээ мөрдөж ажиллах, хэрэгжүүлж ажиллах зарчим салбарууд, тэрний одоо тодорхой чиглэлүүд, төслүүдийг тодорхой заагаад өгчихсэн ийм сайн хөтөлбөр болсон. Одоо энийгээ хэрэгжүүлэх талаар хоёр орон санаа тавьж ажиллаж байна. Энэ их сайн хөтөлбөр болсон юм байна. Одоо Японы талаас бол энэ хөтөлбөрийн ач холбогдлыг байнга хэлдэг болсон. Энэ дотор ийм зүйлүүд орсон юм байна, одоо энийгээ хэрэгжүүлэе гэдэг талаар ярьдаг болж байгаа ийм байна. Монгол, Японы харилцаа яг өнөөдөртөө бол одоо хамгийн сайн үедээ явж байна. Япон Улс Монгол Улстай харилцах бодлогодоо ач холбогдол нь нэмэгдэж байна. Энийг эрээд тэдний гадаад бодлогод эзэлж байгаа Монгол Улсын байр суурь, ач холбогдол бол өсөж байгаа нь харагдаж байгаа. Энэ улс төрийн тэгээд эдийн засгийн бусад сонирхлууд энэ дээр хоёр орны сонирхол бол нийлж байгаа нь бол ийм боломжийг бүрдүүлж байгаа юм байна. Улс төр, аюулгүй байдлын талбарт гэх юм бол Япон Улсаас манай энэ оршин сууж байгаа зүүн хойд улс зүүн Азид бол жаахан тийм ганцаардаж байгаа байдалтай байгааг эрхэм гишүүд харж байгаа байх. Хятадтай хэрүүлтэй зодоонтой байна. Өмнөд Солонгостой харилцаа сайнгүй хэрүүлтэй байна. Хойд Солонгостой ярих юм алга. Оростой газар нутгийнхаа асуудлыг шийдэж чадаагүй, тэр нь эдийн засгийн хамтын ажиллагаанд нөлөөлсөн байдалтай байж байна. Энэ хөрш орнуудаа өөрийнхөө эргэн тойрны орнуудтай харилцаа нь хүндэрсэн ийм нөхцөлд Монгол Улсын стратегийн ач холбогдол өсөж байгаа байдал харагдаж байна. Ерөнхий сайд Абэ Монголыг зүүн хойд Ази дахь манай хамгийн дотно, чухал түнш гэж өнгөрсөн онд Монгол Улсад айлчлахдаа томъёолж, энийгээ зарласан. Энэ бол улс төрийн талаасаа, аюулгүй байдал, стратеги талаасаа Монгол Улсад талаарх сонирхол нь нэмэгдсэн гэдгийг харуулж байгаа зүйл. Хоёрдугаарт, эдийн засгийн талаар хамтарч ажиллах Японы Засгийн газрын болоод хувийнхны сонирхол нэмэгдэж байна. Гол нь Япон Улс өөрөө эрдэс баялаг багатай орны хувьд Монгол орны сайн чанарын нүүрсийг авъя, газрын ховор элемент авъя, тэгээд зэс, уран, молибденум, алт гэсэн ийм газрын ховор элемент гэсэн ийм зүйлүүдээр хамтарч ажиллаж, тэрийг олборлоход нь оролцъё, дэд бүтцийг нь байгуулахад нь оролцъё. Тэгээд тэрийгээ нэлээн хэмжээгээр гаргаад ирэхээр зэрэг бол импортолж авъя гэсэн ийм сонирхол бол байна. Энийгээ цааш нь хөгжүүлэх, бизнесийн орчин, эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар нэлээн анхаарал тавьж ажиллаж байна. Одоо хоёр орны хооронд бол худалдааны хэлэлцээр байж байдаг, хөрөнгө оруулалтын хэлэлцээр байж байдаг, дээрээс нь одоо эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулахаар нэлээн дөхчихсэн явж байна. Өнгөрсөн удаад нийтдээ нэг 5 удаа 5 raund хэлэлцээ*

хийсэн, одоо энэ 4 дүгээр сарын 21-нээс 6 дугаар raund-ийн хэлэлцээндээ орох гэж байна. Амжилттай явбал энэ ондоо багтаад эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг бол байгуулчих, үсэг зурчих ийм нөхцөл ойртож байгаа юм байна. Одоо бол нэг тарифын асуудал, худалдааны либеральчлалын асуудал хоёр дээр нэг жаахан асуудал байгаа. Энийгээ бол тохирч чаднаа гэсэн ийм найдвартай байж байгаа. Яг энэ асуудлаар тохиролцохоор хэлэлцээний өмнө ярилцъя гээд Японы Гадаад яамны Хятад, Монголын хоёрдугаар хэлтсийн дарга ирчихсэн байгаа. Энэ бол эдийн засгийн хамтын ажиллагаа хариуцдаг ийм хэлтэс байгаа юм. Тэгээд урьдчилж манай нөхдүүдтэй ярьчихаад, бэлтгэлээ сайн хангаж байгаад 21-нээс дорвитойхон хэлэлцээнд оръя гэсэн ийм чиглэлтэй явж байна. Одоо нэг хоёр удаа raund хэлэлцээ хийгээдэхвэл эдийн засгийн түншлэлийн хэлэлцээнд үсэг зурах ийм нөхцөл бол бүрдэх юмаа гэсэн байдлаар ингэж харж байгаа. Бизнесийн орчин бүрдүүлэхэд, сайжруулахад манай хөрөнгө оруулалтын хуулийг нэлээн шүүмжлэнгүй ханддаг байсан. Саяны засаж сайжруулсан хууль, тэрний заалтууд, яаж сайжирсан юм, ямар ашигтай нөхцөлүүд гарсан юм гэдгийг таниулах ажлуудыг бол нэлээн олон сувгаар, янз бүрийн түвшинд хийсний үрээр сайжирсан байна аа гэдэг ийм дүгнэлтийг японууд хийж байгаа. Энэ жил айлчилсан Их Хурлын 3 төрлийн гишүүдийн айлчлал энэ дээр бол энийгээ сурталчлахад чиглэсэн, хажуугаар нь Элчин сайдын яам энийгээ сурталчлах ажлууд нэлээн явууллаа. Бүр энд зориулсан семинар симпозиумууд хийлээ, ингээд хөрөнгө оруулалтын хууль бол сайжирсан юм байна гэж дүгнэж байгаа. Тэгэхдээ энэний хэрэгжилт тодоо ямар байх вэ. Бидэнд бас одоо итгэл алга байна шүү гэдгийг сануулж байна. Хэрэгжүүлэлтэн дээр одоо бодож үзүүштэй, бас яг итгэл төрөхүйц тийм зүйл бол сайн харагдахгүй байна шүү. Татварын асуудалтай холбоотой нэг хоёр гурван юм байна. Тэрийгээ одоо тана эдийн засагчид, танай улс төрчид, эд нар энийгээ харж байгаа байх. Тэгээд энэ бүхнийгээ аятайхан шийдэх юм бол хөрөнгө оруулахад учирч байгаа саад бэрхшээл ихээхэн багасах юм байна аа гэсэн ийм зүйлүүдийг Японы Засгийн газрын энэ дотроо эдийн засгийг хариуцдаг улсууд, хувийн хэвшлийнхний зүгээс бидэнд бас хэлж сануулж, захиж байна. Энийг эрхэм гишүүдийн сонорт бас уламжилъя. Засгийн газар нь бол хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад, тэр уруу чиглэсэн эрх зүйн ийм үндсүүдийг нь бий болгох талаар анхаарах байна. Тэгэхдээ одоо хувийнхныгаа тэр уруу аль болохоор чиглүүлэх ийм чигээр явж байгаа бол хувийн хэвшлийнхний сонирхол бол хөрөнгө оруулах сонирхол их байна. Тэгэхдээ болгоомжлол ерөөсөө хэвээр байгаад байна. Саяны тэр хөрөнгө оруулалтын хууль, бусад эрх зүйтэй холбоотой юмнууд байсан. Тэрнийг бол одоо болгоомжлол нь багасаж байгаа байх. Тэгээд цаад талд нь юу гэж хэлж байна вэ гэхээр зэрэг монголчуудад одоо нэг хэцүү асуудал бол ажил хэрэгч чанар сайнгүй байна шүү. Шахаж байгаад ийм юм хэрэгтэй байна гээд гэрээ хэлэлцээр байгуулдаг. Тэрүүгээрээ үүрэг хүлээдэг. Хэрэгжүүлэх гээд эхлэхээр зэрэг тэрэн дээрээ хойрго байдаг шүү. Хүлээсэн үүрэг амлалтаа хэрэгжүүлэх талаар одоо жаахан доголдолтой байгааг их сайн цааш цаашдаа анхаарч байхгүй бол энэ их муу тал байна гэдгийг нэлээн анхааруулж байна. Тэгээд яах вэ манайхыг ерөнхийдөө дэд бүтцийн хөгжил сул, зах зээлийн хэмжээ



бага, гадагшаа транзит тээврийн нөхцөл улам ч бас их сайнгүй гээд олон талын бэрхшээл байна. Тэгэхдээ энэ бүхнийг шийдээд цаашаа хамтын ажиллагаанд урья гэсэн ийм сонирхол хувийнханд ч байна, Засгийн газар бол бүр энэ уруу чиглүүлсэн байдлаар харж байна. Өнгөрсөн онд Ерөнхий сайд Абэ Монголд айлчлахдаа хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааг Японы хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээгээр гол нь монголын тогтвортой хөгжлийг хангахад тус дэм болох, дэмжлэг үзүүлэхүйц ийм байдлаар одоо хөгжүүлье гэсэн ийм санаачилга ярьсан. Энийгээ Абэ инициатив гэж өөрөө нэрлэсэн. Тэгэхээр энийг хэрэгжүүлэхэд манай улсын цаашид одоо хөгжлийн тодорхой том зорилтууд, чиглэлүүд, мега төслүүд эд нарыг одоо санхүүжүүлэх бололцоонуудыг гаргаж өгч байна аа. Боломж бол нэмэгдэж байна. Одоо бол Засгийн газрын зээл гэхэд хоёр шугамаар авах бололцоо байж байна. Нэгдүгээрт, ЖАЙКА-гийн зээл байна. ЖАЙКА-гийн зээл дотор бол энгийн нөхцөлтэй зээлийг авах бололцоо байна. Тусгай нөхцөлтэй зээл авахад болж байна. Эдийн засгийн тусгай түншлэлийн зээл гээд бүр одоо 0.10 хувийн хүүтэй, 40 жилийн хугацаатай, хүүгий нь 10 жилээр төлөхгүй байх гэсэн тийм одоо нөхцөлтэйгээр зээлүүдийг өгөх бололцоо байж байна. Дээрээс нь хоёр шаттай иений зээлээ үргэлжлүүлж өгье гэж байна. ЖАЙКА-гийн энэ зээлээс гадна цаад талд нь зээл авах бололцоо ЖВІС-ийн шугамаар бий болж байна шинээр. Өнгөрсөн онд та бүхэн санаж байгаа байх. Экспортын зээлийн шугам нээх гэдэг хэлэлцээр байгуулсан. Хоёр Засгийн газар. Энэ хэлэлцээрийн дагуу 8 тэрбум иенийн зээлийг эхний удаад олгоноо гэсэн ийм хэлэлцээр байгуулсан. Энэ бол ЖВІС-ийн шугамаар санхүүжилт шинээр олж авах ийм бололцоонуудыг нээж байгаа. Энд импортын зээл байж болж байна. Экспортын зээл байж болж байна. Богино хугацаатай яаралтай тусламжийн одоо элементтэй тийм зээл авч болж байна. Хамгийн гол нь манай сонирхож байгаа хөрөнгө оруулалтын зээлийг нэлээн авч болж байна. Өнгөрсөн онд Батбаяр сайд Японд айлчилсан. Энэ айлчлал бол хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааны талаарх хэн нь юу юу хүсээд байгаа юм, ямар бололцоо байна гэдгийг тодруулахад нэлээн дорвитой сайн айлчлал болсон. Тэрэн дээр та бүхэн Батбаяр сайд ч гэсэн өөрөө ирээд нэлээн мэдэгдэж байгаа харагдсан. Хэрэгжүүлэх төслийн үр ашиг одоо нотлогдох юм бол энэ үнэхээр үр дүнтэй тийм төсөл байнаа гэх юм бол санхүүжүүлэлт дээр бид нар гар татахгүй шүү гэдгийг японууд хэлж байгаа. Одоо ч тэрийгээ сануулж байна. Ингээд ЖАЙКА, ЖВІС хоёрын шугамаар нийтдээ одоо олон төрлийн, 7, 8 төрлийн зээл авах боломж бол байж байна. Дээрээс нь сая авсан самурай бонд байна. Энийг дахиж авах юм бол нөхцөл ецэ цаашаа зөөлрөөд явах ийм нөхцөлтэй юм байна лээ. Ийм одоо дунд хугацааны хөтөлбөрт хэрэгжүүлье гээд заачихсан тодорхой төслүүд байж байгаа. Тэрийг санхүүжүүлье гэсэн боломжууд нь байж байгаа. Одоо энд хоёр зүйл гацаастай байна. Энэ дээр би эрхэм гишүүдийн анхаарлыг энд хандуулахыг хүсэж байна. Одоо:

*Нэгдүгээрт*, энэ өрийн удирдлагын хуулийн асуудал байна. Энэ бүхэнд та бүхэн дөжиртлөө ярьсан байгаа байх. Гэхдээ энийг хэлэхгүй бол болохгүй байна. Одоо Монгол, Японы хооронд нэг юм уу, хоёр том одоо төслийг барьж аваад, санхүүжилтийг нь хийлгэе, зээл авъя гэхэд энэ хууль одоо үйлчлэхгүй бол боломж гарахгүй байна. Тэгэхээр энэ дээр хуулийнхаа

зохицуулалтыг хийхгүй бол японоос санхүүжилт бол авч чадахгүй. Энэ санхүүжилт авч чадахгүй цаашаа яах нь бол та бүхэнд тодорхой харагдаж байгаа. Тэгэхээр энэ Монгол Улс цаашаа хөгжье гэж байгаа болбол том том төслүүдийг хэрэгжүүлэхэд санхүүжилт хэрэгтэй байгаа болбол тэрэн дээр японы зээлүүд, японы тэргүүний технологи хэрэгтэй байгаа бол Өрийн удирдлагынхаа хуулийг зохицуулалт хийхээс өөр аргагүй байдалд хүрч байгаа юм. Энийг та бүхэн улс төрийнх нь талаас тунгаагаач. Эдийн засгийн талаас нь тооцоогоо сайн хийж үзээч. Тэгээд зохицуулалт хийх гарцаа одоо бий болгооч ээ гэж эрхэм гишүүдээс би одоо хүсмээр байна. Энэ нэгдүгээр бэрхшээлийн асуудал байна.

*Хоёрдугаарт*, эрхэм гишүүдийн анхаарлыг хандуулмаар нэг асуудал байгаа нь транзит тээврийн асуудал байна. Бид нар одоо ингээд Оюу толгойгоосоо нэлээн юм авах байх. Таван толгойгоо эзэмшээд ирэх байх. Япончуудын хамгийн их сонирхож байгаа сайн чанарын нүүрсийг гаргах бололцоо гараад ирэх байх нүүрстэй нь. Яаж Японд хүргэх вэ эрдэс баялгаа. Хятадаар яаж явуулах вэ, ямар төмөр замаар нь, ямар боомт дээр нь хүргээд, Оросоор бас ямар төмөр замаар нь яваад, аль боомтыг ашиглаад, ямар тарифтай, ямар хөлстэй, яаж явуулах вэ гэдгийгээ одоо энэ хоёр оронтой хэлэлцээгээ идэвхжүүлэх, хөдөлгөж ярьж эхлэхгүй бол өгөх юмтай болчихдог, тэрийгээ яаж хүргэх вэ гэдэг асуудал гацаатай болох юм. Ингэхээр одоо санхүүгийнхээ эх үүсвэрийг авах бололцоогоо бүрдүүлэх, дараа нь эрдэс баялгаа хүргэх транзит тээврийнхээ асуудлыг шийдэх. Энэ хоёрыг шийдчих юм бол Монгол, Японы эдийн засгийн хамтын ажиллагаанд нэлээн одоо аятайхан төлөв, дорвитой хамтын ажиллагааны төлөв бол нээгдчихсэн байна аа. Энийг эрхэм гишүүдэд би хүргэе гэж одоо бодсон юм.

*Гуравдугаарт*, Япон бол манай тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлье гэж хэлж байгаа нь бол саяны энэ чиглэлүүдээр санхүүжилт өгье, техник технологио нийлүүлье гэж байгаагаас гадна боловсон хүчнийг нь бэлдэж өгөхөд тусалъя гэсэн ийм чиг байгаа. Саяхан ЖАЙКА-гаас 7.5 тэрбум иений боловсролын зээл авахаар хэлэлцээр байгуулсан. Энэ их сайн. Энэ дээр бол Японы техникийн коллежуудад манайд хэрэгцээтэй байгаа инженер техникчдийн мэргэжлээр сургана. Энэ их сайн зүйл болсон гэж бодож байгаа. Энэнтэйгээ хажуугаар нь бас мэргэжилтэй ажилчдыг Японд бэлтгэх энэ асуудал дээр бас анхаармаар байна аа. Тийм боломж байна. Манай энэ одоо ТМС-үүд, ялангуяа барилгын ТМС-үүд, зам, гүүр, тэгээд энэ сантехник эд нар гэсэн яг өнөөдөр Монголд уул уурхай ч гэсэн чиглэлээр ингээд хэрэгцээтэй байгаа мэргэжлийн ажилчдыг энд ТМС төгсгөнгүүт нь, ТМС-д сурч байхад нь хагас жил япон хэлний анхан шатны мэдлэг олгоодохвол цааш нь залгуулаад Японд аваачаад нэг хагас жил сургах, тэгээд компаниудад дадлагажигч ажилтнаар ажиллуулах. Ийм боломж бол сайн хөөцөлдөх юм бол байна аа. Тэгээд ингэж боловсон хүчин бэлтгэх асуудлаа Японтой хамтарч хэрэгжүүлэх төслүүдтэйгээ уяж явбал ямар вэ гэсэн би ийм санал тавимаар байгаа юм. Одоо бид нар шинэ нисэх буудал барьж байгаа. Хамгийн түрүүнд тэр нисэх буудлыг одоо ажиллуулахад хэрэгцээтэй байгаа мэргэжлийн хүмүүсүүдээ тэнд сургах асуудлаа одоо тодорхой ярьж эхлэх ёстой байна. Цааш нь гангийн үйлдвэр байгуулах,

зэс хайлах үйлдвэр байгуулах энэ тэр гээд яриад эхэлбэл энэ чиглэлээр инженер техникийн ажилчдаа сургахаас гадна мэргэжилтэй ажилчдаа бас нэг сургах талаас нь ажилламаар байна. Сайн барилга, барилгын материал, зам, гүүр гээд бидэнд бас хэрэгцээтэй мэргэжлээр хүмүүс сургах бололцоо байж байна. Япон 20 онд олимпын наадмыг Токиод зохион байгуулна гэсэн одоо эрхээ авчихаад, барилгын ажил эхэлж байна. Барилгын ажил эхлэхэд тэнд ажиллах хүчин дутаж байна. Тийм учраас мэргэжилтэй барилгын мэргэжил олсон, ТМС төгссөн гадаадын залуучуудыг одоо олон мянгаар нь авч ажиллуулна гэсэн асуудал уруу одоо орж байна. Энийг бид нар бас ашиглаад тэрэн дээр хүмүүсүүдээ бэлдэж авъя гэсэн ийм зүйлүүдийг шийдмээр байгаа юм. Ерөнхийдөө та бүхний анхааралд төвлөрүүлэхэд ийм л хэдэн асуудал дээр эдийн засгийн юмнууд дээр анхаарч өгнө үү гэж хэлэх зүйл байна. Бусад тодотгосон зүйлүүд, та бүхэнд тараасан тодорхой дэлгэрэнгүй мэдээллийн дотор байж байгаа. Энэ дотроос асуух зүйл байвал би хариулъя.

*Эцэст нь* би эрхэм гишүүдийн анхаарлыг нэг зүйлд бас хандуулахыг хүсэж байна. Энэ Элчин сайдын яамны барилгыг шинэчилж барих асуудал энийг одоо хүргэхгүй бол болохгүй байна аа. Одоо манай төсвийн бололцоо их муу байгаа гэдгийг бол би харж байна. Тийм учраас өнөө маргаашгүй барилгыг нураагаад, шинээр барих төсөв өгөөдөхөөч гэж хэлэх зүрх зориг бол миний амаар гармааргүй байна. Тэгэхдээ байгаа байдлыг эрхэм гишүүдийн бас чихэнд хүргэж байхгүй бол тэнд байдал хэцүү байна аа. 40 жилийн өмнө барьсан барилга байж байгаа. Нэг ч удаа их засвар хийгээгүй байж байгаа. Удаа дараагийн газар хөдлөлтийн улмаас тааз нь, хананууд нь цууралт гарчихсан байж байна. Энэнээс илүү аймшигтай нь бол инженерийн, сантехникийн системүүд нь маш их хуучирч элэгдсэн, одоо аваарийн байдалтай байна. Хамгийн аюултай юм бол газны хоолойнууд байна, хүүхдийн зулай шиг болчихсон. Энүүгээр нөгөө шүүрэлт гараад, газ үнэртээд ирэхээр нь зэрэг компанид нь хэлдэг, тэднийхэн ирээд бүх шугамаа солихгүй бол наадах чинь авааритай байна гээд тэдэнд мөнгө байхгүй гэхээр яах вэ хөөрхий зайлуул нэг юмаар түр ороож өгөөд явдаг. Тэгтэл хэд хоногийн дараа өөр газраар шүүрдэг ийм байдалтай байгаа. Бохирын шугам бас адилхан. Байнга одоо энэ тэрүүгээрээ хагардаг, бохир алддаг, хавь ойрныхныхоо тав тухыг алдуулдаг, пүү пай хүрдэг ийм байдалтай. Цэвэр усны шугам бас их муудсан. Японд газар хөдлөлтийн стандартаа манай энэ байрыг худалдаж авснаас хойш 4 дахиж шинэчилсэн байна. Манайх анхныхаа хэвээрээ байж байна. Тэгээд ерөөсөө 7 хоногийн өмнө та бүхэнд тараасан материал дотор байгаа байх. Дүүргээс мэдэгдэл хүргүүлсэн бидэнд. Манай Элчин сайдын яам байж байгаа Шибуяа дүүргийн захиргаанаас энэ байшин чинь одоо газар хөдлөлтийг тэсэхээ байсан байна. Аюултай байдалд орсон байна. Энийг одоо нурааж шинээр байгуулах ажилдаа яаралтай ор оо гэсэн ийм мэдэгдэл өгсөн. Ер нь бол актыг бол 10-аад жилийн өмнө тавьчихсан юм байна лээ. Одоо юу болж байна вэ гэхээр зэрэг Японд дараачийн нэг их том газар хөдлөлт ирнэ гэж орон даяараа энийг бэлдэж байна. Номхон далайн Японы эргээс цааш байгаа далайн ёроолд хөрсний цууралт гарчихсан юм байна. Тэр зөрчсөн тэр хөрсний ан цаваас лав наашаа түлхэгдэх юм гэнэ. 9 балл хүртэл одоо хүчтэй газар хөдөлнө. Тэрийг дагаад аварга цунами орж ирнэ. Ингэж

орж ирэхэд энэ газар хөдлөлт цунамигаас ямар хохирол гарах вэ гэдгийгээ тооцчихсон байна. Тэгээд тэрэнд бэлтгэх юм бол, бэхлэлт хийх юм бол аюулгүй байдлаа хангах юм бол учирч болзошгүй хохирлуудыг ингэж ингэж багасгаж болох юмаа гэдэг юмаа тооцоогоо гаргачихсан байна. Тэрийгээ ард түмэндээ сурталчилж байна. Тэгээд ийм бэлтгэл хий гэж ийм бэхлэлт хийгээч. Тэрэнд чинь хөрөнгө мөнгө чинь хүрэхгүй байвал гээд Засгийн газраас нь тэрэнд нь хөнгөлөлттэй зээл өгч байна. Ингээд орон даяараа тэр хохирлыг, хохиролтойгоор давъя гэдэг ийм бэлтгэл хийж байдаг. Тэрнийгээ бас гадаадын Элчин сайдын яамдуудаас шаардаж байдаг. Тэгээд манай дээр бол ерөөсөө наад байшингаа нураагаад шинээр эхлэхгүй бол шаардлага хангахгүй байна аа гэсэн ийм зүйл ярьсан. Энийг бол одоо өнөө маргаашгүй бидэнд одоо өгч чадахгүй гэхэд боломж бүрдэхэд өгөхгүй бол тэнд одоо нэг гамшиг болох юм бол бас Элчин сайдын яам нураад ойччихсон байх ийм байдал бол ойрхон байна аа гэдгийг та бүгдийн бас нэг анхааралд хүргэе гэсэн юмаа. За баярлалаа анхаарал тавьсанд.

**Б.Гарамгайбаатар:** -За Элчин сайд Хүрэлбаатар баярлалаа. Тэгээд мэдээлэл хийхэд оролцож байгаа хүмүүсийг танилцуулъя. Л.Болд Гадаад харилцааны сайд, Л.Эрдэнэдаваа Гадаад харилцааны яамны Ази, номхон далайн орны газрын зөвлөх, Б.Шинэбаатар Эдийн засгийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, С.Жавхланбаатар Эдийн засгийн хөгжлийн яамны Гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалт, бүртгэлийн газрын дарга, А.Ариунаа Эдийн засгийн хөгжлийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагаа, зээл тусламжийн бодлогын газрын орлогч дарга, Сувдаа Эдийн засгийн хөгжлийн яамны мэргэжилтэн эдгээр хүмүүс оролцож байна.

**С.Дэмбэрэл:** -Би ерөнхийдөө сая бас С.Хүрэлбаатар сайдын ярьсан зүйлийг газар дээр нь сонсож бас газар дээр нь нүдээрээ харсан. Хамгийн сүүлчийн асуудлаас эхэлье. Элчин сайдын яамны байрны өнөөгийн байдал. Яг ийм байдлаар одоо энэ Элчин сайдын байрны одоо тэр Токио хот. Токио хотын тухайн дүүрэг, тэгээд энэ барилгын аюулгүй байдлыг шалгадаг байгууллагуудаас нь нэг хэсэг нь 10 жилийн өмнө, нэг хэсэг нь саяхан ийм одоо бүх бичиг сачиг аа ирүүлчихсэн юм байна лээ. Тэгэхээр бид бол өнөөдөр бүхэл бүтэн Монгол Улсын, Монгол Улсыг төлөөлж байгаа Элчин сайдын яамны байрны тухай ярьж байна л даа. Нураад уначих вий дээ. Одоо нэг булай юм болж магадгүй шүү. Энийг эртхэн шийдэж, одоо Хүрэлбаатар сайд бол яах ёстой гэхээр энэ бүх бичгийг Гадаад хэргийн яамандаа, Эдийн засгийн хөгжлийн яаманд энийг бүр албан ёсоор тавих ёстой. Яагаад гэвэл хэрэв энийг тавихгүй бол дараа нь танд хариуцлага оногдож магадгүй. Муу юм болбол. Тийм учраас нэгдүгээрт, энийг би таныг тэгээсэй гэж бодож байна. Тэгээд тэрний дараа энэ байрны асуудлыг бид одоо нэгэнт энд сонсгол, мэдээлэл сонссоны дараа энэ асуудлыг шийдэх гарцуудыг хайх ёстой. Одоо номоороо бол энэ чинь улсын төсвөөр яах ёстой. Эсвэл одоо хөнгөлөлттэй зээл уруу оруулж өгдөг юм уу, яадаг юм. Энэ талынхаа юмыг одоо Эдийн засгийн хөгжлийн яам гаргах ёстой байх. Энийг бол ойрын хугацаанд шийдэх ёстой гэж бодож байна *нэгдүгээрт*.

*Хоёрдугаарт*, эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг бол энэ ондоо дуусгах шаардлагатай. Ерөнхийдөө би манай энэ хоёр талын тэр түншлэлийн хэлэлцээрийн агуулга, яригддаг *round*-д дээр яригдсан юмнуудыг хараад байхад бол манай тал нөгөө урьдчилан босгох гэж байгаа байшингийн

гүүрний бүх зүйлүүдийг нь детальчлан хараад, Японы тал бол тэгж харахгүй ерөнхийдөө энэ хүрээ хэлэлцээрээ хийгээд, тодорхой тодорхой асуудал шийдэх ёстой асуудлуудыг явцын дунд хийгээд явъя гэсэн тийм нэг илэрхийлж хэлээгүй мөртлөө тийм явцыг нь харахаар нэг тийм байр суурь ажиглагдсан. Тэгэхээр би саяхан Чулуунбат дэд сайдад захиа бичсэн. Ингэж детальчлан ярихын оронд хүрээ хэлэлцээрээ яаралтай хийгээд, явцын дунд шийдэх ёстой асуудлыг ийм орон зайгаа тэр хэлэлцээртээ бий болгоод явбал энэ хэлэлцээр бол хэрэгтэй. Тэрнээс биш одоо Японы тал ингэчихвэл ингэчихнэ, ингэчихвэл тэгчихнэ гэсэн нэг тийм детальчлан дүрслэн бодох, ургуулан бодох тийм юм хэрэггүй ээ. Тийм учраас энэ ондоо багтааж, энэ хэлэлцээрийг батлах ёстой. Энэ хэлэлцээрийг батлагдсаны ач холбогдол бол зөвхөн Монгол, Японы эдийн засгийн харилцаандаа биш цаашдаа Монгол улс чөлөөт худалдааны хэлэлцээр, бусад улс орнуудтай хийхэд бол бас их түлхэц болж өгөх ийм зүйл байгаа юм хоёрдугаарт.

*Гуравдугаарх нь* тэр өрийн удирдлагын тухай хууль. Тэгэхээр бид бол нэг ийм зүйлийг их анзаарахгүй бол болохгүй болчихоод байна л даа. Зөвхөн Япон төдийгүй Японы одоо санхүүжилт бол түрүүн энд дурдлаа. ЖАЙКА, JBIC, тэгээд самурай бонд гээд ингээд бас бус. Тэгээд тийм хөнгөлөлттэй зээлүүдийн боломж өнөөдөр бусад улс орнуудаас хамгийн их манайд олгож байгаа Япон улс. Япон Улсын энэ зүйлийг их ашиглах хэрэгтэй. Ялангуяа тэр тусгай нөхцөлтэй хөнгөлөлттэй зээлүүдийг. Ингэхийн тулд бид нар энэ Эдийн засгийн байнгын хорооны энэ 2014 оны төлөвлөгөөнд суулгаж өгч байгаа. Ер нь энэ хоёр талын болон олон улсын хөгжлийн түншүүдийнхээ энэ чиглэлээр манайд төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх гэж байгаа энэ ерөнхий мэдээллийг сайн сонсож, бид өөрснөө юу бодож, тэд юу бодож байна, тэгээд эндээс одоо Монгол Улсаас хөрөнгө оруулагчид нь ч тэр, хөгжлийн түншүүд нь ч гар хөлөө татаж аваагүй байна. Тусалъя гэж байна. Тэрний дотор тэр Абэ Ерөнхий сайдын эрчим хөтөлбөрийн хүрээнд. Тэгэхээр энэ тохиолдолд бид өөрөө тодорхой бус байна. Ний нуугүй ярихад гадуур бол янз янзын юм ярьж байна. Олон улсын байгууллагууд, албан болон албан бус уулзалтын үеэр. Энийг бид тодруулж авах ёстой.

Гуравдугаарх нь энэ бол их сайн эхлэл. Гол гол стратегийн ач холбогдолтой, стратегийн түншлэлтэй ч гэдэг юм уу энэ улс орнуудынхаа элчин сайд нарыг ингэж сонсож, анх сонсож байгаад бол одоо би их баяртай байна. Яагаад гэвэл энэ асуудлуудаар ингэж сонссоны үндсэн дээр бид нар цаашдаа Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцаан дээр ер нь ямар яг нэгдсэн бодлого байх. Бид олон хоолойгоор яриад байна. Одоо би тодорхой яамнуудыг хэлэхээ больё. Зүгээр олон хоолойгоор ярьж байна. Монгол Улсад нэг л хоолой байх ёстой. Нэгдсэн эдийн засгийн гадаад бодлого гэсэн. Энэ асуудлуудыгаа нэг ер нь бол нэг цэгцлэх. Энэ бол бас Японтой хамааралтай. Японтой хэдийгээр бид нар яг ингээд стратегийн түншлэл гээд тодорхой яваад байгаа юм шиг мөртлөө ерөнхий одоо жишээлбэл тэр ялангуяа санхүүжилт, зээл тусламжийн асуудал дээр. Монгол Улсыг Япон бол урдын адил хамгийн сайн түншээ, энэ улсад сайн туслах ёстой гэдэг байр суурь нь хэвээрээ байж байгаа. Бүх бичиг баримтуудад тусгачихсан. Бидний зүгээс энэ хамгийн их олгож байгаа давуу талуудыг бүрэн дүүрэн ашиглах чиглэл дээр нэгдсэн бодлогоо гаргах явдал дутагдаж байгаа гэдгийг бас хэлмээр байна. Баярлалаа.



## Сайн суурь тавьсан гэж бодож байгаа

*2014 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн Эдийн засгийн байнгын хорооны ээлжит хуралдааны тэмдэглэлээс: “Засгийн газрын зарим гишүүнийг чөлөөлөх тухай”*

**С.Дэмбэрэл гишүүн:** Засгийн газрын бүрэлдэхүүнээс 2012 оноос хойш хамтарч ажилласан хэсэг нөхөд нь чөлөөлөгдөж байна. Энэ хүмүүсийн чөлөөлөгдсөн шалтгааныг ярихаасаа өмнө, чөлөөлөгдөж байгаа гишүүдтэй өнгөрсөн 2 жилд, олон чиглэлээр маш үр дүнтэй, үр бүтээлтэй хамтран ажиллаж байсныгаа хувиасаа хэлэх нь зүйтэй гэж бодож байна. Монгол улсын засгийн газар 2012 онд байгуулагдаад, нэлээд олон томоохон зорилтуудыг тавигдсан. Засгийн газрын 2012-2014 онд тавьсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд эдгээр чөлөөлөгдөж байгаа гишүүд өөрсдийн мэдлэг боловсрол, туршлагыг дайчлан ажилласан гэдэгт би итгэлтэй байдаг. Цаашдаа Засгийн газарт өнгөрсөн 2 жилээс илүү том зорилтууд тулгарч байгаа. Энэ хүмүүсийн тавьсан сайн суурин дээр дараагийн хүмүүс ажиллах ёстой. Өөрөөр хэлбэл, эдгээр хүмүүсийг “Сайн суурь” тавьсан гэж би бодож байна. Энэ үгээ ч би бас баталж чадна. Ер нь асуудлуудыг тодорхой ярих хэрэгтэй.

Хэрэв аль нэг яамны ажил дээр тодорхой үр дүн гарсан байвал тэрнийг ямар нэгэн улс төрийн өнгө аясгүйгээр хүлээн зөвшөөрдөг, хэлэх үедээ шүүмжилдэг, магтах үедээ магтдаг, хэлэх ёстой үгийг цагт нь хэлдэг байх нь төрийн хүний чанар байх ёстой. Энэ талаас нь бодож, чөлөөлөгдөж байгаа гишүүдэд талархал илэрхийлж байгаа юм шүү. Та бүхний цаашдын ажилд амжилт хүсч байна. Баярлалаа.

**Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны дарга Ж.Батсайхан:** Би бас үг хэлье гэж бодож байна. Манай эдийн засгийн байнгын хорооноос асуудал нь хамаардаг гол яамдын сайд нар чөлөөлөгдөж байна.

**Нэгдүгээрт:** Үнэхээр Монгол орны эдийн засгийг эрчимжүүлэх, Улс орны бүтээн байгуулалтын ажилд онцгой үүрэг гүйцэтгэсэн ийм сайдуудаа бид өнөөдөр бүтцийн өөрчлөлтийн улмаас ажил үүргээс нь чөлөөлж байна. Үндсэндээ өнгөрсөн хоёр жилийн хугацаанд “Шинэчлэлийн засгийн газар”-ын гол нүүр царай болж явсан сайд нар бол манай байнгын хорооноос томилогдсон эдгээр сайд нар байгаа юм. Энэ сайд нарынхаа хийж бүтээснийг дараагийн шинэ сайд нар үргэлжлүүлж, эхэлсэн шинэчлэлийн ажлуудыг нэр төртэй хийж дуусгаасай гэж хүсч байна.

**Хоёрдугаарт:** Шинээр томилогдож байгаа сайдууд байнгын хороотой их нягт холбоотой ажиллах ёстой. Үүнийг сайтар анхаарч ажиллахыг шинээр томилогдох сайдууддаа давхар хэлье. Тийм учраас өнгөрсөн хугацаанд ажлаа сайн хийсэн бүх сайд нартаа гүн талархал илэрхийлж, цаашдынх нь ажил хөдөлмөрт өндөр амжилт хүсье. Та бүхэнд цаашид олон ажлуудыг дахин хийж гүйцэтгэх боломжууд байгаа. Тэр ажлынхаа төлөө ч мөн сэтгэл зүрхээрээ ажиллаарай гэж хүсье !

## С.Дэмбэрэл гишүүний асуултанд хариулт олдсонгүй

*Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2014 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төслицдийг хэлэлцэх цээр*

**З.Энхболд:** С.Дэмбэрэл гишүүн асууя

**С.Дэмбэрэл:** За баярлалаа. Энэ бол Монгол Улсын цаашдын хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулахад чухал ач холбогдолтой хууль. Тийм учраас жишээлбэл, Дэлхийн банкны бизнес эрхлэлтийг хэмжих туслах индексээр Монгол Улс одоо хэддүгээр байранд байгаа вэ, энэ хуульд байгаа үг, үсэг, үзэл санаа хэрэгжсэнээр хэдэн байр ахиж, ямар үр дүнд хүрэх вэ гэсэн нэгдүгээр асуулт байна.

**Хоёрдугаарт:** Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2014 оны батлагдсан орлого, зарлага нь тус тус хэд вэ, 2015 оных нь хэд байх вэ гэдгийг хэлж өгнө үү. Энэ асуулт ч бас энэ хуультай хамааралтай.

**Гуравдугаарт:** Бизнес орохыг хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэж болж байна. Гэтэл одоо ерөнхийдөө улс төрчдийн дунд маргаан дагуулаад, янз янзын зорилгоор ашиглаад байгаа бас нэг тоо байна. Бизнесээс орох, гарах хоёрын жинхэнэ харьцааг танайх яаж гаргадаг юм бэ? Үндэсний статистикийн газрын бизнес регистртэй энэ бүртгэл маань яаж холбогддог юм вэ?

Дээр нь, танай байгууллагын үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт дээр ийм сонин тоонууд байна. Бэлтгэсэн Улсын бүртгэлийн маягт 1000 ширхэг гээд ард нь 1700 ширхэг, 170 мянган ширхэг гэсэн байна. Дүгнэлт гаргах хяналт шалгалтын тоо /мянгаар/ гэхихээд 20,5 гэсэн байна. Энэ юу гэсэн үг вэ? 20 мянган хяналт шалгалт хийнэ гэсэн үг үү? 20500 мянган удаа гэсэн үг үү? Энэ тоонуудын хариуцлага хаана байна? Одоо хууль болж, батлагдах гэж байна. Тийм учраас Улсын бүртгэлийн ерөнхий газраас асуумаар байна. Юу гэсэн үг вэ? Өөрөөр хэлбэл, Төсвийн ерөнхий захирагчдын тоо чанарын үзүүлэлтэнд, Хууль зүй дотоод хэргийн яамныхад ч энэ үзүүлэлт ингээд байж байна. 1700 ба 2,5 гэсэн, хоёулаа мянгаар. Нэг нь 170 мянга гэсэн үг, нөгөөх нь 20 мянга гэсэн үг. Тэгэхээр энэ чинь Хуулийн үзэл санаатай зохицож байна уу? Энэ юу гэсэн үг вэ? Энд маш тодорхой тайлбар авмаар байна. За баярлалаа.

**З.Энхболд:** Дэлхийн банкны бизнес эрхлэхийн асуудлын талаар Х.Тэмүүжин сайд, бусад асуултанд Т.Баттулга хариулъя.

**Х.Тэмүүжин:** Бизнес эрхлэлттэй холбоотой Монгол Улс ямар үзүүлэлттэй хаана явна вэ гэдгийг би яг одоогийн байдлаар мэдэхгүй байна. Манай ажлын хэсгийн Ш.Жолбарыс хариулна.

**З.Энхболд:** Энэ бол бодлогын асуудал учраас өөрөөс чинь асуугаад байна. Хууль оруулж ирж байгаа бол ямар үр дүнд хүрэх зорилготой юм бэ? С.Дэмбэрэл гишүүний асуулт зөв байгаа. Үндсэн асуудал учраас сайд нь өөрөө мэдэж байх ёстой. Т.Баттулга хариулъя.

**Т.Баттулга:** Дэлхийн банкнаас гаргадаг дэлхийн бүх улс орнуудын бизнес орчныг зэрэглэдэг DOING BUSINESS гэдэг зэрэглэл байгаа. Энэ ангиллаар таван үндсэн үзүүлэлтүүдийг шалгуур болгодог. Энэ дотроос

манай бизнесийг эхлэх буюу бизнесийн үйл ажиллагааг явуулах бололцоог бүрдүүлэх бүртгэлийн процессыг нэлээн өндөр үнэлсэн байдаг. Энэ үзүүлэлтээрээ Монгол Улс 2013 оны дүнгээр 25-р байранд орсон. Энэ бол сайн үзүүлэлт. Гэхдээ бид нар энэ хуулийн дагуу нэлээн шинэчлэлт өөрчлөлтгүүдийг хийгээд, илүү шуурхай бүртгэл хийдэг болсноор яг энэ үзүүлэлтээрээ эхний 10-д ч орох бололцоо бий гэж тооцоолж байгаа. Статистикийн мэдээллийн хувьд ерөнхийдөө манайд бүртгэгдсэн мэдээллийг Статистикийн газар шууд аваад, хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой статистик тоонуудоо гаргадаг.

**Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн бүртгэлийн газрын дарга Ш.Жолбарыс:** Статистик тоо мэдээг Статистикийн газар манайхаас авч байгаа. Өнөөдрийн байдлаар 136 мянган хуулийн этгээд мэдээллийн санд бүртгэгдээд байгаа. Статистикийн байгууллага манай бүртгэлийг Бизнес регистр гэсэн нэр томъёогоор ашиглаж байна. Цаашдаа Статистикийн ерөнхий газартай хамтраад хуулийн этгээдийн регистрийг боловсронгуй болгох талаар хамтарч ажиллах зорилгоор тодорхой ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа. Орлого зарлагын талаарх мэдээллийг танд дараа хүргүүлье.

**З.Энхболд:** Хэдэн мянган аж ахуйн нэгжүүд хаалгаа барилаа гэж яриад байгаа. Үнэн юм уу, худлаа юм уу?

**Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн бүртгэлийн газрын дарга Ш.Жолбарыс:** Аж ахуйн нэгжийн хувьд 2014 онд / өнөөдрийн байдлаар/ 13 мянга гаруй аж ахуйн нэгж манайд бүртгүүлсэн байгаа. Үүнээс 425 аж ахуйн нэгж 2014 онд Хуулийн этгээдийн бүртгэлээс хасагдаж, татан буугдсан. Татан буух процесс нь өөрсдийнх нь хүсэлтээр болон татварын байгууллагуудад 6 улирал дараалан тайлангаа өгөөгүйн улмаас, татварын байгууллагын саналыг үндэслэн 400 гаруй аж ахуйн нэгжийг татан буугдсан. Дампуурсан аж ахуйн нэгж өнөөдрийн байдлаар 3 байгаа. 2014 оны статистик тоогоор яг 425 аж ахуйн нэгж татан буугдсан. 2013 онд нийт 16 мянган Хуулийн этгээд бүртгэгдсэн. Үүнээс 425 аж ахуйн нэгж бол татан буугдаж бүртгэлээс хасагдсан байна.

**З.Энхболд:** Та нарын тоо зөрөөд байна. Т.Баттулга болохоор манайхаас статистик мэдээгээ авдаг гэдэг. Статистик чинь болохоор 50-60 мянган аж ахуйн нэгж байгаад эдийн засгийн хямралд болоод 22 мянган алга болсон гээд байна. Хэн нь зөв яриад байгаа юм бэ? Төрийн байгууллагууд ийм замбараагүй, 425 ба 22 мянга гэсэн, хоёр өөр тоотой байж болохгүй. Д.Сарангэрэл гишүүн 22 мянган аж ахуйн нэгж эдийн засгийн хямралаас болоод хаалгаа барьсан гэж хэлж байна. Энэ толгой эргүүлсэн олон тоогоо нэг жигд болгоод, мэдээллээ Улсын Их Хуралд өгөх хэрэгтэй. Шалгалт хийх, 150,000 бланк хэвлэх энэ тэрийгээ хариул. Юуг нь нуугаад байгаа юм бэ? Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэргэжилтэн нь биш, дарга нь өөрөө хариул.

**Ц.Пүрэвдорж:** Та яг ямар тайлангаас ярьж байгааг би сайн мэдэхгүй байна. Хуультай холбогдуулаад боловсруулсан бичиг баримт дотор байхгүй байна. Хяналт шалгалтыг манай тамгын газраас нэгтгээд дамжиж гаргасан тайлан дотор тийм тоо баримт байгаа болов уу гэж бодож байна. Би тэрийг нягталж байгаад танд тодорхой гаргаж өгье гэж бодож байна.

**З.Энхболд:** С.Дэмбэрэл гишүүний асуултад хариулт олдсонгүй.

## “С.Дэмбэрэл гишүүн өөрөө сайн мэдэж байгаа”

*2014 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн “В” заал Эдийн засгийн байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээс: Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай УИХ –ын тогтоолын төсөл хэлэлцэх эсэх асуудал болон бусад хуулийн төсөл хэлэлцэх, ажлын хэсэг байгуулах асуудлыг хэлэлцэх цеэр*

С.Дэмбэрэл: Энэ хурал олон нийтэд шууд дамжуулагдахгүй байгаа. Тиймээс Монгол банк УИХ-ын өмнө аливаа тоон мэдээллийг чөлөөтэй хэлж болно гэсэн үг. Хаалттай хуралдааны дэглэм биш боловч олон нийтэд нээлттэй биш. Үүнтэй холбогдуулан зарим зүйлийг асууя.

*Нэгдүгээрт:* “Валютын ханшийг бид олон нийтэд хэлдэггүй” гэж ярьж байна. Тийм л дээ. Гэхдээ УИХ –ын гишүүдэд хэлэх ёстой. 1750 гэдэг дээр танай байр суурь ямар байгаа юм бэ? Та нар “төсөөлөл хийдэггүй” гэж ярьж байна. Төсөөлөл хийдэггүй юм бол яаж тэр 7 хувийн инфляцийг гаргаж ирсэн юм бэ? Яаж 2 жилээр төсөөлсөн юм бэ? Ингэж, хүүхэдтэй ярьж байгаа юм шиг үг хэлж болохгүй ээ. Тийм учраас, засгийн газраас, бүр тодруулбал, Эдийн засгийн хөгжлийн яамнаас гаргаж, Сангийн яам шууд хүлээж авсан 1750 гэсэн ханш дээр та нар ямар бодолтой байна вэ?

*Хоёрдугаарт:* Төв банкны тухай хуулинд мөнгөний бодлогын үндсэн зорилтыг тодорхойлж өгсөн байдаг. Үүнийг хууль өөрчлөгдөөгүй байхад өөрчлөх эрх хэнд ч байдаггүй. Хуулинд “Эдийн засгийн гадаад тэнцвэрийг хангана” гэсэн үг байхгүй. Эдийн засгийн гадаад тэнцвэрийг хангадаг тэр улс нь Монгол улс биш. Манай төгрөг хөрвөдөггүй. Бид төгрөгийн тогтвортой байдлыг “төгрөгийн дотоод, гадаад үнэ цэнэ” гэж ярьдаг болохоос биш, “гадаад тэнцвэрийг хангах” гэсэн том зорилт тавьдаггүй. Энэ нь мөнгөний бодлогын зорилтод байдаггүй. Тийм учраас эдийн засгийн гадаад тэнцвэрийг хангана гэдгээр юугаа бодож, энэ том зорилтыг зүрхэлж оруулсан юм бэ? Үүний үндэслэл нь юу вэ?

*Гуравдугаарт:* Төв банкны тухай хуулинд “ханш чөлөөтэй бөгөөд уян хатан, бодитой тогтоно” гээд, төгрөгийн гадаад валюттай харьцах “ханш”-ны зарчмыг баримтална гэсэн байна. Хуулинд өөр ямар нэгэн заалт байхгүй. Төв банкны хуулинд “эдийн засгийн тэнцвэртэй байдлыг хангахад тус дөхөм үзүүлэх” гэсэн ийм өгүүлбэр байна. Ийм л зарчим бичсэн байна. Санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах ханш нь эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжихүйц уян хатан тогтож, дунд хугацаанд дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ажлын байрыг хамгаалахтай нийцтэй байх зарчим баримтална. Гэтэл та нарын өгсөн цэнхэр ном дээр чинь валютын ханшны бодлого байхгүй байна. Хуулинд “валютын ханшны бодлого” гээд байгаа. Валютын “ханш”-ны бодлого гэхээр зарчим бичихийг хэлдэггүй. Өмнөх хоёр жилийн зарчмууд дээр хоёр өгүүлбэр нэмж бичээд, жаахан өөрчлөлт хийгээд оруулж ирэхийг хэлдэггүй. Валютын ханшны зарчим, валютын ханш гэж асуухаар, урдаас “төгрөгийн ханш нь уян хатан бөгөөд бодитой тогтоно” гэсэн өгүүлбрийг

хэлээд УИХ-ын гишүүдийн амыг хааж болохгүй. Хоёр жил энэ үгийг хэлж, танай банкыг хамгааллаа. Одоо тэсвэр алдагдаж, урам хугарч байна. Яагаад ийм байна вэ? Энэ “ханш”-ны бодлого чинь юу юм бэ? Ханш нь шокыг шингээгч биш, шокыг үүсгэгч гэдгийг өнгөрсөн сарууд харууллаа. Ийм зүйлүүд байсаар байхад “ханш”-ын тухай ийм сул мэдээлэл оруулж ирж байгаад, би хувьдаа 2014 он, 2015 онд инфляцийг 7 хувьд барина гэдэгт итгэж чадахгүй байна. Та бүхэн өөрсдөө итгэж байна уу?

*Дөрөвдүгээрт:* Сангийн яам төсвийн төслөө өгсөн. Ийм зузаан ном байна. Монголбанк засгийн газарт мөнгөний бодлогоо өгсөн. Засгийн газар уншаагүй, нэг өгүүлбэр бичдэг заншсан ёсоороо л ирүүлсэн байна. Төсвийн талаар танайхаас албан ёсоор санал аваагүй.

**Монгол банкны ерөнхийлөгч Н.Золжаргал:** С.Дэмбэрэл гишүүний асуултанд хариулъя. Засгийн газрын төлбөр тооцоонуудыг үзэхэд, валютын ханшны, төлбөрийн тэнцлийн төсөөлөл дээр нэгэнт зарчмын өөрчлөлт байхгүй учраас валютын ханшаа 1750 гэж, төсвийн алдагдлаа та бүхэнд өргөн барьсан тооны түвшингээс бид өөрсдийн дүгнэлтээ хийгээд ямар ч байсан эерэг валютын орлогыг харж байна. Энэ дээр бол, төлбөрийн тэнцлийн бусад тооны задаргаан дээр харах л ёстой зүйл л дээ. 1750-ыг бүртгэлийн хувьд, төсөв хэлэлцэхэд зайлшгүй тоо хэрэгцээтэйг ойлгож байна. Тэрнээс, бид нар валютын ханшын төсөөллийг хийхдээ ямар аргачлалаар хийдгийг С.Дэмбэрэл гишүүн та сайн мэдэж байгаа байх, түүнээс биш, өөрөөр, ийм хүлээлтийн тоог ярьдаггүй. Энэ нь нууц гэдэгтээ ч гол нь биш. Хүлээлт үүсгэх зах зээлийн нөхцөл байхгүй юм.

Тооцоогоо яаж хийж байгааг гишүүн сайн мэдэж байгаа байх. Ер нь бол инфляцын хүлээлтээрээ жигнэж явдаг. Төсөв дээр энийг хэрхэн тусгах нь мэдээж тухайн төсвийн бүртгэлийн хувьд зарчмын зайлшгүй шаардалагатай учраас сангийн яам тооцоогоо хийж явдаг. *Төлбөрийн тогтвортой байдлыг хангах* гэдэг том зорилт л доо. Үнэн, үнэн. Гишүүний хэлж байгаа шиг тийм ч амаргүй зорилт байх. Гэхдээ үүнийг зорих нь ялангуяа 2015 оны бид нарын эдийн засгийн урд байгаа сорилтонд гол мессэж юм байна гэж бид нар үзэж байгаа. 2015 онд гадаад төлбөрийн тэнцэл дээр, тогтвортой байдал дээр анхаарч ажиллахгүй бол Монгол улсын нийт эдийн засгийн хувьд макро тогтвортой орчинд хамгийн чухал зүйлүүдийн нэг нь болчихоод байна гэдгийг тодорхойлж өгч байгаа юм. Энэ маань өөрөө төлбөрийн тэнцлийг урт хугацаанд тогтвортой байх асуудал ч, энэ удаа 2015 онд маш чухал нөлөөтэй жил болох нь гэдгийг томъёолж өгсөн. Урд нь энэ өгүүлбэрээр тодорхой томъёолж байгаагүй нь үнэн. Энэ удаа чухал жил болох нь гэдэг утгаараа, үүнийг томъёолох гэж зориуд хийж өгсөн. *Гадаад тэнцлийг хангах зорилт* гэдэг нь түрүүчийн хүрээнд хэцүү зорилт нь үнэн. Энэ зорилт нь Монгол банкны зорилт ч биш, Монголын эдийн засгийн өмнө байгаа гол зорилтуудын нэг мөн. Энд зориулагдсан бусад мөнгөний бодлогын бусад арга хэмжээнүүд нь хэрэгжиж явах нь гэсэн Монголбанкнаас бодлогын зорилтыг дэвшүүлж байна гэсэн үг. Ханшны хувьд, энэ тухай олон жил, цөөнгүй удаа ярьж байна. Энэ заншсан хэллэг. Сүүлийн 2 жил ч биш, ер нь өмнөх олон жил явж байгаа хэллэг. Хуулийн өнцгөөс л харж байсан. Одоохондоо бодлогыг тодорхойлж өгсөн тийм томъёолол руу зориглож ороогүй л байна. Яг нарийвчлаад үйл



ажиллагаан дээр дүгнэлтүүдээ хэлэхэд С.Дэмбэрэл гишүүн өөрөө энэ ажил дээр 2 жил бид нартай хамтарч ажиллаа. Өөрийн гэсэн дүгнэлттэй, яг үйл ажиллагаан дээр тодорхой хэмжээний, ханшны бодлогын хувьд ямархуу бодлого хийгддэг тухай сайн мэдэж байгаа байх.

**Сангийн яам:** Мөнгөний бодлого, төсвийн бодлогууд нь мэдээж хоорондоо асар нягт уялдаа холбоотой. Мөнгөний бодлого боловсруулах, мөнгөний бодлого дээр тавигдаж байгаа зорилтуудыг хангах, төсвийн бодлого боловсруулах, төсвийн бодлого дээр тавигдаж байгаа үндсэн зорилтуудыг хангах асуудлыг манай 2 байгууллага нягт уялдаатай хийдэг. Ялангуяа техникийн түвшинд бүх тоонуудыг нарийвчлан тооцож ажилладаг. Мэдээж хэрэг засгийн газраас макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах нэгдсэн төсвийн зохистой бодлогоор мөнгөний бодлогыг дэмжих, гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах, дотоодын үйлдвэрлэл, импортыг орлох үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг авах, татвар, гааль, татаасын чиглээр хийгдэж байгаа энэ бүх үйл ажиллагааны тооцоонуудыг Монголбанкинд өгч, мөнгөний бодлогод тусгуулж явдаг.

### **Одоо батлах гэж байгаа төсвөөр юу хийгээд, ямар үр дүнд хүрэх юм вэ?**

*2014 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс: Монгол Улсын 2015 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцэх цээр*

**С.Дэмбэрэл:** За баярлалаа. Сангийн дэд сайд С.Пүрэвээс зайлшгүй асуух хэдэн асуулт байна. Төсвийг нэг бүрчлэн үзэж байх үеэр 2015 оны Мөнгөний бодлогын баримт бичигт ороод ирлээ. Энэ 2015 оны мөнгөний бодлогын баримт бичигт “2015 онд мөнгөний хатуу бодлого явуулна, Засгийн газар та төлбөрийн тэнцлээ сайжруул, экспортын орлогыг нэмэгдүүл” гэхчилэн Засгийн газарт ийм ийм нөхцөл тавибал инфляцыг 7%-иар барина гэж оруулжээ. Өөрөөр хэлбэл дараа жилийн мөнгөний бодлого “хатуу мөнгөний бодлого” болох юм байна. Эндээс:

**Нэгдүгээрт:** Төсвийн бодлого, 2015 оны Мөнгөний бодлого хоёрын уялдаа яаж хангагдсан вэ гэсэн зайлшгүй асуулт гарч ирж байна.

**Хоёрдугаарт:** Улаанбаатар хотын эдийн засаг, төсвийн талаар маргаан гараад байна. Суурь орлого, зарлага хоёрын зөрүү хэд байсан вэ? Одоо ямар хуулийн дагуу энэ маргаантай асуудал үүсээд байна вэ гэдгийг Сангийн дэд сайд С.Пүрэв та тайлбарлаад, дараа нь бичгээр бас өгнө үү?

**Гуравдугаарт:** Монгол улсын 2015 оны төсвийн тухай хуулийн төслийн нэгдүгээр хавсралтанд байгаа “Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2015 онд

хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт"-ийг төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр нарийвчлан уншаад үзэхэд асар их замбараагүйдэл харагдаж байна. Өөрөөр хэлбэл, бидний батлах гээд байгаа төсвөөр юу хийгээд, ямар үр дүнд хүрэх вэ гэдгээ тайлбарлаж өгнө үү? Төсвийн ерөнхийлөн захирагч нар энд маш их худлаа байрын тоонууд оруулсан байна. Тодорхой жишээнүүдийг хэлье:

1. “Мэргэжлийн хяналтын талаар реформ хийнэ” гэж хуульд оруулсан байна. Хяналт шалгалтанд хамрагдсан “эрсдэлтэй объектын тоо / мянгаар/ гэгчхээд 20000 гэж байна. Эрсдэлтэй объектын эрсдэлийн төвшний өөрчлөлт /мянгаар/ гэгчхээд 50000 гэж байна. Тэгэхлээр Монголд эрсдэлгүй объект гэж юу байна вэ?
2. Өдөрт хичнээн шалгалт хийх гэж байга юм бэ? Шударга өрсөлдөөний газрын шалгалтын тоог авч үзье. Жишээлбэл: Хууль тогтоомжийн хүрээнд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт хийх тоо 1050 гэж байна. Үүнийг 365 хоногт хуваахад /хагас, бүтэн сайнд амралгүйгээр ажиллахад/ өдөрт 3 шалгалт хийнэ гэсэн үг. Ийм л төсвийг үр дүн гэж үзэх гэж байна. Зардал, үр ашгийн шинжилгээ маань тоогоор ингэж хэмжигдэж байна.

*Дөрөвдүгээрт:* Эргээд ухаръя. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын төсөвт “Иргэдийн эрүүл аюулгүй амьдрах эрхийг хангасан, байгальд ээлтэй Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх” гэж бичсэн байна. Энэ чинь юу гэсэн үг вэ? Үүнийг хэрэгжүүлдэг хүн нь миний зүүн гар талд суудаг шиг санагдаад байх юм. Эсвэл энэ тооны алдаа болов уу, үгийн алдаа юм болов уу? Энэ мэтийн хариуцлагагүй хийсэн асуудлууд их гараад байна. Энэ талаар сангийн яам юу гэж үзэж байна?

*Тавдугаарт:* Монгол Улсын Ерөнхий Аудиторын газрын дүгнэлт гарсан байна. Ерөнхий сайд аа, 885-ыг чинь “хэрэггүй” гэсэн байна. А.Зангад даргаас асууя. Ямар үндэслэлээр хөгжлийн банкаар хэрэгжих ёстой зүйл хэрэггүй болчихов?

**С.Пүрэв:** Мөнгөний бодлого, Улсын төсвийн бодлого хоёр зайлшгүй уялдаж хэрэгждэг. Улсын төсвөөр тодорхой хэмжээний бизнесийн орчинг сайжруулах, экспортыг дэмжих талын зардал гардаггүй. Татварын бодлого бусад бодлогоороо экспортыг дэмжиж урамшуулах, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр тодорхой бодлогууд явуулдаг. Өнгөрсөн хугацаанд Засгийн газраас экспортын татварыг буруулах, томоохон хөрөнгө оруулагч нарт төлөх импортын зардлыг нь хойшлуулах, мөн зарим жижиг дунд үйлдвэрийн импортын татварыг хөнгөлөх зэрэг олон төрлийн арга хэмжээ авсан. Энэ нь бизнес эрхлэгчдэд томоохон дэмжлэг болж байгаа байх. Дээр нь ноос, ноолуур, арьс ширд улсын төсвөөс татаас өгдөг. Энэ ч эдийн засгийг эрчимжүүлэх, тэтгэх арга хэмжээ болж байна. Мөн төсвийг үндэслэлгүйгээр хэт их төлөхгүй байх чиглэлээр Монгол банк, Сангийн яам уялдаа холбоотой ажилладаг, бодлогоо зохицуулдаг. Ер нь мөнгөний бодлоготой уялдсан хамгийн гол асуудал бол “Төсвийн хэт тэлэлтийг хязгаарлах” асуудал. Энэ асуудал олон улсад ч онолын хувьд байдаг. Бид үүнийг хэрэгжүүлэхдээ, улсын төсөв орлогыг өөрсдийнхөө бололцоонд тааруулан бодитойгоор төлөвлөж байгаа гэж үзэж байна. Харин хөгжлийн

банкны шугамаар, төсвөөс гадуур хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний хувьд энэ жилээс, /ирэх жилээс/ улсын төсөвт оруулж тооцох хянах чиглэлийн дагуу, мөн үндэсний аюулгүй байдлын газар, олон улсын байгууллагуудаас өгсөн чиглэлийн дагуу төсөвт оруулж тооцох бодлого баримталж байна. Энэ тохиолдолд, мэдээж хэрэг төсвийн алдагдал бидний тооцож байсан хэмжээнээс өндөр болно. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тодорхой хязгаар тавьсан. Энэ хязгаар нэмэгдэх байдал үүсэж болзошгүй байна. Улаанбаатар хотын болон орон нутагтай холбоотой суурь зардлын асуудлаар тодорхой мэдээллийг С.Дэмбэрэл гишүүн асуулаа. Төсвийн хуулийн дагуу:

1. Нийслэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зардал /Урсгал болон хөрөнгийн зардал/
2. Нийгмийн асрамж, халамжийн үйл ажиллагаатай холбоотой урсгал зардал
3. Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой урсгал зардал тус тус үндсэн суурь зардалд ордог.

Хуульд заасан энэ үндэслэлээр нийслэлийн урсгал зардлыг тооцож үзэхэд, 2015 онд 228,5 тэрбум төгрөгийн урсгал зардал гарч байна. Хуучны урсгал зардал 228 болж үлдлээ. Дээр нь урсгал орлогыг хамгийн бага байх хэмжээгээр тооцож үздэг...

**З.Энхболд:** Хурдан хариулахгүй бол цаг таныг хүлээхгүй. Нэгдүгээр хавсралтын талаар хариул. Ерөнхийлөгчид хуучин Агаарын бохирдлын үндэсний зөвлөл байсан үеийн юмаа хуулаад биччихсэн байна. Тэр хууль өөрчлөгдөж татан буугдаад ерөнхий сайдад ирсэн байгаа. 1.1.2.

**Ганцогт:** Төсвийн тухай хуульд 22.6-д заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр хэрэгжүүлэх хөтөлбөр үр дүнг төсвийн төсөлтэй хамт өргөн барих ёстой. Энэ хуулийн заалтын дагуу 2015 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг оруулж ирсэн. Энэ тоо хэмжээг төсвийн ерөнхийлөн захирагч бүр өөрсдөө гаргадаг. Жил бүр төсөв хэлэлцэх үед засгийн газарт хэлэлцэж байгаад оруулж ирдэг.

**З.Энхболд:** Тэрийг мэднэ. Хавсралтын 1.1.2-т яагаад “Ногоон бодлогыг хэрэгжүүлэх” гээд оруулсан вэ? Өмнөх хуульд тийм байсан. Одоо хууль өөрчлөгдсөн. Мэргэжлийн хяналт гэдэгт “бүгдийн шалгана” гэж хамаагүй тоонууд оруулсан байна. 17.3.1-д 1050 шалгалт хийнэ гэхлээр өдөрт 3 шалгалт хийх болчихоод байна. Ийм зүйлүүдийг л асуугаад байна.

**С.Пүрэв:** Чанарын хүрэх үр дүнг Сангийн яам нэгтгэж тооцдоггүй. Харин нэгтгэж төсөвтэйгөө хамт оруулж ирэхийг Сангийн яам хариуцдаг. Үр дүнд хүрсэн үү, хүрэх үү гэсэн тооцоог сангийн яам гаргадаггүй.

**З.Энхболд:** Шударга өрсөлдөөний газрыг өдөр болгон 3 шалгалт хийхийг болж байна гэж үзээд, Ерөнхийлөгчийг Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүл гэж оруулаад ирсэн байна шүү дээ. Та нар бол нэгдүгээр хавсралтыг хариуцахгүй гэж байна, тийм үү? Нийлүүлээд хүснэгт болгоод биччихсэн байна. Хууль яаж өөрчлөгдөж байгааг мэдээгүй байна тийм үү? Үүнийг Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга П.Цагаан оруулсан гэсэн үг үү?

**Ажлын хэсгээс:** Ерөнхийлөгчийн багц байнга буурч байна. Энэ жил ч өмнөх оныхоосоо буурсан. С.Дэмбэрэл гишүүний асууж байгаа зүйлүүд нь манай төсөвт байхгүй. Өөр цас уншаад байх шиг байна.

**З.Энхболд:** Үгүй. Гишүүдэд тараасан зузаан номын нэгдүгээр хавсралтанд байгаа. С.Дэмбэрэл гишүүн тодруулъя.

**С.Дэмбэрэл:** Ерөнхийдөө ойлгож байна. Манайхан үнэхээр болохгүй байна гэдгээ л харуулж байна. С.Пүрэв сайдаас асууя. Засгийн газрын баахан Тусгай сангууд байгаа. Өнөөдрийн байдлаар хэчнээн төгрөг хуримтлагдсан вэ? Энэнийг 2015 оны төсөвт яаж, ямар зүйл ангид оруулсан вэ? Монголд байгаа нийт агентлагуудын орлого, зарлагын тооны талаарх мэдээлэл танайд байна уу?

**С.Пүрэв:** Өнөөдрийн байдлаар төсвийн ерөнхийлөн захирагч болгонд 2-3 тусгай сан байдаг. Нийт дүнгээр 1,6 тэрбум төгрөгийн орлоготой бас нэг их наяд төгрөгийн зарлагатай 30 гаруй тусгай сангууд бий. Засгийн газарт тусгай сангуудыг нэгтгэж янзлах, заримыг нь татан буулгах, заримыг нь шинэчлэн зохион байгуулах хуулийн төсөл боловсрогдоод байна. Энэ асуудлыг удахгүй УИХ-д өргөн барина.

**З.Энхболд:** Энэ тараагдсан төсвийн номд Тусгай сангууд нэр бүрээрээ дэлгэрэнгүй байгаа байх тийм үү? “885-ын” талаарх асуултанд А.Зангад дарга хариулъя.

**А.Зангад:** 2.2 дахь заалтын “төсвийн зардал хэмнэх” гэдэг дээр байна уу? Энд Хөгжлийн банкны 955-ийг улсын төсвийн зарлагад оруулж ирсэн дотор төслийн үр ашгаас эргэн төлөгдөх нөхцөлтэй 309 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээ хасагдах ёстой. Хэрвээ хөгжлийн банкны 955 орвол, энэ дүнгээс 309 нь хасагдах ёстой гэсэн санал юм.

## **Сайдгүй яамны байр суурь хэрэгтэй байхад, үүнийг хэлэлцэж болж байгаа юм уу**

*Монгол Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганы Эдийн засгийн байнгын хорооны 10 дугаар сарын 23-ны өдөр /Пүрэв гараг/-ийн хуралдааны гар тэмдэглэлээс: “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг дээр*

**Байнгын хорооны дарга Б.Гарамгайбаатар:** - “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны анхны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулга. 2014 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Улаанбаатар хот. Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 06 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын

төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2014 оны 7 дугаар сарын 1, 10 дугаар сарын 2-ны өдрүүдийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлээд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн. Дээрх тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсгийн эхний хуралдаан 6 гишүүн буюу 66.7 хувьтай, 2 дахь удаагийн хуралдаан 5 гишүүн буюу 56.9 хувийн ирцтэй хуралдсан. Ажлын хэсгийн гишүүн Н.Батбаяр, Г.Батхүү, Ц.Даваасүрэн нар ажлын хэсгийн хуралдаанд оролцоогүй бөгөөд гишүүн Х.Баттулга хуралдаанд оролцсон ч эсрэг байр суурьтай байгаагаа илэрхийлсэн. Ажлын хэсэг ийнхүү хоёр удаа хуралдаж тогтоолын төслийн талаар дараах зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхоор дэмжиж Байнгын хорооны хуралдаанд оруулж танилцуулах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

1. Тогтоолын төслийн нэг дэх заалтыг хасах.
2. Тогтоолын төслийн хоёр дахь заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах.

1.Таван толгой- Гашуун сухайт, Сайншанд- Ханги, Хөөт- Бичигт, Нарийн сухайт-Шивээ хүрэн чиглэлийн төмөр замын шинэ шугамыг 1435 мм-ийн царигтай. Арц суурь-Эрдэнэт, Таван толгой-Сайншанд Баруун-Урт Хөөт Чойбалсан, Хөөт- Нөмрөг чиглэлийн төмөр замын шинэ шугамыг 1520 мм-ийн царигтай барих ажлыг зохион байгуулж хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуягт даалгасугай/ гэсэн саналууд дэмжигдэв. Ажлын хэсгийн ахлагчийн хувьд дээрх саналын томъёолол болон энэхүү тогтоолын төслийн талаар санал бодлоо илэрхийлэх нь зүйтэй гэж үзэж байна. Дээрх саналын томъёолол нь Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар дэмжигдэн батлагдсан тохиолдолд 2010 онд Улсын Их хурлаас батлагдсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д тусгагдаагүй шинэ маршрут бий болж байна. Тухайлах юм бол Сайншанд-Ханги чиглэл. Түүнчлэн Төмөр замын талаарх бодлогын баримт бичигт тусгагдсан нэгдэх болон хоёр дахь шатанд байгуулах хэд хэдэн чиглэлд өөрчлөлт орж байгаа тул “Төрөөс төмөр замын талаарх бодлогын баримт бичиг”-т өөрчлөлт оруулах зарчмаар асуудлыг нэг тийш нь шийдэх хэрэгтэй гэж үзэж байгаагаа ажлын хэсгийн ахлагчийн хувьд илэрхийлье. Ингээд анхаарал тавьсан та бүгдэд баярлалаа. Ажлын хэсэгт Засгийн газраас орж байгаа бүрэлдэхүүнийг танилцуулъя. Эрдэнэ сайд байхгүй байгаа юм уу. До.Ганболд Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Б.Артур Зам, тээврийн яамны, Эрдэнбүрэн Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч, Б.Нямдорж Зам, тээврийн яамны мэргэжилтэн аль яамных юм бэ. Эдгээр хүмүүс оролцож байгаа юм байна. Эрдэнэ сайд оролцож байна. Төсөл санаачлагчаас болон ажлын хэсгийн санал, дүгнэлтээс асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү. Г.Батхүү гишүүнээр тасаллаа. С.Дэмбэрэл гишүүн асуултаа асууя.

**С.Дэмбэрэл:** -”Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ыг Их Хурлаар батлах гэж байна. Монгол Улсын энэ транзит байрлалыг иж бүрэн ашиглах уг нь нэг ийм бодлого байх ёстой. Тэгээд энэ ганцхан төмөр замын тээврийн талаар ийм Улсын Их Хурлын тогтоол гаргана гээд их л



удаан явлаа л даа. Тэгэхээр ер нь транзит тээврийн бодлогыг яах юм бэ. Одоо хоёр хөрштэйгөө нөгөө транзит тээврийн асуудлаар гэрээ хэлэлцээр хийгээд тодорхой үр дүнгүүд гарсан байгаа. Олон улсын байгууллагуудтай энэ чиглэлээр ажиллаад тодорхой үр дүн гараад явж байна. Одоо 7, 8 жилийн өмнө транзит Монгол гээд бас нэг тийм баримт бичиг батлагдаад тэр нь одоо байж л байгаа. Энэ бүгдийгээ нэг иж бүрэн харсан тийм юм хийж болохгүй юм уу.

*Хоёрдугаарт* энэ сайд нь томилогдоогүй, яамны ямар нэг тодорхой төрийн бодлого гаргах ёстой шүү дээ. Тухайн яам байр сууриа илэрхийлэх. Энийг нь яах юм бэ. Болж байгаа юм уу. Ийм л асуулт байна л даа.

**Б.Гарамгайбаатар:** - С.Эрдэнэ сайд.

**С.Эрдэнэ:** - С.Дэмбэрэл гишүүний асуултад хариулъя. Одоо бодлогын асуудлын талаар манай холбогдох улсууд мэргэжлийн хүмүүс Эрдэнэбүрэн дарга, Ганболд дарга нар хариулна биз. Миний хувьд бол өнөөдөр энэ сайдын асуудлын хувьд бол өнөөдөр энэ асуудал маань ирэх долоо хоногт Улсын Их Хурлын дарга БНХАУ-д айлчлахтай холбоотойгоор зарим нэг асуудлыг яаралтай шийдэх шаардлага байгаа.

*Хоёрдугаарт*, саяын Хятадын Засгийн газрын даргын айлчлал ОХУ-ын Ерөнхийлөгчийн айлчлалтай холбоотойгоор одоо төмөр замын бодлогын талаар тодорхой асуудлуудыг шийдэх шаардлагууд бол байгаа. Сайншанд, Эрээний чиглэлийн өргөн царигт төмөр замын дагуу Нарийн царигтайгаа төмөр зам тавих асуудал бол Оросын талаас зөвшөөрөөгүйтэй холбоотойгоор. Хоёрдугаарт Төмөртэйн орд мөн одоо Хятадтай хамтарсан энэ төмөрлөгийн үйлдвэр байгуулахтай холбоотой Хэнтийн Бугат уруу шууд экспортлох гарц боломжийг харгалзаж энэ Сайншанд Ханги Мандлын чиглэлийн маршрут энэ нарийн царигтай төмөр зам байгуулах асуудлыг бол ярьж байгаа. Энэ асуудлуудыг оруулж ирж байгаа юм. Тэгэхээр яг бүхэлдээ ер нь одоо “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” гэсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл тэрнээс биш бүхэлд нь бол асуудлыг бол авч үзэж байгаа асуудал хараахан биш гэдгийг бас С.Дэмбэрэл гишүүнд тайлбарлая. Нэмэлт тайлбар байвал Да.Ганболд дарга, Р.Эрдэнэбүрэн дарга эд нар хариулчих.

**Б.Гарамгайбаатар :** - Эрдэнэбүрэн төрийн нарийн бичиг хариулъя.

**Р.Эрдэнэбүрэн:**-Зам тээвэр, барилга хот байгуулалтын яам байгуулах тогтоол гарснаас хойш өнгөрсөн хагас сайн өдөр шинээр байгуулагдсан яамны Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгчээр томилсон тушаал гарсан. Тийм учраас энэ талаар бол ямар нэгэн мэдээлэлгүй явж байгаа. Хуучин ажлын хэсэгт байсан хүмүүсийг энд дуудаж ирсэн байх гэж бодож байна. Надад бол ямар нэгэн мэдээлэл өгөх энэ талаар одоо уншиж судалсан зүйл алга байна.

## **Ломбардын харилцааг хэн зохицуулах вэ**

**2014 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн УИХ-ын Чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс: “Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай болон холбогдох хуулиудын төсөл хэлэлцэх цээр**

**С.Дэмбэрэл:** Хуулийн төслийг дэмжиж байна. Гэхдээ хэдэн санал хэлье. *Нэгдүгээрт* Х.Тэмүүжин сайдаас, “судалгаа шинжилгээ нилээд хийсэн” гэж хэлж байна. Та бүхний судалгаа шинжилгээнээс та бүхний авсан зүйл, гишүүдийн төсөл уншаад авах зүйл 2 өөр. Тийм учраас судалгаа шинжилгээнүүдээ нийт гишүүдэд болон УИХ-ын тамгын газрын судалгаа шинжилгээний хэлтэст явуулаасай гэж хүсч байна.

*Хоёрдугаарт:* С.Баярцогт гишүүний ярьж буй процессын буюу бодит амьдрал дээр гардаг харьцаанууд гэж бий. Түүний дотор банк ба иргэн, банк ба аж ахуй нэгж, банк бус санхүүгийн байгууллага ба иргэн, банк бус санхүүгийн байгууллага ба аж ахуй нэгж, ломбард ба иргэн, ломбард ба аж ахуй нэгж гэсэн нийгмийн бүхэл бүтэн том групын, өөрөөр хэлбэл, Монгол улсын хүн амын 50-70 хувийнх нь амьдралын, санхүүгийн өдөр тутмын харьцаанд ордог асуудлыг зохицуулах гэж байна л даа. Тийм учраас тэр амьдралын зүйлүүд, бодит амьдрал дээр гардаг зүйлүүдийг оруулж өгөх хэрэгтэй. Та бүхний ярьж байгаа, асуултанд хариулж байгаа байдал, танилцуулга их хөндий, учир дутагдалтай, ерөнхий сонсогдож байна. Аль байнгын хороогоор орох ёстой вэ? Хууль зүйн байнгын хороогоор ганцхан ороод л явчихвал учир дутагдалтай байна. Эдийн засгийн байнгын хороогоор орж, нарийн яригдах ёстой. Мөн нийгмийн бодлогын байнгын хороо гэж байна. Энэ бүхэн өөрөө нийгмийн, эдийн засгийн маш том үр дагавартай учраас үүнийг сайн бодож боловсруулах ёстой гэсэн ерөнхий зөвлөгөө өгмөөр байна.

*Гуравдугаарт:* Бодит амьдрал дээрх ломбардын харьцааг ярья л даа. Одоо надад ломбардын судалгаа, Ломбардын хуулийн төсөл бэлэн байж байна. Энэ хуулийн төслийг заавал би өөрөө өргөн барих шаардлагагүй. Харин үүнээс иш үндэс аваад ломбардын талаар зохицуулалт хийж болно. Одоогоос 10 гаруй жилийн өмнө гаргасан ломбардын стандартууд байна. Тэр стандартууд огт мөрдөгддөггүй. Та бүхэн мэдэж байгаа. Өнөөдөр нэг ломбарднаас /Хан-Уул дүүрэгт байрлалтай/ 100 мянган төгрөг авахын тулд оюутан, залуус NIKE пүүзээ барьцаалж байна. Энд ч бас санхүүгийн харьцаа явагдаж байна. Ломбардын маш олон эздийн болон иргэдийн 2 талын асуудал, ломбардны өнөөдрийн зах зээл, үүн дээр болж байгаа санхүүгийн харьцаа учир дутагдалтай. Банк болон аж ахуйн нэгжүүдийн хооронд хийгддэг гэрээ хэлэлцээр шиг иргэн ба ломбардын хооронд тэнцвэргүй, тэгш бус, иргэний хуулийг зөрчсөн гэрээт харилцаа үүсчихсэн байдаг. Судалгаанаас үзэхэд Монголд нийт 1050 гаруй ломбард үйл ажиллагаа явуулж байна. Энэ зах зээлийн харьцаа цөөхөн хэдэн ломбардын эзэд байна. Ломбардын эзэд болон иргэдийн дунд эд зүйлсийн барьцаа болон харьцаа маш зохицуулалтгүй зах зээл байна. Үүнийг санхүүгийн зохицуулах хороо зохицуулах юм уу? Хэн зохицуулах юм бэ? Хуучин татварын ерөнхий газраас татварын байцаагч очдог байсан бол, одоо цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг, хулгай гарвал л анхаарч очдог болсон байна. Өөр хэн чанхаарахгүй байна. Энэ бол ядуурлыг нэмэгдүүлж

байгаа нэг хүчин зүйл шүү! Иргэн хүний эдлэх ёстой эрхийг тэгш бус байдлаар хязгаарлаж байгааг анхаарч, хуулиараа зохицуулж өгмөөр байна. Х.Тэмүүжин сайдаа, надад хуулийн төслийг хангаж чадахуйц мэдээлэл нь байна. Үүнийг ашиглаад, жижиг бүлэг болгож, оюуны өмчийн талаас нь оруулаад чамбай сайн хууль гаргавал яасан юм бэ? Одоо надад Ломбардын судалгаа болон миний боловсруулсан хуулийн төсөл бэлэн байж байна. Би үүнийг та бүхэнд өгөхөд бэлэн байна. Үүнээс уламжлан, ломбардын зохицуулалтыг хиймээр байна.

Мөн Оюуны өмчийн, болон оюуны өмчийн лицензийн асуудал ярьж байна. Маш түүхий юм ярьж байна. Оюуны өмчийн тухай хуулинд оюуны өмчийн лицензын гэрээ, лиценз эзэмшигчийн харьцаа гэж байдаг. Ажлын хэсэгт оюуны өмчийн холбогдох хүмүүсийг яаралтай оруулж, энэ чиглэлээр шинээр юм хийх хэрэгтэй байна. Хуулийн төслийн танилцуулгыг голж байгаа юм биш, дутуу байгаа юм байна гэж санал тавьж байна. Та бүхний хариултаас харагдаж байна. Нэгэнт хийснийх нэг мөсөн зохицуулахуйц, чамбай хууль гаргачихаач. Иймэрхүү нарийн ширүүн зүйл ороогүй, ерөнхий хууль гарчихаараа л сүүлд нь...

*Дөрөвдүгээрт:* Маргаан шийдвэрлэх тухай ярьж байна. Монгол улсад үүнийг зохицуулах шүүхийн бус хууль эрх зүйн 2 л боломж байгаа. Нэг нь маргаан гаргахгүйгээр эвлэрүүлэн зуучлах үйлчилгээ /үүнийгээ зааж өг/, нөгөө нь арбитрийн үйлчилгээ юм. Иргэдийн маргаан нь ихэвчлэн нэг удаагийн маргаанд байдаг. Ийм ийм талаас нь бодож эрх зүйн боломжыг нь нээж өгөх, тусгаж оруулах хэрэгтэй байна.

## **Төв банкинд “Төсвийн талаар дүгнэлт ирүүл” гэсэн үүрэг өгье**

*2014 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралданы тэмдэглэлээс, “Т Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх  
цер*

**С.Дэмбэрэл:** Манай хуулинд, Төв банкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хадгалах явдал байдаг. Үүнийг Ё.Отгонбаяр гишүүн ч бас асуугаад байна л даа. Үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдал гэж юу болох тухай олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн 2 утга бүхий нэгдсэн ойлголт байдаг. Энэ нь “тухайн үндэсний мөнгөн тэмдэгтийн дотоод үнэ цэнэ”, нөгөө нь “тухайн үндэсний мөнгөн тэмдэгтийн гадаад үнэ цэнэ” юм. 1996 онд манайхыг хуулиа батлах үеэр Орос, Хятад зэрэг нилээн хэдэн орны хуулинд currency stability гэдгээрээ орчихсон байсан.

Инфляцыг онилох мөнгөний бодлого эхэлж байгаа манай орны хувьд хуулиндаа зайлшгүй өөрчлөлт оруулж, “үндэсний мөнгөн тэмдэгт – төгрөгийн тогтвортой байдал” гэдгийг “үнийн тогтвортой байдал” гэдгээр сольж орлуулах, тодорхой болгох цаг үе нь болсон гэж би бодож байна. Тэгэхгүй бол, энэ тухай УИХ-ын гишүүд бол жил болгон асуусаар л байх болно. Үүнийг ганцхан Монголбанкны Ерөнхийлөгч нь тайлбарлаад нэмэргүй юм. Бусад орны хувьд хуулиндаа энэ тухай тусгаад өгчихсөн байна. Тиймээс бид ч бас хуулиндаа хурдан тусгаж, оруулмаар байна.

*Хоёрдугаарт:* Монгол улсад capital control – капиталийн хяналт байдаггүй, тогтмол ханшгүй, Төв банкны бие даасан байдлыг хуулиараа хангачихсан байдаг. Өөрөөр хэлбэл, Монгол улс боломжтой гурвалжинтай, “боломжгүйн гурвалжингүй”. Энэ нөхцөл байдалд валютын ханш дээр гарч байгаа асуудлууд маань Төвбанкны хуулинд байгаа “ханш нь чөлөөтэй бөгөөд уян хатан, бодитой тогтох” гэсэн ганцхан зарчмаар олон жил явсанд байгаа юм. Гэтэл бусад орнуудын Төв банкнуудын /60 гаруй орны/ валютын ханшны бодлогоо тодорхойлж байгаа туршлагаас нь харахад, валютын ханшны бодлогоо, Засгийн газартайгаа хамтарч тодорхойлоод /манайх бол Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл дээрээ тогтооно гэсэн үг/, харин төв банк нь хэрэгжүүлэх ажлаа 100%, бүрэн хариуцдаг юм байна. Энэ тогтолцоо руу орох ёстой гэж би бодож байна. Тэрнээс биш, мөрдөгдөх боломжгүй нэг зарчим биччихээд, тэр нь ард иргэд, бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөөд, үнийг өсгөөд, тэгээд үнэ өсөхөөр бодлогоо хатууруулаад, түүнийгээ УИХ дээр жил болгон тайлбарлаад байж болохгүй байна. Тийм учраас энэ тал дээр анхаараасай гэсэн асуулт маягийн анхааруулга тавьж байна.

*Гуравдугаарт:* Одоо нэг маш тодорхой асуулт тавья. 2015 оны Төсвийн төслийн тухай нэг ийм зузаан ном ороод ирчихсэн байна. Үүнийг уншиж үзсэн чинь “инфиляц үйлдвэрлэх” хандлага л ажиглагдаад байна. Ийм “инфиляц үйлдвэрлэх” төсөв орж ирээд байхад, Монголбанкныхан та нар инфляцыг 7 хувьд барина гэсэн байх юм. Нийлүүлэлтийн гаралтай инфляци 40 хувь байсныг 5 хувь болно гэсэн байх юм. Тэгэхээр 95 хувь нь эрэлтийн гаралтай болох гээд байна. Эрэлтийн гаралтай болохоор та нар мөнгөний хатууруулах бодлого хэрэгжүүлнэ гэж ярьж байна. Мөнгөний бодлогыг хатууруулчихаар хувийн хэвшил хөдөлгөөн муутай болж, импортын үнэ өсч эхэлнэ. Энэ тохиолдолд юу хийх юм бэ гэдэгт хариулаадхаач! Тэгээд бас, энэ төсвийн зузаан номыг уншсан уу? Уншаагүй бол, УИХ-ын даргаас Төв банкинд, “УИХ-д дүгнэлтээ ирүүл” гэсэн 7 хоногийн хугацаатай үүрэг өгмөөр байна. Ийм хүсэлт, асуулт хоёр байна даа.

## **Инфиляцыг онилох бодлого чинь валютын ханшаар тодорхойлогдох гээд байна!**

*2014 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлээс:*

**УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл:** Гишүүдээс янз янзын санал бодол хэлж байна. Би бас хэдэн асуулт асууя. Нэгдүгээрт: Сангийн дэд сайд С.Пүрэв сайдаас асууя. Засгийн газар дотоод бонд / үнэт цаас / гаргах гэж байна уу? Санхүүгийн зохицуулах хороо үүнийг мэдэж байгаа юу? Хөрөнгийн биржийг идэвхижүүлэх зорилготой гаргаж байгаа юу? Энэ талаар гишүүдэд мэдээлэл өгөх үү.

**Сангийн дэд сайд С.Пүрэв:** Бид нар эрхийнхээ хүрээнд энэ жилдээ гаргах дотоод бонд 1.4 их наядын эрхтэй байгаа. Оны сүүлээр бид 1 их наядаас илүү гаргаж чадахгүй байгаа. Тэр хавьцаа л төлөвлөж байгаа. Бид нар байнга бондоо анзаарч байгаа. Санхүүгийн зохицуулах хороо мэдэж байгаа.

**Г.Баярсайхан:** Манайх сая засгийн газрын үнэт цаасыг хөрөнгийн биржээр арилжаалах журмаа гаргасан. Уг нь хөрөнгийн биржээр арилжих журмыг байнга тавьж байсан. Одоо бол банкууд **бутлок** болчихсон. Өөрийн эрхгүй хөрөнгийн бирж рүү орж байна. Гадны хөрөнгө оруулалтын сангууд авья гэдэг. Гэхдээ банкаар дамжуулахгүйгээр, шууд авахыг хүсдэг. Одоо бол зөв алхам руугаа орж байна гэж ойлгож байгаа. Хөрөнгө оруулалтын сангийн хуулийн дагуу одоо манайхаас хөрөнгө оруулалтын менежментийн 2 компани зөвшөөрөл авсан. Мөн хөрөнгө оруулалтын сангаа байгуулах зөвшөөрлийг 2 газар авчихаад байж байна. Сая МИК ХХК-ны /Монголын ипотекийн корпораци/ 328.5 тэрбумын үнэт цаас гаргах үйл ажиллагааг шийдсэн. 8% зээлээр Худалдаа хөгжлийн банк, Голомт банкуудад **кастон** банкны үйлчилгээг явуулах зөвшөөрөл олгосон. Банкууд, даатгалын зуучлалын үйл ажиллагааны зөвшөөрөл их авч байна. Банкбус СБ-ууд маш ихээр байгуулагдаж байна. /400 тэрбумаар/ Банк бусууд Худалдаа Хөгжлийн банкаар дамжиж банк хоорондын зах руу орохоор гэрээ хэлцэл хийгдлээ. Энэ чиглэлээр Монголбанктэй их хамтарч ажиллаж байна. “Монголын хөрөнгийн бирж”-ын зах зээлийн өнөөгийн байдал нь дараах байдалтай байгаа. Монголын хөрөнгийн бирж /МХБ/ Лондонгийн хөрөнгийн биржтэй /ЛХБ/ дахин гэрээгээ сунгасан байгаа. Манайхаас хамгийн том гол нь Монголын хөрөнгийн зах зээлд бүтээгдэхүүн нийлүүлэх үлдлээ. Хувьцаат компаниудад /идэвхгүй болсон/ хяналт, шалгалт хийгдэж байгаа. Одоо хувьчлалын үед байсан 400 компаниудаас 200 компанийн арилжааг зогсоосон байгаа. Одоо 100 гаруй идэвхтэй компани үйл ажиллагаагаа явуулж байна. Хамгийн гол нь төрийн өмчит компаниудыг задлахгүй байна. Нийт төлбөр тооцооны төвд дээр хадгалагдаж байгаа хувьцааны 85 хувь нь төрийн өмчийн хувьцаа байна. Ерөөсөө үүнийг л хийх ёстой. Бид нар компаниудыг та нар хөрөнгийн бирж дээр гараад ирээчээ гэхээр “Лондонгийн хөрөнгийн бирж”-ын шаардлага жаахан хатуу байна.

**Хоёрдугаарт:** Цэнхэр номны 34-р хуудас гэж хэлээд байгаа. Сая Ч.Хүрэлбаатар гишүүн “exchange control” тавь гэлээ. Түрүүн та нар, хэрэв төв банкны хуулиар заагдсан 3 зүйл /бие даасан, хараат бус байдал/ капиталын контроль /exchange control/ тавьбал, танай төв банкны бие даасан байдал /аль нэг 3 зүйл/ алдагдана.

## **2015 оны Монгол улсын эдийн засагт ихээхэн хүндрэл үүсэхээр байна**

*2014 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн Эдийн засгийн байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээс: Тийн анхны хэлэлцүүлэгийн цэр:*

**С.Дэмбэрэл:** Манай мөнгөний бодлогын ажлын хэсэг сая, 2014 оны 11 дүгээр сарын 1-3 өдрүүд буюу амралтын өдрүүдээр ажиллаад, ерөнхийдөө



2015 оны төсөв, мөнгөний бодлогыг уялдуулах чиглэлээр, Эдийн засгийн байнгын хорооноос мэргэжлийн хорооныхоо хувьд Төсвийн байнгын хороонд тодорхой саналууд өгөх нь зүйтэй гэж үзсэн. Ийм нөхцөл байдалд 2015 оны мөнгөний бодлогыг батлуулахад маш их хүндрэл гарч мэдэхээр байна. Ингэснээр 2015 оны Монгол улсын эдийн засагт ихээхэн хүндрэл үүсэхээр байгааг, эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсэг болон холбогдох яамдууд, Монголбанк төрөл бүрийн судалгаа, шинжилгээгээр нотлон дүгнээд байна. Энэ тохиолдолд, эдийн засгийн байнгын хорооноос 2015 оны төсөвтэй холбогдуулан, төсөв ямар байвал зохистой, төсвийн ямар бодлого явуулбал зохистой талаар, ингэснээрээ макро эдийн засгийн тогтвортой байдлыг яаж хангах талаар тодорхой саналуудыг ажлы хэсгээс боловсруулсан. Үүнийг төсвийн байнгын хороонд явуулах саналдаа тусгаж өгөх нь зүйтэй байгаа гэсэн саналтай байна. Үүнийг хоёрдугаар асуудал ярихаар дэлгэрэнгүй ярих болно.

### **2015 оны төсвийг алдагдалгүй, ашигтай батлах санал хүргүүлээ**

*УИХ энэ долоо хоногт Монгол Улсын 2015 оны төсвийн төслийг батлах хуулийн хугацаа болно. Засгийн газрын өргөн мэдцүлсэн төсөв нь хэт өөдрөг, бодит амьдралд нийцэхгүй болсныг УИХ-ын олон гишүүн шүүмжилж байна. Тэдний нэг УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл төсвийн хуулийг хэлэлцэх үед төсвийн төслийг сайжруулах УИХ-ын гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг байгуулах санал гаргасан. Гишүүд болон Монгол банкны төлөөлөл оролцсон ажлын хэсэг төслийг сайжруулах, найман заалт бүхий саналаа Төсвийн байнгын хороонд хүргүүлжээ. Энэ талаар УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлтэй ярилцлаа.*

- УИХ-аар 2015 оны Мөнгөний бодлогын хууль эцсийн байдлаар батлагдахад бэлэн боллоо. Мөнгөний бодлогын гол агуулга нь юу вэ?

С.Дэмбэрэл: - Ирэх оны мөнгөний бодлогыг маргааш УИХ-аар батлах байх. Инфляцыг нам дор түвшинд буюу долоон хувьд барих, 2015 оны төсөөлөлд 9.5 хувийн хэлбэлзэлтэйгээр нэг оронтой тоонд барих боломжтой гэж үзсэн. Эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд ямарч улсад мөнгөний бодлого, төсвийн бодлого хоёрыг уялдуулах хэрэгтэй байдаг. Эдийн засгийн хүндрэлээс урьдчилан сэргийлэхийн тулд мөнгөний бодлого заавал хатуу байх албагүй л дээ. Төвбанкны гол зорилт бол инфляцыг дунд хугацаанд буюу 24 сарын дотор нам дор түвшинд барих бодлого өөрөө валютын ханшийн бодлого болон бусад мөнгөний бодлогын арга хэрэгслүүдээр дэмжигдэн, энэ нь төсвийн бодлоготойгоо уялдаж байж, дараа жилийн эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох ёстой. Мөнгөний болон төсвийн бодлогын аль аль нь эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах ёстой. Тогтвортой бөгөөд нийт эдийн засгийн оролцоотой өсөлт.

- 2015 оны улсын төсвийн төслийг боловсруулахдаа ямар алдаа гаргасан гэж Та харж байна вэ?

**С.Дэмбэрэл:** - Төсвийн бодлогыг хэлэлцэхдээ УИХ-ын бүх байнгын хороо харьяалагдах яамдынхаа төсвийг авч үзээд, баригдах объектоор нь задалж үздэг. Миний хувьд УИХ-д суухдаа төсөв баталсан хоёр жилийг харахад гаргаж байгаа хамгийн том алдаа нь төсвийн бодлогоо огт ярьдаггүй. Төсвийн бодлого макро эдийн засгийн ямар үр дүнд хүрэх, эдийн засгийг яаж идэвхжүүлэх, бодлогын хувьд мөнгөний бодлоготой уялдаж байгаа, эсэхийг ярих ёстой. Харж байхад өдөр болгон гурван хяналт шалгалт, жилдээ 1070 удаа хяналт шалгалт хийнэ гэсэн заалт оруулсан байна. Эсвэл 170 мянган маягт хэвлүүлнэ ч гэх шиг. Төсвийн мөнгөөр юу хийж, ямар үр дүнд хүргэх талаар их сул анхаарсан төсөв болсон. Гэтэл үүнээс өмнө төсвийн ерөнхийлөн захирагч, объект бүрээр нь шууд задалж, зарцуулах мөнгөний тооцоо хийдэг дутагдлаасаа салж чадаагүй л байна.

*Хоёрдугаарт*, 2015 оны төсвийн төслийг үзэхэд урсгал зардлыг хэмнэсэн байна лээ. Гэхдээ урсгал зардлыг засаг захиргааны бүтэцтэй уялдуулж, илүү хэмнэх боломж харагдаж байна. Тухайлбал, Монгол Улсад яам, агентлаг гэсэн засаглалын бүтэц нутагшсан уу, үгүй юу. Энэ олон яам, тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагууд гэх занхгар бүтэц зөв, эсэхийг цаашид анхаарах ёстой. Энэ жил харамсалтай нь тэгж анхаараагүй л дээ. 2015 оны төсвийн тухайд урсгал зардлыг Сангийн яамнаас хэдийгээр хасаж оруулсан ч илүү танах боломж мэдээж байна. Хүн цалин авах хэрэгтэй, гэхдээ цалин авахын тулд энэ бүх яамаар задалсан төсвийн задаргаа ямар үр дүнд хүргэхийг тодорхойлох учиртай. Төсвийн бодлого тооны болон чанарын ямар үр дүнд хүрэх вэ гэдэг дээр Сангийн яам огт анхаардаггүй юм билээ. Татвар төлөгчийн мөнгийг авах гэж байж, түүний оронд ямар бүтээгдэхүүн гаргах гэж байгаа нь тодорхойгүй. Харж байхад жилд өдөр болгон гурван хяналт, шалгалт, жилдээ 1070 удаа хяналт шалгалт хийнэ гэсэн заалт оруулсан байна. Эсвэл 170 мянган маягт хэвлүүлнэ ч гэх шиг. Төсвийн мөнгөөр юу хийж, ямар үр дүнд хүргэх талаар их сул анхаарсан төсөв болсон.

*Гуравдугаарт*, хөрөнгө оруулалтын асуудал. Аймаг, сум болгонд, Улаанбаатарт ч цэцэрлэг барих хөрөнгө оруулалт хэрэгтэй. Боловсрол, эрүүл мэндийн зардлыг төсвийн бүтээлч зардал гэдэг. Бүтээлч зардал дээрээ мөнгө тавих ёстой. Гэхдээ үүнийхээ үр ашиг, хөрөнгө оруулалтын мөчлөг яаж явагдаж байна, үр ашигтай зарж чадаж байгаа эсэхэд тооцоо хийх ёстой. Өнгөрсөн жил эхэлсэн барилга юм аа, энэ жил үргэлжлүүлэх ёстой гэсэн хандлага л газар авсан. Түүнээс уг хөрөнгө оруулалтын үр ашиг, үхмэл хөрөнгө ямар байдалд байгааг тооцдоггүй.

**- Тэгвэл улсын төсвийн хөрөнгө оруулалтыг үр ашгаар нь эрэмбэлэн санхүүжүүлэх ёстой гэсэн үг үү?**

**С.Дэмбэрэл:** - Хөрөнгө оруулалтын зардал дээр тэргүүн ээлжинд хийх ёстой хөрөнгө оруулалт нь юу вэ, энэ хөрөнгө оруулалт нь эдийн засгийн идэвхжилийг яаж хангах юм. Энэ хөрөнгө оруулалт нь Монголбанкнаас тавигдаж байгаа инфляцыг нам дор түвшинд барих зорилгод шууд нийцэж байна уу, үгүй юу. Ханшийн илүүдэл эрэлтийг бий болгох, эсэхийг анхаарч судлаад нэгтгэх тал дээр учир дутагдал их байна. УИХ-аар төсвийг цаг нь тулчихсан хойно хэлэлцдэг учир засаж, залруулах цаг хугацааны боломжгүй болсон байдаг.

**- Эдийн засгийн байнгын хорооноос ирэх оны төсвийн төслийг засаж, залруулах найман заалт бүхий санал хүргүүлсэн гэж дуулсан. Түүнд чухам ямар саналууд тусгасан бэ?**

**С.Дэмбэрэл:** - Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар 2015 оны улсын төсвийн дээр өгүүлсэн дутагдлуудад дүгнэлт хийж, Монголбанк болон бусад гишүүний саналыг нэгтгээд найман санал гаргаснаа Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд зааснаар төсвийн алдагдал хасах хоёр хувиас хэтрэхгүй байхаар баталдаг. Тэгвэл найман саналын *нэгдүгээрт*, ирэх оны төсвийг алдагдалгүй батлаач гэсэн. Алдагдалгүй батлахаар барахгүй, ашигтай байхаар батлаач гэж байгаа. Энэ нь урсгал зардлаас гадна хөрөнгө оруулалтыг хасна гэсэн үг. Хасахдаа алийг нь яаж хасах, хэмнэгдсэн хөрөнгө оруулалтыг дотор нь шилжүүлэх тухай ярих ёстой. Тухайлбал, эдийн засгийн идэвхжилийг хангана гэдэг зөвхөн барилга, замын салбарыг дэмжээд бай гэсэн үг биш шүү дээ. Нийт эдийн засгийн идэвхжилийг хангах учиртай юм. Энэ бол нэг талаас компаниудын эдийн засгийн идэвхжил, зах зээл дээрх хэрэглэгчийн идэвхжил юм. Нийт эдийн засгаа дэмжсэн, инфляцыг нэг оронтой тоонд барих шаардлага хангасан төсөв хэрэгтэй байна.

**- Ирэх онд цалин, тэтгэврийг нэмэгдүүлэхэд 500 тэрбум төгрөг төсөвлөсөн. Цалин тэтгэврийг нэмлээ ч бараа бүтээгдэхүүний үнэ өсчихвөл нэмэгдэл амьдралд өгөөжөө өгөхгүй. Та энэ тал дээр ямар бодолтой байна вэ?**

**С.Дэмбэрэл:** *Нэгдүгээрт*, Цалингийн нэмэгдэл нь инфляцыг өдөөгөөд, эцсийн дүндээ хүн амын худалдан авах чадвар сайжрах биш, сөрөг үр дүнд авчирвал цалин нэмсний хэрэг гарахгүй. Тийм учраас уялдуулахын гол ач холбогдол нь эндээ байгаа. Хөрөнгө оруулалтын зардлыг хамгийн оновчтой төлөвлөж, үр ашгийг тооцох талын ажил манай улсад их муу хийгдэж байна.

*Хоёрдугаарт*, 2015 төсөвт 708 тэрбум төгрөгийн өр төлөх төсвийг суулгана. Өр төлөх асуудал 2017 оны төсөвт хамгийн их ачаалал өгөхөөр байгаа учир энэ мөнгөө одооноос бага багаар төсөвтөө суулгаж өгөөч ээ гэж байгаа юм. 2017 оноос төлөх Засгийн газрын 500 сая ам.доллар, Засгийн газрын баталгаа бүхий Хөгжлийн банкны 580 сая ам.долларыг төлөх санхүүгийн эх үүсвэрийг 2015, 2016 оны төсөвт жишээлбэл тус бүр 30 хувиар суулгаж байх ёстой. Үлдсэн 30 хувийг зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлнэ гэсэн санал тавьсан. Улсын төсвийн санхүүжилтээр бараа үйлчилгээ худалдан авахдаа бүгдийг дотоодоосоо авдаг байх санал гаргасан. Импортын хамаарлыг багасгахын тулд дотоодынхоо аж ахуйн нэгжүүдийн бараа бүтээгдэхүүнийг, харин Монголд үйлдвэрлэдэггүй цаас, автомашин зэргийг Монгол дахь албан ёсны дистрибутерээс нь авбал дотоодын эдийн засгаа дэмжсэн шийдэл болно.

*Гуравдугаарт*, Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хувийн хэвшилд шилжүүлэх. Төр бүхнийг барьдаг, тендер зарладаг хэр нь нөгөө талд концессийн гэрээгээр ажил гүйцэтгэсэн компанийн мөнгийг өгч чадахгүй, компаниудыг хохироодог. Энэ бүхнийг шийдэх цаг болсон. Монголбанк, Сангийн яам төсвийн хөрөнгө оруулалтын ажилд хүүгийн дэмжлэг үзүүлдэг байх механизм руу шилжье гэж байгаа.

**- Ирэх оны төсөвт орлогыг өмнөхөөс нэмэгдүүлэх тооцоо хийсэн. Эдийн засгийн ийм бодит бололцоо манайд бий юу?**

**С.Дэмбэрэл:** - Сангийн яамнаас орлогын төлөвлөгөөг өндөр тавьдаг. Орлогын төлөвлөгөө гаргахдаа нийт татвар төлөгчид, түүний дотор томоохон татвар төлөгчдийн орлогын дайчилгаа маш өндөр тавьдаг. Өнөөгийн нөхцөлд татвар нэмэгдүүлнэ гэж байхгүй. 2015 оны татвар төвлөрүүлэлт эдийн засгийн өнөөгийн орчинд л явагдана. Татварын гол орлогыг бүрдүүлдэг цөөхөн компани байгаа, тэднээс нэмж авах юм байхгүй. Тиймээс төсвийн орлогыг өмнөх оны түвшинд тооцох санал гаргасан. 2014 оны төсвийн орлогын гүйцэтгэлийг 6.1 их наяд төгрөг байхаар төлөвлөсөн. 2015 онд ч үүнээс том тоо тавих хэрэггүй. Манайд жилийн жилд л төсвийн орлого дутдаг шүү дээ. Энэ нь төсвийн бодлого бодитой бус, УИХ-аас сөрөг нөлөө ороод байна гэсэн үг. Үүнийг болиулах хэрэгтэй.

*Дөрөвдүгээрт*, төсвөөс гадуур явуулж ирсэн “Чингис”, “Самурай” бонд, Хөгжлийн банкны санхүүжилтийг төсвийн орлого, зардлагын аль алинд оруулж тооцох ёстой гэсэн санал бий.

*Тавдугаарт*, зах зээл дээр валютын эрэлтийг үүсгэхгүй байх хэрэгтэй. Импорттоор бараа бүтээгдэхүүн их хэмжээгээр худалдан авахад валютын эрэлт үүснэ. Эрэлт ихэсвэл ханш суларна. Манайд гадаадын хөрөнгө оруулалт маш муу байна. Төлбөрийн тэнцэл хасах үзүүлэлттэй, валютын цэвэр нөөц маш бага байгаа ийм тохиолдолд эдийн засгийн дотоод нөөц бололцоогоор дэмжихээс сайн сонголт үгүй. Улсын төсвийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хурдан батлах хэрэгтэй. Хэдийгээр электрон худалдан авалтын системийг мөрдөж байгаа ч өнөөгийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна. Монгол шиг улирлын хэлбэлзэл ихтэй, хөрөнгө оруулалт бизнесийн идэвхжилийнх нь мөчлөг богинохон байдаг улс оронд энэ онцлогоо дээд зэргээр харгалзсан ил тод, шударга, хөндлөнгийн хяналттай хууль батлах хэрэгтэй.

*Зургадугаарт*, улсын төсвийн санхүүжилтээр бараа үйлчилгээ худалдан авахдаа бүгдийг дотоодоосоо авдаг байх санал гаргасан. Манай улс импортын хамаарал ихтэй. Энэ хамаарлыг багасгахын тулд дотоодынхоо аж ахуйн нэгжүүдээс бара бүтээгдэхүүнээ, харин Монголд үйлдвэрлэдэггүй цаас, автомашин зэргийг Монголд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудаас авбал дотоодын эдийн засгаа дэмжсэн шийдэл болно. Мөн хямралын үед хувийн секторт боломж олгож буй хэлбэр юм. Энэ бол урт хугацаандаа заавал хэрэгжүүлэх ёстой ажил. Нийт эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлнэ гэдэг жижиг, дунд, том аж ахуйн нэгжүүдэд хүрч, тэднийг дэмжих хөшүүрэг төсвийн бодлогод тусгалаа олохыг хэлж байгаа юм. Төсөв бол Монгол Улсын нийт эдийн засгийн 40-50 хувийг эзэлдэг.

**- Төсвийн төслийг сайжруулахтай холбоотой саналаа байнгын хороод Төсвийн байнгын хороонд оруулдаг ч төдийлэн ач холбогдол өгдөггүй. Төсвийн байнгын хороо өөрийн үнэлэлт, дүгнэлт өгсөн төслөө л зүтгүүлдэг гэх шүүмжлэл УИХ-ын чуулганы танхимд сонсогдож байсан?**

**С.Дэмбэрэл:** - Эдийн засгийн байнгын хороо энэ саналаа хүргүүлээд хоёр долоо хонож байна. Эдийн засгийн асуудлыг хариуцдаг гол байнгын хороо ийм санал өгчихлөө шүү дээ. Үүнийг Төсвийн байнгын хорооныхон буурьтай, суурьтай үзэж, тал талаас нь ярилцдаг байх ёстой. Гэтэл өнөөдөр

ярилцдаг эсэхийг ч мэдэхгүй, ярилцдаг процедур нь ч тодорхой биш байна. Үүний оронд ямар барилга байшин санхүүжүүлэх тухайгаа ярилцаад, гол бодлогоо ярихгүй төсвөө баталдаг буруу практикт шилжчихээд байна. Тийм учраас би өчигдөр өглөө УИХ-ын даргатай уулзаж, Төсвийн байнгын хороонд зөв чиглэлээ өгөөч ээ гэж хэлсэн. Төрийн мөнгөний бодлого, төсвийн бодлогыг уялдуулж байж, төсвийн санхүүжилт маань эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлнэ. Идэвхжилийг нэмэгдүүлнэ гэдэг бол объект бүрээр хөрөнгө оруулалт хий гэсэн үг биш шүү дээ. Нийт эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлнэ гэдэг жижиг, дунд, том аж ахуйн нэгжүүдэд хүрч, тэднийг дэмжих хөшүүрэг төсвийн бодлогод тусгалаа олохыг хэлж байгаа юм. Төсөв бол Монгол Улсын нийт эдийн засгийн 40-50 хувийг эзэлдэг. Төсвөөр дамжуулан жижиг, дунд бизнесийг яаж дэмжих юм, тэдэнд хангалттай мөнгө очсон уу гэх мэтээр харах ёстой юм.

**- УИХ-аар маргааш 2015 оны Мөнгөний бодлогын эцсийн хэлэлцүүлгийг хийнэ. Та бүхний гаргасан найман санал мөнгөний бодлоготойгоо хэр зэрэг уялдаж байгаа вэ?**

**С.Дэмбэрэл:** - Улсын төсөв, ирэх оны мөнгөний бодлоготойгоо уялдаасай гэсэн үүднээс бид эдгээр саналыг тавьж байгаа. Болох, эсэхийг мэдэхгүй. Уг нь жил жилд Засгийн газар төсвөө хийчихээд, Монголбанкнаас албан ёсоор санал авдаг байвал зүгээр. Гэтэл авдаггүй юм билээ. Монголбанк төсвийн бүх тооцооллыг албан бусаар олж аваад түүн дээрээ дүгнэлт хийдэг. Тийм учраас ирэх оны мөнгөний бодлогын төсөлд эдийн засгийн төв байгууллагууд болох Монголбанк, Сангийн яам хоорондоо макро мэдээллээ солилцох тогтолцоог бүрдүүлэх заалт орууллаа.

Мөн Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк хамтран санхүүгийн төлөв байдлын илтгэлээ хагас жил тутамд УИХ-д тайлагнаж байх тухай шинэ заалт орууллаа. Валютын ханшийн хэлбэлзэлд юу нөлөөлж байна, төсвийн нөлөөлөл байна уу, төсвийн хөрөнгө оруулалтын зардал валютын эрэлтийг зохиомлоор нэмэгдүүлж байна уу гэх мэтээр тал бүрээс нь задлан шинжилгээ хийсэн илтгэл, тайлангаа УИХ-д ирүүлж байх урьд өмнө байгаагүй шийдлийг тусгаж өгсөн.

Үүний дагуу 2015 оны эхний улирал дуусахад Монгол Улсад мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн дагуу инфляци одоогоор ийм байна. Үүнд ийм ийм хүчин зүйл нөлөөлсөн, цаашид ингэх ёстой гэх мэтээр мэдээлнэ. Төвбанкийг Засгийн газрын нярав боллоо гэх мэтээр шүүмжилдэг. Энэ байдлаас гарахын тулд ирэх оны Мөнгөний бодлогод Төвбанкны үйл ажиллагааны бие даасан байдлыг хангах олон заалт оруулсан.

**- Ирэх оны төсвийг хугацаанд нь баталж амжих болов уу?**

**С.Дэмбэрэл:** - Амжина. Хугацаа бага байгаа тул УИХ-аар тэгсгээд л батлагдчих вий гэж санаа зовж байна. Дараа нь тодотгол хийж таарна. Улсын төсвийг харж, ажлаа төлөвлөсөн аж ахуйн нэгжүүд тодотгол хийхэд хамгийн ихээр хохирдог.



## **Намууд хоцрогдсон арга барилтай байна**

*УИХ-ын гишүүн, ИЗНН-ын дарга, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дарга С.Дэмбэрэл өнөөгийн бизнесийн орчин болоод улс төрийн сонгуульд оролцож байгаа намуудын мөрийн хөтөлбөрт энэ талаар хэрхэн туссан тухай манай порталын асуултад хариулж байна.*

- Манай өнөөгийн нөхцөлд бизнесийн орчин тааламжтай бус, эдийн засгийн өсөлт удаан, татварын дарамт ихтэй болохоор бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа явуулахад хүндрэлтэй гэдэг. Та үүнтэй санал нийлэх үү?

С.Дэмбэрэл: - Мэдээж хэрэг бизнесийн орчин төгс төгөлдөр сайхан байна гэж байхгүй шүү дээ. Хамгийн гол нь бизнесийг хэвийн явуулахад саад болж байгаа янз бүрийн зохицуулалт, хүнд сурталууд бизнест сөрөг нөлөө үзүүлдэг. Үе үеийн Засгийн газар энэ чиглэлээр сайн анхаарч ирээгүй л дээ. Ер нь өнгөрсөн хугацаанд төр эдийн засагт нэлээн оролцох хандлагатай явж ирлээ. Бизнесийн орчин нь төрийн бодлого, Засгийн газрын зохицуулалт, макро эдийн засгийн бодлогоор бий болж байдаг. Эдийн засгийн орчинг сайжруулна гээд дан Засгийн газар явдаггүй. Өнөөдөр бизнес хөрөнгө оруулалтын орчин, эдийн засгийн өсөлт, ядуурал гэх гурван ойлголтыг их холбож ярьж байна.

Бүх улс эдийн засгийн өсөлтийг хүсч байгаа. Эдийн засгийн өсөлтийг яаж бий болгох вэ гэвэл хөрөнгө оруулах бизнесийн тааламжтай орчинг бүрдүүлэх ёстой. Ингэж хөрөнгө оруулах бизнесийн тааламжтай орчинг бүрдүүлж, эдийн засгийн өсөлтийг бий болгосноор ядуурлыг бууруулна. Харин бизнесийн орчинг сайжруулахад Засгийн газар, хувийн хэвшлийн түншлэлийн механизм хэрэгтэй юм. Энэ талаар Монголд ажил хийгдэж эхлээд байна. Саяхан бизнесийн таатай орчинг бүрдүүлэх чиглэгээр “Нэг цэгийн үйлчилгээний зарчим”-д шилжих тухай Засгийн газрын тогтоол гарсан. Энэ бол Засгийн газар нь бидэнд сонгосон болоод л явдаг өнгөрсөн үеийн механизм биш, бид дуу хоолойгоо оруулж үүнийг хянаж байх хоёр талын хариуцлагыг тодорхойлж өгсөн шинэлэг механизм юм. Цаашдаа зөв хэрэгжүүлбэл бусад шилжилт хийж байгаа орнуудад үлгэр жишээ болж ч магадгүй. Саяхан болтол их хүндрэлтэй бизнесийн орчинд амьдарч ирлээ.

- Бизнесийг хүндрэлтэй байдалд оруулж буй шалтгааныг тухайн Засгийн газрын бодлоготой холбож ойлгож болох уу?

С.Дэмбэрэл: - Аль ч Засгийн газар хүнд суртлыг бий болгож байдаг. Реформын Засгийн газар ч адилхан. Тийм учраас орчин үед сайн засаглал гэж ярьдаг боллоо шүү дээ.

- Тэгвэл бизнесийн орчинг сайжруулах талаар улс төрийн намууд мөрийн хөтөлбөртөө яаж тусгасан байна?

С.Дэмбэрэл: - Би мөрийн хөтөлбөрүүдийг нь нарийвчилж уншаагүй. Ер нь ямархуу баримт бичиг гарна гэдгийг нь төсөөлж байсан. Арван хэдэн жил намуудын мөрийн хөтөлбөрийг уншсаар байгаад мэддэг болчихож. МАХН-ын мөрийн хөтөлбөрт “Татварын орчин, бизнесийн орчинг сайжруулна, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд учруулж байгаа захиргааны хүнд суртлыг хална, хувийн хэвшил, иргэний нийгэмтэй ажиллах механизмыг зүгшрүүлж өгнө” гэж тусгаж өгсөн нь сайшаалтай. “Эх орон-

Ардчилал” эвслийнх ч гэсэн “Бизнес дэх төрийн дарамтыг арилгана” гэж тусгасан байна. Намууд мөрийн хөтөлбөртөө тусгана гэдэг ард түмнээс дохио авчихсан байна гэсэн үг. Түүнээс биш тэнгэрээс шүүрч хийхгүй шүү дээ. Өөрөөр хэлбэл, манай намууд ухаан сууж байгаа хэрэг.

- Харьцуулалт хийж болох уу?

С.Дэмбэрэл: - Тэр утгагүй л дээ. Нэг нь гоё бичсэн байна, нөгөөх нь муухай бичсэн байна гэж харьцуулж болохгүй биз дээ.

- Татварыг бууруулна, бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлнэ гэсэн ерөнхий заалт л байгаа болохоос тодорхой зүйлийг заагаагүй юм шиг санагдаж байна. Сонгогчид илүү бодит зүйлийг хүсч байна?

С.Дэмбэрэл:- Монголчууд чинь ерөнхийгөөр ярьдаг хүмүүс шүү дээ. Тэгнэ ээ л гэж. Уг нь тэгнэ, ингэнэ гэхээсээ илүү яаж хийх вэ гэдэг механизмаа суулгаад өгчихвөл илүү тодорхой болох юм. Гэхдээ 145 мянган ажлын байр бий болгоно гээд тийм замаар шийднэ гэсэн зарим нэг тодорхой зүйл анзаарагдсан. Манайд хамгийн түрүүнд шийдэх том асуудал нь ажлын байр, ядуурал, эдийн засгийн өсөлт байна. Эдийн засгийн өсөлтийг бизнесүүд хангана. Яаж хийх вэ гэвэл хөрөнгө оруулалт, бизнесийн тааламжтай орчинд хийнэ.

- Татварын хувьд 100 сая төгрөгөөс доош орлоготой аж ахуйн нэгж 15 хувь, түүнээс дээш орлоготой нь 30 хувийн татвар төлж байна. Энэ нь өндөр татвартай орны тоонд багтдаг гэсэн. Татварыг бууруулна гэдэг хэр бодитой зүйл вэ?

С.Дэмбэрэл: - Өнөөдөр хүмүүс татварын нэг системтэй болох хэрэгтэй гэдэг. Энэ бол прагматик биш л дээ. Үүнийг эдийн засгийн талаас нь сайтар судалж үзэх хэрэгтэй. Наад зах нь татварын байцаагчдыг бизнест яаж найрсаг ханддаг болгох вэ, татварын байгууллагуудын үзүүлж байгаа үйлчилгээнд бизнесменүүд яаж хамтран ажиллавал үр дүнд хүрэх вэ гэдгийг бодох ёстой.

Татвараа төлдөг байя, татварынхаа тайланг авдаг байя гэсэн зарчимд шилжих цаг болсон. Татварын дээд хэмжээ 45 байсныг 35 хувь болгож бууруулсан. Мэдээж төсвөө бодолгүй яахав. Нэг талдаа төрөө үр ашигтай ажилладаг болгох (хүнд сурталгүй байх, илүү дутуу орон тоог халах, төрийн үйлчилгээг найрсаг болгох гэх мэт), нөгөө талдаа эдийн засгийн өсөлтийг татвараар яаж урамшуулах вэ гэдэг асуудал байна. Ядуу хүмүүс их байна. Ногоо тарих юм уу, жижиг худалдаа эрхлэхээр дээрээс нь дүрэм журам гэдэг лантуугаар толгой руу нь цохичихдог. Нөгөө хүнд чинь буцаад ядуурал руугаа орох, эсвэл энэ бүхнийг давж гарах гэсэн хоёр л зам байна. Үүнээс харахад ямар бодлого баримтлах вэ гэдэг нь ойлгомжтой байгаа биз дээ. Ядуурлаас гарахын тулд жижиг бизнесээ дэмжиж, жижиг бизнест эрх чөлөө өгье.

- Зарчмын асуудлууд мөрийн хөтөлбөрт туссан нь биелэгдэж хэрэгжих боломжтой болж байна гэсэн үг үү?

С.Дэмбэрэл: - Мөрийн хөтөлбөрийг би сайхан завшаан гэж боддог. Ялсан нам нь мөрийн хөтөлбөр дээрээ суурилж Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх болно. Хэрэгжүүлэхгүй бол худлаа ярьсан болно. Худал хэлсэн бол дөрвөн жилийн дараа сонгогчид өөр талд нь саналаа өгнө. Ард түмэн сурч байна. Харин намууд бие биеэ муулдаг,

ерөнхий зорилт тавьдаг, худлаа хэлдэг, боломжгүй зүйлийг амладаг хоцрогдсон арга барилтай байна. Бид намуудад ямар нэг санал өгөөгүй. Зарим холбоо ийм зүйлийг тусгачих, тэгвэл бид дэмжье гэж хандаж байна. МХАУТанхимд тийм эрх байхгүй. Мянгаад хүний саналыг би мэдэхгүй. Хэн нэгнийг дэмжинэ гэдэг тэдний улс төрийн сонголтын асуудал. Харин сонгуулийн дараа Засгийн газар бий болж мөрийн хөтөлбөрөө гаргах үед нь бид зөвлөмж өгнө. Ингэвэл эдийн засгийн өсөлт бий болно, хувийн хэвшил хөгжинө, ядуурал багасна гэсэн тодорхой зүйлийг тусгаж өгнө.

## **ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМ-аас улс орны улс төр, эдийн засаг, нийгмийн байдалд өгөх үнэлгээ, дүгнэлт**

Иргэний Зориг Ногоон Намын Улс төрийн Зөвлөл, Үндэсний Хороо 2014 оны 10 дугаар сарын 25-ны өдөр хуралдаж доорхи үнэлгээ, дүгнэлтийг хийж байна. Үүнд:

### **1. Улс төрийн хүрээнд:**

1.1. Улс төрийн хүрээнд өнөөдөр үүсээд буй ээдрээтэй хүнд хэцүү нөхцөл байдал нь цаашдаа монгол улсын үндэсний аюулгүй байдалд заналхийлэл учруулах байдалд хүргэж болзошгүй байна. Ард түмний нийтлэг эрх ашгийг хамгийн түрүүнд бодох ёстой улс төрийн намууд энэ эрхэм үүргээ огоорон нам хоорондын, фракц хоорондын, нам дамжсан бүлэглэл хоорондын эрх мэдлийн төлөө далд хуйвалдаан, тэмцлийн хэлбэрт орж буйг эдгээр улс төрийн намуудын буруу төлөвшил, гаж хөгжлийн үр дүн, үр дагавар гэж олон нийт, ард иргэд жигшин ярьцгааж байна.

1.2. Хүний эрх, эрх чөлөөг ноцтойгоор зөрчих, үндсэн хуульд тунхагласан энэхүү язгуур эрх, эрх чөлөөг үл хүндэтгэж, ямар ч хуулийн заалтаас хамгийн дээр тавигдах учиртай энэ үзэл санааг үл тоомсорлох, үндсэн хууль, бусад хууль, монгол улсын энэ чиглэлээр нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн үг, үсэг, үзэл санаа илт зөрчигдсөөр байхад төрийн эрх барих, хууль тогтоох эрх мэдлийг Үндсэн хуулийн дагуу өөртөө хадгалдаг УИХ, түүнийг бүрдүүлж буй улс төрийн гол намууд энэ ноцтой нөхцөл байдалд нэгдсэн анхаарал, нэгдмэл байр сууриа илэрхийлэхгүй байгаа нь Монгол улсад хуулийн засаглал гажуудах нөхцөл байдал үүссэнийг харуулж байна.

1.3. Энэ бүхний жам ёсны үр дагавар болж, монгол улсад засаглалын хямрал бодитойгоор нүүрлэх нөхцөл байдал үүслээ. Энэ бол засгийн эрхийг хэн барьж буйгаас үл хамааран монгол төр, түүнийг бүрдүүлж буй субъектуудын өмнө ижил тэгшээр тавигдаж буй томоохон сорилт мөн. Энэхүү сорилтыг хэрхэн яаж даван туулах, ямар хариу үйлдэл хийж засаглалын хямралыг зогсоож чадах эсэх нь Монгол улсын нэр хүнд, олон улсын харилцааны хэр зэрэг найдвартай, тогтвортой түнш байх сэхийг харуулах төдийгүй, монгол төрийн дархлаа хир хүчтэй байгаагийн шалгуур болох болно. Монгол улс глобал ертөнцийн нэг хэсэг болохоос бус, дотоодын хэрүүл тэмцэлдээ улайрсан тусгаарлагдсан арал бишээ.

## **2. Эдийн засгийн хүрээнд:**

2.1. Эдийн засгийн хямралт байдлын шинж тэмдгүүд макро эдийн засгийн хүрээнд тэр бүр ил тод харагдахгүй, гайгүй байгаа мэт буруу төсөөлөл үүсгэж буй ч эдийн засгийн системийн өөрийгөө нөхөн тэжээж явдаг гинжин хэлхээ, түүний дархлаа суларч, энэ нь цаашид даамжирахаар байдалд байна. Эдийн засаглалын үр ашиггүй илүүдэл нь данхар засаглалын бүтцийг бий болгож, энэ нь улс төрийн эрүүл бус өрсөлдөөнөөр өдөөгдөн даамжирч, системийн шинжтэй хямрал болох, улс орны эдийн засгийн дархлаа эрс сулрах, улс орон бүхэлдээ эдийн засаг, улс төрийн дефолт болох аюул заналыг үгүйсгэж болохгүй.

2.2. Ардчилсан тогтолцоо үүссэн цагаас хойш ажилласан бүх Засгийн газар, УИХ-ууд монголын ард түмний нийтлэг хүсэн хүлээж суудаг амьжиргаагаа тогтвортой дээшлүүлэх, үнийн өсөлтийн дарамтгүй орчинд амьдрах горьдлого, найдварыг нь биелүүлж чадаагүй. Тийм учраас, "бидний үед инфляци гайгүй байсан, та нарын үед ингэчихлээ" гэх мэтийн улс төрийн мэтгэлцээн, хэрүүлээс ард иргэд залхаж байна. Ард иргэдэд тэдний амьжиргаа, худалдан авах чадварт нь сөргөөр нөлөөлдөггүй зах зээлийн үнийн түвшин, амьдрал ахуйд нь хүрэлцэх хэмжээний цалин, тэтгэвэр, ажил амьдралаа дээшлүүлэх, аж ахуй бизнесээ өсгөж томруулах хүсэл эрмэлзлийг нь дэмждэг, хүчин чармайлтад нь дэм болдог тийм улс төр, эдийн засаг хэрэгтэй байна.

## **3. Нийгмийн хүрээнд:**

3.1. Улс төрийн эрүүл бус өрсөлдөөний уршгаар бий болсон, хүний дотоод хүч нөөц, авьяас чадварыг дэмжих бус, хүмүүсийг тэжээврийн сэтгэхүй, авир төрх лүү өөрийн эрхгүй түлхэж байдаг хавтгайрсан халамжийн нийгмийн бодлогоос татгалзаж чадсан хэдий ч, улам бүр ангал зай нь нэмэгдэж буй орлогын тэгш бус байдал, архагшсан ядуурлыг бодитой бөгөөд үр дүнтэй шийдвэрлэх чадвартай нийгмийн бодлого гарч ирээгүй, монгол улс хүний хөгжлийн олон талт олон хүчин зүйлт бодлогоо иж бүрэн тодорхойлоогүй, "хагас хавтгайрсан" нийгмийн бодлого, үйл ажиллагаа бүхий улс байсаар л байна.

3.2. Монгол хүний эрүүл мэнд доройтож, хүний хөгжлийг иж бүрэн хангах ёстой орчин тааруу, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах баталгаажсан эрх нь хэрэгжихгүй, шалдар булдар нийгмийн орчин, үүнийг өөрчлөх шийдэл болж чадахгүй атлаа эсрэгээр нийгмийг уруудуулах ороо бусгаа улс төр одоо цагт огт хэрэггүй байна. Монголчуудыг манлайлж явах ёстой улс төрчид, улс төрийн намууд бие биенээ унагаж бус, улс орноо өөд татах, урагшлуулах, арагшаа харж бус урагшаа зүтгэх, Монгол хэмээх нийтийн гэр орноо хамт төвхнүүлэх цаг болсон байна. Чухамдаа энэ бол монголчууд бидний хүсэн мөрөөддөг сайн цаг бөгөөд богино зайн улс төрийн тоглолтууд нь зөвхөн цөвүүн цагийн шийдэл гэдгийг ухаарч сэхээрэх нь энэ сайн цаг ирэхийн эхний шалгуур байх болно.

Сайн цаг ирэх болтугай.

*Иргэний Зориг Ногоон Намын Үндэсний хороо.  
Улаанбаатар хот. 2014 оны 10 дугаар сарын 25.*

## **ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМЫН МЭДЭГДЭЛ**

Иргэний зориг ногоон нам Улс төрийн зөвлөл, Үндэсний хорооны хурлаа хуралдуулж, Шинэчлэлийн засгийн газарт орж ажилласан хоёр жилийн хугацаанд гаргасан амжилт, төлөвлөсөн ажлууд болон өнөөгийн улс төр, эдийн засгийн байдалд дүгнэлт хийлээ.

Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд бид хийсэн ажлаа дүгнэж, УИХ дахь намын төлөөлөл идэвхи, санаачлагатай ажиллаж байгааг, Шинэчлэлийн засгийн газрын үндсэн чиг үүргийн яам болох Байгаль орчин, ногоон хөгжлийн яамыг удирдаж, багагүй ажил амжуулж, цөөнгүй ажлыг санаачлан эхлүүлснийг онцлон тэмдэглэв.

Өнөөгийн улс төрийн болон эдийн засгийн нөхцөлд, нэг талаас төрийн тогтвортой байдал, ард түмний ашиг сонирхлыг дээдэлж, нөгөө талаас эрх баригч, сөрөг хүчин гэж хуваагдах, бүлэг фракцаараа талцан, эрх мэдлийн төлөө тэмцлийг өрнүүлэхийн оронд өнөөгийн байдалд бодит дүгнэлт хийж хамтдаа хямралаас гарах ухаалаг алхмуудыг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Монгол улсад өнөөдөр бий болсон улс төр, эдийн засгийн хямрал нь улс орны эрх ашгаас илүү намын болон нам дамнасан бүлгэмүүдийн сонирхолд хөтлөгдөж ирсэн гаж тогтолцооноос үүдэлтэй бөгөөд ардчилсан хувьсгал ялснаас хойшхи 20 гаруй жилийн түүхэнд засгийн газрыг хугацаанаас нь өмнө удаа дараа огцруулахад нам, улс төрчид хожиж, ард түмэн хохирч, ядарч, туйлдаж ирсэн гашуун сургамж байсныг улс төрчид болон улс төрийн намууд мартаж өсгүй.

Манай нам 2000 онд үүсэн байгуулагдсанаас хойш улс орны тогтвортой хөгжлийг хангах, иргэний оролцоотой ардчилалыг бэхжүүлэхийн төлөө тууштай ажиллаж ирсэн билээ. Тиймдээ ч улс орны эдийн засаг хүндэрсэн хэцүү цаг үед төрийг тогтворгүй байдалд оруулах үйлдлүүдийг зохисгүй гэж үзэж байна. Манай нам 2012 оны 07 сарын 19-ны өдрийн Ардчилсан нам, МАХН-МҮАН-ын “Шудрага ёс” эвсэл, Иргэний зориг ногоон намын “Хамтарсан засгийн газар байгуулан ажиллах гэрээ”-ндээ тууштай байж, Шинэчлэлийн засгийн газрын үйл ажиллагааг эрчимжүүлж, тогтвортой ажиллахад улам их хувь нэмэр оруулж ажиллахаар шийдлээ.

Үүнтэй уялдуулан, 2012 оны сонгуулиар Иргэний зориг ногоон намын жагсаалтаар УИХ-д сонгогдсон С.Дэмбэрэл, С.Оюун нарт Шинэчлэлийн засгийн газрын тогтвортой ажиллагааг бүх талаар дэмжин ажиллахыг үүрэг болголоо.

**ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМ**

*Улаанбаатар хот. 2014 оны 10 дугаар сарын 25*



## **Инфиляцыг онилох бодлого чинь валютын ханшаар тодорхойлогдох гээд байна!**

*2014 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Үдийн засгийн байнгын хорооны ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлээс:*

**УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл:** Гишүүдээс янз янзын санал бодол хэлж байна. Би бас хэдэн асуулт асууя. Нэгдүгээрт: Сангийн дэд сайд С.Пүрэв сайдаас асууя. Засгийн газар дотоод бонд /үнэт цаас / гаргах гэж байна уу? Санхүүгийн зохицуулах хороо үүнийг мэдэж байгаа юу? Хөрөнгийн биржийг идэвхжүүлэх зорилготой гаргаж байгаа юу? Энэ талаар гишүүдэд мэдээлэл өгөх үү.

**Сангийн дэд сайд С.Пүрэв:** Бид нар эрхийнхээ хүрээнд энэ жилдээ гаргах дотоод бонд 1.4 их наядын эрхтэй байгаа. Оны сүүлээр бид 1 их наядаас илүү гаргаж чадахгүй байгаа. Тэр хавьцаа төлөвлөж байгаа. Бид нар байнга бондоо анзаарч байгаа. Санхүүгийн зохицуулах хороо мэдэж байгаа.

**Г.Баярсайхан:** Манайх сая засгийн газрын үнэт цаасыг хөрөнгийн биржээр арилжаалах журмаа гаргасан. Уг нь хөрөнгийн биржээр арилжих журмыг байнга тавьж байсан. Одоо бол банкууд бутлок болчихсон. Өөрийн эрхгүй хөрөнгийн бирж рүү орж байна. Гадны хөрөнгө оруулалтын сангууд авья гэдэг. Гэхдээ банкаар дамжуулахгүйгээр, шууд авахыг хүсдэг. Одоо бол зөв алхам руугаа орж байна гэж ойлгож байгаа. Яах аргагүй хөрөнгө оруулалтын сангийн хуулийн дагуу одоо манайхаас хөрөнгө оруулалтын менежментийн 2 компани зөвшөөрөл авсан. Мөн хөрөнгө оруулалтын сангаа байгуулах зөвшөөрлийг 2 газар авчихаад байж байна. Сая МИК ХХК-ны / Монголын ипотекийн корпорац / 328.5 тэрбумын үнэт цаас гаргах үйл ажиллагааг шийдсэн. 8 % зээлээр Худалдаа хөгжлийн банк, Голомт банкуудад **кастон** банкны үйлчилгээг явуулах зөвшөөрөл олгосон. Банкууд, даатгалын зуучлалын үйл ажиллагааны зөвшөөрөл их авч байна. Банк бусууд маш ихээр байгуулагдаж байна. /400 тэрбумаар/ Банк бусууд Худалдаа Хөгжлийн банкаар дамжиж банк хоорондын зах руу орохоор гэрээ хэлцэл хийгдлээ. Энэ чиглэлээр Монголбанктай их хамтарч ажиллаж байна. “Монголын хөрөнгийн бирж”-ын зах зээлийн өнөөгийн байдал нь дараах байдалтай байгаа. Монголын хөрөнгийн бирж /МХБ/ Лондонгийн хөрөнгийн биржтэй /ЛХБ/ дахин гэрээгээ сунгасан байгаа. Манайхаас хамгийн том гол нь Монголын хөрөнгийн зах зээлд бүтээгдэхүүн нийлүүлэх үлдлээ. Хувьцаат компаниудад /идэвхгүй болсон/ хяналт, шалгалт хийгдэж байгаа. Одоо хувьчлалын үед байсан 400 компаниудаас 200 компанийн арилжааг зогсоосон байгаа. Одоо 100 гаруй идэвхтэй компани үйл ажиллагаагаа явуулж байна. Хамгийн гол нь төрийн өмчит компаниудыг задлахгүй байна. Нийт төлбөр тооцооны төвд дээр хадгалагдаж байгаа хувьцааны 85 хувь нь төрийн өмчийн хувьцаа байна. Ерөөсөө үүнийг л хийх ёстой. Бид нар компаниудыг та нар хөрөнгийн бирж дээр гараад ирээчээ гэхээр “Лондонгийн хөрөнгийн бирж”-ын шаардлага жаахан хатуу байна.

**Хоёрдугаарт:** Цэнхэр номны 34-р хуудас гэж хэлээд байгаа. Сая Ч.Хүрэлбаатар гишүүн “exchange control” тавь гэлээ. Түрүүн та нар,

хэрэв төв банкны хуулиар заагдсан 3 зүйл /бие даасан, хараат бус байдал/ капиталын контрол /exchange control / тавьбал, танай төв банкны бие даасан байдал /аль нэг 3 зүйл / алдагдана. Эсвэл ханш маань өөр дэглэм рүү орно гэсэн үг. Энэ бол бидний аргагүйдсэн байдлаар хэлж байгаа юм. Хуулиар тийм боломж байхгүй. Хууль чинь сайндаа биш, дутуу учраас тийм боломж байхгүй. Тийм учраас хууль зүйн талаас нь / Мөнгөний бодлогын аспектиуд / дараагийн долоо хоног н.Эрдэнэбаяраа танай хэлтэс энэ талаас нь бэлдэж, ирээрэй. Нэг ийм санал байна. Сая УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан гишүүн, Ч.Хүрэлбаатар гишүүн, М.Зоригт гишүүн “үнэ тогтворжуулах” хөтөлбөрийн талаар асуулаа.Танайх миний бодлоор аажмаар холдож байна. “Owner ship”-ээ засгийн газарт үлдээгээд, танайх өөрөө гараад явж байгаа ийм бодлого 2015 онд хэрэгжих нь гэж ойлгож болох уу?

Гэтэл энэ хувиа бодсон үйлдэл. Засаг танайтай танайгүй үнэ тогтворжуулах хөтөлбөр хэрэгжүүлээд эхлэхэд ноднингийн туршлагаас харахад нийтэд нь хангах биш, орчныг нь сайжруулж өгөх хэрэгтэй байсан. Нэг өгүүлбэр нэг үг мөртлөө, цаанаа бодлогын чиглэлүүд байсан. Үүнийг гишүүд асууна. УИХ дээр илүү их асууна. Бидний хэсэг нөхөд ярилцаж байгаад / А.Бакей, Н.Золжаргал/ инфляцыг ониллоо, 2013 хойш үзэхэд дунд хугацаа өнгөрсөн байна. /Тэр үед дунд хугацаа гэж ярьж байсан. Ирээдүй цагаар бас дунд хугацаа гэж ярина./ Дунд хугацааны бодлогоо 7-8 хувьд байлгахад, оны сүүлд 10 % болох юм байна гэж урьдчилж харсан. Тэгэхээр инфляцыг онилох бодлого маань эцсийн дүндээ УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатарын хэлсэнчилэн валютын ханшаар тодорхойлогдох гэж байна. УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар чөлөөтэй 50 гэсэн байгаа. Нөгөө талдаа ашигтай. Танайх, хуулиар ганцхан зарчим оруулаад ирсэн байна. Энэ яг 2015 онд ажиллах уу, үгүй юу гэдэг асуудал байгаа. /инфляцыг 1 оронтой тоонд барих/ Хэрэглээний үнийн индексийг улсын дундаж сагсаар үзэж байна. Гэтэл Баян-Өлгий аймагт өөр байна. Монгол банкны ерөнхийлөгч Н.Золжаргалд хэлсэн. Төв банкны салбарууд руу, судалгааны залуучуудаа явуулаад аймаг бүрийн нийлүүлэлтийн гаралтай инфляц ямар байна судлаад үзээч гэж. Бодит амьдрал дээр Баян-өлгий, Увс аймаг инфляцын /хүнсний, бензин/ үнийн эффектүүд өөр өөр байна. Ийм өөр байхад үнийн тогтвортой байдлыг хангах төв банкны үндсэн зорилгоо “CPI”-н дундажаар хэрэгжүүлэх гээд оролдоод байгаа нь өөрөө инфляцыг орон, бүс нутгийн хэмжээнд өөр хүчин зүйлүүдтэй болгож байна. Та нар бол 40 байсаныг 5 болгосон гэж бичиж байгаа. Энэ чинь аймгуудаар өөр байна.Тийм учраас энэ талаас нь арай бүтээлч, бодит амьдралтай хандаарай гэсэн зүйлийг Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргалд хэлсэн. Үүнийг бид нар ярилцаж, байгаад гаргаад ирсэн. Энэ бол их бодитой зүйл шүү. Танай салбарын хүмүүсийг ажилтай болгоод , залуучууд бодит амьдрал дээр гараад тиймэрхүү зүйл хийчүүл их өөр шүү. Одоо энэ мөнгөний бодлого гаргахад ч, цаашид ч, хэлж байгаа юм. Энэ их хөөрхөн үр дүн гарна шүү. Одоо бол аймгуудаар статистик гаргаж байгаа. Тэрний нийлүүлэлтийн гаралтай инфляц, хүнсний гаралтай инфляц, бензины үнийн нөлөөлөл, оюутаны төлбөр дээр нь мөн, Чимэддагва гээд эдийн засагч залуу байдаг. \макро эдийн засагч\ Тэрний багийнханы хийсэн инфляын судалгаа гээд 2014 оны зузаан ном байгаа. Үүнд төрөөс үнийг тогтворжуулах гэдэг энэ бүх бүтээгдэхүүнүүд дээр судалгаа хийгээд 18 бүтээгдэхүүн жагсаасан байгаа. Энэ маань өөрөө танай мөнгөний бодлогын үндсэн зорилтыг хангахад, нилээн сайн материал байгаа шүү. Тэрнийг үзээд үнэлэлт, дүгнэлтээ дараагийн долоо хоногт өгчихөөрэй.

Дэлгэрсайханд тусгайлан юм хэлье. 34 хуудас дээр одоо байгаа хууль дээрээ хоёр өгүүлбэр нэмээд УИХ-аар батлуулана гэж байхгүй шүү! Зүгээр л практик талаас нь бодоод, яаж энэ 2015 оны үндсэн зорилтыг хангахад, таны бодлого бол туслах, хоёрдогч арга хэрэгсэл болдгын хувьд эерэг эффект үзүүлэх арга хэрэгслээ сайн бодож, хүмүүсээ ажлуулж, дараагийн долоо хоногт их тодорхой юм ярих хэрэгтэй байна. Ингэвэл Ч.Хүрэлбаатра гишүүний яриад байгаа капиталын контрол /exchange control / байх уу, үгүй юу? Эсвэл өөр бусад, та нарын хэлж байгаагаар чөлөөтэй тавьчуул риск нь юу байхын, энэ мэт бүх зүйлийг УИХ-ын гишүүд, бид нар мэдмээр байна. Энэ талаасаа та нар сайн бэлдэж, ирээрэй. Бид нар бол УИХ гишүүд. Гэхдээ энд бол бид нар бүтээлч уур амьсгалаар, мөнгөний бодлогыг төсвийн бодлоготой нь уялдуулаад ингээд нэг олигтойхон батल्या гэсэн чин эрмэлзэл бидэнд байна. Бүх гишүүдийн ярьж байгаа зөв. Бид нар үнэхээр хариуцлагүй байна. Та нар уялдуулах тал дээр, төсөв мөнгөний бодлого, хамгийн энгийнээр хэлэхэд бичсэн зүйлүүд чинь мухар, ерөнхий байгаад байгаа шүү. Тийм учраас тас тас хийсэн ийм юмнууд гаргаад ирэхэд, УИХ-ын тогтоол чинь сайжирна, мөнгөний бодлогын чиглэл чинь сайжирна, иймэрхүү юм гаргаж, тэрнийгээ УИХ дээр тайлбарлах үүрэгтэйгээр УИХ-ын гишүүд сууж байна. За ингээд миний хэлэх зүйл энэ байна даа.

## **Хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх тал дээр Монгол улс, УИХ юу хийж байгаа юм вэ?**

*2014 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс: Төсөв дагаж өргөн баригдсан хуулиуд, төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журамын тухай хуулийн зарим зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төсөл болон Монгол улсын 2015 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай, Хүний хөгжил сангаас Монгол улсын иргэнд 2015 онд хүртээх хишиг хувийн хэмжээг тогтоох тухай УИХ тогтоолын төсөл хэлэлцэх эсэх цээр*

**С.Дэмбэрэл:** Энэ хуультай холбогдуулаад хэд хэдэн асуулт байна.

**Нэгдүгээрт:** Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар Ц.Даваасүрэн даргаас асууя. Төсвийн байнгын хороо 19 гишүүнтэй. Бодвол, төсвөө хэлэлцээд олонхын саналаар шийдсэн юм шиг байна. Энэ нэг концепц оруулж иржээ. Энэ Концепцийг тал талаас нь ярилцаж байж буцааж байгаа юу? Өөрөөр хэлбэл, энэ 76 хүнээр хэлэлцүүлэх шаардлагагүй гэж үзэж байгаа юм уу? Миний бодлоор концепцыг маш сайн ойлгоод, тал бүрээс нь ярилцсан зүйл протокол дээр чинь харагдахгүй байна. Тийм учраас тодруулж асууж байна.

*Хоёрдугаарт:* Боловсролын тухай хуулийн талаар УИХ-ын гишүүн Л.Гантөмөр сайдаас нэг асуулт асуумаар байна. Боловсролын хуульд бас нэг концепц оруулж ирсэн. Үндсэн хуульд заасан “суурь боловсролыг үнэ төлбөргүй олгоно” гэсэн заалт бий. Гэхдээ төрийн болон хувийн гэж ялгаагүй байгаа. Үүнийг сургалтын төлбөртэй боловсролын асуудлын сургалтын төлбөрийг багасгах, ихэсгэхгүй байх хөшүүрэг болгож ашиглах гэсэн концепц чинь хэр зэрэг зөв юм бэ?

*Гуравдугаарт:* Ерөнхий сайд Н.Алтанхуягаас асууя. Бүсчилсэн хөгжил гэдэг нэг инээдтэй юм байна. Монгол улс чинь бүсчилэн хөгжих гээд чадахгүй яваад байгаа. Хэдхэн орон тоо болон нэг жаахан төсөвтэй. Үүнийг хасах гэхээсээ илүү, энэ Засгийн газар /аймгууд, ялангуяа Улаанбаатар хот маань эдийн засгийн 50% /хувь/-ийг бүрдүүлж байгаа/ энэ данхар бүтцийг багасгах явдал нь энэ төсөвт хамгийн их чухал ач холбогдолтой. 2015 оны чинь байдал хэцүүднэ шүү. 2015 оны орлого чинь хүрэлцэхгүй, яагаад гэвэл орлогын чинь бүрдэлт хангагдаж чадахгүй. Зарлага дээр чинь, төв төсвийн хэцүү байдлын мэдрэмж тодорхой хэмжээгээр урсгал зардал дээр чинь тусах учиртай. Хөрөнгө оруулалт дээр чинь энэ байхгүй байгаа. Гэхдээ энэ чинь орон нутаг дээр адилхан мэдрэгдэх ёстой. Хариуцлага нь мэдрэгдэх ёстой. Хэмнэлтийг хийнэ гэсэн горим мэдрэгдэх ёстой. Өөрөөр хэлбэл, ийм тэнцүү харьцаа, иймэрхүү нэвчсэн харьцаа явахгүй байгаа тохиодолд зүгээр нэг бүсчилсэн хөгжлийг хасаад ямар ч нэмэргүй. Харин ч эсрэгээрээ бүсчилсэн хөгжлийг хангахад, орон нутгийн хөгжлийн бие даасан байдал гэсэн утгаар нь, энэ талаас нь оруулж ирэх ёстой байсан юм биш үү!

*Дөрөвдүгээрт:* Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай 4-р хуулин дээр Я.Санжмятав сайдаас асуулт байна. Энэ хүүхдүүдэд ажилчин, барилгачин больё гэснийх нь төлөө /Л.Гантөмөр сайдын нэвтрүүлэх гээд байгаа тэтгэлэгийн хэлбэрээс хөшүүргийн хэлбэр лүү оруулах/ ямар юм энд тусгагдсан юм бэ?

*Тавдугаарт:* Сангийн яамнаас асууя. Цагдаагийн албаны тухай 5-р хууль дээр, бэлэн мөнгөөр өгч байхад юу нь болохгүй байсан юм бэ? Яагаад өөрчлөв? Хувь хүнд нь, цагдаад нь өгч байсан бэлэн мөнгө юу нь болохгүй байна вэ? Яагаад ингэж оруулж ирсэн юм бэ?

*Зурдугаарт:* Ц.Даваасүрэн даргаас асууя. Зорилтот хөрөнгө оруулалтын тухай асуумаар байна. Хөрөнгө оруулалт маань бүхлээрээ, бүтнээрээ, түүний дотор бид нарын, УИХ-ын гишүүдийн “жинтэй хувь нэмэр”-ийн улмаас Монгол улсын хувьд дүүрэн үр ашиггүй байдалд байгаа. Үүнийг бид өмөөрөөд, “Энэ болж байна.” Гэж зүтгээд, үүнийгээ хамгаалахын тулд “орон нутагт ачаалал үүрүүлээ, өөрөөсөө ажил зугтаалгалаа” гэсэн аргумент хэлээд сууж байх ёстой юм уу? Ерөөсөө хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх тал дээр УИХ юу хийж байгаа юм бэ? Хөрөнгө оруулалтын үр ашгийг яаж дээшлүүлэх талаар, төсвийг яаж хэлэлцэх юм бэ? Хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх тал дээр төсвийн байнгын хорооны 19 хүнээс /19-үүлээ байлаа ч/ энэ тал дээр жилийн жилд юм сонссонгүй явж ирлээ. Тийм учраас төсөв, эдийн засгийн байнгын хороо хамтарч хэлэлцдэг шинэ механизм руу орж болохгүй юу?

*Долдугаарт:* Ерөнхий сайд Н.Алтанхуягаас асууя. Хүний хөгжил сангийн бүх мөнгийг тэр чигээр нь үргэлжлүүлэн өгөх юм байна. Сайн байна. Сайхан байна. Хүүхдүүдэд хайртай юм байна. Гэхдээ, Монгол улсын эдийн засаг хүндрэлтэй байна. Зөвхөн зорилтот бүлгүүддээ л олгож болохгүй юм уу? 50 хувьд нь л өгье. 265 тэрбум төгрөг байвал 130 тэрбумыг нь өгье л дөө. Ийм байдлаар хийж болохгүй юу?

**Ц.Даваасүрэн:** С.Дэмбэрэл гишүүний асуултанд хариулья. Эхний асуудал болохоор шинэчлэлийн концепц яригдсан юм биш үү, энэ талаар та нар яагаад ярихгүй буцаасан юм бэ гэж байна. Энэ яригдсан. УИХ-ын гишүүн С.Баярцогт “Энд том реформын шинж чанартай асуудал хөндөгдөж байна. Энэ асуудал хуучин удирдах санхүүжилтын хурлаар шийдэгдэж байсан асуудал. Бодлогын, энэ реформын шинж чанартай асуудлаа шийдээгүй байж, төсвийн тухай хуулиар оруулж ирж, ингэж асуудлыг шийдэх боломжгүй зүйл юм” гэж тайлбар хийсэн. УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбат орон нутагт төрийн сангийн дарга, аймгийн засаг дарга гээд санхүүгийн чиглэлээр ажилаж байсан хүнийхээ хувьд мөн ийм саналыг хэлээд байгаа юм. “2003 он хүртэл энэ концепцоор явж байсан. Ингэж санхүүжилтийг өгдөг байсан. Орон нутаг руу шилжүүлдэг, орон нутаг нь сургууль, соёлын төв, цэцэрлэгээ мэддэг. Ямар асуудал үүссэн бэ гэхээр хамгийн том төсөв нь сургууль, цэцэрлэг, эмнэлгийн төсөв байдаг. Дарга нар нь тэр мөнгөнөөсөө “цохичихдог” байсан. Тийм асуудал гардаг байсан учраас, /хэмнэлтийн мөнгө төгрөг нь буруу тийшээ зарцуулагддаг байсан учраас/ удирдлага санхүүжилтын хуулинд гарсан өөрчлөлтийг эрүүл мэндийн салбар, боловсролын яамныхан алгаа ташин дэмждэг. Яагаад гэвэл, “бидний хэмнэгдсэн мөнгө бидэнд үлддэг боллоо” гэх ийм зүйлийг ярьдаг. Тийм учраас, ийм шинэчлэлийн асуудлыг бид ярьж байгаад шийдэх ёстой байсан болов уу гэж би бодож байна. Тийм учраас Байнгын хорооны гишүүд реформын асуудлыг “цаг үетэйгээ тохирох ёстой, сайн ярилцах ёстой.” гээд больсон.

Хөрөнгө оруулалтын үр ашгийн тухайд бол, энд ч ярьвал их зүйл байгаа юм л даа. Ер нь эдийн засгийн байнгын хороогоор яригдана. Эдийн засгийн байнгын хороо санал дүгнэлтээ манайд ирүүлнэ. Тэр санал дүгнэлтийг нь манай дээр ярина. Төсөв чинь бүх байнгын хороогоор хэлэлцэгддэг. Тэр тусмаа эдийн засгийн байнгын хороон дээр хөрөнгө оруулалтын шинж чанартай асуудлууд яригдаад манайд дүгнэлтээ ирүүлнэ. Тэрний дагуу бид хэлэлцэнэ. Үүнд бид нэг зүйлийг үр ашиг талаас нь анхаарах хэрэгтэй цаг болсон. Ер нь энэ хөрөнгө оруулалтаа яах юм бэ? Өнөөдөр улсын төсвөөс санхүүжээд, дуусаагүй байгаа 500 гаруй объект болчихоод байна. Цаана нь концессоор хэдийг өгөх вэ гэдгээ ерөөсөө ярихгүй байгаа. Концессоор бас баахан ажил хийлгэсэн. Тэгээд хувийн хэвшлийнхэнээр, “улсын төсвөөс санхүүжүүлнэ” гээд баахан ажил хийлгэсэн, “концессоор эхлүүллээ” гээд бас баахан ажил эхлүүлчихсэн мөртлөө мөнгийг нь ерөнхийдөө өгөөгүй байгаа. Эд нар чинь банкнаас зээл аваад хийчихсэн. Ялангуяа, концессоор бол, бүгд тийм байгаа. Эхний хагас жилийн тайлан балансаар банкны найдваргүй зээлийн үлдэгдэл яагаад 3 дахин өссөн юм бэ гэдэг чинь үүнтэй л холбоотой шүү дээ. Төсөв цаг хугацааны хувьд их богино боллоо. Тийм учраас УИХ-аас ярих ёстой. Концессоор ямар өр тавчихаад байгаа юм бэ, улсын төсвөөс ямар өр өгөх хэрэгтэй байгааг, үүнийгээ хувийн хэвшлийн компаниудад өгөх юм уу, өгөхгүй юм уу гэдгийг шийдэх ёстой. Жишээлбэл, орон нутгийн хэмжээнд хувийн хэвшлийн гүйцэтгэл бол өчүүхэн хэсэг нь болно. Энэ нь нийт баригдсан барилгуудын 5 хувьд нь ч хүрэхгүй. Энэ асуудлыг шийдэх цаг болсон. Үүнийг ярихгүй үлдээж болохгүй гэж бид ярьсан. Цаашдаа бид хөрөнгө оруулалтын 3 жилийн, дунд хугацааны хөтөлбөрөө батладаг, хуулинд байгаа заалтуудаа хэрэгжүүлээд, үр ашгийг нь тооцдог, иргэдээрээ хэлэлцүүлгэ хийлгээд, жагсаалтаа батлаад явдаг болох ёстой. Хууль өөрөө тийм. Харамсалтай нь, өнөөдрийг хүртэл 3 жилийн дунд хугацааны төдлөвлөлтөө хийж чадаагүй байхад, эдийн



засгийн яам маань байхгүй болчихлоо. Үр ашигтай байя гэвэл, эхлээд эдийн засгийн дунд хугацааны төлөвлөлтөө хийдэг болох хэрэгтэй. Үүнийг шийдвэл нэг алхам болж чадна.

**Л.Гантөмөр сайд:** Суурь боловсролыг үнэ төлбөргүйгээр Монгол хүүхэд бүр эзэмших эрхтэй гэдэг Үндсэн хуулийн заалт зөрчигдөх үү гэсэн ийм асуулт байгаа. Би болоод хууль боловсруулж байгаа хүмүүс зөрчигдөхгүй гэж харж байгаа. Яагаад гэвэл угаасаа төлбөртэй сургуульд сурч байгаа хүүхдүүд үнэ төлбөргүй сурахгүй байгаа. Төлбөр төлж байгаа. Засгийн газар болоод төр яаж байна гэхээр ямар нэг байдлаар урсгал зардалд дэмжлэг үзүүлж байгаа. Урсгал зардлаас гадна, төрийн өмчид үнэгүй сургуулиудад багш нарын цалин хөлс гээд өөр илүү урсгал зардал угаасаа өгч байгаа. Угаасаа нөгөө талд нь зардал нь илүү байгаа. Би бол сургалтын төлбөр асар ихээр нэмэгдэхгүй байх гэж бодож, хөшүүргэд горьдлого тээж байгаа. Ер нь бол ийм хөшүүргүүдийг хийгээд явах нь зөв гэж бодож байгаа.

**Я.Санжмятав сайд:** Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцдаг оюутнуудын тэтгэлгийг хөдөлмөр эрхлэлтийн сан дээр өөрчлөлт оруулахаар болоод байгаа. Ноднин жил төсөв хүрэлцээ муутай байсан учраас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Сум хөгжүүлэх сангийн мөнгийг өгөхөөр заалт орсон. Энэ жилийн яригдаж орж байгаагаар, МСҮТөвийн суралцагчдын тэтгэлгийг бас энэ сангаас өгье гэсэн заалт оруулахаар орж ирсэн байгаа. Энэ асуудал манай төсвийн байнгын хороон дээр яригдаад Ц.Даваасүрэн гишүүн хуулийн төслийг Нийгмийн бодлого, боловсрол соёл, шинжлэх ухааны байнгын хороо дээр хэлэлцэж саналаа гаргах нь зүйтэй гэсэн дүгнэлт гаргасан байна лээ. Энэ ч бас зөв байх гэж бодож байгаа. Бид үүн дээр оруулахдаа жил болгон сум хөгжүүлэх сангийн мөнгө гээд тусад нь оруулаад жил болгон дээл нөхөж байгаа юм шиг, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн тэтгэлгийг эндээс өгье гээд оруулаад байгаа юм л даа. Тэгэхээр энэ юмаа нэгтгээд, энэ 23.1.12 заалтанд “хөдөлмөр эрхлэлтийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд зарцуулна” гэсэн тодорхой заалт оруулчихвал жил болгон өөрчлөгдөөд байхгүй. Тухайлбал ирэх жил 2015 онд сум хөгжүүлэх сан дээр Засгийн газрын мөрийн хөтөлбөр биелэгдсэн гээд хөрөнгө бол тавигдаагүй байгаа учраас ингэж өөрчилбөл яасан юм бэ гэсэн саналаа Нийгмийн бодлогын байнгын хороонд өгсөн байгаа. Олгогдож байгаа мөнгөний хувьд ур чадварыг дээшлүүлэх, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг гаргасан. Үүнийхээ хүрээнд аль болох мөнгийг ялгавартай олгох гэхээсээ илүү хөтөлбөрт программыг эзэмшүүлэх чиглэлийн асуудлыг сургуулийн удирдлага, хүүхдүүдтэй хамтран эзэмшүүлээд, ур чадварыг заавал эзэмшсэн хүүхдүүдэд, тухайлбал, хичээлийн цаг, нийт цагийн гучин 30 хувь нь онолын, 70 хувь дадлагын сургалтууд байгаа учраас, далан хувийг бүрэн эзэмшсэн хүүхдүүдэд тодорхой хэмжээний ур чадварыг эзэмшсэн гэж үзээд кредит цаг, чадамжынх нь хэмжээгээр тэтгэлгийг нь олгож явья гэсэн сайдын хувьд ийм чиглэл болгон, МСҮТ, төрийн болон хувийн оролцоотой сургуулиудад чиглэл өгөн ажиллаж байгаа.

**Сангийн дэд сайд С.Пүрэв:** С.Дэмбэрэл гишүүний асуултанд хариулья. Төсөв алдагдалтай нэмэх байхад сайн уу, муу юу гэж асуусан. Мэдээж хэрэг орлогын төсөөлөл, зардлын тооцоог үндэслэн улсын төсвийг алдагдалтай, үгүй бол нэмэх байхаар төсөөлж тооцоолдог. Хэрэв орлогын төсөөлөл өөдрөг байгаад зардлаа хямгадаж чадах юм бол төсөв ашигтай гарна. Төсөв ашигтай гарсан хэмжээгээр улсын төсвийн нэмэгдсэн хэмжээгээр хуримтлал бий болох талтай. Энэ бол сайн үзүүлэлт.

Цагдаагийн албаны тухай нөхөн төлбөрийн асуудлаар, тээврийн хэрэгслийн талаар тодруулж хэлье. Цагдаагийн албаны тухай хуульд үнэгүй зорчихоор зааж өгсөн байгаа. Харин түүнийг дагалдах хуульд нь энэ нөхөн олговрыг олгоно гэсэн зөрчилтэй заалт байгаа. Энэ хуулийн зохицуулалтын талаар үүнийг нэг болгож оруулж байгаа юм.

**УИХ дарга М.Энхболд :** Хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх талаар асуусан шүү дээ. Ойлгоогүй юу? Бичиж аваагүй юу? С.Пүрэв дэд сайд дахин хариулья.

**Сангийн дэд сайд С.Пүрэв:** Хөрөнгө оруулалтын үр ашиг бол их олон өргөн ойлгоц. Таны асуултыг бид нар өнөөдөр үр ашиг гэдэг асуудал дээр оновчтой хөрөнгө оруулалт хийх, барилгыг богино хугацаанд барих, ашиглалтанд оруулах, дуусаагүй барилгыг багасгах, хөрөнгө мөнгийг хэмнэх гэдгээр ойлгож байна. Энэ чиглэлээр ажиллахад, мэдээж хэрэг хамгийн чухал нь орон нутагт идэвх санаачлага дээр түшиглэж, хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөж, хэрэгжүүлэх энэ асуудал дээр бидний оруулж ирж байгаа санал явж байгаа. Энэ бол бас л хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн ийм арга хэмжээ гэж үзэж байгаа.

**Ерөнхий сайд Н.Алтанхуяг:** Цалин тэтгэвэр, тэтгэмж, Хүүхдийн мөнгө гээд энэ зүйлсийг өгөх боломж байгаа. Тийм учраас одоохондоо тийм ялгаварт байдалтай өгнө гэж бодохгүй байгаа. Явж байгаа практикаараа, авья гэсэн бүх хүүхдүүдэд өгөхөөр ийм бодлого байгаа.

## **Ногоон худалдан авалт 2015 оны төсөв тусгасан байх ёстой**

*2014 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээс: Миийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийх цээр*

**С.Дэмбэрэл:** Энэ хуультай холбогдуулаад хэд хэдэн асуулт байна.

**Нэгдүгээрт:** Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Яамны төсөвтэй холбогдуулан Байгаль Орчин Ногоон Хөгжлийн сайд С.Оюунаас асууя. Монгол улс Байгаль Орчин Ногоон Хөгжлийн стратегитай болсон. Энэ стратеги нь 2015 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс хэрэгжиж эхлэх ёстой. Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн стратегид заасан зорилтуудыг “2015 оны төсөв”-т тусгахдаа их анхаарах ёстой. Эхний асуулт бөгөөд саналыг төсвийн байнгын хорооны дүгнэлтэд тусгаасай гэж хүсч байна. “Ногоон худалдан авалтийн бодлого”, 2015 оны Монгол улсын төсвийн бүх ерөнхийлөн захирагч бүрээр яаж тусгасан бэ? Үүнийг тусгах ёстой. 2015 онд эдийн засаг, төсвийн байдал хүндэрнэ. Түүнчлэн мөнгөний бодлого хатуурна. Монголчууд жинхэнэ хэмнэлтийн горимд шилжих, орчин цаг үе үүсэх гэж байна. Энэ тохиолдолд төсвийн урсгал зардалыг дээд зэргээр хэмнэхээс гадна, хөрөнгө оруулалтыг хамгийн оновчтой болгох ёстой. Оновчтой байх нэг хэлбэр нь 2015 оны нийт төсвийн хөрөнгө оруулалтанд /төсвийн худалдан авалттай холбоотой асуудал/ ногоон худалдан авалтыг тодорхой хувь хэмжээгээр \тухайлбал 20 хүртэлх хувь\ зааж өгөх ёстой юм. Ямар ч байсан энэ ажил 2015 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэх ёстой. Манай байнгын хорооноос төсвийн байнгын хороонд явуулах дүгнэлтэндээ

үүнийг тусгаж өгөх хэрэгтэй. Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, ногоон худалдан авалтын бодлогыг 2015 оны төсөвтөө хэрхэн тусгасан талаараа тодорхой мэдээлэл хэлмээр байна.

*Хоёрдугаарт:* Хүнс хөдөө аж ахуйн салбарт, өнгөрсөн 2013 оны дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хүчин зүйлийг авч үзэхэд, уул уурхайн бус эдийн засгийг хөгжүүлэх шаардлага харагдаж байна. Уул уурхайн талаас дотоодын нийт бүтээгдэхүүнийг өсгөх найдлага бага гэсэн хандлага байсан. Энэ тохиолдолд уул уурхайн бус сектор, түүний дотор хөдөө аж ахуй, хүнсний чиглэлийн хөрөнгө оруулалтыг оновчтой болгох, тухайн салбарын бизнесийн идэвхжүүлэлтийг нэмэгдүүлэх ёстой. Ийм зүйлүүдийг 2015 оны Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яамны төсөвт тусгасан байх ёстой. Энэ талаар тодруулга авмаар байна. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос явах дүгнэлтэнд, тухайлбал, өнөөдрийн малчдын орлогын бүтэц, зах зээлд нийлүүлж байгаа мах, махан бүтээгдхүүн зэргийг харахад, малчдын дунд орлогын хүчтэй ялгарал аль хэдийн үүсээд байна. Энэ тохиолдолд төрийн зүгээс, “малчдын малийн хөлийн татвар”-ыг яах юм бэ гэдэг асуудал гарч ирж байна. Өнөөдөр Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод нийлүүлж байгаа бүх махны 43 хувийг нийт малчин өрхүүдийн 14 хувь л эзлэж байгаа. Үүнийг зөвхөн 500-аас дээш толгой малтай малчин өрхүүд нийлүүлж байна. Өөрөөр хэлбэл орлогын ялгаварлал хүчтэй болж байна. Малчдыг эдийн засгийн харьцаанд бүрэн оруулахын тулд татварын харилцаанд оруулах ёстой. Тиймээс, нэг нуугдмал нөөц бол “малын хөлийн татвар”-ын асуудал юм. Энэ тал дээр Хөдөө аж ахуйн яам болон Сангийн яамны байр суурь ямар байдаг юм бэ?

*Гуравдугаарт:* Хүнс, Хөдөө Аж Ахуйн салбараас Монголбанк гурилны үнийг тогтворжуулах хөтөлбөрөөс 2015 онд аажмаар татгалзаад, арилжааны банк болон холбогдох секторуудад үлдээх хандлагатай байна. Энэ тохиолдолд танай яамны хувьд, 2015 онд гурил, мах, цагаан будаа, элсэн чихэр зэрэг нийлүүлэлтийн гаралтай, инфляцын хүчин зүйл болдог бүтээгдэхүүнүүд дээр ямар бодлого төсөвтөө сулгаж өгсөн бэ?

Мэдээж хэрэг татаас, шилжүүлгүүд байгаа. Тэрнээс гадна, механизмын хувьд яаж өөрчлөгдөх юм бэ? Ийм нэг бодлогын чанартай асуулт, энэ бас санал юм шүү. Тийм учраас байнгын хорооны дүгнэлтэд тусаасай гэж бодож байна.

**Байгаль Орчин Ногоон Хөгжлийн Яамны сайд С.Оюун:** УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл хэмнэлтийн тухай асууж байна. Хэмнэлтийн горим руу орох ёстой. Тэгэхээр энэ төсөв дээр хэмнэлт ямар байгааг авч үзвэл, манай яамны хувьд цэвэр агаар сангийн хөрөнгө оруулалт анх байгуулагдахдаа 30 тэрбум байсан бол, өнгөрсөн жил 20 тэрбум болтлоо буурсан. Тэгээд ирэх жил дахин 30 тэрбум дээр очиж байгаа. Бусад зардлууд ерөнхийдөө буурсан. Байгаль хамгаалах сан 6.1 тэрбум байснаас, ирэх жил 5.4 болтлоо буурсан. Хөрөнгө оруулалт, ойжуулалт дээр, ойн тооллоготойгоо нийлээд 6.5-аас 5.6 тэрбум болж, хөрөнгө оруулалт 6 тэрбумаас 4.2 тэрбум болтлоо тус тус буурсан. Бусдаар бол урсгал зардал, цалин тэтгэвэр батлагдсан хэмжээндээ байгаа. Буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа гадаадын төслүүдийн хэмжээ харин нэмэгдсэн. Энэ жил төсөв дээр гадаадын төслүүдийн хэмжээ 13.4 тэрбум \тоо, танилцуулгууд орсон\ байгаа. Агаарын бохирдлоос бусад зардлууд нь 20 хувиар буурсан байгаа. Ногоон худалдан авалт маань Ногоон хөгжлийн бодлогод суусан. Ногоон худалдан авалтыг УИХ-аас төсвийг дагаж, хэрэгжүүлэхэд гарах тогтоол дээр нэмж суулгах нь зүйтэй гэж бодож байгаа.

**Үйлдвэр, Хөдөө Аж Ахуйн сайд Ш.Түвдэндорж:** Бид нар малын хөлийн татвар гэж яриагүй. Малаас татвар авья гэхээр малын хөлийн татвар гэж яригдаад эхэлдэг. Бэлчээрийн төлбөр авья гэсэн яриа байгаа. Энэ төлбөрийг төв рүү татаж авахгүй. Бэлчээрийн төлбөр бол шинэ сумын төсөл гэдэг шиг, сумандаа хэрэгтэй зүйлд \худаг ус гэх мэт\ зориулагдахаар, тийм төлбөр яригдсан. Гэхдээ эцэслэн шийдээгүй. Гурил, махны асуудал үнэ тогтворжуулах зарчмаараа явагдаж байгаа. Дараа жил мөн энэ зарчмаараа явна. Цагаан будаа, элсэн сахарийг бид зах зээлийн горимоороо нь явуулж байгаа. БОХХААБайнгын хорооны гишүүдийн анхааралд сонордуулахад, энэ жилийн ноосны урамшуулалыг ноднин өгсөн учраас энэ жил дутмагдуу төсөв орсон байгаа. Хоршооны гишүүн хүмүүст ноосны урамшуулал олгож байгаа. Эндээс бас зөрчил үүсээд байна. Энд анхаарал хандуулж өгнө үү гэж протоколд тэмдэглүүлмээр байна.

**Сангийн Яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогт:** С.Дэмбэрэл гишүүний асуултанд хариулья. 2014 оны 10 дугаар сарын 01-ны өдөр өргөн барьсан төсөвтэй хамт “малын хөлийн татварыг сэргээх” хуулийн төсөл УИХ-аар өргөн барьсан байгаа. Манай хуулийн төслийн онцлог гэвэл малын хөлийн татварын дээд хязгаарыг зааж өгөөд, тогтоох уу, тогтоохгүй юу? гэдэг эрхийг нь орон нутагт нь өгч байгаа. Олсон орлого нь орон нутагт орно. Та бас түрүүн малын даац, бэлчээрийн тухай хэллээ. Орон нутгийн бусад шаардлагаасаа хамаарч иргэдтэйгээ хэлэлцээд, иргэдийн төлөөлөгчдийн хурлаасаа тухайн аймаг малын хөлийн татварыг тавих уу, тавихгүй юу гэдгээ өөрсдөө шийдээд явах боломжыг нь УИХ-аас олгоё гэдэг хуулийн төслийг өргөн барьсан байсан. Үүнийгээ өмнөх төсөвтэйгээ хамт татаж авсан. Төсөвтэй хамт орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх 4 татвар оруулж ирсэн. Маш их татвар нэмж байна гэдэг яриа яваад байсан болохоор, ер нь бол төсөв дээр нэг ч мөнгө тусгаагүй орж ирсэн. Орон нутагт боломжыг нь өгөх, төсвийн тухай хууль батлагдсаны дараа, Ерөнхий сайд УИХ-д дахин өргөн барина. Энэ орлогыг улсын төсөвт авахгүй, орон нутгийн төсөвт хэрэглэхээр төлөвлөж байгаа. Төсөвтэй холбогдож буруу ойлголт төрж байсан болохоор бид нар буцааж аваад, төсөв батлагдсаны дараа эдгээр хуулийг өргөн барина.

## **Манай ажлын хэсгээс үлгэр дууриал ав**

*2014 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн Эдийн засгийн байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээс: Мчийг хэлэлцэх цээр*

**С.Дэмбэрэл:** Асуулт асуухаасаа өмнө, ажлын хэсэгтэй холбогдуулан та бүхэнд жишиг болохуйц саналаа хэлье.

**Нэгдүгээрт:** Одоо би мөнгөний бодлогын ажлын хэсгийг ахлан ажиллаж байна. Энэ ажлын хэсэгт МАН-аас Л.Энх-Амгалан, А.Тлейхан, Ч.Хүрэлбаатар нар, Ардчилсан Намаас 3-4 хүн байна. Манай ажлын хэсэг дээд зэргийн уян хатан, бие биенээ ойлгосон, ямар ч улс төржилт байхгүй ажиллаж чадаж байна. Яг ингээд ажиллах хэрэгтэй шүү дээ. Төсөв болон мөнгөний бодлого дээр ямар нэгэн байдлаар, аль нэгнийх нь буруугаас болж ийм байдалтай, ингэж явж болохгүй. Манай ажлын хэсгээс үлгэр дууриал ав. Яаж ажиллахаараа, улс төрийн намууд хамтран, хагас бүтэн сайн өдөргүй суугаад, Монгол улсынхаа төлөө, үр бүтээлтэй сайхан ажиллаж болдгыг бид харуулж байна. Биднээс жишиг ав.

**Хоёрдугаарт:** Сангийн дэд сайд С.Пүрэв сайдаас асууя. Түрүүн УИХ-ын гишүүн Ц.Нямдорж маш үнэн, зөв үг хэллээ. Үүнийг Монгол Ардын нам дэмжиж байгаа байх гэж би бодож байна. Энэ эдийн засаг чинь хэцүү байна шүү. Тийм учраас маш тодорхой асуулт асууя. Энэ батлуулах гэж байгаа зүйлүүд дээр чинь зарлагыг нэмэгдүүлэх, багцыг нэмэгдүүлэх зүйлүүд зөндөө байна. Юуг нь хасах юм бэ? Хасах юм байгаа юм уу? 2015 оны төсвийн орлого чинь хамгийн дээд хэмжээгээр дайчлагдсан байгаа. 40 тэрбум хүртэл хэцүү шүү. Тийм учраас энэ боломжтой юу гэдгийг асуумаар байна. Бодит амьдрал дээр төсвийн орлого дутахаар байгаа шүү.

**Гуравдугаарт:** Сангийн яамнаас асууя. Монгол улсын хамгийн сайн төсөөлөл хийдэг байгууллагуудын судалгаагаар, эдийн засгийн бодит өсөлт чинь 6 хувь л хүрэхээр байна. Энэ 6 хувийг л дотроо төсөөлж, бодож ажиллах хэрэгтэй болохоос бус, тэрнээс дээш оптимист төсөөлөл байгаад нэмэргүй шүү. Бодит амьдралаас дэндүү холдчихоно. Тийм учраас эдийн засгийн бодит өсөлт 6 хувь гарах нөхцөлд, энэ төсвийг яаж хийх юм бэ? Монгол улсын 2015 оны төсвийг, сангийн яамнаас алдагдалгүй батлах, УИХ-аас тооцоог нь гаргуулж, алдагдалгүй байлгамаар байна. 2015 оны төсвийг нэмэх үзүүлэлттэй гаргамаар байна. Ингэж байж, дараа жилийн төсөв, мөнгөний бодлого 2 хоорондоо уялдах төдийгүй, Монгол улс эдийн засгийн энэ хүндрэлтэй, хямралтай байдлаас гаргаж чадах шийдэл чинь болно. Гарц чинь ингэж л харагдаж байна. Үүнийг С.Дэмбэрэл гэдэг хүн л ганцаараа хэлээд байгаа юм биш. Үүнийг ажлын хэсэг бид хоорондоо ярьж, мөн Монголбанк, Сангийн яамтай энэ бүхнийг ярьсан. Тийм учраас манай УИХ-ын эдийн засгийн байнгын хороо, Монгол улсын эдийн засгийг барьдаг “think tank”-ынхаа хувьд, шийдвэр гаргадаг гол субьектынхаа хувьд 2015 оны төсвийн төсөл дээр маш хариуцлагатай, төсөв мөнгөний бодлогыг цогцод нь уялдуулсан байдлаар ажиллах ёстой шүү. 2015 оны төсөв, мөнгөний бодлого яг одоогийн энэ байдлаараа байхад уялдаж чадах уу? Түрүүн байнгын хорооны орон тооны асуудал ярьж байна. Төрийн байгуулалтын байнгын хорооны зүгээс 2015 оны төсвийг төрийн байгууламж талаас нь хараад, бүтцийн өөрчлөлт хийх юм уу, хөрөнгө оруулалтын менежментийг яаж сайжруулах юм бэ гэдгээ тооцоолох учиртай. Төсвийн нэгдүгээр хавсралт болох тоо болон чанарын үзүүлэлт дээр хөгийн юм бичээд, батлах гээд байна. .

**Сангийн яамны дэд сайд Пүрэв:** Сангийн яамнаас энэ жилийн төсвийг нилээн бүсээ чангалсан төсөв болсон гэж үзэж, оруулж байгаа. Өөрөөр хэлбэл, УИХ-аас өгсөн чиглэл, засгийн газраас гаргасан хэд, хэдэн тогтоолын дагуу урсгал зардлыг нэмэгдүүлэхгүй байх, тэвчиж болох зардлыг хасах чиглэл өгсөний дагуу тооцоо, үндэслэлээ хийж, оруулж ирж байгаа. 2015 онд бид 900 тэрбумаар урсгал зардлыг нэмэгдүүлээд байгаа. Гарцаагүй нэмэгдэж байгаа зардлууд нь дийлэнхи хувийг эзлэж байгаа юм. Үүний 500 тэрбум нь цалингийн нэмэгдэл  $50-60\%$ , 100 тэрбум нь хүн ам статистикийн өөрчлөлтийн улмаас төрийн үйлчилгээг хүргэхтэй холбогдсон зардал, цэцэрлэг сургуулийн хүүхдийн өсөлттэй холбогдож үүсэн гарах зардал, 20-30 тэрбум нь шинээр ашиглалтанд оруулах хөрөнгө оруулалтаас хамаарч, боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарт гэх мэтчилэн тодорхой хэмжээгээр нэмэгдэж байгаа. Хэрвээ цаашдаа урсгал зардал, бусад зардлыг хасахаар хийх юм бол, энэ нь бүтцийн томоохон өөрчлөлт хийж байж шийдэгдэх байх гэсэн бодолтой байна. Сангийн яаманд бол ийм чиглэл өгөгдөөгүй байна. Бүтцийн томоохон өөрчлөлт хийвэл тодорхой хэмжээний хэмнэлтийг хийх тооцоог гаргаж болох байхаа гэж бодож байна.



Алдагдалгүй төсөв батлах тухай асууж байна. Энэ бол Сангийн яамны хүсэн эрмэлздэг, тэмүүлдэг зүйл. Төсөв бол алдагдалгүй, нэмэх үзүүлэлттэй байж чаовал хуримтлал, баялагийн санг бий болгоно. Сангийн яамнаас “Ирээдүй өв сангийн хууль” буюу “Баялгийн сан”-ийн тухай хуулийг санаачлан, ерөнхийлөгчийн тамгын газартай хамтарч боловсруулан, Монгол улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдорж-д өргөн барьсан байгаа. Энэ хуулийн гол логик санаа нь “төсөв 0-тэй тэнцэх буюу нэмэх дүнтэй гарах” тухай концепцыг тусгасан байгаа. Энэ тохиолдолд улс оронд хуримтлал бий болно гэж үзэж байгаа. Тэгэхээр энэ алдагдалгүй байлгах нь чухал асуудал. Бид нар ч ач холбогдлыг нь сайн ойлгож байна.

Төсөв мөнгөний бодлого аль зэрэг уялдаж байна вэ гэж асуусан. Энэ бол С.Дэмбэрэл гишүүний санаа тавих ёстой асуудал гэдгийг ойлгож байна. Төсөв мөнгөний бодлоготой уялдах үндсэн 3 суваг байдаг. Нэгдүгээрт, төсвийг алдагдалгүй байлгах, төсвийн алдагдлын хэмжээг зохих хэмжээнээс өсгөхгүй байлгах гэсэн ийм чухал суваг байдаг. Бид нар төсвийг боловсруулахдаа хасах хоёр хувь /-2%/ руу хэтрүүлэхгүй байхаар бодож, боловсруулж, оруулж ирсэн. Хоёрдугаарт, валютын урсгалыг нэмэгдүүлэх чиглэлээр төсөв мөнгөний бодлого хоорондоо уялдах ёстой.

**С.Дэмбэрэл:** Мэдээж хэрэг сангийн яам бүтцийн өөрчлөлт хийхгүй. Эндээс ч тийм чиг үүрэг өгөхгүй нь тодорхой. Бүтцийн өөрчлөлт гэдгийг ганцхан энэ хүрээнд ярьдаг ч зүйл биш, тийм учраас түрүүн би төрийн байгуулалтын байнгын хороо гэж тодотгож хэлсэн юм. Урсгал зардлаа илүү хэмнэх боломж байна. Төсвийн “цэнхэр ном”-ны нэгдүгээр хавсралт дээр “хэнээр, ямар бүтээгдэхүүн гаргуулах” гээд, мөнгө өгч байгаа вэ гэдгээ дахин нэг эргэж харах юм бол урсгал зардлыг хэмнэх итгэл үнэмшил чинь эрс нэмэгдэх боломжтойг та бүхэнд хэлье.Тийм учраас урсгал зардлаа багасгах ёстой. Төсвийг ерөнхийлөн захирагч бүрээр урсгал зардлыг багасгах боломж байгаа. Хөрөнгө оруулалтыг зохистой болгох, түүний тодорхой объектууд дээр гурван зарчим л баримтлах ёстой.

**Сангийн яамны дэд сайд Пүрэв:** Одоо бүх байнгын хороонууд дээр манай төсвийг хэлэлцэж байгаа. Эдийн засгийн байнгын хороо дээр хэлэлцэж байх явцад, төсөв, зардлыг багасгах талаар бусад байнгын хороон дээр ч нилээн саналууд гарч байна. Энэ чиглэлээр холбогдох тооцоо, үндэслэлүүдийг Сангийн яам тухай бүрд нь гаргаж өгч байгаа. Сангийн яам дээр ажлын хэсэг гарсан байгаа тул, УИХ-ын гишүүдээс тодруулах, энэ чиглэлийг нь хасвал ямар үр дүн гарах вэ, болзошгүй сөрөг болон эерэг үр дүнгийн талаар тухайн үед нь гаргаж өгөх боломжтой.

## **Зангидсан нударга шиг байж чадвал, энэ хүнд хэцүү жилийг давна**

*2014 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс. Ерөнхий сайд Н.Алтанхуягыг огцруулах эсэх тухай хэлэлцэх цээр.*

**С.Дэмбэрэл:** За баярлалаа.Өнөөдрийн хэлэх үгэндээ би аль нэг намыг, хэн нэгнийг буруутгахгүй, бас хэнийг ч уриалахгүй. Үндсэн хуулиар бид нарыг аль нэг намын элч биш, харин ард түмний элч гэж нэрлэдэг. Зарим хэвлэл мэдээлэл, олон түмэн бид нарыг “76 мангар” гэж нэрлэдэг. “76 мангар” гэсэн нэрийг зөвтгөх үйлдэл хийхгүй ийм л төр байгаасай гэж

хүсэж байна. Энэ хагас дугуй заалыг УИХ гэж нэрлэдэг бөгөөд Үндсэн хуульд үүнийг “Монгол Улсын төрийн эрхийг барих, хуулийг засаглах хамгийн гол институци” гэдэг. Ийм байгууллага өнөөдөр засгийн газрын асуудлыг хэлэлцэж байна. Монголын ард түмэн аль ч Засгийн үед, аль ч Их Хурлын үед хоёрхон зүйлийг хүсэн хүлээдэг.

1. Шударга ёс, хүний эрх, эрх чөлөө

2. Амьдралд нь сөргөөр нөлөөлдөггүй, үнийн дарамтгүй, авч байгаа цалин хөлс нь хүрэхүйц, эрхэлж байгаа бизнес нь амжилттай яваасай гэсэн горьдлого найдлага байдаг.

Монголын ард түмэн үе үеийн Засгийн газраас, үе үеийн Их Хурлаас үүнийг л хүлээсээр ирсэн. Тэд маань аль нэг газар радио телевиз үзэж суугаа, очерлоод байж байгаа, эмнэлэгт хэвтэж байгаа, бизнес эрхэлж яваа. Тэр хүмүүс бүгд л энэ хоёр зүйлийг хүсэн хүлээдэг. Улсын Их Хурлын гишүүд бид ард түмний энэ хүсэлтийг л биелүүлэх гэж энд сууж байгаа. Хуулийн засаглал, хүний эрх, эрх чөлөөний асуудал бол Монгол Улсын номер нэг асуудал болсон байна. УИХ дахь бүх намууд үүнд нэгдсэн дуу хоолойгоо гаргах цаг нь болсон байна. Үүнийг бид зайлшгүй хөндөх ёстой асуудал.

*Хоёрдугаарт:* Эдийн засгийн салбарт хамгийн гол асуудал бол 2015 оны эдийн засгийн байдал. Сонгогч ард түмэн маань инфляцын дарамтад өртдөггүй, валютын ханшны савлагаанд өртдөггүй, бизнесийн эрх чөлөө, эдийн засгийн эрх чөлөө нь чөлөөтэй байх тийм байдлыг хүсч байна. Хүмүүсийг зүгээр ажиллаж амьдарч байхад нь янз бүрээр шалгаж дарамтлаад байдаггүй, хүнд суртлаас зайлсхийсэн ийм орчин бий болоосой гэж хүсч байна. Аль нэг намууд эсвэл нам доторх фракцууд хоорондоо төрийн эрхийн төлөө маргах асуудал биш, хамгийн гол нь энэ улсын эдийн засаг нь, ард түмний амьдрал нь сайн байгаасай гэж хүсч байна. 2015 оны эдийн засаг хүндэрнэ. Хөрөнгө оруулалт бидний хүссэнээр орж ирэхгүй. Экспортын орлого хүссэнээр байхгүй. Одоо тэгээд яах юм вэ? Ямар шийдэл байна вэ? Төсвөө хариуцлагатай, нэмэх тэмдэгтэй баталж байж, мөнгөний бодлогыг олигтойхон хийж байж, улс төрийн намууд, бүлгүүд нь хоорондоо зөвшилцөж байж, Монголын ард түмэн зангидсан нударга шиг байж энэ хүнд хэцүү жилийг давж чадна. Ийм л зүйлийг хүмүүс хүсч байна. Үүнтэй холбогдуулаад талийгаач Б.Чимэд гуайн хамгийн сүүлд нийтлэлч Г.Отгонбаярт өгсөн ярилцлагыг Улсын Их Хурлын гишүүд та бүхэн зориуд уншаасай гэж бодож байна. Дээр нь манай эртний Алунгоо эхийн таван хүүдээ сум өгөөд, багцаараа бөх, сайн байдаг юм шүү гэж хэлсэн тухай домог байдаг. Бид багцалсан таван сум шиг болж чадаж байна уу гэдгээ бодмоор байна. Дараа жил гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэхгүй, бидний дотроосоо сэмхэн хүсэн хүлээж байгаа тэр зүйл чинь болохгүй. Гадаадын хөрөнгө оруулагч ер нь аль ч хөрөнгө оруулалт энэ улсад тогтвортой байдал, хуулийн засаглал хэрэгжиж чадаж байна уу, үгүй юу, миний өмчийг булаагаад авах нь уу, үгүй юу, эсвэл юу ч болоогүй байхад намайг шоронд хийчихвий гэсэн болгоомжлолдоо тулгуурлан, хамгийн энгийн хүний эрхийн гол зорилтууд энэ улсад хангагдаж чадаж байна уу, үгүй юу гэдгийг л хардаг. Энэ тал дээр илүү их анхаараад, 2015 онд “Төр нь төвшин, түмэн олон минь амгалан” он байх болтугай. Төр нь түвшин, түмэн олон минь амгалан байх нөхцөл, улс төр, эдийн засгийн орчинг нь та бид бүрдүүлэх үүрэгтэй. Яагаад гэвэл, та биднийг Үндсэн хуулиар ард түмний элч гэж нэрлэдэг.

## **Төгрөгийн хадгаламж хүмүүст ашигтай байх нөхцөлийг бодлогоор бий болгох ёстой**

*Монголын Эдийн засгийн форум Төрийн ордонд цргэлжилж байх үеэр ам.долларын ханш, аж ахуйн нэгжүүдийн нөхцөл байдлын талаар УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл сэтгүүлдэд товч тодруулга өгчээ.*

- **Зарим компанийн зүгээс татварын өршөөлийн тухай хуулийг батлах хэрэгтэй байна гэж байгаа. Ингэснээр төсвийн орлого муудах сөрөг нөлөөтэй гэж хүмүүс үзэж байна.**

С.Дэмбэрэл: - Энэ их зөв хандлага бөгөөд аргагүйдсэн л алхам. Чамайг зодоод, цохиод л байвал энэ намайг нэг өршөөчихгүй юм байх даа л гэж боддогтой адилхан. Монголын эдийн засгийг харахаар албан болон албан бус, сүүдрийн болон сүүдрийн бус эдийн засаг гээд хуваагдчихсан. Албан эдийн засаг руугаа улам дайраад, албан буст нь эрх чөлөө ноёлоод байхаар ямар байх вэ? Төр нь зөвхөн орлогыг нэмэгдүүлэхийн тулд янз бүрийн шахалт, дарамт учруулдаг ийм гажиг тогтолцоотой бид удаан явахгүй. Тийм учраас энэ өршөөлийн хууль чухал. Гэхдээ үүнээс өмнө татварын иж бүрэн шинэчлэл хийхгүй бол өршөөлийн тухай яриад хэрэггүй. Татварын реформийн гол үзэл санаа нь юу вэ гэхээр бүгдээрээ төлцгөөе, гэхдээ бага хэмжээтэйгээр. Жишээ нь НӨАТ-ыг 10 байсныг таван хувь болгох зэрэг. Үүнд харин босго зэргийг болих хэрэгтэй. Ингэснээрээ төлдөггүй байсан хүмүүс төлж эхэлж татварын суурь орчин тэлснээр төсвийн орлого одоогийнхоос дутахгүй.

- **Эдийн засгийн нөхцөл байдал таагүй байгаатай холбоотойгоор томоохон аж ахуйн нэгжүүдэд цомхотгол явагдсаар байна.**

С.Дэмбэрэл: - Тийм ээ. Томоохон компаниуд одоо бол жинхэнэ нөөцөөрөө л явж байна. Би олон компанийн төлөөлөлтэй уулзсан. Тэд найдлагаараа л явж байна. Компани гэдэг чинь амьд организм шүү дээ.

- **Ам.долларын өнөөдрийн байгаа ханш хамгийн бодит үзүүлэлт гэж байгаа. Цаашдаа яах бол?**

С.Дэмбэрэл: - Экспорт буурсан. Гадаадын хөрөнгө оруулалт багассан энэ үед Монголбанк ганцаараа интервенц хийгээд нэмэр болохгүй. Юу нэмэр болох вэ гэхээр түр хугацааны арга хэмжээ хэрэгтэй. Тэр нь ам.долларын ханшийг захиргааны журмаар валютын хадгаламж, зээл хоёрын дээд хэмжээг тогтоох хэрэгтэй. Дээрээс нь төгрөгийн хадгаламж хүмүүст ашигтай байх нөхцлийг бодлогоор бий болгох ёстой. Өөрөөр хэлбэл валютын байг тогтоож өгөх хэрэгтэй байна. Манай хөрш гэхэд коридор гэж ярьдаг. Өөрөөр хэлбэл ханш тэд хүртэл өснө гэж хязгаар тавих хэрэгтэй. Иймэрхүү эрс шийдэмгий байдлаар асуудалд хандахгүй бол цаашаа хэд болохыг мэдэхгүй. Ханшинд хүмүүсийн сэтгэл зүй буюу хүлээлтээс гадна дамын хүчин зүйл нөлөөлж байна. Ханшин дээр арилжааны банкууд хүртэл тоглож байна. Энийг хянах ажлыг ганцхан Монголбанк биш Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл гээд хуульд байдаг Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Төв банк энэ асуудлыг шийдэх ёстой. Мөн Эдийн засгийн хөгжлийн яам ч орох ёстой.

- Дээр дурдсан газрууд хуралдаж нэг уулзалт хийж байсан.

С.Дэмбэрэл: - Оны өмнө нэг уулзсан. УИХ-аас нэг тогтоол гаргахаар болсон. Валютын ханшийг тогтворжуулах, эдийн засгийг идэвхжүүлэх чиглэлээр 23 заалттай УИХ-ын тогтоол гаргах ёстой. Тогтоол гаргах гэж ингэж удаж байна шүү дээ.

## **Шүүхийн төсөвт гар татаж болохгүй. Яагаад гэвэл зорилго нь ариун байхгүй юу**

*Шүүхийн төсөв, шүүгчдийн цалин хангамжийн асуудлаар УИХ-ын гишүүдийн байр суурийг бид та бүхэнд цувралаар хүргэж байгаа. Энэ удаад С.Дэмбэрэл гишүүн үзэл бодлоо илэрхийллээ.*

- Ерөнхий сайдыг огцруулах чуулганы хуралдаан дээр та Монголын ард түмэн шударга ёс, хуулийн засаглалыг юун түрүүнд хүсч хүлээж байгаа гэж хэлсэнээ тодруулахгүй юу?

С.Дэмбэрэл: - Ард түмэн хуулийн засаглал гэдэг нэр томъёог хэрэглэхгүй ч гэсэн насан туршдаа үг, үйл хөдлөлөөрөө хоёр л зүйлийг хүсдэг. Хууль, шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй, хуулиар бүгдийг шийддэг. Шүүхийн өмнө хэн боловч гэм буруугаа шүүлгэдэг, эцсийн шийдвэр тэндээс гардаг. Үүнийг аль ч төр, засгийн газар, хууль тогтоох байгууллага хэрэгжүүлэх нь хуульд заасан үүрэг нь. Хүмүүс төрийн гурван өндөрлөг гэж их ярьдаг. Ийм томъёолол Үндсэн хуулинд байхгүй. Төрийн эрх мэдэл хуваарилах онолын дагуу Монгол улс хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл гэсэн гурван засаглалтай. Шүүх эрх мэдлийг бие даасан засаглал болгохын тулд шүүхийн шинэтгэлийн том үйл явц өрнөж байна. Үүний гол цөм нь шүүх бие даан, шүүгч хараат бусаар ажиллах нөхцлийг бүрдүүлэх юм. Энэ нь шүүх төсвөө эрх баригчдаас царай алдаж гуйдаггүй, шүүгчид хэний ч нөлөөнд автдаггүй, зөвхөн хуулийг гул барих биш гол болгон ажиллах зарчмыг бий болгох ёстойг зорьж байна. Монгол улсад энэ чиг үүргийг гардан хэрэгжүүлэхээр Шүүхийн ерөнхий зөвлөл бие даан ажиллаж байгаа. Дэлхийн маш олон оронд шүүхийн бие даан, шүүгчдийн хараат бусаар ажиллах нөхцлийг бүрэн утгаар нь хангаж, түүнийг нь гадны нөлөөллөөс хамгаалж, шүүх засаглалдаа хир халдаахгүй, улам бүр сүр хүчийг нь төгөлдөржүүлж ажилладаг Шүүхийн ерөнхий зөвлөл гэж бие даасан Үндсэн хуулийн байгууллага ажилладаг юм. Улсын төсвийн асуудлаар шүүхийн төсөв, шүүгчдийн цалин пүнлүүний асуудал яригдаж байна. Тэгэхээр төсвийг хэлэлцэхэд ярьж болдог юм, ярьж болдоггүй юм гэж байдаг. Хэрэгтэй, шаардлагатай юман дээр хууль тогтоогчид харамлахгүй, гар татахгүй төсөв хөрөнгийг нь зохистой, үр ашигтай хуваарилах гэж сууж байгаа гэж би бодож байна. Ялангуяа шүүхийн төсөвт гар татаж болохгүй. Яагаад гэвэл зорилго нь ариун байхгүй юу. Хуулийн засаглалыг бий болгохын тулд хараат бусаар ажиллах нөхцлийг шүүгчдэдээ бүрдүүлэх нь хамгийн чухал асуудал. Үүний тулд шүүгчийн ажиллах амьдрах нөхцөл нь төсөв санхүү, цалин хангамж нь хангалттай байх хэрэгтэй. Төрийн эрх мэдлийн энэ институцийн хэн нэгний ятгалга, дарамт шахалтанд орохгүй хэмжээнд хэвийн ажиллах нөхцлийг бусад улс орнууд хамгийн түрүүнд цалин хангамжаар нь дамжуулж бүрдүүлж өгдөг. Ингэсний дараа

шүүхийн байгууллагуудад шинэтгэл хийгдэнэ. Шүүхийн ерөнхий зөвлөл ганцаараа энэ үйлсэд хүч мөхөстөнө. Үүнийг төр дэмнэж, дэмжиж энэ ариун үйлсэд морь шиг хөтөлж, манлайлах ёстой. Ингэж байж, хуулийн засаглалын сүр хүч жинхэнэ утгаараа оршин тогтнож, ард иргэд хуулиа дээдэлж, хараат бус шүүхдээ итгэнэ.Хараат бус шүүх бүрдсэн байхад улс орны эдийн засаг, гадна дотны хөрөнгө оруулалт, ажиллах хүч, иргэдийн амьжиргаа бүгд дагаад сэргэдэг. Өнөөдөр эдийн засаг хүнд байгаа нь үнэн. Дараа жилийн төсөв хүндрэлтэй байгаа нь ч үнэн. Гэхдээ Монголын ард түмний хүсэн хүлээж байгаа үнийн дарамтгүй, хуулийн засаглалтай, шударга ёс нь хамгаалагдсан хараат бус шүүхийг бий болгохын тулд төсөв, цалин хангамжийг нь хуулиар төр хангаж өгөх үүрэгтэй. Монгол улсад ямар ч төмөр зам барьсан, ямар ч орд уурхай ашиглалтанд орсон ч ард иргэд ойрхон юмыг хүсдэг. Тэр нь шударга ёс, хуулийн засаглал, хараат бус шүүх.

- Шүүгчдийн цалинг дур мэдэн нэмлээ, төсвийн мөнгө идлээ гэх шүүмжлэл эрх баригчдын зүгээс дуу өндөртэй явж байгаа л даа?

С.Дэмбэрэл: - Төр оршин тогтнох үндэс шударга ёс, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн үзэл санааны дээд эрмэлзэл, хуулийн засаглал шүү дээ. Үүнийг Монгол улсын Үндсэн хуулиар заагаад өгчихсөн байдаг. Иргэн хүний заяагдмал эрх, төрийн бусад институцүүдийн чиг үүргийг бүгдийг заасан. Багш, эмчийн цалинг шүүгчдийн цалинтай барьцуулж ойлгож болохгүй. Шүүх эрх мэдлийн хараат бус байдал төр улсын хэмжүүр болж байдаг. Гадны хөрөнгө оруулагчид хаалга тогшихдоо улс орныг хамгийн түрүүнд хуулийн засаглал хэр түвшинд вэ гэдгээр нь шинждэг болохоос багш эмч нар нь өндөр цалинтай юм байна гэж хэзээ ч үнэлдэггүй.

- Та шүүхийн шинэтгэлийн талаар ямар мэдээлэл, үнэлэмжтэй байгаагаа хуваалцахгүй юу?

С.Дэмбэрэл: - Би шүүх, хуулийн байгууллагыг гажуудаад байгааг, түүнийг засч залруулах шинэтгэл хэрэгтэйг ил тод хэлдэг хүн. Энэ салбар гажуудаж байна гээд хэлээд зогсохгүй гажуудлаас гаргах арга замыг хамгийн түрүүнд хэлдэг. Би гудамжинд гарч хүний эрх гэж орилдоггүй. Шүүхийн тухай багц хуульд нь санал өгч, шүүх бие даан, шүүгч хараат бусаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө байдаг. Шүүхийн талаар хүмүүс худалдагдлаа, нэг талыг барилаа гэж шүүмжилдэг. Тэр нэр тааруу байгаагийн цаана дан нэр муутай хүмүүс ажилладаг гэж ойлгож болохгүй. Шүүхэд төсөв мөнгийг нь хангалттай хуваарилж, бие даан, хараат бусаар ажиллах нөхцлийг нь хангаж өгснийхөө дараа шударга ёс, өндөр түвшний ёс зүй шаардана аа. Миний байр суурь товчхондоо ийм байна.

## **Хөрөнгө оруулалтын оновчтой бүтцийг батлаж өгөх нь чухал**

*2014 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн намрын ээлжит Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс: Төрөөс мөнгөний бодлогын талаар, 2015 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай, Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийх цээр,*



**Улсын Их Хурлын дарга З.Энхболд:** Байнгын хорооны санал дүгнэлтийг УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл танилцууллаа. Дүгнэлттэй холбогдуулан, асуулттай гишүүд байна уу?

**УИХ-ын гишүүн Р.Гончигдорж:** Эдийн засгийн байнгын хорооноос оруулж ирсэн, зарчмын зөрүүтэй саналууд дотор зөрчил байна. Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг, Монгол улсын засгийн газар \Д.Тэрбишдагва\ -т даалгасугай гэж, УИХ-аас батлагдаагүй, санал хураагдаагүй, эрх шилжүүлэх тухай асуудал дээр тулгуурлаад, шадар сайдын нэрийг оруулж, ирсэн байна. Би Шадар сайд \Д.Тэрбишдагва\ -ыг энд буруутгаж байгаа юм биш. УИХ-аас батлаагүй, шийдвэр дээр эдийн засгийн байнгын хороо, асуудлыг тавих болсон бэ? Эндээс эхлээд хамгийн том зөрчлүүд үүсч байна. Өнөөдөр Шадар сайд \Д.Тэрбишдагва\ -ыг орлох тухай асуудлыг, УИХ-аас батлаагүй, санал хураалт хийгээгүй байна. Цааш нь үүнийг авч үзвэл, хуулийн бус аргаар хэн нэгэнд эрх мэдэл өгч, шууд гүнзгийрүүлж байна, болохгүй шүү дээ. Энэ хүн өөрөө хүсээгүй, хууль бусаар, шийдвэргүйгээр шилжүүлцэн, энэ эрх нь Улсын Их Хурлын санал хураалт дотор орж ирсэн байна. Ингэж болохгүй шүү дээ. Хуулиудаа эргэн харья. Монгол Улсын Үндсэн хуулийн 40 дүгээр зүйлүүдээс эхлээд, түүнээс уламжлан гарсан засгийн газрын тухай хууль, 2000 оны 8 сард оруулсан, засгийн газрын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтүүдээ харцгаа. Дараагийн ерөнхий сайд томилогдтол, ерөнхий сайд нь үүрэг гүйцэтгэгчээрээ ажлаад, энэ засаг төрийн ажил чинь тэр хэвээрээ залгамжлаад явдаг ёстой. Юунд яарч байна вэ? Хэдэн тохиолдолд, өөр хавсарч ажиллаж болохгүй албан тушаалд очсон, тухайлбал, Монгол Улсын ерөнхийлөгчөөр сонгогдсон, эсвэл өвчин зовлонтой шалтгаанаас үүдэн ажил үүргээ хэрэгжүүлэх боломжгүй гэсэн, хоёр, гурвхан тохиолдолд, өөр хүнээр орлуулдаг. Бусад тохиолдолд дараагийн хүн томилтол, үүрэг гүйцэтгээд явж байдаг тэр хуулиуд нь байна. Хэн юунд яарч байгаа вэ, Улсын Их Хурлаас дараагийн шийдвэр лүү ингээд орж байна. Болохгүй шүү дээ. Үүнийг хурдан зогсоо. Улсын Их Хурлаас батлаагүй, шийдвэрээр санал хураалтаа хийгээд явах юм бол, эрх мэдлийн төрийн эргэлт болно шүү дээ.

**Улсын Их Хурлын дарга З.Энхболд:** Санал хэллээ. Эдийн засгийн байнгын хороо асуудлыг, засгийн газрын хуулинд байна гэж оруулж ирсэн. Тэрний дагуу л шийдсэн байгаа. Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл асууя.

**Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл:** 2015оны Монгол Улсын төсвийн төсөлд татварын бус орлогыг 1.2 тэрбум төгрөгөөр, 152.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх нь гэж байна. Үүнээс нэг зүйл тодруулахыг хүслээ. Хэдэн хувь нь торгууль байх юм бэ? Ямар зөрчилтэй холбогдуулж, торгууль нэмэгдэнэ гэж үзэж байгаа юм бэ? Тодруулж хэлж өгнө үү. Ер нь торгуулийн эсрэг байгаа юм бишээ. Торгууль бол өөрөө хариуцлагын механизм учраас байх л ёстой. Гэхдээ урьдчилсан байдлаар, 152.7 тэрбум төгрөгийн хүү торгуулиар нэмэгдүүлэнэ, гэдгийг тодруулмаар байна. Хэдэн хувь нь торгууль, хүү байх юм бэ? Мөн өнөөдөр төгрөгийн ханш уналт 40%, заримдаа 60%-тай байна, аль вэ? 2015 оны төсвийн төсөлд цалинг 500 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр байгаа нь, ханшны уналтын зөрүүг нөхөж чадахаар байгаа юу, энэ тооцоог яаж хийсэн бэ? Тодруулж өгөөч.

**Улсын Их Хурлын дарга З.Энхболд:** Төрөөс мөнгөний бодлогын талаар, баримтлах үндсэн чиглэл ярьж байгаа, гэтэл төсвийн асуудлаар асуулаа. Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл хариулъя. \ Ажлын хэсэг\

**Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл:** Энэ ч одоо манай ажлын хэсэг дээр яригдаагүй. Манай ажлын хэсэг Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэлийн тухай асуудлыг ярьсан. Гэхдээ мөнгө, төсвийн бодлогын уялдааг хангах чиглэлээр, ялангуяа төсвийн бодлогыг мөнгөний бодлогын зүгээс, ер нь ямар байх нь зохистой тухай, эдийн засгийн байнгын хорооноос, төсвийн байнгын хороо руу саналуудаа явуулсан байгаа. Одоо төсвийн байнгын хороо 2015 оны төсвийн зохистой байдлыг яаж хангах тухай хуралдаанаараа ярих ёстой. Торгуулийн хувьд, хэзээ ч, хаана ч төлөвлөдөггүй. Үүнийг төсвийн байнгын хороо дээр 2015 оны төсвийн бодлогыг ярьж, Улсын Их Хурал дээр бид хэлэлцэх ёстой. Валютын ханшны хувьд, бас л төсөвтэй холбоотой. Өөрөөр хэлбэл 2015 онд цалинг 500 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхэд, хүн амын худалдан авах чадвар ямар байх вэ ? Үүнийг урьдчилан хэлэх боломжгүй. Яагаад гэвэл одоогийн валютын ханшны төсөөлөл чинь 1750 төгрөг байна. Өнөөдөр бодит ханш мөнгөний бодлогоор удирдуулан, “2014 ондоо ямар ч байсан савлагаа үүсгэхгүй байх” гэсэн байдалтайгаар, мөнгөний бодлогыг оруулж ирж байна. Тиймээс төсвийн байнгын хороонд нарийвчлан яригдаад, Улсын Их Хурал дээр мөн яригдах асуудал гэж бодож байна.

**Улсын Их Хурлын гишүүн Ц.Нямдож:** Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдоржын хэлсэн, “засгийн газарт гэдэг үгээр цаашаа явчих” даа. Заавал Ерөнхий сайдын нэр дурдаж, энэ будлиантай үед асуудал үүсгэж, хэрэггүй л дээ. Бодвол “Засгийн газар шуу санаатай” засаг гарч ирнэ байлгүй гэж бодож байна.

1. Эдийн засгийн байнгын хорооноос оруулсан саналд хоёр, гурван асуулт байна. Би 4-р заалттай холбогдуулан, асуух гэсэн юм. “Гол нэрийн бараа бүтээгдэхүүнийг тогтворжуулах, дунд хугацааны хөтөлбөрийг зах зээлийн зарчимд нийцүүлэх замаар иргэдийн хэрэглээний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой тогтолцоог бий болгож, хөтөлбөрөөс үе шаттай гарах арга хэмжээг сонгохыг даалгасугай” гэсэн байна. Одоо хүртэл явж ирсэн нь зах зээлийн зарчимд нийцээгүй юм байна, тийм үү, Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл ээ? Анхнаасаа энэ хөтөлбөрөөс гарах нь буруу байсан гэдгийг эдийн засгийн байнгын хороо хүлээн зөвшөөрч байгаа юм байна, гэж ойлгогдлоо. Энэ 2 ойлголт зөв үү?

2. Хадгаламж зээлийн хоршооны гишүүдийн хадгаламжийн мөнгөн даатгалыг хадгаламжын даатгалд, хамруулах бэлтгэл ажлыг хийнэ гэсэн байна. 2009 оны хямралтай үед, иргэдийн банк дахь мөнгөн хадгаламжыг мөн адил даатгалд хамруулсан тохиолдол байдаг. Сүүлд хугацаа дуусаад, энэ хууль хүчингүй болсон. Хэрэв хадгаламж зээлийн хоршоог даатгалд хамруулахаар бол, банк бус санхүүгийн байгууллагын хадгаламж, мөн даатгалд хамрагдах ёстой болно. Гол зүйл чинь, энэ шүү. Үүнийг эдийн засгийн байнгын хороогоор ярьсан уу, үгүй юу?

3. Монголбанкаас өнөөдрийг хүртэл хэрэгжүүлж ирсэн бодлого цаашаа явахгүй. Би энэ талаар олон удаа ярьж байна. Одоогийн Монголбанкны удирдлага юу хийхээ мэдэлгүй, хоёр жил явчлаа. Төгрөгийн тогтвортой

байдлыг хангах нь Монголбанкны үндсэн үүрэг гэж хуулийнх нь дөрөвдүгээр зүйлд заасан байдаг. Энэ Монголбанкны ерөнхийлөгч, \Н.Золжаргал\ барааны үнийн тогтвортой байдалыг ярьдаг. Ийм этгээдтэй цаашаа явж, болох юм уу? Энэ Монголбанкны ерөнхийлөгчын \Н.Золжаргал\ ах Н.Жаргалсайхан гэдэг хүн, 1990 онд Монголбанкыг нэг дампууруулсан. Дүү нь 2012 онд томилогдоход, дахин нэг дампууруулах юм байна даа гэж дотроо бодож байсан. Тэр замаар л явлаа даа. \Хоёр жил\ Ингээд төрсөн ах дүү хоёроор Монголбанкыг хоёр удаа самруулах ёстой гэж, ардчилсан нам үзэж байна, тийм үү? Энэ алдаагаа засахгүй юм байна, тийм үү? Энэ хүн гарч ирж, улс төрийн акц хийгээд, 2012 оны орон нутгийн сонгуулийн өмнө, 10 дугаар сарын 20-ны өдөр үнэ тогтворжуулах дэд хөтөлбөрийг Н.Алтанхуягтай гарын үсэг зурж, нэг дампууруулаад, 3 триллон төгрөг хууль бусаар гадагшаа гаргаж, 2013 оны 7 дугаар сарын 28-ны өдөр, \их хурал засварласны дараа\ төгрөгийн ханш 1800 төгрөг болж, 2013 оны ерөнхийлөгчийн сонгуулиар 8 хувийн зээлийн хүүгийн санамж бичигт гарын үсэг зурж, сарын дараа 60 сая төгрөг байсан орон сууц, 120 сая төгрөгт хүрсэн байсан. Ийм хүнийг хадгалаад байж болж байгаа юм уу? Эцэст нь Монголын эдийн засаг элгээрээ хэвтэхэд, хариуцлагыг хэн хүлээх юм бэ? Яагаад ийм хүнийг өмгөөлөөд, хамгаалаад байдгын энэ эрх баригчид? Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн төдийгүй, Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимын \МҮХАҮТ\ даргын хувьд С.Дэмбэрэл танд, өөрт чинь би хандаж хэлж байна. Монголын Улсын бүх үйлдвэр, аж ахуй нэгж элгээрээ мөлхөж байгаагийн гол шалтгаан нь валютын ханшыг барьж чадаагүйтэй холбоотой шүү. Монголын төр ийм байдалтай суусаар байх юм уу?

**Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл:** Ажлын дэд хэсгээс нэмж хариулна биз дээ. *Нэгдүгээрт:* "Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах" заалт юу гэсэн үг юм бэ гэдэгт, Улсын Их Хурлаас 2014 оны мөнгөний бодлого түүний дотор "үнэ тогтворжуулах хөтөлбөр"-т, тодорхой заалтуудыг оруулаад, зах зээлийн зарчимд шилжүүлэх замаар суулгаад өгсөн. 2015 оны "мөнгөний бодлого"-т, инфляцид нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийн нөлөөлийг тал бүрээс нь судлаад, нийлүүлэлтийн гаралтай инфляци, төрийн зохицуулалттай барааны инфляци, импортын инфляци, гэх мэт инфляцийн бүх хүчин зүйлүүдийг, гаргасны үндсэн дээр томъёололыг оруулж ирсэн. Энэхүү томъёолол нь "Монголбанк, Засгийн газарт тус тус өгөгдөж байгаа үүрэг даалгавар" гэдгийг хэлмээр байна..

*Хоёрдугаарт:* Хадгаламж зээлийн хоршоодын хувьд санхүүгийн зохицуулах хорооноос 2015 оны мөнгөний бодлогод суулгая, үүнийг дэмжиж өгөөчээ гэсэн томъёололоор оруулж ирсэн. Банк бус санхүүгийн байгууллагууд аливаа нэгэн хадгаламж авдаггүй. Банкуудын хадгаламж \хадгаламжийн даатгалын карпораци\ бидний баталсан хуулиар зохицуулагдаад явж байгаа.

*Гуравдугаарт:* Төгрөгийн тогтвортой байдал гэдгийг олон улсын хэмжээнд яг юу гэж ойлгодог талаар маш тодорхой ойлголтыг хэлж өгье. Аливаа мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдал гэдэгт, түүний гадаад үнэ цэнэ, дотоод үнэ цэнэ гэсэн хоёр ойлголтыг олон улсын хэмжээнд авч үздэг. Монгол улсын төв банкны тухай хуулийн үндсэн зорилт нь "төгрөгийн

тогтвортой байдлыг хангах” гэсэн байдаг. Ийм ч учраас, “төгрөгийн тогтвортой байдал” нь дараах байдлаар хэмжигддэг.

1. Үнийн тогтвортой байдал буюу инфляцийг яаж нам, тогтвортой түвшинд барих. \мөнгөний бодлогоор\
2. Инфляцид туслах үүрэг бүхий, валютын ханшны бодлогоор зохицуулагддаг.

Энэ талын заалтуудыг 2015 оны “мөнгөний бодлого”-т тусгасан байгаа. Ерөнхийдөө 2015 оны мөнгөний бодлогын бүх зүйлийг хийхийн тулд, 140 гаруй хуудастай материалыг, ажлын хэсэгт өгсөн. Ажлын хэсэгт, Монгол ардын намаас \Л.Энх-Амгалан, Ч.Хүрэлбаатар, А.Тлейхан\, Ардчилсан намаас \М.Зоригт, Н.Батбаяр, С.Одонтуяа, Ц.Баярсайхан\ нарын гишүүд оролцсон. Дашрамд хэлэхэд, ялангуяа Монгол ардын намаас оролцсон ажлын хэсгийн гишүүд, мөнгөний бодлогыг боловсруулахад маш идэвхитэй, бүтээлчээр оролцсон гэдгийг тэмдэглэж хэлье.

**Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэн:** 2012-2014 оны дунд үе хүртэл мөнгөний тэлсэн бодлого явуулсан. Инфляцийн түвшин энэ жилийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр, 12-13 орчим хувьтай гарах юм байна. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд, мөнгөний зөөлөн тэлсэн бодлого явуулж, валютын ханшаа алдсан. 3 их наяд гаруй төгрөгийг зах зээлд оруулж, одоо огцом 7 % -руу татаж болно. Инфляцийг бүр хатууруулаад, 7%-д барих бололцоо гарч магадгүй. Тэгэхээр өнгөрсөн хоёр жилд зах зээлд бий болгосон, хүлээлтийг яаж тооцсон юм бэ? Магадгүй 7 % гэдгийг бодитоор 8-9 %-д бариад, 10 %-аас доош байлгаж, энэ үед валютын ханшийг 1900 төгрөгөөс алдахгүйгээр, барих тийм нөөц бололцоо байна уу? Энэ талаар ажлын хэсэг дээр ямар тооцоо байгаа вэ? Монголбанк ямар танилцуулга хийсэн бэ? Өөрөөр хэлбэл, нэг туйлаас, 3.4 их наядыг гаргаж, нэг зөөллөөд, эсвэл бүгдийг нь хамж, нөгөө туйл руу савуулаад байхаар, аж ахуй эрхлэхэд, хүнд байна. Үүнд ямар тайлбар хийсэн бэ? Энэ 7%-ийн инфляцийг бодитоор барьж чадах уу? 7 хувийн инфляцийг барихын тулд, бүр хүнд байдалд орж, зээлийн олдоц буурна. Энэ тооцооны уялдааг тайлбарлаж өгөөч.

**Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл:** За.Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүн Ц.Нямдоржын асуултанд дутуу хариулсан байна. Үнэн. Монголын бизнес эрхлэгчид валютын ханшийн савлагаанаас их хохирч байна. 2014 онд УИХ-аас баталсан, мөнгөний бодлогот валютын ханшийн талаар тодорхой заалтууд оруулсан ч, бодит шалтгаан болон төвбанкны энэ чиглэлийн бодлого, дутуугаас ханшийн савлагаанаас улсын гадаад, дотоод эргэлт буурч, эдийн засаг, бизнесийн идэвхжил удааширсан. Тийм учраас, “2015 оны мөнгөний бодлого”-т эдийн засгийн байнгын хорооноос ажилсан ажлын хэсэг энэ асуудалд онцгой анхаарсан. Үүнд:

1. Жилийн жилд авч хэрэгжүүлдэг, “Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж, чөлөөтэй бөгөөд уян хатан тогтох” зарчмыг дэлгэрүүлсэн 2-3 заалт орсон байгаа.

2. Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2015 оны эцэст 7%-д барихад ямар бололцоотой гэдэгт, 2015 оны бодит төсөөллөөр инфляци 11.5% байгаа. “Мөнгөний бодлого”-г 7% нь их чамбай, маш

нарийн сууж өгсөн. \заавал хатууруулах биш\ Ерөнхийдөө инфляцийг тогтворжуулах, нам доор түвшинд барихад Монголбанкны багажинд байдаг бүх арга хэрэгслүүдийг дайчлан ажиллах, чиглэлээр мөнгөний бодлогын 2015 оны үндсэн чиглэлдүүдэд туссан байгаа.

Тиймээс ч өнгөрсөн жилийн зарим, дутуу хэрэгжсэн зорилтуудаас эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсгийн гишүүд санал гаргаад, 2 заалтыг нэмж оруулсан. Инфляцийг 7%-д барих асуудал нь мөнгөний бодлогоор шийдэгддэг асуудал биш юм. Өнөөдөр Монгол Улсын инфляци, өнгөрсөн оны явуулсан “мөнгөний бодлогын инфляцийг нам доор түвшинд барих” бодлогын үр дүнгээр нийлүүлэлтийн гаралтай инфляци, 2010-2012 онд 32.5% байсан бол өнөөдөр 5 % болтлоо буурсан. Инфляцид нөлөөлж байгаа гол хүчин зүйлүүд нь \импортын инфляци, хүнсний бус инфляци, нийлүүлэлтийн гаралтай хүнсний инфляци\ өөрөө тогтворгүй, аймаг, хотуудын түвшинд өөр өөр хүчин зүйлээр нөхцөлдөж байгаа учраас энэ тухай “**нийлүүлэлийн гаралтай инфляцийг аймаг хотын түвшинд тодорхойлох**” заалтыг оруулж өгсөн. Өөрөөр хэлбэл Монгол Улсын засгийн газар, төсвийн тухай хуулиараа, төсвийн тогтвортой байдлын хуулиараа ч үүнийг анхаарах ёстой. Энэ талаас нь бодож, тодорхой зарим заалтуудыг оруулсан гэдгээ хэлмээр байна. Монголбанкны ерөнхийлөгч \Н.Золжаргал\ нэмэлт тайлбар хэлээрэй.

**Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргал:** Б.Чойжилсүрэн гишүүний асуултанд хариулья. 2013, 2014, 2015 оны мөнгөний бодлогууд, хэр зэрэг төстэй явах вэ гэдгийг асууж байна. Ер нь эдийн засагт бий болсон хүндрэлээ юу гэж үнэлэхээс болоод байна. 2013 онд гадаад цэвэр актив 2.5 тэрбум доллараар, 2014 онд 700 доллараар тус тус буураад, цаашид 2015 онд хүлээлт бол эерэг тал руугаа байна гэж бодож байгаа. Тэгэхээр мөнгөний хатуу, зөөлөн бодлогоосоо илүү хувийн секторт аль зэрэг ачаалал болж байна, гэдгээс инфляцийг 7%-д тооцоход, заавал “нэн хатуу бодлого” гэж томъёолох нь буруу юм. Учир нь үнэхээр хямралын түвшин үүнээс ч доошоо байх шаардлага гарвал нэмэх ч гарах боломжтой. Ер нь бол 7%-ийн инфляцийг зориод 9.5 %-ийн хүлээлттэй байгаа тохиолдолд, одоо энэ оноо дуусгаж байгаа нь, өөрөө нилээн хатуу бодлогын сонголт гэдэг нь үнэн. Мөнгөний хатуу бодлогын сонголт нь гадаад цэвэр активын өсөлтөөр зөөлрөх ёстой. Зөөлрөх механизм нь гадаад цэвэр актив юм. Гадаад цэвэр активын хувьд, 2013, 2014 онуудад авч болдог хамгийн өндөр шокоо авчихаад байгаа. Эдийн засгийн шокыг шингээх ажилд Монголбанк 2013, 2014 онд нилээн идэвхитэй ажилласан. Үүний үр дүнд таны хэлээд байгаа 2013 оны мөнгөний бодлогын сонголтуудыг сонгосон байгаа. Энэ нь өөрөө дотоодын эдийн засгийг хамгаалахад чиглэгдсэн сонголтууд байсан боловч одоо цаашид үүнийг удаанаар үргэлжлүүлж, чадахгүй. 2014 оны дунд үеэс “мөнгөний бодлого”-т хүүгээ нэмсэн нь Монгол Улсын дотоод эдийн засагт, ялангуяа төсөвт асар өндөр орлого, зарлагын хүлээлттэй байсанаас улбаатай. Одоо 2015 оны төсөв дээр бодитойгоор орлого, зарлага тал дээрээ өөрчлөлтүүд гаргахгүй бол, 7%-ийн инфляци, үнэхээр хатуу юм шиг бодлого болно. Тэнд эерэг бодлого яваад макро эдийн засгийн баланс хадгалагдаад, эхлэх юм бол 7%-ийн инфляци, гэдэг бол тийм ч аюулын хатуу бодлого биш. Энэ нь бодлогын цогц арга хэмжээний зөвхөн нэг хэсэг нь учраас, дан



ганцаар 7 % гэдэг тоо “аюулын хатуу” гэдэг үгээр тайлбарлах боломжгүй. Нөгөө талдаа төсвийн бодлого аль зэрэг явж байгаагаас шууд хамааралтай зүйл. Монгол Улсын эдийн засгийн тал хувь нь төсөв байдаг учраас, хоёр талын сонголт яваад байна. \нөхцөл байдал ижил биш учраас хоёр өөр сонголтууд байгаа\ Нөгөө талдаа Улсын төсөвт хэрхэн бодлого тусаж, \нийт эдийн засгийн тал мөнгө нь хувиарлагддаг\ тэнд ямар зарцуулалтын систем, байхаас хамаараад, мөнгөний бодлогын инфляцийн түвшингийн зорилтын хатуу, зөөлөн томъёолол өөрчлөгдөх юм. 2014 оны мөнгөний бодлогыг томъёолоход, 7%-ийн инфляцийн зорилтыг тавьж байсан, ер нь инфляцийн зорилт нь өөрөө эдийн засагт хэрэгжихдээ, тодорхой тооноосоо илүү, дунд хугацааны буюу 3 жилийн төсөөлөл нь хамгийн чухал байдаг. 3 жилийн дотор ямар тоо руу зорьж явж байгаа гэдэг нь бодлогын сонголтуудыг томъёолж өгдөг. Мэдээж нөхцөл байдал, саяынх шиг гадаад цэвэр актив хоёр тэрбумаар буурна, нэмэгдэнэ, хасагдана, зориод байгаа тоо нь иргэдийн бодит орлого дээр ямар нөлөөллийг шингээж авчрах юм бэ гэдгийг сонгодог. Төв банкны арга механизм нь ингэж чиглэж байдаг. УИХ-ын гишүүн Б.Чойжилсүрэн, 7%-ийн инфляци нийт хувийн секторт ямар ачаалалтай ирэх юм бэ гэж асуусан, гэж ойлгож байна. Тэр ачаалал нь Монгол Улсын төсвийн бодлого дээр, бодитой тэлэлт явагдвал хатуу, эерэг нөлөөлөл гарвал арай зөөлөн, гадаад цэвэр актив дээр эерэг нөлөөл гарвал, хувийн сектор дээр арай зөөлөн гадаад цэвэр актив дээр гадаадын хөрөнгө оруулалт, шууд хөрөнгө оруулалт нэмэгдэхгүй бол, энэ бол хувийн сектор дээр нилээн хатуу бодлого болж тус тус очдог. Гэхдээ бодлогын сонголтуудаас тийм олон сонголт байхгүй.

**Улсын Их Хурлын дарга З.Энхболд:** УИХ-ын гишүүн Б.Чойжилсүрэн тодруулья.

**Б.Чойжилсүрэн гишүүн:** Улсын Их Хурлын даргаа, одоо төсөв батлаж дуустал долоо хоног байна. Одоо Монголбанкыг, Сангийн яамтай, Эдийн засгийн байнгын хороог, Төсвийн байнгын хороотой нь хамт суулгаад энэ тооцоонуудыг хамтдаа хийхгүй бол, энэ хүн чинь нэг эрх мэдлийн нэг тал учраас болохгүй байна. Энэ хэлэлцүүлгийг хойшлуулан, өнөөдрөөс эхлээд амралтын өдрүүдэд ч суух хэрэгтэй. Магадгүй 7% гэдгийг 10%- руу гаргаж өгөөд, УИХ-аас батлаж гаргасан шийдвэрийг хэрэглэдэг, илүү үр дүн гардаг байдал рүү шилжмээр байна. Тэгэхгүй бол энэ хүн өөрийнхөө өнцгөөс ярьдаг, нөгөө талд нь хүндрэл байдаг, эцэст нь төсвийг бид хөөсрүүлээд баталдаг. Хариуцлагатай баймаар байна. Хамтарсан ажлын хэсэг гараад хоёр талаасаа тулгалдаа.

**Улсын Их Хурлын дарга З.Энхболд:** Төсөв мөнгөний бодлогын уялдааг ханагч чиглэлээр, С.Дэмбэрэл гишүүн нилээн ажилласан, ер нь сүүлийн 2 долоо хоног хамтарч ажиллаж байгаа гэж бодож байна, хариулья.

**Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл:** Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэн маш зөв асуудлыг тавиад байна. Тиймээс ажлын хэсгийн гишүүдийн нэгдэж, тал талаас нь ярьсан асуудал нь дараа жилийн төсөв ямар байж батлагдвал, энэ мөнгөний бодлогыг бодитой хэрэгжих макро орчин нөхцөл үүсэх вэ, тийм учраас эдийн засгийн байнгын хорооноос, төсвийн байнгын хороонд явуулсан, ажлын хэсгийн гишүүд санал нэгдсэн найман санал гаргасан байгаа. Тэр найман санал дотор, тухайлбал

дараа жилийн Монгол улсын төсөв алдагдалгүй, нэмэх тэмдэгтэй, хөрөнгө оруулалтыг валютын ханшны илүүдэл эрэлтийг үүсгэхгүй байх, инфляцийн дарамт учруулахгүй байгаасай гэсэн ийм хэдэн тодорхой саналуудыг төсвийн байнгын хороо руу явуулсан. Гэхдээ төсвийн байнгын хороо, миний сонссоноор, бусад байнгын хорооноос ирсэн саналыг тэгж нухацтай хэлэлцдэггүй. Тийм учраас төсөв мөнгөний бодлогын ажлын хэсгийг уялдуулах чиглэлээр, ажлын хэсэг Монгол Улсын Засгийн газарт, хэдэн заалт “макро, төсвийн зохистой бодлого буюу төсвийн бодлого ямар байвал, дараа жилийн зорилт болох дунд хугацаанд инфляцийг 7%-ийн \нэмэх, хасах\ ямар нэгэн тодорхой хэлбэлзэлтэй байлгах” буюу өөрийн тань хэлж байгаа 1 оронтой тоонд багтаах зорилтыг би ажлын хэсэг дээр гаргаж байсан. Харамсалтай нь дэмжлэг аваагүй. Олон улсын төв банкны практикаас үзэхэд, \инфиляцыг онилж байгаа 40 гаруй орны туршлага\ хэзээ ч парламент нь ийм тогтосон тоо батлаж өгдөггүй, жишээ нь 7% -ийг 1, 2 \нэмэх, хасах\ гэж батлаж өгдөг юм байна. Төвбанкны тайлбарлаж байгаагаар, энэ хэлбэлзэл нь өөрөө “мөнгөний бодлогыг үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, ажлын төлөвлөгөөнд тусгагдсан” гэсэн тайлбар хийсэн учраас зайлшгүй оруулагүй юм. Гэхдээ “төсөв мөнгөний бодлого”-г бүр сарын өмнө яригдсан асуудал. Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлд манай ажлын хэсгээс төлөөлж, би энэ асуудлыг хэлж байсан. Ямар ч гэсэн эдий засгийн байнгын хорооноос, мөнгөний бодлогыг боловсруулдаг төсвийн байнгын хороонд энэ саналуудаа явуулсан. Одоо хамгийн гол нь Их Хурлын гишүүд бид төсвийг батлахдаа ядахдаа “нойл” тэмдэгтэй, эсвэл бүр сайн нь “нэмэх” тэмдэгтэй, төсвийн хөрөнгө оруулалт урсгал зардлыг хэмнэхээс гадна, хөрөнгө оруулалтын оновчтой бүтцийг батлаж өгөх нь чухал. Үүнд макро тэнцвэрийг хангахад, ялангуяа Улсын Их Хурлын гишүүдийн хариуцлага маш чухал болно. Тийм учраас төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангах, 3-4 заалт орсон байгаа гэдгийг нэмж хэлье.